

J. K. ROWLING

A phoenix, a mythical bird that is reborn from its own ashes, is depicted in a state of intense fire and light. The bird is shown in profile, facing left, with its wings spread and its body surrounded by a swirling mass of bright orange and yellow flames. The background is dark, making the fire stand out prominently. The overall effect is one of power and renewal.

ХАРРИ
ПОТТЕР

ФЕНИКСИЙН
БҮЛГИЙНХЭН

Харри Поттер ба Фениксийн бүлгийнхэн

Зохиолч:	J. K. Rowling http://www.jkrowling.com/
Орчуулагч:	Asuult Forum-ийн гишүүн CROFT http://forum.asuultserver.com
Эмхэтгэл, хөрвүүлэлт:	Б.Болдхүү Имэйл: bxbenny@gmail.com Блог: http://www.boldkhuu.com Facebook: http://facebook.com/bxbenny Twitter: http://twitter.com/bxbenny

Эхийг Asuult Forum-аас авав.

ГАРЧИГ

БҮЛЭГ 1: ДАДЛИ УХААН САМУУРСАН НЬ	4
БҮЛЭГ 2: УУЛЬНУУД, УУЛЬНУУД	19
БҮЛЭГ 3: ХАМГААЛАЛТЫН ОТРЯД	38
БҮЛЭГ 4: ГРИММОГИЙН АРВАН ХОЁРДУГААР БАЙШИН	53
БҮЛЭГ 5: ФЕНИКСИЙН БҮЛГЭМ	70
БҮЛЭГ 6: ЭРТНИЙ СУРВАЛЖИТ ГАРАЛТАЙ БЛЭКИЙН ГЭР БҮЛ.....	87
БҮЛЭГ 7: ИД ШИДИЙН ЯАМ	106
БҮЛЭГ 8: СОНСГОЛ	119
БҮЛЭГ 9: ХАТАГТАЙ УИЗЛИЙН АЙДАС	132
БҮЛЭГ 10: ПОЛУМНА ЛАВГУД	156
БҮЛЭГ 11: ХУВААРИЛАГЧ БҮРХ МАЛГАЙН ШИНЭ ДУУ.....	173
БҮЛЭГ 12: ПРОФЕССОР АМБРИЖ	190
БҮЛЭГ 13: ҮДЭШ ДОЛОРЕСИЙНД.....	215
БҮЛЭГ 14: ПЕРСИ БА ТЭНҮҮЛЧ.....	239
БҮЛЭГ 15: ХОГВАРТСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ.....	262
БҮЛЭГ 16: ГАХАЙН ТОЛГОЙНД.....	281
БҮЛЭГ 17: БОЛОВСРОЛЫН ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ХУУЛЬ.....	297
БҮЛЭГ 18: ДАМБЛДОРЫН АРМИ	316
БҮЛЭГ 19: АРСЛАН БА МОГОЙ	336
БҮЛЭГ 20: ХАГРИДЫН ЯРИА.....	354
БҮЛЭГ 21: МОГОЙН НҮД	371
БҮЛЭГ 22: ГЭГЭЭН МУНГОГИЙН ИД ШИДИЙН ӨВЧИН ЭМГЭГИЙН ЭМНЭЛЭГ	391
БҮЛЭГ 23: ТУСГААРЛАГДСАН ЗУЛ САР	412
БҮЛЭГ 24: ОККЛЮМЕНЦИЙ	432
БҮЛЭГ 25: УТСАН ДЭЭРХ ЦОХ	455
БҮЛЭГ 26: ГЭНЭТИЙН ЯВДАЛ.....	476
БҮЛЭГ 27: ХҮН МОРЬ БА ХОВЧ	499
БҮЛЭГ 28: СНЕГГИЙН ХАМГИЙН МУУ ДУРСАМЖ.....	521
БҮЛЭГ 29: МЭРГЭЖЛИЙН СОНГОЛТ.....	544
БҮЛЭГ 30: ГРОХХ.....	566
БҮЛЭГ 31: С.И.Ш	588
БҮЛЭГ 32: ГАЛААС ГАРСАН НЬ.....	609
БҮЛЭГ 33: ТЭМЦЭЛ БА НИСЛЭГ	628
БҮЛЭГ 34: НУУЦЫН ХЭЛТЭС.....	639
БҮЛЭГ 35: ХӨШИГНИЙ ЦААД ТАЛД.....	653
БҮЛЭГ 36: ТҮҮНИЙ ЦОРЫН ГАНЦ АЙДАГ ХҮН.....	676
БҮЛЭГ 37: АЛДАГДСАН ЗӨГНӨЛ.....	687
БҮЛЭГ 38: ХОЁРДУГААР ДАЙН ЭХЛЭВ.....	708

БҮЛЭГ 1: ДАДЛИ УХААН САМУУРСАН НЬ

Зуны бүгчим халуун өдрийн үдэш Улаан модон гудамжны байшингуудад нойрмог нам гүм ноёрхож байв. Машиныуд гялалзахын оронд тоостой зогсож оршин суугчдад ус түгээгүүрийн хоолой хэрэглэхийг хорьсон болохоор зүлэг маргад ногоон өнгөө алдан хатаж шаргалтана. Тэд ердийнхөөрөө машинаа угааж, зүлэг тайрахын оронд байшиндаа сууцгаагаад сэвшээ салхи үлээх байх гэсэн бүтэлгүй найдлагаар цонхоо том нээжээ. Байшинд байгаагүй цорын ганц хүн болох өсвөр насны хүү дөрөвдүгээр байшингийн өмнөх цэцгийн мандал дээр дээшээ хараад хэвтэж байлаа.

Энэ бол туранхай хар үс, нүдний шилтэй, үл ялиг өвдсөн юм шиг цонхигор царайтай хүү байлаа. Жинсэн өмд нь бохир, өнгөгүй гандсан нэвсгэр футболкатай агаад энгийн кэт өмсчээ. Нэг үгээр хэлэхэд Харри Поттерын гадна төрх хөршүүдийн нүдэнд өртөхөөргүй бөгөөд гархин цэцгийн бутны ард чимээгүйхэн хэвтэж байхад нь дэргэдүүр өнгөрөх хүмүүс харахааргүй ажээ. Түүнийг зөвхөн Вернон ах юм уу Петунья эгчийн аль нэг нь зочны өрөөний цонхоор цэцгийн мандал руу толгойгоо шургуулвал харж болохоор байлаа.

Харри ингэж нуугдсандаа баяртай байв. Халуу дүүгсэн хатуу газар хэвтэхэд аягүй байсан ч зочны өрөөнд нагац ах, эгчийнхээ хамт зурагт үзэх болгонд нь байдаг шиг хэн ч түүн рүү муухай харж, мэдээ сонсохын аргагүй шүдээ хавиран, элдэв тэнэг асуулт тавихгүй байлаа.

Гэтэл энэ бодолтой зэрэгцэн нээлттэй цонхоор Харрийн нагац ах Вернон Дурслийн ярих чимээ гарав.

- Хүү нүдэнд торохоо больсон нь сайн хэрэг. Ингэхэд тэр хаана байгаа юм бол?
- Мэдэхгүй. Байшинд лав байхгүй гэж Петунья эгч хайхрамжгүй хэлэв.
- Чи түүний мэдээ сонирхож байгааг нь харсан уу. Түүний толгойд юу байгааг мэдэх юм алга. Жирийн хүүд мэдээ үзэх хэрэг байхгүй. Дадли ойлгох нь бүү хэл манай ерөнхий сайд хэн байдаг гэдгийг ч мэдэхгүй. Тэгээд ч түүний овгийнхонд манай мэдээ ерөөсөө хамаагүй ... гэж Вернон ах шуухитнаснаа зэвүүцэнгүй хэлэв.
- Чшш, Вернон! Цонх онгорхой байна! гэж Петунья эгч шивнэлээ.
- Аан ... тийм л дээ, би мартчихаж.

Дурслийнхан чимээгүй болов. Харри өглөөний зууш болох эрдэнэ шишийн

хөөсөнцөрийн зар явахыг сонссоноо Глициний гудамжинд байдаг хатагтай Фигг гэдэг ухаан муутай мууранд дуртай хөгшин хажуугаар нь удаан майжигнан өнгөрөхийг харлаа. Тэр хөмсөг зангидан хамар дороо ямар нэг юм бувтнаж байв. Харри бутны цаана байгаадаа баярлалаа. Сүүлчийн удаа хатагтай Фигг түүнтэй гудамжинд тааралдаад цай уухаар урьсан юм. Түүнийг булан тойрч үзэгдэхээ болиход цонхоор ахиад Вернон ахын хоолой хадав.

- Дадлид хэнийд зочилж байгаа юм бол?

- Полкиссийнд. Тэр их нийтэч болохоор олон найзтай гэж Петунья эгч хариулав.

Харри тургилахгүй байж арайхийн тэслээ. Тэдний хүү Дадлид хамаатай бүхэнд Дурлсийнхан гайхаж бишрэн ханддаг байлаа. Тэд түүнийг зуны амралтын үдэш бүр эцэг эхчүүд найз нөхөд шигээ гэртээ оройн хоолонд юмуу цай уулгахаар урина гэж итгэдэг байв. Харри ганцаараа л Дадли хэнийд ч зочлоогүй бөгөөд найзуудтайгаа хүүхдийн тоглоомын талбайг сүйтгэн, гудамжны буланд тамхи татан хажуугаар өнгөрөх машин болон хүүхдүүд рүү чулуу шидэж байгаа гэдгийг мэдэж байв. Харри нэг бус удаа тэднийг Литтл Уингингэд хэсүүчилж энэ ажлаа хийж байхыг нь харжээ. Тэр амралтынхаа ихэнхийг гудамжны хогын савнаас сонин түүн өнгөрүүлжээ.

Долоон цагийн мэдээ эхлэх хөгжим явахад Харрийн зүрх цохиллоо. Магадгүй өнөөдөр сарын турш хүлээж байсан өдөр нь юм болов уу?

«Испанийн нисэх онгоцны буудлын ачаа тээш зөөгчид амралтын улирлын үеэр хоёр дахь долоо хоногтоо ажил хаяж ...»

- Минийхээр болдог бол тэдэнд насан туршийнх нь амралт өгөх байсан гэж

Вернон ах бувтнасан учир хөтлөгчийн сүүлчийн үг сонсогдсонгүй.

Харри цэцгийн мандалдаа тайвширлаа. Хэрвээ ямар нэгэн юм болсон бол мэдээж хамгийн түрүүнд мэдэгдэнэ шүү дээ. Үхэл бол амрагч нараас илүү чухал сэдэв юм.

Тэр удаанаар санаа алдаад цэлмэг тэнгэр лүү харав. Энэ зуны өдрүүд бүгд адил байлаа. Хүчилсэн хүлээлт, итгэл найдвар, түр зуурын санаа амралт дараа нь ахиад л хүлээлт ... тэгээд «Яагаад юу ч болохгүй байгаа юм бол?» гэдэг асуулт.

Тэр цааш нь тайлбарлаж боломгүй алга бололт юм уу эсвэл өөр хачирхалтай цугларалт зэрэг маглуудад ойлгомжгүй явдлын тухай сонсохыг хүлээлээ. Гэхдээ испанийн нисэх онгоцны буудлын дараа Английн өмнөд хэсэгт ган болсон тухай

ярилаа (Манай хөрш сонссон гэж найдаж байна! Нууцаар өглөөний гурван цагт зүлгээ услая гэж Вернон ах дуу алдав) цаашаа нисдэг тэрэг Суррейд осолдсон тухай дараа нь алдартай жүжигчин нөхрөөсөө салсан тухай (Бид тэдний бузар булай паянг сонсох ямар хэрэгтэй юм бэ гэж яг энэ тухай сэтгүүл дээрээс хомхойрон уншиж байсан Петунья эгч хэлээд ясархаг гараа савчив) гарлаа.

Харри жаргаж байгаа наранд гялбахгүйн тулд нүдээ анилаа. Хөтлөгч цааш үргэлжлүүлэн,

«Ингээд хамгийн сүүлчийн мэдээ. Банги тоть халуунаас аврагдах шинэ арга олжээ. Банги усны цанаар хичээллэхэд сурсан байна! Манай сурвалжлагч Мэри Доркинс та бүхэнд үйл явдлын тухай мэдээлнэ».

Харри нүдээ нээлээ. Тэд усны цанаар явдаг тотинд хүрсэн болохоор цааш сонсох нь утгагүй байлаа. Тэр чимээгүйхэн дөрвөн хөллөөд болгоомжтойгоор цонхноос холдохоор завдав.

Гэхдээ түүнийг дөнгөж хөдлөв үү үгүй юу маш хурднаар хэд хэдэн зүйл боллоо.

Нойрмог агаарыг буу тасхийх адил чимээ эвдэхэд, машины дэргэд байсан муур огло үсэрч түүнийг даган Дурслийн зочны өрөөнөөс хятад шаазан хагаран эмэгтэй хүн хашгирах, эрэгтэй хүн хараах чимээ гарав. Харрийн удтал хүлээсэн дохио гарсан болохоор хөл дээрээ үсрэн босоод шидэт саваагаа өмднийхөө халааснаас гаргах гэтэл Дурслийн нээлттэй цонхны жаазыг тасхийтэл мөргөв. Чимээ энэ удаад Петунья эгчийг илүү чанга хашгирахад хүргэжээ.

Харрийн толгой хоёр хуваагдах шиг санагдав. Нүдэнд нь нулимс цийлэгнэхэд ганхсанаа гудамжинд чимээ гаргасан зүйлийг харахыг хичээлээ. Тэгтэл цонхноос хоёр том улаан гар гарч хоолойг нь шахав.

- Үүнийгээ одоохон боль! Боль! Хэн ч хараагүй дээр! гэж Вернон ах Харрийн чихэнд архирлаа.

- Намайг тавиач! гэж Харри амьсгаадав.

Тэмцэл хормын турш явагдав. Харри зүүн гараараа нагац ахынхаа зайдас шиг бүдүүн хурууг суллахыг хичээж баруун гартаа шидэт саваагаа чанга атгалаа. Харрийн зулай янгинан өвдөхөд Вернон ах гэнэтхэн тогонд цохиулсан аятай хашгираад гараа тавилаа. Зээгийнх нь биенээс ямар нэг үл үзэгдэх хүч гаран барих боломжгүй болжээ.

Харри амьсгаадсаар бутан дунд унаснаа босоод ийш тийшээ харлаа. Чанга тасхийх чимээ хаана гарсан нь ойлгомжгүй байлаа. Хөршийн цонхоор сониучирхсан царайнууд цухуйж үзэгдэв. Харри саваагаа яаран буцааж хийгээд гэмгүй царай гаргахыг хичээлээ.

- Сайхан үдэш байна! Миний эвдэрхий хөдөлгүүр яаж дуугарсныг сонсов уу? Петунья бид хоёр жаахан сандарлаа шүү! гэж Вернон ах долдугаар байшингийн хөшигний цаанаас цухуйж байсан эзэгтэй рүү даллан хашгирлаа.

Тэр цонхны цаадах сониуч хөршүүд нь алга болтол эв хавгүйгээр үргэлжлүүлэн инээмсэглэв. Тэгтэл инээмсэглэл уур хилэнгээр солигдож Харриг занган дуудлаа.

Харри хэд алхаад Вернон ахын сунгасан гар боомилж чадахааргүй зайд зогсов.

- Чи ямар чөтгөрөө хийгээд байна, хүү минь? Одоохон тайлбарла! гэж Вернон ах сөөнгөтсөн хоолойгоор ууртай хэлэв.

- Би юу хийсэн гэж үү? хэмээн Харри хүйтнээр асуугаад толгойгоо ийш тийш эргүүлэн чимээ гаргасан хүнийг харахыг оролдов.

- Гар буугаар буудсан юм шиг чимээ манай гадаа гарсан ...

- Би ямар ч чимээ гаргаагүй гэж Харри эсэргүүцлээ.

Петунья эгчийн морь шиг туранхай царай, Вернон ахын том ягаан нүүртэй зэрэгцэн цухуйж үзэгдэв. Тэр ууртай байлаа.

- Чи яагаад цонхон дор нуугдаж байсан юм?

- Өө, тийм л дээ! Сайхан асуулт байна, Петунья! Чи манай цонхон доор юу хийж байсан юм?

- Мэдээ сонсож байсан юм гэж Харри эвлэрэнгүй өгүүлэв. Нагац эгч хоёр нь бухимдсан харц солилцов.

- Мэдээ сонссон гэнээ! Ахиад л!

- Өдөр болгон өөрчлөгддөг биз дээ гэж Харри тайлбарлав.

- Өөрийгөө надаас ухаантай гэж бодоо юу, хүү минь! Би чиний ухаанд юу байгааг мэдэхийг хүсч байна! Энэ мэдээ сонсох мэтийн новшийн юмаа бүү яриад бай. Би танай овгийнхонд ...

- Болгоомжтой Вернон! гэж Петунья эгч хэлэхэд Вернон ах дуугаа сонсдох

төдий болгов.

- ... манай мэдээ хамаагүй гэдгийг сайн мэдэж байна!

- Та нар л тэгж бодож байгаа юм гэж Харри эсэргүүцэв.

Түүнийг Дурслийнхан хэдэн хормын турш нүд бүлтийн ширтсэний эцэст Петунья эгч,

- Чи бол новшийн худалч амьтан. Уульнууд чамд мэдээ авчирч байгаа биз дээ? гэж аяархан хэлэхэд сүүлчийн үгийг Харри уруулаас нь олж уншлаа.

- Аанхан! Энэ л байхгүй юу! Чамайг жигшүүртэй шувуунуудаас мэдээ авдаг гэдгийг чинь мэдэхгүй гэж бодоо юу! хэмээн Вернон ах хөөрөн шивнэв.

Харри агшин зуур тээнэгэлзлээ. Түүнд үнэнийг хэлэхдээ ямар таагүй байгааг Дурслийнхан мэдсэнгүй.

- Уульнууд ... надад ямар ч мэдээ авчраагүй гэж тэр сулхан дуугарлаа.

- Итгэхгүй байна гэж Петунья эгч эсэргүүцэв.

- Би ч гэсэн гэж Вернон ах хүчлэн хэлэв.

- Бид чамайг сайнгүй юм бодож байгаа гэдгийг чинь мэдэж байна гэж нагац эгч нь хэлэв.

- Бас тэнэг биш гэдгээ мэдэж байна гэж нагац ах нь дэмжлээ.

- Энэ чинь миний хувьд шинэ мэдээ байна! гэж Харри уурсаад Дурслийнхан юм хэлэхийг хүлээгүй эргэж зүлгэн дээгүүр яван намхан бургасан хашааг өнгөрөөд гудамж руу гарлаа.

Тэр асуудалд орсноо мэдэж байв. Тэр нагац ах эгч хоёртойгоо бүдүүлэг харьцаж уурлуулснаа мэдэж байсан ч одоо өөр зүйл санааг нь зовоож байв. Ухаанд нь илүү чухал зүйлүүд байлаа.

Харри тас хийх чимээ хэн нэгэн шилжсэнээс гарсан гэдэгт эргэлзсэнгүй. Тийм чимээг гэрийн үйлчлэгч Добби агаарт алга болохдоо гаргаж байсан юм. Добби Улаан модон гудамжинд байсан юм болов уу? Тэр үнэхээр энд байж Харригийн араас мөрдөж байсан хэрэг биш биз дээ? Энэ бодол санаанд нь ороход Харри гудамж руу харсан ч хоосон байлаа. Гэхдээ Харри Добби үл үзэгдэхгүй болж чадахыг мэдэж байв.

Тэр хаашаа явахаа төсөөлөлгүй цааш явлаа. Сүүлчийн удаа энэ гудамжаар олон удаа явсан болохоор хөл нь өөрийн эрхгүй ийш нь хөтлөөд ирж. Алхам бүрдээ ийш тийшээ харж байлаа. Харри түүнийг нагац эгчийнхээ цонхны дор хэвтэж байхад дэргэд нь ямар нэг шидэт явдал болсон гэдэгт итгэлтэй байв. Гэхдээ тэр яагаад түүнтэй ярих юмуу холбоо тогтоосонгүй вэ? Яагаад нуугдсан юм бол?

Түүнийг гонсойлт улам өсөн нэмэгдсэн ч итгэлтэй биш байв.

Шидэт чимээ биш байсан юм болов уу? Магадгүй шидэт ертөнцөөс ямар нэгэн дохио хүлээж цөхөрсөндөө болоод ердийн чимээг тэгж хүлээж авсан юм болов уу? Эсвэл хөршийн байшинд ердөө юм унасан юм хэрэг үү?

Харрийн дотор хүнд гунигтай байв. Тэр бүх л зуны турш зовоосон найдлагагүй байдлыг мэдэрчээ.

Маргааш уулийн шуудангаар «Өдөр тутмын зөнч» сонин хүлээн авахын тулд өглөөний таван цагт босох хэрэгтэй. Гэхдээ ингэх хэрэг байна уу? Харри зөвхөн сонины эхний нүүрийг гүйлгэн хардаг байлаа. Волдеморт эргэн төрсөн тухай том гарчигтай гарах нь мэдээж шүү дээ.

Аз болоход уулийн шуудан найзуудаас нь захиа авчирч байв. Гэхдээ тэр ямар нэгэн шинэ мэдээ уншина гэж найдахаа больжээ.

Бид Хэцүү нэртийн тухай юу ч мэдэхгүй. Захиа бусдын гарт орж магадгүй болохоор бидэнд ямар ч чухал юм бичиж болохгүй гэсэн ... Бид их завгүй байгаа ч хэлэх боломжгүй байна ... Дараа уулзахдаа бүхнийг ярьж ...

Тэгээд энэ уулзалт нь хэзээ болох юм бэ? Тодорхой өдрийг хэн ч хэлсэнгүй. Төрсөн өдрийн баяр хүргэсэн ил захидал дээр Гермiona «Бид удахгүй уулзана гэж бодож байна» гэж бичсэн ч энэ удахгүй гэсэн нь хэзээ болохыг бичсэнгүй. Харри тэдний захианаас бүдэг бадаг утгыг нь ойлгож байлаа. Гермiona Роны гэрт эцэг эхийнх нь хамт байгаа бололтой. Түүнийг Улаан модон гудамжинд торж байхад тэд Үүрэнд цагаа хэрхэн хөгжилтэй цаг өнгөрүүлж байгаа талаарх бодлоо Харри арайхийн таслан зогсоов. Тэр уурласандаа төрсөн өдрөөр нь илгээсэн хоёр хайрцаг «Амтат ван»-гийн шоколадан мэлхийг нээлгүй хаяжээ. Оройн хоолон дээр Петунья эгч ядмаг зууш өгөхөд үүндээ харамсахад хүрэв.

Рон, Гермiona хоёр юугаа хийгээд завгүй байгаа юм бол? Тэд яагаад Харрид юу ч хэлэхгүй байгаа юм бол? Тэр тэднээс илүү чадвартай гэдгээ нотлоогүй гэж үү?

Үнэхээр түүний тухай мартсан гэж үү? Тэр оршуулгын газарт байгаагүй, Седрикийн үхлийг хараагүй, булшны чулуунаас алуулахаар хүлээтэй байгаагүй хэрэг үү?

«Энэ тухай битгий бод» гэж Харри зуу дахь удаагаа өөртөө ширүүн хэллээ. Оршуулгын газар болсон зүйл хар дарсан зүүдэнд нь үзэгдэж байгаа нь хангалттай.

Тэр Магнолийн гудамж руу эргээд загалмайлсан эцгээ анх удаа харж байсан гаражын хажуугийн нарийхан гарцаар өнгөрлөө. Сириус түүнд ямар байгааг ойлгож байгаа бололтой. Түүний захианд Рон, Гермиона хоёрынхоос илүү шинэ зүйл байхгүй байсан ч захианы өгүүлбэр нь даажигнасан янзтай аж.

Би чамайг сэтгэлээр унаж байгааг мэдэж байна ... Гарч цэвэр агаар амьсгал тэгвэл бүх зүйл хэвийн болно ... Болгоомжтой байж ямар ч болчимгүй зүйл бүү хийгээрэй ...

Харри Сириусын зөвлөгөөг даган Магнолийн гудамжыг өнгөрч машин зам даган харанхуй хүүхдийн тоглоомын газар явлаа. Юутай ч атугай чөмөндээ шүүрээ хийгээд Үүр лүү явах хүслээ эсэргүүцэж чадлаа. Харри биеэ маш сайн авч явж байгаа гэж бодож байгаа ч Улаан модон гудамжинд зунжингаа Волдемортын тухай ямар нэг юм сонсохыг хичээн цэцгийн мандалд хэвтэж байгаадаа гутран гонсойж байв.

Тэр цоожтой хаалгыг даваад хатсан өвсөн дээгүүр явлаа. Хүүхдийн тоглоомын газар гудамж шиг хоосон байв. Харри Дадли болон түүний найзуудын эвдлээгүй цорын ганц бүтэн үлдсэн зүйл болох эргэдэг сандал дээр гараа зөрүүлэн суугаад бодлогоширон газар ширтлээ. Дурслийн цэцгийн мандалд ахин нуугдах боломжгүй болжээ. Маргааш мэдээ сонсох өөр арга олох хэрэгтэй. Урд нь ахиад нэг сэтгэл түгшсэн хүнд шөнө байлаа. Хэрвээ Седрикийн үхлийн тухай хар даран зүүдлэхгүй бол цоожтой хаалганд хүргэдэг урт харанхуй хонгилын тухай зүүдлэх болно. Тэр зүүдэндээ занганд орсон юм шиг санагдаад сэрдэг байлаа. Заримдаа духан дээрх сорви нь таагүйхэн хатгуулахад үүнийг Рон, Гермиона юм уу Сириуст хэлэх талаар бодсонгүй. Урьд нь сорви Волдепорт хүчтэй болохыг анхааруулан өвддөг байсан бол одоо хэдийн төрсөн болохоор тэд энэ мэдрэмж ямар ч санаа төрүүлэх юм байхгүй гэдгийг бичих байх ...

Шударга бус явдал хүчтэй байсан болохоор уурандаа арай л хашгирчихсангүй. Хэрвээ тэр байгаагүй бол Волдемортын ахин төрснийг хэн ч мэдэхгүй байсан! Харин тэр үүнийхээ шанд бүтэн дөрвөн долоо хоног Литтл Уингингэд шидэт ертөнцөөс таслагдан нуугдаж тоть усны цанаар явж байгаа тухай сонсож байна. Дамблдор яаж

түүнийг ийм амархан авч мартаж чадав аа? Яагаад Рон, Гермиона хоёр хамт байгаа хэр нь түүнийг урихгүй байна? Хэр удаан хугацааны турш Сириусын зөвөлгөөний дагуу сайн хүү байж тэнэг <<Өдөр тутмын зөнч>> сонин Волдеморт эргэж ирсэн тухай мэдээлэхийг хүлээх ёстой юм бэ? Дүрэлзсэн уур хилэн Харриг нөмрөн авахад сэтгэл нь өвдөв. Эргэн тойронд намуухан шөнө болж агаарт хатсан өвс үнэртэн нам гүмийг зөвхөн хашааны гадуур машин хүнгэнэн өнгөрөх чимээ эвдэж байлаа.

Тэр эргүүлгэн сандал дээр хэр удаан сууснаа мэдсэнгүй. Ямар нэгэн хоолой гарахад ухаан ороод толгойгоо өндийлгөв. Гудамжны дэнлүүний гэрэлд хүүхдийн тоглоомын газрын дэргэдүүр өнгөрч байгаа бүлэг хүмүүсийн бараа харагдав. Нэг нь бүдүүлэг дуу аялан бусад нь хөхрөлдөнө. Зарим нь үнэтэй уралдааны дугуй унажээ.

Харри энэ хэн гэдгийг мэдэж байв. Урд нь өөр хэн ч биш түүний үеэл ах Дадли Дурслэ гэр лүүгээ буцахаар үнэнч дагалдагч нартайгаа явж байлаа.

Дадли бүдүүн байсан ч нэг жилийн цагаан хоолны дэглэм үр дүнгээ өгч биеийн хэмжээ нь ажиглагдам өөрчлөгджээ. Түүнчлэн Вернон ах сонсоход бэлэн бүх хүмүүст Дадли саяхан Английн сургуулийн дунд насанд хүнд жингийн боксын аварга болсон тухай хөөрөн ярьж байлаа. «Сайхан спорт» гэж Вернон ах хэлсэн төдийгүй Дадли Харриг өөрийнхөө боксын грүшиг болгохоор сүрдүүлжээ. Харри үеэл ахаасаа айхаа больсон болохоор үүнийг баяртайгаар хүлээн авав. Дадлигийн цохилт одоо дээрджээ. Тэр бүх хөршийн хөвгүүдэд энэхүү «Поттер» бол гэгээн Брутсын насанд хүрээгүй гэмт хэрэгтэн хүүхдүүдийн сургуульд сурдаг танхай этгээд гэж хэлсэн болохоор түүнээс айж байлаа.

Харри зүлгэн дээгүүр гүйж яваа дүрсийг хараад тэд хэнийг хөөж байгаа болохыг нь тааварлав. «Алив хараач дээ ... Эргээд хар ... Хар ... Би ганцаараа сууж байна ... Хялбархан олз ...»

Хэрвээ Дадлийн найзууд түүнийг харах юм бол гарцаагүй ирэх байсан ч тэр үед Дадли юу хийх бол? Дагалдагчдынхаа өмнө нүүрээ түлэхийг хүсэхгүй ч Харриг өдөх нь ямар аймшигтай гэдгийг ... Түүнд Дадли аргагүй байдалд орон хүчгүй болж элэг доог болохыг бодохоос хөгжилтэй байлаа. Харин хэн нэг найз нь цохихоор оролдвол Харрид шидэт саваа нь бэлхэн байлаа. Оролдоод үзэг л дээ ... Тэр өнгөрсөн амьдралыг нь там болон хувирсан хөвгүүдийн урмыг хугалах дуртай байв.

Гэхдээ тэд түүнийг харсангүй хашааг өнгөрөөд талбайд хүрч явлаа. Харри тэдний араас дуудах гэсэн хүслээ эзэмдэв. Зодолдох бол тийм ч ухаантай арга биш ... тэр ид

шид хэрэглэж болохгүй ... ахин хөөгдөх эрсдэлд оруулж болохгүй.

Дадли болон түүний найзуудын хоолой намдаж Магнолийн замаар давхин үзэгдэхээ болив.

«Тэгэхээр Сириус сэтгэл хангалуун байгаа байх даа. Болчимгүй зүйл хийсэнгүй. Цэвэр агаарт гарлаа. Биеэ сайн авч явлаа» гэж Харри гуниглан бодов.

Тэр хөл дээрээ бослоо. Нагац эгч Петунья, нагац ах Вернон хоёр Дадлиг гэртээ ирснээс хойшхи цагийг хоцорсон гэж үздэг юм. Нагац ах нь Харриг Дадлигийн хойно ирэх юм бол шатны хонгилд түгжинэ гэж сүрдүүлэх болохоор Харри хөмсөг зангидсаар хашаанаас гарлаа.

Магнолийн зам Улаан модон гудамжных шиг өргөн цэлгэр, дөрвөлжин байшингууд нь зүлгээ адил тайрч тэгшилсэн, бүдүүн эзэд нь Вернон ахын адил гял цал машинаар явдаг юм. Гэхдээ Литтл Уингингийн хөшигтэй цонхны завсраар тусах хурц гэрэлд «нийгмийн эсрэг» гэж дуудуулалгүй байшингуудын дэргэдүүр өнгөрч болдог үдэш Харрид илүү таалагддаг юм. Тэр алхаагаа хурдасган Магнолийн замын хагаст ахиад л бүлэг хүүхдүүдийг олж харав. Найзууд нь Дадлитай Магнолийн гудамжны эргэлтэн дээр салах ёс хийж байлаа. Харри том бутны сүүдэрт нуугдаад хүлээв.

- ... яг гахай шиг чарлаж байгаа биз гэж бүдүүн Малкольм хэлээд хөхрөв.
- Сайхан дэгээдлээ, Том Дэ гэж Пирс хэлэв.
- За тэгээд маргааш яах гэж байна? гэж Дадли асуулаа.
- Манайд хүрээд ир гэр эзгүй гэж Гордон хэлэв.
- Тохиролцлоо гэж Дадли дуугарлаа.
- Баяртай, Дад!
- Баяртай, Том Дэ!

Харри найзууд нь Дадлигаас салж гэр лүүгээ явахыг хүлээлээ. Тэдний хоолой сонсогдохоо больсон үед булан тойроод түргэн явлаа. Дадли яаралгүйхэн алхах зуураа хамар дороо ямар нэг юм гүнгэнэнэ.

- Сайн уу, Том Дэ!
- Аан, чи юу ... гэж тэр эргэж хараад шуухитнав.

- Чи хэзээнээс Том Дэ болчихоо вэ? гэж Харри асуулаа.
- Амаа тат гэж Дадли хэлээд толгойгоо цааш эргүүлэв.
- Муугүй л нэр байна. Гэхдээ миний хувьд чи үргэлж бяцхан Дадликаар байх болно гэж Харри инээмсэглэн хэлээд зэрэгцэн явлаа.
- Би Амаа тат! гэж хэлсэн шүү хэмээн Дадли нударга зангидав.
- Чиний найзууд ээж чинь юу гэж дууддагыг мэдвэл яах бол?
- Юу гэж ч дуудаггүй, ойлгов уу?
- Чи түүнийг боль гэж тушааж чадахгүй. Харин «үр минь», «бяцхан минь»

гэвэл яаж байна? Минийхээр бол чамд тэгсэн нь дээр байх?

Дадли юу ч хэлсэнгүй. Харри түүнийг уурлуулж биеэ барих чадварыг нь алдуулахыг хичээлээ.

- Чи өнөөдөр хэнийг нүдсэн бэ? Ахиад л арван настай хүхдийг үү? Би чамайг хоёр өдрийн өмнө Марк Эвансыг тэгсэн гэж сонслоо.
- Тэр өөрөө эхэлсэн гэж Дадли хэдэрлэв.
- Тийм гэж үү?
- Тэр надтай бүдүүлэг харьцсан.
- Тийм үү? Магадгүй чамайг хойд хөл дээрээ явж сурах гэж байгаа гахайтай адилхан гэж хэлсэн байх л даа? Хэрвээ Дад, тэгж хэлсэн бол энэ бол бүдүүлэг биш цэвэр үнэн.

Дадлийн хацрын булчин чичигнэлээ. Харрид түүний уурлахыг харах таатай байлаа. Түүнд үеэл ахаа элэглэхээс өөр уйтгар гунигаасаа зугтах арга олдсонгүй.

Тэд Харрийн Сириусыг анх харсан давчуу хонгил руу эргэлээ. Энэ бол Магнолийн гудамж болон Улаан модон гудамжыг холбосон товч зам байв. Тэнд хоосон харанхуй байлаа. Гаражын хананаас өндөр хашаатай бөгөөд тэдний алхаа цуурайтана.

- Чамд энэ тухай бодох чухал шалтгаан байгаа юу? гэх Дадлигийн хоолой хэдэн хормын дараа сонсогдов.
- Юу гэнээ?

- Чиний нууж байгаа. Харри ахиад л инээмсэглэв.
- Чи харагддаг шигээ тэнэг биш л юм байна. Би чамайг явахынхаа зэрэгцээ ярьж чаддаг гэж бодоогүй шүү.

Дадли түүнийг хяламхийн харахад Харри шидэт саваагаа гаргалаа.

- Чамд хориотой. Намайг мэдэхгүй гэж бодоо юу? Хэрвээ чи үүнийг хэрэглэвэл тэр муухай сургуулиасаа хөөгдөнө.
- Чи тэднийг дүрмээ өөрчлөөгүй гэдэгт итгэлтэй байна уу, Том Дэ?
- Өөрчлөөгүй гэж Дадли итгэлгүйхэн хэлэв. Харри аяархан инээлээ.
- Чи үүнгүйгээрээ тийм ч зоригтой биш биз дээ? гэж Дадли архирлаа.
- Хэнд хэлж байна аа. Чамд арван насныхныг зодоход ердөө дөрвөн найз хэрэгтэй байна. Ингэхэд чи боксын цолоо хэнийг нүдэж байж авсан бэ? Хэн чиний эсрэг байсан юм? Долоо юу? Найман настай юу?

- Чиний үеийн арван зургаан настай! Чи үүнийгээ буулгахгүй бол би аавд хэлнэ ...

- Тэгэхээр аав руугаа гүйх юм биз дээ? Түүний жижигхэн боксын аварга нь Харригийн сайнгүй саваанаас айсан гэх нь үү?

- Чи шөнө ийм зоригтой байдаггүй гэж Даддли шоолонгуй хэлэв.
- Харин одоо шөнө биш, Дадлик? Хэрвээ чи үүнийг харанхуй хэлж байгаа бол.
- Би чиний унтаж байсан үеийн тухай хэлж байна.

Дадли зогслоо. Харри ч гэсэн зогсоод үеэл рүүгээ ширтлээ. Тэр Дадлигийн махлаг тарган нүүрэн дээрээс хачирхалтай баяр хөөрийг олж харав.

- Унтаж байхдаа зоригтой биш гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? Би шөнө юунаас айх ёстой юм? Дэрнээс үү? гэж Харри асуулаа.
- Би өнгөрсөн шөнө чамайг сонссон. Зүүдэндээ ярихыг чинь гэж Дадли аяархан хэлэв.
- Үүнийг чинь юу гэж ойлгох вэ? гэж Харри давтахад дотор нь хүйт оргилоо.

Тэр өнгөрсөн шөнө зүүдэндээ бас л оршуулгын газарт байсан юм. Дадли бүдүүлгээр хөхөрснөө хоолойгоо нарийсгаж,

- «Седрикийг битгий ал! Седрикийг битгий ал!» Седрик гэж хэн юм? Чиний найз залуу юу? гэв.

- Би ... чи худал хэлж байна гэж Харри түргэн хэлэв. Гэхдээ ам нь хатжээ. Тэр Дадли худал яриагүйг мэдэж байв. Хэрвээ тэр сонсоогүй бол Седрикийн тухай хаанаас мэдэх билээ?

- «Аав аа! Аав аа, надад туслаарай! Туслаарай! Тэр намайг алах гэж байна! Ёо! Ёо!»

- Амаа тат. Амаа тат, Дадли. Би чамд анхаарууллаа шүү! гэж Харри аяархан хэлэв.

- «Аваа, надад туслаач! Ээжээ туслаарай! Тэр Седрикийг алчихсан! Аав аа, туслаарай! Тэр ирж ...» Над руу үүнийгээ бүү чиглүүл!

Дадли хонгилын хана налав. Харри шидэт саваагаа түүний зүрх рүү тулгалаа. Түүний судсанд арван дөрвөн жил Дадлиг үзэн ядсан уур хилэн буцлахыг мэдэрчээ. Хэрвээ тэр баруун гараараа цохих юм бол гэр лүүгээ тэмтрүүлтэй дүйнгэтэн мөлхөх болно ...

- Энэ тухай ахиад яриад үзээрэй! Намайг ойлгов уу? гэж Харри дүрсхийлээ.

- Наадхаа цааш нь болго!

- Би чамайг ойлгосон уу гэж асууж байна?

- Наадхаа цааш нь холдуул!

- Намайг ойлгов уу?

- Наадхаа цааш нь холдуул ...

Дадли хүйтэн усанд булхсан юм шиг хачирхалтай чичирлээ.

Ямар нэг юм боллоо. Одод түгсэн тэнгэр гэнэт тас харанхуй болон өөрчлөгдөв. Бүх гэрэл унтарч одод ч, сарны гэрэл ч, гудамжны дэнлүү ч гийгүүлсэнгүй. Алсад машины хүнгэнэх чимээ сонсогдохоо больж, мододын навчис хүртэл сэрчигнэсэнгүй. Зуны сайхан үдшийг гэнэтхэн хүйтэн нөмрөн авлаа. Аварга том гар гудамжинд зузаан хүйтэн нөмрөг нөмрүүлчихсэн аятай тэднийг нэвтэршгүй чимээгүй харанхуй тойрон хүрээлжээ.

Агшин зуур Харри өөрөөс нь боллоо гэж бодсон ч дараа нь оддыг алга болгох хүч

байхгүй гэдгээ саналаа. Тэр толгойгоо эргүүлээд юу болсныг харахыг хичээсэн ч хар гивүүр нөмөрчихсөн аятай харанхуй л үргэлжилнэ.

Дадлийн үхтлээ айсан хоолой сонсогдов.

- Ч-и юу хийж байна? Ү-үнийгээ зогсоо!
- Би юу ч хийгээгүй! Чимээгүй битгий хөдөл!
- Би юу ч харахгүй байна! Би сохорчихлоо! Би ...
- Чимээгүй гэж хэлээд байна шүү!

Харри хөшсөн юм шиг зогсоод ийш тийшээ харлаа. Хүйтэн бүх биеийг нь дагжуулав. Гарны арьс нь өрвийж шилний үс нь бослоо. Тэр харанхуй руу хараад юу ч олж харсангүй.

Байж боломгүй юм ... Тэд энд Литтл Унгингэд ирж чадахгүй ... Тэр хүчлэн чагнав. Эхлээд сонсогдож дараа нь харагдана ...

- Би аавд хэлнэ! Чи хаана байна! Юу хийгээд байна? гэж Дадли гонгинов.
- Амаа хамхина уу үгүй юу? Би сонсохыг хичээж байна ... гэж Харри унтууцав. Гэвч нам гүм болохтой зэрэгцэн айж байсан зүйлээ сонслоо.

Хонгилд уртаар сөөнгө амьсгал авах чимээ гарав. Харри айдаст автан хүйтэнд чичирлээ.

- Үүнийгээ боль! Ингэхээ боль! Би чамайг цохино шүү, тангараглая!
- Дадли чим ... Түн!

Зангидсан нударга Харригийн шанаа руу унатал цохилоо. Нүдэнд нь цагаан оч манарав. Хоёр дахь удаагаа толгой нь хуваагдах шиг санагдан хатуу газар унахад саваа гараас нь мулт үсрэв.

- Чи бол тэнэг амьтан, Дадли! гэж Харри дуу алдахад өвдсөндөө нүдэнд нь нулимс дүүрчээ. Тэр дөрвөн хөллөөд харанхуйд саваагаа цөхрөн хайлаа. Дадлийн хашаа мөргөн бүдчин гүйж одох нь сонсогдов.
- Дадли буцаад ир! Чи шууд түүнрүү очиж байна!

Аймшигтай орилох чимээ сонсогдоод Дадлигийн хөлийн чимээ замхрав. Тэр агшинд Харри ардаа хүйтэн сэнгэнэхийг мэдэрлээ. Энэ нэг нь байх нь тэд хоёулаа байж.

- Дадли чимээгүй бай, ойлгов уу? Юу ч болсон чимээгүй бай! Миний саваа!
гэж Харри үглээд газар хуруугаараа тэмтчив.

- Миний саваа хаана байна ... түргэлээрэй ... Люмос!

Тэр цөхөрсөндөө зөнгөөрөө шившлэг хэлэхэд гэрэл хайж байгаа зүйлээ олоход тусаллаа. Ингээд баруун талд нь савааны үзүүрээс гэрэл гялалзахыг хараад нүдэндээ ч итгэсэнгүй. Харри түүнийг барьж хөл дээрээ босоод эргэн харлаа.

Дотор нь палхийв.

Газар дээгүүр өндөр нүүрээ юүдэнгээр халхалсан дүрс хөвж байлаа. Тэр ойртон ирээд шөнийн агаарыг соров.

Харри бүдчин ухраад саваагаа өргөн,

- Экспекто патронум! гэв.

Савааны үзүүрээс нарийхан мөнгөлөг утаа гарахад Дементор удааширсан хэдий ч шившлэг сайн үйлчилсэнгүй. Тэр Дементороос хойшоо ухрахад сандрал бүчин авлаа.

Төвлөр ...

Дементор нөмрөг дороосоо нарийхан саарал яршсан гараа сунгалаа. Чихэнд нь шуугиан сонсогдож эхэлжээ.

- Экспекто патронум!

Харрийн хоолой алсад байгаа юм шиг сонсогдов. Ахин нэг өмнөхөөсөө сул мөнгөлөг утаа савааны үзүүрээс гарлаа. Тэр үүнээс илүүг хийж чадахгүй нь, шившлэг сайн болохгүй нь!

Толгойд нь дотор зарсхийм хүйтэн инээд сонсогдов ... Дементорын ялзарсан үнэр ханхалж үхлийн хүйтэн амьсгал Харрийн уушгийг дүүргэн живүүллээ.

Ямар нэг аз жаргалтай юмны тухай бод.

Гэвч баярлах зүйл юу ч байсангүй ... Дементорын хүйтэн хуруу хоолойд нь ойртоход хүйтэн инээд улам чангарч,

- Үхэхийнхээ өмнө бөхий, Харри ... Чи өвдөлтийг ч мэдэрч амжихгүй ... Би мэдэхгүй ... Би хэзээ ч үхэхгүй... гэх хоолой сонсогдов.

Тэр хэзээ ч ахин Рон, Гермиона хоёртой уулзахгүй.

Тэгтэл тэдний царай зурсхийн үзэгдэхэд агаар амьсгаллаа.

- Экспекто патронум!

Савааны үзүүрээс том мөнгөн буга гараад эврээрээ Дементорыг зүрхэн тушаа газар нь мөргөж холдуулав. Буга цаашаа үргэлжлүүлэн довтлоход Дементор сарьсан багваахай шиг нэвсийн зугтаалаа.

- Одоо тийшээ! гэж Харри буга руу хашгираад саваагаа дээшээ өргөн хонгилоор гүйлээ.

- Дадли! Дадли!

Бараг арваад алхам гүйтэл Дадли газар нүүрээ гараараа хаан хэвтэж байлаа. Түүний дээр хоёр дахь Дементор тонгойно. Ясан сарвуугаараа маш удаан бараг энхрийлсэн маягтай гарыг нь холдуулж байв. Тэгснээ юүдэнтэй толгойгоо үнсэхийг хүссэн мэт ойртууллаа.

- Тэр байна! гэж Харри орилоход дэргэдүүр нь мөнгөн буга шуугин өнгөрөв. Дадлигийн нүүрнээс хэдхэн инчийн зайд байсан Дементорын нүдгүй царай мөнгөн эвэрт мөргүүлэв. Дементор харанхуйд шингэн алга болов. Буга хонгилын үзүүр хүртэл хөөгөөд мөнгөлөг манан болон сарнилаа.

Ахиад л сарны гэрэл туяарч, одод түгэн, гудамжны дэнлүү асав. Хонгилоор дулаахан сэвшээ салхи үлээв. Цэцэрлэгт мододын навчис шаржигнаж, Магнолийн гудамжинд машинд давхих чимээ гарав. Харри хөшсөн юм шиг зогсоод чичирч байв. Хэвийн байдалдаа ороход хэцүү байлаа. Тэр гэнэтхэн цамц нь хөлөрсөн биендээ наалдахыг мэдэрлээ.

Тэр болсон явдалд итгэж чадсангүй. Дементорууд энд Литтл Уингингэд байна.

Дадли газар атийн хэвтэж байв. Тэр чичирэн ёолж байлаа. Харри өвдөглөн суугаад Дадлиг босгох гэтэл ард нь гүйх хөлийн чимээ сонсогдов. Шидэт саваагаа өргөөд ирж байгаа хүн рүү огцом эргэн харав.

Түүн рүү ухаан муутай хөрш болох хатагтай Фигг гүйн ирж байв. Үсний тор дороос нь буурал үс өрвийж, бугуйндаа өлгөсөн цүнхний оосроо савчуулан, дөрвөлжин хээтэй гэрийн шаахай углажээ. Харри саваагаа яаран нуухыг хичээсэн ч ...

- Битгий далд хий, тэнэг хүү минь! Магадгүй бусад нь ирж мэднэ! Би Наземникус Флетчерчийг тас татахад бэлэн байна! гэж тэр ориллоо.

БҮЛЭГ 2: УУЛЬНУУД, УУЛЬНУУД

- Юу? гэж Харри гайхан асуулаа.

- Тэр явчихсан! Хэн нэгэнтэй тогоо болон шүүрний талаар ярилцах гээд!

Хэрвээ би түүнтэй уулзах юм бол арьсыг нь хуулна даа, юу болсныг харж байна уу! Дементорууд! Би ноён Сарвуутыг салхилуулж байсан нь сайн хэрэг боллоо! Гэхдээ бид энд зогсоод ярилцаж болохгүй! Түргэл, би чамайг буцааж хүргэх ёстой! Ямар их гай вэ! Би түүнийг ална гэдгээ чамд хэлэх байна! хэмээн хатагтай Фигг гараа савчин хашгирлаа.

- Гэхдээ ... Та ... шидтэн юм уу?

Түүний ухаан муутай мууранд дуртай хөрш нь Дементоруудыг мэддэг явдал Харрийг хонгилд Дементортой уулзсанаас ч илүүтэйгээр цочирдолд оруулав.

- Би бол сангасваа. Наземникус үүнийг сайн мэднэ! Ийм учраас би чамд Дементоруудын эсрэг тэмцэхэд тусалж чадахгүй. Би түүнд чамайг хараа хяналтгүй орхиж болохгүй анхааруулсан ...

- Наземникус намайг дагаж байсан гэнээ? Хүлээгээрэй ... Тэгэхээр, энэ тэр байж! Манай байшингийн хажуугаас шилжсэн хүн!

- Тиймээ, тийм аз болоход би ноён Сарвуутыг машин дороос авч байтал тэр надад үүнийг дуулгасан юм. Би танай байшин руу очиход чи байгаагүй ... Харин одоо ... Дамблдор юу гэж хэлэх бол! Хөөе, чи! Тарган өгзөгөө дээш нь өргө! гэж тэр газар хэвтэж байгаа Дадли руу хашгирав.

- Та Дамблдорыг мэддэг юм уу? гэж Харри түүн рүү ширтэн асуулаа.

- Мэдээж би Дамблдорыг мэдэлгүй яахав! Хэн түүнийг мэдэхгүй гэж? Алив явцгаая! Хэрвээ тэд эргээд ирвэл надаас тусламж хүлээх хэрэггүй шүү. Би амьдралдаа цайны аяга ч хувиргаж байсангүй!

Тэр доошоо тонгойгоод үрчгэр гараараа Дадлигийн тарган гарнаас угзарлаа.

- Босооч, ашиггүй болхи амьтан минь бос!

Гэвч Дадли хөдлөхийг хүссэнгүй. Тэр урьдын адил үнсэн саарал царайтай чичирсэн хэвээр хэвтэж байлаа.

- Алив би илүү дээр байх.

Харри Дадлигийн гарнаас бариад бүх хүчээрээ татав. Ихээхэн чармайлт гаргаж байж хөл дээр нь босголоо. Дадли одоохон ухаан алдаж унах гэж байгаа юм шиг санагдана. Түүний жижигхэн нүд аягандаа эргэлдэн духан дээр нь хөлс дааварлана. Харри түүнийг орхитол хүчтэй найгав.

- Түргэлээрэй! гэж хатагтай Фигг хашгирав.

Харри Дадлигийн гарыг мөрөн дээгүүрээ давуулаад хүндийн жинд нь хотойсоор түшин явлаа. Хатагтай Фигг урд нь майжигнан алхангаа түгшсэн шинжтэй булангаар шагайв.

- Саваагаа бэлхэн байлгаарай гэж тэр Глициний гудамжинд гарахад анхааруулаад,

- Нууцлалын тухай март. Чи насанд хүрээгүй шидтэний хязгаарыг давчихлаа ... Үүнээс чинь л Дамблдор айж байсан юм ... Гудамжны төгсгөлд юу байна вэ? Аан ноён Прентис байна ... Саваагаа буулгах хэрэггүй, хүү минь ахиад хэлье надаас ямар ч тус гарахгүй шүү гэв.

Саваагаа гартаа бариад Дадлиг түшиж явахад амаргүй байлаа. Харри тэвчээргүйхэн хавирга руу нь нударсан ч Дадли биеэ даан явах ямар ч хүсэлгүй байлаа. Тэр бүх жингээрээ Харрийн мөрөн дээр дараад газар хөлөө чирэн явна.

- Хатагтай Фигг, та яагаад урьд нь сангасваа гэдгээ хэлээгүй юм бэ? Би хичнээн удаа танайд очсон билээ ... Та яагаад чимээгүй байсан юм? гэж Харри амьсгаадан асуулаа.

- Дамблдорын тушаал. Би чамайг нууцаар харж байх ёстой байсан юм. Чи ч жаахан байсан даа. Чамайг эвгүй байлгаж байсанд уучлаарай, Харри. Гэхдээ Дурслийнханд тийм бодол төрүүлж болохгүй байсан юм. Энэ бүхэн амаргүй байсан гэдэгт надад итгээрэй ... Бурхан минь Дамблдор энэ тухай сонсвол ... Наземникус яаж явж чадав аа. Тэр шөнө дунд хүртэл жижүүрлэх ёстой байсан шүү дээ! Ингэхэд тэр хаа байна! Би яаж Дамблдор мэдэгдэх болж байна? Би чинь шилжиж чадахгүй шүү дээ гэж тэр хэлээд гараа савчив.

- Надад ууль байгаа би таньд түр өгье гээд Харри Дадлигийн хүндийн жинд дуу алдан ёолов.

- Харри чи ойлгосонгүй! Дамблдор маш түргэн мэдэгдэх хэрэгтэй. Ид шидийн яамнаас өөрсдийн аргаар насанд хүрээгүй шидтэн шид хэрэглэсэн гэдгийг мэдсэн

байгаа.

- Гэхдээ би Дементороос хамгаалахын тулд ид шид хэрэглэсэн шүү дээ! Тэд Глициний гудамжинд Дементор юу хийж байсан талаар санаа зовох ёстой юм биш үү?

- Өө, хонгор минь, тийм байгаасай гэж ямар их хүснэ вэ! Гэхдээ үгүй айж байна ... Наземникус Флетчер, Би чамайг өөрийн гараараа ална даа!

Муудсан хурган гуа, согтууруулах ундаа ханхлахтай зэрэгцэн агаарт чанга тасхийх чимээ гараад тэдний өмнө тагдгар биетэй үс сахалдаа баригдсан хуучин жанчтай хүн зогсож байв. Тэр богинохон майга хөл, ширэлдсэн урт цайвар үстэй агаад цус хурсан уйтгартай бөлцгөр нүд нь анч нохой шиг харагдуулна. Тэр гартаа мөнгөлөг зүйл эвхэн барьсныг Харри үл үзэгдэх цув гэж танилаа.

- Юу болоо вэ, Фигг? Чи нууцаар харах ёстой биз дээ гэж хатагтай Фигг, Харри, Дадли нарыг харан асуулаа.

- Би чамд нууц гэдгийг үзүүлээд өгье! Ажлаас зайлсхийгч ашиггүй амьтан минь, Дементорууд! гэж хатагтай Фигг хашгирлаа.

- Дементорууд гэнээ? Дементорууд ... энд байна гэж үү? хэмээн Наземникус хулчийн асуулаа.

- Тиймээ, өрөвдөлтэй лууны шивх минь энд байсан! Дементорууд чиний хамгаалах ёстой хүүг дайрсан байна! гэж хатагтай Фигг орилов.

- Чөтгөр гэж ... Юу гэж дээ, чи намайг хэмээн Наземникус сулхан хоолойгоор хэлээд ахиад л тэднийг ээлжлэн харлаа.

- Харин чи хулгайлагдсан тогоо худалдан авахаар явсан! Чамд явж болохгүй гэж хэлсэн үү? Би хэлсэн биз дээ?

- Би ... би ойлгож байсан ... Энэ ... энэ бол маш сайн наймаа байсан ойлгож байна уу? гэж Наземникус эвгүйцэн хэлэв.

Хатагтай Фигг цүнхний оосор угласан гараа савчуулан Наземникусын нүүр болон хүзүү рүү нүдэхэд дотор нь муурын хоол таржигнах чимээ гарав.

- Ёо ... Больж үз ... Больж үз, галзуу хөгшин сарьсан багваахай минь! Хэн нэгэн Дамблдорт хэлэх ёстой биз дээ!

- Тиймээ, хэн нэгэн тэгэх ёстой! Энэ нь чи байх болно! Түүнд яагаад байрандаа

байсангүй тухайгаа хэлээрэй! гэж хатагтай Фигг орилоод Наземникусыг муурын хоолтой цүнхээрээ хүрч болох газраа нүдлээ.

- Тайвширч үз! Явлаа, явлаа! гэж Наземникус толгойгоо гараараа хаан хашгирлаа.

Тэрбээр чанга тасхийх чимээ гаргаад алга болов.

- Дамблдор түүнийг дуусгана гэж ихэд найдаж байна! Алив явцгаая, Харри чи юугаа хүлээгээд байгаа юм бэ? гэж хатагтай Фигг уурсан дуу алдав.

Харри Дадлигийн хүнд жин дорх үлдсэн амьсгалаа түүнтэй ярьж үрэхгүй байхаар шийдлээ. Тэр хагас ухаантай Дадлигийн жинд гуйвсаар урагш алхав.

- Би чамайг үүд рүү хүргэж өгнө. Тохиолдлоор тэд хоёроос ч олон байсан байж мэднэ ... Гэгээн эцэг минь, ямар их зовлон бэ Чи өөрөө тэдэнтэй тэмцсэн байдаг ... Дамблдор хэлэхдээ бидэнд ямар ч тохиолдолд чамд ид шид хэрэглэх боломж өгч болохгүй гэсэн ... За яхав, асгарсан уусмалын хойноос уйлах хэрэггүй гэдэг хэмээн хатагтай Фигг Улаан модон гудамж руу эргэхэд хэлэв.

- Тэгэхээр Дамблдор ... намайг ... мөрдөхийг даалгасан юм уу?

- Тэгэлгүй яхав. Чамайг зургаан сард болсон явдлын дараа хараа хяналтгүй зугаалуулна гэж бодоо юу? Надад чамайг ухаантай гэж хэлсэн ... дотогш ороод үлдээрэй гэж тэр дөрөвдүгээр байшинд хүрэхэд хэлээд,

- Би удахгүй хэн нэгэн харахаар ирнэ гэж найдаж байна гэлээ.

- Харин та юу хийх гэж байгаа юм бэ? гэж Харри түргэхэн асуулаа.

- Би гэр лүүгээ явлаа. Шинэ заавар хүлээнэ. Хаашаа ч битгий яваарай, сонсов уу? Тавтай нойрсоорой гэж хатагтай Фигг харанхуй гудамж руу дагжин харж хэллээ.

- Хүлээгээрэй, хүлээгээрэй! Би асуух гэсэн юм ...

Гэхдээ хатагтай Фигг шаахайтай хөлөөрөө майжигнасаар муурын хоол шаржигнуулан явлаа.

- Хүлээ л дээ! гэж Харри түүний араас хашгирав. Түүнд Дамблдорын тухай асуух зүйл мянга түм байлаа. Гэвч хатагтай Фигг агшин зуур харанхуйд алга болов. Харри ууртайгаар хөмсөг зангидсаар Дадлиг мөрөн дээрээ засч тэгнээд арай ядан дөрөвдүгээр байшингийн урд талын цэцэрлэгийн замаар явлаа.

Үүдний өрөөний гэрэл асаалттай байв. Харри шидэт саваагаа жинсэн өмднийхөө

халаасанд буцааж хийгээд хонх дарж Петунья эгчийн дүрс ойртон ирэхийг шилний цаанаас харлаа.

- Дидди! Цаг оройтоод, би жаахан санаа зовж ... Дидди чи яагаа вэ?

Харри Дадли руу хяламхийн хараад гарыг нь буулгалаа. Дадли хэсэг зуур ганхснаа царай нь цайвар ногоон болжээ ... Дараа нь амаа нээгээд дотор нь муухайрсан мэт үүдний хивс рүү тонгойв.

- Дидди! Дидди чи яагаа вэ? Вернон! Вернон!

Зончы өрөөнөөс Вернон ах гарч ирлээ. Тэр санаа зовсондоо сахал нь өрвийжээ. Тэр Петунья эгчид яаран туслаад хамтдаа Дадлиг оруулав.

- Тэр өвдчихөж, Вернон!

- Хүү минь, яагаа вэ? Юу болоо вэ? Хатагтай Полкисс чамд цай уулгаагүй юм уу?

- Чи яагаад шавхай болчихоо вэ, үр минь? Газар хэвтэж байсан юм уу?

- Хүлээгээрэй! Хүү минь чамайг дээрэмдээ юу? Тийм үү? Петунья эгч орь дуу тавин хашгирлаа.

- Вернон цагдаа дуудаарай! Цагдаа руу утасд! Дидди минь ээждээ ямар нэг юм хэлээч! Тэд чамайг яагаа вэ?

Тэдний хэн нь ч Харрид анхаарал хандуулсангүй. Тэр дотогш ороод Вернон ах хэрхэн хаалга хааж чимээ шуугиантай гал зуух руу орохыг хараад чимээгүйхэн шат руу явав.

- Хэн үүнийг хийсэн бэ, хүү минь? Нэрийг нь хэл. Бид одоохон түүний учрыг олно.

- Чшш! Вернон тэр ямар нэг юм хэлэх гээд байх шиг байна! Дидди юу гэнээ? Ээждээ хэлээч!

Харриг шатны доод гишгүүр дээр хөлөө тавьсан хойно Дадли ухаан оров.

- Тэр.

Харри гишгүүр дээр тавьсан хэвээрээ ярвайлаа. Одоо ч тэсрэлт болно доо!

- Алив хүү минь! Нааш ир.

Айдас болон уур хилэн холилдсоор Харри удаанаар хөлөө буулгаж Дурслийнхан руу очлоо.

Харанхуй газраас гял цал болсон гал зууханд ороход бодит бус юм шиг хачирхалтай мэдрэмж төрөв. Петунья эгч Дадлиг сандал дээр суулгаж байв. Тэр царай нь ногоорч хөлс нь цутгасан хэвээр байлаа. Вернон ах сав суулга хатаагчын урд зогсоод Харриг нүдээ онийлгон харлаа.

- Чи миний хүүг яасан бэ? гэж тэр сүрдүүлэн архирлаа.

- Яагаа ч үгүй гэж Харри хэлэхдээ Вернон ах түүнд итгэхгүй гэдгийг маш сайн ойлгож байлаа.

- Тэр чамайг яасан, Дидди? Энэ ... чи мэдэж байгаа шүү дээ? Тийм үү? Тэр үүнийгээ ашигласан уу? гэж Петунья эгч чичирсэн хоолойгоор Дадлигийн арьсан хүрэмнээс дугтран асуулаа.

Дадли дагжсаар удаанаар толгой дохив.

Нагац эгч нь орь дуу тавьж, нагац ах нь нударга зангидлаа.

- Ерөөсөө ч тэгээгүй! Би түүнд юу ч хийгээгүй. Энэ би биш байсан, энэ ... гэж Харри ширүүн хэллээ.

Тэгтэл гал зууханд эвэрт ууль нисэн орж ирэв. Вернон ахын зулайг шүргэн өнгөрөөд гал зуухан дундуур нисэн хошуундаа зуусан том дугтуйгаа Харрийн хөлд унагалаа. Дараа нь далавчныхаа үзүүрээр хөргөгчин дээрхийг шүргэн цонхоор нисэн одов.

- Ууль! Ахиад л уульнууд! Миний гэрт ямар нэг ууль байхыг ерөөсөө ч тэвчихгүй! гэж Вернон ах дэлбэрээд цонх чанга хаалаа. Түүний санчигны судас уурандаа гүрэлзэж байв.

Харри түүнийг тоолгүй дугтуйг задлан захиаг гаргалаа. Зүрх нь түг түг цохилно.

Эрхэмсэг ноён Поттер!

Бидэнд өнөө үдшийн есөн цаг хорин гурван минутад эгэлчүүдийн оршин суудаг дүүрэгт маглуудын дэргэд Патронусын шид хэрэглэсэн гэсэн мэдээлэл ирлээ.

Энэ бол насанд хүрээгүй шидтэн ид шид хэрэглэхийг хязгаарлах тухай хуулийг ноцтойгоор зөрчиж байгаа хэрэг учир таныг ид шидтэний Хогвартс сургуулиас хөөсний мэдэгдэе. Ойрын хугацаанд ид шидийн яамны төлөөлөгч таны байгаа газар очиж шидэт савааг чинь устгах болно.

Та олон улсын шидтэнгүүдийн холбооны нууцлалын арван гурав дугаар бүлэгт заасан албан ёсны анхааруулгыг урьд нь хэдийн авсан болохоор найман сарын арван хоёрны өглөөний есөн цагт ид шидийн яаман дээр ирэх дуудлага авах болсныг бид харамсалтайгаар мэдэгдэж байна.

Таны бүх зүйл сайн гэдэгт найдна.

Таныг хүндэтгэсэн

Муфалда Хмелкирк. Ид шидтэний яамны ид шидийг хэтрүүлэн хэрэглэхтэй тэмцэх хэлтэс.

Харри захиаг хоёр удаа уншлаа. Вернон ах, Петунья эгч хоёрын яриа алсад сонсогдоно. Толгой нь бадайрч бүх бие нь хөшлөө. Мэдээ түүний тархинд яг сум шиг тусчээ. Тэр Хогвартсаас хөөгдсөн байна. Тэгэлгүй яахав. Тэр хэзээ ч тийшээ буцаж очихгүй.

Харри Дурслийнхан руу харав. Вернон ах хүрэнгэн зангидсан нударгаа өргөн хашгичиж, Петунья эгч Дадлиг огиулахгүйн тулд тэвэрчээ.

Харрийн тархи түр зуурын мансуурлаас гарч ахин ажиллав. Ойрын хугацаанд ид шидийн яамны төлөөлөгч байгаа газарт чинь ирж шидэт савааг чинь устгах болно. Ганц л арга байлаа. Даруйхан зугтах хэрэгтэй. Харри хаашаа зугтаахаа мэдээгүй ч Хогвартсад байсан байгаагүй саваа нь түүнд хэрэгтэй гэдгийг мэдэж байв. Тэр зүүдэлж байгаа аятай саваагаа аваад гал зуухнаас гарахаар эргэлээ.

- Чи хаачих нь вэ? Би чамтай ярьж дуусаагүй байна! гэж Вернон ах орилов.

Харри хариу хэлсэнгүйд ухасхийн гарах замыг нь хаалаа.

- Замаас холд гэж Харри аяархан хэлэв.

- Чи энд үлдэж миний хүүд юу тохиолдсоныг тайлбарлаадах ...

- Хэрвээ намайг явуулахгүй бол ид шид хэрэглэнэ шүү! хэмээн Харри сүрдүүлэн саваагаа өргөв.

- Наадхаа урдаас холдуул! Би чамайг үүнийгээ сургууль гэж нэрлэдэг галзуугийн газраас гадуур хэрэглэх хориотой гэдгийг мэднэ! гэж Вернон ах зандрав.

- Галзуугийн байшингаас намайг хөөсөн. Тийм болохоор би юу хүссэнээ хийж болно. Таньд гурван секунд байна. Нэг ... хоёр ...

Чанга түжигнэх чимээ гарав. Петунья эгч муухай муухай хашгирахад, Вернон ах

доошоо тонгойж энэ үдэш Харри гурав дахь өөрөөсөө хамааралгүй чимээний эзнийг хайлаа. Тэр агшин зуур цонхны тавцан дээр сэгсийсэн ууль суугаад шил онгойлгохоор тогшиж байхыг харав.

Вернон ахын «УУЛЬНУУД!» гэж хашгирах чимээг үл хайхран Харри ухасхийн цонх онгойлгов. Ууль түүн рүү жижигхэн цаас уяатай сарвуугаа сунгалаа. Уяаг тайлж захиаг авмагц агшин зуур нислээ. Харри чичирсэн гараар яарсандаа хар бэхээр толботуулан бичсэн хоёр дахь захиаг нээлээ.

Харри!

Дамблдр сая ид шидийн яаман дээр байдлыг зохицуулахаар ирлээ. Нагац ах эгчийнхээ гэрээс бүү гараарай. Ямар ч шид бүү хэрэглэ. Саваагаа ч битгий өг.

Артур Уизли

Дамблдор байдлыг зохицуулах гэж байгаа гэнээ ... Энэ юу гэсэн үг вэ? Түүнд үнэхээр ид шидийн яамыг зогсоох хүч байна гэж үү? Үнэхээр Харри Хогвартст эргэж очих юм биш байгаа даа? Харрийн зүрх богинохон найдлагаар цохилоход насанд хүрээгүй шидтэн саваагаа шид хэрэглэхгүй хэрхэн хадгалж үлдэх вэ гэдэг асуудал тулгарав? Ид шидийн яамны төлөөлөгчтэй халз тулаан хийхэд хүрвэл түүнийг хөөх төдийгүй Азкабанд суулгана биз.

Ухаан нь түргэн ажиллав. Яамны хүмүүсээс зугтааж эрсдэлд орох уу? Эсвэл суугаад тэдний ирэхийг хүлээх юм уу? Эхний хувилбар илүү боломжтой байсан ч Харри ноён Уизли түүний ... гэхдээ Дамблдор бүгдийг зохицуулвал ч.

- За яахав. Би бодлоо өөрчиллөө. Энд үлдэе гэж Харри хэлээд гал зуухны ширээний ард Дадли, Петунья эгч хоёрын өөдөөс харан суулаа.

Дурслийнхан түүний гэнэтийн шийдвэрийг гайхширан хүлээж авав. Петунья эгч Вернон ах руу цөхрөн харлаа. Түүний судас хэзээ ч байгаагүйгээр хүчтэй цохилж байв.

- Энэ уульнууд хаанаас ирээ вэ?

- Эхнийх нь ид шидийн яамнаас намайг хөөгдсөн гэдгийг мэдэгдэхээр ирсэн гэж Харри тайван хэлээд гадаа яамны төлөөлөгчийн ойртох чимээ гарах нь уу гэж чагнав.

- Хоёр дахь нь миний найз Роны ааваас ирсэн юм. Тэр бас ид шидийн яаманд

ажилладаг юм.

- Ид шидийн яаманд гэнээ? Бас засгийн газартай хэрэг үү? Ойлгомжтой энэ бүхнийг тайлбарлаад өглөө! Орон даяар элдэв жорын амьтад гүйгээд байгаад гайхах явдалгүй юм байна!

Харрийн хариуг хүлээлгүй Вернон ах түүн рүү муухай харснаа амаа ангайж,

- Чамайг яагаад хөөсөн юм бэ? гэлээ.

- Яагаад гэвэл би ид шид хэрэглэсэн юм.

- Аанхан! Үнэнээ хүлээв үү! Чи манай Дадлид юу хийсэн бэ? гэж Вернон ах хашгичаад нударгаараа хөргөгчний орой дэлсэхэд хаалга нь онгойн Дадлигийн цагаан хоол газар асгарав.

- Юу ч хийгээгүй. Энэ би биш ... гэж Харри тайван байдлаа алдан хэллээ.

- Хийсэн гэж Дадли гэнэтхэн хэлэхэд нагац ах, эгч хоёр нь зэрэг Харриг чимээгүй бол гэж дохиод хүү рүүгээ бөхийлөө.

- Ярь, ярь хүү минь. Тэр чамайг яагаа вэ? гэж Вернон ах хэлэв.

- Бидэнд хэлээч, хонгор минь гэж Петунья эгч шивнэлээ.

- Над руу саваагаа чиглүүлсэн гэж Дадли бувтналаа.

- Чиглүүлсэн ч ашиглаагүй ... гэж Харри уурсан хэлсэн ч,

- Чимээгүй! гэж нагац ах, эгч хоёр нь зэрэг хашгирлаа.

- Ярь ярь хүү минь гэж Вернон ах давтаад сахлаа уурсан зулгаав.

- Гэнэтхэн харанхуй болсон. Тас харанхуй. Харин дараа нь би ямар нэг юм сонссон. Миний толгой дотор гэж Дадли сөөнгөтөн хэлээд чичирэв.

Эцэг эх нь айдас дүүрэн харц солилцов. Тэд энэ дэлхий дээр юунаас илүү ид шидэд дургүй ч хүмүүс хоолой сонсоно гэдэг бол арав дахин муу хэрэг байлаа. Нагац ах, эгч хоёр нь Дадлиг ухаан солирсон гэж бодов бололтой.

- Чи юу сонсоо вэ, үр минь? гэж даавуу шиг цонхийн цайсан Петунья эгч нулимс мэлтэлзүүлэн шивнэлээ.

Гэхдээ Дадли ямар нэг юм тайлбарлаж чадахааргүй байлаа. Тэр ахин чичирснээ цайвар үстэй толгойгоо сэгсэрээд хөшихөд Харри анхны ууль ирсэн үеийнх шиг сонирхолд автав. Дементорууд хүний амьдралын хамгийн муу агшинг сануулдаг

билээ. Энэхүү сул доройг дээрэлхэгчид юу сонсогдсон юм бол?

- Чи яагаад унасан юм бэ, хүү минь? гэж Вернон ах хүчилсэн хоолойгоор асуухад хүнд өвчтөн орон дээрээсээ ярьж байна уу гэмээр байлаа.

- Бүдрээд. Дараа нь гэснээ тэр дагжаад махлаг цээж рүүгээ заахад Харри бүгдийг ойлголоо.

Дадли хүйтэн уушгийг нь дүүргэж бүх баяр хөөр найдлага нь сорогдсоныг хэлж байна.

- Аймшигтай байсан. Хүйтэн. Маш хүйтэн гэж тэр сөөнгөтөв.

- Ойлгомжтой гэж Вернон ах хүчлэн тайван хэлэв. Петунья эгч сэтгэл зовсон байртай алгаараа Дадлигийн духыг дарж үзэв.

- Харин дараа нь яасан Даддерс?

- Дараа нь ... яг л ... яг л ...

- Яг л чи хэзээ ч баярлаж чадахгүй юм шиг болсон гэж Харри хэлэв.

- Тиймээ гэж Дадли чичирсэн хэвээр шивнэлээ.

- Тийм байж! Чи миний хүүд ямар нэгэн шид хэрэглэн толгойд нь хоолой сонсуулж аз жаргалгүй болгожээ. Миний ярьж байгаа үнэн үү? гэж Вернон ах ердийн заналхийлсэн байдалдаа ороод хэлэв.

- Хичээн удаа таньд тайлбарлах юм бэ? Энэ биш биш! Энэ бол хоёр Дементор байсан! гэж Харри бас хоолойгоо өндөрсгөн хэллээ.

- Юу гэнээ? Хоёр ... тэнэмэл нохой юм уу?

- Де-мен-то-р. Хоёр Дементор гэж Харри удаанаар давтав.

- Дементор гэдэг чинь юу гэдэг чөтгөр юм?

- Тэд ид шидийн шорон болох Азкабаныг манадаг юм гэж Петунья эгч хэлэв.

Хоёр агшины турш нам гүм болж нагац эгч нь санаандгүй эвгүй үг хэлсэн аятай амаа дарлаа. Вернон ах түүн рүү нүдээ бүлтийлгэн харав. Харрийн толгой эргэж гүйцжээ. Эхлээд хатагтай Фигг харин одоо Петунья эгч?

- Та хаанаас мэддэг юм бэ? гэж тэр гайхан асуув.

Петунья эгч хирдхийсэн байдалтай харагдав. Тэр Вернон ах руу эмзээнгүй уучлал

гуйсан янзтай харснаа морины шүдээ хаасан гараа буулгав.

- Би олон жилийн өмнө ... энэ аймшигт хүний талаар ... тэдний ярьж байхыг сонссон гэж хэлэв.

- Хэрвээ та миний эцэг эхийн тухай ярьж байгаа бол яагаад нэрээр нь нэрлэж болохгүй гэж? хэмээн Харри чанга асуухад нагац эгч нь хариулсангүй. Тэр балмагдаж гүйцжээ.

Харри хөшлөө. Хэдэн жилийн өмнө Петунья эгч Харрийн эх шулмас байсан болохоор хэзээ ч дүүгийнхээ тухай дурсдаггүй гэж хашгирсан. Тэр ийм удаан хугацааны турш ид шидийн ертөнцөд хамаатай ч байсан ч энэ ертөнц байдаггүй гэж итгүүлэхийн тулд бүх хүчээ гарган хичээж байсан гэдэгт итгэмээргүй байлаа.

Вернон ах амаа нээсэн ч хамхиад ахин нээж хамхилаа. Дараа нь ямар нэг юм санасан бололтой гурав дахь удаагаа нээгээд,

- Тэгэхээр ... тэгэхээр ... тэд нар үнэхээр байдаг хэрэг үү ... энэ.. юу ... Дементи ... аан? гэв.

Петунья эгч толгой дохив.

Вернон ах Дадли руу харснаа дараа нь Харри руу хэн нэгэн түүнд «Дөрвөн сарын нэгэн!» гэж хашгирахыг хүссэн мэт харав. Хэн ч үүнд хашгирсангүйд тэр амаа нээж үг хэлэхийг оролдтол энэ үдшийн гурав дахь ууль ирлээ. Тэр онгорхой цонхоор өдтэй их бууны сум шиг нисэн орж ирээд гал зуухны ширээн дээр газардав. Дурслийнхан айдаст автан огло үсэрлээ. Харри уулийн хошуунаас дараагийн албан ёсны дугтуйг аваад урахад ууль хэдийн буцаж нисчээ.

- Бидэнд.. энэ ... уульнууд ... хангалттай гэж Вернон ах уймран бувтнаад хүнд алхлан цонх руу очиж хоёр дахь удаагаа хаалаа.

Хүндэт ноён Поттер!

Бидний хорин хоёр минутын өмнө илгээсэн ид шидийн яамнаас шидэт савааг даруй устгах тухай мэдэгдэлдээ залруулга хийж байна. Та түүнийгээ найман сарын арван хоёронд албан ёсны шийдвэр сонсох хүртлээ хадгалж болно.

Ид шидтэн илбэчиний Хогвартс сургуулийн захирал ид шидийн яамтай хийсэн хэлэлцээний дагуу энэ хугацаа хүртэл хөөгдөх явдлыг хойшлуулахаар боллоо. Та энэ хугацаанд шийдвэр гарахыг хүлээнэ үү.

Сайн сайхныг хүсье.

Таныг хүндэтгэсэн

Муфалда Хмелкирк

Ид шидийн яамны ид шидийг хэтрүүлэн хэрэглэхтэй тэмцэх хэлтэс.

Харри захиаг гурван удаа уншлаа. Түүний цээжин дотор зангирсан зүйл жаахан хөнгөрчээ. Тэгэхээр ямар ч гэсэн хөөгдөж цөлөгдсөнгүй. Харваас найман сарын арван хоёрны дуудлагаас бүх зүйл шалтгаалж байгаа бололтой.

- Тэгээд? Бас юу бичсэн байна? Чамд ямар нэгэн юм хэлж үү? Танай овогт үхлийн шийтгэл байдаг биз дээ? хэмээн Вернон ах Харри руу найдангуй харан асуулаа.

- Би байцаалтанд дуудагдсан байна гэж Харри хэлэв.

- Тэнд тэгж бичиж үү?

- Тиймээ.

- Маш сайн байна гэж Вернон ах хорсолтой хэллээ.

- Хэрвээ энэ бүх ... гэж Харри хэлээд бослоо. Тэр тунгаан бодохын тулд ганцаараа байхыг хүсчээ. Магадгүй Рон, Гермionaгаас юмуу Сириусээс захиа ирж болно шүү дээ.

- Үгүй ээ энэ чинь бүгд биш! Буцаад суу! гэж Вернон ах зандрав.

- Одоо бас юу хэрэгтэй юм? гэж Харри уурсан асуулаа.

- Дадли! Би миний хүүд юу тохиолдсоныг тодорхой мэдмээр байна! гэж Вернон ах орилов.

- Сайн байна! гэж Харри хилэгнэн хашгирахад гартаа барьсан савааны үзүүрээс алтлаг оч гарав. Дурслийнхэн айсандаа давхийлээ.

- Дадли бид хоёр Магнолийн гудамжыг Глицинээс тусгаарласан хонгилоор явж байсан юм. Дадли намайг доромжилсон болохоор би шидэт саваагаа гаргасан. Гаргасан ч ашиглаагүй. Тэгтэл хоёр Дементор гарч ирсэн ... гэж Харри биеэ барихыг хичээн түргэн ярилаа.

- Эцсийн эцэст энэ Дементойд гэдэг чинь юу юм? Тэд юу хийдэг юм? Юу?

- Би таньд хэлсэн биз дээ. Тэд хүний бүх баяр хөөрийг сорон авдаг гэж. Хэрвээ боломж олдвол үнсэнэ ...

- Үнсэнэ гэнээ? Үнсэх ий? хэмээн Вернон ахын нүд бүлтийлээ.

- Тэд хүний сэтгэл санааг амнаас нь сорж авахыг ингэж хэлдэг юм. Петунья эгч сулхан дуу алдав.

- Түүний сэтгэл санааг уу? Үгүй ээ, тэд чадахгүй ... Түүнд үлдсэн ...

Тэр Дадлигийн мөрөн дээрээс нь барьж аваад сэтгэл санаа байгаа эсэхийг нь шалгаж байгаа аятай сэгсэрлээ.

- Мэдээж түүнд үлдсэн. Хэрвээ тэднийг няцаагаагүй бол гэж Харри уурсан хэлэв.

- Тэднийг няцаасан гэнээ? Түүний хуучны нэг хоёр удаагийнхийг авсан юм уу гэж Вернон ах яриаг ойлгохыг хичээн чанга асуулаа.

- Дементорт хуучин нэг хоёр мэдрэмжээ өгч болохгүй гэж Харри шүдэн завсраа сийгүүлэн хэлэв.

- Тэгвэл яагаад түүний бүх юм хэвийн байгаа юм бэ? Тэр яагаад хоосорчихоогүй юм? Аан? хэмээн Вернон дүрсхийв.

- Яагаад гэвэл би шившлэг хэрэглэсэн юм ...

Пир пар! Далавчаараа уурсан түчигнүүлэх чимээ гарч гал зуухны ханан зуухнаас дөрөв дэх ууль нисэн гарч ирлээ.

- Бурханд баярлалаа! Миний гэрт ямар ч ууль байх ёсгүй. Энэ бүхнийг тэвчихгүй гэж хэлсэн биз дээ! хэмээн Вернон ах дэлбэрээд сахлаасаа хоёр туг үс зулгаан хаялаа.

Харри уулийн саварнаас хуйлаастай цаасыг авав Тэр Дементор болон, хатагтай Фигг, ид шидийн яамны үйлдэлийг тайлбарласан Дамблдорын захиа гэдэгт итгэлтэй байв. Дамблдор бүгдийг шалгасан байх ёстой. Гэвч амьдралдаа анх удаа Сириусын бичгийн хэвийг хараад урам хугарлаа. Ууль Вернон ахын уурсан орилохыг тоолгүй шар шурхийлгэн тоос босгоод яндангаар хөөрөхөд Харри зурвасыг уншлаа.

Артур сая бидэнд болсон явдлын тухай мэдэгдлээ. Ямар ч тохиолдолд байшингаасаа бүү гараарай.

Энэ үдэш болсон бүх үйл явдлын хариуг тэр цаасыг эргүүлэн хайлаа. Эсрэг талд нь

юу ч байсангүй.

Ингээд ахиад л уур нь хүрэв. Тэр ганцаараа хоёр Дементорын дайралтыг няцаасанд хэн ч «сайн байна» гэж хэлсэнгүй гэж үү? Тэгэхэд ноён Уизли болон Сириус түүнийг дүрсгүй хүүхэд аятай гэрээсээ гарахгүй байхыг сануулж байна.

- Бүтэн сүрэг ... Би бүтэн сүрэг ууль миний гэрт байна гэж хэлэх гэсэн юм! Би үүнийг тэвчихгүй гэж чамд тодорхой хэлсэн биз дээ ...

- Би тэднийг захиа илгээхэд саад болж чадахгүй! гэж Харри Сириусын захиаг базаад уурсан хэллээ.

- Харин би болсон явдлын тухай үнэнийг мэдэхийг хүсч байна! Хэрвээ Дадли энэ Демендеруудад баригдсан юм бол яагаад чамайг хөөсөн юм? Чи үүнийгээ хүлээн зөвшөөрөө биз дээ!

Харри гүнзгий амьсгал аваад тайвширахыг хичээв. Ахиад л толгой нь янгинаж өвдлөө. Тэр энэ дэлхий дээр юунаас ч илүү Дурслийн гал зуухнаас гарахыг хүсч байв.

- Би Дементоруудаас салахын тулд Патронусын шившлэг хэрэглэсэн юм. Энэ бол тэднийг няцаах цорын ганц арга гэж хүчлэн тайван хэллээ.

- Гэхдээ Дементойдууд Литтл Уингингэд юу хийж байсан юм бэ? гэж Вернон ах уурсан асуув.

- Мэдэх юм алга гэж Харри ядрангуй хэлэв.

Хурц гэгээтэй өдрийн гэрэл толгой дээр нь өвдтөл анивчина. Түүний уур хилэн үгүй болов. Тэр хүчгүй болж цуцжээ. Дурслийнхан түүнийг нүд салгалгүй ширтэнэ.

- Энэ бол чи байсан. Чи л нэг юм хийснээс зайлахгүй болохыг би мэдэж байна.

Түүнээс яах гэж энд байх билээ? Яах гэж тэд хонгилд ирэх билээ? Чи цорын ганц ... цорын ганц ... гээд тэр «шидтэн» гэсэн үгийг хэлсэнгүй.

- Ганцаараа эргэн тойронд хэн байгааг мэднэ.

- Би тэдний энд юу хийж байсныг мэдэхгүй.

Гэхдээ нагац ахынх нь үг Харрийн тархинд нэг санаа төрүүлэв. Дементорууд яагаад Литтл Уингинд ирсэн юм бол? Санаандгүй тохиолдлоор Харрийн явж байсан хонгилд байсан болох уу? Эсвэл тийш нь илгээсэн юм болов уу? Ид шидийн яамнаас Дементоруудыг хяналтаасаа алдсан юм болов уу? Магадгүй тэд Дамблдорын хэлсэн

ёсоор Волдеморттой нэгдсэн юм болов уу?

- Тэгэхээр эдгээр Дементёрууд ямар нэг шоронг хамгаалдаг гэл үү? хэмээн Вернон ах Харрийн бодлогоширлыг таслав.

- Тиймээ гэж Харри хэллээ.

Хэрвээ толгой нь янгинан өвдөхөө больдог бол, хэрвээ гал зуухнаас гарч харанхуй унтлагын өрөөндөө суугаад бодож болдог бол ...

- Бүгд ойлгомжтой! Тэд чамайг баривчлахаар ирж! хэмээн Вернон ах ялгуусан баяр хөөртэйгээр мэдэгдээд,

- Тэгсэн байж таарна? Чи шүүхээс зугтсан байх! гэв.

- Мэдээж үгүй гээд Харри толгойгоо ялаа хөөж байгаа аятай сэгсэрлээ. Тархи нь сайн ажиллаж эхлэв.

- Тэгвэл яагаад? ...

- Магадгүй тэр л тэднийг илгээсэн байх гэж Харри Вернон ахаас илүү өөртөө хэлэв.

- Тэр гэдэг чинь ... хэн юм бэ? Хэн тэднийг илгээсэн гэж?

- Лорд Волдеморт.

Ой ухааных нь хаа нэгтээ Дурслийнхан үргэлж «шидтэн», «ид шид», «шидэт саваа» гэх мэт үгүүдийг сонсохоор уурладаг байсан ч санаанд оров. Харин одоо хэрцгий шидтэний нэрийг сонсоод тэвчихгүй биз.

- Лорд ... гэж хэлсэн үү? Би ийм нэр сонсоогүй ... Энэ чинь хэн ... гэж Вернон ах ярвайн асуулаа. Түүний тооройны нүдэнд ямар нэгэн санахыг оролдож байгаа тэмдэг илрэв.

- Үнэндээ миний эцэг эхийг алсан гэж Харри гунигтай хэллээ.

- Гэхдээ тэр алга болоо биз дээ. Тэгж хэлсэн. Алга болсон гэж хэмээн Вернон ах тэсч ядан хэлэхдээ Харрид эцэг эхийнхээ үхлийнхээ талаар ярилцах нь хүнд байгаа нь огтхон ч хамаагүй байлаа.

- Тэр эргээд ирсэн гээд Харри хүндээр санаа алдав.

Петнуья эгчийн цэвэрхэн гал зууханд орчин үеийн хөргөгч дээрх зурагтын дэлгэцээр Вернон ах Волдемортын тухай тайван ярьж байгаа аятай хачирхалтай зүйл болов.

Дементорууд Литтл Уингингэд ирсэн нь шидтэний ертөнцийг Улаан модон гудамжнаас тусгаарласан үл үзэгдэх ханыг нэвтэлсэн аятай зүйл байлаа. Харрийн амьдралд хоёр удаа бүх зүйл хяналтаа алдав. Дурслийнхан шидтэний ертөнцийн тухай нарийвчлан асууж, хатагтай Фигг Альбус Дамблдорыг мэдэж, Дементорууд Литтл Уингингэд ирж, харин тэр өөрөө хэзээ ч Хогвартст буцаж очихгүй. Харрийн толгой ахин хүчтэй өвдлөө.

- Эргээд ирсэн гэнээ? хэмээн Петунья эгч шивнэлээ.

Тэр Харри руу хэзээ ч харж байгаагүйгээр ширтэв. Тэр гэнэтхэн амьдралдаа анх удаа Петунья эгч эхийнх нь төрсөн эгч гэдгийг мэдэрлээ. Тэр яагаад үүнийг мэдэрсэн болохоо хэлж чадахгүй байв. Тэр ганц л зүйлийг мэдэж байв. Гал зууханд түүнээс гадна ахин нэг хүн Волдемортын эргэн ирсэн тухай мэдэж байна. Нагац эгч нь өмнө нэг ч удаа түүн рүү ингэж харж байсангүй. Түүний том нүд хорсол уур хилэндээ онийсонгүй. Тэд нээлттэй айдас уншиж болохоор байлаа.

- Тиймээ. Ердөө сарын өмнө эргээд ирсэн. Би түүнийг харсан гэж Харри хэллээ.

Түүний алга Дадлигийн мөрний хүрэмнээс шүүрч авав.

- Хүлээгээрэй. Хүлээгээрэй. Чи энэ лорд Воланди ... тэр ... эргээд ирсэн гэсэн үү? хэмээн Вернон ах эхнэр болон Харригийн хооронд болж байгаа үйл явдлыг ойлгохын тулд гайхаж мэгдсэн шинжтэй дуугарав.

- Тиймээ.

- Чиний эцэг эхийг алсан уу?

- Тиймээ.

- Тэр чам руу Дисмембэр илгээсэн үү?

- Тийм байх гэж Харри хэлэв.

- Ойлгомжтой. Энэ ч ажил хэргийг хөнгөвчилж байна шүү. Алив манай гэрээс зайл! гэж Вернон ах хэлээд цонхийн цайсан эхнэр лүүгээ харлаа. Түүний том ягаан нүүр Харрийн нүдний өмнө дүүрэв.

- Юу? гэж Харри асуулаа.

- Чи юу намайг сонссон! Зайл! гэж Вернон ах Петунья эгч, Дадли хоёрыг цочтол хашгираад,

- Зайл! Зайл! Тэгэхэд чамайг авах хэрэггүй байсан юм! Уульнууд манайд гэртээ байгаа юм шиг нисэж, бялуу дэлбэрч, зочны өрөөний хагас нурж, Дадлид сүүл урган, Марж адраас өлгөгдөн, «Англи» гэдэг машин нисээд л ... Зайл! Зайл! Бидний хувьд хангалттай! Хэрвээ чамайг ямар нэгэн солиотой этгээд хөөж байгаа бол энд үлдэж эхнэр хүүхдийг минь аюулд оруулах ёсгүй! Чи үл бүтэх эцэг эхийнхээ орсон замаар явж байна ... миний хувьд хангалттай! Зайл!

Харри гартаа яамны, ноён Уизли, Сириусын захиаг бариад хөшин зогсоо. Ямар ч тохиолдолд гэрээсээ гараарай. Нагац ах эгчийнхээ гэрээс бүү гар.

- Чи чинь дүлийрчихээ юу? гэж Вернон ах хүрэн улаан царайгаа Харрид ойртуулан бөхийгөөд шүлсээ үсчүүлэн орилов.

- Зайл! Чи хагас цагийн өмнө явахыг хүсээд байсан биз дээ! Баяртайгаар дэмжиж байна! Манай гэрийн ойролцоо ахиж битгий ирээрэй! Чамайг яагаад авсандаа ухаан хүрэхгүй юм. Маржын зөв чамайг асрах газар өгөх хэрэгтэй байж! Чамайг жирийн хүн болгон гэдэг маань дэмий хэрэг байж! Гэхдээ чи өөдгүй чигээрээ төрсөн болохоор миний хувьд хангалттай ... Чөтгөрийн уульнууд!

Тав дахь ууль яндангаар нисэн орж ирэхдээ шал цохин чанга гуугчаад агаарт хөөрөв. Харри захиа руу гараа сунгасан авч улаан дугтуйтай ууль толгой дээгүүр нь нисээд Петунья эгчийг чиглэв. Тэр хашгираад толгойгоо даран бөхийлөө. Ууль улаан дугтуйгаа зулай дээр нь унагаад ирсэн замаараа буцлаа.

Харри захиаг авах гэсэн ч нагац эгч нь хориглов.

- Хэрвээ хүсч байвал унш. Гэхдээ би өмнө нь ийм зүйлийг сонсож байсан. Энэ бол аянгын мэдээ байна.

- Түүнд өг, Петунья! Битгий хүр аюултай байж мэднэ! гэж Вернон ах орилов.

- Надад хаяглагдсан байна. Вернон, хараач! Улаан модон гудамж, дөрөвдүгээр байшин, хатагтай Петунья Дурсль ... гэж нагац эгч нь чичирсэн хоолойгоор уншив.

Тэр айдаст автан амьсгаадав. Улаан дугтуй уугиж эхэлжээ.

- Нээ! Энэ бүхнийг дуусга! гэж Харри түүнийг ятгав.

- Үгүй ...

Нагац эгчийнх нь гар чичирлээ. Петунья гал зуухан дотуур аврагдах газар эрэн гүйсэн ч хожимдож дугтуй дэлбэрлээ. Петунья эгч муухай орилон захиаг унагав.

Ширээн дээрх шатаж байгаа захианаас аймшигтай хоолой нүргэлэв.

Миний шийтгэлийг бүү мартаарай, Петунья!

Петунья эгч одоохон ухаан алдаж унах гэж байгаа юм шиг санагдана. Тэр Дадлигийн хажуу дахь сандал дээр унаад нүүрээ гараараа дарлаа. Захианы үлдсэн хэсэг уугин үнс болов.

- Энэ юу вэ? Юу ... Би ойлгохгүй ... Петунья? гэж Вернон ах сөөнгөтөн хэллээ.

Петунья эгч юу ч хэлсэнгүй. Дадли ээж рүүгээ маанагтан гөлийж амаа нээв. Айдас хүрэм нам гүм ноёрхов. Харри эгч рүүгээ үл итгэн харлаа. Толгой нь хагарах шахам өвдөнө.

- Петунья, хайрт минь. П-петунья! гэж Вернон ах эмээнгүй дуудав. Тэр толгойгоо өргөхөд бүх бие нь чичирч байлаа. Тэр шүлсээ залгив.

- Хүү манайд үлдэх болно, Вернон гэж тэр сулхан хоолойгоор хэлэв.

- Юу?

- Тэр үлдэнэ гэж давтаад Харри руу харсангүй. Дараа нь сандлаасаа бослоо.

- Тэр ... гэхдээ, Петунья ...

- Бид түүнийг хөөвөл хөршүүддээ ярих хэрэг гарна гэж тэр цонхийн цайж дуугарсан ч ширүүн төрхөндөө түргэхэн буцаж ирэв.

- Тэд түүнийг хаачсан талаарх янз бүрийн асуулт тавьж эхлэнэ. Бид түүнийг үлдээх хэрэгтэй.

Вернон ах хий нь гарсан хаймран дугуй адил болов.

- Гэхдээ Петунья, хонгор минь ...

Петунья эгч түүнд анхаарал хандуулалгүй Харри руу эргэв.

- Өрөөндөө ор. Гэрээс битгий гар. Харин одоо унт. Харри хөдөлсөнгүй.

- Аянгын мэдээг хэн явуулсан юм бэ?

- Надаас битгий элдэв юм асуугаад бай! гэж Петунья эгч тасхийв.

- Та шидтэнгүүдтэй холбоотой юм уу?

- Би чамайг унт гэж хэлсэн шүү!

- Юу гэсэн үг юм бэ? Ямар шийтгэл юм бэ?

- Ор луугаа!
- Юу ч ойлгосонгүй ...
- Чи нагац эгчийгээ сонсов уу үгүй юу? Даруйхан унт!

БҮЛЭГ 3: ХАМГААЛАЛТЫН ОТРЯД

Би сая Дементорын дайралтыг няцаасаныхаа төлөө Хогвартсаас хөөгдсөн. Би юу болсныг мэдэхийг хүсч байна.

Харри харанхуй унтлагын өрөөндөө ороод ширээний ард сууж эдгээр үгийг гурван өөр цаасан дээр бичлээ. Эхний захиаг Сириуст, хоёр дахийг нь Ронд, гурав дахийг нь Гермионад хаяглав. Хэдваг ууль анд явчихсан болохоор хоосон тор нь ширээн дээр байлаа. Түүний буцаж ирэхийг хүлээх зуураа Харри өрөөн дотуураа урагш хойш холхиж байв. Хэдийгээр ядарсандаа нүд анилдан унтаж амрахыг хүсэвч тархи нь хэтэрхий их бодолдоо автан завгүй байлаа. Дадлиг тэгнэж авчирсан нуруу нь янгинаж, түүнд цохиулсан болон цонхны жааз мөргөсөн толгой нь хагарах шахам өвдөнө.

Тэр цонхны хажуугаар уур хилэнд автан шүд зуугаад нударга зангидан холжих зуураа хоосон одот тэнгэр лүү уурсан харав. Дементорын дайралт, хатагтай Фигг, Наземникус Флетчер хоёрын нууц мөрдөлт, Хогвартсаас хөөгдсөн, ид шидийн яамны дуудлага гээд хэн ч түүнд болсон явдлыг тайлбарлаж өгөхийг хүссэнгүй.

Бас энэ аянгын мэдээ хэнээс ирсэн юм бол? Хэний хоолой гал зууханд тийм аймшигтай сүрдмээр дуугардаг байна?

Тэр яагаад торонд орсон аятай юу ч мэдэхгүй сууж байна? Түүнтэй яагаад дуулгаваргүй хүүхэд шиг харьцаж байна? Гэрээ бүү орхи, ямар ч шид бүү хэрэглэ ...

Тэр чемоданыхаа дэргэдүүр өнгөрөхдөө өшиглөтөл санаа нь амраагүй төдийгүй төдийгүй хөлийн хуруу нь өвдлөө.

Хазганан цонхны дэргэд очтол сулхан далавч шаржигнах чимээ гарч жижигхэн хий үзэгдэл аятай Хэдваг нисэн орж ирлээ.

- Арайхийж ирэв үү! Дараа нь найрлаарай, надад чамд даалгах ажил байна! гэж Харри түүнийг торон дээрээ чимээгүйхэн газардахад ширүүн хэллээ.

Хэдваг түүнийг том хуван шар нүдээрээ зэмлэнгүй харлаа. Хошуундаа үмхий мэлхий зуужээ.

- Наашаа хүрээд ир гээд Харри гурван жижигхэн хуйлаасыг авч Хэдвагийн сарвуунд уялаа.

- Нэг захиаг Сириуст, хоёр дахийг нь Ронд, гурав дахийг нь Гермионад

өгөөрэй. Хариулт автлаа битгий ирээрэй. Тэднийг олигтой юм бичихгүй байвал хошуугаараа тоншоорой. Ойлгов уу?

Хэдвиг хошуундаа мэлхий зуусан хэвээр гууглав.

- Тэгвэл урагшаа! гэж Харри тушаалаа.

Тэр агшин зуур хөөрөв. Уулийг ниссэн хойно Харри орон дээрээ хэвтээд харанхуй адар руу харлаа. Тэр одоо Хэдвигтэй ширүүн харьцсандаа гэмшиж байв. Тэр энэ гарт байгаа түүний цорын ганц найз билээ. Түүнийг Сириус, Рон, Гермиона гурваас хариутай ирэхээр нь элэгсэг байх хэрэгтэй юм байна.

Тэд яаралтай хариу бичих болно. Дементорын дайралтыг үл тоомсорлож болохгүй. Магадгүй маргааш өглөө босоод даруйхан Үүрэнд буцаах төлөвлөгөө бүхий гурван зузаан дугтуй харах биз. Энэхүү тайвшируулсан бодол нь уур хилэнг дарахад гүн нойронд автлаа.

Гэвч Хэдвиг маргааш өглөө нь ирсэнгүй. Харри бүтэн өдрийн турш унтлагын өрөөндөө сууж зөвхөн угаалгын өрөө орохоор гарч байв. Өдөрт гурван удаа Петунья эгч түүнд Вернон ахын гурван жилийн өмнө хийсэн муурын нүхээр хоол оруулж өгнө. Харри түүний хөлийн чимээг сонсох болгондоо аянгын мэдээний талаар асуухыг хичээвч хаалганы бариулаас асуусантай адилхан амжилт олжээ. Хэрвээ түүний ирэлтийг эс тооцвол Дурслийнхан түүний унтлагын өрөөнөөс хол байхыг хичээж байв. Харри ч тэдний нүдэнд өртсөнгүй. Энэ нь шинэ хэрүүлд хүргэж магадгүй тэр уурссандаа ямар нэгэн хориотой шид хэрэглэх байх.

Ийм байдлаар гурван өдөр өнгөрөв. Түүнийг хоёр сэтгэл хөдлөл эзэмдэж байв. Нэгдүгээрт Харри сэтгэл түгшсэн бодлоор дүүрэн байсан бөгөөд өрөөн дотуураа холхин түүнийг энэ бүх новшийн зүйлд хутгасан бүхэнд уурсаж байлаа. Хоёрдугаарт гэвэл орон дээрээ цаг юмуу түүнээс ч илүү хугацаагаар хөдөлгөөнгүй хэвтэж ид шидийн яамнаас хүн ирэх болов уу гэсэн айдастайгаар хоосон газар луу гөлрөнө.

Хэрвээ шийдвэр түүнд ашигтай гарахгүй бол яах вэ? Хэрвээ жинхэнээсээ түүнийг хөөж савааг нь хоёр хэсэг болгон хугалвал яах вэ? Тэр юу хийж хаашаа очих болж байна? Урьдын адил Дурслийнхантай амьдрах юм болов уу? Үгүй, дээ тэр одоо өөрийн байх ёстой ертөнцөө мэддэг болсон. Магадгүй Сириусын гэрт очиж болох юм. Сириус жилийн өмнө түүнд хамт явахыг санал болгож байсан шүү дээ. Харин түүнийг ганцаараа амьдрахыг зөвшөөрөх болов уу? Тэр насанд хүрээгүй шидтэн хэвээр шүү дээ. Эсвэл хөөдөггүй юмаа гэхэд өөр газар явуулахаар шийдэх юм болов

уу. Магадгүй олон улсын шидтэнгүүдийн нууцлалыг зөрчсөн түүнийг Азкабан руу илгээж болох юм. Энэ бодол толгойд нь орох болгонд Харри орноосоо босож өрөөн дотуур холхиж байлаа.

Хэдваг явснаас хойш дөрвөн үдэш өнгөрлөө. Харри орон дээрээ хэвтээд адар ширтэж байв. Ой ухаан нь хүчгүй болж хоосорчээ. Гэнэтхэн унтлагын өрөөнд нагац ах нь орж ирэв. Харри түүнийг удаанаар дагуулан харлаа. Вернон ах хамгийн сайн костюмаа өмссөн байх агаад царайд нь сэтгэл хангалуун байдал илрэнэ.

- Бид явлаа гэж тэр хэлэв.
- Юу гэнээ?
- Чиний нагац эгч, Дадли бид нар одоо явлаа.
- Сайн байна гээд Харри ахин адар руу ширтлээ.
- Биднийг байхгүйд унтлагын өрөөнөөсөө бүү гараарай.
- Ойлголоо.
- Зурагт асаах ч юм стерео системд гар хүрэх зэрэг бусад зүйлсийг оролдож болохгүй.
- За.
- Хөргөгчнөөс хоол хулгайлж болохгүй.
- Тэгэхгүй ээ.
- Би чамайг гаднаас чинь түгжлээ.
- Түгж.

Вернон ах Харри руу итгэлгүйхэн ширтлээ. Түүний маргаагүй явдал ихэд сэжигтэй байв. Дараа нь өрөөнөөс алхлан гараад хаалга хаалаа. Харри цоожны нүхэнд түлхүүр эргэх чимээ болон нагац ахынх нь хүнд алхаа шат уруудахыг сонслоо. Хэдэн хормын дараа хаалга тасхийн хаагдаж, хөдөлгүүр хүржигнэн, машин хөдлөх чимээ гарав.

Харри Дурслийнхны явалтанд ямар ч ач холбогдол өгсөнгүй. Тэдний гэртээ байгаа байхгүй нь огт ялгаагүй байлаа. Босож өрөөний гэрэл ч асаах хүч байсангүй. Өрөөнд улам харанхуй болсоор байв. Тэр хэвтээд Хэдвагийг ирэхийг хүлээн онгойлгосон цонхны цаанаас дуулдах үдшийн чимээг сонсож байлаа.

Хоосон байшин хаа нэг шажигнаж, усны хоолой хоржигнов. Харри золгүй байдалдаа

автан юу ч бодолгүй хэвтлээ.

Тэр гэнэтхэн гал зуухны өрөөнд ямар нэг юм хагарах чимээг тод сонслоо. Огцом өндийн суугаад чимээ анирдав. Дурслийнхан ийм хурдан эргээд ирнэ гэж баймааргүй юм. Тэр машины дууг нь ч сонссонгүй шүү дээ.

Хэдэн хормын турш чимээгүй байснаа дараа нь хоолой гарав.

«Хулгайч» гэж тэр бодоод хөлөө шалан дээр буулгатал хулгайчид эдгээр хүмүүс шиг чанга ярьдаггүй нь санаанд оров.

Тэр орны хажуугийн шүүгээнээс шидэт саваагаа авч хаалга руу дөхөөд бүх хүчээ гарган сонслоо. Хормын дараа цоожны нүх шархийн хаалга цочтол нээгдэв.

Харри хөдөлгөөнгүй зогсоод онгорхой хаалгаар шатны харанхуй талбайг харан чих тавьсан ч юу ч сонсогдсонгүй. Тэр эргэлзсэнээ өрөөнөөс чимээ аниргүй гарч шат уруудлаа.

Зүрх нь түг түг цохилно. Доор харанхуй үүдний өрөөнд хэдэн хүн зогсож байх нь шилэн хаалгаар туссан гудамжны гэрэлд үзэгдэв. Найм юмуу есөн хүн түүн рүү ширтлээ.

- Хэн нэгний нүд рүү чичихээс өмнө саваагаа буулга гэсэн намуухан хоолой гарав.

Зүрх нь галзуурсан юм шиг цохиллоо. Харри хоолойг таньсан ч саваагаа буулгасангүй.

- Профессор Грюм уу? гэж тээнэгэлзэн асуув.

- Би профессор гэж юу хэлээд байгааг чинь мэдэхгүй байна. Би хэзээ ч багшилж байсангүй. Доошоо буугаад ир чамайг харъя.

Харри саваагаа бага зэрэг буулгасан ч чанга атгасан хэвээр байрнаасаа хөдөлсөнгүй. Түүнд сэжиглэх шалтгаан байлаа. Саяхан есөн сарын өмнө нэр зээлдэгч өөрийгөө Хурц нүдэт Грюм гэж нэрлэн ирсэн бөгөөд Харриг алахыг оролдсон юм. Харри цаашид юу хийхээ шийдэж амжаагүй байтал хоёр дахь сөөнгө хоолой гарч,

- Бүх юм хэвийн, Харри. Бид чамайг авахаар ирлээ гэж хэллээ.

Харрийн зүрх үсчин цохилло. Энэ хоолой бас танил хэдий ч бараг жилийн турш сонссонгүй.

- П-профессор Люпин уу? Энэ та мөн үү? гэж үл итгэн асуулаа.

- Бид харанхуйд зогсоод л байх уу? Люмос! гэх үл танил эмэгтэй хүний хоолой гарав.

Доор шидэт савааны үзүүрээс гэрэл гарахад Харри нүдээ анивчлаа. Шатны доор зогсож байсан хүмүүс түүнийг анхааралтай ширтэв. Зарим нь сайн харахын тулд хүзүүгээ өлийлгөжээ.

Тэдний урд Римус Люпин зогсож байв. Тийм ч хөгшин биш ч өвдсөн юм шиг эцэж ядарсан харагдана. Харритай сүүлд уулзсанаас хойш толгойд нь хэдэн буурал үс нэмэгдэж нөхөөстэй элэгдсэн жанч хөдөрчээ. Тэр Харри руу инээмсэглэхэд цочирдсоноо нуухын тулд хариу инээмсэглэхийг хичээв.

- Хөөх, тэр яг л миний бодож байсан шиг юм байна! Сайн уу, Харри! гэж гартаа гэрэлтэй саваа өргөсөн шидтэн уулга алдав. Тэр хамгийн залуу нь байлаа. Цайвар царай гялалзсан хар нүдтэй агаад, богинохон нил ягаан үс нь өрвийнө.

- Тиймээ, чиний зөв Римус. Тэр Жеймстэй адилхан юм гэж бусдаас зайдуу зогсож байсан халзан толгойтой хар арьстай шидтэн хүнгэнэсэн хоолойгоор хэлээхэд өрөөсөн чихэндээ зүүсэн алтан ээмэг нь гялсхийв.

- Нүднээс бусад нь. Нүд нь яг Лилигийнх юм байна гэж хяхтнасан хоолойтой мөнгөлөг үстэй шидтэн хэллээ.

Сэгсгэр буурал үстэй Хурц нүдэт Грюм Харри руу хоёр янзын нүдээрээ сэжигтэй харав. Нэг нь жижигхэн хар, нөгөө нь том дугуй хурц цэнхэр өнгөтэй. Грюм энэ шидэт нүдээрээ хана, хаалга нэвт хараад зогсохгүй шилэн хүзүүгээ ч нэвт хардаг юм.

- Люпин, чи түүнийг мөн гэдэгт итгэлтэй байна уу? Хэрвээ бид түүний оронд ямар нэг зүсээ хувиргасан Үхэл залгигчыг авч явбал таагүй явдал болно доо! Түүнээс зөвхөн жинхэнэ Поттер мэдэх асуулт асуугаач. Эсвэл хэн нэгэн өөртөө Үнэнийг хэлүүлэгч авч явж байна уу?

- Харри чиний Патронус ямар хэлбэртэй вэ? гэж Люпин асуув.

- Буга гэж Харри хэлэв.

- Тэр мөн байна, Хурц нүдэт минь гэж Люпин хэллээ.

Бүгд түүн рүү харах нь амаргүй байлаа. Харри шатаар доошоо уруудахдаа саваагаа арын халаасандаа хийлээ.

- Тийшээ битгий хий, чи намайг сонсов уу? Дэлбэрвэл яана? Нэг талын өгзөг нь

үлдсэн шидтэн бий шүү! гэж Грюм зандрав.

- Хэнийг нь мэдэж болох уу? гэж ягаан үстэй эмэгтэй сониучирхав.

- Ямар ялгаа байна! Зөвхөн шидэт саваагаа арын халаасандаа битгий хий!

Савааны аюулгүй байдал хэнд ч төвөг болохгүй! Тэгээд ч би үүнийг харсан гэж Хурц нүдэт сөөнгөтөөд модон хөлөө түг хийлгэн гал зуух руу явлаа.

Люпин Харритай гар барингаа,

- За, ямаршуу байна даа? гэж хэлээд анхааралтай ширтэв.

- С-сайн ...

Харри үүнийг үнэн гэдэгт итгэсэнгүй. Дөрвөн долоо хоногийн турш түүнийг Улаан модон гудамжнаас авч явна гэдэг ямар ч төлөвлөгөө ч байхгүй байсан хэрнээ гэнэтхэн бүлэг шидтэнгүүд гэрт ирээд юу ч болоогүй аятай яриа дэлгэж байна. Тэр Люпины хажуудах хүмүүс рүү харав. Тэд түүнийг үргэлжлүүлэн ширтсээр байлаа. Тэр дөрвөн өдрийн турш үсээ ч самнаагүй болохоор эвгүйцлээ.

- Би ... та нарын аз болоход Дурслийнхан гэртээ байсангүй ... гэж бувтналаа.

- Ха-ха! Аз таарлаа гэнэ шүү! Би л тэднийг замаасаа зайлуулсан юм.

Маглуудын шуудангаар тэднийг Английн хотын захын хамгийн сайхан зүлэг шалгаруулах тэмцээнд түрүүлсэн гэсэн мэдэгдэл явуулсан. Тэд ялагчийн шагнал авахаар явсан л даа ... гэж ягаан үстэй эмэгтэй инээд алдав.

Харри Вернон ах ямар ч Английн хотын захын хамгийн сайхан зүлэг шалгаруулах тэмцээн байхгүй болохыг мэдээд царай нь яахыг төсөөлөв.

- Бид эндээс явах уу? Удах уу?

- Бараг л даруйхан. Бид дохио хүлээж байна гэж Люпин хэлэв.

- Хаашаа явах юм бэ? Үүр рүү юу? гэж Харри найдангуй асуув.

- Үгүй дээ, Үүр рүү биш. Хэтэрхий эрсдэлтэй. Бид илрүүлж болохооргүй газарт штабаа байрлуулсан. Үүнд цаг хугацаа шаардагдана ... гэж Люпин хэлээд Харриг гал зууханд орохыг занган урилаа. Шидтэнгүүд түүний араас дагалдав. Тэд урьдын адил Харриг сониучирхан харсаар байлаа.

Хурц нүдэт Грюм гал зуухны ширээний ард суугаад дашмагтайгаа балгахад шидэт нүд нь зүг бүр тийш эргэлдэн Дурслийн гал зуухны олон тооны хэрэгслийг харав.

- Харри энэ бол Аластор Грюм гэж Люпин танилцуулав.
 - Тиймээ, мэднэ гэж Харри сонсогдохгүй шахам хэллээ. Тэр жилийн турш энэ хүнийг таньдаг гэж бодож байтал одоо ахиад танилцуулж байгаа нь хачирхалтай санагдав.
 - Харин энэ бол Нимфадора ...
 - Намайг Нимфадора гэж бүү нэрлэ, Римус! Зүгээр л Тонкс гэж дууд хэмээн залуухан шидтэн дүрсхийлээ.
 - Нимфадора Тонкс түүнийг зөвхөн овгоор нь дуудахыг эрхэмлэдэг юм гэж Люпин яриагаа төгсгөв.
 - Хэрвээ эцэг эх чинь чамд ийм тэнэг нэр өгсөн бол чи ч бас тэгэх байсан даа гэж Тонкс бувтналаа.
 - Энэ бол Кингсли Бруствер гээд Люпин өндөр хар арьстай шидтэнийг заахад бөхийлөө.
 - Элфиас Дож (Хэржигнэсэн хоолойтой шидтэн толгой дохив). Дедалиус Дингл ...
 - Бид хэдийн танил гэж Дингл догдлон хэлэхдээ бортгон бүрх малгайгаа унагачихлаа.
 - Эммелина Вэнс (маргад ногоон алчуур толгой дээгүүрээ нөмөрсөн ихэмсэг шидтэн толгойгоо бөхийлгөв). Стержис Подмор (Дөрвөлжин эрүүтэй өтгөн цайвар үстэй шидтэн нүд ирмэв). Ингэд Гестия Жонс (Талх шарагчын дэргэд зогсож байсан хар үс ягаан хацартай шидтэн гар даллав).
- Харри эв дүйгүйхэн Люпины танилцуулсан хүн бүрт бөхийж байв. Ингэхдээ тэднийг өөр ямар нэг юм хараасай гэж хүслээ. Гэхдээ юуны түрүүнд тэд яагаад ийм олуулаа ирснийг ойлгосонгүй.
- Чиний төлөө хичнээн хүн ирснийг хараад гайхаж байна уу? хэмээн Люпин Харрийн бодлыг уншаад хэлэв.
 - Олон байх тусмаа сайн. Бид чиний хамгаалалт, Поттер гэж Грюм баргар царайлан хэлэв.
 - Бид зам чөлөөтэй болох дохио хүлээж байна. Арван таван хором болно гэж

Люпин гал зуухны цонхоор ширтэн хэллээ.

- Эд нар ямар цэвэрхэн амьдардаг юм бэ! Харим манай аав бас магл хэрнээ жинхэнэ хөгшин салан амьтан гэсэн үг. Тэд нар бидэн шиг л янз бүр байх юм даа гэж Тонкс дуу алдаад гал зуухыг сонирхон харав.

- Э ... тийм л дээ. Сонсооч ... гээд Харри Люпин руу эргэлээ.

- Юу болоод байгаа юм бэ? Хэн ч надад юу ч хэлсэнгүй. Волан яасан ...

- Чшш! чшш! гэж хэд хэдэн шидтэнгүүд дуу алдав. Дедалиус Дингл ахиад л малгайгаа унагачихлаа.

- Чимээгүй! гэж Грюм зандрав.

- Яагаад? гэж Харри асуулаа.

- Бид энд юу ч ярилцаж болохгүй хэтэрхий аюултай гэж Грюм Харриг ердийн нүдээрээ харж хэлэхэд шидэт нүд нь өмнөхийн адил адар руу ширтэж байлаа.

- Хараал идээсэй. Энэ ашиглахад үргэлж ... гэж тэр уурсан хэлээд шүдэт нүд рүүгээ гар сунгахад хаймар шалчигнах адил таагүй чимээ гарч сугарав.

- Хурц нүдтээ, үүнийг хориотой гэдгийг мэднэ биз дээ? гэж Тонкс хэлэв.

- Харри, надад аяга ус авчраад өгөөч гэж Грюм гуйлаа.

Харри сав суулга угаагч машинаас цэвэрхэн аяга авч цоргоны усаар дүүргэхэд шидтэнгүүд түүний хөдөлгөөн бүрийг ажиглаж байлаа. Тэдний анхаарал уурыг нь хүргэж эхлэв.

- Баярлалаа. Буцах замд би гурван зуун жаран градусын өнцгөөр харах хэрэг байна гээд тэр Харрийн гараас аягыг аваад шидэт нүдээ усанд унагахад зүг бүр тийш эргэлдэн харав.

- Бид яаж хүрэх вэ? Хаашаа гэдгийг нь асууж болохгүй ч яаж? хэмээн Харри сониучирхав.

- Шүүрээр. Цорны ганц арга. Чи насанд хүрээгүй болохоор шилжиж болохгүй.

Нисдэг дарь ашиглаж болох ч ханан зуухнууд хяналтанд байгаа. Хэрвээ бид зөшөөрөлгүй зөөвөрлөгч ашиглавал таагүй зүйлтэй учирч болзошгүй гэж Люпин хэлэв.

- Римус чамайг муугүй нисдэг гэж хэлсэн хэмээн Кингли Бруствер

хүнгэнүүлэв.

- Тэр маш сайн нисдэг. Биднийг дохио хүлээж байх зуур явж юмаа багласан чинь дээр байх, Харри гэж Люпин цагаа хараад хэллээ.

- Би чамд туслая гэж Тонкс баяртайгаар хэлэв.

Тэр Харриг даган хоёр давхарт гараад эргэн тойрноо харлаа.

- Хөгжилтэй л амьдардаг юм байна. Жаахан дэндүү цэвэрхэн юм. Миний юу яриад байгааг ойлгож байна уу? Арай бодит бус. Өө, энд хамаагүй дээр юм байна гэж Харри өрөөндөө ороод гэрэл асаахад хэлэв.

Түүний унтлагын өрөө байшингийн бусад хэсгээс хамаагүй замбараагүй байлаа. Дөрвөн өдрийн турш сэтгэл санаа тааруу байсан болохоор Харри юм хумаа эмхэлж цэгцэлсэнгүй. Номнууд нь шалаар нэг хөглөрч ар араас нь цуглуулах хэрэг гарав. Хэдвигийн торыг цэвэрлэх болсон болохоор таагүй үнэр ханхална. Онгорхой чемодан дээр магл болон шидтэнгүүдийн холилдсон хувцас байсны ихэнхи нь шалан дээр хэвтэж байлаа.

Харри номнуудаа яаран цуглуулж чемодандаа хийлээ. Тонкс хувцасны шүүгээг нээж хаалганы доторх толинд тусгалаа харангаа,

- Минийхээр бол нил ягаан өнгө надад зохихгүй юм шигээ. Тэр намайг өвдсөн юм шиг харагдуулж байгаа юм шиг санагдахгүй байна уу? гэж бодлогширон хэлээд сэгсийсэн үсээ татав.

- Ээ ... гээд Харри түүн дээрх «Их Британи болон Ирландын квиддичйн багууд» гэсэн зурагт хуудсыг харлаа.

- Тиймээ, ингэсэн нь дээр гэж Тонкс шийдэмгий хэлэв. Тэр ямар нэг юм санахыг хүсэж байгаа мэт нүдээ онийлгосноо секунтын дараа үлээдэг бохь шиг тод ягаан үстэй боллоо.

- Чи яаж чадав аа? гэж Харри гайхан асуув.

- Би бол зүсээ хувиргагч гэж тэр хариулаад үсээ бүх талаас нь харахын тулд толгойгоо эргүүлэв.

- Энэ намайг гадаад төрхөө хүссэнээр өөрчлөхөд тусалдаг юм. Төрөлхийн ийм л дээ. Намайг мракоборец болохоор бэлтгэж байх үед шүдгүй хөгшин болсны төлөө хамгийн өндөр оноо өгсөн. Энэ ч гайхамшигтай байсан шүү гэж Харрийн

бодлогоширсон царайг толины тусгалд хараад хэллээ.

- Мракоборец гэнээ? хэмээн Харри хүндэтгэлтэй асуулаа. Тэр ирээдүйд Хогвартсыг төгсөөд хар шидтэнгүүдтэй тэмцдэг болохыг мөрөөддөг билээ.

- Тиймээ. Кингисли бас мракоборец. Надаас арай өндөр зэрэгтэй. Би ердөө жилийн өмнө дипломоо авсан. Нууцаар мөр олоход арай уначихаагүй. Би аймшигтай эв хавгүй. Сая биднийг гал зууханд орох үеэр үеэр таваг хагалсныг минь сонсоо биз дээ?

- Зүсээ хувиргагч болоход суралцаж болох уу? гэж Харри юмаа цуглуулж байснаа мартан хэллээ.

Тонкс инээд алдав.

- Сорвио нуухыг хүсээ юу?

Тэр Харрийн духан дээрх цахилгаантай төстэй сорви руу харлаа.

- Үгүй би тийм зүйл хүсээгүй гэж Харри бувтнаад цаашаа харлаа. Тэр сорви луу нь хүн харахад дургүй билээ.

- Тийм ч амар зам хүлээж байгаа гэж бодохгүй байна. Зүсээ хувиргагчид төрөлхийн тийм байдаг болохоор ховор тохиолддог юм. Ихэнхи шидтэнгүүд гаднах төрхөө өөрчлөхийн тулд шидэт саваа ашиглах юм уу уусмал хэрэглэдэг. Гэхдээ бид яарах хэрэгтэй, Харри. Бид юмыг чинь цуглуулах гэж гарч ирсэн биз дээ гэж тэр гэмшингүй хэлээд замбараагүй шал руу харлаа.

- Аан ... тийм л дээ гээд Харри хэдэн ном авлаа.

- Орхи хэрэггүй, би чамаас хурдан! гэж Тонкс дуу алдаад саваагаа шалан дээгүүр тойрог хөдөлгөөнөөр даллав.

Ном, хувцас, дуран авай, жинлүүр агаарт нисэн чемодан руу нь орлоо.

- Нямбай байх цаг алга гээд Тонкс замбараагүй чемодан руу харлаа.

- Ээж минь бүх зүйлээ цэвэр нямбай байлгах ёстой гэдэг байсан юм. Оймсоо хүртэл эвхэж тавьдаг байлаа. Гэхдээ би тэгж чадахгүй. Ахиад нэг үзээдхэе ... гээд саваагаа найдангуй даллав.

Харрийн нэг оймс сулхан хөдлөөд ахин дээр нь унав.

- За болно гэж Тонкс хэлээд чемоданы тагийг хаалаа.

- Ямар ч л гэсэн бүгд багтлаа. Одоо үүнийг жаахан цэвэрлэх хэрэгтэй байна гээд саваагаа Хэдвигийн тор луу чиглүүлэн,

- Экскуро! гэв. Хэдэн өд доошоо унаж алга боллоо.

- Арай дээр боллоо. Үнэнийг хэлэхэд би энэ гэрийн эзэгтэй шившлэгийг хэрэглэж чаддаггүй юм. За бүх зүйлээ авсан уу? Тогоо? Шүүр? Хөөх, «Аянга!».

Тэр Харрийн баруун гартаа барьсан Сириусын бэлэг болох олон улсын шаардлагад нийцсэн шүүр лүү нүдээ томруулан хараад,

- Харин би ердөө «Зүлгэгч-260»-аар нисдэг гэж атаархангуй хэлснээ,

- За ... Саваагаа бас л арын халаасандаа хийсэн үү? Сайн байна, урагшаа.

Локомтор, чемодан! гэв.

Харрийн чемодан агаарт хөөрөв. Тонкс саваагаа гартаа удирдаач шиг бариад чемоданыг хаалгаар гарган шат руу чиглүүлэнгээ Хэдвигийн торыг зүүн гартаа барилаа. Харри шүүрээ аван нэг давхар луу араас нь буулаа.

Грюм нүдээ байранд нь буцааж хийжээ. Түүнийг цэвэрлэсний дараа шидэт нүд маш хурдан эргэлдэж байсан болохоор Харрийн толгой эргэлээ. Кингли Бруствер, Стержис Подмор хоёр шарах шүүгээг сонирхож байв. Гестия Жонс шүүгээ онгичин төмс цэвэрлэгч бариад инээд алдав. Люпин Дурслийнханд захиа бичиж байлаа.

- Маш сайн байна. Бидэнд ойролцоогоор хормын хугацаа байна. Цэцэрлэг рүү гарч бэлэн байдалд байх ёстой. Харри би нагац ах эгч хоёрын чинь санааг зовоохгүйн захиа орхилоо гэж Люпин тэр хоёрыг хараад хэллээ.

- Тэгэх хэрэггүй байсан юм гэж Харри хэлэв.

- ... тэдэнд чамайг аюулгүй байгаа гэж ...

- Энэ чинь тэднийг зөвхөн гомдоох л байх.

- ... бас дараачийн зун ирнэ гэж.

- Тэгэхгүй байж болохгүй юм уу? Люпин инээмсэглээд юу ч хэлсэнгүй.

- Нааш ир, хүү минь. Надад чамайг хувиргах хэрэг байна гэж Грюм хэлээд

Харриг шидэт саваагаараа зангалаа.

- Юу гэнээ? хэмээн Харри түгшин асуулаа.
- Хувиргах шид. Люпин чамд үл үзэгдэх цув байгаа гэж хэлсэн ч нисэхэд нэмэргүй. Энэ нь найдвартай. Алив ... гэж Грюм хэлээд саваагаа өргөв.
Тэр саваагаараа зулай руу нь хүчтэй дэлсэхэд Харрийн толгой дээр өндөг хагалсан аятай мэдрэмж төржээ. Түүний саваагаар цохьсон газраас доошоо хүйт оргилоо.
- Сайн болж, Грюм гэж Тонкс урамтай хэлээд Харрийн гэдэс рүү ширтэв.
Харри бие рүүгээ ширтэхэд ямар ч бие байсангүй бөгөөд үнэндээ юу ч байсангүй. Тэр үл үзэгдэх болсонгүй ч ердөө бие нь зогсож байсан газрынхаа өнгөнд хувирчээ. Тэр хамеолон хүн болсон байлаа.
- Явцгаая! гэж Грюм тушаагаад саваагаа арын хаалга руу чиглүүлэн онгойлгов. Бүгд Вернон ахын нямбай засч янзалсан зүлгэн дээгүүр явцгаав.
- Цэлмэг шөнө байна гээд Грюм шидэт нүдээрээ тэнгэр лүү ширтсэнээ,
- Жаахан үүл байвал саад болохгүйсэн. Тэгэхээр намайг сонс гэж Харрид хандан хэллээ.
- Цуваагаар ниснэ. Тонкс чиний урд байх болохоор араас нь сүүл барин нисээрэй. Люпин чамайг доороос чинь хааж би ард чинь ниснэ. Үлдсэн нь биднийг тойрцгооно шүү. Ямар ч тохиолдод эгнээгээ бүү эвдээрэй намайг ойлгов уу? Хэрвээ бидний хэн нэг үхвэл ...
- Тэгэх боломжтой юм уу? гэж Харри түгшин асуусан ч Грюм сонссонгүй.
- ... бусад нь сааталгүй цааш нисээрэй. Хэрвээ чамаас бусад нь бүгд үхвэл тусламжын бүлэг тоглоомд оролцоно. Дорно зүг рүү үргэлжлүүлэн нисээрэй тэд чамайг хамгаалалтандаа авна.
- Таатай зүйл ярихаа больж үз, Хурц нүдэт. Харри биднийг ажил хэрэгтээ хайхрамжгүй ханддаг бодвол яана гэж Тонкс хэлээд чемоданыг Хэдвигийн тортой шүүрэндээ бэхлэв.
- Би зүгээр л хүүд төлөвлөгөөгөө тайлбарлаж байна. Бидний даалгавар бол түүнийг штабын байранд бүрэн бүтнээр нь хүргэх явдал. Хэрвээ үүнд бидний амь нас шаардагдвал ...
- Хэнд ч үүнд амьдралаа үрэхгүй гэж Кингсли Бруствер тайвшируулав.
- Бүгд шүүрэндээ! Эхний дохио өглөө! гэж Люпин тодоор хэлээд тэнгэр рүү

заав.

Тэнгэрт одод дунд хурц улаан оч ярсхийв. Харри оч шидэт саваанаас гарсан болохыг шууд ойлгов. Тэр баруун хөлөө давуулан «Аянга»-ндаа мордоод бариулаас нь чанга зуурахдаа шүүр нь агаарт хөөрөх гэж тэсэн ядан чичирч байгааг мэдэрчээ.

- Хоёр дахь дохио! Урагшаа! гэж Люпин ногоон оч цацрахад хашгирлаа.

Харри газар огцом түлхэн хөөрөв. Үдшийн хүйтэн агаар үсийг нь хийсгэхэд Улаан модон гудамжны нямбай арчилсан цэцэрлэг алга болж харанхуй ногоон толбо болон хувираад салхи толгойноос нь яамны дуудлагын тухай бүх бодлыг нь хийсгэн алга болгов. Зүрх нь баяр хөөрөөр дүүрлээ. Тэр бүх зуны турш мөрөөдөж байсан Улаан модон гудамжны үзэн яддаг байшинг орхин нисч байлаа ... Богинохон агшины турш одот тэнгэрт хөөрөөд санаа зовох зүйл юу ч үгүй юм шиг санагдав.

- Зүүн тийшээ, зүүн тийшээ нэг магл дээшээ харж байна! гэх Грюмын хоолой ард нь сонсогдов. Тонкс гайхалтай эргэлт хийхэд Харри түүнийг дагалдахдаа шүүрэн дорх чемодан галзуурсан мэт савчихыг олж харлаа.

- Бид өндөрт хөөрөх хэрэгтэй ... ахиад милийн дөрөвний нэг!

Дээшээ хөөрөхөд хүйтэн агаар Харрийн нүдийг хорсгон нулимс гоожуулав. Доор жижигхэн гэрэлтэй толбо болох машины гэрэл болон гудамжны дэнлүүний гэрлээс өөр юу ч харагдахгүй байлаа. Энэ хоёр жижиг гэрэл бол Вернон ахын машиных байх ... Дурслийнхан хуурамч зүлгэний тэмцээнээс хоосон гэртээ уур хилэнтэй эргэж ирээд ... Харри энэ тухай бодоод чанга инээд алдсан ч шидтэнгүүдийн жанчны дэрвэн хийсч байгаа чимээнд дарагдлаа. Шүүрэнд бэхлэгдсэн чемодан, тор хоёр улин исгэрэх салхинд хяхтнана. Харри сарын турш ийм жаргалтай байсангүй.

- Өмнө зүг рүү! Хот руу урагшаа! гэж Хурц нүдэт хашгирав. Тэд аалзны тор шиг гялалзсан гал руу нисэхээр баруун тийш эргэлээ.

- Одоо зүүн өмнө зүг рүү өндөрөө бариарай! Тэнд хөнгөхөн үүлтэй болохоор халхлагдаж болно! гэж Грюм тушаав.

- Үүлэн дундуур нисэж яах юм. Бид голдоо хүртэл норох болно, Хурц нүдэтээ! гэж Тонкс ууртай хашгирав.

Харри үүнийг сонсоод санаа амарлаа. «Аянга»-ын бариулаас зуурсан хуруунууд нь хүйтэнд бээрчээ. Тэр чичирч эхлэхдээ хүрмээ өмсөөгүйдээ харамслаа.

Тэд Грюмын тушаал ёстоор зүгээ өөрчлөв. Харри чих өвдтөл улин исгэрэх хүйтэн салхинаас хамгаалахын тулд нүдээ онийлголоо. Тэр гуравдугаар дамжаанд байхдаа нэг удаа ийм хүйтэнд Пуффендуй тэнхимийн эсрэг тэмцээнд шүүрээр ниссэн тухайгаа саналаа. Харриг хамгаалж байгаа шидтэнгүүд дэргэд нь махчин шувуу аятай эргэлдэнэ. Харри цаг хугацааны баримжаагаа алдлаа. Тэр хэр удаан ниссэнээ мэдсэнгүй ч цагаас доошгүй хугацаа өнгөрөх шиг санагдав.

- Баруун өмнө зүг рүү эргэ! Бид замаас холдох хэрэгтэй гэж Грюм хашгирав. Харри доор явж байгаа машинуудын дулаан тохитой бүхээгт суугаад явах юмсан гэж дагжин бодлоо. Нисдэг даринь тусламжтай ханан зууханд эргэлдэхэд тухгүй хэдий ч галын дөл дулаацуулна ... Дэргэдүүр нь халзан толгойтой Кингсли Бруствер нисэн өнгөрөхөд сарны гэрэлд ээмэг нь гялсхийв ... Одоо баруун талд нь Эммелина Вэнс шидэт саваагаа бэлхэн барьж нисэх бөгөөд толгойгоо баруун зүүн тийш эргүүлэн харна ... Дараа нь тэр дээш хөөрч байрыг нь Стержис Подмор эзлэв ...

- Араас дагаж байгаа эсэхийг мэдэхийн тулд хойшоо эргэе гэж Грюм хашгирав.

- Чи өөрийн жхаантай байна уу, хурц нүдэтээ! Бид шүүрэн дээрээ хөлдлөө!

Үргэлж ийш тийшээ яваад байвал долоо хоногийн дараа ч хүрэхгүй! Тэгээд ч бараг хүрч ирээд байна! гэж урд нисэж байсан Тонкс хашгирав.

- Доошлох цаг боллоо! Харри Тонксыг хоцролгүй дагаарай гэх Люпины хоолой сонсогдов.

Тонкс огцом шумбахад Харри түүнийг дагалдав. Тэд хамгийн том гэрлийн цуглуулга руу чиглэв. Урагш хойш хэрэлдсэн гэрэл харанхуйд тодоор үзэгдэнэ. Бүгд улам доошлоход Харри машины гэрэл болон, гудамжны дэнлүү, яндангийн утаа, зурагтын антенн зэргийг ялган харлаа. Тэр хөлдөх шахаж байсан тул бушуухан газардахын хүслэн болж байв.

- За бид ирлээ! гэж Тонкс хашгирав. Хэдэн хормын дараа тэр жижигхэн талбайн зүлгэн дээр буулаа.

Харри архан талд нь газардав. Тонкс хэдийн түүний чемоданыг буулгажээ. Харри чичирсээр эргэн тойрноо харав. Урдхан талд нь байгаа утаа тортогтой хашааны ар дахь баргар төрхтэй байшингууд таатай сэтгэгдэл төрүүлсэнгүй. Хагарсан цонхнууд дээр дэнлүүний гэрэл тусаж үүдний хаалганы будаг нь халцарсан байх агаад овоолоостой хогийн сав байлаа.

- Бид хаа байна? гэж Харри асуув.
- Түр хүлээгээрэй гэж Люпин аяархан хэлэв.

Грюм мойног хуруугаараа жанчныхаа халаасыг онгичоод,

- Оллоо гэж бувтнав. Тэр гартаа мөнгөлөг асаагууртай зүйл бариад шархийлгэв.

Ойролцоох гудамжны дэнлүү бөглүүхэн пүнхийгээд унтарлаа. Хоёр дахь удаагаа шархийлгэхэд дараагийнх нь унтрав. Грюм ийм маягаар талбай дээрх бүх гудамжны дэнлүүг унтраахад хөшигтэй цонхноос тусах сулхан гэрэл үлдлээ.

- Дамблдороос зээлсэн юм. Энэ нь тохиолдлоор ямар нэгэн магл цонхоор харахаас сэргийлж байгаа юм. Одоо түргэхэн орцгоо гээд Грюм асаагуураа халааслав.

Тэр Харрийн тохойноос бариад явган замыг хөндлөн гаран хашаа руу орлоо. Люпин, Тонкс хоёр араас нь Харрийн чемоданыг дамжилсаар дагалдав. Үлдсэн шидтэнгүүд саваагаа бэлхэн барьсаар явлаа.

Ойролцоох байшингийн дээд талын давхарт хөгжим дуугарах сонсогдов. Тэднийг эвдэрхий хаалгаар ороход хогийн савнаас ялзарч муудсан үнэр ханхална.

- Май. Түргэн уншаад тогтоож ав гэж Грюм аяархан хэлээд Харрийн гарт цаасны өөдөс атгуулж савааныхаа гэрлийг ойртуулав.

Харри цаас руу харлаа. Танил угалзтай гоёмсог бичгээр бичжээ.

Фениксийн бүлгэмийн штабын байрны орших хаяг: Лондон хот, Гриммогийн арван хоёр дугаар байшин.

БҮЛЭГ 4: ГРИММОГИЙН АРВАН ХОЁРДУГААР БАЙШИН

- Бүлгэм гэдэг чинь юу юм? ... хэмээн Харри эхлэв.
- Энд бишээ! Биднийг дотогш орохыг хүлээ! гэж Грюм зандрав.

Тэр Харригаас цаасыг аваад савааныхаа үзүүрийг хүргэн шатаалаа. Дөл дүрэлзэхэд үрчийсэн цаас хийсэн алга болов. Харри ахиад л байшин руу харлаа. Түүний өмнө арван нэг дугаартай байшин байх агаад зүүн талд нь арав дугаартай, баруун талд нь арван гурвын тоо харагдана.

- Гэхдээ хаана ...?
- Тогтоохын тулд бодолдоо давт гэж Люпин аяархан хэлэв.

Харриг «Арван хоёр дугаар байшин» гэсэн үг цээжилж байх зуур арван нэг арван гурав дугаар байшингийн дундаас хаалга татагдан гарч ирэхэд түүнийг дагалдан бохир хана утаа тортог болсон цонх үзэгдлээ. Нэмэлт байшин түүний нүдэн дээр хөршүүдтэйгээ залгагдав. Харри түүн рүү харж амаа ангайв. Арван нэгдүгээр байшинд юу ч болоогүй мэт хөгжим дуугарсаар байх аж. Оршин суугчид болох маглууд юу ч мэдэрсэнгүй бололтой.

- Алив, түргэл! гээд Грюм Харрийн нуруу руу түлхэв.

Харри довжоо руу чулуун шатаар өгсөхдөө будаг нь халцарсан хаалганаас нүд салгасангүй. Могойны дүрстэй мөнгөлөг хаалганы цохиур харагдана. Цоожны нүх болон захиа шургуулдаг нүх байсангүй.

Люпин хаалгыг ганц удаа шидэт саваагаар тогшлоо. Харри олон янзын цоож шажигнах болон гинж гүйх чимээ сонсов. Хаалга чахран нээгдлээ.

- Түргэн ор, Харри. Дотогш ороод хол явалгүй юунд ч битгий хүрээрэй гэж Люпин шивнэв.

Харри босго даваад харанхуй үүдний өрөөнд оров. Чийгний үнэртэй зэрэгцэн нялуун үнэр ханхална. Ямар нэгэн хаягдсан эзгүй байшинд орсон мэт сэтгэгдэл төрөв. Тэр эргэж харахад бусад нь араас нь орж ирлээ. Люпин, Тонкс хоёр чемоданыг нь Хэдвигийн тортой оруулж ирлээ. Грюм довжооны дээд талын гишгүүр дээр гараад унтраагуураа чадхийлгэн дэнлүү асаахад талбайг ахин шаргал гэрэл гийгүүлэв. Грюм хазганан дотогш ороод байшингийн хаалгыг хаахад үүдний өрөөнд пад харанхуй болов.

- Алив ингээд ...

Тэр Харрийн толгой руу шидэт саваагаараа хүчтэй цохилоо. Харри ахиад л нуруугаар нь халуу дүүгэхийг мэдрээд шид тайлагдсаныг ойлгов.

- Хүлээгээрэй, би гэрээл асаагаадхая гэж Грюм шивнэлээ.

Бусад нь нам гүм болоход Харрид үхсэн хүний гэрт ирсэн юм шиг муу ёрын мэдрэмж төржээ. Ханан дээрх хуучин загварын хийн дэнлүүнээс аяархан шивнэлт сонсогдоно. Тэд сэмэрсэн хивс дэвссэн бүүдгэр гэрэлтэй урт баргар хонгилд зогсож байлаа. Толгой дээрх лааны сууринд аалзны шүлс торж хананд бараан хөргүүд өлгөжээ. Харрид шалны хөвөөнөөс ямар нэгэн юм сонсогдох шиг болов. Ширээний хөл, лааны суурьтай бүрхүүл гээд бүгд могой хэлбэртэй аж.

Яаран алхах чимээ сонсогдоод хонгилын үзүүрээс хатагтай Уизли гарч ирэв. Тэрбээр инээмсэглэн хүрч ирэхэд Харри тэдний сүүлчийн уулзалтаас хойш турж цонхийснийг ажиглав.

- Өө, Харри минь чамайг харахад ямар баяртай байна гээч хэмээн шивнээд хавиргыг нь шажигнатал тэвэрлээ.

- Чи сайнгүй харагдаж байна. Чамайг сайхан тордоод өгнө оройн хоол удахгүй болно гэснээ ард нь зогсож байгаа шидтэнгүүдэд хандан,

- Тэр саяхан ирсэн цугларалт эхэллээ гэв.

Шидтэнгүүд сэтгэл хөдөлсөн янзтай нэг нэгнийхээ араас Харрийн дэргэдүүр өнгөрч хатагтай Уизлийн гарч ирсэн хаалга руу орлоо. Харри Люпины араас хөдөлсөн ч хатагтай Уизли түүнийг зогсоов.

- Үгүй дээ, Харри цугларалт бол зөвхөн бүлгэмийн гишүүдийн хувьд болно.

Рон, Гермиона хоёр дээр байгаа. Чи тэдэнтэй байж бай. Уулзалт дуусахаар нь оройн хоол идэх болно. Хонгилд аяархан яриарай гэж шивнэлээ.

- Яагаад?

- Хэн нэгнийг сэрээчихэж магад.

- Би ойл ...

- Дараа, дараа тайлбарлая. Би цугларалтанд очих хэрэгтэй байна. Би чамд унтлагын өрөөг чинь заагаад өгье.

Тэр уруулдаа хуруугаа наагаад өлмий дээрээ гишгэлэн цагаан эрвээхэй идэгдсэн хөшигний хажуугаар өнгөрөхөд Харри ард нь хаалга байгаа байх гэж бодлоо. Тэд савдгийн тас цавчсан хөлөөр хийсэн юм шиг суурьтай том шүхрийн хажуугаар өнгөрөөд харанхуй шатаар өгслөө. Харри хананд хуванцар саванд хийсэн хэдэн хатсан толгой тавилсныг харлаа. Ойртон ирэхэд гэрийн үйлчлэгч нарынх болох нь ойлгомжтой ажээ. Бүгд хоншоортой адилхан хамартай байв.

Харри алхам бүрдээ мэгдэж сандрах нь улам нэмэгдэж байлаа. Тэд харваас хар шидтэний байж болох гэрт юу хийж байгаа юм бол?

- Хатагтай Уизли, яагаад ...

- Хонгор минь, чамд Рон, Гермиона хоёр бүгдийг тайлбарлаж өгнө. Харин би гүйх хэрэгтэй байна гэж хатагтай Уизли түгшин шивнэснээ,

- Энэ байна. Чиний өрөө баруун талынх нь. Дуусахаар нь би дуудъя гэж хоёрдугаар давхарт гараад хэлэв.

Тэрбээр доошоо яаран явлаа.

Харри бохир шатны талбай дээр гараад могойн толгойн дүрстэй унтлагын өрөөний хаалганы бариулыг онгойлгов.

Тэр агшин зуур өндөр адар бүхий хоёр ортой бүүдгэр унтлагын өрөө байхыг олж харлаа. Дараа нь чанга жиргэх чимээ гарч үүний араас уулга алдах дуу сонсогдоод нүднийх нь урдуур өтгөн үс халхлав. Гермиона түүнийг ухасхийн тэврэхдээ золтой л унагачихсангүй. Харин Роны жижигхэн ууль Гахай толгой дээгүүр нь галзуурсан юм шиг эргэлдэн нисэв.

- Харри! Рон, Харри энд байна! Бид чамайг байшинд орж ирэхийг сонссонгүй!

Чи хэр байна даа? Зүгээр үү! Бидэнд их уурласан уу? Мэдээж уурласаныг би ойлгож байна. Бидний захианд баярлах юм бага байсан ч бид чамд юу ч бичиж болохгүй байлаа. Дамблдор биднийг чамд юм хэлэхийг хатуу хориглосон! Чи бидэнд бүхнийг яриач! Дементоруудын тухай! Бид ид шидний яамны дуудлагыг сонсоод зэвүүцсэн. Би номноос харахад тэд чамайг хөөж чадахгүй. Насанд хүрээгүй шидтэн амьдралд нь аюул заналхийлсэн үед тулд шид хэрэглэх эрхтэй байдаг юм ...

- Түүнд амьсгалах боломж олго, Гермиона гэж Рон инээн хэлээд Харрийн ардахь хаалгыг хаалаа.

Тэр сарын хугацаанд хэдэн дюйм өсөж улам өндөр эв хавгүй болжээ. Гэхдээ урт хамар, гал шаргал үс, сэвх нь хэвээрээ байлаа.

Гермиона баясан гийж Харриг тавиад юм хэлэхийн зуургүй аяархан гууглах гарч ямар нэгэн цагаан юм харанхуй шүүгээнээс нисэн мөрөн дээр нь буулаа.

- Хэдвиг!

Цасан цагаан ууль Харриг илэхэд хошуугаараа чихийг нь аярхан тоншив.

- Тэр яасан юм болоо! Чиний сүүлчийн захиаг авчиралдаа биднийг үхтэл тоншсон шүү. Энэ хараач ...

Тэр баруун гараа сунгаж эдгэж байгаа гүнзгий шарх үзүүлэв.

- Тиймээ, ойлгож байна. Би хариу авахыг хүссэн болохоор их харамсалтай байна гэж Харри хэлэв.

- Биднийг хариулахыг хүсээгүй гэж бодож байна уу? гэж Рон цагаатгалаа.

- Гермиона чамайг ганцаараа нэг ч шинэ сонингүй сууж байхдаа ямар нэгэн тэнэг юм хийж магад гэж итгэлтэй байсан. Гэхдээ Дамблдор ...

- ... биднийг хатуу хориглосон. Тиймээ, Гермиона надад хэлсэн гэж Харри хэлэв.

Уулзалтын баяр хөөр унтарч дотор нь хүйт оргив. Бүтэн сарын турш Рон, Гермиона хоёр хамт байсныг тэр гэнэтхэн мэдэрлээ.

Хүчилсэн нам гүм бий болоход Харри найзууд руугаа харалгүй Хэдвигийг илнэ.

- Тэр тэгсэн нь дээр гэж бодсон. Дамблдор гэж Гермиона сулхан хоолойгоор хэлэв.

- Ойлгомжтой гээд Харри түүний гар дээрх Хэдвигийн тоншсон мөрийг харсан ч уучилсангүй.

- Тэр чамайг маглуудтай байхад аюулгүй гэж бодсон ... хэмээн Рон эхлэв.

- Тийм үү? Та нарын хэн нэгнийг энэ зун Дементор дайрсан уу? гээд Харри хөмсгөө өргөлөө.

- Үгүй л дээ, гэхдээ ... тэр Фениксийн бүлгэмийн хүмүүсийг чамайг харахаар явуулсан ...

Харрийн шатны гишгүүр алгасан харайж байгаа мэт дотор нь хүчтэй донслохыг

мэдэрчээ. Тэгэхээр түүнийг мөрдөж байсныг бүгд мэдэж байсан байх нь. Түүнээс бусад нь ...

- Муу харжээ, тийм үү? Өөрөө л мултрах хэрэг гарлаа гэж хэлэхдээ Харри бүх хүчээ гарган хэвийн дуугарахыг хичээв.

- Тэр их уурласан. Дамблдор. Бид Наземникус жижүүрийн байраа орхисныг мэдэх үед нь харсан. Тэр аймшигтай байсан гэж Гермиона айсан янзтай хэлэв.

- Харин би Наземникус явсанд баяртай байна. Хэрвээ би шид хэрэглээгүй бол Дамблдор намайг зуны турш Улаан модон гудамжинд үлдээх байсан гэж Харри хүйтнээр хэллээ.

- Харин чамайг ... ид шидийн яаманд дуудсан явдал санаа зовохгүй байна уу? гэж Гермиона аяархан асуув.

- Үгүй гэж Харри худал хэллээ. Тэр Хэдвигийг мөрөн дээрээ тавиад сэрүүн харанхуй өрөөг ийш тийшээ харав. Энд чийгтэй харанхуй байлаа. Нүцгэн ханыг гоёмсог хээ хуартай жааз бүхий хөргүүд чимэглэж түүн дээрээс аяархан инээд сонсогдох шиг болно.

- Дамблдор яагаад надаас болсон явдлыг нуусан юм бол? Та нар ... м-м ... түүнээс энэ талаар асуусан уу? гэж Харри өмнөхийн адил тайван дуугарахыг хичээв.

Рон, Гермиона хоёр түүн рүү харав. Тэгэхээр тэд үүнээс л болгоомжилж байсан байх нь. Энэ дүгнэлт нь сэтгэл санааг нь дээрдүүлсэнгүй.

- Бид Дамблдорд чамд бүхнийг хэлэхийг хүсч байна гэж хэлэх гэсэн. Харри үнэхээр тэгсэн. Гэхдээ тэр завгүй байгаа болохоор ийшээ ирэхэд нь ердөө хоёр удаа харсан. Түүнд бараг цаг байдагүй. Ер нь бол тэр биднээс чамд ямар ч чухал юм бичиж болохгүй гэж амлалт авсан. Ууль замаасаа баригдаж магадгүй гэж хэмээн Рон хэлэв.

- Хэрвээ тэр хүссэн бол та нар уульгүйгээр илгээх аргыг мэднэ шүү дээ гэж Харри хөндий хэлэв.

Гермиона Рон руу харлаа.

- Би ч бас энэ тухай бодсон. Гэхдээ тэр чамайг юу ч мэдэхгүй байх нь дээр гэж шийдсэн.

- Магадгүй надад итгэж болохгүй гэж бодсон юм болов уу? гэж Харри тэдний

царайг харан хэллээ.

- Тэнэг юм бүү ярь гэж сэтгэлээр унасан Рон хэлэв.
- Эсвэл би өөртөө санаа тавьж чадахгүй гэж бодсон юм болов уу?
- Мэдээж тэр тэгж бодоогүй! гэж Гермиона сэтгэл зовон дуу алдав.
- Тэгвэл яагаад та нар бүхэнд оролцож байхад би Дурслийнд байж байдаг билээ? Яагаад та нар бүгдийг мэдэж байхад харин би үгүй байдаг билээ? гэж Харри дуугаа өндөрсгөн асуулаа.
- Бид бас мэдэхгүй! Ээж биднийг бага байна гээд цугларалтанд оролцуулдаггүй ... гэж Рон яриаг нь таслав.

Тэгтэл Харри биеэ барьж чадахаа болиод хашгирав.

- Та нарыг уулзалтанд оролцуулдаггүй гэнээ! Хөөрхий амьтад! Гэхдээ та нар чинь энд байсан биз дээ? Бүгд хамтдаа байхад би бүтэн сарын турш Дурслийнд торж байлаа. Би та хоёроос их зүйл хийснийг Дамблдор мэдэж байгаа! Хэн гүн ухааны чулууг хамгаалсан билээ? Хэн Реддлээс салсан билээ? Хэн та хоёрыг дементороос аварсан билээ?

Харрийн сарын турш бодсон гашуун бүхэн халин асгарлаа. Тэр найзуудаа хамт байсан болон араас нь мөрдөж байсныг сонсоод уур хилэндээ автав ... Хэдвиг айсандаа гууглаад мөрөн дээрээс нь нисэн шүүгээн дээр суув. Гахай түгшсэн янзтай толгой дээгүүр нь улам хурдан эргэлдлээ.

- Хэн өнгөрсөн жил лууны хажуугаар өнгөрч хэн Сфинкс болон бусад заваан юмыг давсан билээ? Хэн түүнийг эргэн төрснийг харсан билээ? Хэн түүнээс аврагдсан юм? Би!

Рон мэгдсэн байртай амаа нээсэн ч юу хэлэхээ мэдсэнгүй. Гермиона одоохон цурхиран уйлах гэж байгаа мэт санагдана.

- Гэхдээ би яагаад юу болсныг мэдэх ёсгүй юм? Яагаад хэн ч надад юу болсныг хэлэхгүй байгаа юм?
- Харри бид чамд үнэхээр хэлэхийг хүссэн ... гэж Гермиона хэлэв.
- Хүссэн гэнээ, тийм ч их биш байна даа! Над руу ууль илгээхээс өөр зүйл хийх байсан юм! Дамблдор та нараас амлалт авсан ...

- Тэр үнэхээр авсан ...
- Би бүтэн сарын турш улаан модон гудамжинд тэнэг амьтан шиг суугаад хогийн савнаас сонин түүж ямар нэг юм мэднэ гэж найдаж байлаа ...
- Бид хүссэн ...
- Би та нарыг энэхүү тухтай газар нуугдаад инээлдэж байсан байх гэж бодож байна ...
- Үгүй дээ, үнэндээ ...
- Харри, бидэнд үнэхээр харамсалтай байна! Чиний бүрэн зөв! Би чиний оронд байсан бол бас галзууртлаа уурлах байсан! гэж Гермиона нулимс мэлтэлзүүлэн цөхрөн дуу алдав.

Харри амьсгаадсан хэвээр түүн рүү ширтээд урагш хойш холхиж эхлэв. Хэдвийг шүүгээн дээрээс баргар гууглав. Удаан хугацааны турш чимээгүй болоход зөвхөн Харрийн хөл дор шалны хавтан гунигтай чахрах чимээ дуулдана.

- Энэ юу гэдэг газар юм? гэж тэр гэнэтхэн хэлэв.
- Фениксийн бүлгэмийн штабын байр гэж Рон даруй хариулав.
- Надад юун бүлгэм болохыг хэлээд өгөх хүн байна уу?
- Энэ бол нууц нийгэмлэг. Түүнийг Дамблдор байгуулсан бөгөөд удирддаг юм.

Гол зорилго нь Хэцүү нэртэй тэмцэх явдал гэж Гермиона түргэн хэлэв.

- Хэн багтдаг юм бэ? гээд Харри огцом зогсон гараа халаасандаа хийлээ.
- Тийм ч олон биш.
- Бид арван хоёрыг нь мэднэ. Гэхдээ өөр байдаг байх гэж Рон хэлэв. Харри тэдэн рүү хараад,
- Тэгээд? гэж шаардангуй асуулаа.
- Э ... Юу тэгээд гэж? хэмээн Рон дуугарав.
- Волдеморт л байхгүй юу! гэж Харри уурсан орилоход найзууд нь зэрэг цочив.
- Ямар мэдээ байна? Тэр юу хийж байна? Тэр хаа байна? Бид түүний эсрэг яаж тэмцэх юм бэ?
- Биднийг бүлгийн цугларалтанд оролцуулдаггүй гэж хэлсэн биз дээ хэмээн

Гермиона бухимдсан янзтай хэлээд,

- Бид нарийн үйл ажиллагааг нь мэдэхгүй ч ерөнхийд нь тааварлаж байгаа гэж Харрийн царайны хувирлыг хараад яаран нэмж хэлэв.

- Фред, Жорж хоёр Уртасгагч чих зохиосон. Маш хэрэгтэй эд гэж Рон дуугарлаа.

- Уртасгагч юу гэнээ?

- Чих байгаа юм. Үнэнийг хэлэхэд сүүлийн үед ашиглахгүй байгаа. Ээж мэдээд бөөн шуугиан дэгдээсэн. Фред, Жорж хоёр ээжийн гаргаж хаяагүй бүх чихээ нуусан. Гэхдээ бид урьд нь үүнийгээ сайн ашиглаж байсан л даа. Бүлгэмийн зарим гишүүд Үхэл залгигчидыг мөрдөж байгаа тухай мэдсэн ...

- Бусад нь бүлэгтээ шинэ гишүүн элсүүлэхийн тулд ажиллаж байгаа гэж Гермиона батлав.

- Харин гурав дахь хэсэг нь ямар нэг юм хамгаалдаг. Тэд үргэлж жижүүрлэх тухай яриа өрнүүлдэг гэж Рон хэлэв.

- Тохиолдлоор намайг биш биз дээ? гэж Харри даажигнан асуулаа.

- Аан, яг тийм байна! гээд Рон ойлгосон янзтай дуу алдав.

Харри тургиллаа. Тэр ахиад л өрөөн дундуур Рон, Гермиона хоёроос бусад зүйлийг харан холхиж эхэллээ.

- Хэрвээ та нар цугларалтанд оролцдоггүй юм бол юу хийж байсан юм? Та нар их завгүй байсан гэж бичсэн байсан.

- Энэ үнэн. Бид байшин цэвэрлэж байсан юм. Их олон жил цэвэрлээгүй болохоор бөөн хог цугларсан байсан. Гал зуух болон ихэнхи унтлагын өрөөнүүд бэлэн болсон болохоор маргааш зочны өрөө рүү ...

Хоёр удаа тасхийх чимээ гараад өрөөний дунд Фред, Жорж хоёр шилжин гарч ирлээ. Гахай галзуурсан аятай жиргэж Хэдвигийн суусан шүүгээний дэргэдүүр нисэв.

- Үүнийгээ больж үз! гэж Гермиона ядарсан шинжтэй ихрүүдэд хэлэв.

- Сайн уу, Харри! Бидний чиний аятай сайхан дууг сонслоо гэж Жорж баясан хэллээ.

- Харри минь дуугаа намсгаж үз! Тэгэхгүй бол тавин милийн зайд байсан

хүмүүс сонсож мэдэхээр байна! гэж Фред мөн адил баясан хэлэв.

- Та хоёр шилжих шалгалт өгчихөө юу? гэж Харри дурамжхан бувтналаа.
- Онц дүн авсан гэж гартаа барьсан биений өнгөтэй урт оосор барьсан Фред хэлэв.
- Шатны доошоо гучин секунтын дотор бууж байгаа гэж Рон хэллээ.
- Цаг бол алт дүү минь. Ер нь бол Харри тийм ч сайн сонсогдоогүй л дээ. Бид Уртасгагч чихээр гэж Фред Харрийн хөмсгөө өргөхийг хараад хэлэнгээ оосроос нь өргөв.
- Доор юу болж байгааг мэдэхийг оролдож байсан юм.
- Анхааралтай байж үзээрэй дээ. Хэрвээ ээж ахин харах юм бол ... хэмээн Рон Уртасгагч чихийг хараад зөвлөв.
- Тэнд том цугларалт болж байгаа болохоор эрсдэлд ороход болох гэх газаргүй хэмээн Фред хэллээ.

Хаалга онгойж урт шаргал үстэй охин орж ирэв.

- Өө, Харри сайн уу! Надад чиний хоолой сонсогдлоо гэж Жинни баяртайгаар дуу алдаад Фред, Жорж хоёр луу эргэв.
- Уртасгагч чихээр юу ч бүтэхгүй. Тэр гал зуухны хаалгыг Хүрч болохгүй шидээр шившсэн.
- Чи хаанаас мэдэж байгаа юм? гэж Жорж сэтгэлээр унан асуулаа.
- Надад Тонкс яаж ажилладгийг нь тайлбарлаж өгсөн. Чи хаалга руу юм шидвэл хүрэхгүй цаашаа нисээд явчихна. Би шатны уруу шивхэн бөмбөг өнхрүүлэхэд хаалганаас цаашаа өнгөрчихсэн. Түүнд Уртасгагч чих хүрч болно гэж бодохгүй л байна шүү.

Фред гүнзгий санаа алдав.

- Харамсалтай байна. Хөгшин Снегг юу хийж байгааг мэдэхийг хүссэн юмсан.
- Снегг гэнээ! Тэр энд юу хийж байгаа юм бэ? гэж Харри хэлэв.
- Аан. Одоохон тайлбарлаад өгье. Дээд зэргийн нууц! гэж Жорж хэлээд хаалга сайтар хааж Фред, Жинни хоёрын дэргэд суулаа.

- Зэвүүн амьтан гэж Фред залхуутай хэлэв.
- Тэр одоо манай талд байгаа гэж Гермiona зэмлэнгүй дуугарлаа. Рон тургилаад,
- Бидэнтэй тааралдах үедээ тэр яаж харсан гээч! гэв.
- Билл ч гэсэн түүнд дургүй гэж Жинни хэлэв.

Харри уур хилэн нь намжсанд итгэлгүй байлаа. Гэхдээ мэдээлэлээр цангаж байсан хүсэл нь ахин хашгирахыг хүсч байв. Тэр эсрэг талын орон дээр суулаа.

- Билл бас энд байгаа юм уу? Би түүнийг Египетэд байгаа гэж бодсон юмсан.
- Тэр бүлгэмийн ажлыг хийхийн тулд гэртээ үлдээхийг гуйсан. Бунхангүй уйдаж байна гэж ярьж байгаа ч үүнийхээ нөхөн төлөөсийг авсан хэмээн Фред инээвхийлэв.
- Энэ чинь юу гэж байгаа юм?
- Флер Делакурыг санаж байна уу? Тэр ч гэсэн Гринготтс банкинд ажилд орсон. Англи хэлээ сайжруулж байгаа юм.
- Харин Билл түүнд цагийн хичээл зааж байгаа гээд Фред хөхрөв.
- Чарли ч гэсэн бүлгэмийн гишүүн. Гэхдээ тэр Румынд байгаа хэвээр.

Дамблдор өөрийн талдаа гадаадын аль болох олон гишүүн татахыг хүсэж байгаа болохоор чөлөөт цагаараа тэдэнтэй харилцаа тогтоодог юм.

- Үүнд бас Перси оролцож байгаа юу? гэж Харри хэллээ. Түүнийг сүүлд сонсох үед Уизлигийн гурав дахь ах нь ид шидийн яамны олон улсын хамтын ажиллагааны хэлтэст ажиллаж байсан билээ.

Түүний нэрийг дурсахад Уизличууд болон Гермiona учиртай баргар харц солилцов.

- Ээж аавын дэргэд Персигийн тухай бүү дурсаарай гэж Рон хүчилсэн хоолойгоор хэлэв.
- Яагаад тэр вэ?
- Түүний нэрийг сонсонгуут аав барьсан юмаа эвдэлж, ээж уйлж эхэлдэг юм гэж Фред тайлбарлав.
- Зүгээр л аймшиг гэж Жинни гунигтай хэлэв.

- Бид түүнтэй харилцаагаа дуусгасан гэж бодож байна хэмээн Жорж хилэнтэйгээр хэлэв.

- Юу болоо вэ? гэж Харри асуулаа.

- Перси аавтай маргалдсан. Би хэзээ ч аавыг тийм байхыг хараагүй. Хэрвээ манайд хүн хашгиравал гол төлөв ээж байдаг юм гэж Фред ярилаа.

- Энэ бол амралтын эхний долоо хоногт болсон явдал. Бид ийшээ ирж бүлгэмийн гишүүдтэй нэгдэх ёстой байсан юм. Харин Перси гэртээ ирээд тушаал дэвшсэн мэдэгдсэн.

- Юу гэнээ? хэмээн Харри гайхлаа.

Тэр Перси үргэлж өндөр юманд санаархдагыг мэддэг ч эхний ажилдаа амжилт гаргаагүйг нь мэдэж байлаа. Перси дарга нь Лорд Волдемортын хяналтанд байсныг мэдэлгүй бүдүүлэг алдаа гаргасан билээ (Ид шидийн яамнаас үүнд итгэхгүй Краучыг ухаан солирсон гэж бодож байгаа юм).

- Бид ч гэсэн их гайхсан. Персид Краучаас болж таагүй явдал их учирсан.

Мөрдөн шалгасан юм. Перси Краучыг хэт хөөргөж байснаа ойлгосон байх. Гэхдээ чи Персиг мэднэ дээ. Крауч түүнийг орондоо орхисонд гомдоллох хэрэг байхгүй шүү дээ.

- Тэгвэл яагаад түүнийг дэвшүүлсэн юм бол?

- Үүнийг л бид ойлгохгүй байгаа юм гэж Рон Харриг орилуулахгүй хэвийн яриа өрнүүлэхийн тулд яриаг бүх хүчээрээ дэмжих санаатай хэллээ.

- Тэр гэртээ сэтгэл хангалуун ирсэн. Ямар сэтгэл хангалуун байсныг нь чи төсөөлж байна уу. Ингээд аавд Фажын дор ажиллах болсон гэж хэлсэн. Залуу хүн Хогвартсыг төгсөв үү үгүй юу сайдын туслах болдог муугүй амжилт шүү. Тэр харваас аавыг хөөрнө гэж бодсон бололтой.

- Гэхдээ аав тэгээгүй гэж Фред баргар хэлэв.

- Яагаад? гэж Харри асуулаа.

- Фаж ид шидийн яамнаас хэнийг ч Дамблдортой холбоотой байлгахгүйн тулд шалгаж байгаа гэж Жорж тайлбарлав.

- Ид шидийн яаманд одоо Дамблдор гэдэг нэр хараалын үг шиг сонсогдох болсон. Тэд түүнийг Хэцүү нэртийг төрсөн гэж худал хэлсэн гэж бодож байгаа

юм гэж Фред дэмжлээ.

- Аав Фажын хараанд орсонд хамаг гай байгаа юм. Фаж түүнийг Дамблдортой найзууд гэдгийг мэддэгийн дээр эртнээс маглуудын хэнээтэй гэдэг байсан юм.

- Гэхдээ Перси энд ямар хамаатай юм бэ? гэж Харри гайхширан асуулаа.

- Яагаад хамаагүй гэж. Аав Фаж Персиг манай гэр бүлийг болон Дамблдорыг тагнуулахын тулд туслахаараа авсан гэдэгт итгэлтэй байгаа юм.

Харри аяархан исгэрлээ.

- Перси үүнийг дуртай хийнэ гэж мөрийцсөн ч болох байна хэмээн Рон хөгжилтэй бус инээд алдаад,

- Перси галзууртлаа уурласан. Хичнээн аймшигтай үг хэлсэн гээч. Ид шидийн яаманд орсон анхны өдрөөс аавын олиггүй нэр хүндтэй тэмцэх шаардлага гарсан болон түүнийг албан тушаал ахих боломжгүй учир бид үргэлж ... ямар ч мөнгөгүй байсан гэсэн ... гэлээ.

- Юу? гэж Харри чихэндээ итгэлгүй асуулаа. Жинни уурссан муур шиг дуу алдав.

- Тиймээ. Дараа нь бүр ч муу зүйл болсон. Тэр аавыг Дамблдорыг дэмждэг тэнэг амьтан гэж хэлээд түүнийг дагалдвал том асуудалд орно гэсэн. Перси шударга үнэнч болохоор яаманд байгаа гэсэн. Бас ээж аавыг яамнаас мөрдөн шалгахад хүрвэл бүгдэд өөрийгөө манай гэрийн гишүүн биш гэж мэдэгдэнэ гэсэн. Тэр үдшээ юм хумаа цуглуулж аваад явчихсан. Одоо Лондонд амьдарч байгаа гэж Рон ярилаа.

Харри аяархан хараалаа. Түүнд Перси үргэлж Роны ах нараас бага таалагддаг хэдий ч ноён Уизлид тэгж хэлсэн гэдгийг огт төсөөлөхгүй байлаа.

- Ээж өөрийгөө мэдэхээ больсон. Ойлгож байгаа биз дээ нулимс урсаад л.

Лондон явж Перситэй ярилцах гэсэн ч цаадах нь хамрынх нь урд хаалгаа хаачихсан. Түүнийг аавтай ажил дээрээ тааралдахаар яадгийг нь мэдэхгүй юм. Мэдээж танихгүй дүр үзүүлдэг биз.

- Гэхдээ Перси Волдеморт ахин төрсөн гэдгийг мэдэх ёстой. Тэр тэнэг биш болохоор эцэг эх нь ямар ч шалтгаангүй бүгдийг эрсдэлд оруулахгүй гэдгийг ойлгох ёстой гэж Харри удаанаар хэлэв.

- М-тийм л дээ дашрамд чиний нэр хүртэл дуулдсан шүү гэж Рон хэлээд Харри

руу сэмхэн хяламхийв.

- Перси цорын ганц баталгаатай зүйл бол чиний үгэнд ... итгэж болохгүй гэж хэлсэн.

- Перси «Өдөрт тутмын зөнч» сонинд чухалчлан ханддаг гэж Гермiona хэлэхэд бусад нь толгой дохицгоов.

- Та нар юуны тухай яриад байна? гээд Харри тэдэн рүү харлаа. Найзууд нь түүн рүү болгоомжлон харав.

- Чи ... «Зөнч» сонин авдаггүй юм уу? гэж Гермiona түгшин асуулаа.

- Авдаг тэгээд юу гэж!

- Харин чи ... анхааралтай уншсан уу? гэж Гермiona илүү их түгшин асуулаа.

- Мэдээж бүгдийг биш л дээ. Хэрвээ Волдемортын тухай ямар нэг юм гарвал тэргүүн нүүрэнд том гарчигтай гарна биз дээ.

Энэ нэрийг сонсоод бүгд давхийв.

- Орхилгүй эхнээс нь дуустал унших хэрэгтэй байж. Энэ долоо хоногт чиний тухай хоёр удаа гарсан ... гэж Гермiona яаран хэлэв.

- Гэхдээ би харах байсан ...

- Үүнийг зөвхөн эхний нүүр уншдаг хүн харах боломжгүй. Би том гарчигтай сэдвийн тухай яриагүй байна. Тэд чиний нэрийг жижүүрийн тоглоомоо болгосон гээд Гермiona толгой сэгсэрлээ.

- Ойлгосонгүй ...

- Ер нь бол энэ бүхэн бохир хэрэг л дээ. Тэд Рита Скитерийн ажлыг үргэлжлүүлж байгаа тэгээд л гүйцээ гэж Гермiona хэлэхдээ аль болох тайван дуугарахыг хичээв.

- Тэр бичихээ болио биз дээ?

- Тиймээ, тэр үгэндээ хүрсэн. Түүнд өөр сонголт байхгүй юм чинь. Гэхдээ тэр суурийг нь тавьсан болохоор бусад нь үргэлжлүүлж байгаа.

- Одоо юуны тухай бичиж байгаа юм? гэж Харри тэвчээргүйхэн хэллээ.

- Тэр чамайг үргэлж ухаан алдан унаж сорви чинь өвддөг гэснийг санаж байна уу?

- Санаж байна гэж Рита Скитерийн түүхийг мартаагүй байсан Харри яаран дуугарав.

- Харин одоо тэд чамайг бусдын анхаарлыг татахын тулд ингэсэн гэж бодож байгаа юм. Өөрийгөө эмгэнэлт баатар болгон харуулахын тулд. Хэрвээ одоо ямар нэгэн хэтрүүлэгтэй түүх гарах юм бол «Харри Поттерын ёгт үлгэр». Хэрвээ хэн нэгэнд инээдтэй зүйл тохиолдох юм бол «Түүний духан дээр сорви гарч ирэхгүй гэж найдаж байна. Тэгвэл бид түүнийг шүтэх хэрэгтэй болох нь ...» гэж ярьцгааж байгаа.

- Бид шүтүүлэхийг хүсээгүй шүү дээ! гэж Харри уурслаа.

- Хүсээгүй гэдгийг чинь мэдэж байна гэж Гермиона айсандаа түргэн хэлээд,

- Мэдэж байна, Харри. Гэхдээ чи тэдний юу хийж байгааг ойлгохгүй байна уу?

Тэд чамд хэн ч итгэдэггүй болгон хувиргаж байна. Энэ бүхний ард Фаж зогсож байгаа гэж мөрийцсөн ч болох юм. Тэр шидтэнгүүдэд чамайг алдар гавъяанд дуртай хөгийн түүх зохиож ярьсан тэнэг хүү гэж бодуулахыг хүсч байгаа юм.

- Би гуйгаагүй ... Би хүсээгүй ... Волдеморт миний эцэг эхийг алахыг! Би алдартай болсон нь ердөө л тэр миний эцэг эхийг алж намайг алж чадаагүйд байгаа юм! Хэнд тийм нэр алдар хэрэгтэй юм бэ? Тэд үнэхээр намайг ... гэж Харри орилов.

- Харри бид мэднэ гэж Жинни буурьтай хэлэв.

- Мэдээж чамайг Дементорууд дайрсан тухай нэг ч үг гараагүй. Хэн нэгэн энэ тухай дуугүй байхыг зарлигдсан. Тэгээгүй бол жинхэнэ шуугиан болох байлаа! Дементорууд гэмгүй хүн рүү дайрчээ! гээд л. Тэд чиний олон улсын нууцлалыг зөрчсөн тухай ч бичээгүй. Бид үүнийг сайны дохио гэж бодож байгаа юм. Гарцаагүй чамайг хөөгдсөний дараа гарах гэж байгаа байх... Би чамайг хэрвээ хөөгдвөл гэх гэсэн юм л даа гэж яаран заслаа.

- Гэхдээ хэрвээ тэд хуулиа баримталвал юу ч тохиолдохгүй. Чамд буруутгах зүйл байхгүй.

Ахиад л яриа хүсээгүй сэдэв рүүгээ эргэж орлоо. Тэр сэдвийг өөрчлөх гэсэн ч шатан дээр хөлийн чимээ дуулдав.

- Атас!

Фред Уртасгагч чихээ угз татан аваад тасхийх чимээ гарган Жоржын хамт алга

болов. Хормын дараа унтлагын өрөөнд хатагтай Уизли орж ирэв.

- Цугларалт дууссан болохоор доошоо хооллохоор явж болно. Бүгд чамайг харахыг хүлээж байгаа, Харри. Гэхдээ хэн гал зуухны хаалганы дэргэд шивхэн бөмбөг тавьсан бэ?

- Живоглот байх. Тэр түүгээр тоглох дуртай гэж Жинни гэмгүй царайлан худал хэлэв.

- Ойлгомжтой. Харин би Кикимер байх гэж бодлоо. Тэр нэг иймэрхүү хачирхалтай зүйл хийгээд байдаг юм. Хонгилд чимээгүй байхаа мартав даа. Жинни чиний гар аймшигтай хар болчихож юу хийгээ вэ? Хоолны өмнө явж угаа.

Жинни ярвайн гарч одлоо. Харри, Рон, Гермиона хоёрын хамт үлдэв. Одоо бүгд явсан хойно түүнийг ахин хашгирах гэж байгаа аятай найзууд нь эмээнгүй харцгаав. Тэдний байдал нь түүнийг ичээлээ.

- Би ... гэж тэр хэлэхэд Рон толгойгоо сэгсэрч харин Гермиона аяархнаар,

- Бид чамайг уурлана гэдгийг мэдэж байсан болохоор өчүүхэн төдий ч гомдоогүй. Гэхдээ чи биднийг үнэхээр Дамблдортой ярихыг хичээсэн гэдгийг ойлго гэлээ.

- Тиймээ, мэднэ гэж Харри хэллээ.

Тэр захиралтай холбоотой сэдвийн тухай ярилцахыг хүссэнгүй. Дамблдорын тухай ганц бодоход л дотор нь ахиад уур хилэн дүрхийв.

- Кикимер гэж хэн юм бэ?

- Эндхийн гэрийн үйлчлэгч. Жинхэнэ солиотой амьтан. Тийм зүйлтэй хэзээ ч таарч байсангүй гэж Рон хэлэв.

Гермиона түүн рүү ууртай харлаа.

- Тэр солиотой амьтан биш, Рон.

- Түүний амьдралын зорилго бол толгойгоо ээжийнхээ адил хананд өлгүүлэх явдал. Энэ чинь хэвийн хэрэг үү, Гермиона? гэж Рон даажигнан хэллээ.

- Гэхдээ ... тэр бага зэрэг хачирхалтай ч үүнд буруу байхгүй. Рон Харри руу наргиантай хараад,

- Гермиона нийгэмлэгээ оролдсон хэвээр байгаа ... Тэнд хэр байна? гэлээ.

- Би зөвхөн үйлчлэгч нарыг хамгаалахын төлөө тэмцэхийг хичээж байна ойлгов уу? Дамблдор бас биднийг Кикимертэй эелдэг харьцах ёстой гэж бодож байгаа юм.

- За болно, болно. Явцгаая би өлсөж үхэх нь гэж Рон хэллээ. Тэр түрүүлж гараад доошоо уруудах гэснээ,

- Зогсоорой. Тэд хонгилд байна ямар нэгэн юм сонсож магадгүй гэж шивнээд тэднийг хойш нь түлхэв.

Гурвуулаа чимээгүйхэн бөхийгөөд доош харлаа. Харанхуй хонгилд шидтэнгүүд дүүрэн байсан бөгөөд тэдний дунд Харриг хамгаалж байсан хүмүүс харагдана. Бүгд хөөрсөн янзтай шивнэлдэж байв. Харри хүмүүсийн голд Хогварстын дургүй багш болох тослог хар үс, унжуу хамартай профессор Снегг харлаа. Харри шатны хашлага дээгүүр улам тонгойлоо. Түүнд Снегг Фениксийн бүлгэмд юу хийж байгаа нь маш сонирхолтой байв.

Нүдний урдуур нь гэнэт урт оосор унжлаа. Дээшээ хартал Фред, Жорж хоёр хонгилд байгаа хүмүүс рүү Уртасгагч чихээ болгоомжтойгоор буулгаж байв. Хормын дараа шидтэнгүүд хөдөлж харагдахаа болив.

Фред аяархан хараагаад Уртасгагч чихээ буцаан татлаа.

Үүдний хаалга хэрхэн нээгдсэн шигээ хаагдах чимээ сонсогдов.

- Снегг хэзээ ч энд хооллодоггүй юм. Энэ нь ч сайн хэрэг дээ. Явцгаая гэж Рон аяархан хэлэв.

- Харри, хонгилд чимээгүй байхаа бүү мартаарай гэж Гермиона шивнэн сануулав

Тэд ханан дээрх үйлчлэгч нарын толгойн дэргэдүүр өнгөрөөд үүдний олон тооны цоож цуургыг Люпин, хатагтай Уизли, Тонкс нар илбэдэн түгжихийг харлаа.

- Гал зууханд хооллоно. Харри хонгор минь, өлмий дээрээ тэр хаалга руу яваарай гэж хатагтай Уизли тэднийг хараад шивнэн хэллээ.

Тар няр!

- Тонкс! гэж хатагтай Уизли бухимдан хашгирлаа.

- Уучлаарай! Би энэ тэнэг шүхэрт хоёр дахь удаагаа бүдэрлээ ... гэж газар тэрийн хэвтэж байсан Тонкс хэлэв.

Үүнтэй зэрэгцэн аймшигтай чих дөжирч цус царцам орилох чимээ гарав.

Харрийн түрүүн дэргэдүүр нь өнгөрсөн цагаан эрвээхэйд идэгдсэн хамба хилэн хөшигний ард ямар ч хаалга байсангүй. Агшин зуур Харрид хар малгайтай эмгэн хашгирч байгаа цонх руу харж байгаа юм шиг санагдав. Дараа нь энэ зөвхөн амьдралдаа харсан хамгийн таагүй хөрөг болохыг ойлгов.

Эмгэн амнаасаа хөөс сахруулан нүдээ эргэлдүүлэн шаргал арьсаа үрчийлгэн орилов. Хонгил даяар өөр хөргүүд сэрж ар араасаа орь дуу тавьцгаахад Харри чихээ алгаараа таглалаа.

Люпин, хатагтай Уизли хоёр эмгэний хөрөг рүү ухасхийж хөшиг татахыг оролдсон ч юу ч бүтсэнгүй улам чанга хашгирч ясархаг сарвуугаараа тэдний нүүрийг маажихыг оролдов.

- Бузар! Шаарнууд! Ой гутам амьтад! Эрлийзүүд, мутантууд, гаж амьтад! Эндээс зайлцгаа! Та нар миний эцгийн гэрийг яаж доромжилж зүрхлэв ...

Тонкс уучлал гуйсаар савдгийн хөлийг байранд нь тавилаа. Хатагтай Уизли хонгилоор гүйж үлдсэн хөргүүдийг Хөшөөх швшлэгээр чимээгүй болгохыг оролдов. Тэгтэл Харрийн урд нь зогсож байсан хаалгаар урт хар үстэй эрэгтэй хүн гарч ирлээ.

- Амаа тат, хөгшин шулам минь. Амаа тат! гэж тэр зандарлаа. Эмгэний царай хувхайрлаа.

- Чи-и-и-и-и! Чи бол манай удмын шившиг болсон зэвүүн урвагч! гэж нүдээ бүлтийлгэн хашгирав.

- Би Амаа тат! гэж хэлсэн шүү гэж тэр ахин зандраад Люпины хамтаар хөшгийг хүчээр хаав.

Хөгшиний орилоон намдахад нам гүм болов.

Урт харанхуй хонгилд Харрийн загалмайлсан эцэг эргэн хараад,

- За сайн уу, Харри. Чамайг миний ээжтэй хэдийн танилцсан байх гэж бодож байна хэмээн баргар хэлэв.

БҮЛЭГ 5: ФЕНИКСИЙН БҮЛГЭМ

- Чинийх гэнээ ...

- Тиймээ, миний ээж. Бид түүнийг өөр газар луу холдуулахыг хүссэн ч Үүрд мөнхийн шидээр хананд наалттай байсан. Алив тэднийг ахиад сэрэхээс өмнө түргэн доошилцгооё.

- Гэхдээ чиний ээжийн хөрөг яагаад энд өлгөөтэй байгаа юм бэ? гэж Харри нарийхан чулуун шатаар гал зуух руу уруудахдаа асуулаа.

- Чамд хэн ч хэлээгүй юм уу? Энэ бол эцэг эхийн минь гэр. Би Блэкийн удмаас үлдсэн сүүлчийн хүн болохоор байшин минийх юм. Би түүнийг Дамблдорт штабын байр болгон хэрэглүүлэхээр өгсөн. Энэ бол миний хийж чадах цорын ганц ашигтай зүйл.

Харри илүү элэгсэг харьцаа хүлээж байсан ч Сириусын хоолой гашуун дуулдав. Тэр загалмайлсан эцгээ даган уруудаж гал зуух руу орлоо.

Энэ бол хонгилтой адил бүдүүлэг хийцийн чулуун ханатай баргар өрөө байлаа. Гэрлийн ихэнхи нь өрөөний төгсгөлд байх том ханан зуухнаас гарч байв. Яндангаас гарсан утаа агаарт хөшиглөж сүрдэм дүрс үүсгэн харанхуй адарт өлгөсөн хоолны сав, хайруулын тавгыг тойрон суунаглана. Өрөөний голд тавьсан урт модон ширээг тойруулан олон тооны сандал байх агаад цугларалтаас үлдсэн хуйлаастай цаас, дарсны лонх, цомнууд харагдана. Ширээний төгсгөлд ноён Уизли том хүү Биллтэйгээ суугаад бие бие рүүгээ бөхийн аяархан шивнэлдэж байлаа.

Хатагтай Уизли ханиалгав. Түүний нөхөр болох өндөр туранхай оройгоороо халзарч яваа шаргал үстэй нүдний шилтэй шидтэн толгойгоо өргөөд үсрэн босов.

- Харри! Чамайг харсандаа ямар их баяртай байна гээч! хэмээн тэр дуу алдаад яаран ирж гарыг нь сэгсэрлээ.

Харри түүний мөрөн дээгүүр урт үсээ ардаа боосон Билл яаран ширээн дээрх цаасыг хуйлж байхыг ажиглав.

- Аялал хэвийн байв уу, Харри! Хурц нүдэт чамайг Греланд оруулаагүй гэж найдаж болох уу? гээд Билл бүх цаасыг нэгэн зэрэг хуйлж авлаа.

- Тэр хүссэн л дээ, гэхдээ ... хэмээн Тонкс Биллд туслахаар ухасхийхдээ цаасан дээр лаа унагачихлаа.

- Өө, үгүй ээ ... өршөөгөөрэй ...

- Зүгээр дээ хонгор минь гэж хатагтай Уизли уурсан хэлээд саваагаа даллан цаасыг хэвийн байдалд оруулав. Түүний шившлэгийн гэрэлд ямар нэгэн барилгын схем зурагтай адил зүйл байхыг Харри олж харлаа.

Хатагтай Уизли түүний харцыг ажиглачихлаа. Тэр төвлөвлөгөөг шүүрч аваад Биллийн гар дээрх овоолоостой цаас дээр тавив.

- Энэ бүхнийгээ цугларалтын дараа даруй түргэн цэвэрлэж бай гэж тэр ширүүн хэлэнгээ хоолны хуучин шүүгээнээс таваг гаргалаа.

Билл шидэт саваагаа гаргаад,

- Эванеско! гэж бувтнахад хуйлааснууд алга боллоо.

- Алив, суугаач Харри. Чи Назменикустай танил биз дээ? гэж Сириус хэлэв. Харриг суухад тэр чанга хурхирч байснаа цочин сэрээд алгуур босож ирэв.

- Хэн нэгэн миний нэрийг хэлсэн үү? Би Сириусыг зөвшөөрч байна ... гэж Наземникус нойрмог бувтналаа.

Тэр бохир гараа санал өгч байгаа аятай өргөхөд гунигтай цус хурсан нүд нь төвлөрсөн юмгүй ширтэж байв.

Жинни хөхөрлөө.

- Цугларалт дууссан. Харри ирчихээд байна гэж Сириус бүгдийг ширээнд суусан хойно хэлэв.

- Ээ? Намайг аянга ниргэг, тэр байна ... Ажил хэрэг ямар байна даа, Харри? гэж Наземникус баргар царайлан хэлээд Харри руу шаргал үснийхээ цаанаас ширтэн харлаа.

- Зүгээр дээ гэж Харри хэлэв.

Наземникус Харри руу харсаар түгшсэн янзтай халаасаа тэмтчиж хар өнгийн гаанс гаргалаа. Тэр амандаа гаансаа зуугаад савааныхаа үзүүрээр гал асаав. Хормын дараа түүнээс өтгөн ногоон утаа суунаглаж байлаа.

- Би чамд сүүлчийн удаа анхааруулж байна шүү, Наземникус! Би чамайг гал зууханд тамхи татахгүй байхыг гуйсан биз дээ. Ялангуяа биднийг хоол идэж байх үед! гэж хатагтай Уизли хашгирлаа.

- Аан ... тийм л дээ. Уучлаарай, Молли гэж Наземникус хэлэв.

Тэр гаансаа халаасандаа буцааж хийхэд утаан үүл алга болсон ч агаарт гашуун үнэр нь хоргодон үлджээ.

- Хэрвээ та нар шөнө дунд хүртэл хооллох гээгүй бол надад тусламж хэрэгтэй байна гэж хатагтай Уизли бүгдэд хандан хэлээд,

- Үгүй дээ чи сууж бай, Харри хонгор минь. Замд ядарсан байлгүй гэв.

- Юу хийх хэрэгтэй вэ, Молли? гэж Тонкс асуугаад урам зоригтойгоор суудлаасаа үсрэн босов.

Хатагтай Уизли түүн рүү болгоомжлон харлаа.

- Э... үгүй дээ, Тонкс баярлалаа. Юу ч хэрэггүй чи бас ядарсан байх.

- Үгүй дээ, үгүй би туслахыг хүсч байна! гэж Тонкс баяртай уулга алдаад замдаа байсан сандлыг холдуулан Жиннигийн хоолны хэрэгсэл гаргаж байгаа шүүтээ рүү ухасхийлээ.

Ноён Уизлигийн хяналтан дор хэд хэдэн том хутга хүний тусламжгүй мах, ногоо хэрчиж, хатагтай Уизли гал дээр өлгөөтэй байгаа тогоог хутгахад бусад нь ширээн дээр таваг, цом болон идэх юм өрлөө. Харри ширээнд сууж үлдэхэд Наземникус нүдээ анивчин гунигтай ширтэв.

- Хөгшин Фиггийг харав уу? гэж тэр асуулаа.

- Үгүй. Ер нь бол би хэнийг ч хараагүй гэж Харри хэлэв.

- Дүү минь сонс, би тэгэхэд явах гээгүй юм. Зүгээр л надад аятай боломж гараад ... гэж Наземникус бөхийгөөд өрөвдөлтэй хоолойгоор шивнэлээ.

Харри ямар нэгэн сагсгар зүйл өвдөгт нь хүрэхийг мэдрээд цочсон ч энэ ердөө Гермонагийн майга хөлтэй шаргал муур Живоглот байсан хэрэг байж. Тэр хүржигнэн хөл доогуур нь яваад Сириусын өвдгөн дээр үсрэн гарч цагариглав. Сириус түүний чихийг маажгаад Харри руу баргар царайлан харав.

- Зуныг сайхан өнгөрүүлэв үү?

- Ёстой олиггүй гэж Харри хэлэв.

Сириусын царайд анх удаагаа инээмсэглэл тодров.

- Би чиний оронд байсан бол гомдлохгүй л байсан.

- Яагаад? гэж Харри гайхан асуулаа.
- Би өөрийн биеэр Дементорын дайралтыг няцаасан бол баярлах байсан юм. Үхлийн тэмцэл бол уйтгар гунигийг арилгах сайн зүйл шүү дээ. Чи үүнээс муу зүйл байхгүй гэж бодож байгаа ч үнэндээ хаа нэг тийшээ явж хөлөө тэнийлгэн тулалдаж байна ... Харин би бүтэн сарын турш цоожтой суулаа.
- Яагаад? гэж Харри хөмсөг зангидан асуулаа.
- Яагаад гэвэл ид шидийн яамнаас урьдын адил намайг эрсэн хэвээр байгаа. Волдеморт намайг Сүүлтээс анимаг гэж мэдсэн болохоор зүсээ хувиралт минь ашиггүй болсон. Иймээс миний Фениксийн бүлгэмд хийж чадах зүйл бага байна ... Ямар ч гэсэн Дамблдор ингэж бодож байгаа юм.
- Сириус энэ нэрийг хүйтнээр хэлэхэд Харри түүний яагаад Хогвартс сургуулийн захиралд сэтгэл хангалуун бус байгааг нь ойлголоо. Харри гэнэтхэн загалмайлан эцгээ хайрлах сэтгэлийг мэдэрчээ.
- Гэхдээ чи цугларалтанд байсан биз дээ гэж тэр Сириусыг дэмжив.
- Өө, тийм л дээ гэж Сириус даажигнан хэлээд.
- Намайг ард тав тухтай байхад Снеггийн хэрхэн амьдралаа эрсдэлд оруулж байгаа талаарх ёжтой үгийг сонсож байлаа ... Надаас бүр цэвэрлэгээ ямар байгааг асуусан шүү.
- Юун цэвэрлэгээ? гэж Харри асуулаа.
- Энэ байрыг хүн амьдарч болохоор болгохыг хичээж байна гээд Сириус баргар гал зуух руу дохив.
- Арван жилийн өмнө хүндэт ээж минь нас барсан үеэс хойш ямар ч ашиггүй хөгшин гэрийн үйлчлэгчийг эс тооцвол энд хэн ч амьдарч байсангүй. Харин тэр эртнээс юу ч цэвэрлэхээ больсон.
- Сириус. Энэ цэвэр мөнгө үү? гэж ярианд анхаарал хандуулалгүй гартаа барьж байсан цомыг ширтэж байсан Наземникус хэлэв.
- Тиймээ Арван тавдугаар зууны үед Блэкийн овгийн сүлдийг мөнгөн дээр сийлбэрлэн хийсэн албинуудын хийц гээд Сириус цом руу зэвүүцэнгүй харлаа.
- Шинэ юм шиг харагдаж байна гэж Наземникус бувтнаад цомыг ханцуйгаараа

арчлаа.

- Фред, Жорж ... Яагаад гараараа болдоггүй юм! хэмээн хатагтай Уизли хашгирав.

Тэд агшин зуур эргэн харцгаав. Фред, Жорж хоёр жигнэсэн махтай том тогоо, төмөр домботой цөцгийний шар айраг, талх зүсдэг хутга зоосон хавтгай модыг агаарт тэдний зүг шившин хөөргөжээ. Үнс тортог болсон тогоо ширээний өнцөг дээр ширүүн газардаад модон гадаргуу дээгүүр урт хар судал үлдээн ирмэг хүртэл гулгахад, цөцгийтэй шар айрагны домбо хангинан унаж бүх зүйл нь цацагдав. Талхны хутга самбараас мулт үсрэн хэдэн секундэд өмнө Сириусын баруун гар байсан газар зоогдчихлоо.

- Бурханд баярлалаа! Яах гэж ингэж байгаа хэрэг вэ? Миний хувьд хангалттай. Та нарыг өчүүхэн зүйлд саваагаа хэрэглэж бай гэж ид шид хэрэглэх зөвшөөрөл олгоогүй.

- Би зөвхөн цаг хэмнэхийг хүссэн юм! Уучлаарай, Сириус ... Бид хүсээгүй гэж Фред хэлээд яаран талхны хутгыг ширээнээс суга татан авлаа.

Харри, Сириус хоёр хөхрөлдөхөд Наземникус цочсондоо сандалтайгаа хойш унаад хараан босч ирлээ. Живоглот ууртай хүржигнээд гал зуухны шүүгээн доор ухасхийн орж харанхуйгаас том шар нүд гялалзав.

- Хөвгүүдээ ээжийн чинь зөв. Та нар одоо насанд хүрсэн болохоор биеэ хариуцлагатай авч явах хэрэгтэй гэж ноён Уизли тогоог ширээний голд эргүүлэн тавиад хэллээ.

- Нэг ч ах нар чинь ийм зүйл хийж байсангүй! гэж хатагтай Уизли хилэгнээд шинэхэн цөцгийний шар айрагтай домбыг тасхийтэл ширээн дээр тавихад ахиад цацагдлаа.

- Билл таван алхам тутамд шилжих талаар боддоггүй байсан! Чарли гарын дорх зүйлд шившлэг хэрэглэдэггүй байсан! Перси ...

Тэр огцом чимээгүй болсноо айсан шинжтэй нөхөр лүүгээ харлаа.

- Алив идэцгээе гэж Билл түргэн хэлэв.

- Сайхан харагдаж байна, Молли гэж жигнэсэн мах таваглаж буй Люпин хэллээ.

Хэдэн хормын турш чимээгүй болж зөвхөн хутга сэрээ харших, сандал чахрах чимээ гарч байлаа. Тэгтэл хатагтай Уизли Сириус руу эргэв.

- Би чамтай зарим зүйлийн талаар ярилцах гэсэн юм, Сириус. Зочны өрөөний бичгийн ширээн дор ямар нэг юм үргэлж түжигнээд байна. Энэ магадгүй Боггарт байх би Алосторыг харахаас өмнө түүнээс ангижирсан нь дээр гэж бодож байна.

- Хүссэнээрээ бол гэж Сириус хайхрамжгүй хэлэв.

- Бас хөшгөөр нэг докси дүүрчихэж. Бид маргааш тэдний эсрэг тэмцэж болох юм? гэж хатагтай Уизли үргэлжлүүлэв.

- Үүнд зөвхөн гар шаардагдана гэж Сириус хэлэхэд Харри түүний хоолойны гашуун өнгийг сонссон ч бусад нь сонссон эсэхийг мэдсэнгүй.

Харрийн эсрэг талд суусан Тонкс хоол идэх зуураа Гермiona, Жинни хоёрт хамраа хувирган үзүүлэх аж. Тэр Харрийн өрөөнд байсны адил нүдээ онийлгон Снеггийн хамрыг санагдуулам хурц хошуутай болсноо багасган товчны хэмжээтэй болгоход хамраас нь туг үс цухуйж байлаа. Гермiona, Жинни хоёр уралдан дуртай хамраа захиалж эхэллээ.

- Гахайн хамартай болж болох уу, Тонкс?

Тонкс тооройн хоншоортой болоход Харрид агшин зуур эмэгтэй Дадли инээмсэглэж байх шиг санагджээ.

Ноён Уизли, Билл, Люпин нар албингуудын талаар улайран хөөрөлдөнө.

- Тэд бараг л хар талынх. Тэднийг одоо хүртэл ахин төрсөнд нь итгэж байгаа эсэхийг ойлгохгүй байна. Магадгүй төвийг сахиж байж болзошгүй. Дийлсэн тал руу нь явна гэж Билл ярилаа.

- Би тэднийг хэзээ ч Хэцүү нэртийн талд орохгүй гэдэгт итгэлтэй байна. Тэд ч гэсэн бас зовлонд өртөө биз. Сүүлчийн аллагаараа тэр Ноттингемийн ойролцоо албингийн гэр бүлийг алсныг санаж байна уу? гээд ноён Уизли толгой сэгсэрлээ.

- Минийхээр бол тэдэнд юу санал болгохоос хамаарна. Би алтны тухай яриагүй байна. Хэрвээ тэдэнд бидний зууны турш хязгаарласан эрх чөлөөг амлах юм бол зөвшөөрөх байх. Тэгэхээр Билл Рагноктой болсонгүй юу? гэж Люпин хэлэв.

- Тэр шидтэнгүүдийн эсрэг бодолтой байгаа. Үргэлж шидийн яамнаас Бэгмений гэмт хэргийг далдлан албингуудад алтыг нь өгөхгүй байна гэж ярьдаг юм.

Ширээний дунд хэсгээс хөгжилтэй инээд хадлаа. Фред, Жорж, Рон, Наземникус нар сандлаасаа нурж унах шахам инээлдэнэ.

- ... харин дараа нь гэж нулимсаа гартал инээсэн Наземникус үргэлжлүүлэн хэлээд,

- Дараа нь түүний надад хэлсэн үгэнд итгэж байна уу. «Хонгор найз минь чи энэ бахыг хаанаас олсон бэ? Миний бүх бах алга болсныг харж байна уу» гэсэн. Харин би түүнд «Чиний бахнууд алга болсон гэнээ? Ямар таагүй явдал вэ. Чамд шинэ бах хэрэгтэй юм байна» гэсэн. Тэнэг луу надаас өөрийн бүх бахаа анх авснаасаа илүү үнэтэй авсан юм даа ...

- Наземникус бидэнд чиний худалдааны ажил хэргийн яриа хангалттай, их баярлалаа гэж хатагтай Уизли хэлэв. Рон инээсээр хүчгүй болон ширээн дээр уналаа.

- Өршөөгөөрэй, Молли гээд Наземникус Харри руу нүд ирмэснээ,

- Хэрвээ тэгээд Уилл явчихсан бол би тэднийг Харрисад нэг их үнэ хүргэн зарж чадахгүй байлаа гэв.

- Наземникус чамайг хаана суралцсаныг мэдэхгүй байгаа ч хамаг чухал хичээлээ алгассан гэдэгт итгэлтэй байна хэмээн хатагтай Уизли хүйтнээр хэллээ.

Фред, Жорж хоёр хөхрөлдөн цөцгийний шар айрагтай цомын ард нуугдав. Гишүүний үйрмэгтэй бялуу авчирахаар өндийсөн хатагтай Уизли Сириус руу яагаад ч юм маш таагүй харав. Харри загалмайлан эцэг рүүгээ харлаа.

- Молли Наземникусыг тэвчиж чаддаггүй юм гэж Сириус нам дуугаар хэлэв.

- Тэр бүлэгт яаж орсон юм бэ? гэж Харри аяархан асуулаа.

- Тэр ашигтай байсан юм. Бүх луйварчингуудыг таньдагийн дээр тоог нь ч мэднэ. Хамгийн гол нь Дамблдорт үнэнч бөгөөд нэг удаа том гайгаас аварсан юм. Тиймэрхүү талын хүнээс сайн юм сонсоно гэж бодолтгүй ч Молли түүнийг манай ширээнд гутааж байгаа нь арай дэндэнэ. Тэр түүнийг чамайг хамгаалалтгүй орхисны төлөө уучлахгүй байгаа юм.

Гурван зүсэм гишүүний бялуу идсэний дараа Харри өмд нь гэдэс барихыг мэдэрчээ. Тэр халбагаа доош тавихад яриа хөөрөө намжсан байв. Ноён Уизли цатгалан сэтгэл хангалуунаар сандлаа хойш налж, Тонкс хамраа ердийн хэвэнд оруулаад амттайхан эвшээв. Жинни Живоглотыг гал зуухны шүүгээн дороос гаргахаар цөцгийний шар

айрагны үйсэн бөглөө өнхрүүлэхэд муур араас нь хөөв.

- Орондоо орох цаг болж гээд хатагтай Уизли эвшээлээ.

- Үгүй дээ, Молли жаахан хүлээгээрэй. Чи намайг гайхуулж байна шүү. Миний бодлоор чи юуны түрүүнд Волдемортын тухай асуулт тавих ёстой баймаар юм гэж Сириус хоосон таваг дээгүүр Харри руу хандан хэлэв.

Өрөөнд Дементор орж ирсэн аятай уур амьсгал огцом өөрчлөгдөв. Ердөө агшины өмнө өрөөнд нойрмог тайван байдал ноёрхож байсан бол одоо бүгд сэргэн давхийцгээжээ. Волдемортын нэр үл ялиг чичрүүдэс үүсгэв. Люпин дарс шимж уугаад цомоо аажуухан тавьж түгшсэн янзтай харлаа.

- Яагаад тавиагүй гэж! Рон, Гермиона хоёроос асуусан ч тэд бүлэгт багтдаггүй болохоор ... гэж Харри таагүйхэн хэлэв.

- Тэдний зөв. Чи хэтэрхий залуухан гэж хатагтай Уизли хэлээд суудал дээрээ нударга зангидан өндийхөд нойрмоглосон ул мөр нь оргүй алга болжээ.

- Үүнийгээ Фениксийн бүлгийн гишүүнээс асуух хэрэгтэй байсан юм биш үү?

Харри бүтэн сарын турш маглуудын байшинд байсан. Тэр юу болсныг мэдэх

...

- Хүлээгээрэй! гэж Жорж чангаар орилов.

- Яагаад зөвхөн Харри асуултандаа хариу авах ёстой гэж? хэмээн Фред ууртай асуув.

- Бид сарын турш ямар нэг аргаар өчүүхэн төдий зүйл мэдэх гэж оролдож байна! гэж Жорж хашгирав.

- Та нар хэтэрхий залуухан, бас бүлгийн бишүүд биш гэж Фред ээжтэйгээ жигтэйхэн адилхан хоолойгоор хэлээд,

- Харри ч гэсэн насанд хүрээгүй! гэв.

- Та нарт бүлгийн ажил яриагүйд би буруугүй. Эцэг эх чинь тэгж шийдсэн юм.

Харригийн хувьд бол өөр хэрэг ... гэж Сириус тайван хэлэв.

- Харрид юу хэрэгтэй эсэхийг чи бие дааж шийдэхгүй! Чамайг Дамблдорын үгийг мартаагүй гэж найдаж болох уу? хэмээн хатагтай Уизли түүний яриаг огцом таслахад эелдэг царай нь гэнэтхэн сүрдэм төрхтэй болоо.

- Чухам юу гэж? хэмээн Сириус тулаанд бэлтгэж байгаа хүний байдалтай эелдэгхэн хэллээ.

- Түүнд чухал хэрэгтэй зүйлийг Харри мэдэх ёсгүй гэж хатагтай Уизли сүүлчийн хоёр үгийг тодотгон дуугарав.

Рон, Гермиона, Фред, Жорж нар Сириус хатагтай Уизли хоёр одон бөмбөг тоглож байгаа аятай толгойгоо эргүүлцгээнэ. Жинни шалан дээр өвдөглөсөн хэвээр үйсэн бөглөөгөө мартаад ам ангайн сонсож байлаа. Люпин Сириусээс харц салгасангүй.

- Харин би түүнд мэдэх ёстой зүйлийг нь хэлэх хэрэгтэй гэж бодож байна, Молли. Тэр Волдеморгын эргэн ирэлтийн гэрч болсон шүү дээ. (Энэ нэрийг хэлмэгц бүгд ахин давхийлээ) Түүний зөв, олон ...

- Тэр Фениксийн бүлгэмийн гишүүн биш! Тэр ердөө арван таван настай ... гэж хатагтай Уизли мэдэгдэв.

- Тэр гишүүдийн ихэнхээс илүү сорилтыг туулсан гэж Сириус эсэргүүцэв.

- Хэн ч түүний хийсэн зүйлийг үгүйсгээгүй байна. Гэхдээ тэр ... гэж хатагтай

Уизли хашгирахад сандлын түшлэг дээр тавьсан гар нь чичирлээ.

- Тэр хүүхэд биш! гэж Сириус уурсан хэлэв.

- Бас насанд хүрсэн ч биш. Тэр Жеймс биш, Сириус! гэж хатагтай Уизли хацраа улайлган хашгирав.

- Баярлалаа, Молли. Би түүний хэн болохыг сайн мэднэ гэж Сириус хүйтнээр хэлэв.

- Үүнд чинь итгэлгүй байна! Заримдаа чи түүнтэй сайн найз чинь буцаад ирсэн юм шиг ярих юм! гэж хатагтай Уизли дуу алдав.

- Үүнд чинь буруу юу байна? гэж Харри асуулаа.

- Харри эцэгтэйгээ адилхан ч тэр биш гэдэгт буруу юм байгаа юм! Чи сургуульд сурч байгаа хэвээр бөгөөд үүнийгээ бүү март! гэж хатагтай өмнөхийн адил Сириус руу нүдээ гялалзуулан хэлэв.

- Намайг хариуцлагагүй загалмайлан эцэг гэж хэлэхийг хүсээ юу? гэж Сириус дуугаа өндөрсгөв.

- Дамблдор чамайг гэрээс гаралгүй үлд гэж сануулж байхад чи болчимгүй зүйл

хийх гэж байна, Сириус ...

- Бид Дамблдорын зааврын тухайд энэ удаад орхиж үзье! гэж Сириус чанга хашгирав.

- Артур! Артур намайг дэмжээч! гээд хатагтай Уизли нөхөр лүүгээ хандав.

Ноён Уизли шууд хариулсангүй. Тэр эхнэр лүүгээ харалгүй шилээ аваад жанчаараа удаан арчлаа. Дараа нь хариулахын өмнө хамар дээрээ болгоомжтойгоор зүүв.

- Дамблдор байдал өөрчлөгдсөнийг ойлгож байгаа, Молли. Тэр Харриг штабын байранд ирэхийг зөвшөөрсөн болохоор мэдэх эрхтэй гэж үзсэн байх.

- Гэхдээ энэ чинь өөр зүйл хэлсэн болохоос биш дуртай асуултаа асууж болно гэсэн үг биш!

- Миний хувьд гэж Люпин аяархан хэлэхэд Сириусээс нүд салгахгүй байсан хатагтай Уизли холбоотон руугаа түргэн эргэн харлаа.

- Би Харри бүх зүйлийг мэдэх хэрэггүй гэж бодож байна, Молли. Гэвч ерөнхий мэдээллийг өгөхгүй бол бусдаас бидний тухай буруу ташаа мэдээлэл ...

Түүний царай зөөлхөн байсан ч Харри Люпин хатагтай Уизлийн цэвэрлэгээнээс үлдсэн Уртасгагч чихний тухай мэдэж байна гэдэгт эргэлзсэнгүй.

- Тэгэхээр гэж хатагтай Уизли хүндээр амьсгаадан хэлээд дэмжлэг эрэн ийш ийшээ харав.

- Би цөөнх болсноо харж байна. Би зөвхөн үүнийг л хэлэх гэсэн юм. Дамблдор Харрид хэтэрхий олон зүйл хэлэхгүй байх шалтгаан байсан. Би Харриг ойр дотны хүн шигээ боддог болохоор ...

- Тэр чиний хүү биш гэж Сириус аяархан хэлэв.

- Чиний ч хүү биш! Түүнд өөр хэн байгаа юм бэ? гэж хатагтай Уизли хилэгнэв.

- Түүнд би байна!

- Тийм байж гэхдээ чи Азкабанд цоожтой сууж байсан болохоор анхаарал тавихад хүнд байсанд хамаг учир оршиж байгаа юм.

Сириус суудлаасаа өндийлөө.

- Молли чи энэ ширээнд Харрид санаа зовж байгаа цорын ганц хүн биш.

Сириус, суу! гэж Люпин ширүүн хэллээ.

Хатагтай Уизлийн доод уруул чичирлээ. Цонхийн цайсан Сириус алгуурхан суудалдаа суув.

- Бид Харрийн юу хэлэхийг сонсох хэрэгтэй гэж бодож байна. Тэр шийдвэр гаргахаар хангалттай том болсон.

- Би юу болсныг мэдэхийг хүсч байна гэж Харри агшин зуур хэлэв.

Тэр хатагтай Уизли руу харсангүй. Хэдийгээр түүнийг хүү шигээ боддог гэсэн үг торж байсан ч, Сириусын зөв тэр хүүхэд биш болсон.

- Маш сайн байна. Жинни ... Рон ... Гермиона ... Фред ... Жорж! Даруйхан гал зуухнаас гарцгаа гэж хатагтай Уизли хангинав.

Агшин зуур хөл үймээн боллоо.

- Бид насанд хүрсэн! гэж Фред, Жорж хоёр зэрэг орилов.

- Харри болж байхад бид болохгүй юу? гэж Рон хашгирлаа.

- Ээжээ, би сонсохыг хүсч байна! гэж Жинни орь дуу тавив.

- Үгүй! Би хатуу хориглож байна ... гэж хатагтай Уизли хашгираад суудлаасаа нүдээ гялалзуулан үсрэн босов.

- Молли, чи Фред, Жорж хоёрыг хорьж чадахгүй. Тэд үнэхээр насанд хүрсэн гэж ноён Уизли ядрангуй хэлэв.

- Тэд сурагч хэвээр шүү дээ.

- Гэхдээ хуулиар бол насанд хүрсэн гэж ноён Уизли хэлэв. Хатагтай Уизлийн царай час улайлаа.

- Би ... За яахав тэгвэл, Фред Жорж хоёр үлдэж болно гэхдээ Рон ...

- Харри, Гермиона бид хоёрт бүгдийг ярина! Ярина биз дээ? Тийм үү? гэж Рон хашгираад Харри руу итгэлгүйхэн ширтэв.

Харрид агшин зуур өөрийгөө хамгаалахын тулд Ронд юу ч хэлэхгүй гэж хэлэх гэсэн бодол орж ирсэн ч түүнийг хараад сарнин алга болов.

- Мэдээж ярина гэж Харри амлав. Рон, Гермиона хоёр баясан гийлээ.

- Сайн байна! Сайн байна! Жинни, унт! гэж хатагтай Уизли тушаав.

Жинни чимээгүй гарч явсангүй. Тэр шатны гишгүүр өгсөх болгондоо уурсан үглэж

хонгилд хүрэхэд хатагтай Блэкийн чих дөжрөм орилох чимээ гарав. Люпин эмгэнийг тайвшируулахаар яарав. Түүнийг эргэж ирээд гал зуухны хаалга хааж байрандаа суусан хойно Сириус,

- Ингэхэд Харри чи юу мэдэхийг хүсээ вэ? гэлээ.

Харри гүнзгий амьсгал аваад сүүлчийн сар зовоож байсан асуултаа тавилаа.

- Волдеморт хаана байна? Тэр юу хийж байна? Би маглуудын мэдээ үзсэн ч тэнд ямар ч хачирхалтай үхэл сэжигтэй зүйл юу ч байгаагүй гэж асуухдаа давхийсэн хүмүүсийг тоосонгүй.

- Учир нь ямар ч хачирхалтай үхэл болоогүй ... Тэгсэн бол бид мэдэх л байсан ... Гэхдээ бид хангалттай зүйл мэдэж байгаа.

- Ямар ч гэсэн түүний бодож байгаагаас илүү ихийг гэж Люпин хэлэв.

- Тэр хүмүүсийг алахаа больсон юм уу? гэж Харри асуулаа. Тэр Волдемортыг сүүлийн жил нэг бус удаа аллага хийсэн гэдгийг мэдэх билээ.

- Тэр өөртөө анхаарал татахыг хүсэхгүй байгаа. Энэ түүний хувьд аюултай.

Эргэж ирэлт нь түүний хүссэнээр болоогүй. Тэр сэтгэлээр унасан гэж Сириус тайлбарлав.

- Эсвэл чи түүнийг тоглоомноос гаргасан гэж Люпин сэтгэл хангалуун инээмсэглэв.

- Яаж? гээд Харри ойлгосонгүй.

- Чи амьд үлдэх ёсгүй байсан! Үхэл залгигчдаас өөр хэн ч түүний хүчтэй болсон гэдгийг мэдэх ёсгүй байсан. Гэтэл чи бүгдийг хараад амьд үлдсэн гэж Сириус хэлэв.

- Тэр юунаас ч илүү эргэж ирснээ Дамблдорт мэдүүлэхийг хүсээгүй юм.

Дамблдорт даруй бүгдийг мэдэгдсэний чинь төлөө талархаж байна гэж

Люпин нэмэрлэв.

- Гэхдээ энэ яаж тусалсан гэж?

- Чи тоглож байна уу? Дамблдор бол Хэцүү нэртийн айдаг цорын ганц хүн гэж

Билл ярианд оролцов.

- Зөвхөн чиний ачаар л Дамблдор Фениксийн бүлгийн гишүүдийг Волдеморт эргэн ирснээс хойш цагийн дотор цуглуулсан гэж Сириус хэллээ.
- Энэ бүлэг юу хийдэг юм бэ? гэж Харри асуугаад бүгдийг ээлжлэн харлаа.
- Бүх хүчээ гарган Волдемортын төлөвлөгөөг эвдэхийн төлөө тэмцэнэ гэж Сириус хариулав.
- Түүний төлөвлөгөөг яаж мэдэх юм бэ? гэж Харри түргэн асуулаа.
- Дамблдор өөрийн гэсэн таавар бий. Дамблдорын таавар ерөнхийдөө үнэнд ойртдог юм гэж Люпин хариулав.
- Түүний төлөвлөгөөний талаар Дамблдор юу гэж бодож байгаа юм бэ?
- Нэгдүгээр тэр армия ахин босгохыг хүсч байгаа. Хуучин өдрүүдэд түүний дор айлган сүрдүүлсэн, шившлэгийн нөлөөнд оруулсан олон арван шидтэнгүүд болон үнэнч Үхэл залгигчид тушаалыг нь биелүүлдэг байлаа. Чи түүний аварга биетэнгүүдийг өөрийн талдаа элсүүлэхээр төлөвлөж байгааг сонссон ч энэ бол ердөө ганц зүйл нь юм. Тэр мэдээж ид шидийн яам руу хэдхэн Үхэл идэгчийн төлөө дайрахгүй.
- Харин та нар шинэ дэмжигчид олоход саад хийж байгаа хэрэг үү?
- Тиймээ хэрэгтэй бүхнийг гэж Люпин хэлэв.
- Гэхдээ яаж?
- Хамгийн гол нь аль болох олон хүнд Хэцүү нэртийн эргэж ирсэн гэдгийг итгүүлэх явдал юм. Гэхдээ энэ амаргүй байна гэж Билл хэлэв.
- Яагаад?
- Яамны чиг хандлага. Харри чи Корнелиус Фажыг Хэцүү нэртийн эргэн ирсний дараа харсан биз дээ. Түүний байдалд өөрчлөлт ороогүй. Тэр энэ бүхэн үнэхээр болсон гэдгийг хатуу эсэргүүцэж байгаа гэж Тонкс хэллээ.
- Гэхдээ яагаад? Тэр яагаад тийм тэнэг байгаа юм бол? Хэрвээ Дамблдор ... гэж Харри сэтгэлээр унан асуулаа.
- Энэ чинь л байхгүй юу. Түүний Дамблдортой харьцах харьцаа гээд ноён Уизли гашуунаар инээмсэглэв.

- Фаж түүнээс айдаг юм гэж Тонкс гунигтай хэлэв.
 - Дамблдороос айдаг гэнээ? хэмээн Харри итгэсэнгүй.
 - Түүнийг өөрөөсөө илүү гэж боддог учир айдаг юм. Фаж Дамблдор түүнийг унагаад сайд болохыг хүсч байгаа гэж боддог хэмээн ноён Уизли тайлбарлав.
 - Гэхдээ Дамблдор тэгж хүсээгүй биз дээ ...
 - Мэдээж хүсээгүй. Хэдийгээр Милисента Багнолдыг тэтгэвэртээ гарахад олон хүмүүс хүсч байсан ч гэсэн тэр хэзээ ч сайдын суудал руу тэмүүлж байгаагүй.
 - Фаж сэтгэлийн гүндээ Дамблдор түүнээс ухаантай бөгөөд хүчирхэг шидтэн гэдгийг ойлгодог учир сайд болсон эхэн үедээ үргэлж зөвлөгөө авдаг байлаа. Харин тэр одоо алдар нэрийн амтанд орж өөртөө илүү итгэлтэй болсон. Түүнд сайд байх нь таалагдаж байгаа бөгөөд өөрийгөө хамгийн ухаантай Дамблдор бол ердөө самуун дэгдээгч гэж итгүүлсэн.
 - Тэр яаж тэгж бодож чаддаг байна аа? Тэр Дамблдорыг худал хэлсэн гэж яаж бодож байна аа? Бас намайг худал хэлсэн гэж? хэмээн Харри ууртай асуув.
 - Учир нь Волдеморт ахин төрсөн гэдгийг зөвшөөрөх юм бол яаманд томоохон толгойны өвчин үүснэ. Тэд иймэрхүү зүйлтэй бараг арван дөрвөн жил учирсангүй. Фаж үнэнтэй нүүр тулахыг хүсэхгүй байгаа бөгөөд Дамблдор худал хэлсэн гэж бодох нь илүү аятайхан байгаа юм гэж Сириус гашуунаар нэмэрлэлээ.
 - Асуудал юунд байгааг ойлгож байна уу? гээд Люпин,
 - Ид шидийн яамнаас Волдеморт эргэн төрсөн ч айх зүйл байхгүй гэж хүмүүсийг ятгаж байгаа ч өөрсдөө түүндээ итгэхгүй байгаа юм. Яамнаас «Өдөр тутмын зөнч» сонинд Дамблдорыг худалч гэж бичихийг даалгасан. Ийм учраас ихэнхи шидтэнгүүд болсон явдлын талаар юу ч мэдэлгүй Үхэл идэгч нарын Имперуус шившлэгийн хялбархан зууш болж байгаа юм гэлээ.
 - Гэхдээ та нар хүмүүст мэдэгдсэн биз дээ? Түүнийг ахин төрсөн гэж хэлсэн биз дээ? гэж Харри асуугаад хатагтай Уизли, Сириус, Билл, Наземникус, Люпин, Тонкс нарыг ээлжлэн харав.
- Тэд хөгжилтэй бус инээмсэглэв.
- Хүн болгон намайг аймшигт алуурчин гэж боддог болохоор яамнаас миний толгойд мянган галлеон амласан. Ийм болохоор би гудамжинд гарч ухуулах хуудас

тарааж чадахаар байна уу? гэж Сириус хэлэв.

- Би ч гэсэн шидтэнгүүдийн гэрийн хамгийн хүсээгүй зочин. Аюултай хүн чоно гэдгийг минь нэмэрлээд үз дээ гэж Люпин дуугарлаа.

- Тонкс, Артур хоёр баруун зүүнгүй ярьж эхэлвэл таагүй явдал тохиолдоно.

Харин бидэнд яаманд хүмүүсээ байлгах нь үнэхээр хэрэгтэй байгаа юм. Тэнд

Волдемортын хүмүүс гарцаагүй бий.

- Гэхдээ бид чадахаараа хүмүүсийг итгүүлж байгаа. Жишээ нь Тонкс байна.

Тэр их залуухан саяхан бүлгийн гишүүн болсон. Манай бүлгийн эгнээнд мракоборец орж ирнэ гэдэг бол том амжилт. Кингсли Бруствер ч бас үнэтэй хүн. Тэр Сириусыг мөрдөх анг толгойлдог болохоор ид шидийн яаманд түүнийг Тибетэд нуугдсан гэж итгүүлэн төөрөлдүүлж байгаа.

- Хэрвээ та нарын нэг ч Волдеморт ахин төрсөн гэдгийг мэдэгдээгүй юм бол ...

- Нэг ч биш гэж хэн гэж хэлж байгаа юм? Чинийхээр бол Дамблдор учирсан таагүй явдал юу болох вэ? гэж Сириус хэллээ.

- Ямар?

- Тэд үргэлж түүний нэр төрийг гутаахыг хичээж байгаа. Чи өнгөрсөн долоо хоногийн «Зөнч» сонин уншаагүй юм уу? Тэд олон улсын шидтэнгүүдийн холбооноос түүнийг хөгширч ухаан муудсан учир санал хураалтаар ерөнхийлөгчийн байрнаас буулгасан гэсэн. Гэхдээ энэ бол худал. Тэр Волдемортыг эргэн ирснийг мэдэгдсэнээс хойш яамны шидтэнгүүдээр толгойлуулсан бүлэг шидтэнгүүд эсрэг санал өгсөн юм. Харин одоо тэр шидтэнгүүдийн Визенгамот шүүхийн тэргүүлэгчийн байр сууриа алдаж бас Мерлиний нэгдүгээр зэргийн одонг нь хураах тухай яриа явж байгаа гэж Люпин тайлбарлав.

- Гэхдээ Дамблдор энэ бүхнийг тоохгүй байгаа. Хамгийн гол нь түүнийг шоколадан мэлхийнээс авч хаяагүй гэсэн гээд Билл инээмсэглэв.

- Ямар ч инээдтэй зүйл алга. Хэрвээ тэр цаашид ийм маягаар ид шидийн яамыг үл тоомсорлох юм бол Азкабанд орж бид хүрч чадахгүй болно. Хэцүү нэртэд Дамблдор чөлөөтэй байгаа гэдэг нь илт байгаа болохоор сэрэмжтэй хөдөлж

байгаа юм. Дамблдорыг холдуулмагц Хэцүү нэртийн зам чөлөөлөгдөнө гэж ноён Уизли ширүүн хэлэв.

- Гэхдээ Волдеморт шинэ Үхэл залгигчдыг цуглуулахыг хичээж байгаа юм бол ирснээ яаж нууц байлгах юм бэ? гэж Харри цөхрөнгүй асуулаа.

- Волдеморт хүмүүсийн байшингийн хаалга үүд цохиж явдаггүй. Тэр мэхэлж, шившиж, дарамталдаг. Түүний ажил хэрэг нууц байдалд байдаг. Зөвхөн түүний сонирхсон дагалдагч нар нь цуглардаг. Түүнд чимээ шуугиангүй хийхээр төлөвлөсөн өөр зүйл байгаа болоод гол анхаарлаа төвлөрүүлж байгаа юм.

- Түүнд дэмжигчидээс нь өөр юу хэрэгтэй гэж? хэмээн Харри асуухад Сириус Люпин хоёр түргэн харц солилцов.

- Нэг тийм зэвсэг бий гэж хэлж болно. Түүнд өнгөрсөн удаа байгаагүй гэж Сириус нэмлээ.

- Түүнийг хүчтэй болохын өмнө үү?

- Тийм.

- Ямар зэвсэг юм? Авада Кедаврагаас ч аймшигтай юу?

- Хангалттай! гэж хаалганы сүүдэрт зогсож байсан хатагтай Уизли уулга алдав.

Харри түүний Жинниг унтуулаад өрөөнд хэзээ эргэн ирснийг анзаарсангүй. Тэр гараа урдаа зөрүүлээд ууртай зогсож байв.

- Би та нарыг даруйхан орондоо орохыг хүсч байна гэж тэр шаардангуй хэлээд Фред, Жорж, Рон, Гермiona нарыг ээлжлэн харлаа.

- Та бидэнд тушааж чадахгүй ... гэж Фред хэллээ.

- Сириус, намайг хараач. Чи Харрид зөндөө зүйл хэллээ. Бүлгэмд элсүүлэх нь дутаад байна гэж хатагтай Уизли чичирэн хэлэв.

- Яагаад үгүй гэж? Би дуртайяа элсэх байна. Тэмцэхийг хүсч байна гэж Харри түргэхэн хэлэв.

- Үгүй.

Энэ үгийг хатагтай Уизли биш Люпин хэлжээ.

- Бид зөвхөн насанд хүрсэн шидтэнийг авдаг. Гэхдээ бас сургуулиа төгсөх хэрэгтэй гэж Фред, Жорж хоёрын амаа нээхийг хараад хэлэв.

- Гишүүд ямар аюул дунд байдгийг та нарын хэн ч ойлгохгүй. Би Моллигийн

зөв гэж бодож байна, Сириус. Бид түүнд хангалттай зүйл хэллээ.

Сириус үл мэдэг мөрөө хавчаад маргасангүй. Хатагтай Уизли хөвгүүдээ болон, Гермионаг занган захирлаа. Тэд нэг нэгнийхээ араас босоход Харри ялагдсанаа ойлгон хамгийн сүүлд нь гарлаа.

БҮЛЭГ 6: ЭРТНИЙ СУРВАЛЖИТ ГАРАЛТАЙ БЛЭКИЙН ГЭР БҮЛ

Хатагтай Уизли баргар төрхтэй тэдний араас дээшээ гарч ирлээ.

- Бүгд даруйхан унтацгаа ямар ч яриа хөөрөө байхгүй. Маргааш хүнд өдөр болно гэснээ Гермiona руу хараад,
- Жинни унтаж байгаа болохоор битгий сэрээгээрэй гэлээ.
- Унтаж байгаа гэнээ. Хэрвээ Жинни одоо Гермionaг бүх зүйл ярихыг хүлээгээгүй унтаж байвал би флоббер-өт болог ... гэж Фред Гермiona бүгдэд тавтай нойрсохыг ерөөгөөд дээшээ өгсөхөд аяархан хэлэв.
- Алив Рон, Харри гээд хатагтай Уизли хоёр давхарын унтлагын өрөөний хаалгыг онгойлгосноо,
- Ор луугаа гэв.
- Тавтай нойрсоорой гэж Харри, Рон хоёр ихрүүдэд хэлэв.
- Сайхан зүүд зүүдлээрэй гээд Фред нүд ирмэлээ.

Хатагтай Уизли Харрийн ард хаалга тасхийтэл хаав. Унтлагын өрөө улам харанхуй чийгтэй болсон мэт санагдана. Хананд өлгөсөн хоосон зурагнаас үл үзэгдэх хүн унтаж байгаа мэт удаанаар гүн амьсгалах чимээ гарч байв. Харри унтлагын цамцаа өмсөж шилээ тайлаад чийглэг орондоо ороход, Рон шүүгээний оройд байсан Хэдвиг, Гахай хоёрт уулийн жигнэмэг өгч байв. Тэд далавчаа дэвэн хошуугаараа тас нясхийлгэн тоншино.

- Бид тэднийг шөнө болгон анд явуулж болохгүй гэж Рон тайлбарлаад унтлагын хүрэн цамцаа өмсөж,
- Дамблдор талбайг тойроод хэтэрхий олон ууль нисэх нь сэжигтэй харагдана гэж бодож байгаа юм. Аан тийм л дээ, би мартчихаж гээд хаалга руу очиж түгжив.
- Энэ чинь ямар учиртай юм?
- Кикимерээс болоод гэж Рон хэлэнгээ гэрэл унтраав.
- Намайг эхний шөнө энд унтах үед тэр гурван цагийн үед ирсэн. Зүгээр л байшин дотуур тэнээд явж байдаг юм. Надад итгэ, чи түүнийг унтлагын өрөөнд тэнүүчилж байхыг нь харахыг хүсэхгүй дээ. За тэр ч яахав гээд хөнжилдөө орж шургаснаа Харри луу харлаа.

- Чи юу бодож байна?

Харри Роны юу хэлсэн тухай асуух хэрэг байсангүй.

- Тэд бидэнд бага зүйл хэлсэн болохоор өөрсдөө тааварлах хэрэг гарах нь. Бид зөвхөн бүлгийн гишүүд Волан ... гишүүн элсүүлэх төлөвлөгөөг тасалдуулах гэж байгааг мэдлээ ...

Рон огцом амьсгал авлаа.

- ... де-Морт гэж Харри хатуу төгсгөөд,

- Чи хэзээнээс түүний нэрийг хэлж сурах юм бэ? Сириус, Люпин хоёр хэлж байгаа биз дээ гэв.

Үүнд Рон юу ч хэлсэнгүй.

- Тиймээ, чиний зөв. Гэхдээ бид Уртасгагч чихний тусламжтай бараг бүх зүйлийг мэдэж байжээ. Шинэ гэвэл зөвхөн ...

Тас няс.

- Ёо-о-о!

- Чимээгүй, Рон ээж хүрээд ирнэ.

- Та нар миний өвдгөн дээр газардчихлаа!

- Харанхуйд амар байна гэж бодоо юу?

Харри Фред, Жорж хоёрын бүдэг дүрс Роны орон дээрээс харайхыг харлаа. Дараа нь пүрш хяхтнах чимээ гарч Жорж Харрийн хөлд суухад гудас нь хэдэн инч гулсав.

- За эхэлцгээсэн үү? ... гэж Жорж тэсч ядан хэлэв.

- Сириусын зэвсгийн тухай яриаг уу? гэж Харри асуулаа.

- Тиймээ энэ тухай. Хуучин Уртасгагч чих маань бидэнд энэ тухай мэдэгдээгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой гэж Роны хажууд сууж байсан Фред сэтгэл хангалуун хэллээ.

- Энэ юу байж болох вэ? гэж Харри асуулаа.

- Юу ч байж болно гэж Фред хариулав.

- Гэхдээ Авада Кедаврагаас ч дор зүйл байж болох юм! Үхлээс дор юу байж болох вэ? гэж Рон асуулаа.

- Тийм зүйл л хүмүүсийг бөөнөөр нь алж чадна гэж Жорж хэлэв.
- Магадгүй аллагын онцгой тамлах арга байх гэж Рон айдаст автан хэллээ.
- Түүнд Круциатус байхад л хүмүүсийг өвтгөж чадна. Түүнээс хүчтэй юу ч байхгүй гэж Харри эсэргүүцэв.

Бүгд чимээгүй болоход Харри тэдний ямар зэвсэг тийм аймшигтай байж болох талаар бодож байгааг мэдэж байв.

- Тэр одоо хэнд байж болох вэ? гэж Жорж хэлэв.
- Манай талынханд байгаа гэж найдаж байна хэмээн Рон догдолсон янзтай хэллээ.
- Хэрвээ тийм бол Дамблдорт л байгаа гэж Фред үргэлжлүүлэв.
- Хаана? Хогвартст уу? гэж Рон түргэхэн асуулаа.
- Мэдээж шүү дээ! Тэр тэнд гүн ухааны чулуу хадгалж байсан юм чинь гэж Жорж хэллээ.
- Зэвсэг гүн ухааны чулуунаас том хэмжээтэй байх! гэж Рон тааварлалаа.
- Заавал тийм байх албагүй хэмээн Фред эсэргүүцэв.
- Хэмжээ хүчинд хамаагүй. Жинниг аваад үз л дээ гэж Жорж зөвшөөрлөө.
- Чи юу хэлэхийг хүсээ вэ? гэж Харри асуулаа.
- Чи хэзээ ч түүний шившлэгийг хараагүй юм уу?
- Чшш! Сонсож байна уу! гээд Фред өндийлөө.

Бүгд чимээгүй болов. Шатаар өгсөх хөлийн чимээ дуулдлаа.

- Ээж гэж Жорж хэлээд Фредийн хамт тасхийх чимээ гарган алга болоход Харри орны жин хөнгөрөхийг мэдэрчээ. Хэдэн хормын дараа хаалга чахран нээгдээд хатагтай Уизли тэдний ярьж байгаа эсэхийг чагнав.

Хэдвиг, Гахай хоёр гунигтай гууглав. Шалны хавтан ахин чахрах чимээ гараад хатагтай Уизли дээшээ Фред, жорж хоёрыг шалгахаар явлаа.

- Тэр үргэлж биднийг сэжиглэж байх юм даа гэж Рон харамсангуй хэлжээ. Харри унтаж чадахгүй гэдэгтээ итгэлтэй байв. Энэ үдшийн үйл явдлыг удаан хүлээсэн болохоор бодох хэрэгтэй байлаа. Тэр Ронтой үргэлжлүүлэн ярихыг хүссэн ч

хатагтай Уизли шатаар ар араасаа гишгүүр чохруулан буух нь тод сонсогдлоо ... Унтлагын өрөөний гадна олон хөлтэй амьтан шогшуулан ирэхэд Хогвартсын шидэт амьтны хичээлийн багш Хагрид гарч ирээд «Сайхан байгаа биз. Тийм үү, Харри? Бид энэ жил янз бүрийн зэвсэг судлах болно ...» Тэгтэл Харри руу амьтны үхэр буу шиг толгой эргэхэд ... бөхийлөө.

Дараагийн мэдэрсэн зүйл нь тэр дулаахан хөнжлөөрөө хучин хэвтэж байсан бөгөөд өрөөнд Жоржын чанга хоолой сонсогдов.

- Ээж та нарыг өглөөний цайны дараа зочны өрөөнд хүлээж байна гэсэн. Тэнд маш олон докси байгаа болохоор түүний бодлоор буйдан дороос үүр нь ч олдож магадгүй байгаа юм.

Хагас цагийн дараа Харри, Рон хоёр босож хувцаслаад түргэн хооллож нэг давхрын өндөр адар, бохир саарал ногоон өнгийн ханын цаастай зочны өрөөнд орлоо. Хивсэн дээр алхам болгонд тоос бужигнаж урт ногоон хамба хилэн хөшигний цаанаас үл үзэгдэх сүрэг зөгий дүнгэнэх мэт чимээ гарна. Тэнд хатагтай Уизли, Гермiona, Жинни, Фред, Жорж гээд л бүгд цугларчээ. Тэд толгойдоо алчуур зүүж хамар амаа боосон нь хачирхалтай харагдана. Хүн бүр гартаа том хар шингэнтэй шил барьжээ.

- Нүүрээ далдлаад шүршигчээ авцгаа гэж хатагтай Уизли Рон, Харри хоёрыг харж хэлээд урт нарийхан хөлтэй ширээн дээр байгаа хар шингэнтэй лонх руу заав.

- Энэ бол докси устгагч. Амьдралдаа ийм их шимэгчийг харж байсангүй.

Сүүлчийн арван жил энэ гэрийн үйлчлэгч юу хийж байсан юм бол?

Хэдийгээр Гермiona нүүрээ алчуураар далдалсан байсан ч гэсэн хатагтай Уизли руу зэмлэнгүй харц чулуудахыг Харри тод олж харлаа.

- Кикимер их хөгшин болохоор ийм зүйл ...

- Гермiona чи Кикимерийн хүссэн зүйлээ хийдгийг мэдээд гайхаж байна уу гэж өрөөнд цус болсон хархтай цүнх барьсаар орж ирсэн Сириус хэлээд,

- Би Клювокрылыг тэжээх гэж байгаа юм. Би түүнийг дээр эхийнхээ унтлагын өрөөнд байлгаж байгаа. Харин энэ ширээний хувьд бол ... гэв.

Тэр хархтай цүнхээ буйдан дээр тавиад бичгийн ширээний цоожтой шургуулга рүү бөхийхөд Харри анх удаагаа үл мэдэг чичирэхийг нь олж харлаа.

- Тиймээ, Молли энэ Боггарт гэдэгт би итгэлтэй байна. Гэхдээ ямар ч гэсэн

Грюмыг харахаас өмнө бид зайлуулж чадах байх. Миний ээж үргэлж муу юмнаас болгоомжилдог байсан гэж Сириус цоожны нүх рүү харан хэллээ.

- Би бас тэгж бодож байна, Сириус гэж хатагтай Уизли хэлэв.

Тэд хоорондоо эелдэг хүндэлтгэлтэй ярихад Харри тэдний үдшийн маргаанаа санаж байгаа болохыг нь ойлгож байлаа.

Доор үүдний хонх жингэнэхэд үүнийг дагалдан агшин зуур орь дуу тавих чимээ гарав.

- Хичнээн удаа би түүнд хонх битгий дар гэж хэлэх юм бэ! гэж Сириус уурсан хэлээд хаалга руу явав.

Түүний хөлийн чимээ шат уруудахад хатагтай Блэкийн орилоон байшингаар нүргэлэв.

- Жигшүүртэй амьтад, үзлийн муухай эрлийзүүд манай удмыг бузарлаж байна

...

- Харри минь, хаалга хааж үз гэж хатагтай Уизли хэлэв.

Харри шатны доор юу болсныг сонсохын тулд аль болох удаанаар хаалаа. Хашгиралт намдсаныг үзвэл Сириус эхийнхээ хөргийг хөшгөөр хаасан бололтой. Харри Сириусын хэрхэн хонгилоор явж дараа нь үүдний хаалганы гинж шаржигнуулан нээхэд Кингсли Брустверийн хүнгэнэсэн хоолой гарахыг сонслоо.

- Би саяхан Гестиятай солигдлоо. Тэр Грюмээс үл үзэгдэгч цувыг авсан. Харин би Дамблдорт мэдээлэл үлдээх хэрэгтэй байна ...

Шилэн хүзүүн дээр нь хатагтай Уизлигийн харц мэдрэгдэхэд Харри дургүйхэн хаалга хааж доксийн эсрэг дайралтын бүлэгт нэгдэв.

Хатагтай Уизли буйдан дээр хэвтэж байсан алтан хонгиот Туг үсийн «Гэрийн хортон» гэдэг лавлахыг нээж доксийн хуудсыг гаргалаа.

- Болгоомжтой байцгаарай. Тэдний шүд нь хортой юм байна. Би хэн нэгэнд хэрэг болж магадгүй гээд хорны эсрэг уусмалыг нь авсан.

Тэр дээшээ босож нүүрээ хаагаад гараа зангахад бүгд түүн рүү ойртов.

- Би тушаал өгмөгц даруй шүршиж эхлэнэ шүү. Тэд бидний дундуур нисвэл шингэнээ шууд чиглүүлээрэй. Мэдээ алдахаар нь энэ хувин руу хийгээрэй.

Тэр болгоомжойгоор галын шугам руу харснаа шүршигчээ өргөөд,

- Анхааралтай ... эхлэе! гэв.

Харри хормын дараа хөшигний цаанаас гялалзсан цох шиг далавчаа дүнгэнүүлэн, зүү шиг хурц шүдээ ярзайлгасан докси нисэн гарч ирэхийг харлаа. Жижигхэн үсэрхэг биетэй агаад дөрвөн гарынхаа нударга зангиджээ. Харри түүнийг угтан шингэнээ цацав. Тэр нислэг дундаа хөшөөд хивсэн дээр түсхийтэл уналаа. Харри түүнийг авч хувин руу хийлээ.

- Фред чи юу хийж байна? Даруйхан шүрш! гэх хатагтай Уизлигийн таагүй хоолой гарав.

Харри эргэж харлаа. Фред мултрахыг зүтгэж байгаа доксиг хурууны завсартаа барьжээ.

- Тэгэлгүй яахав! гэж Фред хөгжилтэй хэлээд доксигийн нүүр лүү шүршиж хатагтай Уизлиг эргэн хармагц Харри руу нүд ирмээд халаасандаа хийв.

- Бид түүний хорыг Ажлаас зайлсхийгч зуушиндаа туршиж үзэхийг хүсч байгаа юм гэж Жорж чимээгүйхэн тайлбарлав.

Харри хамрынхаа урд байсан хоёр доксиг шүршээд Жорж руу дөхөж,

- Ажлаас зайлсхийгч зууш гэдэг чинь юу юм бэ? гэж шивнэлээ.

- Өвдсөн юм шиг харагдуулдаг амттан гэж Жорж хэлэхдээ хатагтай Уизлигийн нуруунаас болгоомжилсон харцаа салгасангүй.

- Гэхдээ хүндээр өвдөхгүй зөвхөн ангиас гарахад л хангалттай. Фред бид хоёр энэ зун зохион бүтээсэн юм. Өнгөөр кодолсон хоёр үзүүртэй. Хэрвээ шаргал талыг нь идвэл чамайг хичээлээс шууд эмнэлгийн ор луу аваачина, харин улаан талынхыг нь залгивал ...

- Чи ахин эрүүл сэргэлэн болж ашигтай зүйлд үрэх цагтай болно. Бид зар сурталчилгаандаа ингэж бичиж байгаа гэж Фред шивнээд хатагтай Уизлийн хараанаас гадуур газраас хэдэн докси халаасандаа авч хийлээ.

- Гэхдээ үнэнийг хэлэхэд жаахан ажиллах хэрэгтэй байгаа юм. Биднийг шалгаж үзэхэд жаахан асуудал гарсан.

- Шалгахад гэнээ?

- Бид нар өөрсдөө идсэн. Хоёулаа ээлжлээд л. Ухаан алдуулдаг самар, Хамраас

цус гоожуулагч чихэр турших үед бидний хамраас цус гарсан л даа гэж Фред тайлбарлав.

- Ээж биднийг зодолдсон гэж бодсон хэмээн Жорж хэлэв.

- Тэгэхээр энэ тоглоом чинь алчихгүй биз? гэж Харри сониучирхаад шингэнийхээ цоргыг янзалж буй дүр үзүүлэв.

- Бидэнд үйлчилгээний байр олох боломж алга. Бид одоо захиалгаа шуудангаар авч байгаа. Дараагийн долоо хоногт «Өдөр тутмын Зөнч» сонинд зар сурталчилгаа гаргана гэж Фред бүр нам дуугаар хэлэхэд хатагтай Уизли дайралт хийхээ зогсож духан дээрх хөлсөө арчив.

- Бүгдэд чинь баярласан шүү. Чи санаа зовох хэрэггүй дээ ... Ээж мэдэхгүй. Тэр чиний болон Дамблдорын тухай янз бүрийн худал юм бичиж байгаа учир

«Зөнч» сонин уншихаа больсон гэж Жорж шивнэлээ.

Харри инээвхийлэв. Тэр ихрүүдэд шидэт дэлгүүр нээхэд нь туслахаар гурван шидтэний тэмцээнээс хожсон мянган галлеоноо өгсөн болохоор хатагтай Уизли түүний алхамын талаар мэдээгүйд баяртай байлаа. Тэр хөвгүүдээ тоглоомын дэлгүүрээс илүү зохистой ажил хийлгэхийг мөрөөддөг юм.

Докситэй хөшиг өглөөний ихэнхи цагийг авав. Үд дунд хатагтай Уизли нүүрээ хаасан алчуурыг аваад ядарсан шинжтэй сандал дээр суумагцаа хашгиран үсрэн боссон бөгөөд буйдан дээр хархтай цүнх хэвтэж байв. Хөшиг норж чийгтэн дүнгэнэх чимээ гарахаа больжээ. Тэдний дэргэдэх хувинд ухаангүй докси болон домбонд хар өнндөгнүүд нь дүүрэн байлаа. Фред, Жорж хоёр энэ баялаг руу шунахайран харахад Живоглот тургиллаа.

- Би үүнийг хоолны дараа учрыг нь олж болно гэж бодож байна гэж хатагтай Уизли хэлээд задгай зуухны тавцангийн хоёр талд байгаа тоостой шилэн нүүртэй шүүгээг заав.

Тэнд янз бүрийн хачирхалтай зүйлс дүүрэн байлаа. Зэвэнд идэгдсэн чинжал хутганы цуглуулга, хумс, мушгиралдсан могойн арьс, Харрийн үл мэдэх бичгээр бичсэн өнгөө алдсан мөнгөлөг хайрцаг, хамгийн таагүй нь гэвэл том опал чулуун таглаатай хээ хуартай болор шилэн дотор ямар нэг шингэн дүүрэн байх нь цус байхаас зайлахгүй аж.

Доор ахиад л чанга хонх дуугарлаа. Бүгд хатагтай Уизли руу харцгаав.

- Энд үлдэцгээ. Би ийшээ хачиртай талх аваад ирье гэж тэр хатагтай Блэкийн шинэ орилоон дунд хархтай цүнхийг аваад хэлэв.

Тэр өрөөнөөс гарч хаалга нямбайлан хаалаа. Бүгд дор хэн байгааг харахаар цонх руу ухасхийхэд үүдэнд тогоонууд давхарлан барьсан ширэлдсэн шаргал үстэй зулай харагдав.

- Наземникус байна! Тэр энд яах гэж тогоонуудаа авчирч байгаа юм бол? гэж Гермiona хэлэв.

- Магадгүй нуух гэсэн биз. Тэр намайг харахаа больсон үдшийг санаж байна уу. Хулгайлагдсан тогоо авахаар явсан юм гэж Харри хэллээ.

- Тиймээ, чиний зөв! Ээжид ч энэ таалагдахгүй дээ гэж Фред дуу алдав. Хаалга нээгдэж Наземникус тогоонуудтайгаа алга болов.

Тэд Жоржын хамт хаалга руу явж анхааралтай сонслоо. Хатагтай Блэк хашгирсангүй.

- Наземникус Сириус, Кингсли хоёртой ярилцаж байна. Сайн сонсогдохгүй юм ... Уртасгагч чихийг ашиглаж болохгүй юм болов уу? гэж Фред хөмсөг зангидан хэлэв.

- Болох байх. Би дээшээ сэм гарч хоёрыг аваад ирье гэж Жорж дэмжлээ.

Энэ агшинд дор Уртасгагч чих хэрэггүй жинхэнэ шуурга дэгдлээ. Бүгд хатагтай Уизли хамаг чадлаараа хашгирахыг тод сонсоцгоолоо.

- Бид нар хулгайлсан зүйл хадгалагч биш!

- Би ээжийг над руу орилоогүй байгаад ямар дуртай гээч. Баярламаар зүйл шүү хэмээн Фред сэтгэл хангалуун инээмсэглэхэд нээлттэй хаалгаар хатагтай Уизлигийн хашгиралт өрөөнд цуурайтайв.

- Ямар ч хариуцлагагүй! Бидэнд хулгайлагдсан тогоонуудад санаа тавих л дутаад байна гэж дээ.

- Ямар тэнэг юм бэ! Яах гэж түүнд ийм шалтаг өгдөг байна? Түүний анхаарлыг таталгүй хийх хэрэгтэй байсан юм. Гэхдээ Наземникусыг жижүүрийн байраа орхисон явдалд тэр дайрах шалтгаан хүлээж байсан л даа ... Харин одоо Сириусын ээжийн хоолой гарч байна.

Хатагтай Уизлитай зэрэгцэн шинэ хашгирах чимээ гарахад хонгилын хөргүүд даган орилолдоо. Жорж хаалга хаахыг завдтал түүгээр гэрийн үйлчлэгч шурган орж ирлээ.

Тэр бүсэлхийгээрээ бохир алчуур уясныг эс тооцвол бараг нүцгэн байсан бөгөөд их хөгшин ажээ. Бусад бүх гэрийн үйлчлэгч нарын адил халзан хэдий ч сарьсан багваахайтай адил дэлдэн чихний хажуугаар буурал үс сөрвийнө. Усархаг саарал цус хурсан нүд, хоншоортой адилхан урт хамартай аж.

Үйлчлэгч Харрид анхаарал хандуулсангүй. Тэднийг хараагүй юм шиг хөлөө чирэн бөгтийн аажуухан өнгөрч булан руу явахдаа хамар дороо бах мэлхий адил сөөнгө хоолойгоор бувтнана.

- Өмхий хулгайч байшинд эд зүйлээ авчирч байна, өө хөөрхий эзэгтэй минь хэрвээ мэдсэн бол эндээс хөө гэж хөгшин Кикимерт хэлэх байсан даа. Ай ямар их ичгүүртэй юм бэ, бохир цустангууд, хүн чононууд, удам угсаа доромжилогч, хулгайчид хөөрхий хөгшин Кикимер юу хийж чадах билээ ...

- Сайн уу, Кикимер гэж Фред чанга хэлээд хаалга хаалаа. Гэрийн үйлчлэгч хөшин зогсоод бувтнахаа больж гайхан харлаа.

- Кикимер залуу зочныг харсангүй гэж хэлээд Фредэд тонгойн бөхөлзөв. Дараа нь харцаа хивснээс өргөлгүй,

- Удам угсаагаа доромжилогч бузар хүү чи гэв.

- Юу гэнээ? Уучлаарай чиний сүүлд хэлсэн үгийг чинь сонссонгүй гэж Жорж асуулаа.

- Кикимер юу ч хэлээгүй гээд үйлчлэгч ахин тонгойсноо энэ удаад Жоржыг үгэндээ нэмэн нам дуугаар,

- Аан энэ дүү чинь байх нь. Бас л нэг бузар амьтан биз гэв.

Харри инээх эсэхээ мэдсэнгүй. Үйлчлэгч цэхлэн зогсоод бүгдийг хорсолтойгоор харж хэн ч сонсоогүй гэж бодов бололтой ахин бувтналаа.

- Ичгүүргүй эрлийз хивсэн дээр зогсож байхыг хэрвээ миний эзэгтэй харсан бол уйлах байсан даа, энд бас нэг хүү байна, Кикимер түүнийг нэрийг мэдэхгүй. Тэр энд юу хийж байгаа юм бол? Кикимер мэдэхгүй байна ...

- Энэ бол Харри Кикимер гэж Гермiona түүнд хандан хэлээд,

- Харри Поттер гэлээ.

Кикимерийн усан нүд томорсоноо ууртайгаар,

- Бохир цустан Кикимертэй найз шиг нь ярилаа. Хэрвээ миний эзэгтэй Кикимерийг ийм байдалтай байхыг харсан бол ... гэж бувтналаа.

- Түүнийг бохир цустан гэж бүү нэрлэ! хэмээн Рон, Жинни хоёр нэгэн зэрэг ууртай хэлэв.

- Зүгээр дээ. Тэр ярьж байгаа зүйлээ ойлгохгүй байх шиг байна гэж Гермiona бувтналаа.

- Боль доо, Гермiona тэр юу ярьж байгаагаа ойлгож байгаа гэж Фред хэлээд Кикимер руу таагүй харав.

Кикимер Харри руу нүд салгалгүй харж бувтналаа,

- Энэ үнэн гэж үү? Үнэхээр энэ Харри Поттер гэж үү? Кикимер сорвийг нь харж байгаа болохоор энэ Хар лордыг зогсоосон хүү байх нь. Кикимер түүнийг яаж хийснийг нь гайхаж байна ...

- Бид бүгд гайхаж байна, Кикимер гэж Фред хэлэв.

- Чамд юу хэрэгтэй вэ? гэж Жорж асуулаа. Кикимерийн том нүд түүний зүг хараад,

- Кикимер цэвэрлэж байна гэж зальжин хэлэв.

- Маш зүйтэй гэх дуу Харрийн нурууны ард гарав.

Сириус эргээд иржээ. Тэр хаалганы дэргэд зогсоод үйлчлэгч руу дургүйцсэн байртай харна. Хонгилын шуугиан намдсаныг бодоход хатагтай Уизли, Наземникус хоёр хэрүүлээ гал зууханд үргэлжлүүлж байгаа бололтой.

Сирусыг хараад Кикимер хамраараа шал шүргэх шахам гүнзгий бөхийн ёслов.

- Алив босоодох. Харин одоо юу бодсоноо хэл гэж Сириус уурсан хэллээ.

- Кикимер цэвэрлэж байна. Кикимер эртний сурвалжит Блэкийн байшинд үнэнчээр зүтгэх ёстой ...

- Сурвалжит бохир гэж Сириус хэлэв.

- Эзэн үргэлж тоглож байх юм гэж Кикимер хэлээд ахин бөхийн ёслоод

бувтнасан нь,

- Эзэн бол хүний ач санадаггүй зэвүүн гахай, тэр ээжийнхээ зүрхийг шархлуулсан ... гэв

- Миний ээжид ямар ч зүрх байгаагүй, Кикимер! Хөгшин зөвхөн уур хилэнгээр амьдарч байсан гэж Сириус хашгирав.

Кикимер ахин нэг удаа бөхийн ёсолж,

- Эзний таллаар болог гэж ууртай бувтнаснаа,

- Эзэн бол ээжийнхээ шавартай гуталд ч хүрэхгүй амьтан, өө хөөрхий миний эзэгтэй хэрвээ тэр Кикимер түүнд үзэн ядан урам хугаран зүтгэлж байгааг харсан бол уйлах байсан даа.

- Би чамаас юу хийж байгааг чинь асууж байна. Чамайг цэвэрлэгээ хийх гэж байгаа дүр үзүүлж хаа сайгүй гэтэж явахдаа өрөөндөө хулгайлсан зүйл зөөж байгааг чинь мэдэж байна гэж Сириус хүйтнээр хэлэв.

- Кикимер хэзээ ч эзний сайн сайхан гэрээс юм хулгайлдаггүй гэж үйлчлэгч эсэргүүцээд ахин түргэн бувтналаа,

- Хэрвээ долдугаар зуунаас хойшхи гэр бүлийн хөргийг устгуулвал эзэгтэй Кикимерийг уучлахгүй дээ. Кикимер түүнийг аврах ёстой. Кикимер гэр бүлийн хөрөнгийг удам угсаагаа доромжилогч эзэнд устгуулах боломж өгч болохгүй ...

- Би ч бас тэгж бодож байна гэж Сириус хэлээд эсрэг талын хана руу унтууцан харж,

- Энэ хөргийг хананд үүрд мөнхийн шившлэгээр тогтоосон ч гэлээ би түүнээс ангижирч чадах нь эргэлзээгүй. Харин одоо Кикимер эндээс яв гэв.

Кикимер шууд тушаалыг биелүүлэхгүй байх аргагүй тул Сириусын дэргэдүүр өнгөрөхдөө жигшүүртэй харцаар харж бувтналаа.

- Азкабанаас ирчихээд Кикимерийг ийш тийшээ хөөнө гэнээ өө, хөөрхий миний эзэгтэй тэр хэрвээ гэр нь юу болж хувирсныг харсан бол юу хэлэх байсан бол. Хогийн шаарнууд амьдарч, эрдэнэсийг нь зөөж байна, тэр түүнд хүү байхгүй гэсэн ч, тэр энд зогсоод ярьж байна, алуурчин ...

- Намайг бас алуурчин гэнээ! хэмээн Сириус уурсан хэлээд хаалга хаалаа.

- Сириус түүний толгой зүгээргүй байхаа. Би түүнийг яриаг нь сонсож байгаа

гэдгийг ойлгохгүй байх шиг байна хэмээн Кикимерийг Гермiona өмөөрөв.

- Тэр хэтэрхий удаан ганцаараа байсан юм. Ээжийн хөргийн өгсөн ухаангүй тушаалыг биелүүлээд өөртэйгээ ярьдаг байсан юм. Гэхдээ тэр үргэлж жижигхэн зэвүүн амьтан байсан даа ...

- Хэрвээ түүнд эрх чөлөө өгвөл гэж Гермiona мөрөөдөнгүй хэлэв.

- Түүнд эрх чөлөө өгч болохгүй. Тэр бүлгэмийн тухай хэтэрхий олон зүйл мэднэ. Гайхширал түүнийг алж мэднэ. Чи түүнд энэ гэрийг орхихыг санал болговол хараад байгаарай яг тэгнэ.

Сириус ерөөн дундуур яваад Кикимерийн хамгаалахыг оролдож байсан зураг бүхий өргөн хана руу очлоо. Харри болон бусад нь түүний араас дагалдав.

Хөрөг ихэд хуучиран доксид хэмлүүлсний улмаас өнгөө алджээ. Гэхдээ алтлаг утас нь тод туяарч гэр бүлийн модны мөчирийг харж болохоор байлаа. Харри дундад зууны үеэс ч эртний эд болохыг нь ойлгов. Хамгийн дээд талд том үсгээр «ЭРТНИЙ СУРВАЛЖИТ ЯЗГУУРТАН БЛЭКИЙН ГЭР БҮЛ» гэж бичжээ. Жаахан доод талд нь «цэвэр цус мөнх» гэжээ.

- Чи энд алга байна! гэж Харри дуу алдаад манай үед хамааралтай модны доод мөчрүүдийг анхааралтай судлав.

- Би урьд нь энд байсан. Миний хүндэт ээж намайг гэрээсээ явсны дараа шатаасан. Кикимиер энэ тухай чимээгүй бувтнах тун дуртай байдаг юм гэж Сириус хэлээд жижигхэн дугуй түлэгдсэн нүх рүү заалаа.

- Чи гэрээсээ зугтсан юм уу?

- Арван зургаан настай байхдаа. Миний хувьд хангалттай гэж бодсон.

- Тэгээд хаачсан юм бэ? гэж Харри асуугаад түүн рүү ширтэв.

- Эцгийн чинь гэр рүү очсон. Чиний өвөө эмээ намайг сайхнаар хүлээж авсан.

Яг л төрсөн хүү шигээ. Сургуулийн амралтаа би тэднийд өнгөрүүлж арван долоо хүрээд өөрийн амьдралаа хөөсөн юм. Миний авга ах Альфард надад гэрээслэл үлдээсний төлөө түүнийг бас энэ зургаас зайлуулсан нь гарцаагүй. Ямар ч байлаа гэсэн би өөртөө санаа тавьдаг болсон. Ням гаригийн оройн хоолон дээр би ноён ба хатагтай Поттерын үргэлж хүсэн хүлээж байдаг зочин байлаа.

- Гэхдээ ... чи яагаад ...?

- Эндээс зутсан гэж үү? хэмээн Сириус гашуунаар инээмсэглээд хуруугаараа сэгсгэр урт үсээ самналаа.

- Яагаад гэвэл би эдгээр хүмүүсийг үзэн яддаг байсан юм. Эцэг эх минь цэвэр цусны дон шүглэсэн хүмүүс байсан бөгөөд үргэлж Блэкийн гэр бүлд вангийн удмын цус байгаа гэдэг байлаа ... тэнэг дүү минь сул дорой болохоор тэдэнд итгэсэн юм ... Тэр энэ байна.

Сириус хуруугаараа модны хамгийн доод төгсгөлд бичсэн Регулус Блэк гэсэн нэрийг заалаа. Дэргэд нь төрсөн болон үхсэн сар өдөр байлаа (түүнээс хойш арван таван жил өнгөрчээ).

- Регулус надаас залуу байсан. Тэр тэдний сайн хүү нь байлаа.

- Гэхдээ тэр үхсэн.

- Тиймээ. Ухаангүй тэнэг амьтан ... Тэр Үхэл залгигч байсан юм гэж Сириус хэлэв.

- Чи тоглож байна уу?

- Боль доо, Харри чи энэ байшинг хараад манай гэр бүлд ямар шидтэнгүүд байдаг талаар хангалттай ойлголттой болохоор болсон.

- Чиний ... чиний эцэг эх чинь бас Үхэл залгигчид байсан уу?

- Үгүй дээ, үгүй гэхдээ надад итгэ тэд Волдемортын шидтэнгүүдийг цэвэрлэх бодлогыг зөв гэж боддог байсан. Тэд бүх зүрх сэтгэлээрээ шидтэнгүүд маглуудаас ангижирахыг дэмждэг байсан. Зөвхөн тэд ч биш. Олон хүмүүс Волдемартыг үнэн царайгаа үзүүлэхээс өмнө үүнийг дэмждэг байсан юм ... Гэхдээ эцэг эх минь түүний эрх мэдлийн хүслийг хараад хулчийсан. Би тэднийг Регулусыг жинхэнэ баатар гэж боддог байсан гэдэгт мөрийцсөн ч болох байна.

- Түүнийг мракоборец алсан уу?

- Үгүй. Үгүй түүнийг Волдеморт устгасан. Эсвэл Волдемартын тушаалаар устгасан байх. Би Регулусыг алах чухал шалтгаан Волдемортод байсан гэж бодож байна. Би түүнийг үхсэн хойно ямар юмтай зууралдсанаа ойлгоод буцаж гарахыг хичээсэн гэдгийг мэдсэн. Гэхдээ Волдеморт өршөөл уучлалыг мэдэхгүй. Үйлчил эсвэл үхэл.

- Үдийн хоол гэх хатагтай Уизлийн дуу сонсогдов.

Тэр гартаа шидэт саваагаа бариад үзүүрт нь том тавиуртай хачиртай талх, бялуу тэнцүүхэн тогтоожээ. Түүний царай улаан байхыг бодвол их ууртай байгаа бололтой. Бүгд түүн руу ухасхийхэд Харри Сирустэй зураг руу бөхийсөн хэвээр үлдэв.

- Би хичнээн жил үүнийг хараагүй болохоо санахгүй байна. Энэ бол Финеас Найжелус ... миний өвөг эцэг ... Хогвартсын захирал байсан юм. Араминта Мелифлуа ... миний эхийн үеэл эгч ... ид шидийн яаманд маглуудыг агнах хуулийг батлуулахыг оролдож байсан юм. Харин энэ бол хүндэт нагац эгч Элладора. Түүний үеэс эхлэн цай зөөхөд хэт хөгшин гэрийн үйлчлэгчдийн толгойг нь авах уламжлал тогтсон юм даа ... Гэр бүлд хэн нэгэн шоовдорлогдсон хүн байдаг. Жишээ нь Тонкс. Ийм учраас л Кикимер түүний тушаалыг биелүүлэхгүй байдаг биз ...

- Тонкс та хоёр хамаатан юм уу? гэж Харри гайхан асуулаа.

- Тиймээ түүний ээж Андромеда миний хайртай үеэл эгч байгаа юм. Андромедаг эндээс бас зайлуулсан ... гэж Сириус хэлээд зураг руу ширтэв.

Тэр хоёр эмэгтэй хүний нэрэн дундах шатаасан дугуй нүхийг заалаа. Беллатриса, Нарцисса.

- Андромедын дүү нар цэвэр цусны шидтэнтэй гэрлэсэн хэдий ч тэр магл Тед Тонкстой гэрлэсэн учир ...

Сириус савааны үзүүрээ шатсан хэсэгт хүргэн гашуунаар инээмсэглэв. Харри Андромедийн баруун талын нэр рүү харж байсан учир инээмсэглэсэнгүй. Нарцисса Блэк болон Люциус Малфойн хоёр алтан утас холбогдон тэндээс гарсан алтан шугам нь Дракогын нэрэнд хүрч байлаа.

- Чи Малфойн хамаатан юм уу?

- Бүх цэвэр цусны гэр бүлүүд хоорондоо холбоотой. Хэрвээ чи хүү юмуу охиноо зөвхөн цэвэр цусны шидтэнтэй гэр бүл болгохыг хүсвэл сонголт хязгаартай байдаг юм. Бидэн шиг бараг үлдсэнгүй.

Гэхдээ Харри Андромедагийн шатсан нүхний зүүн тал дахь Беллатрис Блэк гэсэн нэрийг харлаа. Тэр Родольфус Лестрейнжтэй холбогдож байв.

- Лейстрэнж ... гэж Харри чанга уншив. Энэ нь нэр хаа нэгтээ сонссон юм шиг санагдах ажээ. Гэхдээ хаана гэдгийг нь мэдсэнгүй. Тэд хачирхалтай таагүй мэдрэмжийг төрүүлэх аж.

- Тэд Азкбанд байгаа гэж Сириус товч хэлэв. Харри түүн рүү сониучирхан харлаа.

- Беллатриус болон түүний нөхөр Родольфус тийшээ бага Барти Краучын хамт илгээгдсэн юм. Тэдэнтэй Родольфусын ах Рабастан хамт байсан гэж Сириус ширүүн хэлэв.

Тэгэхэд Харри саналаа. Тэр Беллатрис Лейстрейнжийг Дамблдорын оюун ухааны цүнхээлд харсан юм байна. Өндөр хар үстэй хүнд зовхитой эмэгтэй шүүгчдийн өмнө зогсоод Волдеморт эргэж ирнэ түүний уналтын дараа үнэнч байсны төлөө шагнана гэж байсан.

- Чи надад хэзээ ч түүний тухай ... ярьж байгаагүй ...

- Миний үеэл эгч гэж үү?. Тэр миний гэр бүл биш болохоор хамаагүй. Би түүнийг чиний насан дээр ч хардаггүй байсан. Хэрвээ түүнийг Азкабанд явуулсан өдөр харсаныг эс тооцвол. Намайг тийм хамаатнаараа бахархана гэж бодож байна уу?

- Уучлаарай. Би хүсээгүй ... Би зөвхөн гайхсандаа ... гэж Харри түргэн хэлэв.

- Уучлал гуйх зүйл болоогүй. Эндэх надад таалагдаггүй юм. Би хэзээ ч энэ байшинд буцаж ирнэ гэж бодож байсангүй гэж Сириус бувтнаад эргэж харан гараа халаасандаа шургуулав.

Харри түүнийг маш сайн ойлгож байлаа. Тэр хэрвээ насанд хүрсэн шидтэн болвол Улаан модон гудамжны дөрөвдүгээр байшинтай холбоотой байх хэдий ч хэзээ ч тийшээ амьдрахаар эргэж очихгүй.

- Мэдээж штабын байрны хувьд тохиромжтой газар. Миний эцэг амьдарч байх үедээ гэрээ аюулгүй байлгахын тулд хамгаалалтын шид хэрэглэсэн юм. Түүнийг эвдэх боломжгүй учраас маглууд харах юмуу хүссэн ч ийшээ орж ирж чадахгүй. Харин одоо Дамблдор өөрийн хамгаалалтаа нэмсэн болохоор үүнээс илүү аюулгүй газрыг олох аргагүй болсон. Дамблдор бүлгийн нууцыг хадгалагч учраас хаана байрладгийг нь хэлээгүй тохиолдолд хэн ч олж чадахгүй. Ийм учраас л Дамблдорын гараар бичсэн хаягийг Грюм чамд үзүүлсэн юм. Хэрвээ миний эцэг эх одоо тэдний гэрийг яаж ашиглаж байгааг харсан бол ... Ээжийн хөрөг чамд төсөөлөл өгөхгүй байна уу гэж Сириус инээд алдав.

Хормын турш тэр хөмсөг зангидан чимээгүй байснаа дараа нь санаа алдан,

- Би эндээс хааяа нэг гарч ямар нэг ашигтай юм хиймээр байна. Би Дамблдороос чамайг ид шидийн яам руу хүргэж болох эсэхийг асуухаас. Чи энэ тухай юу гэж бодож байна? гэв.

Харрийн дотор палхийхэд тоостой хивс рүү цөмрөөд орох шиг санагджээ. Ид шидийн яамны мэдэгдлийн тухай өчигдөр оройн хоолноос цааш санасангүй. Ойр дотнын хүмүүстэйгээ уулзсан сэтгэл хөдлөлд автаад таг мартжээ. Сириусын үгийн дараа айдас ахин нөмрөн авлаа. Тэр Гермiona болон Уизличууд хачиртай талх идэхийг хараад хэрвээ тэд түүнгүй Хогвартс буцна гэвэл ямар санагдахыг төсөөлөв.

- Санаа зовох хэрэггүй. Би чамд ямар ч муу зүйл тохиолдохгүй гэдэгт итгэлтэй байна. Олон улсын шидтэнгүүдийн нууцлалд шидтэн өөрийн амьдралаа аврахын тулд шид хэрэглэхийг зөвшөөрсөн заалт байдаг юм гэж Сириус хэлэхэд Харри түүн рүү загалмайлсан эцэг нь ширтэж байсныг ойлгов.

- Гэхдээ намайг хөөчихвөл яах вэ. Ийшээ буцаж ирээд чамтай амьдарч болох уу? гэж Харри аяархан асуув.

Сириус гашуудалтай инээмсэглэв.

- Харцгаая л даа.

- Би Дурслийнхан руу буцаах вий гэдэгт санаа зовж байна.

- Хэрвээ чи энэ гэрт байна гэвэл тэдэнд муу юм болно гэж Сириус баргар хэллээ.

- Сириус, Харри та хоёр яарахгүй юу ч үлдэхгүй нь байна гэж хатагтай Уизли дуудав.

Сириус хүндээр санаа алдаад зураг руу хөмсөг зангидан харахаа больж Харригийн хамтаар хачиртай талх руу явлаа.

Үдээс хойш шилэн хаалгатай шүүгээг цэвэрлэх үед Харри яамны дуудлагын тухай бодохгүй байж чадсангүй. Аз болоход тоостой шургуулгуудад байгаа олон тооны зүйлсийг цэвэрлэхэд багагүй анхаарал шаардагдав. Сириус мөнгөлөг хайрцганд хуруугаа хатгуулахад хормын дараа түүний бугуй цустай бээлий өмссөн юм шиг болов.

- Зүгээр дээ гэж Сириус гараа сонирхон харангаа хэлээд савааныхаа үзүүрийг арьсандаа хүргэн жирийн төрхөнд нь оруулав.

Тэд хайрцагыг шүүгээнээс буулгасан хог новшийн уут руу хийв. Харри Жоржын хэрхэн нямбайлан гартаа барьсан алчуур дороо хайрцагыг хулгайлан докситой халаасандаа хийхийг харлаа.

Харри тавиур дээрээс мөнгөлөг чимхүүртэй төстэй таагүй мөнгөн эдлэл авахад гар дээгүүр нь аалз аятай гүйж арьсыг нь цоолохыг оролдов. Сириус түүнийг барьж аваад «Язгууртан шидтэний уг гарал» гэдэг номоор хэмх цохилоо. Шүүгээнээс олон тооны зүйл илрүүлсний дотор намуухан муу ёрын ая гаргадаг эгшигт хайрцаг байсан бөгөөд хэрвээ Жинни тагийг нь хаагаагүй бол бүгд нозоорон унтах байлаа, Тэдний хэн нь ч оннгойлгож чадаагүй хүзүүний зүүлтний гуу, Сириусын өвөөгийн яаманд байгуулсан гавъяаны төлөө авсан Мерлиний нэгдүгээр зэргийн одонтой тоостой хайрцаг гарав.

- Тэр үүнийг алтаар худалдаж авсан байх гэж Сириус зэвүүцэнгүй хэлээд одонг хогийн савны уутанд хийлээ.

Өрөөнд хэдэнтээ Кикимер орж ирээд эдгээр зүйлсээс хулгайлахыг оролдох бөгөөд баригдах бүрдээ айшигтай хараал бувтнаж байлаа. Сириус түүний гараас Блэкийн сүлдтэй том бөгжийг булааж авах үед Кикимер нулимс асгаруулан Сириусыг Харрийн хэзээ ч сонсож байгаагүй үгээр булав.

- Энэ миний эцгийн юм. Кикимер түүнд ээжид үнэнч зүтгэдэг шигээ байгаагүй ч өнгөрсөн долоо хоногт хуучин өмдийг нь хулгайлахыг оролдоход нь барьсан гэж Сириус хэлээд бөгжийг бас уутруу хийлээ.

Хатагтай Уизли тэднийг дараагийн хоёр өдөр ажлаар дарав. Гурван өдрийн дараа зөвхөн зочны өрөө цэвэрлэгдэж дуусав. Тэндэх таагүй зүйлээс зөвхөн Блэкийн гэр бүлийн мод хананаас устгах гэсэн бүх оролдлогыг эсэргүүцэн үлдлээ. Грюм энэ хугацаанд штабын байранд үзэгдсэнгүй.

Зочны өрөөний дараа нэг давхарын гал зуух руу орлоо. Тэнд шүүгээн дээр дийзний хэмжээтэй аалз бужигнаж байлаа (Рон түргэн цай хийж аваад хагас цаг эргэж ирсэнгүй). Блэкийн овгийн сүлд бүхий шаазангуудыг Сириус бүдүүлгээр хүүдийнд хийсэн бөгөөд өнгө нь гандсан мөнгөн жаазтай хуучин гэрэл зургуудыг энэ ч бас тойрсонгүй. Жаазны шилийг хагалахад тэд муухай орилж байлаа.

Снегг энэ ажлыг «цэвэрлэгээ» гэж нэрлэж байсан ч Харрийн бодлоор бол байшинтай хийсэн жинхэнэ дайн байлаа. Гэрийн үйлчлэгч өмнөхийн адилаар тэдний цугласан газраар явж хогийн саванд хийх ууттайгаас хулгайлахыг оролдон бувтналт нь илүү

доромжилсон өнгө аястай болж байлаа. Сириус түүнийг алчуураар шавхуурдан хөөв. Кикимер түүн рүү усархаг нүдээрээ харснаа,

- Эзэн хүссэн зүйлээ хийж болно гээд эргэж харснаа чангаар,

- Гэхдээ эзэн Кикимерийг хөөж чадахгүй, Кикимер тэдний юу нууж байгааг мэднэ өө тийм л дээ, эзэн Хар лордын эсрэг тэмцэх хуйвалдаанд эрлийзүүд, урвагчид, нийгмийн шаарнуудтай оролцож байгаа ...

Сириус Гермionaгийн эсэргүүцлийг хайхралгүй Кикимерийн алчуураас барьж аваад өрөөнөөс хүчтэй түлхэн гаргав.

Өдөрт хэдэн удаа хаалганы хонх дуугарч түүнийг дагалдан Сириусын ээж орилох бөгөөд Харри болон түүний нөхөд хатагтай Уизлийн ажил дуудахаас өмнө ямар нэг юм олж сонсохыг хичээсэн ч маш бага зүйл олж сонсчээ. Снегт нэг бус удаа ирсэн ч Харри түүнтэй нүүр тулгарсангүйдээ санаа амарлаа. Бас нэг удаа Харри хувиргалын багш профессор МакГонагаллыг харсан бөгөөд маглуудын пальто өмссөн нь маш хачирхалтай харагдаж байлаа. Гэхдээ тэр удаан саатсангүй. Заримдаа ирэгсэд туслахаар үлдэж байв. Жишээ нь Тонкс тэдэнтэй мартагдашгүй өдрийг өнгөрүүлэнгээ дээд давхарын жорлонгийн өрөөнөөс хөгшин хий үзэгдлийг илрүүлжээ. Люпин Сириусын байшинд амьдрах хэдий ч бүлгийн нууц ажлаар оролдох бөгөөд тэдэнд зогссон цаг засахад тусалж, ирэсдийг явсны дараа цоож түгжих таагүй зуршилтай болоод байв. Наземникус алдаагаа засахыг хичээн хатагтай Уизлийн нүдэн дээр Ронд хувцасны шүүгээнээс хувцаснууд гаргахад туслав.

Хэдийгээр Харри урьдын адил муу унтаж цоожтой хаалгатай хонгил зүүдэлж сорви нь хатгуулж байсан ч гэлээ зуны турш байгаагүйгээрээ хөгжилтэй байлаа. Тэр завгүй байсан нь сайн хэрэг. Гэхдээ энэ бүхэн дуусах үед хүчгүй болж адарт сүүмэлзэх сүүдрийг харан орон дээрээ хэвтээд ид шидийн яамны дуудлагын тухай бодолдоо буцдаг байв. Хэрвээ түүнийг хөөчихвөл гэсэн айдас дотор нь зүү орсон юм шиг хатгуулна. Айдас их байсан болохоор Рон, Гермoина хоёртой ирээдүйн тухай ярьж ч зүрхлэхгүй байлаа. Тэд түүний сэтгэл санааг ойлгож байсан болохоор энэ сэдвээр ярихаас зайлсхийн санаа зовсон харцаар харцгаана. Заримдаа тэр ид шидийн яамнаас шидэт савааг нь хоёр хугалаад Дурслийнх руу буцаах шийдвэр гаргаж байна гэж хүртэл төсөөлж байлаа ... Гэхдээ түүнд ийм зүйл тохиолдохгүй. Ингэж хатуу шийджээ. Тэр ийшээ Гриммогийн байшин руу ирж Сириустэй амьдрах болно.

Үдэш бүгд оройн хоолны ширээнд суусан хойно хатагтай Уизли түүн рүү

чимээгүйхэн эргэж хараад,

- Харри, би маргааш өглөө гэхэд хувцасыг чинь угаагаад индүүдчихнэ. Чи өнөөдөр толгойгоо угаасан чинь дээр байх. Анхны сэтгэгдэл олон зүйлийг төрүүлдэг юм гэлээ.

Харрид гэдсэн дотор тоосго уначих шиг санагджээ. Рон, Гермиона, Фред, Жорж, Жинни нар чимээгүйхэн түүн рүү харна. Харри толгой дохиод зажлахыг хичээсэн ч залгиж чадсангүй.

- Би тийшээ яаж хүрэх юм бэ? гэж хатагтай Уизлигаас асуулаа.

- Артур чамайг ажил руугаа аваад явна гэж тэр аяархан хэлэв. Ноён Уизли урамшуулсан байртай инээмсэглээд,

- Хурал эхэлтэл миний өрөөнд сууж бай гэлээ.

Харри Сириус руу хараад асуулт асуух гэсэн ч хатагтай Уизли,

- Профессор Дамблдор Сириус чамайг хүргэх нь сайхан санаа гэж бодохгүй байгаа гэв.

- ... түүний зөв гэж бодохгүй байна хэмээн Сириус шүд зуун хэлэв. Хатагтай Уизли хөмхийгөө зуулаа.

- Дамблдор чамд хэзээ энэ тухай хэлсэн юм бэ? гэж Харри Сириус руу харан асуув.

- Тэр өнгөрсөн шөнө чамайг унтаж байхад энд ирсэн гэж ноён Уизли хариулав.

Сириус бодлогоширон сэрээгээрээ төмс хатгалаа. Харри таваг руугаа ширтэв. Дамблдор гэрт байсан хэрнээ түүнтэй уулзаагүй гэдэг нь юунаас ч илүү муу санагдлаа.

БҮЛЭГ 7: ИД ШИДИЙН ЯАМ

Маргааш нь Харри өглөөний тав хагаст чихэнд нь хүн хашгирсан аятай огцом сэржээ. Хэдэн хором хөдөлгөөнгүй хэвтгэл яамны дуудлагын тухай бодол тархийг нь эзэмдэв. Дараа нь үүнийг тэвчих хүчгүй болоод өндийж шилээ зүүлээ. Хатагтай Уизли орных нь дэргэд өчигдөр орой угааж индүүдсэн жинс футболкыг нь тавьжээ. Харри яаран хувцаслахад ханан дээрх хоосон зураг хөхөрлөө.

Рон нуруугаараа дээшээ харж хэвтээд амаа ангайн бөх унтаж байлаа. Тэр Харриг өрөөн дотуур явж хаалга аяархан хаахад хөдөлсөнгүй. Ронтой өнгөрүүлсэн сүүлчийн үдшийн тухай болон Хогвартст хамт сурахгүй талаар бодохгүйг хичээн Харри шатаар чимээгүй уруудаж Кикимерийн удмын олон толгойнуудыг өнгөрөөд гал зуух руу очив.

Тэр гал зуух хоосон гэж бодсон ч хаалганд дөхөж очоод намуухан дүнгэнэх хоолой сонслоо. Хаалга түлхээд ноён ба хатагтай Уизли, Сириус, Люпин, Тонкс нар түүнийг хүлээн суухыг олж харлаа. Хатагтай Уизли ягаан халат өмсөж бусад нь бүрэн хувцаслажээ. Харриг хараад хатагтай Уизли үсрэн босч,

- Өглөөний хоол гэж хэлээд шидэт саваагаа аван ханан зуух яаран очлоо.
- Ө-глөөний мэнд, Харри. Сайхан нойрсов уу? гэж Тонкс эвшээв. Энэ удаад түүний үс цайвар буржгар болжээ.
- Тиймээ гэж Харри хэлэв.
- Харин би дугхийж чадсангүй. Нааш ирээд суу гэж тэр ахин эвшээж хэлэв. Тэр түүнд хажуу дахь сандлаа дөхүүлж өглөө.
- Юу идэх вэ, Харри? Будаа юу? Утсан загас уу? Өндгөн жаврай юу? Шарсан талх уу? гэж хатагтай Уизли асуув.
- Зүгээр л шарсан талх их баярлалаа гэж Харри хэлэв. Люпин түүн рүү хараад дараа нь Тонкст хандан,
- Чи Скримжерын тухай хэлэх гэж байсан бэ? гэлээ.
- Аан ... тийм л дээ түүнтэй болгоомжтой байх хэрэгтэй. Тэр Кингсли бид хоёроос эвгүй асуулт асуусан ...

Харри ярианд оролцох хэрэггүй болсонд санаа амарчээ. Түүний дотор бүх зүйл хөрвөж байлаа. Хатагтай Уизли урд нь хоёр зүсэм шарсан талх жимсний чанамалын

хамт тавилаа. Тэр идэхээр хазсан ч хивс зажлах гэж байгаа аятай зүйл боллоо. Хатагтай Уизли дэргэд нь суугаад футболкных нь шошгыг дотогш чихэж мөрөн дээрх үрчлээг нь тэгшилэхэд таагүй санагдав.

- ... би Дамблдорто маргааш шөнө гарч чадахгүй гэж хэлэх гэсэн юм. Маш их ядарлаа гээд Тонкс том эвшээлээ.

- Би чамайг орлоё. Илтгэлээ хэзээ ч дуусгасан болно гэж ноён Уизли амлав.

Ноён Уизли жанчныхаа оронд судалтай нарийхан өмд, хуучин арьсан хүрэм өмсчээ. Тэр Тонкс, Харри хоёр луу харлаа.

- Хэр байна даа? Харри мөрөө хавчлаа.

- Бүх зүйл түргэн дуусна. Хэдхэн цаг болоход чи цагаатгагдана гэж ноён Уизли зоригжуулав.

Харри чимээгүй байлаа.

- Хурал манай давхарт Амелий Боунсын өрөөнд болно. Тэр ид шидийн хуулийг албадан мөрдүүлэх хэлтсийг толгойлдог юм. Тэр чамд асуулт тавих байх.

- Амелий Боунсаас айх хэрэггүй, Харри. Тэр их шударга болохоор чамайг сонсоно гэж Тонкс чухалчлан хэлэв.

Харри толгой дохисон ч өмнөхийн адил үг хэлэх хүчгүй болсон байлаа.

- Толгойгоо унжуулах хэрэггүй. Эелдэг байж баримтанд түшиглээрэй гэж Сириус хэлэв.

Харри ахиад л толгой дохилоо.

- Хууль чиний талд байгаа. Насанд хүрээгүй шидтэн аюул учирсан тохиолдолд ид шид хэрэглэх эрхтэй байдаг юм гэж Люпин аяархан хэлэв.

Харри шилэн хүзүү нь гэнэт хүйт оргихийг мэдрэв. Тэр хувиргах шидийн талаар бодсон ч дараа нь хатагтай Уизли үсийг нь норгон самнахаар дайралтанд орсныг ойлгов. Тэр үсийг нь толийлгохыг оролдоод,

- Арзайхыг нь болиулж болдоггүй юм уу? гэж цөхрөн асуув. Харри толгой сэгсэрлээ.

Ноён Уизли цагаа харснаа Харри руу харцаа өргөв.

- Явах хэрэгтэй гэж бодож байна. Бид жаахан эрт очоод яаман дээр хүлээвэл

дээр байх.

- За гэж Харри хэлээд талхаа тавьж бослоо.
- Бүх зүйл сайхан болно, Харри гэж Тонкс итгүүлээд мөрөн дээр нь алгадав.
- Амжилт хүсье. Бүх зүйл бүтнэ гэдэгт итгэлтэй байна хэмээн Люпин хэллээ.
- Хэрвээ үгүй бол би Амелий Боунстай өөрөө учраа олно гэж Сириус баргар хэлэв.

Харри дүйгүйхэн инээмсэглэв. Хатагтай Уизли түүнийг тэврээд,

- Бид чамайг дэмжиж байгаа шүү гэлээ.
- Баярлалаа.

Тэр ноён Уизлиг даган шатаар өгсөж үүдний хонгилд гарлаа. Хөшигний цаана Сириусын эхийн хөрөг хурхирна. Ноён Уизли түгжээг тайлж хаалга нээгээд өглөөний бүрхэг хүйтэн агаарт гарлаа.

- Та ажилдаа явган явдаггүй биз дээ? гэж Харри тэднийг хашаанаас түргэн гарахад асуулаа.
- Үгүй дээ, үргэлж шилждэг юм. Гэхдээ чиний хувьд боломжгүйгээс хойш бид шидгүй явсан нь дээр ... Энэ нь чамайг буруутгаж байгаа зүйлийн эсрэг сайхан сэтгэгдэл төрүүлэх болно.

Тэд цааш явцгаахад ноён Уизли гартаа хүрмээ барилаа. Харри түүний шидэт саваагаа нууж байгааг ойлгож байв. Гудамжинд бараг хүнгүй байсан ч газар доорх жижигхэн цахилгаан тэрэгний буудал дээр өглөөний зорчигчид дүүрэн байлаа. Дэргэдүүр нь өдөр тутмын ажилдаа яваа маглууд өнгөрөхөд ноён Уизли сэтгэл хөөрлөө арайхийн барилаа.

- Ямар гайхамшигтай юм бэ. Гайхалтай өвөрмөц гэж хэлээд тасалбар шалгадаг автоматыг заалаа.
- Тэд эвдэрчихсэн юм байна гэж Харри хэлээд хаяг руу нь дохив.
- Тэгсэн ч гэсэн ... гэж ноён Уизли хэлээд бахадсан харцаа салгасангүй.

Тэд нойрмог худалдагчаас тасалбар худалдан авахад (Ноён Уизли маглуудын мөнгийг ялгаж чадахгүй болохоор Харри энэ үүргийг өөртөө хүлээжээ) таван хормын дараа галт тэргэнд орж Лондонгийн төв рүү явлаа. Ноён Уизли сэтгэл

түгшсэн байртай цонхны дээдэх буудлын схем зургийг харж байв.

- Ахиад дөрвөн буудал үлдлээ, Харри ... Одоо гурван буудал ... Ердөө хоёр зогсох үлдлээ, Харри ...

Галт тэрэг Лондонгийн төв буудал дээр зогсоход тэд костюм өмсөж дипломат цүнх гартаа барьсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн урсгал дундуур гарлаа. Тэд урсдаг шатаар өгсөн тасалбар шургуулдаг хаалтыг нэвтрэн (Ноён Уизли нүх түүний тасалбарыг залгихыг баяртайгаар харлаа) өндөр сүрлэг байшин барилга бүхий машин пиг дүүрсэн өргөн гудамжинд гарлаа.

- Бид хаана байна? гэж ноён Уизли мэгдсэн байртай асуухад Харрийн зүрх палхийгээд явчихав. Ноён Уизли үнэхээр буудлын зургийг ялгалгүй өөр газар ирсэн юм биш байгаа даа? Гэвч агшины дараа,

- Аан тийм л дээ ... Ийшээ, Харри гээд зэргэлдээх гудамж руу аваачлаа.

- Уучлаарай, би урьд нь ийшээ галт тэргээр ирж байгаагүй болохоор маглуудын зүгээс бүх зүйл өөр харагдах юм. Үнэнийг хэлэхэд би анх удаа зорчигчийн хаалгаар орох гэж байна.

Тэд цаашаа явахад том барилгууд цөөрөв. Эцэст нь хэдэн зүдэгхэн албан байгууллагын байр, гаднаа хог овоолсон уушийн газартай гудамжинд хүрэв. Харри ид шидийн яамыг ийм үзэмжгүй газар байдаг гэж төсөөлж чадсангүй.

- Ирлээ гэж ноён Уизли хөгжилтэй хэлээд ханан дээр нь элдэв зүйл сараачсан улаан телефон утасны бүхээгийг заалаа.

- Чиний дараа, Харри гээд тэр хаалга нээлээ.

Харри гайхширан орлоо. Ноён Уизли араас нь орж хаалга хаав. Дотор давчуу ажээ. Харри ямар нэгэн танхай этгээд эвдэлсэн бололтой мурийсан утасны аппарат руу луу харлаа. Ноён Уизли дэргэдүүр нь гар сунгаж харилцуурыг авав.

- Ноён Уизли энэ утас ажиллахгүй байх хэмээн Харри хэлэв.

- Үгүй дээ, үгүй би сайн ажиллана гэдэгт итгэлтэй байна гэж тэр эсэргүүцээд харилцуурыг барьж тоо руу хараад,

- Алив зургаа ... хоёр ... дөрөв ... ахиад дөрөв ... ахиад хоёр хэмээн дугаарыг цуглуулан хийв.

Тоо аяархан чагхийн байрандаа ирэхэд бүхээгт эмэгтэй хүний тунгалаг хоолой

сонсогдлоо. Гэхдээ ноён Уизлийн барьж байсан харилцуураас биш дэргэд нь үл үзэгдэх эмэгтэй зогсож байгаа юм шиг тод хэлэв.

- Ид шидийн яаманд тавтай морилоорой. Нэр болон ирсэн зорилгоо хэлнэ үү.
- Э ... гэж ноён Уизли харилцуураар ярих эсэхээ мэдсэнгүй. Тэр ярьдаг хэсгийг нь чихэндээ ойртуулаад,
- Артур Уизли, эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтэс. Харри Поттерыг дуудлаганд хүргэж ирлээ ...

- Баярлалаа. Орохдоо тэмдгээ жанчны энгэрт зүүнэ үү.

Ямар нэг юм шархийхэд Харри зоос гарч ирдэг нүхээр юм цухуйхыг харлаа. Энэ нь дөрвөлжин мөнгөн тэмдэг бөгөөд дээрээ «Харри Поттер. Сахилгын дуудлага» гэж бичигтэй ажээ. Тэр тэмдгийг энгэртээ зүүлээ. Дараа нь ахин эмэгтэй хүний хоолой гарлаа.

- Хүндэт зочдоо, та бүхэн орохын өмнө саваагаа жижүүрийн шидтэнд бүртгүүлэнэ үү.

Бүхээгийн шал чичирсэнээ алгуур доошоо орлоо. Харри явган зам хэрхэн шилний цаана өсөн нэмэгдсээр харанхуйд орохыг түгшин харлаа. Нэг хэсэгтээ юу ч харагдахгүй болов. Чихэнд нь зөвхөн утасны аппарат газар дор дүнгэнэх чимээ сонсогдож байлаа. Ойролцоогоор хормын дараа хөл дор алтлаг туяа татав. Гэрэл өсөн нэмэгдсээр эцэст нь бүх биеэрээ гарахад нүдээ анивчлаа.

- Ид шидийн яамнаас таньд өдрийг сайхан өнгөрүүлэхийг хүсч байна хэмээн эмэгтэй хүний хоолой хэллээ.

Бүхээгийн хаалга нээгдэхэд ноён Уизли гарлаа. Харри түүний араас гарахдаа гайхсандаа амаа ангайжээ.

Тэд нүүр харагдтал өнгөлсөн маш урт хар өнгийн паркетан шалтай сүр жавхлантай танхимын төгсгөлд зогсож байлаа. Солонгорсон хөх өнгөтэй адарт алтлаг тэмдгүүд гялалзаж хөдлөх нь аварга том мэдээллийн самбар адил санагдана. Хананд гөлгөр хар модоор хийсэн олон тооны ханан зуухнууд байлаа. Хором тутамд зүүн талын ханан зуухнаас сулхан исгэрх чимээ гаран шидтэнгүүд гарч ирэх аж. Баруун талын ханан зууханд яамнаас гарах гэсэн шидтэнгүүдийн багахан цуваа үүсчээ.

Танхимын төв хэсэгт голдоо алтан хөшөөнүүдтэй усан оргилуур байлаа. Голд нь

өндөр сүр жавхлантай шидтэн саваагаа тэнгэр лүү өргөн зогсчээ. Түүнийг тойроод үзэсгэлэнтэй шидтэн эмэгтэй, хүн морь, албин, гэрийн үйлчлэгч зогсож байлаа. Тэд голын шидтэн рүү хүндэтгэсэн маягтай харах аж. Шидтэний савааны үзүүрээс, хүн морины сумнаас, албингийн малгайны оройноос, үйлчлэгчийн чихнээс гялалзсан ус шоржигнон олгойдно. Зуугаад шидтэнгүүд өглөө эртийн баргар царайлан танхимын төгсгөл дэх алтан хаалга руу явж байв.

- Тийшээ гэж ноён Уизли хэлэв.

Тэд яамны ажилчдийн урсгалтай нэгдлээ. Зарим нь овоолоостой цаас, элэгдсэн цүнх барьсан байх агаад явуут дундаа «Өдөр тутмын зөнч» сонин уншиж байв. Усан оргилын дэргэдүүр өнгөрөхөд Харри ёроолд мөнгөн сикль хүрэл кнат гялтагнахыг олж харлаа. Дэргэд нь жижигхэн хаяг байлаа.

ШИДТЭН АХ ДҮҮ НАРАА УСАНД САНД ОРСОН БҮХ ЗҮЙЛ ГЭГЭЭН МУНГОГЫН ИД ШИДИЙН ӨВЧИН ЭМГЭГИЙН ЭМНЭЛЭГТ ХАНДИВЛАГДАХ БОЛНО.

«Хэрвээ Хогвартсаас хөөгдөхгүй бол арван галлеон хандивлана даа» гэж Харри цөхрөн бодлоо.

- Ийшээ, Харри гэж ноён Уизли хэлээд алтан хаалга руу чиглэсэн албан хаагчдын томоохон урсгалаас гарлаа. Тэд зүүн талын «Хамгаалалт» гэсэн хаягтай ширээ рүү ойртоход солонгорсон хөх жанчтай шидтэн сууж байв. Жижүүр тэднийг ойртон ирэхийг хараад «Зөнч» сониноо доошлуулав.

- Би зочныг дагалдаж явна гэж ноён Уизли Харри руу дохин тайлбарлав.

- Наашаа ир гэж жижүүр уйдсан хоолойгоор хэлэв.

Харри түүн рүү ойртоход шидтэн алтлаг нарийхан антенн шиг уян хатан зүйл өргөөд Харрийн урдуур хойгуур шалгав.

- Шидэт саваагаа гэж хамгаалалтын шидтэн бувтнаад алтлаг шалгагчаа доош буулгалаа.

Харри түүнд саваагаа өглөө. Жижүүр түүнийг жинлүүртэй төстэй дийзэн дээр тавихад чичирснээ нарийхан завсраар цаас гулган гарч ирлээ. Шидтэн түүн дээр бичигдсэн зүйлийг уншив.

- Арван нэгэн дюйм, галт шувууны өдтэй дөрвөн жил ашигласан. Тийм үү?

- Тиймээ гэж Харри түгшингүй батлав.
- Энэ надад үлдэнэ. Үүнийг таньд гэж хамгаалалт хэлээд цаасыг хадаасанд хатгангаа Харрид шидэт савааг нь буцаан өглөө.
- Баярлалаа.
- Хүлээгээрэй ... гэж жижүүр удаанаар дуудав.

Түүний нүд Харрийн энгэр дээрх тэмдэг дээр туссанаа духан дээрх сорви руу нь харлаа.

- Баярлалаа, Эрик гэж ноён Уизли хатуу хэлээд Харрийн мөрнөөс атгаж алтан хаалгаар орж байгаа яамны албан хаагчдын зүг эргүүлэв.

Харри ноён Уизли хоёр үл ялиг түлхэлцсээр хаалгаар орж алтан сараалжтай хориод цахилгаан шат бүхий багахан танхимд хүрэв. Харри, ноён Уизли хоёр тэдний нэгний өмнө хүмүүсийн хамт зогслоо. Тэдний ойролцоо зогсож байсан бавгар сахалтай шидтэний барьсан том хайрцагнаас харжигнах чимээ гарна.

- Юу байна даа, Артур? гэж шидтэн асуугаад ноён Уизлид толгой дохив.
- Чиний энд юу байгаа юм бэ, Боб? гэж ноён Уизли асуугаад хайрцаг руу харав.
- Сайн мэдэхгүй байна. Бид үүнийг дэгдээхэй гэж бодож байгаа ч тэр гэнэт галаар тургиад эхэлсэн. Үүлдэр угсааны хууль зөрчсөн үйлдэл бололтой гэж шидтэн хариулав.

Түжигнэсэн чимээ гараад тэдний урд цахилгаан шат бууж ирэн алтан сараалж нээгдэхэд Харри, ноён Уизли хоёр хүмүүсийн хамт бүхээгт орлоо. Харри арын хана руу шахагдан зогсов. Зарим шидтэн түүнийг сонирхож харна. Сараалж хаагдан цахилгаан шат алгуур дээш түжигнэн өгсөхөд телефон утасны бүхээгт дуулдсаны адил эмэгтэй хүний хоолойг Харри сонслоо.

- Долоон давхар. Ид шидийн спорт тоглоомын хэлтэс. Англи, Ирландын квиддичийн холбооны удирдлагын байр болон Чулуун наадгайн албан ёсны клуб, шидэт тоглоомд патент олгох хэлтэс.

Цахилгаан шатны хаалга нээгдэв. Харри хонгилын нэг хананд янз бүрийн квиддичийн багийн зурагт хуудас өлгөснийг олж харлаа. Цахилгаан шатнаас шүүртэй шидтэн гарч хонгилоор явлаа.

Хаалга хаагдан цахилгаан шат чичигнэн дээш хөдлөхөд эмэгтэй хүний хоолой

гарлаа.

- Зургадугаар давхар. Ид шидийн тээврийн хэлтэс, Нисдэг дарины хяналтын байр болон, Шүүр хяналтын алба, Шилжих эрх өгөх хэлтэс.

Хаалга ахин нээгдэн дөрөв таван шидтэн гарахад араас нь хэдэн цаасан онгоц дагалдав. Үлдсэн нь удаанаар зорчигчдын толгой дээгүүр эргэлдэнэ. Тэд бүгд цайвар ягаан өнгөтэй бөгөөд далавчин дээр нь ид шидийн яам гэсэн тамга даржээ.

- Хэлтэс хоорондын захианууд. Урьд нь ууль ашигладаг байсан ч бохир гэж тамтаггүй юм болсон. Бүх ширээн дээр ... гэж ноён Уизли тайлбарлав.

Цахилгаан шат ганхан хөдлөхөд зурвасууд бүхээгийн адраас өлгөсөн дэнлүүг тойрон эргэлдэв.

- Тавдугаар давхар. Олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтэс.

Олон улсын худалдааны зөвлөл болон Олон улсын ид шидийн хууль тогтоох газар, Олон улсын шидтэнгүүдийн холбооны Англи дахь төлөөлөгчийн газар.

Хаалга нээгдэхэд шидтэнгүүдийн хамтаар хоёр зурвас нисэн гарахад хэд хэдэн шинэ онгоц нэмэгдлээ. Тэд дэнлүү тойрон эргэлдэв.

- Дөрөвдүгээр давхар. Шидэт амьтан хянан зохицуулах хэлтэс, Албингуудтай холбоо тогтоох байр болон Хортон шавьжны устгалын алба.

- Зөвшөөрнө үү гэж галт дэгдээхэйтэй шидтэн хэллээ. Түүнийг даган сүрэг зурвас гарлаа. Хаалга хяхтнан хаагдав.

- Гуравдугаар давхар. Ид шидийн золгүй явдал аваар осол болон Санаандгүй шидийг цуцлах хэлтэс, Маглуудад тайлбар тавих хороо.

Энэ давхарт цахилгаан шат бараг хоосорч ноён Уизли, Харри хоёроос гадна үзүүр нь шал хүрсэн урт хуйлаастай цаас уншиж байгаа шидтэн үлдэв. Бүхээг чичигнэн хөдлөхөд үлдсэн зурвасууд урьдын адил дэнлүү тойрон хөвлөө. Дараа нь хаалга нээгдэж хоолой,

- Хоёрдугаар давхар. Ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх болон, Эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтэс, Мракоборецуудын удирдлагын төв байр, Визенгамтоын захиргааны алба гэв.

- Ирлээ. Миний өрөө хонгилын төгсгөлд байгаа гэж ноён Уизли хэлээд шидтэнг дагалдан олон тооны хаалга бүхий хонгилд гарлаа.

- Ноён Уизли бид газар дор байгаа биш юм уу? гэж Харри нарны гэрэл туссан цонхны хажуугаар өнгөрөөд хэллээ.

- Тиймээ газар дор. Энэ бол илбэдсэн цонх байгаа юм. Ямар цаг агаар харуулахыг ид шидийн үйлчилгээний албанаас шийддэг. Саяхан бид хоёр сарын турш шуурга харсан. Тэд ийм аргаар гомдлоо тайлдаг юм ... Ийшээ эргэ, Харри.

Тэд булан тойрон нээлттэй том царсан хаалгаар орон хаалтаар хуваагдсан том танхимд ороход инээд яриа хөөрөө хадав. Зурвасууд урагш хойш жижигхэн пуужин шиг нисэлдэнэ. Дээр нь Мракоборецуудын төв байр гэсэн хаяг өлгөжээ.

Харри танхим дундуур өнгөрөх зуураа тасалгаанууд руу сэмхэн харлаа. Бүхээгийн хананд маркоборецууд гэр бүлийнхээ болон янз бүрийн шидтэнгүүдийн гэрэл зураг, квиддичийн шүтдэг багийн зурагт хуудас, түүнчлэн «Өдөр тутмын зөнч» сонины хайчилбар өлгөжээ. Биллээс ч урт үстэй гал улаан жанчтай шидтэн бичгийн ширээний ард хөлөө ачин суугаад үзгээрээ юм бичүүлж байв. Цаахан талд нь Кингсли Брустверийн өрөө байлаа.

- Өглөөний мэнд, Уизли. Таньтай хоёр үг сольж болох уу? гэж Кингсли тэднийг ойртон ирэхэд хайхрамжгүй хэллээ.

- Үнэхээр нэг хоёр бол болно. Надад хугацаа бага байна гэж ноён Уизли хэлэв.

Тэд хоорондоо сайн танил биш аятай ярилцахад Харри ноён Кингслитэй мэндлэхээр ам нээсэн авч ноён Уизли хөл дээр нь гишгэв. Тэд Кингслиг дагалдан эгнээ хооронд явсаар алсын бүхээгт хүрлээ.

Эргэн тойронд нь Сириусын царай ширтэхэд Харри үл мэдэгхэн цочролд оржээ. Хананд сонингийн хуучин гэрэл зураг болон Сириусын Поттерын хурим дээр авхуулсан зураг битүү наажээ. Цорын ганц хоосон зайд дэлхийн газрын зургийг үнэт чулуу шиг толгойтой жижигхэн зүүгээр хатган тогтоосон байлаа.

- Энэ гэж Кингсли ажил хэрэгч өнгөөр хэлээд ноён Уизлид хэдэн цаас сунгав.

- Надад маглуудын нүдэн дээр нисч өнгөрсөн нисдэг тээврийн хэрэгслүүдийн сүүлчийн хоёр сарын мэдээлэл хэрэгтэй байна. Бид Блэкийг өмнөхийн адил хуучин мотоциклээ ашигласаар байгаа гэсэн мэдээлэл авсан гээд Харри руу нүд ирмэснээ шивнэн,

- Түүнд сэтгүүлийг үзүүлээрэй сонирхолтой санагдах болно гээд урьдын адил өнгөөр,

- Яарах хэрэгтэй шүү, Уизли манай ажил хэрэг сарын дотор өгөхийг шаардаж байгаа юм гэлээ.

- Харин та миний галт зэвсгийн талаарх мэдээллийг ямар хугацаанд авсанаа мэднэ. Мотоцикльтэй холбоотой мэдээллийн хувьд таныг хүлээх хэрэгтэй болох нь гэж айж байна. Би их завгүй байгаа гэснээ дуугаа багасган,

- Долоо гэхэд чөлөөлөгдөхийг бодоорой. Молли махтай бөмбөлөг хийж байгаа гэлээ.

Тэр Харри руу зангаад Кингслигийн бүхээгийг орхин хоёр дахь царсан хаалгыг өнгөрөөд хонгилоор явж зүүн талын ондоо хонгилоор орсноо баруун тийш эргэж бүүдгэр гэрэлтэй үзэмжгүй хонгилын эцэст хүрэхэд зүүн талын дутуу хаагдсан хаалганы завсраар шүүрний пин харагдав. Баруун талын хаалган дээр «Эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар хэрэглэхтэй тэмцэх хэлтэс» гэсэн өнгөө алдсан зэс хаяг өлгөжээ.

Ноён Уизли шүүрний пингээс үл ялиг давчуу гэрэл муутай өрөөнд орлоо. Ханын дагуу дээрээ янз бүрийн бичиг цаас овоолсон шүүгээ эгнүүлсэн учир бичгийн хоёр ширээний хооронд бараг зай үлдсэнгүй. Ханын жижиг зайд ноён Уизлийн сонирхдог зүйл болох машины зургууд, хөдөлгүүр эд ангийн схем, маглуудын хүүхдийн номноос авсан бололтой шуудангийн хайрцагны зураг өлгөжээ. Бас залгуурын бүтцийн зураг байлаа.

Ноён Уизли янз бүрийн эд зүйл, хуучин талх шарагч зэрэг овоолсон шүүгээнээс арьсан бээлий аваад хуруундаа эргэлдүүлэв. Ойролцоох хайрцаганд Уизлийн гэр бүлийн зураг харагдана. Харри Перси түүн дээр байхгүй болохыг ажиглав.

- Харамсалтай нь манай өрөөнд цонх байхгүй. Бид гуйсан ч тэд шаардлагагүй гэж бодож байгаа юм. Суу, Харри. Перкинс ирээгүй байна гэж Уоён уизли уучлал гуйсан маягтай хэлээд сандал дээр арьсан хүрмээ өлгөлөө.

Харри Перкинсийн ширээний сандал татан суухад ноён Уизли Кингли Брустверийн өргөсөн цаасыг эргүүлж үзэв.

- Аан хэмээн инээмсэглээд «Шүүмжлэгч» нэртэй сэтгүүлийг тавьж,

- Тиймээ. Түүний зөв. Би Сириусыг хөгжинө гэдэгт итгэлтэй байна ... Өө энэ чинь одоо бас юу вэ? гэлээ.

Нээлттэй хаалгаар зурвас орж ирээд далавчаа дэвэн талх шарагч дээр газардав. Ноён

Уизли түүнийг авч дэлгээд чанга уншив.

- Бетнал Гринд бөөлждөг гурав дахь жорлон илэрсэн тул даруйхан шалгах хэрэгтэй байна ...

- Бөөлждөг жорлон гэнээ?

- Маглуудын эсрэг эд байгаа юм. Бид өнгөрсөн долоо хоногт хоёрыг Уимблдон болон Элефант-энд-Каслед илрүүлсэн. Маглууд ус татахад доторх бүх зүйл нь алга болохын оронд ... Чи ямар болохыг нь төсөөлж байна уу. Хөөрхийн амьтад сотейников дуудаад? Хоолой үздэг хүн ...

- Сантехникч уу?

- Аан тийм л дээ будилчихлаа. Цорын ганц найдлага бол хэн тэгснийг нь олох явдал юм.

- Хэн хайх юм, мракоборецууд уу?

- Үгүй дээ энэ тэдний хувьд хэтэрхий хөнгөдөнө. Ерөнхийдөө бол ид шидийн хуулийг албадан хэрэгжлүүлэх хэлтсийн эргүүл ... Аан, энэ бол Перкинс танилц, Харри.

Өрөөнд бөгтөр зүрх муутай байрын цагаан үстэй хөгшин шидтэн орж ирлээ.

- Өө, Артур! гэж тэр цөхрөнгүй уулга алдав.

- Бурханд баярлалаа. Чамайг хайхын оронд энд хүлээсэн нь дээр байж. Би дөнгөж сая танай гэр лүү ууль илгээсэн ... Арван хормын өмнө яаралтай дуудлага ирсэн ...

- Би бөөлждөг жорлонгийн тухай мэднэ гэж ноён Уизли хэлэв.

- Үгүй ээ, жорлон биш энэ бол Поттерын хэрэг. Тэд цаг болон уулзалтын газраа өөрчилсөн. Найман цагт есөн давхарын хуучин шүүн таслах байранд.

- Доор байдаг хуучин гэнээ ... Гэхдээ надад хэлэхдээ ... Мерлиний сахал минь! гээд ноён Уизли цагаа харснаа дуу алдан үсэрч бослоо.

- Түргэлээрэй, Харри бидэнд таван хором л байна.

Перкинс цаасан шүүгээнээс юм аваад ноён Уизлид өгөх гэсэн ч гүйн гарлаа. Харри ч үлдсэнгүй.

- Тэд яагаад цагаа өөрчилдөг байна? гэж тэр амьсгаадан асуугаад

маракоборецуудын тасалгааны хажуугаар өнгөрөв. Хүмүүс толгойгоо өргөн тэднийг дагуулан харахад Харри ноён Перкинсийн өрөөнд буцаж орсон нь дээр санагджээ.

- Ойлгох юм алга гэхдээ бид эрт ирсэн нь сайн хэрэг! Хэрвээ чи осолд ороод ирээгүй бол!

Ноён Уизли цахилгаан шатны өмнө гулган зогсоод хуруугаараа доошоо явах товчлуурыг дарлаа.

- Түргэлээрэй!

Цахилгаан шат түжигнэн ирэхэд яаран бүхээгт орлоо. Ноён Уизли зогсолт болгон дээр хараал тавьж есөн давхарын товчлуурыг дарж байлаа.

- Тэр танхимыг ашиглаагүй удаж байна. Би тэдний яагаад тэнд хийхээр болсныг ойлгохгүй юм ...

Цахилгаан шатанд уугьж буй цом барьсан махлаг бүдүүн шидтэн орж ирэхэд ноён Уизли яриагаа болив.

- Атриум гэж эмэгтэй хоолой мэдэгдэхэд алтан сараалж онгойлоо. Харри алтан хөшөөтэй усан оргилуурыг зэрвэс харлаа. Тарган эмэгтэй явчихлаа. Шаравтар арьстай гашуудлын царайтай шидтэн орж ирлээ.

- Өглөөний мэнд, Артур. Манай газар дор үргэлж ирээд байдаггүй зочин байна даа гэж цахилгаан шат доош хөдлөхөд гунигтай хоолойгоор хэлэв.

- Яаралтай ажил, Боуд гэж ноён Уизли хэлээд тэвчээр алдан дороо дэвхэрснээ Харри руу түгшин харлаа.

- Аан, ойлгомжтой. Тэгэлгүй яахав гэж Боуд Харри цавчилгүй харан хэллээ. Боудын хатуу харц Харрид тайвширах боломж өгсөнгүй.

- Нууцын хэлтэс гэж эмэгтэйн хоолой хэлэв.

- Түргэлээрэй, Харри гэж ноён Уизи тушаалаа.

Тэд агшин зуур хонгилд гарахад дээр харсантай адил зүйл байсангүй. Хаалга цонх байхгүй нүцгэн хананууд байсан бөгөөд ердөө урт харанхуй хонгил үргэлжилжээ. Харри түүгээр явна гэж бодсон ч ноён Уизли гараас нь барьж зүүн тийш нь эргүүлээд шат руу явдаг бололтой үүд рүү авчрав.

- Доошоо доошоо. Ийшээ цахилгаан шат ч явдаггүй гүнд байдаг юм. Яагаад

энд хийхээр шийдсэн юм бол гэж ноён Уизли гишгүүр алгасан буунгаа хэлэв.

Тэд шатны ёроолд хүрээд Снеггийн газар дорхи хонгилыг санагдуулсан хонгилоор гүйлээ. Чулуун хананд бамбар асаж төмөр цоожны нүхтэй том хаалганы хажуугаар өнгөрөв.

- Танхим ийшээ ... Аравдугаар ... бид бараг хүрээд байна ... тиймээ.

Ноён Уизли харанхуй том цоожтой хаалганы өмнө огцом зогслоо. Тэр хана налан хүндээр амьсгаадан цээжээ барин зогслоо.

- Ийшээгээ ор гэж хүндээр амьсгаадан хэлээд хаалга руу заав.

- Та надтай хамт орохгүй юм уу?

- Үгүй, үгүй би болохгүй. Амжилт хүсье!

Харрийн зүрх хэнхдэгээсээ үсрэн гарах шахам цохилв. Тэр арайхийн шүлсээ залгиад хүнд бариулыг эргүүлэн шүүхийн танхим руу орлоо.

БҮЛЭГ 8: СОНСГОЛ

Харрийн амьсгаа давхцав. Газар доорхи уужим танхим маш танил санагдав. Тэр урьд нь түүнийг харж байгаагүй ч Дамблдорын оюун ухааны цүнхээлд энд ирсэн юм байна. Түүний нүдэн дээр Лейстрэнжүүдийг Азкабанд хоригдох ялаар шийтгэсэн билээ.

Ханыг бараан чулуугаар хийсэн агаад бамбарын бүдэг гэрэл тусна. Баруун болон зүүн талын эгнээ хоосон байсан ч өмнө талд нь өндөр сандал дээр олон хүний дүрс харагдав. Тэд аяархан ярилцаж байснаа Харри хаалга хаамагц чимээгүй болов.

- Та хоцорлоо гэх эрэгтэй хүний хүйтэн хоолой сонсогдов.
- Өршөөгөөрэй. Би ... цаг өөрчлөгдсөнийг мэдсэнгүй гэж Харри сэтгэл түгшин хэллээ.
- Үүнд Визенгамотын буруу байхгүй. Өглөө таньд ууль илгээсэн. Суу гэж хоолой хэллээ.

Харри танхимын дундах гинжтэй сандал руу харлаа. Тэр оюун ухааны цүнхээлд энэ гинжээр суусан хүнийг дөнгөлж байхыг харсан билээ. Түүнийг алхахад чулуун шалан дээр чанга цуурайтах чимээ гарав. Тэр болгоомжтой сандалд ойртоод ирмэг дээр нь суутал гинж сүртэй хангиналаа. Харри өмнөө суусан хүмүүс рүү харав.

Тэд тавиулаа байсан бөгөөд ягаан өнгийн энгэр дээрээ мөнгөлөг «В» үсэг бүхий сайхан хийцтэй жанч өмсчээ. Зарим нь түүнийг ширүүн харж байхад зарим нь сонирхсон янзтай ажиглана.

Эгнээний төв хэсэгт ид шидийн яамны сайд Корнелиус Фаж сууж байлаа. Махлаг биетэй Фаж өнөөдөр цайвар ногоон малгайгаа өмсөөгүй байлаа. Фажын зүүн талд дөрвөлжин эрүүтэй богинохон буурал үстэй эмэгтэй сууж байв. Түүний нүдэнд өрөөсөн нүдний шил гялсхийх нь сүрдмээр харагдав. Фажын баруун талд өөр шидтэн сууж байсан ч түшлэгээ налан суусан тул царай нь сүүдэрт харагдсангүй.

- Маш сайн байна. Буруутгал эхлэх цаг боллоо. Эхэлж болно. Та бэлэн үү? гэж Фаж доор сууж байгаа хүнд хандан хашгирав.
- Тиймээ, ноёнтон гэх танил хоолой гарав.

Роны ах Перси нүүрэн талын эгнээний хамгийн захын суудал дээр сууж байлаа. Харри түүн харан танилын ямар нэг шинж хүлээсэн авч юу ч болсонгүй. Перси үзгээ

бэлхэн бариад эвэр хүрээтэй шилнийхээ цаанаас өмнөө байгаа цаас руу ширтэв.

- Сахилгын дуудлагага найман сарын арван хоёронд нээснийг мэдэгдэе гэж Фаж хэлэхэд Перси хурлын протокол хөтөлж эхлэв.

- Насанд хүрээгүй шидтэн ид шид хэрэглэхийг хязгаарласан олон улсын шидтэнгүүдийн нууцлалыг зөрчсөн хэрэгт буруутгагдаж байгаа Харри Жемс Поттерын хаяг, Суррей гүнлэг, Литтл Унингиг хот, Улаан модон гудамж, дөрөвдүгээр байшин.

- Байцаалтыг ид шидийн яамны сайд Корнелиус Освальд Фаж, ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийн дарга Амелия Сьюзен Боунс, сайдын нэгдүгээр зэргийн орлогч Долорес Жейн Амбриж нар явуулах болно. Шүүхийн бичээч Перси Игнациус Уизли ...

- Хамгаалах гэрч Альбус Персиваль Вулфрик Брайн Дамблдор гэх аяархан хоолой Харрийн ард сонсогдов.

Тэр хүзүүгээ өвдтөл огцом эргэн харав.

Урт хөх жанч өмссөн Дамблдор танхимд яаралгүйхэн алхлан орж ирэхдээ маш тайван төрхтэй байв. Түүний буурал үс сахал нь бамбарын гэрэлд гялалзав. Тэр Харри руу харалгүй Фаж руу харлаа.

Визенгамотын гишүүд өөр хоорондоо шивнэлдэв. Бүгдийн харц орж ирсэн хүн дээр тусчээ. Шүүгчийн зарим нь уурсаж, зарим нь айсан байдалтай байхад хоёр ахимаг насны шидтэн Дамблдорт нөхөрсгөөр гар даллав.

Захирлыг хараад Харрийн цээжинд галт шувууны дуу сонсогдсон аятай хүчирхэг найдвар төржээ. Тэр Дамблдор түүн рүү харахыг хүссэн авч тэрбээр түгшсэн байртай харагдах Фажаас нүд салгасангүй.

- Аа ... Дамблдор. Тиймээ. Тэгэхээр та ... манай ... цаг ... байр солигдсон тухай мэдэгдлийг авсан байх нь? гэж сайд мэгдэн хэлэв.

- Таны илгээмжийг аваагүй. Гэхдээ аз болоход би тохиолдлоор яаманд гурван цагийн урд ирсэн болохоор муу юм тохиолдсонгүй гэж Дамблдор хөгжилтэй хэллээ.

- Тиймээ ... сайн байна ... бидэнд нэг суудал хэрэг болох нь ... Уизли?

- Санаа зовох хэрэггүй гэж Дамблдор хэлээд саваагаа өргөн хөнгөн даллахад Харрийн дэргэд түшлэгтэй сандал бий болов.

Дамблдор түшлэг дээр гараа тавин суугаад Фажыг сонирхон ширтэв. Визенгамотын гишүүд тайван бус өөр хоорондоо шивнэлдсэн хэвээр байсан авч Фажыг ахин ярихад чимээгүй болов.

- Тиймээ. Сайн байна. Ингээд буруутгал эхэллээ. Тийм гэж цаас шар шурхийлгэн хэлэв.

Тэр ширээн дээр байгаа овоолттой цааснаас хэрэгтэйгээ сонгон аваад гүнзгий амьсгал авч чанга уншлаа.

- Шүүхээс түүнийг өмнө нь ид шидийн яамнаас анхааруулга авч байсан болохоор хууль бус үйлдэлээ бүрэн ойлгож байсан гэж үзэж байгаа тул найман сарын хоёрны есөн цаг хорин гурван минутад Патронусын шидийг маглуудын оршин суудаг дүүрэгт маглуудын хажууд хэрэглэн насанд хүрээгүй шидтэн ид шид хэрэглэхийг хязгаарлах тухай мянга найман зуун далан таван оны арван гуравдугаар хэсгийн олон улсын ид шидийн холбооны нууцлалын дүрмийг зөрчсөн хэрэгт буруутгаж байна.

- Та Харри Жеймс Поттер. Суррей гүнлэг, Литтл Уингинг хот, Улаан модон гудамж, дөрвөн тоот байшинд амьдран суудаг уу? гэж Фаж асуугаад Харри руу харав.

- Тиймээ гэж Харри хэллээ.

- Та гурван жилийн өмнө ид шидийн яамнаас хууль бус шид хэрэглэсэн анхааруулга авч байсан уу?

- Тиймээ, гэхдээ ...

- Тэгсэн атал найман сарын хоёрны үдэш Патронусын шидийг дуудсан уу?

- Тиймээ, гэхдээ ... гэж Харри хэллээ.

- Таньд арван долоон нас хүрээгүй байхдаа сургуулиас гадуур шид хэрэглэх хориотой гэдэг ойлгомжтой байсан уу?

- Тиймээ, гэхдээ ...

- Таны оршин сууж байгаа дүүрэгт дүүрэн маглууд байдаг гэдгийг ойлгож байсан уу?

- Тиймээ, гэхдээ ...

- Тэр үедээ маглуудын хажууд байсан гэдгээ хүлээн зөвшөөрч байна уу?

- Тиймээ, гэхдээ би үүнийг зөвхөн бидэнд ... гэж Харри ууртай хэлэв. Шидтэн эмэгтэй түүний яриаг чанга хоолойгоор таслаад,
 - Та бүрэн гүйцэд Патронусын шидийг дуудсан уу? гэв.
 - Тиймээ яагаад гэвэл ...
 - Биежсэн хэлбэртэй Патронус уу?
 - Юу? гэж Харри асуулаа.
 - Таны Патронус ямар дүрстэй харагддаг вэ? Үүл үү утаа юу?
 - Тийм биш. Энэ бол буга байсан. Үргэлж буга байдаг гэж Харри цөхөрсөндөө уурсан хэллээ.
 - Үргэлж гэнээ? Та урьд нь Патронусыг дуудаж байсан юм уу? гэж хатагтай Боунс нүргэлүүлэв.
 - Тиймээ анхны удаа ойролцоогоор жилийн өмнө.
 - Арван таван настай байхдаа юу?
 - Тийм ...
 - Та үүнийг сургуульд сурсан уу?
 - Намайг гуравдугаар дамжаанд байхад профессор Люпин сургасан. Яагаад гэвэл ...
 - Сэтгэл хөдөлмөөр юм. Түүний насанд жинхэнэ Патронус гаргана гэдэг ... үнэхээр сэтгэл хөдөлмөөр юм гэж хатагтай Боунс түүн рүү харан хэллээ.
- Хэд хэдэн шидтэнгүүд ахин шивнэлдэхэд зарим нэг нь дэмжин толгой дохиж зарим нь хөмсөг зангидан толгой сэгсэрлээ.
- Гол учир нь энэ шидийн сэтгэгдэл төрөм гэдэгт биш байгаа юм. Хэрвээ баримтыг авч үзвэл сурагч маглуудын нүдэн дээр хийсэн гэдэг нь илүү сэтгэгдэл төрмөөр байгаа юм гэж Фаж унтууцав.
- Тэд хөмсөг зангидан нам дуугаар ярилцаад Харриг ярихыг зөвшөөрөхөд Перси урамшуулан толгой дохив.
- Би Дементорыг хөөхийн тулд хийсэн юм! гэж биеэ барьж дийлэхээ больсон Харри чанга хэллээ.

Тэр дараагийн шивнэлтийг хүлээсэн авч нам гүм боллоо.

- Дементор гэнээ? Та үүгээрээ юу хэлэхийг хүсээ вэ залуу хүү минь? гэж хатагтай Боунс өтгөн хөмсгөө өргөхдөө шилээ золтой унагасангүй.

- Би хонгилын гарцанд намайг болон үеэл ах бид хоёрыг Дементор дайрсан гэж хэлэхийг хүссэн юм!

- Аа ... гэж Фаж Визенгамот руу таагүй инээмсэглэн харсанаа шүүгчдийн хамтаар инээлдэв.

- Тиймээ, тэгэлгүй яахав. Бид иймэрхүү маягийн юм сонсоно гэж итгэлтэй байсан юм.

- Дементорууд Литл Унингиггэд байсан гэж үү? Юу ч ойлгохгүй байна? гэж хатагтай Боунс мэл гайхан хэллээ.

- Амелия ойлгохгүй байна уу? Харин би тайлбарлаад өгье. Тэр Дементоруудаар маш сайхан жижиг түүх зохиохоор шийдсэн байна. Дементорыг маглууд харж чадахгүй. Их таатай байна, маш таатай ... Гэхдээ таны үгэнд ямар ч гэрч байхгүй ... гэж Фаж өмнөхийн адил инээмсэглэн хэлэв.

- Би худал хэлээгүй! гэж Харри чанга хэлэхэд сандалд дээгүүр дараагийн сэтгэл хөдөлсөн шивнэлт түгэв.

- Тэд хоёулаа байсан хонгилын эсрэг талаас ойртон ирэхэд гэнэт харанхуй хүйтэн болж миний үеэл ах тэднийг мэдрээд зугтсан ...

- Хангалттай, хангалттай! Гэхдээ намайг уучлаарай үүнийг таслан зогсоох хэрэгтэй байх эргэлзээгүй сайтар төлөвлөсөн яриа ... гэж Фаж дуу алдаад сэжигтэй харав.

Дамблдор хоолой засан ханиалгав. Визенгамот ахин чимээгүй боллоо.

- Дадли Дурсль Дементоруудын хонгилд ирсэн цорын ганц гэрч биш гэж тэр хэллээ.

Фажын махлаг царай агаар агаар дутагдсан мэт сулбайв. Тэр Дамблдор руу хоёр хормын турш ширтсэнээ дараа нь биеэ барин,

- Дамблдор бидэнд санаанаасаа зохиосон зүйл сонсож байх цаг байхгүй гэж айж байна. Би түргэн асуухыг хүсч байна гэлээ.

- Би алдсан байж болох юм гэж Дамблдор эелдэгээр хэлээд,

- Гэхдээ надад Визенгамотын шүүх буруутгалд гэрчээр оролцохыг зөвшөөрсөн. Хатагтай Боунс гэж тэр өрөөсөн нүдний шилтэй шидтэнд хандан хэлээд, Энэ шид шидийн албадан хэрэгжүүлэх хуулийг зөрчөөгүй биз дээ?

- Тиймээ. Таны бүрэн зөв гэж хатагтай Боунс хэлэв.

- За за. Тэгээд гэрч чинь хаана байна? гэж Фаж хөндий хэлэв.

- Би эмэгтэйг өөртэйгээ аваад ирсэн. Тэр хаалганы цаана хүлээж байгаа. Би ... болох уу? гэж Дамблдор хэлэв.

- Үгүй ээ, үгүй ... Уизли гараарай! гэж Фаж Персид хандан хэлэхэд тэр даруйхан босож гүйгээд Дамблдор, Харри хоёрын дэргэдүүр өнгөрөхдөө тэдэн рүү харсангүй.

Хормын дараа Перси хатагтай Фиггийг дагуулан ирлээ. Ухаан муутай хөгшин ердийнхөөсөө илүү их айсан байлаа. Харри түүнийг гэрийн шаахайгаа солиогүйд ихэд харамсчээ.

Дамблдор босож суудлаа хатагтай Фиггт тавьж өгөөд өөртөө илбэдэн бий болгов.

- Таны нэр! гэж Фаж чанга хэлэхэд хатагтай Фигг айсан янзтай сандлын өнцөгт суулаа.

- Арабелла Дорин Фигг гэж хатагтай Фигг чичирсэн хоолойгоор хэлэв.

- Ингэхэд та хэн байна? гэж Фаж таагүй өнгөөр хэлэв.

- Би Литтл Уингигын оршин суугч. Манай гэр Харри Поттерын гэрээс холгүй байдаг гэж хатагтай Фигг хэлэв.

- Бид Литтл Уингингэд Харри Поттерээс гадна шидтэн өөр шидтэн оршин суудаг тухай мэдээлэл байхгүй гэж хатагтай Боунс даруй хэлэв.

- Би бол сангасваа. Ийм учраас та намайг бүртгээгүй байх гэж хатагтай Фигг тайлбарлав.

- Сангасваа гэнээ? Бид үүнийг шалгах болно. Миний туслах Уизли таны эцэг эхийн талаар тодорхойлолт авах болно. Дашрамд хэлэхэд сангасваа Дементорыг харж чадах уу? гээд Фаж эргэн тойрноо харлаа.

- Чадалгүй яахав! гэж хатагтай Фигг дуу зэвүүцэн дуу алдав. Фаж хөмсгөө өргөөд ахин түүнийг харав.

- Их сайн байна. Тэгээд бидэнд юу хэлэхийг хүсээ вэ?
- Найман сарын хоёрны оройн есөн цагт би Глициний гудамжинд байдаг булангийн дэлгүүрээс муурын хоол худалдаж авахаар гарсан юм. Тэгээд би Магнолийн гудамжыг Глициний гудамжнаас тусгаарлагдсан гарцанд ямар нэгэн чимээ гарахыг сонссон. Ойртож очоод Дементор гүйж байхыг харсан ... гэж хатагтай Фигг цээжилсэн аятай дуржигнуулав.
- Гүйсэн гэнээ? Дементорууд гүйдэггүй гулсдаг юм гэж хатагтай Боунс ширүүн хэлэв.
- Би ингэж л хэлэхийг хүссэн юм гэж хатагтай Фигг яаран засахад хацар нь ягаарлаа.
- Тэд гарцанд байсан хоёр өсвөр насны хүү рүү гулган ойртож байсан.
- Тэд ямар харагдаж байсан бэ? гэж хатагтай Боунс нүдээ нарийсган асуугаад нэг нүдний шилээ холдуулав.
- Нэг нь бүдүүн нөгөөдөх нь эсрэгээрээ туранхай.
- Үгүй дээ. Дементорууд. Тэдний гаднах төрхийг хэл гэж хатагтай Боунс гэвчээр алдан хэллээ.
- Өө, тэд том. Том биетэй нөмрөгтэй байсан хэмээн хатагтай Фигг хүзүү нь час улайж хэллээ.

Харрийн дотор аймшигтай болохыг мэдрэв. Хатагтай Фиггийн яриа Дементорыг зурган дээрээс харсан мэт сонсогдох бөгөөд ямар ч зурган дээрээс эдгээр амьтдыг ойроос харсан мэдрэмж төрөхгүй юм. Тэд хэрхэн газар дээгүүр гулсан хөвдөг. Хичнээн муухай ялзарсан үнэртэй болох. Аймшигтай сөөнгө хоолойгоор эргэн тойрны агаараа сорж байсан гээд л.

Хоёрдугаар эгнээнд суусанд намхан биетэй өтгөн хар сахалтай шидтэн буржгар үстэй хөршдөө ямар нэг юм шивнэлээ. Тэр инээмсэглэн толгой дохив.

- Том биетэй нөмрөгтэй гэнээ хэмээн хатагтай Боунс хүйтнээр давтахад Фаж тохуурхан инээмсэглэв.
- Ойлгомжтой. Өөр ямар нэг юм байна уу?
- Тиймээ. Би тэднийг мэдэрсэн. Зуны дулаахан өдөр байсан ч гэсэн маш хүйтэн болсон. Миний бүх аз жаргал байхгүй болох шиг санагдсан ... Би аймшигтай

зүйлсийг санасан гээд түүний хоолой чичирснээ чимээгүй боллоо.

Хатагтай Боунсын нүд томроход хөмсгөн дороос нь Харри нүдний шилний улаан ормыг олж харлаа.

- Дементорууд юу хийсэн бэ? гэж тэр асуухад Харрид найдлага төрөв.
- Тэд хүүд ойртсон гэж хатагтай Фигг илүү итгэлтэй хоолойгоор хэлэхэд улаан өнгө түүний царайнаас ариллаа.
- Нэг хүү унасан. Харин нөгөөдөх нь эргэн харж Дементорыг хөөхийг оролдсон. Энэ бол Харри байсан. Тэр хоёр оролдлого хийхэд зөвхөн мөнгөлөг үүл гарсан. Гурав дахь удаагийн оролдлогоор Патронусаа дуудахад буга гарч эхний Дементорыг хөөгөөд дараа нь Харрийн гуйлтаар үеэл ахыг нь хоёр дахиас нь хамгаалсан. Ер нь бол иймэрхүү юм болсон гэж хатагтай Фигг яриагаа эв хавгүйхэн төгсгөв.

Хатагтай Боунс чимээгүйхэн доошоо ширтлээ. Фаж цаас шаржигнуулан гэрч рүү харсангүй. Эцэст нь дээшээ хараад,

- Тэгэхээр та үүнийг харсан юм биз дээ? гэв.
- Тиймээ ийм явдал болсон гэж хатагтай Фигг давтав.
- Их сайн байна. Явж болно гэж Фаж хэллээ.

Хатагтай Фигг Фаж руу айсан янзтай харснаа босож хаалга руу майжигнав. Харри түүний ард хаалга хаагдахыг сонслоо.

- Хэтэрхий үнэмшилтэй гэрч байна гэж Фаж дээрэнгүй хэлэв.
- Мэдэхгүй, мэдэхгүй. Тэр Дементорын дайрсан дүр зургийг маш тод хэллээ.

Хэрвээ тэр худал хэлсэн бол яагаад ингэснийг төсөөлж чадахгүй нь гэж хатагтай Боунс хүнгэнүүлэв.

- Гэхдээ Дементорууд маглуудын амьдардаг хотын захад шидтэнтэй санаандгүй тааралдсан гэж үү? Энэ маш хачирхалтай юм. Бэгмен хүртэл мөрийцөхгүй байх гэж Фаж хэлэв.

- Би Дементорууд тэнд санамсаргүй тааралдсан гэж бодохгүй байна гэж Дамблдор дуугарлаа.

Фажын баруун талд сүүдэрт сууж байсан шидтэн эмэгтэй суудал дээрээ үл мэдэгхэн

хөдлөхөд бусад нь хөдөлгөөнгүй болж нам гүм болов.

- Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Фаж мөс шиг хүйтэн хоолойгоор асуув.
- Миний бодлоор бол тэднийг тийш очихыг тушаасан гэж Дамблдор хэлэв.
- Хэрвээ хэн нэгэн хоёр Дементорыг Литтл Уингингийн гарц руу явахыг тушаасан бол бид энэ тухай мэдэх байсан! гэж Фаж дүрсхийв.
- Хэрвээ Дементорууд зөвхөн ид шидийн яамны тушаалийг биелүүлэхээ больсон бол. Би таньд хэдийн шалтгааныг нь хэлсэн, Корнелиус.
- Тиймээ мэдэгдсэн гэхдээ надад дэмий үгэнд итгэх шалтгаан байхгүй, Дамблдор. Дементорууд Азкбанд байж бидний шаардсаныг хийх болно.
- Тэгвэл гээд Дамблдор аяархан боловч тод хоолойгоор,
- Бид яагаад ид шидтэний яамнаас найман сарын хоёрны өдөр хоёр

Дементорыг тийш нь илгээснийг асуух ёстой гэв.

Нам гүм болоход Фажын баруун талд сууж байсан шидтэн урагш бөхийхөд Харри анх удаагаа нүүрийг нь харлаа.

Тэр намхан тагдгар том бах шиг ажээ. Нүүр нь өргөн бөгөөд хүзүү нь Вернон ахын шиг богино, дарвагар том амтай байлаа. Нүд нь том дугуй үл ялиг бүлтгэр аж. Богинохон буржгар үсэн дээрээ жижигхэн хамба хилэн тууз зүүсэн нь хэлээ сунган том ялаа барих гэж байгаа бахыг санагдуулна.

- Сайдын нэгдүгээр зэргийн орлогч Долорес Жейн Амбриж үг хэлнэ гэж Фаж мэдэгдэв.

Харри түүнийг сөөнгөтөх байх гэж хүлээж байсан болохоор жижигхэн охиных шиг шингэн хоолойг сонсоод цочирдов.

- Би таныг буруу ойлгосон гэдэгт итгэлтэй байна, профессор Дамблдор гэж тэр худал инээн хэлэхэд дугуй том нүд нь хүйтрэв.

- Миний зүгээс тэнэг хэрэг боллоо. Гэхдээ богинохон нэг агшины турш надад та ид шидийн яамнаас хэн нэгэн энэ хүүг дайрах тушаал өгсөн гэж хэлсэн юм шиг санагдлаа!

Тэр инээд алдахад Харрийн шилэн хүзүүний үс бослоо. Түүний хамт Визенгамотын

хэдэн гишүүд инээв. Гэвч тэдэнд инээдтэй санагдаагүй гэдэг нь ойлгомжтой байлаа.

- Дементорууд зөвхөн ид шидийн яамны тушаалаар хөдөлдөг. Энэ бол баримт. Долоо хоногийн өмнө хоёр Дементор Харриг үеэл ахынх нь хамт дайрсан байна. Энэ ч гэсэн баримт. Логик ухаанаар бодоход яамны хэн нэгэн энэ дайралтыг тушаасан байна. Мэдээж энэ хоёр Дементор яамны хяналтаас гараагүй бол ... гэж Дамблдор эелдэгээр хэлэв.

- Бүх Дементоруд зөвхөн яамны хяналтанд байдаг! гэж Фаж дүрсхийгээд час улайлаа.

Дамблдор толгойгоо бөхийлгөснөө дээш болгов.

- Тэгвэл эргэлзээгүй яамнаас хоёр Дементорыг Азкабанаас алс хол зөвшөөрөлгүй дайралт хийлгэхээр илгээсэн байх нь.

- Ид шидийн яам юу хийх хийхгүйг та заадаг юм биш, Дамблдор! хэмээн Фаж зандрaad Вернон ахын адил ягаарлаа.

- Мэдээж тийм биш. Би ердөө энэ асуудал анхаарлын гадна үлдэхгүй гэдэгт итгэлтэй байхыг хүссэн юм.

Тэр өрөөсөн нүдний шилээ ахин тохируулж буй хатагтай Боунс руу харлаа. Тэр хөмсөг зангидав.

- Би энд байгаа хүн бүхэнд Дементор өнөөдөр бидний авч хэлэлцэх асуудал биш гэдгийг сануулмаар байна. Бид энд Харри Поттерыг насанд хүрээгүй шидтэн шид хэрэглэхийг хязгаарлах тухай хуулийг зөрчсөнд буруутгах гэж цугласан! гэж Фаж хэлэв.

- Яг үнэн, гэхдээ Дементорууд энэ хонгилд байсанд гол учир байгаа юм.

Зарлигийн долдугаар зүйлд насанд хүрээгүй шидтэн амьдралдаа аюул учирсан онцгой тохиолдолд шидтэн маглуудын дунд амьдардаг эсэх нь хамаагүй ...

- Бид долдугаар зүйлийг мэднэ, баярлалаа! гэж Фаж хашгирав.

- Мэдээж мэднэ. Тэгвэл бид Харри Поттер тэр агшинд Патронусын шившлэгийг ашигласнаараа журмыг зөрчөөгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой гэж Дамблдор эелдэгээр хэлэв.

- Тэнд Дементор байсан гэдэгт би эргэлзэж байна.

- Та үүнийг гэрчээс маш тодорхой сонссон. Хэрвээ та өмнөхийн адил түүнд эргэлзсээр байгаа бол ахин дуудан асууж болно. Би түүнийг татгалзахгүй гэдэгт итгэлтэй байна.
- Энэ ... би ... ямар ч! Надад ... би энэ бүхнийг өнөөдөр дуусгахыг хүсч байна гэж Фаж бухимдан цаас шаржигнуулав.
- Тэгвэл таньд ноцтой алдаа гаргахгүйн тулд гэрчүүдийг хэдэн удаа сонсох нь ялгаагүй юм шив дээ.
- Ноцтой алдаа гэнээ! Сургуулиас гадуур шид хэрэглэснийг цагаатгах жигшүүртэй арга байна даа. Дамблдор таньд энэ хүү хичнээн удаа утгагүй түүх зохиосон тухай асуулт тавимаар байна! Тэр гурван жилийн өмнө Левитацийн шившлэг хэрэглэснийг мартсан бололтой гэж Фаж бүх хүчээрээ орилов.
- Энэ бол би биш гэрийн үйлчлэгч байсан гэж Харри хэлэв.
- Харж байна уу! Гэрийн үйлчлэгч! Маглуудын гэрт! Таньд өөр юу хэрэгтэй вэ? гэж Фаж дэлбэрээд Харри руу бардам зангалаа.
- Гэрийн үйлчлэгч Хогвартс сургуульд ажиллаж байгаа. Хэрвээ хүсч байвал би түүнийг гэрчийн мэдүүлэг өгүүлэхээр дуудъя.
- Надад ... гэрийн үйлчлэгчийн үгийг сонсож байх цаг байхгүй! Ямар ч байсан энэ ганц удаагийн тохиолдол биш ... Хэн нагац эгчээ хийллээ? гэж Фаж орилоод шүүгчдийн ширээг нударгаараа дэлсэхэд бэх асгарав.
- Та харваас шидтэн үргэлж өөрийгөө барьж чаддаггүй тохиолдлыг ашиглахыг хүссэн бололтой гэж Дамблдор тайван хэлээд Фаж бэхийг цааснаасаа арилгахаар оролдохыг харлаа.
- Би түүний сургуульдаа хэрхэн дүрсгүйтсэн тухай бас ярьж эхлээгүй байна шүү.
- Ид шидийн яаманд Хогварстын сурагч сургуульдаа буруу хэрэг хийсний төлөө шийтгэх эрх мэдэл байхгүй гэж Дамблдор эелдэг боловч хүйтнээр хэллээ.
- Аан. Тэр сургууль дотор биеэ авч явах нь бидний хэрэг биш үү? Та үнэхээр тэгж бодож байна уу?
- Ид шидийн яамнаас Хогвартсын сурагчыг хөөх эрх байхгүй гэдгийг би дахин сануулъя, Корнелиус. Найман сарын хоёрны үдшийн хувьд ийм баталгаагүй хэргийн

төлөө шидэт саваа хурааж авах нь утгагүй зүйл. Ингээд би ахин тэр өдрийг сануулья. Таны гайхалтай сайхан хурдан хуулиа баримталж байгааг бахдахын сацуу санд мэнд зөрчихгүй гэдэгт эргэлзэхгүй байна.

- Хуулийг өөрчилж болно гэж Фаж ууртай хэлэв.

- Мэдээж болно. Иймээс та алхам тутамдаа өөрчилж байгаа юм шиг сэтгэгдэл төрж байна, Корнелиус. Яагаад хэдхэн долоо хоногийн өмнө намайг гарахыг шаардаж байсан Визенгамотын шүүх өчүүхэн асуулт тавихын төлөө насанд хүрээгүй шидтэнийг бүрэн бүрэлдхүүнээрээ шүүж байна?

Хэд хэдэн шидтэнгүүд аягүйцсэн төрхтэй болов. Фажын царай тоосго шиг хүрээнтэн улайв. Бахтай адил шидтэн Дамблдор руу царайны хувиралгүй ширтэнэ.

- Харри буруутгалд өөрийн хамгаалалттай ирэх ёстой нь надад илэрхий байна л даа. Ингээд одоо бид шүүхийн тогтоолыг хүлээж байна.

Дамблдор чимээгүй болоод хурууны үеүдээ нийлүүлэв. Уурссан Фаж түүн рүү муухай харна. Харри Дамблдор руу харан тайвшруулах шинж тэмдэг хүлээсэн ч болсонгүй. Тэр итгэлгүй байсан ч Дамблдор Визенгамотод шийдвэр гаргахаар зүйтэй үг хэллээ. Гэхдээ захирал ахиад Харрийн анхаарал татах оролдлогыг үл тоомсорлов. Тэр урьдын адил Визенгамтын гишүүд шивнэлдэж байгаа сандал руу харсаар байв.

Харри хөл рүүгээ ширтлээ. Зүрх нь хэвийн хэмжээнээс томорч хавиргаа чанга дэлсч байв. Тэр итгэлгүй байсан ч сайн сэтгэгдэл төрүүллээ. Түүнээс асуусан бол Дементоруудын тухай, яаж унаж, Дадлиг арай үнсээгүй тухай ярих байлаа ...

Тэр хоёр ч удаа Фаж амаа нээхийг хараад зүрх нь дэлбэрэх шахам цохилж агаар дутагдаж байгаа юм шиг санагдахад гүнзгий амьсгал аваад гутал руугаа харлаа.

Дараа нь шивнэлт намдлаа. Харри шүүгчид руу харахыг хүссэн ч үдээсээ судалсан нь хамаагүй дээр байв.

- Хэн цагаатгахыг хүсч байна? гэх хатагтай Боунсын нүргэлүүлэв.

Харри толгойгоо өргөв. Агаарт олон гар өргөджээ ... хагасаас олон! Тэр амьсгаадсаар тоолохыг оролдсон ч дуусахаас нь урьтаж хатагтай Боунс,

- Хэн буруутгахыг хүсч байна гэлээ?

Фаж гараа өргөхөд түүний баруун талд нь сууж байсан шидтэн болон хоёрдугаар эгнээний өтгөн сахалтай, буржгар үстэй шидтэн тэргүүтэй хагасаас бага хүмүүс

гараа өргөв.

Фаж эргэн тойрноо хараад хоолойд нь юм тээглэсэн аятай гараа буулгав. Дараа нь хоёр гүнзгий амьсгал аваад ууртайгаар,

- Тэгэхээр сайн байна. Бүх төрлөөр цагаатгагдлаа гэв.
- Маш сайн байна гэж Дамблдор хөгжилтэй хэлээд босч шидэт саваагаа даллан хоёр түшлэгтэй сандлыг алга болгов.
- Би явах ёстой. Бүгдэд сайн сайхныг хүсье.

Ингээд Харри руу харалгүй танхимаас түргэн гарч явлаа.

БҮЛЭГ 9: ХАТАГТАЙ УИЗЛИЙН АЙДАС

Дамблдорын түргэн гарч явалт Харриг гайхшируулав. Тэр өмнөхийн адил гинжтэй сандалд суугаад цочирдол болон санаа амралттайгаа тэмцэхийг хичээж байлаа. Шүүгчид босож хоорондоо ярилцаар бичиг цаасаа цуглуулав. Эцэст нь Харри бослоо. Дамблдорын хажууд сууж байсан бах шиг шидтэнгээс өөр хэн ч түүнд анхаарал хандуулсангүй. Тэр Харри руу ширтэж байв. Харри түүний харцыг тоолгүй Фаж юмуу хатагтай Боунс руу харж явж болох эсэхийг мэдэхийг оролдов. Фаж ааш муутай байсан болохоор Харриг ажигласангүй, харин хатагтай Боунс цүнхэндээ төвлөрсөн хэвээр ажээ. Харри эхлээд хаалга руу итгэлгүй хэдэн алхам урагшилснаа дараа нь маш түргэн явлаа.

Хаалганы өмнө хүрээд гүйж эхэллээ. Тэр огцом гарахдаа гадаа зогсож байсан ноён Уизлитай золтой мөргөлдсөнгүй. Түүний царай түгшсэн байртай цонхийн цайжээ.

- Дамблдор юу ч хэлсэнгүй ...
- Цагаатгагдсан. Бүх заалтаар! гэж Харри түүнд хэлээд хаалга хаалаа. Ноён Уизли баясан гийж Харрийн мөрийг тэвэрлээ.
- Харри энэ чинь гайхамшигтай хэрэг! Мэдээж тэдэнд нотлох баримт байхгүй болохоор чамайг буруутгаж чадахгүй ...

Ноён Уизли хаалга нээгдэхэд чимээгүй болов. Визенгамотын шүүгчид гарч эхэллээ.

- Намайг луу идээсэй! Чамайг бүрэн бүрэлдэхүүнээр шүүсэн хэрэг үү? гэж ноён Уизли гайхан дуу алдаад Харриг хажуу тийш холдуулав.
- Тэгсэн бололтой гэж Харри чимээгүйхэн хэлэв.

Хоёр гурван шидтэн дэргэдүүр нь өнгөрөхдөө Харрид толгой дохиж, зарим шидтэн түүний дотор хатагтай Боунс ноён Уизлид өглөөний мэнд хүсэж, үлдсэн нь нүд салгалгүй ширтэж байлаа. Корнелиус Фаж, бах хоёр хамгийн сүүлд гарагсдын тоонд оров. Фаж Харри, ноён Уизли хоёрыг хананы нэг хэсэг адил хяламхийн харсан бол эмэгтэй Харри руу цэгнэн ширтэв. Танхимаас хамгийн сүүлд Перси гарч ирэв. Тэр Фажын адил эцэг болон Харриг үл тоомсорлон гартаа хуйлаастай цаас, үзэг бариад хонгилоор нуруугаа тэгшилж толгойгоо өндөрт өргөн яаран явлаа. Ноён Уизлийн ам үл мэдэг мурийсанаас өөрөөр хажуугаар нь гурав дахь хүү нь өнгөрсөн ямар нэг шинж тэмдэг мэдэгдсэнгүй.

- Би чамайг бүгдийг баярлуулахын тулд штабын байранд хүргээд өгье гэж хэлээд Персиг алга болохыг хүлээснээ есөн давхар руу явлаа.

- Би Бетнал-Грин руу явж жорлонгийн учрыг олох замдаа чамайг буулгая. Явцгаая ...

- Та жорлонгийн тухайд яах гэж байна? хэмээн Харри инээвхийлэв. Бүх зүйл гэнэтхэн ердийнхөөс тав дахин инээдтэй санагдав. Ой ухаанд нь тэр цагаатгагдсан, тэр Хогвартсд буцаж очно зэрэг зүйлс эргэлдэж байлаа.

- Өө, жирийн шившлэг хангалттай. Гэхдээ гол учир нь учруулсан хохиролдоо биш танхай этгээд хэн бэ гэдэгт байгаа юм. Шидтэнгүүдийн хувьд хөгжилтэй санагдаж болох ч энэ гүнзгийрвэл илүү хор хөнөөлтэй болж ... гэж ноён Уизли шатаар өгсөхдөө хэлэв.

Ноён Уизли чимээгүй боллоо. Тэд есдүгээр давхарт гарч иржээ. Тэднээс хэдэн алхамын зайд Корнелиус Фаж зогсоод өндөр цайвар үс, цонхигор царайтай хүнтэй ярилцаж байв.

Тэдний хөлийн чимээг сонсоод хоёр дахь хүн эргэж харлаа. Тэр ч гэсэн яриагаа зогсооход хүйтэн саарал нүд нь Харрийн царайд төвлөрөн нарийслаа.

- Тийм байж ... Патронус Поттер гэж Люциус Малфой хүйтнээр хэлэв.

Харри сэтгэл санаагаар уналаа. Энэ хүйтэн саарал нүдийг тэр өнгөрсөн удаад Үхэл залгигчийн юүдэн дор харсан билээ. Энэ шоолонгуй хоолойг тэр сүүлчийн удаад Волдеморт түүнийг харанхуй оршуулгын газарт тамлах үед сонссон билээ. Харри Люциус Малфой түүний урдаас харж зүрхэлж байна гэдэгт итгэж чадсангүй. Энэ хүн энд ид шидийн яаманд Корнелиус Фажтай эелдэгээр ярилцаад зогсож байна. Гэтэл ердөө хэдхэн долоо хоногийн өмнө Харри Фажад Малфойг Үхэл залгигч гэж хэлсэн билээ.

- Сайд сая надад чамайг азтай тохиолдлоор мултарсан гэж хэллээ, Поттер. Та маш хэцүү нүхнээс могой шиг мултраад гараад явчихдаг нь гайхалтай юм гэж ноён Малфой үгээ сунган хэлэв.

Ноён Уизли Харрийн мөрөн дээр дарлаа.

- Тиймээ. Би муугүй зугтдаг гэж Харри хэлэв. Люциус Малфой ноён Уизли руу харав.

- Аан, Артур Уизли ямар таатай юм бэ! Та энд юу хийж байгаа юм бэ, Артур?
 - Би энд ажилладаг гэж ноён Уизли хөндий хэлэв.
 - Яг энд биш биз дээ? гэж ноён Малфой асуугаад ноён Уизлигийн мөрөн дээгүүр цаана нь байгаа хаалга руу харлаа.
 - Би таны хоёр давхарт байдаг бөгөөд ... маглуудын бүтээлийг гэртээ сэм шившин хувиргадаг гэж бодсон юмсан?
 - Үгүй ээ, тийм биш гэж ноён Уизли эгдүүцлээ. Түүний хуруунууд Харрийн мөрөнд шигджээ.
 - Харин та энд юу хийж байгаа юм бэ? гэж Харри Люциус Малфойгоос асуулаа.
 - Сайд бид хоёрын хувийн яриа таньд хамаатай гэж бодохгүй байна, Поттер гэж Малфой хэлээд жанчаа илэн толийлгов. Харри халаасны дотор талд ямар нэг юм жингэнэхийг тод сонслоо. Бодвол дүүрэн алт байгаа бололтой.
 - Чи Дамблдорын хайртай сурагч болсон гэлүү. Тийм болохоор бусадтай эрээ цээргүй харьцаж болно гэж бодоогүй биз дээ. Сайдаа таны өрөө лүү өгсөх үү?
 - Тэгэлгүй яахав. Ийшээ, Люциус гэж Фаж хэлээд Харри, ноён Уизли хоёр луу нуруугаа харуулан эргэлээ.
- Тэд аяархан ярилцсаар хамтдаа явцгаалаа. Ноён Уизли Харрийн мөрийг цахилгаан шатны хаалга хаагдтал тавьсангүй.
- Хэрвээ түүнд Фажтай ярилцах ажил байгаа юм бол ягаад өрөөнд нь хүлээж болдоггүй юм бол? Энд байх ямар хэрэгтэй юм бэ? гэж Харри унтууцан асуув.
 - Би түүнийг шүүгчдийн танхим руу нэвтрэхийг оролдсон байх гэж бодож байна. Чамайг хөөгдсөн эсэхийг мэдэхийн тулд. Би одоо чамайг хүргэж өгөөд Дамблдорт зурвас орхино. Тэр Малфой ахин Фажтай ярилцсаныг мэдэх ёстой гэж ноён Уизли хэлээд ардаа хэн нэгэн байгаа эсэхийг шалган сэтгэл зовонгүй эргэж харлаа.
 - Ямар хувийн ажил тэд ярилцдаг байна?
 - Мөнгө л байхгүй юу. Малфой нэг бус жилийн турш өгөөмөр сэтгэлээр баруун зүүнгүй тарааж байгаа ... Энэ нь түүнд хэрэгтэй хүмүүстэй байхад тусалдаг юм. Дараа нь тэр тэдэнд гуйлтаараа хандана. Люциус Малфой маш сайн хэлхээ

холбоотой гэж ноён Уизли уурсан хэллээ.

Цахилгаан шат ирэхэд хэрвээ ноён Уизлигийн толгой дээгүүр эргэлдэх зурвасыг эс тооцвол шат хоосон байлаа. Тэр товчлуур дараад дотогш орохыг зангалаа. Хаалга хяхтнан хаагдав.

- Ноён Уизли хэрвээ Фаж Малфойн адил Үхэл залгигчтай ганцаарчлан уулзаж байвал бид түүнд Имперуус хэрэглэсэн эсэхийг яаж мэдэх вэ? гэж Харри удаанаар хэлэв.

- Бидний толгойд энэ ороогүй гэж бодож байна уу, Харри. Гэхдээ Дамблдор Фажыг өөрийн дураар оролцсон гэж бодож байгаа юм. Гэхдээ энэ Дамблдорыг тайвшируулахгүй байгааг хэлэх ёстой. Одоо энэ тухай ярих цаг биш, Харри гэж ноён Уизли нам дуугаар хэллээ.

Хаалга гулсан нээгдэхэд тэд бараг хүнгүй болсон үүдний танхим руу гарав. Үүдний жижүүр Эрик ахиад л «Өдөр тутмын Зөнч» сонины ард нуугджээ. Тэднийг алтан усан оргилуур өнгөрсөн хойно Харри саналаа.

- Хүлээгээрэй гэж тэр ноён Уизлид хэлээд халааснаасаа мөнгөтэй хүүдий гаргаж гэдрэг буцав.

Тэр сүрлэг алтан шидтэний царай луу харахад үл мэдэг сул дорой тэнэгдүү санагдав. Шидтэн эмэгтэй өрсөлдөгч рүүгээ таагүй инээмсэглэж харин албин, хүн морь хоёрын хувьд бол хэзээ ч хүнд эелдэг хандахгүй нь тодорхой байлаа. Зөвхөн гэрийн үйлчлэгч царайчилсан янзтай ширтэнэ. Харри хэрвээ Гермiona энэ үйлчлэгчийн хөшөөг харвал юу гэж хэлэх бол гэж бодон инээмсэглээд арваас илүү зоос доош унагалаа.

- Би мэдсэн юм! Чи үргэлж уснаас хуурай гардаг! хэмээн Рон гараа савчин орь дуу тавив.

- Тэд өөрөөр шийдэж чадахгүй. Чиний эсрэг ямар ч баримт байхгүй байсан гэж Гермiona хэлээд Харриг гал зууханд орж ирэхэд түгшсэндээ чичирсэн гараараа нүдээ арчив.

- Хэрвээ тэд намайг цагаатгана гэж мэдэж байсан юм бол чиний царай яагаад санаа амарч байгаа юм бэ? гэж Харри инээмсэглэн асуулаа.

Хатагтай Уизли нүүрээ арчив. Фред, Жорж, Жинни нар ялалтын дуу хадаана

«Цагаатгагдсан, цагаатгагдсан».

- Хангалттай! Тайвширч үз! гэж ноён Уизли хашгираад инээмсэглэн,
- Сонсооч Сириус бид ид шидийн яаманд Люциус Малфойтой уулзсан ... гэлээ.
- Юу гэнээ? хэмээн Сириус дуу алдав.
- Цагаатгагдсан, цагаатгагдсан, цагаатгагдсан ...
- Чимээгүй гэж би хэлсэн биз дээ! Тиймээ бид түүнийг есөн давхарт Фажтай ярилцаж зогсож байхыг харсан. Дараа нь Фаж түүнийг өрөө лүүгээ аваад явсан. Дамблдор энэ тухай мэдэх ёстой.

- Тэгэлгүй яахав. Бид түүнд уламжлах болохоор санаа зовох явдалгүй гэж Сириус хэлэв.

- Харин би одоо Бетнал-Грин руу явж бөөлждөг жорлонгийн учрыг олох хэрэгтэй байна. Молли, би Тонксыг орлох болохоор хоцорч ирэх байх. Оройн хоолонд Кингсли ирж магадгүй ...

- Цагаатгагдсан, цагаатгагдсан, цагаатгагдсан ...

- Фред, Жорж, Жинни хангалттай! гэж хатагтай Уизли гал зуухнаас нөхрөө гарч явахад тушаалаа.

- Харри хонгор минь ийшээ суугаад өдрийн хоол ид. Чи өглөөний цай нэг их уугаагүй.

Рон, Гермиона хоёр эсрэг талд нь суулаа. Гриммогийн арван хоёр дугаар байшинд ирсэн цагаас хойш тэдний царайд анх удаагаа аз жаргалтай байдал тодроход, Харри Люциус Малфойтой уулзсанаас хойш ахин санаа амрахыг мэдэрчээ. Энэ баргар байшин гэнэтхэн дулаахан эелдэг болж Кикимер хүртэл гал зуухны хаалгаар хамраа шургуулан юун чимээ шуугиан болоод байгааг ойлгохыг хичээв.

- Дамблдор чиний талд зогсоогүй бол тэд чамайг гарцаагүй шийтгэх байсан гэж Рон аз жаргалтай хоолойгоор хэлээд тавагнуудад төмсний нухаш дүүргэв.

- Тиймээ, тэр надад үнэхээр тусалсан гэж Харри зөвшөөрөөд эвгүйцэхээ мэдэрсэн ч «Тэр надтай ярилцана байх гэж бодсон. Эсвэл над руу харна гэж» хэмээн хүүхэд шиг зүйл ярьсангүй.

Энэ тухай бодтол сорви нь халуу шатан өвдсөн учир духаа барилаа.

- Чи яагаа вэ? гэж Гермиона түгшлээ.
- Сорви. Гэхдээ зүгээр дээ ... Энэ бүх хугацаанд үргэлж ингэж байгаа юм ... гэж Харри бувтналаа.

Бусад нь юу ч ажигласангүй. Бүгд хоол идэх зуураа Харрийн гайхамшигтай сайхан аврагдсан тухай ярилцана. Фред, Жорж, Жинни гурав өмнөхийн адил дуулсан хэвээр аж. Гермиона түгшсэн төрхтэйгээр юм хэлэх гэсэн ч Рон баяртайгаар,

- Харж байна уу. Дамблдор өнөө орой бидэнтэй баярлахаар ирэх байх гэлээ.
- Би тэгж бодохгүй л байна шүү, Рон. Тэр одоо маш завгүй байгаа гэж хатагтай Уизли эсэргүүцээд Харрид тахианы шарсан мах таваглаж өгөв.
- Цагаатгагдсан, цагаатгагдсан, цагаатгагдсан ...
- Чимээгүй байцгаа! гэж хатагтай Уизли хашгирав.

Дараагийн өдрүүдэд Харри Гриммогийн арван хоёр дугаар байшингаас Хогвартс буцах болсондоо баярласан цорын ганц хүн биш болохоо ажиглажээ. Харри цагаатгагдсан гэдгийг мэдээд Сириус баярлан гарыг нь чанга атгаад нүүр дүүрэн инээмсэглэв. Төдөлгүй тэр урьдын адил ууртай нөхөрсөг бус болж тэр ч байтугай Харритай хүртэл бага ярин ихэнхи цагаа ээжийнхээ өрөөнд Клювокрылтэй өнгөрүүлж байлаа.

- Чи өөрийгөө буруутгах хэрэггүй! Чиний байх ёстой газар бол Хогвартс гэдгийг Сириус маш сайн мэдэж байгаа. Минийхээр бол тэр хувиа бодож байгаа юм гэж Гермиона ширүүн хэлэхэд Харри, Рон хоёр гурван давхарын хөгцөрсөн шалыг сойздон угааж байлаа.

- Чи түүнд хэтэрхий ширүүн хандах юм. Чи энэ байшинд ганцаар үлдээж байна гэж төсөөлөөд үз дээ хэмээн Рон хөмсөг зангидан хэлээд хуруугаараа хөгцийг арилгахаар үрэв.

- Тэр ганцаараа биш! Энд чинь Фениксийн штабын байр байгаа биз дээ! Тэр зүгээр л Харриг үлдэж хамт амьдрах байх гэж найдаж байсан байх.

- Би тэгж бодохгүй байна. Би түүнээс үлдэж болохыг асуухад хариу өгөөгүй гэж Харри хэлээд алчуураа сэгсэрлээ.

- Тэр өөрийн найдаж байгаагаа харуулахыг хүсээгүй байх л даа. Тэгээд ч өөрийн буруутай болохоо мэдэрч байгаа. Яагаад гэвэл жинхэнээсээ чамайг

хөөлгөхийг хүсч байсан. Тэгвэл та хоёр хамтдаа цөлөгдөнө гэж Гермiona хэлэв.

- Больж үз! гэж Рон, Харри хоёр зэрэг хашгирахад Гермiona мөрөө хавчлаа.

- Юу гэж бодно уу дураараа бол. Гэхдээ би Роны ээжийн зөв гэж бодож байна.

Сириус чиний эцгийг орлохгүй, Харри.

- Чинийхээр бол тэр галзуу хүн үү? гэж Харри дургүйцэн асуулаа.

- Үгүй ээ, маш олон цагийг ганцаар өнгөрүүлсэн хүн гэж Гермiona зальжин хэлэв.

Тэр агшинд унтлагын өрөөний хаалгаар хатагтай Уизли орж ирэв.

- Дуусаагүй л байна уу? гэж тэр асуугаад толгойгоо шүүгээнд шургуулав.

- Харин би таныг болиулахын тулд ирсэн юм байх гэж бодлоо. Бид энд амьдрах гэж байгаа юм шиг хичнээн их хөгц цэвэрлэснийг мэдэх үү? гэж Рон гашуунаар хэлэв.

- Та нар бүлгийн төлөө ажиллахыг хүсч байна гэж ярих хэрэгтэй. Та нарын даалгавар бол штабын байрыг хүн амьдарч болоход туслах явдал.

- Би өөрийгөө гэрийн үйлчлэгч шиг мэдэрч байна гэж Рон үглэв.

- Хэрвээ чи тэднийг ямар аймшигтай амьдрал хүлээж байдгийг үнэн сэтгэлээсээ ойлгосон бол үйлчлэгч нарын төлөө идэвхтэй тэмцэж эхлэх хэрэгтэй! гэж Гермiona хатагтай Уизлиг гарсан хойно найдангуй хэлээд,

- Надад хүмүүст үргэлж цэвэрлэгээ хийх ямар аймшигтай болохыг үзүүлэх нэг санаа байна. Бид Гриффиндорын зочны өрөөг угаасны төлөө цалин авч болох юм. Энэ бидний сан хөмрөгийг нэмэгдүүлнэ гэлээ.

- Чамд хэдийг төлвөл энэ тэнэг зүйлээрээ оролдохоо болих юм? гэж Рон ууртай бувтнасан ч үүнийг зөвхөн Харри л сонсчээ.

Амралтын сүүлээр Харри Хогвартс явахыг илүү их хүсэх боллоо. Тэр Хагридтай уулзахыг тэсэн ядан хүлээж, квиддич тоглож тэр ч байтугай ургамал судлалын хүлэмжийн дэргэдүүр өнгөрөхийг хүсч байлаа. Энэ шүүгээний хагас нь цоожтой байдаг, харанхуй буланд нь сөөнгө доромжлогч Кикимер хэсүүчилж байдаг тоостой хуучин байшинг орхих нь өөрөө шагнал том болох байлаа. Сириусын хувьд Харри ярихыг хичээсэнгүй.

Волдемортын эсрэг тэмцэл хийхээр зохион байгуулагдсан штабын байрны амьдрал тийм ч сонирхолтой сэтгэл хөдлөм байсангүй

Фениксийн бүлгийн гишүүд ердийнхөөрөө ирж явцгаан заримдаа хооллохоор үлдэх бөгөөд бусад үед шивнэлдэн ярихад хатагтай Уизли гадны чих байлгахгүйн тулд санаа тавьж (түүний тоонд Уртасгагч чих орно) байсан тул Харри болон түүний найзуудад юу ч оногдсонгүй. Хэн ч тэр ч байтугай Сириус хүртэл Харрид анхны үдшийнх шиг юм хэлэх бодолгүй нь илт байлаа.

Амралтын сүүлчийн өдөр Харри шүүгээний орой дээрх Хэдвигийн баасыг цэвэрлэж байтал Рон унтлагын өрөөнд хоёр дугтуйтай орж ирлээ.

- Сурах бичгийн жагсаалт. Аль хэдийн ирэх байсан юм. Би бүр тэднийг илгээхээ мартсан юм байх гэж бодж байлаа шүү ... гээд дугтуйг Харрийн зогсож байсан сандал дээр тавилаа.

Харри сүүлчийн баасыг хамаад уутыг нь Роны толгой дээгүүр хогийн сав руу чулуудахад цаасан хайрцгыг залгиад чанга хэхрэв. Тэр дугтуйг задлав. Түүн дотор хоёр хуудас цаас байсны нэг нь хичээлийн жил есөн сарын нэгэнд эхлэнэ гэсэн ердийн сануулга, нөгөө нь чухал шаардлагатай номын жагсаалт байв.

- Хоёр шинэ ном нэмэгджээ. Миранда Гуссоклын «Ид шидийн сурах бичиг, тавдугаар дамжаа», Уилберта Слинкхардын «Ид шидийн хамгаалах онол».

Тас!

Харрийн дэргэд Фред, Жорж хоёр шилжин гарч ирэв. Тэр үүнд хэдийн дассан ч гэлээ золтой л сандлаасаа унасангүй.

- Бид Слинкхардын номыг хэн жагсаалтанд оруулсан талаар асуулт тавих гэсэн юм? гэж Фред юу ч болоогүй аятай хэлэв.

- Энэ нь Дамблдор хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багшаар хэнийг сонгосныг мэдэхэд хэрэг болох юм гэж Жорж дэмжив.

- Цаг тухайд нь гэж Фред хэлэв.

- Та нар юуны тухай яриад байна? гэж Харри асуугаад шалан дээр харайн буулаа.

- Бид хэдэн долоо хоногийн өмнө Уртасгагч чихээр ээж аав хоёрын яриаг сонссон юм. Дамблдор энэ жил багш хайхад жинхэнэ асуудал үүсч байгаа гэсэн.

- Хэрвээ сүүлчийн дөрвөн жил болсон явдлыг санах юм бол гайхах юмгүй гэж Жорж хэлэв.

- Нэг нь халагдаж, нөгөө нь үхэж, гурав дахь нь ой санамж нь арчигдаж, дөрөв дэх нь есөн сарын турш цоожтой авдарт хэвтсэн гэж Харри хуруу даран тоолон хэллээ.

- Рон чи яагаа вэ? гэж Фред гэнэтхэн сониучирхав.

Рон хариулсангүй. Харри эргэж харав. Рон амаа ангайн хөдөлгөөнгүй зогсоод Хогвартсаас ирсэн захиаг харж байв.

- Тэнд юу байгаа юм? гэж Фред тэсч ядан асуугаад мөрөн дээгүүр нь өнгийлөө. Фредийн ам бас ангайлаа.

- Ахлагч гэнэ үү? Ахлагч уу? гэж тэр нүдэндээ итгэлгүй асуулаа.

Жорж урагш ухасхийн Роны гараас дугтуйг суга татан авлаа. Түүний алган дээр ямар нэгэн алтлаг улаан юм унав.

- Байж боломгүй юм гэж Жорж нам дуугаар хэлэв.

- Алдаа байх. Хэний ч ухаанд Рон ахлагч хийж чадна гэж орохгүй гэж Фред хэлээд Роны захиаг гэрэлд өргөн усан тэмдэглэгээг нь шалгав.

Ихрүүд Харри руу зэрэг эргэн хараад,

- Бид үүнийг чамайг байх болно гэж итгэлтэй байсан! гэж Харри л тэднийг ямар нэг аргаар хуурсан аятай хэлэв.

- Бид Дамблдорч чамаас өөр хувилбар байхгүй гэж бодсон! хэмээн Жорж эгдүүцсэн байртай дэмжив.

- Гурван шидтэний тэмцээнд хожсон! гэж Фред хэллээ

- Бас түүний хийсэн олон галзуу зүйлийг аваад үз л дээ гэж Жорж Фредэд хэлэв.

- Тиймээ. Харри хэтэрхий олон хэрэг хийсэн. Бид түүнийг хүндэтгэж байна гэж Фред бодлогоширонгуй хэлэв.

Тэр Харрийн мөрөн дээр алгадаад Роныг зэвүүцсэн харцаар ажиглав.

- Ахлагч ... Бяцхан Ронни ... Ахлагч!

- Ээжийн яахыг төсөөлөхөөс ч дотор муухайрч байна гэж Жорж дуу алдан ёолоод Роны ахлагчын тэмдгийг бохир юманд хүрсэн аятай буцааж өглөө.

Рон нэг ч үг хэлэлгүй тэмдэг рүүгээ хараад Харриг жинхэнэ эсэхийг нь шалгахыг гуйх мэт сунгалаа. Харри тэмдгийг авав. Тэнд том «С» үсгэн дээр Гриффиндорын арслан байв. Тэр ийм тэмдгийг Персигийн цээжин дээр Хогвартс явах анхны өдрөө харж билээ.

Хаалга цохих чимээ гарснаа онгойлоо. Өрөөнд Гермiona орж ирлээ. Хацар нь улайж үс нь сэгсийжээ. Тэр гартаа дугтуй барьсан байв.

- Чи ... чи авчихаа юу?

Тэр Харрийн гарт байгаа тэмдэг рүү харснаа хашгирлаа.

- Би мэдээд байсан юм! Би ч гэсэн, Харри бас ахлагч! гэж тэр хөөрөн мэдэгдээд захиагаа даллав.

- Үгүй үгүй. Энэ бол Рон, би биш гэж Харри түргэн хэлээд тэмдгийг Ронд сунгалаа.

- Энэ чинь ... юу гэж байгаа юм?

- Рон ахлагч болохоос биш биш гэж Харри тайлбарлав.

- Рон гэнээ? Гэхдээ ... чи итгэлтэй байна уу? Миний бодлоор ... гэж Гермiona амаа ангайн хэллээ.

Тэр улайлаа. Рон түүн рүү өдсөн байртай хараад,

- Захиа миний нэр дээр ирсэн гэлээ.

- Би ... Энэ чинь сайн хэрэг байна шүү дээ! Баяр хүргэе, Рон. Энэ болж жинхэнэ ... гэж Гермiona будилсан янзтай хэлэв.

- Гэнэтийн явдал гээд Жорж толгой дохив.

- Үгүй ... Яагаад үгүй гэж. Рон бүгдийг хийсэн ... Тэр үнэхээр ... гээд Гермiona улам улайлаа.

Тэдний ард хаалга онгойж өрөөнд хатагтай Уизли угааж цэвэрлэсэн жанч барьсаар орж ирэв.

- Жинни надад номын жагсаалт ирсэн гэж хэллээ гээд тэр дугтуй руу хальт харснаа жанчуудыг тусад нь эвхэн тавилаа.

- Надад өг, би өнөөдөр Тахир гудамж руу явж та нарын ном болон бусад зүйлсийг авна. Рон би чамд шинэ хүрэм авахаас. Чи итгэмээргүй түргэн өсч байна ... Чи ямар өнгийг хүсч байна?

- Түүнд тэмдэгтэй нь адилхан улааныг авч өг гээд Жорж егөөдөнгүй хэлэв.

- Юутай адилхан гэнээ? хэмээн хатагтай Уизли асуугаад хүрэн оймсыг Роны хувцсан дээр тавив.

- Тэмдэг. Түүний ахлагчын гялалзсан шинэ тэмдгэнд зориулж гэж Фред сайн сайхныг хүсэхээсээ илүү мууг хүссэн хүний шинжтэй хэллээ.

Фредийн үг хүрэм эвхэж байсан хатагтай Уизлийн санаанд даруй буусангүй.

- Тэр ... гэхдээ ... Рон чи биш? ... Рон түүнд тэмдгээ үзүүлэв.

Хатагтай Уизли Гермionaгийн адил хашгирав.

- Итгэж ч чадахгүй нь! Ерөөсөө ч итгэж чадахгүй нь! Өө, Рон минь ямар гайхамшигтай хэрэг вэ! Ахлагч! Энэ ч манай гэрийн хүн бүрд уламжлал болсон зүйл дээ!

- Харин Фред бид хоёр гэр бүлийн гишүүн биш юм биз дээ? Хөршүүд үү? гэж Жорж эгдүүцэхэд эх нь түүнийг түлхээд бага хүүгээ тэврэхээр ухасхийв.

- Эцэг чинь сонсоод баярлана даа! Рон минь би чамаар ямар их бахархаж байна гээч! Ямар сайхан мэдээ вэ! Цаашдаа Билл, Перси хоёрын адил бүх сургуулийн ахлагч болж болох юм. Энэ бол зөвхөн эхний алхам! Ямар их баяр хөөр вэ, би маш хөөрч байна, Ронни ...

Фред, Жорж хоёр түүний нурууны ард огиулж байгаа чимээ гаргасан ч хатагтай Уизли тоосонгүй. Тэр Роны хүзүүгээр чанга тэврээд ахлагчын тэмдэг шигээ улаан болсон нүүрэн дээр нь үнсэв.

- Ээжээ ... хэрэггүй ... ээжээ, тайвшир даа гэж тэр түүнийг түлхэн бувтналаа. Хатагтай Уизли түүнийг тавиад хүндээр амьсгаадан,

- За тэгэхээр? Персид бид ууль авч өгсөн гэтэл чамд хэдийн байгаа гэлээ.

- Та юуны тухай яриад байна? гэж Рон чихэндээ итгэлгүй асуулаа.

- Чамд үүний төлөө бэлэг авч өгнө. Сайхан ёслолын хувцас байвал яаж байна? гэж Хатагтай Уизли уулга алдав.

- Хэрэггүй бид түүнд худалдаж аваад өгчихсөн гэж Фред гүнээ харамссан байртай хэлэв.

- Эсвэл шинэ тогоо ч юм уу? Чарлийн хуучин тогоо зэвэнд идэгдчихсэн. Эсвэл шинэ харх ч юм уу? Чи Коростад их хайртай байсан даа ...

- Ээжээ надад шинэ шүүр авч өгч болох уу? гэж Рон найдангуй хэлэв. Хатагтай Уизлийн царай барайлаа. Шүүр бол хямд эд биш шүү дээ.

- Хамгийн сайныг нь авч өгөх албагүй! Зөвхөн ... шинэ хуучин нь бүр муудчихсан гэж Рон яаран нэмэрлэв.

Хатагтай Уизли тээнэгэлзсэнээ инээмсэглэв.

- Бололгүй яахав ... Хэрвээ шүүр худалдаж авах болсон бол би яарах хэрэгтэй болох нь. За дараа уулзая ... Миний жижигхэн Ронни ахлагч! Чемоданаа баглахаа битгий мартаарай ... Ахлагч ... Бүх бие минь чичирч байна...

Тэр Роны хацар дээр ахин үнсээд чанга шуухитнан өрөөнөөс гарлаа. Фред, Жорж хоёр бие бие рүүгээ харлаа.

- Хэрвээ бид чамайг үнсэхгүй бол зүгээр биз дээ, Рон? гэж Фред хуурамч санаа зовсон өнгөөр хэлэв.

- Хэрвээ хүсч байвал дүр үзүүлж болох юм гэж Жорж нэмэрлэв.

- Та хоёр амаа тат! гэж Рон хэлээд тэднийг ууртай харцаар ажиглав.

- Тэгэхгүй бол яана гэж? Биднийг хичээлийн дараа үлдээх үү? гээд Фредийн царайд зальжин инээмсэглэл тодров.

- Түүний оролдож үзэхийг харах юмсан гэж Жорж инээвхийлэв.

- Хэрвээ буруу зүйл хийх юм бол үлдээх л болно доо! гэж Гермiona уурсан хашгирав.

Фред, Жорж хоёр хөхрөлдлөө.

- Гермiona, болно гэж Рон бувтналаа.

- Жорж! Бид алхам бүрдээ биеэ анхааралтай авч явах шаардлагатай болох нь.

Энэ хоёр тоглоом муу ойлгодог гэж Фред хэлээд айсандаа чичирсэн дүр үзүүлэн баашлав.

- Тиймээ бидний хууль зөрчдөг дүрсгүй явдал төгсгөл болжээ гээд Жорж

толгой сэгсэрлээ.

Ихрүүд хөхрөлдсөөр тасхийх чимээ гарган алга болов.

- Та хоёрыг дээ! Тэдэнд бүү анхаарал хандуул. Атаархсандаа тэгж байгаа юм! гэж Гермiona уурсан хэлээд Фред, Жорж хоёрын инээд сонсогдож байгаа адар луу харлаа.

- Үгүй ээ, тэгж бодохгүй байна. Тэд үргэлж ахлагч бол усан тэнэгүүдийн хийдэг ажил гэдэг байсан юм гэж Рон эргэлзэнгүй хэлээд адар руу харснаа илүү баяртай өнгөөр,

- Ямар ч л гэсэн ... тэдэнд хэзээ ч шинэ шүүр авч өгөхгүй! Би сонгож болохгүй нь харамсалтай байна ... «Нисдэг лус»-д бидний мөнгө хүрэхгүй гэхдээ

«Зүлгэгч»-ийн шинэ загварыг авч болох юм. Энэ ч бас муугүй. Хэвээ би түүнийг араас гүйж «Зүлгэгч» хүсч байгаагаа хэлвэл яадаг бол ...

Тэр өрөөнөөс харвасан сум шиг гараад Харри, Гермiona хоёрыг орхилоо.

Харри яагаад ч юм Гермiona руу харахыг хүссэнгүй. Тэр ор луугаа эргээд цэвэрлэсэн жанчыг авч чемодандаа хийлээ.

- Харри? ... гэж Гермiona итгэлгүйхэн хэлэв.

- Баяр хүргэе, Гермiona. Гайхалтай. Ахлагч. Маш сайхан гэж Харри хэлэхдээ хоолойгоо ууртайгаар сонсогдуулахгүйг хичээсэн авч гадных юм шиг сонсогджээ.

- Баярлалаа. М-м-м ... Харри ... Би чамаас Хэдвигийг түр авч болох уу. Эцэг эхдээ мэдэгдэх гэсэн юм. Тэдэнд үнэхээр таатай санагдана даа. Ахлагчыг тэд ойлгодог юм.

- Хэлэх юу байна ав! гэж Харри ууртай хоолойгоор хэллээ.

Тэр чемодан руугаа бөхийгөөд жанчаа хийнгээ ямар нэгэн юм хайж буй дүр үзүүлэв. Гермiona шүүгээ рүү очиж Хэдвигийг дуудав. Хэдэн хормын дараа хаалга хаагдахад Харри хоосон зураг инээх, хогийн сав уулийн баасанд ханиалгахыг сонслоо.

Тэр дээшээ босоод эргэж харлаа. Гермiona Хэдвигийн хамт явчихжээ. Харри орон дээрээ удаанаар суугаад хувцасны шүүгээний хөл рүү ширглээ.

Тэр тавдугаар дамжаанд ахлагч томилдог гэдгийг мартсан байна шүү дээ. Түүнийг хөөгдөх явдал зовоож байсан болохоор тэмдгийг ямар хүн авч болох талаар бодсонгүй. Гэхдээ тэр хэнийг санах байсан гэж ... хэрвээ энэ тухай бодоод үзвэл ...

үүнийг хүлээж байсан билүү?

Үүнийг биш гэх хоолой түүний толгойд сонсогдлоо.

Харри ярвайн гараараа нүүрээ хаалаа. Тэр өөртөө худал хэлж чадсангүй. Хэрвээ тэр ахлагчын тэмдгийн талаар санаж байсан бол Роныг биш түүнийг сонгохыг хүлээх байсан. Тэр Драко Малфой шиг биеэ тоож байна гэж үү? Өөрийгөө бүгдээс шилдэг гэж бодож байна гэж үү? Раноос илүү гэж итгэж байгаа юм болов уу?

Үгүй гэх дуу дотроос нь сонсогдов.

Тэгвэл юу үнэн гэж? Харри хэмээн түгшин асуугаад мэдрэмжийнхээ урчыг олохоор оролдов.

Би квиддич сайн тоглодог. Гэхдээ бусад зүйлээрээ ялгарахгүй.

«Яг үнэн» гэж Харри бодлоо. Тэр хичээл дээр Раноос дээрддэг гэж үү? Гэхдээ хичээлээс гадуур бол? Рон, Гермиона хоёртой Хогвартст сурах анхны жилдээ болсон адал явдлын хувьд бол үргэлж хөөгдөх эрсдэл заналхийлж байсан биз дээ?

Юу гэж дээ Рон, Гермиона хоёр ихэнхи цагаа надтай өнгөрүүлсэн гэх хоолой Харрийн толгойд сонсогдлоо. Бүх цагаа биш гэж Харри татгалзав. Тэд намайг Квиреллтэй зодолдоход туслаагүй. Тэд Реддл болон Василисктэй тэмцэхэд ирээгүй. Би ганцаараа Сириусыг Азкабанаас зугтдаг шөнө Дементоруудыг хөөсөн. Тэд надтай Волдеморт эргэн төрөх үед оршуулгын газар хамт байгаагүй ...

Түүнийг Сириусын гэрт ирсэн үеийнх шиг шударга бус мэдрэмж эзэмдэн авлаа. «Би гарцаагүй илүү ихийг хийсэн. Би тэдний хэнээс ч илүү ихийг хийсэн» гэж Харри бодов.

Гэхдээ магадгүй Дамблдор хүмүүсийг ахлагч болгохоор сонгохдоо аюултай адал явдалд оролцсоноор нь дүгнэдэггүй байх ... Магадгүй түүнд өөр чухал шалтгаан байсан байх ... Ронд байхад чамд байхгүй гэх шударга хоолой сонсогдов.

Харри нүдээ нээгээд хурууны завсраараа шүүгээний хөл рүү харахад Фредын хэлсэн «Хэний ч толгойд Роныг ахлагч болно гэж санаанд орохгүй» гэсэн үг сонсогдлоо. Харри тургилав. Гэсэн ч хормын дараа өөртөө дур гутлаа.

Рон Дамблдороос ахлагчын тэмдгийг гуйгаагүй. Түүний буруу байхгүй. Харин одоо Роны хамгийн дотны найз Харри тэнэг аваагүйн төлөө дүнсийн уурлаж байгаа хэрэг үү? Ихрүүдийн хамт Роны ардаас инээлдэх үү? Роны амьдралд анх удаа Харриг

давсан зүйл болсон юм биш үү?

Тэгтэл Харри Роны шатан дээрх хөлийн чимээг сонслоо. Тэр босож шилээ засаад

Роныг өрөөнд гүйн орж ирэхэд царайдаа инээмсэглэл тодруулав.

- Түүнийг гүйцсэн! Зүлгэгч худалдаж авах хүсэлтэйгээ хэлсэн гэж Рон баяртайгаар мэдэгдэв.

- Гайхалтай гээд Харри хоолойд нь уур хилэн сонсогдохоо больсныг мэдрээд санаа амарлаа.

- Сонсооч, Рон. Чи сайн байна. Роны инээмсэглэл бөхөв.

- Би хэзээ ч өөрийгөө ахлагч болно гэж бодсонгүй! Би чамайг гэж бодсон гээд тэр толгой сэгсэрлээ.

- Үгүй дээ, надад хэтэрхий олон асуудал байгаа гэж Харри Фредийн үгийг давтав

- Тиймээ, магадгүй юм ... За, чемоданаа баглацгаах уу?

Энд ирснээс хойш тэдний юм хум хичнээн их болсныг хэлэхэд ч аймшигтай байв. Тэд үдээс хойш сургуулийн номоо дөнгөж эмхэлж амжлаа. Харри Рон ахлагчын тэмдэгээ хаа ч орхихгүй байгааг ажиглажээ. Эхлээд ширээн дээр тавьснаа, дараа нь өмднийхөө халаасанд хийж, эвхээстэй жанчин дээр хэрхэн улаарч байгааг харж болохоор байлаа. Зөвхөн тэгэхэд л Фред, Жорж хоёр түүний тэмдгийг Үүрд мөнхийн шидээр духанд нь наахыг санал болгон Рон тэмдгээ бор оймсондоо хийн чемоданд түгжлээ.

Зургаан цагт хатагтай Уизли Тахир гудамжнаас номнуудтай ирэхдээ урт хуйлаастай зүйл авчирав. Рон түүнээс бэлэг авахдаа тэсч ядан дуу алдав.

- Одоо задлана гэж бүү бодоорой. Бүгд хооллох гэж байгаа болохоор доош бууцгаа гэж хэлсэн ч Рон агшин зуур цаасыг урж шинэ шүүрийнхээ дюйм бүрийг бахдан харлаа.

Гал зууханд хатагтай Уизли ширээн дээр бичигтэй том улаан далбаа өлгөжээ. ШИНЭ АХЛАГЧ

РОН, ГЕРМИОНА ХОЁРТ

БАЯР ХҮРГЭЭ!

Бүх амралтын турш Харри түүний ийм баяртай байхыг харсангүй.

- Өнөөдөр бидэнд ер бусын оройн зоог байгаа. Багахан баярын гэж тэр Харри, Рон, Гермиона, Фред, Жорж, Жинни нарыг бууж ирэхэд хэлэв.

- Эцэг чинь болон Билл нар удахгүй ирнэ, Рон. Би тэдэнд ууль илгээсэн болохоор их хөөрч байгаа гэж баясан нэмэрлэв

Фред нүдээ эргэлдүүлэв.

Сириус, Люпин, Тонкс, Кингсли Бруствер нар гал зууханд хэдийн байлаа. Харри цөцгийний шар айраг дүүргэж автал Хурц нүдэт Грюм хүнд алхалсаар орж ирэв.

- Өө, Аластор чамайг харахад ямар баяртай байна гээч. Бид чамаас юм гуйх гэсэн юм. Чи зочны өрөөний бичгийн ширээн дотор юу байгааг хараад өгч чадахгүй биз? Бид түүнийг нээхийг зүрхлэхгүй байгаа юм. Гэнэт дотор нь аймшигтай юм байвал яана гэж хатагтай Уизли Хурц нүдэтийг аяны жанчаа тайлахад хэлэв.

- Тэгэлгүй яахав, Молли.

Грюмын хурц цэнхэр шидэт нүд дээшээ эргэлдэн гөлрөөд гал зуухны адар ширтэв.

- Зочны өрөөнд гэнээ ... Булангийн ширээнд үү? Харсан, харсан ... Тиймээ, энэ Боггарт ... Би түүний учрыг олохыг хүсч байна уу, Молли? хэмээн Грюм сөөнгөтөөд нүдээ нарийсгав.

- Үгүй ээ, би дараа учрыг нь олчихъё. Амарч юм уу. Бидэнд үнэнийг хэлэхэд багахан баяр болж байна гээд тэр улаан далбаа руу зааснаа,

- Гэр бүлийн дөрөв дэх ахлагч! гэж дуу алдаад Роны үсийг сөргүүлэн илэв.

- Ахлагч гэнээ? хэмээн Грюм Рон руу жирийн нүдээрээ хараад шидэт нүдээ эргэлдүүлэв. Харрид нүд түүнийг нэвт харчих шиг таагүй мэдрэмж төржээ.

- Баяр хүргэе. Дамблдор чамайг шившлэгийн эсрэг тэмцэх чадвартай учир сонгосон байх гэж Грюм Рон руу жирийн нүдээрээ ширтсэн хэвээрээ хэлэв.

Ронд ийм зүйлийг хүлээгээгүй бололтой ч түүнийг хариулж амжихаас урьтаж эцэг болон том ах нь ирлээ. Хатагтай Уизли өндөр сэтгэгдэлтэй байсан болохоор тэдний хамт ирсэн Наземникусыг тээршаасангүй. Тэр энд тэндээ төвийсөн хачирхалтай урт пальто өмссөн байсан бөгөөд түүнийгээ Грюмын жанчтай хамт тайлж тавихыг хатуу татгалзав.

- Би хундага өргөө гэж ноён Уизли хэлээд цомуудыг дүүргэж өөрийнхийгөө

өргөв.

- Гриффиндорын шинэ ахлагч Рон, Гермиона хоёрын төлөө! Бүгд уугаад алга ташихад Рон, Гермиона хоёр баясан инээмсэглэв.

- Харин би хэзээ ч ахлагч байгаагүй гэж Харрийн ард байсан Тонкс бүгд тавагтай хоол өөр лүүгээ ойртуулахад хөгжилтэй хэллээ. Түүний үс өнөөдөр улаан лоолийн өнгөтэй болсон бөгөөд бүсэлхий хүртлээ урт болсон байсан нь Жиннигийн эгч юм шиг харагдуулах ажээ.

- Манай тэнхимийн эрхлэгч хэлэхдээ надад чухал шаардлагатай чадвар байхгүй гэсэн.

- Ямар? гэж Жинни асуугаад жигнэсэн төмс авлаа.

- Биеэ сайн авч явах чадвар гэж Тонкс тайлбарлав.

Жинни хөхрөхөд Гермиона инээх эсэхээ мэдсэнгүй. Тэр цомтой цөцгийн шар айрагаас том балгаад ханиалгав.

- Харин чи, Сириус? гэж Жинни асуугаад Гермионагийн нуруун нуруун дээр алгадав.

Харрийн дэргэд сууж байсан Сириус инээмсэглэв.

- Хэний ч толгойд намайг ахлагч болгох бодол төрж байгаагүй. Би ихэнхи цагаа Жеймстэй хичээлийн дараа шийтгүүлэн өнгөрүүлдэг байлаа. Люпины хувьд өөр хэрэг тэр тэмдэг авсан.

- Дамблдор намайг найзуудаа сайн хянаж чадна гэж найдсан байх. Гэхдээ би үүнийг бүрэн дүүрэн алдсаныг нэмэх хэрэгтэй гэж Люпин хэлэв.

Харрийн зүрх гэнэт ёгхийлээ. Түүний эцэг бас ахлагч байгаагүй юм байна. Тэр гэнэтхэн сэтгэл амрахыг мэдэрсэнд тавгаа таатайхан дүүргэлээ.

Рон сонсохыг хүссэн хүн бүхэнд шинэ шүүрийнхээ тухай ярихад бэлэн байлаа.

- Арван секунтэд далан миль. Муугүй байгаа биз, тийм үү «Зүлгэгч-260» зөвхөн жар байдаг. Сүүлнийхээ үзүүрээр маш сайн салхи зүсэн хурдалдаг гэж «Шүүрээ сонго» сэтгүүлд бичсэн байсан.

Гермиона ихэд буурьтайгаар Люпинтэй гэрийн үйлчлэгч нарын талаар яриа өрнүүлэв.

- Энэ хүн чоныг ялгаварладагийн адил ухаангүй дэмий зүйл биш үү? Шидтэнгүүд өөрсдийгөө бусад амьтдаас дээр гэж үздэг аймшигтай бодлыг үндсээр нь ...

Хатагтай Уизли ердийнхөөрөө Биллтэй үсний талаар яриа үүсгэлээ.

- Чи угаасаа дажгүй харагддаг. Жаахан тайрчихвал бүр сайхан харагдах байх, тийм үү, Харри?

- Өө ... мэдэх юм алга гэж Харри саналыг нь асуусанд түгшин хэлээд буланд Наземникустай ярилцаж байсан Фред, Жорж хоёр луу очлоо. Харриг хараад Наземникус чимээгүй болсон ч Фред нүд ирмэв.

- Санаа зовох хэрэггүй. Харрид итгэж болно тэр манай ивээн тэтгэгч байгаа юм.

- Бидэнд Флетчер юу авчирсныг хараач гэж Жорж хэлээд хатаж хорчийсон хар буурцагтай адил үзүүлэв. Тэд хөдөлгөөнгүй хэвтэх хэдий ч аяархан шажигнах чимээ гарна.

- Хортой тэмтрүүл. Бид түүнийг Ажлаас зайлсхийгч зуушиндаа хэрэглэх гэж байгаа юм. Тэд «С» ангилалын гүйлгээтэй бараанд орсон ч асуудал үүссэн гэж Жорж тайлбарлав.

- Тэгээд Наземникус арван галлеон уу? гэж Фред асуув.

- Харин надад түүнийг олох ямар хэцүү байсан гээч. Намайг уучлаарай залуус минь би хорин кнат ч хасахгүй гэж Наземникус хэлээд нүдээ бүлтийлгэв.

- Тэр биднээр тоглож байгаа юм гэж Фред Харрид хэлэв.

- Энэ ч тодорхой. Хамгийн ихдээ гэвэл зургаан сикль, боодол үзэг болно гэж Жорж дэмжив.

- Болгоомжтой бай гэж Харри аяархан анхааруулав.

- Яасан? Ээж Роныг ахлагч болсон хөөрөөд ямар ч аюулгүй болсон гэж Фред хэлэв.

- Гэхдээ Грюм та нарыг хараад байна гэж Харри тайлбарлав. Наземникус түгшсэн шинжтэй ийш тийшээ харав.

- За яахав тэгвэл, залуусаа арав бол арав л биз түргэхэн өгөөрэй.

- Сайн байна, Харри! гэж Наземникус халаасаа ихрүүдийн гар дээрхээр дүүргээд хоол руу эргэхэд Фред бахдан хэлээд,

- Бид дээшээ явсан нь дээр байх гэлээ ...

Тэднийг дагуулан харахдаа Харри ичингүйрлийг мэдрэлээ. Түүний толгойд ноён ба хатагтай Уизли эрт орой нэгэн цагт Фред, Жорж хоёрын шидэт тоглоомын дэлгүүрийг мэдээд түүнд мөнгө хаанаас шаарддагдсаныг асуух болно. Тэр ихрүүдэд Гурван шидтэний тэмцээнээс ялсан шагналаа өгсөн ч хэрвээ энэ нь гэр бүлийн шинэ маргаанд хүргэж Персигийн адил хөндийрүүлэх юм биш байгаа даа? гэсэн бодол оров. Хатагтай Уизли Харриг хүүг шигээ үздэг хэдий ч Фред, Жорж хоёрын зохимжгүй ажилд тусалсныг мэдвэл яах бол?

Ихрүүдийн явахыг харж байсан Харри гэнэтхэн нэрээ сонслоо. Кингли Брустверийн хүнгэнэсэн хоолой сонсогдов.

- Дамблдор яагаад Поттерыг ахлагч болгосонгүй вэ?

- Түүнд ямар нэг шалтгаан байсан байх хэмээн Люпин хэлэв.

- Гэхдээ энэ түүнд итгэдгийг харуулна шүү дээ. Би тэгж л хийх байсан.

- Ялангуяа «Зөнч» сонин түүнтэй өдөр бүр тооцоо бодож байгаа үед ...

Харри тийшээ харсангүй. Тэр Люпин юмуу Кингли түүний сонсож байгааг мэдээсэй гэж хүсэхгүй байв. Тэр өлсөхгүй байсан ч ширээнд буцан сууж байгаа Наземникусыг дагалдав. Баярын сэтгэл хөөрөл түргэн алга болж ор луугаа явахыг хүслээ.

Хурц нүдэт Грюм хамрынхаа үлдсэн хэсгээр тахианы гуя үнэрлэж байв. Түүнээс хор үнэртэж байгааг шалгахаас нааш шүдэндээ зуусангүй.

- Улаан модоор модоор хийсэн бариул шившлэгийн эсрэг хамгаалсан өнгөлгөөтэй, чичрэлт тэнцүүлсэн удирдлагатай гэж Рон Тонкст хэлэх нь сонсогдов.

Хатагтай Уизли том эвшээлээ.

- Явж Боггартын учрыг олъё ... Артур залуу хүмүүсийг битгий хэтэрхий оройтуулаарай. Харри хонгор минь тавтай нойрсоорой.

Тэр гал зуухнаас гарлаа. Харри таваг руу харан анхаарал таталгүй эндээс яаж гарах вэ хэмээн бодлогоширов.

- Поттер, зүгээр үү? гэж Грюм сөөнгөтөв.
- Тиймээ, бүгд хэвийн гэж Харри худал хэлэв.

Грюм дашмагтайгаа балгаад хурц цэнхэр нүдээрээ Харриг хяламхийн харлаа.

- Нааш ир, би чамд сонирхолтой юм үзүүлье.

Грюм жанчныхаа дотор талын халааснаас үнгэгдсэн хуучин шидэт гэрэл зураг гаргаж ирэв.

- Фениксийн бүлгэм эхэндээ ийм байсан юм. Надад хэдэн үл үзэгдэгч цув байсан ч Подмор хамгийн сайныг нь аваад эргүүлж өгөөгүй. Би хүмүүсийг ийм зүйл харах дуртай гэж боддог.

Харри зургийг авлаа. Гэрэл зурган дээр бүлэг хүмүүс сууж байв. Түүнийг хараад нэг нь нөхөрсгөөр даллахад бусад нь хундагатайгаа өргөв.

- Энэ бол би гэж Грюм хэлээд өөрийгөө заасан нь илүүц хэрэг байлаа. Грюмыг гэрэл зурган дээр эндүүрэхийн аргагүй байсан бөгөөд буурал үсгүй хамар нь бүтэн байлаа.

- Миний хажууд Дамблдор нөгөө талд Дедалус Дингл байна ... Энэ бол Марлин Маккиннон түүнийг хоёр долоо хоногийн дараа гэр бүлийнх нь хамт алсан. Энэ бол Фрэнк болон Алиса Долгопупс нар.

Харри Алис Долгопупс руу харахад дотор нь эвгүй болов. Тэр түүнийг харж байгаагүй хэдий ч энэ дугуй нөхөрсөг царайг сайн мэдэх билээ. Түүний хүү Невилл амьд хуулбар нь байлаа.

- Хөөрхий амьтад. Тэдэнд ийм явдал тохиолдсоноос үхсэн нь дээр биз ... Харин энэ бол Эммелина Вэнс чи түүнийг мэднэ ... Энэ бол Люпин ... Бенжи Фенвик түүний биенээс зөвхөн хэсгийг олсон ... жаахан хажуу тийшээ бол гэж тэр гуйгаад зурган дээр хуруугаараа заахад дүрсүүд ард сууж байгаагаа харуулахын тулд баруун зүүн тийш хөдлөв.

- Энэ бол Эдгар Боунс ... Амелий Боунсын ах. Түүнийг бас гэр бүлийнх нь хамт дуусгасан. Агуу шидтэн байсан юм ... Стержис Подмор ямар залуу байна аа ... Карадок Дирборн хагас жилийн дараа алга болсон бид түүний биеийг ч олоогүй ... Хагрид энэ ч тэр чигээрээ байгаа биз ... Элфиас Дож чи түүнийг харсан, би түүний энэ тэнэг малгай өмссөнийг мартчихаж. Гидеон Пруэтт ... түүнийг ах Фабианых нь

хамт таван Үхэл залгигч алахыг оролдоход ах дүүс баатрын ёсоор амь үрэгдсэн ...
Хөдлөөрэй, хөдлөөрэй ...

Зурган дээрх хүмүүс ахин чихцэлдэн хажуу тийш болоход хамгийн арын эгнээ гарч ирэв.

- Энэ бол Дамблдорын ах Аберфорт, би түүнтэй нэг л удаа уулзаж байсан юм жигтэй амьтан ... Энэ бол Доркас Мелоуз, Волдеморт түүнийг өөрөө алсан ... Сириус үс нь урт ураагүй байсан юм ... Гэхдээ би чамайг үүнийг л сонирхох байх гэж бодож байна!

Харрийн зүрх булгилав. Түүн рүү эцэг эх нь инээмсэглэн харж байлаа. Тэдний дунд жижигхэн биетэй усархаг нүдтэй хүн сууж байсныг Харри агшин зуур танилаа. Сүүлт тэднээс урваж Волдемортод барьж өгөхийн өмнө байна шүү дээ.

- За? гэж Грюм асуулаа.

Харри зураг руу харахаа болиод Грюмын сорвитой царай луу ширтлээ. Грюм Харриг баярлана гэж бодсон нь илэрхий.

- Тиймээ гээд Харри ахин инээмсэглэхийг хичээв.

- Өө ... Сонсооч би чемоданаа цэгцлээгүй юм байна шүү дээ ...

Түүнийг тээшээ баглаагүй явдал зовоосонгүй. Түүнийг хажуугаар нь өнгөрөх үед Сириус түүнээс, «Грюм чамд юу үзүүлэв?» гэж асуухад Грюм тэдний зүг эргэлээ. Харри хэн нэгэн арас нь дуудахаас өмнө түргэхэн гал зуухнаас гарч шатаар өгсөв.

Тэр яагаад чичирснээ ойлгосонгүй. Тэр урьд нь эцэг эхийнхээ гэрэл зургийг харж байсан ч Сүүлттэй амьдаар нь тулгарч байсан ч ... Гэхдээ ийм явдалд бэлэн байсангүй. «Ийм зүйл хэнд ч таалагдахгүй» гэж тэр уурсан бодлоо.

Дараа нь тэр тойрон хүрээлсэн баяртай царай дундаас ... биеийнх нь хэсэг үлдсэн Бенжи Фенвик, баатрын ёсор үхсэн Гидеон Пруэтт, ухаан солиортлоо тамлуулсан Долгопупсууд ... Бүгд гэрэл зурган дээр хөгжилтэй даллан тэднийг ямар хувьд заяа хүлээж байгааг мэдэхгүй байлаа. Хэрвээ Грюм үүнийг сонирхоно гэж бодсон бол Харрид маш хүнд байлаа ...

Харри өлмий дээрээ гишгэлэн шатаар өгсөөд үйлчлэгч нарын толгойны дэргэдүүр өнгөрөв. Гэхдээ түүнийг хоёр давхар луу ойртоход чимээ сонсогдов. Зочны өрөөнд хэн нэгэн цурхиран уйлж байлаа.

- Хэн энд байна? гэж Харри асуув.

Хариулт байсангүй. Цурхиралт үргэлжилсээр. Харри хоёр гишгүүр алгасан харайгаад шатны талбайд дээр гарч зочны өрөөний үүдийг онгойлгов.

Харанхуй хананы дэргэд дальдичсан эмэгтэй зогсож байв. Гартаа шидэт саваа барьсан байх агаад бүх бие нь чичирнэ. Тоостой хивсэн дээр сарны гэрэлд үхсэн Рон хэвтэж байв.

Харри гэнэтхэн амьсгалж чадахаа больж шал цөмөрчих шиг санагджээ. Тархи нь хүйт оргилоо. Рон үхсэн гэж үү байж боломгүй юм ...

Гэхдээ хүлээгээрэй энэ үнэхээр байж боломгүй юм ... Рон доор байсан ...

- Хатагтай Уизли? гэж Харри сөөнгөтөн асуулаа.

- Р...р... ридикулус! гэж хатагтай Уизли цурхираад чичирсэн гараараа шидэт саваагаа Роны бие рүү чиглүүлэв.

Тас няс.

Роны үхсэн бие Биллийн бие болон өөрчлөгдөв. Нүд нь хоосорч шил шиг гөлийжээ. Хатагтай Уизли илүү чангаар цурхирав.

- Р... ридикулус! гэж тэр ахиад хашгирав. Тас няс.

Одоо шалан дээр Билл биш ноён Уизли хэвтэж байлаа. Бас үхсэн байв. Нүдний шил нь хэлтийж царайг нь даган цус урсана.

- Үгүй! Үгүй. Ридикулус! Ридикулус! Ридикулус! гэж хатагтай Уизли дуу алдав. Тас няс. Ихрүүдийн үхэл. Тас няс. Персигийн үхэл. Тас няс. Харригийн үхэл.

- Хатагтай Уизли холдоорой! гэж Харри хашгираад өөрийнхөө бие рүү харлаа.

- Өөр хүн оролдсон нь ...

- Энд юу болоод байна?

Өрөөнд Люпин гүйн орж ирэхэд хэдэн алхамын зайд Сириус дагалджээ. Харанхуйгаас Грюмын модон хөлийн чимээ сонсогдов. Люпин хатагтай Уизли руу харсанаа дараа нь Харригийн амьгүй бие рүү харж дор нь бүхнийг ойлгов. Тэр шидэтс саваагаа өргөөд хатуу бөгөөд тод хоолойгоор,

- Ридикулус! гэв.

Үхсэн Харри алга болов. Түүний оронд хэвтэж байсан газар нь мөнгөлөг бөмбөлөг

хөөрөв. Люпин шидэт саваагаа ганц даллахад бөмбөлөг мөнгөлөг үүл боллоо.

- Өө ... өө! гэж хатагтай Уизли шүлсээ залгиад нүүрээ гараараа хаан эхэр татан уйллаа.

- Молли. Молли, хэрэггүй гэж Люпин хэлээд ойртов. Хормын дараа тэр нулимстай нүүрээ мөрөнд нь наалаа.

- Молли энэ чинь ердөө Боггарт шүү дээ. Ердөө л өрөвдөлтэй тэнэг Боггарт гээд тайвшируулахыг хичээн толгойг нь илэв.

- Би тэдний үхлийг харлаа! Надад энэ зүүдлэгдэх байх! гэж хатагтай Уизли гингэнүүлэв.

Сириус хивсэн дээр Харрийн үхсэн бие хэвтэж байсан газар луу харлаа. Грюм Харри руу нүд салгалгүй ширтэнэ. Түүнд Грюмын шидэт нүд гал зуухнаас гарсан цагаас хойш мөрдөөд байсан мэт сэтгэгдэл төржээ.

- Артурд битгий хэлээрэй. Түүнийг миний ямар тэнэг байсныг мэдэхийг хүсэхгүй байна гэж гэж хатагтай Уизли эхэр татаад нүдээ арчлаа.

Люпин түүнд алчуур өгөхөд нусаа нийв.

- Намайг уучлаарай, Харри. Чи одоо миний тухай юу гэж бодох бол? Боггартыг ч хөөх чадваргүй ... гэж тэр чичирсэн хоолойгоор хэлэв.

- Юу гэж дээ гэж Харри эсэргүүцээд инээмсэглэхийг хичээлээ.

- Би зөвхөн санаа зовоод байна. Гэр бүлийн хагас бүлэгт байдаг ... Перси бидэнтэй ярихгүй байгаа ... Биднийг түүнтэй уулзуулахгүй ямар аймшигтай зүйл тохиолдоо вэ? Хэрвээ Артур бид хоёрыг үхвэл хэн Рон, Жинни хоёрт санаа тавих вэ? гэж хэлээд ахин нулимс асгаруулж эхлэв.

- Молли хангалттай. Одоо тийм болчихоогүй байна. Бүлэг сайн бэлтгэгдсэн бид Волдеморгын юу хүсч байгааг ...

Энэ нэрийг сонсоод хатагтай Уизли дуу алдан хашгирлаа.

- Өө, Молли минь алив л дээ. Хэн ч гэмтэхгүй гэж би амалж чадахгүй ер нь хэн ч үүнийг амалж чадахгүй. Гэхдээ бид өнгөрсөн удаагаас илүү дээр болсон. Чи яагаад тэр үед бүлэгт байгаагүйгээ ойлгохгүй байх шиг байна. Өнгөрсөн удаад бидний хүн бүр хорин Үхэл залгигчидтай тулж байлаа ...

Харри чимээгүй болж гэрэл зургаас гийх эцэг эхийнхээ царайг бодлоо. Тэр Грюм

урьдын адил түүнийг харсаар байгаа гэдгийг мэдэж байв.

- Персид санаа зовох хэрэггүй. Тэр буцаад ирнэ. Энэ ердөө цаг хугацааны асуудал. Волдеморт хөдөлж эхэлмэгц ид шидийн яамнаас биднээс уучлалт гуйна. Гэхдээ би уучлал гуйна гэдэгт итгэлгүй байна л даа гэж Сириус гашуунаар нэмж хэллээ.

- Харин Артур та хоёрыг үхвэл Рон, Жинни хоёрын хувь заяаны тухайд гэвэл хэмээн Люпин инээмсэглээд,

- Бид тэднийг өлсгөж үхүүлнэ гэж бодож байна уу? гэв. Хатагтай Уизли инээмсэглэв.

- Би ямар тэнэг юм бэ гэж тэр давтаад нүдээ арчлаа.

Гэхдээ Харри арван хормын дараа унтлагын өрөөний хаалгаа хаахдаа түүнийг тэнэг гэдгийг зөвшөөрч дасангүй. Тэр эцэг эхийгээ өөрсдийг нь болон найз нөхдийнх нь олонхын амьдрал удахгүй төгсгөл болно гэдгийг мэдэлгүй элэгдсэн хуучин гэрэл зурган дээр инээмсэглэж байхыг харсан. Нүдний өмнө Боггарт Уизлийн гэр бүлийн гишүүдийн цогцос болж байгаа дүр зураг үзэгдэв.

Гэнэтхэн сорви нь ахиад өвдөв.

- Энэ бүхнийг дуусгая, ойлгомжтой юу? гэж тэр хатуу хэлээд сорвио үрэв.

Өвдөлт намдлаа.

- Галзуурлын анхны шинж тэмдэг бол өөртэйгээ ярих явдал юм гэж хананы хоосон зураг хэллээ.

Харри түүний үгийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв. Тэр арай том болсноо мэдрээд ердөө хэдхэн цагийн өмнө Фред, Жорж хоёрын дэлгүүр Роны ахлагч болсон явдал зовоож байсан гэхэд итгэхэд бэрх санагдав.

БҮЛЭГ 10: ПОЛУМНА ЛАВГУД

Харри тайван бус унтлаа. Нойронд нь эцэг эх нь зурсхийн үзэгдсэн ч үг хэлсэнгүй. Хатагтай Уизли Кикимерийн үхсэн биеийн өмнө мэгшин уйлж тэдэн рүү титэм өмссөн Рон, Гермиона хоёр ширтэнэ, дараа нь Харри ахин цоожтой хаалгатай хонгилыг зүүдэллээ. Түүнийг давхийн сэрмэгц сорви нь ахин хатгуулан өвдөв. Рон хэдийн бүрэн хувцаслажээ.

- Түргэлээрэй, ээж сая галт тэрэгнээс хоцорч байна гэж хэлсэн.

Байшинд бөөн хөл үймээн дэгджээ. Харри түргэхэн хувцаслаад Фред, Жорж хоёрын үймүүлэхийг сонслоо. Тэр чемоданаа шившиж шатны уруу хөвүүлжээ. Чемодан шатаар буухдаа Жиннигийн хөл рүү цохиход гэдсээрээ унаад хоёр гишгүүр гулгав. Хатагтай Блэк, хатагтай Уизли хоёр хамаг чадлаараа хашгиралдав.

- Түүнд гэмтэл учруулж болох байлаа, тэнэгүүд минь!

- Бохир цустангууд миний эцгийн гэрээс зайлцгаа!

Харрийн өрөөнд сэтгэл түгшсэн Гермиона орж ирлээ. Тэр мөрөн дээрээ Хэдвигийг суулган, гартаа Живоглотыг барьжээ.

- Хэдвиг саяхан манай эцэг эхээс ирлээ. Чи бэлэн үү? Ууль далавчаа дэвээд торон дээрээ суулаа.

- Бараг л. Жинни зүгээр үү? гэж Харри асуугаад шилээ зүүлээ.

- Хатагтай Уизли түүнийг харж байгаа. Гэхдээ Хурц нүдэт Стержис Подморгүй ирээгүй болохоор хамгаалалт хангалтгүй байхад явахгүй гэсэн.

- Хамгаалалт гэнээ? Кингс Кросс буудалд хүрэхэд хамгаалалт хэрэгтэй юм уу? хэмээн Харри итгэсэнгүй.

- Бидэнд биш чамд хамгаалалт хэрэгтэй гэж Гермиона засав.

- Яах гэж? Волдеморт одоо чимээгүй байгааг би ойлгож байна. Тэр хогийн савны араас үсрэн гарч ирээд дайрах юм байх даа? гэж Харри уурсан асуулаа.

- Мэдэхгүй, би зөвхөн Хурц нүдэтийн юу хэлснийг л хэлсэн. Ямар ч байлаа гэсэн бид ойрын үед гарахгүй бол галт тэрэгнээс хоцрох нь байна гэж Гермиона сэтгэлээр унан хэлээд цагаа харлаа.

- Бүгд одоохон доошоо бууцгаа! гэж хатагтай Уизли орь дуу тавихад Гермиона

өрөөнөөс түлэгдсэн аятай үсрэн гарав. Харри Хэдвигийг торонд хийн түгжээд чемоданаа чирэн Гермионагийн араас хөдлөв.

Хатагтай Блэкийн хөрөг уурсан орилох хэдий ч хөшгийг нь татах талаар хэн ч санаа тавьсангүй. Хонгилд гарч байгаа чимээ шуугиан түүнийг ахиад сэрээх нь дамжиггүй байлаа.

- Харри, чи Тонкс бид хоёртой явна! гэж хатагтай Уизли «Эрлийзүүд!

Шаарнууд! Бузар амьтад!» гэсэн орилоон дундуур хашгираад,

- Чемодан болон уулиа орхи. Тээшийг Аластор авчрах болно ... Бурханы минь аврал, Сириус би Дамблдор үгүй гэж хэлсэн биз дээ!

Энэ агшинд Харри хатагтай Уизли чемодан хоёрын дундуур хонгилд гараад баавгайтай төстэй хар нохойг харлаа.

- Хэлэх ч үг алга ... Ойлгож байгаа бол толгойгоо дохь! гэж хатагтай Уизли цөхрөн хэллээ.

Тэр үүдний хаалгыг онгойлгоход есөн сарын нарны гэрэл тусав. Харри нохой хоёр түүний араас гарлаа. Тэдний ард хаалга хаагдахад хатагтай Блэкийн хашгираан агшин зуур чимээгүй болов.

- Тонкс хаа байна? гэж Харри асуугаад ийш тийшээгээ харлаа. Тэднийг явган зам дээр дөнгөж гармагц байшингийн дугаар алга болов.

- Тэнд хүлээж байна гэж хатагтай Уизли хэлэхдээ Харрийн дэргэд яваа хар нохойг харахгүйг хичээлээ.

Буланд тэдэнтэй хөгшин хатагтай мэндлэв. Тэр буурал үстэй, ягаан бүрх малгайтай байлаа.

- Сайн уу, Харри гэж тэр нүд ирмэн хэлснээ,

- Молли яарсан нь дээрх байх гээд цагаа харлаа.

- Мэдэж байна, мэдэж байна гэж хатагтай Уизли ёолон дуу алдаад алхаагаа хурдасгалаа.

- Хурц нүдэт биднээс Стержисийг хүлээхийг хүссэн. Хэрвээ Артур ахиад яамнаас машин авсан бол ... Гэхдээ Фаж түүнд одоо хоосон бэхийн сав ч өгөхгүй дээ ... Энэ маглууд яаж ид шидгүй аялдаг байна.

Аварга том хар нохой тэднийг тойрон баяртай үсчиж тагтаа хөөгөөд сүүлнийхээ араас эргэлдэв. Харри инээдээ барьж тэссэнгүй. Сириус маш удаан хугацаагаар гадагш гарсангүй. Хатагтай Уизли Петунья эгчийн адил хөмхийгөө зуув.

Тэд Кингс Кросс буудал дээр хорин хормын дараа хүрэв. Замд ямар ч үйл явдал тохиолдоогүй болохоор Сирус муур айлган Харриг хөгжөөлөө. Буудлын дотогш ороод тэд есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцанг тусгаарласан хаалт руу дөхөж очив. Ээлж ээлжээрээ тохиромжтой мөчийг хүлээн хаалтыг давж тавцан дээр гарахад Хогвартс Экспресс буухиа галт тэрэгнээс өтгөн хар утаа олгойдож байлаа. Тавцан дээгүүр сурагчид гэр бүлийнхэнтэйгээ холхилдоно. Харри танил үнэр болон урам зоригийг мэдэрлээ. Тэр буцаад ирж ...

- Бусад маань хоцроогүй байгаа гэж хатагтай Уизли түгшин хэлээд нэвтрэн орж ирсэн нуман хаалга руу харав.

- Сайхан нохой байна, Харри! гэж өндөр хүү хашгирав.

- Баярлалаа, Ли гэж Харри инээмсэглэхэд Сириус сүүлээ тэсч ядсан байртай хөдөлгөв.

- Өө, ашгүй дээ. Аластор тээштэй ирж байна, хараач ... гэж хатагтай Уизли санаа амран хэлэв.

Зөөгчийн малгай нүдээ далдлан тавьсан Грюм нуман хаалгаар хазганасаар тэргэнцэртэй ачаа түрэн орж ирэв.

- Бүх зүйл хэвийн. Биднийг дагаагүй ... гэж тэр хатагтай Уизли Тонкс хоёрт нам дуугаар хэлэв.

Хэдэн хормын дараа галт тэрэгний тавцан дээр ноён Уизли, Рон, Гермиона нар ирлээ. Тэд Грюмын адил тэргэнцэр түрж араас нь Люпин, Фред, Жорж, Жинни нар ирлээ.

- Бүгд тайван уу? гэж Грюм сөөнгөтөв.

- Тиймээ гэж Люпин хэлэв.

- Би Дамблдорт Стержисын талаар гомдол мэдүүлнэ. Долоо хоногт хоёр дахь удаагаа байхгүй байна. Яг л Наземникус шиг найдлагагүй болж байна гэж Грюм хэллээ.

- За найзууд минь биеэ бодож байгаарай. Чи ч гэсэн, Харри. Болгоомжтой

байгаарай гээд Люпин бүгдтэй гар барилаа. Тэр Харритай хамгийн сүүлд салах ёс гүйцэтгэхдээ мөрөн дээр нь алгадлаа.

- Энэ ч тодорхой гэж Грюм дэмжээд Харритай бас гар барингаа,
- Ингээд бүгдэд хамаатай зүйлийг санаж авцгаа. Захиагаа болгоомжтой бичээрэй. Ер нь бол захиа бичиж болно гэдэгт чинь эргэлзэж байна гэлээ.
- Та нартай танилцах их таатай байлаа. Удахгүй уулзана гэж найдъя гэж Тонкс хэлээд Гермiona, Жинни хоёрыг тэвэрлээ.

Жолооч хөдлөхийн өмнөх анхааруулгын дохио өгөв. Буудал дээр зогсож байсан сурагчид галт тэрэг лүүгээ яарлаа.

- Түргэл, түргэл. Захиа бичээрэй... биеэ сайн авч яваарай ... хэрвээ ямар нэг юм мартсан бол бид илгээнэ ... Галт тэрэг лүүгээ яарцгаа гэж хатагтай Уизли хэлээд бүгдийг ялгаагүй тэвэрлээ. Харриг хоёр ч удаа тэврэв.

Агшин зуур том хар нохой арын хөл дээрээ босож Харрийн мөрөн дээр урд сарвуугаа тавилаа. Хатагтай Уизли Харриг галт тэрэг лүү түлхээд,

- Бурханд баярлалаа, Сириус биеэ нохой шиг авч яв! гэж шивнэлээ.
- Баяртай! гэж Харри галт тэрэг хөдлөхөд нээлттэй цонхоор хашгирав.

Рон, Гермiona, Жинни нар дэргэд нь зогсоод гараа даллаж байв. Тонкс, Люпин, Грюм, ноён ба хатагтай Уизли түргэн алга болсон ч хар нохой сүүлээ даллан цонхтой зэрэгцэн давхилаа. Галт тэрэгний буудал дээр байгаа хүмүүс нохой араас нь хөөхийг инээлдэн харна. Дараа нь галт тэрэг эргэхэд Сириус үзэгдэхээ болив.

- Тэр биднийг дагах ёсгүй байсан юм гэж Гермiona санаа зовсон байртай хэлэв.
- За боль доо. Хөөрхий амьтан сарын турш гадагш гараагүй юм чинь гэж Рон хэллээ.
- Тэгэхээр хүүхдүүдээ би өдрийн турш энд яриад зогсож байж чадахгүй.

Бидэнд Литэй ярилцах ажил байна. Удахгүй уулзая гэж Фред хэлээд Жоржын хамт хонгилоор баруун тийш эргэн явлаа.

Галт тэрэг хурдаа авахад цонхны цаана байшин жирэлзэн өнгөрнө.

- Явж тасалгаа олох уу? гэж Харри хэлэв. Рон, Гермiona хоёр бие биеэ харлаа.
- Э ... гэж Рон дуугарлаа.

- Бид ... Рон бид хоёр ахлагч нарын вагон руу явах хэрэгтэй гэж Гермиона ичсэн байртай хэлэв.

Рон Харри руу харсангүй гэнэтхэн зүүн гарынхаа хумсыг сонирхож гарлаа.

- Аан, ойлгомжтой. Тэгвэл яахав гэж Харри хэллээ.

- Бид тэнд бүх замын турш суугаад байхгүй. Захианд бичсэнээр бол сургуулийн ахлагчын зааврыг тэнд авах ёстой юм. Харин дараа нь хонгилоор үе үе хэвийн жижүүрлэх ёстой гэж Гермион яаран хэллээ.

- Ойлгомжтой. За тэгвэл ... Дараа уулзацгаая гэж Харри хэллээ.

- Намайг тийшээ явахыг хүсч байна гэж бүү бодоорой, би бодож байгаа ч ... гэхдээ биднээс шаардаж байна ... Би Перси шиг баярлахгүй байна гэж Рон хэлээд Харри руу түргэхэн харлаа.

- Би мэднэ ээ гээд Харри инээмсэглэлээ.

Гермиона, Рон хоёр чемодан болон Живоглот, Гахайн торыг өргөсөөр урд талын вагон руу явахад Харрид ганцаар үлдсэндээ таагүй сэтгэгдэл төржээ. Тэр нэг ч удаа Хогвартс Экспрессэд Ронгүй явж байгаагүй юм байна.

- Явъя. Суудал олъё гэж Жинни хэлэв.

- Тэгье гэж Харри зөвшөөрөөд нэг гартаа Хэдвигийн торыг авч нөгөө гараараа чемоданаа чирлээ.

Тэд хонгилоор арайхийн явж тасалгааны шилэн хаалгаар шагайж байсан ч бүгд дүүрэн байв. Харри хүүхдүүд түүнийг сонирхсон янзтай харж хажуудахаа нударч байхыг анзаарлаа. Таван вагон өнгөрсний дараа Харри «Өдөр тутмын зөнч» сонин зуны турш уншигчдадаа түүнийг нэр алдарт дуртай худалч гэж хэлснийг саналаа. Толгойд нь ахин таагүй асуулт орж ирэв. Хүмүүс түүнд итгээд дагуулж хараад байгаа юм биш байгаа даа?

Сүүлчийн вагонд тэд Гриффиндорын тавдугаар дамжааны сурагч Невилл Долгопупсыг олж харлаа. Түүний дугуй нүүр үрчийгээд нэг гартаа чемодан, нөгөө гартаа Треворыг бариад зогсоно.

- Сайн уу, Харри. Сайн уу Жинни. Бүгд дүүрэн болохоор суудал олж чадсангүй.

- Бүгд биш байлгүй гэж Жинни эсэргүүцээд Невиллийн дэргэдүүр түлхэн

өнгөрч ардах тасалгаа руу шагайлаа.

- Энд өрөө сул зөвхөн Лавгуд байна.

Невилл хүсэхгүй байгаа тухай ямар нэг үг бувтналаа.

- Тэнэг байх хэрэггүй. Тэр зүгээр дээ гэж Жинни инээд алдав.

Тэр хаалга түлхэн орж чемоданаа дотогш оруулав. Харри, Невилл хоёр араас нь орлоо.

- Сайн уу Полумна. Бид чамтай хамт явж болох уу? гэж Жинни асуув.

Цонхны дэргэд сууж байсан охин харцаа өргөв. Тэр бүсэлхийгээ хүрсэн урт үс, цайвар хөмсөг өнгөгүй нүдтэй ажээ. Харри агшин зуур Невилл яагаад энэ тасалгаанд явахыг хүсээгүй болохыг ойлгов. Полумна холхон явмаар төрхтэй байлаа. Шидэт саваагаа тэр аль нэг тийш аюулгүй газар хийхийн оронд зүүн чихэндээ хавчуулж, хүзүүндээ цөцгийний шар айрагны бөглөө хэлхэж зүүгээд, сэтгүүл буруу харуулан уншиж байлаа. Тэр Невиллийг харснаа Харри дээр тогтоод толгой дохилоо.

- Баярлалаа гээд Жинни инээмсэглэв.

Харри, Невилл хоёр гурван чемодан, Хэдвигийн торыг тээшийн тавиур дээр тавиад суулаа. Полумна тэднийг уруугаа харсан «Шүүмжлэгч» сэтгүүлийн цаанаас ширтэнэ. Тэр жирийн хүмүүсээс цөөхөн нүдээ анивчдаг юм шиг санагдав. Түүнийг Харри руу нүдээ бүлтийлгэн ширтэж эхлэхэд эсрэг талд нь суусандаа харамслаа.

- Зуныг сайхан өнгөрүүлэв үү, Полумна? гэж Жинни асуулаа.

- Тиймээ. Муугүй. Харин чи Харри Поттер байна гэж Полумна бүүдгэр хоолойгоор Харригаас нүд салгалгүй хэллээ.

- Би хэн гэдгээ мэднэ гэж Харри хэлэв.

Невилл инээд алдав. Полумна түүн рүү цайвар нүдээрээ харлаа.

- Харин чамайг хэн болохыг би мэдэхгүй.

- Би хэн ч биш гэж Невилл хурдхан хэлэв.

- Худалч. Невилл Долгопупс гэдэг юм, Полумна Лавгуд. Полумна надтай чацуу

Когтевранд сурдаг юм.

- Ухаан алтнаас үнэтэй гэж Полумна аялгуулан хэллээ.

Тэр сэтгүүлээ өндөрт өргөн царайгаа хаагаад чимээгүй болов. Харри, Невилл хоёр хөмсгөө өргөн бие биеэ рүүгээ харлаа. Жинни инээд алдав.

Галт тэрэг түжигнэн давхина. Хачирхалтай тодорхойлж боломгүй өдөр байлаа. Бараан үүл дундаас нарны туяа гийгүүлэх аж.

- Надад төрсөн өдрөөр юу өгсөнийг таах уу гэж Невилл хэлэв.

- Ахин нэг сануулагч уу? гэж Харри асуугаад Невиллийн эмээгийн түүнийг юу ч мартуулахгүйн тулд өгсөн зүйлийг санав.

- Үгүй. Тэр надад их тус болсон ч би хаячихсан ... Үүнийг хараач.

Тэр Треворыг нөгөө гартаа бариад цүнхээ ухан жижигхэн саарал кактустай төстэй өргөстэй ургамал гаргаж ирээд,

- Мимбулус мимблетония гэж бардам хэлэв.

Харри ургамлыг харлаа. Тэр дотоод эрхтэн нь өвчтэй юм шиг булдруу нь үл мэдэг гүрвэлзэн цохилох нь эвгүй сэтгэгдэл төрүүлнэ.

- Маш их ховор байдаг юм. Хогвартсын хүлэмжинд байгаа эсэхийг ч мэдэхгүй байна. Профессор Стебльд үзүүлэхийг тэсэн ядан хүлээж байна. Миний үеэл ах Элжи үүнийг надад Ассирээс авчирсан юм. Үржүүлж болно гэж бодож байна хэмээн Невилл баясан хэллээ.

Харри Невиллийн дуртай хичээл ургамал судлал болохыг мэдэж байсан ч энэхүү таагүй ургамлаас сайн юм хүлээнэ гэж ер бодсонгүй.

- Тэр ямар нэг юм хийж чадах уу? гэж Харри асуулаа.

- Бүгдийг! Түүнд гайхамшигтай хамгаалалтын систем бий. Треворыг барьж байгаач.

Тэр бахаа Харрийн өвдгөн дээрээ тавиад цүнхнээсээ үзэг гаргалаа. Сэтгүүлийн ирмэг дээгүүр Полумна Лавгуд Невиллийн юу хийхийг харахыг хүссэн бололтой цухуйв. Тэр мимбулус мимблетонг нүднийхээ урд бариад үзгээрээ хатгалаа.

Тэгтэл булдруу болгоноос өтгөн ногоон өмхий шингэн цацагдаж адар, цонх болон Полумна Лавгудын сэтгүүлийг будав. Жинни нүүрээ гараараа хааж амжсан ч ногоон малгай өмссөн мэт харагдсан бол Харрийн хувьд Треворыг барьж байсан болохоор нүүрэндээ сайн цохилт авлаа. Өмхий шивх шиг үнэртэй ажээ.

Невиллийн нүдээ цэвэрлэх гэж толгойгоо хүчтэй сэгсэрлээ.

- Уучлаарай. Би урьд нь оролдож үзээгүй болохоор... Яаж болдогыг нь мэдсэнгүй ... Гэхдээ санаа зовох хэрэггүй, өмхий шингэн хортой биш гэж нэмээд Харри аман дахиа нулимахыг харлаа.

Тэр агшинд тасалгааны хаалга нээгдэв.

- Өө, сайн уу, Харри. Би цагаа олсонгүй юу гэх хоолой гарав.

Харри сул гартаа Треворыг бариад шилээ арчив. Үүдэн дээр гялалзсан урт хар үстэй охин хөөрхөн инээмсэглэн зогсож байв. Энэ бол Когтевраны квиддичийн багийн баригч Чжоу Чанг байлаа.

- Сайн уу гэж Харри өнгөгүй хоолойгоор хэлэв.

- М-м. Би зөвхөн мэнд мэдэх гэсэн юм... Дараа уулзая гэж Чжоу хэлэв.

Тэр улайгаад хаалга хаалаа. Харри нуруугаараа суудал налаад ёолов. Тэр Чжоуд сайн найзуудынхаа хамтаар инээлдэн тоглож байхдаа харагдахыг илүүд үзэж байв. Гэтэл үүний оронд Чжоу түүнийг Невилл Долгопупс, Полумна Лавгуд хоёртой гартаа бах бариад өмхий шингэнд будагдсан байхыг нь харлаа шүү дээ.

- Ямар ч аймшигтай юм алга. Бид үүнээс хялбархан ангижирч болно гээд Жинни саваагаа өргөн,

- Экскуро гэв.

Өмхий шингэн алга болов.

- Өршөөгөөрэй гэж Невилл аяархан хэллээ.

Рон, Гермiona хоёр цагийн дараа тэргэнцэртэй хоол явж өнгөрсний дараа ирэв. Харри, Жинни, Невилл нар хулууны жигнэмэг идэж дуусаад шоколадан мэлхийний зураг солилцож байтал хаалга нээгдэж Гриффиндорын ахлагч нар орж ирлээ. Гермiona Живоглотыг барьсан бол харин Рон чанга гууглах Гахайг тортой нь барьжээ.

- Өлсөж үхэх нь гэж Рон мэдэгдээд Гахайг Хэдвигийн торны дэргэд тавиур дээр тавьж Харригаас шоколадан мэлхий аваад зэрэгцэн суулаа. Тэр цаасыг нээн мэлхийн толгойг хазаад ядарсан шинжтэй нүдээ анин суудлаа хойш налав.

- Тавдугаар дамжаанд тэнхим бүрээс хоёр ахлагч сонгогдсон. Эрэгтэй болон эмэгтэй гэж Гермiona суугаад мэдэгдэв. Тэр аймшигтай бухимдсан төрхтэй байлаа.

- Слизериний ахлагч хэн болсныг таа даа? гэж Рон нүдээ нээлгүй хэллээ.
- Малфой гэж Харри агшин зуур тааварлав.
- Мэдээж гэж Рон гашуунаар батлаад мэлхийний үлдсэн хэсгийг амандаа чихэв.
- Бас тэнэг үнээ Пэнси Паркинсон. Түүнийг ямар ахлагч гэх вэ. Тэр чинь тарган бүдүүн савдаг шиг юм чинь ... гэж Гермиона хорон өнгөөр хэллээ.
- Пуффендуйгаас хэн болсон? гэж Харри асуулаа.
- Эрни МакМиллан, Ханна Аббот хоёр гэж Рон сөөнгөтөв.
- Харин Когтевранаас Энтони Голдстейн, Падма Патил хоёр гэж Гермиона хэлэв.
- Чи Падма Патилтай бүжигт үдэшлэгт явсан гэх хэн нэгний бүдэг хоолой гарлаа.

Бүгд Полумна Лавгуд руу эргэж харахад тэр Рон руу цавчилгүй сэтгүүл дээгүүрээ ширтэж байв. Тэр аман дахь шоколадаа залгиад,

- Би хэнтэй явснаа мэднэ гэж гайхсан янзтай хэлэв.
- Түүнд таалагдаагүй гэсэн. Тэр чамд хэнтэй явах нь чухал биш байсан гэсэн.

Бас бүжиглээгүй гэж. Харин надад бол энэ нь дээр байна. Бүжиглэх дургүй гэж нэмэрлэв.

Тэгснээ ахиад л сэтгүүлийн ард нуугдав. Рон хэдэн хормын турш сэтгүүлийн хавтас руу мэлэрснээ инээхгүйн тулд амаа дарсан Жинни рүү ямар нэг тайлбар хүсэх мэт эргэж харлаа. Тэгснээ толгой сэгсэрч цагаа харлаа.

- Бид үе үе хонгилд жижүүрлэх ёстой. Бас хүүхдүүдийг сахилгагүйтвэл шийтгэнэ. Би Крэбб, Гойл хоёрыг шийтгэхийг тэсэн ядан хүлээж байна ...
- Чи ахлагчын байр суурийг хортойгоор ашиглах ёсгүй, Рон! гэж Гермиона ширүүн хэлэв.
- Тиймээ зөв, Малфой өчүүхэн төдий ч хортойгоор ашиглахгүй дээ гэж Рон даажигнан хэлэв.

- Чи түүн шиг доошоо уруудах гээ юу?
- Үгүй, би зүгээр л тэр миний найзуудад хүрэхээс өмнө би түүнийхэд хүрэх гэж байна.

- Больж үз, Рон ...

- Би Гойлд мөр бичүүлэх даалгавар өгнө. Тэр бичихийг үзэн яддаг болохоор энэ нь түүнийг алах байх даа гэж Рон баяртайгаар мэдэгдлээ. Тэгснээ хоолойгоо намсган Гойлын шуухитнах хоолойг дуурайн нүүрээ өвдсөн янзтай үрчийлгэж агаарт бичиж байгаа дүр үзүүлээд,

- Би ... сармагчны ... өгзөг ... харах ... ёсгүй ... гэлээ.

Бүгд инээлдэхэд Полумна Лавгуд илүү чангаар инээлээ. Тэр цангинатал хөхөрсөн учир Хэдвиг сэрж далавчаа унтууцан хөдөлгөхөд, Живоглот тээшийн тавиур руу харайлаа. Полумна хөхөрсөөр сэтгүүлээ барьж чадахаа больсон учир шал руу гулсан уналаа.

- Ёо, би чадахгүй нь!

Тэр нүдэндээ нулимс цийлэгнүүлэн амьсгаадсаар Рон руу харав.

- Чи тохуурхаж байна уу? гэж Рон хөмсөг зангидан асуулаа.

- Сармагчны ... өгзөг гэж тэр амьсгаадан хөхрөөд хавиргаа барилаа.

Бүгд инээж байгаа Полумна руу харахад Харри газар унасан сэтгүүл рүү ширтлээ. Полумна түүнийг хавтасыг нь уруугаа харуулан учрыг нь олоход хүндрэлтэй болгосон ч Харри цайвар ногоон бүрх малгайгаар нь Корнелиус Фажын зураг байсныг ойлголоо. Фаж нэг гартаа мөнгөтэй хүүдий барьсан бөгөөд нөгөө гартаа албинг боомилжээ.

Фаж хэр эртнээс Гринготтс банкнаас завшихыг оролдож байсан бэ?

Арай доор өөр нийтлэлийн гарчгууд байлаа.

Квиддичийн лигийн завхрал: «Хар салхи» баг ямар аргаар тэргүүн байранд орсон бэ? Эртний хараалын нууцыг тайлахуй

Сириус Блэк хорон санаатан уу хохирогч уу?

- Үзэж болох уу? гэж Харри Полумнагаас асуулаа. Тэр толгой дохиод Роныг харж хөхөрсөн хэвээр байв.

Харри сэтгүүлийг нээж хуудсыг эргүүлэхдээ гэнэт ноён Уизли, Кингсли, Сириус нар «Шүүмжлэгч» сэтгүүлийн дугаарыг авсныг ойлголоо. Тэр хэрэгтэй хуудсаа олоод сэтгэл түгшин уншлаа.

Энд ч бас таагүй гэрэл зураг хавсаргажээ. Хэрвээ нэрийг нь бичээгүй бол Харригийн толгойд Сириус гэж орохооргүй ажээ. Түүний загалмайлсан эцэг нь хүний овоолсон араг ясан дээр шидэт саваагаа барин зогсож байв. Нийтлэлд дараахь гарчгийг тавьжээ.

Сириус Блэк хар шидтэний гэр бүлээс гаралтай юу? Цуст алуурчин уу эсвэл гэмгүй эстрадын од уу?

Харри энэ өгүүлбэрийг хэдэнтээ уншаад буруу хараагүй гэдэгтээ итгэлтэй боллоо. Сириус эстрадын од гэдэг нь юу гэж байгаа юм бол?

Арван дөрвөн жилийн өмнө Сириус Блэкийг арван хоёр гэм зэмгүй магл, нэг шидтэнг алсан гэж буруутган билээ. Блэк Азкабанаас хоёр жилийн өмнө зугтсаны дараа ид шидийн яамнаас том хэмжээний эрэл хайгуул явуулсан. Бүгд зуун хувь түүнийг барилвчилж Дементорт өгөх хэрэгтэй гэдэгт зуун хувь итгэлтэй байсан.

ГЭХДЭЭ ТЭГЭХ ХЭРЭГТЭЙ БАЙСАН ГЭЖ ҮҮ?

Бид саяхан Сириус Блэк Азкабанд орох гэмт хэрэг үйлдэхээр хүн биш гэсэн мэдээлэл авлаа. Литл нортонь, Акантоваягийн арван наймдугаар гудамжинд оршин суудаг Дорис Перкиссын баталж байгаагаар бол Блэк аллага үйлдэгдэх үед өөр газар байжээ.

Хүмүүс яагаад Сириус Блэкийн нэрийг буруугаар ойлгодогийг мэдэхгүй юм. Хүмүүсийн цуст алуурчин гэж боддог энэ хүн арван таван жилийн өмнө Литл Нортонь Чурч танхимд тоглосон Голгоблины хамтлагт гоцлол дуучин байсан юм. Би түүний зургийг сонингоос хараад таньсан. Сириус бол тийм гэмт хэрэг хийхээргүй хүн бөгөөд тэр үйл явдал болохоос өмнө надтай лааны гэрэлд романтик оройн зоог барьсан. Би ид шидийн яаманд захидал бичээд цагаатгагдахыг нь хүлээж байна.

Харри хуудсыг үргэлжлүүлэн уншаад нүдэндээ итгэсэнгүй. Магадгүй энэ тоглоом ч байж болох юм. Магадгүй сэтгүүл элэглэж байж болох юм. Тэр хэдэн хуудас эргүүлээд Фажын тухай өгүүллийг оллоо.

Ид шидийн яамны сайд Фаж таван жилийн өмнө сонгогдсоныхоо дараа шидэт банк Гринготтсыг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөө боловсруулж байжээ. Фаж үргэлж бидний алтыг найрамдалтай ажиллах нэрийн дор хадгалахыг хүсч байна гэж мэдэгдэж ирсэн.

ГЭХДЭЭ ЭНЭ ТИЙМ БИШ БАЙВАЛ ЯАХ ВЭ?

Сайд саяхан албинуудын алтыг хяналтандаа оруулах гэж санаархаж байсан нь илт боллоо. Тэрбээр гарцаагүй тохиолдолд хүч хэрэглэхээр завдаж байжээ.

«Энэ нь түүний хувьд анхны зүйл биш» ид шидийн яамны ажилтан мэдэгдсэн байна. Корнелиусын ойрын найзууд түүнийг «Албин-няц дарагч» Фаж гэж дууддаг байна.

Тэр зөвхөн албинуудыг устгах тухай ярьдаг бөгөөд нэгийг нь живүүлж, нөгөөг нь цонхоор гарган шидэж, гурав дахийг нь хордуулан, дөрөв дэхийг нь бялуунд шарах ...

Харри цааш уншсангүй. Фаж албинг бялуунд жигнэх тушаал өгсөн гэж төсөөлөхөд хэцүү байлаа. Тэр сэтгүүлийг гүйлгэн уншсан боловч хуудас бүрд зогсож байв.

«Татсхилл Торнадо» баг хэрхэн квиддичийн тэмцээн дээр сүрдүүлэг хэрэглэх арга замаар ялсан тухай, Сар луу «Зүлгэгч-6» шүүртэй нисээд цүнх дүүрэн мэлхий авчирсан гэж нотлох шидтэнгээс авсан ярилцлага, эртний хараалын тухай Полумнагын буруу харуулаад уншиж байсан хэсэгт эрхлэгч нь хараалыг илчлэхийн тулд дайсныхаа чихийг зүрж болгон хувиргах ёстой гэж баталжээ. Энэ сэтгүүлийн хавтсан дээр Сириус Гопгоблин хамтлагт гоцлол дуучин байсан гэх үнэмшмээргүй зүйлүүд байлаа.

- Ямар нэг сонирхолтой юм байна уу? гэж Рон Харриг сэтгүүл хаахад асуув.
- Харах царайны юу ч байхгүй. Бүгдэд энэ сэтгүүл хөгийн гэдэг нь ойлгомжтой хэмээн Гермiona Харриг хариулахаас өмнө хэлэв.
- Өршөөгөөрэй. Түүний эрхлэгч бол миний эцэг гэх дуу бүүдгэр гарлаа.
- Би ... тэнд мэдээж ... ямар нэгэн сонирхолтой гэж Гермiona ичингүйрэн бувтналаа.
- Би авч болох уу? гэж Полумна хүйтнээр хэлээд Харрийн гараас суга татан авлаа. Тавин долдугаар хуудсыг нээгээд ахин түүний ард алга болов. Энэ удаад тасалгааны хаалга гурав дахь удаагаа нээгдэв.

Харри толгойгоо өргөлөө. Мэдээж түүний хүлээж байсанчлан Драко Малфой үнэнч дагалдагч Крэбб, Гойл хоёрын хамт инээмсэглэн зогсож байв.

- Юу хэрэгтэй вэ? гэж Харри Малфойг ам нээж амжихаас өмнө таагүй дуугарлаа.

- Эелдэг бай, Поттер тэгэхгүй бол шийтгэнэ шүү. Намайг харж байна уу, чамаас ялгаатай нь гэвэл ахлагч. Ингээд би чамаас ялгаатай учраас шийтгэх эрхтэй гэж Малфой үгээ сунган хэлэхэд гялалзсан цайвар үс нь яг эцгийнхээ адил байлаа.

- Тэгж болох юм. Гэхдээ чи надаас ялгаатай өөдгүй амьтан учраас биднийг тайван орхи гэж Харри хэлэв.

Рон, Гермиона, Жинни, Невилл нар инээлдэв. Малфой ярвайлаа.

- Харин надад хэлээдэх, Поттер. Уизлигийн дараа хоёрдугаар байранд орсноо мэдрэх ямар байна?

- Амаа, тат Малфой гэж Гермиона ширүүн хэлэв.

- Би эмзэг газрыг нь хөндсөн бололтой. Чи намайг хар, Поттер! Учир нь би яг нохой шиг чиний юу хийж байгааг мөрдөж шиншилж байх болно.

- Эндээс зайл! гэж Гермиона хашгираад үсрэн босов.

Малфой хөхрөөд Харри руу хорсолтой харснаа Крэбб, Гойл хоёрыг дагуулан гарлаа. Гермиона хаалга чанга хаагаад түүний адил түгшсэн Харри руу эргэж харлаа. Рон юу ч ажигласангүй.

Невилл, Полумна хоёрын дэргэд Харри чөлөөтэй ярилцаж чадсангүй. Ахин нэг удаа Гермионатай бухимдсан харц солилцоод цонхоор ширтлээ.

Энэ агшинд тэр Сириус буудал дээр хүргэж ирсэн нь гэнэтхэн болгоомжгүй эрсдэлтэй алхам хийсэн санагджээ ... Гермионагийн зөв ... Сириус явах хэрэггүй байсан юм. Хэрвээ Драко ноён Малфойд хар нохойны тухай хэлвэл яах вэ? Хэрвээ тэр эхнэр, нөхөр Уизли, Люпин, Тонкс, Грюм нар Сириусын хаана нуугдаж байгааг мэдвэл яах вэ? Эсвэл Малфойн «нохой» гэсэн үгийг санамсаргүй тохиолдол гэх нь үү?

Галт тэрэг хойд зүг рүү алслан холдох тусам цаг агаар тогтворгүй болж байлаа. Цонхны шилийг бороо шавшиж, цонхигор нар үүлний цаанаас хаа нэгтээ цухуйна. Галт тэргэнд харанхуй болсон учир гэрэл асахад Полумна «Шүүмжлэгч» сэтгүүлээ хумхиж цүнхэндээ нямбайлан хийгээд тасалгаанд байгаа хүмүүс рүү ширтлээ.

Харри цонхны дэргэд духаа шилэнд наан суугаад алсад Хогвартсын барааг зэрвэс харахыг хичээсэн ч саргүй шөнө байсан болохоор борооны дуслаас өөр зүйл

харагдсангүй.

- Бид хувцсаа сольсон нь дээр байх гэж Гермiona хэлэхэд бүгд чемоданаа хүндхэн онгойлгож сургуулийн жанчаа гаргаж ирлээ. Рон тэр хоёр энгэртээ ахлагчын тэмдгээ нямбайлан зүүлээ. Харри Рон харанхуй шилэнд тусгалаа тольдож байхыг ажиглав.

Эцэст нь галт тэрэг удааширч эхлэхэд сурагчид гарахад бэлтгэн тээш болон амьтнаа авах зэрэг чимээ шуугиан хадав. Рон, Гермiona хоёр энэ бүхнийг хянах хэрэгтэй байсан болохоор гарч явахдаа Живоглот, Гахай хоёрыг үлдээв.

- Би энэ уулийг авъя гэж Полумна хэлээд Гахай руу гар сунгах агшинд Невилл Тревороо энгэрийн халаасандаа хийлээ.

- Өө, баярлалаа гэж Харри хэлээд түүнд торыг өгч Хэдвигийг аятайхан барилаа.

Тэд удаанаар үдшийн цэвэр агаар сэнгэнэсэн хонгилд гарч бүгдийн хамтаар галт тэрэгний үүд рүү явав. Харри нуурын дэргэдэх зам дагуу ургасан байдаг нарсны үнэрийг мэдрэв. Тэр тавцан дээгүүр ийш тийшээ харан Хагридын танил хоолой «Нэгдүгээр дамжааныхан, ийшээ! ... Нэгдүгээр дамжааныхан!» гэж дуудахыг хүлээлээ.

Гэхдээ тэр дуугарсангүй. Түүний оронд ондоо эмэгтэй хүний хоолой гарч,

- Нэгдүгээр дамжааныхан энд зогсоцгооно уу! Нэгдүгээр дамжааныхан над дээр! гэв.

Харри дэнлүүний гэрэлд өнгөрсөн жил тэдэнд Хагридын оронд шидэт амьтны хичээлийг зааж байсан дөрвөлжин эрүү ширүүн төрхтэй профессор Граббли Дергийг олж харлаа.

- Хагрид хаана байгаа юм бол? гэж тэр чанга асуулаа.

- Мэдэхгүй. Алив эндээс холдоё тэгэхгүй бол зам хаагаад байна гэж Жинни хэлэв.

- Өө, тийм л дээ.

Харри, Жиннигийн хамт тавцан дээгүүр явахдаа олны дунд Хагридыг хайлаа. Хагридтай уулзах нь баяртай үйл явдлын нэг болохоор энд байгаа гэдэгт нь Харри найдаж ихэд найдаж байлаа. Гэтэл Хагрид байсангүй.

«Тэр сургуулиас явж чадахгүй» гэж Харри өөртөө хэлээд хүмүүсийн дундуур удаанаар нарийхан хаалга руу явлаа.

Тэр профессор Граббли Дергийн ярилцахаар тухай Рон, Гермиона хоёрыг хайсан авч ойр байсангүйд харанхуй нойтон бороон дундуур Хогсмидын тавцангаас гарлаа.

Түүний дэргэд хоёр дугаар дамжаанаас нь хойш сурагчдыг хүргэж ирсэн ойролцоогоор зуугаад морьгүй сүйх тэрэг зогсож байлаа. Харри Рон, Гермиона хоёрыг хайн сүйх тэрэг рүү харав.

Сүйх өнөөдөр морьгүй байсангүй. Түүний оронд морь гэж хэлж болох ч төсөөгүй амьтан хөллөөстэй байв. Тэд арга ясан дээр арьс тохчихсон аятай товгор гүдгэр бүрийг нь харж болохоор туранхай ажээ. Толгой нь яг лууных шиг, том цагаан нүдтэй бөгөөд аварга том сарьсан багваахайных хар далавчтай байлаа. Харанхуйд эдгээр хачирхалтай амьтад хөдөлгөөнгүй зогсож байх нь дотор зарсхийм үзэгдэнэ. Харри яагаад эдгээр аймшигтай морьд өөрсдөө хөдөлж чаддаг сүйх тэргэнд шаардагдсаныг ойлгосонгүй.

- Гахай хаана байна? гэх Роны хоолой гарав.

- Түүнийг Полумна авсан гээд Харри Хагридын тухай ярилцахаар түргэн эргээд,

- Сонсооч чинийхээр бол хаана ... гэв.

- Хагрид уу? Мэдэхгүй. Түүнд ямар нэг юм тохиолдоогүй байгаа даа ... гэж Рон сэтгэл зовон хэллээ.

Цаахан талд Драко Малфой Крэбб, Гойл, Пэнси Паркинсон нарын хамтаар аймхай хоёр дугаар дамжааныхныг шийтгэж байв. Агшин зуур Гермиона амьсгаадсаар хүрч ирэв.

- Малфой нэгдүгээр дамжааныханд жигшүүртэй загнаж байна. Би түүнд гомдол гаргах болно доо! Гурван минут тэмдэгээ зүүв үү үгүй юу хүмүүсийг баруун зүүнгүй дээрэлхэж эхлэх юм ... Ингэхэд Живоглот хаана байна?

- Жиннид байгаа. Тэнд байна гэж Харри хэллээ. Жинни Живоглотыг гартаа тэвэрсээр гарч ирлээ.

- Баярлалаа. Явж дүүрэхээс нь өмнө чөлөөтэй сүйх тэрэг олцгооё гэж Гермиона Жиннигээс муураа аваад хэлэв.

- Би Гахайг авах хэрэгтэй байна! гэж Рон эсэргүүцсэн ч Гермиона хэдийн хоосон сүйх тэрэг рүү явж очжээ. Харри Ронтой үлдэв.

- Чи энэ амьтны тухай юу бодож байна? гэж тэр асуугаад дэргэдүүр нь сурагчид холхих аймшигтай морины зүг дохилоо.

- Ямар амьтад?

- Морьд ...

Полумна Гахайн торыг барьсаар ирэв. Жижигхэн уульхан ердийнхөөрөө баясан жиргэж байлаа.

- Май энэ байна. Ямар хөөрхөн жижигхэн ууль вэ! гэж Полумна хэлэв.

- Тиймээ. За явж сууцгаая ... Харри чи юу хэлсэн бэ?

- Би чамаас энэ морьдын тухай юу бодож байна гэж асуусан? хэмээн Харри хэлээд Рон, Полумна хоёрын хамтаар Гермиона Жинни хоёрын суусан сүйх тэрэг рүү явлаа.

- Ямар морьд?

- Сүйх тэргэнд хөллөсөн! гэж Харри тэвчээр алдан хэлэв. Тэд эдгээр амьтдын дэргэдүүр өнгөрөхөд том цагаан нүдээрээ ширтэв. Рон тэвдсэн байртай харагдав.

- Би чиний юу яриад байгааг ойлгохгүй байна.

- Би үүний тухай ярилаа шүү дээ, хараач!

Харри Роны гарнаас барьж аваад далавчтай морины зүг рүү эргүүлэв. Рон хормын турш ширтсэнээ Харри руу харлаа.

- Чи намайг юу хар гээд байгаа юм бэ?

- Сүйх тэргэнд хөллөөтэй байгаа зүйлийг! Чиний өмнө байна ...

Гэхдээ Рон урьдын адил нүд бүлтийн ширтээд юу ч ойлгосонгүй тул Харрийн толгойд гайхалтай бодол орж ирлээ.

- Чи ... чи тэднийг харахгүй байна уу?

- Юуг тэр вэ?

- Сүйх тэргэнд хөллөсөн. Рон тоглоомгүй түгшлээ.

- Чи зүгээр үү, Харри?

- Би юу ... тиймээ.

Харри бүр будилж гүйцэв. Түүний өмнө тавцангаас тусах бүдэг гэрэлд гөлгөр арьстай хар морь үдшийн жихүүн агаарт хамрын нүхнээсээ уур савсуулан зогсож байлаа. Хэрвээ Рон тоглоогүй бол энэ бол их тэнэг хэрэг байна даа. Тэр түүнийг огт харсангүй.

- Сууж болох уу? гэж Рон итгэлгүйхэн хэлээд Харри руу түгшин ширтэв.

- Тиймээ. Явцгаая.

- Санаа зовох хэрэггүй. Чи ухаан солиороогүй. Би бас тэднийг харж байна гэх бүүдгэр хоолой харанхуй сүйх тэрэгнээс гарлаа.

- Харж байна гэнээ? хэмээн Харри сэтгэл зовон асуугаад Полумна руу эргэлээ.

Түүний мөнгөлөг нүдэнд далавчтай морьдын тусгалыг харав.

- Тиймээ. Ийшээ ирсэн анхны өдрөөсөө л харсан. Тэд үргэлж энэ сүйх тэргэнд хөллөөтэй байдаг юм. Санаа зовох хэрэггүй дээ. Чи над шиг солиотой биш.

Тэр инээмсэглээд сүйх тэрэг рүү Роны араас орлоо. Харри бас тийш орлоо.

БҮЛЭГ 11: ХУВААРИЛАГЧ БҮРХ МАЛГАЙН ШИНЭ ДУУ

Харри бусаддаа Полумна бас хий юм харсныг хэлсэнгүй. Хэрвээ энэ үнэхээр хий юм харсан хэрэг байвал яана. Ийм учраас сүйх тэргэнд байраа эзлээд хаалга хааж морьдын тухай ярьсангүй. Нэг л удаа цонхоор хар морьдын дүрс рүү шагайн харлаа.

- Та нар Граббли Дергийг харсан уу? Тэр энд юугаа хийж байгаа юм бол?

Хагрид сургуулиас явчихсан юм биш биз дээ? гэж Жинни асуулаа.

- Хэрвээ тэр явсан бол би баяртай байна. Минийхээр бол тэр нэг их сайн багш биш гэж Полумна хэлэв.

- Тэр сайн багш! гэж уурсан Харри, Рон, Жинни нар зэрэг эсэргүүцлээ. Харри Гермiona руу харлаа. Тэрбээр хоолой засан ханиалгаад түргэнээр,

- Тиймээ ... тэр их сайн гэлээ.

- Харин Когтевраныхан түүнийг инээлгүйгээр харж чадахгүй гэж боддог юм хэмээн Полумна хэлэв.

- Та нар түүгээр тоглоом тохуу хийж болохгүй! хэмээн Рон тэрэгний дугуйны чакраан дунд дүрсхийлээ.

Роны бүдүүлэг байдал Полумнагийн санааг ер зовоосонгүй. Тэр хэсэг хугацааны турш түүн рүү зурагтын сонирхолгүй хөтөлбөр үзэж байгаа аятай хайхрамжгүй ширтлээ.

Сүйх тэрэг түжигнэн найгасаар замаар хатируулав. Тэднийг хоёр талдаа далавчтай гахайн хөшөө бүхий өндөр баганатай хаалгаар дотогш ороход Харри Хориотой ойн цоорхойд Хагридын овоохойн гэрлийг харахаар найдангуй цонхоор шагайв. Сургуулийн нутаг дэвсгэр харанхуй байлаа. Хогвартс шилтгээн ойртох тусам томрон хүчирхэг цамхагууд нь харанхуй тэнгэр шовгор дүрс үүсгэж хурц гэрэлтэй цонхны туяа тусна.

Шилтгээн рүү орох үүд болох царсан хаалгатай чулуун гишгүүрийн өмнө сүйх тэрэг хяхтнан зогсов. Харри түрүүлж гарлаа. Тэр эргэж хараад ахиад л ойн цоорхой руу харсан авч амьдралын ямар ч шинж тэмдэг байсангүй. Харри тэднийг алга болсон байх гэж найдан дургүйхэн сүйх тэрэг рүү хартал хачирхалтай ясархаг амьтад шөнийн агаарт цагаан нүдээ гялалзуулан чимээгүй зогсож үзэгдэв.

Харри урьд нь Роны харахгүй зүйлийг харж байсан удаатай ч толины тусгалаас ч

илүү бодит зуугаад амьтад хүнд сүйх тэргэнд хөллөөстэй байхыг юу гэж бодохоо мэдсэнгүй. Хэрвээ Полумнад итгэх аваас тэд үл үзэгдэх байж болох юм. Харин Харри яагаад гэнэтхэн тэднийг харсан юм бол? Бас Рон яагаад харахгүй байгаа юм бол?

- Явах юмуу үгүй юм уу? гэх Роны хоолой ард нь сонсогдов.

- Аан тийм л дээ гэж Харри түргэн хэлээд олны урсгалд яаран нэгдэж чулуун шатаар өгслөө.

Үүдний танхимыг хурц гэрэлтэй бамбар гийгүүлж сурагчдын алхаа бул чулуун шалан дээр цуурайтана. Бүгд баруун тийш эргэн хичээлийн жилийн цайллагад оролцохоор хоёр хавтастай хаалгаар Их танхимд орлоо.

Их танхимд тэнхимийн дөрвөн урт ширээнд сурагчид сууцгааж дээгүүр нь цонхны гадаах тэнгэртэй ямар ч ялгаагүй одгүй адар харлана. Ширээний дээгүүр лаанууд хөвж, гялалзсан мөнгөлөг хий үзэгдлүүд танхим дундуур холхиж, сурагчид өөр хоорондоо зуны амралтын тухай сонин хачин хөөрөлдөн, тэнхим хоорондын найзууд хашгиран мэндэлцгээж, бие биенийхээ шинэ үсний засалт болон жанчыг харж байлаа. Харри ахиад л түүний дэргэдүүр нь өнгөрсөн хүмүүс бие биеэ түлхэн шивнэлдэж байхыг ажиглав. Тэр шүдээ зуун юу ч ажиглаагүй юм шиг өнгөрлөө.

Полумна Когтевраны ширээ рүү явлаа. Тэднийг Гриффиндорын ширээнд хүрэх агшинд Жинниг дөрөвдүгээр дамжааны найзууд нь дуудан тэдэнтэй нэгдэв. Харри, Рон, Гермиона, Невилл нар ширээний дунд хэсэгт дөрвөн суудал олов. Ширээний нөгөө талд бараг толгойгүй Ник болон, Парвати Патил, Лаванда Браун нар сууж байсан бөгөөд Харриг нөхөрсгөөр мэндлэхэд яриагаа зогсоолоо. Гэхдээ түүний ухаанд санаа зовох илүү чухал зүйл эргэлдэж байсан учир сурагчдын толгой дээгүүр багш нарын ширээ рүү харлаа.

- Тэр тэнд алга.

Рон, Гермиона хоёр бас тийшээ харлаа.

- Тэр сургуулиас явж чадахгүй гэж Рон түгшсэн байртай хэлэв.

- Мэдээж чадахгүй гэж Харри хатуу батлав.

- Чи түүнийг гэмтсэн юмуу ... ямар нэг юм тохиолдсон гэж бодож байна уу?

хэмээн Гермиона тавгүйтэн асуулаа.

- Үгүй гэж Харри даруйхан хэлэв.

- Гэхдээ тэр хаана байгаа юм бол?

Харри чимээгүй болсноо Невилл, Парвати, Лаванда нарт сонсогдохооргүй аяархан хоолойгоор,

- Эргэж ирэхгүй ч байж магадгүй. Та нар Дамблдор түүнд зун өгсөн даалгаварыг санаж байна уу ... гэлээ.

- Тийм ... тэгсэн байх гэж Рон зөвшөөрсөн ч Гермiona уруулаа хазлан багш нарын ширээний зүг Хагридын эзгүйд тайлбар олохыг хүссэн юм шиг харав.

- Энэ одоо хэн бэ? гэж тэр огцом асуугаад ширээний гол хэсэг рүү заалаа.

Харри бас тийшээ ширтээд ширээний голд өндөр түшлэгтэй сандалд сууж байгаа профессор Дамблдорыг олж харлаа. Тэр мөнгөлөг ододоор чимэглэсэн хүрэн ягаан өнгийн жанч мөн адил одод бүхий малгай өмсчээ. Дамблдор дэргэдээ сууж байгаа эмэгтэй рүү толгойгоо бөхийлгөн чихэнд нь юм хэллээ. Тэр Харрид хэн нэгний нагац эгч шиг санагдав. Тарган, богинохон буржгар үстэй бөгөөд толгойдоо жанчны гадуур өмссөн цамцтайгаа адил аймшигтай хурц ягаан тод өнгийн тууз зүүжээ. Тэр цомтойгоо уухаар толгойгоо эргүүлэхэд Харри бахтай адил царай, бүлтгэр нүдийг таниад айдаст автлаа.

- Энэ чинь Амбриж байна шүү дээ!

- Хэн гэнээ? гэж Гермiona асуулаа.

- Тэр Фажын дэргэд ажилладаг юм!

- Сайхан цамц байна даа! хэмээн Рон инээвхийлэв.

- Фажын дэргэд ажилладаг гэнээ! хэмээн Гермiona хөмсөг зангидан давтан асууснаа,

- Тэр энд юу хийж байгаа юм бол? гэлээ.

- Мэдэхгүй.

Гермiona багш нарын ширээ рүү харснаа,

- Үгүй. Байж боломгүй юм ... гэж бувтналаа.

Харри түүний хэлснийг ойлгоогүй болохоор давтаж асуух гэсэн ч анхаарал нь багш нарын ширээнд Хагридын байранд дөнгөж сая ирж суусан профессор Граббли

Дергэд татагдав. Тэр нэгдүгээр дамжааныхныг нууран дээгүүр аялуулан шилтгээн рүү авчирсан байх нь. Тэгтэл ч үнэхээр хэдэн хормын дараа Их танхимын хаалга нээгдэв. Танхимд айсан шинжтэй шинэ сурагчдын урт эгнээ профессор МакГонагаллаар толгойлуулан орж ирэхэд тэр эртний шидэт бүрхийг сандал дээр авчирч тавилаа. Малгай улам ч элэгдэж ноорсон харагдав.

Их танхим даяар яриа хөөрөө чимээгүй болов. Нэгдүгээр дамжааныхан багш нарын ширээний өмнө сурагчид руу харан зогслоо. Профессор МакГонагалл тэдний өмнө сандлыг болгоомжтойгоор тавив.

Нэгдүгээр дамжааныхны царай лааны гэрэлд цонхийн цайсан харагдана. Баруун талын эгнээний дунд хэсэгт зогсож байсан нэг хүү чичирч байлаа. Харри агшин зуур түүний байранд сорилт хүлээн зогсохдоо ямар айдаст автаж байснаа саналаа.

Сургуул даяар амьсгаа даран хүлээлээ. Тэгтэл малгайн хөвөө дээр амтай адил нүх нээгдэн дуулав.

Эрт дээр үед намайг шинэхэн байхад

Сайн үйлсийн төлөө нэгдсэн дөрвөн шидтэн Энэ сургуулийн суурийг нь тавьсан юм
Тэдний бодол тэнгэрлэг ариун байлаа

Хаа ч байхгүй сургуулийг босгох хүсэлтэй байлаа

Залуу хойч үедээ өөрсдийн мэдлэгийг өвлүүлэхийн тулд

Ид шидийн ундаргыг ширгээхгүйн тулд Хамтдаа, босгож, ажиллаж, сургахын тулд
Шидтэн найзууд шийдвэр гаргасан юм

Тэд өөрсдийн зорилгоо өөрөөр төсөөлж байсан билээ Хэрүүл, тэмцэл, үхлээс ондоо
үзэж байсан билээ Слизерин Гриффиндортой анд нөхөд

Пуффендуй Когтеврантай анд нөхөд

Энэхүү гэр бүл нэгдэн нийлж

Нэгэн зорилгодоо хамтдаа зүтгэж байлаа

Анд нөхдийн хайрыг үл зөвшөөрч болно гэж үү? Тэдний хамтын ажиллагаа унаж
болно гэж үү? Би тэнд байсан болохоороо үүнийг хэлэх байна Миний үгийг
сонсоорой ямар байсныг ярьж өгье Слизерин зөвхөн цэвэр цусны хүүхдийг авна гэж

Когтевран зөвхөн ухаантай сэргэлэнг сургана гэж

Гриффиндор зөвхөн эр зоригтонууд л хэрэгтэй Нэр бол чухал биш ажил хэрэг чухал гэж Пуффендуй надад бүгд дотно болохоор Бүгдийг өөрийн ивээлд авахад бэлэн гэжээ Анхны зөрөлдөөн хэрүүл маргаан болсонгүй

Учир нь гэвэл тэнхим бүрд хангалттай зай байлаа

Гриффиндор зөвхөн уран авхаалжтайгаар

Хэлсэн үг, үйл хэрэгтээ үнэнч эр зоригтнуудыг элсүүлж

Слизерин өөр шигээ зальтай Цэвэр цусныхыг элсүүлж байлаа Когтевран хурц оюун ухаантайг нь

Пуффендуй энэ бүгдийн үлдсэнүүдийг элсүүлэн Өөрсдийн тэнхимүүдээ үндэслэн босгож Эвтэй сайхан найрсаг байцгаалаа

Төрсөн ах дүүс эгч нарын адил

Аз жаргалтайгаар хэдэн оныг өнгөрүүлэв Олон амжилт бүтээлээр дүүрэн байсан ч Дараа нь тэдний сул дорой атаархал зангаас

Чимээгүй хагарал муудалцааны үндэс эхэлсэн юм

Дөрвөн том суурь баганаар боссон тэнхимүүд Цагтаа сургуулийг бат бөх бэхэлж байсан юм Шируүн маргаан өрсөлдөөн дэгдэхэд

Тэдний бат тэнцвэр сууриараа ганхаж Хогвартсыг муу хувь заяа хүлээсэн билээ Урьдын юм эргэж ирэхгүй болон

Хэрүүл тэмцэл бужигнаан үймээн дунд

Анд нөхөд нэг нэгнийхээ эсрэг босож

Ингээд нэгэн гунигт өглөө Слизерин уурсан явж салахад Илт дайсагнал надмсан ч

Бидэнд хүнд гунигтай болсон юм

Дөрвүүлээс байснаас гурав үлдлээ

Тэр цагаас хойш бүтэн жаргалтай байсангүй

Хагас эмзэгхэн эв нэгдэлтэй

Сургууль маань олон жилийг үдсэн юм

Одоо эртний малгай би та бүгдэд ахин ирлээ

Энэ сургуулийн хүүхдүүдэд Амьдрал сурах замыг нь зааж өгөх Гунигтай хувь заяа

надад ноогдсон юм Гэхдээ өнөөдөр би та нарт юу хэлэх гэвэл Хэн ч намайг бүү шүүмжлэн хэлэлцээрэй Үүнээс надад ашиг байхгүй ч

Жил болгон та нарыг хувиарлах ёстой

Сэтгэл санаагаар зовдог ч

Жилээс жилд хуваарилалт явагддаг

Атаархахааргүй хувь заяа

Аюул бидэнд ирж байна

Түүх бидэнд бүдэг дохио илгээж байна

Агаарт аюулын үнэр мэдрэгдэж байна

Хогвартсын сургуулийг гадны дайсан сүрдүүлж байна

Том дайралтыг амархан давахгүй нь

Амьд үлдэхийн төлөө бид нэгдэх ёстой эс бөгөөс унана

Авралыг бид юугаар ч худалдаж авахгүй

Бүгдийг би та нарт хэллээ, хэрвээ дүлий биш ойлгоорой

Харин одоо хуваарилалтаа эхлэе

Малгай чимээгүй болж хөшив. Алга ташилт сонсогдохын оронд Харрид анх удаагаа шивнэлдэх чимээ дуулав. Их танхим даяар сурагчид бие бие рүүгээ эргэн харахад Харри юуны тухай ярилцаж байгааг нь ойлгож байлаа.

- Тэр энэ жил юу дуулав аа? гэж Рон хэлээд гайхан хөмсөгөө өргөв.

- Харин тийм гэж Харри зөвшөөрлөө.

Хуваарилагч бүрх малгай ердийнхөөрөө шинэ сурагчдыг Хогвартсын өөр хоорондоо ялгаатай дөрвөн тэнхимд хуваарилах ёстой өөрийн үүргийн тухай дуулдаг байлаа. Харри түүний урьд нь сургуульд зөвөлгөө өгч байсныг санасангүй.

- Тэр урьд нь сургуульд ийм анхааруулга өгч байсан болов уу? гэж Гермiona түгшсэн байртай асуув.

- Тиймээ, байсан гэж бараг толгойгүй Ник хэлээд урагш бөхийн Невиллийг нэвтлэхэд цаадах нь давхийн эвгүйцлээ.

- Малгай удааны хугацааны туршид аюул мэдэрсэн үедээ анхааруулга ...

Гэвч профессор МакГонагалл нэгдүгээр дамжааныхны нэрийг уншихын өмнө шивнэлдэж буй сурагчид руу ширүүн харав. Бараг толгойгүй Ник шивнэлт намдахад тунгалаг хуруугаа уруулдаа ёсорхуу хүргэлээ. Профессор МакГонагалл дөрвөн танхимын ширээ рүү ширүүн харснаа урт хуйлаастай цаас руу бөхийн эхний нэрийг дуудав.

- Аберкромби, Юан.

Айсан янзтай хүү бүдчин гарч ирээд малгайг толгойдоо өмсөхөд томдож чих нь цухуйлаа. Малгай хормын турш бодлогширсоноо,

- Гриффиндор! гэж хашгирлаа.

Харри болон бусад Гриффиндорчууд чанга алга ташихад Юан Аберкромби гуйван алхсаар тэдний ширээнд суухдаа хэний ч нүдэнд өртөхгүйн тулд шал цөмрөөд орохыг хүссэн мэт харагдав.

Шинэ сурагчдын урт эгнээ алгуур шингэрэв. Хуваарилагч бүрх шийдвэр гаргахын өмнө бодлогоширсноо нэр хэлэх болоход Харри Роны гэдэс чанга хүржигнэхийг сонсож байлаа. Эцэст нь Целлер Роза Пуффендуйд ороход профессор МакГонагалл сандалтай малгайг авч танхимаас гарлаа. Сургуулийн захирал профессор Дамблдор босов.

Харрийн сүүлийн үед түүний талаар бодсон гашуун болгон Дамблдор босоход үл мэдэг тайвширлаа. Хагрид луун морьд ч юмуу өөр ямар нэг таагүй амьтдыг арчилахаар яваад ирээгүй байж болох юм. Хичээлийн жил болгоны эхэнд Хогвартсын захирал цайллагын өмнө босон мэндчилгээний үг хэлдэг билээ.

- Манай шинэ сурагчид тавтай морилоорой. Манай хуучин сурагчид тавтай морилоорой! Одоо олон таван үг ярих цаг биш. Идэцгээ! гэж тэр гараа алдлан инээмсэглэн хэлэв.

Инээд хөөр нижигнэсэн алга ташилтан дундуур Дамблдор суугаад урт сахлаа мөрөн дээгүүрээ давуулан тавагнаасаа холдуулав. Тэр үед танхимын таван урт ширээнд чанасан мах, хуушуур, ногоотой хоол, талх, шилтэй сүмс болон хулууны шүүстэй домбо бий болов.

- Сайхан аа гэж өлссөн Рон дуу алдаад ойролцоох чанасан махнаас өөртөө таваглахыг бараг толгойгүй Ник гунигтай харж байлаа.

- Чи хуваарилалтын өмнө малгайн анхааруулгын тухай юу ярих гэж байсан бэ?

хэмээн Гермоина хий үзэгдэлд сануулав.

- Өө, тийм л дээ гээд Ник шарсан төмс идэж байсан Роноос баяртайяа харц буруулан эргэж хараад,

- Би түүнийг хэдэн удаа сургуульд том аюул тохиолдохоос өмнө анхааруулга өгч байсныг сонссон юм байна. Ингээд үргэлж нэг янзаар «хүчтэй байхын тулд нэгдэцгээ» гэж дуусгадаг байсан.

- Млг ханс сугльд таю тохдыг мдэн бол? гэж Рон асуулаа.

Түүний ам дүүрэн байсан болохоор Харри ямар нэг үг хэлсэн нь том амжилт гэж боджээ.

- Өршөөгөөрэй? гэж бараг толгойгүй Ник эелдэгээр асуухад Гермiona Рон руу таагүй харлаа. Рон аман дахиа залгиад,

- Малгай хаанаас сургуульд том аюул тохиолдохыг мэдсэн юм бол? гэв.

- Мэдэх юм алга. Гэхдээ тэр Дамблдорын өрөөнд амьдардаг болохоор тэндээс ямар нэг зүйл мэдсэн биз гэж бараг толгойгүй Ник хэллээ

- Тэр бүх тэнхимийг найзууд байлгахыг хүссэн юм болов уу? Сайхан хэрэг байна даа гэж Харри хэлээд Слизериний ширээнд сууж байгаа Драко Малфой руу харлаа.

- Чи заавал тэгж бодох ёсгүй. Найрамдал хамтын ажиллагаа бүгдийн түлхүүр.

Бидний хий үзэгдэлүүд ч тэнхимээрээ ялгардаг ч гэлээ нөхөрсөг холбоотой байдаг. Би Гриффиндор Слизериний хоорондоо өшөө хорсол өрсөлдөөнд оролцож цуст баронтой маргалдахыг хүсэхгүй байна.

- Учир нь чи түүнээс айдаг гэж Рон хэллээ.

Бараг толгойгүй Ник ихэд доромжлогдсон төрхтэй болов.

- Би айсан гэнээ? Ноён Николас де мимси-Дельфингтон амьдралдаа хэзээ ч аймхай гэж дуудуулж байсангүй! Миний судсанд язгууртны удмын цус бий ...

- Цус гэнээ? Хэрвээ чамд байдаг бол ч ... гэж Рон хэллээ.

- Энэ бол зөвхөн ярианы дүрслэл. Би хэдийнээс сурагчдын идэж уухдаа хүртэл миний үхлээр тоглоом тохуу хийхэд дассан гэж бараг толгойгүй Ник уурсан хэлэхэд толгой нь торгоогдсон хэсэгхэн арьсан дээрээ осолтой чичирлээ.

- Ник тэр чамайг шоолж зүрхлэхгүй! гээд Гермiona Рон руу уурсан харав. Золгүй Роны ам дүүрэн байсан болохоор дэлбэрэх гэснээ «Бэ зхн асхг хссн» гэхэд Ник ахин өршөөл гуйх талаар бодсонгүй.
- Тэр агаарт хөөрөн өдтэй малгайгаа сэгсрээд ширээний өөр хэсэгт ах дүү Кривигийн дунд суудал оллоо.
- Сайн байна, Рон! гэж Гермiona тасхийв.
- Яасан? Би жирийн асуулт асууж болохгүй юу? гэж Рон аман дахаа залгиад эгдүүцэн дуугарлаа.
- За, энэ тухай мартаж үз гэж Гермiona уурсан хэлэхэд бүгд чимээгүй болов. Харри дэмий юмнаас болж маргалдсан Рон, Гермiona хоёрыг эвлэрүүлэхийг оролдсоноос шарсан мах, бөөртэй хуушуур идэж цаг өнгөрүүлсэн нь дээр гэж үзлээ. Сурагчид хоолоо идэж дуусгахад Дамблдор ахин бослоо. Яриа хөөрөө агшин зуур намдаж бүгд захирлын зүг эргэв. Харри таатайхан нойрмоглохоо мэдэрчээ. Түүнийг дээр дөрвөн хөлтэй, гайхамшигтай зөөлөн, дулаахан ор нь хүлээж байгаа ...
- Одоо бид гайхамшигтай сайхан цайллагын хоолоо шингээж байх зуур би та бүхний анхаарлыг хичээлийн жилийн эхэнд хэлдэг ердийн зүйлсээр татъя. Нэгдүгээр дамжааныханд сургуулийн талбайд байдаг Хориотой ойд орох хориотой гэдгийг санаж авцгаа. Хэд хэдэн ахлах дамжааныхан үүнийг санаж байгаа гэж найдна. (Харри, Рон, Гермiona нар бие бие рүүгээ инээмсэглэн харлаа).
- Манай сургуулийн харуул ноён Филчийн гуйлтаар дөрвөн зуун жаран хоёр дахь удаагаа бүх төрлийн шидийг хонгилд хэрэглэхийг зөвшөөрөхгүй гэдгийг сануулъя. Өөр бусад хориотой зүйлсийн жагсаалттай та бүхэн ноён Филчийн газар дорхи өрөөнд танилцаж болно.
- Багш нарын хувьд энэ жил хоёр өөрчлөлт гарсан. Бид та бүхэнд шидэт амьтны хичээлийн багш профессор Граббли Дергийг танилцуулахдаа баяртай байна. Түүнчлэн хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багш профессор Амбрижийг танилцуулж байна.
- Эелдэгээр урам зориггүй хуурамч алга ташихад Харри, Рон, Гермiona нар бие биерүүгээ хараад үл мэдэгхэн цочролд автлаа. Дамблдор Граббли Дергийг хэр удаан багшлахыг хэлсэнгүй.

Дамблдор цааш нь яриагаа үргэлжлүүлэв.

- Тэнхимийн квиддичийн шигшээгийн сонголтын хувьд ...

Тэр чимээгүй болсноо гайхан профессор Амбриж руу харлаа. Дамблдор яагаад яриагаа зогсоосныг хэн ч ойлгосонгүй. Тэгтэл хоолой засан ханиалгах «кхэ, кхэ» гэж дуу сонсогдож профессор Амбриж хөл дээрээ бослоо.

Дамблдор хэсэг зуур саатсанаа яриаг нь сонссон нь дээр гэж бодсон бололтой суугаад профессор Амбриж руу түгшин харлаа. Бусад багш нар гайхсанаа нууж чадсангүй. Профессор Стеблийн хөмсөг сэгсгэр буурал үсэн дороо алга болсон бол, профессор МакГонагалл уруулаа Харрийн хэзээ ч харж байгаагүйгээр жимийв. Шинэ багш хэзээ ч Дамблдорын яриаг зогсоохыг зүрхэлж байсангүй. Энэ эмэгтэйн харваас Хогвартст юу хийхээ мэддэггүй явдалд олон сурагчид инэвхийлэв.

- Таньд баярлалаа, захиралаа. Уулзалтын хэдэн эелдэг үг хэлье гэж тэр худал инээн хэлэв.

Түүний охиных шиг цангинасан хоолой дуулдахад Харри ахиад л тайлбарлаж боломгүй тааламжгүй зүйл мэдэрчээ. Тэр хүн бүр түүний тэнэг хоолой хөвсгөр ягаан цамцанд дургүйлхэж байгааг мэдэж байлаа. Тэр ахин хоолой засан «кхэ, кхэ» гэж ханиалгаснаа,

- Хогвартсад ахин ирэх таатай байна гэдгийг хэлэх ёстой! Ингээд над руу хандсан баяртай жижигхэн царайнуудыг олж харлаа! гээд хурц шүдээ гарган инээмсэглэв.

Харри танхимд ямар нэгэн баяртай царай олж харсангүй. Харин ч эсрэгээрээ бүгд түүнийг таван настай хүүхэд шиг хандсанд гайхан харцгааж байлаа.

- Би та нартай танилцахыг тэсэн ядан хүлээж байгаа бөгөөд сайн найзууд болно гэдэгтээ итгэлтэй байна!

Сурагчид бие бие рүүгээ хараад нууцгайхан инээлдэв.

- Би түүнтэй найзалвал цамцыг нь гуйж өмсөхгүй дээ гэж Парвати Лавандад шивнээд хоёул чимээгүй хөхрөлдөв.

Профессор Амбриж ахин хоолой засан «кхэ, кхэ» гэж ханиалгаснаа ярьж эхлэхэд хоолойд нь байсан түгшсэн өнгө үгүй болжээ. Тэр илүү ажил хэрэгч дуулдсан ч үг нь уйтгартай нэгэн хэвийн байлаа.

- Ид шидийн яамнаас үргэлж залуу шидтэнгүүдийн боловсролыг чухалчлан авч үздэг билээ. Бид төрөлхийн ховор авъяасыг дэмжин хөгжүүлж тусалж дэмжих болно. Эртнээс өвлөгдөж ирсэн шидтэнгүүдийн нэгдмэл байдал бидний залгамж халааны үед алдагдсаар цаашдаа бүр байхгүй болоход хүрч байна. Бидний өвөг дээдэс эрдэнэсийн авдар шиг ид шидийн мэдлэгийг хураан цуглуулж засан сайжруулдаг сайхан мэргэжлийг багш гэж дууддаг билээ.

Тэгснээ профессор Амбриж чимээгүй болж дэргэдээ байгаа багш нар руу багахан бөхийхөд хэн ч хариу бөхийсөнгүй. Профессор МакГонагалл хөмсгөө ширүүн зангидахад махчин шувуутай төстэй болов. Харри түүний профессор Стеблътэй учиртай харц солилцохыг ажиглалаа. Амбриж ахин нэг удаа «кхэ кхэ» гэж ханиалгаад яриагаа цааш нь үргэлжлүүлээ.

- Хогвартсын шинэ захирал бүр энэхүү эртний түүхтэй сургуулийг зогсолтонд оруулахгүйн тулд удирдан зохицуулах хүндхэн үүрэг даалгавар хүлээн авдаг юм. Ингээд өсөлт хөгжилт үргэлжилсээр бидний үед уламжлалыг барих шаардлагагүй болсон гэж үзэж байна. Хуучин ба шинийн тэнцвэрийг барихын тулд тогтмол байдал ба өөрчлөлт, уламжлал ба өөрчлөлт шинэчлэлт ...

Харри анхаарал нь суларч байгааг мэдрэв. Дамблдорыг ярих үед чимээгүй байсан танхим хөдөлгөөнд орж сурагчид бие биерүүгээ бөхийн шивнэлдэж инээлдэв. Когтевраны ширээнд Чжоу Чанг найзтайгаа ярилцаж байлаа. Чжоугаас холгүй суусан Полумна Лавгуд «Шүүмжлэгч» сэтгүүлээ ахин дэлгэжээ. Пуффендуйн ширээнд Эрни МакМиллан цөөн хүмүүсийн адил Амбриж руу харах хэдий ч Харри гөлийсөн харцнаас нь түүний энгэр дээр гялалзаж байгаа ахлагчын шинэ тэмдэг биеэ тэгж авч явахыг шаардаж байгаад эргэлзсэнгүй.

Профессор Амбриж сурагчдыг ажигласангүй. Харрид түүний хамар дор бослого үймээн дэгдсэн ч эцсээ хүртэл ярих байх гэсэн сэтгэгдэл төржээ. Багш нар маш анхааралтай сонсож байв. Гермiona Амбрижийн нэг ч үгийг гээлгүй сонсох бөгөөд дотроо тунгааж байгаа нь илэрхий.

- ... яагаад гэвэл манай эринд шинэ алхам хийхийн тулд зарим зүйлийг өөрчилж сайжруулах шаардлагатай. Энэ хооронд зарим хоцрогдсон хуучин зуршлыг халж татгалзах ёстой. Бид шинэ эрин рүү урагш алхан үр ашигтай хариуцлагатай байдлаа хадгалан улам сайжрах хэрэгтэй байна.

Тэр доошоо суулаа. Дамблдор алга ташив. Багш нар түүний жишээг дагалдахад

зарим нь нэг хоёр удаа ташиж байгааг Харри харлаа. Хэдэн сурагчид ярианы төгсгөлийг сонсоогүй болохоор жинхэнээсээ алга ташилаа. Дамблдор ахин бослоо.

- Гүн гүнзгий тодруулсан явдалд маш их баярлалаа, профессор Амбриж.

Ингээд би яриагаа үргэлжлүүлээ. Квиддичийн шигшээгийн сонголтын хувьд

...

- Тиймээ энэ үнэхээр тодотгосон явдал боллоо гэж Гермiona аяархан хэлэв.

- Чамд таалагдсан гэж бүү хэлээрэй дээ. Энэ миний сонсож байсан хамгийн уйтгартай яриа болоо. Персигээс ч илүү гэж Рон хэлээд Гермiona руу цаггалан царайгаар харав.

- Би тодотгосон гэж хэлсэн болохоос биш таалагдсан гэж хэлээгүй. Энэ олон зүйлийг тайлбарлаж өглөө.

- Үнэн үү? Надад бол нуршуу юм шиг санагдлаа гэж Харри гайхлаа.

- Нуршуу үгийн цаана чухал зүйл нуугдсан байдаг юм гэж Гермiona хэлэв.

- Энэ чинь тэгээд юу гэж байгаа юм? гэж Рон тэсгэлгүй дуугарлаа.

- Би чамд юу бодсоноо л хэлж байна. Энэ нь ид шидийн яамнаас Хогвартсын хэрэгт оролцоно гэсэн үг.

Тэр үед эргэн тойронд чимээ шуугиан дэгдлээ. Дамблдор тэднийг ярилцаж байх хооронд төгсгөлийн үгээ хэлжээ. Сурагчид босож эхлэн үүд рүү хөдлөв. Гермiona тэвдсэн шинжтэй хөл дээрээ үсрэн бослоо.

- Рон бид нэгдүгээр дамжааныханд зам зааж өгөх ёстой.

- Аан тийм л дээ. Хөөе! Хөөе, чи! Атигар аа!

- Рон!

- Харин чинийхээр бол хэн гэж? Аварга биет юм уу?

- Тэднийг жижигхэн болохоор атгигар нэрлэж болохгүй! Нэгдүгээр дамжааныхан! Наашаа ирцгээ! гэж Гермiona захирангуй хашгирав.

Гриффиндор болон Пуффендуйн ширээний дундуур хэсэг шинэ сурагчид эмээнгүй ойртож ирэв. Тэд их жаахан санагдахад Харри анх удаа ирэх үедээ арай том харагдаж байсан гэдэгтээ итгэлтэй байлаа. Тэр тэдэнд инээмсэглэв. Юан Аберкормбигийн хажууд зогсож байсан цайвар үстэй хүү хөшин зогсоод түүнийг

тохойгоороо нудран чихэнд нь юм шивнэлээ. Юан Аберкромби айсан янзтай Харри руу харлаа. Тэгэхэд Харри инээмсэглэл нь алга болохыг мэдэрчээ.

- За тэгвэл баяртай гэж тэр Рон, Гермона хоёрт хэлээд Их танхимын үүд рүү ганцаар хөдлөхдөө бүх хүчээ гарган шивнэлт болон харцыг ажиглахгүй байхыг хичээв. Үүдний танхимд байсан хүүхдүүдийн дундуур гарахдаа урагшаа харан чигээрээ явж гантиг шатаар гүйн гараад хоёр ч нууц гарцаар гарч ихэнхи сурагчдыг ардаа орхилоо.

Тэнэг байхгүйн тулд өөртөө уурласаар цөөхөн хүмүүстэй дээд талын хонгилд гарч ирлээ. Мэдээж бүгд түүнийг харж байгаа. Тэр ердөө хоёр сарын өмнө Гурван шидтэний тэмцээний төөрдөг байшингаас сурагчийн үхсэн биетэй гарч ирээд Волдеморт эргэн төрсөн гэж хэлсэн юм чинь. Түүнд гэр лүүгээ явахын өмнө хүмүүст оршуулгын газар болсон аймшигтай үйл явдлыг нарийвчлан ярих цаг байгаагүй.

Харри хонгилын эцсийн Гриффиндорын амралтын өрөөнд орох гарц болох тарган хатагтайн хөргөнд хүрээд шинэ нууц үг мэдэхгүй гэдгээ саналаа.

- Э ... гэж хэлээд тарган хатагтай руу харахад ягаан атласан даашинзныхаа нугалаасыг тэнийлгээд ширүүн ширтлээ.

- Нууц үггүй бол оруулахгүй гэж тэр сүрлэг мэдэгдэв.

- Харри, би түүнийг мэднэ!

Ард нь хэн нэгний аахилах чимээ сонсогдоход эргэн хараад гүйн ирж байгаа

Невиллийг харлаа.

- Юу гэдгийг нь чи таахгүй дээ! Харин би ганц хэлүүлээд л тогтоосон гээд тэр галт тэргэнд үзүүлсэн кактусаа даллаад,

- Мимбулус мимблетония! гэв.

- Тиймээ үнэн гэж тарган хатагтай хэлээд хөрөг эргэн орох хаалга нээгдэхэд

Харри, Невилл хоёр орлоо.

Гриффиндорын дугуй амралтын өрөө дулаахан тухтай бөгөөд түшлэгтэй зөөлөн сандал, санжигнасан хуучин ширээтэй байлаа. Ханан зууханд гал хөгжилтэй асаж хэдэн сурагчид унтахын өмнө гараа ээнэ. Өрөөний эсрэг талд Фред, Жорж Уизли хоёр зарлалын самбар дээр ямар нэг зүйл нааж байв. Харри тэдэн рүү тавтай нойрсохыг даллаад хөвгүүдийн унтлагын өрөө рүү чиглэхэд Невилл түүнийг

дагалдав.

Дин Томас, Симус Финниган хоёр унтлагын өрөөнд түрүүлж ирээд орны дэргэдэх хананд гэрэл зураг болон зурагт хуудас нааж байв. Харриг ороход тэд ярилцаж байснаа чимээгүй боллоо. Харри тэднийг өөрийнх нь тухай ярилцаагүй байгаа даа гэж бодсон ч дараа нь хий сэжиглэх өвчтэй болж гэж бодлоо.

- Сайн уу гээд тэр чемодан руугаа очин онгойлголоо.
- Сайн уу, Харри. Амралтаа сайхан өнгөрүүлсэн үү? гэж Дин хэлээд Вес Хэм багийн хувцасны өнгөтэй унтлагын цамц өмслөө.
- Муугүй шүү. Харин чи? гэж Харри бувтнахдаа амралтаа яаж өнгөрүүлснээ тухайгаа ярих хүч байсангүй.
- Тиймээ, дажгүй. Ямар ч байсан Симусынхаас дээр. Тэр сая надад ярьж байлаа.
- Юу болоо вэ, Симус? гэж Невилл асуугаад Мимбулус мимбилотиягаа орныхоо хажуугийн шүүгээн дээр энхрийлэн тавилаа.

Симус шууд хариулсангүй. Тэр ямар нэг юмны тухай бодлогоширон квиддичийн багийн зурагт хуудсыг нааж тэгшилэх зуураа Харри руу эргэн харсангүй.

- Ээж намайг явуулахыг хүсээгүй.
- Юу? гээд Харри жанчаа тайлахаа болин хөшлөө.
- Ээж намайг Хогвартс явуулахыг хүсээгүй.

Симус эцэст нь зурагт хуудсаа нааж дуусаад Харри руу харалгүй чемоданаасаа унтлагын цамцаа гаргалаа.

- Гэхдээ яагаад? гэж Харри гайхан асуулаа. Тэр Симусын ээж шидтэн бөгөөд Дурслийнхантай адилгүй гэдгийг мэддэг байв. Симус цамцаа өмсөж дуусах хүртэл хариулсангүй.
- Тэгэхээр ... чамаас болсон байх гэж бодож байна.
- Энэ чинь ямар учиртай юм? гэж Харри түргэн асуулаа. Түүний зүрх хурдсан цохилж ямар нэгэн бүдэг бадаг зүйл мэдэрлээ.
- Тэгэхээр гэж Симус ахин Харрийн харцнаас зугтан хэлснээ,
- Тэр ... ээ ... үгүй зөвхөн чамд ч биш Дамблдорт бас байгаа юм байна ... гэв.

- Тэр «Өдөр тутмын зөнч» сонинд итгээ юу? Намайг худалч, Дамблдорыг хөгшин тэнэг гэж бодож байна уу?

Симус түүн рүү харав.

- Тиймээ, тэгж бодож байх шиг байна.

Харри юу ч хэлсэнгүй. Тэр шүүгээн дээр шидэт саваагаа тавиад жанчаа тайлж ууртайгаар чемодандаа хийн унтлагын цамцаа өмслөө. Бүгд түүнийг харж эхэлсэн цагаас л хэл нь загатнаж байлаа. Тэгэхээр тэд болсон явдлын тухай өчүүхэн ч төсөөлөл байхгүй байгаа юм байна ... Хатагтай Финниган гэдэг тэнэг эмэгтэй юу ч мэдэхгүй болохоор Харрийн талаар муугаар бодож байгаа юм байна.

Тэр орондоо орж хөшгөө хаах гэтэл Симус гэнэтхэн,

- Сонсооч ... Тэр шөнө юу болсон юм бэ ... Чи ойлгож байгаа биз дээ ... Седрик Диггорийн үхэл болон бас бус зүйл гээд л? гэв.

Симусын хоолой түгшсэн хэдий ч сонирхсон янзтай байлаа. Чемодан руугаа бөхийсөн Дин тэр чигтээ хөшиж чих тавилаа.

- Надаас асуух ямар хэрэгтэй юм? Ээж шигээ «Өдөр тутмын Зөнч» сонин уншвал чамд саад болохгүй л байх. Тэндээс чи мэдэх гэсэн бүх зүйлээ олно.

- Миний ээжийн тухай тэгж бүү хэл! гэж Симус уурсав.

- Намайг худалч гэж нэрлэсэн бүх хүнийг тэгж хэлэх болно.

- Надтай ингэж бүү ярь.

- Би чамтай хүссэнээрээ л ярих болно гэж Харри хэлээд уур хилэн нь огцом дүрэлзэж орны хажуугийн шүүгээн дээрээс шидэт саваагаа шүүрэн авлаа.

- Надтай нэг өрөөнд унтахыг хүсэхгүй байвал МакГонагаллаас очиж чамайг гаргахыг гуй. Ээж чинь түгших нь багасах болно ...

- Миний ээжийг тайван орхи, Поттер!

- Энд юу болоод байна?

Хаалгаар Рон орж ирэв. Тэр нүдээ томруулан Симусын зангидсан нударга болон орон дээрээ өвдөглөн шидэт саваагаа чиглүүлсэн Харрийг олж харлаа.

- Тэр миний ээжийн тухай яриад байна! гэж Симус орилов.

- Юу? Боль доо, Харри тэгэхгүй. Бид чиний ээжтэй уулзах үед таалагдсан ...
 - Өдөр тутмын Зөнч сонины миний талаар хэлсэн өмхий үг болгонд итгээгүй байхдаа таалагдаж байсан! гэж Харри чанга хашгирав.
 - Өө ... тэгвэл гээд Роны сэвхтэй нүүрэнд нь ойлгосны шинж илрэв.
 - Юу мэдсэн гэж? Түүний зөв, би нэг өрөөнд хамт амьдрахыг хүсэхгүй байна. Тэр галзуу юм байна гэж Симус хорсолтой харж уурсан хэллээ.
 - Тэгж болохгүй, Симус гэж Рон хэлэхэд чих нь хэдийн улайж эхэлжээ.
 - Болохгүй гэнээ? Тэгэхээр чи түүний Хэцүү нэртийн тухай хэлсэн дэмий зүйлд итгэж байгаа хэрэг үү? Чинийхээр бол тэр үнэн хэлсэн хэрэг үү? гэж Смиус орилов.
 - Тиймээ би итгэж байна гэж Рон уурсан дуу алдав.
 - Тэгвэл чи ч гэсэн галзуурсан юм байна гэж Симус зэвүүцлээ.
 - Тийм үү? Гэхдээ азгүй нь гэвэл найз минь би ахлагч! Тийм учраас хэрвээ шийтгэл хүлээхийг хүсээгүй бол юу хэлж байгаагаа бодож бай! гээд Рон энгэр дээрх тэмдгээ заалаа.
- Хэдэн хормын турш Симус тийм шийтгэл хүлээхэд бэлэн харагдсан ч дараа нь амаа хамхин огцом эргэж орныхоо хөшгийг хүчтэй татахад цууран тоостой шалан дээр унав. Рон Симус руу таагүй харснаа Дин, Невилл хоёр луу харлаа.
- Өөр хэний эцэг эх Харрийн эсрэг байна? гэж тэр сүрдүүлэн асуулаа.
 - Миний эцэг эх маглууд. Тэд Хогвартсад болсон үхлийн тухай юу ч мэдэхгүй.
- Би мэдээж тэдэнд хэлэх тэнэг биш л дээ гээд Дин мөрөө хавчлаа.
- Чи миний ээжийг мэдэхгүй байна. Тэр юуг ч хаанаас мэдчих хүн! гэж Симус ширүүн хэлээд,
 - Тэгээд ч чиний эцэг эх чинь «Өдөр тутмын зөнч» сонин авдаггүй. Тэд манай захирлыг Визенгамот болон олон улсын шидтэний холбооны тэргүүлэгчээс ухаан муудсаны улмаас халагдсан гэдгийг мэдэхгүй ... гэв.
 - Миний эмээ энэ бүхнийг дэмий яриа гэсэн гэж Невилл хашгирлаа.
 - Тэр «Зөнч» сонин худалч болохоос Дамблдор биш гэсэн. Тэр ч байтугай хүчингүй болгоход гарын үсэг зураагүй. Бид Харрид итгэж байгаа гээд орон дээрээ суугаад хөнжлөө эрүүгээ хүртэл татсанаа Симус руу харж,

- Эмээ үргэлж Хэцүү нэрт хэзээ нэгэн цагт эргэж ирнэ гэдэг байсан юм. Тэр хэрвээ Дамблдор түүнийг эргэж ирнэ гэж хэлсэн бол энд байгаа л гэсэн үг гэв.

Харри үүнийг сонсоод Невиллд талархах сэтгэл төрлөө. Өөр хэн ч юу ч хэлсэнгүй. Симус шидэт саваагаа гарган хөшгөө засаад түүний ард нуугдав. Дин орон дээрээ хэвтээд цааш харан чимээгүй болов. Невилл сарны гэрэлд кактусаа энхрийлэн харна.

Рон унтахад бэлтгэн хувцсаа солилоо. Харри зэргэлдээх орон дээр нь дэрэн дээрээ эргэж хэвтлээ. Өөр хичнээн хүн түүнийг ингэж бухимдуулах бол?

Харин Дамблдор? Тэр зунжингаа ийм зүйлийг амсаж эхлээд Визенгамот дараа нь олон улсын шидтэний холбооны тэргүүлэгчээс хөөгдсөн гэж үү? Магадгүй ийм учраас эдгээр саруудын турш Харрид уурлахгүйн тулд зугтаж байгаа юм болов уу? Юутай ч атугай болсон үйл явдал тэднийг нэгтгэсэн. Дамблдор Харрийн бүх зүйлд итгэсэнээ эхлээд бүх сургуулийнхны өмнө дараа нь шидтэнгүүдийн өмнө зарласан. Харриг худалч гэж бодож байгаа хүмүүс Дамблдорыг бас худал хэлсэн гэж бодож байгаа ...

Рон орондоо хэвтээд сүүлчийн гэрлийг унтраахад Харри золгүй байдлаа мэдэрч тэд эрт орой хэзээ нэгэн цагт түүний зөв гэдгийг ойлгоно гэж бодлоо. Гэхдээ өнөөдрийн адил хичнээн дайралтыг тэсэх хэрэгтэй вэ?

БҮЛЭГ 12: ПРОФЕССОР АМБРИЖ

Өглөө нь Симус түргэн хувцаслаад унтлагын өрөөнөөс нисэн алга болов. Харри оймсоо ч өмсөж амжсангүй.

- Тэр надтай нэг өрөөнд хэтэрхий удаан байвал ухаан солиорно гэж бодсон юм болов уу? гэж Харри Симусын жанчны үзүүр гялсхийн алга болоход хэлэв.

- За боль доо, Харри. Тэр зүгээр л ... гэж Дин цүнхээ мөрөндөө үүрээд бувтналаа.

Симус үнэндээ «зүгээр» л гэж хэлэх гээгүй ч чимээгүй болсноо өрөөнөөс гарлаа. Невилл, Рон хоёр Харри руу зэрэг энэ бол түүний асуудал болохоос чинийх биш гэсэн харцаар ширтэв. Гэхдээ Харри тийм амархан тайвширахааргүй байлаа.

Хичнээн их зүйлийг тэвчиж өнгөрөөх ёстой юм?

- Юу болоо вэ, Харри? Чи нэг л тиймэрхүү байх чинь ... гэж тэднийг өглөөний цайндаа явахаар буухад амралтын өрөөнд таван хормын дараа гүйцэж ирсэн Гермиона хэлснээ,

- Энэ чинь одоо юу вэ? гэлээ.

Тэр самбар дээрх том зарлал руу харав. ГАЛЛЕОНУУД ГАЛЛЕОНУУД Халаасанд чинь мөнгө байна уу?

Багахан алт зарцуулахыг хүсэхгүй байна уу? Тэгвэл Гриффиндорын амралтын өрөөнд Фред, Жорж Уизли хоёр дээр хүрээд ир

(Бид бүх эрсдлийг нь бид хүлээх болно)

- Тэднийг хязгаарлах хэрэгтэй! Бид тэдэнтэй ярилцах ёстой, Рон гэж Гермиона ууртай хэлээд цаасыг уран цаана нь байсан арван сард Хогсмид явахыг зарлалыг гаргалаа.

Рон түгшсэн янзтай харагдав.

- Яагаад?

- Яагаад гэвэл бид ахлагч! Биднээс өөр хэн энэ утгагүй явдлыг зогсоох юм бэ! гэж Гермиона хөргөн нүхээр гараад хэлэв.

Рон юу ч хэлсэнгүй хэдий ч баргар төрхнөөс нь Фред, Жорж хоёрыг зогсоох

оролдлого нэг их баярлуулахгүй байгааг Харри ойлгожээ.

- Бас чи яагаа вэ, Харри? Чи хэн нэгэнд аймшигтай уурласан байна гэж Гермиона тэд шатаар уруудан хоорондоо хөөрөлдөж буй шидтэнгүүдийн хөргийн хажуугаар өнгөрөхөд хэллээ.

- Симус Харриг Хэцүү нэргийн тухай худал хэлсэн гэж бодож байгаа гэж Рон Харрийн хариулахыг хүсэхгүй байгааг ойлгоод дуугарав. Харри Гермонаг уурсах байх гэж найдсан ч ердөө санаа алджээ.

- Лаванда бас тэгж бодож байсан.

- Чи түүнтэй намайг алдар гавъяаны араас хөөцөлдөгч өөдгүй худалч гэж ярилцав уу? хэмээн Харри чанга асуулаа.

- Үгүй. Би түүнд тэвчээргүй том амаа хамхиж бай гэж зөвлөсөн. Харин чи Рон бид хоёр луу дайрахаа боливол их эелдэг хэрэг байна. Чамайг бидний талд чинь байгаа гэдгийг ажигласан эсэхийг мэдэхгүй юм даа.

- Уучлаарай гэж удтал чимээгүй болсны эцэст Харри аяархан хэллээ.

- Зүгээр дээ. Дамблдор хичээлийн жилийн төгсгөлийн цайллаган дээр юу хэлснийг санаж байна уу?

Харри, Рон хоёр түүн рүү асуунгүй харахад Гермиона ахин санаа алдав.

- Хэцүү нэргийн тухай. Түүнийг дайснуудаа зөрчилдүүлэхдээ маш гарамгай гэсэн. Бид үүнтэй тэмцэхийн тулд холбоо болон итгэл нөхөрлөлөө бататгах ёстой гэсэн.

- Чи яаж ийм зүйлийг санадаг байна? гэж Рон асуугаад бишрэн харлаа.

- Би сонссон юм, Рон тэгээд л тэр гэж Гермиона хүйтнээр хэлэв.

- Би лав нэг ч үг тодорхой санаж чадахгүй нь ...

- Гол учир нь гэвэл Дамблдорын хэлсэн үгэнд л байгаа юм. Хэцүү нэрт ердөө хоёр сарын өмнө төрөөд байхад бид хэдийн өөр хоорондоо дайсагналцаж эхлээд байна. Шидэт бүрхийн анхааруулгыг санаж байна уу? Хамтдаа байж нэгдмэл бай гэсэн.

- Гэхдээ өчигдөр орой Харригийн зөв байсан шүү дээ. Хэрвээ бид Слизеринтэй нөхөрсөг харилцаагаа өргөжүүлэх юм бол ...

- Минийхээр бол тэнхим хоорондын холбоогоо бэхжүүлэхийг оролдохгүй бол харамсалтай хэрэг гэж тэр уурсан эсэргүүцэв.

Тэд гантиг шатны ёроолд хүрлээ. Үүдний танхимд хэсэг дөрөвдүгээр дамжааны Когтевранчууд байсан бөгөөд Харриг харангуутаа хамгийн сүүлд үлдсэн рүү нь дайрахаас айсан мэт түргэн алга болцгоов.

- Алив, тэгээд нөхөрлөлөө бататга л даа гэж Харри даажигнан хэллээ.

Тэд Когтевранчуудын араас Их танхим руу орохдоо зөнгөөрөө багш нарын ширээ рүү харцгаав. Профессор Граббли Дерг тэнд суугаад одон орон судлалын хичээлийн багш профессор Синистратай ярилцаж байлаа. Хагрид өчигдөр оройн адил байсангүй. Илбэдсэн шидэт адарт Харрийн сэтгэл санааг үзүүлэх мэт гунигтай саарал үүл хөшиглөжээ.

- Дамблдор бидэнд Граббли Дерг хэр удаан хугацаагаар багшлахыг хэлсэнгүй гэж тэр Гриффиндорын ширээ рүү явах замдаа хэлэв.

- Магадгүй ... гэж Гермиона бодлогоширонгүй хэллээ.

- Юу? гэж Харри, Рон хоёр зэрэг асуув.

- Магадгүй ... Хагридын байхгүй явдалд анхаарал татахыг хүсээгүй байх.

- Анхаарал татахгүй гэдэг чинь юу гэж байгаа юм? Яаж үүнийг ажиглахгүй байж болох юм бэ? гэж Рон инээд алдав.

Гермионаг хариулж амжихаас урьтаж Харри руу өндөр хар үстэй охин ирэв.

- Сайн уу, Анжелина.

- Сайн уу. Зуныг сайхан өнгөрүүлэв үү? гээд тэр хариулт хүлээлгүй,

- Сонсооч би Гриффиндорын квиддичийн багийн ахлагч болсон гэв.

- Сайхан мэдээ байна гэж Харри инээмсэглэхдээ Анжелинагийн эрч хүчтэй ярианаас Оливер Вудын адил тоглогчидоо зовоохгүй байгаа гэж сэжиглэв.

- Бидэнд Оливерийн оронд шинэ хаалгач хэрэгтэй байна. Сонголтыг баасан гаригийн таван цагаас явуулна. Би багийнхнаа бүрэлдхүүнээр нь цуглараасай гэж хүсч байна. Шинэ хүнээ харах хэрэгтэй.

- Ойлголоо гэж Харри хэлэв. Анжелина инээмсэглэсээр явлаа.

- Би Вуд сургуулиа төгсчихсөн гэдгийг мартчихсан байна. Манай багийн хувьд

томоохон алдагдал боллоо доо гэж Гермiona хэлээд Роны дэргэд суун тавган дээрээ шарсан талх тавилаа.

- Тийм шүү. Тэр сайн хаалгач байсан гэж Харри хэлээд эсрэг талд нь суулаа.

- Та нарт шинэ цус сэлбэхэд болохгүй юм шиг санагдахгүй байна уу? гэж Рон дуугарав.

Дээд талын цонхоор агаар зүсэн исгэрэх чимээ гарч зуугаад ууль хөөрөн орж ирлээ. Тэд танхим дундуур нисэлдэн авчирсан захиа болон илгээмжээ эздэд нь өгөхдөө өглөөний цайн дээгүүр ус дуслуулж байлаа. Хэдвиг байсангүйд Харри гайхсангүй. Түүнд захиа бичдэг цорын ганц хүн Сириус байсан болохоор хорин дөрвөн цагийн дотор ямар нэгэн шинэ сонин зүйл гарсан гэдэгт эргэлзэж байв. Гермiona жүржийн шүүсээ хажуу тийш түргэн холдуултал хошуундаа нойтон «Өдөр тутмын зөнч» сонин зуусан ууль газардав.

- Чи урьдын адил захиалсан хэвээр байгаа юм уу? Надад лав ийм зүйл хэрэггүй гэж Харри Симусын тухай бодоод уурсан хэлэхэд Гермiona уулийн хөлд уяатай арьсан хүүдийд кнат хийж байв.

- Дайсныхаа юу бичиж байгааг мэдэх хэрэгтэй шүү дээ хэмээн Гермiona баргар хэлээд сонинг дэлгэн үзэгдэхээ болиод Харри, Рон хоёрыг хоолоо дуусгатал гарч ирсэнгүй.

- Юу ч алга. Чиний тухай ч Дамблдорын тухай ч юу ч алга гэж тэр сонинг хуйлан тавган дээрээ тавилаа.

Профессор МакГонагалл ширээний дагуу явж хичээлийн хуваарь тарааж байв.

- Өнөөдөр чинь ямар гээчийн өдөр вэ! Ид шидийн түүх, уусмалын хичээл хоёр цаг, мэргэ төлгө, хар урлагаас хамгаалах хичээл хоёр цаг ... Бинс, Снегг, Трелони бас Амбриж гээд бүгд нэг өдөр шүү! Фред, Жорж хоёр Ажлаас зайлсхийгч зууш хийсэн нь сайн хэрэг боллоо ... гэж Рон дуу алдан ёолов.

- Би юу сонсов оо? Миний чих хуураагүй байгаа даа? Хогвартсын ахлагчид хичээлээс гадуур зугаалахыг хүсч байна гэж үү? хэмээн Харрийн хажууд ирж суусан Фред Жоржоос асуулаа.

- Бидэнд өнөөдөр юу байгааг хараач. Миний амьдралд тохиолдсон хамгийн муу өдөр байна гэж Рон дүнсийн хэлээд Фредэд хуваариа дөхүүлэв.

- Би чамайг ойлгож байна, дүү минь. Чамайг хүсвэл Цус гоожуулагч чихрээ хямд өгье.
- Яагаад хямд өгч байгаа юм? гэж Рон сэжигтэй асуулаа.
- Учир нь гэвэл чиний хамраас цус гараад тогтохгүй. Эсрэг зүйл нь бидэнд байхгүй гэж Жорж тайлбарлаад утсан загас идлээ.
- Баярлалаа. Гэхдээ би хичээлдээ суусан нь дээр байх гээд Рон хуваариа халаасандаа хийлээ.
- Ингэхэд та нарын Ажлаас зайлсхийгч зуушны хувьд гэвэл гэж Гермiona тэдэн рүү нүдээ гялалзуулан харж хэлээд,
- Та нар Гриффиндорын самбарт сурталчилгаа гаргаж болохгүй гэв.
- Хэн бидэнд хэлэх юм? гэж Жорж гайхан асуулаа.
- Би. Бас Рон гэж Гермiona хэлэв.
- Намайг бүү оролцуул гэж Рон яаран хэллээ.

Гермiona түүн рүү муухай харлаа. Фред, Жорж хоёр инээлдэв.

- Гермiona чи удахгүй өөр дуу дуулна даа. Чи тавдугаар дамжаанд орсон болохоор удахгүй өөрөө биднээс зуушыг минь гуйх л болно гэж Фред хэлээд талхан дээр зузаан тос түрхлээ.
 - Яагаад тавдугаар дамжаанд би зууш хэрэглэхийг хүсдэг билээ?
 - Тавдугаар дамжаанд С.И.Ш өгдөг юм гэж Жорж тайлбарлав.
 - Тэгээд юу гэж?
 - Та нарын урд шалгалт байна. Нуруун дээр чинь их ачаалал ирнэ гэж Фред сэтгэл хангалуун хэллээ.
 - Манай дамжааны хагас нь С.И.Ш өгөхийн төлөө сэтгэлийн хямралд орсон.
- Нулимс ба орилоон хашгираан ... Патриция Стимпсон үргэлж ухаан алдан унадаг байлаа ...
- Харин Кеннет Таулер цэврүүтсэнийг санаж байна уу? гэж Фред сануулав.
 - Яагаад гэвэл чи түүний халаасанд цэврүүтүүлдэг дарь хийсэн гэж Жорж хэлэв.

- Өө, тийм л дээ. Би мартчихаж ... Бүгдийг толгойдоо санаж байх заримдаа хэцүү юм гэж Фред инээмсэглэв.

- Ямар ч байлаа гэсэн тавдугаар дамжаа бол хар дарсан зүүд гэсэн үг. Бас шалгалтын үр дүнд зовох хэрэг гарна. Гэхдээ Фред бид хоёр гуниглаагүй л дээ.

- Тийм шүү ... Та нар яалаа? Ердөө гурван С.И.Ш авсан гэж Рон сануулав.

- Бидний ирээдүйн амьдралд ямар ч сургуулийн амжилт хэрэггүй гэж Фред санаа зовсон янзгүй хэлэв.

- Бид бүр долдугаар дамжаанд сурах эсэх талаар бодож үзсэн шүү. Бидэнд одоо байгаа болохоор ... гэж Жорж хэлснээ Харригийн анхааруулсан харцыг харлаа.

Ахиад жаахан л удсан бол тэдэнд Харри Гурван шидтэний тэмцээний шагналаа өгсөн тухай хэлэх байлаа.

- Бидэнд С.И.Ш байлаа гээд яах юм бэ. Бидэнд ямар хэрэгтэй юм бэ? Гэхдээ бид ээжид сургуулиас эрт гарах тухайгаа хэлэхгүй. Персигийн явалт ээжийг их гомдоосон болохоор бидний сургуулиас гаралт хүнд тусах байх.

- Гэхдээ бид энд байх сүүлчийн жилээ үрэхгүй гэж бодож байна. Бид зах зээлээ хайж Хогвартсын сурагчдад тоглоомын дэлгүүрээс шаардагдаж байгаа зүйлийг судлан шидэт тоглоомынхоо үр дүнг нь судлах болно гээд Фред Их танхим руу харлаа.

- Гэхдээ та нар эхлэлийн хөрөнгөө хаанаас авах юм бэ? Та нарт ихээхэн хэмжээний уусмалын орц хэрэг болно биз дээ гэж Гермiona үл итгэн асуулаа.

Харри ихрүүд рүү харсангүй. Түүний нүүр халуу оргиход зориуд сэрээгээ унагаад авахаар доошоо тонгойв. Тэгтэл Фред,

- Багахан асуух юм бол багахан худал хэлэхийг сонсоно шүү, Гермiona. Явъя Жорж, хэрвээ яарвал ургамал судлалын хичээлээс өмнө хэдэн Уртасгагч чих зарж болох байх гэв.

Харри ширээн дороос өндийгөөд ихрүүд гартаа шарсан талх барьсаар явахыг харлаа.

- Үүнийг юу гэж ойлгох вэ? Тэдэнд ажил хэргээ эхлэх хөрөнгө байгаа юм болов уу? гэж Гермiona асуугаад Харри, Рон хоёр руу харав.

- Би ч гэсэн гайхаж байна. Энэ зун тэд надад шинэ ёслолын хувцас авч өгсөн.

Тэднийг хаанаас мөнгөтэй болсныг ойлгох юм алга ... гээд Рон духаа

бодлогоширон үрчийлгэв.

Харри яриаг аюулгүй тийш залсан нь дээр гэж шийдэв.

- Энэ жилийн шалгалт нээрэн хүнд байх гэж бодож байна уу?
- Магадгүй л юм. С.И.Ш. бол ямар ажил мэргэжил сонгохоос авхуулаад маш чухал зүйл юм. Энэ жил Билл биднийг мэргэжлийн сонголт хийнэ гэсэн. Түүгээр сүүлчийн жилдээ юу судлахаа тогтоох юм байх.
- Ингэхэд та хоёр Хогвартсыг төгссөний дараа юу хийхийг хүсч байна? гэж Харри Рон, Гермона хоёртой их танхимаас гарч ид шидийн түүх рүү явахдаа асуулаа.
- Би магадгүй ... гэж Рон удаанаар хэлэв. Тэр гэнэтхэн ичингүйрлээ.
- Юу? гэж Харри асуув.
- Мракоборец болвол муугүй л байна гэж Рон хайхрамжгүй хэлэв.
- Тийм шүү! гэж Харри батлав.
- Гэхдээ тэд бол дээд зэрэглэлийнх болохоор их хичээх хэрэгтэй. Харин чи, Гермона?
- Мэдэхгүй. Жинхэнэ чухал ажил хийхийг хүсч байна.
- Мракоберец бол чухал ажил шүү дээ! гэж Харри дуу алдав.
- Тиймээ, гэхдээ энэ дэлхий дээрх цорын ганц чухал ажил биш. Би жишээлбэл үйлчлэгч нарын хөдөлмөрийг хамгаалахын төлөө тэмцэх ч юмуу гэж Гермона гүнзгий бодлогоширон хэллээ.

Харри Рон хоёр бие биерүүгээ харлаа.

Ид шидийн түүх хамгийн уйтгартай хичээл байлаа. Профессор Бинс нэгэн хэвийн хөврүүлэн ярих бөгөөд ердөө арван хорон өнгөрөхөд нойр хүрэн өрөөний дулаан тав дахин ихсэв. Түүний багшлах загвар нь гэвэл бувтнаад л байна бувтнаад л байна нэг бол чи суугаад бичиж авах нөгөө бол нойрмог нэг тийш гөлрөх үлдэнэ. Харри, Рон хоёр өнгөрсөн жил энэ хичээл дээр муу дүн авах шахсан ч аз болоход Гермона шалгалтын өмнө бэлтгэсэн төлөвлөгөөгөө өгчээ. Тэр зөвхөн ганцаараа профессорын хоолоойг нойрмоглохгүй чагнах хүчтэй байлаа.

Өнөөдөр дөчин таван минутын турш аварга биетүүдийн дайны тухай хичээлийг тэсэх хэрэгтэй болов. Эхний арван минутад Харрид өөр ямар ч багш энэ хичээлийг

сонирхолтой зааж чадах нь ойлгомжтой болов. Дараа нь үлдсэн гучин тавын минутын турш Ронтой цаасны булан дээр дүүжлээстэй хүнийг тоглоход Гермiona тэдэн рүү зэвүүцэнгүй харлаа.

- Та нарынхаар хэрвээ би энэ жил бэлтгэсэн материалаа өгөхгүй бол яах вэ? гэж тэр ангиас гарч явахдаа хүйтнээр асуулаа.

- Бид С.И.Ш.-дээ унана. Чи үүнийг тэвчих үү, Гермiona?

- Гавъяагаа хүртэж байгаа юм чинь. Та нар ядаж түүнийг сонсохыг оролдсон ч үгүй шүү дээ.

- Өөр яаж оролдох юм. Гэхдээ бидэнд чиний тархи байхгүй болохоор төвлөрч чадахгүй байна. Тэгээд ч чи биднээс ухаантай юм чинь.

- Бүү тэнэг юм ярь гэж Гермiona хэлээд гадаах чийгтэй хашаанд гарахдаа царай нь эелдэг болсон байлаа.

Тэнгэрт хөнгөн манан униартаж сурагчид хашаан дотор бужигналдана. Харри, Рон, Гермiona нар тагтан дор аятайхан буланд зогсоод эхний хичээл дээр Снеггийн өгсөн даалгавар шиг хүйтэн борооноос хамгаалан жанчныхаа захыг босгов. Тэгтэл хэн нэгэн хүн булан руу ирэхийг харлаа.

- Сайн уу, Харри!

Энэ бол Чжоу Чанг байсан бөгөөд хамгийн ер бусын нь гэвэл ганцаараа явж байлаа. Ийм явдал ховорхон тохиолддог юм. Чжоу үргэлж инээлдсэн охидоор хүрээлүүлэн явдаг бөгөөд Харри түүнийг бүжигт үдэшлэгт урихад хэр хэцүү байсныг саналаа.

- Сайн уу гэж Харри хэлээд царай нь улайхыг мэдрэв. «Эцсийн эцэст одоо өмхий шингэнд будуулаагүй байна» гэж тэр өөртөө хэлэв. Чжоу бас тиймэрхүү юм бодсон бололтой.

- Чамайг шингэнээсээ салсаныг харж байна.

- Аан тийм л дээ гэж Харри хэлээд сүүлчийн уулзалт нь инээдтэй болсныг санан инээмсэглэхийг хичээв.

- Чи ... зуныг сайхан өнгөрүүлэв үү?

Тэр ингэж хэлмэгцээ харамслаа. Чжоу Седрикийн найз охин болохоор түүний үхэл Харригийн адил амралтанд нь муугаар нөлөөлсөн байж таарна. Түүний царай чангарснаа,

- Тиймээ чи мэдэж байгаа биз дээ, тийм ч муугүй гэв.
- Энэ «Хар салхи»-ны тэмдэг үү? Чи тэднийг дэмждэг юм уу? гэж Рон гэнэтхэн асуугаад Чжуогийн жанчны энгэр дээр байсан цэнхэр дэвсгэр дээрх хоёр алтан «Х» үсэгтэй тэмдэг рүү заалаа.
- Тиймээ, дэмждэг гэж Чжоу хариулав.
- Чи үргэлж түүнийг дэмждэг байсан уу? Эсвэл аваргуудын тэмцээнд яласан цагаас нь дэмжиж эхэлсэн үү? гэж Рон Харрийн бодлоор бол хэт прокурорын төрхтэй асуулаа.
- Би түүнийг зургаан настайгаасаа хойш дэмжиж байгаа. За баяртай, Харри гэж Чжоу хүйтнээр хэлэв.

Тэр явчихлаа. Гермiona Чжоуг цаашаа явахыг хүлээгээд Рон руу эргэв.

- Чиний зүгээс бүдүүлэг явдал боллоо доо!
- Яагаад? Би зөвхөн асуусан биз дээ ...
- Тэр чамтай биш Харритай ярихыг хүссэн нь ойлгомжтой биш байна гэж үү?
- Тэгээд? Би ярихад саад болоогүй биз дээ?
- Чи яагаад түүн рүү квиддичийн багийн тухай дайраад байсан юм бэ?
- Дайрсан гэнээ? Би дайраагүй зөвхөн ...
- Түүний «Хар салхи»-ийг дэмждэг эсэх нь хэнд хамаатай юм бэ?
- Өө, алив л дээ чи энэ тэмдгийг өнгөрсөн улиралаас хүмүүсийн хагас нь зүүж эхэлснийг хараагүй гэж үү ...
- Тэгээд юу гэж?
- Энэ бол түүнийг жинхэнэ хөгжөөн дэмжигч биш зөвхөн сонирхогч гэдгийг харуулж байгаа юм ...
- Хичээлдээ орцгооё гэж Харри хэлээгүй бол Рон, Гермiona хоёр хонх дуугарахыг сонсохооргүй чанга маргалдаж байлаа.

Тэдний маргаан Снеггийн газар дорхи хонгил хүртэл үргэлжилсэн учир Харри ихэнхи цагаа Невилл болон Рон шиг дагалдагчидтай өнгөрүүлж байхад Чжоутай хоёр хормын ч яриа өрнүүлж болохгүй нь гэж бодлоо.

Ингэж бодсоор Снеггийн ангийн гадаа үүссэн дараалалын өмнө очиж зогсохдоо тэр түүнтэй ярихыг хүссэн эсэхэд гайхав. Тэр Седрикийн найз охин болохоор Харриг Гурван шидтэний тэмцээнээс Седрикийн үхлийн дараа амьд үлдсэнд үзэн ядаж байж болох биш үү. Гэхдээ үгүй бололтой тэр түүнтэй галзуу юм уу худалч хүн шиг биш нөхөрсөг ярилаа. Тэр өөрөө түүнтэй ярихаар ирсэн явдал хоёр дахь удаагаа тохиолдлоо. Энэ бодол Харрийн сэтгэл санааг дээрдүүлэв. Тэр ч байтугай Снеггийн өрөө лүү орох хаалганы чакраан хүртэл цээжнийх нь гүн дэх найдлагыг бусниулж чадсангүй. Тэр Рон, Гермiona хоёрыг дагалдан ердийнхөөрөө дассан газар болох арын ширээнд суухдаа тэдний хоорондох уурссан дуу алдалтыг анхаарсангүй.

- Тайвширцгаа гэж Снегг хүйтнээр хэлээд хаалга хаалаа.

Энэ бол илүүц тушаал байсан бөгөөд хаалга хаагдмагц өршөөлгүй нам гүм нөмрөн авлаа. Снеггийг байхад ангид үргэлж хангалттай нам гүм байдаг юм.

- Өнөөдрийн хичээлийг эхлэхийн өмнө гэж Снегг хэлээд ширээ рүүгээ яван анги руу харж,

- Би та нарыг зургаан сард маш чухал шалгалт өгөх бөгөөд шидэт уусмалын найрлага бэлтгэхэд суралцах ёстой гэж бодож байна. Хэдийгээр та нарын дунд усан тэнэг амьтан байгаа нь эргэлзээгүй «хангалттай» гэдэг дүн авахын төлөө хөдөлмөрлөнө гэж найдаж байна. Тийм тохиолдолд цаашид миний шаардлагыг хангахгүйд хүрэх юм.

Түүний харц энэ агшинд Невилл дээр зогсоход шүлсээ залгив.

- Тавдугаар дамжааны төгсгөлд та нарын олонхи чинь над дээр суралцахаа болино. Төгсөлтийн шалгалтанд бэлтгэх хөтөлбөр дээр би зөвхөн хамгийн шилдэг уусмалын ангийг бүрдүүлэх бөгөөд бусадтай нь салах ёс гүйцэтгэх болно.

Тэр Харри руу харахад ам нь мурийлаа. Харри түүн рүү нүд рүү хараад тавдугаар дамжааны төгсгөлд уусмалын хичээл төгсгөл болох байх гэсэн баргар сэтгэгдэл төржээ.

- Гэхдээ баяртай гэж хэлэх хүртэл ахин нэг жил байна. Ийм учраас та нарыг бүх хүчээ гарган шалгалтан дээр өндөр оноо авахыг хичээхийг зөвлөө.

- Өнөөдөр бид тавдугаар дамжааны С.И.Ш-ийн шалгалтанд ирдэг уусмал бэлтгэхэд суралцана. Энэ бол Тайвшируулдаг уусмал бөгөөд сэтгэл хямралыг намжаахад тусалдаг юм. Гэвч анхааруулахад уусмалын орцыг буруу найруулвал

эсрэгээрээ үйлчилэн гүн нойронд автуулдаг учраас маш анхааралтай байх шаардлагатай (Харрийн зүүн талд сууж байсан Гермiona суудал дээрээ цэхрэн царай нь анхааралтай төвлөрлөө).

- Уусмал бэлтгэх найрлага гээд Снегт саваагаа даллав. (самбар дээр бичээстэй байлаа). Та нарт хэрэгтэй зүйл шүүгээнд байгаа гээд тэр ахин даллав (шүүгээний хаалга чахран нээгдлээ). Та нарын мэдэлд хагас цаг байна ... Эхэлцгээ.

Харри, Рон, Гермiona нар Снегт хэцүү найрлага бүхий уусмал өгч гэдгийг тааварлажээ. Уусмалын орц яг нарийн тоо хэмжээтэй бөгөөд шингэнийг нар зөв хэдэн удаа болон нар буруу хэдэн удаа хутгах тоо болон галаа тааруулсны эцэст орцоо нэмэх ёстой байлаа.

- Та нарын уусмал одоо мөнгөлөг уур гаргаж байх ёстой гэж Снегт арван минут үлдэхэд хэлэв.

Харри хөлөрч ийш тийшээ цөхрөн харлаа. Түүний тогооноос өтгөн хар саарал утаа суунаглаж байсан бөгөөд Ронхоос ногоовтор оч цацарч байв. Симус сэтгэл хөдөлсөн байртай савааныхаа үзүүрийг тогооны ёроолын галд хүргэн засна. Харин Гермionaгийнх мөнгөлөг уур гаргаж байсан ч Снегт дэргэдүүр нь түргэн өнгөрөхдөө юу ч хэлсэнгүйн дээр унжуу хамраа ч эргүүлж харсангүй. Харрийн тогооны дэргэд Снегт зогсоод хорон инээмсэглэв.

- Поттер, энэ таныхаар бол юу вэ?

Эхний эгээнд сууж байсан Слизеринийхэн сэтгэл ханамжтай толгойгоо эргүүлэв. Тэдэнд Снеггийн Харриг тохуурхдаг нь ихэд таалагддаг юм.

- Тайвшируулдаг уусмал гэж Харри хүчлэн хэлэв.

- Надад хэлээч, Поттер. Та уншиж чаддаг уу? Драко Малфой инээмсэглэв.

- Чадна гэж Харри хэлээд шидэт саваагаа чанга атгалаа.

- Тэгвэл гурав дахь мөрийг нь надад уншаад өг дөө, Поттер.

Харри самбар руу харлаа. Янз бүрийн өнгөтэй савсаж буй уурны дор зааврыг олж харахад амаргүй байв.

- Нунтагласан сарны чулууг цагийн зүүний эсрэг гурван удаа эргүүлэн зөөлөн гал дээр долон минут чанаад агширганын хоёр дусал шүүс нэмнэ.

Түүний зүрх палхийлээ. Тэр агширганын шүүс нэмээгүй юм байна шүү дээ. Зөвхөн

дөрөв дэхь мөрний дагуу долоон минут чанасан.

- Та гурав дугаар мөрөнд бичигдсэн бүх зүйлийг хийсэн үү, Поттер?
- Үгүй гэж Харри аяархан хэлэв.
- Уучлаарай би сонссонгүй.
- Үгүй. Би агширганыг мартсан байна гэж Харри чанга хэллээ.
- Би таныг мартсаныг мэдэж байна. Поттер энэ бол таны ажил ямар ч үр дүнгүй болсныг хэлж байна. Эванеско!

Харрийн бэлтгэсэн уусмал алга болж яг л тэнэг амьтан шиг хоосон тогооны дэргэд зогсож байлаа.

- Та нарын зааврын дагуу уусмалаа бэлтгэсэн бол шилэн саванд хийгээд нэр овгоо бичин миний ширээн дээр шалгуулахаар тавиарай. Гэрийн даалгаварт арван хоёр инч цаасан дээр сарны чулууны тухай болон уусмалд яаж хэрэглэх тухай бичээрэй. Пүрэв гаригт хураалгана шүү.

Бүгд шилэн саваа дүүргэхэд Харри юм хумаа цэгцлэв. Түүний уусмал Ронх шиг ялзарсан өндөгний үнэртэй болоогүй, Невиллийнх шиг өтгөн цемент шиг болоогүй ч Харри хийсэн ажилдаа тэг оноо авлаа. Тэр шидэт саваагаа цүнхэндээ буцааж хийгээд суудалдаа суун бусад хүмүүс уусмалаа Снеггэд өгөхийг харлаа. Хонх дуугарахад Харри хамгийн түрүүнд гарч яван Их танхимд хоолоо идэж байхад нь Рон, Гермiona хоёр ирлээ. Танхимын адар уйтгартай саарал өнгөөр хөшиглөнө. Цонхны цаана бороо орж байв.

- Энэ ч үнэхээр аймшигтай шударга бус хэрэг боллоо. Чиний уусмал Гойлынхоос хамаагүй дээр байсан. Тэр уусмалаа шилэн саванд хийх үед хага үсрээд жанч нь шатчихсан шүү гэж Гермiona тайвшируулахыг хичээн хэлээд дэргэд нь сууж хоолоо авлаа.

- Анхны удаагаа биш дээ. Снегг хэзээ нэг цагт надад шударга байсан үе байна уу? гэж Харри таваг руугаа харсан хэвээр хэлэв.

Асуулт хариултгүй үлдсэн ч гурвуулаа Харрийн анх удаа Хогвартсад элссэн цагаас хойш Снеггийн таагүй дайсагнасан харьцааны тухай мэдэж байв.

- Харин би энэ жил түүнийг дээрдэх байх гэж итгэлтэй байсан. Яагаад гэвэл ...

та нар ойлгож байгаа биз дээ гээд тэр эргэн тойрноо болгоомжтой харахад хажуугийн суудлууд нь хоосон байсан бөгөөд дэргэдүүр нь хэн ч өнгөрсөнгүй.

- Одоо тэр бүлэгт байгаа болохоор ...

- Ямар ялгаа байна хортой мөөг өөрчлөгддөггүй юм. Би үргэлж Дамблдорыг Снеггэд итгэдэгт гайхдаг. Гэхдээ түүнийг Хэцүү нэртэд үнэхээр ажиллахаа больсон гэх баталгаа хаа байна? гэж Рон хэлэв.

- Би Дамблдорт баталгаа хангалттай байгаа гэж бодож байна, Рон. Тэр заавал чамд хэлэх албагүй гэж Гермiona тасхийв.

- Та хоёр амаа хамхи гэж Харри Роныг маргахаар амаа нээхэд нь ядрангуй хэллээ. Гермiona, Рон хоёр уурсаж гомдсон царай гаргав.

- Намайг амар байлгаж болохгүй байна уу? Та нар үргэлж маргалдсаар байгаад намайг галзууруулах нь байна гээд хоолоо орхин цүнхээ мөрөндөө үүрэн бослоо.

Тэр гантиг шатаар дээшээ өгсөн хоёр гишгүүр ахиад байтал урдаас нь үдийн хоолондоо яарсан сурагчид бууж ирлээ. Уур хилэн гэнэт дүрсхийхэд Рон, Гермiona хоёрын гомдсон царай нүдний өмнө үзэгдэн сэтгэл нь хангалуун боллоо. Тэд яагаад түүнд амрах боломж өгөхгүй байгаа юм бол... цаг үргэлж л муудалцаж байх юм ... энэ хангалттай.

Тэр шатны талбай дээрх ноён Кэдоганы том хөргийн дэргэдүүр өнгөрлөө. Ноён Кэдоган сэлмээ ууртай гозолзуулан,

- Буцаад ир, өөдгүй нохой минь! Миний өмнө зогсоод тулалд! гэж дуулганыхаа цаанаас орилоод Харриг дэргэдүүр нь өнгөрөхөд дагахыг хичээн зэргэлдээх зураг руу үсрэн ороход зэрлэг нохой дургүйцэн хөөж гаргав.

Харри үдийн хоолны үлдсэн цагийг ганцаараа Умард цамхагын тагтай үүдний доор өнгөрүүлэв. Хонх дуугарсны дараа тэр ганцаараа мөнгөлөг шатаар Сивилла Трелонигийн анги руу орсонд гайхах явдалгүй байлаа.

Түүний дургүй хичээлийн тоонд уусмалын хичээлийн дараа мэргэ төлгийн хичээл ордог бөгөөд Харрид бүхнээс бага таалагддаг гол шатгаан гэвэл профессор Трелони хэд хэдэн хичээл дээр Харриг үхнэ гэж зөгнөн хэлсэн явдал юм. Тэр маш туранхай бөгөөд мөрөн дээгүүрээ алчуур унжуулан тоо тоомшгүй бөгж бугуйвч зүүж том нүднийхээ шилний цаанаас нүд нь хэд дахин томорч харагддаг нь Харрид үргэлж

ямар нэг шавжийг санагдуулдаг байлаа. Тэр дугуй ширээнүүд дээр элэгдсэн арьсан хавтастай ном тараан тавьж байв. Дэнлүүний гэрэл асан хана зуухны галаас дотор мансуурам үнэр ханхлана. Сүүлчийн таван хоромд үлдсэн сурагчид орж ирэв. Рон тагтай нүхээр орж ирээд анхааралтай ширтэн Харри олж хараад дөхөн ирлээ.

- Гермiona бид хоёр маргаанаа дуусгасан гэж Рон дэргэд нь суухдаа мэдэгдэв.
- Баяр хүргэе гэж Харри бувтналаа.
- Гэхдээ Гермiona хэрвээ чи бидэнд уураа гаргахаа боливол их эелдэг хэрэг гэж бодож байна.
- Би юу? ...
- Би зөвхөн чамд үг дамжуулж байна. Гэхдээ би түүний зөв гэж бодож байна.

Хэрвээ Симус, Снегг хоёр чамайг гомдоосон бол бидний буруу энд байхгүй.

- Би хэзээ ч тэгж хэлээгүй.
- Сайн байна уу гэж профессор Трелолони бүүдгэр хоолойгоор хэлэхэд Харри ахин уурсахаа мэдэрч үл ялиг ичлээ.
- Мэргэ төлгийн хичээлд тавтай морилоорой. Амралтын турш би та нарын хувь заяаны талаар анхааралтай судалж Хогвартст аюулгүй ирэхийг чинь урьдаас мэдсэн юм.
- Ширээ болгон дээр Иниго Имагогын «Зүүдний мэргэ» гэсэн ном байгаа. Зүүдний тайлал бол ирээдүйг харах чухал аргын тоонд ордог бөгөөд та нарын шалгалтанд ирэх юм. Мэдээж би шалгалтанд унах явдал гарахгүй гэдэгт итгэж байна. Хэнд дотоод мэлмий байгааг нь үнэлэн зэрэглэлийн гэрчилгээ олгоно. Хэдийгээр захирал та нарыг шалгалтандаа ...

Тэр хоолойгоо улам зөөлөн болгоход бүгдэд профессор Трелони шалгалт шиг чухал зүйлийн тухай ярьж байгаа нь ойлгомжтой болов.

- Номоо нээж зүүдний тайлалын тухай уншицгаа. Дараа нь хос болон хуваагдаж бие биенийхээ зүүдийг тайлан ярилцаарай. Эхэлцгээ.

Энэ хичээлийн цаг хоёр цаг биш ганц байсан нь сайн хэрэг боллоо. Тэд номоо уншиж дуусаад бараг арван хормын турш зүүдээ тайлан ярилцав. Харри, Рон хоёрын зэргэлдээх ширээн дээр Дин, Невилл хоёр байсан бөгөөд Невилл даруй хар дарсан зүүдэнд эмээгийнх нь малгайг аварга том хайч хайчилж байсан тухай бичлээ. Харин

Харри, Рон хоёр бие биенээ баргар царайлан харцгаав.

- Би зүүдээ хэзээ ч санаж байгаагүй. Тэгэхээр чи хэл гэж Рон хэлэв.

- Аль нэгийг нь санах ёстой биз дээ гэж Харри уурсан хэллээ.

Тэр хэнд ч өөрийнхөө зүүдэнд хардаг зүйлийг хэлмээргүй байв. Түүний хар дарсан зүүдэнд ердийнхөөрөө оршуулгын газар байдаг бөгөөд Ронд болон профессор Трелонид хэлж тэнэг зүүдний тайлал хэлэхийг нь сонсмооргүй байв.

- Өнгөрсөн шөнө би квиддич тоглосон гэж зүүдэлсэн санагдаж байна.

Чинийхээр бол энэ гэсэн юу вэ? гэж Рон хэлээд духаа үрчийлгэн санахыг хичээлээ.

- Магадгүй чи эмийн ургамал идсэн байх гэж Харри хэлээд «Зүүдний мэргэ» номын хуудсыг ямар ч сонирхолгүй эргүүлэв. Энэ бол маш уйтгартай ажил байсан бөгөөд профессор Трелони тэдэнд сарын хугацаанд зүүдний тэмдэглэл хөтлөх даалгавар өгөхөд ч сэргэсэнгүй. Хонх дуугарахад Харри, Рон хоёр түрүүлж доошоо буув.

- Бидэнд хичнээн их даалгавар өгснийг чи ойлгож байна уу? Бинс аварга биетүүдийн дайны тухай зохион бичлэг бичих даалгавар өгч, Снегт сарны чулуу шинжихийг хүссэн, харин одоо Трелони сарын зүүдний тэмдэглэл хөтлөхийг хүсч байдаг! Фред, Жорж хоёр С.И.Ш-ийн тухай үнэн хэлсэн байна. Хэрвээ одоо энэ Амбриж бас өөр зүйл өгвөл ... гэж Рон чангаар үглэв.

Тэднийг хар урлагаас хамгаалах хичээлийн танхимд орох үед профессор Амбриж багшийн ширээнд сууж байла. Тэр өчигдөр үдшийн адил хөвсгөр ягаан цамц өмссөн бөгөөд орой дээрээ хар хилэн тууз зүүжээ. Харрид ахиад л ялаа барих гэж байгаа том бах шиг санагдав.

Профессор Амбриж сахилга журам хэр баримталдгыг хэн ч мэдсэнгүй болохоор ангид бүгд чимээгүй байхыг хичээж байв ...

- Сайн байна уу! гэж тэр сурагчдыг байрандаа суумагц хэллээ. Хэдэн сурагч хариу мэндлэв.

- Хүлээгээрэй хүлээгээрэй. Үгүй дээ, найзууд минь энэ бүтэхгүй. Би та нарыг «Сайн байна уу, профессор Амбриж» гэж хариулахыг хүсэж байна. Ахин нэг удаа давтаад үзье. Сайн байна уу, сурагчдаа!

- Сайн байна уу, профессор Амбриж! гэж ангиараа хэллээ.

- Маш сайн байна. Тийм ч хэцүү биш байгаа биз дээ? Шидэт саваагаа хурааж үзгээ гаргана уу гэж профессор Амбриж хэлэв.

Энэ үгийг сонсоод олон хүүхдүүд таагүй харц солилцов. Энэ сонирхолтой хичээл нэг ч удаа шидэт саваагаа хураах тушаалаар эхэлж байсангүй. Харри цүнхнээсээ үзэг, бэх, цаас гаргалаа. Харин профессор Амбриж эсрэгээрээ цүнхнээсээ шидэт саваагаа гаргаж ирээд самбар дээр тогшиход үг бичигдлээ.

Хар урлагаас хамгаалах хичээл

Үндсэн зарчимдаа буцаж ирлээ

- Танай өмнөх багш нар сэдвийг хангалттай өөрчлөн бусниулсан. Тийм биз дээ? гэж профессор Амбриж хэлээд анги руу нүүрээ харуулан,

- Багш нар байнга солигдож байсан ч хэн нь ч ид шидийн яамнаас дэмжин сайшаасан хөтөлбөрийг даган мөрдөж байсангүй. Харамсалтай үр дүнд нь гэвэл би та нараас С.И.Ш-ийн шалгалтыг жишгийн дагуу авах болно гэв.

- Та нар энэ бүх асуудал одоо цэгцэрсэн гэдгийг мэдэх ёстой. Энэ хичээлийн жилд бид хамгаалах хичээлийн ид шидийн яамнаас дэмжсэн хөтөлбөрийн онолыг анхааралтай үзэцгээх болно. Бичицгээ.

Тэр ахиад л самбар дээр тогшиход эхний бичсэн үг арилж оронд нь,

ДАМЖААНЫ ЗОРИЛТ

1. Хамгаалах хичээлийн үндэс суурь бол зарчим гэдгийг ойлгох явдал
2. Хамгаалах шидийг хууль зүйн дагуу хэрэглэх нөхцлийг ойлгож сурах
3. Хамгаалах хичээлийн ерөнхий агуулгад дадлагын хичээл багтана

Хоёр хормын турш ангид зөвхөн цаасан дээр үзэг чахрах чимээ гарч байлаа. Бүгд профессор Амбрижийн дамжааны зорилтыг бичиж авсны дараа тэр,

- Ингэхэд бүгдэд Уилберт Слинкхардын «Ид шидийн хамгаалах онол» гэдэг ном байгаа биз дээ? гэв.

Сурагчид амандаа дүнгэнэлдэв.

- Надад ахин нэг удаа оролдож үзэх хэрэгтэй юм шиг санагдаж байна. Намайг асуулт тавих үед ийм маягаар хариулах хэрэгтэй. «Тиймээ, профессор Амбриж» эсвэл «Үгүй ээ, профессор Амбриж». Тэгэхээр бүгдэд Уилберт Слинкхардын «Ид

шидийн хамгаалах онол» гэдэг ном байна уу?

- Тиймээ, профессор Амбриж гэж сурагчид зэрэг хариулав.

- Сайн байна. Одоо та нарыг тавдугаар хуудасны «Нэгдүгээр бүлэг. Эхлэн сурахын үндэс» гарчгийг нээхийг хүсэж байна. Ярих шаардлагагүй.

Профессор Амбриж самбараас холдон ширээндээ суугаад ангийг бөлцгөр бахын нүдээрээ ширтэв. Харри тавдугаар хуудсыг нээгээд уншиж эхлэв.

Энэ бол профессор Бинсийг сонсохоос ч уйтгартай ажил байлаа. Харри төвлөрөхийг оролдсон ч юу ч бүтсэнгүй. Тэр даруйхан нэг өгүүлбэр уншсан ч цаашаа үргэлжлүүлж чадсангүй. Иймэрхүү байдалтайгаар хэдэн хором өнгөрлөө. Түүний дэргэд сууж байсан Рон гартаа үзгээ эргэлдүүлэн хуудасны нэг цэг рүү харна. Харри баруун тийш хараад ихэд гайхлаа. Гермiona номоо ч нээгээгүй байв. Тэр профессор Амбриж руу харан гараа өргөж байв.

Харри Гермionaгийн сурах бичиг уншихгүй орхиж байсан удааг санасангүй. Тэр асуунгүй байртай харахад хариуд нь ердөө толгой дохиод өөр тийш ширтэж буй профессор Амбриж руу харсан хэвээр байлаа.

Хэдэн хормын дараа Харри ганцаараа Гермiona руу ширтэж байгаа хүн биш болов. Бүгд эхлэн суралцагчын залхуутай үндсээ орхиод Гермionaгийн профессор Амбрижийн анхаарлыг өөртөө татах оролдлогыг чимээгүйхэн харцгаалаа.

Ангийн тал хэсэг ном руугаа биш Гермiona луу харсан хойно профессор Амбриж юу ч болоогүй юм шиг дүр үзүүлэхээ блоихоор шийдэв бололтой.

- Чи бүлгийн талаар асууж лавлахыг хүсээ юу хонгор минь? гэж тэр Гермionaд дөнгөж сая анзаарч буй мэт хэлэв.

- Бүлгийн тухай асуулт биш гэж Гермiona хэлэв.

- Тэгэхээр одоо бид уншиж байгааг харж байгаа биз дээ. Чамд өөр асуулт байгаа бол хичээлийн төгсгөлд бол гэж профессор Амбриж шүдээ зуун хэлэв.

- Би дамжааны зорилтын талаар асуух гэсэн юм. Профессор Амбриж хөмсгөө өргөлөө.

- Таны нэр?

- Гермiona Грэйнджер.

- Хатагтай Грэйнджер би анхааралтай унш гэж маш тодорхой хэлсэн шиг

санагдах юм гэж профессор Амбриж эелдэг байдлаа хадгалахыг хичээсэн хоолойгоор хэлэв.

- Надад тэд ойлгомжгүй байна. Тэнд хамгаалахад шившлэгийг яаж ашиглах тухай бичээгүй байна гэж Гермiona татгалзав.

Богинохон нэг агшины дараа олонхи сурагчид духаа үрчийлгэн самбар луу харлаа.

- Хамгаалахад шившлэг ашиглах гэнээ? Би энэ ангид болж байгаа үл явдлаас харахад танд хамгаалах шившлэг шаардагдана бодохгүй байна. Эсвэл та хичээл дээр хэн нэгэн дайрна гэж бодоод байгаа юм уу? гэж профессор Амбриж инээд алдан асуулаа.

- Бид шившлэг ашиглах тухай судлахгүй юм уу? гэж Рон чанга асуулаа.

- Миний хичээл дээр юм хэлэхийг хэлэхийг хүсвэл гараа өргө, ноён ...

- Уизли гэж Рон хэлээд гараа өргөлөө.

Профессор Амбриж инээмсэглэсэн хэвээр цаашаа эргэв. Харри, Гермiona хоёр яаран гараа өргөлөө. Агшины дараа профессор Амбрижийн нүд Харри дээр туссан ч Гермionaгаас асуулаа.

- За, хатагтай Грэйнджер. Та ямар нэг юм асуухыг хүсээ юу?

- Тиймээ. Хар урлагаас хамгаалах хичээлд шившлэггүйгээр дадлага хийж болно гэж үү?

- Хатагтай Грэйнджер та ийм асуулт тавих ид шидийн яамны боловсролын мэргэжилтэн үү? гэж профессор Амбриж хуурамч нялуун хоолойгоор асуув.

- Гэхдээ ...

- Тэгвэл би таныг миний хичээлийг шүүн хэлэлцэх хүн биш гэж айж байна.

Шинэ хичээлийн хөтөлбөрийг та нараас ахмад ухаалаг шидтэнгүүд зохиосон. Та нар хамгаалах хичээлийг аюулгүй эрсдэлгүй замаар суралцах ...

- Юу ашиглах юм? Хэрвээ биднийг дайрвал тийм аргаар хамгаалж болно гэж үү ...

- Гараа өргө, ноён Поттер! гэж профессор Амбриж хэлэв.

Харри гараа өргөлөө. Ингээд ахиад л профессор Амбриж цаашаа эргэсэн ч өөр хэдэн хүүхдүүд нэмж өргөлөө.

- Таны нэр? гэж профессор Амбриж Динд хэлэв.
- Дин Томас.
- Тэгээд ноён Томас?
- Би Харриг зөвшөөрч байна. Хэрвээ биднийг дайрвал эрсдэлгүй хамгаалах боломжгүй.
- Би давтаж хэлье. Та нар миний хичээл дээр дайралтыг хүлээгээ юу? гэж профессор Амбриж уурсан төрхтэйгээр Дин рүү тэвчээр алдан инээмсэглэв.
- Үгүй, гэхдээ.

Профессор Амбриж түүний яриаг тасалж,

- Би энэ сургуулийг шүүмжлэхийг хүсэхгүй байна гэж нүүр дүүрэн хүчлэн инээмсэглэн хэлээд,
- Гэхдээ итгэхэд бэрх хэдий ч энэ ангид маш хариуцлагагүй шидтэнгүүд хичээл зааж байсан гэдгийг хэлэх байна. Хариуцлагагүйн дээр маш аюултай хагас цустангууд.
- Хэрвээ та профессор Люпины тухай ярьж байгаа бол хамгийн шилдэг нь байсан ... гэж Дин уурсан хэлэв.
- Гараа өргө, ноён Томас! Үргэлжлүүлэхийг зөвшөөрнө үү. Та нар насандаа ахадсан хэцүү хүнд шившлэгүүдтэй тулж танилцсанаар үхлийн аюулд хүрч болно. Ингэхэд та нар өдөр болгон хар хүч дайрна гэж айдаг хэрэг үү ...
- Ерөөсөө ч тийм биш. Бид ердөө ... гэж Гермiona дуугарлаа.
- Таны гар өргөгдөөгүй байна, хатагтай Грэйнджер! Гермiona гараа өргөсөн хэдий ч профессор Амбриж цааш эргэв.
- Миний ойлгож байгаагаар өмнөх солигдсон хүн маань та нарт хууль бус шившлэг зааж байсан юм байна.
- Та түүнийг галзуу байсан гэх нь үү? Гэхдээ тэр бидэнд олон зүйлийг заасан гэж Дин хэлэв.
- Таны гар өргөгдөөгүй байна, ноён Томас! Одоо ид шидийн яамны бодлоор бол шалгалтан дээр оноо авахад онолын хичээлийн хангалттай мэдлэгтэй байхад болно. Таны нэр? гээд тэр Парвати руу харж асуулаа.

- Парвати Патил. Хар урлагаас хамгаалах хичээл дээр дадлагын хичээл хийхгүйгээр С.И.Ш өгөх юм уу? Бид ямар нэгэн хараалын эсрэг зүйл үзүүлэхгүй юм уу?

- Та нар онолын хангалттай мэдлэгтэй байхад ямар ч таагүй явдал тохиолдохгүй. Шалгалт бүрэн хяналтан дор явагдах учир зарим нэг шившлэг үзүүлэх юм гэж профессор Амбриж зэвүүцэнгүй хэлэв.

- Ямар ч бэлтгэл хийхгүйгээр үү? Та бидэнд анх шалгалтан дээр ирнэ гэж хэлээгүй биз дээ?

- Давтан хэлье. Та нар онолын мэдлэг хангалттай сурсан байхад ...

- Энэ онол чинь бодит ертөнцөд ямар хэрэгтэй юм бэ? гэж Харри агаарт гараа өргөн чанга асуулаа.

Профессор Амбриж түүн рүү харав.

- Энэ бол сургууль ноён Поттер бодит ертөнц биш.

- Бид сургуулийн гадаа хүлээж байгаа зүйлд бэлтгэгдэж байгаа биш юм уу?

- Ямар ч аймшигтай зүйл таныг тэнд хүлээгээгүй, ноён Поттер.

- Тийм гэж үү? гээд түүний уур хилэн оргилон буцлав.

- Хэн та нар шиг хүүхдийг дайрах юм бэ? гэж профессор Амбриж жигшүүртэй нялуун хоолойгоор хэллээ.

- Хмм, бодоод үзье. Магадгүй ... лорд Волдеморт байж болох юм биш үү? гэж

Харри хэллээ.

Роны амьсгаа давхцан, Лаванда Браун дуу алдаж, Невилл сандлаасаа гулган унасан бол харин профессор Амбриж хөмсгөө ч хөдөлгөсөнгүй. Тэр Харри руу таагүй өнгөөр харна.

- Гриффиндороос арван оноо хаслаа, ноён Поттер.

Анги чимээгүй болж хөдөлгөөнгүй боллоо. Нэг хэсэг нь Амбриж руу харж байхад нөгөө хэсэг нь Поттер руу харж байв.

- Харин одоо надад үг хэлэх боломж олгоодох гээд профессор Амбриж босоод ширээн дээгүүрээ урагш алгаа хавсран бөхийлөө.

- Чи үхсэн хар шидтэн эргэн ирсэн гэж хэлэх гээ юу ...

- Тэр үхээгүй. Ахин ирсэн! гэж Харри ууртай хэлэв.
 - Ноён-Поттер-та-хэдийн-гэнхимээсээ-арван-оноо-алдчихаад-байна гэж профессор Амбриж нэг амьсгаагаар хэлээд,
 - Давтаж хэлье та хар шидтэн ахиад эргэн ирсэн гэж хэллээ. Энэ бол худал.
 - Үгүй ээ, энэ бол худал биш! Би түүнийг харж, би түүнтэй тэмцсэн! гэж Харри хашгирав.
 - Та шийтгэгдсэн ноён, Поттер! гэж Амбриж ялгуусан баяр хөөртэйгээр дуу алдаад,
 - Маргааш үдээс хойш хичээлийн дараа миний өрөөнд таван цагаас ирээрэй. Та нарт бүдэд ахин хэлье энэ бол худал. Ид шидийн яамнаас хар шидтэн та нарт аюул заналхийлэхгүй гэж баталгаа өгч байна. Хэрвээ та нар энэ тухай санаа зовсон хэвээр байгаа бол хичээлээс гадуур над дээр ирж болно. Хэрвээ хэн нэгийг хар шидтэн эргэн төрсөн тухай дэгс яриа түгшээгээд байгаа бол би сонсоход бэлэн байна. Би энд та нарт туслахын тулд ирсэн билээ. Би та нарын найз. Харин одоо үргэлжлүүлэн уншижцгаа. Тавдугаар хуудас гэв.
- Профессор Амбриж суудалдаа суулаа. Харри эсрэгээрээ бослоо. Бүгд түүн рүү харав. Сиумын царай айсан хөөрсөн өнгө холилдон харагдана.
- Харри, хэрэггүй! гэж Гермiona шивнээд Харрийн ханцуйнаас нь дугтарсан ч угз татан авлаа.
 - Таныхаар бол Седрик Диггори хэн ч алаагүй байхад өөрөө үхсэн юм биз дээ? гэж Харри чичирсэн хоолойгоор хэлэв.
- Бүгдээрээ чимээтэй амьсгал авлаа. Рон, Гермiona хоёроос өөр ангид байсан бусад хүмүүс Харри Седрикийн үхлийн тухай ярьж байхыг сонсоогүй билээ. Бүгд түүн рүү харахад профессор Амбрижийн царайнаас хуурамч инээмсэглэлийн мөр оргүй алга боллоо.
- Седрик Диггорийн үхэл эмгэнэлтэй золгүй явдал байсан юм гэж хүйтнээр хэлэв.
 - Энэ бол аллага байсан гээд Харрийн бие чичирлээ. Тэр ангид байсан хүн бүр түүнийг тэсч ядан сонсож байгааг мэдэв.
 - Түүнийг Волдеморт алсаныг та мэдэж байгаа.

Профессор Амбрижийн царайд юу ч илэрсэнгүй. Агшин зуур Харрид тэр хашгирах гэж байгаа юм шиг санагджээ. Гэвч тэр охины зөөлөн хоолойгоор,

- Наашаа хүрээд ир, ноён Поттер гэв.

Тэр сандлаа хөлөөрөө түлхээд Рон, Гермиона хоёрын дэргэдүүр өнгөрч багшийн ширээ рүү явлаа. Бүгд түүнийг амьсгал даран хүлээв. Тэр уур хилэндээ автсан тул яаж төгсөх нь ялгаагүй байлаа.

Профессор Амбриж цүнхнээсээ хуйлаастай жижигхэн ягаан цаас гарган ширээн дээр тавьж үзгээ бэхэнд дүрэн зурвас бичлээ. Бүгд чимээгүй болов. Хормын дараа тэр шидэт саваагаараа цаасыг хуйлаад битүүмжлэн онгойхооргүй болгов.

- Үүнийг профессор МакГонагаллд аваачиж өг гээд тэр цаасыг сунгав.

Харри цаасыг аваад нэг ч үг хэлэлгүй ангиас гарч хаалга хаахдаа Рон, Гермиона хоёр луу харсангүй. Тэр профессор МакГонагаллд өгөх цаасыг гартаа чанга атгаад хонгилоор түргэн явж булан эргэтэл том амтай хий үзэгдэл Пивз агаарт хөвөн бэхийн саваар жонглёр тоглож байв.

- Түй, энэ чинь солиотой жижигхэн Поттер байна шүү дээ! гэж Пивз инээгээд хоёр бэхийн савыг унагахад газар мөргөн хагарч хана бэхээр будав. Харри арайхийн зайлж амжив.

- Эндээс зайл, Пивз!

- Өө, манай солиот уурлаж байна гэж Пивз хэлээд Харрийн араас даган хонгилоор нисэж маасайн харлаа.

- Энэ удаад солиотой найз минь яасан бэ? Хоолой сонссон уу? Юм харсан уу?

Бас ...хэлээр ярьдаг гэж ярьцгааж байна гээд Пивз таагүй чимээ гаргав.

- Намайг тайван орхи гэж чамд хэлсэн шүү! гэж Харри орилоод ойролцоох шатаар доош уруудахад Пивз шатны хашлагаар гулгав.

- Солиотой жижигхэн хүү бүдүүлэг загнаж байх шив дээ. Харин Пивз сайхан сэтгэлийн үүднээс түүнийг галзуурсан гэж хэлсэн дээ.

- Амаа тат!

Харрийн зүүн талын хаалга нээгдэн профессор МакГонагалл түгшсэн байртай шагайлаа.

- Та яагаад энд орилоод байна, Поттер? Та яагаад хичээл дээр биш байна? гэж тэр ширүүн асуухад Пивз баясан инээсээр алга болов.

- Намайг тань руу илгээсэн.

- Илгээсэн гэнээ? Илгээсэн гэдгийг чинь юу гэж ойлгох вэ?

Тэр профессор Амбрижийн зурвасыг сунгав. Профессор МакГонагалл түүн рүү хөмсөг зангидан харснаа цаасыг аваад саваагаараа тэнийлгэн уншиж эхэллээ. Түүний нүд дөрвөлжин хүрээтэй шилнийхээ цаанаас мөр дагуу гүйх бүрдээ харц нь улам ширүүн боллоо.

- Ийшээ ороод ир, Поттер.

Тэр түүнийг ангид даган орлоо. Хаалга хаагдав.

- Тэгэхээр энэ үнэн үү? гэж профессор МакГонагалл хэлэв.

- Юу үнэн үү? Профессор оо? гэж тэр зэвүүцсэн өнгөө даран асуулаа.

- Та профессор Амбриж руу хашгирсан үнэн үү?

- Тийм гэж Харри хэлэв.

- Та түүнийг худалч гэж дуудсан уу?

- Тийм.

- Та түүнд Хэцүү нэрт ахин төрсөн гэж хэлсэн үү?

- Тийм.

Профессор МакГонагалл бичгийн ширээний ард суугаад хөмсөг зангидан Харри руу харснаа,

- Жигнэмэг ав, Поттер гэлээ.

- Юу авна гэнээ?

- Жигнэмэг гэж тэр уурсандавтаад шотландын зурагтай хайрцагтай жигнэмэгийг заалаа.

- Тэгээд суу.

Тэр эсрэг талын сандал дээр суугаад жигнэмэг авлаа. Профессор МакГонагалл зурвасыг ширээн дээр тавиад Харри руу ихэд нухацтайгаар ширтлээ.

- Поттер та болгоомжтой байх ёстой.

Харри жигнэмэгээ залгиад түүн рүү харлаа. Түүний хоолой ширүүн, догшин, ажил хэргийн ч биш аяархан түгшсэн янзтай байлаа.

- Долорес Амбрижийн хичээл дээр гаргасан буруу үйлдэл чинь таньд томоохон таагүй явдал учруулж тэнхимийн онооноос хасаад зогсохгүй хичээлийн дараа үлдэх шийтгэл оногдуулсан байна.

- Та юуны тухай яриад байна?

- Сайн бод, Поттер. Та түүний хаанаас ирснийг мэдэж байгаа гэж профессор зандарснаа агшин зуур ердийн төрхөндөө эргэн орлоо.

Завсарлагааны хонх дуугарлаа. Толгой дээр болон эргэн тойронд юм түжигнэж сурагчдын хөлийн чимээ сонсогдов.

- Энд таныг маргаашнаас эхлээд хичээлийн дараа өдөр болгон үлдэх ёстой гэсэн байна гээд профессор МакГонагалл Амбрижийн зурвас руу ахин харлаа.

- Энэ долоо хоногт өдөр бүр гэнээ! гэж Харри айдаст автан давтаад,

- Гэхдээ профессор та болиулж чадахгүй юу? гэв.

- Үгүй чадахгүй гэж профессор МакГонагалл хатуу татгалзав

- Гэхдээ ...

- Тэр таны багш болохоор шийтгэх бүрэн эрхтэй. Маргааш таван цагаас түүний өрөөнд байх ёстой. Ингээд санаж ав. Долорес Амбриж тоглоом муу ойлгодог юм шүү.

- Гэхдээ би үнэнийг л хэлсэн шүү дээ! Волдеморт ахин төрснийг та мэдэж байгаа. Профессор Дамблдор ч мэдэж байгаа гэж Харри уурсан дуу алдав.

- Бурханд баярлалаа, Поттер гэж профессор МакГонагалл хэлээд ууртайгаар шилээ заслаа (Тэр Волдемортын нэрийг хэлэхэд давхийн цочжээ).

- Хэргийн учир нь таны үнэн худал хэлсэн эсэхэд байгаа юм биш. Гол учир гэвэл та чимээгүй сууж биеэ барих хэрэгтэйд байгаа юм!

Тэр босож хамраа сарталзуулан уруулаа жимийхэд Харри ч бас бослоо.

- Ахиад жигнэмэг ав гэж тэр уурсан хэлээд хайрцагыг түлхэв.

- Үгүй ээ, баярлалаа гэж Харри хүйтнээр хэлэв.

- Тэнэг байх хэрэггүй гэж профессор МакГонагалл хашгирав. Тэр жигнэмэг

аваад,

- Баярлалаа гэж дургуйхэн дуугарав.

- Та Долорес Амбрижийн хичээлийн жилийн эхний цайллаган дээр хэлсэн үгийг дуулаагүй юу, Поттер?

- Сонссон. Ид шидийн яам Хогвартсын хэрэгт оролцохыг хүсч байгаа гэсэн утгатай юу.

Профессор МакГонагалл хэсэг зуур түүн рүү ширтсэнээ шуухитнан ширээнээс босож хаалга онгойлголоо.

- Би таныг Гермiona Грэйенжерийг сонссон явдалд баяртай байна гэж хэлээд өрөөнөөс гаргав.

БҮЛЭГ 13: ҮДЭШ ДОЛОРЕСИЙНД

Их танхимын оройн хоол Харрид тэр өдөр амтгүй санагдав. Түүний Амбриж руу хашгичсан явдал Хогвартсад ер бусын хурдтай таржээ. Тэр Рон, Гермиона хоёрын дунд суугаад хооллож байхад хаа сайгүй шивнэлт сонсогдож байв. Хөгжилтэй нь гэвэл шивнэлт түүнд сонсогдуулахыг хүссэн мэт чанга ярилцаж байлаа. Магадгүй тэд түүнийг ахин уурлаж хашгируулан түүхийн тухай хэлэхийг нь сонсохыг хүссэн байх.

- Тэр Седрик Диггорийг яаж алахыг харсан гэсэн ...
- Тэр Хэцүү нэртэй тулалдсан гэсэн ...
- Боль доо ...
- Тэр тоглож байсан юм болов уу?
- Би ерөөсөө ойлгохгүй байна. Тэд нар яагаад хоёр сарын өмнө Дамблдорыг энэ түүхийг ярихад итгэж байсан хэр нь ... гэж Харри шүд зуун хэлээд хэлээд хутга сэрээгээ тавилаа (түүний гар барьж чадахааргүй чичирч байв).
- Учир нь үүнд байгаа юм, Харри. Би тэднийг тэр үед итгэсэн гэдэгт итгэлтэй биш байна гэж Гермиона хэлэв.

Тэр хутга сэрээгээ доош нь тавиад ширээ тогшин Рон алимын бялуу идэж дуусгахыг гунигтай харлаа. Тэднийг Их танхимаас гарах үед бүгд ширтэж байв.

- Тэднийг Дамблдор итгэсэн гэдэгт чи яагаад итгэхгүй байгаа юм бэ? гэж Харри шатны ёроолд хүрээд Гермионагаас асуулаа.
- Чи тохиолдсон үйл явдлыг ойлгохгүй байх шиг байна. Чи эргэж ирэхдээ зүлгэн дээр Седрикийн биетэй хэвтэж байсан ... Төөрдөг байшинд юу болсныг бидний хэн ч хараагүй ... Дамблдор бидэнд зөвхөн Хэцүү нэрт ахин төрж Седрикийг алаад чамтай тулалдсан гэсэн.
- Гэхдээ энэ чинь үнэн шүү дээ! гэж Харри дуу алдав.
- Би мэднэ Харри. Ийм учраас над руу дайрахаа боль. Би бүгдээрээ амралтаараа гэр лүүгээ буцаад хоёр сарын турш чамайг солиотой, Дамблдор бол ухаан муутай хөгшин гэж уншицгаасан тухай хэлж байна!

Тэднийг хоосон хонгилоор Гриффиндорын цамхаг руу явах үед цонхны шилний

цаана бороо шаагина. Харрид сургуулийн анхны өдөр долоо хоног болон уртассан мэт санагдаж унтахаасаа өмнө уул шиг овоолсон гэрийн даалгавараа хийх хэрэгтэй байлаа. Тэднийг хонгилоор тарган хатагтайн хөрөг рүү эргэх үед Харри цонхоор харанхуй нуга руу харлаа. Хагридын овоохойн гэрэл унтраалттай байв.

- Мимбулус мимблетония гэж Гермона тарган хатагтайн асуултыг хүлээлгүй хэлэв. Хөрөг нээгдэхэд найзууд орлоо.

Хүүхдүүд хоолоо дуусгаж амжаагүй болохоор Гриффиндорын амралтын өрөө бараг хоосон байлаа. Живоглот түшлэгтэй сандал дээр цагариглан хэвтэж байснаа чанга хүржигнэж тэднийг угтан ирлээ. Андууд зуухны хажуугийн дуртай сандалдаа суухад муур Гермонагийн өвдгөн дээр үсэрч гараад үстэй шаргал дэр шиг цагариглан хэвтэв. Харри гал руу харан эцэж ядарснаа мэдрэв.

- Дамблдор энэ бүхнийг зөвшөөрч яаж чаддаг байна аа? гэж Гермона гэнэт хашгирахад Харри, Рон хоёр цочиж, Живоглот гомдсон байртай өвдөг дээрээс нь үсрэн буулаа. Тэр ууртайгаар сандлын түшлэгийг нүдэв.

- Тэр яаж энэ аймшигтай авгайд биднийг сургахыг зөвшөөрч чадав аа? Бас жилийн эцэст биднээс С.И.Ш авна гээд байгаа шүү!

- Гэхдээ хар урлагаас хамгаалах хичээлийн багш бидэнд байхгүй шүү дээ. Хагрид юу хэлснийг санаж байна уу? Хараал идсэн ажил болохоор хэн ч хийхийг хүсэхгүй гэсэн гэж Харри хэллээ.

- Шидэт саваа хэрэглэхийг хориглоно гэнээ! Дамблдор юу хийгээд байгаа юм бол? Ойлгох юм алга.

- Тэр тагнуул элсүүлэхийг хүсэж байгаа юм. Түүний үгийг санаж байна уу? Тэр Хэцүү нэртийг ахин төрсөн тухай ярьж байгаа хүмүүсийг ирж мэдэгдэхийг хүссэн гэж Рон хэлэв.

- Мэдээж тэр энд биднийг тагнахын тулд байгаа нь тодорхой. Ийм учраас л Фаж түүнийг ийш нь ирүүлсэн байх гэж Гермона ширүүн хэллээ.

- Зөвхөн ахин маргаж бүү эхлээрэй дээ гэж Харри Роныг хариу хэлэхээр ам нээхэд гуйгаад,

- Бүгдээрээ гэрийн даалгавараа хийцгээе гэлээ.

Тэд буланд хэвтэж байсан цүнхээ авч сандал дээрээ эргэж суулаа.

Гриффиндорынхон оройн хоолноос эргэн ирж эхлэв. Харри үүд рүү харахгүй хичээж байсан ч тэдний харцыг нь мэдэрч байлаа.

- Эхлээд Снеггийн хичээлийн учрыг олох уу? гэж Рон санал болгоод үзэг, бэхээ гаргангаа,

- Сарны чулуу түүнийг шинж чанар ... уусмал бэлтгэхэд ашиглах нь гэж бувтнаад цаасан дээгүүр мөр бичингээ,

- Тэгэхээр сарны чулууны мөн чанар болон уусмалд яаж хэрэглэх вэ? хэмээн гарчгийн доогуур зураас тавиад Гермiona руу найдангуй харлаа.

Гэвч Гермiona түүнийг сонссонгүй. Тэр амралтын өрөөний буланд Фред, Жорж, Ли Жордан нар гэмгүй төрхтэй нэгдүгээр дамжааныхнаар хүрээлүүлэн суугаад бүгд Фредийн гарт байгаа том цаасан хайрцагнаас юм авч зажлахыг харж байлаа.

- Үгүй ээ, тэд арай дэндэж байна. Явъя Рон гээд уурсан босч зогслоо.

- Юу? Хаашаа явах гэж? хэмээн Рон цаг хожихыг хичээн асуугаад,

- Үгүй ... Тэгэхгүй, Гермiona. Бид яаж тэдний амттанг хориглох юм бэ? гэв.

- Чи энэ бол амттан биш Хамраас цус гаргадаг самар гэдгийг мэдэж байгаа шүү дээ. Бас ...

- Ухаан алдуулдаг чихэр гэж Харри аяархан хэлэв.

Толгой руугаа үл үзэгдэх алхаар цохиулсан аятай нэгдүгээр дамжааныхан сандлаасаа гулган ухаан алдан унаж, зарим нь түшлэгнээсээ өлгөгдөв. Тэдэн рүү харсан бүх хүмүүс инээлдэхэд Гермiona ганцаараа мөрөө тэгшилээд шийдэмгий хүрч очлоо. Фред, Жорж хоёр тэмдэглэлийн дэвтэр гартаа бариад ухаан алдсан хүүхдүүдийг харж байв. Рон суудлаасаа өндийснөө Харрид хандан «тэр өөрөө чадна» гэж бувтнаад гээд буцаж суун доошоо шигдлээ.

- Арай багасгавал дээр! гэж Гермiona Фред, Жорж хоёрт чанга хэлэхэд тэд гайхан харцгаалаа.

- Тиймээ чиний зөв. Орц нь арай ихэдсэн бололтой гээд Жорж толгой дохив.

- Би та нарт өглөө сурагчид дээр тэнэг зүйлээ туршихаа бол гэж хэлээ биз дээ!

- Бид тэдэнд төлж байгаа гэж Фред ундууцан дуугарав.

- Энэ чухал биш. Та нар тэднийг аюулд оруулж байна!

- Тэнэг юм гэж Фред эсэргүүцлээ.
- Тайвшир, Гермiona тэдний бүх зүйл хэвийн! гэж Ли итгүүлэн хэлээд нэгдүгээр дамжааныханы аманд хүрэн улаан өнгийн чихэр хийлээ.
- Харж байна уу тэд хэвийн болж байна гэж Жорж хэлэв.

Хэд хэдэн нэгдүгээр дамжааныхан үнэхээр хөдлөв. Бусад нь шалан дээр хэвтэх юм уу түшлэгэн дээр цочирдсон янзтай өлгөгдөхөд Харри Фред, Жорж хоёр амттан яаж үйлчилдэг тухай анхааруулаагүй болохыг ойлгов.

- Бие чинь зүгээр үү? гэж Жорж хөлдөө хэвтэж байгаа жижигхэн хар үстэй охиноос асуулаа.

- Тиймээ гэж сулхан хоолойгоор хэлэв.
- Маш сайн байна гэж Фред баяртайгаар хэлэхэд Гермiona агшин зуур тэмдэглэлийн дэвтэр болон хайрцагтай амттанг нь булаан авлаа.

- Ямар ч сайн зүйл алга!
- Боль доо тэд амьд байгаа биз дээ гэж Фред уурсав.
- Ахиж үүнийгээ бүү хийгээрэй! Хэрвээ хэн нэгэн хүнд өвдвөл яана?
- Хэн ч өвдөхгүй. Бид аль хэдийн өөрсөд дээрээ туршаад үзчихсэн болохоор бүгдэд адил үйлчилж байгааг харж байгаа биз дээ.
- Хэрвээ та нар үүнийг болихгүй бол ...
- Хичээлийн дараа үлдээх үү? гэж Фред оролдож үзэхийг чинь харах юмсан гэсэн байртай дуугарлаа.
- Биднээр мөр бичүүлэх нь үү? хэмээн Жорж инээвхийлэв.

Амралтын өрөө даяар инээд хадав. Гермiona нүдээ зураас болгон онилгож өтгөн үс нь цахилгаанжан өрвийлөө.

- Үгүй. Би ээжид чинь захиа бичнэ гэж тэр уурсаж чичирсэн хоолойгоор хэлэв.
- Чи үүнийг хийж чадахгүй гэж Жорж айдаст автан хэлээд алхам ухарлаа.
- Бүр яаж хийнэ гээч. Хэрвээ та нар энэ тэнэг зүйлүүдээ өөрсдөө хүссэн юм бол хичнээн бол залгицгаа. Гэхдээ нэгдүгээр дамжааныханд өгөхийг бол би зөвшөөрөхгүй!

Фред, Жорж хоёр аянганд ниргүүлсэн мэт болов. Гермionaгийн сүрдүүлэг хүнд туссан нь тодорхой байлаа. Тэр сүүлчийн удаа сүрдүүлэн хараад Фредэд тэмдэглэлийн дэвтэр болон хайрцагыг нь эргүүлж өгөөд сандал руугаа эргэн ирэв. Рон гүнзгий доошоо шигдэн суусан болохоор хамар нь өвдөгтэйгээ зэрэгцэх шахам харагдана.

- Дэмжсэнд баярлалаа, Рон гэж Гермiona ёжтой хэлэв.
- Чи тэдэнтэй учраа сайн олно шүү дээ гэж Рон бувтналаа.

Гермiona хэдэн хормын турш цэвэрхэн цаас руу харснаа унтууцсан байртай,

- Төвлөрч чадахгүй нь. Би явж унтлаа гэв.

Тэр цүнхээ онгойлгов. Харри түүнийг номоо хийх нь гэж бодсон ч эхлээд хэлбэр муутай хоёр ноосон зүйл гаргав. Тэднийг болгоомжтойгоор ширээн дээр гарган тавиад дээрээс нь хугархай үзэг болон цаас тавилаа.

- Мэрлиний нэрийг барин асууя чи юу хийж байгаа юм бэ? гээд Рон айдаст автан харлаа.
- Энэ бол гэрийн үйлчлэгчийн малгай гэж тэр урамтай хэлээд номоо буцаан хийлээ.
- Би зун нэхсэн юм. Ид шидгүй болохоор их удаан байсан ч сургуульд илүү түргэн болох байх гэж бодоод.
- Чи тэдэнд энэ малгайг орхих гэж байгаа юмуу? Тэгвэл тэднийг хогийн савнаас олж харах байх даа?
- Яг тийм гэж Гермiona хэлээд цүнхээ мөрөндөө үрлээ.
- Тэгж болохгүй. Чи тэдэнд малгайг мэхлэн өгөх гэж байна. Тэдний хүслийн эсрэг чөлөөлөхийг хүсч байна.
- Мэдээж тэд чөлөөлөгдөхийг хүсч байгаа! Малгайнд хүрээд үзээрэй, Рон! гээд Гермiona царай нь ягаарлаа.

Тэр өсгий дээрээ эргээд явчихлаа. Рон түүнийг охидын унтлагын өрөөний хаалга хүртэл дагуулан хараад дараа нь ноосон малгайнуудыг хаяв.

- Тэд үүнийг харах юм бол авах болно. Харин үүний хувьд бол ... гээд Снеггийн зохион бичлэгийн гарчигтай цаасаа хуйлаад,

- Одоо хийх нь ухаангүй явдал. Гермionaгүйгээр би юу ч бичиж чадахгүй.

Сарны чулууны талаар ойлгохгүй байна. Харин чи? гэлээ.

Харри толгой сэгсрээд чамархайны баруун талд нь янгинан өвдөхийг мэдэрлээ. Аварга биетүүдийн дайны тухай урт зохион бичлэг судсанд нь зоолттой юм шиг шаналгаж байв. Тэр өглөө хийгээгүй гэрийн даалгавартаа харамсахыг мэдэж байсан ч сурах бичгээ буцаан цүнхэллээ.

- Би бас явж унтлаа.

Тэр унтлагын өрөө явах замдаа Симусын дэргэдүүр өнгөрсөн ч харсангүй. Харрид Смиус юм хэлэхийг хүсэн ам нээх шиг сэтгэгдэл төрсөн ч алхаагаа түргэсгэн эргүүлгэн шатаар өгсөж хүнгүй өрөөнд орлоо.

Маргааш өглөө нь урьд өдрийн адил бороотой бүрхэг байв. Өглөөний хоолон дээр Хагрид багш нарын ширээнд үзэгдсэнгүй.

- Өнөөдөр Снеггийн хичээл алга гэж Рон урамтай хэлэв.

Гермиона том эвшээгээд өөртөө кофе аягалав. Тэр юунд ч юм баяртай харагдсанд Рон энэ тухай асуухад,

- Малгай байхгүй болсон байсан. Тэгэхээр үйлчлэгч нар чөлөөлөгдөхийг хүсэж байгаа байх нь гэв.

- Мэдэх юм алга. Тэд малгай гэж ойлголгүй цэвэрлэсэн байх. Надад бол ноосон давсагтай төстэй юм шиг санагдсан.

Гермиона түүнтэй өглөөний турш ярилцсангүй.

Шившлэгийн хичээлийн хоёр цагийн дараа хувиргалын хичээл хоёр цаг орлоо. Ингээд профессор Флитвик, профессор МакГонагалл нар эхний арван таван минутын турш С.И.Ш хичнээн чухал болох тухай ярилаа.

- Та нар ойлгох ёстой гэж ширээнийхээ ард ном давхарлан зогссон жижигхэн биетэй профессор Флитвик хэлээд,

- Энэ шалгалт та нарын ирээдүйн олон зүйлд нөлөөлнө! Хэрвээ та нар мэргэжлийн сонголт хийх талаар чухалчлан бодож үзээгүй байвал одоо л цаг нь болсон. Харин тэр хооронд бид ердийнхөөсөө илүү их ажиллах болов уу гэж айж байна.

Тэд үүний дараа шалгалтан дээр ирэх Татах шидийн тухай яриад хичээлийн төгсгөлд их хэмжээний гэрийн даалгавар өглөө.

Хувиргалын хичээл ч мөн адил явагдав.

- Та нар хичээл зүтгэл дадлага сургуульгүйгээр С.И.Ш өгч болохгүй. Би энэ ангид хувиргалын шалгалт өгөх амжилттай өгч чадах хүнийг олж харахгүй байна. Үүний тулд их хөдөлмөрлөх хэрэгтэй гэхэд Невилл дуу алдан ёолов.

- Тиймээ, та Долгопупс. Таны ажил муугүй ч өөртөө итгэлгүй байдаг. Ингээд бид өнөөдөр Алга болох шидийг үзнэ. Энэ бол анги дэвших шалгалтанд үе шаттайгаар бэлтгэхэд туслах хүнд шид юм.

Түүний зөв байлаа. Харри Алга болох шидийг аймшигтай муу хийж байлаа. Хоёр цагийн төгсгөлд Рон тэр хоёр эмгэн хумс ч алга болгож дөнгөсөнгүй. Харин Гермiona гурав дахь оролдлогоороо амжилттай хийж Гриффиндорт арван оноо авлаа. Профессор МакГонагалл ганцаараа гэрийн даалгавар өгөөгүй бөгөөд бүгдэд шившлэгээ орой сургуулилахыг даалгажээ.

Уул шиг их гэрийн даалгавараа хийхийн тулд Харри, Рон хоёр үдийн хоолны цагаа номын санд өнгөрүүлж сарны чулуугаар уусмал бэлтгэх аргыг судаллаа. Гермiona ноосон малгайны тухай Роны хэлсэн үгэнд уурласан хэвээр байсан учир тэдэнтэй нэгдсэнгүй. Үдээс хойш нь шидэт амьтны хичээл дээр Харрийн толгой ахиад өвдлөө.

Жихүүн салхитай өдөр байсан бөгөөд тэднийг нуга дундуур Хориотой ойн захад байдаг Хагридын овоохой руу уруудахад борооны дусал орж байв. Профессор Граббли Дерг сурагчдыг хүлээн овоохойны хаалганаас урд арван алхамын урд зогсож байв. Түүний өмнөх урт тавцантай ширээн дээр тэгнэсэн мөчрүүд байв. Харри, Рон хоёр ширээ рүү ойртоход ард нь чанга инээд сонсогдон Драко Малфой тэргүүтэй Слизеринийхэн ирэх нь үзэгдэв. Тэр ямар нэгэн хөгжилтэй юм ярихад Крэбб, Гойл, Пэнси Паркинсон нар Харри руу хараад баясан хөхрөлдлөө.

- Бүгд ирсэн үү? Тэгвэл хичээлдээ орцгооё. Үүнийг юу гэж нэрлэдгийг хэн хэлэх вэ? гэж профессор Граббли Дерг тэднийг очиход асуулаа.

Тэр өмнөө байгаа овоолоостой мөчрийг заав. Гермionaгийн гар агаарт өргөгдөв. Түүний ард зогсож байсан Малфой шүдээ зуун хариулах гэж тэсэн ядсан хөдөлгөөнийг нь давтан даажигнан үсэрлээ. Пэнси Паркинсон инээд алдсан ч энэ нь даруй хашгиралт болон хувирлаа. Ширээн дээр байсан мөчир үсрэн босоход модоор

хийсэн юм шиг биетэй жижигхэн шунгинууртай адилхан амьтан байсан бөгөөд хүрэн булцуутай гар хөл, мөчиртэй адилхан хоёр хуруутай, холтсон царай дээр нь хүрэн бор нүд гялтагнаж байлаа.

- О-ёо-ёо! гэж Парвати, Лаванда хоёр Хагрид хэзээ ч тэдэнд сэтгэгдэл төрүүлэх амьтан үзүүлж байгаагүй юм шиг хашгирахад Харрийн цухал хөдөллөө. Тиймээ флоббер-өт уйтгартай ч хэдий, саламандр, гиппогрифыг бол ингэж хэлж болохгүй бөгөөд соллохвостуудын хувьд бол сонирхолтой амьтад билээ.

- Алив, охидоо чимээгүй! гэж профессор Граббли Дерг тушаагаад амьд мөчрүүдийг тараан тавингаа,

- Тэгэхээр хэн надад юу гэж нэрлэдгийг нь хэлэх вэ? Хатагтай Грэйнджер? гэлээ.

- Лукотрус. Энэ бол модны хамгаалагч бөгөөд ихэвчилэн шидэт саваа хийхэд хэрэглэгддэг юм.

- Гриффиндорт таван оноо өглөө. Тиймээ, энэ лукотрусууд хатагтай Грэйнджерийн хэлсэнчлэн ойд амьдардаг бөгөөд сайн чанарын шидэт саваа хийх мод болдог юм. Тэд юугаар хооллодогыг мэдэх үү?

- Модны шимэгч. Бас шидэт дагины өндөг хэрвээ тэднийг авч чадвал.

- Маш сайн байна ахиад таван оноо өглөө. Хэрвээ та нарт модны навч юмуу мөчир хэрэгтэй бол лукотрусыг тайвшируулахын тулд шимэгчээр хооллох хэрэгтэй. Тэд гэм хоргүй харагдах хэдий ч уурлуулах юм бол хуруугаараа хүний нүдийг цоо хатгачихаж чадна. Харин одоо ойртож модны шимэгчээр тэжээн биеийн бүтцийг нь судалцгаа. Нэг лукотрус дээр гурван хүн шүү. Би хичээлийн төгсгөлд хүн бүр лукотрусын биеийн хэсэг бүрийг дүрсэлсэн зураг гаргасан байхыг хүсч байна.

Сурагчид овооролдон ширээ рүү ойртоход Харри ухран гарч профессор Граббли Дергийн дэргэд очлоо.

- Хагрид хаана байна? гэж тэр хүүхдүүдийг лукотрусоо сонгож авах зуур хэлэв.

- Чиний хэрэг биш гэж профессор Граббли Дерг ширүүн хэлэв. Тэр өнгөрсөн жил Хагридыг орлохдоо бас ингэж хэлж байсан билээ. Драко Малфой нүүр дүүрэн инээмсэглээд хамгийн том лукотрусыг барьж авлаа.

- Магадгүй тэр ухаан муутай тэнэг өөрийгөө шархдуулсан байх гэж зөвхөн Харрид сонсогдохоор нам дуугаар хэлэв.

- Амаа тат гэж Харри шивнэв.

- Хөөгдөөгүй байх гэхдээ тэр хэтэрхий том зүйлтэй холбоотой болохоор чиний юу яриад байгааг ойлгож байгаа биз дээ.

Малфой мөрөн дээгүүрээ инээмсэглээд явахад Харрийн дотор гэнэт эвгүй болов. Малфой ямар нэг юм мэдэж байгаа юм биш байгаа даа? Түүний эцэг Үхэл залгигч болохоор Хагридын хувь заяаны тухай Фениксийн бүлгэмийн авч чадаагүй мэдээллийг сонссон юм болов уу? Харри ширээ рүү яаран хүрч очиход Рон, Гермиона хоёр ногоон дээр өвдөглөн суугаад лукотрусыг зурахын тулд хөдөлгөөнгүй барихыг хичээж байв. Харри үзэг цаас авч доошоо суугаад найзууддаа Малфойгоос юу сонссон тухайгаа ярилаа.

- Хэрвээ Хагридад ямар нэг юм тохиолдсон бол Дамблдор мэдэх байсан.

Малфой зүгээр л санаа зовсон дүр эсгэж байгаа юм. Тэр биднийг юу ч мэдэхгүй болохыг харж байгаа. Түүнд битгий анхаарал хандуул, Харри. Май энэ лукотрусыг түшиж бай даа би царайг нь зураадхая.

- Тиймээ гэх ойролцоо зогсож байсан Малфойн сунжруу яриа сонсогдлоо.

- Миний эцэг хэдэн өдрийн өмнө сайдтай ярилцахад ид шидийн яамнаас Хогвартсад мэргэжлийн бус багш нар багшилахыг эцэс болгохыг хүсэж байгаа гэсэн. Тийм учраас тэр усан тэнэг ахин ирэх юм бол даруйхан холдуулна.

- Ёо!

Харри лукотрусыг хугалчих шахам чанга барьсан учир тэр хариуд нь гарыг хүчтэй цохиод хоёр урт шарх үүсгэв. Харри гараа тавилаа. Крэбб, Гойл нар Хагридын тухай ярилцан хөхрөлдөж байх зуур хүн саваа хөл дээрээ босоод ойн дунд нуугдахаар гүйлээ. Алсад хонх дуугарах сонсогдов. Харри цус болсон гараа Гермионагийн алчуураар боогоод ургамал судлалын хичээл рүү явахад чихэнд нь Малфойн доогтой инээд сонсогдсоор байлаа.

- Хэрвээ тэр ахиж Хагридыг усан тэнэг гэж хэлэх юм бол ... хэмээн Харри шүдний завсраар сийгүүлэв.

- Харри Малфойтой бүү орооцолд. Түүний ахлагч гэдгийг мартаа юу тэр чиний амьдралыг хүндхэн болгож өгч чадна.

- Хөөх, хүнд амьдрал гэдэг чинь юу болох талаар би гайхаж байна л даа? гэж

Харри даажигнан хэлэхэд Рон инээд алдаж харин Гермиона хөмсөг зангидав. Тэд яаралгүйхэн ногооны талбай дундуур гарав. Тэнгэр бүрхэг бороо оруулах эсэхээ шийдэж чадаагүй нь гэмээр байлаа.

- Би зөвхөн Хагридыг түргэн ирээсэй гэж хүсч байна гэж Харри хүлэмжний үүдэнд хүрэхдээ аяархан хэлээд,

- Тийм болохоор надад Грабл Дергийг илүү дээр багш гэж бүү ярь! гэж сүрдүүлэн нэмэрлэв.

- Би тэгээгүй гэж Гермиона тайван хэлэв.

- Яагаад гэвэл түүний амьдрал Хагридынхтай харьцуулахын аргагүй байсан юм гэж Харри хатуу хэлэхдээ үлгэр жишээ шидэт амьтаны хичээл заах туршлагатай багшид уурласан хэвээр байлаа.

Ойролцоох хүлэмжний хаалга нээгдэн Жинни тэргүүтэй дөрөвдүгээр дамжааныхан гарч ирлээ.

- Сайн уу гэж тэр дэргэдүүр нь өнгөрөхдөө баяртай хэлэв.

Хэсэг хугацааны дараа Полумна Лавгуд гарч ирлээ. Тэр ангийнхаа хамгийн сүүлд явж байв. Хамар нь шороо болж урт үсээ зулай дээрээ боожээ. Тэр Харри руу нүдээ бүлтийлгэн хараад хүрч ирэв. Нэг ангийхан нь сониучирхсан янзтай толгойгоо эргүүлэн харлаа. Полумна том амьсгал аваад,

- Би Хэцүү нэртийг эргэн төрсөн гэдэгт итгэж байна. Чи түүнтэй тулалдсан гэдэгт итгэж байна гэлээ.

- Э ... тиймээ гэж Харри эв хавгүйхэн хэллээ.

Полумна чихэндээ шаргал өнгийн лууван адил ээмэг зүүжээ. Парвати, Лаванда хоёр хөхрөлдөн чихний гэдэс рүү нь хуруугаараа заалаа.

- Хүссэнээрээ инээж болно! гэж Полумна тэр хоёрыг хэлсэн үгэнд нь инээсэн гэж бодсон бололтой дуугаа өндөрсгөн хэлээд,

- Хүмүүст бас үрчгэр эвэртийг байхгүй гэж бодож байсан үе байсан юм шүү гэлээ.

- Тэдний зөв биш үү. Үнэхээр тийм амьтан байхгүй юм биш үү гэж Гермиона хэлэв.

Поулмна түүн рүү эгдүүцэн хараад цааш явахад чихэндээ зүүсэн лууван нь

санжиганав. Одоо зөвхөн Парвати, Лаванда хоёр инээсэнгүй.

- Надад итгэсэн цорын ганц хүнийг гомдоохоо больж үз гэж Харри

Гермионагаас анги руугаа явах замдаа гуйлаа.

- Өө, бурхан минь Харри чи түүнээс дээрийг олж чадсангүй юу. Полумнагийн тухай Жинни надад бүгдийг ярьсан. Тэр зөвхөн ямар ч баталгаагүй зүйл итгэдэг гэсэн. Тэгээд ч «Шүүмжлэгч» сэтгүүлийн эрхлэгчийн охиноос өөр юу ч хүлээх билээ дээ.

Харри дотор эвгүйцэм төрхтэй далавчтай морьд харсан тухайгаа саналаа. Полумна тэднийг бас харсан гэж хэлсэн. Түүний сэтгэл хүндхэн болов. Тэр үнэхээр худал хэлсэн юм болов уу? Гэхдээ түүнийг учрыг олж амжихаас урьтаж санааширлыг нь Эрни МакМилланы чанга дуу таслав.

- Би чиний мэдэж байгаа зүйлийг мэдэхийг хүсч байна, Поттер. Чи галзуу биш. Би хувьдаа чамд зуун хувь итгэж байна. Манай гэр бүл үргэлж Дамблдорын талд зогсдог, би ч гэсэн зогсох болно.

- Их баярлалаа, Эрни гэж Харри гайхан хэллээ.

Хэдийгээр Эрни сүржин байдалтай хэлээгүй ч гэлээ Харри чихэндээ лууван зүүгээгүй хүн түүнийг дэмжсэнд таатай байлаа. Эрнигийн үгийг соноссод Лаванда Брауны царай дахь инээмсэглэл алга болж Рон, Гермона хоёр луу эргэлээ. Харри нүднийхээ булангаар Симусын зөрүүд царайд ичсэн өнгө тодрохыг харлаа.

Профессор Стебль хичээлээ эхлэхдээ С.И.Ш хичнээн чухал болох тухай ярьсанд Харри бүх багш нар үүнийгээ ярихыг болихыг хүслээ. Энэ тухай бодохоос л гэдэс дотор нь хөрвөх шиг болно. Энэ мэдрэмж нь ялангуяа хичээлийн төгсгөлд Стебль зохион бичлэг бичих даалгавар өгөхөд хүчтэй боллоо. Тэд ядарч зүдрэн лууны шивх ханхалуулсаар Гриффиндорын цамхаг руу буцлаа. Хоорондоо бараг ярилцсангүй.

Харри таван цагаас эхний шийтгэлтэй байсан учир цүнхээ ч тавилгүй шууд хоол идэхээр явлаа. Гэхдээ Их танхимын хаалгаар орж амжаагүй байтал ард нь чанга ууртай хоолой хадав.

- Хөөе, Поттер!

- Юу вэ? гэж ядрангуй бувтнаад эргэхдээ уурсаж хилэгнэсэн Анжелина

Жонсонг олж харлаа.

- Би чамд юу болохыг нь одоохон тайлбарлаад өгье. Чи яаж баасан гаригийн таван цагаас шийтгэлтэй болж чадав аа? гэж хуруугаараа цээж рүү нь чичлэн хэлэв.

- Юу? Аан ... хаалгачын сорилт билүү!

- Одоо санав уу! Би чамд бүх багаараа шинэ тоглогч яаж сонгохыг харах хэрэгтэй гэсэн биз дээ. Би тусгайлан квиддичийн талбай авсан гэж хэлсэн биз дээ. Харин чи тэгтэл тийшээ явахгүйгээр шийдсэн байдаг! гэж Анжелина ууртайгаар хашгирав.

- Би юу ч шийдээгүй! Намайг Амбриж Хэцүү нэртийн тухай үнэнийг хэлсэн учир шийтгэсэн юм гэж Харри шударга бус байдалд гоморхон хэллээ.

- Тэгвэл явж түүнээс баасан гаригийн үдэш чөлөөлөхийг гуй. Яаж хийх чинь надад хамаагүй. Хэцүү нэрт чиний хийсвэр төсөөлөл чинь байсан гэж хэлсэн ч болно. Ямар ч байсан баасан гаригт байх ёстой!

Тэр огцом эргээд явчихлаа.

- Юу гэдгийг нь мэдэж байна уу? «Паддмир Юнайтед» багийн бэлтгэл дээр Оливер Вуд үхсэн эсэхийг мэдмээр байна. Анжелина нэг л биш байна гэж Харри Рон, Гермиона хоёртой Их танхимд орох үедээ хэлэв.

- Амбриж чамайг баасан гаригт чөлөөлөх ямар нэг боломж байхгүй юу? гэж Рон Гриффиндорын ширээнд суух үедээ эргэлзэнгүй асуулаа.

- Тэгээс ч бага гэж болно. Гэхдээ оролдоод үзэж болох юм. Жишээлбэл дараа нь нэмж хоёр шийтгэл авахаар ч юм уу гэж Харри баргар царайлан хэлээд чанасан хонины мах авлаа.

- Өнөөдөр намайг удаан саатуулахгүй байх гэж найдаж байна. Гурван зохион бичлэг хийх хэрэгтэй байдаг. МакГонагаллын Алга болох шившлэгийг сургуулилан, Флитвикийн эсрэг шившлэгийн тухай зохион бичлэгийг хийж, дээрээс нь локотрусын зургийг дуусгаж бас Трелонигийн тэнэг зүүдний өдрийн тэмдэглэлийг бичих хэрэгтэй байна!

- Бороо орж байна хэмээн Рон шидэт адар руу хараад дуу алдан ёлов.

- Бид гэрийн даалгаварын тухай ярьж байхад юун бороо вэ? гээд Гермиона хөмсгөө өргөв.

- Юу ч биш гэж тэр хурдан хэлээд чих нь улайлаа.

Таван цагаас Харри найзуудтайгаа салах ёс гүйцэтгээд гурван давхарт байх Амбрижын өрөө рүү очлоо. Өрөөний үүдийг цохиход нялуун хоолойгоор «Ор ор» гэх нь дуулдав. Тэр болгоомжтой ороод ийш тийшээ харав.

Тэр энэ өрөөнд өөр гурван хүний үед ирснээ саналаа. Алтан хонгиот Туг үсийг байх үед ханан дээгүүр инээмсэглэж байгаа хөргүүд нь байдаг байсан. Люпины үед ямар нэгэн хар шидийн гайхалтай амьтантай тор юмуу, шилэн хорго байдаг байлаа. Харин Грюмын нэр зээлдэгчийн хувьд өрөөнд янз бүрийн нууцлаг эд зүйл байдаг байсан.

Харин одоо өрөө танигдахын аргагүй болон өөрчлөгджээ. Ширээний гадаргууг торон нэхээстэй даавуугаар бүтээжээ. Дээр нь хатсан цэцэгтэй хэдэн ваар байх бөгөөд тус бүрээс нь амны цаас цухуйна. Нэг талын ханандаа тавагны цугуулга өлгөсний дотор янз бүрийн зангиа хүзүүндээ зүүсэн тод өнгөтэй муурууд байлаа. Харри алмайран харахад муурнууд уурсан хүржигнэлээ. Тэгтэл профессор Амбрижийн дуу гарлаа.

- Оройн мэнд ноён Поттер.

Харри цочоод ийш тийшээ харлаа. Түүнийг шууд ажигласангүйн учир гэвэл цэцэгтэй жанч нь бичгийн ширээний бүтээлэгтэй ман сайн зохицжээ.

- Оройн мэнд профессор Амбриж гэж Харри хүйтнээр дуугарлаа.

- Алив суу гэж тэр хэлээд нэхсэн торон бүтээлэгтэй жижиг ширээний ард тавьсан сандал руу зангав. Ширээн дээр Харриг хүлээж байхаас зайлахгүй цэвэр цаас хэвтэж байв.

- Профессор Амбриж бид эхлэхийн өмнө би юм асуух гэсэн юм. Түүний нүд онийлоо.

- Би таныг сонсож байна.

- Би Гриффиндорын багт квиддич тоглодог юм. Баасан гаригийн таван цагаас би хаалгач сонгох сорилтон дээр байх ёстой ... хэрвээ та намайг тэр өдөр шийтгэлээс чөлөөлвөл ... би оронд нь ... өөр өдөр нөхөөд ...

Түүнийг яриагаа дуусгахад юу ч бүтэхгүй нь тодорхой болов.

- Өө, үгүй дээ. Та юу яриад байна гэж Амбриж хэлээд нүүр дүүрэн инээмсэглэн тарган ялаа залгисан аятай шүлсээ залгилаа.

- Үгүй үгүй. Ноён Поттер та утгагүй хор хөнөөлтэй түүх ярисаныхаа төлөө шийтгэсэн. Шийтгэл ганц тухтай байдлын төлөө тасалдах ёсгүй. Та энд маргааш таван цагаас болон, түүний маргааш гээд л түүнчлэн баасан гаригт шийтгэлээ хүлээхээр ирэх болно. Би таныг хийхийг үнэхээр хүссэн зүйлээ алдах нь сайн талтай гэж бодож байна. Энэ бол миний таньд заахыг оролдож байгаа хичээлийг улам батжуулах юм.

Харри чих рүү нь алхаар цохьчихсон аятай цус хэрхэн толгой руу нь хөөрөхийг мэдэрлээ. Түүнийг утгагүй хор хөнөөлтэй түүх ярьсан гэж хэлсэн үү?

Тэр түүн рүү толгойгоо үл мэдэг бөхийн харахдаа урьдын адил нүүр дүүрэн инээмсэглэж байсан ч ахин хашгирах эсэхийг нь харах гэсэн нь тодорхой байлаа. Харри хүчлэн харц буруулаад цүнхээ шалан дээр тавьж сандал дээр суулаа.

- Харж байна уу бид түргэн аашаа хянаж байсан нь дээр байгаа биз дээ? Одоо ноён Поттер та хэдэн мөр бичих ёстой. Үгүй ээ таны үзгээр биш гэж Харриг цүнх рүүгээ гараа сунгахад нь хэлээд,

- Та миний тусгай үзгийг ашиглах болно. Май энэ байна гэв. Тэр урт нарийхан ер бусын хурц үзүүртэй хар үзэг сунгалаа.

- Би таныг «Би худал хэлэхгүй» гэж бичихийг хүсч байна.

- Хэдэн удаа? гэж Харри түүний эелдэг байдалд санаа амран хэллээ.

- Хичнээн шаардагдах тусам бичих болно. Эхэл.

Тэр ширээндээ очиж суугаад цаас руугаа тонгойв. Харри хурц үзүүртэй үзгийг авахдаа юугаар бичихээ ойлгосонгүй.

- Та надад бэх өгсөнгүй.

- Өө, таньд бэх шаардагдахгүй гэж профессор Амбриж инээмсэглэн хэлэв. Харри хурц үзгийг авч цаасан дээр «Би худал хэлэхгүй» гэж бичлээ.

Тэр өвдөлтийг мэдэрчээ. Цаасан дээр үг гялалзсан улаан бэхээр бичигдэв. Тэгтэл үүнтэй зэрэгцэн баруун гарын ард дээр нь мэс заслын хутгаар зүссэн мэт ором гарч ирснээ ахин эдгэрэхдээ улаавтар толбо үлдээв.

Харри Амбриж руу харав. Тэр түүн рүү бахны амаараа инээмсэглэв.

- За?

- Юу ч биш гэж Харри аяархан хэлэв.

Тэр ахин цаас руу хараад үзгээрээ хоёр дахь удаагаа «Би худал хэлэхгүй» гэж бичтэл халуу оргин өвдлөө. Үг ахиад арьсан дээр нь зүсэгдэн гарч ирээд ахин эдгэлээ.

Ингээд цааш үргэлжлүүлэв. Цаашлах тутам Харрид үг цаасан дээр бэхээр биш өөрийнхөө цусаар бичиж байгаа нь тодорхой болов. Ахин дахин үгнүүд арьсан дээр нь гарч ирээд үзгээ цааснаас холдуулмагц арилж байлаа.

Амбрижын өрөөний цонх харанхуй болов. Харри энэ бүхэн хэзээ дуусахыг асуусангүй. Тэр цагаа ч харсангүй. Тэр түүн рүү сул дорой болсны ямар нэгэн тэмдгийг хүлээн харж байгааг мэдэж байсан тул бүтэн шөнө суух хэрэг гарсан ч үзгээрээ гаран дээрээ бичих болно ...

- Наашаа хүрээд ир гэж тэр эцэст нь хэлэв.

Тэр бослоо. Баруун бугуй нь хүчтэй хорсон өвдөж байв. Тэр гараа хараад зүсэгдсэн шарх эдгэн улаан мөр үлдээснийг харлаа.

- Гараа өг гэж профессор Амбриж хэлэв.

Тэр гараа сунгалаа. Тэр түүнд богинохон бүдүүн хуруугаараа хүрэхэд Харри чичрэхгүй байж арайхийн тэслээ.

- Үр дүн даруухан болж. Тэгэхээр маргааш орой үргэлжлүүлцгээх үү? Явж болно.

Харри нэг ч үг хэлэлгүй гарч явлаа. Сургууль эзгүйрэн хоосорсоныг бодвол шөнө дунд дөхөж байгаа бололтой. Тэр хонгилоор удаан явж булан тойроод хөлийн чимээ нь сонсогдохоо больсон үед гүйлээ.

Түүнд Алга болох шившлэг сургуулилах, зүүдний тэмдэглэл хөтлөх, лукотрусын зураг зурж дуусгах, зохион бичлэг хийх хүч үлдсэнгүй. Иймээс өглөөний цайнд явалгүй мэргэ төлгийн хичээлд зориулан хоёр хуурамч зүүд бичлээ. Хачирхалтай нь гэвэл түүнтэй сэгсийсэн үстэй Рон нэгдлээ.

- Өчигдөр орой чамд хийхэд юу саад болоо вэ? гэж Харри найзаасаа асуулаа.

Харриг Амбрижын өрөөнөөс унтлагын өрөөндөө ирэхэд Рон бөх унтаж байсан бөгөөд ямар нэгэн өөр зүйл хийсэн тухай бувтнан цаасан дээрээ хэдхэн мөр бичлээ.

- За болно гээд тэр өдрийн тэмдэглэлээ хааж,

- Би шинэ гутал худалдаж авч байна гэж зүүдэлсэн гээд биччихлээ. Тэр үүнээс

ямар нэгэн хачирхалтай зүйл олж чадах болов уу гэв.

Хоёулаа умард цамхаг руу түргэн явав.

- Амбрижийн шийтгэл ямар байв даа? Тэр чамаар юу хийлгэсэн бэ?

Харри хормын турш эргэлзсэнээ,

- Мөр бичүүлсэн гэлээ.
- Тэгвэл ямар ч аймшигтай зүйл алга шив дээ? гэж Рон асуулаа.
- Тиймээ гэж Харри хэллээ.
- Дашрамд тэр чамайг тав дахь өдөр чөлөөлсөн үү?
- Үгүй.

Рон өрөвдөнгүй дуу алдан ёолов.

Ахиад л нэг таагүй өдөр болов. Тэр хувиргалын хичээл дээр Алга болох шидийг сургуулилаагүйн шанд ганцаараа муу хийлээ. Үдийн хоолны цагаараа лукотроусын бүтэн зургийг зурж дуусгасан бөгөөд энэ зуур профессор МакГонагалл, Граббли Дерг, Синстра нар тэдэнд шинэ гэрийн даалгавар өгсөн ч Амбрижийнд орой шийтгэлтэй болохоор дуусгах боломж байсангүй. Түүнийг Ажелина Жонсон оройн хоолон дээр ахин барьж аваад баасан гаригт хаалгачын сорилтон дээр байж чадахгүйг мэдмэгц урам хугаран багтаа үлдэхийг хүсэж байвал бэлтгэл дээр бусадтайгаа байх ёстойг сануулав.

- Би шийтгэгдсэн гээд байгаа биз дээ? Чи надад хөгшин бахтай байх нь квиддич тоглохоос илүү гэж бодоо юу? хэмээн Харри түүний араас орилов.

- Эцсийн эцэст зөвхөн мөр бичих шүү дээ. Тийм ч аймшигтай шийтгэл биш гэж Гермiona түүнийг суумагц тайвшируулахыг хичээн хэлээд бөөртэй хуушуур амандаа ойртуулав.

Харри ам ангайсан ч дараа нь хааж толгой дохилоо. Тэр яагаад Рон, Гермiona хоёроос Амбрижийн өрөөнд болсон үйл явдлыг нууж байгаагаа ойлгохгүй байсан ч найзуудынхаа нүдэнд айдас харахыг хүсэхгүй байв. Амбриж түүнийг тэдэнд гомдоллосон тухай сонсвол сэтгэл ханах нь лавтай.

- Хичнээн их гэрийн даалгавар хийх болсондоо итгэж ч чадахгүй байна хэмээн

Рон золгүй хоолойгоор дуугарлаа.

- Өчигдөр орой чамайг яагаад юу ч хийгээгүй чинь ойлгохгүй байна? Ингэхэд чи хаана байсан бэ? гэж Гермiona асуулаа.

- Би ... ердөө зугаалсан юм гэж Рон зайлсхийв.

Тэгтэл Харрид түүнийг нэг юм нуугаад байна гэсэн мэдрэмж хоёр дахь удаагаа төржээ.

Амбрижийнд өнгөрүүлсэн хоёр дахь үдэш дээрдсэнгүй. Арьс нь одоо маш түргэн улайн үрэвслээ. Удалгүй үг гар дээр нь сийлэгдэж эхлэхэд Амбриж сэтгэл хангалуун байх болно. Тиймээс тэр өвдөлтөндөө санаа алдах ч боломж өгөлгүй «оройн мэнд», «тавтай нойрсоорой» гэсэн үг ч сонссонгүй.

Гэрийн даалгавар хийх болсондоо цөхөрсөн амьтан Гриффиндорын амралтын өрөө рүү эргэж очлоо. Тэр ядарсан ч унтахаар явсангүй сурах бичгээ онгойлгоод сарны гэрэлд Снеггийн өгсөн зохион бичлэгийг хийгээд нэг хагаст дуусгав. Тэр үүнийгээ хөөрхийлөлтэй ажил болсон гэж мэдэж байвч юу ч хийхгүй байж байгаад энэ удаад Снеггээс шийтгэл авахыг хүссэнгүй. Дараа нь МакГонагаллын өгсөн асуултанд хариулж, профессор Граббли Дергийн лукотрусын тухай бичээд ор луугаа ганхан очиж хувцастайгаа агшин зуур унтлаа.

Пүрэв гариг ядарсандаа манан дунд өнгөрөв. Рон ч гэсэн их нойрмог байсанд Харри яагаад гэдгийг нь ойлгосонгүй. Гурав дахь шийтгэл өмнөх хоёр өдрийн адил байсан ч хоёр цагийн дараа «Би худал хэлэхгүй» гэсэн үг Харрийн гар дээр бичигдэхэд цус асгарлаа. Үзэг чахрах чимээ зогсохд профессор Амбрижи харцаа өргөлөө.

- Аан. Сайн байна. Энэ таньд сайхан сургамж боллоо. Өнөөдрийн хувьд хангалттай гэж ширээнээс босон гарыг нь шалгаад хэллээ.

- Маргааш би ирэх үү? гэж Харри асуугаад зүүн гараараа цүнхээ авлаа. Баруун гар нь их өвдөж байв.

- Тэгэлгүй яахав. Маргааш үг бичих тусам бид улам ихийг суралцана гэж найдаж байна хэмээн профессор Амбриж нүүр дүүрэн инээмсэглэв.

Харри өмнө нь хэзээ ч Снеггээс ч илүү үзэн ядах багш байж болно гэж төсөөлсөнгүй. Гэхдээ Гриффиндорын цамхаг руу явах замдаа Снеггийн хүчтэй өрсөлдөгчийг хүлээн зөвшөөрчээ. Тэр бол жигшүүртэй муу ёрын амьтан, галзуу хөгшин гэж

бодсоор долоон давхарт гарлаа.

- Рон?

Тэр шатны дээр гараад баруун тийш эргэтэл Десмонда Долговязогийн хөшөөний ард шүүр барин нуугдаж байсан Ронтой тулгарлаа. Тэр Харриг хараад шинэ шүүрээ ардаа нуулаа.

- Чи энд юу хийж байгаа юм бэ?

- Юу ч биш. Харин чи юу хийж байгаа юм бэ? Харри хөмсөг зангидлаа.

- Боль доо надад хэлж болно биз дээ! Чи энд яагаад нуугдаж байсан юм бэ?

- Мэдэхийг хүсээд байгаа бол би Фред, Жоржоос нуугдаж байсан юм. Тэд саяхан нэгдүгээр дамжааныхантай хамт явж өнгөрсөн. Ахиад ямар нэг юм

турших гэж байгаа байх. Би тэднийг амралтын өрөө рүү явж чадахгүй гэж бодож байна. Учир нь тэнд Гермiona байгаа л даа.

Тэр сандарсан шинжтэй түргэн ярих ажээ.

- Гэхдээ шүүр чамд ямар хэрэгтэй юм? Хаашаа нисээ вэ?

- Би ... за. .. за хэлье, за юу. Харин битгий инээгээрэй? гэж Рон улам улайн хэлээд,

- Би дажгүй шүүртэй болсон юм чинь намайг Гриффиндорын багт хаалгачаар авахгүй байгаа бодсон юм. Алив инээ л дээ гэлээ.

- Ямар ч инээх зүйл алга. Маш сайхан санаа байна! Хэрвээ чи манай багт орвол гайхамшигтай шүү дээ! Гэхдээ чамайг хаалгач болж байхыг чинь харж байсангүй. Сайн тоглодог уу?

- Муугүй. Чарли, Фред, Жорж нар амралтаараа сургуулилт хийхэд би үргэлж тэдний хаалгач болдог байсан юм гэж Рон Харрийн үйлдэлд сэтгэл амран хэллээ.

- Өнөө шөнө сургуулилаа юу?

- Мягмар гаригаас хойш хойш өдөр болгон сургуулилж байгаа ... Би квоффлыг илбэдэн өөр лүүгээ нисгэхийг хичээсэн ч энэ их хэцүү байсан болохоор надад ашигтай болсон гэж бодохгүй байна. Намайг сорилтон дээр очвол Фред, Жорж үхтлээ инээх байх даа. Намайг ахлагч болсон ч гэсэн тэд даажигнасан хэвээр байгаа.

- Би тэнд байхгүй нь харамсалтай байна гэж Харри гашуунаар хэлээд хамтдаа

зочны өрөөнд орлоо.

- Тийм шүү ... Харри чиний гар яагаа вэ?

Харри баруун гараараа хамраа маажсанаа нуухыг хичээсэн ч Рон «Зүлгэгч»-ээ нуух гэсэнтэй адил зүйл боллоо.

- Зүгээр л урчихсан юм ...

Рон Харрийн бугуй татан арагш нь эргүүллээ. Тэр удаанаар чимээгүй арьсан дээр сийлэгдсэн үг рүү харав. Эцэст нь гарыг тавилаа.

- Чи зөвхөн мөр бичүүлж байгаа гэсэн биз дээ?

Харри тээнэгэлзсэнээ эцсийн эцэст Рон түүнд ийм нээлттэй байгаа явдалд Амбрижийн өрөөнд өнгөрүүлсэн бүх үнэнийг хэллээ.

- Хөгшин шулам! Тэр галзуу юм байна. МакГонагалл руу очоод түүнд бүгдийг хэл! гэж Рон зэвүүцэн шивнээд толгойгоо унжуулан зүүрмэглэж байгаа тарган хатагтай өмнө зогслоо.

- Үгүй. Ингэснээрээ би зөвхөн Амбрижийг баярлуулах болно. Ингэхийг хүсэхгүй байна.

- Чи түүнд ингэж хийх боломж өгөх ёсгүй!

- Тэгээд ч МакГонагалл түүнд нөлөөлөх эсэхийг мэдэхгүй байна.

- Тэгвэл Дамблдор руу оч.

- Үгүй гэж Харри хатуу хэлэв.

- Яагаад үгүй гэж?

- Надгүйгээр түүнд ажил хангалттай гэж Харри хэлэхдээ жинхэнэ шалтгааныг нь хэлсэнгүй. Дамблдорын тусламжыг авахыг хүсээгүй учир гэвэл тэр түүнтэй зургаан сараас хойш нэг ч яриагүй билээ.

- Ямар ч гэсэн би тэгэх ёстой бодож байна гэж Рон хэлэхэд тарган хатагтай нойрмог хараад,

- Та нар нууц үгээ хэлэх үү үгүй юу? Би шөнөжингөө яриаг чинь дуустал хүлээж чадахгүй шүү гэв.

Баасан гаригт урьдын адил чийгтэй дүнсгэр байлаа. Харри Их танхим руу орохдоо

зөнгөөрөө багш нарын ширээ рүү харахдаа Хагридыг харна гэж найдахаа больжээ. Түүнд өөр илүү асуудал тулгарав. Тийм уул овоо шиг их гэрийн даалгаварыг Амбрижийн өрөөнд шийтгүүлснийхээ дараа яаж хийх вэ гэдэг.

Харриг энэ өдөр хоёр бодол дэмжиж байлаа. Нэгдүгээрт нь гэвэл маргааш амралтын өдөр, хоёрдугаарт гэвэл Амбрижийнд сүүлчийн хүнд үдшээ өнгөрүүлэх үедээ цонхоор квиддчийн талбай руу харж аз болвол Роны оролдлогыг харах байх. Үнэнийг хэлэхэд Хогвартсад ирснээс хойш тийм аймшигтай долоо хоногийг үзсэнгүй.

Орой таван цагаас Харри сүүлчийн удаа гэж найдсаар Амбрижийн өрөөний үүдийг цохин орох зөвшөөрөл сонслоо. Торон бүтээлэгтэй ширээн дээр түүнийг цэвэр цаас хүлээж байсан бөгөөд дэргэд нь хурц үзүүртэй үзэг хэвтэж байлаа.

- Та юу хийх ёстойгоо мэднэ, ноён Поттер гэж Амбриж инээмсэглэн хэлэв. Харри үзгийг авч цонх руу харлаа. Хэрвээ сандлаа баруун тийш хэдхэн дюйм ахиулвал ... Тэр ширээ рүү дөхөх далимдаа үүнийг хийв. Түүнд одоо квиддчийн талбай дээгүүр Гриффиндорын квиддчийн баг нисэж байгаа төдийгүй гурван өндөр цагаригийн дор зогсож байгаа хар дүрсүүд харагдав. Энэ бол гарцаагүй хаалгачид дугаарлан хүлээж байгаа хэрэг. Тэдний хэн Рон болохыг ийм зайнаас харна гэдэг боломжгүй хэрэг ажээ.

«Би худал хэлэхгүй» гэж Харри бичлээ. Баруун бугуйн дээр нь ахин зүсэгдсэн шарх улайн гарч ирэв.

«Би худал хэлэхгүй». Шарх улам гүнзгийрч гар нь хатгуулан өвлөө.

«Би худал хэлэхгүй». Бугуйг нь даган цус дуслав.

Тэр цонх руу ахин нэг удаа хяламхийв. Хэн нэгэн онооны цагаригийн өмнө байх бөгөөд маш тааруу харагдав. Харри хэсэгхэн зуур зүрхлэн харахад Кэти Белл бөмбөг оруулав. Роныг хаалгач болоосой гэж найдсаар цусаар бичигдсэн цаас руу харлаа.

«Би худал хэлэхгүй»

«Би худал хэлэхгүй»

Тэр Амбрижийн үзэг чахрах чимээг сонсогдох юм уу ширээний шургуулга онгойх үеийг тааруулан дээшээ харлаа. Гурав дахь хүн маш сайн байж, дөрөв дэх нь аймшигтай, тав дахь нь блажераас бултаж бөмбөгөө алдав. Цохны цаана бүрэнхий

болоход Харри зургаа долоо дахь хүмүүсийг харж болох эсэхийг мэдсэнгүй.

«Би худал хэлэхгүй»

«Би худал хэлэхгүй.»

Цаас тэр чигтээ цусны дусалд будагдан гар нь маш хүчтэй өвдлөө. Харриг ахин толгойгоо өргөх үед харанхуй болж квиддичийн талбай дээр юу ч харагдахаа больсон байв.

- Надад бичсэн мөрөө үзүүлнэ үү? гэх Амбржийн аяархан хоолой хагас цагийн дараа сонсогдов.

Тэр түүн рүү дөхөж очоод цустай бугуйгаа сунгахад богинохон хуруугаараа барьж аваад үгийг харлаа. Тэгтэл шарх нь халуу оргихтой зэрэгцэн духан дээрх сорви нь өвдлөө. Үүнтэй зэрэгцэн цээж нь давчдах шиг хачирхалтай мэдрэмж төржээ.

Тэр цочин гараа татаад Амбриж руу харлаа. Тэр түүн рүү харан том амаараа инээмсэглэв.

- Өвдөж байна уу?

Тэр хариулсангүй. Зүрх нь маш хүчтэй хурдан цохилгов. Тэр шархтай гарыг нь хэлсэн юм болов уу эсвэл духан дээрээ өвдөлт мэдэрснийг хэлсэн юм болов уу?

- Тэгэхээр би таныг миний хараанд өртөхөөр зүйл хийнэ гэж бодохгүй байна, ноён Поттер. Явж болно.

Тэр цүнхээ аваад түргэхэн явлаа.

«Тайван бай» гэж шатаар өгсөхдөө өөртөө хэлэв. «Тайван бай энэ бол чиний бодож байгаа зүйл заавал байх албагүй».

- Мимбулус мимблетония! гэж хэлэхэд тарган хатагтай хөрөг нээгдэв. Амралтын өрөөнд түүнийг баяртай нүргээн угтав. Рон баясан гийж цөцгийн шар айраг цалгиулан гүйж ирлээ.

- Харри би хаалгач болсон!

- Юу? Хөөх ямар сайхан хэрэг вэ! гэж Харри хэлээд инээмсэглэхийг хичээсэн ч зүрх нь хурдан цохилж гар нь янгинан өвдлөө.

- Май цөцгийн шар айраг. Би итгэж ч чадахгүй нь. Ингэхэд Гермiona хаана байгаа юм бол? гээд Рон түүнд шилтэйг сунгав.

- Тэр энд байна гэж Фред тайвшируулаад цөцгийний шар айраг том балгаж ханан зуухны өмнөх сандал руу заав. Гермiona түүн дээр гартаа цом хазайлган бариад зүүрмэглэж байв.

- Мэдэх юм бол баярлана даа гэж Рон мэдэгдэв.

- Тэр унтаж байна гэж Жорж яаран хэлээд Харриг ойлгож амжихаас урьтаж хэд хэдэн нэгдүгээр дамжааныхныг бөөгнүүлэн амтатанаа тараав.

- Рон наашаа хүрээд ир! Энэ Оливерийн хуучин бэлтгэлийн хувцас. Бид зөвхөн түүний нэрийг солиход болно гэж Кэти Белл дуудав.

Роныг явах үед Харри руу Анжелина шийдэмгий ойртлоо.

- Уучлаарай би жаахан түргэдчихлээ, Поттер. Энэ ажил бүр сэтгэлийн дарамт болж үзлээ. Би бүр заримдаа Вудыг шударга байж гэж бодож эхлээд байна шүү.

Тэр гартаа байгаа цомоо өргөж байгаа Рон руу хөмсөг зангидан харлаа.

- Би түүнийг чиний сайн найз гэдгийг мэдэж байгаа ч нэг их баярлахгүй байгаа гэдгээ хэлэх байна. Түүнтэй жаахан сургуулилчихвал бүтэх байх. Түүний гэр бүлд сайн тоглогчид байдаг байсан. Үнэнийг хэлэхэд би түүнийг авсны учир нь өнөөдрийнхөөс илүү авъяас үзүүлээсэй гэсэндээ тэр. Викки Фробишер, Жеффи Хупер сайн нисэж Хупер нь жинхэнэ ялагч байсан ч тэр цаг үргэлж ямар нэг юмны тухай гомдоллоод байсан. Бид маргааш хоёр цагаас бэлтгэлтэй. Ингэхэд чамаас гуйхад Ронд аль болохоороо туслаарай, ойлгов уу?

Харри толгой дохиод Анжелина Алисия Спиннет рүү эргэлээ. Харри Гермionaгийн хажууд суухад тэр шалан дээр цүнхээ унагаад цочин сэрлээ.

- Өө, энэ чи юу, Харри. Роныг авсан нь сайн хэрэг болжээ. Харин би маш их ядарлаа. Өчигдөр шөнийн нэг цаг хүртэл малгай нэхсэн юм. Тэд гэрлийн хурдтай алга болж байгаа шүү!

Харри амралтын өрөөнд ноосон малгай үйлчлэгч санамсаргүй хүрч болох бүх газар байхыг харлаа.

- Гайхамшигтай гэж тэр урам зориггүй хэлээд,

- Сонсооч Гермiona, би сая Амбржийн өрөөнд байх үед тэр надад хүртэл ... гэж ярилаа.

Гермiona маш анхааралтай сонслоо. Харриг яригаа дуусгах үед тэр удаанаар,

- Чи түүнийг Хэцүү нэрт Квиреллийн адил хянаж байж болох юм гэж айж байна уу? гэв.

- Тиймээ. Болох л юм гэж Харри аяархан хэлэв.

- Тиймээ, боломжтой. Гэхдээ би түүнийг Амбиржийг Квиреллийн адил удирдаж байна гэж бодохгүй байна. Тэр одоо биетэй болсон болохоор хэн нэгний биеийг ашиглах хэрэггүй болсон. Би түүнийг Имперуус шившлэгийн нөлөөнд орсон байж болох гэж бодож байна хэмээн Гермiona итгэлгүйхэн дуугарав.

Харри хэсэг зуур Фред, Жорж, Ли Жордан нар шар айрагны хоосон шилээр жонглёрдохыг харав. Тэгтэл Гермiona,

- Өнгөрсөн жил чиний сорви хэн нэгэн хүрэх үед өвдөөгүй. Дамблдор чамд Хэцүү нэртийг хүчтэй сэтгэл хөдлөл мэдрэх үед өвддөг гэж хэлсэн биз дээ. Би энэ нь Амбрижтай холбоогүй тохиолдлоор таарсан хэрэг байх гэж бодож байна гэлээ.

- Тэр бол ёрын амьтан гэж Харри хатуу хэлэв.

- Тиймээ, тэр аймшигтай ... Харри. Гэхдээ би чамайг Дамблдорт сорвио өвдсөн гэдгийг хэлэх ёстой гэж бодож байна.

Түүнд хоёр дахь удаагаа Дамблдор луу явахыг зөвөлсөн ч хариулт нь адил байлаа.

- Би түүнд ийм зүйлээр төвөг удахыг хүсэхгүй байна. Чи сая чухал биш гээ биз дээ. Зунжингаа миний сорви үргэлж өвдөж байсан өнөөдөр ердөө л хүчтэй өвдлөө.

- Харри би Дамблдорт хэлэх хэрэгтэй гэдэгт итгэлтэй байна.

- Тиймээ Дамблдор зөвхөн миний сорвийг сонирхдог гэж Харри биеэ барьж чадахаа болиод хэлэв.

- Тэгж бүү хэл энэ бол худал!

- Энэ тухай Сириуст бичиж юу бичихийг нь сонсоё.

- Харри захиа илгээж болохгүй! Чи мартсан гэж үү? Грюм биднийг маш анхааралтай бичих хэрэгтэй гэж хэлсэн! Хэн ч ууль замаасаа баригдахад саад болж чадахгүй шүү дээ! гэж Гермiona түгшин дуу алдав.

- За яахав, тэгвэл захиа бичихгүй! Явж унтлаа. Ронд баяр хүргээрэй гэж Харри уурсан хэллээ.

- Өө, үгүй ээ чи унтахаар явж байгаа бол би ч гэсэн явна. Би маргааш шинэ

малгай хийх ёстой. Сонсооч чи надад жаахан туслахгүй биз? Энэ бол маш сонирхолтой ажил. Би эсгүүрийг нь гаргаад өгчихвөл.

Харри баяртай царай гаргахыг хичээсэн ч болсонгүй.

- Ээ ... үгүй ээ, би чадахгүй, баярлалаа. Маргааш лав бүтэхгүй. Би зөндөө их гэрийн даалгавар хийх ёстой.

Тэр шатаар гэлдрэн өгсөж хөвгүүдийн унтлагын өрөөнд орлоо. Гермиона түүний араас урам хугарсан байртай харан хоцров.

БҮЛЭГ 14: ПЕРСИ БА ТЭНҮҮЛЧ

Маргааш өглөө нь Харри хамгийн түрүүнд сэрлээ. Тэр хөшигний завсраар тусах нарны гэрэлд тоос бужигнахыг хараад харамссан ч бямба гариг гэдгийг санаад баярлалаа. Эхний долоо хоногийн хичээл яг л нэг эцэс төгсгөлгүй үргэлжилсэн ид шидийн түүхийн урт хичээл шиг санагдлаа.

Үүр цайсны дараа нар мандаад удаагүй болохоор нойрмог нам гүмийг нэвтлэн нарны гэрэл тусна. Тэр орныхоо хөшгийг нээгээд босч хувцаслав. Алсад шувуудын жиргэх болон унтлагын өрөөнд Гриффиндорынхны гүнзгий амьсгалах чимээнээс өөр юу ч сонсогдсонгүй. Тэр цүнхээ аяархан нээж үзэг, цаас гаргаад амралтын өрөө рүү явлаа.

Гал нь унтраад удаагүй байгаа ханан зуухны хажуудах дуртай түшлэгтэй зөөлөн сандалдаа суугаад цаасыг тавьж харав. Ердийнхөөрөө хогийн сав өдрийн төгсгөлд дүүрсэн зүйл болох үнгэгдсэн цаасны өөдөс, хуучин чулуун тоглоом, уусмалын орцны хоосон сав, чихрийн цаас гээд зүйлсээр дүүрэн байдаг ч одоо хоосон байлаа. Гермionaгийн нэхсэн үйлчлэгчийн малгай ч байсангүй. Хичнээн үйлчлэгч чөлөөлөгдөхийг хүсэж байгаа эсэх тухай Харри залхуутайгаар бодоод үзгээ бэхэндээ дүрэн гилгэр шар цаас руу харж гүнзгий бодлогоширов. Тэр хормын дараа хоосон ханан зуух руу харснаа юу бичих ёстойгоо мэдсэнгүй.

Тэр одоо л Рон, Гермiona хоёрт түүнд зун захидал бичих ямар хүнд байсныг ойлголоо. Сириуст сүүлчийн долоо хоног болсон зүйлийг яаж гадны хүн ухаж ойлгохооргүй хэлэх вэ?

Тэр зуух руу ширтэн удаан суугаад эцэст нь шийдвэрт хүрч үзгээ ахин дүрээд тууштай бичиж эхлэв.

Хүндэт Ньюхалз.

Чиний бүх зүйл сайн гэж найдна. Энд өнгөрүүлсэн эхний долоо хоног аймшигтай байсан болохоор дууссанд нь би баяртай байна.

Бид профессор Амбриж гэдэг хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багштай болсон. Тэр бараг л чиний ээж шиг эелдэгхэн эмэгтэй. Чамд бичиж байгаагийн учир гэвэл өнгөрсөн зун бичсэнтэй адил явдал өчигдөр үдэш би Амбрижyнд шийтгэлтэй байхад боллоо.

Манай том биетэй найзыг түргэн ирнэ гэж найдна. Түргэн хариулахыг хүсье.

Харри.

Тэр нилээн хэдэн удаа захиагаа уншаад гадны хүний нүдээр харахыг хичээв. Энд юу яригдсаныг болон хэнд хаяглагдсаныг ойлгоход бэрх санагдав. Тэр Сириус Хагридын тухай бичсэнийг ойлгоод хэзээ ирэхийг хэлнэ байх гэж найджээ. Нээлттэй асуухыг хүсээгүй бөгөөд энэ нь Хагрид сургуульд байхгүй явдалд анхаарал татаж магадгүй юм.

Захиа маш богинохон хэдий ч бичих гэж удсан тул нарны гэрэл амралтын өрөөний хагасыг туулж дээр унтлагын өрөөнд хөдөлгөөн сонсогдож эхэлжээ. Тэр цаасаа нямбай хуйлаад хөргөн нүхээр гарч уулийн байшин руу явлаа.

- Би чиний оронд байсан бол энэ замаар явахгүй байсан даа. Пивз үүгээр түрүүлж явсан хүний дээрээс Парацельсын баримал унагахаар бодсон байгаа гэж бараг толгойгүй Ник хэлэв.

- Парацельс түүний толгой дээр унах уу? гэж Харри асуулаа.

- Их инээдтэй байна. Пивз хэзээ ч онцгой ухаантай байгаагүй юм. Явж цуст бароныг олъё. Тэр түүнийг зогсоох байх. Баяртай Харри.

- Баяртай гээд Харри баруун тийшээ биш зүүн тийш эргэн уулийн байшин хүрэх илүү урт боловч аюулгүй зам сонгон авлаа.

Түүний сэтгэл санаа дээрджээ. Цонхны цаана цэлмэг хөх тэнгэр харагдаж өнөөдөр бэлтгэлтэй болохор квиддичийн талбай дээр гарна. Ямар нэг юм шагайг нь шүргэн өнгөрлөө. Тэр доошоо хараад хатагтай Норрис гэдэг туранхай саарал муурыг олж харлаа. Тэр дэнлүү шар нүдээрээ ширтсэнээ Уилфред Унылогийн хөшөөний цаагуур алга болов.

- Би ямар ч буруу зүйл хийгээгүй гэж араас нь Харри хашгирав. Тэр муур эзэн рүүгээ мэдээлэл хүргэхээр явсан гэдэгт эргэлзсэнгүй ч хагас сайн өдрийн өглөө уулийн байшин явахад ямар буруу байгааг ойлгосонгүй.

Харри уулийн байшинд ороход нар өндөрт хөөрөн мандаж шилгүй цонхоор нүд гялбуулан дугуй өрөө рүү тусахад хонуур дээрээ сууж байгаа зуугаад уулийн зарим нь хурц гэрэлд тавгүйцэж, зарим нь саяхан ангаасаа эргэж ирээд байлаа.

Харри Хэдвигийг хайн явахад хөл дор нь сүрэл шажигнаж ямар нэг жижигхэн амьтны ясыг гишгэв.

- Чи тэнд байна уу. Нааш хүрээд ир. Надад захиа байна гэж хэлээд бараг адар шүргэх шахам хамгийн дээд талын хонуур руу харлаа.

Ууль аяархан гууглаад том цагаан далавчаа дэлгэн мөрөн дээр нь суув.

- Нюлхазад захиа аваачиж өг гэж хэлээд хошуунд нь захиа зуулгаснаа яагаад гэдгийг мэдэхгүй ч шивнэн,

- Гэхдээ Сириуст гэдгийг ойлгосон биз дээ? гэлээ. Хэдвиг шар нүдээ анивчсан нь ойлгосны дохио бололтой.

- Тэгвэл сайн явж хүрээрэй.

Харри түүнийг нэг цонх руу аваачихад гарыг нь түлхэн цэлмэг хөх тэнгэрт хөөрлөө. Тэр араас нь хар толбо алга болтол дагуулан харж дараа нь Хагридын овоохой руу харахад байшин сайн харагдаж байсан ч эзгүй гэдэг нь тодорхой хөшиг нь татаастай яндангаар нь утаа гарахгүй байлаа.

Хориотой ойн мододын орой дээгүүр сэвшээ салхи үлээнэ. Харри цэвэр агаарыг нүүрэндээ мэдрэнгээ квиддичийн тухай бодлоо ... Тэгтэл гэнэтхэн Хогвартсын сүйх тэргийг зөөж байсантай адил далавчтай морь мододын дээгүүр том шувуу адил нисэхийг харлаа. Тэр агаарт тойрог эргэлдээд мод руу шунгав. Энэ удаад маш түргэн болсон учир Харри нүдэндээ итгэж чадсангүй ч зүрх нь хүчтэй цохилон.

Ард нь хаалга онгойлоо. Тэр цочоод эргэж харвал Чжоу Чанг гартаа захиа бариад зогсож байлаа.

- Сайн уу гэж Харри дуугарлаа.

- Өө ... сайн уу. Би өглөө эрт болохоор хэн ч байхгүй гэж бодсон юм ... Би дөнгөж сая өнөөдөр ээжийн төрсөн өдөр гэдгийг саналаа.

Тэр цаасаа үзүүлэв.

- Аан гэж Харри бувтнав. Түүний толгой зай завсаргүй мэт болов. Тэр ямар нэг хөгжилтэй юм хэлэхийг хүссэн авч бодлыг нь аймшигтай далавч морьд эзлээд юу ч бодож олж чадахааргүй байлаа.

- Сайхан өдөр байна гээд цонх руу заагаад сэтгэлээр унасандаа дотор нь давчдав. Цаг агаар. Тэр цаг агаарын тухай ярилаа ...

- Тиймээ. Квиддич тоглоход сайхан өдөр байна. Би долоо хоногийн турш тоглосонгүй. Харин чи? гээд Чжоу харцаараа тохиромжтой ууль хайлаа.

- Би ч гэсэн гэж Харри хэлэв.

Чжоу сургуулийн нэг уулийн өмнө зогсов. Түүнийг гар дээрээ аргадангуй авахад шувуу сарвуугаа сунгав.

- Гриффиндор шинэ хаалгачтай болсон гэл үү?

- Тиймээ. Миний найз Рон Уизли. Чи түүнийг мэднэ биз дээ?

- Нөгөө «Хар салхи»-ийг үзэн яддаг уу? Тэр сайн тоглодог уу? гэж Чжоу хүйтнээр асуув.

- Тийм байх гэж бодож байна. Гэхдээ тоглож байхыг нь хараагүй. Шийтгэлтэй байсан юм гэж Харри хэлэв.

Чжоу захиагаа уулийн саварт уяж байснаа толгойгоо өндийлгөв.

- Энэ Амбриж аймшигтай жигшүүртэй эмэгтэй. Тэр чамайг түүнийг хэрхэн үхсэн тухай ... үнэнийг хэлсэн учир шийтгэсэн. Бүгд үүнийг сонссон болохоор сургууль даяараа мэдэж байгаа. Чи маш зоригтой алхам хийлээ.

Харрид одоохон уулийн байшингийн шалнаас хөөрөх гэж байгаа юм шиг сэтгэгдэл төржээ. Энэ тэнэг нисдэг морьд хэнд хамаатай юм бэ? Чжоу түүнийг зоригтой гэж бодож байна. Тэр түүнд санамсаргүй мэтээр сорвитой гараа үзүүлэх тухай хүртэл бодож үзлээ. Илгээмж уяхад нь туслахаар ... энэ агшинд уулийн байшингийн хаалга ахин нээгдэв.

Сургуулийн харуул Филч өрөөнд амьсгаадан орж ирэв. Түүний хацар улайн толботож, эрүү нь чичрэн, буурал үс нь өрвийснийг үзвэл ийшээ гүйж ирсэн бололтой. Хатагтай Норрис араас нь орж ирээд аяархан дуугарав.

Хонуур дээр далавчаа дэвэх тайван бус хөдөлгөөн гарч том хүрэн ууль хошуугаа заналхийлгэн тас нясхийлгэв.

- Аанхан! Надад чамайг шивхэн бөмбөгний томоохон илгээмж захиалсан гэдэг мэдээлэл ирлээ гээд Филч Харри руу шийдэмгий ойртоход хацар нь уурандаа чичирч байлаа.

Харри энгэртээ гараа зөрүүлээд муухай харав.

- Намайг шивхэн бөмбөг захиалсан гэж хэн хэлсэн юм?

Чжоу ч гэсэн Филч рүү хөмсөг зангидан харж зогсоход гарт нь байсан ууль нэг хөл

дээрээ зогсоод сэрэмжлүүлэн гууглав.

- Надад өөрийн гэсэн эх сурвалж бий. Алив захиагаа нааш нь өг гэж Филч сэтгэл хангалуун хэлэв.

Харри цаг үрэлгүй захиагаа явуулсандаа баярлан,

- Чадахгүй аль хэдийн явуулчихсан гэв.
- Явуулчихсан гэнээ? гээд Филчийн царай уурандаа мурийлаа.
- Илгээчихсэн гэж Харри тайван хэлэв.

Филч амаа ангайснаа нүдээ бүлтийлгэн Харрийн жанч руу ширтлээ.

- Чиний халаасанд байхгүй гэдгийг би яаж мэдэх юм бэ?
- Яагаад гэвэл ...
- Би түүнийг илгээхийг харсан гэж Чжоу уурсан хэлэв. Филч түүн рүү эргэлээ.
- Чи түүнийг харсан гэнээ?
- Тиймээ харсан гэж тэр ууртай хэлэв.

Хормын турш чимээгүй болов. Филч Чжоу руу уурсан харахад тэр мөн адил харцаар хариулав. Эцэст нь сургуулийн харуул хаалганы зүг хөлөө чирэн явлаа. Тэгснээ хаалганы бариулаас бариад Харри руу эргэж,

- Хэрвээ зөвхөн шивхэн бөмбөг үнэртэх л юм бол ... гэв.

Тэр шатаар доош буулаа. Хатагтай Норрис сүүлчийн удаа уульнуудыг хомхой харцаар хараад түүний араас яарав.

Харри Чжоу руу харлаа.

- Баярлалаа.
- Зүгээр дээ. Чи нээрээ шивхэн бөмбөг захиалаагүй биз дээ? гэж Чжоу улайгаад уулийн сарвуунд захиагаа уяж дуусгав.
- Үгүй гэж Харри хэллээ.
- Чамайг захиалсан гэж тэр юу яриад байсан юм бол? хэмээн тэр асуугаад шувууг цонхоор тавилаа.

Харри мөрөө хавчлаа. Тэр түүнээс дутуугүй энэ тухай бодож байсан ч одоо яагаад ч юм бага зовоолоо.

Уулийн байшингаас хамтдаа гарцгаалаа. Шилтгээний хонгилд ороод баруун зүг рүү эргэхийн өмнө Чжоу,

- Би ийшээ явна ... Дараа уулзая, Харри гэв.

- Дараа уулзая.

Тэр инээмсэглээд явлаа. Харри цааш хөдлөхөд сэтгэл нь догдолжээ. Тэр ярианы туршид нэг ч удаа ичсэнгүй. «Чи маш зоригтой алхам хийсэн.» Чжоу түүнийг амьд үлдсэний төлөө зоригтой гэж нэрлэж байна. Тэр мэдээж Седрикийг эрхэмлэдэг нь ойлгомжтой. Хэрвээ тэр түүнийг Седрикээс эрт бүжигт үдэшлэгт урьсан бол бүх зүйл орвонгоороо эргэж болох байлаа ... Тэр гуйлтаас нь татгалзсан нь үнэхээр харамсалтай байна.

- Өглөөний мэнд гэж Харри Их танхимд ороод Гриффиндорын ширээнд сууж байсан Рон, Гермиона хоёрт хөгжилтэйгээр хэлэв.

- Чи яагаад ийм сэтгэл хангалуун байгаа юм бэ? гэж Рон гайхлаа.

- Ээ ... Квиддич удахгүй тоглоно ... гэж Харри баяртай хэлээд том тавган дээр өндгөн жаврай хийж авлаа.

- Аан ... тийм л дээ. Сонсооч чи надтай жаахан эрт явахгүй биз? Жаахан сургуулилах хэрэгтэй байна л даа гээд Рон талх руугаа харан хулууны шүүс балгав.

- Тэгэлгүй яахав гэж Харри хэллээ.

- Би тэгж бодохгүй л байна шүү. Та хоёрт гэрийн даалгавар зөндөө их байхад ...

Тэр өглөөний шуудан ирсэн учир яриагаа дуусгалгүй таслав. Гермионад үргэлж «Өдөр тутмын зөнч» сонинг хошуундаа зуусан хашгираа ууль авчирдаг бөгөөд чихрийн савны дэргэд маш ойрхон газардаад сарвуугаа сунгав. Гермиона түүний арьсан хүүдийд кнат хийгээд сонинг авч эхний нүүрийг нь дэлгэхэд ууль нисэж одлоо.

- Ямар нэг сонирхолтой юм байна уу? гэж Рон асуув.

Харри Рон гэрийн даалгаварын тухай таагүй сэдвийг дуусгахыг хүсч байгааг ойлгоод инээд алдав.

- Онцын юм алга. Эмгэн шулам хамтлагийн баз гитарчин нөхөрт гарч байгаа юм байна.

Гермиона сонингоо эргүүлж түүний ард алга болов. Харри хоёр дахь өндгөн жаврайгаа авлаа. Рон санааширан өндөр цонх руу харав.

- Хүлээгээрэй. Өө, үгүй ээ ... Сириус! гэж Гермиона гэнэтхэн дуу алдав.

- Юу болсон бэ? гэж Харри асуугаад сонинг шүүрэн автал хоёр хэсэг урагдан

Гермионагийн гарт хагас нь үлдэв.

- «Ид шидийн яаманд найдвартай эх сурвалжаас зартай алуурчин Сириус Блэк Лондонд нуугдаж байгаа тухай мэдээлэл ирсэн байна!» гэж Гермиона уншив.

- Люциус Малфой гэж юугаар ч мөрийцсөн болох юм. Тэр Сириусыг тавцан дээр байхыг мэдсэн гэж Харри уурсан хэлэв.

- Юу? Чи юу хэлэхийг хүсээ вэ гэж Рон түгшлээ.

- Чшш! гэж хоёулаа хэлэв.

- «Ид шидийн яамнаас шидтэнгүүдэд Блэк маш аюултай алуурчин бөгөөд арван гурван хүн алж Азкабанаас зугтсан гэдгийг анхааруулж байна». Бас л нөгөө хөгийн юмаа бичжээ гээд Гермиона сонингийнхоо талыг доош тавьж Харри, Рон хоёр луу айдаст автан харлаа.

- Тэр ахиад гэрээс гарах боломжгүй болжээ. Дамблдор түүнд болохгүй гэдгийг анхааруулсан биз дээ.

Харри урагдсан «Зөнч» сонин руу баргар царайлан ширтэв. Хуудасны ихэнхийг хатагтай Максимын «Амьдралын бүх тохиолдолд хэрэглэгдэх хувцас» дэлгүүрийн зар сурталчилгаа эзэлжээ.

- Хөөе! Үүнийг хараач! гэж Харри хэлээд сонинг ширээн дээр тавилаа.

- Надад жанч минь хангалттай гэж Рон хэлэв.

- Үгүй ээ. Энэ жижигхэн мэдээллийг хараач.

Рон, Гермиона хоёр сонин руу бөхийв. Мэдээ хэдхэн мөр алгасаад баганын хамгийн доод хэсэгт байлаа.

ИД ШИДИЙН ЯАМАНД ЗӨВШӨӨРӨЛГҮЙ НЭВТЭРЧЭЭ

Клэпем, Лабурнум Гарденсийн хоёр тоотод оршин суудаг гучин найман настай Стержис Подморыг Визенгамотын шүүх хоёр дахь удаагаа ид шидийн яаманд найман сарын гучин нэгний шөнө хууль бусаар нэвтрэх гэж оролдсон хэмээн

буруутгажээ. Подмор шөнийн нэг цагаас нууцын зэрэглэлд хамаарагдах хаалганд нэвтрэх гэж оролдож байгаад ид шидийн яамны жижүүр Эрки Манчед баривчлагдсан байна. Подмор өөрийгөө хамгаалан мэдүүлэг өгсөн ч гэлээ буруутай гэж үзэн зургаан сарын турш Азкабанд хоригдох ялаар шийтгэгджээ.

- Стержис Подмор гэнээ? Нөгөө сүрлээр хийсэн юм шиг толгойтой юу? Тэр бас бүл... гэж Рон удаанаар хэлэв.

- Рон, чшш! гэж айсан Гермиона эргэн тойрноо харан дуу алдлаа.

- Зургаан сар Азкабанд! Зөвхөн ямар нэг хаалга руу орохыг хүссэний төлөө!

гэж Харри гайхан шивнэв.

- Тэнэг юм бүү ярь хаалганд нэвтрэх гэсэнд учир байгаа юм биш. Тэр ид шидийн яаманд шөнийн цагаар юу хийж байсан гэдэгт учир байгаа юм? гэж Гермиона шивнэлээ.

- Түүнийг бүлгийн ажлаар явж байсан гэж бодож байна уу? хэмээн Рон шивнэн асуув.

- Хүлээгээрэй. Стержис биднийг хүргэж өгөх ёстой байсныг санаж байна уу? Хоёулаа түүн рүү харав.

- Тэр биднийг Кингс Кросс буудал руу хамгаалан хүргэж өгөх ёстой байсан биз дээ? Грюм түүнийг ирээгүй гэсэн тэгэхээр тийшээ тэдний даалгавараар яваагүй байх нь?

- Магадгүй тэд түүнийг баригдсан гэж бодоогүй байх хэмээн Гермиона хэлэв.

- Энэ бол зохиомол хэрэг байх! Үгүй ... Сонсож бай! гэж Рон уулга алдсанаа

Гермионагийн сүрдүүлсэн харцан доор дуугаа намсган,

- Ид шидийн яамнаас түүнийг Дамблдорын хүн гэдгийг нь мэдэж байгаа болохоор ... мэдэхгүй юм ... тэр хаалганд нэвтрэх гээгүй яаманд занганд оруулсан байж болох юм! Зөвхөн яаж барьсанийг нь хараад үз дээ!

Тэднийг чимээгүй болоход Харри, Гермиона хоёр бодлогоширлоо. Харрид энэ хувилбар итгэмээргүй санагдав. Гермионад ч эсрэгээрээ сэгтгэгдэл төрүүлсэн бололтой.

- Хэрвээ энэ үнэн бол би огтхон ч гайхахааргүй байна.

Тэр бодлогоширонгүй сонингоо хуйлнаа Харриг хутга сэрээгээ авах үед гэнэтхэн саналаа.

- Тэгэхээр Стеблийн өөрийгөө бордогч бутны зохион бичлэгийг түргэн дуусгачихвал оройн хоолны дараа МакГонагаллын Инаниматус Коньюрус шившлэгээр сургуулилж болох байх ...

Уул овоо шиг их гэрийн даалгавар түүнийг дээр хүлээж байсанд Харрийн дотор палхийсэн хэдий ч тэнгэр цэлмэг бөгөөд харин тэр долоо хоногийн турш «Аянга»-аараа нисээгүй байдаг.

- Орой хийж болно байх гэж Рон хэлээд шүүрээ мөрөн дээрээ тавиад нугаар өнгөрөн квиддичийн талбай руу явж байхад Гермionaгийн тэднийг бүх С.И.Ш.-дээ унана гэсэн сүрдүүлэг чихэнд нь хангинасаар байлаа.

- Бас маргааш гэж бүтэн өдөр байна. Ер нь тэр хэтэрхий их ажилладагт түүний зовлон байгаа юм гээд чимээгүй болсноо түгшсэн янзтай,

- Тэр биднийг хуулуулахгүй гэж жинхэнээсээ хэлээгүй байгаа даа? гэв.

- Тэгсэн байх. Гэхдээ хэрвээ багаас хөөгдөхийг хүсээгүй бол бэлтгэл хийх хэрэгтэй гэж Харри хэллээ.

- Зүйтэй. Бидэнд цаг хангалттай байгаа гэж Рон хөгжилтэй хэлэв.

Квиддичийн талбай дээр очсон хойноо Харри Харанхуй ойн зүг харлаа. Хэн ч түүн дээгүүр нисээгүй тэнгэр хоосон байх агаад тэртээд уулийн байшингийн цамхагыг тойрон шувууд эргэлдэнэ. Тэр нисдэг морьдын тухайд хангалттай санаа зовсон болохоор энэ тухай бодохоо болихоор шийдэв.

Тэд хувцас солих өрөөний шүүгээнээс бөмбөг авч ажилдаа орлоо. Рон гурван өндөр цагирагийг хамгаалж харин Харри ангууч болон цагаригт квоффл оруулав. Харрийн бодлоор бол Рон муугүй бөгөөд гурав дөрвөн оролдлого хийхэд тухай бүрд нь итгэлтэй хааж байлаа. Хоёр цагийн дараа тэд шилтгээн рүүгээ үдийн хоолонд орохоор буцахад Гермiona хариуцлагагүй гэж бодож байгаа нь илт харагдаж байлаа. Тэд хоолны дараа ерөнхий бэлтгэлдээ орлоо. Анжелинагаас бусад бүх баг хувцас солих өрөөнд орлоо.

- Рон зүгээр үү? гэж Жорж асуугаад нүд ирмэв.

- Тийм гэж Рон хэлээд шал ширтлээ.

- Жижигхэн ахлагч минь бидэнд үзүүлээд өгөхөд бэлэн үү? гэж Фред инээмсэглэн хэлээд сэгсгэр үстэй толгойгоо бэлтгэлийн хувцас руугаа шургуулав.

- Амаа тат гэж чулуун царайлсан Рон хэлээд багийнхаа дүрэмт хувцсыг анх удаагаа өмслөө. Хэдийгээр Оливер өргөн мөртэй байсан ч бэлтгэлийн хувцас нь яг таарав.

- Бүгдээрээ, анхаар! Эхэлцгээе. Алисия, Фред хоёр хайрцагтай бөмбөгийг гаргаарай. Тэнд үзэгчид цугласан байна. Тэдэнд анхаарал хандуулах хэрэггүй шүү гэж Анжелина өрөөнд орж ирээд хэлэв.

Тэр үүнийг хайхрамжгүй хэлсэн ч Харрид урилгагүй үзэгчид хэн бэ гэдэг нь тодорхой байлаа. Тэднийг хувцас солих өрөөнөөс хурц наранд гарахад үзэгчдийн хоосон суудал дээр суусан Слизериний багийн шоолж исгэрэх болон тохуурхан хашгирах чимээ цэнгэлдэх хүрээлэнд цуурайтав.

- Уизли юугаар нисэх гэж байна? Өмхөрсөн гуалинд нисэх шившлэг хийгээ юу? гэж Малфой дооглонгуй хэлэв.

Крэбб, Гойл, Пэнси Паркинсон нар хөхрөлдөв. Рон шүүрэндээ суугаад дээш хөөрөхөд Харри араас нь дагалдав. Роны чих улайжээ.

- Тэдэнд анхаарал хандуулах хэрэггүй. Тэмцээний дараа яаж инээлдэхийг нь харья гэж тэр найзыгаа гүйцээд хэллээ.

- Зөв харьцаа байна, Харри гэж Анжелина урамшуулаад квоффл барин агаарт хөөрч багийнхаа өмнө зогсоод,

- Тэгэхээр бүгдээрээ халаалт хийхийн тулд жаахан дамжуулалт хийцгээе гэв.

- Хөөе Жонсон үс чинь яагаа вэ? Хэн чиний үсийг өт шиг харагдуулахыг бодсон юм бол? гэж Пэнси Паркинсон хашгирав.

Анжелина урт үсээ духнаасаа тайвнаар холдуулаад,

- Тарцгаа бид юу хийж чадахыг харцгаая гэлээ.

Харри талбайн эсрэг зүгт нисэхэд Рон цагариг руу нислээ. Анжелина квоффлыг нэг гартаа бариад Фредэд хүчтэй дамжуулахад цаадах нь Жоржод дамжуулаад, Жорж Харрид, Харри Рон руу Рон түүнийг алдчихлаа.

Малфой тэргүүтэй Слизеринийхэн чих дүлийрэм хашгиралдан инээлдэв. Рон газар унасан бөмбөг авахаар доош ухасхийгээд улайсаар ахин ажилдаа орлоо. Харри Фред,

Жорж хоёр бие бие рүүгээ харсан ч чимээгүй байхыг хараад талархах сэтгэгдэл төрөв.

- Рон дамжуулаарай гэж Анжелина хашгирав.

Рон Алисад бөмбөгийг дамжуулахад, тэр Харрид дамжуулаад цааш нь Жоржод дамжуулав.

- Хөөе Поттер сорви чинь өвдөхгүй байна уу? Бүтэн долоо хоног эмнэлэгт хэвтсэнгүй шүү дээ? Дээд амжилт байна даа гэж Малфой хашгирав.

Жорж квоффлыг Анжелинад дамжуулаад, тэр Харрид дамжуулахад хурууныхаа үзүүрээр барьж аваад юу ч бодолгүй шууд Рон руу илгээв. Рон огцом хөдөлсөн ч бөмбөгийг хэдхэн инчийн зөрүүтэй алдчихлаа.

- Алив ээ, Рон. Анхааралтай бай гэж Анжелина Ронд хашгираад квоффлын араас газар луу ухасхийв.

Роны цагаригийн урд эргэн ирэхэд түүний царай квоффл хоёрын аль нь улаан болохыг хэлэхэд хэцүү байлаа. Малфой болон бусад Слизеринчүүд үхтэлээ инээлдэв.

Рон гурав дахь оролдлогоороо квоффолыг барьж аваад санаа амарсандаа урам зоригтойгоор Кэтид өгөхөд бөмбөг түүний гараас нисээд шууд нүүр лүү нь цохилоо.

- Уучлаарай! гэж тэр дуу алдаад гэмтлийг нь харахаар ухасхийв.

- Байрандаа үлд, тэр зүгээр! гэж Анжелина тасхийгээд,

- Ахин дамжуулах үедээ шүүрийг нь битгий оночихоорой доо! Бидэнд бас блажер байгаа шүү! гэлээ

Кэтигийн хамар цус болжээ. Үзэгчдийн суудал дээр сууж байсан Слизеринчүүд хөлөөрөө газар нүдэн тохуурхацгаав. Фред, Жорж хоёр Кэти рүү нисэв.

- Май үүнийг ав. Дор нь зогсооно гэж Фред хэлээд халааснаасаа жижигхэн улаан өнгөтэй зүйл гаргаж өглөө.

- За болно. Фред, Жорж хоёр цохиураа болон блажераа аваарай. Рон онооны цагаригтаа. Биднийг Рон руу дамжуулж эхлэхэд Харри снитчийг бариарай гэж Анжелина хашгирав.

Харри ихрүүдийг дагалдав.

- Роны баруун чих гахайных юм шиг санагдахгүй байна уу? гэж Жорж тэднийг бөмбөгтэй харцагны дэргэд газардахад бувтналаа.

- Сэтгэл нь догдлоод байгаа юм. Өглөө бид хоёр удаа бэлтгэл хийхэд зүгээр байсан шүү дээ гэж Харри хэлэв.

- Тиймээ, түүнийг оргилд гарахгүй нь гэж найдахаас хэмээн Фред хэлэв.

Тэд агаарт буцан хөөрөв. Анжелина шүгэл үлээхэд Харри снитчийг гаргаж харин Фред, Жорж хоёр блажерыг тавилаа. Энэ агшингаас эхлээд Харри бусад нь юу хийж байгааг анзаарсангүй. Түүний даалгавар бол алтан бөмбөгийг барих явдал бөгөөд барьсан тохиолдолд баг нь шууд зуун тавин оноо авдаг учир хурдтай нисдэг билээ. Тэр хурдаа нэмэн ануугчдыг тойрон эргэлдэхэд намрын дулаахан агаар нүүр лүү нь үлээн чихэнд нь Слизеринчүүдийн утга учиргүй инээд хадна ... гэвч удалгүй түүнийг шүгэл зогсоолоо.

- Зогс ... зогс ... Зогс! Рон чи дунд талын цагаригны урд зогсоогүй байна! гэж Анжелина хашгирлаа.

Харри Рон руу харахад зүүн талын цагаригны өмнө нөгөө хоёрыгоо хамгаалалтгүй орхиод хөвж байлаа.

- Өө, уучлаарай.

- Чи үргэлж ангуучдыг дагуулан харж байх ёстой! Төвд нь зогсоод цагаригаа хамгаалахад бэлэн бай эсвэл цагаиргнуудын хооронд эргэлд битгий ганц талд нь зогс чи ингэснээрээ сүүлчийн гурван цохилтыг алдлаа!

- Уучлаарай гэж Рон давтахад царай нь цэлмэг тэнгэрт байгаа улаан гэрлэн дохио адил болов.

- Кэти чиний цус тогтохгүй нь уу?

- Улам их гарч байна! гэж Кэти ээдрэн хэлээд ханцуйгаараа арчлаа.

Харри сэтгэл зовсон шинжтэй халаасан дахаа шалгаж байгаа Фред руу харлаа. Дараа нь ямар нэгэн жижигхэн улаан юм хараад айдаст автан Кэти рүү эргэлээ.

- Ахин нэг оролдоод үзье гэж Анжелина хэлэв. Тэр «Гриффиндор гуталчин» гэж хашгирч байгаа Слизеринийхэнд анхаарал хандуулсангүй.

Энэ удаад Анжелинагийн шүгэл тэднийг гурван минутын дараа зогсоолоо. Харри

дөнгөж снитч эсрэг талын цагаригны дэргэд байгааг ажигласан тул гоморхолд автав.

- Бас юу болоо вэ? гэж тэр Алисиягаас уурсан асуулаа.

- Кэти гэж товчхон хэлэв.

Харри эргэж хараад Анжелина, Фред, Жорж нар Кэти рүү ухасхийхийг харав. Тэр Алисиягийн хамт тийшээ очлоо. Анжелина цагаа олж бэлтгэлийг зогсоожээ. Кэти цусгүй болон шохой шиг цайсан байлаа.

- Түүнийг эмнэлэг рүү хүргэх хэрэгтэй гэж Анжелина хэллээ.

- Бид хүргэе. Тэр ... андуураад өөр юм залгичихаж гэж Фред хэллээ.

- Довтлогч болон нэг ангуучгүй үргэлжлүүлэх бодол алга. Бүгд явж хувцсаа сольцгоо гэж Анжелина Фред, Жорж хоёр Кэтиг хоёр талаас нь дэмжин шилтгээн рүү нисэхэд хэллээ.

Слизеринийхэн хашгиралт тэднийг хувцас солих өрөө хүртэл дагалдав.

Харри хагас цагийн дараа Роны хамтаар Гриффиндорын амралтын өрөөний үүдээр орж байлаа.

- Бэлтгэл хэр өнгөрөв дөө? гэж Гермiona хүйтнээр асуув.

- Энэ ч ...? гэж Харри хэлэв.

- Ёстой олиггүй гэж Рон хөндий хоолойгоор дуусгаад дэргэд нь суулаа.

Гермиона түүн рүү хараад,

- Энэ чиний анхны бэлтгэл байсан биз дээ. Цаг хугацаа шаардлагатай гэж тайвшируулах санаатай хэллээ.

- Хэн намайг олиггүй байсан гэж байгаа юм? хэмээн Рон дүрсхийв.

- Хэн ч биш. Би бодохдоо гэж тэр сэтгэлээр унан хэллээ.

- Чи намайг хөгийн байсан гэж бодоо юу?

- Үгүй дээ, би тэгээгүй! Чамайг олиггүй гэж хэлэхээр чинь ...

- Би явж хичээлээ хийлээ гэж Рон уурсан хэлээд шатаар хөвгүүдийн унтлагын өрөө лүү өгсөж алга болов.

- Тэр тааруухан тоглоо юу? гээд Гермiona Харри руу эргэв.

- Үгүй гэж Харри үнэнийг хэлэв. Гермiona хөмсгөө өргөв.

- Би түүнийг сайн тоглож чадах байсан гэж бодож байна. Гэхдээ чи анхны бэлтгэл гэж үнэн хэллээ ...

Тэр үдэш Рон, Харри хоёрын гэрийн даалгаварт төдийлөн ахиц гарсангүй. Харри Роныг өөрийгөө муу тоглосонд сэтгэлээр унаж байгааг ойлгож байсан бөгөөд чихэнд нь «Гриффиндор гуталчин!» гэсэн дуу хангинаж байлаа.

Ням гаригийг тэд хоосон амралтын өрөөнд суун ном эргүүлж өнгөрүүлэв. Бас нэг сайхан өдөр байсан болохоор нэг ангийхан нь жилийн эцсийн нарны туяаг таашаахаар агаарт гарчээ. Үдэш болоход Харрид хэн нэгэн тархин дотроос нь нүдээд байгаа юм шиг мэдрэмж төрлөө.

- Бид даалгавараа дуусгахгүй бол ирэх долоо хоногт улам их нэмэгдэх байх даа гэж Харри Ронд хэлэхэд тэд эцэст нь профессор МакГонагаллын даалгасан Инаниматус Коньюрус шившлэгийн урт зохион бичлэгийг дуусгаж, профессор Синистрагийн өгсөн Бархасвадь гаригийн дагуулуудын тухай хүндхэн зохион бичлэгийг авлаа.

- Тиймээ гэж Рон зөвшөөрөөд улайсан нүдээ нухан тавь дахь базсан цаасаа ханан зуух руу шидэв.

- Сонсооч ... Бид Гермionaгаас хийсэн даалгавараа үзүүлэхийг гуйвал ямар вэ? Харри түүний зүг харлаа. Гермiona өвдөг дээрээ Живоглотыг тавин суугаад Жиннитэй хөгжилтэй яриа дэлгэж нэхмэлийн зүү гялалзуулан ээлжит гэрийн үйлчлэгчийн оймс нэхэж байв.

- Үгүй тэр үзүүлэхгүй гэдгийг чи мэдэж байгаа гэж тэр хатуу хэлэв.

Ингээд тэд ажлаа үргэлжлүүлэхэд цонхны гадаа харанхуйлав. Амралтын өрөө алгуурхан хоосорлоо. Арван нэг хагаст тэдэн рүү Гермона эвшээсээр хүрч ирэв.

- Дуусаагүй л байна уу?

- Үгүй гэж Рон хэлэв.

- Бархасвадь гаригийн хамгийн том дагуул бол Ганимэд болохоос Каллисто биш. Энд галт уул байх ёстой гэж тэр хуруугаараа Роны зохион бичлэгийн мөрөн дээгүүр зааж хэлэв.

- Баярлалаа гэж Рон гомдолтой бувтналаа.

- Уучлаарай, би зүгээр л ...

- Чи зөвхөн биднийг шүүмжлэхээр ирээ юу ...
- Рон ...
- Надад номлол сонсож байх цаг алга, Гермiona. Хүзүүгээр давсан их ажилтай байна.
- Хөөх, тэрийг хараач!

Гермиона цонх руу заалаа. Цонхны гадаа тавцан дээр сайхан ууль зогсоод Рон руу харж байв.

- Гермес биш биз дээ? гэж Гермiona гайхлаа.
- Чөтгөр гэж, тэр байна! Перси надад юу бичсэн юм бол? гэж Рон аяархан хэлээд үсрэн босож үзгээ унагалаа.

Тэр цонх онгойлгоход Гермес амралын өрөөнд нисэн орж ирээд Роны зохион бичлэг дээр газардан сарвуундаа уясан захиаг сунгалаа. Рон захиаг авахад шувуу эргэж нисэхдээ Иогийн зураг дээр бэхэн мөр үлдээв.

- Гарцаагүй Персигийн бичиг байна гээд тэр сандал дээр суугаад «Рональд Уизли, Гриффиндорын тэнхим, Хогвартс» гэсэн хаягийг нь уншаад Харри, Гермiona хоёр луу харлаа.
- Юу гэж бодож байна?
- Онгойлго! гэж Гермiona тэсч ядан хэлэхэд Харри толгой дохилоо.

Рон хуйлаасыг тэнийлгээд уншиж эхлэв. Түүний нүдний харц мөр даган доошлох тусам улам барайж байв. Ингээд захиагаа дуусгах үедээ зэвүүцсэн төрхтэй боллоо. Тэр захиаг Харри, Гермiona хоёрт өгөхөд хамтдаа уншлаа.

Хүндэт Рон.

Би дөнгөж сая (өөр хэнээс ч биш ид шидийн яамнаас томилсон чиний шинэ багш болох профессор Амбрижээс) чамайг ахлагч болсон гэдгийг сонслоо.

Би энэхүү мэдээг таатайгаар гайхан хүлээн авсан бөгөөд юуны түрүүнд чамд баяр хүргэхийг хүсч байна. Би үргэлж чамайг Фред, Жорж хоёрын замаар орчих вий гэж болгоомжилдог байснаа хүлээн зөвшөөрөх ёстой. Ийм учраас би чамайг бусдыг аялдан дагахаа больж биеэ жинхэнэ хариуцлагатай авч явсанд талархах сэтгэл төрж байна.

Гэхдээ зөвхөн баяр хүргэхийг хүссэнгүй, Рон. Би чамд хэдэн зөвөлгөө өгөх гэсэн юм. Захиагаа яагаад өглөөний шуудангаар биш шөнө явуулсны учир нь гэвэл энэ. Чамайг бусдын сониуч нүд болон таагүй асуултаас зайлсхийн захиагаа уншиж байгаа болов уу гэж найдна.

Надад сайд хэлэхдээ чамайг ахлагч болсон ч гэсэн өмнөхийн адил Харри Поттертой үерхсээр байгаа гэлээ. Рон чи тэмдгээ алдах аюулд учрахгүйн тулд энэ сурагчтай нөхөрлөхөө болих ёстой гэдгийг хэлэх юун. Гэхдээ миний үг чамайг гайхуулж байгаа бол чи Поттер үргэлж Дамблдорын хайртай сурагч байсан гэдэгт эргэлзэхгүй байгаа бол Дамблдор Хогвартсад гол хүнээр удаан үлдэхгүй гэдгийг хэлэх байна. Хэрвээ чи маргаашийн «Өдөр тутмын зөнч» сонинг авах юм бол салхи хаашаа эргэж байгааг мэдэн хувь заяагаа зөв сонгон авах болно!

Рон чи Поттерийн талаар нухацтайгаар бодож үзээрэй. Энэ магадгүй чиний ирээдүйд сургуулиа төгсөх хэтийн төлөвт хортойгоор нөлөөлж болох юм. Чи шүүхэд түүнийг манай эцэг хүргэж ирсэн болон энэ зун Поттерын сахилгын дуудлага дээр Визенгамотоын өмнө тийм ч сайнгүй аргаар зөвтгөгдсөн гэдгийг мэдэж байгаа. Түүнийг бүх зүйлээр цагаатгасан ч гэлээ хэрвээ миний бодлыг мэдэхийг хүсвэл би өмнөхийн адил түүнийг буруутай гэдэгт итгэж байна.

Магадгүй чи Поттертой харьцаагаа тасалсан тохиолдод гаргах араншингаас нь айж байж болох юм гэдгийг би мэдэж байна. Хэрвээ чи үүнд сэтгэл түгших юм уу түүний зүгээс ямар нэг сэтгэл түгшээсэн зүйл олж ажиглавал Долорес Амбрижад хандаарай. Энэ гайхамшигтай эмэгтэйг би мэдэх бөгөөд чамд баяртайгаар тусалж зөвөлгөө өгөх болно.

Ингээд зөвөлгөөний хоёр дахь хэсэгтээ орьё. Би Дамблдорын Хогвартс дахь дэглэм удахгүй төгсгөл болно гэдэг битүү дохио авсан. Чиний үнэнч шударга зан түүнд биш харин сургууль болон ид шидийн яаманд хэрэгтэй байна. Би яамнаас Хогвартсад чухал шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх хүслийг төлөөлсөн профессор Амбриж багш нараас маш бага дэмжлэг авсан гэдгийг сонсоод маш их харамслаа (Ирэх долоо хоногт түүнд илүү амар болно. Ахиад хэлэхэд маргаашийн «Өдөр тутмын зөнч» сониныг хараарай!). Мөн түүнчлэн профессор Амбрижад тусалцаа үзүүлэхэд бэлэн сурагч хоёр жилийн дараа сургуулийн ахлагч болох маш сайхан боломжтой гэдгийг хэлэх байна!

Чамтай энэ зун бараг уулзаагүйд намайг уучлаарай. Намайг эцэг эхээ буруушаах

сэтгэл шаналгаж байсан бөгөөд тэдний Дамблдорыг тойрон хүрээлсэн аюултай харилцааны хүрээлэлд амьдарч чадаагүй юм (Чи ээжид Дамблдорын ойр дотны найз Стержис Подмор саяхан Азкабанд ид шидийн яаманд хууль бус нэвтрэх оролдлого хийн хоригдсон гэдгийг хэлээрэй. Магадгүй энэ түүний нүдийг нээх байх). Би азтайгаар энэ хүмүүсээс зугтсанаараа гутамшигт нэрээ цэвэрлэж чадсан бөгөөд сайд надад том найдлага тавьж байгаа. Рон чи гэрийн бүлийн холбоонд уягдан манай эцэг эхийн алхамыг сохор нүдээр төөрөлдөн харж байгаа байх. Би тэднийг цаг нь ирэхэд хэрхэн гүнзгий төөрөлдөж байснаа ойлгоно гэж чин сэтгэлээсээ найдна. Хэрвээ тийм өдөр ирэх юм бол тэднийг уучлахад бэлэн байна.

Гуйя ялангуяа миний энд бичсэн Харри Поттерын тухай зүйлийг сайн бодож үзээрэй. Ингээд ахин нэг удаа чамд ахлагч болсонд баяр хүргэе.

Чиний ах

Перси

Харри Рон руу эргэлээ.

- Тэгэхээр хэрвээ хүсвэл ... гэж тоглосон маягтай сонсогдохыг хичээн хэлээд захиа руу харангаа,

- Надтай харилцаагаа таслахыг хүсч байвал би уурлахгүй гэдгээ тангараглаж байна гэлээ.

- Надад өг гэж Рон гараа сунгаад,

- Тэр энэ дэлхийн ...(Персигийн захиаг хоёр хэсэг хуваалаа) хамгийн том (дөрвөн хэсэг болов) ... новшийн амьтан (найман хэсэг болов) гээд өөдөснүүдийг зуух руу хаяв.

- Алив өглөө болохоос өмнө дуусгах хэрэгтэй байна гээд тэр одон орны зохион бичлэг рүү буцаж эргэлээ.

Гермиона түүн рүү хачирхалтай харцаар харснаа,

- Алив нааш нь өг гэж гэнэт хэлэв.

- Юу? гэж Рон гайхлаа.

- Надад зохион бичлэгээ өг. Би хараад засаад өгье.

- Үнэн үү? Гермиона чи бидний амьдралын аврагч шүү. Би чиний төлөө юу хийх вэ? гэж Рон хэлэв.

- Чи «бид гэрийн даалгавараа ахин оройтуулахгүй гэдгээ амлаж байна» гэж хэлэхэд л болно гээд тэр гартаа зохион бичлэгүүдийг аваад хөгжилтэй болов.

- Мянга дахин баярлалаа гэж Харри ядрангүй хэлээд сандал дээр буцаж суун нүдээ нухав.

Хэдийн шөнө дунд болсон болохоор амралын өрөө хоосорч зөвхөн тэр гурваас гадна Живоглот үлджээ. Гермionaгийн үзэг тэдний зохион бичлэг дээгүүр чахарч баримт нягтлан лавлахын хуудас шар шур хийлгэнэ. Харри их ядарчээ. Дотор нь хоосорсон юм шиг хачирхалтай мэдрэмж төрөх нь ядарсандаа биш ханан зууханд орсон захианаас болов бололтой.

Тэр Хогвартсын сурагчдын тэн хагас нь түүнийг хачирхалтай тэр ч байтугай галзуу гэж бодож байгааг мэдэж байв. Хэрвээ «Өдөр тутмын зөнч» сонин цаг үргэлж түүнийг ёжтой үгээр дайраад байвал Рон Персигийн захиандаа дурьдсан зөвлөгөөг даган профессор Амбриж руу очихыг хэн мэдэхэв дээ. Тэр Перситэй хамт дөрвөн жил сурч, гэрт нь зуны амралтаараа очиж, нэг майханд хамт квиддичийн дэлхийн авар шалгаруулах тэмцээн үзэн, тэрч байтугай Перси түүнд Гурван шидтэний хоёр дахь тэмцээнд өндөр оноо өгч байсан. Харин одоо Перси түүнийг солиотой хэрцгий амьтан гэж бодож байна.

Тэгтэл загалмайлан эцгээ өрөвдөх сэтгэл төрөв. Харри Сириус л зөвхөн түүний юу мэдэрч байгааг ганцаараа ойлгохыг мэдэрлээ. Учир нь бүхий л шидтэний ертөнц түүнийг маш аюултай алуурчин Волдемортын томоохон дэмжигч гэж боддог нь түүнд арван дөрвөн жилийн ийм амьдралыг өгсөн билээ.

Харри нүдээ анивчлаа. Түүнд гал дотор юм харагдах шиг болсон ч юу ч байсангүй. Гялсхийгээд алга болов. Үгүй ... байж боломжгүй юм ... тэр Сириусын тухай хэтэрхий их бодоод ...

- За, үүнийг бич гэж Гермiona Ронд хэлээд цаасан дээр бичсэн зохион бичлэгээ түлхэв.

- Миний бичсэн дүгнэлтийг зүйлийг нэмээрэй.

- Гермiona чи дэлхий дээр миний уулзаж байсан хамгийн гайхамшигтай хүн.

Хэрвээ би чамд ахин бүдүүлэг хандвал ... гэж Рон уулга алдав.

- Би чамайг эргээд хэвэндээ орно гэдгийг мэдэж байна. Харри чинийх зүгээр байна. Зөвхөн энэ төсгөлд нь, чи профессор Синистрагийн хэлсэн үгийг буруу

сонссон юмаа даа. Европ тив цастай байхад арслан байгаагүй ... Харри чи яагаа вэ?
Харри сандлаас дээрээс гулган элэгдсэн хивсэнцэр дээр өвдөглөөд гал руу ширтлээ.

- Хөөе, Харри? Чи юугаа хараад байгаа юм бэ? гэж Рон итгэлгүйхэн дуугарав.
- Яагаад гэвэл би гал дотор Сириусын толгойг харлаа.

Харри өнгөрсөн Сириусын толгой өнгөрсөн жил түүнтэй ярихыг харсан болохоор маш тайван байлаа. Тэр түүнийг сая үнэхээр харсан гэдэгтээ итгэлгүй байсан ч ... агшин зуур алга болсон доо.

- Сириусын толгой гэнээ? Тэр чамтай Гурван шидтэний тэмцээн дээр ярихыг хүссэн үеийн шиг үү? Гэхдээ одоо биш энэ дэндүү ... гээд Гермiona гал руу харснаа,
- Сириус? гэж хашгирлаа.

Рон үзгээ унагав. Галын дөл дунд Сириусын урт хар үстэй толгойд инээмсэглэл гэрэлтэж байв.

- Би та нарыг хүмүүсийг явахаас өмнө эрт унтчихаж магадгүй гэж бодлоо. Цаг болгон шалгаж байлаа.
- Цаг болгон ханан зууханд байсан гэнээ? хэмээн Харри хөхрөн асуув.
- Цэвэр болсон гэдэгт итгэхийн тулд хэдхэн секунд харж байлаа.
- Хэрвээ чамайг харсан бол яана? гэж Гермiona айн дуу алдав.
- Нэгдүгээр дамжааны нэг охин намайг зэрвэс харсан. Гэхдээ санаа зовох хэрэггүй дээ би амжаад нуугдчихсан болохоор тэр намайг хачирхалтай дүрстэй түлээ гэж бодсон байх хэмээн Сириус Гермiona амаа дарахыг хараад хэллээ.
- Гэхдээ энэ чинь томоохон эрсдэлтэй явдал ... гэж Гермiona эхлэв.
- Чи яг Молли шиг ярьж байна. Энэ бол Харригийн нууцалсан захианд хариу өгөх цорын ганц арга. Харин нууцлал эвдэгдчихвэл.

Харригийн захианы тухай сонсоод Гермiona, Рон хоёр зэрэг эргэн харлаа.

- Чи бидэнд нэг ч үг хэлээгүй гэж Гермiona зэмлэнгүй дуугарав.
- Мартчихаж гэж Харри хэлэв. Энэ үнэн байлаа. Тэр Чжоутай уулийн байранд уулзсанаас өмнөх явдал бүгд толгойноос нь арчигджээ.
- Над рүү битгий ингэж хараад бай, Гермiona. Захианд ямар ч нууц мэдээлэл

байгаагүй, тийм биз дээ Сириус?

- Тиймээ маш сайн бодсон байсан. Бид яарахгүй бол ... чиний сорви ...
 - Юу гэнээ? гэж Рон хэлсэн ч Гермиона түүний яриаг таслан,
 - Дараа тайлбарлая. Сириус цаашаа ярь гэлээ.
 - Сорви өвдөхөд баярлах юм бага гэдгийг ойлгож байна. Гэхдээ үүнд санаа зовох зүйл байхгүй байх. Тэр өнгөрсөн жил ч гэсэн өвдөж байсан биз дээ?
 - Тиймээ, Дамблдор Волдемортыг хүчтэй сэтгэл хөдлөл мэдрэх үед тэгдэг гэж хэлсэн гэхэд Рон, Гермиона хоёр давхийн цочлоо.
 - Тэр надад шийтгэл хүлээдэг өдөр уурласан ч байж болох юм.
 - Тиймээ одоо тэр эргээд ирсэн болохоор байнга өвдөж байгаа гэж Сириус хэлэв.
 - Чи үүнийг Амбриж надад шийтгэл хүлээлгэхдээ хүрснээс болсон гэж бодохгүй байна уу?
 - Магадгүй л юм. Гэхдээ би түүний нэр хүндээс нь үзвэл Үхэл залгигч биш гэдэгт итгэлтэй байна.
 - Тэр бол зэвүүн муухай эмэгтэй гэж Харри хэлэхэд Рон, Гермиона хоёр дэмжин толгой дохилоо.
 - Тиймээ, гэхдээ сайн хүмүүс болон Үхэл залгигчидыг хувааж болдоггүй юм. Би түүний ажил хэрэгтээ хэрхэн аймшигтай байдаг тухай Люпины ярьж байхыг сонссон гэж Сириус инээмсэглэн хэллээ.
 - Люлин түүнийг мэддэг юм уу? гэж Харри түргэн асуугаад Амбриж эхний хичээл дээрээ түүнийг хагас цустай аюултай амьтан гэж хэлснийг саналаа.
 - Үгүй. Хоёр жилийн өмнө тэр хүн чонын эсрэг хориг тавиж түүнд ажил олох боломжгүй болгосон.
- Харри Люпины ямар харагдаж байсныг санаад Амбрижад дургүйцэх нь улам ихэслээ.
- Тэр яагаад хүн чононуудад дургүй юм бол? гэж Гермиона ууртай асуув.
 - Тэднээс айдаг байх гэж бодож байна хэмээн Сириус зэвүүцэнгүй инээмсэглэв.

- Эсвэл хагас хүмүүсийг тэвчиж чаддаггүй байж болох юм. Өнгөрсөн жил усны хүмүүсийн эсрэг компанит ажил эхэлүүлсэн. Төсөөлж байна уу усны хүмүүсийг мөрдөхөд цагаа зарцуулах нь яг л Кикимерийн дураараа зугаалахыг харж байгаатай адил.

Рон инээмсэглэхэд, Гермиона гомдсон төрхтэй болов.

- Сириус! Үнэнийг хэлэхэд чи Кикимерийн хичээл зүтгэлийг жаахан үнэлвэл түүнийг өөрчлөгдөх байх гэж бодож байна. Ямар ч байсан чи гэр бүлийн сүүлчийн гишүүн болохоор профессор Дамблдор хэлэхдээ ...

- Амбрижийн хичээл дээр юу зааж байна? Та нарт хагас цустай хүмүүсийг алах тухай зааж байна уу? гэж Сириус түүний яриаг таслав.

- Үгүй. Тэр бидэнд ид шид хэрэглэхийг зөвшөөрөхгүй байгаа гэж Харри хэлэхдээ гомдсон төрхтэй Гермонад анхаарал хандуулсангүй.

- Тэнэг сурах бичиг уншихаас өөр юу ч алга гэж Рон хэлэв.

- Бүгд ойлгомжтой. Манай ид шидийн яаман дахь хүмүүсээс Фаж та нарыг тэмцэлд бэлтгэхийг хүсэхгүй байгаа гэсэн мэдээлэл ирсэн.

- Тэмцэлд бэлтгэх гэнээ! Тэр биднийг арми цуглуулна гэж бодсон юм байх даа? гэж Харри гайхлаа.

- Тэр үнэхээр тэгж бодож байгаа гэж Сириус батлаад,

- Үнэндээ бол Дамблдор хувийн армиа зохион байгуулах вий гэдгээс ид шидийн яам айж байгаа юм гэлээ.

Хэсэг зуур чимээгүй болсны эцэст Рон,

- Амьдралдаа Полумна Лавгудын ярианаас илүү ийм тэнэг зүйл сонсож байсангүй гэлээ.

- Бидэнд хар урлагаас хамгаалахыг судлах боломж өгөхгүй байгаа нь Фаж биднийг ид шидийн яамны эсрэг босохоос айсан хэрэг байх нь уу? гэж Гермиона уурсав.

- Яг тийм. Фаж Дамблдорыг зогсоохын тулд баривчлах хэрэгтэй гэж үзэж байгаа. Тэр өдөр ирэх тусам хартай сэжигч болж байна. Дамблдорыг ямар нэгэн зүйлээр буруутгаж болох сэжүүр гарахыг хүлээж байгаа.

Тэгэхэд Харри Персигийн захиаг саналаа.

- Маргаашийн «Өдөр тутмын зөнч» сонинд Дамблдорын тухай юу гарахыг мэдэхгүй биз? Роны ах Перси бидэнд нэг юм хэлсэн.

- Мэдэхгүй. Энэ долоо хоногт бүлгийнхнээс хэнийг нь ч харсангүй. Кикимер бид хоёр л байлаа гэж Сириус гомдонгуй хэллээ.

- Хагридын тухай ямар нэг зүйл сонсов уу?

- Аан ... тэр эргэж ирж байгаа. Гэхдээ түүнд юу тохиолдсоныг хэн ч мэдэхгүй байгаа л даа гээд тэдний цочирдсон царайг харж түргэхэн,

- Дамблдор үүнд огт санаа зовохгүй байгаа. Хагридийг эрүүл амьд гэдэгт итгэлтэй байна гэлээ.

- Гэхдээ тэр хэдийн ирэх ёстой болсон баймаар юм гэж Гермiona аяархан хэлэв.

- Тэр хатагтай Максимтай байсан болохоор бид түнтэй холбоо тогтооход гэрлүүгээ буцах замд гарсан гэсэн. Түүнд ямар нэг аюул учирсан гэж бодохгүй байна.

Хүүхдүүдийг энэ итгүүлсэнгүй түгшин бие биенээ харцгаав.

- Сонсоцгоо, Хагридын тухай олон асуулт тавих хэрэггүй. Ингэснээрээ та нар түүний эзгүйд анхаарал татах бөгөөд Дамблдор үүнийг хүсэхгүй байгаа юм. Хагрид хүчтэй болохоор сайн байгаа. Ингэхэд та нар хэзээ Хогсмид явах вэ? Би галт тэрэгний буудал дээр нохой болсны адил очиж болох юм гэж бодлоо

...

- Үгүй! гэж Гермiona Харри хоёр зэрэг дуу алдав.

- Сириус чи «Өдөр тутмын зөнч» сонин уншаагүй юм уу? гэж Гермiona сэтгэл түгшин хэлэв.

- Аан тэр үү. Тэд үргэлж таацгааж байдаг ч жинхэнэ учрыг нь мэдэхгүй.

- Гэхдээ тэд энэ удаад таасан байж болох юм. Малфой чамайг мэдсэн бололтой галт тэргэнд хачирхалтай зүйл хэлсэн. Түүний эцэг нь Люциус Малфой бас буудал дээр байсан. Чи ахиж үзэгдэж болохгүй. Хэрвээ Малфой чамайг ахиад мэдэх юм бол

...

- За за, ойлголоо. Би зүгээр л санал болгосон юм. Та нарыг уулзахыг хүсэж

байгаа юм байх гэж бодлоо ... тэр унтууцан хэлэв.

- Тиймээ, гэхдээ чамайг Азкабан руу илгээхийг хүсэхгүй байна! гэж Харри хэллээ.

Сириус хэсэг зуур чимээгүйхэн галын дөл дундаас Харри руу хөмсөг зангидан ширтэв.

- Чи миний бодсон шиг эцэгтэйгээ адилгүй юм. Эцэг чинь эрсдэлд дуртай байсан гэж хүйтнээр хэлэв.

- Сонсооч ...

- Би явалгүй болохгүй нь. Кикимер шатны уруу ирж байх шиг байна гэж Сириус хэлсэн ч Харри үүнд итгэсэнгүй.

- Би та нартай ханан зууханд дахин хэзээ уулзахаа бичиж болох уу? Хэрвээ энэ чамд хэтэрхий эрсдэлтэй санагдахгүй бол ч.

Аяархан тасхийх чимээ гараад толгой байсан газар дөл дүрэлзэж байлаа.

БҮЛЭГ 15: ХОГВАРТСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

Тэд маргааш нь Гермionaг «Өдөр тутмын зөнч» сонингоо авах үед Персигийн захианд дурьдсан зүйлийг хайн эхнээс нь авхуулаад эцсийг нь хүртэл шүүрдэхээр шийдлээ. Гэхдээ уулийн шуудан сүүний саван дээрээс хөөрч амжихаас урьтаж Гермiona чанга дуу алдахад ширээн дээрх сонин дээрээс Долорес Амбриж нүүр дүүрэн инээмсэглэн нүдээ анивчиж байлаа.

ИД ШИДИЙН ЯАМНААС БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛТ ХИЙХИЙН ТУЛД ДОЛОРЕС АМБРИЖИЙГ ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ БОЛГОН ТОМИЛЛОО

- Амбриж ерөнхий байцаагч гэнээ? Энэ чинь одоо юу гэсэн үг юм бол? гэж Харри баргар царайлан хэлээд хазсан талхаа доош нь тавилаа. Гермiona чанга уншив.
- «Өчигдөр үдэш ид шидийн яамнаас ид шидтэний Хогвартс сургуулийг хяналтандаа байлгахын тулд шинэ хууль гаргасан гэсэн гэнэтийн мэдэгдэл хийлээ.
- Сүүлийн үед сайд Хогвартсын ажил хэрэгт түгшин хандах болсон. Тэр сургуулийг хүсээгүй зүг рүү нь эргэчих вий гэж сэтгэл зовсон эцэг эхчүүдийн дуу хоолойд хариу өгч байгаа юм гэж түүний туслах Перси Уизли бидэнд мэдэгдлээ.
- Энэ бол сүүлийн үед ид шидийн яамны сайд Корнелиус Фаж шидтэний сургуулийг сайжруулах шинэ хууль баталж байгаа анхны тохиолдол биш юм. Саяхан найман сарын гучинд боловсролын хорин хоёрдугаар зарлиг ёсоор хэрвээ одоогийн захирал багш нараа сонгон авах чадваргүй юм бол яамнаас өөрсдийн зохимжтой хүнээ тавих болно гэж мэдэгджээ.
- Ийм учраас л Хогвартсад Амбрижийг багш болгон илгээжээ. Дамблдор хэнийг ч олоогүй болохоор сайд Амбрижийг томилсон бөгөөд амжилттай сонголт болж чаджээ ... гэж Уизли ярьсан байна».
- Ямар сонголт? гэж Харри чанга асуулаа.
- Хүлээгээрэй энэ ч бас бүгд биш гэж Гермiona хэлээд,
- «Үүний үндсэн дээр хар урлагаас хамгаалах хичээлийг амжилттайгаар эрс өөрчилсөн бөгөөд сайд Хогвартсад одоо үнэн хэрэгтээ юу болж байгаа тухай мэдээлэл авсан байна.
- Энэ бол яамнаас албан ёсны боловсролын тухай хорин гурав дугаар зарлигийг

үндэслэн Хогвартсад ерөнхий байцаагч томилох ёстойг харууллаа.

- Энэ нь сайдын Хогварстын уналтыг зогсоон гартаа авах үе шаттай төлөвлөгөөний нэг хэсэг юм. Байцаагч багш нарын сурган хүмүүжүүлэх явцад шалгалт хийх эрхтэй юм. Энэ байр сууринд профессор Амбриж хангалттай нийцэж байгаа бөгөөд үүн дээрээ нэмэн багшлах үүргийг баяртайгаар зөшөөрсөн юм.

- Хогварстын сурагчдын эцэг эхүүд яамны энэ алхамыг урам зоригтойгоор хүлээн авлаа.

- Дамблдорын ажил хэрэгт хяналт тавих болсоныг мэдээд миний санаа амарлаа гэж дөчин нэгэн настай ноён Люциус Малфой хэлэв.

- Сүүлчийн жил бидний олонхи эцэг эхүүд Дамблдорын этгээд шийдвэрийн улмаас манай хүүхдүүд тодорхойгүй хувь заяа заналхийлж байсан түгшиж байсан болохоор яамнаас сургуульд хяналт тавих болсонд баяртай байна.

- Энэхүү этгээд шийдвэр нь боловсон хүчний маргаантай асуудлыг сөхөн гаргаж байгаа юм. Урьд нь энэ тухай сонинд бичиж байсан бөгөөд үүний тоонд хүн чоно Римус Люпин, хагас аварга биет Рубеус Хагрид, хартай сэжигч мракоборец байсан Хурц нүдэт Грюм нар орно.

- Цуу ярианаас үзэхэд Альбус Дамблдор өмнө нь Визенгамотын болон олон улсын шидтэнгүүдийн холбооны тэргүүлэгч байхдаа ч Хогвартсын ажил хэргийг гартаа авч чаддаггүй байжээ.

- Ерөнхий байцаагчийн эхний алхам бол Хогвартст итгэж болох захирал тавих явдал юм гэж өчигдөр ид шидийн яамны ажилтан мэдэгдсэн байна.

- Визенгамотын ууган гишүүн Гризельда Марчбэнкс болон Тиберий Огден нар Хогвартсад байцаагч томилох мэдэгдлийг эсэргүүцэн огцрох өргөдлөө өгчээ.

- Хогвартс бол сургууль болохоос Корнелиус Фажын албан өрөө биш. Энэ бол Альбус Дамблдорын нэр хүндийг гутаах гэсэн ээлжит оролдлого гэж хатагтай Марчбэнкс хэлсэн байна.

- (Хатагтай Марчбэнкс албингуудын хорлон сүйтгэх бүлэгтэй холбоотой байсан тухай арван долдугаар нүүрнээс уншина уу.)

Гермиона уншиж дуусаад андууд руугаа харав.

- Тэгэхээр одоо бидэнд Амбриж яах гэж ирсэн нь ойлгомжтой боллоо. Фаж энэ

хуулийг хүчээр хэрэгжүүлэхээр явуулсан байна! Бас түүнд бусад багш нарыг шалгах эрхийг өгчээ! Итгэмээргүй юм. Зэвүүцмээр хэрэг байна даа! гэж хүндээр амьсгаадан нүдээ гялалзуулан хэллээ.

- Зөвшөөрч байна гэж Харри хэлээд баруун гар луугаа харан Амбрижийн бичүүлсэн үг цайрахыг харлаа.

Роны нүүрэнд инээмсэглэл тодров.

- Яасан? гэж Харри, Гермиона хоёр зэрэг асуулаа.

- Түүний МакГонагаллыг яаж шалгахыг харах юмсан. Амбриж түүнд яаж цохилт өгөхөө мэдэхгүй дээ.

- Явцаая. Магадгүй тэр Бинсийн хичээлийг шалгаж байвал бид хоцорч болохгүй гэж Гермиона хэлээд үсрэн бослоо.

Гэхдээ профессор Амбриж ид шидийн түүхийн хичээлийг шалгаагүй байсан бөгөөд өнгөрсөн даваа гаригийнх шиг уйтгартай байлаа. Тэр Снеггийн газар дорхи хонгилийн уусмалын хичээлийн хоёр цаг дээр ч ирсэнгүй. Харри сарны чулууны тухай зохион бичлэгэндээ том хар тэг авчээ.

- Би та нарын хийсэн ажлыг дүгнээд үнэлгээ тавьсан гэж Снегг мушийн мэдэгдээд гэрийн даалгаварыг нь буцааж өгөхдөө,

- Та нар шалгалтан дээр юу хүлээж байгаа тухай бодит төсөөлөлтэй болсон байх гэв.

Тэр цаашаа эргээд анги дундуур явлаа.

- Энэ гэрийн даалгаварын түвшин бол маш хүнд. Шалгалтан дээр та нарын ихэнхи чинь унасан. Та нарыг хайтан цэцгээр хорны эсрэг уусмал хийх дараагийн даалгавартаа илүү төвлөрөнө гэж найдаж байна. Урьдын адил тэнэг байсан хэвээр байвал тэг дүн дээр нэмээд хичээлийн дараа үлдээх болно.

- Хэн тэг авсан бэ? Ха! гэж Малфой баясан шивнэлээ.

Харри Гермиона түүний дүн рүү зэрвэс харахыг хараад сарны чулууны тухай зохион бичлэгээ цүнхэндээ хийлээ. Тэр өөрийн амжилтын тухай дурьдсангүй.

Ингээд Снеггэд түүнийг энэ хичээл дээр доромжлох боломж өгөхгүйн тулд самбар дээр байгаа мөр болгоныг гурван удаа шалгалаа. Түүний Хүч оруулагч уусмал оюу шиг тунгалаг шиг болсонгүй, Гермионагийнх шиг цэнхэр, Неиллийнх шиг ягаан

болсонгүй. Хичээлийн төгсгөлд дашмагаа Снеггийн ширээн дээр тавиад санаа амарлаа.

- Энэ удаад өнгөрсөн долоо хоногийнх шиг муу болсонгүй тийм үү? Гэрийн даалгавар ч муугүй боллоо? гэж Гермиона тэдний шатаар өгсөн хоолонд явахад хэлэв.

Рон, Харри хоёр хариулаагүй ч Гермиона цааш үргэлжлүүлэн,

- Би өнөөдөр хамгийн сайн үнэлгээ авч чадаагүй ч муугүй болсон гэж бодож байна гэв.

Харри дэмжсэн үг хэлсэнгүй.

- Мэдээж шалгалтанд олон зүйл өөрчлөгдөж болох ч бидэнд сайжрах цаг хангалттай байгаа болохоор өнөөдрийн үнэлгээ төгсгөлийн дүн биш. Ингэхэд цаашдаа ...

Тэд Гриффиндорын ширээнд суулаа.

- Хэрвээ надад «Ш» дүн тавьсан бол би хөөрөх байлаа.

- Гермиона чи биднийг ямар дүн авсныг мэдэхийг хүсээд байгаа юм бол түүнийгээ хэл гэж Рон унтууцав.

- Үгүй дээ би тэгж бодоогүй ... Хэрвээ хэлэхийг хүсэхгүй байгаа бол ...

- Би «Т» авсан. Хангалттай юу? гэж Рон хэлээд тавгандаа шөл хийлээ.

- Ичих зүйл юу ч алга гэж ширээнд Жорж болон Ли Жорданы хамт ирж суусан

Фред хэлэв.

- «Т» гэдэг чинь тааруу гэсэн үг үү? гэж Гермиона гайхлаа.

- Тиймээ, тааруу гэж Ли Жордан батлаад,

- Гэхдээ «Ж»-гээс дээр жигшүүртэй гэв.

- Харри нүүр нь улайхыг мэдээд ханиалгалаа.

- Тэгэхээр хамгийн дээд үнэлгээ «Ш» шилдэг юм бол дараа нь «Х» юу?

- Үгүй «И». Илүү найдлагатай. Би үргэлж Фред бид хоёр авахгүй юм байх даа гэж боддог байлаа. Учир нь хичээл болгонд хэтэрхий их найдлага тавьж байсан юм.

Гермионагаас бусад бүх хүн инээлдэв.

- Тэгэхээр «И»-гийн дараа «Х» хангалттай юм бол энэ сүүлчийн сайн дүн үү?
- Тиймээ гээд Фред шөл халбагадан залгилав.
- Дараа нь «Т» тааруу ... «Ж» жигшүүртэй бий гэж Рон хэллээ.
- Бас «С» гэж бий хэмээн Жорж сануулав.
- «С» гэнээ? «С» гэдэг чинь юу юм бэ? гэж гэж Гермиона асуулаа.
- Савдаг гэж Жорж хэлэв.

Харри ахин инээд алдахдаа тоглосон эсэхийг нь ойлгосонгүй. Тэр Гермиона шалгалтан дээр авсан «С»-ээ яаж нуухыг хичээж байгааг төсөөлөв.

- Та нарын хичээл дээр шалгалт орсон уу? гэж Фред асуув.
- Үгүй. Харин та нарт? гэж Гермиона даруй асуулаа.
- Үдийн хоолны өмнө. Шившлэгийн хичээл дээр орсон гэж Жорж хэлэв.
- Ямар байна? гэж Харри, Гермиона хоёр зэрэг асуулаа. Фред мөрөө хавчив.
- Ямар ч сонирхолтой зүйлгүй. Амбриж буланд суугаад тэмдэглэлийн дэвтэртээ үе үе юм бичиж байсан. Флитвик түүнд зочин шиг хандаж байсан. Тэр тийм ч их яриагүй. Алисагаас хоёр асуулт тавихад маш сайн хариулсан. Тэгээд дууссан.
- Хөгшин Флитвикд таагүй зүйл бодно гэж бодохгүй байна. Түүний хувьд шалгалтаа сайн өгсөн.
- Харин хоолны дараа юу орох юм бэ? гэж Фред Харригаас асуулаа.
- Трелони ...
- Би ахин нэг «Т» харлаа.
- Бас Амбриж.
- Тэгэхээр Амбрижийн хичээл дээр биеэ барьж сайн хүү байгаарай даа. Хэрвээ ахин нэг бэлтгэл алгасвал Анжелина ухаан солиорох байх гэж Жорж хэлэв.

Гэхдээ Харри Амбрижтай хар урлагаас хамгаалах хичээл дээр уулзах боломж таарсангүй. Тэр тэмдэглэлийн дэвтэртэйгээ мэргэ төлгийн хичээлийн бүүдгэр танхимд байлаа. Рон тохойгоороо хавирга руу нь нудрахад тэр тагтай үүдээр гарч

ирэхдээ харлаа. Анги хөгжилтэй ярилцаж байснаа чимээгүй болов. Гэнэтийн нам гүм байдлыг профессор Трелонигийн «Зүүдний зөн» номоо тараах чимээ эвдэнэ.

- Өдрийн мэнд, профессор Трелони. Та миний шалгалт хийх өдөр цагтай зурвасыг авсан гэж найдна? хэмээн Амбриж нүүр дүүрэн инээмсэглэн хэлэв.

Трелони толгой дохиод бухимдсан байртай эргэн харж номоо үргэлжлүүлэн тараалаа. Амбриж өмнөхийн адил инээмсэглэсээр ойролцоох түшлэгтэй сандлыг аваад Трелонигийн сандлын яг ард тавин суув. Тэр өврөөсөө том тэмдэглэлийн дэвтэр гаргаж толгойгоо өргөн эхлэхийг хүлээв.

Профессор Трелони чичирсэн гараараа мөрөн дээрх алчуураа засаад зузаан шилнийхээ цаанаас анги руу харав.

- Өнөөдөр бид зөнтэй зүүдний тухай үргэлжлүүлэн үзнэ. Хос болон хуваагдаж «Зүүдний зөн» номоо нээн хамтрагчынхаа өнгөрсөн шөнийн зүүдийг шинжинэ үү гэж нууцлаг хоолойгоор дуугарахыг хичээсэн ч үл мэдэг чичирлээ.

Тэр суудалдаа буцаж суухыг хүссэн авч ардаа байгаа Амбрижыг хармагц өнгөрсөн шөнийн зүүдний тухай ярилцаж буй Лаванда, Парвати хоёр луу эргэв.

Харри «Зүүдний зөн» номоо нээх зуур Амбриж руу нууцгайхан харав. Тэр тэмдэглэлийн дэвтэрээ нээн хэдийн бичээд эхэлжээ. Хэдэн хормын дараа тэр босож Трелонигийн араас даган сурагчидтай хийх яриаг нь сонсох зуураа үе үе асуулт тавьж байв. Харри яаран ном руугаа тонгойлоо.

- Түргэн зүүднийхээ тухай бод. Хөгшин бах одоохон ирэх гэж байна гэж Ронд хэллээ.

- Би түрүүчийн удаа бодсон шүү дээ. Чиний ээлж гэж Рон эсэргүүцэв.

- Өө, мэдэх юм алга гэж Харри цөхрөн шивнэлээ. Тэр сүүлийн үед зүүдэлсэн ганц ч зүүдээ санасангүй.

- Би Снегг миний тогоонд живж үхэж байна гэж зүүдэлсэн санагдаж байна. Рон писхийтэл инээд алдаад номоо онгойлгов.

- Тэгэхээр чи нас болон зүүднийхээ он сарыг хэлэх хэрэгтэй ... Яг ямар байсан юм? Снегг, тогоо, живэх ...

- Энэ чухал биш. Дуртайгаа бич гэж Харри болгоомжлон харж хэллээ.

Профессор Трелони тэр үед Невиллээс өдрийн тэмдэглэлийн дэвтэртээ бичсэн

зүүдний тухай асууж байсан бөгөөд Амбриж ард нь зогсож байлаа.

- Чамд хэзээ зүүдлэгдсэн юм бэ? гэж Рон асуулаа.

- Мэдэхгүй ... хэрвээ хүсээд байвал ... өнгөрсөн гэж Харри хэлээд Амбрижийн юу хэлхийг сонсохыг хичээв. Одоо Рон тэр хоёрыг профессороос ердөө ганцхан ширээ тусгаарлажээ.

Амбриж тэмдэглэлийн дэвтэртээ ахин юм тэмдэглэхэд Трелони сэтгэлээр унасан байртай харагдав.

- Тийм байж. Та энэ хичээлийг хэр удаан зааж байна?

Профессор Трелони хөмсөг зангидан цээжиндээ гар зөрүүлээд шалгалтыг үл ойшоосон байртай зогслоо. Гэхдээ тэр асуултыг тоохгүй өнгөрч болохгүй нь гэж бодов бололтой таагүйхэн өнгөөр,

- Бараг арван зургаан жил гэв.

- Хангалттай удаан юм байна. Таныг ажилд профессор Дамблдор авсан уу? гэж профессор Амбриж хэлээд дэвтэртээ юм тэмдэглэлээ.

- Тиймээ.

Профессор Амбриж ахин нэг юм бичлээ.

- Таны өвөг эцэг алдарт ирээдүйг харагч Касандра Трелони мөн үү?

- Тиймээ гэж Трелони батлаад үл мэдэгхэн тэгширэн зогслоо. Ахин нэг удаагийн тэмдэглэл бичигдэв.

- Минийхээр бол ... хэрвээ намайг алдсан бол засаарай. Кассандрагын дараа та гэр бүлээсээ ирээдүйг харагч эхний хүнээр тодорсон уу?

- Энэ зүйл ... гурван удам алгасдаг юм. Амбрижийн бах шиг царайд инээмсэглэл тодров.

- Магадгүй л юм. Та надад ямар нэг юм зөгнөн хэлж чадах уу? гээд өмнөхийн адил инээмсэглэсэн хэвээр Трелони руу харлаа.

Тэр чихэндээ итгэлсэнгүй байртай хөшөөд,

- Би таныг ойлгохгүй байна гэхэд туранхай хүзүүндээ зүүсэн алчуур нь татвалзлаа.

- Би танаас зөгнөл хэлэхийг гуйж байна гэж Амбриж тод хэлэв.

Одоо зөвхөн Рон, Харри хоёр тэдний зүг сэм харсангүй. Бараг бүх ангиараа Трелони бөгж бугуйвчаа шаржигнуулан цэхэлж зогсохыг харлаа.

- Билгийн мэлмий тушаал дагахгүй! гэж тэр доромжлогдсон байртай хэлэв.
- Ойлгомжтой гэж профессор Амбриж хэлээд дэвтэртээ юм бичлээ.
- Би ... гэхдээ хүлээгээрэй! Би ямар нэгэн юм харсан шиг санагдаж байна ... таньд хамаатай ... тиймээ ямар нэг зүйл мэдэрсэн ... хар ... томоохон аюул занал гэж хэлэхдээ профессор Трелони бүүдгэр хоолойд уур хилэн илэрлээ.

Профессор Трелони чичирсэн хуруугаараа профессор Амбриж руу заахад хөмсгөө өргөн инээмсэглэв.

- Таньд том аюул заналхийлж байна гэж айж байна! хэмээн профессор Трелони жүжиглэсэн байртай яриагаа дуусгав.

Чимээгүй болов. Профессор Амбриж өмнөхийн адил хөмсгөө өргөн профессор Трелони руу харсан хэвээр байлаа.

- За яахав. Хэрвээ энэ таны хэлж чадах бүх зүйл бол гэж аяархан хэлээд ээлжит ажиглалтаа дэвтэртээ бичив.

Түүнийг цаашаа явахад профессор Трелони цээжээ түхэлзүүлэн шалнаас ургасан мэт үлдэв. Харри Рон руу хараад адил зүйл бодож байгаагаа ойлгов. Тэд хоёулаа профессор Трелониг хөгшин луйварчин гэж мэдэх ч Амбрижад дургүйцсэндээ түүний талд орлоо.

- За? Алив таны зүүдний өдрийн тэмдэглэлийг харцгаая гэж тэр огцом хэлээд урт хуруугаа Харрийн хамрын урд тас няс хийлгэв.

Түүнийг Харрийн зүүдний тухай чангаар тайлбарлаж дуусах үед (түүний будаа идэж байгаад үхэх тухай) түүнийг өрөвдсөн сэтгэл дусал ч үлдсэнгүй. Энэ үед профессор Амбриж хоёр алхамын зайд зогсоод тэмдэглэлийн дэвтэртээ юм бичиж байсан бөгөөд хонх дуугарсны дараа түрүүлж мөнгөн шатаар буулаа.

Арван хормын дараа тэднийг хар урлагаас хамгаалах хичээлд ирэх үед Амбриж хэдийн ангидаа хүлээж байлаа. Тэр амар дотроо юм гүнгэнэснээ инээмсэглэв. Харри, Рон хоёр «Ид шидийн хамгаалах онол» номоо гаргаж тавиад Гермionado (тэр сая шидэт тооны хичээлээс иржээ) Трелонигийн хичээл дээр юу болсон тухай ярив. Гермiona юм тодруулан асуух гэсэн ч профессор Амбриж ангийг чимээгүй болгов.

- Шидэт саваагаа хураацгаа гэж тэр инээмсэглэн тушаахад хүүхдүүд саваагаа цүнхэндээ гунигтайгаар далд хийв.

- Бид өнгөрсөн хичээл дээр эхний бүлгийг дуусгасан. Одоо номныхоо арван есдүгээр хуудсыг нээнэ үү. Хоёрдугаар бүлэг руу орцгооё «Хамгаалах хичээлийн ерөнхий онол болон үүсэл». Яриагаа цэглээрэй.

Тэр сэтгэл хангалуун инээмсэглэн ширээнд суулаа. Сурагчид чангаар санаа алдан номныхоо арван есдүгээр хуудсыг нээлээ. Харри залхуутайхан хичээлийн жилийн эцэс хүртэл бүлгийг уншиж амжина гэж бодоод нээлттэй хуудас руу харахдаа Гермiona ахиад гараа өргөхийг анзаарлаа.

Профессор Амбриж бас үүнийг анзаарсан хэдий ч энэ удаад аргаа өөрчилжээ. Тэр өргөөстэй гарыг хараагүй дүр эсгэхийн оронд эхний эгнээний урдуур яваад Гермiona руу бөхийн бусдад сонсогдохгүйгээр,

- Энэ удаад юу болов, хатагтай Грэйнджер? гэлээ.

- Би хоёрдугаар бүлгийг уншчихсан.

- Тэгвэл гуравдугаар бүлгийг унш.

- Түүнийг ч гэсэн уншчихсан. Би бүх номыг уншчихсан. Профессор Амбриж нүдээ цавчсанаа түргэн сэхээрэв.

- Ийм тохиолдод та надад Слинкхард арван тавдугаар бүлэгт эсрэг шившлэгийн тухай юу дурьдсаныг хэлж өгөхгүй юу.

- Тэр үүнийг тохиромжгүй нэр гэсэн байсан. Тэр хүмүүс өөрсдийнхөө шидийг тааламжтай сонсогдуулахын тулд «эсрэг шившлэг» гэсэн үг хэрэглэдэг гэсэн.

Профессор Амбриж хөмсгөө өргөхөд Харри сэтгэгдэл төрснийг нь ойлголоо.

- Гэхдээ би зөвшөөрөхгүй байна гэж Гермiona үргэлжлүүлэв. Амбрижийн хөмсөг дээшлэх тусам царай нь хүйтрэв.

- Зөвшөөрөхгүй байна гэнээ?

- Тиймээ. Ноён Слинкхард шившлэгт дургүй юм шиг санагдлаа. Гэхдээ би түүнийг ашигтайгаар хамгаалахад хэрэглэж болно гэж бодож байна хэмээн Гермiona Амбрижын адил шивнэсэнгүй бүгдэд сонсогдохоор чанга хэллээ.

- Та тэгж бодож байна уу? Бид энэ ангид ноён Слинкхардын үзэл бодлыг сонирхож байгаагаас биш таныхыг биш гэж айж байна гэж профессор Амбриж

шивнэхээ болиод дээшээ болон хэлэв.

- Гэхдээ ... гэж Гермiona эсэргүүцэхийг хүслээ.
- Хангалттай. Хатагтай Грэйнджер би Гриффиндороос таван оноо хаслаа гээд Амбриж цаашаа эргэн явлаа. Анги даяар чимээ шуугиан болов.
- Юуны төлөө? гэж Харри уурсан асуулаа.
- Үүнд битгий орооцолд! гэж Гермiona шивнэн гуйлаа.
- Ангид утга учиргүй зүйл ярьж хичээлд саад болсны төлөө гэж профессор

Амбриж тайван хэлээд,

- Би энд ид шидийн яамнаас сайшаасан арга барилаар хичээл заахын тулд ирснээс биш сурагчдын хичээлийн талаарх бодлыг сонсох гэж ирээгүй. Танай өмнөх багш нар харваас сахилгын талаар та нарт илүү их чөлөө өгч байсан бололтой. Тэдний нэг болох профессор Квирелл сэдвийг хязгаарлаж байсныг шалгалтын үр дүнд олж тогтоосон.
- Тиймээ, Квирелл гайхамшигтай багш байсан. Зөвхөн нэг жижигхэн сул талтай. Түүний шилэн хүзүүнээс Волдеморт цухуйж байсан юм гэж Харри чанга хэлэв.

Ангид Харрийн хэзээ ч сонсож байгаагүй нам гүм болов. Тэгтэл,

- Би таныг ахин нэг долоо хоног нэмэлт хичээл авбал ашигтай байх гэж бодож байна, ноён Поттер гэж Амбриж хэллээ.

Харрийн зүсэгдсэн гар өглөө ахин эдгэрлээ. Амбрижийнд шийтгүүлэхдээ тэр түүнд сэтгэл ханамж өгөхгүйн тулд гомдоллосонгүй. Түүнийг ахин дахин «би худал хэлэхгүй» гэж бичихэд амнаас нь үг гараагүй хэдий ч шархны үсэг улам гүнзгийрч байлаа.

Хамгийн муу нь гэвэл хоёр долоо хоногийн шийтгэл Жоржын хэлснээр Анжелинагийн өвчнийг хөдөлгөжээ. Тэр мягмар гаригт өглөөний хоолонд ирэхдээ чанга хаширсан болохоор профессор МакГонагалл тэдэн рүү багш нарын ширээнээс гүйж ирэв.

- Хатагтай Жонсон та яаж Их танхимд ийм чимээ шуугиан гаргаж зүрхэлнэ вэ?

Гриффиндороос таван оноо хаслаа!

- Профессор тэр ахиад л хичээлийн дараа үлдэх болж.
 - Юу гэнээ, Поттер гээд МакГонагалл түүн рүү эргэн харлаа.
 - Шийтгэл гэнээ? Хэнээс?
 - Профессор Амбриж гэж Харри хэлээд дөрвөлжин хүрээтэй шилний цаадах нүд рүү харахаас эмээлээ.
 - Алив надад хэлээдэх гэж тэр сониучирхсан Когтевранчуудад сонсуулахгүйн тулд дуугаа намсгаад,
 - Миний өнгөрсөн даваа гаригийн анхааруулыг тоолгүй та ахиад л профессор Амбрижийн хичээл дээр биеэ барьж тэссэнгүй юу? гэв.
 - Тиймээ гэж Харри хэллээ.
 - Поттер, та биеэ брьж сурах ёстой! Та ноцтой асуудалд ороод байна! Гриффиндороос ахин таван оноо хаслаа!
 - Гэхдээ ... яагаад? Профессор! Намайг хэдийн шийтгэсэн байтал та яагаад таван оноо хасч байгаа юм бэ? гэж Харри шударга бус байдалд уурсан хэллээ.
 - Яагаад гэвэл та өөрийнхөө буруугаас болж шийтгэгдсэн. Ямар ч эсэргүүцэл байхгүй, Поттер! Харин хатагтай Жонсон таны хувьд хэрвээ багийн ахлагчаар үлдэх хүсэлтэй бол цэнгэлдэх хүрээлэнд байгаа юм шиг хашгирах хэрэггүй гэдгийг сануулъя.
- Профессор МакГонагалл багш нарын ширээ лүү буцаж явлаа. Анжелина Харриг зэвүүцсэн харцаар шагнаад явахад тэр Роны дэргэд очиж суув.
- Тэр намайг өдөр болгон гараа зүсүүлсний төлөө Гриффиндорыг торголоо! Энэ чинь шударга хэрэг үү?
 - Би мэднэ гэж Рон хэлээд Харригийн тавган дээр утсан мах тавилаа.
- Гермиона «Өдөр тутмын зөнч» сонин гарчиглана.
- Чинийхээр бол МакГонагаллын зөв үү? гэж Харри Корнелиус Фажын хөргөөр нүүрээ хаасан Гермионад ууртай хандав.
 - Надад чамайг торгосон нь харамсалтай байгаа ч тэр чамайг Амбрижтай зөв харьцахыг анхааруулсан гэх Гермионагийн хоолой Фажын араас сонсогдов.

Шившлэгийн хичээл дээр Харри Гермионатай ярьсангүй ч хувиргалын хичээл руу явахдаа гомдлоо мартсан байлаа. Буланд Амбриж тэмдэглэлийн дэвтэртэйгээ сууж харагдахад өглөөний цайны үеэр болсон явдал зурсхийв.

- Сайн байна. Амбриж яаж хариугаа хүртэхийг харъя гэж Рон байраа эзлэхдээ шивнэлээ.

Профессор МакГонагалл ангид шийдэмгий алхлан орж ирэхдээ Амбрижийг анзаарсангүй.

- Юу хийх вэ гэвэл. Ноён Финниган та энэ гэрийн даалгаварыг буцааж тараа.

Хатагтай Браун энэ хайрцагтай хулганыг ав ... тэнэг байх хэрэггүй дээ тэд таныг хазахгүй ... хүн бүрт тараагаарай ...

- Кхэ, кхэ.

Тийм тэнэг ханиалтаар профессор Амбриж хичээлийн анхны өдөр Дамблдор үг хэлж байхад эвдсэн билээ. Профессор МакГонагалл түүнийг сонссонгүй. Симус Харрийн зохион бичлэгийг буцаан өглөө. Харри түүнийг аваад «Х» тавьсан байхыг сэтгэл амран харлаа.

- Ингээд анхаарцгаана уу бүгд сонсоцгоо. Дин Томас хэрвээ та хулганатай ахин ингэж харьцах юм бол хичээлийн дараа үлдээнэ шүү ... Та нарын ихэнхи чинь эмгэн хумсыг амжилттайгаар алга болгосон болохоор зарчмын ялгааг нь ажигласан байх. Бид өнөөдөр ...

- Кхэ, кхэ ...

- За? гээд профессор МакГонагалл хөмсгөө өргөн эргэж харлаа.

- Би, профессор таныг миний шалгалтын өдөр цагтай зурвасыг авсан эсэхийг мэдэх гэсэн юм ...

- Мэдээж авсан эсрэг тохиолдолд бол би таныг миний хичээл дээр юу хийж байгааг асуух байлаа гэж профессор МакГонагалл хэлээд шийдэмгий эргэлээ. Сурагчид баясан бие бие рүүгээ харцгаав.

- Давтаж хэлэхэд бид өнөөдөр илүү хүнд хулгана алга болгох дасгал хийх болно. Алга болгох шившлэг ...

- Кхэ, кхэ ...

- Сонирхолтой юм ... гээд МакГонагалл уурсан профессор Амбриж руу эргэлээ.

- Та миний багшлах арга барилтай танилцахыг хүсч байгаа бол хором бүр намайг таслан зогсоохоо болино уу. Намайг хичээл дээрээ өөрөө ярьдагыг минь харж байгаа биз дээ.

Профессор Амбриж нүүр лүүгээ алгадуулсан юм шиг болов. Тэгснээ чимээгүй болж ууртайгаар тэмдэглэлийн дэвтэртээ юм бичлээ.

МакГонагалл түүнийг үл тоомсорлон анги руугаа эргэв.

- Алга болох шившлэг хэцүү бөгөөд амьтан дээр бол бүр хэцүү гэдгийг би хэлсэн. Эмгэн хумс бол сээр нуруугүй амьтан бөгөөд тийм ч хэцүү байгаагүй. Хулгана бол сүүн тэжээлтэн учир түүнтэй ажиллахад хамаагүй хэцүү. Иймээс ид шид гэдэг бол та нарын оройн хоол мөрөөдөхтэй адилгүй юм. Бид одоо шившлэгээ мэдэх болохоор юу хийж чадахаа харцгаая.

- Тэр надад яаж Амбрижыг яаж тоохгүй байх талаар хичээл үзүүлж байх шив! гэж Харри Ронд шивнэн инээмсэглээд МакГонагаллд уурласан уур нь гарчээ.

Профессор Амбриж профессор МакГонагаллын хичээл дээр Трелонигийн адил холхисонгүй. Үүнийг МакГонагалл тэвчихгүй гэдийг ойлгосон бололтой. Гэхдээ буланд суугаад илүү их бичиж байсан бөгөөд МакГонагаллыг анги дотуур явах үед баргар харцаар дагуулан харж байв.

- Энэ бол зөвхөн эхлэл гэж Рон хэлээд хулганы урт сүүлийг хайрцагт буцааж хийн Лавандад өгөв.

Сурагчид ангиас гарахад Харри Амбриж багш нарын ширээ рүү очихыг хараад Роныг нудран юу хэлэхийг нь сонсохоор үлдэв.

- Та Хогвартст хэр удаан багшилж байна? гэж профессор Амбриж асуулаа.

- Арван хоёр сард гучин есөн жил болно гэж МакГонагалл бүдүүлгээр хэлээд цүнхээ тас хийтэл хаав.

Амбриж дэвтэртээ юм бичлээ.

- Маш сайн байна. Шалгалтын үр дүнг таньд арван өдрийн дараа мэдэгдэх болно.

- Тэсэн ядан хүлээе гэж МакГонагалл хүйтнээр хайхрамжгүй хэлээд хаалга руу явахдаа,

- Та гурав яарах хэрэгтэй шүү гэж хэлээд Харри, Гермiona, Рон нарыг урдаа гаргав.

Харри инээдээ барьж арайхийн тэслээ.

Тэр Амбрижыг хичээлийн дараа шийтгүүлэхдээ харна гэж бодсон ч алджээ. Тэднийг нуга дээгүүр шидэт амьтдын хичээл рүү явахад профессор Граббли Дерг төдийгүй Амбриж тэмдэглэлийн дэвтэртэйгээ хүлээж байлаа.

- Та ер нь энэ ангид хичээл заадаггүй юмаа даа? гэх түүний асуултыг Харри урт ширээ рүү очих үедээ сонсов. Ширээн дээр мөчиртэй адилхан хэдэн лукотрус байлаа.

- Яг тийм гэж профессор Граббли Дерг хэлээд гараа ардаа барилаа.

- Би профессор Хагридыг орлож байгаа юм.

Харри Рон, Гермiona хоёр луу түгшин харлаа. Малфой Крэбб, Гойл хоёртой юм шивнэлдэв.

- Хмм ... гээд Амбриж дуугаа намсгасан хэдий ч Харрид сайн сонсогдож байв.

- Сонирхолтой юм ... захирал надад шалтгааныг нь тайлбарлахгүй байгаа л даа.

Харин та надад профессор Хагрид хаачсаныг хэлж чадахгүй биз? Харри Малфой бас чих тавихыг харлаа.

- Чадахгүй нь гэж айж байна. Би энэ талаар танаас илүү зүйл мэдэхгүй.

Дамблдор над руу ууль илгээгээд нэг хоёр долоо хоног ажиллахгүй юу гэсэн юм. Би зөвшөөрсөн. Энэ бол миний мэдэх бүх зүйл. Тэгэхээр эхэлцгээх үү?

- Тэгэлгүй яахав гэж профессор Амбриж хэлээд тэмдэглэлийн дэвтэртээ юм бичив.

Амбриж энд өөр арга сонгон авч сурагчдын дудуур холхин шидэт амьтдын тухай асуулт тавьж байлаа. Ихэнхи хэсэг нь сайн хариулахад Харрийн сэтгэл санаа арай дээрдэв.

- Ерөнхийдөө та түр зуур багшилж байгаа болохоор Хогвартсад ямар байна даа? Сургуулийн удирдлагаас туслалцаа үзүүлж байна уу? гэж Амбриж хэлээд профессор Граббли Дерг рүү эргэж харлаа.

- Өө тэгэлгүй яахав, Дамблдор аугаа хүн. Надад энд ажиллах нь их таалагддаг юм гэж Граббли Дерг хэлэв.

Амбрижийн эелдэг царайд үл итгэсэн байдал тодорч тэмдэглэлийн дэвтэртээ юм тэмдэглэв.

- Ингэхэд та энэ жил профессор Хагрид эргэж ирэхгүй бол багшилсаар байхыг төлөвлөж байна уу?

- Би тэдэнд С.И.Ш. дээр ирдэг амьтад дээр ажиллахыг үзүүлж байгаа. Тийм ч олон зүйл үлдээгүй. Тэд хэдийн ганц эвэрт болон нюхлерийг судалчихсан. Бид глиноклокам болон жмырами судалчихвал ч.

- Та харваас өөрийн ажлаа сайн мэддэг бололтой гэж Амбриж хэлээд дэвтэртээ ажиглагдам тэмдэглэгээ тавилаа.

Харрид түүний «та» гэж цохон хэлсэн явдал болон Гойлоос асуусан асуулт таалагдсангүй.

- Би энэ ангид сурагч шархдаж байсан гэж сонслоо.

Гойл тэнэгдүүхэн инээмсэглэв. Хажуунаас нь Малфой хариулахаар яарлаа.

- Тэр чинь би байсан юм. Намайг гиппогриф дайрсан юм.

- Гиппогриф гэнээ? гэж профессор Амбриж давтаад ажил хэрэгчээр бичлээ.

- Яагаад гэвэл тэр тэнэг болохоороо Хагридын хэлсэн үгийг сонсоогүй юм гэж

Харри уурсан хэллээ.

Рон, Гермиона хоёр ёолов. Амбриж удаанаар Харри руу эргэлээ.

- Ахин нэг удаа хичээлийн дараа үлдээрэй. За их баярлалаа, профессор Граббли Дерг надад бүх зүйл тодорхой боллоо гэж бодож байна. Таньд шалгалтын үр дүнг арван хоногийн дараа мэдэгдэх болно.

- Маш сайн байна гэж Граббли Дерг хэлэхэд Амбриж нуга дээгүүр шилтгээн рүү явлаа.

Харри Амбрижын өрөөнөөс шөнө дундын орчимд гарав. Зүсэгдсэн гараас нь цус гоожиж байсан болохоор алчуураар боолоо. Тэр амралтын өрөө хоосон гэж бодсон ч Рон, Гермиона хоёр хүлээж байв. Тэр Гермиона шүүмжлэхээсээ илүү дэмжсэн шинжтэй байсанд баярлав.

- Гараа ийшээ дэвтээ. Энэ бол муртлафын даршилсан тэмтрүүл байгаа юм. Тус болох болно гэж тэр сэтгэл зовон хэлээд шар шингэнтэй таваг руу заалаа.

Харри янгинан өвдөж байгаа цустай гараа тавган дээр тавиад өвчин намжихыг мэдэрлээ. Живоглот чанга хүржигнээд өвдөг дээр нь үсрэн гарав.

- Баярлалаа гэж Харри хэлээд зүүн гараараа муурын чихийг маажив.
- Чи энэ тухай хэлэх ёстой гэж Рон аяархан хэлэв.
- Үгүй гэж Харри эсэргүүцлээ.
- Хэрвээ МакГонагалл мэдэх юм бол дэлбэрэх байх даа.
- Тэгэх л байх. Чи Амбриж ерөнхий байцаагч хүссэн хүнээ хөөх шинэ хууль гаргана гэж бодохгүй байна уу?

Рон амаа нээсэн ч хэлэх үгээ ололгүй хаалаа.

- Тэр аймшигтай эмэгтэй. Аймшигтай. Би чамайг сая ирэхээс өмнө Ронд энэ тухай ярьж байлаа. Бид түүний тухайд ямар нэг юм хийх хэрэгтэй гэж Гермiona аяархан хэлэв.
- Би хор санал болгосон гэж Рон баргар дуугарлаа.
- Үгүй ээ ... бид тэрэн шиг новшийн багшаас хамгаалах талаар суралцахгүй.
- Бид юу хийж чадах юм бэ? Аль хэдийн оройтсон байгаа биз дээ. Тэр хэдийн байраа эзэлсэн болохоор зайлуулах боломжгүй. Фаж үүнийг зөвшөөрөхгүй гээд Рон эвшээлээ.
- Миний өнөөдөр юу бодсоныг мэдэж байна уу. Би өөрсдөө хичээллэж болох юм гэж бодлоо гээд Гермiona Харри руу болгоомжлон харав.
- Юугаар хичээллэх гэж? хэмээн Харри сэжигтэй асуугаад гараа шингэнд үргэлжлүүлэн дүрэв.
- Өөрсдийгөө хар урлагаас хамгаалахад суралцах гэж Гермiona хэлэв.
- Боль доо. Бидэнд нэмэлт ажил дутаад байна гэж дээ. Харри бид хоёр, хоёр дахь долоо хоногтоо хичнээн их гэрийн даалгавартай байгааг чи мэдэж байна уу?
- Гэхдээ энэ гэрийн даалгавараас илүү чухал биз дээ! гэж Гермiona хэлэв. Харри, Рон хоёр түүн рүү нүдээ бүлгийлгэн харлаа.
- Харин би дэлхий дээр түүнээс чухал зүйлгүй гэж бодож байна! хэмээн Рон хэлэв.
- Тэнэг юм. Байлгүй яахав гэж Гермiona хэлэхэд Харри түүний царай

үйлчлэгчийг чөлөөлөх тухай ярьдаг үеийнх шигээ эрч хүчтэй болохыг хараад айлаа.

- Харри Амбрижийн эхний хичээл дээр зөв хэлсэн. Бид сургуулийн хананаас гадуур хүлээж байгаа зүйлд бэлтгэгдэх ёстой. Бид өөрсдийгөө хамгаалж чаддаг байх ёстой. Хэрвээ бид энэ жил юу ч суралцахгүй бол ...

- Бид тийм олон зүйлийг хийж чадна гэж үү? хэмээн Рон ялагдсан байртай хэлээд,

- За яахав номын сан руу явж шившлэг харж хичээлэх үү? гэлээ.

- Үгүй ээ, бид номноос гадуурх үе шатыг суралцах хэрэгтэй. Бидэнд шившлэгийг яаж ашиглахыг заадаг жинхэнэ багш хэрэгтэй.

- Хэрвээ та нар Люпины тухай ярьж байгаа бол ... гэж Харри хэлэв.

- Үгүй ээ, үгүй Люпины тухай биш. Тэр бүлгийн ажилтай завгүй байгаа болохоор бид зөвхөн Хогсмидын амралтын өдрүүдээс ондоо үед уулзаж чадахгүй.

- Тэгвэл хэн гэж? хэмээн Харри хөмсөг зангидан хэллээ. Гермиона гүнзгий санаа алдлаа.

- Тодорхой биш байна уу? Би чиний тухай ярьж байна, Харри.

Нам гүм болов. Шөнийн сэвшээ салхи цонх таржигнуулахад галын дөл дүрсхийлээ.

- Миний тухай гэнээ?

- Чи биднийг хар урлагаас хамгаалахад сургах болно.

Харри түүн рүү харлаа. Дараа нь Рон руу эргэн Гермионагийн гэрийн үйлчлэгчийн тухай ярьдаг үеийнх шиг ууртай харц хүлээсэн авч байсангүй.

Рон хөмсөг зангидан санааширав. Дараа нь,

- Энэ бол зөвхөн санаа л даа гэв.

- Ямар санаа? гэж Харри асуулаа.

- Чи биднийг сургах.

- Гэхдээ ...

Харри тэднийг тоглож байна гэж бодоод инээмсэглэв.

- Би багш биш. Би чадахгүй ...

- Харри чи энэ жил хар урлагаас хамгаалах хичээлд шилдэг нь болоо биз дээ

гэж Гермiona хэлэв.

- Би юу? Үгүй дээ, би биш. Чи намайг бүх сорилтонд сайн байсан гэх гээ юу гээд түүний инээмсэглэл улам ихэслээ.

- Үгүй ээ, тийм биш. Гуравдугаар дамжаанд чи шилдэг нь байсан. Энэ бол анхны жинхэнэ сорилт, хичээлээ мэддэг анхны багш байсан. Гэхдээ би хичээлийн тухай яриагүй. Чи юу хийсэн тухайгаа сана даа!

- Би юу хийсэн гэж?

- Би ийм тэнэг багштай болно гэдэгтээ итгэлгүй байна гэж Рон егөөдөнгүй инээмсэглээд,

- Алив бодоод үзье. Анхны жил чи Хэцүү нэртээс гүн ухааны чулууг аварсан гэв.

- Зүгээр л аз байсан юм гэж Харри хэлэв.

- Хоёр дахь жилдээ чи василискыг алж Реддлийг устгасан.

- Тиймээ, гэхдээ Фоукс ирээгүй бол ...

- Гурав дахь жилдээ чи зуугаад Дементорыг эсэргүүцсэн гэж Рон дуугаа өндөрсгөв.

- Жинхэнэ цэвэр тохиолдол байсан гэдгийг чи мэднэ шүү дээ. Хэрвээ цаг хугацааны эрчлүүр байгаагүй бол ...

- Харин өнгөрсөн жилийн хувьд чи ахин Хэцүү нэртэй нүүр тулгарсан гэж Рон бараг хашгирлаа.

- Намайг сонс! гээд Харри тэдний инээмсэглэлд уурлаж эхлэв.

- Зүгээр л сонсоцгоо, ойлгов уу? Энэ бүхэн маш сайхан сонсогдож байгаа хэдий ч надад ердөө аз таарсан юм. Би зарим үед өөрөө юу хийж байгаагаа ч ойлгоогүй, юу ч төлөвлөөгүй, бараг үргэлж туслалцаа авч байсан.

Рон, Гермiona хоёрыг урьдын адил инээмсэглэх тусам Харри уурлах нь улам ихсэж яагаад уурлаад байгаагаа өөрөө ч ойлгосонгүй.

- Та нар юу мэддэгтээ инээгээд байгаа юм? Би тэнд байсан ойлгож байна уу?

Учир нь гэвэл би хар урлагаас хамгаалах хичээлд сайндаа ч биш яагаад гэвэл

... яагаад гэвэл тусламж цаг үргэлж ирэх юмуу эсвэл тааж ... бүгдийг таамгаар хийж

байсан юм ... Инээхээ больцгоо!

Шингэнтэй таваг шалан дээр унаад хагарахад Харри сая л боссоноо анзаарлаа. Живоглот буйдан доогуур оров. Найзууд нь инээмсэглэхээ болилоо.

- Энэ юу гэдгийг та нар мэдэхгүй байна! Та нар хэзээ ч түүнтэй нүүр тулж байгаагүй. Зөвхөн хичээл дээр хэдэн шившлэг тогтооход болно гэж бодож байна уу? Чи үргэлж эргэн тойронд үхэл ... чиний тархи эсвэл зүрх зориг өөр юу ч байсан ... Эсвэл найзууд чинь нүдэн дээр үхэхэд ... Хэн ч та нарыг үүнд сургаж, тайлбарлаагүй. Та хоёр энд намайг ухаантай хүү болохоороо үлдэж харин Диггори тэнэг болохороо тэгээгүй юм шиг сууж байна ... Та нар ойлгохгүй байна ... энэ бол хэрвээ Волдемортод хэрэггүй байсан бол.

- Бид тийм зүйл ерөөсөө яриагүй. Диггориг хэн ч буруутгаагүй чи буруу ярьж байна гэж Рон эмээнгүй хэлээд гайхсан Гермiona руу тусламж эрэн харлаа.

- Харри чи үнэхээр ойлгохгүй байна гэж үү? Ийм л учраас бид чамаас гуйж байгаа юм. Бид Волдеморттой нүүр тулгарах ямар байдгийг мэдэхийг хүсч байна гэж тэр айсан байртай хэлэв.

Түүнийг Волдемортын нэрийг дурсмагц Харри тайвширлаа. Тэр хүндээр амьсаадан сандал дээрээ суухад гар нь ахиад янгинан өвдлөө. Тэр шингэнтэй тавгийг хагалсандаа харамслаа.

- Энэ тухай бодоорой. За юу? гэж Гермiona аяархан хэлэв.

Харри юу хэлэхээ мэдсэнгүй. Түүнд ичгүүртэй байв. Тэр толгой дохихдоо зөвшөөрсөн гэдгээ муухан ойлгов.

Гермiona босч зогсоод,

- Би явж унтлаа гэв. Рон ч гэсэн босоод,

- Явах уу? гэж Харрид итгэлгүйхэн хандав.

- Тиймээ ... нэг хором л болно. Одоохон цэвэрлээдхэе. Харри хагарсан таваг руу заалаа. Рон толгой дохиод явчихлаа.

- Репаро гэж Харри шидэт савагаа хагархай руу чиглүүлэв. Тэд нэгдэн хагараагүй юм шиг шинэ болсон ч шингэнийг хэрэглэх боломжгүй болжээ.

Тэр гэнэт ядарснаа мэдрэн сандал дээр суухыг хүссэн ч хүчлэн Роны араас дээш өгсөв. Шөнө ахиад л урт хонгил цоожтой хаалганы тухай тайван бус түгшүүртэй зүүд зүүдэлсэн бөгөөд өглөө сорви нь хатгуулахад сэрлээ.

БҮЛЭГ 16: ГАХАЙН ТОЛГОЙНД

Гермиона хоёр долоо хоног Харри тэднийг хар урлагаас хамгаалахад сургах ёстой гэж ярьсангүй. Амбрижийн шийтгэл дуусах үед тэр гаран дээр нь бичигдсэн үг хэзээ нэгэн цагт арилах болов уу гэж харамсжээ. Рон ахин дөрвөн удаа бэлтгэлд оролцсон ч сүүлчийн хоёр дээр нь хашгирах явдал гаргуулсангүй. Тэд хувиргалын хичээл дээр хулгана алга болгож (Гермиона бүр муур ч алга болгож байлаа) сурав. Ширүүн салхитай есөн сарын сүүлчийн өдөр гурвуулаа номын санд суугаад Снеггийн уусамлын хичээлийн орцыг судалж байлаа.

- Сонсооч Харри чи хар урлагаас хамгаалах талаар бодов уу? гэж Гермиона гэнэт хэлэв.

- Мэдээж бодсон. Биднийг энэ шулмас сургаж байхад яаж бодохгүй байж болох юм.

- Үгүй ээ, Рон бид хоёрын чамд ярьсан зүйлийн тухай гэхэд Рон түүн рүү уцаарласан байртай харлаа. Тэр хариуд нь хөмсгөө зангидав.

- За яахав, би чамаас биднийг сургахыг гуйсан даа.

Харри хариу хэлэхдээ удааширан «Азийн хорны эсрэг уусмал» номын хуудсыг анхааралтай уншиж байгаа дүр үзүүлэнгээ юу хэлэх тухайгаа бодлоо.

Тэр өнгөрсөн хоёр долоо хоногийн турш энэ тухай багагүй бодсон байв. Гермиона энэ тухай ярьсан ярьсан үдшээс л түүнд ухаангүй юм шиг санагджээ. Гэхдээ заримдаа өөр хоорондоо ялгаатай дайснууд болох хар шидийн амьтад болон Үхэл залгигчидтай тэмцэхэд туслах шившлэгийн тухай бодоод дотроо хичээлийн төлөвлөгөө гаргаж байв ...

- Тиймээ гэж тэр эцэст нь хэлээд,

- Бага зэрэг бодсон гэв.

- Тэгээд яасан? гэж Гермиона тэсч ядан асуулаа.

- Мэдэхгүй гэж Харри хэлээд Рон руу харлаа.

- Надад энэ бодол анхнаасаа таалагдсан гэж Рон Харриг ахин хашгирах эсэхийг магадлаад ярианд дургүйхэн оролцов.

Харри сандал дээрээ хавчганалаа.

- Та нар миний олонхид нь аз тохиосон гэж хэлэхийг сонссон биз дээ?
- Тиймээ, Харри. Гэхдээ чи хар урлагаас хамгаалахыг эзэмшсэн гэдгээ эсэргүүцэж чадахгүй биз дээ. Өнгөрсөн жил чи ганцаараа Имперуус шившлэгийг эсэргүүцэж насанд хүрсэн шидтэний чадахгүй Патронусыг дуудаж байсан. Виктор үргэлж хэлэхдээ ...

Рон түүн рүү хүзүүгээ хугалах шахам эргэж харав. Тэр шилэн хүзүүгээ үрлээ.

- Тэгээд? Вики юу хэлсэн гэж?
- Ха ха гэж Гермiona уйтгартайгаар инээгээд,
- Тэр Харри түүний чадахгүй зүйлийг хийдэг гэсэн. Гэтэл тэр Дурмстрангийн төгсөх дамжаанд байсан шүү дээ.

Рон түүн рүү сэжигтэй харлаа.

- Чи түүнтэй одоо хүртэл холбоотой байгаа юм уу?
- Тэгээд юу гэж? Захидлаар харилцаж болно биз дээ гэж Гермiona хүйтнээр хэлэхэд царай нь улайлаа.
- Тэр чамтай зөвхөн захидлын найз биш гэж Рон зэмлэнгүй дуугарав.

Гермiona уурсангүй толгойгоо сэгсрээд Ронд анхаарал хандуулахаа больж Харри руу харлаа.

- Тэгээд юу гэж бодож байна? Биднийг сургах уу?
- Зөвхөн Рон та хоёрт уу?
- Юу гэвэл ... чи битгий уурлаарай, Харри ... би чамайг сурахыг хүсч байгаа бүх хүнийг сургах ёстой гэж бодсон. Бид В ... Волдемортоос өөрсдийгөө хамгаалж сурахыг хүсч байна. Өө Рон, битгий инээдтэй царайлаад бай. Хэрвээ бид бусаддаа тийм боломж өгөхгүй бол шударга бус хэрэг болно.

Харри хормын турш бодлогоширлоо.

- Сайн байна гэхдээ би та хоёроос бусад нь суралцахыг хүсч байгаа гэж бодохгүй байна. Би галзуурсан биз дээ, санаж байна уу?
- Хичнээн хүүхэд чамайг сонсоход бэлэн байгааг мэдээд чи гайхах байх даа гээд тэр Харри, Рон хоёр луу бөхийгөөд,
- Хэрвээ анхны уулзалтаа арван сарын эхний долоо хоногийн амралтын өдөр

Хогсмид явахдаа зохиоё гэвэл ямар байна? гэлээ.

- Яагаад сургуульд биш гэж? хэмээн Рон асуулаа.

- Яагаад гэвэл Амбриж бидний юу бодож байгаа мэдэх юм бол баярлана гэж бодохгүй байна гэж Гермиона номноос хятад байцааны зураг хуулах зуураа хэллээ.

Харри Хогсмид явах өдрөө тэсэн ядан хүлээж байсан ч яагаад ч юм сэтгэл нь түгшиж байлаа. Есөн сарын эхэнд Сириус ханан зууханд үзэгдэх үеэр ч сэтгэл санаа нь ийм байсангүй. Харри түүнийг эрсдэлд орохгүй байхыг гуйснаараа уурлуулснаа мэдэж байсан ч Сириусыг болгоомжтой байхыг үл тоомсорлох вий гэж айж байлаа. Хэрвээ том хар нохой тэдэнтэй Хогсмидэд гүйж байгаад Драко Малфойн нүдэнд өртвөл яах вэ?

- Чи түүнийг үүнийг төлөө буруутгаж болохгүй гэж Харриг тэдэнд айдсынхаа талаар ярихад Рон хэлээд,

- Тэр хоёр жилийн турш зугтаж байгаа болохоор чөлөөлөгдөхийг хүсэх нь зөв биз дээ. Харин одоо тэгтэл аймшигтай үйлчлэгтэй хамт цоожтой сууж байдаг гэв.

Гермиона түүн рүү муухай харлаа.

- Хамаг гай үүнд л байгаа юм Вол ... Волдеморт тайвшир даа Рон. Сириус нуугдах ёстой биз дээ? Дамблдор үнэнийг хэлсэн ч гэлээ тэнэг яамныхан Сириусыг буруугүй гэдийг ойлгохгүй байгаа. Одоо энэ тэнэгүүд жинхэнэ Үхэл залгигчдыг барьж эхлэлмэгц Сириус тэдний тал биш гэдэг нь ойлгомжтой болно. Нэгдүгээрт гэвэл түүнд тамга байхгүй ... гэж Харри хэлэв.

- Сириус ахиад ирэхээр тэнэг гэж бодож байна уу. Дамблдор түүний үгийг сонсоогүй явдалд маш их уурласан даа.

Гэвч Харри өмнөхийн адил санаа зовсон хэвэр байсанд Гермиона сатааруулахыг оролдон,

- Сонсооч, Рон бид хоёр хүүхдүүдийг хар урлагаас жинхэнэ хамгаалж сурахыг хүсч байна уу гэхэд хүүхдүүд их сонирхож байсан шүү. Бид тэдэнтэй Хогсмидэд уулзахаар тохирсон гэв гэв.

- Сайн байна гэж Харри хэлээд Сириусын тухай бодсоор байлаа.

- Санаа зовох хэрэггүй дээ, Харри. Чамд Сириусгүй хангалттай их ажил байгаа.

Түүний зөв байлаа. Тэр орой болгон Амбрижийнд шийтгэлийн үдшийг өнгөрүүлээд

гэрийн даалгавараа арай ядан амжин хийж байсан бөгөөд илүү дээр болж байлаа. Рон ч гэсэн долоо хоногт хоёр удаа квиддичийн бэлтгэл хийгээд бусад үед нь ахлагчын үүрэгт ажлаа гүйцэтгэх ёстой учир бас хоцорч байв. Гермiona тэдэн шиг зөвхөн гэрийн даалгавраа хийх биш нэмэлт хичээл судлан чөлөөт цагаараа гэрийн үйлчлэгчийн хувцас амжин нэхэх аж. Түүний нэхмэл дээрдэж оймс малгай нь ялгагдан харагдах болжээ.

Хогсмид явах өглөө цэлмэг хэдий ч салхитай байлаа. Тэд өглөөний цайны дараа эцэг эхийн зөвшөөрөл шалгаж байсан Филчийн дэргэд дугаарлан зогсов. Хэрвээ Сириус байгаагүй бол тийшээ явахгүй байсан даа гэж Харри гэмшингүй бодов.

Түүнийг Филч руу очих үед ямар нэг зүйл үнэрлэх гэсэн мэт хамраараа хүчтэй шиншлээ. Дараа нь хацраа чичрүүлэн толгой дохиод Харри чулуун шатаар гарч нарны гэрэлд гарлаа.

- Филч чамаас юу шиншлээд байгаа юм? гэж Рон хашааны хаалга руу явахдаа асуулаа.

- Шивхэн бөмбөг шалгаж байгаа юм. Би чамд хэлэхээ мартчихаж гэж Харри инээмсэглэв.

Тэр Сириуст захиа илгээгээд хором болсны дараа Филч ирээд захиагаа үзүүлэхийг шаардсан тухай хэлэв. Түүний гайхлыг төрүүлэн Гермiona болсон явдлыг маш их сонирхлоо.

- Түүнд чамайг хэн шивхэн бөмбөг захиалсан гэж хэлдэг байна?

- Мэдэхгүй. Магадгүй Малфой л даажигнахаар шийдсэн байх гээд Харри мөрөө хавчив.

Тэд далавчтай гахай бүхий өндөр чулуун баганы дундуур гараад зүүн тийш эргэн тосгон орох замаар явахад салхи үсийг нь хийсгэн нүүр лүү нь шавхуурдаж байлаа.

- Малфой гэнээ? Харин л дээ гэж Гермiona эргэлзэнгүй хэлэв. Тэр тосгоны зах хүртэл бодлогоширон явлаа.

- Хаашаа явах уу? «Гурван шүүр» рүү юу? гэж Харри асуулаа.

- Үгүй дээ. Тэнд үргэлж дүүрэн хүн чимээ шуугиантай байдаг. Би бусаддаа «Гахайн толгой»-д уулзая гээд хэлчихсэн. Төв гудамжинд байдаагүй өөр шар айрагны мухлаг байгаа юм. Минийхээр бол сурагчид нэг их очоод байдаггүй газар.

Тэд төв гудамжинд гарч шидэт тоглоомын дэлгүүр «Зонко»-г өнгөрөхдөө Фред, Жорж, Ли Жордан нар байхыг харлаа. Цаашаа шуудангийн дэргэдүүр өнгөрч булан тойроод жижигхэн дэн буудал руу очлоо. Хаалган дээр зэвэнд идэгдсэн төмөр хаяг байх агаад гахайн толгойноос цагаан бүтээлэг дээр цус дусалж байгаа зураг дүрсэлжээ. Хаяг салхинд чахран хөдлөнө. Гурвуулаа хаалганы өмнө тээнэгэлзэн зогсов.

- Орох уу? гэж Гермiona сэтгэл түгшин хэллээ. Харри түрүүлж оров.

Дотор «Гурван шүүр»-ийнх шиг дулаахан цэвэрхэн байсангүй. «Гахайн толгой» уушийн газар жижигхэн бохир харанхуй өрөөтэй бөгөөд ямар нэг юмны үнэр хүчтэй ханхлах нь ямааных бололтой. Цонхны шил нь тортоглон бохирдож лааны гэрэлд бүдүүлэг хийцийн модон ширээнүүд харагдана. Шалан дээр шууд газар харагдах шиг санагдсан ч Харри он удаан жил хуримтлагдсан хир буртаг болохыг ойлгов.

Харри Хогвартсад сурсан эхний жил Хагрид энд юүдэнтэй хувцастай үл таних хүнээс лууны өндөг хожсон гэж ярьсаныг саналаа. «Гахайн толгой»-д олон янзын гайхамшигтай хүмүүстэй учирч болно гэж тэр хэлж байсан. Харри Хагридыг юүдэнтэй үл таних хүнтэй ярилцсан явдалд гайхаж байсан ч нүүрээ нуух бол эндхийн нэг хэв загвар болохыг ойлгов. Толгойгоо бүхэлд нь бохир саарал боолтоор ороож амны нүх гаргасан хүн шилэн аягатай уугьсан шингэн балгаж байв. Цонхны дэргэд Дементорыг санагдуулсан хоёр юүдэнтэй хүн суугаад йоркшийн хатуу аялгаар ярилцана. Ханан зуухны хажуу дахь харанхуй буланд хөлөөсөө толгой хүртлээ хар гивлүүртэй шидтэн сууж байсан бөгөөд зөвхөн хамрын үзүүр нь цухуйж байлаа.

- Мэдэхгүй юм Гермiona. Чиний толгойд Амбриж гивлүүр дор нуугдаж байгаа юм шиг санагдахгүй байна уу? гэж Харри лангууны дэргэд очоод бувтналаа.

Гермiona түүнийг шинжин харлаа.

- Амбриж илүү намхан биетэй. Хэдийгээр тэр ийшээ ирсэн ч гэлээ бидэнд саад болж чадахгүй. Би хоёр гурван удаа сургуулийн дүрмийг шалгасан. Бид юу ч зөрчөөгүй. Профессор Флитвикээс сурагчид «Гахайн толгой»-д байж болох уу гэж асуухад тийм гээд өөрийнхөө уудаг юмыг зөвлөсөн. Би хүмүүст гэрийн даалгавараа хийхээр цугласан бүлэг хүүхдүүд шиг харагдах байх гэж бодож байна. Би үүнийг сайхан санаа гэж бодохгүй байгаа ч нүд хуурахын тулд ингэсэн нь дээр байх.

- За яахав гэхдээ чи арай бүлгээрээ гэрийн даалгавар хийх гэж төлөвлөөгүй биз

дээ? гэж Харри хэлэв.

Арын өрөөнөөс баарны үйлчлэгч гарч ирлээ. Тэр өндөр туранхай биетэй урт буурал үс сахалтай бөгөөд Харрид үл мэдэг танил санагдав.

- За? гэж тэр бувтналаа.

- Гурван цөцгийн шар айраг гэж Гермiona хэлэв.

Үйлчлэгч лангуун дороос бохир тоостой лонхнууд гаргаж ирээд лангуун дээр тасхийтэл тавилаа.

- Зургаан сикль.

- Би төлчихье гэж Харри түргэн хэлээд мөнгөө өглөө.

Үйлчлэгч түүний сорви руу харав. Дараа нь хөгшин мөнгийг өөрөө онгойдог хуучин мөнгөний кассанд хийлээ. Харри, Рон, Гермiona гурав хамгийн булангийн ширээнд очиж суугаад ийш тийшээ харав. Боолттой хүн хуруугаараа лангуу бөмбөрдөн ээлжит уугьсан ундаагаа авлаа.

- Юу гэдгийг нь мэдэх үү? Бид энд хүссэн бүгдээ захиалж болно. Хөгшинд бид юу авах нь хамаагүй. Би үргэлж галт шарз уухыг хүсдэг байлаа гэж Рон баарыг хөөрсөн харцаар харж хэллээ.

- Чи чинь ахлагч шүү дээ! гэж Гермiona эгдүүцэв.

- Аан тийм л дээ гээд түүний инээмсэглэл бөхөв.

- Тэгэхээр бидэнтэй уулзахаар хэн ирнэ гэсэн бэ? гээд Харри зэвтэй бөглөөг онгойлгон шар айрагнаас балгав.

- Хоёр гурван хүн гээд Гермiona цагаа хяламхийснээ үүд рүү сэтгэл зовсон янзтай харангаа,

- Би тэднийг энд ирэхийг хүссэн. Эндхийг тэд мэднэ ... Өө, хараач тэд ирж байх шиг байна гэв.

Хаалга нээгдэв. Хаалгаар туссан нарны цацрагт өрөөний тоос бужигнан бүлэг хүмүүс орж ирлээ.

Невилл, Дин, Лаванда нар орж ирэхэд араас нь Парвати, Падма Патил болон Чжоу үргэлж инээж байдаг найз охинтойгоо (Харрийн зүрх ёгхийв), мөрөөдөнгүй харцтай Полумна Лавгуд, Кэти Белл, Алисия Спиннет, Анжелина Жонсон, Колин Деннис

Криви, Эрни МакМиллан, Жастин Финч Флетчли, Ханна Аббот, Харрийн нэрийг нь мэдэхгүй Пуффендуйн урт гээгтэй охин, Когтевраны гурван сурагч Энтони Голдстейн, Майкл Корнер, Терри Бут, Жинни болон цайвар үстэй өндөр хөвгүүн (Харри түүний Пуффендуйн квиддичийн багт тоглодогийг мэддэг байлаа). Фред, Жорж Уизли хоёр өөрсдийн анд Ли Жордонгийн хамтаар «Зонко»-гоос авсан цаасан хайрцагтай зүйлсээ авч явлаа.

- Хоёр гурван хүн гэлүү? Хоёр гурван хүн юм биз дээ? гэж Харри даажигнан хэлэв.

- Тиймээ маш сайхантүгээмэл санаа боллоо. Рон чи хэдэн сандал дөхүүлээдхээч гэж Гермиона баяртайгаар хэлэв.

Үйлчлэгч хэзээ ч угааж байгаагүй мэт санагдах бохир алчуураар шилэн аяганы гадаргуу арчиж байснаа болилоо. Магадгүй тэр амьдралдаа ийм олон тооны үйлчлүүлэгч харж байгаагүй биз.

- Сайн байна уу? гээд Фред дагалдагч нараа түргэн тоолоод,

- Бидэнд ... хорин таван цөцгийний шар айраг өгч болох уу? гэв.

Үйлчлэгч түүн рүү хэсэг зуур харснаа маш чухал зүйл хийж байхад нь саад болсон аятай алчуураа уцаарлангуй тавьж лангуун дороос тоостой лонхнууд гаргаж эхлэв.

- Авцгаагаарай гээд Фред түүнийг хүүхдүүд тараангаа,

- Мөнгөө нэмээрэй. Минийх хүрэхгүй нь гэлээ.

Харри зочдоо хөгжилтэй ярилцан шар айрагаа авах зуураа жанчныхаа халааснаас мөнгө гаргахыг харлаа. Тэр ийм олон хүн цугласанд итгэж чадахгүй байснаа гэнэт дотор нь хүйт оргин Гермиона руу эргэлээ.

- Чи тэдэнд юу гэж хэлсэн бэ? Тэд юу хүлээж байгаа юм бол?

- Би тэдэнд зөвхөн чамайг сонсохыг хүсэж байгаа хэлсэн гэж Гермиона тайвшируулав. Гэхдээ Харри ууртай харцаар үргэлжлүүлэн харахад,

- Чамаас юу ч шаардагдахгүй би өөрөө эхлэнэ гэв.

- Сайн уу, Харри гэж Невилл баясан хэлээд эсрэг талд нь суулаа.

Харри инээмсэглэсэн ч юу ч хэлсэнгүй. Чжоу инээмсэглээд Роны баруун талд суулаа. Харин түүний буржгар шаргал үстэй найз инээмсэглэсэнгүй бөгөөд хэрвээ миний мэдэл хүрдэгсэн бол ийшээ ирэхгүй байсан гэсэн байрын үл итгэсэн харцаар

Харриг шагналаа.

Хоёр гурваараа Харри, Рон, Гермиона гурвыг тойрон суухад зарим нь сэтгэл доогдолсон, зарим нь сониучирхсан байдалтай харагдана. Полумна Лавгуд мөрөөдөнгүй хоосон газар луу ширтэж байв. Бүгдийг суусан хойно яриа хөөрөө намдав. Хүн бүрийн харц Харри руу чиглэлээ.

- Ээ... тэгэхээр... сайн уу гэж Гермиона хэлэв.

Одоо бүгдийн анхаарал түүн рүү хандсан ч хүүхдүүд Харриг харсан хэвээр байлаа.

- Тэгэхээр бидний цугласан учир гэвэл Харрид санаа төрсөн юм (Харри түүн рүү уурсан харлаа) За яахав надад нэг санаа төрсөн юм хар урлагаас хамгаалж сурахыг хүсэж байгаа хүн бүхэнд ашигтай ... Амбрижийн биднээр хийлгээд байгаа шиг хөгийн юм биш жинхэнээсээ түүнд суралцах болно. Яагаад гэвэл энэ бол хамгаалалт биш хоосон яриа. (Яг үнэн гэж Энтони Голдстейн хэлэхэд Гермиона илүү зоригтой боллоо). Ийм учраас бид ажил хэргээ өөрсдийн гартаа авбал илүү дээр гэж бодлоо гээд тэр чимээгүй болсноо Харри руу хараад яриагаа үргэлжлүүлэв.

- Учир нь гэвэл хамгаалахыг онолоор биш жинхэнэ шившлэгээр суралцах ёстой ...

- Гэхдээ хар урлагаас хамгаалах хичээлээр С.И.Ш. өгөхийг хүсч байгаа биз дээ? гэж Майкл Корнер хэлэв.

- Мэдээж хүсч байна. Гэхдээ зөвхөн энэ ч биш би жинхэнээсээ өөрийгөө хамгаалж сурахыг хүсч байна. Яагаад гэвэл ... учир нь ... лорд Волдеморт эргээд ирсэн.

Хариу үйлдэл агшин зуур болов. Чжоугын найз дуу алдаад шар айргаа өөр лүүгээ цалгиулан асгасан бол, Терри Бут давхийн цочиж, Падма Патил чичирэн, Невилл хачирхалтай дуу гаргаснаа ханиалгаж байгаа дүр үзүүлэв. Үүний дараа бүгд Харри руу тэсч ядсан байртай харлаа.

- Ямар ч гэсэн төлөвлөгөө бий. Хэрвээ бидэнтэй нэгдэхийг хүсч байвал үүнийг хаана ...

- Волдеморт эргэн төрсөн гэх баталгаа хаа байна? гэж Пуффендуйн цайвар үстэй тоглогч хэллээ.

- Дамблдор үүнд итгэж байгаа гэж Гермиона хариулав.

- Чи түүнд итгэж болно гэж хэлэх гээ юу? гээд тэр Харри руу зангав.
- Чи чинь хэн гээч вэ? гэж Рон бүдүүлгээр дуу алдав.
- Захария Смит. Минийхээр бол бид түүний яагаад Хэцүү нэрт эргэн ирсэн гэж бодож байгааг сонссон нь дээр байх.
- Сонсооч бид үүний төлөө цуглараагүй гэж Гермиона түргэхэн хэлэв.
- Зүгээр дээ, Гермиона гэж Харри хэлэв.

Түүнд яагаад ийм олон хүмүүс ирсэн нь тодорхой болов. Гермиона үүнийг мэдэх ёстой байсан юм. Тэдний зарим нь магадгүй ихэнхи нь түүхийг түүнээс сонсох гэж иржээ.

- Яагаад би Хэцүү нэртийг эргэн ирсэн гэж бодож байгаа вэ гэвэл? гээд Харри Захариягийн нүд рүү харлаа.
- Би түүнийг харсан. Дамблдор өнгөрсөн жил юу болсон талаар бүх сургуулийнханд ярьсан. Хэрвээ чи түүнд итгээгүй бол надад итгэхгүй байна гэсэн үг. Харин би та нарыг ятгахын тулд цагаа үрмээргүй байна.

Бүгд амьсгал даран түүний яриаг сонслоо. Харрид үйлчлэгч хүртэл чих тавьж байх шиг санагджээ. Тэр алчуураараа шилэн аяга арчихаасаа илүү будаж байгаа юм шиг харагдлаа.

Захария үл ойшоосон дүр эсгэв.

- Дамблдор өнгөрсөн жил бидэнд зөвхөн Седрик Диггориг Хэцүү нэрт алсан чи түүний биеийг Хогвартст авчирсан гэсэн. Ямар ч тодорхой зүйл яриагүй. Диггориг яаж алсаныг тэр хэлээгүй ...
- Хэрвээ та нар Волдеморт яаж алсаныг сонсох гэж ирсэн бол юугаар ч тусалж чадахгүй нь дээ гэж Харри хэлэхэд сүүлийн өдрүүдэд намдаад байсан уур хилэн нь ахин дүрэлзэв. Тэр Чжоугын харцаас зугтан Захариягийн царайнаас нүд салгасангүй.
- Би Седрик Диггорийн тухай ярихыг хүсэхгүй байна ойлгомжтой юу? Хэрвээ та нар үүний төлөө энд ирсэн бол явсан чинь дээр.

Тэр Гермиона руу уурсан ширтэв. Тэр бүгдийг ямар нэгэн түүх сонсуулахаар ирүүлсэн буруутай. Гэхдээ хэн ч явсангүй тэр ч байтугай Захария Смит хүртэл үлдээд урьдын адил Харри руу итгэлгүйхэн ширтсээр байлаа.

- За тэгэхээр хэрвээ хамгаалахад суралцахыг хүсч байвал хаана хичээллэх болон хэзээ уулзахаа шийдэх хэрэгтэй байна гэж Гермиона нарийхан хоолойгоор хэлэв.
 - Чи Патронусыг дуудаж чаддаг гэсэн үнэн үү? гэж урт гээгтэй охин асуулаа. Сониучирхсан шивнэлт сонсогчдын дунд түгэв.
 - Тиймээ гэж Харри хэлэв.
 - Биежсэн Патронусыг уу? Харрийн санаанд нэг зүйл орлоо.
 - Чи санамсаргүй хатагтай Боунсыг танихгүй биз? Охин инээмсэглэв.
 - Тэр миний нагац эгч. Би бол Сьюзен Боунс. Тэр надад ид шидийн яаманд болсон шүүх хурлын тухай хэлсэн. Тэгэхээр энэ үнэн үү? Чи буган Патронусыг дуудаг юм уу?
 - Тиймээ.
 - Чөтгөр гэж, Харри! Харин би юу болохыг нь огт мэдэхгүй гэж Ли сэтгэгдэл төрсөн байртай дуу алдав.
 - Ээж Ронд энэ тухай бүү ярь. Хэтэрхий анхаарал татна гэж хэлсэн хэмээн Фред тайлбарлаад Харри руу инээмсэглэв.
 - Энэ ч тодорхой гэж Харри бувтнахад зарим хүмүүс инээлдэв. Гивлүүртэй шидтэн сандлаа ойртуулан суулаа.
 - Бас чи Дамблдорын өрөөнд байдаг илдээр василискыг алсан юм уу? гэж Терри Бут асуулаа.
 - Тиймээ алсан.
- Жастин Финч Флетчли исгэрэхэд, ах дүү Криви айж бахадсан харц солилцон, Лаванда Барун аяархан «Хөөх!» гэлээ. Харри улайж эхлэхээ мэдрэн Чжоугын харцаас зугтахыг хичээв.
- Нэгдүгээр дамжаандаа тэр гүн удааны чулуу аварсан гэж Невилл мэдэгдэв.
 - Гүн ухааны гээч гэж Гермиона шивнэлээ.
 - Тиймээ, Хэцүү нэртээс гэж тэр яриагаа дуусгав. Ханна Абботын нүд галлеон шиг дүгрэглэв.
 - Бас түүнийг Гурван шидтэний тэмцээний даалгаварыг хэрхэн биелүүлсэн

тухай дурсах явдалгүй. Лууны дэргэдүүр өнгөрөн, лусын дагина, аалз гээд л ... хэмээн Чжоу хэлэв. (Харри түүн рүү зовонгуй харахад Чжоу инээмсэглэж байсанд ахиад л гэдэс дотор нь хөрвөчих шиг болжээ.)

Хөөрсөн чимээ шуугиан дэгдэв. Харрин дотор мушгирахад бүх хүчээ гарган сэтгэл хангалуун биш царай гаргахыг хичээв. Чжоугын түүнийг магтсан явдал байдлыг улам хэцүү болж байлаа.

- Сонсоцгоо ... би даруухан байхыг оролдож байгаа юм шиг сонсогдох байх л даа. Гэхдээ надад ихэнхи зүйл дээр нь тусалсан юм.

- Луун дээр лав биш. Чи маш сайн нисэж байсан гэж Майкл Корнер хэлэв.

- Тиймээ гэж Харри хэлэхдээ дотроо эсэргүүцэхээ мэдэрчээ.

- Бас зун Дементорыг хөөхөд чамд хэн ч туслаагүй гэж Сьюзен Боунс хэлэв.

- Тиймээ, тийм. За яахав. Зарим зүйлийг би гадны тусламжгүй хийсэн ч миний хэлэх гэсэн зүйл бол ...

- Бидэнд үзүүлбэрээсээ үзүүлэхгүйн тулд зайлсхийж байна уу? гэж Захария Смит хэлэв.

- Надад нэг санаа байна. Чи яагаад амаа хамхиж болохгүй гэж? хэмээн Рон

- Харриг хариулж амжихаас урьтаж дуугарлаа.

Магадгүй түүний зайсхийж байна гэсэн үг Харрид хүчтэй нөлөөлсөн байж мэднэ. Ямар ч атугай тэр Захарияд үзүүлээд өгөхийг хүслээ. Захария улайгаад,

- Бид түүнээс суралцахаар ирсэн байтал үнэн хэрэгтээ юу ч чаддаггүй гэж тайлбарлаж байна шүү дээ гэв.

- Тэр ингэж хэлээгүй гэж Фред тасхийв.

- Чи чихээ цэвэрлэх болсон юм биш үү? гэж Жорж сонирхоод «Зонко»-гийн дэлгүүрийн хайрцагнаас төмөр хэрэглэл гаргав.

- За, сайн байна цаашаа явцгаая. Бид Харригаар хичээл заалгахыг зөвшөөрч байна уу? гэж Гермiona хэллээ.

Цуглагсад дэмжин шуугилдав. Захария цээжиндээ гараа зөрүүлээд чимээгүй болон Фредын гарт байгаа эдлэлийг судлаж байгаа дүр эсгэв.

- Тэгэхээр гэж Гермиона тохиролцоонд хүрсэн явдалд баярлан хэлээд,
 - Одоо хаана хичээллэх вэ гэдэх хоёр дахь асуулт байна? Минийхээр бол долоо хоногт нэг байхад болох ...
 - Хүлээгээрэй энэ чинь манай бэлтгэлтэй давхцахгүй байх нь чухал гэж Анжелина хэлэв.
 - Манай ч гэсэн гэж Чжоу дэмжив.
 - Манайх ч гэсэн адил гэж Захария Смит нэмэрлэв.
 - Бид бүгдийг чөлөөтэй байх орой сонгон авч болно гэдэгт итгэлтэй байна гэж Гермиона тэсвэр алдан хэлээд,
 - Бид Үхэл залгигчид болон Во ... Волдемортоос өөрсдийгөө хамгаалж сурахыг хүсч байгаа болохоор маш чухал ажил гэж бодож байна гэлээ.
 - Би хувьдаа үүнийг жилийн эцэст С.И.Ш авахаас ч чухал гэж бодож байна гэж Эрни МакМиллан хэлээд хүүхдүүдийн үгүй гэж хэлэхийг хүлээсэн мэт сүрдүүлэн харлаа. Бүгд чимээгүй болов.
 - Би яамнаас шийдвэрлэх үед ямар ч ашиггүй багшийг бидэнд тулгаж байгааг ойлгохгүй байна. Тэр Хэцүү нэртийн эргэн ирснийг үгүйсгэж байгаа болохоор биднийг шившлэгээр хамгаалахыг зөвшөөрөхгүй шүү дээ.
 - Бид Амбрижид хар урлагаас хамгаалахад сургахыг хүсэхгүй байх шалтгаан бий гэж бодож байгаа. Учир нь түүнд Дамблдор сурагчдаар хувийн армиа бүрдүүлэхийг хүсч байгаа гэсэн ухаангүй бодол байгаа юм. Ид шидийн яамны эсрэг босох гэж Гермиона хэлэв.
- Бараг бүгдийг энэ сонин мэгдүүлэхэд Полумна Лавгуд,
- Ямар утгагүй явдал вэ. Корнелиус Фажад хувийн арми бий шүү дээ гэлээ.
 - Юу? гэж Харри гэнэтийн мэдээнд гайхширан асуулаа.
 - Тиймээ, түүнд Гелиопатовын арми бий гэж Полумна хөөрөн хэллээ.
 - Байж боломгүй юм! гэж Гермиона дуу алдав.
 - Болно гэж Полумна эсэргүүцлээ.
 - Гелиопат гэдэг чинь юу юм? гэж Невилл гайхширан асуув.

- Энэ бол галт сүнс гээд Полумнагийн нүд томорсноо,
- Аварга том дүрэлзэн шатаж байгаа амьтад тэд газар дээр гарч ирэхдээ замдаа тааралдсан бүхнийг шатаадаг юм гэлээ.
- Тэд байдаггүй юм, Невилл гэж Гермиона шоолонгуй хэлэв.
- Үгүй ээ, байдаг! гэж Полумна уурлан мэтгэлээ.
- Намайг уучлаарай баталгаа нь хаа байна? гэж Гермиона дүрсхийв.
- Хангалттай нүдээр харсан гэрчүүд байгаа. Хэрэв чи богино ухаантай болоод хамар дорхоосоо өөр зүйл хардаггүй бол ...
- «Кхэ кхэ» гэж Жинни Амбрижыг дуурайн ханиалгахад хүүхдүүд түүн рүү айн харснаа инээлдэв.
- Бид хамгаалах хичээлээ хэдэн удаа хийхээ шийдэх ёстой биш үү?
- Тиймээ, Жинни чиний зөв гэж Гермиона дэмжлээ.
- Долоо хоногт нэг байхад болно гэж Ли Жордон хэлэв.
- Зөвхөн ... гэж Анжелина хэлэв.
- Тиймээ мэднэ квиддичид саад болохгүй гэж Гермиона дуусгаад,
- Одоо хаана уулзахаа шийдэцгээе гэлээ.

Энэ хүнд асуудал боллоо. Бүгд чимээгүй болцгоов.

- Номын санд болох уу? гэж Кэти Белл санал болгов.
- Хэрвээ бид тэнд шившлэгээр хичээллэж байна гэдгийг хатагтай Пинс мэдэх юм бол хөөрөхгүй л байх даа гэж Харри хэлэв.
- Хоосон ангид болох уу? гэж Дин хэлэв.
- Болох л юм. Магадгүй МакГонагалл өөрийнхөө ангийг өгөх байх. Тэр Харриг Гурван шидтэний тэмцээнд оролцож байх үед өгч байсан гэж Рон хэлэв.

Гэхдээ Харри энэ удаад МакГонагалл зочломтгой бус байна гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. Хэдийгээр Гермиона гэрийн даалгавар хийх дугуйлан хичээлүүлнэ гэж хэлээд зөвшөөрөл авна гэсэн ч боломжгүй гэдэг нь тодорхой байлаа.

- За өөр юм бодож олохыг хичээе. Уулзах газар болон цагаа шийдсэн хойно хүн бүрт зурвас явуулна гэж Гермиона хэллээ.

Тэр цүнхээ онгичин үзэг цаас гаргаж ирээд чухал мэдэгдэл хийх гэж байгаа юм шиг тээнэгэлзсэнээ,

- Хэн хэн оролцож байгааг мэдэхийн тулд бүгд нэрээ бичсэн нь дээр байх. Бас юу хийж байгаа талаараа булан бүрд хашгичаад хэрэггүй шүү. Хэрвээ энд гарын үсгээ зурвал бидний төлөвлөгөөний талаар Амбриж болон бусдад хэлэхгүй гэсэн баталгаа болно гэв.

Фред шууд үзгийг авч тааламжтайгаар бичихэд Харри зарим хүмүүс цаасан дээр нэрээ бичих болсон явдалдаа нэг их баярлахгүй байгааг харжээ.

- Э ... Эрни надад хаана цуглахыг хэлэх байх гэж Захария удаанаар хэлээд Жоржын дамжуулсан цаасыг буцаж түлхэв.

Гэвч Эрни өөрөө гарын үсэг зурах эсэхээ шийдээгүй байлаа. Гермiona хөмсгөө өргөлөө.

- Ойлгож байна уу ... бид чинь ахлагч шүү дээ. Хэрвээ цаас олдох юм бол ... чи өөрөө Амбрижыг мэдэх юм бол гэж хэлээ биз дээ ...

- Чи хормын хамгийн чухал ажил гэдгийг зөвшөөрч байсан биз дээ хэмээн Харри сануулав.

- Би ... тийм л дээ. Тэгж бодож байсан ... Зүгээр л ...

- Эрни чи үнэхээр би цаасыг хаа нэгтээ хаячихна гэж бодоо юу? хэмээн Гермiona асуулаа.

- Үгүй л дээ. Мэдээж үгүй. За би гарын үсгээ зурлаа гэж Эрни яльгүй тайвширан хэллээ.

Эрнигийн дараа хэн ч эсэргүүцсэнгүй. Гэхдээ Харри Чжоугын найз гарын үсэг зурахын өмнө түүн рүү зэмлэнгүй харахыг ажиглажээ. Сүүлчийн хүн болох Захария гарын үсэг зурсан хойно Гермiona цаасыг авч цүнхэндээ нямбайлан хийв. Бүгдэд хачирхалтай мэдрэмж төрлөө. Одоо тэд ямар нэгэн зүйлээр холбоотой болсон юм шиг санагдах ажээ.

- За цаг яваад байна. Жорж, Ли бид гурав өөр зүйл худалдаж авах ёстой. Дараа уулзая гэж Фред хөгжилтэй хэлэв.

Хүүхдүүд хоёр гурваараа тарлаа. Чжоу явахын өмнө цүнх рүүгээ удаанаар тонгойход

өтгөн хар үс нь царайг нь халхлав. Найз хажууд нь гараа зөрүүлэн зогсоод түүнгүйгээр явах янзгүй байлаа. Хаалгаар найзтайгаа гарч явахдаа тэр Харри руу гараа даллав.

- Муугүй л боллоо гэж Гермиона тэднийг «Гахайн толгой»-ноос нарны гэрэлд гарахад сэтгэл хангалуун хэлэв. Харри, Рон хоёр шилтэй цөцгийний шар айрагаа барьжээ.

- Энэ Захария бол жинхэнэ новш гэж Рон ууртайгаар хэлээд холдож буй Смитын нуруу луу харлаа.

- Надад ч гэсэн тэр таалагдсангүй. Гэхдээ тэр миний Эрни болон Ханнатай Пуффендуйн ширээнд ярьж байхыг сонсоод бас ирэхийг хүссэн юм. Би яах ёстой байсан гэж? Олон хүн байх тусмаа сайн шүү дээ. Майкл Корнер хэрвээ Жиннитэй зугаалдаггүй байсан бол ирэхгүй байсан даа ...

Рон сүүлчийн дусал шар айрагаа уугаад хахаж цацан ханиалгав.

- Тэр яасан гэнээ? Тэр миний дүүтэй зугаалж байна гэж хэлсэн үү? Майкл Корнертой юу? гэж хэлэхэд чих нь түүхий махны өнгөтэй болов.

- Ийм учраас түүнийг найзуудтайгаа ирсэн байх гэж бодож байна. Хэрвээ Жинни түүнд бидний төлөвлөгөөг хэлээгүй бол хамгаалахад суралцахыг сонирхохгүй байсан.

- Тэр хэзээнээс ... түүнтэй ...

- Тэд бүжигт үдэшлэг дээр танилцаад өнгөрсөн жилийн эцсээс найзалж байгаа гэж Гермиона тайвнаар мэдэгдэв.

Гурвуулаа төв гудамжинд гарч Писсарогийн Үзэгний дэлгүүрийн өмнө зогсоход шилэн лангуунд лангуунд үзгэний цуглуулга алаглаж харагдав.

- Хм, шинэ үзэгнээс татгалзахгүй шүү гээд Гермиона дэлгүүр лүү ороход Харри, Рон хоёр араас нь дагалаа.

- Майкл Корнер гэдэг чинь хэн нь юм бэ? гэж Рон ууртай асуув.

- Хар үстэй.

- Тэр надад таалагдаагүй.

- Би ч гэсэн гайхсан гэж Гермиона бувтналаа.

- Гэхдээ би Жинни Харриг сонирхдог гэж бодсон юмсан! хэмээн Рон Гермионаг үзэгний эгнээ дундуур даган явахдаа хэллээ. Гермиона түүн рүү өрөвдсөн байртай хараад толгой сэгсрэв.

- Жинни Харрид сайн ч энэ бол олон сарын өмнө болсон явдал. Энэ бол чи түүнд таалагддаг гэсэн үг биш гэж Харрид эелдэгээр хэлээд урт хар алтан үзэг авлаа. Харри Чжоугийн салах ёс гүйцэтгэсэн талаарх бодолд автсан болохоор энэ сэдэв сонирхолтой санагдсангүй. Түүний санаанд гэнэтхэн нэг зүйл оров.

- Тэр яагаад одоо ярьж байгаа юм бол? Тэр надтай урьд нь ярьдаггүй байсан даа гэж Гермионад хэллээ.

- Ер нь бол. Алив би үүнийг аваадхая.

Тэр лангуу рүү дөхөж очоод арван таван силь хоёр кнат өгөв. Рон өмнөхийн адил хүзүү рүү нь амьсгалсан хэвээр байлаа.

- Рон гээд тэр ширүүн хэлээд эргэж харахдаа хөл дээр нь гишгэчихлээ.

- Ийм учраас л Жинни чамд Майклтай уулздаг тухайгаа хэлээгүй юм. Чамайг муугаар хүлээж авна гэж мэдсэн хэрэг. Гэхдээ үүнийгээ боль гэж би чамаас гуйж байна.

- Энэ чинь юу гэсэн үг юм? Хэн муугаар хүлээж авсан гэж? гэж Рон гудамжинд гараад бувтнав.

Гермиона Харри руу нүдээ эргэлдүүлэн хараад Майкл Корнерийн тухай зүхсэн үг бувтнаж байгаа Ронд сонсогдохгүйгээр,

- Майкл, Жинни хоёрыг тайван орхиё. Харин Чжоу та хоёр юу болж байна? гэлээ.

- Чи юуны тухай яриад байна? гэж Харри түргэхэн асуулаа.

Дотор нь ус буцлах шиг халуу оргин нүүр нь улайлаа. Үнэхээр энэ бүхэн тийм ажиглагдам байсан гэж үү?

- Тэр чамаас нүд салгахгүй байсан биз дээ? гээд Гермиона инээмсэглэв.

Харри урьд нь хэзээ ч Хогсмид хичнээн сайхан тосгон болохыг ажиглаж байсангүй.

БҮЛЭГ 17: БОЛОВСРОЛЫН ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ХУУЛЬ

Харри амралтын үлдсэн хэсгийг сэтгэл өндөр өнгөрүүлэв. Ням гаригийн өдрийн ихэнхийг Ронтой хамт гэрийн даалгавар хийн өнгөрүүлсэн бөгөөд үүнийг хөгжилтэй гэж хэлэхэд бэрх байлаа. Тэд гэрийн даалгавараа амралтын өрөөнд хийхийн оронд намрын нарны сүүлчийн туяанд нуурын эрэг дээр эвэрлэг модны сүүдэрт хийхээр шийджээ. Гермiona мэдээж агаарт ноосон утастай зүү гозолзуулан шинэ оймс ороолт нэхлээ.

Тэдний Амбриж болон яамны эсрэг бослого гаргаж байгаа явдалд гол үүрэг гүйцэтгэж байгаадаа Харри туйлын сэтгэл хангалуун байв. Бямба гаригийн цугларалтан дээр хичнээн хүүхдүүд хар урлагаас хамгаалахад суралцахыг хүсэж байсан ... ямар царайтайгаар түүний яриаг сонсож байсан ... Чжоу түүний Гурван шидтэний тэмцээний тухай магтаж байсан ... гээд л бүгдийг саналаа. Эдгээр хүмүүс түүнийг худалч галзуу хүн биш хүндэт хүлээх гавъяатай гэж бодож байсан учир даваа гаригийн өглөө сэтгэл өндөр сэржээ.

Рон тэр хоёр унтлагын өрөөнөөс гараад өчигдөрийн бэлтгэл дээр Анжелинагийн гаргасан санааны тухай ярилцаар буулаа. Амралтын өрөөнд нарны гэрэл тусаж хүүхдүүд сууцгаана.

Гриффиндорын мэдээллийн самбар дээр урьдын адил шившлэгийн хуучин номын хямдрал, Аргус Филчийн сургуулийн дүрэм журмын сануулга, квиддичийн бэлтгэлийн цагийн хуваарь, школадан мэлхийний зураг солилцох санал, сүүлчийн хяналтын ажлын зарлал, Хогсмид явах өдөр гээд дүүрэн цаас наалттай байлаа. Шинэ зүйл гэвэл албан ёсын байдалтай том хар үгсийн дор нямбайлан гарын үсэг зурсан цаас харагдана.

ХОГВАРТСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН ТУШААЛ

Бүх сурагчдын нийгэмлэг, баг, дугуйлан, клубууд татан буугдсаныг мэдэгдэе. Нийгэмлэг, баг, дугуйлан, клубыг гурваас илүү сурагчыг тооцон байгуулна.

Шинэчилэн байгуулагдах зөвшөөрлийг ерөнхий байцаагч олгоно (профессор Амбриж).

Ерөнхий байцаагчын зөвшөөрөлгүй ямар ч нийгэмлэг, баг, дугуйлан, клубууд зохион байгуулагдахгүй болохыг мэдэгдэе.

Сурагчид ерөнхий байцаагчын зөвшөөрөлгүй нийгэмлэг, баг, дугуйлан, клуб зохион байгуулсан бол хөөх хүртэл арга хэмжээ авна ...

Боловсролын тухай хуулийн хорин дөрөвдүгээр зүйл.

Гарын үсэг зурсан: ерөнхий байцаагч Долорес Жейн Амбриж

Харри Рон хоёр зарлалыг уншихад ард нь сэтгэл зовсон хоёрдугаар дамжааныхан цугларлаа.

- Чулууны дугуйлан хаагдаж байгаа юм байх даа? гэж нэг нь асуув.
- Танай чулууны дугуйлан өнгөрсөн биз хэмээн Рон баргар царайлан хариулахад хоёрдугаар дамжааныхан давхийн холдоцгоов.
- Харин бидэнд аз таарсангүй тийм үү, Харри?

Харри тушаалыг уншихад бямба гаригийн баяр хөөр сарнин алга болж уур хилэн нь ахин дүрэлзлээ.

- Энэ бол тохиолдлын хэрэг биш. Тэр мэдсэн байна гээд уурсан нударга зангидлаа.
- Яаж тэр вэ? гэж Рон эсэргүүцэв.
- Биднийг бааранд сонссон байна. Эсвэл ирсэн хүмүүст итгэж болно гэж үү?

Тэдний хэн ч Амбриж руу гүйгээд хэлж болно шүү дээ. Харин тэр түүнд итгэж биширч байна гэж бодож л байдаг!

- Захария Смит! Эсвэл Майкл Корнер гэж Рон хэлээд нударга зангидав.
- Гермionaг харав уу? гээд Харри охидын унтлагын өрөөний зүг эргэв.
- Түүнд хэлэх хэрэгтэй гээд Рон эргүүлгэн шатаар ухасхийв.

Түүнийг зургаа дахь гишгүүр дээр хүрэхэд дуут дохио шиг чимээ хадаж шат гөлгөр ташуу болов. Хормын төдийд Рон дээшээ зугтаахыг хичээснээ гараа салхин тээрэм шиг эргүүлэн хойшоогоо унаж Харрийн хөлд газардав.

- Бид охидын унтлагын өрөө рүү орж болохгүй шиг байна гэж Харри хэлээд босоход нь туслахдаа инээдээ арайхийн барьж тэслээ.

Чулуун ховил дээгүүр хоёр дөрөвдүгээр дамжааны охин баяртайгаар инээлдэн гулгав. Тэр босоод Харри, Рон хоёр луу харлаа.

- Та нарын хэн чинь орохыг оролдсон бэ?
- Би гэж үс нь сэгсийсэн Рон хэлээд,
- Хэн ингэж боддог байна аа? Энэ чинь шударга бус хэрэг шүү дээ! Гермиона манай унтлагын өрөөнд орж болж байхад бид яагаад болдоггүй юм гэж Харрид хандав.
- Энэ бол эртний дүрэм гэж Гермиона өрөөнөөсөө гарч ирэхдээ хэллээ.
- «Хогвартсын түүх»-энд хэлэхдээ үүсгэн байгуулагчид хөвгүүдийг охидоос илүү ёс журамтай байх ёстой гэсэн байдаг юм. Харин чи тийшээ орж яах гэсэн юм?
- Чам руу очих гэсэн юм. Үүнийг хар! гэж Рон хэлээд түүнийг самбар луу чирлээ.

Гермиона тушаал руу хараад царай нь чулуужсан аятай болов.

- Хэн нэгэн түүнд чалчсан байна гэж Рон ууртай хэлэв.
- Хэн ч чадахгүй гэж Гермиона аяархан хэллээ.
- Битгий гэнэн бай л даа. Хэрвээ чи бүгдийг шударга итгэж болно гэж боддог бол ...
- Тэд чадахгүй яагаад гэвэл би цаасан дээрх гарын үсгийг шившсэн юм. Тайван бай хэрвээ хэн нэгэн Амбрижад хэлсэн бол бид гарцаагүй мэдэх бөгөөд тэр үүндээ харамсах болно.
- Түүнд юу тохиолдох юм? гэж Рон сонирхов.
- Элоиза Миджены батгатай дүйцэх дүүрэн сэвхтэй болно. Явж өглөөний цай уухдаа бусдынхаа юу бодож байгааг харцгаая. Үүнийг бүх тэнхимд тараасан юм болов уу?

Тэднийг Их танхимд орох үед Амбрижын тушаал зөвхөн Гриффиндорын цамхагт гарсан биш гэдэг нь тодорхой болов. Эргэн тойрон эгдүүцсэн яриа хөөрөө дэгдэж бүгд тушаалын тухай ярьж байлаа. Харри, Рон, Гермиона нар дөнгөж суув уу үгүй юу Невилл, Дин, Фред, Жорж, Жинни нар ирэв.

- Та нар харсан уу?
- Түүнийг мэдсэн гэж бодож байна уу?
- Бид юу хийх ёстой вэ?

Бүгд Харри руу харлаа. Тэр ойр хавьд багш байгаа эсэхийг шалгаад,

- Бид ямар ч л байсан үүнийг хийх болно гэж аяархан хэлэв.
- Би чамайг ингэж хэлэхийг мэдэж байсан юм гэж Жорж баясан хэлээд мөрөн дээр нь алгадав.
- Ахлагчид бидэнтэй юу? гэж Фред хэлээд Рон, Гермiona хоёр луу шоолонгуй харлаа.
- Мэдээж гэж Гермiona хүйтнээр хэлэв. Рон ийш тийшээ харснаа,
- Тэнд Эрни, Ханна Аббот хоёр явж байна. Бас Когтевраны Симт ... гэхдээ тэдний хэн ч сэвхтэй харагдахгүй байна гэлээ.

Гермионагийн байдал түгшсэн шинжтэй боллоо.

- Энэ чинь юуны ч тэмдэг биш. Тэнэг л биш бол түүнийгээ ийшээ ирж харуулахгүй ... Доошоо суу! гэж тэр хэлээд тэднийг Пуффендуйн ширээнд суухад даллав.
- Дараа! Дараа нь та нартай ярилцъя!
- Би Майклд хэлье гээд Жинни сандлаасаа үсрэн босоод Когтевраны ширээ рүү ухасхийлээ.

Харри түүний араас дагуулан харав. Чжоу холгүйхэн суугаад «Гахайн толгой»-д авчирсан буржгар үстэйгээ найзтайгаа ярьж байлаа. Тэр дараагийн цугларалтад Амбрижийн тушаалаас айгаад ирэхгүй болов уу?

Гэхдээ тушаалын жинхэнэ уур хүргэсэн явдал Их танхимаас гарч ид шидийн түүх рүү явахад болов.

- Харри! Рон!

Тэдэн рүү цөхөрсөн царайтай Анжелина гүйж ирэв.

- Зүгээр дээ. Бид бодсонгүй ... гэж Харри түүнийг ойртоход хэлэв.
- Та нар үүнд квиддич бас хамаатайг ойлгохгүй байна уу? Бид түүнээс очиж Гриффиндорын квиддичийн багийн зөвшөөрлийг авах ёстой.

- Юу гэнээ? хэмээн Харри хэллээ.
- Чи тоглож байна уу? гэж Рон хирдхийлээ.

- Та нар тушаалд «баг» гэж бичсэн байхыг уншсан биз дээ. Сонсооч Харри ... би чамаас сүүлчийн удаа гуйя. Чи Амбрижийн уурыг хөдөлгөөд байх юм бол тэр цаашдаа бидэнд тоглох боломж өгөхгүй нь.

- Ойлголоо гэж Харри Анжелина уйлах нь холгүй харагдсан учир түргэн хэллээ.

- Санаа зовох хэрэггүй. Би биеэ барих болно.

- Амбрижийг өнөөдөр ид шидийн түүх дээр ирнэ гэж мөрийцсөн ч болох юм.

Тэр Бинсийг шалгаагүй байгаа. Тэнд л байгаа байх гэж Рон хэлэв.

Гэхдээ тэр алджээ. Тэднийг ангид орох үед ангид зөвхөн профессор Бинс аварга биетүүдийн дайны тухай гүнгэнэхэд бэлтгэн сандал дээгүүрээ хөвж байлаа. Харри хичээлийг сонсохыг оролдолгүй цаасан дээр юм зурахдаа Гермionaгийн ууртай харцыг тоосонгүй ч хавирга руу нь өвдтөл нудархад уурсан харлаа.

- Яасан бэ?

Тэр цонх руу заахад цонхны ирмэг дээр Хэдваг суугаад хөлдөө захиа уясан байхыг харлаа. Харри түүнийг яагаад урьдын адил өглөөний цай ууж байх үед нь захиа авчраагүй болохыг ойлгосонгүй. Хүүхдүүд бие биендээ Хэдвагийг заалаа.

- Би энэ уулинд дуртай. Ямар үзэсгэлэнтэй гээч хэмээн Лаванда Парватид шивнэлээ.

Харри эцэс төгсгөлгүй бувтнаж байсан профессор Бинс руу харахад ангийн анхаарал сарнисныг мэдээгүй байв. Харри чимээгүйхэн сандлаасаа босоод доошоо бөхийн эгнээ хоорондуур явж цонх онгойлгов.

Тэр Хэдвагийг сарвуугаа сунган захиагаа өгөөд уулийн байшин руу нисэхийг хүлээсэн авч цонх онгойнгуут гунигтай гууглаад тавцан дээр үсрэн орж ирлээ. Харри профессор Бинс руу сэтгэл түшин хараад Хэдвагийг мөрөн дээрээ суулган бөхийн буцлаа. Тэр суудалдаа суугаад Хэдвагийг өвдөг дээрээ тавин хөлд нь уяатай захиаг авлаа.

Тэгэхэд л Хэдвагийн өд сөд өрвийсэн бөгөөд нэг жигүүр нь дэлгэгдэхгүй болохыг ажиглажээ.

- Тэр шархдаж! Хараач далавч нь гэмтсэн байна гээд Харри ууль руугаа бөхийлөө. Рон хүзүүгээ сунгахад Гермiona үзгээ унагав.

Хэдваг чичирч байлаа. Харриг жигүүрт нь хүрэх үед тэр агзасхийгээд өд сөдөө өрвийлгөн зэмлэнгүй харлаа.

- Профессор Бинс миний бие муу байна гэж Харри чанга хэлэхэд бүгд түүн рүү эргэж харлаа.

Профессор ярихаа болиод толгойгоо гайхан өргөлөө.

- Бие муу байна гэнээ? хэмээн ойлгосонгүй давтав.

- Бие тааруу байна. Би эмнэлэг рүү явах хэрэгтэй байх гэж Харри хэлээд Хэдвагийг ардаа нуун бослоо.

- Тиймээ, тийм эмнэлэг рүү ... яв, Перкинс гэж профессор юу болсныг ойлгосон янзгүй хэлэв.

Харри өрөөнөөс гараад мөрөн дээрээ Хэдвагийг суулган аюулгүй зайд холдмогц бодохоор зогслоо. Мэдээж хамгийн түрүүнд Хагридаас тусламж эрэх байсан хэдий ч хаа байгаа нь тодорхойгүй байв. Зөвхөн профессор Граббли Дергийг хайх үлджээ.

Тэр цонх руу харлаа. Хагридын овоохойн гадна хэн ч байсангүй. Хэрвээ Граббли Дерг хичээл дээрээ байгаагүй бол багш нарын өрөөнд л байгаа байх. Харриг доош явахад Хэдваг мөрөн дээр нь ганхсанаа сулхан гууглав.

Багш нарын өрөөний хаалганы хажууд хоёр луу байлаа. Тэдний нэг Харриг ойртоход,

- Чи яагаад хичээл дээрээ байхгүй байна хүү минь гэж сөөнгөтөв.

- Яаралтай хэрэг гэж Харри товч хэлэв.

- Яаралтай хэрэг гэнээ? Ийм учраас л биднийг тавьсан хэрэг үү гэж хоёр дахь нь хэлэв.

Харри хаалгыг тогшлоо. Хаалганы цаана алхаа сонсогдсоноо үүд нээгдэхэд профессор МакГонагалл зогсож байв. Дөрвөлжин хүрээтэй шил нь ууртай гялсхийлээ.

- Чи ахиад л шийтгүүлчихээ юу?

- Үгүй, профессор! гэж Харри яаран хэлэв.

- Тэгвэл яагаад ангидаа байхгүй байгаа юм?

- Харваас яаралтай хэрэг байгаа биз дээ хэмээн хоёр дахь луу егөөдөнгүй хэлэв.

- Би профессор Граббли Дергийг хайж байна. Миний ууль шархдчихсан.
- Шархдсан ууль гэж хэлсэн үү?

Профессор МакГонагаллын нурууны ард профессор Граббли Дерг гартаа «Өдөр тутмын зөнч» сонин болон уугисан гаанс бариад зогсож байв.

- Тиймээ. Тэр бусад шуудангийн уульнуудаас хоцорч ирэхдээ далавч нь гэмтсэн байсан хараач ... гээд Харри Хэдвигийг мөрнөөсөө болгоомжтой буулгалаа.

Профессор Граббли Дерг амандаа гаансаа зуугаад Хэдвиг рүү харлаа.

- Хмм. Минийхээр бол түүнийг дайрсан юм шиг байна. Яах гэж ингэснийг нь ойлгох юм алга. Заримдаа фестралууд шувуу руу дайрдаг ч эндхийнхийг бол Хагрид уулинд хүргэхээргүй сургасан байдаг.

Харри фестрал гэж юу болох тухай мэдэхийг ч хүссэнгүй. Тэр зөвхөн Хэдвигийн эдгэх эсэхийг мэдэхийг хүсч байв. Профессор МакГонагалл Харри руу ширүүн харснаа,

- Поттер энэ шувуу хэр холоос ниссэж ирснийг мэдэх үү? гэв.
- Ээ ... Лондонгоос байх.

Тэр түүний харцнаас Лондон гэдэг нь Гриммогийн арван хоёр дугаар байшин гэдгийг тодорхой олж харав.

Профессор Граббли Дерг жанчныхаа халааснаасаа өрөөсөн нүдний шил гаргаж зүүгээд Хэдвигийн далавчыг анхааралтай үзэв.

- Хэрвээ чи надад орхивол би ямар нэг юм хийж чадах байх. Гэхдээ хэдэн өдрийн турш алсын нислэг хийж болохгүй.
- Сайн байна ... баярлалаа гэж Харри хэлэхэд хонх дуугаран яриа тасаллаа.
- Зүгээр дээ гэж Граббли Дерг бүдүүлгээр хэлээд багш нарын өрөө лүү орлоо.
- Хүлээгээрэй, Вильгельмина! Поттерын захиа! гэж профессор МакГонагалл хэлэв.
- Өө, тийм л дээ! гээд Харри уулийн хөлд уяатай байгааг захиаг мартсан байлаа.

Граббли Дерг Харрид захиаг өгөд Хэдвигтэй өрөө лүү орлоо. Ууль түүн рүү бусдын гарт өгсөнд итгэж чадахгүй байгаа мэт харав. Тэр гэм буруутайгаа мэдэрсээр цааш

явахад МакГонагалл зогсоов.

- Поттер!

- За, профессор.

Тэр хонгилын дагуу сурагчдын явж байгаа зүг хараад,

- Хогвартсын суваг хараанд орсон байж магадгүй, ойлгомжтой юу? гэж түргэхэн хэлэв.

- Би ... гэж Харри хэлэх гэсэн ч сурагчдын оволзсон урсгал ирлээ.

Профессор МакГонагалл толгой дохиод багш нарын өрөө лүү оров. Гадаа хашааны буланд Рон, Гермиона хоёр салхинаас нуугдан түүнийг хүлээн зогсож байв. Харри захиаг замдаа нээхэд Сириусын гараар бичигдсэн таван үг байлаа.

Өнөөдөр нөгөө газартаа тэр цагтаа.

- Хэдвиг хэр байна? гэж Гермиона угтан асуув.

- Чи түүнийг хэнд өгөв? гэж Рон асуулаа.

- Граббли Дергэд. Тэнд МакГонагаллыг харлаа. Сонсооч ...

Тэр профессор МакГонагаллын үгийг давтав. Хачирхалтай нь тэд гайхсангүй. Эсрэгээрээ учиртай харлаа.

- Яасан бэ? гээд Харри тэдний урдаас ширтэв.

- Би сая Ронд хэлж байлаа л даа ... Хэн нэгэн Хэдвигийг барихыг оролдсон болов уу гэж? Урьд нь түүнийг замд нь дайрч байгаагүй биз дээ?

- Хэний захиа юм? гэж Рон асуугаад Харригаас цаасыг авлаа.

- Нюлхазаас гэж Харри аяархан хэлэв.

- Нөгөө газартаа тэр цагтаа гэнээ. Амралтын өрөөний ханан зууханд уу?

- Тодорхой шүү дээ. Би үүнийг хэн нэгэн уншаагүй гэж найдаж байна хэмээн

Гермиона зурвасыг гүйлгэн уншаад хэлэв.

- Гэхдээ тэр өмнө нь зүгээр байсан шүү дээ. Хэн ч биднийг өнгөрсөн удаа ярилцсаныг ойлгохгүй гэж Харри биеэ барихыг хичээн хэллээ.

- Мэдэхгүй юм. Цаасыг шидийн тусламжтай буцаж хуйлахад хэцүү биш.

Хэрвээ хэн нэгэн нисдэг дарины сараалжыг хянаж байгаа бол ... Бид түүнд захиа

замаасаа баригдсан байж магадгүй гэдгийг анхааруулах ёстой гэж Гермiona сэтгэл зовон хэлээд хонх дуугарахад цүнхээ мөрөндөө үүрэв.

Тэд үүнд толгойгоо гашилгасаар Снеггийн газар дорхи өрөө лүү буулаа. Тэднийг шатны ёроолд хүрэхэд ангийн хаалганы гадаа гартаа албан ёсны цаас дэвэн зогсож байсан Драко Малфойн дуу хадав.

- Тиймээ, Амбриж Слизериний багт шууд зөвшөөрөл өгсөн болохоор бид үргэлжлүүлэн тоглож болно. Би өглөө түүн рүү очсон юм. Бүх зүйл маш амархан бүтсэн. Тэр эцгийг минь сайн мэддэг юм. Тэр яаманд байнга очдог болохоор ... Харин Гриффиндорынхны хувьд гэвэл тоглох зөвшөөрөл авах эсэхийг нь бид харах л үлдлээ ...

- Тоох хэрэггүй. Тэр зөвхөн үүнийг хүлээж байгаа гэж Гермiona Рон, Харри хоёрыг уурсан нударга зангидахад гуйлаа.

- Хамгийн гол нь яаман дахь холбоо хэлхээ гэж Малфой чангаар хэлээд тэдний зүг нүдээ хорсолтой гялалзуулан харангаа,

- Харин эдний хувьд бол би боломж бага гэж бодож байна. Аав хэлэхдээ эртнээс Артур Уизлийг буруутгах шалтаг эрж байгаа гэсэн ... Харин Поттерын хувьд бол ... энэ зөвхөн цаг хугацааны асуудал. Яамныхан түүнийг гэгээн Мунгогийн эмнэлэгт ид шидийн улмаас ухаан нь муудсан тусгай хүмүүсийн тасагт хэвтүүлэхээр хатуу шийдсэн гэв.

Малфой царайгаа маанаг төрхтэй болгосноо нүдээ эргэлдүүлэв. Крэбб, Гойл хоёр хөхрөлдөхөд Пэнси Паркинсон инээд алдав.

Харрийн мөрийг ямар нэг юм түлхэн өнгөрөхөд агшин зуур Невилл Малфой руу ухасхийх нь үзэгдэв.

- Невилл, зогс!

Харри түүний жанчны араас зууран хойш татлаа. Невилл нударга зангидан Малфой руу уурсан зүтгэлээ.

- Рон туслаач! гэж Харри хашгираад нэг гараараа Невиллийн хүзүүгээр нь тэврэн зогсоохыг хичээв. Крэбб, Гойл хоёр Малфойн урд гараа өргөн хамгаалан зогслоо. Рон Невиллийн гараас зууран хамтдаа хойш нь татав. Түүний царай хүрэгтэн хоолой нь шахагдсан болохоор ойлгогдохын аргагүй үгүүд бувтнав.

- Инээдтэй ... биш ... байна ... Мунго ... түүнд ... үзүүлээд ... өгье ...

Ангийн хаалга нээгдэн Снегг орж ирэв. Түүний хар нүд Гриффиндорынхон дээр тусаад Невиллийг барин зогсох Харри, Рон хоёр луу харлаа.

- Поттер, Уизли, Долгопупс нар зодолдоо юу? Гриффиндороос арван оноо хаслаа. Долгопупсыг тавь, Поттер эс бөгөөс хичээлийн дараа үлдээнэ шүү. Бүгд анги руугаа гэж хүйтэн хоолойгоор хэллээ.

Харри Невиллийг тавихад амьсгаадан зогсож муухай харлаа.

- Би чамайг зогсоох ёстой байсан. Крэбб, Гойл хоёр чамайг арчаад хаячихна гэж Харри амьсгаадан хэлээд цүнхээ авлаа.

Невилл хариулсангүй цүнхээ аваад анги руу орлоо.

- Юун чимээ шуугиан бэ? гэж Рон асуулаа.

Харри юу ч хэлсэнгүй. Тэр Невиллд гэгээн Мунгогын ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгт хэвтэж байгаа хүмүүсийн тухай яриа хүнд тусдагыг мэдэх ч Дамблдорт нууц алдахгүй гэж амалсан билээ. Тэр ч байтугай Невилл хүртэл түүнийг мэддэг гэж сэжиглээгүй байгаа юм.

Харри, Рон, Гермиона нар арын эгнээнд дадсан газраа суугаад үзэг, цаас болон «Ид шидэт мянган ургамал мөөг» гэсэн номоо гаргалаа. Анги даяараа Невиллийн тухай шивнэлдэн ярилцаж байснаа Снегг хаалга чанга хаахад чимээгүй болов.

- Бид өнөөдөр зочинтой байгаа гэдгийг анзаарна уу гэж Снегг намуухан ёжтой хоолойгоор хэлэв.

Тэр ангийн харанхуй булан руу заахад Харри Амбрижийг тэмдэглэлийн дэвтрээ өвдөг дээрээ тавин суусныг харлаа. Тэр андууд руу хяламхийн хараад хөмсгөө өргөв. Снегг, Амбриж хоёр хамгийн үзэн яддаг багш нар болохоор хэнд нь энэ уулзалтаас таагүй явдал хүсэхээ шийдэхэд хэцүү байлаа.

- Бид өнөөдөр Хүч оруулагч уусмал дээрээ үргэлжлүүлэн ажиллах болно. Та нарыг өнгөрсөн хичээл дээр орцыг нь олсон байх ёстой. Хэрвээ амралтын хоёр өдөр зөв найрлагаа олсон бол ... Заавар самбар дээр байгаа гээд шидэт саваагаа даллав.

Професср Амбриж эхний хагас цагийн турш зөвхөн тэмдэглэлийн дэвтэр дээрээ юм бичив. Харрид тэр Снеггээс юу асуух нь сонирхолтой байсан болохоор уусмалдаа анхаарал хандуулж чадсангүй.

- Саламандрын цус, Харри! Анарын шүүс биш! гэж Гермiona дуу алдан ёолоод түүнийг гурав дахь удаагаа буруу орц хийхээс өмнө гарыг нь барин зогсоолоо.

- Өө гэж Харри хэлээд лонхыг доош нь тавьж булан руу үргэлжлүүлэн ширтлээ.

Амбриж булангаас босож Снеггийн дэргэдэх ширээ рүү очин Дин Томасын тогоо руу бөхийв.

- Хичээл дээр уусмалуудыг муугүй бэлтгэдэг юм шиг санагдлаа. Би Хүч оруулагчын адил уусмалуудыг тэдэнд заах нь зүйтэй эсэхийг асуумаар байна. Миний бодлоор ид шидийн яамнаас түүнийг сургалтын хөтөлбөрөөс хасуулах хэрэгтэй гэж бодож байна.

Снегг дээшээ босоод түүн рүү удаанаар эргэн харлаа.

- Та Хогвартсад хэр удаан багшилж байна? гэж тэр асуугаад үзгээ дэвтэр лүүгээ ойртуулав.

- Арван дөрвөн жил гээд Снеггийн царай ойлгогдохын аргагүй болов.

Харри тэднийг үргэлжлүүлэн харах зуураа уусмалдаа хэдэн дусал нэмэхэд сүртэй шаржигнах чимээ гарснаа шаргал болон хувирлаа.

- Та эхнээсээ л хар урлагаас хамгаалах хичээлийн багш болох хүсэлтэй байсан уу?

- Тиймээ гэж Снегг аяархан хэлэв.

- Гэхдээ амжилтгүй болж тийм үү? Снеггийн уруул ярвайлаа.

- Харж байгаа биз дээ

Тэр дэвтэртээ юм бичлээ.

- Таныг Хогвартс орсноос хойш хар урлагаас хамгаалах хичээлд тогтмол орон тоо гарч байж тийм үү?

- Тийм гээд Снегг уруулаа жимийлээ. Тэр их ууртай байв.

- Дамблдор яагаад таныг томилдоггүй юм бол?

- Та түүнээс асуусан нь дээр байх гэж Снегг таталдан бувтнав.

- Өө, тэгэлгүй яахав гэж профессор Амбриж инээмсэглэн хэллээ.

- Энэ таны ажил хэрэгт хамааралтай эсэхийг асууж болох уу? гээд Снегг нүдээ онийлгов.

- Тэгэлгүй яхав. Шууд хамааралтай. Ид шидийн яамнаас багш нарын өмнөх явдлын тухай сонирхож байгаа юм гэж профессор Амбриж хэлэв.

Тэр Пэнси Паркисон руу очоод хичээлийн тухай асуув. Снегг Харри руу харахад харц нь мөргөлдөв. Харри яаран доошоо харцаа буруулахад уусмал нь шатаж байгаа хаймар шиг үнэртэв.

- Ахиад ямар ч үнэлгээ байхгүй, Поттер гэж Снегг сэтгэл ханамжтай хэлээд шидэт саваагаа даллан тогоог нь хоослов.

- Надад энэ уусмалын зөв найрлага болон яагаад алдсан тухайгаа бичиж ирээрэй. Дараагийн хичээл дээр ойлгов уу?

- За гэж Харри уурсан хэлэв.

Снегг тэдэнд хэдийн гэрийн даалгавар өгсөн болохоор квиддичийн бэлтгэлийн дараа ахин хоёр шөнө нойргүй хонох нь. Тэр маргааш өглөө сэтгэл өндөр сэрнэ гэж бодож чадсангүй. Одоо зөвхөн энэ өдөр хурдан дуусаасай гэж мөрөөдөж байв.

- Магадгүй би мэргэ төлгийн хичээлээс чөлөөлөгдөж болох байх. Өвдсөн гэж хэлээд Снеггийн зохион бичлэгийг хийвэл шөнө дунд хүртэл суух хэрэггүй болно гэж үдийн хоолны дараа хашаанд зогсож байхдаа хэлэв.

- Чи мэргэ төлгийн хичээлийг алгасч болохгүй гэж Гермiona ширүүн хэлэв.

- Хэн үүнийг хэлж байна аа! Чи Трелони үзэн яддаг болохоор хичээлээс нь явсан биз дээ гэж Рон эгдүүцэв.

- Асуудал үзэн яддагтаа байгаа гэдэгт биш. Би зүгээр л түүнийг муу багш төдийгүй хөгшин луйварчин гэж боддог юм. Гэхдээ Харри хэдийн ид шидийн түүхээс гадуур зугаалсан болохоор өнөөдөр ахиж болохгүй гэж бодож байна.

Ажиглалт шударга байсан болохоор хагас цагийн дараа Харри бүх дэлхий ертөнцөд уурласаар мэргэ төлгийн ангид орлоо. Профессор Трелони ахин «Зүүдний мэргэ»-ээ тараалаа. Харри цагийг илүү ашигтай өнгөрүүлсэн бол Снеггийн шийтгэлийн даалгаварыг хийж дуусгах байсан тухай бодсоор хэдэн зүүд бодож олохыг оролдов.

Тэр ганцаараа ааш муутай байсангүй бололтой. Профессор Трелонин номоо Харри, Рон хоёрын ширээн дээр тасхийтэл тавиад хөмхийгөө зуулаа. Дараа нь Симус, Дин

хоёрт номоо өгөхдөө толгой руу нь цохих шахан, ахин нэг номоороо Невиллийн цээж рүү сандлаас унатал түлхэв.

- Үргэлжлүүлцгээ! Та нар юу хийх ёстойгоо мэдэж байгаа! Эсвэл би та нарыг номыг нээлгэж чадахааргүй сул дорой багш юм уу?

Хүүхдүүд түүн рүү гайхан харснаа бие бие рүүгээ харцгаав. Харри учир юунд болохыг тааварлав. Терлони түшлэгтэй сандалдаа буцаж суухдаа зузааны шилний цаана дүүрэн нулимстай харагдав. Тэр Рон руу бөхийгөөд,

- Түүнийг шалгалтын дүнгээ авсан байх гэж бодож байна гэв.

- Профессор? Профессор, юу болоо вэ? гэж Парвати Патил хулчгардуухан асуув (Лаванда тэр хоёр профессор Трелониг шүтэн биширдэг билээ).

- Юу болсон гэнээ? Юу ч биш! Намайг доромжилсон ... гүжирдсэн ... үндэслэлгүй буруутгасан. Өөр юу ч болоогүй юу ч биш! гэж чичирсэн хоолойгоор хэлэв.

Тэр татвалзан санаа алдсанаа Парвати руу нулимс дүүрэн нүдээр харлаа.

- Арван зургаан жилийн минь зүтгэлийг яриад ч хэрэггүй ... тэд ажиглагдамгүй өнгөрч ... би өөрийгөө доромжлохыг зөвшөөрөхгүй. Зөвшөөрөхгүй!

- Хэн таныг доромжлоо вэ, профессор? гэж Парвати асуулаа.

- Эрх мэдэлтэн! Хэний нүдэнд орчлон ертөнц харагдаж хэн харахгүй байгааг би харж байгаа ч мэдэхгүй байна. Ирээдүйг зөгнөгч бид үргэлж айж шахан мөрдүүлдэг ... Ай халаг гэж бидний хувь заяа ...

Тэр шүлсээ залгиад нойтон хацраа алчуурынхаа үзүүрээр арчсанаа ханцуйнаасаа жижигхэн хатгамалтай алчуур гаргаж ирээд Пивзийн адил нусаа нийв.

Рон инээд алдахад Лаванда түүнийг зэвүүцсэн харцаар шагналаа.

- Профессор ... магадгүй энэ профессор Амбрижтай холбоотой юу? гэж Парвати асуулаа.

- Надад энэ эмэгтэйн тухай бүү дурс! Хийж байгаа ажлаа үргэлжлүүлцгээ! гэж профессор Трелони хашгираад зүүлтээ шаржигнуулан үсрэн бослоо.

Тэр хичээлийн төгсгөл хүртэл ширээ хооронд холхин нулимс мэлтрүүлэн бувтнаж байлаа.

- Халагдаж болно гэнээ ... доромжилж байна ... туршилтын хугацаа ... харах юм гэнээ ... тэр яаж зүрхэлж байна.

- Амбриж та хоёрт нийтлэг зүйл байна. Тэр бас Трелониг хөгшин луйварчин гэж бодож байгаа болохоор ажилд тэнцэх эсэхийг нь туршиж үзэх гэж байх шиг байна гэж Харри Гермионатай хар урлагаас хамгаалах хичээл дээр уулзаад хэлэв.

Энэ удаад Амбриж хар туузтайгаа сэтгэл хангалуун инээмсэглэл тодруулан орж ирэв.

- Сайн байна уу, сурагчидаа.

- Сайн байна уу, профессор Амбриж гэж тэд уйтгартай хоолойгоор хэлэв.

- Шидэт саваагаа хураацгаа.

Энэ удаад хэн ч саваагаа хураасангүй.

- «Ид шидийн хамгаалах онол» сурах бичгийн гучин дөрөвдүгээр хуудсыг нээж Ид шидийн дайралтын эсрэг түрэмгий биш байх нь гэдэг хуудсыг гаргацгаа. Ямар ч ...

- Яриа хөөрөө байхгүй гэж гурван найзууд шивнэлдлээ.

- Квиддичийн бэлтгэл болохгүй гэж Анжелина тэднийг хоолны дараа амралтын өрөөнд ирэхэд гунигтай хэлэв.

- Гэхдээ би түүнтэй маргалдаагүй. Нэг ч үг хэлээгүй чамд тангараглая, Анжелина гэж Харри айдаст автан хэлэв.

- Мэднэ, мэднэ. Тэр түүнд учрыг нь олох цаг хэрэгтэй гэж хэлсэн.

- Юуны учир олох гэж? Слизеринийхэнд зөвшөөрөл өгсөн. Харин бидэнд яагаад үгүй гэж? хэмээн Рон уурслаа.

- Чи үүнийг гэрэлтэй талаас нь хараад үз дээ. Чамд ядаж Снеггийн гэрийн даалгаварыг хийх цаг гарч байна! гэж Гермиона хэлэв.

Рон түүн рүү гайхан харахад Харри,

- Гэрэлтэй тал гэнээ? Квиддичийн бэлтгэл байхгүй уусалын нэмэлт даалгаварыг уу? гэж унтууцав.

Тэр сандалдаа лаг хийтэл суугаад цүнхнээсээ уусмалын хичээлийн зохион бичлэгээ

гаргалаа. Снегг шаардана гэж мэдэж байсан ч төвлөрөхөд бэрх байлаа. Тэр таван хормын турш гал харж суув. Амралтын өрөөнд учир нь олдохооргүй чимээ шуугиантай байлаа. Фред, Жорж хоёр ээлжлэн Ажлаас зайлсхийгч зуушаа өөрсдийн биеэр туршиж үзүүлж байсан бөгөөд дэмжсэн хашгиралт сонсогдоно.

Эхлээд Фред чихрийн шаргал үзүүртэй талыг нь зажлаад урдаа байгаа сав руу бөөлжив. Дараа нь хүчлэн улаан төгсгөлийг нь зажлахад бөөлжилт даруй зогсов. Үзүүлбэрийн туслах Ли Жордан залхуутайхан Снегг Харрийн уусмалыг алга болгосонтой адил Алга болгох шившлэгээр сагсан дахийг арилгав.

Огих чимээг дагалдан үзэгчдийн шинийг захиалан хөгжилтэй хашгирах чимээ гарахад Харри ой ухаанаа Хүч оруулагч уусмалын найрлагад хүндхэн төвлөрүүлэв. Гермionaд ч гэсэн энэ тусалсангүй бололтой. Тэр Фред, Жорж хоёрын сагс руу бөөлжих тоолон дургүйцэн тургилж Харрийн тэсвэрийг барлаа.

- Үүнийг больж үз! гэж тэр грифоны нунтаг сарвууны жинг дөрөв дэх удаагаа буруу бичээд уурсан хэллээ.

- Би чадахгүй нь. Тэд зүгээр л ёс төдий дүр үзүүлж байна. Тэд өөрсдийн дуртай муухай зүйлсээ таарсан тэнэгүүдэд худалдаж байна ...

- Фред, Жорж хоёрыг яагаад зөвхөн гурван С.И.Ш авсан гэдгийг ойлгохгүй юм.

Тэд өөрсдийн ажлаа сайн мэддэг юм байна шүү гэж Харри хэлээд Жорж тэр хоёрыг худалдан авагчдынхаа алтыг сэтгэл хангалуун цуглуулахыг харлаа.

- Нүд хуурсан тоглоомд ямар ч ашиг байхгүй гэж Гермiona эсэргүүцэв.

- Ашиггүй гэнээ? Тэд хэдийн хорин зургаан галлеон цуглуулчихаад байна гэж Рон хэлэв.

Ихрүүдийг тойрон цугласан хүүхдүүд удтал тарсангүй учир амралтын өрөө шөнө дунд болоход хоосров. Фред хайрцагтай зоосоо шажигнуулан сэгсрээд эрэгтэйчүүдийн унтлагын өрөөний үүдийг хаав. Харри ажилдаа маш бага төвлөрч байсан ч өнөөдөр дуусгахаар шийдэв. Түүнийг номоо хаамагц Рон сандал дээр зүүрмэглэж байснаа цочин сэрээд ханан зуух руу харлаа.

- Сириус! гэж тэр хэлэв.

Харри огцом эргэж хараад Сириусын сэгсгэр үстэй толгойг харлаа.

- Сайн уу гэж Сириус инээмсэглэн хэлэв.

- Сайн уу гэж тэд зэрэг мэндлээд зуухны өмнө өвдөглөн суулаа. Живоглот чанга хүржигнээд ханан зуух руу очиж халууныг үл тоомсорлон хошуугаа Сириус руу сунгав.
 - Юу байна даа? гэж Сириус хэлэв.
 - Тийм ч сайнгүй. Ид шидийн яамнаас ахин нэг хууль гаргаж биднийг квиддич тоглохыг хориглосон гэж Харри хэлэхэд Гермiona Живоглотыг сахлаа хуйхлахаас өмнө хойш нь татав.
 - Хар урлагаас хамгаалах нууц дугуйланыг ч гэсэн үү? гэж Сириус хэлэв. Нам гүм болов.
 - Чи яаж мэдээ вэ? гэж Харри гайхлаа.
 - Уулзалт хийх газраа ухаалаг сонгон авч бай. «Гахайн толгой» бол илт газар гэж тэр нүүр дүүрэн инээмсэглэн хэллээ.
 - Гэхдээ л «Гурван шүүр»-ээс дээр шүү дээ. Тэнд үргэлж дүүрэн хүнтэй байдаг гэж Гермiona эсэргүүцэв.
 - Тэр тусмаа та нарыг сонсох боломж бага. Чи бас л суралцах хэрэгтэй байна даа, Гермiona.
 - Хэн биднийг сонссон юм? гэж Харри асуулаа.
 - Наземникус л байхгүй юу гээд Сириус тэдний гайхсан төрхийг харж инээмсэглээд,
 - Тэр гивлүүртэй шидтэн байсан юм гэлээ.
 - Наземникус уу? Тэр «Гахайн толгой»-нд юу хийж байсан бэ? гэж Харри мэгдэн асуулаа.
 - Чинийхээр бол юу хийх ёстой гэж? Чамайг л харж байхгүй юу гэж Сириус хэлэв.
 - Намайг одоо хүртэл дагасаар байгаа юм уу? гэж Харри уурсан асуулаа.
 - Тиймээ харж байгаа. Тэгээд чиний хууль бус хамгаалах дугуйлан цуглуулж байгаа талаар чинь мэдсэн.
- Гэхдээ тэр уурлах юмуу түгшсэн янзтай харагдсангүй. Эсрэгээрээ Харригаар бахархсан шинжтэй харагдаж байлаа.

- Тэгвэл Назем яагаад биднээс нуугдсан юм бэ? Бид түнийг хараад баярлах байсан гэж Рон урам хугарсан янзтай дуугарав.

- Тэр «Гахайн толгой»-ноос хорин жилийн өмнө хөөгдсөн. Харин энэ баарны эзэн хэтэрхий сайн дурсамжтай. Бид Стержисыг баригдах үед Грюмын үл үзэгдэгч цувьг алдсан болохоор Назем сүүлийн үед үргэлж гивлүүртэй шидтэн болж хувирч байгаа ... Юуны түрүүнд гэвэл Рон чамд эхээс чинь дамжуулах үг байна.

- Юу юм? гэж Рон таагүйхэн хэлэв.

- Тэр чамайг ямар ч тохиолдолд нууц хар урлагаас хамгаалах дугуйланд оролцож болохгүй гэсэн. Чамайг хөөгдөх учир амьдрал чинь сүйрэх болно. Чамд өөрийгөө хамгаалж сурах хангалттай цаг байгаа бөгөөд энэ тухай санаа зовоход эрт байна гэсэн. Үүнээс гадна Харри, Гермiona хоёрт энэ ажлаа болихыг зөвлөсөн. Тэр үүнийгээ бичсэн ч ууль илгээж чадахгүй учир явуулаагүй л дээ. Тэр үүнийгээ өөрөө хэлэх боломжгүй байгаа юм. Өнөөдөр жижүүрлэж байгаа.

- Ямар жижүүр? гэж Рон гайхлаа.

- Энэ чухал биш бүлгийн ажил байгаа юм. Тийм учраас намайг заавал дамжуулаад чамд хэлсэн гэх баталгаа авахыг хүссэн. Учир нь тэр надад итгэдэггүй юм.

Ахин чимээгүй болоход Живоглот дуугаран Сириусын толгой руу сарвуугаараа хүрэхийг оролдоход Рон ханан зуухны өмнөх хивсний нүхээр оролдов.

- Чи намайг хамгаалах дугуйланд оролцохыг хүсэхгүй байгаа юм уу? гэж Харри эцэст нь бувтналаа.

- Би юу? Огтхон ч үгүй. Минийхээр бол гайхамшигтай бодол байна! гэж Сириус гайхширан хэллээ.

- Үнэн үү? гэж Харри баярлав.

- Тэгэлгүй яахав! Аав бид хоёр чинь байсан бол энэ хөгшин шулам Амбрижийн тушаалыг зөрчихийн тулд яах байсан гэж бодож байна?

- Гэхдээ чи өнгөрсөн хичээлийн жилийн турш эцэс төгсгөлгүй эрсдэлд орохгүй болгоомжтой бай гэж давтаад байсан биз дээ.

- Өнгөрсөн жил Харри Хогвартсын дотор чамайг алах гэсэн хэн нэг хүн байсан!

Энэ жил Хогвартсын гадаа чамайг алахыг хүсч байгаа хүн байгаа болохоор өөрийгөө хамгаалж сурах бол сайхан бодол гэж хэлэх байна! гэж Сириус тэсвэр алдан хэлэв.

- Хэрвээ биднийг хөөчихвөл яах вэ? гэж Гермiona асуулаа.
- Гермiona, энэ чинь чиний санаа биз дээ! гэж Харри хэлэв.
- Би мэднэ. Зүгээр л Сириус юу бодож байгаа нь сонирхолтой байна.
- Сургуульд юу ч чадахгүй аюулгүй сууж байснаас хамгаалж чаддаг болоод хөөгдсөн нь дээр шүү.
- Зүйтэй үг байна! гэж Харри, Рон хоёр дэмжив.
- Тэгэхээр бүлгээ зохион байгуулсан уу? Хаана цуглах гэж байна?
- Энэ л асуудал болоод байна. Хаана уулзахаа мэдэхгүй байна гэж Харри хэлэв.
- Орилоо овоохойд яах бол? гэж Сириус санал болгов.
- Сайхан санаа байна! гэж Рон дуу алдсан ч Гермiona үл тоомсорлосон чимээ гаргалаа.

Гурвуулаа түүн рүү эргэн харав.

- Сириус та нар Орилоо овоохойд цуглах үедээ дөрвүүлхнээ байсан шүү дээ.
- Бас бүгдээрээ амьтан болон хувирч нэг үл үзэгдэх цув дотор багтдаг байсан. Харин бид хорин наймуулаа нэг ч анимаг байхгүй үл үзэгдэх цацар л байдаггүй юм бол ...
- Шударга үг байна гэж Сириус сэтгэлээр унасан янзтай хэлээд,
 - Гэхдээ өөр юм бодож олж болно гэдэгт итгэлтэй байна. Дөрвөн давхарын толины ард ашиглаж болохоор нууц хонгил байгаа. Тэнд бэлтгэл хийж болно байх.

Харри толгойгоо сэгсэрлээ.

- Фред, Жорж хоёр адар нь нурсан гэсэн.
- Аан. Би бас өөр ... гэж Сириус хөмсөг зангидан хэлэв.

Тэр яриагаа дуусгасангүй. Түүний царай гэнэтхэн түгшсэн янзтай болж тоосгон хана руу эргэн харлаа.

- Сириус? гэж Харри дуу алдлаа.

Гэхдээ тэр алга болчихлоо. Харри гал руу хэсэг зуур ширтсэнээ Рон, Гермiona хоёр луу харлаа.

- Тэр яагаад гэнэт?

Гермиона гэнэт айн дуу алдаад зуух руу харсаар үсрэн босов.

Галын дунд богинохон булцгар хуруутай гар хэн нэгнийг барихыг хүссэн мэт самардав.

Хүүхдүүд хар хурдаараа зугтлаа. Эрэгтэйчүүдийн унтлагын өрөөний өмнө очоод Харри эргэж харлаа. Амбрижын гал дахь гар хормын өмнө Сириусын үс байсан газар зуурахыг хүссэн мэт тэмтчиж байв.

БҮЛЭГ 18: ДАМБЛДОРЫН АРМИ

- Амбриж чиний шууданг уншсан байна, Харри. Өөр тайлбар алга.
- Чи Амбриж Хэдвигийг дайрсан гэж бодож байна уу?
- Бараг л итгэлтэй байна. Мэлхийгээ хараач зугтаж байна гэж Гермиона хэлэв.

Харри ширээний өнцөг дээр баяртай дэвхцэн гуаглаж байгаа мэлхий рүү саваагаа чиглүүлэв.

- Акцио! Мэлхий хөөрөн түүний гарт баригдав.

Шившлэг хичээл үргэлж хоорондоо ярилцахад тохиромжтой газар болдог билээ. Тийм их чимээ шуугиан дунд нууцаар хүн сонсож чадахгүй. Өнөөдөр ангид мэлхий гуаглах болон хэрээний сөөнгөтөн гуаглах дуу, цонхны шилийг бороо нижигнүүлэн нүдэх чимээнд Харири, Рон, Гермиона гурав шивнэлдэх зовлонгүй Амбриж Сириусыг барих шахсан тухай ярилцаж байлаа.

- Би Филчийг шивхэн бөмбөг захиалсан гэж буруутгасан үеэс л сэжиглэсэн юм. Тоогоогүй өнгөрсөн нь тэнэг хэрэг хэрэг болж. Чи тэднийг захиалаагүй нь ойлгомжтой байсан шүү дээ. Чамд тийм тэнэг зүйл захиалах ямар хэрэг байгаа юм бэ? Харин би дараа нь хэн нэгэнд чиний захиаг унших шалтгаан байсан юм болов уу гэж бодсон л доо. Амбриж үүнийг өлхөн чадна. Тэр Филчээр захиа шалгах, замаас нь хулгайлах юм уу үзүүлэхийг шаардсан хар ажлаа хийлгэсэн байх. Филч мэдээж сурагчийн талд орон түүнийг эсэргүүцэхгүй. Харри, чи мэлхийг бяцлах нь байна гэж Гермиона хэлэв.

Харри гар луугаа харахад мэлхийн нүд бүлтийж байсанд ширээн дээр түргэн тавилаа.

- Өнөөдөр орой бүх зүйл тодорхой боллоо. Амбриж яаж амжилт ойрхон байгааг мэдсэн юм бол? Силенцо.

Мэлхий Чимээгүй болгох шившлэгт дүйнгэтэн зэмлэнгүй харлаа.

- Хэрвээ тэр Ньюхалзыг барьсан бол ...
- Өнөө өглөө Азкабанд байх байлаа гэж Харри яриаг нь дуусгав.

Тэр сэтгэлээр унан шидэт саваагаа даллалал мэлхий ногоон бөмбөлөг адил хөөгөөд писхийн исгэрэх чимээ гарав.

- Силенцо! гэж Гермиона мэлхий рүү саваагаа чиглүүлэн түргэхэн хэлээд чимээгүйхэн хийг нь гаргаж, Тэр тэгэх ёсгүй байсан юм. Түүнд яаж анхааруулахаа ч мэдэхгүй байна. Ууль илгээж болохгүй байдаг гэв.

- Би түүнийг ахин эрсдэлд орно гэж бодохгүй байна. Тэр тэнэг биш шүү дээ. Тэр баригдах шахсанаа ойлгож байгаа. Силенцо! гэж Рон хэлэв. Том зэвүүн хар хэрээ урдаас нь тохуурхан гуаглав.

- Силенцо. Силенцо! Хэрээ улам чанга гуаглав.

- Чи саваагаа буруу хөдөлгөөд байна. Огцом хөдөлгөж болохгүй гэж Гермиона хэлээд түүнийг шүүмжлэнгүй харав.

- Хэрээ мэлхийнээс илүү хэцүү гэж Рон шүд зуун хэлэв.

- Сайн байна тэгвэл сольё гэж Гермиона хэлээд Роны хэрээг мэлхийгээрээ солин тавилаа. Силенцо!

Хэрээ үргэлжлүүлэн хошуугаа ангалзуулсан ч чимээ гарсангүй.

- Маш сайн байна, хатагтай Грэйнджер! Харин одоо ноён Уизли оролдоод үз дээ гэх профессор Флитвикийн дуу тэдний ард гарахад бүгд цочив.

- Аан? ... Тийм л дээ, тийм одоохон гэж Рон агшин зуур улайгаад,

- Э-э ... Силенцо! гэв.

Тэгтэл мэлхий чанга гуаглаад ширээн дээрээс шал руу үсрэв.

Харри, Рон хоёр Чимээгүй болгох шидийг гэрийн даалгавартаа нэмэлтээр авсан явдалд хэн ч гайхсангүй.

Гадаа аадар бороотой учир сурагчдыг дотор байхыг зөвшөөрчээ. Тэднийг нэг давхарын чимээ шуугиантай ангид сул газар эрэх үед Пивз мөрөөдөнгүй лааны бүрхүүл тойрон хөвж үе үе бэхийн сав хэн нэгний шилэн хүзүү рүү унагана. Тэднийг суумагц Анжелина Жонсон хоорондоо ярилцаж байсан хүүхдүүдийн дундуур зүтгэлэн ирэв.

- Би зөвшөөрөл авчихсан! Багаараа цугларч болно!

- Гайхамшигтай! гэж Рон, Харри хоёр дуу алдав.

- Тиймээ гэж Анжелина баясан хэлээд,

- Би МакГонагалл руу очсон болохор түүнийг Дамблдорт хэлсэн байх гэж

бодож байна. Ямар ч гэсэн Амбриж зөвшөөрөл өгсөн. Ха! Та нарыг орой долоон цагаас талбай дээр хүлээж байя. Бид алдсан цагаа нөхөх хэрэгтэй байна. Та нар эхний тэмцээн ердөө гурван долоо хоногийн дараа гэдгийг ойлгож байна уу? гэв.

Түүнийг явмагц Пивзийн унагасан бэхийн сав нэгдүгээр дамжааныхны хажууд хагарлаа.

Рон цонхны шил балбаж байгаа бороо руу хараад инээмсэглэхээ болив.

- Орой намдана гэж найдаж байна. Чи яагаа вэ, Гермiona?

Тэр бас цонх руу харж байсан ч бороог харсангүй. Харц нь төвлөрсөн юмгүй хөмсөг зангидан ширтэж байв.

- Би бодлоо л доо ... гээд бороонд угаагдсан цонх руу ширтсэн хэвээр байв.

- Сири ... Нюлхазын тухай юу? гэж Харри асуулаа.

- Үгүй ... тийм биш ... өөр юм ... Бид зөв зүйл хийж байгаа эсэх ... Та нарынхаар бол?

Харри, Рон хоёр бие бие рүүгээ харлаа.

- Аан энэ ч ажил хэргийг тодруулж байна шүү. Чи арай тодорхой хэлж болохгүй байна уу? гэж Рон хэлэв.

Гермиона сая л түүний байгааг санасан мэт харав.

- Би зүгээр л бодсон юм. Бид хар урлагаас хамгаалах дугуйлан байгуулснаараа зөв зүйл хийсэн болов уу гэж.

- Юу? гэж Харри, Рон хоёр зэрэг хэллээ.

- Гермiona, энэ чиний санаа байсан! гэж Рон дургүйцлээ.

- Мэднэ. Гэхдээ Нюлхазтай ярьсан ярианы дараа ... гээд Гермiona хуруугаараа оролдов.

- Тэр бүрэн бүтэн байгаа гэж Харри хэлэв.

- Тийм л дээ. Ийм учраас бид зөв зүйл бодсон эсэхэд би эргэлзсэн юм гэж хэлээд ахин цонх руу ширтлээ.

Пивз тэдний дээгүүр сөнөөгч онгоц шиг хөвөхөд бүгд цүнхээрээ толгойгоо халхлав.

- Алив учраа олцгооё. Сириус биднийг дэмжиж байгаа учир чи татгалзах

хэрэгтэй гэж бодоо юу? хэмээн Харри цүнхээ газар тавиад ууртай хэллээ.

Гермиона ихэд золгүй харагдав. Тэр гар луугаа ширтэн,

- Харин чи түүний бодолд итгэж байна уу? гэв.

- Тиймээ, итгэж байна! Тэр үргэлж гайхамшигтай зөвөлгөө өгдөг юм!

Бэхийн сав тэдний дэргэдүүр нисэн өнгөрч Кэти Беллийн чихийг онов. Кэти хойш үсрээд дээшээ харж ухасхийн холдов. Гермиона түүн рүү харан ярьж эхлэхдээ үгээ маш болгоомжтойгоор сонгож,

- Та нарт ... түргэдсэн юм шиг санагдахгүй байна уу ... тэр Гриммогийн арван хоёрдугаар байшинд нуугдаж байгаа биз дээ? Та нарт тэр бидний дунд байгаа юм шиг санагдахгүй байна уу?

- Бидний дунд байгаа гэдэг чинь юу гэсэн үг юм? гэж Харри гайхлаа.

- Миний бодлоор ... тэр ид шидийн яамны хамар дор нууц хамгаалалтын нийгэмлэг байгуулах болсондоо хөөрч байгаа ... Тэр цоожтой юу ч хийх боломжгүй сууж байгаадаа гутраад ... биднийг мөрдөж байгаа юм.

Рон ихэд гайхсан байртай харагдав.

- Сириусын зөв. Чи яг миний эх шиг ярьж байна.

Гермиона уруулаа хазаад үг хэлсэнгүй. Хонх дуугарахад Пивз бүх бэхээ Кэти Беллийн толгой руу асгалаа.

Өдөр үргэлжилсээр орой болоход цаг агаар дээрдсэнгүй. Харри, Рон хоёр долоон цагаас шалба норсон өвсөн дээгүүр хальтирсаар квиддичийн бэлтгэл хийхээр явлаа. Тэнгэрт бараан үүл сүртэй хуралдсан учир дулаахан гэрэлтэй хувцас солих өрөөнд орж санаа амрахдаа энэ удаан үргэлжлэхгүй гэдгийг мэдсэнгүй. Фред, Жорж хоёрыг Ажлаас зайлсхийгч зуушаа хэрэглэх эсэхдээ маргалдана.

- Тэр шууд л тааварлана даа. Би яах гэж өчигдөр түүнд зарав аа? гэж Фред хэлэв.

- Магадгүй Халууруулдаг чихрээ туршаад үзэж болох юм биш үү? Түүнийг хэн ч хараагүй байгаа.

- Тэр үнэхээр үйлчилэх үү? гэж Рон найдангүй асуугаад дээвэр нижгэнэтэл балбаж байгаа бороо болон цонхны цаана улин исгэрэх салхи руу харлаа.

- Ер нь бол тийм. Биеийн хэм чинь өснө гэж Фред хэллээ.
 - Чи бас идээтэй том хатигтай болж болно. Бид харин яаж түүнээс салах талаар бодоогүй байгаа гэж Жорж хэлэв.
 - Би ямар ч хатиг харахгүй байна гээд Рон ихрүүд рүү харав.
 - Мэдээж харахгүй. Тэд хүмүүсийн үзүүлэх дургүй газар дээр гардаг юм гэж Фред хэллээ.
 - Гэхдээ шүүрэндээ суумагц яаж өвдөнө гээч. Өрөөнд Анжелина орж ирлээ.
 - За, бүгдээрээ намайг сонсоцгоо. Би цаг агаар тийм сайхан биш байгааг мэдэж байгаа ч бидэнд Слизеринтэй ийм нөхцөлд тоглох хэрэг гарвал ашиг нь гарах болно. Харри чи шилээ Пуффендуйтай тоглсон үеийнх шиг бороонд нордоггүй болгож болохгүй юу?
 - Гермiona тэгсэн юм гээд Харри шидэт саваагаараа шилээ тогшоод,
 - Импервиус! гэлээ.
 - Алив бүгдээрээ оролдоод үзэцгээе. Хэрвээ царайгаа бороонд норгодоггүй болгочихвол харахад их хэрэгтэй байна. Алив хамтдаа Импервиус! Болчихлоо, явцгаая.
- Тэд саваагаа жанчныхаа халаасанд буцааж хийгээд шүүрээ мөрөн дээрээ тавин Анжелинагийн араас хувцас солих өрөөнөөс гарлаа.
- Талбайн дунд гүнзгий шавар шавхай үүсчээ. Импервиус шидийн харагдац хөөрхийлөлтэй байлаа. Бүүдгэр өдөр болохоор бороон хөшиг газар шавхуурдана.
- Шүгэл үлээлээ шүү! гэж Анжелина хашгирав.

Харри шавар цацлан газар түлхэн агаарт хөөрөхдөө салхинд арай л шидэгдсэнгүй.

Тэр ийм цаг агаартай байхад снитчийг яаж олж харахаа төсөөлөхгүй байлаа. Тэр ч байтугай бэлтгэлдээ авчирсан ганц блажерыг ч олж харахад бэрх байсан бөгөөд олж харсан сүүлийн мөчдөө огцом эргэн бултлаа. Харамсалтай нь үүнийг Анжелина харсангүй. Ер нь бол тэр юу ч харсангүй. Тэдний хэн ч бусдынхаа юу хийж байгааг харахын нөхцөлгүй байв. Салхи ширүүсэхэд Харри бороо нуурын гадаргууд шаагих чимээг сонслоо.

Анжелина тэдний бараг цаг хөөгөөд ялагдсанаа хүлээхээс өмнө бууж өгөв. Норж

уцаарласан багийнхан хувцас солих өрөөнд ирэхэд тэр бэлтгэл хоосон өнгөрөөгүй гэж баталж байсан ч итгэлтэй өнгө хоолойд нь үгүй байлаа. Ялангуяа Фред, Жорж хоёр уурсан хөдлөх бүрдээ ярвайцгааж байв. Харри толгойгоо алчуураар арчихдаа тэдний гомдоллохыг сонслоо.

- Миний хэдэн хатиг хагарчихлаа гэж Фред хэлэв.

- Минийх бол үгүй. Аймшигтай таталдаж байна ... улам томорч байх шиг байна гэж Жорж үрчийн хариулав.

- Ёо! гэж Харри дуу алдав.

Тэр өвдсөндөө алчуураа нүүрэндээ хүчтэй наалаа. Сорви нь галаар төөнөж байгаа юм шиг өвджээ.

- Юу болоо вэ? гэх хоолой сонсогдов.

Харри алчуураа нүүрнээсээ холдуулахад хувцас солих өрөө бүүдгэртэн үзэгдэж нүдний шилгүй байгаа бөгөөд бүгд түүн рүү харж байгаа болохыг ойлгов.

- Зүгээр дээ. Нүд рүүгээ хатгачихлаа.

Гэхдээ тэр багийнхнаа жанчаа өмсөн малгайгаа чих рүүгээ дараад өрөөнөөс гарахад Рон руу учиртай харлаа.

- Юу болоо вэ? Сорви уу? гэж Рон Алисияг хаалга хаах агшинд асуулаа. Харри толгой дохив.

- Гэхдээ тэр ойрхон байх боломжгүй юм? гэж Рон айдаст автан хэлээд харанхуй бороотой цонх руу харлаа.

- Үгүй ээ. Эндээс олон милийн зайд байгаа байх. Өвдсөн учир гэвэл ... тэр ... уурлаж байна.

Харрийн хэлсэн үг түүний чихэнд сонсогдох шиг болов. Тэр тэдний зөв гэдгийг шууд ойлгов. Яагаад гэдгийг нь мэдэхгүй байсан ч ойлгож байлаа. Одоо Волдеморт хаана ч байсан гэлээ энэ агшинд уурлаж байна.

- Чи түүнийг харсан уу? Чамд ... ямар нэг зүйл үзэгдэв үү? гэж Рон эмээнгүй асуулаа.

Харри хөдөлгөөнгүй суугаад хөлөө ширтэн өвдөлтийн дараа тайвширахыг оролдов. Бүүдгэр дүрс хашгирах хоолой ...

- Тэр ямар нэг юм хийлгэхийг хүссэн ч хэтэрхий удаан болжээ. Ингээд ахиад л энэ үг амнаас гарав уу үгүй үнэн гэдгийг нь гайхан мэдрэв.

- Гэхдээ ... чи хаанаас мэдэж байгаа юм?

Харри нүдээ алгаараа дараад толгой сэгсэрлээ. Тэр Рон дэргэд нь суугаад түүнийг харж байгааг мэдрэв.

- Өнгөрсөн удаагийнтай адил байна уу? Амбрижийн өрөөнд сорви өвдсөн шиг.

Хэцүү нэрт уурлаж байна уу? гэж Рон сулхан хоолойгоор асуув. Харри толгой сэгсрэв.

- Тэгвэл юу гэж?

Харри энэ ямар байсныг санах гэж хичээв. Тэр Амбрижын царай луу хартал ... сорви нь өвдөж ... дотор нь хачирхалтай мэдрэмж төрсөн ... баяртай байгаа юм шиг ... тэгэхэд тэр ойлгоогүй болохоор золгүй байгаагаа мэдэрсэн.

- Үгүй ээ, өнгөрсөн удаад тэр баяртай байсан. Их баяртай байсан. Тэр ямар нэг таатай юмны тухай бодож байсан. Харин сургуульд ирэх өдрийн өмнөх шөнө тэр галзууртлаа уурласан ... гэж Харри Гриммогийн арван хоёрдугаар байшинд Роны хамт унтлагын өрөөнд байхад сорви нь хэрхэн өвдсөнийг санаад хэллээ.

Рон түүнийг нүдээ томруулан ширтээд,

- Найз минь чи Трелони шиг болж байх шиг байна гэж бишрэнгүй хэлэв.

- Би ямар ч зөгнөл хэлээгүй шүү дээ.

- Үгүй, чи юу хийж байгааг мэдэж байна уу? Харри, чи Хэцүү нэртийн бодлыг уншиж байна! гэж Рон айж гайхах зэрэгцэн хэлэв.

Харри толгойгоо сэгсэрлээ.

- Үгүй ээ. Зөвхөн ... сэтгэл хөдлөлийг нь. Би зөвхөн түүний араншингийн тусгалыг авдаг юм. Дамблдор өнгөрсөн жил бас үүнтэй адилхан юм ярьсан. Тэр Волдеморт хэтэрхий ойрхон байх юм уу уурлавал намайг мэдэрдэг гэсэн. Харин би одоо түүний сэтгэл хангалуун байгааг мэдэрч байна.

Нам гүм болов. Салхитай бороо байшингийн дээврийг шавхуурдана.

- Чи хэн нэгэнд хэлэх ёстой.

- Өнгөрсөн удаа Сириуст хэлсэн биз дээ.

- Тэгвэл одоо хэл.
- Яаж тэр вэ? Амбриж ууль болон ханан зуухнуудыг хянаж байгааг мартчихаа юу?
- Тэгвэл Дамблдор.
- Түүнийг мэдэж байгаа гэж чамд хэлээд байна шүү дээ. Ахиж хэлэх ямар хэрэгтэй юм гээд Харри босож жанчаа өлгүүрээс авлаа.

Рон жанчаа өмсөж буй Харри руу бодлогоширон ширтэнэ.

- Дамблдор энэ тухай мэдэхийг хүсч байж болох юм. Харри мөрөө хавчлаа.
- Алив ээ ... Явж Чимээгүй болгох шившлэгээ сургуулилцгаая.

Тэд харанхуй нуга дээгүүр шаварт гулгаж бүдчин яаран явлаа. Хоёулаа чимээгүй байв. Харри гүнзгий бодолд автлаа. Волдемортыг юу тэгж уурлуулсан юм бол?

Түүнд өөр төлөвлөгөө байгаа ... тэр үүнийгээ чимээ шуугиангүй хийхийг хүсэж байгаа ... нууцаар авах гэж байгаа юм ... ямар нэг ... зэвсэгтэй төстэй зүйлийг ... Түүнд өнгөрсөн удаад байсан шиг.

Харри удтал энэ үгийн тухай бодсонгүй. Тэр Хогвартсад ирээд яамны бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох гэсэн Амбрижтай тэмцэл хийж хэтэрхий завгүй байсан ... харин одоо энэ бодол ахин орж ирэв ... Волдемортын уур хилэнг зэвсгэндээ хүрч чадаагүйгээр тайлбарлаж болох юм. Бүлэг түүний төлөвлөгөөг тасалдуулахын төлөө байгаа биш үү? Тэр хаана хадгалагдаж байгаа бол? Тэр хэнд байгаа бол?

- Мимбулус мимблетония гэх Роны хоолой сонсогдоход Харри араас нь даган хөргөн нүхээр амралтын өрөөнд орлоо.

Гермиона эрт унтсан бололтой Живоглот сандал дээр цагариглан хэвтээд зуухны хажуугийн ширээн дээр үйлчлэгчийн эв хавгүйхэн нэхсэн малгай байлаа. Харри түүнд сорвиныхоо өвдөлтийн тухай ярьж Дамблдор руу яв гэж зөвлөхийг нь сонсохыг хүсээгүй болохоор байхгүйд нь баярлалаа. Түүнийг зохион бичлэгээ дуусгахаар шившлэгийн номоо дэлгэхэд Рон түгшсэн шинжтэй харлаа. Гэхдээ Роныг унтахаар явах хүртэл төвлөрч байгаа худал дүр үзүүлж байсан болохоор хэдхэн мөр бичиж амжжээ.

Шөнө дунд болох хүртэл тэр өвс ургамлыг хэрхэн ашиглах тухай уншиж өнгөрүүлэв.

Энэ ургамал уур хилэнг намдаах нөлөөтэй бөгөөд Бухимдаж түргэдсэн аашийг засах

уусмалд хэрэглэдэг бөгөөд шидтэнгүүдийн хүслэн болсон ...

... Гермиона Сириусыг Гриммогийн байшинд түгжээтэй сууж байгаа болохоор түргэдсэн гэсэн.

... Уур хилэнг намдаах нөлөөтэй бөгөөд бухимдаж түргэдсэн аашийг засахад хэрэглэддэг бөгөөд ...

... «Өдөр тутмын Зөнч» сонин хэрвээ түүнийг Волдемортын сэтгэл хөдлөлийг мэдэрдэг гэж шинших юм бол ...

... За яахав. Тэр яагаад Волдемортын сэтгэл хөдлөлийг мэдэрдэг юм бол? Ямар аймшигтай холбоо бий болоод Дамблдор хүртэл тайлбарлаж чадахгүй байгаа юм бол?

... шидтэнгүүдийн хүсэл болсон ...

... яг л Харрийн унтахыг хүсч байгаа шиг

Цонхны гадаа аадар бороо шаагиж байхад ханан зуухны хажуу дахь сандал дээр дулаахан аятай байлаа. Живоглот тас нясхийх гал руу харан хүржигнэв.

Ном Харрийн суларсан гараас бөглүү чимээ гаран хивсэн дээр унав. Харрийн толгой унжлаа ...

Тэр ахин цонхгүй харанхуй хонгилоор явж байх агаад нам гүм байв. Хонгилын эцсийн хаалга сүүмэлзэн үзэгдэхэд зүрхний цохилт нь түргэсэн ... хэрвээ түүнийг нээвэл ... тийшээ орвол ...

Түүний гар өргөгдлөө ... хуруу нь ердөө хэдхэн инчийн зайд ...

- Харри Поттер, ноёнтоон!

Тэр цочин сэрлээ. Амралтын өрөөний гэрэл хэдийн унтарч дэргэд нь нэг юм хөдлөв.

- Тэнд хэн байна? гээд Харри суудал дээрээ өндийлөө. Зуухны гал бөхөж өрөөнд харанхуй байлаа.

- Доббид таны ууль байна, ноёнтоон! гэх часхийсэн дуу гарав.

- Добби юу? гэж Харри хэлээд харанхуй руу харав.

Добби гэрийн үйлчлэгч Гермионагийн нэхсэн малгайнуудаа орхисон ширээний хажууд зогсож байв. Түүний том дэлдэн чих Гермионагийн нэхсэн малгайны давхарлан өмссөн бүхэл бүтэн цуглуулга дороос дэрчийж байсан учир толгой нь

хоёр гурван футээр өссөн юм шиг санагдах ажээ. Хамгийн дээд талд нь Хэдвиг сууж байв. Тэр тайван гууглахыг бодвол эдгэрсэн бололтой.

- Добби сайн дураараа Харри Поттерийн уулийг нь авчирлаа. Профессор Граббли Дерг түүнийг эрүүл болсон гэж хэлсэн, ноёнтоон гэж үйлчлэгч хүндэтгэлтэй хэлээд гүнзгий мэхийн ёслохдоо харандаа шиг урт хамраараа сэмэрсэн хивсэнцэр шүргэхэд Хэдвиг уурсан гууглаад Харрийн сандлын түшлэг дээр буув.

- Баярлалаа, Добби!

Харри хаалганы тухай дүр зургийг мартахыг хичээн Хэдвигийн толгойг илэхэд нүдээ анивчлаа ... энэ маш тод байсан. Тэр Добби руу хараад үйлчлэгч хэд хэдэн ороолт болон маш олон тооны оймс давхарлан түнтийлгэж өмссөнийг ажиглав.

- Чи Гермionaгийн нэхсэн хувцсыг бүгдийг нь өмсчихсэн юм уу?

- Үгүй дээ, ноёнтоон. Добби бас Винкид өгсөн гэж үйлчлэгч баяртайгаар мэдэгдэв.

- Винки хэр байна? Доббийн чих унжлаа.

- Винки урьдын адил уусаар байгаа, ноёнтоон гэж үйлчлэгч гашуудалтайгаар хэлээд одон бөмбөг шиг бүлтгэр ногоон нүдээрээ урвайн доош харлаа.

- Тэр хувцсандаа анхаарал тавихгүй байгаа, ноён Харри Поттер. Яг л бусад гэрийн үйлчлэгч шиг. Тэдний хэн ч Гриффиндорын цамхагаас малгай, оймс авахыг хүсэхгүй байгаа. Тэд үүнийг доромжлогдсон гэж үзэж байгаа юм, ноёнтоон. Харин Добби бүгдийг өөртөө авсан. Добби үргэлж Харри Поттертой уулзахаар шөнө болгон ирдэг юм! гээд үйлчлэгч ахин мэхийн ёслов.

- Гэхдээ ноён Харри Поттер гашуудалтай байгаа юм шиг санагдлаа гээд тэр босч эмээнгүй харснаа, Добби түүний зүүдэндээ ярихыг сонссон. Харри Поттер муухай зүүд зүүдлээ юу? гэв.

- Тийм ч муу биш дээ. Үүнээс ч дор бас байсан юм гэж Харри эвшээн хэлээд нүдээ нухлав.

Добби түүн рүү бүлтгэр ногоон нүдээрээ хараад чихээ унжуулав.

- Добби Харри Поттерт туслахыг хүсч байна. Харри Поттер Доббиг чөлөөлсөн болохоор илүү аз жаргалтай болсон.

- Чи тусалж чадахгүй, Добби. Гэхдээ санал болгосонд баярлалаа гэж Харри

инээмсэглэв.

Тэр уусмалын номнуудаа цуглуулав. Маргааш зохион бичлэгээ бичиж дуусгахаас. Тэр номоо хаахад зуухны бүдэг гэрэлд гаран дээрх Амбрижийн шийтгэлийн сорви харагдав.

- Хүлээгээрэй, Добби. Чи надад тусалж чадах юм шиг байна. Үйлчлэгч баяртай эргэв.

- Зөвхөн хэлэхэд болно, ноён Харри Поттер!

- Надад хар урлагаас хамгаалахад хорин найман хүн хичээллэж болох багш нарын мэдэхгүй тийм газар хэрэгтэй байна. Ялангуяа профессор Амбриж гээд сорвио цайртал гараа зангидав.

Тэр үйлчлэгчийн царайнаас инээмсэглэл алга болж, чих нь унжих юм уу, ямар нэгэн зүйл олохыг оролдъё гэж хэлэхийг хүлээсэн авч болсонгүй. Түүний гайхлыг төрүүлэн Добби үсрээд чихээ баяртай хөдөлгөн алгаа хавсрав.

- Добби гайхамшигтай газар мэднэ, ноёнтоон! Добби түүний тухай Хогвартсад ирээд бусад үйлчлэгч нараас сонсож байсан. Түүнийг Орж гардаг өрөө юм уу эсвэл Шаардлагатай өрөө гэдэг!

- Яагаад? хэмээн Харри сониучирхлаа.

- Яагаад гэвэл энэ өрөөнд зөвхөн жинхэнэ хэрэгцээтэй байгаа хүн л орж чадна.

Тэр заримдаа гарч ирээд заримдаа үгүй болдог бөгөөд гарч ирэхдээ гуйгчийн хүссэн зүйлээр тоноглогдсон байдаг юм. Добби бас ашиглаж байсан ноёнтоон гээд үйлчлэгч дуугаа намсган гэмшингүй харж,

- Винкиг согтуу байх үед нь оруулсан юм. Тэр түүнийг Шаардлагатай өрөөнд нуухад цөцгийн шар айрагны эсрэг уусмал үйлчлэгчийн хэмжээтэй орны хамт байсан. Бас Добби ноён Филч нэмэлт цэвэрлээний материалаа тэндээс авдгийг мэднэ ... гэв.

- Хэрвээ чамд жорлон хэрэгтэй болвол хэмээн Харри өнгөрсөн жилийн бүжигт үдэшлэг дээр Дамблдорын хэлсэн үгийг санаж хэлээд,

- Суултуураар дүүрэн өрөө гарч ирэх үү? гэв.

- Тийм гэж бодож байна, ноёнтоон. Энэ бол гайхалтай өрөө байгаа юм.

- Түүний тухай хичнээн хүн мэдэх бол?

- Маш бага, ноёнтоон. Ихэнхи хүмүүс дэргэдүүр нь хэрэгтэй зүйлтэйгээ бүдчин явдаг ч ихэвчилэн олж чаддаггүй юм. Тэд тэнд үргэлж дуудахад бэлэн үйлчилгээ хүлээж байдагийг мэдэхгүй, ноёнтоон.

- Энэ ч гайхалтай сонсогдож байна гээд Харрийн зүрх хүчтэй цохиллоо.

- Юу хэрэгтэй вэ, Добби. Чи надад хэзээ үзүүлэх вэ?

- Хүссэн үед чинь, ноён Харри Поттер. Хэрвээ хүсч байвал одоо ч болно! гэж Добби урам зоригтойгоор хэллээ.

Энэ агшинд Харри Доббитой хамт явахаар бодсон ч сандлаасаа босож үл үзэгдэх цуваа авахаар гүйхийн урьд Гермionaгийн шивнэлттэй маш адилхан дуу чихэнд нь «түргэдсэн» гэж шивнэлээ. Эцсийн эцэст их орой болсон тэр эцэж ядарсан байлаа.

- Өнөөдөр биш, Добби гэж Харри дурамжхан хэлээд сандалдаа буцаж суулаа.

- Энэ бол маш чухал ажил болохоор би бүтэхгүй болоосой гэж хүсэхгүй байна.

Бүгдийг сайтар бодох хэрэгтэй. Чи надад эхлээд Шаардлагатай өрөө хаа байдаг болон яаж тийшээ орохыг хэлээч?

Тэднийг ургамал судлалын хоёр цагийн хичээлд орохоор шавар шалбаагтай ногооны талбай дундуур явахад салхи жанчных нь хормойг хийсгэж байв. Хүлэмжийн дээврийг мөндөртэй бороо нүдэж профессор Стеблейн үг арай ядан сонсогдоно. Үдээс хойш нь шидэт амьтаны хичээл дээр шуурга үргэлжилсэн учир нэг давхарын хоосон ангид хичээллэж, үдийн хоолон дээр бүгдийн санааг амраан Анжелина багийн гишүүдэд бэлтгэл цуцлагдсаныг хэлэв.

- Сайн байна, бид эхний уулзалтаа хийх газар олсон. Өнөөдөр найман цагаас долоон давхарын эсрэг талын Варновой Вздрюченны савдагууд зодолдож байгаа зураг шүү. Кэти Алисия хоёрт дамжуулаарай.

Тэр үл мэдэгхэн гайхсан ч бусаддаа дамжуулахаар амлав. Харри өлссөндөө нухаштай зайдас руугаа буцаж орлоо. Хормын дараа хулууны шүүс авахдаа түүн рүү Гермiona ширтэж байхыг харлаа.

- Яасан? гэж амаараа дүүрэн хоолтой асуув.

- Доббигийн төлөвлөгөө үргэлж аюулгүй байдаггүй. Тэр чиний гарны ясыг байхгүй болсоныг санаж байна уу?

- Энэ өрөө бол зөвхөн Доббийн бодол биш. Дамблдор бас түүнийг мэдэж байсан. Тэр бүжигт үдэшлэг дээр надад хэлсэн юм.

Гермионагийн царай гэрэлтэв.

- Дамблдор түүний тухай хэлсэн гэнээ?
- Зүгээр л дурссан юм гээд Харри мөрөө хавчлаа.
- Өө, тэгвэл сайн байна гээд тэр цаашаа дургүйцсэнгүй.

Тэд Роны хамт өдрийн ихэнхийг «Гахайн толгой»-нд цугларсан хүүхдүүдэд уулзах газрын тухай хэлж өнгөрүүлэв. Харри Жинни Чжоу болон түүний найзыг түрүүлж олсон явдалд урам хугарсан боловч оройн хоолон дээр хорин таван хүнд мэдээлэл хүрсэн гэдэгт итгэлтэй байлаа.

Долоо хагаст Харри, Рон, Гермиона гурав амралтын өрөөнөөс гарахад, Харри гартаа хуучин цаас барьжээ. Тавдугаар дамжааныханыг есөн цаг хүртэл хонгилоор явахыг зөвшөөрдөг учир гурвуулаа долоон давхарт гараад сэтгэл түгшин эргэн тойрноо харлаа.

- Хүлээгээрэй гэж Харри шатны сүүлчийн гишгүүр дээр зогсон анхааруулаад цаасыг нээн шидэт саваагаараа тогшиж,.
- Зөвхөн дүрсгүйтэнэ гэдгээ баясгалантайгаар тангараглаж байна гэж бувтналаа.

Хоосон цаасан дээр Хогвартсын газрын зураг гарч ирэв. Нэр бүхий жижигхэн хар цэгүүд хөдүүлж хүмүүсийн хаана байгааг заана.

- Филч хоёр давхарт байна. Харин хатагтай Норрис дөрвөн давхарт байна гэж Харри газрын зураг руу хараад хэлэв.
- Амбриж хаана байна? гэж Гермиона сэтгэл зовон асуулаа.
- Өрөөндөө байна. Сайн байна явцгаая.

Тэд яаран Доббийн тодорхойлон хэлсэн газар болох эсрэг талдаа Варнав Вздрюченногийн анхаарал татах гэж тэнэг савдагнууд бүжиглэх хана руу очив.

- Тэгэхээр гэж Харри цагаан эрвээхэйд идэгдсэн савдагууд бүжиглэхээ болиод тэдэн рүү харахад хэлэв. Добби энэ хананы дэргэдүүр гурван удаа явахдаа хэрэгцээтэй зүйлдээ сайн төвлөрөх ёстой гэсэн.

Тэд ийм маягаар цонх хүртэл яваад эргэж хүний биеийн хэмжээтэй ваарны дэргэд зогслоо. Рон нүдээ сөлийлгөн төвлөрсөн бол Гермiona ямар нэг үг бувтнаж байв. Харри нударга зангидан урагшаа хараад бодлоо.

«Бид тэмцэж сурах ёстой. Бидэнд бэлтгэл хийж болох газрыг өгөөч ... Хаанаас олох вэ»

- Харри! гэж Гермiona тэднийг гурав дахь удаагаа явсан хойно хашгирав. Хананд гялалзсан хаалга бий болжээ. Рон түүн рүү болгоомжлон харав. Харри зэс бариулаас татан үүдийг онгойлгоод бамбарын гэрлээр гийгүүлэгдсэн уужим танхимд түрүүлж оров.

Ханын дагуу номын тавиурууд үргэлжилэн шалан дээр сандлын оронд том хөвсгөр дэрүүд байлаа. Алсын булангийн шүүгээнд вредноскоп, стервовизор, худал хэлэхийг илрүүлэгч болон Харрийн жилийн өмнө Грюмын өрөөнд өлгөөтэй байхыг харсан дайсан илрүүлэгч том толь байлаа.

- Энэ чинь Хөшөөх шившлэг сургуулилахад тохиромжтой газар байна гэж Рон дэрийг урамтай өшиглөн дуу алдав.

- Хичнээн ном байгааг хараач! гэж Гермiona баяртай дуу алдаад хуруугаа арьсан хавтастай ботиуд дээгүүр гүйлгэв.

- «Хараал болон эсрэг хамгаалалтын цуглуулга», «Хар урлагыг зальдах нь», «Өөрийгөө шившлэгээс хамгаалах» ... Хөөх! гээд тэр Харри руу улаа бутран харснаа,

- Гайхамшигтай Харри! Энд бидэнд хэрэгтэй бүх зүйл байна! гэв.

Ингээд олон юм ярилгүй тавиур дээрээс «Шившлэг болон шившлэгүүд» гэсэн номыг авч ойролцоох дэрэн дээр суулаа.

Хаалга аяархан цохив. Харри эргэж харлаа. Жинни, Невилл, Лаванда, Парвати, Дин нар орж ирэв.

- Хөөх! Энэ юун газар вэ? гэж Дин эргэн тойрноо харж хэлэв.

Харри тайлбарлаж эхлээд яриагаа дуусгахаас урьтаж шинээр хүмүүс ирэн эхнээс нь ярих хэрэгтэй болов. Найман цагт бүх дэр эзэнтэй боллоо. Харри үүд рүү очиж түлхүүрийг нь эргүүлэн түгжив. Чанга шархийх чимээ гарахад бүгд чимээгүй болон түүн рүү руу харлаа. Гермiona анхааралтайгаар номын хуудсаа эргүүлж үзнэ.

- Тэгэхээр бид хичээллэх газраа олсон болохоор бүх юм бүтэмжтэй боллоо гэж Харри хэллээ.

- Гайхмаар юм! гэж Чжоу хэлэхэд хэдэн хүүхдүүд дэмжсэн дуу алдав.

- Этгээд юм гэж Фред хөмсөг зангидан итгэлгүйхэн хэлээд, Нэг удаа бид энд Филчээс нуугдаж байсныг санаж байна уу, Жорж? Тэгэхэд энэ шүүрний пин байсан даа гэлээ.

- Харри энэ юу вэ? гэж Дин хэлээд өрөөний цаад хэсгийн дайсан илрүүлэгч болон вредноскоп руу заав.

- Хар хүч илрүүлэгч. Зарчмын хувьд тэд бүгд хар шидийн дайсан эргэн тойронд байхыг илрүүлдэг ч тэнэг л биш бол үүнд найдах хэрэггүй дээ гэж Харри дэрний дундуур шүүгээ рүү явахдаа хэллээ.

Тэр дайсан илрүүлэгч рүү харахад хэн гэдгийг нь ялгах боломжгүй бүүдгэр дүрс хөдөлж байлаа.

- Миний бодлоор бид эхлээд ... ээ ... гээд гар өргөхийг анзаарлаа. -Яасан бэ, Гермiona?

- Бид удирдагчаа сонгосон нь дээр гэж бодож байна.

- Харри удирдагч шүү дээ гэж Чжоу даруйхан хэлээд Гермionaг солирсон юм шиг харлаа.

Харрийн зүрх ёгхийлээ.

- Тийм л дээ гэхдээ санал хураасан нь дээр байх. Тэгвэл албан ёсны болно.

Тэгэхээр бүгд Харриг удирдагчаа болгохоор сонгож байна уу? Бүгд түүний дотор Захария Смит хүртэл дургүйхэн гараа өргөв.

- Ээ ... баярлалаа. Бас яасан бэ, Гермiona? гэж Харри улайн хэлэв.

- Би бас нэрээ сонгох хэрэгтэй гэж бодож байна. Энэ нь бидний нөхөрлөлийг бэхжүүлэх болно, тийм биз дээ? гэж тэр гараа өргөсөн хэвээр хэлэв.

- Амбрижийн эсрэг холбоо гэж нэрлэвэл яаж байна? хэмээн Анжелина найдангуй хэлэв.

- Эсвэл ид шидийн яам болон усан тэнэгүүдийн бүлэг гэж Фред санал болгов.

- Би хүн болгонд хэлж болохгүй ч бид уулзахдаа тайван хэлж болохоор тийм

нэр байвал дээр гэж бодож байна гэж Гермiona Фред руу хөмсөг зангидан харж хэллээ.

- Хамгаалалтын нийгэмлэг? Х.Н гээд богиносгочихвол хэн ч бидний юу ярилцаж байгааг мэдэхгүй шүү дээ гэж Чжоу хэлэв.

- Тиймээ зохимжтой л юм. Зөвхөн Дамблдорын арми гэвэл яаж байна. Ид шидийн яам зөвхөн үүнээс л айж байсан биз дээ гэж Жинни хэллээ.

Хариуд нь дэмжсэн инээд шуугиан хадав.

- Бүгд Д.А-г зөвшөөрч байна уу? гэж Гермiona дэрэн дээрээ өвдөглөн даргархуу асуугаад,

- Олонхийн саналаар энэ нэрийг сонголоо! гэв.

Тэр гарын үсэг бүхий цаасыг ханан дээр наагаад дээр нь том үсгээр бичлээ.
ДАМБЛДОРЫН АРМИ

- Сайн байна. Бэлтгэлээ эхэлж болох уу? Би зэвсэггүй болгох Экспеллиармус шившлэгээс эхлэвэл яасан юм бэ гэж бодлоо. Энэ бол маш сайн суурь болох бөгөөд надад их тусалсан юм ...

- Өө, гуйж байна. Чи үнэхээр Экспеллиармус бидэнд Хэцүү нэргийн эсрэг тэмцэхэд туслана гэж бодож байна уу? гэж Захария Смит хэллээ.

- Би түүний эсрэг хэрэглэсэн. Тэр миний амийг зургаан сард аварсан гэж Харри тайван хэлэв.

Захария амаа хамхив. Бүгд чимээгүй боллоо.

- Хэрвээ чи үүнийг доогуур гэж үзэж байвал явж болно. Смит хөдөлсөнгүй. Бусад нь ч гэсэн.

- Сайн байна. Бэлтгэл хийхийн тулд хос хосоороо хуваагдаж гэж Харри хэлээд бүгд түүн рүү харсанд ам нь хуурайшихыг мэдрэв.

Заавар өгч дасаагүй болохоор хачирхалтай үр дүнг хүлээсэн ч бүгд даруйхан босож хуваагдлаа. Урьдаас тааварласан ёсоор Невилл хамтрагчгүй үлдэв.

- Алив надтай бол. Тэгэхээр гурав хүртэл тоолъё. Нэг ... хоёр ... гурав ... Өрөөгөөр дүүрэн Экспеллиармус гэсэн хашгиралт хадав. Шидэт саваанаас зүг бүр оч нисэн гарч номын тавиур болон адар өөд хөөрлөө. Невилл Харрийн эсрэг амжсангүй

саваа гараас нь суга үсэрч адар цохин оч асгаруулаад номын тавиурын орой дээр унахад Харри Татдаг шидээр татан авлаа. Тэр өрөөг тойруулан хараад үндсэн зөвөлгөө өгсөн нь дээр юм гэж бодлоо. Олонхи хүний өрсөлдөгчийгөө зэвсэггүй болгох шид амжилтгүй болж арагш нь ухраах юм уу дэргэдүүр нь шүрхийгээд өнгөрөв ...

- Экспеллиармус гэж Невилл Харриг гэнэдүүлэн хэлэхэд саваа гараас нь суга үсэрлээ.

- Болчихлоо! Анхны удаагаа болчихлоо! гэж Невилл хашгирав.

- Сайн байна гэж Харри түүнийг магтаад Невиллтэй жинхэнээсээ халз үзэхгүйн тулд өөр тийш харан саваагаа буулгав.

- Сонсооч Невилл чи Ронтой ээлжлэн Гермионатай гурван хором тутамд сургуулилаарай. Харин би явж бусад нь яаж хийхийг харах хэрэгтэй байна.

Тэр өрөөний дундуур явлаа. Захария Смитэд хачирхалтай юм болоод байв. Тэр Энтони Голдстейнийг зэвсэггүй болгохыг оролдох тоолонд өөрийнх нь саваа гараас нь мулт үсрээд байв. Харин Энтони ямар ч дуу гаргасангүй. Харри үүнийг юу гэж бодохоо ойлгосонгүй ч Симтээс хэдэн алхамын зайд зогсож байсан Фред, Жорж хоёр ээлжлэн шидэт саваагаа түүний нуруу луу чиглүүлж байхыг харлаа.

- Уучлаарай, Харри. Тэсч чадсангүй гэж Жорж түүний харцыг хараад хэлэв. Харри өөр хос руу явж буруу хийж байгаа шившлэгийг нь засахыг хичээв. Жинни

Майкл Корнерийн эсрэг зогсоод сайн болж байсан авч Майкл түүнийг зэвсэггүй

болгохыг хүсэхгүй байсан болохоор сул болж байлаа. Эрни МакМиллан шидэт саваагаа хэтэрхий ихээр даллан өрсөлдөгчдөө амжин хамгаалах боломж өгч байв. Ах дүү Криви урам зоригтойгоор замбараагүй үзэлцэн эргэн тойрны тавиурын бүх номыг үсэргэлээ. Полумнагийнх итгэлгүй болж заримдаа Жастин Финч Флетчлийгийн саваа гараас нь үсрэн, заримдаа үс нь хийсэж байлаа.

- Бүгд, зогс! Зогс! Зогс! гэж Харри хашгирлаа.

Надад шүгэл хэрэгтэй юм байна гэж тэр бодсон даруйдаа шууд ойролцоох номын тавиур дээр байхыг нь харлаа. Түүнийг авч чанга шүгэлдэв. Бүгд саваагаа буулгацгаав.

- Энэ муугүй боллоо гэж Харри хэлэхэд Захария Смит таагүй харав.

- Гэхдээ хамгаалалтаа сайжруулах хэрэгтэй байна. Ахиад нэг удаа оролдоод үзье.

Тэр ахин өрөөн дундуур холхиж үе үе зөвөлгөө өгөхийн тулд зогсож байв. Хүүхдүүд аажмаар дээрдэж эхэллээ.

Харри эхэндээ Чжоу болон түүний найзын дэргэдүүр явахаас зайлсхийж байсан ч удаан тоохгүй байж чадсангүй.

- Өө, үгүй ээ! Экспеллиармиос! Экспеллимеллиус! Ёо, өршөөгөөрэй, Мариэтта! гэж Чжоу түүнийг ойртоход хэлэв.

Түүний буржгар үстэй найзын ханцуй шатжээ. Мариэттэ саваагаа даллан унтраагаад түүний л буруу мэт Харри руу ууртай харав.

- Би хэтэрхий догдлоод байна. Өмнө нь хийж болж байсан юм! гэж Чжоу гэмшингүй хэлэв.

- Одоо муугүй болж байна гэж Харри худал хэлээд түүний хөмсөг өргөхийг хармагцаа,

- Үгүй дээ, ёстой олиггүй. Гэхдээ би чамд яаж гэдгийг нь заагаад өгье гэв. Чжоу инээд алдав. Мариэтта тэдэн рүү гашуунаар хараад цааш эргэлээ.

- Түүнийг бүү тоо. Хэрвээ намайг ятгаагүй байсан бол тэр ирэхгүй байсан. Эцэг нь эх нь түүнд Амбрижийг уурлуулахыг хориглосон гэсэн. Ойлгож байна уу, ээж нь яаманд ажилладаг юм.

- Харин чиний эцэг эх?

- Тэд ч гэсэн намайг Амбрижтай орооцолдохыг хориглосон. Гэхдээ тэд намайг Седрикт тохиолдсон явдлын дараа Хэцүү нэрттэй тэмцэнэ гэж бодохгүй байгаа ...

Тэр саваагаа буулгахад эвгүй нам гүм бий болов. Терри Бутын саваа Харрийн чихний хажуугаар шүнгэнэн өнгөрч Алисия Спиннетийн хамар луу онов.

- Манай аав лав яамны эсрэг бүх зүйлийг маш их дэмждэг юм! гэж Харрийн ард зогсож байсан Полумна Лавгуд Жастин Финич Флетчлийг толгойдоо углагдсан жанчны ээдрээг гаргах зуур бардам хэлэв. Тэр харваас тэдний яриаг сонссон бололтой. Тэр үргэлж Фаж янз бүрийн зүйл хийдэг гэсэн. Жишээлбэл хичнээн албин алсан гээч! Бас нууцын хэлтэстээ аймшигт хор найруулж эсрэг боссон хүмүүст өгдөг

гэсэн ...

Чжоу гайхсандаа амаа ангайлаа.

- Битгий асуу гэж Харри шивнэхэд тэр инээд алдав.
- Харри гэж өрөөний буланд байсан Гермиона дуудаад.
- Чи цаг хэд болж байгааг харав уу? гэлээ.

Харри цагаа харан ес арав болж болж байгааг мэдээд гайхширлаа. Хэрвээ Филчэд баригдаж шийтгүүлэхийг хүсээгүй л юм бол тэднийг даруйхан амралтын өрөө лүү нь буцаах хэрэгтэй байлаа. Тэр шүглээ үлээхэд бүгд хашгирахаа зогсож Экспеллиармус гээд сүүлчийн хоёр саваа шалан дээр тачигнан уналаа.

- Ер нь бол муугүй болж байна. Гэхдээ бид хоцрох нь байна. Долоо хоног бүр энэ цагтаа цуглаж байх уу?
- Жаахан эрт! гэж Дин Томас гуйхад хүүхдүүд дэмжин толгой дохив. Гэвч тэднийг Анжелина зогсоолоо.
- Квиддичийн улирлын тоглолт эхлэх гэж байхад бэлтгэл хийх хэрэгтэй байна!
- Тэгвэл дараагийн лхагва гаригийн орой юмуу өөр өдөр сонгоё. Харин одоо явах хэрэгтэй байна гэж Харри хэллээ.

Тэр Тэнүүлчний газрын зургийг авч долоон давхарт багш нар байгаа эсэхийг анхааралтай шалгав. Дараа нь тэднийг гурав дөрвөөр нь гаргаж жижигхэн цэг болгоныг амралтын өрөөндөө аюулгүй хүрэх хүртэл сэтгэл түгшин дагуулан харж байлаа. Пуффендуйн амралтын өрөө хонгилын гал зуух руу явдаг замд байдаг бол, Когтевранчуудынх шилтгээний баруун цамхагт, Гриффиндорынх тарган хатагтайн хөрөг бүхий хонгилд байлаа.

- Бүх зүйл их сайхан бүтлээ, Харри гэж Гермиона эцэст нь үлдээд хэлэв.
- Тийм шүү! гэж Рон урамтай дэмжлээ. Тэднийг хонгил руу гарах үед хаалга чулуун хана болон хувирлаа. Чи намайг Гермионаг яаж зэвсэггүй болгохыг харсан уу?

Гермиона хатгуулсан мэт болов.

- Ердөө нэг удаа. Би чамайг илүү олон удаа.
- Нэг биш гурван удаа биз дээ.

- Хэрвээ чи бүдэрч унахдаа хөлөөрөө миний савааг цохисоныг тооцох юм бол ч

...

Тэд амралтын өрөө хүрэх замын турш маргалдсан ч Харри сонссонгүй. Тэр Тэнүүлчний газрын зураг руу харан Чжоуд юу хэлвэл гэж сэтгэлээр унагахгүй байх талаар гэж бодлоо.

БҮЛЭГ 19: АРСЛАН БА МОГОЙ

Хоёр долоо хоногийн турш Харрид цээжиндээ овгийн нууцыг хадгалсан сахиус зүүсэн юм шиг мэдрэмж төрж байсан нь Амбржийн хичээлийг тэвчихэд тусалж тэр ч байтугай түүний аймшигтай бүлцгэр нүдний өмнөөс эелдэгээр инээмсэглэхэд хүргэж байлаа. Тэр болон ДА-гийнхан түүний хамар дор эсэргүүцэн босож ид шидийн яамны бүхнээс илүү айж байсан зүйлийг хийж байсан учир хичээл дээр Уилберт Слинкхардын номыг уншихдаа сэтгэл хангалуунаар сүүлчийн цугларалтаа санан Невилл яаж Гермионаг амжилттайгаар зэвсэггүй болгож байсан, Колин Криви хэрхэн гурван хичээлийн дараа Саад арилгах шидийг эзэмшсэн, Парвати Патил хэрхэн багасгах шившлэгээр вредноскоптой ширээг тоос болгон хувиргасныг санаж байлаа.

ДА-гийн хувьд цаг агаараас хамааралтай өөрчлөгддөг гурван багийн квиддичийн бэлтгэлээс болоод тодорхой өдөр сонгох боломжгүй байлаа. Гэхдээ Харри үүнд харамссангүй харин ч тодорхой цагийн хуваарьгүй болсноороо хэрвээ хэн нэгэн тэднийг мөрдөж байгаа бол будлиантуулахад ашигтай байв.

Гермиона төдхөн бүх оролцогчдод цугларалтын өдрийг хэлэх маш ухаалаг арга бодож олсон бөгөөд энэ нь анхаарал татахгүй сайн талтай байв. Хэрвээ янз бүрийн тэнхимийн сурагчид Их танхимд үргэлж уулзан хоорондоо ярилцаад байвал энэ нь сэжигтэй харагдах нь мэдээж. Бүх ДА-гийн гишүүдэд Гермиона хуурамч галлеон өгчээ (Рон түүнийг анх хараад сагсанд жинхэнэ алт байна гэж их баярлажээ).

- Зоосны ирмэг дээрх тоог харж байн уу? гэж тэр дөрөв дэх хичээлийн эцэст гялалзсан зоосыг бамбарын гэрэлд заан асуугаад,

- Жинхэнэ галлеоны серийн дугаар бол албингуудад хамааралтай байдаг юм.

Харин энэ хуурамч зоосны тоо өөрчлөгдөн цугларалтын өдөр цагийг зааж байх болно. Өдөр өөрчлөгдөхөд зоос халуун болон гялалзаж халаасанд байхад ч мэдрэгдэх болно. Харри уулзалтын цаг өдрөө товлосон үедээ дугаараа өөрчилөхөд та нарынх ч гэсэн өөрчлөгдөнө. Учир нь би өөрчилдөг шившлэг хэрэглэсэн юм гэв.

Түүний үгийн хариуд чимээгүй болов. Гермиона сандрангуй сонсогчид руугаа харлаа.

- Би үүнийг сайхан санаа гэж бодсон юм. Жишээлбэл Амбриж та нарын халаасыг нэгжлээ гэхэд ямар ч сэжигтэй зүйл олж харахгүй. Гэхдээ ... та нар

хүсэхгүй байгаа бол ...

- Чи өөрчилдөг шидийг чаддаг юм уу? гэж Терри Бут асуув.
- Тиймээ.
- Гэхдээ энэ чинь ... зургадугаар дамжааны түвшнийх шүү дээ.
- Өө ... магадгүй ... тийм байх гэж Гермiona даруу дуугарахыг хичээн хэллээ.
- Чи яагаад Когтевранд ороогүй юм бэ? Чиний тархи? гэж тэр бараг гайхан асуулаа.
- Хуваарилагч бүрх малгай намайг Когтевранд илгээх талаар нухацтай бодсон ч эцэст нь Гриффиндорт хуваарилсан. Тэгэхээр бид зоосыг ашиглахаар болов уу? гэж Гермiona хөгжилтэй хэллээ.

Зөвшөөрсөн чимээ сонсогдож бүгд сагс руу очлоо. Харри түүн рүү харав.

- Энэ юу санагдуулж байгааг мэдэх үү?
- Үгүй, юу гэж?
- Үхэл залгигчдийн сорви. Волдеморт нэгэнд нь хүрэхэд бүгдийнх нь халуу шатдаг. Энэ бол тэднийг дууддаг дохио.
- Аан ... тийм л дээ, тэндээс санаа авсан юм ... Би өдөр сарыг гишүүдийн арьсанд буулгаж байснаас төмөр зүйлд сийлсэн нь дээр гэж бодоод.
- Тийм шүү ... Чиний арга ухаалаг байлаа. Ганц болгоомжлох зүйл гэвэл бид тэднийг санамсаргүй үрчих вий дээ гэж Харри инээмсэглээд зоосыг халаасандаа хийлээ.
- Чөтгөр гэж би түүнийг жинхэнэ галлеоноос ялгахгүй юм байна гэж Рон хэлээд зоосыг гашуудангуй харлаа.

Улирлын анхны тэмцээн ойртов. Гриффиндор Слизериний эсрэг. Анжелина арай л ДА-гийн цугларалтыг болиулж өдөр бүр сургуулилахыг шаардах нь холгүй байв. Квиддчийн цомыг удтал аваагүй болохоор мөдхөн ирэх тэмцээнийг бүгд сэтгэл хөдлөн хүлээж байлаа. Пуффендуй болон Когтевранчууд тоглолтын үр дүнг ихэд сонирхож байсан бөгөөд энэ багуудын ялсантай тоглох учир ойлгомжтой байв. Тэнхимийн эрхлэгчид ёс журмыг баримтлан дундыг барьсан дүр үзүүлж байсан ч үнэн хэрэгтээ өөрсдийнхөө багийн ялалтыг хүсч байлаа. Харри Профессор МакГонагаллд Слизеринийг хожих нь хичнээн чухал болохыг тэмцээн болохоос

долоо хоногийн өмнө тэдэнд гэрийн даалгавар өгөхөө болиход нь ойлгожээ.

- Би та нарыг ойрын өдрүүдэд үүнгүйгээр хангалттай их ажилтай гэж бодож байна гэж тэр ихэмсгээр хэлэхэд тэд чихэндээ итгэсэнгүй. Тэгсэнээ Харри, Рон хоёр руу ширүүн харж,

- Би квиддичийн цомыг өрөөндөө байхыг харж дассан болохоор профессор Снеггийн гарт орохыг үнэхээр хүсэхгүй байна шүү гэлээ.

Снегг ч бас үүнээс дутуугүй багийнхаа ялалтыг хүсч байлаа. Тэр Слизеринийхний бэлтгэд зориулан үргэлж талбай захиалан авч байсан учир Гриффиндорын заримдаа бэлтгэл хийх болгомжгүй болоход хүрч байв. Түүнчлэн Слизеринийхэн Гриффиндорын тоглогчидтой хонгилд хэрхэн ширүүн харьцаж байгаа тухай гомдлыг чихнийхээ хажуугаар өнгөрүүлж байлаа. Алисия Спиннет эмнэлэгийн жигүүрт хөмсөг нь өтгөн ургаж нүдийг нь халхалсан учир хүргэгдэв. Ингээд арван дөрвөн гэрч түүнийг номын санд байхад ард нь зогсож байсан Слизериний хаалгач Майлс Блетчли шившлэг хэрэглэсэн гэж баталсан боловч Снегг сонсохыг ч хүссэнгүй бөгөөд түүнийг өөрөө л үс өтгөрүүлэгч шид хэрэглэсэн гэжээ.

Харри Гриффиндорынхонд ялах сайхан боломж байна гэж бодлоо. Тэд Малфойн багт нэг ч удаа хожигдож байгаагүй юм. Мэдээж Рон Вудын түвшинд хүрэхгүй байсан ч амжилттайгаар сайжирч байв. Түүний хамгийн том сул тал гэвэл оноо алдсаны дараа өөртөө итгэлтэй байдлаа алдан муйхар алдаа гаргаж сандарч тэвдэн бөмбөг алдаж эхэлдэг байлаа. Өөр зүгээс бол тэр гайхалтайгаар цохилтыг хааж байлаа. Нэг удаагийн бэлтгэл дээр тэр шүүрнээсээ үсрэн гараараа зүүгдэж квоффлыг хөлөөрөө хүчтэй өшиглөхөд бөмбөг талбай дээгүүр эсрэг талын онооны цагариг руу нислээ. Бүгд гайхаж үүнийг Ирландын шигшээгийн Барри Райны Польшийн урдаа барьдаг ангууч Ладислав Замойскогийн эсрэг байгуулсан саяхны гавъяатай адилтган үзжээ. Тэр ч байтугай Фред хүртэл Жоржын хамт дөрвөн жилийн дараа анх удаа Ронноор бахархах эсэхээ нухацтайгаар бодож үзэж байна гэжээ.

Харриг нэг зүйл зовоож байсан нь Роныг Слизериний багийнхан талбай дээр гаргахын өмнө сэтгэлээр унагах арга хэрэглэж байсантай холбоотой байв. Тэр дөрвөн жилийн турш тэдний ёжилж тохуурхсан харьцаанд дассан болохоор «Хөөе, Потти, би Уоррингтон чамайг хагас сайнд шүүрнээс чинь унагаана гэж тангараглаж байхыг сонслоо» гэж хэлсэн нь айлгасангүй бөгөөд харин ч инээдийг нь хүргэжээ.

«Уоррингтон онилохдоо муу болохоор би түүнийг хажуугийн хүнийг минь оночих

вий гэж санаа зовж байна» гэж хэлэхэд Рон, Гермиона хоёр инээлдэн Пэнси Паркинсоны нүүрэнд байсан тэнэгдүү инээмсэглэл алга болов.

Гэтэл Рон хайр найргүй доромжлол, доог тохуу, сүрдүүлэгтэй хэзээ ч учирч байсангүй. Слизеринийхний долдугаар дамжааны том биетэй сурагч тэднийг хонгилд явж байхад нь «Эмнэлгийн ороо захиалсан уу, Уизли?» гэхэд тэр инээсэн ч үгүй царай нь ногоорлоо. Драко Малфй түүнийг хэрхэн квоффл алдсан гэдгийг уулзах болгондоо элэглэн үзүүлэхэд Роны чих улайж гар нь чичирэн барьж байсан зүйлээ унагаана.

Арван сар усархаг бороо салхины исгэрээнтэй дуусаж хөлдүү хүйтэн арван нэгэн сар айлчлан ирэхэд өглөө болгон тэнгэрт цасан шуурга тавьж гар хөл жиндүүлнэ. Их танхимын шидэт адар Хогвартсын тойрон хүрээлсэн уулсын өмссөн малгай адил сувдан саарал өнгөөр хөшиглөхөд шилтгээнд хүйтэрч сурагчид хичээлийн хооронд явахдаа хүйтнээс хамгаалахын тулд лууны арьсан зузаан бээлий өмсөж байв.

Тэмцээний өглөө хүйтэн цэлмэг байлаа. Харри сэрээд Рон орон дээрээ өвдгөө тэврэн нэг зүг рүү гөлрөн сууж байхыг харав.

- Өвдөөгүй биз дээ?

Рон хариуд нь толгойгоо сэгсэрлээ. Харри Роныг санаандгүй өөртөө өтөөр бөөлждөг шившлэг хийгээд цонхийн цайж хөлс нь цутган амаа нээхээс айж байсныг саналаа.

- Чи өглөөний цайгаа уух хэрэгтэй. Явцгаая гэж Харри хөгжилтэй хэлэв.

Их танхим дүүрэн хүнтэй бөгөөд хөгжилтэй чимээ шуугиантай байлаа. Тэднийг шуугилдаж буй Слизериний ширээний дэргэдүүр өнгөрөхөд Харри эргэж хараад ногоон хувцас мөнгөн могойтой малгай дээрээ нэмэлт болгож бүгд энгэртээ титэмний дүрстэй мөнгөн тэмдэг зүүснийг харлаа. Тэдний ихэнхи нь Рон руу гар даллан чанга хөхрөлдөж байв. Харри тэмдгэн дээр юу бичигдсэнийг уншихыг хичээсэн ч амжсангүй.

Гриффиндорын ширээнд тэднийг алтлаг улаан хувцас өмссөн хүмүүс халуун дотноор угтав. Гэхдээ мэндчилгээнд Роны сэтгэл санаа өргөгдөхийн оронд эсрэгээрээ доройтлоо. Тэр ойролцоох сандал дээр лагхийн суухдаа сүүлчийн удаа өглөөний хоол идэж буй мэт харагдав.

- Би үүнийг чадна гэж зүгээр л бодсон байна гэж тэр сөөнгөтөн шивнэв.

- Битгий дэмий юм ярь. Чи сайн л байсан шүү дээ. Сэтгэл догдлол бол жирийн зүйл гэж Харри түүнийг ятгав.

- Би муу. Би олиггүй. Ална гэсэн ч тоглож чадахгүй нь. Би юугаа бодож байсан юм бол?

- Биеэ барь. Чи хөлөөрөө хүртэл хааж байсан биз дээ. Фред, Жорж хоёр хүртэл гайхамшигтай гэж хэлсэн.

Рон түүн рүү золгүй царайгаар харав.

- Энэ санаандгүй тохиолдол байсан юм юм. Би тэгье гэж бодоогүй ... Би шүүрнээсээ гулгаж унаад буцаж гарахыг хичээхдээ санамсаргүй бөмбөгийг өшиглөчихсөнийг та нар харсан байх гэж өрөвдөлтэй хоолойгоор бувтнав.

- Зүгээр дээ. Ахиж ийм хоёр санаандгүй тохиолдол гаргавал тоглолт бидний гарт байна гэж Харри гэнэтийн мэдээнд таагүй мэдрэмж төрөхгүйн тулд хурдхан хэлэв.

Эсрэг талд нь суусан Гермiona, Жинни хоёр алтлаг улаан ороолт, бээлий өмсөж улаан цэцэг зүүжээ.

- Хэр байна даа? гэж Жинни тавгандаа байгаа будаа руу ширтэж байсан Рonoос асуув.

- Тэр жаахан догдлоод байгаа юм гэж Харри хэлэв.

- Энэ ч сайны тэмдэг шүү. Би шалгалтаа амжилттай өгөхийн өмнө догдолдгоо анзаарсан гэж Гермiona тайвшируулав.

- Сайн уу гэх мөрөөдөнгүй хоолой тэдний ард сонсогдов.

Харри толгойгоо өргөлөө. Тэдний ширээ рүү Когтевраны Полумна Лавгуд иржээ. Хүүхдүүд түүний зүг харж инээлдэн зарим нь хуруугаараа зааж байлаа. Тэр арслангийн толгойтой малгай илбэдэн ямар нэг шидээр толгой дээрээ тогтоожээ.

- Би Гриффиндорыг дэмжиж байгаа гэж Полумна мэдэгдээд малгай руугаа зааж, Бидний юу чадахыг хар даа ... гэв.

Тэр малгайгаа шидэт саваагаар тогштол арслангийн ам нээгдэн чанга архирахад ойр байсан хүмүүс цочлоо.

- Муугүй байгаа биз дээ? Би Слизеринийг төлөөлүүлэн могой идэж байгаа болохыг оролдсон ч бүтээгүй. Юутай ч гэсэн амжилт хүсье, Рональд! гэж Полумна

баяртайгаар хэлэв.

Тэр цаашаа явчихлаа. Тэднийг Полумнагийн малгайн цочирдлоос гарч амжаагүй байтал Анжелина Жонсон Кэти болон хатагтай Помфрийн ачаар хэвийн хөмсөгтэй болсон Алисия нарыг дагуулан яаран ирлээ.

- Чи бэлэн үү. Бид талбай руу явж агаар хараад хувцас солих өрөө лүү очих гэж байна.

- Бид араас чинь очье. Рон өглөөний цайгаа уух хэрэгтэй байна гэж Харри хэлэв.

Ойролцоогоор арван хором өнгөрсний дараа Рон юу ч идэж чадахгүй нь ойлгомжтой болмогц Харри түүнийг хувцас солих өрөөнд аваачсан нь дээр гэж бодлоо. Тэднийг ширээнээс босмогц Гермiona даган босоод Харрийн гараас татан холдуулав.

- Ронд Слизериний тэмдгийг харуулахгүйг хичээгээрэй.

Харри түүн рүү асуунгуй харахад анхааруулсан байртай толгой сэгсэрлээ. Тэдэн рүү цөхөрсөн Рон хүрч ирлээ.

- Амжилт хүсье, Рон гэж Гермiona хэлээд өлмий дээрээ босон хацар дээр нь үнсэв. Чамд ч гэсэн, Харри.

Рон Их танхимаас гарахдаа яльгүй хөгжив. Тэр юу болсныг ойлгосонгүй бололтой Гермionaгийн үнссэн газрыг бодлогоширонгуй илэв. Харри Слизериний ширээний дэргэдүүр өнгөрөхдөө тэмдэг рүү нь сониучирхан хараад энэ удаад үгийг ялган уншлаа.

Уизли бидний хаан.

Дотор нь таагүй мэдрэмж төрөхөд Харри яаран Роныг үүдний танхим руу гаргаж чулуун шатаар хүйтэн агаарт гарлаа.

Тэднийг ташуу нугаар цэнгэлдэх хүрээлэн рүү явах үед хөлдсөн өвс ногоо хөлийн дор таржигнаж байв. Салхигүй байсан бөгөөд тэнгэр сувдан саарал өнгөөр бүүдгэртэн нар нүд гялбуулахгүй сайн талтай байлаа. Харри энэ тухай Ронд замдаа тайлбарлав.

Анжелина хэдийн хувцасаа солиод тэднийг орох үед багтаа сүүлчийн заавраа өглөө. Харри, Рон хоёр хувцсаа солин (Рон хүртэл хэдэн хормын турш хувцсаа буруу харуулан өмсөхийг оролдоход Алисия туслажээ) суугаад тэмцээний өмнө үзэгчдийн

чанга шуугилдан цэнгэлдэх хүрээлэн рүү ирэх чимээг сонсов.

- Би сая л Слизерийн багийн сүүлийн үеийн бүтцийг оллоо гэж Анжелина Жонсон хэлээд цаас руу харлаа.

- Өнгөрсөн жилийн довтлогч Деррик, Боул хоёр байхгүй бөгөөд Монтегю тэдний оронд нисч чаддаг горилл авсан байна. Тэдний нэрийг Крэбб, Гойл гэдэг. Тэдний тухай сайн мэдэхгүй юм.

- Бид сайн мэднэ гэж Харри, Рон хоёр зэрэг хэлэв.

- Тэднийг бусдынхаа шүүрнийхээ үзүүрийг ялгадаг гэж бодохгүй байна.

Деррик, Боул хоёр талбай дээр зам заах тэмдэггүйгээр зүгээ олж чаддаггүй байсан гэж Анжелина хэлээд цаасаа халаасандаа далд хийв.

- Крэбб, Гойл хоёр бас адил гэж Харри хэлэв.

Үзэгчдийн суудал руу өгсөж буй олон зуун хөлийн чимээ гарав. Зарим хүмүүс Харрийн учрыг нь олж чадахааргүй дуу дуулж байлаа. Тэр бас догдолж байсан ч түүний зовнил Роны цонхийн цайж ногоорсон айдасын хажууд юу ч биш байлаа.

- Цаг боллоо гэж Анжелина аяархан хэлээд цагаа харав. – Алив явцгаая ... бүгдэд амжилт хүсье.

Багийнхан босч мөрөн дээрээ шүүрээ тавиад цэнгэлдэх хүрээлэн рүү гарав. Үзэгчдийн орилж хашгиран исгэрэх, дуулах чимээ тэднийг угтан нүргэлэв.

Слизериний баг тэднийг хүлээж байлаа. Энгэртээ титэмний зурагтай мөнгөлөг тэмдэг зүүцгээжээ. Тэдний шинэ ахмад Монтегю Дадли Дурсльтай жигтэйхэн адилхан эв хавгүй агаад цайвар үстэй нэгэн аж. Түүний ард нүсэр том биетэй Крэбб, Гойл хоёр зогсоод дүйнгэтэн нүдээ анивчин тэнгэр лүү цохиураараа даллаж байв. Сүүмгэр нарны гэрэл Малфойн цайвар үсийг нь гийгүүлнэ. Тэр Харрийн харцтай тулгармагц инээгээд энгэр дээрх тэмдгээ цохив.

- Багийн ахлагчид гар барьцгаа гэж хатагтай Нугарагч тушаахад Монтегю Анжелина хоёр урд урдаасаа ойртов. Харри Монтегю Анжелинагийн гарыг өвдтөл базахыг харсан ч тэр нүдээ анивчсангүй.

- Шүүрэндээ сууцгаа ...

Шүүгчийн шүгэл тасхийв. Бөмбөг суллагадаж арван дөрвөн тоглогч агаарт хөөрөв. Харри нүднийхээ булангаар Роныг цагариг руугаа нисэхийг харлаа. Тэр блажераас

бултан улам дээшилж талбайн баруун тал руу нисээд алтан снитч гялалзах эсэхийг хараачилав. Малфой талбайн нөгөө өнцгөөс бас тэгж харж байв.

- Бөмбөг Жонсонд байна. Жонсон бөмбөгийг эзэмшиж, би энэ тоглогч охинтой жилийн турш болзохыг хүссэн ч тэр надтай уулзаагүй ...

- Жордан! гэж гэж профессор МакГонагалл хашгирав.

- Сонирхолтой байлгахын тулд жаахан хувийн зүйл нэмсэн юм, профессор ...

Тэр Уоррингтоноос бултаад Монтегюгийн хажуугаар өнгөрөн ... ёо ... түүний араас Крэббийн илгээсэн блажер цохилоо. Монтегю квоффлыг аваад эсрэг талынхаа цагариг руу тэмүүлж байна ... Жорж Уизлигийн Монтегийн толгой руу чиглүүлсэн блажерын сайхан цохилт боллоо, Монтегю квоффлыг алдаж бөмбөг Кэти Беллд ... Гриффиндрын Кэти Белл бөмбөгийг Алисия Спиннетэд дамжуулаад, Спиннет буцаан ...

Тайлбарлагч Ли Жорданы хоолой цэнгэлдэх хүрээлэн даяар цуурайтахад Харри салхины улин исгэрэх, үзэгчдийн орилж хашгирах дуулах дундуур хүчлэн сонслоо.

- Спиннет Уоррингтоныг хуураад блажераас бултан ... ахиад жаахан Спиннет ...

Үзэгчид хөөрч байна юу дуулж байгааг нь сонсож байна уу?

Тэр дууг сонсохын тулд тайлбарлахаа зогслоо. Дуу ногоон мөнгөлөг хувцастай Слизериний дэмжигчдийн зүгээс талбайг дээгүүр чанга сонсогдлоо.

Рональд Уизли бидний хаан Рональд Уизли бидний баатар Цагаригийн өмнө цоорхой байдаг Үргэлж цаашдаа ийм байх болно

Квоффлыг Уизли барьж чадахгүй Ялахад бидэнд тэр тусална Угаадасны хажууд төрсөн болохоор Слизеринд тэр ялахад туслана

- Алисия квоффлыг Анжелинад буцаан дамжууллаа! гэж Ли хашгирахыг Харри эргэлт хийгээд уурсан сонслоо. Тэр Ли дууны үгийг дарахыг хичээж байгааг ойлгож байв.

- Алив ээ, Анжелина ... түүний өмнө зөвхөн хаалгач байна! Тэр цохилоо ... аах

...

Слизериний хаалгач бөмбөгийг барьчихлаа. Тэр бөмбөгийг Уоррингтонд Алисия, Кэти хоёрын дундуур дамжуулав. Түүнийг Ронд ойртох үед дуу улам чангарав.

Рональд Уизли бидний хаан Рональд Уизли бидний баатар Цагаригийн өмнө цоорхой байдаг Үргэлж цаашдаа ийм байх болно

Харри тэссэнгүй снитчийг хайхаа болиод Роныг харахаар «Аянга»-аа эргүүлэхэд гурван цагаригийн өмнө хөөрөх дүрс рүү нүсэр том биетэй Уоррингтон тэмүүлж байв.

- Квоффл Уоррингтонд байна. Уоррингтон цагаригт ойртож блажер хүрэхээргүй зайд холджээ, түүний өмнө зөвхөн хаалгач байна ...

Слизериний үзэгчид чанга нүргэлүүлэв.

Цагаригийн өмнө цоорхой байдаг

Үргэлж цаашдаа ийм байх болно

- Энэ бол Гриффиндорын довтлогч Фред, Жорж хоёрын дүү шинэ хаалгач Уизлийн эхний сорилт байлаа ... Тэсээрэй, Рон.

Хөөрсөн хашгиралт Слизериний зүгээс сонсогдов. Рон квоффлыг барихаар гараа сунган шумбахад дэргэдүүр нь өнгөрөөд дунд талын цагаригт орлоо.

- Слизерин оноо авлаа! Арав-тэг, Слизерин тэргүүлж байна ... Гуниглах хэрэггүй дээ, Уизли!

Слизеринийхэн улам чанга дуулав.

УГААДАСНЫ ХАЖУУД ТӨРСӨН БОЛОХООР СЛИЗЕРИНД ТЭР ЯЛАХАД ТУСЛАНА

- Бөмбөг буцаж Гриффиндорынхонд шилжлээ. Кэти Белл урагшаа довтолж байна гэх Лигийн хоолой чих дөжрөм дуулах чимээ дундуур сонсогдлоо.

КВОФФЛЫГ РОН БАРЬЖ ЧАДАХГҮЙ ЯЛАХАД ТЭР БИДЭНД ТУСЛАНА

- Харри, Чи юу хийж байна? Хөдлөөч! гэж Анжелина хашгираад дэргэдүүр нь Кэти Блеллийн араас нисэн өнгөрөв.

Харри зөвхөн сая л снитчийг мартаад агаарт хөдөлгөөнгүй зогсож байгаагаа мэдрэв. Тэр айдаст автан доошлоод талбайг тойрон эргэлдэж Слизериний дуунд анхаарал хандуулахгүй байхыг хичээв.

РОНАЛЬД УИЗЛИ МАНАЙ ХААН РОНАЛЬД УИЗЛИ МАНАЙ БААТАР

Снитч хаа ч байсангүй. Малфой мөн адил талбай дээгүүр эргэлдэж байлаа. Тэд талбайн дунд урд урдаасаа угталцан нисэхэд Харри түүний чанга дуулж байхыг сонслоо.

УГААДАСНЫ ХАЖУУД ТӨРСӨН БОЛОХООР

- Ахиад Уоррингтонд байна, Пьюсид дамжууллаа. Пьюси Спиннетийг хуураад ... алив Анжелина чи түүнийг зогсоож чадна байх ... болсонгүй. Фред Уизлийн блажерын сайн цохилт байлаа... үгүй ээ, Жорж Уизли ямар ялгаа байна тэдний нэг нь л ... Уоррингтон квоффлоо алдахад Кэти Белл аваад ... ээ, бас алдчихлаа ... квоффл Слизериний багийн ахлагч Монтегюд байна. Монтегю квоффлыг аваад талбай дээгүүр цагариг руу нисэж ... Алив л дээ Гриффиндор, түүнийг хаа!

Харри Роныг харахгүйн тулд Слизериний цагариг руу хөөрөн хаалгач Блетчлигийн дэргэдүүр өнгөрөхөд дэмжигчдийн хамт дуулж байлаа.

ЦАГАРИГИЙН ӨМНӨ ЦООРХОЙ БАЙДАГ

- Пьюси ахин Анжелинагаас бултаад цагариг руу нисэж байна ... Анхааралтай, Рон!

Харри болсон явдлыг хараагүй ч бүх зүйл ойлгомжтой байлаа. Гриффиндорын үзэгчдийн аймшигтай дуу алдан ёолох, Слизеринийхний хашгирч алга таших чимээ гарлаа. Тэр доош харлаа. Пэнси Паркинсон Слизериний үзэгчид рүү харан зогсоод дууг нь удирдаж байлаа.

УГААДАСНЫ ХАЖУУД ТӨРСӨН БОЛОХООР СЛИЗЕРИНД ТЭР ЯЛАХАД ТУСЛАНА

Хорь – тэг. Гэхдээ тийм ч аймшигтай биш снитийг барих цаг байна. Хэдхэн оноо авахад л ердийнхөөрөө тэргүүлж эхлэнэ гэж Харри өөрийгөө тайвшируулан бодоод тоглогчдийг сүлжин явахад Монтегюгийн бугуйн ойролцоо ямар нэг зүйл гялалзав.

Рон ахин хоёр оноо алдав. Харри сандралд орж эхэллээ одоо л снитчийг барихгүй бол. Түүнийг барьж тоглоомыг түргэн дуусгах хэрэгтэй байлаа.

- Гриффиндорын Кэти Белл Пьюсиг хуураад Монтегьюгээс бултан ... Сайхан эргэлт байлаа Кэти! Уоррингтоныг мэхлээд цагариг руу тэмүүлж урагшаа Анжелина ... Гриффиндо оноо авлаа! Оноо дөч-арав Слизеринийхэндд ашигтай байна, бөмбөг Пьюсид ...

Харри Гриффиндорныхны баясан хашгиралтан дунд Полумнагийн арслангийн архиралтыг сонслоо. Ердөө гучин оноо тайван гүйцэж болно. Тэр Крэббийн илгээсэн блажераас бултаад снитчийг хараачлан Малфойг харахад түүний адил талбай дээгүүр нисэн алтан бөмбөгийг хайж байлаа.

- Пьюси Уоррингтонд өглөө. Уоррингтон Монтегюд, Монтегю Пьюсид буцаан өглөө ... Жонсон ковоффлыг таслан зогсоож Беллд дамжуулаа, гайхалтай ... үгүй ээ, түүнийг Гойлын илгээсэн блажер цохиж бөмбөг ахин Пьюсид шилжлээ ...

УГААДАСНЫ ХАЖУУД ТӨРСӨН БОЛОХООР СЛИЗЕРИНД ТЭР ЯЛАХАД
ТУСЛАНА РОНАЛЬД УИЗЛИ БИДНИЙ ХААН ...

Харри эцэст нь жижигхэн далавчтай алтан бөмбөлөг Слизериний цагаригийн ойролцоо газар дээгүүр хөвөхийг харлаа.

Тэр шумбалаа ...

Зүүн талд нь Малфойн мөнгөлөг ногоон дүрс бүүдгэртэн үзэгдэв ...

Снтич зүгээр өөрчлөн эсрэг талын үзэгчид руу нисэхэд Малфойн гар ойртлоо. Харри «Аянга»-аа эргүүлж толгой зэрэгцэн нислээ.

Харри газраас гурван футын өндөрт баруун гараараа шүүрнийхээ ишнээс барьж снтичийн араас сунгалаа ... Харин баруун талд нь Малфойн гар бас сунгагдаж сарвайсан хуруу нь агаарт тэмтчив ...

Хоёрхон секундийн зүрхний цохилт, салхины исгэрэлт тэгээд л дууслаа. Харрийн хуруу жижигхэн снитчийг атган авахад Малфойн хумс түүний гарыг цөхрөнгүй маажив. Харри шүүрээ дээш эргүүлэн гартаа бөмбөгийг өргөхөд Гриффиндорын хөгжөөн дэмжигчид уухайлан хашгиралдлаа.

Рон хэдэн оноо алдсаныг эс тооцвол тэд аврагдлаа, маргааш энэ тухай хэн ч санахгүй байх болно хамгийн гол нь Гриффиндрын ялалт ...

Түн.

Блажер түүний араас цохиход урагшаа шүүрээ даван унав. Аз болоход ердөө тав зургаан футын өндөрт байж. Харри снитчийг бариад хөлдүү газар нуруугаараа унав. Тэр шүүгчийн чих дөжрөм шүгэл, үзэгчдийн уурсан хашгирах болон шоолж ирсгэрэх, дараа нь Анжелинагийн цочирдолд орсон хоолой,

- Чи зүгээр үү? гэхийг сонслоо.

- Зүгээр дээ гээд хөл дээрээ босохоор гараа өглөө.

Хатагтай Нугарагч Слизериний нэг тоглогчийн зүг хөөрөн нисчээ.

- Энэ бол дээрэмчин Крэбб байсан. Тэр чамайг снитч барьсан хойно блажерыг илгээсэн. Гэхдээ бид хожсон, Харри хожсон!

Харрийн нурууны ард шуухитнах гарахад снитчийг барьсан чигээр эргээд Драко Малфой газардахыг харлаа. Уурсаж хилэгнэсэн тэрбээр хүчлэн инээмсэглэж байв.

- Уизлийг шившигээс аврав уу? Үүнээс муу хаалгачыг харж байсангүй ... тэр угаадасны дэргэд төрсөн юм чинь. Чамд миний шүлэг таалагдав уу, Поттер?

Харри хариулсангүй. Тэр ялалтын уухай хадуулан гар занган газардаж буй тоглогчид руугаа эргэв. Рон онооны цагаригийн ёроолд буугаад ганцаараа хувцас солих өрөө рүү гэлдрэв.

- Бид ахиад хоёр мөр бичихийг хүссэн! Гэхдээ бүдүүн муухай ээжийнх нь тухай үг олоогүй л дээ гэж Малфой Алисия, Кэти хоёр Харриг тэврэхэд хашгирлаа.

- Ялагдсандаа гашуудаж байх шив гэж Анжелина зэвүүцэн бувтналаа.

- Бас авъяасгүй тэнэг эцгийнх нь талаар ашигтай үг олж чадаагүй ...

Фред, Жорж хоёр Харрийн гарыг барин сэгсрэхдээ энэ үгийг сонсоод хөшчихлөө. Тэд Малфойн зүг эргэв.

- Больцгоо! Орхи, Фред. Хожигдсондоо уурлаж байгаа юм гэж Анжелина хэлээд Фредийн гараас зуурлаа.

- Чи Уизлийн гэр бүлд дуртай биз дээ, Поттер? Амралтаа тэднийд өнгөрүүлсэн гэл үү? Чамайг ойлгохгүй байна. маглуудын дунд амьдарч байсан болохоор угаадсанд очих таатай санагдаа юу?

Харри Жоржыг хойш нь татлаа. Анжелина, Алисия, Кэти нар хөхөрч буй Малфой руу ухасхийсэн Фредийг тал талаас нь зуурлаа. Харри Крэббийг шударга бус дайралт хийсэнд нь загнаж байгаа хатагтай Нугарагч руу харлаа.

- Эсвэл магадгүй ээжийнхээ байшингийн өмхий үнэрээ санасан уу, Поттер.

Уизлийнхны гахайн байшинд төрсөн гэрийнхээ үнэрийг мэдрээ юу?

Харри Жоржыг яаж тавьсанаа мэдээгүй ч дараагийн агшинд хоёулаа Малфой руу ухасхийв. Тэр энэ бүхэн багш нарын нүдэн дээр болж багааг мартаад зөвхөн

Малфойг яаж өвтгөх вэ гэсэн ганцхан л хүсэлд автжээ. Шидэт саваагаа гаргах цаг ч байсангүй снитч атгасан гараараа бүх хүчээ гарган дайсныхаа гэдэс рүү цохилоо.

- Харри! Харри! Жорж! Больцгоо!

Тэр охидын хашгиралт, Малфойн орь дуу тавих, шүүгчийн шүгэл үлээх, үзэгчдийн орилооныг сонссон ч одоо түүнд хамаагүй болжээ. Дэргэд нь хэн нэгэн Инпедимента гэж хойшоо ухраах шившлэг хэлээгүй бол Малфойн хүрч болох бүх газар нүдэх байлаа.

- Та нар юу хийж байна? гэж хатагтай Нугарагч хашгирав.

Харри хөл дээрээ бослоо. Тэр л шившлэг илгээсэн бололтой. Нэг гартаа шүгэл нөгөө гартаа шидэт саваа барьсан байх агаад шүүр нь хэдэн алхамын зайд хэвтэж байв. Малфой газар эвхрэлдэн ёолон гонгинож хамраас нь цус гарч байлаа. Жоржын уруул хавдаж, Фредийг гурван ангууч зуурч тогтоон ард нь Крэбб зогсоод инээж байв.

- Би амьдралдаа хэзээ ч ийм зүйлийг харж байсангүй. Шилтгээн рүүгээ буц. Та хоёр шууд эрхлэгчийн өрөө рүү! Явцгаа! Одоохон!

Харри, Жорж хоёр талбай дээгүүр амьсгаадан чимээгүйхэн явлаа. Үзэгчдийн орилж хашгирах чимээ ард хоцорч тэд үүдний танхимд ороход хөлийн алхаанаас ондоо юу ч сонсогдсонгүй. Харри Малфойн эрүүг цохиод хөхөрсөн баруун гарынхаа үеийг харлаа. Хурууны завсраар нь снитчийн мөнгөн өрөвлөг чөлөөлөгдөхийг хүссэн мэт чичигнэж байв.

Профессор МакГонагалл тэднийг хаалганы өмнө гүйцэв. Тэр цонхийн цайж Гриффиндорын ороолт зүүсэн байх агаад чичирсэн гараараа угз татан хаалга руу ууртай зааж,

- Орцгоо! гэлээ.

Харри, Жорж хоёр орлоо. Тэр ширээндээ очиж суухдаа уурсан чичирч ороолтоо аван шал руу шидэв.

- За? Би хэзээ ч тийм гутамшигтай зүйл үзэж байсангүй. Нэгийн эсрэг хоёр.

Тайлбарла!

- Малфой биднийг өдсөн гэж Харри хэлэв.

- Өдсөн гэнээ? хэмээн тэр ширээ цохин хашгирахад дөрвөлжин хээтэй лааз онгойж шалан дээр жигнэмэг асгарав.

- Тэр хожигдсон. Мэдээж та нарыг өдөхийг хүсч байгаа! Гэхдээ юу хэлсэн болоод та хоёр ...

- Тэр миний эцэг эхийг доромжилсон. Бас Харрийн эхийг гэж Жорж уурсан хэлэв.

- Гэхдээ үүнийг хатагтай Нугарагчид үлдээхийн оронд маглуудын халз үзэлцэх аргыг сонгож аваа юу? Та хоёр юугаа бодсон юм?

- Кхэ хкэ.

Харри, Жорж хоёр зэрэг эргэн харав. Хаалган дээр ногоон жанч өмссөн Долорес Амбриж бахын нүүрэндээ дур гутам инээмсэглэл тодруулан зогсож байв. Харрид муу ёрын зөн совин татав.

- Профессор МакГонагалл таньд туслаж болох уу? гэж тэр хорон нялуун хоолойгоор асуулаа.

МакГонагаллын царай хүрээтэн улайв.

- Туслах уу? гэнээ? Туслах гэдэг чинь юу гэж байгаа юм? Амбриж инээмсэглэсээр өрөөнд орж ирлээ.

- Би жаахан нэмэлт эрх мэдэлтэй болсон болохоор таньд баяртай туслах байна. Харри профессор МакГонагаллын хамраас оч нисэн гарсан бол гайхахааргүй байлаа.

- Та буруу бодож гэж тэр хэлээд эргэж харлаа.

- Харин та хоёр анхааралтай сонсоцгоо. Надад та нарыг Малфой яаж доромжилсон нь хамаагүй. Тэр ч байтугай гэр бүлийн чинь гишүүн бүрийг доромжилсон ч гэлээ. Та нарын гаргасан авир жигшүүртэй байсан бөгөөд долоо хоногийн турш хичээлийн дараа үлдэх шийтгэл оногдуулж байна! Над руу ингэж харах хэрэггүй дээ, Поттер та үүнийг хүртэх гавъяатай! Ингээд ахин нэг л удаа ...

- Кхэ кхэ.

Профессор МакГонагалл тэнгэрээс тэвчээр хайрлахыг хүссэн мэт нүдээ аниад Амбриж руу эргэн харав.

- За?

- Би тэднийг илүү шийтгэл хүлээх гавъяатай гэж бодож байна хэмээн нүүр дүүрэн инээмсэглэн хэлэв.

Профессор МакГонагалл нүдээ том нээлээ.

- Гэхдээ харамсалтай нь гэвэл тэд миний тэнхимд сурдаг гэж бодож байна, Долорес гэж хариу инээмсэглэхийг хичээн хэлэв.

- Тэгвэл таныг гомдоох болох нь дээ, Минерва гэж Амбриж худал инээн хэлээд,

- Миний бодлоор үүнийг харсан нь дээр байх. Хааш нь хийчихлээ дээ?

Корнелис саяхан илгээсэн юм ... Аан энэ байна гэлээ. Тэр цаас гарган тэнийлгээд хоолой засан ханиалгаснаа уншлаа.

- Кхэ кхэ. Боловсролын тухай хуулийн хорин тавдугаар зүйл ...

- Үнэхээр ахин нэг гэж үү? хэмээн МакГонагалл уулга алдав.

- Тиймээ, тийм гэж Амбриж инээмсэглэн батлаад,

- Минерва таныг залруулах хэрэгтэй болох нь дээ ... Та над дээр хавсралт авчирснаа санаж байна уу? Харин би Гриффиндорын багт тоглох зөвшөөрөл өгөхийг хүсэхгүй байсан даа. Та Дамблдор тэр багт тоглох зөвшөөрөл өгсөн гэж шаардсан. Би юу ч хийж чадаагүй юм. Би тэр үед сайдтай холбогдоод тэр надад ерөнхий байцаагч ямар ч сурагч шийтгэх онцгой эрх олгосон ... Одоо харж байна уу, Минерва миний Гриффиндорын багт тоглох зөвшөөрөл өгөхийг хүсэхгүй байсан минь хичнээн зөв байсан болохыг. Аймшигтай араншин ... би сайжруулсан нэмэлтийг уншъя ... кхэ кхэ. «Ерөнхий байцаагчид үүнээс хойш Хогвартсын сурагчид холбоотой шийтгэлийн бүрэн эрх мэдлийг олгов. Гарын үсэг зурсан ид шидийн яамны сайд Корнелиус Фаж, Мерлиний нэгдүгээр зэргийн одонт».

Тэр цаасыг хуйлаад инээмсэглэн цүнхэндээ далд хийв.

- Тэгэхээр ... би та хоёрыг квиддич үүрд тоглохыг хориглох хэрэгтэй болох нь гэж тэдэн рүү дараалан харж хэлэв.

Харри снитч атгасан гарт нь чичигнэхийг мэдэрлээ.

- Хориглоно гэнээ? Үүрд үү? гэж асуухад түүний хоолой алсад байгаа юм шиг сонсогдов.

- Тиймээ, ноён Поттер би насан туршид нь хориглосон нь дээр гэж бодож байна. Ноён Уизли та хоёрыг. Миний бодлоор залуу хүмүүсийн аюулгүй байдлын тулд ихрүүдийн тоглохыг зогсоосон нь дээр байх. Хэрвээ багийн нөхөд чинь

зогсоогоогүй бол тэр ч гэсэн ноён Малфойг дайрах байсан гэж бодож байна. Би тэдний шүүрийг шийтгэл зөрчигдөх явдал гаргуулахгүйн тулд хураан авч өрөөндөө хадгална гэж тэр мөсөөр сийлсэн юм шиг нүүртэй МакГонагаллд хандаад,

- Багийн үдсэн гишүүд үргэлжлүүлэн тоглож болно. За ингээд болох шив гэлээ. Амбриж дээд зэргийн сэтгэл ханамжтай өрөөнөөс гарч явахад үхлийн нам гүм ноёрхов.

- Хориглосон гэнээ. Хориглосон. Баригчгүй довтлогчгүй ... ямар баг байх юм бэ? гэж Анжелина тэднийг амралтын өрөөнд ороход дуу алдлаа.

Тэдэнд ялсан урам зориг байсангүй. Харри ханан зуухны эргэн тойронд суусан багийнхаа гишүүдийн ууртай урам хагарсан царайг харж байлаа. Рон ганцаараа тэмцээний төгсгөлөөс хойш ирээгүй байв.

- Энэ чинь шударга бус хэрэг. Крэбб блажерийг шүгэл үлээсний дараа цохьсон биз дээ? Түүнийг бас хориглох хэрэгтэй байсан юм гэж Алисия хэлэв.

- Тиймээ гэж Гермionaгийн хамт Харрийн дэргэд сууж байсан Жинни гунигтай хэлээд,

- Гэхдээ түүнийг зөвхөн мөр бичүүлэхээр болсон гэсэн. Монтегю энэ тухай оройн хоолон дээр хөөрөн ярьж байсан гэв.

- Харин Фредийг юу ч хийгээгүй байхад хориглосон! гээд Алисия уурсан хэлээд өвдгөө балбалаа.

- Би юу ч хийгээгүй нь миний буруу биш. Хэрвээ гурван хүн араас бариагүй байсан бол тэр новшийг үхтэл нь балбаад өгөх байсан гэж Фред муухай харж хэллээ.

Харри харанхуй цонх руу харав. Цас орж байв. Снитч амралтын өрөөний эргэн тойронд эргэлдэн хүүхдүүд Живоглот сандал дээрээс үсрэн барихыг хичээхийг харлаа.

Анжелина бослоо.

- Би явж унтлаа. Магадгүй энэ бүхэн муухай зүүд байж ... маргааш өглөө сэрэхэд бид тоглоогүй ...

Түүний араас Алисия, Кэти хоёр явлаа. Арай хойхон Фред, Жорж хоёр тэдний хажуугаар баргар царайлан өнгөрөхөд араас нь Жинни явлаа. Ханан зуухны хажууд зөвхөн Гермiona, Харри хоёр үдэв.

- Роныг харав уу?. Харри толгойгоо сэгсрэв.

- Минийхээр бол тэр биднээс зугтаад байх шиг байна. Түүнийг хаана байгаа гэж бодож байна?

Энэ агшинд хаалга чахрах чимээ сонсогдож тарган хатагтай нээгдэн хөргөн нүхээр цонхийн цайж үс нь цас болсон Рон хорж ирэв. Тэр андуудаа хараад хөшсөн юм шиг зогслоо.

- Чи хаана байсан бэ? гээд Гермиона үсрэн бослоо.

- Зугаалсан юм гэж Рон бувтнав. Тэр бэлтгэлийн хувцастайгаа хэвээр байлаа.

- Чи бүр хөлдөх шахаж. Зууханд ойртоод суу гэж Гермиона хэлэв.

Рон Харри руу харалгүй өнгөрөөд сандал дээр холхон суулаа. Снитч тэдний толгой дээгүүр эргэлдэнэ.

- Намайг уучлаарай гэж Рон шал ширтэн хэллээ.

- Юуны төлөө? гэж Харри асуув.

- Би квиддич тоглож чадна гэж бодсон юм. Маргааш өглөө татгалзах болно.

- Татгалзана гэнээ тэгвэл багт гуравхан хүн үлдэнэ. Биднийг үүрд хөөчихсөн.

Фред, Жорж бид гурвыг.

- Юу? гэж Рон дуу алдав.

Гермиона түүнд Гермиона бүгдийг тайлбарлаж өгөв. Харрид ахин энэ түүхийг давтах хүч байсангүй. Түүнийг яриагаа дуусгамагц Рон улам зовж шаналсан төрхтэй боллоо.

- Бүгдэд би буруутайт ...

- Гэхдээ чи над руу Малфойг явуулаагүй биз дээ гэж Харри уурлалаа.

- Хэрвээ би квиддич дээр аймшигтай байгаагүй бол ...

- Энэ үүнд ямар хамаатай юм?

- Би дуунд сэтгэлээр унаад ...

- Бүгд л сэтгэлээр унасан.

Гермиона маргаанаас холдон босож цонх руу очоод цас хунгарлан орохыг харав.

- Сонсооч үүнийгээ боль! Чамайг өөрийгөө буруутгасан буруутгаагүй таагүй

явдал хангалттай байна!

Рон чимээгүй бодол болон жанч руугаа ширтэв. Хэсэг зуурын дараа уйтгартай хоолойгоор,

- Би амьдралдаа хэзээ ч ийм новшийн байдалд орж байсангүй гэв.
- Одоо ганцхан чи биш гэж Харри уурслаа.
- Та нар тайвширах хэрэгтэй юм шиг байна гэж Гермiona чичирсэн хоолойгоор хэллээ.
- Юунд тэр вэ? гэж Харри унтууцав.
- Юунд гэвэл. Хагрид эргээд ирж гэж тэр харанхуй цас орж байгаа цонх руу инээмсэглэн харж хэллээ.

БҮЛЭГ 20: ХАГРИДЫН ЯРИА

Харри хөвгүүдийн унталгын өрөө лүү чемоданаасаа үл үзэгдэгч цув болон Тэнүүлчний газрын зургаа авахаар гүйгээд Роны хамтаар түргэн буцан ирж Гермионаг охидын унтлагын өрөөний үүдэнд таван хором хүлээхэд үйлчлэгчийн нэхмэл ороолт, малгай, бээлий өмсчихсөн гарч ирэв.

- Тэнд хүйтэн байна! гэж тэр Роныг тэвчээргүйхэн ам нээхэд уучлал гуйсан хоолойгоор хэлэв.

Тэд хөргөн нүхээр гарч үл үзэгдэх цуваа яаран нөмрөхөд Рон нилээн өссөн болохоор хөлөө гаргахгүйн тулд тонгойх хэрэг гарчээ. Цашаа алгуур болгоомжтой хөдлөн гишгүүрээр уруудахын өмнө зогсож газрын зураг дээр Филч болон хатагтай Норрис ойрхон байгаа эсэхийг шалгав. Аз болоход зөвхөн сэтгэлээр унасан бараг толгойгүй Ник «Уизли манай хаан»-тай ихэд адилхан дууг гүнгэнэсээр хөвөн өнгөрөв. Тэд үүдний танхимд ороод чимээгүйхэн цастай нуга руу гарлаа. Хагридын байшингийн яндангаас утаа суунаглаж дөрвөлжин цонхноос гэрэл тусахыг хараад Харрийн зүрх баяртай цохил. Тэр догдолсондоо алхаагаа хурдасгахад Рон, Гермиона хоёр түлхэлцэн дагав. Зузаан цас чахруулан явсаар модон хаалганд хүрлээ. Харри гурван удаа цохиход байшин дотор нохой хуцав.

- Хагрид бид байна! гэж Харри цоожны нүхээр хашгирав.

- Мэдэхгүй гэж бодоо юу! гэх бүдүүлэг хоолой гарав.

Гурвуулаа цуван дороо бие бие рүүгээ баяртай эргэж харлаа. Хагридын дуунаас үзэхэд сэтгэл хангалуун байгаа бололтой.

- Босго давж амжаагүй байхдаа ... замаас холд, Соёт ... холдооч нойрмог нохой минь ...

Хаалга чахран нээгдэж Хагридын толгой цухуйв. Гермиона дуу алдан хашгирлаа.

- Мерлиний сахал минь чимээгүй! Цувтай байгаа юм уу? Алив орцгоо! гэж

Хагрид тэдний толгой дээгүүр харан хэлэв.

- Уучлаарай гэж Гермиона Хагридын дэргэдүүр өнгөрөхдөө шивнээд цуваа тайлмагц,

- Би зүгээр л ... Ёо, Хагрид! гэж дуу алдав.

- Дэмий яриа! Дэмий яриа! гээд Хагрид хаалгаа хааж хөшгөө яаран татав.

Гермиона түүнийг айдаст автан ширтлээ. Хагридын ширэлдсэн үсэн дээр хатсан цус тогтож, зүүн нүд нь том хавдаж хөхөрчээ. Нүүр болон гарт нь маажуулсан цусны мөр тогтсон харагдана. Бас болгоомжтой хөдөлж байгаагаас нь үзэхэд хавиргаа хугалснаас зайлахгүй гэж Харри бодлоо. Тэр саяхан ирсэн нь илт байлаа. Сандлын түшлэг дээр зузаан хар аяны дээл өлгөөстэй, хаалганы хажуугийн хананд хэд хэдэн хүүхэд багтаж болохоор том үүргэвч өлгөжээ. Хагрид өөрөө хоёр хүний биеийн хэмжээтэй болохоор гал руугаа хазганан очиж зэс данхтай цай тавилаа. Соёот тэднийг тойрон үсчиж нүүрийг нь долоохыг оролдов.

- Чамд юу тохиолдоо вэ? гэж Харри асуулаа.
- Зүгээр гээд байхад. Та нарыг харахад сайхан байна шүү. Зуныг сайхан өнгөрүүлэв үү гэж Хагрид тэдэн рүү баяртай хараад хэллээ.
- Хагрид чамайг дайрсан байна! гэж Рон хэлэв.
- Хичнээн удаа дэмий яриа гэж хэлэх юм бэ!
- Хэрвээ хэн нэгэн улаан нүүрэндээ ингэж цохиулсан бол дэмий яриа гэж хэлэхгүй байсан даа? гэж Рон шаардав.
- Чи хатагтай Помфри руу очих хэрэгтэй. Шарх чинь сайнгүй харагдаж байна гэж Гермиона сэтэгл зовон хэллээ.
- Эмчгүй аргалчихна ойлгомжтой юу? гэж Хагрид эсэргүүцэв.

Тэр өрөөний дунд байгаа том модон ширээ рүү очоод саван дээр байсан алчуур татав. Түүн дор машины дугуйны хэмжээтэй түүхий ногоон өнгийн цустай зүсэм мах байлаа.

- Чи идэх гээгүй биз дээ, Хагрид? Хортой юм шиг байна гэж Рон мах руу тонгойн хэлэв.
- Өөрөөр яаж харагдана гэж? Лууны элэг байгаа юм. Би идэх гэж аваагүй.

Тэр элгийг авч нүүрнийхээ зүүн талд наахад сахал дээр нь ногоовтор цус дуслан санаа амарсан байртай дуу алдав.

- Хэдийн дээрдэж. Хорсохгүй байхад тусалдаг юм.
- Бидэнд юу тохиолдсоноо хэлэхгүй юм уу? гэж Харри асуулаа.
- Чадахгүй нь, Харри. Энэ бол том нууц. Намайг ажилгүй болгох гээ юу.

- Чамайг аварга биетүүд рүү явуулсан уу? гэж Гермiona аяархан асуухад Хагридын хуруунаас лууны элэг гулган цээжин дээр нь палхийв.
- Аварга биетүүд гэнээ? гээд тэр махыг бүсэндээ хүрэхээс нь өмнө аваад нүүрэндээ нааж,
- Хэн чамд аварга биет гэж хэлээ вэ? Чи хэнээс сонссон юм? Хэн чамд намайг тэгж байна гэж хэлээ вэ, аан? гэлээ.
- Бид тааварласан юм гэж Гермiona уучлал гуйсан өнгөөр хэлэв.
- Аанхан, тааварласан юм биз дээ гээд Хагрид маханд далдлагдаагүй нүдээрээ ширүүн харлаа.
- Энэ ч ... илэрхий байсан гэж Рон хэлэв.

Харри толгой дохилоо. Хагрид тэдэн рүү ууртай харж тургилаад махаа ширээн дээр тавин исгэрч байгаа данхыг авахаар явлаа.

- Хэзээ ч ийм хүүхдүүдийг үзээгүй юм байна. Би магтаагүй л дээ. Дэндүү сониуч. Бусдын хэрэгт оролцоно гэж тэр гурван том хувин шиг аяганд цай аягалах зуураа хэлэв.

Гэвч сахал дороо инээмсэглэж харагдана.

- Тэгэхээр чи аварга биетүүдийг хайсан хэрэг үү? гэж Харри инээмсэглэн хэлээд ширээнд суув.

Хагрид тэдний урд цай тавиад өөдөөс нь харж суун махаа авч ахин нүүрэндээ наалаа.

- Тиймээ, эрсэн.
- Тэгээд олсон уу? гэж Гермiona шивнэн асуув.
- Үнэнийг хэлэхэд олоход тийм ч хэцүү байгаагүй. Ойлгож байна уу? Том биетэй юм чинь.
- Тэд хаана байна? гэж Рон асуув.
- Ууланд гэж Хагрид тодорхойгүй хэллээ.
- Маглууд тэднийг хардаггүй юм уу.
- Тиймээ тааралддаг. Тэд ууланд үргэлж золгүй явдал гардаг гэж ярьцгаадаг юм гэж тэр баргар хэлээд махаа хамгийн том хөх толбон дээр тааруулан заслаа.

- Алив ээ, Хагрид юу хийж байснаа яриад байгаарай! Аварга биетүүд яаж дайрсан тухай яриарай харин Харри чамд хэрхэн Дементор дайрсан тухай ярих болно гэж Рон хэлэв.

Хагрид аягатай цайндаа хахаж цацаад лууны элгээ унагачихлаа. Тэр ширээн дээгүүр цай болон лууны цус цацагдтал ханиалгахад мах ширээн дээрээс газар гулган уналаа.

- Дементорууд дайрсан гэдэг чинь юу гэж байгаа юм?

- Чи мэдээгүй юм уу? гэж Гермiona нүдээ томруулан хэлэв.

- Миний эзгүйд юу болсныг мэдэхгүй байна. Би нууц даалгавартай байсан болохоор ууль илгээгээд байж болохгүй байлаа. Дементорууд гэнээ! Та нар үнэн ярьж байна уу?

- Тийм шүү. Тэд Литл Уингингэд үеэл ах бид хоёр луу дайрсны дараа ид шидийн яамнаас намайг хөөсөн ...

- Юу гэнээ?

- ... тэгээд сонголд орохоор явсан юм гэхдээ чи эхлээд аварга биетүүдийн тухай ярь.

- Чамайг хөөсөн гэнээ?

- Надад зуныг яаж өнгөрүүлснээ хэлвэл би хариуд нь ярья.

Хагрид түүн рүү эрүүл нүдээрээ ширтлээ. Харри түүний гэмгүй шийдэмгий царай луу хараад харц буруулав.

- Тэгсэн юм байж гэж тэр эвлэрэнгүй хоолойгоор хэлээд Соёотын амнаас лууны элгийг авахаар доош тонгойв.

- Хагрид энэ чинь эрүүл ахуйч биш шүү дээ гэж Гермiona түүнийг махаа хавдсан нүдэн дээрээ тавиад цай балгахад хэллээ.

- Бид хичээл дууссаны дараа явсан юм ...

- Хатагтай Максим та хоёр уу? гэж Гермiona асуулаа.

- Тиймээ гээд түүний ногоон махаар хаагаагүй царай зөөлрөв.

- Хоёулаа явсан. Би та нарт Олимпияг зөөлөн биш эмэгтэй гэж хэлэх байна. Ер нь бол үзэсгэлэнтэй сайхан эмэгтэй ... Би хаашаа явахаа мэдэж байсан болохоор хад асган дээр хоноглоход тэр ганц ч удаа гомдоллоогүй шүү.

- Чи хаашаа явахаа мэдэж байсан юм уу? Аварга биетүүд хаана амьдардаг юм? гэж Харри асуулаа.

- Дамблдор мэдээд бидэнд хэлсэн.

- Тэд нуугдаж байна уу? Тэдний хаа амьдардаг нь нууц биз дээ?

- Юуных нь нууц байхав. Зөвхөн шидтэнгүүд л тэднийг алс хол байлгахад хүргэсэн. Гэхдээ тэдний байгаа газар хүрэхэд хэцүү. Ялангуяа хүмүүсийн хувьд. Ийм учраас Дамблдороос заавар авсан юм. Тэнд хүрэхэд сарын хугацаа шаардагдсан.

- Сар гэнээ? Зөөвөрлөгч ашиглаж болдоггүй юм уу? гэж Рон амьдралдаа анх удаа тийм утгагүй удаан аялалын тухай сонссон аятай хэллээ.

Хагрид хавдсан нүдээрээ түүн рүү хачирхалтай харав. Бараг өрөвдсөн ч юм шиг.

- Биднийг мөрдөж байсан юм, Рон.

- Хэн?

- Хэн байдаг юм. Ид шидийн яамнаас Дамблдорын хэнтэй ярьж хөдөлж байна гээд л бүх зүйлийг тагнаж байгаа.

- Үүнийг бид мэднэ. Бид ид шидийн яамнаас Дамблдорыг тагнаж байгааг мэднэ гэж Харри яриаг үргэлжлүүлэн сонсохын тулд тэсч ядан хэлэв.

- Тэгэхээр шидтэний тээврийн хэрэгслээр чи тэнд хүрч чадахгүй байсан хэрэг үү? Бүх замын турш магл шиг явсан уу? гэж Рон гайхширан асуув.

- Үргэлж тийм биш гэж Хагрид булзан хэлээд, Гэхдээ бид болгоомжтой байх хэрэгтэй байлаа. Олимпия бид хоёр анхаарал татам байсан гэж хэлж болно гэв.

Рон шуухитнаж найтааж байгаа эсэх нь ойлгомжгүй чимээ гаргаснаа яаран цай балгалаа.

- Биднийг мөрдөхөд амархан байсан. Бид амарч байгаа дүр үзүүлэн Францын байдаг Олимпиягийн сургууль руу явсан юм. Ингэхдээ ид шидийн яамны хэн нэгэн бидний араас дагаж байгааг мэдсэн. Чимээгүй явж байсан учир ид шид ашиглаж болохгүй байлаа. Яамнаас зөвхөн шалтаг өгөхийг хүлээж байв. Гэхдээ бид сүүлнээсээ Ди-Жонд салсан л даа.

- Ди-Жонд гэнээ? Би тэнд чинь амралтаараа байсан. Харин чи харсан уу? гэж

Гермиона хөөрөн хэлснээ Роныг харахад чимээгүй боллоо.

- Харин үүний дараа жаахан ид шид хэрэглэсэн болохоор муугүй аялал болсон. Польшийн хил дээр хоёр галзуу савдагтай таарч, Минскийн бааранд цус сорогч тулгарсан ч бүгд хэвийн өнгөрсөн.
- Очих газраа хүрээд ууланд авирч тэднийг хайсан ... Тэд шидтэнгүүд ойрхон байхад дургүйн дээр бас айдаг. Дамблдор Хэцүү нэрт аварга биетүүдийг бас хайж байгаа гэж анхааруулсан. Тэднийг хэдийн илгээмж явуулсан гэсэн. Болгоомжтой байж анхаарал татахгүй байх хэрэгтэй. Тэдний ойролцоо гэнэтхэн Үхэл залгигчидтай тааралдаж мэднэ гэсэн гээд Хагрид чимээгүй болон цайгаа балгалаа.
- Цаашаа! гэж Харри тэвчээргүйхэн хэлэв.
- Тэднийг олсон. Шөнө уулын хяр дээгүүр явсан тэд бидний дор байсан. Харанхуйд жижиг түүдэг галыг тойроод том дүрсүүд харагдсан ...
- Тэд ямар хэмжээтэй байна? гэж Рон аяархан асуулаа.
- Хорин фут. Зарим томууд нь хорин тав ч байж магадгүй гэж Хагрид хайхрамжгүй хэлэв.
- Тэд хэдүүлээ байна? гэж Харри асуулаа.
- Долоо юмуу найм байсан байх.
- Ингээд л болоо юу? гэж Гермiona хэллээ.
- Тиймээ гэж Хагрид гашуудалтай хэлээд,
- Өөр хоорондоо ялгаатай зуугаад овог байснаас ийм үлдсэн байсан. Тэд зууны туршид үхэж сөнөсөн. Заримыг нь шидтэнгүүд алж гэхдээ гэхдээ ихэнхдээ тэд бие биеэ алсан болохоор түргэн хорогдсон юм. Тэд хамтдаа амьдарч чаддаггүй юм. Дамблдор шидтэнгүүд тэднийг хүчээр хол хөөж нэг дор байлгасан учир буруутай гэж хэлсэн.
- Тэднийг хараад дараа нь яасан? гэж Харри яаран асуулаа.
- Өглөө болохыг хүлээсэн. Харанхуйд ойртохыг хүсээгүй аюултай. Шөнийн цагаар тэд суугаагаараа унтаж байдаг юм. Харин бид унтахаас айсан. Тэдний хэн нэгэн бидний дэргэдүүр өнгөрвөл яана. Ер нь бол гэгээ ороход тэдэн рүү очсон.
- Шууд очсон хэрэг үү? Аварга биетүүдийн буудал руу юу? гэж Рон эмээнгүй хэлэв.

- Дамблдор бидэнд тэдэнтэй яаж харьцахыг хэлсэн. Гургуд бэлэг өгч хүндэтгэж байгаагаа нэг үгээр хэлэх ёстой.

- Хэнд бэлэг авчирсан гэнээ? хэмээн Харри асуулаа.

- Гургуд толгойлогч нь байгаа юм.

- Хэн Гургу гэдгийг нь яаж мэдэх юм бэ? гэж Рон асуулаа.

Хагридыг асуулт хөгжөөв бололтой.

- Маш амархан. Хамгийн том, хамгийн аймшигтай залхуу нь. Суугаад бусдыгаа хоол авчирч өгөхийг хүлээж байдаг юм. Үхсэн ямаа болон бусад зүйлс. Түүний нэрийг Каркус гэдэг байсан. Хорин хоёр гурван фут өндөр нас бие гүйцсэн зааны жинтэй. Арьс нь яг л хирснийх шиг.

- Чи түүн рүү очоо юу? гэж Гермiona тэсч ядан асуув.

- Хөндийд хэвтэж байхад нь дөхсөн. Тэр дөрвөн өндөр уулийн дундах нуурын эргээс холгүй хотгорт хэвтэж байсан. Каркус хэвтээд бусад нь түүнд болон эхнэрт нь хоол авчирч өгч байсан. Олимпия бид хоёр доошоо уруудсан.

- Тэд та нарыг хараад алахыг хүссэнгүй юу? гэж Рон гайхлаа.

- Бодсон л байх. Гэхдээ бид Дамблдорын хэлсэн ёсоор хийсэн. Бусдыг нь тоолгүй зөвхөн гургугийн урд бэлгээ өргөн тавьсан. Тэгж хийсэн. Үлдсэн нь тэнд тайван хэвтээд биднийг Каркусын хөл рүү очин бөхийгөөд бэлэг урд нь тавихыг харж байсан.

- Та нар аварга биетүүдэд юу аваачиж өгөө вэ? Хоол уу? гэж Рон асуув.

- Үгүй дээ, түүнд хоол хангалттай. Бид түүнд шидэт зүйл аваачсан. Аварга биетүүд ид шидэд дуртай ч тэдний эсрэг хэрэглэхэд дургүй. Товчхондоо бид эхний өдөр түүнд Губрайтовын галтай мөчир өгсөн.

Гермиона аяархан дуу алдахад Харри, Рон хоёр гайхан харлаа.

- Ямар мөчир гэнээ?

- Мөнхийн гал. Та хоёр мэдэх ёстой биз дээ. Профессор Флитвик хичээл дээр хамгийн багадаа хоёр удаа ярьсан гэж Гермiona уурсан тайлбарлав.

- Товчхондоо гэвэл Дамблдор энэ мөчрийг үргэлж асч байхаар илбэдсэн юм.

Үүнийг шидтэн бүр чадаад байдаггүй. Би түүнийгээ Каркусын хөлд цасан дээр

тавиад «Аварга биетүүдийн гургуд Альбус Дамблдороос хүндэтгэн мэндчилж бэлэг авчирлаа гэсэн».

- Каркус юу гэж хэлсэн бэ? хэмээн Харри сонирхов.
- Юу ч хэлээгүй. Англи хэл мэддэггүй юм.
- Чи тоглож байгаа байлгүй дээ!
- Энэ чухал биш. Дамблдор бидэнд тийм зүйл тохиолдож болзошгүй гэж анхааруулсан. Каркус гадаад хэл мэддэг хоёр аварга биетүүдээр орчуулуулсан юм.
- Бэлэг түүнд таалагдсан уу? гэж Рон асуув.
- Өө, тэгэлгүй яахав юу болохыг нь мэдээд арай л цовхроогүй гэж Хагрид хэлээд хавдсан нүдэн дээрээ лууны элгийг хүйтэн талаар нь эргүүлэн тавилаа. Их сэтгэл хангалуун байсан. Би Альбус Дамблдор гургуд маргааш өглөө шинэ бэлэг өгнө гэсэн.
- Яагаад шууд ярилцаж болдоггүй юм? гэж Гермiona гайхлаа.
- Дамблдор биднийг удаанаар хийхийг хүссэн юм. Бид маргааш ахин нэг бэлэгтэй ирнэ гэж хэлсэн. Сайхан сэтгэгдэл төрүүлэх гэж байгааг ойлгож байгаа биз дээ? Харин тэд анхны бэлгээ шалгаж сайн зүйл гэдгийг мэдмэгц ахин хүссэн. Ерөнхийдөө Кракусын адил аварга биетүүдийн тархийг шинэ мэдээгээр хэтэрхий дүүргэвэл чамайг алах аюултай. Бид мэхийн ёслоод явж хоноглох сайхан газар олоод өглөө нь буцаж ирэхэд энэ удаад Каркус суугаад биднийг тэсч ядан хүлээж байсан.
- Чи түүнтэй ярьсан юм уу?
- Тэгэлгүй яахав. Бид эхлээд түүнд албингуудын хийсэн ган дайны дуулга бэлэглээд дараа нь суугаад ярьсан.
- Тэр ярьсан уу?
- Бага зэрэг. Ихэнхидээ сонсоон. Гэхдээ энэ бол сайны тэмдэг. Тэр Дамблдорыг хэрхэн Англид сүүлчийн аварга биетийг алсны эсрэг байгааг сонссон. Каркусд Дамблдорын хэлсэн үг ихэд сонирхолтой байсан. Тэдний ялангуяа англи хэл мэддэгүүд нь бас дөхөж ирээд сонссон. Бид тэр өдөр найдлагатай явсан юм. Маргааш нь ахиад өөр бэлэгтэй ирэхийг амалсан. Харин шөнө бүх зүйл буруугаараа эргэсэн.
- Яагаад тэр вэ? гэж Рон асуулаа.

- Би тэднийг хамтдаа байж тэсдэггүй хэлсэн биз дээ. Тийм том бүлэг юм чинь. Тэд шууд л бие биенийгээ ална. Эрчүүд нь эрэгтэйчүүдтэйгээ, эмэгтэйчүүд нь эмэгтэйчүүдтэйгээ тулалдаж, хуучин овгийн үлдэгдэлүүд өөр хоорондоо гал юм уу газрын төлөө тэмцдэг юм. Чи бүх хамаатан чинь бие биеэ дуусгаж байна гэж төсөөлөөд үз дээ гээд Хагрид гүнзгий санаа алдлаа.

- Тэр шөнө зодоон болсон. Бид агуйн аман дээрээс харсан юм. Цагийн турш учир нь олдохын аргагүй чимээ шуугиан болсон. Харин нар мандах үед цас улайн түүний толгой нуурын ёроолд хэвтэж байлаа.

- Хэний толгой? гэж Гермiona айн асуув.

- Каркусын. Тэдний шинэ гург Голгомаф болсон байсан. Бид хоёр өдрийн дараа шинэ гург томилогдоно гэж бодоогүй болохоор эхнийх шигээ нөхөрсгөөр ирсэн ч Голгомаф биднийг сонсохыг хүсээгүй.

- Та нар түүнтэй ярих гэж очсон юм уу? Нүдэн дээр чинь өөр аварга биетийн толгойг тасалсаны дараа юу? гэж Рон гайхширан асуулаа.

- Мэдээж тэгсэн. Бид тийм хол очиж хоёр өдөр өнгөрөөд байсан юм чинь.

Каркусд бэлтгэсэн бэлэгтэй очсон. Гэхдээ би амаа нээж амжаагүй байхдаа л бүтэхгүй гэдгийг нь ойлгосон. Тэр Каркусын дуулгыг өмсөн суугаад биднийг ойртоход муухай харсан. Хамгийн том биетэй нь байсан. Хар үстэй, ясаар хэлхэж хийсэн зүүлттэй. Би лууны том хуйлсан арьс өгөөд «Аварга биетийн гургууд бэлэг авчирлаа гэсэн». Тэгээд эргэж харж амжилгүй толгой уруугаа харан зүүгдэж хоёр дагалдагч нь миний хөлөөс барьсан байлаа.

Гермиона алгаараа амаа дарав.

- Чи тэднээс яаж суллагдсан бэ? гэж Харри асуулаа.

- Олимпиягүй бол юу ч бүтэхгүй байсан. Тийм хурдан саваа гаргахыг ер нь харж байснаа санахгүй юм байна. Гайхамшигтайгаас өөр хэлэх зүйл алга. Намайг барьж байсан хоёрын нүд рүү Конъюнктивитус шившлэг илгээхэд шууд унагаасан. Одоо бид тэдний эсрэг ид шид хэрэглэсэн учир асуудал тулгарсан даа. Тэд үүний төлөө л шидтэнгүүдийг үзэн яддаг юм. Бид өөр арга байхгүй болсон гэдгийг мэдэж байсан учир буудал руугаа зугтсан.

- Чөтгөр гэж, Хагрид хэмээн Рон шивнэлээ.

- Тэгвэл тэнд ердөө гурван өдөр байсан юм бол гэр лүүгээ яагаад тийм удаан ирсэн юм бэ? гэж Гермiona асуув.
- Бид тэнд гурван өдөр байгаагүй. Дамблдор бидэнд найдаж байсан юм! гэж Хагрид унтууцан хэлэв.
- Гэхдээ чи арга байхгүй болсон гэж хэлээ биз дээ!
- Өдөр бол байхгүй байсан. Бүгдийг бодох хэрэгтэй болсон. Хоёр өдөр өнгөрөхөд хадан дээр суугаад харж байлаа. Ингээд бидэнд таалагдахгүй зүйлийг олж харсан.
- Тэр ахиад хэн нэгний толгойг огтлоо юу? гэж Гермiona нүдээ даран асуув.
- Үгүй. Түүнээс ч дор.
- Юу болсон юм?
- Тэднийг бүх шидтэнгүүдийн эсрэг биш зөвхөн бидний эсрэг байгааг харсан.
- Үхэл залгигчид уу? гэж Харри тааварлав.
- Тиймээ. Тэдний хоёр нь өдөр бүр түүн рүү очиж гургуд бэлэг өгөхөд доош нь харуулан дүүжлээгүй.
- Тэднийг Үхэл залгигчид гэж яаж мэдсэн юм бэ? гэж Рон асуув.
- Би нэгийг нь таньсан. Макнейрийг санаж байна уу? Клювокрылыг цаазлахаар явуулсан байсан. Донтой алуурчин. Голгомафаас дутуугүй алах дуртай.
- Тэгэхээр Макнейр аварга биетүүдийг Хэцүү нэртийн талд нэгдэхийг ятгасан юм биз дээ?
- Тэвчээртэй бай, би түүхээ дуусаагүй байна! гэж Хагрид зандрав. Тэр эхэндээ ярихыг хүсэхгүй байсан ч одоо бол сэтгэл хангалуун ярьж байлаа. Олимпия бид хоёр хэрвээ гург Хэцүү нэртийг дэмжвэл бусад нь ч гэсэн дэмжинэ гэж ярилцаад шийдсэн. Голгомафыг гургу болгохыг хүсэхгүй байгаа бусадтай нь ярих хэрэгтэй байлаа.
- Та нар тэдний тийм гэдгийг яаж ойлгосон юм бэ? гэж Рон асуув.
- Голгомаф тийм санаатай хүмүүсээ цааш нь зайлуулж бидэн шиг агуйд нуугдсан байлаа. Бид тэдэн рүү шөнө очихоор шийдсэн юм.
- Та нар харанхуй агуйд орж аварга биетүүдийг эрсэн хэрэг үү?

- Бидний санааг аварга биетүүд зовоогоогүй. Бид Үхэл залгигчидаас илүү болгоомжилж байсан. Дамблдор тэдэнтэй орооцолдох хэрэггүй гэж хэлсэн ч гай болоход биднийг мэдсэн. Голгомаф л хэлсэн байх гэж бодож байна. Шөнө аварга биетүүд унтсан хойно бид агуйгаасаа гарахыг хүссэн ч Макнейр туслагчтайгаа ууланд биднийг хайж байсан. Би Олимпияг тэдэн рүү дайруулахгүй гэж арайхийн тогтоосон.

- Шууд л дайрсан ... ямар их уурласан гээч ... франц цус нь л хөөргөсөн байх.

Хагрид бүүдгэр нүдээр гал руу харлаа. Харри түүнд санах гучин секунд өгөөд дараа нь чанга ханиалгав.

- Тэгээд яасан бэ? Та нар бусад аварга биетүүд дээр очоод?

- Аан? Юу? Тийм л дээ, хүрсэн. Каркусыг алсаны гурав дахь шөнө бид агуйгаас гарч хөндий рүү орсон. Үхэл залгигчидтай тааралдахгүйн тулд сэрэмжтэй явж байлаа. Хэд хэдэн агуй хоосон байсан. Харин зургаа дахаас нь гурван аварга биет олсон.

- Тэд агуйд шахцалдаггүй юм уу гэж Рон хэллээ.

- Ямар байшин биш дээ.

- Тэд та нарыг харангуутаа дайрсангүй юу? гэж Гермiona асуулаа.

- Хэрвээ хүч нь хүрсэн бол дайрах л байсан байх. Гэхдээ гурвуулаа хүнд шархадсан байсан. Голгомаф тэднийг ухаан алдтал нь балбасан болохоор сэргээд хамгийн ойрын газар нуугдсан юм байж. Тэднийг нэг англи хэл бага зэрэг ойлгодог болохоор бусаддаа миний юу ярьсныг дамжуулж ойлгосон байх. Ингээд нэг хэсэг зургаа долоог итгүүлсэн.

- Зургаа долоо гэнээ? Муугүй шүү. Тэгэхээр тэд Хэцүү нэртийн эсрэг бидэнтэй хамт тэмцэхээр ирсэн үү? гэж Рон баярлав.

Харин Гермiona,

- Хагрид чи яагаад нэг хэсэг гэж хэлсэн юм бэ? гэв. Хагрид түүн рүү гунигтай харав.

- Голгомаф агуй руу дайрсан. Амьд үлдэгсэд үүний дараа бидэнтэй ярихыг хүсээгүй.

- Тэгэхээр ... аварга биетүүд ирэхгүй юм уу? гэж Рон урам хугаран асуув.

- Үгүй гээд Хагрид хүндээр санаа алдсанаа махаа эргүүлэн хүйтэн талаар нь нүүрэн дээрээ тавилаа.

- Гэхдээ бид Дамблдорын үгийг тэдэнд дамжуулж сонгосон. Тэд Голгомафтай үлдэхийг хүсэхгүй байвал уулнаас гарч Дамблдор тэдэнд найрамдал хүссэнийг санаад ...

Цонхны гадаа цас хунгарлаж байлаа. Харри Соёт өвөр дээр нь шүлсээ гоожуулан хэвтэж байсан учир өвдөг нь шалба норсоныг мэдрэв.

- Хагрид? гэж Гермiona эмээнгүй дуугарав.

- Хмм?

- Харин чи ... эхийнхээ тухай ямар нэг зүйл сонссон уу ... хэн нэгэн ярьсангүй юу?

Хагридын нүд Гермiona дээр амаргүй асуулт тавьсан мэт тогтлоо.

- Уучлаарай ... би мартчихаж.

- Үхсэн. Аль эрт. Тэд надад хэлсэн гэж Хагрид бувтналаа.

- Өө, надад их харамсалтай байна үнэн шүү гэж тэр аяархан хоолойгоор хэллээ. Хагрид өргөн мөрөө хавчив.

- Зүгээр дээ. Түүнийг санахгүй байна. Сайн ээж байгаагүй юм.

Тэд ахин чимээгүй болцгоов. Гермiona Харри, Рон хоёр луу ямар нэг зүйл ярихыг хүссэн мэт харав.

- Гэхдээ Хагрид чи яагаад ингэж чимэглэгдсэнээ тайлбарласангүй гээд Рон цус хурсан царай руу нь заалаа.

- Бас яагаад удтал буцаж ирээгүй гэдгээ. Сириус хатагтай Максим зуун жилийн өмнө буцаад ирсэн гэсэн шүү.

- Хэн чамайг дайрсан юм? гэж Рон асуулаа.

- Хэн ч намайг дайраагүй! Би ...

Түүний яриаг гэнэтийн хаалга тогших чимээ тасалдуулав. Гермiona дуу алдахад аяга гараас нь унан хагарав. Соёт хуцлаа. Хөшигний цаана жижигхэн хүний сүүдэр харагдлаа.

- Энэ тэр байна! гэж Рон шивнэлээ.

- Ийшээ ор! гэж Харри түргэн хэлээд үл үзэгдэх цуваа авч Гермиона бүтээхэд Рон тэдэн рүү ширээн доогуур ухасхийлээ. Тэд шахцалдан буланд зогсов. Соёот хаалга руу галзуурсан юм шиг хуцав. Хагрид мэгдсэн байртай харагдана.

- Хагрид бидний аягыг нуу!

Хагрид Рон, Харри хоёрын аягыг авч Соёотын жинтүүн доогуур хийлээ. Соёот үүд рүү дэвхэрч байв. Хагрид Соёотыг хөлөөрөө замаасаа холдуулаад онгойлгов.

Үүдэн дээр профессор Амбриж ногоон жанчтайгаа зогсож байв. Тэр Хагридын бараг хүйсээр татаж байсан тул хөмхий зуун нүүрийг харахаар хойш гэдийв.

- Тэгэхээр. Та Хагрид уу? гэж дүлий хүнтэй ярилцаж байгаа юм шиг чанга асууснаа хариулт хүлээгүй гэрт орж бүлцгэр нүдээрээ зүг бүр тийш ширтэв.

- Цаашаа гэж тэр зандраад нүүрийг нь долоохоор үсчиж буй Соёот руу цүнхээ савлаа.

- Бүдүүлэг байхыг хүсэхгүй байна л даа. Гэхдээ та хэн бэ? гэж Хагрид түүн рүү харж асуулаа.

- Намайг Долорес Амбриж гэдэг.

Түүний харц өрөөг нэгжив. Хоёр ч удаа Харри, Рон, Гермиона гурвын шахцалдан зогссон булан руу харлаа.

- Долорес Амбриж гэнээ? Би таныг яамных гэж бодож байна. Та Фажын дэргэд ажилладаггүй биз? гэж Хагрид хэлэв.

- Тиймээ, би сайдын нэгдүгээр зэргийн орлогч гэж Амбриж хэлээд өрөөн дундуур явж хананд өлгөсөн үүргэвч болон аяны дээлийг нь харав. Харин одоо хар урлагаас хамгаалах хичээлийн багш ...

- Зоригтой эмэгтэй байна. Энэ ажлыг хийх тийм ч олон хүн байдаггүй юм гэж Хагрид хэлэв.

- ... бас Хогвартсын ерөнхий байцаагч гэж Амбриж түүнийг сонсоогүй мэт үгээ дуусгав.

- Энэ чинь юу гэсэн үг юм? гээд Хагрид хөмсгөө зангидав.

- Ийм асуултыг би таньд л тавимаар байна гээд Амбриж Гермионагийн хагалсан аягыг заав.

- Аан ... гээд Хагрид зочдынхоо нуугдсан булан руу хяламхийн,
- Аан энэ үү ... Соёотоос болж байгаа юм. Тэр аяга хагалчихсан. Би оронд нь өөрийг хэрэглэж байлаа гэв.

Тэр цай ууж байсан аягаа заагаад нүдэндээ лууны мах наалаа. Одоо л Амбриж түүний урд зогсож гадаад байдлыг нь шинжив.

- Би хоолой сонссон.
- Би нохойтойгоо ярьж байсан юм гэж Хагрид шийдэмгий хэлэв.
- Тэгээд тэр таньд хариулж байна уу?
- Тэгж хэлж болно л доо. Би заримдаа Соёотыг бараг л хүн шиг боддог юм.
- Гадаа цасан дээр шилтгээний хаалганаас танай үүд хүрсэн гурван мөр гарсан байсан.

Гермиона дуу алдахад Харри амыг нь дарлаа. Аз болоход Соёт профессор Амбрижийг жанчыг чимээтэй шиншилж байсан учир тэр юу ч сонссонгүй.

- Би саяхан эргэж ирсэн. Магадгүй хэн нэгэн ирээд буцсан биз гээд Хагрид аварга том гараараа үүргэвчээ заалаа.
- Байшингаас буцсан хөлийн мөр байхгүй байсан.
- Яагаад гэдгийг нь ... мэдэхгүй юм гэж Хагрид хэлээд ахин хүүхдүүдийн зогсож байгаа булан руу тусламж хүсэх мэт харав.

Амбриж эргээд өрөөн дундуур явж анхааралтай харлаа. Орон доогуур бөхийж үзэн шүүгээ онгойлгон шалгав. Хүүхдүүдийн хажуугаар хоёрхон инчийн өнгөрлөө. Харри түүнийг ойртоход дотор нь палхийлээ. Дараа нь Хагридын хоол хийхдээ бэлтгэдэг том тогооны доторхыг хараад эргэж,

- Таньд юу тохиолдоо вэ? Хаана ингэж шархдаа вэ? гэлээ. Хагрид яаран лууны элгийг нүүрнээсээ холдуулаад,
- Багахан осол болсон гэж итгэлгүйхэн тайлбарлав.
- Ямар төрлийн осол гэж?
- Би ... би уначихсан юм.
- Уначихсан гэнээ? гэж Амбриж мөс шиг хоолойгоор давтлаа.

- Яг тийм. Найзынхаа шүүрнээс. Би өөрөө нисдэггүй. Намайг ямар хэмжээтэй болохыг минь харж байгаа биз дээ. Шүүр намайг даасангүй. Намайг Абраканскийн морьд л даана. Таныг мэдэх эсэхийг мэдэхгүй юм. Нэг тийм далавчтай амьтад байдаг юм ...

- Та хаана байсан бэ? гэж Амбриж хүйтнээр яриаг нь таслав.

- Би хаана байсан гэж үү?

- Тиймээ хаана байсан юм? Хичээл хоёр сарын өмнө эхэлсэн. Таныг өөр багш орлож байгаа. Хэн ч таны хаана байгааг мэдэхгүй байсан. Та хаягаа үлдээгээгүй. Ингэхэд та хаана байсан бэ?

Нам гүм болоход Хагрид хөхөрсөн нүдээрээ Амбриж руу ширтлээ. Харри түүний тархи яаж ажиллаж байгааг бараг сонсох шиг болов.

- Эрүүл мэндээ засах гээд явсан юм.

- Эрүүл мэндээ засах гэнээ. Ойлгож байна гээд тэр өнгөө хувирган хавдсан царай болон хантаазан дээр нь дусалсан лууны цусыг харлаа.

- Тиймээ жаахан цэвэр агаар амьсгалах гэсэн юм, ойлгож байна уу.

- Тиймээ, ойн сахиул цэвэр агаарын дутагдалд орж гэж Амбриж хорон өнгөөр хэлэв. Хагридын нүүрний хөхрөөгүй хэсэг улаан болов.

- Уулын агаар уу? гэж Амбриж түргэн хэллээ. Тэр мэдэж байна гэж Харри цөхрөн бодлоо.

- Уулынх гэнээ? Үгүй дээ, би Францын өмнө зүг рүү явсан. Жаахан нар тэнгис гээд л.

- Үнэн үү? Борлосон харагдахгүй л байна даа.

- Тиймээ ... мэдрэмхий арьс байгаа юм гэж Хагрид зусардахыг хичээн инээмсэглэв.

Харри түүний хоёр шүд байхгүй болохыг ажиглалаа. Амбриж түүн рүү хүйтнээр харахад инээмсэглэл нь алга болов. Тэр цүнхээ тохойндоо эгэлдэргэлээд,

- Би сайдад таны хоцорч ирснийг мэдээлэх болно гэв.

- Зүйтэй гээд Хагрид толгой дохив.

- Таныг ерөнхий байцаагч багш нарыг шалгаж байгаа гэдгийг мэдэх ёстой гэж

бодож байна. Тэгэхээр бид удахгүй уулзах байх.

Тэр цаашаа эргээд хаалга руу явлаа.

- Та биднийг шалгаж байгаа юм уу? гэж Хагрид гайхан араас нь дагуулан харж хэллээ.

- Өө, тэгэлгүй яахав гээд Амбриж хаалганы бариулаас барин эргэж харснаа,

- Ид шидийн яамнаас шаардлага хангахгүй багш нарыг халахаар хатуу шийдсэн байгаа, Хагрид. Тавтай нойрсоорой гээд хаалга хаав.

Харри үл үзэгдэх цуваа тайлахыг хүссэн ч Гермiona бугуйнаас нь барин зогсоогоод,

- Хүлээгээрэй. Тэр яваагүй байж мэднэ гэж чихэнд нь шивнэлээ.

Хагрид бас тэгж бодсон бололтой. Үүд рүү очоод хөшиг сөхөн харав.

- Шилтгээн рүү явчихлаа. Чөтгөр гэж ... тэр хүмүүсийг шалгаж байгаа юм уу?

- Тиймээ. Трелонид хэдийн туршилтын хугацаа өгсөн гэж Харри цуваа сөхөөд хэлэв.

- Хагрид чи бидэнд ямар төрлийн хичээл заахаар төлөвлөж байна даа? гэж

Гермиона асуулаа.

- Өө, энэ тухай санаа зовох хэрэггүй би сайхан хичээл заахаар бэлдсэн гэж Хагрид урам зоригтой хэлээд лууны махыг ширээн дээрээс авч нүдэндээ ахин наагаад,

- Та нарын С.И.Ш хамгаалахад зориулан хэдэн амьтан бэлтгэсэн байгаа.

Жинхэнэ онцгой амьтан харнаа гэв.

- Онцгой гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Гермiona асуулаа.

- Би хэлэхгүй. Гэнэтийн бэлгээ задлахыг хүсэхгүй байна гэж Хагрид баяртай хэллээ.

- Сонсооч, Хагрид хэрвээ чи хичээл дээр ямар нэг аюултай амьтан авчирах юм бол профессор Амбриж баяртай байх болно гэж Гермiona эелдэг байхаа болиод шаардангуй хэллээ.

- Аюултай гэнээ? Тэнэг байх хэрэггүй, би ямар ч аюултай зүйл авчираагүй гэж

Хагрид гайхлаа.

- Хагрид чи Амбрижын шалгалтан дээр аятайхан байх ёстой. Хэрвээ чи бидэнд глиноклок, нарлов ч юмуу иймэрхүү амьтад заавал ...

- Энэ чинь ямар ч сонирхолгүй, Гермiona. Надад сэтгэл хөдлөм зүйл бий. Би анхны жилдээ Англид сүргийг гаршуулсан гэж бодохгүй л байна шүү.

- Хагрид ... гуйя ... Амбриж Дамблдорд ойрхон багш нарыг зайлуулах дурын шалтаг хайж байгаа. Бидэнд С.И.Ш авахад ямар нэг уйтгартай юм өгөөрэй.

Гэвч Хагрид том эвшээгээд булангийн том ор луугаа харав.

- Сонсооч, энэ их урт өдөр байлаа бас орой болчихож гээд Гермionaгийн мөрөн дээр зөөлөн алдахад өвдөг нь шал руу нугарч уналаа.

- Өө, уучлаарай гээд Хагрид түүнийг шилэн хүзүүнээс нь татан босголоо.

- Чи надад санаа зовох хэрэггүй. Би та нарын хичээл дээр хөгжилтэй амьтан авчирсан үнэн шүү ... Харин одоо хүүхдүүдээ шилтгээн рүү буцахдаа мөрөө арилгахаа битгий мартаарай!

- Түүний чиний яриаг ойлгосон эсэхийг мэдэхгүй юм гэж Рон тэднийг шилтгээн рүү хунгарласан цасан дээгүүр буцахад хэллээ. Гермiona Устгах шившлэгээр мөрөө арилгаж байв.

Тэгвэл би маргааш ахиад түүн рүү очно. Шаардлагатай бол түүний хичээлийн төлөвлөгөөг үзнэ. Надад Трелониг халах хамаагүй ч Хагридыг бол тэсэхгүй.

БҮЛЭГ 21: МОГОЙН НҮД

Ням гаригийн өглөө Гермiona өвдөг хүрсэн цасанд шигдсээр ахин Хагридын овоохой руу явлаа. Харри, Рон хоёр түүнтэй явахыг хүссэн авч уул овоо шиг их гэрийн даалгавараасаа болоод амралтын өрөөнд дургүйхэн үлдэж гадаа хүүхдүүдийн хөлдсөн нууран дээр тэшүүрээр наадаж, чаргаар гулгах хөгжилтэй дууг тоохгүй байхыг хичээсэн ч хамгийн муу нь гэвэл Грриффиндорын цамхагийн цонх руу цасан бөмбөлөг шидэх чимээ байлаа. Эцсийн эцэст Рон тэвчихээ болиод цонхоор толгойгоо цухуйлган орилов.

- Хөөе! Би бол ахлагч. Хэрвээ ахин нэг удаа цас цонх руу шидэх юм бол ... Ёо! гээд толгойгоо түргэн оруулахад нүүр нь цас болсон байлаа. Энэ Фред, Жорж хоёр байна гэж тэр гашуунаар хэлээд цонх хаав.

Гермиона Хагридынхаас үдийн хоолны үеэр өвдгөө хүртэл норсон жанчтай үл мэдэг чичирэн ирэв.

- За? Түүний бүх хичээлийн хөтөлбөрийг үзэв үү? гээд Рон түүнийг дагуулан харав.

- Оролдсон гэж тэр гунигтай хариулаад Харрийн дэргэд суулаа. Дараа нь шидэт саваагаа даллаж төгсгөлөөс нь халуун уур гаргаад жанч руугаа чиглүүлэн хатааж эхлэв.

- Намайг очих үед тэр гэртээ байгаагүй. Би хаалгыг нь бараг хагас цаг цохисон. Дараа нь ойгоос гарч ирсэн.

Харри дуу алдан ёолов. Хориотой ой Хагридын юунаас түрүүнд дуртай амьтдаар дүүрэн байдаг билээ.

- Тэр тэнд юу хийж байсан юм бол? Хэлсэн үү?

- Үгүй, бидэнд гэнэтийн бэлэг барихыг хүсч байна гэсэн. Би түүнд Амбрижийн тухай тайлбарлаж өгөхийг оролдсон ч тэр ойлгоогүй. Зөвхөн ямар ч эрүүл ухаантай хүн нарл, химерийг судлахгүй гэсэн ... Үгүй ээ түүнийг химер авчирсан гэж бодохгүй байна гэж Харри, Рон хоёрын хирдхийсэн царайг харж яаран яасаад,

- Энэ бол тэр оролдоогүй гэсэн үг биш. Би түүний үгнээс өндгийг нь авчрахад ямар хэцүү болохыг ойлгосон. Түүнд хичнээн удаа Граббли Дергийн хөтөлбөрийг дагасан нь дээр гэж хэлснээ ч мэдэхгүй байна. Тэр миний хэлсэн үгийн зөвхөн

хагасыг л сонссон байх. Нэг тийм хачин зантай байсан. Яаж шархадсан тухайгаа ярихыг ч хүсээгүй гэв.

Хагрид маргааш нь багш нарын ширээнд өглөөний цайны үеэр ирэхэд бүх сурагчид хөөрөн хашгиралдаж угтсангүй. Зарим нь Фред, Жорж, Ли нар шиг баяртай хашгирч Гриффиндор, Пуффендуйн ширээний дундуур том гараас нь атгахаар гүйж байхад зарим нь Парвати, Лавандагийн адил баргар харц солилцон толгойгоо сэгсэрцгээж байлаа. Харри олон хүүхдүүд профессор Граббли Дергийн хичээлийг эрхэмлэдгийг мэддэг ч хамгийн муу нь гэвэл сэтгэлийн гүндээ энэ зөв гэдгийг ойлгож байв. Граббли Дергийн хичээл сонирхолтой хэнийг ч эрсдэлд оруулахааргүй байдаг билээ.

Харри, Рон, Гермиона гурав мягмар гаригт Хагридын хичээл рүү явах үед сэтгэл түгших нь улам ихсэж зүрх нь хүнд оргиж байлаа. Харри зөвхөн Хагридын бэлтгэсэн гэнэтийн бэлэгт ч биш хэрвээ хичээл Амбрижийн хараан дор явагдвал бусад сурагчдын ялангуяа Малфойн яаж авирлахыг мэдэхгүй байв.

Тэднийг хунгарласан цас туучин явахад ерөнхий байцаагчын бараа байсангүй. Хагрид ганцаараа тэднийг Хориотой ойн цоорхойд хүлээж байлаа. Түүний нүүр хагас сайны оройнх шиг хөхөрсөн байсан ч ногоон шаргал болон хувирч зарим шарх нь цусны мөртэй хэвээр байв. Харри Хагридыг ямар нэг хортой амьтан дайрч шарх нь одоо хүртэл эдгээгүй байгаа эсэхийг ойлгосонгүй. Тэднийг Хагридын мөрөн дээр үхсэн үнээ байгаа юм шиг эвгүйцэм дүр зураг угтав.

- Бид өнөөдөр энд хичээллэнэ! гэж Хагрид сурагчдыг угтан баяртай хашгираад толгойгоо харанхуй мододын зүг дохив. Тэд харанхуйд нуугдах дуртай юм!

- Хэн харанхуйд дуртай гэж? хэмээн Малфойн мэгдсэн хоолой Крэбб, Гойл хоёроос асуух нь Харрид сонсогдов. Тэр хэнийг харанхуйд дуртай гэж хэлсэн бэ?

Харри Малфойн Хориотой ойд орж төдийлөн зоригтой биш гэдгээ үзүүлсэн цорын ганц тохиолдлыг санаад инээмсэглэв. Тэр квиддичийн тэмцээний дараа Малфойд таагүй явдал тохиолдохоос эсэргүүцэхгүй байгаа билээ.

- Бэлэн үү? гэж Хагрид хөгжилтэй асуугаад сурагчдыг тойруулан харав.

- Би тавдугаар дамжааныханд ойн дунд аялал хийх эрх авсан. Харин одоо явж эдгээр амьтдыг газар дээр нь харъя. Бид өнөөдөр маш ховор амьтад судлах юм. Би Англид зөвхөн тэднийг дасгасан хүн ганц байдаг гэж бодож байна.

- Та тэднийг дасгасан гэдэгтээ итгэлтэй байна уу? Бидэнд зэрлэг амьтан авчирч

байгаа ганц удаагийн тохиолдол биш биз дээ? гэж Малфой айн асуулаа.

Слизеринийхэний зөвшөөрөлдөн гүнгэлдэхэд хэд хэдэн Гриффиндорынхон Малфойн адил болгоомжилсон төрхтэй болов.

- Мэдээж тэднийг дасгасан гэж Хагрид муухай харан хэлээд амьтанаа мөрөн дээрээ засч тавилаа.

- Таны царай яагаа вэ? гэж Малфой шаардангуй асуув.

- Чиний хэрэг биш! Хэрвээ тэнэг асуултаа дуусгасан бол миний араас яв! гэж

Хагрид зандрав.

Тэр эргээд ой руу орлоо. Хэн ч түүнийг дагахыг хүсэхгүй байх шиг санагдана. Харри Рон, Гермиона хоёр луу харахад тэд санаа алдан толгой дохиод хамтдаа Хагридын араас хөдлөв.

Тэр арван хором явсны эцэст өтгөн ширэнгэн дундах цасгүй харанхуй бүүдгэр газар очлоо. Хагрид шуухитнан үхсэн амьтнаа газар тавиад ухран хүүхдүүд рүү харав.

Тэдний олонхи нь модны дундаас дурын агшинд дайралт ирэх юм шиг түгшин харж байв.

- Цугларцгаа, цугларцгаа. Одоо тэд махны үнэрт татагдан ирэх ч би тэднийг дуудаадахъя. Намайг ирснийг сонсоод баярлах болно.

Тэр нүүрнээсээ үсээ холдуулахын тулд толгойгоо сэгсэрснээ махчин шувуу шиг хачирхалтай авиа гаргалаа. Хэн ч инээсэнгүй бөгөөд олонхи хүүхдүүд айн хөшлөө.

Хагрид ахин орилов. Хүүхдүүд тэндээс л гараад ирэх юм шиг мододын зүг хулчгардуухан эргэж харав. Хагридыг гурав дахь удаагаа толгойгоо сэгсрэн цээжиндээ агаар цуглуулахад Харри тохойгоороо Роныг түлхээд хоёр улаан модны хоорондох руу заав.

Харанхуйгаас тэдэн рүү хос цагаан нүд гялалзан ойртсоноо дараагийн агшинд лууны толгой, хүзүү ясархаг бие том хар далавчтай морь гарч ирлээ. Тэр хүүхдүүд рүү хараад урт хар сүүлээ хөдөлгөн толгойгоо бөхийлгөж хурц шүдээрээ үхсэн үнээг зулгаав.

Харрийн сэтгэл гүнээ амрав. Эцсийн эцэст тэдгээр амьтад түүний төсөөлөл биш жинхэнэ байдаг гэдгийн нотолгоо гарч ирлээ. Хагрид бас тэднийг мэддэг юм байна. Тэр Рон руу сониучирхан эргэж харахад өмнөхийн адил ширэнгэ рүү ширтэж

байснаа,

- Хагрид яагаад ахиад дуудахгүй байгаа юм бол? гэлээ.

Ихэнхи сурагчдын царайд Роны адил гайхширч мэгдэн хүлээсэн өнгө тодорсноос үзэхэд морийг хараагүй бололтой. Ердөө хоёр хүн түүнийг харсаны нэг нь Гойлын ард зогсож байсан Слизериний туранхай хүү бөгөөд идэхийг нь зэвүүцсэн янзтай ажиглаж байлаа. Бас Невилл урт хар сүүл даллахыг дагуулан харна.

- Өө, ахиад нэг ирж байна! гэж Хагрид бардам хэлэхэд харанхуй мододын дундуур хоёр дахь далавчтай хар морь гарч ирээд толгойгоо мах руу сунган ховдоглон идэв.

- Одоо ... Хэн түүнийг харж байгаа нь гараа өргөцгөө!

Эцэст нь далавчтай морьдын нууц тайлагдсан баярласан Харри гараа өргөлөө. Хагрид толгой дохив.

- Тиймээ ... тийм би чамайг харна гэдгийг мэдэж байсан. Чи ч гэсэн, Невилл харж байна уу? Бас ...

- Уучлаарай. Таныхаар бол бид юу харах ёстой юм? гэж Малфой ёжтой асуулаа.

Хагрид хариулахын оронд газар хэвтэж байгаа үнээ рүү заалаа. Хэдэн хормын турш бүгд түүн рүү харснаа дуу алдаж Парвати часхийн орилоход Харри яагаад гэдгийг нь ойлгов. Шинэхэн махны яс агаарт алга болох нь ер бусын үзэгдэл байлаа.

- Энэ юу болоод байна? Хэн түүнийг идэж байгаа юм? гэж Парвати айдаст автан асуугаад мод руу ухарлаа.

- Фестрал гэж Хагрид бардам хэлэхэд Гермiona аяархан дуу алдаж, Харрид энэ үг нэгийг санагдуулав. Хогвартст бүтэн сүрэг байгаа. Хэн үүнийг мэдэх вэ?

- Тэд бол маш их золгүй амьтад. Янз бүрийн аймшигтай золгүй явдалд тохиолдсон хүн тэднийг хардаг гэсэн. Профессор Трелони надад нэг удаа тэгж хэлсэн хэмээн айсан Парвати хэлэв.

- Үгүй дээ, үгүй. Энэ бол мухар сүсэг. Тэд золгүй амьтад биш хичнээн ухаалаг гээч! Бас ашигтай. Зөвхөн тэд л сургуулийн сүйх тэргийг ийш тийшээ зөөдөг юм. Гэхдээ Дамблдор хол явах хэрэг гарвал шилжих ... Хараач ахин нэг хос байна гээд Хагрид инээмсэглэв.

Модны араас өөр хоёр морь гарч ирээд Парватид ойртов. Тэр чичирснээ модноос тэвэрч,

- Тэр дэргэд байгаа юм шиг санагдаж байна! гэв.
- Санаа зовох хэрэггүй дээ тэр чамайг гомдоохгүй. Харин тэднийг яагаад зарим нэг чинь хараад бусад нь харахгүй байгааг хэн хэлэх вэ?

Гермиона гараа өргөлөө.

- Хэлээрэй гэж Хагрид баярлав.
- Фестралуудыг зөвхөн үхлийг харсан хүн л харж чадна.
- Зүйтэй сайн байна. Гриффиндорт арван оноо өглөө. Харин одоо фестралууд ...
- Кхэ кхэ.

Профессор Амбриж хүрэлцэн иржээ. Тэр Харригаас хэдэн алхамын зайд ногоон жанчтайгаа зогсоод тэмдэглэлийн дэвтрээ бэлхэн барьсан байлаа. Хагрид Амбрижийн хуурамч ханиахыг сонсож байгаагүй болохоор ойролцоох фестрал руу тэндээс л чимээ гарсан мэт ширтэв.

- Кхэ кхэ.
- Аа, сайн байна уу! гэж Хагрид чимээний эх сурвалжыг олоод инээмсэглэн хэлэв.
- Та миний өглөө гэр лүү чинь илгээсэн зурвасыг авсан уу? Таны хичээл дээр шалгалт хийнэ гэсэн? гэж Амбриж гадаад хүнтэй ярилцаж байгаа аятай өнгөрсөн удаагийнх шиг удаан чангаар хэлэв.
- Өө, тэгэлгүй яахав. Таныг биднийг олсон явдалд баяртай байна! Та харж байна уу ... эсвэл мэдэхгүй юм даа ... Харагдаж байна уу? Өнөөдөр бидэнд фестралууд орж байгаа.
- Уучлаарай. Та юу хэлсэн бэ? гэж Амбриж чихэндээ алгаа барин чанга асуулаа.

Хагрид үл ялиг сандарлаа.

- Ээ ... Фестралууд! Том биетэй далавчтай морьд байдаг юм! гээд том гараа даллав.

Профессор Амбриж хөмсгөө өргөөд тэмдэглэлийн дэвтэр дээр үг бувтнан бичлээ.

- «Хэл ... яриа ... зангааг нь ... сайжруулах ... хэрэгтэй».
- За ... цаашаа ... Хм ... би юу ярьж байлаа гэж Хагрид мунгинан сурагчид руу харлаа.
- «Тэр ... харваас ... хөөрхийлөлтэй ... муу ... ой тогтоолттой» гэж Амбриж бүгдэд сонсогдохоор чанга бувтналаа.

Драко Малфой зул сарын баяр сарын өмнө болох гэж байгаа аятай инээмсэглэхэд, Гермiona уурандаа хүрэнгэн улайв.

- Аан, тийм л дээ гэж Хагрид тэмдэглэлийн дэвтэр рүү түгшин хараад,
- Би яаж сүрэг болгосон тухайгаа ярих гэж байсан юм. Бид эхэндээ тавыг л олсон. Энэ бол Тенебрус ойд хамгийн анх төрсөн хайртай амьтан минь байгаа юм гээд түрүүлж ирсэн морийг зөөлөн алгадав.
- Та ид шидийн яамнаас фестралуудыг аюултай ангилалд оруулж үздэгийг мэдэхгүй юу? гэж Амбриж чанга хэлэв.

Харрийн дотор палхийсэн ч Хагрид хариуд нь инээд алдав.

- Фестралууд аюулгүй! Мэдээж тэднийг жинхэнээс нь уурлуулвал хазаж магадгүй.
- «Хүч хэрэглэх ... харьцааг ... урамшуулсан ... шинж ... тэмдэг» гэж Амбриж бувтнаад тэмдэглэлийн дэвтэр дээгүүр сараачив.
- Үгүй ээ, алив л дээ! гээд Хагрид түгшлээ,
- Ямар ч нохой хаздаг биз дээ. Харин фестралууд муу нэртэй байдгийн учир нь үхлийг харсан хүмүүс тэднийг муугийн шинж тэмдэг мэт үздэг юм. Миний юу хэлж байгааг ойлгож байна уу?

Амбриж хариулсангүй. Тэр тэмдэглэлийн дэвтэртээ бичиж дуусаад Хагрид руу харж чанга бөгөөд удаанаар,

- Хичээлээ цаашаа үргэлжлүүлээрэй. Харин би ... гээд алхаж буй дүр үзүүлэхэд (Малфой, Пэнси Паркинсон хоёр чимээгүй инээд алдав) Сурагчдын дундуур явж тэдэнд асуулт тавина (тэр ангийн тусдаа байгаа хүүхдүүд рүү заалаа) гээд ам руугаа заан ярьж буй дүрс үзүүлэв.

Хагрид түүнийг яагаад энгийн англи хэл мэдэхгүй гэж үзэж байгааг огт ойлгосонгүй байртай харлаа. Гермiona уурандаа нулимс цийлэгнүүлэв.

- Шулам, хөгшин шулам! Би чиний юу хийж ойлгож байна аймшигтай, муухай, жигшүүртэй ... гэж Амбриж Пэнси Паркинсон руу очиход шивнэлээ.

- Хмм ... гээд Хагрид хичээлийг буцаж гартаа авахыг оролдон Тэгэхээр фестралууд. Тийм л дээ. Тэдэнд олон сайн талууд бий ... гэв.

- Та нар профессор Хагридын ярьж байгааг ойлгож байна уу? гэж Амбриж Пэнси Паркинсоноос чанга асуулаа.

Пэнси Паркинсон Гермionaгийн адил нүдэндээ нулимс мэлтэрүүлжээ. Тэрбээр инээдээ барьж ядан арайхийн дуугарлаа.

- Үгүй ... яагаад ... гэвэл ... ихэнхдээ ... хуухитнаж ... байгаа юм шиг ... дуугараад ... байгаа ... болохоор.

Амбриж тэмдэглэлийн дэвтэртээ юм бичлээ. Хагридын нүүрний хөхрөөгүй хэсэг улайж Пэнси Паркинсоны хариултыг сонсоогүй дүр эсгэхийг оролдов.

- Тиймээ ... фестралуудад сайн тал бий. Тэднийг гаршуулсан байхад чи хэзээ ч хэзээ ч төөрөхгүй. Гайхалтай зөвхөн хаашаа явах гэж байгааг хэлэхэд л хангалттай ...

- Хэрвээ тэд таны хуухитнахыг ойлгож байгаа бол гэж Малфой чанга хэлэхэд Пэнси Паркинсон писхийтэл инээд алдав.

Амбриж инээмсэглэн тэдэн рүү харснаа Невилл рүү эргэлээ.

- Та фестралуудыг харж байна уу, Долгопупс? Невилл толгой дохив.

- Таны хэн үхсэн юм бэ? гэж тэр хайхрамжгүй асуув.

- Миний ... миний өвөө.

- Тэдний талаар юу гэж бодож байна? гээд тэр богинохон гараараа хүүрнээс үлдсэн яс руу заав.

- Ээ ... тэд сайн гэж Невилл шийдвэргүйхэн хэлээд Хагрид руу харав.

- «Сурагчид ... айж ... сандарсандаа ... юу хийхээ ... мэдэхгүй байлаа» гэж Амбриж бичив.

- Үгүй! Би тэднээс айхгүй байна! гэж Невилл сэтгэлээр унан хэлэв.

- Зүгээр дээ, зүгээр гэж Амбриж хэлээд Невиллийн мөрөн дээр алгадан ойлгосон дүр үзүүлэн инээмсэглэхэд Харри уурсан ярвайлаа. Тэр Хагридын зүг

эргэж чанга бөгөөд удаанаар,

- Ингэхэд, Хагрид. Бидний хувьд хангалттай гэж бодож байна. Та шалгалтын үр дүнг нь (тэр дэвтрээ заав) арван өдрийн дараа аваарай (агаараас ямар нэг зүйл урд нь авчирч буй дүрс үзүүлээд арван хуруугаа гозойлгов) гээд бахных адил том амаараа инээмсэглэсээр ардаа хөхрөлдөж байгаа Малфой, Пэнси Паркинсон, уурсан чичирэх Гермiona, сэтгэлээр унасан Невилл нарыг орхин явлаа.

- Жигшүүртэй худалч хөгшин луу! гэж Гермiona тэднийг хагас цагийн дараа шилтгээний зүг цасан дэггүр явж байхад дэлбэрэн хэллээ.

- Та нар түүний хаашаа хазайлгаж байгааг ойлгосон уу? Энэ түүний хагас цусны хүмүүст яаж ханддагийг харууллаа. Тэр Хагридыг ухаангүй мунхаг савдаг гэж харуулахыг хүсч байна яагаад гэвэл ээж нь аварга биет болохоор ... энэ бол шударга бус хэрэг үнэндээ тийм ч муугүй хичээл байсан ... Би ахин соплохвостууд байх вий гэж бодож байсан ч ... харин фестралууд бол сайн амьтад шүү дээ. Хагрид маш сайн байна!

- Амбриж тэднийг аюултай гэж хэлсэн хэмээн Рон эсэргүүцэв.

- Хагрид тэднийг өөртөө санаа тавьдаг гэсэн. Граббли Дерг шиг багш нар бидэнд үзүүлэхгүй байсан ч тэд маш сонирхолтой байсан тийм биз дээ? Зарим нэг нь харж байхад зарим нь үгүй! Би тэднийг харахыг хүсэж байна.

- Тийм гэж үү? хэмээн Харри аяархан хэлэв. Тэр гэнэтхэн айдаст автав.

- Өө, Харри уучлаарай би сая тэнэг юм хэлчихлээ.

- Зүгээр дээ, санаа зовох хэрэггүй.

- Би хичнээн хүн харсанд гайхаж байна. Бүх ангиас ердөө гурав гэж Рон хэлэв.

- Тийм шүү, Уизли. Бид ч гэсэн гайхаж байна гэх хоолой ард нь сонсогдлоо.

Тэдний ард Малфой, Крэбб, Гойл нар явж байлаа. Хэрвээ чи хэн нэгний үхэхийг харсан бол квофлыг харах байсан болов уу?

Тэд чанга инээлдээд дэргэдүүр нь түлхэн өнгөрч шилтгээн рүү явахдаа «Уизли бидний хаан» гэж дуулахад Роны чих улайлаа.

- Анхаарал хандуулах хэрэггүй битгий тоо гэж Гермiona хэлээд саваагаа гарган халуун агаар үлээлгэж хүлэмж хүрэх замыг хайлуулан явахад амар болгов.

Арван хоёр сар гарахад цасан уруй шиг гэрийн даалгавар тавдугаар дамжааныхныг

дарав. Зул сар ойртох тусам Рон, Гермиона хоёр ахлагчын үүрэг улам төвөг дарамттай болж байлаа. Тэд шилтгээнийг чимэглэлийг харгалзан, (Чи Пивзийн мөнгөн цаасаар боох гэж байхад мултархыг оролдоод үз дээ гэж Рон хэлжээ) нэг болон хоёрдугаар дамжааныхныг завсарлагаар хүйтэнд гүйн гаргахгүй байх талаар санаа тавьж (Ямар нусанхай гээч бид нэгдүгээр дамжаандаа тийм байгаагүй шүү), Аргус Филчтэй ээлжлэн жижүүрлэж залуу шидтэнгүүдийг халз тулаан хийлгэхгүй байх талаар санаа тавьж байлаа (Тархи нь дүүрэн шивхтэй байдаг байх гэж Рон уурсан хэлэв). Тэд их завгүй болж Гермиона хүртэл үйлчлэгчийн малгай нэхэхээ зогсоожээ.

- Хичнээн хөөрхий үйлчлэгчдийг би чөлөөлөөгүй болохоор тэд зул сараар малгайгүй үлдсэн байх даа!

Харри түүнд бүх малгайг Добби авсаныг хэлэх зүрх хүрсэнгүй ид шидийн түүхийн зохион бичлэг рүүгээ тонгойлоо. Тэр зул сарын тухай бодохыг хүсэхгүй байв. Анхны жилдээ тэр Хогвартсад амралтаа өнгөрүүлэхийг ихэд хүсч байсан билээ. Гэтэл одоо квиддичийн багаас хөөгдөн, Хагридийг туршилтын хугацаа авах дарамт учирч байлаа. Цорын ганц баярлуулах зүйл гэвэл Д.А-гийн уулзалт байсан ч амралтаар бүх хүүхдүүд гэртээ харих учир зогсох юм. Гермиона эцэг эхтэйгээ цанаар гулгахаар явна. Маглууд нүцгэн модон дээр олсоор бэхлээд уулнаас гулгадаг амралтын тухай Рон анх сонсоод ихэд хөгжлөө. Тэр гэр лүүгээ буцах байв. Харри хэдэн өдрийн өмнөөс түүнд атаархал хөдлөн гэр лүүгээ явахын өмнө «Чи бас хамт явна! Би чамд хэлээгүй билүү? Ээж сарын өмнө надад захиа бичиж чамайг урь гэж хэлсэн» гэж асуухыг хүлээж байлаа.

Гермиона түүн рүү нүдээ эргэлдүүлсэн ч Харри гүн бодолд автлаа. Түүний сэтгэл санаа Үүрэнд зул сар гайхамшигтай байх тухайд халин нисч Сириус тэнд байхгүйд гэмших сэтгэл төрж байв. Тэр хатагтай Уизлитай загалмайлан эцгийгээ уриулахаар ярих тухай хүртэл бодож үзэв. Гэхдээ Дамблдор Сириусыг Гриммогийн байшинг орхихыг зөвшөөрнө гэдэгт эргэлзэж байсан бөгөөд хатагтай Уизли зөвшөөрөхгүй бол яаж ч чадахгүй билээ. Сириус сүүлчийн удаа ханан зууханд ярилцсанаас хойш үзэгдээгүй бөгөөд Амбриж харуулдаж байгааг мэдэж байсан учир түүнтэй холбоо тогтоохыг оролдох нь тэнэг хэрэг байлаа. Гэхдээ л Сириусыг эхийнхээ хуучин байшинд ганцаархнаа сөөнгө Кикимертэй үлдээхийг хүссэнгүй.

Амралтын өмнөх сүүлчийн ДА-ийн цугларалтын дээр Харри Шаардлагатай өрөөнд

эрт очлоо. Тэр бамбарын гэрэлд Добби зул сарын чимэглэх үүргийг өөртөө авсаныг хараад ихэд баярлав. Үйлчлэгч л үүнийг хийсэн нь мэдээж. Учир нь өөр хэний ч толгойд Харрийн нүүрний зургийг тойруулан «ХАРРИ, ХАРРИ, МИНИЙ ОД» гэж бичсэн зуугаад алтан тоглоомыг адраас өлгөх санаа орохгүй билээ.

Түүнийг сүүлчийн тоглоомыг зулгааж дөнгөж амжтал хаалга чахран нээгдэж Полумна Лавгуд үргэлж байдаг шигээ мөрөөдөнгүй орж ирэв.

- Сайн уу. Сайхан юм байна. Чи хийгээ юу? гэж тэр бодлогширон хэлээд чимэглэлийг харлаа.

- Үгүй. Добби гэрийн үйлчлэгч.

- Цагаан боронз гэж тэр хэлээд Харрийн толгой дээр байгаа том цагаан жимснүүдийг заалаа. Тэр дороос нь үсрэв.

- Сайхан хийсэн байна. Тэр үргэлж нарглуудаар дүүрэн байдаг юм.

Харри наргл гэж юу болох тухай асуух гэсэн ч Анжелина, Кэти, Алисия нар орж ирлээ. Гурвуулаа хөлдөх шахсан харагдаж байв.

- Тэгэхээр бид чамайг орлох хүн олсон гэж Анжелина жанчаа тайлаад буланд тавьж баргар царайлан хэлэв ...

- Надад орлох хүн гэнээ? гэж Харри гайхан асуулаа.

- Чамайг бас Фред, Жорж хоёрыг. Шинэ баригч авсан! гэж ууртай тодотгов.

- Хэн юм бэ? гэж Харри түргэхэн асуулаа.

- Жинни Уизли.

Харри түүн рүү алмайран харлаа.

- Мэдэж байна. Гэхдээ тэр сайн тоглодог юм. Чиний зэрэгт хүрэхгүй ч гэсэн гээд Анжелина шидэт саваагаа гарган муухай харлаа.

Харри «Чи үнэхээр намайг хөөгдсөндөө зуу дахин харамсаагүй гэж бодож байн уу?»

гэж үг сөргөхийг хүссэн ч хэвийн дуугарахыг хичээн,

- Довтлогчид нь хэн юм? гэлээ.

- Эндрю Керк, Жек Слоупер хоёр. Тийм гоц гойд биш ч тэнэгүүдтэй харьцуулахад ...

Үүдээр Рон, Гермиона, Невилл нар ярилцсаар орж ирэхэд таван хормын дараа өрөө дүүрэн хүнтэй болж Харри Анжелинагийн уурсан цоргих харцнаас аврагдав.

- За, сайн байна гэж тэр цуглагсдыг чимээгүй болоход хэлээд,

- Би өнөөдөр өнгөрсөн удаагийн зүйлээ давтсан нь дээр гэж бодож байна. Энэ бол амралтын өмнөх сүүлчийн цугларалт болоход шинэ юм эхлэх санаа алга. Хэрвээ гурван долоо хоногийн өмнө байсан бол ...

- Шинэ юм байхгүй юм уу? Мэдсэн бол ирдэггүй байж гэж Захария Смит таагүй хэлэв.

- Харри, чамайг анхааруулаагүй нь ямар харамсалтай юм бэ гэж Фред чанга дуугарлаа.

Хэдэн хүүхдүүд тэдний дотор Чжоу инээхэд Харрийн дотор ахиад л хөрвөчих шиг болж хөл нь гишгэгдэлээ олж чадахгүй байх шиг санагдав.

- Хос болон хуваагдаарай. Арван хором Саад арилгах шившлэгээр сургуулилаад дараа нь дэрэн дээр Хөшөөх шившлэг хийе.

Бүгд дуулгавартайгаар хуваагдав. Харри урьдын адил Невиллийн эсрэг боллоо. Өрөөгөөр дүүрэн Импедимента! гэсэн хашгиралт сонсогдов. Хүмүүс хормын турш удааширахад хамтрагч нь ийш тийшээ бусад хосыг харж зогсоод удааширсан байдлаас гарахад нь шившлэгийг харилцан хийж байлаа.

Невилл танигдахын аргагүй болон өөрчлөгджээ. Харри гурван удаа удааширч хэвийн байдалдаа орсний эцэст түүнийг Рон, Гермиона хоёртой орхиод өрөөн дундуур явж бусдыг нь харлаа. Тэр Чжоугийн дэргэдүүр өнгөрөхөд баяртай инээмсэглэсэн учир ахин хэдэн удаа хажуугаар нь явахгүй байж чадсангүй.

Арван хором Саад арилгах шидээр сургуулилсаны дараа бүх дэрүүдийг тараан тавиад Хөшөөх шившлэг хийлээ. Зай хэтэрхий бага болохоор бүгд зэрэг хийх боломж байсангүйд хагас нь зогсоод бусдыгаа харж байлаа.

Харри тэдний ажлыг харж бахарах сэтгэл төрөв. Невилл Диныг хөшөөх гээд дэргэдэх Падма Патилыг хөшөөсөн ч хамаагүй бага алдаа хийж бусад нь өмнөхөөсөө амжилттай хийж байлаа.

Цагийн дараа Харри зогс гэж тушаалаа.

- Та нарынх их сайн болж байна. Амралтаас эргэж ирэхэд чинь арай хүндхэн

зүйл магадгүй Патронусыг туршаад үзэж болох юм.

Баярласан дуу алдалт хадав. Ердийнхөөрөө хоёр гурваараа тарсаар өрөө хоосорлоо. Хүүхдүүд явахдаа Харрид зул сарын мэнд хүргэж байлаа. Тэр хөгжилтэйгээр Рон, Гермiona хоёрын хамт дэрнүүдийг нямбайлан хураалаа. Рон, Гермона хоёрыг явахад Чжоугаас зул сарын мэнд гэсэн үг сонсохыг найдан үлдэв.

- Үгүй ээ, чи яв гэж тэр найз Мариэтгдээ хэлэхэд түүний зүрх баяртай үсчин цохилон.

Харри дэрнүүдийг янзалж буй дүр үзүүлэн хоёулхнаа үлдээд Чжоуг ярихыг хүлээв. Гэтэл үүний оронд чанга шуухитнах чимээ дуулдав.

Тэр эргэхдээ Чжоу өрөөний дунд зогсоод хацар дээр нь нулимс бөмбөрч байхыг харлаа.

- Юу ...?

Тэр юу хийхээ мэдсэнгүй. Чжоу зогсоод чимээгүйхэн уйлна.

- Юу болоо вэ?

Тэр толгойгоо сэгсрээд нулимсаа ханцуйгаараа арчлаа.

- Намайг уулчаарай. Бид ... тэр үед ... энэ шившлэгүүдийг сурсан бол ... гэж бодоод ... хэрвээ тэр мэддэг байсан бол ... амьд үлдэх байсан.

Харрийн зүрх шимширлээ. Тэр үүнийг мэдэх ёстой байсан юм. Тэр Седрикийн тухай ярихыг хүссэн байна.

- Тэр бүгдийг нь мэдэж байсан. Хэрвээ сайн хийж чаддаггүй байсан бол төөрдөг байшингийн төвд хүрэхгүй шүү дээ. Гэхдээ хэрвээ Волдеморт чамайг алахыг хүссэн бол ямар ч боломж байхгүй.

Чжоу Волдемортын нэрийг сонсоод ханиалгасан ч Харригаас нүд салгасангүй.

- Харин чи жаахан хүүхэд байсан ч амьд үлдсэн гэж аяархан хэлэв.

- Тиймээ. Яагаад гэдгийг нь хэн ч мэдэхгүй болохоор бардах зүйл юу ч байхгүй гэж Харри ядрангүй хэлээд үүд рүү явлаа.

- Үгүй ээ, битгий яв! гээд Чжоу ахин нулимс асгаруулж эхлэв.

- Намайг ингэсэн явдалд үнэхээр уучлаарай Би ингэхийг хүсээгүй ...

Тэр ахиад л мэгшив. Улайж хавдсан нүдтэй ч гэлээ Чжоу хөөрхөн харагдаж байв.

Харри золгүй болохоо мэдрэв. Хэрвээ түүнд зүгээр л зул сарын мэнд хүсээд явсан бол хичнээн таатай байхсан билээ.

- Би чамд хүнд байгааг ойлгож байна. Би Седрикийн тухай ярьж байхад харин тэр чиний нүдэн дээр үхсэн байдаг ... Чи мэдээж бүгдийг мартахыг хүсэж байгаа биз? гэж тэр ахиад л ханцуйгаараа нулимсаа арчаад хэлэв.

Харри юу ч хэлсэнгүй. Энэ үнэн байлаа тэр үнэхээр зүрх сэтгэлгүй зүйл ярьж байна.

- Чи маш сайн багш. Би урьд нь хэзээ ч хөшөөж чаддаг байгаагүй гэж Чжоу нулимстай нүдээр харан хэлэв.

- Баярлалаа гэж Харри ичингүйрэн хэллээ.

Тэд бие бие рүүгээ удтал ширтлээ. Харри өрөөнөөс үсрэн гарахыг хүсэвч хөл нь шалнаас ургаатай юм шиг болжээ.

- Цагаан боронз гэж хэлээд Чжоу толгой дээрх адар руугаа заав.

- Тиймээ. Магадгүй наглаар дүүрэн байх гээд түүний ам хатлаа.

- Наргл гэдэг чинь юу юм?

- Мэдэхгүй гэж тэр хэлэхэд Чжоу ойртон ирэв. Түүний тархи хөшсөн юм шиг болов. Полумна Лавгудаас асуусан нь дээр байх. Түүний санаа л даа.

Чжоу инээж уйлж байгаа нь мэдэгдэхгүй хачирхалтай авиа гаргав. Тэр одоо дэндүү ойрхон зогсож байлаа. Түүний хамар дээрх сэвхийг нь хүртэл тоолж болохоор байв.

- Чи надад их таалагддаг, Харри.

Тэр юу ч бодож чадсангүй. Бүх бие нь доргилон хөл гар, тархи нь ажиллагаагүй болох шиг болов.

Тэр хэтэрхий ойрхон байна. Тэр сормуусных нь ширхэг бүрийг харж байна.

Харри хагас цагийн дараа амралтын өрөөнд эргэн ирэхэд Рон, Гермиона хоёр зуухны өмнөх дуртай сандалдаа суугаад бараг ихэнх хүүхдүүд унтахаар явсан байлаа. Гермиона ширээний ирмэг даван унжсан урт захиа бичиж байсан бөгөөд Рон хивсэнцэр дээр хэвтэн хувиргалын хичээлийн зохион бичлэг хийнэ.

- Чи яагаад саатав? гэж Рон Харриг Гермионагийн дэргэд суухад асуув.

Харри хариулсангүй. Тэр цочирдолд оржээ. Түүний биеийн нэг хэсэг найзууддаа энэ тухай ярихыг хүсэвч нөгөө хагас нь энэ нууцыг хадгалахыг хүсч байлаа.

- Чи зүгээр үү, Харри? гэж Гермиона асуугаад үзгэн дээгүүрээ харав.

Харри хагас дутуу мөрөө хавчлаа. Үнэнийг хэлэхэд эрүүл эсэхээ ч өөрөө ойлгосонгүй.

- Яасан бэ? Юу болсон? гэж Рон хэлээд Харриг сайн харахын тулд тохой дээрээ өндийв.

Харри тэдэнд хэлэхийг хүсэж байгаа эсэхтээ итгэлгүй байлаа. Хэдийгээр тэр юу ч хэлэхгүй гэж шийдсэн ч Гермиона ажил хэргийг гартаа авлаа.

- Чжоу юу? Тэр чамтай цугларалтын дараа үлдсэн үү? гэж ажил хэрэгчээр асуув.

Мэгдсэн Харри толгой дохив. Рон инээд алдсан ч Гермионагийн харцанд чимээгүй болов.

- Тэгээд ... тэр юу хүссэн юм бэ? гэж тэр дооглонгуй асуув.

- Тэр ... гээд Харри сөөнгөтөхөд хоолойгоо засахыг хичээн ханиалгаад, Тэр ... ээ ... гэв.

- Чамайг үнссэн үү? гэж Гермиона мөн адил ажил хэрэгч янзаар асуулаа.

Рон огцом өндийхөд хамаг бэх нь хивсээр нэг цацагдав. Тэр үүнд анхаарал хандуулалгүй Харри руу хомхойрон харав.

- Тэгээд? гэж шаардан асуулаа.

Харри түүний шоолонгуй сониучирхсан хөгжилтэй харц, Гермионагийн хөмсөг зангидсан харц руу хараад толгой дохилоо.

- Ха!

Рон ялсан дүртэй нударга дэлсэн чанга инээхэд хоёрдугаар дамжааны хоёр аймхай хүүхэд цонхны дэргэдээс огло үсрэв. Роныг хивсэн дээгүүр өнхрөхийг хараад Харри дурамжхан инээмсэглэв.

Гермиона Рон руу захиан дээгүүрээ ихэд зэвүүцэн харлаа.

- Тэгээд? Ямар байна даа? гэж Рон эцэст нь хэлэв. Харри хоромхон зуур бодлогоширсноо үнэнээ хэлэв.

- Чийгтэй.

Рон баярлаж жигшсэн нь мэдэгдэхгүй ойлгомжгүй чимээ гаргалаа.

- Учир нь тэр уйлж байсан юм гэж Харри нухацтай хэлэв.
 - Өө, тийм муу үнссэн юм уу? гээд Роны инээмсэглэл буурлаа.
 - Мэдэхгүй. Магадгүй л юм гээд Харри гэнэтхэн санаа зовнилоо.
 - Үгүй дээ гэж Гермиона захиагаа бичсэн хэвээр хэлэв.
 - Чи яаж мэдэж байгаа юм? гэж Рон болгоомжлон асуулаа.
 - Яагаад гэвэл Чжоу одоо үргэлж уйлж байгаа. Хоолон дээр ч, жорлонд ч тэр хаа сайгүй.
 - Түүнийг үнсэлт жаахан баясгасан гэж бодож байна уу хэмээн Рон инээд алдав.
 - Рон чи миний тааралдаж байсан хамгийн хатуу сэтгэлтэй хүн гэж Гермиона сүржин хэлээд үзгээ бэхэндээ дүрэв.
 - Энэ чинь юу гэж байгаа юм? Чамайг үнсэхэд уйлдаг хүн хэнд хэрэгтэй юм? гэж Рон эгдүүцэв.
 - Тиймээ. Яагаад тэгсэн юм бол? гэж Харри цөхрөн хэллээ.
- Гермиона тэдэн рүү өрөвдсөн шинжтэй харав.
- Та нар одоо Чжоугийн юу мэдэрч байгааг ойлгохгүй байна уу?
 - Үгүй гэж зэрэг хариулав.
- Гермиона санаа алдаад үзгээ доош тавилаа.
- Тэр Седркийн үхэлд их гашуудаж байгаа юм. Би түүнд Седрик их таалагддаг байсан ч одоо Харри таалагдаж байгаа болохоор хэн нь их таалагдаж байгааг мэдэхгүй байгаа гэж бодож байна. Түүнд бас Харритай үнсэлдсэнээрээ Седрикийн дурсгалыг доромжилсон юм шиг буруутай мэдрэмж төрж хүмүүс юу гэж хэлэх бол гэхээс санаа нь зовж байгаа. Тэр энэ мэдрэмжүүдийнхээ учрыг олж чадахгүй байгаа юм, Харри. Бүх зүйл их ээдрээтэй хэцүү байгаа биз. Тэгээд бас муу нисэж байгаа учир Когтевраны квиддичийн багаас хөөчих вий гэж айж байгаа.
- Гайхширсан нам гүм бий болсны эцэст Рон дуугарлаа.
- Нэг хүн ийм олон зүйлийг шууд мэдэрч чадахгүй.
 - Учир нь чиний сэтгэл хөдлөлийн цар хүрээ цайны халбага шиг байгаад юм

гэж Гермиона хэлээд үзгээ авлаа.

- Тэр өөрөө л эхэлсэн. Би биш ... тэр над руу ирээд ... уйлж эхэлсэн ... Би юу хийхээ мэдээгүй.

- Өөрийгөө буруутгах хэрэггүй дээ, найз минь гэж Рон хэлээд сэтгэл түгшээсэн дүр зургийг төсөөлөн бодов.

- Чи ердөө түүнд найрсаг байхад болно. Тийм байсан гэж найдаж болох уу? гэж Гермиона хэлэв.

- Би би түүний нуруун дээр алгасан гэж Харри хэлээд нүүр нь халуу оргихийг мэдэрлээ.

Гермионагийн нүд орой дээрээ гарах шахав.

- Үүнээс ч муу байж болох байлаа. Чи түүнтэй ахин уулзах уу?

- Магадгүй. Бид чинь цугларалтан дээр уулзана биз дээ?

- Чи миний юу хэлж байгааг мэдэж байгаа гэж Гермиона тэвчээргүйхэн хэлэв.

Харри юу ч хэлсэнгүй. Гермионагийн үг түүнд алсын бодол төрүүлэв. Тэр Чжоутай хаа нэг тийшээ жишээлбэл Хогсмид руу явах талаар төсөөлөхийг оролдов. Тэр түүнээс сүүлд болсон явдлын дараа урилга хүлээж байж болох юм ... Энэ бодол орж ирэхэд сэтгэл нь өвдлөө.

- Чамд түүнийг урих сайхан боломж байгаа гэж Гермиона хөндий хэлээд толгойгоо захиа руу хандуулав.

- Хэрвээ тэр урихыг хүсэхгүй бол яах вэ? гэж Рон Харриг сонжин харж хэллээ.

- Битгий тэнэг юм ярь. Тэр Харрид эртнээс таалагдаж байгаа. Тийм биз дээ, Харри?

Харри хариулсангүй. Тиймээ Чжоу эртнээс түүнд таалагдаж байгаа ч түүнтэй хоёулхнаа байгаагаар төсөөлж байгаа ч Чжоу энэ үйл явдалд баяртай байвал ч харин эсрэгээрээ Чжоу түүний мөрөн дээр уйлаад байвал.

- Харин чи хэнд энэ романыг бичиж байгаа юм? гэж Рон Гермионагийн цаас руу шагайхыг хичээн өндийн асуулаа.

Гермиона түүнийг түлхэв.

- Викторд.

- Крамд уу?
- Өөр ямар Виктор байдаг юм?

Рон юу ч хэлсэнгүй ч түүний байдал сэтгэл хангалуун бус төрхтэй байв. Хорин хормын турш тэд чимээгүйхэн байцгаав. Рон хувиргалын хичээлийн зохион бичлэгээ дуусгахдаа уурсангүй тургилж, Гермiona захиагаа эцсийг нь хүртэл бичиж дуусаад болгоомжтой хуйлан харин Харри гал руу Сириусын толгой гарч ирээд охины тухай зөвөлгөө өгөх юм шиг мөрөөдөнгүй харж суулаа. Ой ухаанд нь бүдэг дурсамж зурсхийхэд Харри ийш тийшээ хараад зөвхөн тэд амралтын өрөөнд үлдсэнийг харлаа.

- Тавтай нойрсоорой гэж Гермiona том эвшээн хэлээд шатаар өгсөн охидын унтлагын өрөө лүү явлаа.
- Тэр Крамаас юугаа харсан юм бол? гэж Рон шатаар өгсөхдөө Харригаас шаардангуй асуулаа.

Харри бодоод хэлсэн нь,

- Магадгүй тэр арай ахмад ... бас олон улсын шигшээд квиддич тоглодог болохоор ... гэв.
- Тэгээд юу гэж? Баргар царайтай биз дээ? гэж тэр цухалдав.
- Тиймээ, баргар царайтай гэж Харри Чжоугын тухай бодсон хэвээр зөвшөөрөв.

Тэд унтлагын хувцсаа чимээгүйхэн сольж өмсөв. Дин, Симус, Невилл нар хэдийн унтжээ. Харри шилээ тайлан орны хажуугийн шүүгээн дээр тавиад хөшгөө таталгүй Невиллийн орны дээгүүр одот тэнгэр лүү харав. Тэр өнгөрсөн шөнө хорин дөрвөн цагийн өмнө Чжоуг үнссэн мэт санагдах ажээ.

- Тавтай нойрсоорой гэж Рон баруун талд нь бувтнав.
- Тавтай нойрсоорой.

Магадгүй дараагийн удаа ... хэрвээ ахиад тийм зүйл болох юм бол ... тэр гунигтай биш байх. Түүнийг урих хэрэгтэй байх. Тэр үүнийг хүлээж байсан болохоор маш их уурлаж ... эсвэл хэвтэж уйлаад Седрикийн тухай бодож байгаа байх. Тэр юу бодохоо мэдсэнгүй. Гермionaгийн тайлбар тодорхой биш бүх зүйл ярвигтай байлаа.

«Тэд бидэнд охидын толгой хэрхэн ажилладгийг заах ёстой байсан юм ... энэ бол мэргэ төлгөөс хамаагүй ашигтай шүү дээ» гэж Харри бодоод хажуу тийшээ эргэлээ.

Невилл нойрондоо шуухитнав. Хаа нэгтээ ууль гууглав.

Харри Шаардлагатай өрөөнд байна гэж зүүдлэжээ. Чжоу түүнийг хуурамч шалтгаар хуурч авчирсан гэж буруутган зуун тавин школадан мэлхийний зураг өг гэж амлахыг шаардаж байв. Харри эсэргүүцлээ ... Чжоу «Седрик надад зөндөө олон шоколадан мэлхийн зураг өгсөн, хар!» гэж хашгираад жанчныхаа халааснаас зураг гаргаж савчлаа. Дараа нь тэр Геррмионатай тааралдахад «Чи түүнд амлах ёстой, Харри ... Би чамайг түүнд арай дээр зүйл өгөх ёстой гэж бодож байна ... магадгүй Аянгаа ч юмуу». Харин тэр Чжоуд Аянга өгөх боломжгүй яагаад гэвэл Амбриж хурааж авсан гэж хэлж байна. Ингээд тэр Шаардлагатай өрөөнд ирэхэд зөвхөн Доббийн толгойн зурагтай бөмбөлөгнүүд л байна ...

Зүүд өөрчлөгдөв.

Түүний бие гилгэр хүчирхэг уян зөөлөн болсон байлаа. Тэр гялалзсан төмөр сараалж дундуур харанхуй хүйтэн шалаар мөлхөв ... Тэр хатуу шалан дээгүүр элгээрээ гулгаж байлаа ... эргэн тойрон харанхуй тод өнгийн гялалзсан хачирхалтай эдлэлүүд ... тэр толгойгоо эргүүлж ... анхны харцаар хонгил хоосон байхыг харлаа ... үгүй ээ ... шалан дээр урд нь хүн эрүүгээ цээж рүүгээ унжуулаад сууж байгаа дүрс харанхуйд гялтагнав ...

Харри хэлээ гозолзуулан ... амьд унтаж байгаа ... хүний үнэрийг мэдрэв ... тэр хонгилын төгсгөлийн хаалганы дэргэд сууж байлаа ...

Харри хүнийг хазахыг хүслээ ... гэхдээ хүслээ тэвчих хэрэгтэй ... түүнийг илүү чухал ажил хүлээж байгаа ...

Гэтэл хүн хөдөлж ... мөнгөлөг жанч хөлд нь унахад цочлоо. Харри тод өнгийн бүдэг дүрс өмнө нь сүндэрлэж шидэт саваагаа бүснээсээ сугалахыг харлаа ... түүнд сонголт үлдсэнгүй ... тэр толгойгоо өндийлгөн нэг, хоёр, гурав дахь удаагаа дайран соёогоо хүний биед шигтгэхдээ хавирганы яс эрүүнд нь шажигнан бүлээн цус оргилохыг мэдрэв ...

Хүн өвдсөндөө хашгирсан ч ... дараа нь чимээгүй боллоо ... тэр хана даган унаж ... шалан дээр цусны мөр үлдээв ...

Толгой нь тэсвэрлэхийн аргагүй өвдөж ... хагарах гэж байгаа юм шиг янгиналаа ...

- Харри! Харри!

Тэр нүдээ нээлээ. Бүх биеийнх нь хүйтэн хөлс цувж орны даавуу нь номхотгодог

цамц шиг наалдан духыг нь цайртал нь улайсгасан шилээгүүрээр хайрах шиг санагдана.

- Харри!

Түүний өмнө айж сандарсан Рон зогсож байлаа. Орны хөлд өөр бас дүрс харагдав. Тэр толгойгоо гараараа барилаа. Өвдөлт тэсвэрлэхийн аргагүй байв ... Тэр орон дээгүүрээ өнхрөн хажуу тийш бөөлжлөө.

- Тэр өвдчихөж. Хэн нэгнийг дуудах хэрэгтэй гэсэн айсан хоолой сонсогдов.

- Харри! Харри!

«Тэр Ронд энэ тухай хэлэх ёстой ...» Тэр гүнзгий амьсгал аваад өндийн суулаа. Дараа нь арайхийн амаа нээв.

- Чиний аав. Түүнийг дайрсан ...

- Юу? гээд Рон ойлгосонгүй.

- Чиний эцэг! Тэр хазуулсан, үнэн шүү хаа сайгүй цус байсан ...

- Явж тусламж дуудъя гэх айсан хоолой гараад хүн унтлагын өрөөнөөс гүйж гарлаа.

- Харри, найз минь чи ... ердөө зүүдэлсэн байлгүй дээ гэж Рон итгэлгүйхэн хэлэв.

- Үгүй! гэж Харри уурсав. Үүнийг Ронд ойлгуулах нь маш чухал байлаа.

- Энэ бол зүүд биш байсан ... жирийн бус зүүд. Би тэнд байсан би түүнийг харсан ... Би үүнийг хийсэн ...

Тэр Симус, Дин хоёрын аяархан шивнэлдэхийг сонсов. Духан дээрх өвдөлт нь яльгүй намдсан ч хөлс нь цутгасан хэвээр халуурсан юм шиг чичирч байлаа. Ахин хий огиулахад Рон арагш үсрэн ухрав.

- Харри чи эрүүл биш байна. Невилл тусламж дуудахаар явсан гэж чичирсэн хоолойгоор хэлэв.

- Би эрүүл! гээд Харри хахаж цацан ханиалгаж амаа ханцуйгаараа арчлаа.

- Надад санаа зовох хэрэггүй зөвхөн эцгийнхээ төлөө санаа тавь. Бид түүний байгаа газар очих ёстой. Тэр битүү цусанд будагдсан байсан ... би ... би том могой байсан.

Тэр орноосоо босохыг оролдсон ч Рон хойш нь түлхэн суулгав. Дэргэд нь Дин, Симус хоёр шивнэлдсэн хэвээр. Нэг хором өнгөрсөн үү аравн хором өнгөрсөн үү Харри мэдсэнгүй. Тэр суугаад чичирч сорвины өвдөлт алгуур намдахыг мэдрэв ... Дараа нь шатан дээр яарсан алхаа сонсогдож Невиллийн хоолой,

- Ийшээ, профессор гэх нь сонсогдов.

Профессор МакГонагалл унтлагын өрөөнд яаран орж ирэхдээ шотландын дөрвөлжин хээтэй халат өмсөж нүдний шилээ хамрын үзүүртээ зүүжээ.

- Юу болоо вэ, Поттер? Хаана чинь өвдөж байна?

Харри хэзээ ч түүнийг хараад ингэж баярлаж байсангүй. Түүнд одоо Фениксийн бүлгэмийн хэн нэгэн хэрэгтэй байлаа.

- Роны эцэг. Түүнийг могой дайрсан. Түүний бие муу байна. Би энэ бүхэн яаж болсныг харсан.

- Болсон явдлыг харсан гэдэг чинь юу гэж байгаа юм? гээд МакГонагалл хөмсгөө хөдөлгөв.

- Мэдэхгүй ... би унтаж байсан ч дараа нь тэнд байсан ...

- Та үүнийг зүүдэлсэн гэж хэлэх гээд байна уу?

- Үгүй дээ! гээд Харри уурслаа. (Үнэхээр хэн ч үүнийг ойлгохгүй байна гэж үү?) Эхлээд би шал өөр тэнэг юм зүүдэлж байтал ... зогссон. Энэ бол миний төсөөлөл биш бодит явдал байсан. Ноён Уизли шалан дээр унтаад түүн рүү аварга могой дайрч цусанд будагдаад газар унасан, түүнийг хаана байгааг олох хэрэгтэй байна.

Профессор МакГонагалл түүн рүү дөрвөлжин хүрээтэй шилнийхээ цаанаас айдаст автан харлаа.

- Би худал хэлээгүй би галзуураагүй! Би таньд болсон явдлыг харсан гээд байгаа биз дээ! гэж Харри хашгирлаа.

- Би таньд итгэж байна, Поттер. Хүрмээ өмсөөд захирал руу явцгаая.

БҮЛЭГ 22: ГЭГЭЭН МУНГОГИЙН ИД ШИДИЙН ӨВЧИН ЭМГЭГИЙН ЭМНЭЛЭГ

Түүнийг жинхэнээсээ хүлээн авсан явдалд баярласаар Харри агшин зуур орноосоо үсрэн бууж хүрмээ өмсөн шилээ зүүлээ.

- Уизли бас явах хэрэгтэй гэж профессор МакГонагалл хэлэв.

Тэд профессор МакГонагаллын араас дагалдан чимээгүй зогсож байсан Невилл, Дин, Симус нарын дэргэдүүр өнгөрөөд унтлагын өрөөнөөс гарч эргүүлгэн шатаар амралтын өрөө рүү уруудан тарган хатагтайн хөргөөр нэвтрээд сарны гэрэлд гийгүүлэгдсэн хонгилоор явав. Харри цочирдож сандарсандаа Дамблдорт хэлэхээр гүйхийг хүслээ. Ноён Уизли цусанд будагдаад байхад харин тэд хонгилоор тайван алхаж явна. Хэрвээ энэ шүд хортой байсан бол яана? (Харри миний соёо гэж бодохгүйг хичээв). Тэд дэнлүү шиг нүдээрээ харж байсан хатагтай Норрисын дэргэдүүр өнгөрөхөд сулхан хүржигнэсэн ч МакГонагалл «Холд!» гэхэд муур харанхуйд уусан алга болов. Хэдэн хормын дараа тэд Дамблдорын өрөө рүү орох үүд болох чулуун лууны өмнө зогсож байлаа.

- Шажигнуур чихэр гэж профессор МакГонагалл хэлэв.

Луу амилж хажуу тийшээ үсрэн холдоход хананд мушгиа цахилгаан шат адил чулуун шат нээгдэв. Тэд хөдөлдөг гишгүүр дээр гарахад ард нь бөглүү чимээ гаран хана хаагдаад шат дээш нь эргэлдүүлэн зэс цохиур бүхий гялалзсан царс модон хаалганд хүргэв.

Хэдийн шөнө дунд болсон ч хаалганы цаана дүнгэнэх хоолой сонсогдоно. Яг л Дамблдор арваас доошгүй хүмүүстэй ярилцаж байгаа юм шиг ажээ.

Профессор МакГонагалл гурван удаа алхаар үүдийг цохиход хоолой чимээгүй боллоо. Хаалга онгойход МакГонагалл тэргүүлэн Харри, Рон хоёр өрөөнд орлоо.

Өрөөнд бүүдгэр харанхуй байсан бөгөөд хачирхалтай мөнгөн эдлэлүүд жингэнэн утаа гаргалгүй хөдөлгөөнгүй зогсож байлаа. Ханан дахь өмнөх захирлын хөргүүд жаазандаа зүүрмэглэж байв. Хаалганы хажуугийн хонуур дээр гайхамшигтай сайхан алтлаг өнгөтэй хун шиг шувуу толгойгоо жигүүр доогуураа шургуулаад унтаж байв.

- Өө, энэ та байсан юм уу профессор МакГонагалл ... бас ...

Дамблдор бичгийн ширээний ар дахь өндөр түшлэгтэй сандал дээр сууж байлаа. Тэр

урагш бөхийхөд лааны гэрэл ширээн дээрх бичиг баримтуудыг гийгүүлэв. Тэрбээр цасан цагаан өнгөтэй унтлагын цамцан дээгүүрээ нил ягаан хатгамалтай нөмрөг хөдөрсөн байсан ч нойрмог харагдсангүй. Хурц цэнхэр нүд нь профессор МакГонагл дээр зогслоо.

- Профессор Дамблдор, Поттер ... хар дарсан зүүд зүүдэлсэн байна. Тэр хэлэхдээ ...

- Энэ зүүд биш байсан гэж Харри яриаг нь таслав.

Профессор МакГонагалл түүн рүү хөмсгөө зангидан эргэж хараад,

- Сайн байна, Поттер захиралд өөрөө ярь гэлээ.

- Би ... би унтаж байсан юм гэж Харри хэлэв. Тэр айдаст автан цөхөрч Дамблдор т бүгдийг тайлбарлахыг хүссэн ч захирал түүн рүү харалгүй хуруугаа оролдсон явдалд уур нь хүрлээ.

- Гэхдээ энэ ер бусын зүүд байсан ... жинхэнэ болсон юм шиг ... би энэ бүхэн яаж болохыг харсан ... Роны эцэг ноён Уизли руу аварга могой дайрсан.

Үг өрөөнд цуурайтахад инээдтэй сонсогдов. Нам гүм болоход Дамблдор сандлаа налан гэдийгээд адар руу ширтэн санааширав. Цайж мэгдсэн Рон Харри, Дамблдор хоёр луу харна.

- Чи үүнийг яаж хараа вэ? гэж Дамблдор тайвнаар Харри руу харалгүй асуулаа.

- Мэдэхгүй гэж тэр ууртай хэллээ (Энэ ямар хамаатай юм бэ?). Миний толгой дотор болсон ...

- Чи намайг ойлгосонгүй. Би чамайг энэ дайралтыг аль өнцгөөс нь харсан бэ гэж асууж байна. Хохирогчийн дэргэд зогсож байсан уу эсвэл үйл явдлыг дээрээс нь харсан уу? гэж Дамблдор тайван хэлэв.

Асуулт Харриг гайхуулахад захирал руу алмайран ширтлээ. Яг л тэр бүгдийг мэдэж байгаа юм шиг ...

- Би могой байсан. Би түүний нүдээр харсан.

Чимээгүй болов. Дараа нь Дамблдор хөлс нь цутгасан нүүртэй Рон руу харснаа огцом,

- Артур хүнд шархадсан уу? гэв.

- Тиймээ гэж Харри хүчлэн хэлэв. Тэд яагаад тийм урт шүд хазсан хүн хичнээн цус алдаж болохыг ойлгохгүй байгаа юм бол? Бас яагаад Дамблдор түүн рүү харахгүй байгаа юм бол?

Дамблдор огцом босоход Харри цочлоо. Захирал ойролцоо өлгөөтэй байсан нэг хөрөг рүү очоод,

- Эдвард! Бас Дайлис! гэж тушаангуй хэлэв.

Шарангуй нүүртэй богинохон хар үстэй ахимаг насны шидтэний хөргийн зэргэлдээ урт мөнгөн цагаригласан үстэй шидтэн эмэгтэй бөх унтаж байснаа нүдээ нээж харлаа.

- Та нар сонсов уу?

- Шидтэн толгой дохиод, эмэгтэй,

- Ойлгомжтой гэж хэлэв.

- Тэр шаргал үстэй нүдний шилтэй. Эдвард та түгшүүр зарлаж түүнийг манай хүмүүс олоход санаа тавих хэрэгтэй байна ...

Тэд хоёулаа толгой дохиод жаазнаасаа явж зэргэлдээх хөргөнд ч үзэгдсэнгүй (Хогвартсад энэ нь ердийн зүйл) алга болчихлоо. Нэг зурганд зөвхөн хар хөшиг нөгөөд нь арьсан суудалтай түшлэгтэй сандал үлдэв. Харри бусад захирлууд дуг нойронд автан хурхирч байсан ч хагас аньсан нүднийхээ завсраар түүн рүү сэм харахыг ажиглав. Түүнд одоо тэднийг орж ирэхээс өмнө хэнтэй ярьж байсан гэдэг нь ойлгомжтой болов.

- Эдвард, Дайлис хоёр Хогвартсын хамгийн алдартай захиралууд байсан юм гэж Дамблдор хэлээд зочдынхоо хажуугаар шурдхийн өнгөрч хаалганы дэргэдэх хонуур дээр унтаж байсан шувуу руу явлаа.

- Маш алдартай учир тэдний хөрөг олон чухал шидтэнгүүдийн өрөөнд өлгөөтэй байдаг юм. Иймээс тэд өөрсдийн хөрөг хоорондоо чөлөөтэй шилжиж чадахаас гадна бидэнд өөр газар болсон явдлыг дуулгаж чадна.

- Гэхдээ ноён Уизли хаана ч байж болно шүү дээ! гэж Харри хэлэв.

- Алив бүгдээрээ сууцгаа гэж Дамблдор хэлээд,

- Эдвард, Дайлис хоёр түүнийг хэдхэн хормын дараа олж чадна. Профессор

МакГонагалл хэдэн сандал гаргаадхаач гэв.

Профессор МакГонаглл халааснаасаа шидэт саваа гаргаж ирээд даллахад агаарт Дамблдорын ид шидийн яаманд гаргаж ирсний адил гурван модон сандал бий болов. Харри суугаад мөрөн дээгүүрээ Дамблдор руу ширтэв. Тэр Фоуксын алтлаг толгойг нь илбэхэд галт шувуу даруйхан сэрж үзэсгэлэнтэй толгойгоо өргөн Дамблдор руу гялалзсан хар нүдээрээ ширтэв.

- Бидэнд анхааруулга хэрэгтэй байна гэж Дамблдор тайван хэлэв. Дөл дүрсхийгээд галт шувуу алга болчихлоо.

Дамблдор мөнгөн эдлэл рүү түргэн очиж нэгийг нь аваад ширээн дээр тавьж шидэт саваагаараа хөнгөн тогшлоо.

Мөнгөн эдлэл хангир жингэр хийн амь орж жижигхэн цоргоор ногоон утаа савсуулав. Захирал утаа руу духаа үрчийлгэн анхааралтай харлаа. Хэдэн хормын дараа утаа шингэрэн агаарт цагариглахад ... түүнээс могойн толгой гарч ирээд амаа ангайлаа.

Харри мөнгөн эдлэл түүний яриаг баталж байгаа юм болов гэж гайхан Дамблдор луу харж өөр лүүгээ харахыг тэсч ядан хүлээсэн авч болсонгүй.

- Ойлгомжтой. Гэхдээ мөн чанар нь хуваагдсан уу? гэж тэр бувтнаад утаа руу өчүүхэн ч гайхсан янзгүй ширтэв.

Асуулт Харрид таавар хэвээр үлдэв. Утаан могой алгуур хоёр болон хуваагдаж харанхуй агаарт цоролзов. Дамблдор баргар царайлан мөнгөн эдлэлийг саваагаараа хөнгөхөн тогшиход утаан могой цайрч хэлбэр дүрсгүй манан болоод агаарт шингэлээ.

Дамблдор багажаа ширээн буцааж тавив. Харри захирлын хөргүүд түүн рүү харж байхыг мэдрээд эргэтэл унтаж буй дүр үзүүлэв. Харри хачирхалтай мөнгөн хэрэглэл юу болохыг асуух гэсэн ч түүнээс урьтаж баруун талын ханан дээр Эдвард нэртэй шидтэний хашгиралт сонсогдож жаазандаа амьсгаадсаар гарч ирлээ.

- Дамблдор!

- Ямар мэдээ байна? гэж шууд асуулаа.

- Би хэн нэгнийг иртэл хашгирлаа гэж шидтэн нойтон духаа ардах хөшгөөрөө арчин хэлээд,

- Би доор ямар нэг хөдөлгөөн сонссон гэж хэлсэн ... Тэд надад шууд итгээгүй ч

юу болсныг харахаар буусан ... чи доор харж болохоор хэн нэгний хөрөг байхгүйг мэднэ дээ. Товчхондоо гэвэл хэдэн хормын дараа түүнийг авчирсан. Цусанд будагдсан тийм ч сайнгүй харагдаж байсан. Тэднийг явсан хойно би Эльфрид Крэгтийн хөрөг руу сайн харахын тулд гүйсэн гэв.

- Сайн байна. Тэгэхээр Дайлис түүнийг харсан байх нь гэж Дамблдор хэлэхэд Рон татвалзлаа.

Хормын дараа мөнгөлөг мушгиа үстэй шидтэн хөргөндөө ирээд сандал дээрээ сууж ханиалгаснаа,

- Түүнийг гэгээн Мунгогийн эмнэлэгт аваачсан, Дамблдор ... миний хөргийн хажуугаар авч явсан ... их тааруу харагдаж байсан гэв.

- Баярлалаа гэж Дамблдор хэлээд МакГонагалл руу эргэв.

- Минерва минь, Уизлийн бусад хүүхдүүдийг сэрээх хэрэгтэй байна.

- Тэгэлгүй яахав.

Профессор МакГонагалл босоод хаалга руу түргэн ухасхийв. Харри Рон руу хальт харахад царайд нь айдас тодорсон байлаа.

- Дамблдор Моллиг яах гэж байна? хэмээн МакГонагалл үүдэн дээр саатан асуулаа.

- Үүнийг Фоуксд даалгасан ойр хавьд урилгагүй зочид байгаа эсэхийг шалгаж байгаа. Гэхдээ тэр хэдийн мэдсэн байх ... маш сайхан цагтай шүү дээ ...

Харри Дамблдорын цагны тухай яриаг ойлголоо. Энэ нь цаг хугацаа зааж үзүүлдэггүй бөгөөд Уизлийн гишүүн бүрийн байрлалыг заадаг билээ. Бодвол ноён Уизлийн зүү үхлийн аюул гэсэн хэсгийг заасан байх. Харри боггарт хатагтай Уизлийн өмнө ноён Уизлийн амьгүй шил нь хазайсан нүүрнээс нь цус урссан дүрд хувирсныг санаад хүйт даалаа ... Гэхдээ ноён Уизли үхээгүй ... тэр үхэх ёсгүй ...

Дамблдор тэр үед Харри, Рон хоёрын арын шүүгээг онгичин юм хайж байв. Тэр эцэст нь харласан хуучин данх гэргаж ирээд бичгийн ширээн дээр болгоомжтой тавив. Тэгснээ саваагаа өргөн Портус! гэж хэлэхэд данх чичирэн хачирхалтай цэнхэр өнгөтэй болсноо дараа нь урьдынх шигээ хар болов.

Дамблдор ухаалаг царайтай шовх урт сахалтай өөр шидтэний хөрөг рүү очив. Тэр Слизериний мөнгөлөг ногоон хувцас өмссөн агаад бөх унтаж байсан учир сэрээхийг

оролдсон ч сонссонгүй.

- Финеас, Финеас.

Хөргөн дэх хүмүүс сэргэж эхлэн жаазандаа болсон явдлыг сайтар харахаар хөдөлцгөөв. Ухаалаг урт сахалтай шидтэн унтсан дүр үзүүлсэн хэвээр байсан тул зарим хөргүүд,

- Финеас! Финеас! Финеас! гэж хашгиралдав.

Тэр цаашид унтсан дүр үзүүлэх боломжгүй болсон учир сэрээд нүдээ том нээлээ.

- Хэн нэгэн нь дуудсан уу?

- Өөр хөрөг рүүгээ явах хэрэгтэй байна, Финеас. Надад шинэ мэдээ байна.

- Өөр хөрөг рүү очих гэнээ? хэмээн Финеас эвшээн хэлээд (түүний нүд Харри дээр тусав). Үгүй дээ, Дамблдор би өнөөдөр их ядарлаа гэв.

Харрид ямар нэгэн танил мэдрэмж төрлөө. Тэр үүнийг хаа сонслоо? Гэхдээ түүнийг санаж амжихаас урьтаж ханан дахь хөргүүд эсэргүүцэн шуугилдав.

- Шийтгэл хүлээлгэ, эрхэм ээ! Тушаал биелүүлсэнгүй! гэж улаан хамартай шидтэн орилоод нударга зангидав.

- Бид Хогвартсын ажил хэрэгт үйлчлэх хүндтэй үүрэг хүлээж байдаг.

Ичгүүртэй юм, Финеас! гэж Харрийн Армандо Диппет гэж мэдэх хөгшин шидтэн хашгирлаа.

- Би түүнийг ятгаад өгөх үү? гээд хурц нүдтэй шидтэн саваагаа өргөв.

- За сайн байна хэмээн Финеас зөвшөөрөөд саваа руу болгоомжлон харав.

Хэдийгээр миний хөрөгний зураг утсан ч гэлээ би гэр лүүгээ очих боломжтой байх ...

- Сириус таныг хөргийг устгах ёсгүй гэдгийг мэдэж байгаа гэж Дамблдор хэлэхэд Харри Финеасын хоолой Гриммогийн арван хоёрдугаар байшингийн унтлагын өрөөний хоосон жаазнаас сонсогдож байсныг саналаа.

- Та түүнд Артур Уизли хүнд шархадсан бөгөөд түүний эхнэр, хүүхдүүд болон Харри Поттер удахгүй гэрт нь очно гэдгийг дамжуул. Ойлгов уу?

- Артур Уизли шархдаж, эхнэр, хүүхдүүд, Харри Поттер тэднийд очно гэж Финеас уйдсан өнгөөр давтаад,

- За за гэлээ.

Тэр жаазнаасаа гулган алга болоход өрөөний үүд нээгдэв. Профессор МакГонагалл үс нь сэгсийж цочирдсон унтлагын хувцастай Фред, Жорж, Жинни нарыг оруулж ирлээ.

- Харри юу болоо вэ? Профессор МакГонагалл чамайг аавыг шархадсаныг харсан гэж хэллээ хэмээн Жинни айн асуув.

- Танай эцэг Фениксийн бүлгийн даалгаварыг биелүүлж байгаад шархадсан.

Түүнийг гэгээн Мунгогийн ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгт аваачсан. Би та нарыг Сириусын гэр лүү явуулна. Эмнэлэгт Үүрнээс илүү ойр. Та нар тэнд ээжтэйгээ уулзана.

- Бид тийшээ яаж хүрэх юм бэ? Нисдэг дариар уу? гэж Фред асуув.

- Үгүй ээ. Одоо сараалжнууд хяналтанд байгаа учир нисдэг дарь аюултай. Та нар зөөвөрлөгч ашиглана гээд ширээн дээр байгаа хуучин цайны данхыг заалаа.

- Бид Финеас Найжелусын мэдээллийг хүлээж байна ... Та нарыг аваачихаас өмнө зам цэвэр эсэхийг шалгах хэрэгтэй байна.

Өрөөний дунд галын дөл дүрсхийж нэг ширхэг алтлаг өд шалан дээр алгуур унав.

- Энэ бол Фоуксын анхааруулга гэж Дамблдор хэлээд өдийг барьж авснаа,

- Профессор Амбриж та нарыг унтлагын өрөөндөө байхгүй гэдгийг мэдсэн байна ... Минерва минь явж ямар нэг түүх бодож олоод саатуулж үзээч гэлээ.

Профессор МакГонагалл гарч одов.

- Тэр баяртай байх болно гэж хэлж байна гэх уйдсан хоолой Дамблдорын ард гарч шидтэн Финеас Слизериний далбааны урд ахин эргэж ирлээ. Миний өвөг дээдэс үргэлж зочид хүлээн авахдаа баяртай байдаг юм.

- Тэгвэл нааш ирцгээ. Хэн нэгэн орж ирэхээс өмнө түргэл гэж Дамблдор Харри болон Уизличуудад хэлэв.

Тэд ширээнд ойртон зогслоо.

- Бүгд урьд нь зөөвөрлөгч ашиглаж байсан биз дээ? Тэд толгой дохиод

хуруугаа данханд хүргэлээ.

- Сайн байна. Гурав тоолъё. Нэг хоёр ...

Бүх зүйл агшин зуур болов. Түүнийг гурав гэж хэлэх богинохон нэг агшинд Харри Дамблдорын цэнхэр нүд царай дээр нь тогтсоныг харлаа.

Тэр даруй сорви нь хуучин шарх задрах адил аймшигтай халуу шатан өвдөж үзэн ядалт дотор нь дүрэхийхэд энэ дэлхий дээр юунаас ч илүү энэ хүнийг шүдээрээ зуун тасар татаж хаямаар санагдав.

- ... гурав.

Харри хүйснээсээ хүчтэй татагдахаа мэдрэн хөл нь газраас хөндийрч гар нь данханд наалдаад бие биеэ цохилсоор тавуул салхинд эргэлдэн нислээ. Удалгүй хөл дор газар мэдрэгдэж өвдгөөрөө хүчтэй цохин унахад данх тачигнан өнхөрч хэн нэгний хоолой,

- Урвагчид эндээс зайлцгаа. Танай эцэг үхсэн гэсэн үнэн үү? гэх нь сонсогдов.

- Зайл! гэх өөр хоолой сонсогдлоо.

Харри хөл дээрээ босоод эргэн тойрноо харав. Тэд Гриммогийн арван хоёрдугаар байшингийн бүүдгэр гал зууханд байв. Өрөөнд байх цорын ганц гэрэл ханан зуух болон нэг лаанаас гарч ганц хүний оройн зоогийг гэрэлтүүлнэ. Кикимер хаалгаар зугтаж гарахдаа зэвүүнээр эргэн харлаа. Тэдний дэргэд түгшсэн Сириус гүйж ирлээ. Тэр үс сахлаа хусаагүй ердийн хувцастай байх агаад Наземникусын адил архи үнэртэнэ.

- Юу болоо вэ? Финеас Найжелус Артур Уизлиг хүнд шархадсан гэж хэллээ гээд Жиннийг босоход туслав.

- Харригаас асуу гэж Фред хэлэв.

- Би ч гэсэн сонсохыг хүсч байна гэж Жорж хэлэв.

Ихрүүд болон Жинни түүн рүү эргэн харав. Кикимерийн шатан дээрх алхаа намдав.

- Энэ бол ... гэж Харри эхэлсэн ч МакГонагалл, Дамблдор хоёрт ярьсанаас илүү хүнд байлаа. Надад юм үзэгдсэн.

Тэр харсан зүйлээ ярихдаа могойн зүгээс дайралтыг харсан биш хажуу талаас нь харсан болгон өөрчилөв. Рон урьдын адил даавуу шиг цайгаад түүн рүү харсан ч юу ч хэлсэнгүй. Харриг яриагаа дуусгамагц Фред, Жорж, Жинни нар чимээгүй гөлрөн

харцгаав. Тэр тэдний юу бодож байгааг ойлгоогүй ч харцнаас зэмлэнгүй өнгийг олж харлаа. Хэврээ тэр дайралтын гэрч болсноороо буруутай бол могойн дотор байсныг хэлээгүй нь сайн хэрэг боллоо.

Фред Сириус руу эргэлээ.

- Ээж энд байгаа юу?

- Тэр мэдээгүй байж болох юм. Та нарыг Амбриж саад болохоос өмнө авах чухал байсан. Харин би одоо л Дамблдорыг Моллид хэлж байгаа байх гэж бодож байна.

- Бид гэгээн Мунгогийн эмнэлэг рүү явах хэрэгтэй байна гэж Жинни хэлээд унтлагын хувцастай ихрүүд рүү харснаа,

- Сириус бидэнд жанч ч юмуу өөр ямар нэгэн зүйл өгч болох уу? гэв.

- Хүлээгээрэй та нар эмнэлэг рүү явж болохгүй.

- Мэдээж бид явна. Энэ чинь манай эцэг шүү дээ! гэж Фред гэжүүдлэв.

- Та нар золгүй тохиолдлыг хаанаас мэдсэнээ яаж тайлбарлах гэж байгаа юм.

Эмнэлэгээс эхнэрт нь ч мэдэгдээгүй байхад?

- Ямар ялгаа байна? гэж Жорж дүрсхийв.

- Учир нь бид Харриг үйл явдал болсон газраас зуун милийн зайд үзэгдэл харсан гэдэгт анхаарал татахыг хүсэхгүй байна гэж Сириус ууртай хэлээд, Та нар ид шидийн яаманд мэдээлэл хаанаас авсан гэдгээ яаж тайлбарлах юм бэ?

гэв

Фред, Жорж хоёр түүн рүү ид шидийн яам мэтийн зүйл огтхон ч хамаагүй гэж харсан бол Рон цонхийсон чигээр дуугүй байв.

- Бидэнд өөр хүн хэлсэн байж болно шүү дээ. Заавал Харригаас сонссон байх албагүй гэж Жинни хэллээ.

- Жишээ нь хэнээс? Сонсоцгоо та най эцэг бүлгийн дагаварыг биелүүлж байгаад шархадсан болохоор сэжиглэлгүй өнгөрөхгүй. Бас хүүхдүүд нь болсон явдлыг даруй мэдсэн байдаг. Энэ нь бүлэгт ноцтой аюул хүргэж болно.

- Бидэнд та нарын тэнэг бүлгэм хамаагүй! гэж Фред хашгирав.

- Бидний эцэг үхэж байхад юуны тухай ярих юм! гэж Жорж орилов.
- Эцэг чинь бүлэгт хор учруулсныг чинь мэдвэл талархахгүй л байх даа! Яагаад та нарыг бүлэгт авдаггүйн учир гэвэл энэ ... та нар үхэж болох аюул байдгийг ойлгохгүй байна.
- Чамд суугаад ярихад амар байгаа л даа. Чиний арьсаа хамгаалж байгааг чинь харахгүй байна гэж бодоо юу! хэмээн Фред дэлбэрлээ.

Сириусын царай үнс шиг цонхийн цайлаа. Тэр одоохон Фредийг цохих гэж байгаа мэт санагдсан боловч тайван хоолойгоор дуугарлаа.

- Би энэ хүнд байгааг мэдэж байгаа ч одоо ямар ч зүйл болоогүй мэт биеэ авч явах ёстой. Чимээгүй суугаад эхээсээ мэдээ хүлээ.

Фред, Жорж хоёрыг энэ тайвшируулсангүй. Жинни ойролцоох сандал дээр суулаа. Харри Рон руу харахад толгой дохисон мөрөө хавчсан нь мэдэгдэхгүй ойлгомжгүй хөдөлгөөн хийв. Ихрүүд Сириус руу цоргисон харцаар ширтсэнээ Жиннигийн хажууд суулаа.

- Сайн байна гэж Сириус урамтай хэлээд,
- Алив бүгдээрээ хүлээх зуураа ууцгаая. Ацио цөцгийний шар айраг! гэв.

Ингэж хэлснийхээ дараа тэрбээр шидэт саваагаа өргөхөд лонхнууд нисэн ирж оройн хоолны үлдэгдэлтэй ширээн дээр хүн бүрийн урд тавигдав. Чимээгүйхэн ууцгаахад ханан зууханд тас нясхийх чимээ гарч үе үе лонх ширээн дээр жингэтэл тавих дуу гарна.

Харри ямар нэг зүйл хийж сатаарахын тулд лонхтойг авлаа. Дотор нь халуу оргин гэмших сэтгэл төрнө. Хэрвээ тэр байгаагүй бол тэд энд сууж байхгүй орондоо тайван унтаж байх байсан. Гэхдээ тэр түгшүүр зарлаагүй бол ноён Уизлиг түргэн олохгүй байсан гэж өөрийгөө ятгахыг хичээсэн ч тэр л өөрөө дайрсан мэт зэвүүн бодол орж ирэх ажээ.

«Битгий тэнэг юм ярь чамд могойн шүд байхгүй. Чи орондоо хэвтээд хэнийг ч дайраагүй» гэж тэр өөртөө хэлээд тайвширахыг хичээсэн ч гарт нь байсан лонх чичирлээ.

«Тэгвэл Дамблдорын өрөөнд юу болсон юм бол? Тэр түүнийг дайрахыг хүсээгүй гэж үү?»

Тэр лонхтойг ширээн дээр цалгиулан тавилаа. Хэн ч үүнд анхаарал хандуулсангүй. Тэгтэл агаарт дөл дүрсхийж бохир тавагыг гэрэлтүүлэв. Бүгд цочирдон хашгирахад ширээн дээр ганц алтан өд уналаа.

- Фоукс! гэж Сириус дуу алдаад цаасыг авлаа.

- Энэ Дамблдорын бичиг биш байна. Ээжийнх чинь л байх. Аваарай. Тэр захиаг Жоржод сунгахад нээгээд чанга уншлаа.

Эцэг чинь амьд. Би эмнэлэг рүү явж байна. Байгаа газартаа үлдээрэй. Удахгүй хэл хүргэнэ. Ээж чинь.

Жорж ширээ рүү харлаа.

- Амьд гэнээ ... Үүнийг чинь юу гэж ойлгох ...

Түүнд яриагаа үргэлжлүүлэх хэрэг байсангүй. Харрид захианы өгүүлбэрээс ноён Уизли үхлийн дээсэн дөрөөн дээр байна гэж сонсогдох шиг болов. Рон цусгүй цайж захиа руу тайвшируулах үг сонсохыг хүссэн мэт харав. Фред цаасыг Жоржоос авч уншаад дараа нь Харри руу харав. Түүний лонхтой гар нь чичрэхэд чанга атгалаа.

Хэзээ ч ийм урт шөнө байсангүй. Сириус итгэлгүй хоолойгоор бүгдийг унтахыг санал болгосон ч Уизличуудын жигшсэн харц тодорхой хариулт болов. Тэд ширээ тойрон чимээгүй суугаад лааны дөл улам намсан лав урсахыг харж хааяа нэг лонхоо уруулдаа хүргэх юмуу цаг асуунгаа эмнэлэг дээр юу болж байгааг тааварлан эсвэл бусдыгаа тайвшируулахын тулд муу юм болсон тохиолдолд хатагтай Уизли тэнд байгаа болохоор тэд мэдэх байсан гэж ярьж байлаа.

Фред зүүрмэглэн толгойгоо мөр рүүгээ унжуулав. Жинни сандал дээр муур шиг цагариглаад нүд нь нээлтэй байлаа. Харри тэдний царайг галын гэрэлд харлаа. Рон нүүрээ алгаараа дараад унтаж байгаа эсэх нь ойлгомжгүй үзэгдэнэ. Харри, Сириус хоёр гэр бүлийн хэрэгт оролцохгүйн тулд бие бие рүүгээ харангаа хүлээгээд л ... хүлээгээд л байлаа.

Зургаан цаг арван минутад гал зуухны хаалга нээгдэж хатагтай Уизли орж ирэв. Тэр цонхийн цайсан бүгд түүн рүү эргэж Харри, Рон, Фред гурав босоход сулхан инээмсэглэв.

- Тэр дээрдэж байгаа. Та нар дараа уулзаарай. Одоо түүнтэй Билл байгаа өглөө ажилдаа явахгүй гэж ядарсан хоолойгоор хэлэв.

Фред сандал дээр буцаж унаад нүүрээ алгаараа хаалаа. Жорж, Жинни хоёр эх рүүгээ ухасхийн тэврэв. Рон итгэлгүйхэн инээгээд лонхтойгоо нэг амьсгаагаар хоослов.

- Өглөөний хоол! гэж Сириус хөгжилтэй чанга хашгираад үсрэн босов.
- Нөгөө хараал идсэн үйлчлэгч хаачив аа? Кикимер! Кикимер! Гэхдээ Кикемер дуудахад ирсэнгүй.
- За яахав чамгүй болно гээд тэр зочдоо тоолов.
- Ингээд өглөөний хоол ... долоон хүний өндөгтэй жаврай, цай, шарсан талх ...

Харри туслахаар ухасхийв. Тэр Уизлийн гэр бүлийн баяртай мөчийг эвдэхийг хүсээгүйн дээр хатагтай Уизли түүнээс үйл явдлын тухай асуух вий гэж эмээжээ. Түүнийг таваг автал хатагтай Уизли ирж тэвэрлээ.

- Чамайг байхгүй байсан бол яахыг ч төсөөлөхгүй байна, Харри. Хичнээн цагийн дараа олоход оройтсон байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ тэр амьд чамд талархаж байна. Дамблдор Артурыг яагаад тэнд байсан тухай түүх зохиож ярьсан. Биднийг ямар таагүй явдал хүлээж байгааг ч төсөөлөхгүй юм. Хөөрхий Стержисыг бодоод үз дээ.

Харри энэ талархлыг шаналан сонссон ч аз болоход тэр Сириуст хүүхдүүдийг нь шөнө харж байсанд талархал илэрхийлэхээр тавилаа. Сириус хариуд нь маш баяртайгаар ноён Уизлиг эмнэлэгт байх үед гэрт нь үлдэж болно гэлээ.

- Өө, Сириус минь би ямар их талархаж байна гээч ... хэрвээ тэд байхыг хүсэх юм бол ... эмнэлэгт ойрхон ... магадгүй зул сар хүртэл үлдэх байх.
- Энэ чинь хөгжилтэй шүү дээ! гэж Сириус чин сэтгэлээсээ хэлэхэд тэр баясан гийгээд хормогч өмсөж өглөөний хоол бэлдэхэд туслав.
- Сириус чамтай хоёр үг сольж болох уу? Яг одоо гэж Харри цашид тэвчих хүчгүй болоод хэллээ.

Тэр харанхуй зoorь луу гарахад Сириус араас нь дагав. Харри загалмайлан эцэгтээ өөрийн харсан бүх зүйлээ могой байснаас авхуулаад ноён Уизлиг дайрсан тухай дэлгэрэнгүй ярилаа. Түүнийг яриагаа зогсоохд Сириус,

- Чи энэ тухай Дамблдорд хэлэсэн үү? гэв.
- Тиймээ. Гэхдээ тэр юу болохыг тайлбарлаагүй. Тэр надтай юу ч ярихгүй байгаа.

- Чамд хэлж түгшээхгүй байх шалтаан байсан биз гэж Сириус тайвшируулав.
- Гэхдээ энэ ч бас бүгд биш. Сириус би ухаан солиорч байх шиг байна. Түүний өрөөнд байхдаа зөөвөрлөгчөөр явахын өмнө би ахиад л өөрийгөө могой гэж бодсон шүү. Могой шиг мэдрэн сорви халуу шатаж Дамблдор руу харахад ... Сириус би түүн рүү дайрахыг хүссэн!

Харри түүний баргар царай луу харлаа.

- Энэ бол чиний харалтын уршигаас өөр зүйлгүй. Чи зүүдээ санасан юм уу эсвэл өөр юу ...
- Үгүй ээ, тийм биш. Надад могой миний дотор байгаа юм шиг санагдсан.
- Чи амрах хэрэгтэй. Өглөөний цайгаа уугаад дээшээ гарч унт. Өдрийн хоолны дараа Артур луу явна. Чи цочирдолд орсон байна, Харри. Чи ийм зүйл харсандаа өөрийгөө буруутгаж байна. Аз болоход чи үүнийг харсан болохоор Артур үхсэнгүй. Өөрийгөө зовоохоо боль.

Тэр Харрийн мөрөн дээр алгадаад зоориноос гарлаа. Харри харанхуйд ганцаар үлдэв. Өглөө Харригаас бусад хүмүүс унтав. Тэр өнгөрсөн зун байсан унтлагын өрөөндөө ороход Рон шууд орондоо шургалан унтсан бол Харри орон дээр хувцастайгаа суугаад тухгүйхэн бөхийж хэрвээ унтах юм бол ахиад могой болж Роныг хазах юм уу эсвэл энэ гэрт байгаа хэн нэгнийг дайрахаас айж байв.

Роны сэрэх үед Харри бас сэрж байгаа дүр үзүүлэв. Үдийн хоолны үед тэдний чемодан Хогвартсаас ирж маглуудын хувцас солин гэгээн Мунгогийн эмнэлэг рүү явах боломжтой болжээ. Харригаас бусад бүх хүн аз жаргалтайгаар ярилцан жинс футболкаа сольж өмсөв. Тэднийг эмнэлэгт хамгаалан хүргэж өгөхөөр Тонкс, Хурц нүдэт хоёр ирлээ. Хүүхдүүд тэдэнтэй баяртай хашгиран уулзаж Грюмын шидэт нүдээ далдлан тавьсан бүрхийг шоолон инээлдээд урьдын адил богинохон тод ягаан үстэй болсон Тонксоос илүү анхаарал татам байна гэв.

Тонкс Харрийн харалтыг их сонирхож байсан ч энэ түүхийг ахин давтаж ярих өчүүхэн ч хүсэл байсангүй.

- Танай удамд үзмэрч байгаагүй юу? гэж тэр галт тэргэнд сууж Лондонгийн төв рүү явахад асуув.

Үгүй гэж Харри хэлээд энэ асуултанд профессор Трелони доромжлогдсон мэт

хандсаныг саналаа.

- Үгүй гэнээ? Хэдийгээр чи жинхэнэ зөн хэлээгүй ч гэлээ. Чи ирээдүйг биш харин жинхэнэ болсон явдлыг харсан нь хачирхалтай байгаа биз? Гэхдээ ашигтай юм гэж Тонкс бодлогширон хэлэв.

Харри хариулсангүй. Аз болоход Лондонгийн төв буудал дээр ирэхэд хөл үймээн дунд Харри дундаа Фред, Жорж хоёрыг оруулж түрүүлэн гарлаа. Тэд түүний араас цахилгаан шат хүртэл явахад бүрх малгай духдуулан нэг гараа хүрэмнийхээ товч дундуур шургуулан шидэт саваагаа брьсан Грюмын модон хөлийн чимээ ард сонсогдоно. Харри нуугдсан нүд түүнийг дагуулан хараад ч байгаа юм шиг хачирхалтай мэдрэмж төржээ. Харалтын тухай шинэ асуултаас зугтахын тулд Харри Грюмээс гэгээн Мунгогийн эмнэлэг хаана байдгийг асуулаа.

- Эндээс холгүй гэж Грюм тэднийг хүйтэн агаарт гарахад сөөнгөтөв.

Тэдний өмнө зул сарын баярын худалдан авагчаар дүүрэн өргөн гудамж байлаа. Грюм Харриг түлхэн урдаа гаргаад араас нь дагав. Харри одоо түүний нүд бүх зүг рүү эргэлдэн харж байгааг мэдэж байв.

- Эмнэлэгт тохиромжтой байрлал олох амаргүй. Тахир гудамж давчуу, ид шидийн яам шиг газар доорхи газар эмнэлэгт тохиромжгүй. Эцэст нь энд аятайхан барилга олдсон. Онол ёсоор бол өвчтэй шидтэнгүүд ирэхийн тулд анзаарагдахгүй хүмүүсийн тулд холилдон ирэх ёстой.

Тэр цахилгаан барааны дэлгүүрийн гадаа бөөгнөрөн шуугилдаж байгаа хүмүүсийн дунд алдчихгүйн тулд Харрийн мөрөн дээр дарав.

- Ирлээ гэж хормын дараа хэлэв.

Тэд хуучин тоосгон их дэлгүүрийн өмнө зогсож байв. Байшин өнгө үзэмжгүй бөгөөд шилэн лангуунд нь арван жилийн өмнө загвараас хасагдсан хиймэл үстэй хэдэн хиймэл хүн харагдана. Тоостой хаалган дээр нь «Засвартай хаагдсан» гэсэн хаяг өлгөжээ. Харри бүдүүн эмэгтэй хуванцар хаягийг уншаад үргэлж хаалттай байх юм гэж хэлэхийг сонслоо.

- Ийшээ гэж Тонкс хэлээд тэднийг шалан дээр зогсож байгаа үзэмжгүй эмэгтэй хиймэл хүний зүг аваачив. Түүний хуурамч сормуус нь ховхорсон агаад ногоон нейлонон хормогчтой байлаа.

Бүгд Тонксыг тойрон цугларав. Грюм ахин Харрийн нуруу руу түлхэн ойртуулахад

Тонкс хиймэл хүн рүү харж лангуу руу бөхийгөөд,

- Бид Артур Уизли дээр ирлээ гэж хэлэв.

Харри гудамжинд автобус холхилдон хүмүүс дүүрэн байхад хиймэл хүн шилийг нэвтлэн аяархан хоолой сонсох нь утгагүй хэрэг гэж бодлоо. Үнэнийг хэлэхэд хиймэл хүн сонсдоггүй юм. Харин секунтын дараа гайхсандаа амаа ангайжээ. Хиймэл хүн ажиглагдам толгой дохиод хуруугаа нийлүүлэхэд Тонкс Жинни болон хатагтай Уизлийн тохойноос барин шил рүү орон алга болов.

Тэдний араас Фред, Жорж, Рон нар оров. Харри эргэн тойрны хүмүүсийн урсгал руу харсан ч хэний ч толгой лангуу руу эргэсэнгүй. Хэн ч зургаан хүн агаарт алга болохыг харсангүй.

- Явъя гэж Грюм шивнээд Харрийн нуруу руу ахин түлхэхэд хүйтэн усан хөшиг нэвтлэх шиг болж хуурай дулаахан газар орлоо.

Энд ямар ч хиймэл хүн, шилэн лангуу байсангүй. Тэд хүлээн авалтын өрөө бололтой эгнүүлэн тавьсан яйжгий модон сандал дээр шидтэнгүүд суусан танхимд орж ирлээ. Зарим нь жирийн байдалтай «Шидэт долоо хоног» уншиж, зарим нь аймшигтай зэрэмдэг төрхтэй агаад их бие нь заан шиг эсвэл нэмэлт гар цээжнээс нь цухуйх аж. Энд гудамжин дахиас чимээгүй агаад олонхи өвчтөн өвөрмөц чимээ гаргаж байв. Нүүрэн талын эгнээний дунд сууж байсан хөлстэй нүүртэй шидтэн «Өдөр тутмын зөнч» сонин гарчиглах зуураа уурын тогоо шиг нарийхан исгэрэхэд, буланд суугаа бохир шидтэн хөдлөх бүрдээ толгойгоо хонхны хэл шиг савчуулж байсан тул чихнээсээ атгажээ.

Эгнээ хоорондуур цайвар ногоон хувцастай шидтэнгүүд явж асуулт тавих бөгөөд гартаа Амбрижийнх шиг тэмдэглэлийн дэвтэр барьжээ. Харри тэдний цээжин дээр шидэт саваа яс зөрсөн бэлгэ тэмдэг хатгамласан байхыг харлаа.

- Энэ эмч үү? гэж Роноос аяархан асуулаа.

- Эмч гэнээ? Маглуудыг зүсдэг хүмүүс үү? Үгүй дээ тэд анагаагч байгаа юм.

- Ийшээ! гэж хатагтай Уизли буланд сууж байсан шидтэний дээгүүр дуудахад тэд «Лавлах» гэсэн бичигтэй ширээний ард суусан махлаг шаргал үстэй шидтэн рүү очих дараалалд зогслоо.

Тэдний арын ханан дээр дараах үтгэй зурагт хуудас байв. «ЦЭВЭР ТОГОО ТАНЫ УУСМАЛЫГ ХОР БОЛОН ХУВИРГАХГҮЙ.» Тэнд бас урт цайвар мушгиа үстэй

шидтэний зураг өлгөж дор нь бичиг бичжээ.

Дайлис Дервент

Гэгээн Мунгогийн эмнэлэгийн ангаагч (1722-1741)

Ид шидтэн илбэчиний Хогвартс сургуулийн захирал (1741-1768).

Дайлис Уизлийнхнийг ойртон ирэхэд тоолж буй мэт харлаа. Харри түүн лүү харахад үл мэдэг ирмээд жаазныхаа хажуу руу орон алга болов.

Тэр агшинд дарааллын урд зогсож байсан залуу шидтэн хором тутамд өвдсөндөө хашгирч үүнийгээ ширээнд суугаа хүнд тайлбарлахыг оролдож байв.

- Энэ өсгийтэй гутал ... ёо ... ах минь надад өгсөн юм ... ёо ... тэд намайг идэж байна ... Ёо ... хөл ... харж байна уу ... аах ... шившлэгтэй юм ... Ээ-жээ би тэднийг тайлж чадахгүй гээд халуун нүүрсэн дээр гишгэсэн мэт хөл дээрээ догонцон бүжиглэлээ.

- Гутал уншихад саад хийгээд байна уу? гэж шаргал үст уурсан асуугаад ширээний зүүн талын том зарлал руу заагаад, Та дөрвөн давхарын шившлэгийн гэмтэл рүү явах хэрэгтэй. Зааврыг харж байна уу? Дараагийнх нь! гэв.

Шидтэн догонцон явахад Уизлийнхан алхам урагшилж Харри зааврыг уншлаа.

ЗОЛГҮЙ ЯВДАЛААС ҮҮССЭН ГЭМТЭЛ ... газар доорхи давхар

Тогоо дэлбэрэх, шидэт саваа эргэж шивших, шүүрний осол гэх мэт.

АМЬТДЫН ГАРАЛТАЙ ШАРХ ... нэгдүгээр давхар

Хазуулах, хатгуулах, түлэгдэх, өргөсөнд зоогдох гэх мэт.

ИД ШИДИЙН ВИРУС ... хоёрдугаар давхар

Халдварт өвчин, лууны тууралт, алга болдог өвдөлт гэх мэт.

УУСМАЛ БОЛОН УРГАМЛЫН ХОР ... гуравдугаар давхар

Бижрүүтэх, бөөлжих, инээдээ барьж чадахгүй байх гэх мэт.

ШИВШЛЭГИЙН ГЭМТЭЛ ... дөрөвдүгээр давхар

Чалчих, тааламжгүй амьдрал, буруу ашиглагдсан шид гэх мэт.

ЗОЧДЫН ЦАЙНЫ ГАЗАР БОЛОН ЭМНЭЛЭГИЙН ДЭЛГҮҮР ... тавдугаар давхар

ХЭРВЭЭ ТА ХААШАА ХАНДАХАА МЭДЭХГҮЙ БОЛОН ЖИРИЙН ЯРИХ

БОЛОМЖГҮЙ ЭСВЭЛ ЯАХ ГЭЖ ИРСНЭЭ САНАХГҮЙ БАЙГАА БОЛ МАНАЙ ШИДТЭНГҮҮД ТАНЬД ТУСЛАХАД БЭЛЭН БАЙНА.

Одоо ширээ рүү хөгшин бөгтөр шидтэн очоод,

- Би Бродерк Боуд дээр ирлээ гэж хэржигнэв.

- Дөчин есдүгээр өрөө. Гэхдээ таныг цагаа дэмий үрж байгаа болов уу гэж айж байна. Тэр өөрийгөө данх гэж бодсон хэвээр байгаа. Дараагийнх нь!

Зовж зүдэрсэн царайтай шидтэн жижигхэн охиноо шагайнаас нь барьжээ. Охин хүрэм нэвтлэн цухуйсан өдтэй далавчаа дэвэн дээш хөөрч байлаа.

- Дөрөвдүгээр давхар гэж шаргал үст асуугаагүй байхад уйдсан хоолойгоор хэлэхэд эрэгтэй ширээний ард талын далавчтай хаалгаар охиноо агаарын бөмбөлөг шиг өргөн барьсаар оров.

- Дараагийнх нь!

Хатагтай Уизли ширээ лүү очлоо.

- Сайн байна уу. Миний нөхөр Артур Уизли өглөө өөр тасагт шилжсэн байх ёстой. Та хэлж өгөхгүй юу?

- Артур Уизли юу? гээд тэр хуруугаа урт жагсаалтын дагуу гүйлгэснээ,

- Тиймээ нэг давхарын баруун талаасаа хоёр дахь хаалга Даи Луэллиний өрөө гэв.

- Баярлалаа. Явцгаая хүүхдүүдээ.

Тэд хоёр далавчтай хаалгаар орж алдартай домчдын хөргөөр чимэглэгдсэн нарийхан хонгилоор явахад адраас дүүрэн лааны гэрэлтэй болор бөмбөлөг том савангийн хөөс шиг унжиж байлаа. Хаалгаар цайвар ногоон халаттай шидтэнгүүд орж гаран хөлхөлдөнө. Нэг хаалганаас шатдаг хий санагдуулсан үнэр үнэртэх агаад ёолон орь дуу тавих чимээ гарч байв. Тэд шатаар өгсөн амьтны гаралтай шархны хэсэг рүү ирлээ. Баруун талаасаа хоёр дахь хаалган дээр «Аюултай Даи Луэллиний тасаг, ноцтой хазуулсан» гэсэн хаяг өлгөсөн байв. Дор нь «Жижүүрийн анагаагч: Гиппократ Сметвик. Дадлагын анагаагч Август Сепсис» гэж бичсэн байлаа.

- Молли бид гадаа хүлээж байя. Артур ийм олон зочдыг зэрэг хүлээн авч болохгүй ... Эхлээд гэрийнхэн нь орцгоо гэж Тонкс хэлэв.

Хурц нүдэт дэмжингүй бувтнаад нуруугаараа хана налан шидэт нүдээ зүг бүр тийш

эргэлдүүлэв. Харри бас ухарсан ч хатагтай Уизли гараас нь бариад хаалга руу түлхэв.

- Тэнэг байх хэрэггүй дээ, Харри. Артур чамд талархахыг хүсч байгаа.

Өрөө дэндүү жижигхэн царай муутай бөгөөд хаалганы эсрэг талын хананд нарийхан цонх байлаа. Адраас зүүгдсэн болор бөмбөлөгөөс гэрэл гарна. Ханыг царсан хавтангаар доторлож ууртай шидтэний хөрөг өлгөөд дор нь «Уркхарт Ракплуг, 1612-1697, Гэдэс дотроос хараалыг зайлуулагч» гэж бичсэн байв.

Тэнд ердөө гурван өвчтөн байлаа. Ноён Уизли цонхны ойролцоох орны ирмэг дээр сууж байв. Харри түүний дэр налан «Өдөр тутмын зөнч» сонин гарчиглан суухыг хараад санаа амарлаа. Өрөөнд орж ирж буй цорын ганц нарны гэрэл түүний орыг гийгүүлнэ. Тэр сонингоо холдуулан хэн ирж байгааг хармагц хөгжилтэй инээмсэглэв.

- Сайн уу! Билл саяхан явсан, Молли. Тэр ажил руугаа явах хэрэгтэй болсон ч дараа ирнэ гэж амалсан.

- Бие чинь ямар байна, Артур? гээд хатагтай Уизли бөхийн хацар дээр нь үнсээд царай луу нь халамжлангуй харлаа. Жаахан сульдчихаа юу даа.

- Би маш сайн байна. Хэрвээ боолтыг авчихвал гэртээ харьж болно гээд тэр эрүүл гараа Жинниг тэврэхийн тулд сунгав.

- Яагаад боолтыг тайлж болохгүй байгаа юм? гэж Фред асуув.

- Тэднийг авахыг оролдох болгонд аймшигтай их цус гарч байгаа гэж ноён Уизли хөгжилтэй тайлбарлаад шүүгээн дээр байсан шидэт савааг авч даллахад зургаан сандал бий болов.

- Энэ могойны соёо ер бусын хортой байсан бололтой шарх нь анихгүй байгаа юм. Гэхдээ тэд хорны эсрэг үйлчлэлийг олно гэдэгт итгэлтэй байгаа. Цаг тутамд цус сэлбэгч ханд өгч байгаа. Харин энэ хөөрхий хөрш минь, хүн чононд хазуулсан юм гэж тэр дуугаа намсган хэлээд эсрэг талын орон дээр адар ширтэн хэвтэж байгаа ногоовтор царайтай хүн рүү заалаа.

- Хүн чоно гэнээ? Тэр яагаад нийтийн тасагт байгаа юм бэ? Түүнийг тусгаарладаггүй юм уу? гэж хатагтай Уизли түгшин асуулаа.

- Арван тавны сар хоёр долоо хоногийн дараа гарна гэж ноён Уизли аяархан

сануулаад,

- Өнөөдөр түүнтэй анагаагч ярилцсан. Хэвийн амьдралдаа орно гэж итгүүлэхийг хичээж байгаа юм. Би түүнд хүн чоно хэдий ч маш сайн залууг танина гэж хэлсэн гэв.

- Харин тэр юу гэж хэлсэн бэ? гэж Жорж асуулаа.

- Тэр намайг амаа хамхихгүй бол хазна гэсэн. Харин тэр эмэгтэй гээд гурав дахь орон дээр хэвтэж байгаа хүн рүү заагаад, Анагаагчид түүнийг хэн хазсаныг мэдэхгүй байгаа ч хууль бус амьтан гэж сэжиглэж байгаа юм. Ямар ч байсан гэсэн түүний хөлний боолтыг нь солих үед их таагүй үнэр гардаг юм гэв.

- Та бидэнд юу болсныг ярьж өгөхгүй юм уу? гэж Фред асуугаад сандлаа дөхүүлэв.

- Та нар хэдийн мэдсэн биз дээ? Бүгд их энгийн. Би урт өдрийн дараа ядраад жижүүр дээрээ зүүрмэглэж байтал могой намайг хазсан гэж ноён Уизли Харри руу инээмсэглэн хэлэв.

- «Зөнч» сонинд энэ дайралтын тухай гарсан уу? гэж Фред эцгийнхээ барьсан сонинг заан асуулаа.

- Үгүй дээ хэмээн ноён Уизли гашуунаар инээмсэглэн хэлээд,

- Ид шидийн яамнаас хүн бүр зэвүүн аварга том могой ...

- Артур! гэж хатагтай Уизли хориглов.

- Надад хүрснийг мэдүүлэхийг хүсэхгүй байгаа юм гэж яаран дуусгахад Харрид өөр зүйл хэлэхийг хүссэн мэт санагджээ.

- Энэ явдал болох үед та хаана байсан юм? гэж Жорж асуулаа.

- Энэ миний хэрэг гэж эцэг нь эсэргүүцээд «Өдөр тутмын зөнч» сониноо дэлгэлээ.

- Та нарыг ирэх үед би Уилли Уидершинс баривчлагдсан тухай уншиж байлаа.

Энэ зуны бөөлждөг жорлон түүний ажил байх. Түүний нэг шившлэг нь буцаж үйлчлэн жорлон дэлбэрэхэд хагархайн дунд ухаангүй хэвтэж байхад нь олсон байна. Хөлөөсөө толгой хүртлээ ...

- Та жижүүрлэж байсан гэж хэлсэн үү. Юу хийж байсан юм? гэж Фред түүний

яриаг таслав.

- Чи эцгээ сонссон. Бид энэ тухай ярилцах гэж ирээгүй! Тэгээд Уиддершинс яасан бэ Артур?

- Надаас түүнийг жорлонгийн хэрэгт яаж буруутгаж байгаа тухай асуух хэрэггүй. Юугаар будагдсанаас нь л тааварлахад хэцүү биш гэж ноён Уизли баргар хэлэв.

- Та түүнийг хамгаалж байсан уу? Зэвсэгийг үү? Хэцүү нэртийн хойноос нь хөөцөлдөж байгаа? гэж Жорж аяархан асуулаа.

- Чимээгүй, Жорж! гэж эх нь зандрав.

- Юутай ч болов энэ удаад Уиллиг хаздаг хаалганы бариул маглуудад зарах үед нь барьсан байна. Би сонингоос хоёр магл хуруугаа алдаад гэгээн Мунгогийн ослын яс ургуулалт ой ухаан өөрчлөлтийн тасагт хэвтэж байгаа тухай уншсан. Маглууд гэгээн Мунгод хэвтэж байна гэж бодоод үз дээ! Сонирхолтой юм тэд ямар өрөөнд байгаа бол? гээд ноён Уизли эргэн тойрондоо ямар нэг шинж тэмдэг харахыг хүссэн мэт харлаа.

- Харри чи Хэцүү нэртэд могой бий гэж ярьсан биз дээ? гэж Фред эцгээ ширтэн асуулаа. Аварга могой. Чи түүнийг эргэж ирсэн шөнө харсан гэсэн биз дээ?

- Хангалттай гэж хатагай Уизли хилэгнээд,

- Хурц нүдэт, Тонкс хоёр гадаа хүлээж байгаа, Артур. Чамтай уулзахыг хүсэж байгаа юм. Харин хүүхдүүдээ та нар гадаа хүлээж бай. Дараа нь салах ёс гүйцэтгээрэй. Алив гэлээ.

Тэд хонгилд гарлаа. Хурц нүдэт, Тонкс хоёр өрөөнд орж хаалга хаав.

- Сайн байна. Бидэнд юу ч хэлэхгүй байж болно гэж Фред хөмсгөө өргөн хэлээд халаасаа ухлаа.

- Үүнийг хайж байна уу? гээд Жорж орооцолдсон биений өнгөтэй оосор гаргав.

- Чи миний бодлыг уншчихлаа. Гэгээн Мунгогийн хаалгыг Хурч болшгүй шидээр шившсэн эсэхийг харцгаая гэж Фред инээмсэглэв.

Тэр хоёр утасны орооцолдоог гаргаад таван ширхэг Уртасгагч чих хүн бүрт өгөв. Харри нэгийг авах эсэхдээ эргэлзлээ.

- Алив ээ, Харри ав. Чи аавын амийг аварсан. Чи хэнээс ч илүү яриаг сонсох

эрхтэй.

Харри түгшингүй инээмсэглээд оосрыг авч чихэндээ наалаа.

- Алив хөдлөөрэй! гэж Фред шивнэлээ.

Биений өнгөтэй урт оосор хаалганы доогуур могой шиг мушгиралдан орлоо. Эхлээд Харри юу ч сонссонгүй ч гэнэтхэн Тонкс хажууд нь байгаа юм шиг шивнэсэнд цочлоо.

- Эргэн тойрны бүх газар могойг хайсан ч олоогүй. Чамайг дайрсны дараа алга болсон бололтой, Артур. Гэхдээ Хэцүү нэрт могойг дотогш нь оруулах гэж бодоогүй байх?

- Би түүнийг тагнуул хийлгэхийн тулд илгээсэн байх гэж бодож байна. Үүнд гайхах явдалгүй биз дээ. Үгүй ээ, түүнийг байдал ямар байгаа тухай төсөөлөл авахыг хүссэн байх гэж бодож байна. Хэрвээ Артур байгаагүй бол энэ жигшүүртэй амьтан харж амжих байсан биз. Тэгэхээр Поттер болсон явдлыг харсан гэж хэлсэн үү? гэж Грюм хэлэв.

- Тиймээ. Дамблдор Харигаас бараг л иймэрхүү зүйл хүлээж байсан гэж ноён Уизли тавгүйцэн дуугарлаа.

- Энэ хүүд нэг л хачирхалтай юм байгааг бид мэднэ.

- Би өглөө Дамлдортой ярихад Харригаас түгшиж байх шиг санагдсан гэж хатагтай Уизли шивнэлээ.

- Түгшихгүй яана гэж. Хэцүү нэртийн могойн нүдээр харна гэдэг бага юм биш.

Тэр өөрөө юу болохыг ойлгохгүй байгаа ч хэрвээ Хэцүү нэрт түүнийг эзэмдэж байвал ...

Харри Уртасгагч чихээ угз татахад зүрх нь галзуурсан юм шиг цохилж нүүр лүү нь цус хөөрлөө. Тэр хүүхдүүд рүү харлаа. Бүгд түүний нүдэнд нь айдас хурсан байхыг харжээ.

БҮЛЭГ 23: ТУСГААРЛАГДСАН ЗУЛ САР

Ийм учраас л Дамблдор түүний нүд рүү харахгүй байсан байх нь! Түүний нүдэнд Волдеморт харагдахаас айсан юмуу эсвэл ногоон өнгө нь улаан болон хувирч муурынх шиг нарийсна гэж бодсон хэрэг үү? Харри Волдемортын могойн нүүртэй адилхан царай профессор Квиреллийн шилэн хүзүүнээс цухуйж байсныг санаад алгаараа шилэн хүзүүгээ илэн толгой байна уу үгүй юу гэдгийг шалгаж үзэв.

Тэр одоо галт тэргэнд үхлийн аюултай нян тээж яваа юм шиг бохир завааныг мэдэрч гэм зэмгүй цэвэр хүмүүс рүү Волдемортын халдвар тарааж байгаа юм шиг санагдана

... Тэр зөвхөн могойг хараагүй, тэр могой байсан, одоо үүнийгээ мэдлээ.

Аймшигтай бодол түүний толгойд орж ирэхэд дотор нь могой мушгиралдах шиг болов.

Түүнд дагалдагчидаас нь гадна өөр юу хэрэгтэй юм?

Тэр зөвхөн нууцаар эзэмдэж чадна ... ямар нэг зэвсэг шиг. Түүнд өнгөрсөн удаад байсан.

Би энэ зэвсэг гэж Харри бодтол хор түүний судсаар тарж галт тэрэг харанхуй хонгилд ороход хүйтэн хөлс нь цутгалаа. Волдеморт намайг ашиглахыг хүсч байгаа болохоор хааш нь ч явуулахгүйн тулд хамгаалалт гаргасан байх нь. Энэ надаас бусад хүмүүсийг хамгаалахад тусалсангүй тэд намайг Хогвартсад барьж чадсангүй. Би тэр шөнө ноён Уизлиг дайрсан. Волдеморт намайг эзэмдсэн болохоор магадгүй дотор суугаад бодлыг минь сонсож байгаа биз.

- Харри хонгор минь чи зүгээр үү? Тааруу харагдаж байх чинь. Өвдөөгүй биз дээ? гэж хатагтай Уизли галт тэрэг харанхуй хонгил дундуур түжигнэн өнгөрөхөд Жиннигийн хажуугаар шивнэн асуулаа.

Бүгд түүн рүү харав. Тэр уурсан толгойгоо сэгсрээд даатгалын сурталчилгаа руу харахыг хичээлээ.

- Харри чи үнэхээр өвдөөгүй биз дээ? гэж тэр Гримогийн байшингийн өмнөх зүлэгтэй талбайд хүрэхэд халамжлангуй асуугаад,

- Бүр цонхийчихож ... өглөө унтсан уу? Одоо явж унт оройн хоолон дээр дуудъя гэв.

Тэр толгой дохиод бусадтай ярихыг хүсэхгүй байсан болохоор аятайхан шалтаг гэж

бодлоо. Ийм учраас үүдний хаалга нээгдэхэд савдагийн хөлний хэмжээтэй шүхрийн хажуугаар түргэн өнгөрч шатаар өгсөн унтлагын өрөөндөө орлоо.

Тэр хоёр орны дундуур болон Финеас Найжелусын хоосон зургийн дэргэдүүр холхихдоо ахин дахин асуулт тавьж аймшигтай зүйл төсөөлөн бодож байлаа.

Тэр яаж могой болсон юм бол? Тэр анимаг юм болов уу? ... үгүй ээ, мэдэх байсан ... Магадгүй Волдеморт анимаг юм болов уу? Тиймээ энэ үнэн байж болох юм.

Волдеморт могой болон хувирдаг байж болох юм ... Тэр намайг эзмдэх үед бид хоёулаа хувирдаг ... Гэхдээ ямар аргаар Лондон хүрээд орондоо таван хормын дотор ирсэн юм бол гэдийг тайлбарлаж боломгүй байлаа ... Гэхдээ Волдеморт Дамблдорын дараа орох хүчтэй шидтэн болохоор хүмүүсийг ингэж тээвэрлэх нь ямар ч асуудалгүй биз.

Тэр айдаст автахад галзуурсан мэт бодол төрөв. Волан-де-Морт намайг эзэмдэж байгаа бол надаар дамжуулан Фениксийн бүлгийн байрыг харж байгаа биш үү! Яг энэ агшинд! Тэр бүлэгт Сириусаас гадна хэн байгааг мэдэх болохоор ... Сириусын анхны өдөр ярьсан зүйлийг ... бүгдийг нь сонссон.

Зөвхөн ганц гарц байлаа. Даруйхан Гриммогийн байшинг орхих. Тэр Хогвартст зул сарыг бусдад аюул заналхийлэхгүйгээр өнгөрүүлж ... үгүй ээ үгүй болохгүй тэнд хүмүүс байгаа. Хэрвээ тэр алвал яах вэ. Хэрвээ дараагийнх нь Симус, Дин юм уу эсвэл Невилл байвал яана. Тэр Финеас Найжелусын хоосон хөргийн өмнө зогслоо. Бүх бие нь хүйт даажээ. Сонголт байхгүй Улаан модон гудамжинд эргэн очиж өөрийгөө бусад шидтэнгүүдээс тусгаарлах хэрэгтэй.

Тэгэхээр тэр үүнийг хийх ёстой. Тэгээд Дурслийнхан түүнийг зургаан сарын урд босгон дээр нь байхыг харвал яах талаар бодохгүйг хичээн чемоданаа хаагаад түгжиж зөнгөөрөө Хэдвигийг хайснаа Хогвартс байгаа гэдгийг саналаа. Нэг ч гэсэн зүйл торонд түгжигдэхгүй юм байна гэж бодоод чемоданаа авч үүд рүү явлаа. Замын хагаст түүнийг егөөдсөн хоолой зогсоолоо.

- Зугтах гэж байна уу?

Тэр эргэж харав. Финеас Найжелус ахин хөргөндөө эргэж ирээд шоолонгуй бөхийн харж байв.

- Зугтахгүй гэж Харри хэлээд чемоданаа чирэн хоёр алхам алхлаа.

- Би Гриффиндорт зоригтой хүмүүсийг авдаг гэж бодсон юмсан! гэж тэр урт

шовгор сахлаа илбэн хэлээд,

- Чи ухаантай болохоор миний тэнхимд тохирох байж. Слизеринчүүд бид зоригтой хэдий ч тэнэг биш. Бид заримдаа сонголт хийж өөрсдийнхөө амийг авардаг гэв.

- Би өөрийнхөө амьдралыг авраагүй гэж Харри эсэргүүцээд цагаан эрвээхэйд идэгдсэн хивсэн дээгүүр чемоданаа чирэн хаалганы өмнө аваачлаа.

- Аан ойлгож байна. Энэ бол аймхай зугталт биш чи уужим сэтгэлтэй байхыг хүсчээ гэж Финеас Найжелус сахлаа илбэсэн хэвээр хэлэв.

Харри хариулахыг хүсээгүй тул хаалганы бариулаас барьтал Финеас Найжелус залхуутайгаар,

- Надад Альбус Дамблдороос илгээсэн мэдээлэл байна гэв. Харри эргэн харлаа.

- Ямар?

- Байрандаа үлд.

- Би зогсож л байна шүү дээ! Ямар илгээмж юм? гэж Харри бариулаас барьсан чигээрээ асуулаа.

- Би сая дамжууллаа, тэнэг минь. Дамблдор байрандаа үлд гэж хэлсэн.

- Яагаад? Тэр яагаад намайг үлдэхийг хүссэн юм бол? Өөр юм хэлсэн үү? гэж

Харри чемоданаа тавиад асуулаа.

- Өөр юу ч хэлээгүй гэж Финеас Найжелус Харриг эрээ цээргүй гэж бодсон аятай хэлээд нарийхан хөмсгөө хөдөлгөв.

Харрийн уур хилэн өндөр өвсөнд орсон могой адил хүрлээ. Тэр зовж зүдрэн сэтгэлээр унаж айдаст автан арван хоёр цаг өнгөрүүлсэн байхад Дамблдор түүнд юу ч хэлэхийг хүсэхгүй байдаг!

- Энэ чинь юу гэж байгаа юм? Байрандаа үлд гэдэг чинь! Намайг Дементорууд дайрсны дараа бас ингэж хэлж байсан! Чимээгүй суу, Харри насанд хүрэгчид чамгүй учрыг нь олчихно! Чамд тайлбарлаж болохгүйн учир нь жижигхэн тархи чинь үүнийг ойлгохгүйд байгаад юм!

- Мэдэж байна уу ийм л учраас би багшийн ажлыг үзэн яддаг юм! Залуу хүн

бүгдэд өөрийн зөв гэдэгт итгэлтэй байдаг. Чиний толгойд хөөрхий их зантай Хогвартсын захирал чамд төлөвлөгөөнийхөө нарийн ширийн бүрийг хэлэх шалтгаан байгаа гэж бодоо юу? Чи гомдолдоо автан Дамблдорын тушаал хэзээ ч чамайг аюул рүү хөтлөхгүй гэж бодоо юу? Үгүй дээ, үгүй. Та нар шиг залуу хүмүүс ганцаараа байхдаа аюул ослыг мэдрэн илүү итгэлтэй болдог юм, чи ганцаараа л Хар лордын ухаанд нэвтэрч юу төлөвлөж байгааг мэдэж чадна

...

- Тэгэхээр тэр намайг ашиглахаар төлөвлөж байгаа юм биз дээ? гэж Харри түргэн асуулаа.

- Би ингэж хэлсэн гэж үү? хэмээн Финеас Найжелус асуултыг асуултаар хариулаад торгон бээлийгээ ширтэн,

- Харин одоо уучлаарай, намайг өсвөр насны хүүгийн гомдлыг сонсохоос илүү чухал ажил хүлээж байна ... өдрийг сайхан өнгөрүүлээрэй гэв.

Тэр хөргийн зах руу явлаа.

- Сайн байна яв л даа! Дамблдор миний талархалыг дамжуулаарай! гэж Харри хоосон жааз руу орилов.

Хөрөг чимээгүй болов. Сэтгэлээр унасан Харри чемданаа буцааж орны дэргэд тавиад доош харан суулаа.

Тэр нүдээ анихад бүх бие нь хүндрэн цуцлаа. Яг л нэг зуугаад миль явган явчихсан юм шиг мэдрэмж төрж байна ... Хорин дөрвөн цагийн өмнө Чжоу Чангтай цагаан боронзны дор зогсож байсан гэхэд ямар итгэмээргүй юм бэ ... тэр их ядарч ... тэр унтахаас айж байна ... хэр удаан зүүдтэйгээ тэмцэж чадахаа ч мэдэхгүй байна ...

Дамблдор түүнийг үлд гэж хэлсэн ... Магадгүй унтаж болох ч ... аймшигтай юм ... ахиад нөгөө зүүдээ зүүдлэвэл яана?

Тэр харанхуйд живлээ.

Толгойд нь дүр зураг киноны хальс шиг эргэлдэв. Тэр хар хаалгатай хоосон хонгилоор явж бамбарын гэрэлтэй чулуун ханыг өнгөрөөд хаалганы дэргэдүүр явж чулуун шатаар доош уруудан зүүн тийш эргээд ...

Тэр хар хаалга руу очсон ч онгойлгож чадсангүй ... Зогсоод түүн рүү цөхрөн харж ... түүний цаана хамгийн ихээр хүсэж байгаа юм нь байна ... зүүдэнд ч оромгүй шагнал

... хэрвээ зөвхөн сорви нь хатгуулахаа больдог бол ... тэр тодорхой төсөөлж ...

- Харри гэх Роны хоолой алсад сонсогдон, Ээж оройн хоол бэлэн болсон гэж хэлсэн гэхдээ чи босохыг хүсэхгүй байгаа бол үлдээ гэж байна гэв.

Харри нүдээ нээхэд Рон өрөөнд байхгүй байлаа.

«Тэр надтай ганцаар үлдэхийг хүсэхгүй байна. Грюмын хэлсэн үгийг сонссоны дараа» гэж Харри бодлоо.

Тиймээ энэ байшинд хэн ч түүнийг тэвчихийг хүсэхгүй байна.

Тэр хооллохоор явсангүй. Нөгөө талаараа эргэн хэвтээд ахин унтлаа. Удаан унтаж өглөө эрт хоосон ходоод нь хонхолзоход сэрэв. Нөгөө талын орон дээр Рон хурхирч байлаа. Харри нүдээ нээнгүүт Финеас Найжелусын хар дүрс хөргөндөө зогсож байхыг харлаа. Бодвол Дамблдор түүнийг хэн нэгнийг дайрч магадгүй гэж илгээсэн байх.

Бохир завааныг мэдрэх нь улам хүчтэй болов. Тэр Дамблдорын үгэнд орсондоо харамсахад бэлэн байв. Хэрвээ ийм амьдрал түүнийг Гриммогийн байшинд хүлээж байгаа бол магадгүй Улаан модон гудамж руу буцсан нь дээр байх.

Өглөө бүгд зул сарын гоёл чимэглэл зүүж өнгөрүүлэв. Харри Сириусын хэзээ ч тийм сайхан ааштай байхыг харж байсангүй. Тэр зул сарын сүлд дуулал дуулж зул сарыг ганцаараа биш олноороо өнгөрүүлэх болсондоо өгүүлэшгүй баяртай байв. Түүний хоолой цонхны цаана будрах цас ширтэн суусан Харрид зочны өрөөний хүйтэн шал нэвтлэн сонсогдоход бусад нь түүний тухай ярих биш завгүй байгаад уурсан баярлаж суув. Өдрийн хоолон дээр хатагтай Уизли түүнийг шатны дороос аяархан дуудсан ч тоолгүй улам дээш өгсөв.

Ойролцоогоор зургаан цагт хаалганы хонх дуугарч хатагтай Блэк ахин орилов. Наземникус юмуу бүлгийн хэн нэгэн гишүүн ирсэн бололтой. Харри Клювокрылын өрөөний хананы дэргэд гиппогрифын өмхий хархан дунд нуугдан суугаад өлсгөлөнгөө мартахыг хичээж байв. Тэгтэл өрөөний хаалга хаалга хүчтэй цохиход тэр гайхлаа.

- Би чамайг энд байгаа гэдгийг чинь мэдэж байна. Гараад ир. Чамтай яримаар байна гэх Гермionaгийн хоолой сонсогдов.

- Чи энд юу хийж байгаа юм бэ? Би чамайг ээж аавтайгаа цанаар гулгаж байгаа гэж бодсон юмсан гээд Харри хаалга онгойлгоход Клювокрыл сүрэлтэй шал дээгүүр

хархны яс эрэн тэмтчив.

- Үнэнийг хэлэхэд би цанаар гулгах дуртай биш. Би эндхийн зул сарын баярт ирсэн юм гээд түүний үс цас болж царай нь хүйтэнд улайжээ.

- Гэхдээ Ронд битгий хэлээрэй. Би түүнд маш сайхан гэж хэлсэн болохоор тэр намайг шоолох болно. Ээж аав хоёр намайг шалгалт ойртсон болохоор Хогвартст үлдэнэ гэхэд жаахан гомдсон. Гэхдээ тэд намайг ойлгосон. Товчхондоо гэвэл чиний унтлагын өрөө рүү явъя. Роны ээж хачиртай талх явуулсан.

Харри түүний араас даган хоёр давхар руу явлаа. Түүний гайхлыг төрүүлэн унтлагын өрөөнд Рон, Жинни хоёр орон дээр сууж байлаа.

- Би «Шөнийн хүлэг баатар» автобусаар ирсэн гэж Гермiona хэлээд хүрмээ тайлангаа, Дамблдор надад өчигдөр юу болсныг хэлээд хичээл албан ёсоор дуусахыг хүлээх хэрэгтэй гэсэн. Амбриж та нарыг хамар дороос нь алга болсонд үхтэлээ уурласан шүү. Дамблдор түүнд ноён Уизли гэгээн Мунгогийн эмнэлэгт хэвтсэн болохоор та нарт зөвшөөрөл өгсөн гэсэн.

Тэр Жиннигийн дэргэд суугаад гурвуулаа Харри руу харлаа.

- Чи ямаршуу байна даа? гэж Гермiona асуулаа.

- Маш сайн гэж Харри хөндий өгүүлэв.

- Битгий худал хэл, Харри. Рон, Жинни хоёр чамайг эмнэлэгээс ирснээс хойш үргэлж нуугдаж байгаа гэсэн.

- Тэгсэн гэж үү? хэмээн Харри ах дүү хоёр руу ууртай харав. Рон гутал руугаа ширтсэн бол, Жинни өчүүхэн төдий ч ичсэнгүй.

- Тиймээ нуугдсан! Тэгээд бидний хэнийг ч харахыг хүсэхгүй байгаа!

- Харин та нар л намайг харахыг хүсэхгүй байгаа! гэж Харри ууртай хэлэв.

- Магадгүй та нар бие биеэ ээлжлэн харвал дээр юм биш үү? гэж Гермiona санал болголоо.

- Маш ухаалаг байна гээд Харри өөр тийшээ харав.

- Буруу ойлгохоо боль л доо. Тэд надад өчигдөр чиний Уртасгагч чихээр сонссон зүйлийг хэлсэн.

- Тэгээд? Бүгд миний тухай ярилцаа юу? Зүгээр дээ би дасчихсан гээд Харри

гараа халаасандаа хийн цонхоор харлаа.

- Бид чамтай ярихыг хүссэн ч чи үргэлж нуугдаад байсан гэж Жинни хэлэв.
- Харин би хэн ч надтай ярихыг хүсэхгүй байна гэж Харри уурсан хэллээ.
- Гэхдээ энэ чинь тэнэг хэрэг шүү дээ. Чи Хэцүү нэрт хэн нэгнийг эзэмдэх ямар байдгийг мэдэхгүй. Харин би чамд хэлж чадна гэж Жинни хэллээ.

Харри агшин зуур хөшсөнөө мэгдэн сонсов.

- Би мартчихаж.
- Баяр хүргэе гэж Жинни хүйтнээр хэлэв.
- Уучлаарай. Тэгэхээр ... чи намайг эзэмдсэн гэж бодож байна уу? гэж Харри хэлээд ичихээ мэдэрлээ.
- Чи хийсэн зүйл бүрээ санаж байгаа юу? Эсвэл юу хийснээ мэдэхгүй байсан удаа байна уу?

Харри санахыг оролдов.

- Үгүй.
- Тэгвэл Хэцүү нэрт чамайг эзэмдээгүй. Надад энэ тохиолдох үед би цагийг юу хийж өнгөрүүлсэн болон хаана байснаа ч санадаггүй байсан.

Харри түүнд итгэхээс айсан ч сэтгэл санаа нь дээрдлээ.

- Тэгвэл чиний аав болон могойтой зүүдийг яах болж байна?
- Харри чи урьд нь ийм зүүд зүүдэлдэг л байсан биз дээ. Чи өнгөрсөн жил заримдаа Волдемортын бодлыг мэдэрдэг байсан хэмээн Гермiona өгүүлэв.

Харри толгой сэгсэрлээ.

- Энэ удаад тийм биш. Би могой дотор байсан. Яг л өөрөө могой юм шиг ...

Хэрвээ гэнэтхэн Волдеморт намайг Лондон руу авчирсан бол яах вэ?

- Харри чи хэзээ нэгэн цагт «Хогвартсын түүх»-ийг уншиж байсан бол Хогвартсын нутаг дэвсгэрт шилжиж болохгүй гэдгийг мэдэх ёстой. Тэр ч байтугай Волдеморт хүртэл чамайг унтлагын өрөөнөөс гаргах хүч байхгүй гэж Гермiona бухимдангуй дуугарлаа.

- Чи ороо орхиогүй ойлгов уу? Чамайг хөлөөрөө нүдэж байхыг чинь хараад бид

сэрээсэн гэж Рон хэлэв.

Харри ахин өрөөн дундуур холхилоо. Тэдний ярьж байгаа зүйл тайвшируулмааргүй байсан ч зүйтэй сонсогдож байв. Тэр тавагтай хачиртай талхнаас аваад өлссөндөө амандаа чихлээ.

«Ямар ч гэсэн би зэвсэг биш юм байна» гэж тэр бодов. Зүрх нь баяртай цохилоход шатны дээшээ гиппогрифын өрөө рүү хөгжилтэй дуулан өгсөж байгаа Сириустэй нэгдэхэд бэлэн байлаа.

Түүнд зул сараар Улаан модон гудамж руу явах хэрэг гарсангүй. Сириус гэрээ зочдоор дүүрэн байгаад баяртай байлаа. Тэр зуных шигээ баргар зочломтгой бус байхаа больж эцэж цуцалтгүй гэрээ цэвэрлэж чимэглэхэд туслан байшин танигдахын аргагүй боллоо. Өнгөө алдсан бүрхүүлийг тойроод аалзны шүлсийн оронд алт мөнгөн туузтай цэцгийн хэлхээ өлгөгдөн, сэмэрсэн хуучин хивсэн дээгүүр шидэт цас орж, Сириусын гэр бүлийн модны зургийг хааж тавьсан зул сарын гацуурыг Наземникусын авчирсан жинхэнэ шидэт дагинасаар чимэглэсэн бөгөөд үйлчлэгчийн хатсан толгойг өвлийн өвгөнтэй адил улаан малгай өмсгөн цагаан сахал зүүгээд өлгөжээ.

Харри зул сарын баярын өглөө сэрээд овоолттой бэлгээ олж харав. Рон хэдийн өөрийнхийгөө задалж байлаа.

- Энэ жил сайхан олзтой байна. Гермионад шүүрний луужин өгсөн явдалд баярлалаа. Түүний гэрийн даалгавар төлөвлөгчийг харсан уу? гэж тэр хэлэв.

Харри өөрийнхийгөө бас задлан Гермионагийн бэлгийг олов. Тэр түүнд өдрийн тэмдэглэлтэй адилхан зүйл өгсөн агаад дурын хуудсыг нээхэд «Маргааш, маргааш өнөөдөр биш гэж залхуучууд хэлдэг юм!» гэж чанга хэлэх аж.

Сириус, Люпин хоёр түүнд «Хамгаалалтын ид шидийн дадлага болон түүнийг ашиглан хар урлагийн эсрэг тэмцэх нь» гэдэг цуврал ном бэлэглэсэн бөгөөд эсрэг шидийг яаж хэрэглэх тухай өнгөт зургаар дүрслэн үзүүлжээ. Харри эхний ботийн хуудсыг сониучирхон нээгээд ДА-гийн хичээлд маш чухал зүйл олж харав. Хагрид түүнд хулгайчийн эсрэг бололтой үслэг бор өнгийн шүдтэй хэтэвч бэлэглэсэн ч Харри мөнгөө тийшээ хийхдээ хуруугаа хазуулна гэж сэрэмжиллээ. Тонкс түүнд жижигхэн «Аянга»-ын загвар бэлэглэсэн нь өрөөн дотуур нисч том загвар нь байхгүйд харамсахад хүргэв. Рон түүнд том хайрцагтай янз бүрийн амттай Беррти

Боттс үрэл өгч, ноён ба хатагтай Уизли ердийнхөөрөө гэр бүлийн нэхсэн цамц болон үзэмтэй, самартай бялуу бэлэглэн харин Доббигоос өөрөө л зурсан бололтой аймшигтай зураг иржээ. Тэр түүнийг сайн харахын тулд эргүүлтэл чанга тасхийх чимээ гараад орны хөлд Фред, Жорж хоёр шилжин гарч ирэв.

- Зул сарын мэнд. Доошоо битгий буугаарай гэж Жорж хэлэв.
- Яагаад? гэж Рон асуулаа.
- Ээж ахиад уйлж байна. Перси түүний зул сарын цамцыг буцаажээ гэж Фред хэлэв.
- Зурвас ч үгүй. Эцгийнхээ бие ямар байгаа тухай ч асуулгүй гэж Жорж нэмэрлэв.
- Бид түүнийг тайвшируулахыг оролдсон. Түүнд Перси хархын том бааснаас өөр юу ч хүртэх гавъяагүй гэж тайлбарласан гэж Фред хэлээд Харрийн зургийг үзэхээр ор луу нь явлаа.
- Гэхдээ энэ тус болоогүй л дээ. Одоо Люпин биднийг орлож байгаа. Түүнийг уйлж дуустал өглөөний цайгаа уухаа хүлээх болох нь гэж Жорж хэлээд шоколадан мэлхий авлаа.
- Энэ чинь одоо юу вэ? гэж Фред хэлээд Доббийн зураг руу анивчин харав.
- Энэ Харри байна! Өөрөөр хэлж боломгүй юм гээд Жорж хуруугаараа заав.
- Адилхан л юм гэж Фред инээд алдахад Харри түүн рүү гэрийн даалгавар төлөвлөгчөө шидлээ. Тэр хана мөргөн шалан дээр унаад баяртайгаар «Ажлаа дуусгаад зоригтойгоор зугаал!» гэж хашгирав.

Рон, Харри хоёр хувцаслав. Бүгд бие биедээ зул сарын баярын мэнд гэж баяр хүргэх нь сонсогдож байлаа. Тэд босгон дээр Гермионатай тааралдав.

- Номонд чинь баярлалаа, Харри. Зуун жил «Шидэт тооны ухааны шинэ онол» гэсэн номтой болохыг хүсч байлаа. Харин чиний сүрчиг ер бусын байсан шүү, Рон.
- Дэмий юм. Энэ хэнийх вэ? гээд Рон түүний гарт байгаа бэлэг рүү дохив.
- Кикимерийнх.
- Энэ хувцас байж болохгүй! Чи Сириусын Кикимер хэтэрхий олон зүйл мэдэх болохоор чөлөөлж болохгүй гэж хэлснийг мэднэ биз дээ!

- Энэ бол хувцас биш. Минийхээр болдогсон бол бохир алчуурынх нь оронд өөр юм өгмөөр байна. Энэ бол зүйдэлтэй хөнжил түүний унтлагын өрөөг арай дээрдүүлэх байх гэж бодоод.

- Ямар унтлагын өрөө? гэж Харри Сириусын эхийн хөргийн дэргэдүүр өнгөрөхдөө дуугаа намсган хэлэв.

- Сириус унтлагын өрөө биш нүх гэсэн. Тэр гал зуухны уурын тогооны дор пинд унтдаг юм гэж Гермiona хэлэв.

Тэднийг доошоо уруудахад хатагтай Уизлигаас өөр хэн ч байсангүй. Тэр зуухны өмнө зогсоод нулимстай нүдээр бүгдэд нь зул сарын баярын мэнд хүсэхэд нүд буруулан өнгөрлөө.

- Тэгэхээр энэ Кикимерийн унтлагын өрөө юм биз дээ? гэж Рон хэлээд зоорины эсрэг талын булангийн бохир хаалга руу харлаа. Харри түүний онгорхой байхыг хэзээ ч харж байсангүй.

- Тиймээ. Цохьсон нь дээр байх гэж Гермiona итгэлгүйхэн хэлэв. Рон хаалгыг цохьсон ч хариу дуугарсангүй.

- Дээр хаа нэгтээ байгаа биз гэж Рон хэлээд үүдийг онгойлгон. Түй! гэв.

Харри пин рүү шагайлаа. Түүний ихэнх зайг хуучин том уурын тогоо эзэлж доогуур нь хоолойнууд явсан нь Кикимер үүрэнд байгаа юм шиг ажээ. Шалан дээгүүр янз бүрийн эмх замбараагүй алчуур болон хачин үнэртэй хөнжил хөглөрөлдөн дунд нь Кикимерийн шөнө бүр унтдаг жижигхэн хонхорхой байлаа. Энд бас хатсан талх хөгцтэй зүсэм бяслаг байлаа. Буланд зоостой төстэй жижиг зүйлс гялалзаж байсныг Харри Сириусын их цэвэрлэгээнээс аврагдсан зүйл болохыг ойлгов. Тэр бас Сириусын зун гарган хаясан мөнгөн жаазтай гэр бүлийн зургийг цуглуулжээ. Хагарсан шилний цаана байгаа жижигхэн хар цагаан хүн Харри руу ихэрхүү харахад Дамблдорын гүн ухааны цүнхээлд харсан хар үстэй хүнд зовхитой эмэгтэй болох Беллатрис Лестрейнжийн зургийг таниад дотор нь палхийв. Тэр харваас Кикимерийн дуртай зураг бололтой хагарсан шилийг нь шидэт наалдамхай хальсаар наажээ.

- Бэлгээ энд орхисон нь дээр байх. Тэр дараа нь олно биз гээд Гермiona хайрцгаа алчуур болон хөнжлийн хонхор дээр нямбай тавилаа.

- Хэн нэгэн сүүлийн үед Кикимерийг харсан уу? гэж зоориноос том цацагт хяруул гаргаж ирсэн Сириус асуулаа.

- Би түүнийг энд ирсэн шөнөөсөө хойш харсангүй. Чи түүнийг гал зуухнаас хөөж гаргасан биз дээ гэж Харри хэлэв.

Сириус хөмсөг зангидав.

- Тийм л дээ. Минийхээр бол би ч гэсэн тэр үеэс хойш хараагүй байна ... Дээр хаа нэгтээ нуугдаж байгаа биз.

- Тэр эндээс явж чадах уу? Чи зайл гэж хэлснийг гэрээс яв гэж ойлгосон байж болно шүү дээ.

- Үгүй дээ, үгүй гэрийн үйлчлэгч нар явж хувцас өгөхөөс наана явж чадахгүй.

Тэд гэр бүлийн байшинтай холбоотой байдаг юм.

- Хэрвээ их хүсвэл чадна. Хоёр жилийн өмнө Добби надад анхааруулахын тулд Малфойн гэрээс ирж байсан. Үүний дараа өөрийгөө шийтгэдэг юм гэж Харри үгүйсгэв.

Сириусын царайд мэгдсэн өнгө тодорсон ч,

- За яахав дараа түүнийг эрж хольё. Дээр хаа нэгтээ суугаад миний ээжийн хөгжин цэцэглэж байсан үеийн тухай ярин уйлж байгаа биз. Шүүгээнд нь агаар оруулахгүй бол бүтэж үхчихгүй гэж найдъя гэв.

Фред, Жорж, Рон нар инээлдэхэд Гермiona зэвүүцэнгүй харав.

Уизлийн гэр бүл болон Харри, Гермiona нар зул сарын өдрийн зоогоо бариад ноён Уизли дээр Люпин, Хурц нүдэт хоёроор хамгаалуулан айлчилахыг төлөвлөжээ. Зул сарын бялуугаа идэж дуусгах үед Наземникус цахилгаан галт тэрэг ажиллахгүй учир зээлсэн машинтайгаа хүрч ирэв. Харри түүнийг ажилуулах мэдлэгтэй эсэхэд эргэлзлээ. Энэ нь Уизлийн хуучин «Англи» гэдэг машин шиг Томруулах шид хэрэглэсэн бөгөөд гаднаасаа жирийн харагдах ч дотроо бол жолооч Наземникусыг оролцуулаад арван хүн тухтай явж болохоор байлаа. Хатагтай Уизли дотогш орохын өмнө удтал эргэлзэн зогсоход Харри Наземникус түүний шидгүй аялалын эсрэг тэмцэж байгаад дургүйцсэн болохыг мэдэж байв. Эцсийн эцэст гадаа хүйтэн байсан болохоор хүүхдүүдийнхээ гуйлтаар Фред, Билл хоёрын дунд суулаа.

Гэгээн Мунгогийн эмнэлэг рүү явах аялал түргэн болов. Гудамжинд замын хөдөлгөөн бага байлаа. Хүнгүй гудамжаар эмнэлэг рүү шидтэнгүүд явж харагдана. Харри бусадтайгаа машинаас гарахад Наземникус булан тойроод тэднийг хүлээв.

Тэд ердийнхөөрөө ногоон нейлонон хувцастай хиймэл хүн рүү очин шил нэвтлэн оров.

Хүлээх авах танхим баяр ёслолын байдалтай харагдаж болор бөмбөлөгүүд алтлаг улаан өнгийн зул сарын баярын тоглоомуудыг гэрэлтүүлэн, булан бүрд шидэт цасаар хучигдсан гацуур зассан байх агаад орой дээр нь алтан од гялалзана. Өнөөдөр тийм ч их хүн байсангүй. Харри замынхаа хагаст хамрынхаа зүүн талд аяга наасан шидтэнд зам тавьж өглөө.

- Гэр бүлийн цугларалт уу? Өнөөдөр та гурав дахь нь болж байна ... Шидийн гэмтэл дөрөвдүгээр давхар гэж цайвар үст инээмсэглэн хэлэв.

Тэднийг орох үед ноён Уизли орон дээрээ суугаад өвдөг дээрээ тавьсан тавиуртай цацагт хяруулыг дуусгаж байсан бөгөөд царай нь гэмшингүй харагдана.

- Бүх зүйл хэвийн үү, Артур? гэж хатагтай Уизли тэднийг мэндчилэн бэлгээ гардуулахад асуулаа.

- Маш сайн. Чи анагаагч Сметвикийг харав уу? гэж ноён Уизли асуулаа.

- Үгүй. Яасан? гэж хатагтай Уизли сэжигтэй асуув.

- Юу ч биш гэж тэр хэлээд бэлгээ задлангаа,

- Бүгд өдрийг сайхан өнгөрүүлсэн үү? Та нарт юу бэлэглэсэн бэ? Өө, Харри энэ чинь гайхамшигтай байна гээд цахилгаан эдлэлд зориулсан халивны цуглуулгыг нээв.

Хатагтай Уизли нөхрийнхөө хариултанд сэтгэл ханасангүй. Тэр нөхрөө Харригаар гар барихаар бөхийхөд унтлагын цамцан доторх боолтыг нь харчихлаа.

- Артур гэж тэр хулганы хавханд орсон мэт тасхийн дуугараад,

- Чи үүнийгээ солих ёстой. Чи яагаад урьд өдрийнхөө боолтыг солиогүй юм бэ?

Тэд надад маргааш энэ шаардагдахгүй гэж хэлсэн гэв.

- Юу гэнээ? Аан тийм л дээ ... энэ зүгээр гэж ноён Уизли айсан байртай эхнэрийнхээ цоргисон харцан дор хий нь гарах мэт хөнжлөө цээж рүүгээ татан хэллээ.

- Тэгэхээр ... Молли сэтгэл зовох хэрэггүй дээ, Август Сепсисд нэг санаа байгаа юм ... чи мэднэ дээ нөгөө дадлагын анагаагч ... дажгүй залуу их сонирхдог юм

... маглуудын хуучин эмчлгээний аргыг ... үүнийг тэд оёх гэж нэрлэдэг юм. Молли тэд маглуудын шархыг маш сайн эмчилдэг юм.

Хатагтай Уизли хүрхэрэлттэй төстэй заналхийлсэн дуу гаргахад Люпин хүн чонын ор руу очоод цугласан хүмүүс рүү санааширсан байртай харав. Билл аяга цай уух тухай бувтнахад Фред, Жорж хоёр инээд алдан хамт гарлаа.

- Чи надад маглуудын эмийг хаанаас авсанаа хэлэх үү үгүй юу? гэж хатагтай Уизли чанга асуухдаа дагалдагчид нь зугтаж байгааг анзаарсангүй.

- Молли хонгор минь, хаанаас ч аваагүй. Энэ бол зүгээр л... зүгээр л Август бид хоёр оролдож үзэхийг ... харамсалтай нь ийм шарханд... тийм ч сайн үйлчилдэггүй юм билээ гэж ноён Уизли царайчилсан хоолойгоор хэлэв.

- Яасан гэнээ?

- Харж байгаа биз дээ ... иймэрхүү оёдол яаж үйлчилдэгийг мэдээгүй.

- Энэ чинь чи арьсаа оёхыг оролдсон юм шиг сонсогдож байна даа. Үгүй дээ, Артур тийм тэнэг зүйл битий хий гэж хатагтай Уизли ширүүн хэлэв.

- Би бас цай уулаа гэж Харри хэлээд хөл дээрээ үсрэн босов.

Гермиона, Рон, Жинни нар үүд рүү гүйх шахам хурдлав. Тэдний ард хаалга хаагдахаас урьтаж хатагтай Уизлийн,

- Энэ чинь зүгээр л санаа гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? гэж хашгирах сонсогдлоо.

- Аавын хувьд ердийн зүйл дээ. Оёх гэдэг нь яаж ... гэж Жинни хэлээд толгой сэгсрэв.

- Хэрвээ шидэт шарх биш бол тэд тусалдаг юм. Могойн хоронд ууссан бололтой. Ингэхэд цайны өрөө нь хаана байдаг юм бол? гэж Гермиона хэлэв.

- Таван давхарт гэж Харри жижүүрийн шидтэний хажуугийн зарлалыг санан хэллээ.

Тэд хонгил руу гарч хоёр хаалга өнгөрөөд яйжгий шатаар өгсөн ширүүн төрхтэй анагаагчын хөргийн дэргэдүүр явлаа. Дээшээ явах замд нь анагаагч араас нь гүйцэж хачирхалтай өвчний онош тавьж эмчилгээний арга санал болгов. Дундад зууны үеийн хувцастай анагаагч илэрхий Роныг дуудсан учир тэр ихэд доромжлогдсон төрхтэй болов.

- Юу хэлэх гэсэн? хэмээн Рон түүнийг зургаан хөрөг даган мөшгихөд тэссэнгүй асуув.
- Залуу эзэн минь арьс чинь ямар эвгүй өвчинд нэрвэгдээ вэ. Аймаар муухай толботой болж ...
- Чи хэнийг аймшигтай гэж хэлээд байгаа юм! гэж Рон хэлээд чихээ улайлгалаа.
- Цорын ганц эмчилгээ бол бахын элэг хоолойндoo сайн наагаад арван тавны сартай шөнө могой загасны нүдтэй торхонд нүцгэн зогс ...
- Үгүй дээ, надад хэрэггүй!
- Гэхдээ таны царай дээрх толбо үзлийн муухай харагдаж байна, залуу эзэн минь.
- Энэ бол сэвх! Хөрөг рүүгээ буцаж намайг тайван орхи! гэж Рон уурсан орилов.

Тэр дагалдагчид руугаа эргэлээ.

- Энэ хэдэн давхар вэ?
- Тав байх гэж Гермiona хэлэв.
- Үгүй ээ, дөрөв. Ахин нэг дээшээ гэж Харри дуугарлаа.

Тэд шатны талбай дээр огцом зогсоод хаалган дээр «ИД ШИДИЙН ГЭМТЭЛ» гэж бисчсэн хаяг өлгөснийг харав. Тэднийг үүдний цонхоор буржгар цайвар үстэй, хурц цэнхэр нүдтэй залуу хамраа шилэнд наагаад цагаан шүдээ яралзуулан инээмсэглэн харж байлаа.

- Чөтгөр гэж! хэмээн Рон энэ царайг харан дуу алдав.
- Бурхан минь. Профессор, Туг үс! гэж Гермiona дуу алдав.

Тэдний хуучин хар урлагаас хамгаалах багш хаалга түлхэн гарч ирэхдээ урт хөх ягаан халат өмссөн байлаа.

- Та нарыг мэндчилье! Миний гарын үсгийг авахыг хүсээ юу?
- Ер өөрчлөгдсөнгүй шив гэж Харри Жиннид шивнээд инээмсэглэв.
- Ээ ... таны бие ямар байна, профессор? гэж Рон буруутай өнгөөр асуулаа.

Түүний буруу ажиллагаатай саваа л профессорын ой санамжыг өөрчилж гэгээн Мунгогийн эмнэлэгт ирэхэд хүргэсэн билээ. Гэхдээ тэр үедээ Харри, Рон хоёрын ой ухааныг арчихаар завдсан болохоор Харри үүнд харамссангүй.

- Би маш сайн байна, баярлалаа! гэж Туг үс хөөрөн хэлээд халааснаасаа тогосын өдөн үзэг сэтгэл хангалуун гаргаж,

- Ингэхэд та нарт хэдэн гарын үсэг хэрэгтэй вэ? Би одоо бичиж чаддаг болсон гэв.

- Баярлалаа, бидэнд одоохондоо хэрэггүй гэж Рон хэлээд Харри руу том харахад тэрбээр,

- Профессор та хонгилоор явж болох юм уу? Өрөөндөө хэвтсэн нь дээргүй юу? гэж асуулаа.

Туг үсийн царайнаас инээмсэглэл алга боллоо. Тэр хэдэн хормын турш Харрийн царай луу ширтсэнээ,

- Бид уулзаж байсан уу? гэв.

- Тиймээ. Та биднийг Хогвартет сургаж байсан санаж байна уу?

- Сургаж байсан гэнээ? Би юу? Үнэхээр үү? гэж Туг үс сэтгэл зовнилоо. Харин одоо түүний инээмсэглэл ахин гарч ирэхдээ түгшсэн янзтай болов.

- Би та нарыг бүгдийг нь сургасан юм биз дээ? Тэгээд гарын үсэг авах юм уу?

Жижигхэн найзуудаа хэнийг ч үлдээхгүйн тулд хичнээнийг авсан ч болно! Энэ удаа хонгилийн булангийн хаалга онгойж эхийн халамжлангуй хоолой,

- Туг үсээ, дүрсгүй хүү минь чи хаашаа зугтчихав? гэлээ.

Сайхан сэтгэлтэй байрын анагаагч тэдэн рүү яаран хүрч ирээд инээмсэглэв.

- Аан, Алтан хонгиот чам дээр зочид ирээ юу! Зул сараар ямар сайхан хэрэг вэ.

Хөөрхий амьтан түүнийг хэн ч эргэж ирдэггүй яагаад энд байгаагаа ч ойлгодоггүй юм.

- Бид гарын үсэг зурж байна! гэж Туг үс хэлээд нүд гялбам инээмсэглэв.

- Тэд олныг авахыг хүссэн болохоор би татгалзаж болно гэж үү! Надад гэрэл зураг хангалттай байгаа гэж найдъя!

- Зүгээр л түүнийг сонсоорой гэж сувилагч хэлээд Алтан хонгиотын гарыг хоёр настай хүүхэд шиг энхрийлэн авлаа.

- Хэдэн жилийн өмнө тэр алдартай хүн байсан болохоор ахин гарын үсэг зурж эхлэхэд ой ухаан нь сэргэж байгаа болов уу гэж бид найдаж байгаа юм. Ийшээ явцгаах уу? Тэр өрөөндөө түгжээтэй байдаг ч намайг зул сарын бэлэг түгээх үеэр гараад ирж. Тэр аюултай биш л дээ! Гэхдээ ... гээд дуугаа намсгаснаа, Тэр өөртөө аюултай, хөөрхий амьтан ... хэн гэдгээ ч санадаггүй юм ... та нар түүнийг эргэхээр ирсэн чинь ямар сайхан хэрэг вэ гэлээ.

- Ээ ... Бид үнэндээ гэж хэлээд Рон адар руу заав.

Гэхдээ сувилагч Роны «цай уухаар явж байсан юм» гэж сулхан бувтнасан үгийн хариуд инээмсэглэв. Тэд бие биенээ дэмий л хараад анагаагчын хамт явж байгаа Туг үсийн араас дагалаа.

- Удахгүй шүү гэж Рон шивнэв.

Анагаагч шидэт саваагаа Янус Тикигийн өрөө рүү чиглүүлээд,

- Алохомора гэв.

Хаалга савлан нээгдэхэд Алтан хонгиотыг өрөө рүү авч орны хажуугийн сандал дээр суулгав.

- Энд удаан хугацааны өвчтөнгүүд байдаг юм гэж тэр хүүхдүүдэд аяархан хэлээд,

- Шившлэгийн гэмтэл засал авдаггүйг мэднэ дээ. Мэдээж эрчимтэй эмчилгээний уусмалын тусламжтай бид зарим нэг сайжрилд хүрээд байгаа. Алтан хонгиот сайжирч байгаа ч бид ноён Будыг буцааж жирийн хэл ярианд нь оруулахад хүндхэн байна. Тэр бидний мэдэхгүй хэлээр яриад байгаа л даа. Намайг зул сарын баярын бэлгээ өгч дуусгатал та нар жаахан ярилцаж байгаарай гэв.

Харри эргэн тойрноо харлаа. Өрөө эргэлзээгүй өвчтөнгүүдийн байнгын гэр болжээ. Энд ноён Уизлийн өрөөг бодвол хувийн зүйл ихтэй бөгөөд хананд Туг үсийн зурагт хуудсууд наасан нь нүд гялбам инээмсэглэж даллах аж. Тэдний олонхи нь хүүхдийн бичгийн хэвээр өөртөө гарын үсэг зурж байв. Анагаагчыг суудлаасаа босмогц Туг үс багц гэрэл зураг аваад тэдэнд зориулан гарын үсэг зурж эхэллээ.

- Тэднийг дугтуйд хий гэж Жиннид зөвлөөд өвдөг дээрээ ар араас нь зурах

зуураа,

- Би шүтэн бишрэгчидээсээ захиа авдаг байсныг санаж байна ... Глэдис Гажен надад долоо хоног бүр бичдэг байлаа ... яагаад гэдгийг нь мэдэхгүй ч хэмээн хөнгөхөн бодолхийлснээ ахин баясан инээмсэглэж эрчтэйгээр гарын үсгээ зурангаа, Харваас миний сайхан гадаад төрхөнд бололтой гэлээ.

Эсрэг талд нь хэвтэж байгаа зүдэнги гашуудалтай царайтай шидтэн адар өөд ширтэн бувтнаж эргэн тойрны хүмүүсийг анзаарахгүй байх аж. Холгүй орших орон дээр хэвтэж байсан эмэгтэйн нүүр үсээр бүрхэгджээ. Харри хоёрдугаар дамжаанд байх үед Гермionado ийм золгүй явдал тохиолдсоныг санасан ч аз болоход энэ нь цаг хугацааны хэрэг байсан билээ. Өрөөний буланд цэцэгтэй хөшиг хөндлөн татсан хоёр ор байгаагаас үзэхэд эргэлтээр ирсэн хүн бусдын нүднээс далд суудаг бололтой.

- Харин үүнийг чамд, Агнес гэж анагаагч хөгжилтэй хэлээд үстэй нүүртэй эмэгтэйд зул сарын бэлэг өгөв.

- Чамайг мартаагүйг харж байна уу? Хүү чинь ууль илгээж өнөө шөнө ирнэ гэж хэлүүлсэн. Таатай байгаа биз дээ?

Агнес хэдэн удаа удаа чанга хуцлаа.

- Харин үүнийг чамд, Бродерик. Сар бүр дээрээ янз бүрийн гиппогрифын хөгжилтэй зурагтай сайхан хуанли байна. Хөгжилтэй байгаа биз?

Анагаагч бувтнаж байгаа хүний орны дэргэдэх шүүгээн дээр хуанлиг тавин холдоход зэвүүн муухай ургамал хуанли руу тэмтрүүлээ сунгалаа.

- Өө, хатагтай Долгопупс та явах гэж байна уу?

Харри толгойгоо эргүүллээ. Булангийн хөшиг нээгдэхэд орны хажуугаас хоёр хүн бослоо. Ширүүн байрын хөгшин шидтэн эмэгтэй урт ногоон дашинз, цагаан эрвээхэйд идэгдсэн тасын өд бүхий шовгор оройтой бүрх малгай өмсчээ. Түүний ард сэтгэлээр унасан Невилл зогсож байв.

Харри гэнэтхэн буланд байгаа хүмүүс хэн болохыг ойлголоо. Тэр Невиллийг гарах хүртэл найзуудынхаа анхаарлыг сарниулахыг хичээсэн ч Рон бас Долгопупсын нэрийг олж сонсоод Харрийн зогсоож амжихаас урьтаж «Невилл!» гэж хашгирав.

Невилл дэргэдүүр нь бууны сум өнгөрсөн мэт дальдчин цочлоо.

- Невилл, бид байна! Чи харсан уу? Туг үс энд байсан! Чи хэн дээр ирсэн юм

бэ? гээд Рон үсрэн бослоо.

- Чиний найзууд уу, Невилл хонгор минь? гэж эмээ нь эелдэгээр тэдэнд хандан хэлэв.

Невилл газар дор шигдээд орохыг хүссэн мэт төрхтэй харагдав. Дугуй нүүр нь хүрэнтэн улайж хэнийг ч харахгүйг хичээнэ.

- Аан тийм, тийм. Би чиний хэн гэдгийг мэднэ. Невилл чамайг их үнэлдэг юм гэж эмгэн Харриг харж хэлээд үрчгэр ясархаг гараа сунгалаа.

- Баярлалаа гээд Харри гар барилаа.

Невилл түүн рүү харалгүй доошоо ширтэх зуураа бүр улайлаа.

- Харин чи эргэлзээгүй Уизли байх нь гэж хөгшин үргэлжлүүлээд эхлээд гараа Ронд өгч дараа нь Жиннитэй барингаа, Би танай эцэг эхийг мэднэ. Сайн хүмүүс шүү. Харин чи Гермиона Грэйнджер байх? гэлээ.

Гермиона хөгшин хатагтай түүний нэрийг мэдэж байгаад эмээсэн янзтай харагдсан ч бас гар барилаа.

- Тиймээ, Невилл чиний тухай ярьдаг юм. Тэр сайн хүү хэдий ч эцгийнхээ авъяасыг өвлөөгүй гэж айж байна хэмээн эмгэн ширүүн харцаар Невилл рүү харснаа булангийн ор луу толгой дохиход малгайд хадсан тасын өд нь чичигнэв.

- Юу? гэж Рон гайхширан асуулаа. (Харри түүний хөлийг гишгэхийг хүссэн ч жанчтай биш жинсэн өмдтэй байсан тул хэт ажиглагдам байлаа). Энэ чиний аав юм уу, Невилл?

- Би юу сонсов оо, Невилл? Чи найзууддаа эцэг эхийнхээ тухай яриагүй юм уу? гэж хөгшин хатагтай ширүүн хэлэв.

Невилл гүнзгий санаа алдсанаа адар руу харж толгой сэгсэрлээ. Харри өрөвдөх сэтгэлийг мэдэрсэн ч одоо Невиллд юугаар ч туслахаасаа өнгөрчээ.

- Үүнд ямар ч ичих зүйл байхгүй! гэж хатагтай Долгопупс уурсан хэлээд,

- Чи тэдний нэрээр бахархах ёстой, Невилл! Тэд цорын ганц хүү нь ичээсэй гэж эрүүл ухаанаа алдтал зовоогүй юм шүү! гэв.

- Би ичээгүй гэж Невилл сулхан хэлээд өмнөхийн адил найзууд руугаа харсангүй.

Рон өвчтөнгүүдийг харахын тулд өлмий дээрээ өндийв.

- Үүнийгээ тэгээд яаж үзүүлж байгаа нь энэ вэ! Миний хүү болон эхнэр хоёрыг нь Хэцүү нэртийн талынхан зэрлэгээр ухаангүй болтол нь тамласан юм гээд Харри болон бусад руу нь эргэн харлаа.

Жинни, Гермiona хоёр алгаараа амаа дарлаа. Рон Невиллийн эцэг эхийн зүг хүзүүгээ өлийлгөхөө болив.

- Тэд мракоборецууд байсан бөгөөд шидтэнгүүдийн ертөнцөд хүндтэй хүмүүс байсан юм. Хоёулаа маш авъяаслаг байлаа. Би аан ... тийм л дээ, Алиса? Яасан бэ хонгор минь?

Тэдний ард Невиллийн ээж унтлагын цамцтайгаа ажиглагдамгүй хүрч иржээ. Грюмын Харрид үзүүлж байсан Фениксийн бүлгэмийн эхэн үеийн зураг шиг махлаг дугуй царайтай аз жаргалтай эмэгтэй биш байлаа. Турж эцэн нүд нь томорсон бөгөөд үс нь бууралтаж туниа муутай харагдана. Тэр ярихыг хүсэхгүй байгаа мэт Невиллийн гарыг сунгахаар хучлгардуухан хөдөлгөөн хийв.

- Ахиад л уу? гэж хатагтай Долгопупс ядрангуй хэлээд, Маш сайн байна, хонгор минь маш сайн байна ... Невилл үүнийг ав гэлээ.

Гэхдээ Невилл хэдийн гараа сунгахад ээж нь түүн дээр Друбблсын хамгийн сайн тэсэрдэг бохины хоосон цаас унагав.

- Маш таатай байна хонгор минь гэж Неиллийн эмээ хуурамч баярласан дүр үзүүлэн хэлээд мөрийг нь илэв.

Харин Невилл аяархан,

- Баярлалаа ээжээ гэв.

Алис орондоо үг дуугүй хэвтлээ. Невилл хүүхдүүд рүү «алив инээ л дээ» гэсэн байртай харсан ч Харри амьдралдаа ямар ч инээдгүй зүйл харж байсангүй гэж бодлоо.

- За бид буцсан нь дээр байх гэж хатагтай Долгопупс санаа алдан хэлээд урт ногоон бээлий өмсөж,

- Та нартай танилцахад таатай байлаа, залуу хүмүүс минь. Невилл цаасыг хогийн саванд хаяарай түүний өгсөн цаас унтлагын өрөөнд чинь хангалттай байгаа шүү гэлээ.

Гэхдээ Харрри Невилл хаалгаар гарахдаа цаасыг ажиглагдамгүй халаасандаа хийхийг харлаа.

Тэдний ард хаалга хаагдав.

- Би мэдсэнгүй гэж Гермiona уйлах шахам дуугарлаа.
- Би ч гэсэн гэж Рон сөөнгөтөв.
- Би ч бас гэж Жинни шивнэлээ. Тэд Харри руу харлаа.
- Би мэдэж байсан. Дамблдор надад хэлсэн ч би чимээгүй байх ам өгсөн юм ...

Беллатрис Лестрейнжийг үүнийх нь төлөө Азкабан руу явуулсан. Тэр Невиллийн эцэг эхийг Круциатус шившлэгэр тамлаж ухаан солиоруулсан байсан.

- Беллатриас Лестрейнж гэнээ? Кикимерийн зурган дээр байсан эмэгтэй юу? гэж Гермiona айдаст автан шивнэлээ.

Удтал нам гүм болоход Туг үсийн ууртай хоолой эвдэж,

- Сонсоцгоо би захидлын үсэг бичиж сурч байна гэлээ.

БҮЛЭГ 24: ОККЛЮМЕНЦИЙ

Кикимер дээврийн хөндийд нуугдсан байлаа. Түүнийг Сириус олоход үйлчлэгч битүү тоос болсноос үзэхэд Блэкийн гэр бүлийн холбогдолтой пиндээ нуух зүйл эрж байсан нь эргэлзээгүй. Сириус үүнийг баяртайгаар тайлбарласан ч Харрийн санаа амарсангүй. Кикимер ахин гарч ирсэнийхээ дараа сайхан зантай байж хорон үглэхгүй тушаалыг дуулгавартай биелүүлж байсан ч Харри хэдэнтээ түүн рүү харахад хомхой харц нь нүд буруулахыг харжээ.

Харри сэжиглэлээ Сириуст хэлсэнгүй, зул сарын дараа түүний баяр хөөр түргэн алга болов. Тэдний Хогвартс руу буцах өдөр ойртох тусам тэр хатагтай Уизлийн хэлдэгчилэн баргар чимээгүй болж ууртай дүнсийн гиппогрифтэйгээ ганцаар өдрийг өнгөрүүлнэ. Түүний уйтгар гуниг байшингийн хаалган доогуур хортой хий тавьсан юм шиг бусдад халдварлав.

Харри ахин Сириусыг Кикимертэй үлдээгээд Хогвартсад буцахыг хүссэнгүй бөгөөд сургуульдаа буцах болсондоо анх удаа баярласангүй. Сургуульд түүнийг Амбрижийн дарлал хүлээж байгаа бөгөөд эзгүй хойгуур нь олон арван хууль зохиосон нь лавтай, түүнчлэн квиддичийн багаас хөөгдөж, гэрийн даалгавар овоорсны дээр шалгалт улам ойртож байлаа. Бас Дамблдор түүнээс өмнөхийн адил зугтсаар байсан юм. Хэрвээ ДА байгаагүй бол Харри Сириусээс сургуулиа орхиж Гриммогийн байшинд үлдэх зөвшөөрөл гуйх байлаа.

Амралтын сүүлчийн өдөр Харри сургуульд буцах болсон тухайгаа айдаст автан бодлогоширов.

- Харри хонгор минь, гал зуух руу нэг шагайгаадхаач. Чамтай профессор Снегг ярилцахыг хүсч байна гэж хатагтай Уизли түүнийг Ронтой шатар тоглож Жинни, Гермiona, Живоглот нар харж байх үед толгойгоо унтлагын өрөө рүү шургуулан хэллээ.

Харрид түүний үг даруй ойлгогдсонгүй. Түүний тэргийг Роны хүү идэхэд Харри ууртайгаар,

- Түүнийг өг, тэнэг минь энэ чинь ердөө хүү. Уулчаарай хатагтай Уизли, та юу гэж хэлсэн бэ? гэв.

- Профессор Снегг хонгор минь. Гал зууханд байгаа. Чамтай ярилцахыг хүсч байна.

Харри айсандаа амаа ангайлаа. Тэр Рон, Жинни, Гермиона нар руу харахад урдаас нь ширтэж байв. Сүүлчийн арван таван хормын турш Гермионагийн тэврэлтнээс чөлөөлөгдөхийг оролдож байсан Живоглот баяртайгаар шатрын хөлөг рүү үсрэн дээр нь буухад дүрсүүд чангаар орь дуу тавив.

- Снегг гэнээ? хэмээн Харри гайхан давтлаа.
- Профессор Снегг гэж хатагтай Уизли зэмлэнгүй засаад,
- Түргэлээрэй түүнд цаг бага байгаа гэсэн шүү гэв.
- Тэр чамаас юу хүссэн юм бэ? Чи юу ч хийгээгүй биз дээ? гэж Рон эхийгээ ерөөнөөс гарахад асуув.
- Хийгээгүй! гэж Харри зэвүүцэнгүй хэлээд Снегг түүнийг Гриммогийн байшин хүртэл мөрдөхөөр ямар гэмт хэрэг хийснээ бодохыг хичээв. Тэр сүүлчийн гэрийн даалгавараа хийсэн билүү?

Хоёр хормын дараа тэр гал зуухны үүдийг түлхэн ороод Сириус, Снегг хоёр урт ширээний ард бие биенийхээ өөдөөс харж суухыг олж харав. Тэдний чимээгүй байдал харилцан дургүйцсэн төрхтэй байлаа. Сириусын өмнөх ширээн дээр нээлттэй захиа хэвтэнэ.

Харри ирснээ мэдэгдэхийн тулд ханиалгав.

Снегг эргэж харахад тослог үс нь хөшиг шиг намиран бүрхэв.

- Суу, Поттер.
- Снегг би чамайг энд тушаал өгөх эрхгүй гэж бодож байна. Энэ бол миний гэр ойлгож байна уу гэж Сириус чанга хэлээд сандлынхаа хойд хоёр хөл дээр гэдийн адар ширтлээ.

Снеггийн цонхигор зэвүүн царай харанхуйлав. Харри Сириусын дэргэд суугаад Снегг рүү ширтлээ.

- Би чамтай ганцаарчилан ярих хэрэгтэй, Поттер гэж Снегг ёжтой инээмсэглэн хэлээд,
- Гэхдээ Блэк ... гэв.
- Би түүний загламайлсан эцэг гэж Сириус чанга хэлэв.
- Би энд Дамблдорын тушаалаар ирсэн. Гэхдээ үлд л дээ, Блэк. Би чамайг

холбоотой байхыг хүсч байгааг мэднэ гэж Снегг аяархан бөгөөд хорон өнгөөр хэлэв.

- Үүнийг чинь юу гэж ойлгох болж байна? гээд Сириус сандлынхаа дөрвөн хөлийг тасхийтэл чанга буулгалаа.

- Тиймээ би чиний юу мэдэрч байгааг ойлгож байна ... ах ... бүлэгт ашигтай зүйл юу ч хийж чадахгүй болохоороо сэтгэлээр унаж байгааг чинь гэж сүүлчийн үгээ тодотгон хэлэв.

Одоо Сириусын царай улайлаа. Снегг ялалтын байдалтай уруулаа мушийлган

Харрид хандаж,

- Захирал намайг чамд хүсэлтийг нь дамжуул гэж явууллаа. Бид энэ улиралд окклюменцийн хичээл судлах болно гэв.

- Юу судлах гэнээ? хэмээн Харри ойлгосонгүй. Снегг тохуурхан инээмсэглэв.

- Окклюменций, Поттер. Оюун ухаанаа гадны нөлөөлд автуулахгүй байх ид шидийн хамгаалалт. Ид шидийн багахан хэрэглэгддэг төрөл ч ашигтай шүү.

Харрийн зүрх галзуурсан мэт цохилон. Нөлөөллөөс хамгаалах гэнээ? Гэхдээ тэр юунд ч эзэмшүүлээгүй шүү дээ тэд үүнийг зөвшөөрсөн ...

- Би яагаад окклю ... судлах ёстой юм бэ?

- Яагаад гэвэл тэгэх хэрэгтэй гэж захирал бодож байгаа юм. Та долоо хоногт нэг удаа нэмэлт хичээл авч хэнд ч энэ тухайгаа юунаас түрүүнд Долорес Амбрижэд хэлэхгүй байх ёстой. Намайг ойлгов уу?

- Тиймээ. Хэн намайг сургах юм бэ?

- Би гээд Снегг хөмсгөө өргөв.

Харрийн дотор жигшүүртэй мэдрэмж төрөв. Снеггээс нэмэлт хичээл авна гэнээ тэр яагаад ийм шийтгэл хүлээх ёстой гэж? Тэр түргэхэн Снегг рүү тусламж эрэн харлаа.

- Дамблдор яагаад өөрөө түүнийг сургаж болдоггүй юм бэ? Яагаад чи гэж?

хэмээн Сириус өдсөн байртай асуув.

- Яагаад гэвэл захирал иймэрхүү таатай ажлыг бусдаар хийлгэх эрхтэй. Би чамд энэ ажлыг гуйгаагүй гэдгээ хэлэх байна гээд бослоо.

- Би таныг даваа гаригийн үдшийн зургаан цагаас хүлээж байя, Поттер. Миний өрөөнд шүү. Хэрвээ хэн нэгэн асуувал уусмалын хичээлийн нэмэлт даалгавар авсан

гээрэй. Миний хичээл дээр байхыг харсан хэнд ч энэ хэрэгтэй гэдэг нь ойлгогдох болно.

Тэр хаалга руу хар жанчаа намируулан хөдлөв.

- Түр хүлээгээрэй гээд Сириус суудалдаа цэхлэн суув. Снегт тэдэн руу мушийн эргэн харав.

- Би яарч байна, Блэк. Надад чамд үрэх цаг алга гэдэг нь тодорхой байгаа биз дээ.

- Ажил хэрэг ярих гэсэн юм гээд тэр Снегт рүү харан босоод халаасандаа хийсэн гараа зангидахад Харри тэнд нь шидэт саваа байгаа гэдэгт эргэлзсэнгүй. Хэрвээ энэ окклюменцийн хичээлийг чи Харриг зовоох байдлаар ашиглавал үүнийгээ надад төлөх болно шүү.

- Ямар уярмаар юм бэ. Гэхдээ чи Поттер эцэгтэйгээ маш адилхан гэдгийг ажигласан биз дээ? хэмээн Снегт ёжтой инээвхийлэв.

- Ажигласан гэж Сириус бардам хэлэв.

- Тэгвэл түүний хичнээн бардам зантай болохыг тааварлаж байгаа биз дээ.

Сириус сандлаа хойш түлхэн Снегт рүү шидэт саваагаа гарган ухасхийв. Снегт өөрийнхийгөө гаргалаа. Тэд хоёулаа бэлэн байдалд оров. Сириус уур хилэнд автсан байсан бол, Снегт тооцоолсон харагдсан агаад нүд нь Сириусын саваа руу гүйгээд царай дээр нь буцаж тогтов.

- Сириус! гэж Харри чанга хэлсэн ч тэр сонссонгүй.

- Би чамд анхааруулсан шүү, Ньюниус. Надад чамайг Дамблдор өөрчлөгдсөн гэж бодож байгаа чинь хамаагүй. Би чамайг сайн мэднэ! гэж Снегтийн хөлөөс толгойны үзүүр лүү гүйлгэн хараад хэллээ.

- Өө, тэгвэл чи яагаад түүнд хэлээгүй юм бэ? Эсвэл эхийнхээ гэрт хагас жил нуугдсан хүний үгийг хэрэгсэхгүй гэж айгаа юу? хэмээн Снегт шивнэв.

- Тэгвэл надад Люциус Малфой энэ өдрүүдэд юу хийж байсныг хэл? Чи түүнийг Хогвартс дахь үнэнч нохой болсондоо сэтгэл хангалуун байгаа биз дээ?

- Нохойны хувьд гэвэл Люциус Малфой чамайг сүүлчийн аялалын үеэр чинь таньсныг мэдэж байгаа биз дээ? Буудал дээр очих чинь сайхан санаа байлаа, Блэк ... Хамраа үүрнээс цухуйлдаггүй хүнд сайхан цагаатгал шүү.

Сириус саваагаа өргөв.

- Үгүй! Сириус, хэрэггүй! гэж Харри хашгираад ширээн дээгүүр харайн тэдний хооронд нисэн орлоо.

- Чи намайг хулчгар гэж хэлж байгаа юм уу? гэж Сириус дэлбэрээд Харриг түлхэн холдуулах гэсэн ч хөдөлсөнгүй.

- Өө, тийм л дээ тэгсэн санагдаж байна хэмээн Снегг хэлэв.

- Харри хөлд битгий тээглээд бай! гэж Сириус түүнийг сул гараараа түлхэн архирлаа.

Гал зуухны үүд нээгдэж Уизлийн бүх гэр бүл Гермionaгийн хамтаар аз жаргалтай орж ирэв. Тэдний дунд ноён Уизли бардам алхлах агаад судалтай халат өмсчээ.

- Эдгэрсэн! Эв эрүүл болсон! гэж тэр гал зуухны өрөөгөөр нэг хашгирав.

Тэр болон бусад Уизличууд босгоны дэргэд хөшин болж буй үйл явдлыг харцгаалаа. Сириус, Снегг хоёр дайсагнасан байдалтай саваагаа бие биенийхээ нүүр лүү чиглүүлж харин Харри тэднийг холдуулахыг хичээн гараа тэлэн зогсож байв.

- Намайг луу идээсэй, энд юу болоод байна гээд ноён Уизли инээмсэглэхээ болив.

Сириус, Снегг хоёр савааг буулгахад Харри ээлжлэн харлаа. Хоёулангийнх нь царайд туйлаас зэвүүцсэн өнгө тодорсон агаад гэнэтийн олон гэрчийн нүдэн дээр ингэж харагдсандаа эвгүйцсэн байртай харагдав. Снегг саваагаа халаасандаа хийгээд юу ч хэлэлгүй үүд рүү явлаа. Хаалган дээр очоод эргэн харж,

- Даваа гаригт оройн зургаан цагаас шүү, Поттер гэв. Түүнийг гарахад Сириус дагуулан харснаа саваагаа буулгав.

- Энд юу болоо вэ? гэж ноён Уизли ахин асуув.

- Зүгээр дээ, Артур. Зөвхөн сургуулийн хуучин хоёр андын нөхөрсөг яриа боллоо гээд Сириус хүндээр амьсгаадан инээмсэглэв.

- Тэгэхээр чи эдгэсэн юм биз дээ? Энэ чинь сайхан мэдээ байна. Маш сайхан мэдээ байна.

- Үнэн үү? гээд хатагтай Уизли нөхрөө сандалд суулгангаа,

- Анагаагч Сметвик могойн хорны эсрэг үйлчилгээтэй эмийг гайхамшигтайгаар

олсон. Харин Артур маглуудын эмнэлгийн эмчилгээнд суралцахаар саваагүйтэж байдаг. Үнэн биз дээ, Артур? гэж сүрдүүлсэн байртай асуулаа.

- Тиймээ Молли, хонгор минь гэж ноён Уизли хүлцэнгүй дуугарав.

Ноён Уизли ахин гэр бүлдээ эргэн ирсэн учир оройн хоол хөгжилтэй болов. Харри Сирусын бүгдийн уур амьсгалыг дэмжихийг хичээж байсан ч Фред, Жорж хоёрын тоглоомд инээсэнгүй бөгөөд, зочдоо ч хоолоор дайралгүй царай нь бодлогоширсон уйтгартай байхыг харлаа. Тэдний хооронд Артурын эдгэсэн явдалд баяр хүргэхээр ирсэн Наземникус, Грюм хоёр суужээ. Харри түүнтэй ярилцан Снеггийн албаар өдсөн үгийг сонсох хэрэггүй, Дамблдор түүнийг энэ байшинд нуугдахыг тушаасаны улмаас хэн ч аймхай гэж бодоогүй гэж хэлэхийг хүслээ. Гэхдээ түүнд тийм боломж гарсангүйд Сириусын баргар царай луу харж боломж гарсан ч ярилцаж чадах эсэхдээ гайхлаа. Тэр зөвхөн Рон, Гермиона хоёртой Снеггийн окклюменцийн хичээлийн тухай шивнэлдэж амжжээ.

- Дамблдор чамайг Волдемортын тухай зүүдлэхийг болиулахыг хүсэж байгаа байх. Чи түүнгүй уйдаагүй биз дээ? гэж Гермиона хэллээ.

- Снегээс нэмэлт хичээл авах гэнээ? Надад бол хар дарсан зүүд шиг санагдаж байна! гэж Рон эмээнгүй дуугарав.

Маргааш нь тэд Хогвартс руу «Шөнийн хүлэг баатар» автобусаар буцахаар болсон бөгөөд Тонкс, Люпин хоёр хамгаалан хүргэх болов. Өглөө нь Харри, Рон, Гермиона гурав гал зуух руу ороход тэд хоол идэж байв. Насанд хүрэгчид нам дуугаар шивнэлдэж байснаа Харриг орж ирэхийг хараад чимээгүй болов.

Яаран өглөөний цайгаа уусны дараа нэг сарын өглөө хүйтэн байсан учир хүрмээ өмсөж, ороолтоо зүүцгээв. Харрийн дотор таагүй давчдахад Сириустэй салах ёс гүйцэтгэхийг хүссэнгүй. Түүнд ахин хэзээ уулзахаа мэдэхгүй байсан учир загалмайлсан эцгээ ямар нэг тэнэг юм хийлгэхгүй байлгахаар анхааруулах хэрэгтэй гэсэн хүндхэн мэдрэмж төрөв. Харри түүнийг Снеггийн хулчгар гэж буруутгасны дараа ямар нэг ухаангүй алхам хийн Гриммогийн байшингаас гарах вий гэж эмээж байсан юм. Гэхдээ ямар нэг юм хэлж амжихаас урьтаж Сириус түүний зүг тонгойлоо.

- Би чамайг үүнийг авахыг хүсч байна гээд нимгэн хавтастай ном шиг хуйлаастай зүйл сунгав.

- Энэ юу вэ?
- Хэрвээ Снегг чамайг зовоож эхлэвэл надад мэдэгдэх зүйл. Энд битгий онгойлгоорой! гээд Сириус ихрүүдийг бээлий өмсөхөөр ухуулах хатагтай Уизли руу болгоомжлон харснаа,
- Молли намайг дэмжихгүй гэж айж байгаа ч хэрвээ шаардлага гарвал заавал ашиглаарай. Тохиров уу? гэлээ.
- Аанхан гэж Харри хэлээд цаасыг авч хүрэмнийхээ халаасанд хийв.

Гэхдээ тэр хэзээ ч энэ зүйлийг ашиглахгүйгээ мэдэж байв. Түүнд Снеггийн мөдхөн орох гэж буй окклюменцийн хичээл заналхийлж буй ч Сириусыг нуугдсан газраас нь гаргахыг хүссэнгүй.

- Тэгвэл явцгаая гээд Сириус баргар царайлан инээмсэглэж мөрөн дээр нь алгадав.

Харри юу ч хэлж амжсангүй хомрын дараа хүнд гинжээр түгжээтэй хаалганы өмнө Уизличуудын дунд зогсож байв.

- Баяртай, Харри. Биеэ бодож байгаарай гэж хатагтай Уизли тэврээд шивнэлээ.
- Эрүүл байж тэнд могой байгаа эсэхийг харж байгаарай! гэж ноён Уизли эелдэгээр хэлээд гар барилаа.
- Тэгэлгүй яахав гэж Харри уймран хэлэв.

Энэ бол Сириусээс эрсдэлд орохгүй байхыг гуйх сүүлчийн боломж байлаа. Харри загалмайлсан эцэгтэйгээ ярихыг хүсэн эргэсэн авч амаа нээж амжсангүй. Сириус түүнийг нэг гараараа түргэн тэврээд,

- Өөрийгөө бодож байгаарай, Харри гэв.

Дараагийн агшинд түүнийг Тонксын хамт хүйтэн агаарт довжоон дээр (Тонкс өнөөдөр буурал үстэй хатагтай болсон байлаа) түлхэн гаргав.

Байшингийн хаалга ард нь хаагдав. Тэдний араас Люпин гарч ирэхэд явган зам дээр гарцгаалаа. Харри эргэж харав. Арван хоёрдугаар байшин агшин багасч хоёр талаасаа шахагдаад агшин зуур алга боллоо.

- Түргэн автобусанд суухын тулд явсан нь дээр байх гээд Тонкс талбай руу ширтэв.

Люпин баруун гараа хаялав. Түн!

Хурц ягаан өнгийн гурван давхар автобус тэдний өмнө агаарт бий болоод гэрлийн шон арай мөргөлгүй арагш үсрэн ухарлаа.

Туранхай, ов тов бүхий батга, дэлдэн чихтэй ягаан хувцастай залуу газар үсрэн буугаад,

- Тавтай морил ... гэлээ.
- Тиймээ, тийм мэднэ. Орцгооё гэж Тонкс тэвчээргүйхэн хэлэв.

Тэр Харриг бүлтийн харсан тасалбар түгээгчийн хажуугаар түлхээд даган орлоо.

- Аан ... энэ чинь Харри!
- Ахин түүний нэрийг дурсах юм бол үхлийн шившлэг хийнэ шүү гэж Тонкс заналхийлээд Гермiona, Жинни хоёрыг дэмжин орууллаа.
- Бүх насаараа үүнд суухыг мөрөөдөж байлаа гэж Рон баяртай хэлээд Харрийн дэргэд очин ийш тийшээ харав.

Харри өнгөрсөн удаад «Шөнийн хүлэг баатар» автобусаар явахад гурван давхар зэс ороор дүүрэн байсан. Одоо өглөө эрт байсан болохоор цонхны дэргэд муухан зохицсон сандал чихэн дүүргэжээ. Зарим шидтэнгүүд автобус Гриммогийн байшингийн өмнө огцом тоормосолоход унасан бололтой дургүйцэн үглэж хөл дээрээ босоцгооно. Хэн нэгний тээш шалан дээр задарч мэлхийний түрс, жоом, шингэн тос шалаар нэг таржээ.

- Бид хуваагдах хэрэгтэй болох нь гэж Тонкс сул суудлыг харж хэлээд,
- Фред, Жорж, Жинни гурав тэнд суу ... Римус та нартай үлдэнэ гэв.

Тэр Харри, Рон, Гермiona нарын хамтаар хамгийн урд тал болон ардаа хоёр сул суудалтай дээд давхарт гарч ирлээ. Тасалбар түгээгч Стэн Шанпайк урам зоригтойгоор Харри, Рон хоёрыг дагуулан явав. Зорчигчдын толгой тэдний зүг хандаад Харри суумагц бүгд урагшаа эргэж харлаа.

Харри, Рон хоёр Стэнд арван нэгэн сикль өгөхөд автобус урагш хөдөлж эвгүйхэн савлав. Тэр Гриммогийн байшингийн хажуугийн замаар нижигнэн өнгөрч гүүр лүү чиглэнгээ «Түн!» гэж дуугарах чимээ хадахад бүгд хойш шидэгдлээ. Роны сандал хөмрөхөд Гахайн тор өвдөг дээрээс нь шидэгдэж шувуу чанга жиргэн урагш нисээд Гермioангийн мөрөн дээр газардав. Харри лааны сууринаас зуурсан тулдаа

унасангүй. Тэр цонхоор харахад автобус хурдаа авч байлаа.

- Бирменгемд ирчихлээ гэж Стэн Харрийн асуунгуй харцны хариуд баяртайгаар хэлэхэд Рон шалнаас бослоо.

- Чи хэр байна даа, Харри? Зун чиний тухай сонинд олон удаа бичсэн ч сайн зүйл юу ч байгаагүй. Би Эрнитэй бидэнтэй явахдаа галзуу хүн байгаагүй гэж ярилцаж байлаа.

Тэр тасалбарыг нь өгөөд Харриг үргэлжлүүлэн бахдан харав. Стэнд галзуу ч бай үгүй ч бай хамаагүй хамгийн гол нь сонинд бичигдсэн алдартан гэдэг нь л чухал байв. «Шөнийн хүлэг баатар» осолтой ганхаад урдаа яваа машиныг гүйцэж түрүүлэв. Харри Гермiona нүдээ алгаараа таглаж, Гахай түүний мөрөн дээр баясгалантай жиргэж байхыг харлаа.

Түн!

Сандал ахин урагш гулгахад «Шөнийн хүлэг баатар» Бирменгемийн зам руу үсрээд тахир муруй явган хүний замаар аяархан явлаа. Амьд бургасан хашаа замын хоёр талыг хүрээлж автобус эргэлээ. Дараа нь тэд хотын төв гудамжаар давхиж өндөр толгодыг хүрээлсэн солбих гүүрээр гарахад ахин нэг удаа чанга «Түн!» хийх чимээ гарав.

- Би бодлоо өөрчиллөө. Ахиж хэзээ ч үүгээр явахыг хүсэхгүй байна хэмээн Рон үглээд зургаа дахь удаагаа шалнаас өндийв.

Тэдэн рүү Стэн хүрч ирэв.

- Сонсооч дараагийн зогсоол Хогвартс. Энэ захирангүй авгай та нарыг дараа нь гаргахыг тушаасан. Одоо зөвхөн хатагтай Маршыг буулгах хэрэгтэй байна ... Түүний бие сайн биш байгаа юм гээд доош буухад бөөлжих дуулдаж аймшигтай шүршигдэх чимээ гарав.

Хэдэн хормын дараа «Шөнийн хүлэг баатар» жижигхэн баарны өмнө дугуйгаа чахруулан тооромслов. Тэд Стэн хэрхэн золгүй хатагтай Маршыг автобуснаас гарахад тусалж байгааг сонсоход хоёр давхарын хөршүүд нь санаа амран гүнгэнэлдэв. Автобус ахин байрнаасаа ухасхийв.

Түн!

Тэд хэдийн цастай Хогсмидэд хүрчээ. Харри гудамжинд «Гахайн толгой» зурсхийн

өнгөрөхөд гахайн толгойны зураг салхинд савчихыг харлаа. Цасан ширхэг салхины шилийг нүднэ. Эцэст нь тэд Хогвартсын хаалганы гадаа хүрэв.

Люпин, Тонкс хоёр тэдний тээшийг автобуснаас гаргахад тусалж дараа нь салах ёс гүйцэтгэлээ. Харри гурван давхар автобус руу харахад бүх зорчигчид нь хамраа цонхонд наасан байлаа.

- Сургуулийн нутаг дэвсгэрт та нар аюулгүй байх болно. Хичээлд чинь амжилт хүсье гэж Тонкс хоосон замыг шалган хараад дуугарлаа.

- Биеэ бодож яваарай гээд Люпин хүүхдүүдтэй ээлжлэн гар барив. Хамгийн сүүлд Харри үлдэхэд,

- Сонсооч, би чамайг Снегэд дургүй гэдгийг мэдэх ч тэр маш сайн оккломенист. Ийм учраас бид бүгд чамайг өөрийгөө хамгаалж сурахыг хүсч байгаа юм. Хичээгээрэй ойлгов уу? гэлээ.

- Хичээе ээ. Дараа уулзая. гэж Харри хөгжилтэй бус өгүүлээд Люпины үрчлээтэй царай луу харав.

Зургуулаа чемоданаа шрсээр шилтгээн хүрэх замаар орлоо. Гермiona хэдийн орой унтахын өмнө үйлчэгчийн малгай нэхэх тухайгаа ярьж эхэлжээ. Царсан хаалганд хүрэх үедээ Харри эргэж харахад «Шөнийн хүлэг баатар» ор мөргүй алга болж, маргааш оройн хичээлийг бодохдоо автобусанд үлдээгүйдээ бараг харамслаа.

Дараагийн өдөр Харри айдаст автан үдшийн хичээлийг хүлээв. Өглөөний хоёр цагийн уусмалын хичээл ч түшүүрийг нь басгасангүй. Снег үргэлжид байдаг шигээ дайсагнасан хэвээр байлаа. Түүнийг орой уулзах эсэх тухай найдангуй асуух ДА-гийн гишүүд юунаас илүү сэтгэлээр унагав.

- Та нарт ердийн аргаар цугларалтыг мэдэгдэнэ. Гэхдээ өнөөдөр чадахгүй. Би уусмалын нэмэлт хичээлтэй гэж ахин дахин хэлж байлаа.

- Уусмалын нэмэлт хичээл гэнээ? хэмээн үдийн хоолны дараа үүдний танхимд гүйцэж ирсэн Захария Смит сэжигтэй асуугаад,

- Бурхан минь чи юу хэлж байна аа. Снег хэзээ ч нэмэлт хичээл өгдөггүй юм гэлээ.

Түүнийг хөгжилтэйгээр цааш одоход Рон дайсагнасан харцаар үдэнгээ шидэт саваагаа Смитийн мөр лүү чиглүүлэн өргөөд,

- Түүнийг шившчих үү? гэв
- Мартаж үз. Одоо бүгд тэгж бодож байгаа ... гэж Харри гунигтай хэлэв.
- Сайн уу, Харри гэх хоолой ард нь сонсогдлоо. Түүнийг эргэж харахад Чжоу зогсож байв.
- Өө, сайн уу гээд Харрийн гэдэс дотор хөрвөх шиг болов.
- Харри бид нар номын санд байж байя гэж Гермiona шийдэмгий хэлээд Роны тохойноос зууран гантиг шатны зүг чирлээ.
- Зул сарыг сайхан өнгөрүүлэв үү? гэж Чжоу асуув.
- Муугүй.
- Харин бид нар нам гүм өнгөрүүлсэн. Ирэх сард Хогсмид яах зарлалыг уншсан уу? гэж тэр ичсэн байртай хэлэв.
- Юу гэнээ? Аан үгүй дээ, би зарлалын самбарыг хараагүй байна.
- Гэгээн валентиний өдөр байгаа юм ...
- Ойлгомжтой хэмээн Харри түүний яах гэж ингэж хэлснийг ойлголгүй хэлээд, Чи магадгүй хүссэн байх л даа? ... гэв.
- Зөвхөн чи л хүсэж байвал.

Харри «Чи магадгүй ДА-гийн цугларалт хэзээ болох талаар мэдэхийг хүсч байгаа байх?» гэж асуух шахсан болохоор хариу хэлж чадсангүй.

- Би ... э-э ... мэдэхгүй ...
- Өө, хэрвээ хүсэхгүй бол хэрэггүй. Санаа зовох хэрэггүй дээ. Дараа уулзая гэж тэр доромжлогдсон байртай хэллээ.

Тэр цааш явчихлаа. Харри түүний араас дагуулан хараад гэнэт нэг санаа төрөв.

- Чжоу! Хөөө ... Чжоу! гээд түүний араас гүйн шатны хагаст гүйцэв.
- Чи надтай гэгээн Валентины өдөр Хогсмид явахыг хүсээ юу?
- Т-ий-м! гэж Чжоу инээмсэглэн хэлээд улайв.
- Сайн байна ... тэгвэл тохиролцолоо гээд Харри баяртайгаар дээшээ нисэн гарч үдшийн хичээлийн өмнө Рон, Гермiona хоёртой номын санд уулзахаар одлоо.

Зургаан цагт Чжоуг амжилттай урьсандаа бүх бие нь халуу оргисоор Снеггийн өрөө

рүү эрч хүчтэй чиглэв.

Тэр дэлхий дээр хамгийн үзэн яддаг газар луу орохын өмнө хаалганы урд зогсоод гүн амьсгал авч тогшоод орлоо.

Бүүдгэр гэрэлтэй өрөөнд тавиур дээгүүр зуугаад шилэн сав эгнүүлэн тавьсан агаад янз бүрийн өнгөтэй уусмалд амьтан, ургамлын хэсгүүд хөвнө. Буланд байгаа дүүрэн уусмалын орц бүхий шүүгээний урд Снегг зогсоод Харриг сэжиглэнгүй харлаа. Түүний анхаарал ширээн дээр байгаа янз бүрийн дүрс тэмдэг бүхий сийлбэртэй чулуун аяга дээр тусав. Харри түүнийг шууд танилаа. Энэ бол Дамблдорын гүн ухааны цүнхээл байв. Тэр яагаад энд байгаа юм бол? Тэгтэл харанхуйгаас Снеггийн хүйтэн хоолой гарахад давхийн цочив.

- Хаалгаа хаа, Поттер.

Харри тушаалыг биелүүлэхдээ шоронд байгаа юм шиг мэдрэмж төрөв.

Түүнийг өрөө рүү эргэж харахад Снегг гэрэлд гаран зогсоод ширээний эсрэг талын сандал руу зангалаа. Харри суухад Снегг бас суугаад хүйтэн хар нүдээрээ цавчилгүй ширтэхэд царайных нь үрчлээс нугалаа бүрт таагүй өнгө тодорч харагдав.

- Тэгэхээр Поттер, та юуны учир энд байгаагаа мэдэж байгаа. Захирал надаас чамд окклюменций заахыг гуйсан. Таныг уусмалын хичээлээс илүү амжилт гаргана гэж найдахаас.

- Ойлгомжтой гэж Харри хэлэв.

- Энэ бол ер бусын хичээл болохоор, Поттер би урьдын адил багшлах хэдий ч надад «ноёнтоон» юмуу «профессор» гэж хандах ёстой гээд Снегг түүн рүү хорсолтойгоор онийн ширтэв.

- Тиймээ ... ноёнтоон.

- Ингээд окклюменций. Би чамайг гал зуухны өрөөнд хайрт загалмайлан эцэгтэйгээ байхад чинь гадны нөлөөлөл болон халдлагаас оюун санаагаа хамгаалдаг шидийн төрөл гэдгийг хэдийн тайлбарласан.

- Профессор Дамблдор яагаад надад хэрэгтэй гэж бодсон юм бол ноёнтоон?

гэж Харри асуусан ч Снеггийн нүдийг хараад хариулах эсэхэд нь эргэлзлээ. Снегг хэсэг зуур чимээгүй болсноо дараа нь зэвүүцэнгүй,

- Чи үүнийг хэдийн тааварласан биз дээ, Поттер? Хар лорд бол легилменцийн

дээд зэргийн мэргэжилтэн ... гэв.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Ноёнтоон?
- Энэ бол бусдын ой ухааныг эзэмдэх авъяас юм ...
- Тэр бодол уншиж чадах уу? гэж Харри асуугаад айдаст автав.
- Поттер, та нарийн ялгааг нь ойлгосонгүй. Энэ таны уусмалын хичээлийн гунигтай амжилт гаргадагийн чинь шалтгаан байгаа юм гэж тэр нүдээ гялалзуулан хэлэв.

Снегг энэ доромжлолоо таатайгаар мэдрэхийн тулд чимээгүй болсноо,

- Зөвхөн маглууд л бодол унших гэж ярьдаг юм. Оюун ухаан бол ном биш түүнийг нээхийн тулд аажмаар судлах хэрэгтэй. Бодол бол тархин дотор цөмрөн орж анхааралтай судалж болохоор зүйл биш. Бодол санаа бол олон давхарга бүхий ярвигтай зүйл, Поттер. Хэдийгээр легилменцийг эзэмшсэн хүн бусдын бодол санаанд нэвтэрч чадах хэдий ч хохирогчынхоо бодол санааг зөв тайлбарлахын тулд эрэх шаардлагатай. Хар лорд бараг үргэлж хэн худал хэлж байгааг мэддэг. Зөвхөн окклюменций л худал хэлсэн мэдрэмжийг үгүйсгэж чадна гэв.

Снеггийн легилменцийн тухай яриа бодол уншдагтай адил сонсогдсон нь Харрид таалагдсангүй.

- Тэгэхээр тэр одоо бидний юу бодож байгааг мэдэх үү? Ноёнтоон?
- Хар лорд Хогвартсын нутаг дэвсгэрээс алсад байгаагийн дээр хамгаалалтын олон янзын эртний илбэ шид байдаг болохоор дотор нь байгаа хүн бие болон оюун ухаан хамгаалттай байна гэж хэлж болно. Цаг хугацаа бол орон зай бол шидийн төрөл зүйл юм, Поттер. Легилменцийд харааны холбоос зайлшгүй хэрэгтэй.
- Тэгвэл би яагаад окклюменцийг сурах ёстой юм бэ?

Снегг Харри руу хараад урт цагаан хуруугаараа уруулаа имэрлээ.

- Ердийн хуулиуд харваас чамд хамаагүй бололтой, Поттер. Хараал чамайг алаагүй ч Хар лорд та хоёрын дунд холбоос үүсгэсэн. Бүхий л шинж тэмдэгээс үзэхэд таны ухаан эмзэг хэврэг байна. Жишээлбэл чи унтаж байх үедээ зүүдэндээ Хар лордын сэтгэл хөдлөлийг мэдэрдэг биз дээ. Захирал үүнийг төгсгөл болгох хэрэгтэй гэж бодож байгаа юм. Тэр намайг чамд Хар лордоос оюун ухаанаа хааж сургахыг хүсч байгаа.

Харрийн зүрх ахин палхийлээ.

- Тэгвэл профессор Дамблдор яагаад үүнийг зогсоохыг хүсэж байгаа юм бэ?

Надад энэ таалагдахгүй байгаа ч ашигтай биш үү? Би бодохдоо ... би ноён Уизлиг могой дайрч байхыг харсан. Хэрвээ хараагүй бол профессор Дамблдор түүнийг аварч чадахгүй байсан биз дээ? Ноёнтоон?

Хормын турш Снегг түүн рүү уруулаа имэрсэн чигээр харлаа. Дараа нь ярьж эхлэхдээ үг бүрээ алгуур сунган,

- Сүүлийн үе хүртэл хар Лорд хоорондын холбоогоо сэжиглээгүй байсан. Одоо хүртэл чи түүний бодол мэдрэмжийг хуваалцаж байгаа биз дээ. Зул сарын үеэр болсон харалтын чинь хувьд ...

- Ноён Уизли, могой хоёрын тухай юу?

- Битгий миний яриаг таслаад бай, Поттер гэж Снегг заналхийлэн хэлээд,

- Би чиний зул сарын өмнөх богино харалтыг Хар лордын бодол руу хүчтэй цөмрөн орсны улмаас болсон гэж бодож байна ... гэв.

- Гэхдээ би могойн дотор талаас харсан болохоос биш түүнийх биш!

- Чамд миний яриаг битгий тасал гэж хэлсэн шиг санагдах юм.

Гэхдээ Харри профессорын уур хилэнд анхаарлаа хандуулсангүй. Тэр сандлын ирмэг дээр сууж байгаагаа анзааралгүй урагшилтал тэнцвэр алдан унах шахлаа.

- Би тэгээд яаж Волдемортын бодлыг могойн нүдээр харсан болж байна?

- Хар лордын нэрийг бүү дурс! гэж Снегг зандрав.

Таагүйхэн нам гүм болов. Тэдний харц гүн ухааны цүнхээлд туслаа.

- Профессор Дамблдор түүний нэрийг хэлдэг гэж Харри аяархан хэлэв.

- Дамблдор бол хүчирхэг шидтэн. Тэр энэ нэрийг айлгүй дурьдаж болно ... бидний хувьд бол ... гээд Снегг мэдэлгүй зүүн гараа илэхэд Харри тэнд хар тамга байгаа болохыг мэдэж байв.

- Би зөвхөн ойлгохыг хүссэн юм. Яагаад ... гэж Харри ахин эхлэхдээ эелдэгээр ярихыг хичээв.

- Чи могойн тархинд орсны учир нь энэ үед Хар лорд тэнд байсан юм. Тэр үед могойг эзэмдсэн байсан учир дотор нь байгаа гэж зүүдэлсэн хэрэг.

- Тэгээд Вол ... тэр намайг байгаа гэдгийг ойлгосон болов уу?
- Тэгсэн байх гэж Снегг хүйтнээр хэлэв.
- Та хаанаас мэдээ вэ? Энэ зөвхөн Дамблдорын таавар юм уу? Эсвэл ...
- Би чамд намайг ноёнтоон гэж дууд хэлсэн биз дээ гээд Снегг нүдээ нарийсган сандлаасаа бослоо.
- Тиймээ, ноёнтоон. Гэхдээ та хаанаас мэдэж байгаа юм ... гэж Харри тэвчээргүйхэн хэлэв.
- Бид хангалттай зүйл мэднэ. Хамгийн чухал нь гэвэл Хар лорд одоо бүгдийг мэдсэн. Тэр энэ байдалд дүгнэлт хийгээд эсрэгээр нь ашиглаж болзошгүй. Цаашдаа тэр чиний бодолд нэвтэрдгийг чинь ойлгоод ...
- Тэр намайг юм хийлгэхээр оролдох болов уу? гэж Харри асуугаад, Ноёнтоон гэж яаран нэмэрлэв.
- Бүрэн боломжтой. Үүнээс окклюменций аврах болно гэж Снегг хайхрамжгүй хэлэв.

Тэр жанчныхаа дотоод халааснаас шидэт саваа гаргахад Харри сандалдаа атийлаа. Гэвч Снегг түүнийг зөвхөн чамархайдаа хүргэв. Түүнийг саваагаа холдуулахад аалзны шүлс мэт мөнгөлөг зүйл гарч зузаан гүн ухааны цүнхээлд орлоо. Снегг хоёр ч удаа саваагаа хүргэн мөнгөлөг зүйл гарган авч чулуун суулганд хийгээд Харри руу эргэн харж саваагаа бэлхэн барилаа.

- Бос, Поттер шидэт саваагаа хураалга.

Харри хөл дээрээ бухимдангуй босов. Тэд урд урдаасаа бие биенээ харав.

- Магадгүй чи савааны тусламжтай намайг зэвсэггүй болгох юм уу ямар нэг аргаар хамгаалж болох юм гэж Снегг хэлэв.

- Харин та юу хийх гэж байгаа юм ? гэж Харри асуугаад саваа руу түгшин харлаа.

- Би оюун ухаанд чинь цөмрөх гэж байна. Хэр тэсэхийг чинь харъя. Би чиний Имperiус шившлэгийг эсэргүүцэх чадвартайг чинь сонссон. Харин одоо энд адил амжилт гаргах эсэхийг харцгаая. Одоо төвлөр. Легилеменс!

Харри бэлтгэж амжсангүй, Снегг ч түүнийг хүлээсэнгүй. Өрөө нүдний өмнө

эрээлжлэн алга болж тархинд нь кино хальс шиг хурц тод дүрсүүд эргэлдлээ.

Тэр таван настай байлаа. Дадли түүний урдуур шинэ улаан дугуйтайгаа явахад зүрхэнд нь атаархах сэтгэл оволзов ... Түүнийг Риппер нэртэй бульдог нохой мод руу хөөн гаргахад Дурслийнхан зүлгэн дээр инээлдэн зогсож байна ... Тэр Хуваарилагч бүрхтэй суугаад түүнийг Слизеринд элс гэж хэлж байна ... Гермiona эмнэлгийн орон дээр бүх нүүр нь үстэй хэвтэж байна ... Зуугаад Дементорууд харанхуй нуурын дэргэдээс хөвөн ойртлоо ... Чжоу Чанг түүнтэй цагаан боронзын дор зогсоод ...

«Үгүй» гэх хоолой Чжоугын тухай дурсамж гарч ирэхэд түүний толгойд сонсогдлоо.

«Чи үүнийг харахгүй, чи үүнийг харахгүй, энэ зөвхөн минийх».

Харри өвдөг нь янгинан өвдөхийг мэдэрлээ. Нүдний өмнө ахин Снеггийн өрөө байх агаад шалан дээр унахдаа өвдөгөө ширээнд өвдтөл цохьжээ. Тэр Снегг рүү харахад саваагаа буулгаад бугуйгаа үрж байв. Бугуйн дээр нь түлэгдсэн юм шиг сорви бий болжээ.

- Чи Түлдэг шидээр хамгаалахыг хүсээ юу?
- Үгүй гэж Харри ууртай хэлээд бослоо.
- Би ч тэгж бодсон юмаа. Чи хяналтаа алдаад намайг хэтэрхий хол явууллаа.
- Та миний харсан бүх зүйлийг харсан уу? гэж Харри асуухдаа хариултыг нь сонсохыг хүсч байгаадаа итгэлгүй байлаа.
- Жаахан л гэж Снегг уруулаа мушийлган хэлээд,
- Хэн бульдогийг явуулсан юм? гэв.
- Нагац эгч Марж гэж Харри хэлэхдээ дотроо Снеггийг үзэн ядлаа.
- Анхны удаад гэхэд санаснаас муугүй байлаа гээд Снегг ахин саваагаа өргөнгөө, Хэдийгээр чи хашгирч энергээ үрсэн ч гэсэн намайг зогсоож чадлаа. Чи төвлөрөх ёстой. Бодолдоо няцаавал саваагаа хайн гүйх шаардлага гарахгүй гэв.
- Би хичээсэн гэхдээ та надад яаж гэдгийг нь хэлсэнгүй шүү дээ! хэмээн Харри ууртай хэлэв.
- Хүндэтгэл хэрэгтэй шүү, Поттер гэж Снегг аюултайгаар хэлээд, Харин одоо нүдээ ань гэлээ.

Харри түүн рүү зэвүүцэн харлаа. Снеггийн чиглүүлсэн саваан дор нүдээ анин зогсох өчүүхэн ч хүсэл байсангүй.

- Ой ухаанаа хоосол, Поттер. Бүх сэтгэл хөдлөлөө чөлөөл гэж хүйтэн хоолой тушаалаа.

Гэвч уур хилэн Харрийн судсаар могойн хор шиг нэвчив. Уур хилэнгээ чөлөөлөх гэнээ? Тэгснээс хөлөө салгасан нь дээр биз ...

- Та намайг сонссонгүй, Поттер. Таны сахилга бат хангалтгүй бололтой ... Одоо төвлөр.

Харри бодохгүй, санахгүй, мэдрэхгүйгээр ой ухаанаа хоослохыг хичээлээ.

- Ахин нэг удаа оролдоод үзье. Гурав хүртэл тоолно. Нэг ... хоёр ... гурав ...

Легилименс!

Түүний өмнө аварга том хар луу байна ... Эцэг эх нь шидэт тольноос даллаж байна ... Седрик Диггори газар дээр хэвтээд гөлийсөн нүдээрээ ширтэж байна.

- Үгүй ээ!

Харри нүүрээ гараараа дарж ахин өвдөглөн унахад хэн нэг нь тархи руу нь балбаж байгаа мэт янгинан өвдлөө.

- Бос! гэж Снегг тушаагаад,

- Бос! Чи хичээгээгүй учраас амжилт гаргасангүй. Чи намайг дурсамжын айдас руугаа оруулахыг зөвшөөрч өөрөө зэвсгээ өгч байна! гэв.

Харри босоход Седрикийн оршуулгын газар хэвтэж байсан үхсэн биеийг жинхэнээсээ харсан аятай зүрх нь галзуурсан мэт цохилон. Снегг ердийнхөөсөө цонхийн цайж уурласан ч Харрийн ууртай эн зэрэгцсэнгүй.

- Би ... тэмцэхийг ... хичээсэн гэж Харри шүд зуун хэлэв.

- Би чамайг сэтгэл хөдлөлөө чөлөөл гэж хэлсэн!

- Тиймүү? Гэхдээ одоо надад энэ хэцүү байна гэж Харри дүрсхийлээ.

- Тэгвэл чи өөрийгөө Хар лордын хөнгөн олз болгоно гэж Снегг хэрцгийгээр уурсан хашгираад,

- Өөрийн мэдрэмжээ хянаж чаддаггүй гунигтай дурсамжандаа автсан тэнэгүүд амархан өдөөлөгт автдаг юм. Өөрөөр хэлбэл сул дорой хүмүүст тэмцэх

боломж байдаггүй. Тэр таны ухаанд яг л тосонд шигдсэн хутга шиг орно, Поттер! гэв.

- Би сул дорой биш гэж Харри нам дуугаар хэлэхэд уур хилэн нь буцалж Снегг рүү энэ агшинд дайрахад бэлэн байв.

- Тэгвэл үүнийгээ батал! Өөрийгөө гартаа ав! гэж Снегг зандрав. Уур хилэнгээ хяна! Ухаан бодлоо эзэмд! Бид ахин нэг удаа оролдоод үзье. Бэлэн үү! Легилеминс!

Вернон ах шуудангийн нүхийг хадаасаар хадаж байна ... Зуугаад Дементорууд түүн рүү нууран дээгүүр ойртож байна ... Тэр цонхгүй хонгилд ноён Уизлигийн хамтаар гүйж байна ... Тэд хонгилын эцсийн хар хаалганд ойртлоо ... Харри түүгээр орох гэж бодсон ч ... ноён Уизли түүнийг зүүн тийш эргүүлээд доош чулуун шатаар ...

- Би Ойлголоо! Ойлголоо!

Тэр ахиад л Снеггийн өрөөнд дөрвөн хөллөн хэвтээд сорви нь хатгуулж байсан ч амнаас нь баяртай дуу гарлаа. Тэр босоод шидэт саваагаа өргөсөн Снегг рүү харав. Энэ удаад Снегг Харриг тэмцэж эхлэхээс өмнө шидийг тайлсан бололтой.

- Юу болсон бэ, Поттер? гэж тэр асуугаад Харри руу сонирхон харав.

- Би харсан ... би санасан ... би одоо л ойлголоо гэж Харри амьсгаадан хэлэв.

- Юу ойлгосон гэж?

Харри даруй хариу хэлсэнгүй. Тэр духаа үрэн энэ харалтын агшинд баярлалаа.

Тэр хонгилын эцэст байдаг цоожтой хаалганы тухай сарын турш зүүдлэхдээ бодит газар гэдгийг нь ойлгоогүй байна. Харин одоо дурсамжиндаа хараад энэ бүх хугацаанд ноён Уизлитай найман сарын арван хоёронд шүүгчдийн танхим руу гүйхдээ дэргэдүүр нь өнгөрсөн хаалга зүүдлэгдсэн болохыг ойлгов. Хонгил нууцын хэлтсийнх бөгөөд ноён Уизли тэнд Волдемортын могой дайрах үед сууж байсан билээ.

Харри Снегг рүү харав.

- Нууцын хэлтсийн дотор юу байгаа юм бэ?

- Чи юу хэлсэн бэ? гэж Снегг аяархан асуухад Харри бухимдаж эхлэхийг нь баясан харлаа.

- Би нууцын хэлтсийн дотор юу байгаа юм бэ гэж асуусан, ноёнтоон?

- Яагаад ийм асуулт асууж байгаа юм?
 - Учир нь миний сая харсан хонгил гээд Харри Снеггийн царай луу анхааралтай ширтэж,
 - Надад хэдэн сарын өмнөөс зүүдлэгдсэн болохоор ... би сая л танилаа. Тэр нууцын хэлтсийнх ... Волдемортод хэрэгтэй зүйл түүний дотор байгаа ... гэв.
 - Би чамд Хар лордын нэрий хэлэхийг хориглосон!
- Тэд бие бие рүүгээ муухай харлаа. Харрийн сорви ахин халуу шатан өвдөхөд тоосонгүй. Снегг сэтгэл түгшсэн ч хайхрамжгүй маягтай,
- Нууцын хэлтэст олон янзын зүйл бий, Поттер. Гэхдээ чамд хамааралтай зүйл юу ч байхгүй. Би ойлгомжтой хэлэв үү? гэв.
 - Тиймээ гэж Харри хэлээд халуу төөнөж байгаа сорвио үрлээ.
 - Лхагва гаригт энэ цагтаа шүү. Бид ажлаа үргэлжлүүлэх болно.
 - Сайн байна гэж Харри хэллээ. Тэр Снеггийн өрөөнөөс даруй гарч Рон, Гермиона хоёрыг хайхыг хүслээ.
 - Шөнө болгон унтахын өмнө сэтгэл хөдлөлөө чөлөөлж бай. Чи цэвэрлэгдэж, ухаан санаагаа хоослон, тайван байх ёстой. Ойлгомжтой юу?
 - Тиймээ гэж Харри хэлэхэдээ бараг сонссонгүй.
 - Ингээд анхааруулахад, Поттер ... хэрвээ би чамайг сургуулилаагүй гэж мэдэх юм бол.
 - Ойлголоо.

Харри цүнхээ мөрөндөө тохож өрөөнөөс яаран гарлаа. Хаалга ойнгойлгохдоо Снегг рүү хяламхийн харвал цаашаа харан зогсоод гүн ухааны цүнхээл рүү саваагаараа бодлоо хянамгай хийж байв. Харри чимээгүйхэн гарч хаалга хаахад сорви нь өвдсөн хэвээр байв.

Рон, Гермиона хоёрыг номын санд Амбрижийн гэрийн даалгаварыг хийж байхад нь оллоо. Цонхны цаадах тэнгэр харанхуйлжээ. Тавдугаар дамжааныхан голдуу сурагчид лааны гэрэл дор суугаад хамраа сурах бичигт шигтгэн үзгээрээ сараачина. Энд зөвхөн хатагтай Пинсийн шаахайгаа аяархан чахруулан эгнээ хоорондуур мярааж үнэт ном руугаа бөхийсөн хүний шилэн хүзүүн дээр заналхийлэн амьсгалахаас ондоо чимээ үгүй байв.

Харри сорви өвдсөн хэвээр халуунтай хүн шиг чичирч байв. Найзуудынхаа урдаас харан суугаад тусгалаа эсрэг талын цонхонд харахад царай нь зэвхийрч, сорви нь ердийнхөөс тод болсон байв.

- Ямар болж өнгөрөв дөө? Чи зүгээр үү, Харри? гэж Гермиона халамжлангуй шивнэв.

- Сайн ... мэдэхгүй байна гээд Харри сорви нь ахин өвдөхөд үрчийлээ. Сонсооч ... би юу ойлгосон гээч.

Ингээд тэдэнд Снегийн өрөөнд юу харсан тухайгаа ярилаа.

- Чиний бодлоор Хэцүү нэртийн араас нь хөөцөлдөж байгаа зэвсэг ид шидийн яаманд байгаа хэрэг үү? гэж Рон дэргэдүүр нь хатагтай Пинс өнгөрөхөд шивнэв.

- Нууцын хэлтэст байж болох юм. Би энэ хаалгыг эцэг чинь сонсгол руу дагуулан уруудахад харсан юм. Тэр түүнийг могой дайрах үед хамгаалж байсан.

Гермиона гүнзгий санаа алдав.

- Тэгэлгүй яахав.

- Юу тэгэлгүй яахав? гэж Рон тэвчээргүйхэн асуулаа.

- Рон, чи өөрөө бодоод үз дээ ... Стержис Подмор ид шидийн яамны нууц хаалга руу нэвтрэхийг оролдсон. Энэ хэтэрхий олон тохиолдол биш үү?

- Стержис манай тал байж яагаад тийшээ нэвтрэхийг оролдсон юм бол? хэмээн Рон асуув.

- Ойлгох юм алга. Энэ ч хачирхалтай хэрэг байна гэж Гермиона хэллээ.

- Нууцын хэлтэсийн дотор юу байгаа юм бол? Эцэг чинь чамд энэ тухай ярьж байгаагүй юу? гэж Харри асуулаа.

- Зөвхөн «хэлж боломгүй» хүмүүс тэнд ажилладаг гэдгийг л мэднэ. Минийхээр бол тэд юу хийдгийг хэн ч мэдэхгүй байх. Гэхдээ тэнд зэвсэг хадгалахад хачирхалтай газар байна гэж Рон хэллээ.

- Ямар ч хачирхалтай зүйл алга. Хамгийн тохиромжтой. Ид шидийн яамнаас бүтээж буй ямар нэг нууц зүйл байдаг биз. Харри чи өвдөөгүй биз? гэж Гермиона дуугарав.

Харри энэ үед алгаараа духаа үрж байснаа илж байгаа юм шиг харагдахыг хичээв.

- Тиймээ ... зүгээр. Би жаахан л ... Надад окклюменций таалагдсангүй гээд гараа буулгахад чичигнэлээ.

- Би хэн нэгний оюун ухаан руу довтлох үед суларч доройтдог гэж бодож байна. Алив амралтын өрөө рүүгээ явцгаая тэнд тухтай.

Гэвч амралтын өрөөгөөр дүүрэн хүн байсан бөгөөд дүүрэн инээд хөөр хадна. Фред, Жорж хоёр тоглоомын дэлгүүрийн сүүлийн үеийн шинэ бараагаа танилцуулж байв.

- Толгойгүй болгодог малгай! гэж Жорж хашгирахад Фред ягаан өдөөр чимэглэсэн сурагчын шовгор оройтой бүрх малгай даллав. Нэг нь хоёр галлеон. Одоо Фредийг харцгаагаарай!

Баясан гийсэн Фред малгайг толгойдоо углалаа. Эхний секундэнд тэр ихээхэн тэнэг төрхтэй харагдсанаа дараа нь толгой нь алга болов.

Хэдэн охид айн хашгирсан ч ихэнхи хүүхдүүд инээлдэв.

- Харин одоо тайллаа! гэж Жорж мэдэгдээд Фредийн мөрөн дээгүүр гараараа тэмтчихэд толгой нь ахин ягаан өдтэй малгайны дороос гарч ирлээ.

- Энэ малгайг яаж хийсэн юм бол? Хэмээн Гермiona гэрийн даалгавараасаа сатааран хэлээд, Энэ ямар нэг үл үзэгдэх шидийг ухаалгаар ашигласан нь ойлгомжтой ч шившүүлсэн биетийг яаж хүрээлж байгаа нь сонирхолтой ... энэ шид удаан үйлчлэхгүй гэж бодож байна гэв.

Харри өвдсөндөө хариулсангүй.

- Маргааш үргэлжлүүлэхээс гээд тэр номоо хааж цүнхэндээ хийлээ.

- Тэгвэл гэрийн даалгаварын төлөвлөгөөндөө бич! Мартахгүйн тулд! гэж Гермiona зөвлөв.

Харри Рон руу харснаа цүнхнээсээ даалгавар төлөвлөгч гаргаад итгэлгүйхэн эргүүлэв.

- Одоо хийчих юмыг дараа гэж хойш бүү тавьж бай! гэж дэвтэр хашгирахад

Харри Амбрижийн гэрийн даалгавар гэж сараачлаа. Гермiona баясан гийв.

- Би явж унтлаа гээд Харри даалгавар төлөвлөгчийг цүнхэндээ хийхдээ анхны боломжтой агшинд ханан зуух руу хийхээр шийджээ.

Тэр амралтын өрөөн дундуур явж Толгойгүй болгодог малгай өмсгөх гэсэн Жоржоос

зайлсхийн холдоод хүйтэн сэрүүн шатаар өгсөж унтлагын өрөө рүү өгслөө. Дотор нь могой зүүдлэсэн шөнө шиг муухайрч байсан ч жаахан хэвтвэл зүгээр болно гэж бодов.

Харри унтлагын өрөөний үүдийг нээн алхам урагшилахад тархи нь хагарах шахам өвдөв. Тэр зогсож хэвтэж байгаа эсэхээ ч ойлгосонгүй, нэрээ ч санасангүй.

Чихэнд нь галзуу мэт инээд хадан ... маш урт хугацаанд аз жаргалтай байгаагүй юм шиг баяртай байна ... тэр баярлаж, хөөрч, цэнгэж байна ... ямар нэгэн гайхамшигтай зүйл болсон байна.

- Харри? Харри!

Хэн нэгэн нүүр лүү нь алгадав. Ухаангүй инээд өвдсөн хашгиралт болон хувирлаа. Баяр хөөр түүнийг орхин гарсан ч инээд үргэлжилсээр ...

Тэр нүдээ нээгээд зэрлэг инээд амнаас нь гарч байгааг ойлгов. Ойлгомгоц инээд зогслоо.

Харри шалан дээр хэвтээд хүндээр амьсгаадан адар руу харахад сорви нь тэсвэрлэхийн аргагүй өвдөв. Түүн рүү айсан Рон тонгойж харагдана.

- Юу болоо вэ?

- Мэдэхгүй. Тэр жаргалтай байна ... зүгээр л аз жаргалтай байна ... гээд Харри амьсгаадсаар өндийн суув.

- Хэцүү нэрт үү?

- Ямар нэг сайхан юм болж. Ямар нэгэн зүйлд тэр найдаж байна гэж хэлэхэд дотор нь ноён Уизлиг могой дайрсан үеийнх шиг дотор нь муухай оргив.

Тэр Гриффиндорын хувцас солих өрөөнд байхдаа энэ үгнүүд амнаас нь гарахад хачирхалтайгаар үнэн гэдийг мэдсэн. Харри Рон руу бөөлжихгүйн тулд гүн амьсгал авангаа энэ удаад Симус, Дин хоёрыг хараагүйд баярлав.

- Гермiona явж чамайг харахыг гуйсан гэж Рон аяархан хэлээд босоход нь туслангаа, Чиний хамгаалах хүч Снеггийн ухаан руу чинь нэвтрэх оролдлогын дараа доройтсон байгаа гэж хэлсэн ... Гэхдээ дараа нь ашигтай болно гэж бодож байгаа юм гэв.

Рон түүн рүү эргэлзэн хараад орон дээр суулгав. Харри итгэлгүйхэн толгой дохиод дэрээ дэрлэн хэвтлээ. Олон тооны шалан дээр уналтын дараа сорви нь төдийгүй бүх

бие нь өвдөж байлаа. Түүний окклюменцийн анхны оролдлого хүчтэй болгох нь битгий хэл эсрэгээрээ сул дорой болгосныг мэдрээд юу тэгж арван дөрвөн жилийн дараа Волдемортыг аз жаргалтай болгосон юм бол гэж түгшин бодов.

БҮЛЭГ 25: УТСАН ДЭЭРХ ЦОХ

Харри асуултынхаа хариуг маргааш авлаа. Гермiona «Өдөр тутмын зөнч» сонин ирэх үед дэлгэж эхний нүүрийг харснаа дуу алдахад ойр хавьд сууж байсан бүх хүмүүс эргэж харав.

- Яасан? гэж Рон, Харри хоёр зэрэг асуулаа.

Тэр хариулахын оронд сонингоо урд нь дэлгэж тэргүүн нүүрэнд нийтлэгдсэн арван ширхэг хар цагаан зургийг үзүүлэв. Есөн эрэгтэй болон, нэг эмэгтэйн зураг байлаа. Зарим нэг нь чимээгүйхэн ярзайн инээж, нөгөө нэг нь хуруугаараа зурагний хүрээ балбана. Хүн бүрийн зураг дээр хоригдлын нэр байлаа.

«Антонин Долохов. Гидеона болон Фабиана Пруэттовыг хэрцгийгээр хөнөөсний улмаас яллагдсан» гэж өндөр туранхай биетэй Харри руу шоолонгуй харж байгаа шидтэний дор бичжээ.

«Август Руквуд. Ид шидийн яамны нууцыг Хэцүү нэртэд задруулсаны улмаас яллагдсан» гэж сэвхтэй царай, тослог үстэй зурагны хүрээ наан уйтгарласан янзтай зогсож байгаа шидтэний дор бичжээ.

Гэхдээ Харрийн анхаарлыг эмэгтэйн зураг татав. Өтгөн сэгсгэр үс нь өнгөрсөн удаа харсны адил гялалзаж байлаа. Тэр түүн рүү нүд зовхин дороосоо муухай харж нарийхан уруулдаа басамжилсан инээмсэглэл тодруулав. Сириусын адил Азкабанд удаан хоригдсон ч гэлээ гоо үзэсгэлэнгээ хадгалан авч үлджээ.

«Беллатриса Лестрейнж Фрэнк болон Алис Долгопусыг тамласаны улмаас яллагдсан».

Гермиона Харриг нудраад зургийн дээд талын гарчгийг заалаа.

АЗКАБАНЫ ШОРОНГООС БҮЛЭГ ГЭМТ ХЭРЭГТЭНГҮҮД ОРГОЛОО ИД ШИДИЙН ЯАМНААС ХУУЧИН ҮХЭЛ ЗАЛГИГЧ БЛЭКИЙГ НЭГДСЭН БОЛОВ УУ ГЭЖ АЙЖ БАЙНА.

- Блэк гэнээ? Яагаад тэр вэ? гэж Харри чанга хэлэв.

- Чшш! Чимээгүй. Аман дотроо унш! гэж Гермiona шивнэв.

Өчигдөр орой ид шидийн яамнаас Азкабаны шоронгоос бүлэг гэмт хэрэгтэн оргосон гэж мэдээллээ.

Ид шидийн яамны сайд Корнелиус Фаж ажлын өрөөндөө сурвалжлагчид ярилцлага

өгөхдөө хэдхэн цагийн өмнө онц аюултай гэмт хэрэгтэнгүүд зугтсан гэдгийг баталсан бөгөөд маглуудын ерөнхий сайдад энэ тухай мэдэгдсэн гэжээ.

«Ихэд харамсалтай нь шоронгоос хоёр жилийн өмнө Блэк оргож байсантай адил үйл явдал давтагдлаа» гэж өчигдөр үдэш Фаж мэдэгдсэн байна.

- Гэхдээ бид энэ хоёр тохиолдлын хооронд уялдаа холбоо олж харахгүй байна. Оргодолуудад гаднаас тусламж үзүүлсэн гэж үзэж байгаа бөгөөд Блэкийн Азкабанаас зугтсан түүхийг эргэн санаж үзвэл туслагчын дүрд сайхан зохицож байгаа юм. Түүнчлэн оргосон гэмт хэрэгтнүүдийн тоонд Блэкийн үеэл эгч Беллатрис Лейстрэнж орсон болохоор Блэкийг удирдсан байх гэж үзэх бүрэн боломжтой. Тийм учраас бид эдгээр гэмт хэрэгтэнгүүдийг бүх хүчээ дайчлан хайх бөгөөд шидтэнгүүдийн ертөнцөд болгоомжтой байхыг анхааруулж байна. Ямар ч тохиолдолд эдгээр гэмт хэрэгтэнгүүдэд ойртож болохгүй.

- Чиний таавар, Харри. Тэр яагаад өнгөрсөн шөнө баярласан нь ийм учиртай байж хэмээн гайхаж мэгдсэн Рон хэлэв.

- Итгэж ч чадахгүй нь. Фаж орголтонд Сириусыг яаж буруутгаж чадаж байна аа? гэж Харри уурслаа.

- Түүнд өөр хэн үлдсэн гэж? хэмээн Гермiona гашуунаар хэлээд,

- «Уучлаарай, эрхэмүүдээ Дамблдор надад Азкабаны харгалзагчид лорд Волдемортын талд орон ийм явдал болж магадгүй гэж анхааруулсан ... (гонгинохоо боль доо, Рон) харин одоо түүний хамгийн аюултай дэмжигчид чөлөөтэй боллоо гэж хэлэх хэрэг үү?» Ойлгож байна уу, тэр сүүлчийн хагас жилийн турш хүн бүрт Дамблдор та хоёрыг худалч гэж хэлж байсан биз дээ?

Тэр хуудсыг эргүүлээд мэдээллийг цааш уншихад Харри Их танхим руу харлаа. Тэр яагаад сурагчдыг тэргүүн нүүрэнд гарсан аймшигтай мэдээнээс эмээхгүй байгааг ойлгож чадаагүй ч үнэн хэрэгтээ Гермionaгийн адил сонинг өдөр тутам цөөн тооны хүн авдаг байлаа. Тэднийг гэрийн даалгавар, квиддич болон өөр бусад дэмий зүйлсийн тухай ярилцан сууж байх хооронд Волдемортод арван Үхэл залгигч нэгдээд байдаг.

Тэр багш нарын ширээ рүү харлаа. Тэнд дүр зураг өөр харагдав. Дамблдор МакГонагаллтай гүнзгий яриа өрнүүлж хоёулангийнх нь царай сэтгэл зовсон төрхтэй харагдав. Профессор Стебль «Зөнч» сонин сүмсний шил түшүүлэн тавиад эхний

нүүрэн дээр төвлөрөхдөө хөндий барьсан халбаганаас нь өвдөг рүү нь өндөгний шар дуслахыг анзаарсангүй. Харин ширээний үзүүрт суусан профессор Амбриж будаа идэж байв. Түүний зовхин дорх бүлцгэр бахын нүд нь танхим дундуур сахилга зөрчигчийг хайн тэнэсэнгүй. Хоолоо ам руугаа халбагадах зуураа үе үе Дамблдор, МакГонагалл хоёр луу ууртай хяламхийнэ.

- Өө, бурхан минь гэж сонингоо үргэлжлүүлэн уншиж байсан Гермiona дуу алдав.

- Бас яагаа вэ? гэж Харри асуулаа. Түүний мэдрэл хөвчирчээ.

- Аймшигтай юм гээд Гермiona чичирснээ сонингийн арав дахь хуудсыг эргүүлж Харри, Рон хоёрт дөхүүлэв.

ИД ШИДИЙН ЯАМНЫ АЛБАН ХААГЧ ЭМГЭНЭЛТЭЙГЭЭР ҮХЛЭЭ

Өчигдөр үдэш Гэгээн Мунгогийн эмнэлэгээс ид шидийн яамны албан хаагч Бродерик

Боудыг орондоо тасалгааны ургамалдаа боомилуулсан байхыг нь олсон гэж мэдэгдлээ. Болсон үйл явдалын дараа анагаагчид ноён Боудыг сэхээж чадаагүй бөгөөд золгүй тохиолдлоор өрөөндөө нас барсан байна.

Уг явдал болох үед жижүүрлэж байсан анагаагч Мириам Страутыг ажлаас халсан бөгөөд эмнэлэгийн төлөөлөгч сэтгүүлчдэд «Гэгээн Мунгогийн эмнэлэгээс ноён Боудын үхэлд гүнээ харамсаж байна гэж мэдэгджээ».

Бид ерөнхий журмын дагуу анагаагч Страутыг өрөөнд нэвтрэхийг зөвшөөрсөн ч зул сарын баярын бэлэг гардуулан завгүй байх үедээ ноён Боудын хажуугийн шүүгээн дээр тавьсан онц аюултай ургамалд анхаарал хандуулаагүй байна. Түүний хэл яриа дээрдэж байсан бөгөөд анагаагч Страутыг явсан хойгуур гэмгүй төрхтэй чөтгөрийн ургамал ноён Боудыг агшин зуур боомилжээ.

Эмнэлэгээс ургамал ямар аргаар өрөөнд орсныг тайлбарлаж чадаагүй ч бүх шидтгэнгүүдээс уучлал гуйж байна гэжээ.

- Боуд ... Нэг л танил нэр байх чинь гэж Рон хэлэв.

- Бид түүнийг харсан шүү дээ. Санаж байна уу эмнэлэгт? Туг үсийн эсрэг талын орон дээр адар ширтээд хэвтэж байсан. Бас чөтгөрийн ургамалыг яаж авчирсан болохыг ч харсан. Анагаагч хэлэхдээ зул сарын бэлэг гэж хэлсэн биз дээ.

Харри ахин нийтлэл рүү харлаа. Айдас түүний хоолойг атгажээ.

- Бид яагаад чөтгөрийн ургамалыг таньсангүй вэ? Бид түүнийг урьд нь харж байсан ... бид болсон явдалд саад болж чадах байсан ...

- Хэн чөтгөрийн ургамал тасалгааны ургамалын саванд суулгаастай ирнэ гэж бодох юм бэ? Үүнд бид биш тэр илгээсэн хүн буруутай! Тэр юу худалдаж авч байгаагаа шалгаагүй ёстой усан тэнэг байж дээ гэж Рон хэлэв.

- Өө, боль доо Рон. Би хэн нэг хүн чөтгөрийн ургамалыг танилгүй саванд суулгасан гэж бодохгүй байна. Тэд хүрсэн болгоныг л ороож авахыг хичээдэг. Энэ бол ... энэ бол аллага байсан ... зальжин ухаалаг аллага ... хэрвээ ургамалыг нэр нь үл мэдэгдэх хүн илгээсэн бол хэн хийснийг нь яаж мэдэх болж байна? гэж Гермiona чичирсэн хоолойгоор хэлэв.

Гэхдээ Харри чөтгөрийн ургамалын тухай бодсонгүй. Тэр сонсголын өдөр цахилгаан шатаар ид шидийн яамны арван давхар луу буухад үүдний танхимаас ногоовтор нүүртэй эрэгтэй хүн орж ирснийг саналаа.

- Би Боудыг мэднэ. Эцэгтэй чинь яам руу явахдаа харж байсан. Рон амаа ангайлаа.

- Аав түүний тухай ярьж байсныг санаж байна! Тэр нууцын хэлтэст ажилладаг! Хормын турш тэд бие бие рүүгээ ширтсэнээ дараа нь Гермiona сонингоо хумхиж эхний нүүрэн дээр байгаа Үхэл залгигчад руу ууртай харангаа босов.

- Чи хаачих нь вэ? гэж Рон асуув.

- Захиа илгээе. Бүтэх эсэхийг нь мэдэхгүй л байна ... гэхдээ оролдож үзэх хэрэгтэй гээд Гермiona цүнхээ мөрөндөө өлгөв.

- Түүний биеэ хэрхэн авч явж байгааг тэвчиж чадахгүй нь гэж Рон Харрийн хамт Их танхимын үүд рүү явж байхдаа бувтналаа. Бидэнд хэлэхгүй бол үхэх гээд байгаа юм байх даа? Ердөө арван секунд л болно биз ... Хөөе, Хагрид!

Хагрид үүдний танхимын хаалган дээр зогсоод Когтевранчуудыг өнгөрөхийг хүлээж байв. Тэр аварга биетүүдийн даалгавараас ирсэн үеийнх шиг хөхөрсөн хэвээр хамрынх нь дээгүүр шинэхэн шарх харагдана.

- Амьдрал ямар байна даа? гээд тэр инээмсэглэхийг хичээсэн ч өвдсөндөө нүүрээ үрчийлгэв.

- Чи зүгээр үү, Хагрид? гэж Харри асуугаад Когтевранчуудын араас гарав.
- Сайн гэж Хагрид наргисан өнгөөр хэлээд гараа даллахдаа хажуугаараа өнгөрсөн профессор Векторыг золтол л цохьсонгүй. Жаахан завгүй л байна. Ойлгож байна уу ... хичээлдээ бэлтгэх хэрэгтэй ... хоёр саламандрын хайрс гэмтсэн ... надад туршилтын хугацаа өгсөн.
- Чамд туршилтын хугацаа өгсөн гэнээ? хэмээн Рон чанга асуухад эргэн тойрны хүүхдүүд сониучирхан харцгаав. Уучлаарай ... Үнэхээр туршилтын хугацаа гэж үү? хэмээн шивнэлээ.
- Тиймээ ... Үнэнийг хэлэхэд би өөр зүйл хүлээгээгүй. Та нар ажиглаагүй байж болох ч шалгалт тийм сайн болоогүй ... Явж саламандарын сүүлийг нунтаг халуун ногоогоор үрэхээс. Дараа уулзая хүүхдүүдээ.

Тэр хаалга руу сажилж чулуун шатаар уруудан нойтон нуга руу гарлаа. Харри түүний араас дагуулан харахдаа ахин нэг муу мэдээ дуулах юм бол тэвчих хүч хүрэхгүй нь гэж бодлоо.

Хагридаас сонссон туршилтын хугацааны мэдээ дараагийн өдрүүдэд сургууль даяар тарж Харрийн уурыг хүргэн бараг хэн ч үүнд санаагаар унасангүй бөгөөд ялангуяа Драко Малfoy тэргүүтэй хүмүүс баясаж байлаа. Ид шидийн яамны ажилтан гэгээн Мунгогийн эмнэлэгт хачирхалтайгаар үхсэн явдал зөвхөн тэдний урмыг хугалсан мэт санагдана. Хонгилд зөвхөн арван Үхэл залгигч зугтаасан тухай нэг л түүх өрнөж байлаа. Цуу ярианаас үзэхэд зарим оргодлууд Хогсмидэд үзэгдэж, Орилоо овооход нуугдан, Сириус Блэкийн адил Хогвартс руу нэвтрэхийг оролдож байгаа гэлцэнэ.

Шидтэний гэр бүлд төрж өссөн хүүхдүүд хар багаасаа Үхэл залгигчдын нэрийг мэдэх болохоор Хар лордын засаглаж байсан домогт үеийнх шиг айдас нөмөрчээ. Авга ах, нагац эгч болон үеэл ах нь тэдний гарт өртсөн Сьюзен Боунс ургамал судлалын хичээл дээр Харрид ямар байгааг одоо л ойлголоо гэж хэлжээ.

- Чиний яаж тэвчиж байгааг мэдэхгүй юм. Гэхдээ энэ бол аймшиг гэж тэр хэлээд хэтэрхий их лууны шивх үрслэгчийн тавиур руу хийхэд орилон мушгиралдлаа.

Тиймээ энэ үнэн байсан бөгөөд эдгээр өдрүүдэд Харриг хонгилд ахин зааж шивнэлдэх нь сэргэжээ. Тэр одоо тэднээс дайсагнал биш сониучирхалыг мэдэрч байв. Түүнчлэн нэг хоёр удаа хүүхдүүд Үхэл залгигчид Азкабаны хатуу

хамгаалалттай цайзаас яаж зугтсан тухай хэлэлцэж байхыг сонсчээ. Үүний цорын ганц тайлбар гэвэл өнгөрсөн жил тэдэнд Харри, Дамблдор хоёрын хатуу баталж байсан зүйл байлаа.

Зөвхөн сурагчдын байдал өөрчлөгдсөнгүй. Хонгилд профессорууд хоёр гурваараа нам дуугаар шивнэлдэн өнгөрөх зуураа ойр тойрондоо сурагчид байх юм бол яриагаа даруй больж байв.

- Тэд мэдээж багш нарын өрөөнд чөлөөтэй ярилцаж чадахгүй. Одоо тэнд Амбриж байгаа гэж Гермiona шившлэгийн танхимын өмнө зогсох МакГонагалл, Флитвик, Стебль нарын дэргэдүүр өнгөрөхдөө аяархан хэлэв.

- Тэднийг ямар нэгэн зүйл мэдсэн гэж бодож байна уу? гэж Рон асуугаад багш нар луу эргэн харлаа.

- Мэдсэн ч байсан гэсэн бид энэ тухай сонсож чадахгүй. Энэ хуулийн дараа ... хэд дэх дугаартай нь байлаа?

Азкабаны шоронгоос гэмт хэрэгтнүүд зугтсан өглөөний мэдээний дараа зарлалын самбар дээр ийм мэдээ гарчээ.

ХОГВАРТСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧЫН ТУШААЛ

Багш нар сурагчдад энэ сэдвээр мэдээлэл өгөхийг хатуу хориглож байна

Боловсролын тухай хуулийн хорин зургадугаар зүйл

Гарын үсэг зурсан. Ерөнхий байцаагч Долорес Жейн Амбриж

Энэ сүүлчийн хууль сурагчдын дунд хэтэрхий олон тооны шуугиан дэгдээлээ. Ли Жордан Амбриж Фред, Жорж хоёрыг арын ширээн дээр дэлбэрдэг зураг тоглох юм бол ангиас хөөж гаргана гэсэн шинэ хууль гаргасны дараа,

- Профессор, дэлбэрдэг зураг хар урлагтай ямар ч холбоогүй! Энэ таны хэлсэн мэдээлэл биш гэв.

Харри Жорданыг дараагийн удаа гараа цус болгосон байхыг харжээ. Харри түүнд муртлафын тосыг зөвлөв.

Тэр Амбрижийг хайрт Фажынх нь хамар дороос Азкабаны шоронгийн гэмт хэрэгтүүд зугтсанд арай зөөлрөх байх гэж боджээ. Гэхдээ үгүй байлаа түүний бүхий л хүсэл Хогвартсын амьдралд бүхий л талаар хувийн хяналтаа тогтооход чиглэсэн мэт санагдана. Тэр ойрын хугацаанд хамгийн багадаа нэг багшийг халахаар шийдсэн

бөгөөд профессор Трелони, Хагрид хоёрын хэн нь түүрүүнд вэ гэдэгт байлаа.

Мэргэ төлөг болон шидэт амьтаны хичээл болгон дээр Амбриж тэмдэглэлийн дэвтэртэйгээ ирж байв. Тэр бүгчим халуун цамхагын өрөөнд ханан зуухны дэргэд нуугдан Трелонид хүнд асуултууд тавин зовоож байлаа. Харрид Трелони удахгүй энэ их даралтыг тэсэлгүй нугарч унах вий гэсэн бодол төржээ. Хэдийгээр профессор цамхагтаа суухыг эрхэмлэдэг ч гэсэн Харри түүний хэдэн удаа хонгилд ямар нэг юм бувтнаж гараа савчин айсан янзтай мөрөн дээгүүрээ эргэж харсаар явахыг харсан бөгөөд дарсны үнэр хүчтэй ханхалуулж байв. Хэрвээ тэр Хагридад санаа зовоогүй бол түүнийг өрөвдөх байлаа. Гэхдээ тэдний нэгийг хөөж гаргахад хүрвэл Харрид нэг л сонголт байсан юм.

Харамсалтай нь Хагридыг хичээлдээ Трелонигоос дээр гэж хэлж болохгүй байв. Тэр Гермонагийн зөвөлгөөг даган тэдэнд аймшигтай зүйл үзүүлсэнгүй. Хичээл дээрээ сэтгэлээр унасан байдалтай биеэ хачин авч явж сурагчдад асуулт тавингаа цаг үргэлж Амбриж руу түгшин харж байлаа. Тэр Харри, Рон, Гермiona гуравтай өмнөх шигээ шууд харьцахаа больсон бөгөөд харанхуй болсон хойно ирэхийг хоригложээ.

Харрид Амбриж алхам бүрээр Хогвартсын амьдрал дахь баяр баясгалан бүрийг сүйрүүлж байх шиг санагдав. Хагридын овоохойд айлчлах, Сириусээс захиа ирэх, квиддичийн «Аянга» гээд л. Тэр зөвхөн үүнээс ДА-гийн хичээлээ эрчимжүүлснээр хариугаа авч чадах байв.

Тэр арван Үхэл залгигч зугтсан тухай мэдээ бүгдийг тэр дундаа Захария Смитийг хүртэл идэвхтэй болгосныг ажиглав. Гэхдээ тэдний хэнд ч энэ нь Невиллийн адил хүчтэй нөлөөлсөнгүй. Эцэг эхийг тамласан алуурчин эрх чөлөөтэй зугаалж яваа мэдээ түүнийг хачирхалтай тэр ч байтугай айдас хүрэм тал руу нь эргүүлжээ. Тэр нэг ч удаа Харри, Рон, Гермiona гуравтай гэгээн Мунгогийн эмнэлэг уулзсан тухайгаа ярьсангүйд тэд түүнийг жишээг дагалдан бас чимээгүй байлаа. Бас Беллатрис Лестренжийн зугталтын тухай нэг ч үг цухуйлгасангүй. Тэрбээр одоо ДА-гийнхантай бараг ярилцалгүй Харрийн тэдэнд үзүүлсэн шившлэг бүр дээр шаргуу бэлтгэл хийхдээ уруулаа ууртай хазлан юунд ч анхаарал хандуулдаггүй байв. Үүний хүчинд маш хурдан сайжирлаа. Харри тэдэнд шившлэг буцаж ойлгодог Бамбай шидийг заах үед зөвхөн Невилл, Гермiona хоёр л эзэмшиж чаджээ.

Харрийн окклюменцийн хичээлд амжилт гаргах нь Невилл ДА-гийн хичээл суралцсантай адил зүйл болов. Хэдийгээр Снеггийн хичээл амжилтгүй эхэлсэн ч

гэлээ сайн тал руугаа өөрчлөгдсөнгүй. Эсрэгээрээ хичээл болгон дээр суларч байлаа.

Тэр окклюменцийг сурч эхлэх үед сорви нь хааяа нэг юмуу ердийнхөөрөө шөнө эсвэл Волдемортын сэтгэл хөдлөлийг мэдрэх үед өвддөг байв. Одоо энэ нь байнга шахуу өвдөх болсон бөгөөд Волдемортын сэтгэл хөдлөлийг дамжин үзүүлдэг агаарын антен болон хувирсан юм шиг дотор нь жигшүүртэй мэдрэмж төрөхөд Снеггийн окклюменцийн эхний хичээлээс үүсэлтэй гэдэгт эргэлзсэнгүй. Тэр одоо шөнө болгон зүүдэлж нууцын хэлтсийн хонгилоор тэнүүчилэн хар хаалгаар нэвтрэхийг зовж тарчлан хүсэх болсон байна.

- Магадгүй энэ өвчин байх гэж Гермиона түүнийг айдсаа яриахд нь сэтгэл зовон хэлээд,

- Халууралт шиг. Эхэндээ муу байгаа ч дараа нь дээрдэх байх гэв.

- Снеггийн хичээл улам дор болж байна. Миний сорви өвдөж шөнө болгон энэ хонгилоор явж байна. Энэ хаалга нээгдээсэй билээ гэв.

- Битгий тэгж бод. Дамблдор чамайг хаалганы тухай зүүдээ болиосой гэж хүссэн болохоор Снеггэд окклюменций сургахыг даалгасан. Чи зүгээр л илүү хичээх хэрэгтэй.

- Би хичээж л байна! Оролдож байна ... Снегг чиний тархи руу орохыг оролдох нь ... таатай биш гэдгийг мэднэ биз дээ! гэж Харри уурсан хэлэв.

- Хэрвээ ... гэж Рон удаанаар хэлэв.

- Хэрвээ гэдэг чинь юу гэж байгаа юм? хэмээн Гермиона дүрсхийв.

- Хэрвээ Харри оюун ухаанаа хааж чадахгүйдээ буруугүй бол гэж Рон баргар царайлан тайлбарлав.

- Чи юу хэлэхийг хүсээ вэ? гэж Гермиона асуулаа.

- Магадгүй Снегг Харрид туслахыг хүсэхгүй байж болох юм ...

Харри, Гермиона хоёр түүн рүү харлаа. Рон баргар царайлан тэдэн рүү ширтсэнээ,

- Магадгүй Снегг үнэн хэрэгтээ Харрийн ой ухааныг илүү дэлгэр нээлттэй болгохыг хүсч ... Хэцүү нэртэд амархан болгохын тулд ... гэж аяархан дуугарлаа.

- Амаа тат, Рон. Хичнээн удаа чамд Снеггийг сэжиглэх хэрэггүй гэж хэлэх юм бэ? Дамблдор түүнд итгэдэг болохоор бүлэгт ажиллаж байгаа нь хангалттай гэж Гермиона уурсав.

- Тэр бол Үхэл залгигч. Манай талд орсон гэсэн баталгаа хаана байгаа юм? гэж Рон зөрүүдлэв.
- Дамблдор түүнд итгэдэг. Хэрвээ бид Дамблдорт итгээгүй бол хэнд ч итгэх боломжгүй.
- Энэ бүх түгшүүрийн дараа гэрийн даалгавар тэднийг нөмрөн авахад тавдугаар дамжааныхан шөнө дунд хүртэл хичээлээ хийж, ДА-гийн нууц уулзалт, Снеггийн хичээлүүд үргэлжилсээр нэгдүгээр сар ажиглагдамгүй өнгөрөв. Харри эргэж харж ч амжаагүй байтал чийглэг дулаан цаг агаартай хоёрдугаар сар айлчилж Хогсмид явах өдөр боллоо. Тэр үед Харри Чжоутай тосгонд уулзах тухайгаа ярих гэсэн ч ховорхон тааралдаж байлаа. Түүний өмнө Валенттний өдрийн тулж ирэв.
- Хоёр сарын арван дөрөвний өглөө Харри босож хянамгай хувцаслав. Түүнийг Роны хамт өглөөний цайндаа ирэхэд шуудангийн уулиуд ирж байв. Хэдваг тэдний дунд байсангүй тэр ч хүлээсэнгүй. Харин Гермionaд үл таних ууль захиа авчирлаа.
- Ёстой цагаа олж! Хэрвээ өнөөдөр ирээгүй бол гээд тэр дугтуйг тэвчээргүйхэн задалж цаасыг гаргав. Түүний нүд хуудсан дээгүүр урагш хойш гүйхэд таагүй төрхтэй болов. Тэр Харри руу хараад,
- Сонсооч, Харри энэ маш чухал шүү. Чи надтай «Гурван шүүр»-энд үд дунд уулзаж чадах уу? гэлээ.
- Мэдэхгүй л байна. Чжоу намайг лав өдрийг хамт өнгөрүүлнэ гэж бодож байгаа байх. Бид юу хийхээ ярилцаагүй байгаа.
- Тэгвэл түүнийг аваад ир. Чи тэгээд ирэх үү? гэж тэр шаардангуй дуугарлаа.
- За ... тэгвэл ч яахав. Харин юу болсон юм бэ?
- Одоо тайлбарлах цаг алга. Түргэн хариу илгээх хэрэгтэй байна гээд нэг гартаа захиа, нөгөө гартаа шарсан талх бариад Их танхимаас гүйн гарлаа.
- Харин чи явах уу? гэж Харри Роноос асуув. Тэр уйтгартайгаар толгой сэгсрэв.
- Би явж чадахгүй. Анжелина өдөржингөө сургуулилахыг хүсэж байгаа. Энэ туслах байх. Биднээс муу багыг амьдралдаа харж байсангүй. Чи Слоупер, Керка хоёрыг харсан ч болоосой надаас долоон дор амьтад шүү. Анжелина намайг яагаад багаас гарахыг зөвшөөрөхгүй байгааг ойлгохгүй юм.
- Яагаад гэвэл чи хэвийн үедээ сайн тоглодог учраас гэж Харри уурсан

дуугарав.

Тэр Ронд хүнд байгааг мэдэж байсан ч мөдхөн болох гэж буй Пуффендуйн тэмцээн дээр тоглохын тулд юугаа ч өгөхөд бэлэн байлаа. Рон Харрийн дууны өнгийг ойлгосон бололтой өглөөний хоолон дээр квиддичийн тухай ахиж ярьсангүй. Түүнийг цэнгэлдэх хүрээлэнгийн хувцас солих өрөө рүү явах үед Харри үүдний танхимд Чжоутай уулзахын өмнө цайны халбаганд тусгалаа харж үсээ илэн толийлгохыг оролдов. Тэр түүнтэй юу ярихаа мэдэхгүй байсан учир эмээх сэтгэл төрлөө.

Чжоу түүнийг царсан хаалганы дэргэд хүлээж байсан бөгөөд үсээ хойш нь боосон нь маш хөөрхөн харагдав. Түүний хөл гэнэтхэн гуйвахад айдаст автан гараа утгагүй савчив.

- Сайн уу гэж Чжоу хэлэв.
- Сайн уу.

Хэдэн хормын турш тэд бие биенээ ширтсэнээ дараа нь Харри,

- Тэгэхээр ... явцгаах уу? гэв.
- Явцгаая.

Тэд гарын үсэг шалгаж буй Филчийн өмнө дугаарлан зогсохдоо үе үе бие бие рүүгээ харж инээмсэглэсэн ч ярилцсангүй. Эцэст нь агаарт гарах үед дараалалд зогсож байх үедээ дотор нь давчдаж байсан Харри сэтгэл амран санаа алдав. Сэрүүхэн салхитай өдөр байлаа. Харри цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэдүүр өнгөрөхдөө Рон, Жинни хоёрыг суудал дээгүүр нисч байхыг хараад тэдэнтэй байж чадахгүйдээ зүрх нь шимширлээ.

- Тоглоомоо санаж байна уу? гэж Чжоу асуулаа. Тэр эргэж хараад урдаас нь ширтэж байхыг олж харав.
- Тиймээ. Маш их.
- Бид гуравдугаар дамжаанд байхдаа бие биенийхээ эсрэг анх тоглосныг санаж байна уу?
- Тиймээ. Чи үргэлж намайг дагаад байсан гээд Харри инээмсэглэв.
- Харин Вуд чамайг жентельмен байх хэрэггүй. Түүнийг шүүрнээс нь түлх гэж хашгирч байсан гэж Чжоу инээмсэглэн хэлээд,

- Би түүнийг «Первенц Портри» багт авсаныг сонссон энэ үнэн үү? гэв.
- Үгүй дээ «Паддмир Юнайтейд» багт байгаа. Би түүнтэй өнгөрсөн зун дэлхийн аваргын тэмцээн дээр уулзсан.
- Өө, би чамайг бас тэнд харсан санаж байна уу? Бид нэг буудалд байсан биз дээ. Сайхан хэрэг шүү тийм үү?

Квиддичийн дэлхийн аваргын тухай сэдэв үргэлжилсээр хашааны хаалга руу ойртов. Харри түүнтэй Рон, Гермiona хоёрын адил маш хялбархан ярилцаж байгаадаа гайхаж явлаа. Ингээд тайвширч хөгжилтэй болоод байтал Пэнси Паркинсон тэргүүтэй Слизериний бүлэг охид араас нь гүйцэв.

- Поттер ба Чанг! гэж Пэнси орилоход бусад нь шоолон инээлдэв. Түй, Чанг би чамайг гэж хөөрхөн гэж бодохгүй байна ... Диггори чамаас илүү царайлаг байсан юм!

Охид цааш явахдаа чанга хашгиран инээлдэж тэдэн лүү эргэн харцгаахад ичсэндээ чимээгүй боллоо. Харри квиддичийн тухай ярих эсэхээ мэдсэнгүй, Чжоу үл мэдэг улайгаад доошоо ширтэнэ.

- Тэгэхээр хаачих вэ? гэж Харри Хогсмид руу орох үедээ асуув.

Төв гудамжинд дүүрэн сурагчид холхилдож, шилэн лангуу руу шагайн, чулуун зам дээр бөөгнөрөлдөнө.

- Мэдэхгүй ... Дэлгүүр орох уу? гээд Чжоу мөрөө хавчлаа.

Тэд «Дэрвиш Бэнгс» мухлаг руу орлоо. Цонхон дээр том зурагт хуудас өлгөж хэд хэдэн оршин суугчид ширтэж байв. Тэднийг ороход хүмүүс холдсон бөгөөд Харри ахин арван Үхэл залгигчдын зургийг олж харлаа. Зурагт хуудсан дээр «Ид шидийн яамны тушаал» гэж бичээд баригдсан шидтэн болгонд мянган галлеоны шагнал өгөхөөр амлажээ.

- Хачирхалтай юм гэж Чжоу аяархан хэлээд Үхэл залгигчдын зураг руу харж,
- Сириус Блэкийг зугтах үед Хогсмидээр дүүрэн Дементорууд байсныг санаж байна уу? Харин одоо арван Үхэл залгигч зугтчихаад байхад ямар ч Дементор байдаггүй ... гэв.
- Тиймээ. Тийм, хачирхалтай хэрэг шүү хэмээн Харри Беллатрис

Лестрейнжийн зурагнаас арайхийн харц салган хэллээ.

Тэр Дементорууд энд байхгүйд харамсаагүй ч хэрвээ бодоод үзэх аваас энэ нь учиртай байлаа. Дементорууд Үхэл залгигчидыг зугтахыг зөвшөөрөөд зогсохгүй хайж төвөг удалгүй ... магадгүй тэд ид шидийн яамны хяналтаас гарсан байх ...

Арван Үхэл залгигч тэдний зам дахь дэлгүүрийн цонх бүрээс ширтэн харж байлаа. Харри, Чжоу хоёрыг Писсаррогийн дэлгүүрт орох үед хүйтэн борооны хүнд дуслууд орж царай болон шилэн хүзүү норгов. Бороо улам ширүүсэхэд Чжоу итгэлгүйхэн,

- Мм ... явж кофе уух уу? гэв.
- Тэгье л дээ. Харин хаана вэ? гэж Харри эргэн тойрноо харж хэллээ.
- Энд холгүйхэн аятайхан газар байгаа. Чи хэзээ ч хатагтай Паддифутынд байж үзээгүй юу?

Чжоу түүнийг гудамжаар дагуулан урьд нь хэзээ ч анзаарч байгаагүй жижигхэн кафед авчрав. Кафе жижиг давчуухан агаад үсний боолт, туузаар чимэглээстэй газар байлаа. Энэ нь түүнд Амбрижийн өрөөнд байгаа юм шиг эвгүй сэтгэгдэл төрүүлэв.

- Аятайхан байгаа биз? гэж Чжоу баяртай хэлэв.
- Аан ... тийм л дээ гэж Харри зөвшөөрлөө.
- Харж байна уу, Валентиний өдрийн чимэглэлийг! гээд Чжоу тус бүрийнх нь дээр алтлаг сахиусан тэнгэр хөвж үе үе ягаан чихэр унагах дугуй ширээнүүдийг заалаа.
- Э-э ...

Тэд хөлөрсөн цонхны дэргэдүүр өнгөрөөд сүүлчийн сул ширээнд суулаа. Тэднээс хэдхэн алхамын зайд Когтевраны багийн ахлагч Рожер Дэвис цайвар үстэй хөөрхөн охинтой сууж байв. Тэд гар гараасаа барьжээ. Харри кафенд сууж байгаа хүмүүс хос хосоороо сууж гар гараасаа барьсан болохыг хараад дотор нь тавгүй болов. Магадгүй Чжоу түүний гараас барихыг хүлээж байгаа юм болов уу?

- Та нарыг юугаар зочлох вэ, хонгорууд минь? гэж Рожер Дэвис болон тэдний ширээний дундуур хүндхэн зүтгэлж ирсэн хатагтай Паддифут гэдэг махлаг биетэй гялалзсан хар үсээ ардаа боосон эмэгтэй асуулаа.
- Хоёр кофе өгнө үү гэж Чжоу хэлэв.

Тэдний кофе бэлэн болох үед Рожер Дэвис болон түүний найз охин хоёр чихрийн сав дээгүүр үнсэлдэж эхлэв. Харри тэднийг үүнийгээ болиосой гэж хүслээ. Магадгүй

Чжоу түүнийг Дэвисийн жишгийг дагахыг хүлээж байгаа ч юм билүү. Тэр царай нь халуу оргихыг мэдэрч цонхоор харахыг оролдсон ч битүү уур цан болсон болохоор гадаа юу байгаа нь харагдсангүй. Тэр адар ширтэн хээг нь судалсан ч нүүр нь сахиусын чихрийн хаясан битүү чихэр болов.

Хэдэн хормын зовлонтой агшин өнгөрөхөд Чжоу Амбрижийн тухай яриа өдлөө. Харри санаа амран энэ сэдвээр баяртай хэдэн хормыг өнгөрүүлж хамтдаа профессорыг зүхсэн ч энэ нь удаан үргэлжилсэнгүй. Ахин чимээгүй болов. Хөрш ширээнд үнсэлдэх чимээ дуулдахад Харри юу хэлэх талаараа бодлогоширов.

- Ээ ... Сонсооч надтай үдийн хоолны үеэр «Гурван шүүр» рүү явахыг хүсэж байна уу? Би тэнд Гермiona Грэйнджертэй уулзах ёстой юм.

Чжоу хөмсгөө өргөв.

- Чи Гермiona Грэйнджертэй уулзана гэнэ ээ? Өнөөдөр үү?

- Тиймээ. Тэр намайг ирэхийг гуйгаад би амалчихсан. Надтай явахыг хүсэж байна уу? Тэр цуг ирж болно гэж хэлсэн.

- Аан ... юу гээч ... түүний зүгээс их эелдэг хэрэг байна даа.

Гэхдээ Чжоуд огтхон ч эелдэг санагдаагүй нь илт байлаа. Эсрэгээрээ түүний хоолой хүйтэрч гэнэтхэн дайсагнасан төрхтэй болов.

Ахин хэдэн хором чимээгүй өнгөрөв. Харри кофеого түргэн уусан учир удалгүй шинэ аяга шаардагдав. Харин дэргэд нь Рожер Дэвис болон түүний охин хоёр уруулаараа наалдсан мэт байлаа.

Чжоугийн гар кофены аяганы дэргэд тавиастай харагдахад Харри түүнийг атган авахыг хүслээ. Алив л даа гэж тэр өөртөө хэлээд сэтгэл нь хүчтэй догдлохыг мэдрэв. Гайхалтай нь гэвэл ширээн дээгүүр түүний гар луу хуруугаа сунгах нь снитч барихаас хүнд байлаа.

Гэхдээ түүнийг гараа хөдөлгөмөгц Чжоу гараа татлаа. Тэрбээр эелдэгээр Рожер Дэвис найз охинтойгоо үнсэлдэхийг харж суув.

- Тэр намайг урьсаныг мэдэх үү. Хоёр долоо хоногийн өмнө. Гэхдээ би татгалзсан л даа.

Харри гэнэтийн үйлдэлээ тайлбарлахын тулд чихрийн сав авахдаа түүний яагаад энэ тухай ярьж байгааг ойлгосонгүй. Хэрвээ тэр энд сууж хөрш ширээнд Рожертэй

үнсэлдээгүйдээ харамсаж байгаа бол яагаад түүнтэй явахыг зөвшөөрсөн юм бол?

Тэр юу ч хэлсэнгүй. Сахиусан тэнгэр тэдний дээрээс атга дүүрэн чихэр унагахад ихэнхи нь Харрийн үлдээсэн хүйтэн шавхруу руу орлоо.

- Би өнгөрсөн жил Седрикийн хамт ирсэн гэж Чжоу хэлэв.

Түүнийг ингэж хэлэхэд Харрийн дотор хүйт даалаа. Байж боломжгүй юм тэр эргэн тойронд нь хосууд үнсэлдэн толгой дээгүүр нь сахиусан тэнгэр хөвж байхад Седрикийн тухай ярихыг хүслээ гэж үү.

Чжоу ахин ярьж эхлэхдээ энэ удаа чангаар,

- Би чамаас эртнээс асуухыг хүссэн юм ... Седрик ... тэр м-м үхэхийн өмнө намайг санасан болов уу? гэв.

Тэр энэ дэлхий дээр юунаас ч илүү энэ сэдвээр ялангуяа Чжоутай ярилцахыг хүсэхгүй байлаа.

- Үгүй ээ. Тэнд ... тэр үед ... түүнд юу ч хэлэх боломж байгаагүй ... Харин чи ... амралтаараа ... квиддич тоглосон уу? Чи «Хар салхи»-ийг дэмждэг биз дээ?

Харри дууных нь өнгөнд хуурамч хөгжилтэй өнгө дуулдахыг сонслоо. Ингээд зул сарын өмнөх сүүлчийн ДА-гийн цугларалт дээр байсан шиг түүний нүдэнд нулимс цийлэгнэхийг айдаст автан харлаа.

- Мэдэж байна уу ахиж Седрикийн тухай ярилцахаа больё ... өөр зүйлсийн тухай ярилцъя гэж өөр хүнд сонсуулахгүйн тулд урагш бөхийн цөхрөн хэллээ.

Гэхдээ энэ шударга бус гуйлт гэдэг нь илэрхий байлаа.

- Би бодлоо л доо гэж тэр хэлэхэд нулимс нь хэдийн ширээн дээр дусалж эхэлжээ. Чи ... ойлгож байна уу! Би энэ тухай ярих хэрэгтэй байна! Чамд ч гэсэн ... бас хэрэгтэй! Чи энэ бүхнийг яаж болсныг ... харсан биз дээ?

Хар дарсан зүүднээс ч долоон дор зүйл болов. Рожер Дэвисийн найз охин үнсэлдэхээ болиод уйлж буй Чжоу руу харав.

- Гэхдээ ... би энэ тухай Рон, Гермиона хоёртой ярьсан ч ...

- Чи Гермиона Грэйнджерт хэлсэн байна шүү дээ! гэж тэр нулимс гялалзуулсан царайгаар ширүүн хэллээ.

Өөр хэдэн үнсэлдэж байсан хосууд тэднийг харахын тулд салав.

- Харин надтай болохоор ярихыг хүсэхгүй байдаг ... М-магадгүй ... бид одоо ... чи зүгээр л Гермiona Герейнжертэй уулзахаар явсан дээр байх. Чи үүнийг л хүсч байх шиг байна!

Харри түүний амны цаасны алчуураар нулимсаа арчихыг сэтгэлээр унан харлаа.

- Чжоу! гэж тэр гуйсан хоолойгоор хэлэхдээ Рожер ахин охинтойгоо үнсэлдэж тэднийг харахаа болиосой гэж маш их хүслээ.

- Тэгвэл яв л даа! гээд Чжоу амны алчуураар нүдээ даран уйлав. Хэрвээ чи дараа нь өөр охинтой уулзахаар төлөвлөсөн юм бол яагаад намайг урьсныг чинь ойлгохгүй байна ... Гермionaгийн дараа хичнээн охинтой уулзах гэж байгаа юм?

- Үгүй дээ, тийм биш! гэж тэр эцэст нь түүний гомдлыг ойлгоод санаа амран инээмсэглэв. Тэгээд энэ нь алдаа байсныг шууд л олж харлаа. Гэвч оройтжээ.

Чжоу хөл дээрээ үсрэн бослоо. Өрөөнд байсан бүх хүмүүс чимээгүй болж түүн рүү харав.

- Сайн байна, Харри гэж тэр үл мэдэг эхэр татан жүжигчилсэн байдалтай хэлээд хаалга руу ухасхийн бороон дундуур үсрэн гарлаа.

- Чжоу! гэж тэр араас нь орилсон ч хаалга хэдийн хаагдаж жингэнэлээ.

Кафе даяар чимээгүй болов. Бүгд Харри руу харцгаана. Тэр ширээн дээр галлеон орхиод үсэн дээрээ унасан ягаан чихрийг сэгсэрч Чжоугын араас гарлаа.

Гадаа бороо улам ширүүсч Чжоу бараа сураггүй алга болжээ. Тэр ердөө хагас цагийн өмнө бүх зүйл хэвийн байсан атал юу болсныг ойлгосонгүй.

- Эмэйгтэйчүүд! хэмээн тэр ууртай бувтнаад гараа халаасандаа шургуулж нойтон гудамжаар хэрэн явлаа. Түүнд Седрикийн тухай ярих нь ямар хэрэгтэй юм бэ? Яагаад энэ сэдвийг хөндөхөөрөө үргэлж нойтон нүдэлж байдаг юм бол?

Харри баруун тийш эргээд өвсөн дээгүүр үс цацлуулан гүйж хэдэн хормын дараа

«Гурван шүүр»-ийн үүдээр орлоо. Хэтэрхий эрт байсан учир Гермiona тэнд ирсэн байх боломжгүй ч хэн нэг танил хүнтэй уулзан цаг нөгцөөнө гэж найдлаа. Духнаасаа нойтон үсээ сэгсрэн холдуулаад ийш тийшээ харав. Хагрид гашуудалтай буланд ганцаар сууж байв.

- Сайн уу, Хагрид! гээд Харри түүн рүү сандал татан суулаа.

Хагрид цочин харсан ч шууд таньсангүй. Харри түүний царай дээр шинэхэн хоёр

шарх, хэдэн хөхрөлт бий болсныг харлаа.

- Аан энэ чи юу, Харри. Ямаршуу байна даа?
- Сайн гэж Харри худал хэлээд гунигтай Хагридыг өрөвдсөндөө,
- Харин чи? гэлээ.
- Би юу? Би ч гэсэн сайн байна, Харри. Маш сайн байна.

Тэр томхон хувин шиг цагаан тугалган шар айрагны аяга руу харснаа санаа алдлаа. Харри юу хэлэхээ мэдсэнгүй. Хормын турш тэд чимээгүй суув. Дараа нь Хагрид гэнэтхэн,

- Бид адилхан юм тийм үү, Харри? гэв.
- Гэхдээ ...
- Тийм л дээ ... би өмнө нь ч хэлж байсан ... хоёулаа гадуурхагдсан ... Хоёулаа өнчин. Тиймээ ... хоёулаа өнчин.

Тэр аягатайгаасаа балгав.

- Хамгийн том ялгаа гэвэл сайн гэр бүл байна. Аав минь сайн хүн байсан. Харин чиний эцэг эх хоёр бас сайн хүн байсан. Хэрвээ амьд байсан бол амьдрал өөр тийш эргэх байсан, тийм биз?
- Магадгүй тийм байх гэж Харри болгоомжтой зөвшөөрөв. Хагридыг иймэрхүү байдалтай харах нь дасал болоогүй зүйл байлаа.
- Гэр бүл ... гэж Хагрид гунигтай хэлээд, Хэдийгээр цус чухал гэж хэлдэг ч ... хэмээн хөхрөлтөө үрэв.
- Хагрид чи яагаад үргэлж шархдаад байгаа юм бэ? гэж Харри тэсэхээ болиод хэллээ.
- Аан? Юун шарх? гэж Хагрид гайхлаа.
- Энэ л байхгүй юу! гээд Харри нүүр рүү нь заав.
- Аан ... зүгээр л мөргөлдөөд хөхөрчихсөн юм, Харри. Миний ажил ийм л бүдүүлэг шүү дээ гэж тэр үл тоомсорлон хэлэв.

Тэр аягатайгаасаа уугаад ширээн дээр тавин бослоо.

- Баяртай, Харри. Эрүүл энхийг хүсье.

Тэр золгүй төрхтэй сажилсаар баарнаас гарч усархаг бороонд алга болов. Харри түүнийг гомдолтойгоор дагуулан харлаа. Хагрид золгүй байсан ч шийдэмгий нууж ямар ч тусламж хүсэхгүй байна. Юу болсон юм бол? Гэхдээ Харриг энэ тухай бодож амжихаас урьтаж нэрийг нь хүн дуудав.

- Харри! Харри, ийшээ!

Өрөөний нөгөө өнцгөөс Гермiona түүн рүү даллаж байв. Тэр өндийгөөд цугласан хүмүүс дундуур явлаа. Хэд хэдэн ширээ өнгөрөөд түүнийг ганцаараа биш болохыг харав. Тэр ширээндээ хамтран уухад ер бусын хос болох Полумна Лавгуд болон «Өдөр тутмын Зөнч» сонины сурвалжлагч байсан Рита Скитер нартай сууж байв.

- Чи эрт ирлээ! Би чамайг Чжоутай цагийн дараа ирнэ гэж бодож байсан юм! гэж Гермiona түүнийг суухад хэлэв.

- Чжоу гэнээ? Охин уу? хэмээн Рита Харри руу шуналтай харцаар ширтэв. Тэр матрын арьсан цүнх рүүгээ гараа шургуулав.

- Тэр зуун охинтой хамт байсан ч энэ таньд хамаагүй гэж Гермiona хүйтнээр дуугарлаа.

Рита цүнхнээсээ хэдийн хортой ногоо үзгээ гаргажээ. Түүний царай шиг өмхий шингэн уусан аятай болсноо цүнхээ тасхийтэл хаалаа.

- Чи юу бодоо вэ? гэж Харри асуугаад Рита, Полумна хоёр луу харлаа.

- Манай залуу төгс хатагтай сая л чиний ирэхийг хэллээ гээд Рита аягатайгаа чимээтэй балгаснаа, Надад түүнтэй ярих боломж өгөх юм байгаа биз дээ? гэж даажигнан хэллээ.

- Болно байх хэмээн Гермiona хүйтнээр хэлэв.

Ажилгүйдэл Ритаг сайхан харагдуулсангүй. Үсээ гоёмсогоор буржийлгахын оронд тэнцүү хуваан унжуулж, хоёр инчийн урттай улаан хумсны үзүүр нь хугаран, нүдний шилнийх нь хуурамч чулуу алга болсон харагдана. Тэр ахин аягатайгаасаа балгаад уруулаа жимбийлгэн,

- Тэр хөөрхөн охин уу, Харри? гэв.

- Ахин нэг удаа Харрийн хайрын амьдралын тухай үг хэлэх юм бол хэлэлцээрээ цуцлана шүү гэж Гермiona сүрдүүлэв.

- Ямар хэлэлцээр? гээд Рита амаа гарынхаа араар арчсанаа,
 - Хатагтай маяглагч минь, чи ахиж хэлэлцээр байгуулаагүй зөвхөн намайг ирэхийг гуйсан. Зүгээр л тэдгээр өдрүүдэд ...
 - Тиймээ, тийм тэдгээр өдрүүдэд та Харри болон бидний тухай жигшүүртэй түүхээ зохиож байсан биз дээ?
 - Энэ жил Харрийн тухай миний оролцоогүй багагүй жигшүүртэй түүх зохиогдсон гээд тэр түүн рүү хяламхийн бүдүүлгээр,
 - Чи тэднийг уншаад ямар мэдрэмж төрсөн бэ, Харри? Ойлгомжгүй санагдсан уу? Түгшсэн үү? гэж шивнэлээ.
 - Мэдээж тэр уурласан. Тэр ид шидийн яаманд үнэнийг хэлсэн ч сайд тэнэг юм болохоороо итгээгүй гэж Гермiona чангаар хэллээ.
 - Тэгэхээр чи урьдын адил Хэцүү нэртийг эргэж ирсэн гэж зүтгэлсээр байгаа хэрэг үү? гээд Рита шилээ доошлуулж Харри шинжин харахад хуруу нь матрын арьсан цүнх рүүгээ алгуур гулгав. Дамблдорын Хэцүү нэртийг эргэж ирэхэд чамайг гэрч болсон тухай утгагүй яриаг дэмжиж байгаа хэрэг үү?
 - Би цорын ганц гэрч байгаагүй. Тэнд арваад Үхэл залгигч байсан. Тэдний нэрийг мэдэхийг хүсч байна уу? гэж Харри уурсан хэлэв.
 - Дуртайяа сонсох байна гээд тэр ахин цүнхээ тэмтчингээ Харриг амьдралдаа хэзээ ч ийм сайхан зүйл харж байгаагүй мэтээр харав.
 - Томоохон үсгээр «Поттер буруутгаж байна» гэсэн гарчиг тавихад болно. Доор нь «Харри Поттер Үхэл залгигчдыг нэрлэлээ» гэсэн нэмэлт гарчиг тавина. Харин тэдний доор чиний гайхалтай сайхан том зураг байх юм. «Хэцүү нэртийн дайралтаас амьд үлдсэн арван таван настай өсвөр насны хүү Харри Поттер өчигдөр хилэнтэйгээр Үхэл залгигчид гэж нэрлэгдэх шидтэнгүүдийг буруутгалаа».
- Түргэн бичигч үзэг хэдийн түүний гарт бий болсон ч гэнэтхэн царайнаас нь хөөрсөн өнгө алга боллоо.
- Гэхдээ манай жижигхэн төгс хатагтай ийм түүх бичүүлэхийг хүсч байгаа юм уу? гээд Рита үзгээ тавьж Гермiona руу харлаа.
 - Чухам үүнийг л танай жижигхэн хатагтай хүсч байна гэж Гермiona эелдэгээр хэлэв.

Рита түүн рүү гайхан харлаа. Харри ч гэсэн. Уизли манай хаан дуу мөрөөдөнгүй аялж байсан Полумна мэгдсэндээ коктейль руугаа саваанаасаа сонгино унагачихлаа.

- Чи намайг түүний Хэцүү нэртийн тухай хэлсэн болгоныг мэдээлэхийг хүсээ юу? гэж Рита Гермионагаас аяархан асуулаа.

- Тиймээ. Үнэн түүх. Бүх баримттай нь. Харригийн мэдээлсний дагуу. Тэр таньд бүх зүйлийг нарийвчлан зүйлийг ярьж, Үхэл залгигчдын нэрийг илчлэн Волдеморт яаж харагдаж байсныг хэлэх болно ... Өө, биеэ барь л даа! гэж тоомсоргүй хэлэхэд Хар лордын нэрийг сонсоод Рита цочсондоо сандлаасаа унах шахаж галт шарзныхаа хагасыг асгачихлаа.

Рита Гермионагаас нүд салгалгүй ширтэнгээ дээлээ амны алчуураар арчаад,

- «Зөнч» сонин үүнийг хэвлэхгүй. Хэн ч энэ түүхэнд итгэхгүй байгааг чи ажигласан байлгүй дээ. Бүгд түүнийг хууран мэхлэгч гэж үзэж байгаа. Гэхдээ энэ түүхийг өөр өнцгөөс өөрчлөх юм бол ... гэв.

- Бидэнд Харрийн тухай ахин өөр түүх хэрэггүй. Баярлалаа, бидэнд хангалттай!

Би зөвхөн түүнийг хүмүүст үнэнийг хэлэх сайхан боломж олгохыг хүссэн юм!

гэж Гермиона уурсан хэлэв.

- Гэхдээ ийм түүх хэвлэгдэхгүй гэж Рита хүйтнээр хэлэв.

- Та «Зөнч» сонин Фаж зөвшөөрөхгүй учир нийтлэхгүй гэж хэлэх гээ юу? хэмээн Гермиона асуулаа.

Рита хүйтэн харцаар хариулав. Дараа нь ширээн дээгүүр бөхийн ажил хэрэгч байдалтайгаар,

- Тиймээ, Фаж сонинд ийм зүйл нийтлэхийг зөвшөөрөхгүй. Тэд ч Харриг сайн талаас нь харуулахыг хүсэхгүй ... Хэн ч түүнийг уншихгүй. Энэ чинь нийтийн жишиг шүү дээ. Хүмүүс одоо зөвхөн Азкабаны шоронгийн орголтонд л санаа зовж байгаа. Тэд Хэцүү нэртийг эргэн ирсэнд итгэхийг хүсэхгүй байгаа юм гэлээ.

- Тэгэхээр «Өдөр тутмын Зөнч» сонин зөвхөн хүмүүс сонсохыг хүссэн зүйлийг л хэлдэг байх нь ээ? гэж Гермиона зэвүүцэнгүй асуув.

Рита өндийж хөмсгөө өргөөд ганц балгалтаар аягатайгаа хоослов.

- «Зөнч» зөвхөн зарагдахад хэрэгтэй зүйлийг бичдэг юм, тэнэг охин минь.

- Аав үүнийг жигшүүртэй сонин гэж хэлсэн хэмээн Полумна гэнэтхэн ярианд оролцов. Тэр Рита руу том нүдээрээ харж,

- Тэр зөвхөн хүмүүст хэрэгтэй зүйлсийг нийтлэн гаргадаг юм. Тэр мөнгөнд санаа зовдоггүй гэлээ.

Рита түүнийг үл ойшоон харлаа.

- Чиний аавыг жижигхэн тосгоны сонин гаргадаг гэж бодож байна? Магадгүй болзоонд явах хорин таван арга бичдэг байх даа?

- Үгүй. Тэр «Шүүмжлэгч» сэтглүүлийн эрхлэгч гээд Полумна аяганаасаа сонгиныг гаргалаа.

Рита чанга тургилахад зэргэлдээх ширээнийхэн эргэж харцгаав.

- Хүмүүст хэрэгтэй зүйл гэнэ ээ? хэмээн тэр элэглэн хэлээд,

- Би цэцэрлэгээ ийм сэтгүүлийн уранхайгаар борддог юм гэлээ.

- Ингэхээр таньд түүнийг жаахан дээшлүүлэх боломж байна гэж Гермiona эелдэгээр зөвлөөд,

- Полумна аав нь Харрийн ярилцлагыг баяртайгаар нийтлэх болно гэсэн.

Ингээд хаана гарах нь шийдэгдлээ гэв.

Рита агшин зуур хоёр охин руу харснаа дараа нь чангаар хөхрөв.

- «Шүүмжлэгч» сэтгүүл шүү! Хэрвээ энэ Шүүмжлэгчид гарвал хүмүүс жинхэнээсээ хүлээн авна гэж бодож байна уу?

- Зарим нь үгүй л байх. Гэхдээ «Зөнч» сонинд шоронгоос зугтаасан тухай нийтлэл эцэс төгсгөлгүй гарч байгаа. Магадгүй зарим хүмүүс үүнд илүү илтгэлтэй тайлбар хүлээж байж болох юм. Хэрвээ ер бусын сэтгүүл дээр өөр түүх нийтлэгдвэл олон хүмүүс түүнийг сонирхох байх.

Рита юу ч хэлсэнгүй Гермionaг шинжин гараад толгойгоо бөхийлгөв.

- За яахав, тэгвэл би үүнийг хийе. Харин үүний төлөө надад хэдийг төлөх юм?

- Аав хүмүүсийг сэтгүүлдээ бичсэний төлөө мөнгө төлдөггүй. Тэд нэрээ бичигдсэнийг харж шагнал гэж боддог юм хэмээн Полумна мөрөөдөнгүй хэлэв.

Рита ахин өмхий шингэн уусан аятай ярвайж Гермiona руу эргэлээ.

- Би тэгээд үнэгүй бичих болж байна уу?
- Тийм л дээ гээд Гермиона аягатайгаасаа шимэн тайвнаар батлаад,
- Өөрөөр бол би таныг бүртгэгдээгүй анимаг гэдгийг эрх мэдэлтэнгүүдэд мэдэгдэх болно. Мэдээж «Зөнч» сонин таньд Азкабаны шоронгийн амьдралаас сурвалжилсны төлөө илүү ихийг төлж болох юм гэв.

Рита түүн рүү энэ дэлхий дээр юунаас ч илүү аягатайгаас нь цухуйсан цаасан шүхрийг шүүрэн авч хамар луу нь чихэхийг хүссэн мэт унтууцан харав.

- Надад сонголт үгүй болсоныг би ойлголоо гэж чичирсэн хоолойгоор хэлээд ахин цүнхээ нээж цаас Түргэн бичигч үзгээ гаргалаа.
- Аав баяртай байх болно гэж Полумна хөгжилтэйгээр хэлэв. Ритагийн эрүү чангарлаа.

Гермиона Харри руу эргэв.

- Харри, чи хүмүүст үнэнийг хэлэхэд бэлэн үү?
- Тэгэлгүй яахав гэж Харри Рита болон цаасан дээр бэлэн байх Түргэн бичигч үзэг рүү харж хэллээ.
- Эхэл дээ, Рита гэж Гермиона хэлээд аяганы ёроол дахь интоороо авлаа.

БҮЛЭГ 26: ГЭНЭТИЙН ЯВДАЛ

Полумна эцэг нь саяхан үзэгдсэн үрчгэр эвэртийн тухай томоохон нийтлэл гаргахаар шийдсэн учир Ритагийн Харригай хийсэн ярилцлагыг «Шүүмжлэгч» сэтгүүд хэзээ гарахыг мэдэхгүй байна гэсэн хариулт өгчээ. Мэдээж энэ их чухал сэдэв болохоор дараагийн дугаарт гарах байх гэж Полумна тайлбарласан байна.

Харри түүнд Волдемортын буцаж ирсэн өдрийн тухай ярихад амаргүй байгааг анзаарчээ. Рита түүний дурсамжийн жижиг сажиг зүйл бүрийг тодруулан асуухад эцэст нь ертөнцөд үнэнийг хэлэх боломж олдсоныг ойлгоод санаж чадах бүхнээ хэллээ. Тэр хүмүүс түүхэнд яаж хандахыг мэдсэнгүй. Магадгүй түүний ярилцлага үрчгэр эвэртийн дараа гарах болохоор ихэнхи хүмүүс түүнийг бүрэн галзуурсан гэж үзэх боломжтой юм. Гэхдээ Беллатриса Лестрейнж болон бусад Үхэл залгигчдын зугталт Харрид ямар нэг зүйл их хүсэл төрүүлсэн болохоор бүтэх эсэх нь хамаагүй байлаа.

- Амбриж чиний энэ алхамд яаж хандах нь сонирхолтой юм гэж Дин даваа гаригийн оройн хоолны үеэр эмээнгүй хэлэв. Түүний хажууд сууж байсан Симус хоёр хацраа бөмбийтөл тахианы мах, бялуу чихсэн ч Харри түүний яриа сонсож байгаа болохыг нь мэдэж байлаа.

- Чи зөв хийсэн, Харри гэж эсрэг талд нь сууж байсан цонхийн цайсан Невилл хэлээд нам дуугаар,

- Магадгүй энэ тухай ярихад хэцүү байсан байх тийм үү? гэв.

- Хэцүү байсан. Гэхдүү хүмүүс Волдемортын тухай мэдэх ёстой биз дээ?

- Тийм л дээ бас түүний Үхэл идэгч нарыг ... мэдэх ёстой ...

Невилл ярианыхаа төгсгөлийг дуусгалгүй шарсан төмсөндөө оров. Симус дээш хараад Харрийн харцтай тулгармагцаа ахин таваг руугаа тонгойв. Удалгүй Дин, Симус, Невилл нар амралтын өрөөний зүг зүглэхэд Харри, Гермiona хоёр квиддичийн бэлтгэлээс оройн хоолондоо ирж амжаагүй Роныг хүлээж үлдэв.

Танхимын хаалгаар Чжоу Чанг найз охин Мариэттайгаа орж ирэв. Харрийн дотор таагүй мэдрэмж төрсөн ч Чжоу Гриффиндорын ширээ рүү харалгүй цаашаа харан суулаа.

- Ингэхэд би асуухаа мартчихаж чиний Чжоугаи хийсэн болзоо юу болсон бэ?

Чи яагаад тийм эрт ирсэн юм? гэж Гермiona Когтевраны ширээний зүг хяламхийн хараад сониучирхан асуулаа.

- Ээ ... энэ ч ... гэж Харри бувтнаад гишүүний үйрмэгтэй бялуунаасаа хазан,
- Ер нь бол маш муу болсон гэв.

Ингээд түүнд хатагтай Падифутын кафед болсон үйл явдлын тухай ярьж өглөө.

- ... тэгтэл гээд тэр хэдэн хормын дараа яриагаа дуусгаж, Тэр хөл дээрээ үсрэн босоод, «Сайн байна, Харри!» гээд гүйгээд гарчихсан гээд халбагаа доош тавин Гермiona руу харж,
- Надад энэ бүхэн юу болохыг хэлээд өгөхгүй биз? Тэр яасан юм бол? гэж асуулаа.

Гермоина Чжоугын шилэн хүзүү рүү харснаа санаа алдав.

- Өө, Харри минь дээ. Намайг уучлаарай чамд ер арга барил алга гэж гунигтай хэлэв.
- Арга барил алга гэнээ? Эхлээд бүх зүйл гайхамшигтай байснаа дараа нь тэр гэнэтхэн надад Рожер Дэвис урьсан гэж яриад, Седриктэй тэр тэнэг кафед үнсэлдсэн гэсэн. Чинийхээр бол энэ надад таатай байх уу?
- Ойлгож байна уу? Чи түүнд болзооныхоо дундуур надтай уулзахаа хэлэх ёсгүй байсан юм гэж Гермiona нэг дээр нэгийг нэмхэд хоёр байдгийг жаахан хүүхдэд тайлбарлаж байгаагийн адил тэвчээртэй хэлэв.
- Гэхдээ ... гэхдээ чи намайг арван хоёр цагаас түүнтэй ирэхийг хүссэн биз дээ.

Би тэгээд яаж хэлэхгүйгээр үүнийг хийж чадах байсан юм бэ?

- Өөр зүйл хэлэх хэрэгтэй байсан юм гэж Гермiona тэвчээргүйхэн уурсан хэлээд,
- Чи түүнд харамсалтай нь би чамайг хоолонд оруулахаар амласан болохоор «Гурван шүүр» лүү очих ёстой, хэдийгээр чи тийшээ явахыг хүсэхгүй бүтэн өдрийг түүнтэй өнгөрүүлэхийг хүсэж байгаа ч золгүй нь гэвэл тэнд очих ёстой болохоор түүнтэй хамт явбал надаас аль болох хурдан сална гэж хэлэх хэрэгтэй байсан юм. Бас намайг жигшүүртэй гэж бодож байгаагаа дурьдах хэрэгтэй байсан гэж Гермiona нэмэрлэв.

- Гэхдээ би чамайг жигшүүртэй гэж бодоогүй шүү дээ хэмээн Харри гайхширан хэлэв.

Гермиона инээд алдав.

- Харри чи Роноос ч дор юм гээд санаа алдах агшинд Рон танхимд шавар шавхай үсчүүлсээр таагүй царайлан орж ирэв.

- Ойлго, чи надтай уулзахаа хэлснээрээ Чжоуг сэтгэлээр унагаасан байна. Тэр чамайг хардуулах гэсэндээ тийм аргаар түүнтэй хичнээн хайхрамжгүй хандаж байгааг ойлгуулах гэсэн байна.

- Аан, энэ л байж! гэж Харри хэлтэл Рон эсрэг талын сандал дээр палхийтэл суугаад хүрч чадах бүх хоолоо ойртуулав. Гэхдээ тэр надаас та хоёрын хэн нь илүү таалагдаж байгааг асуувал хялбар байсан юм биш үү?

- Охидууд тийм асуулт тавьдаггүй юм.

- Тэгвэл эсрэгээрээ болох байсан юм! Би тэр үед надад таалагддагыг нь хэлээд түүнд Седрикийн үхлийн хойноос ахин уйлах хэрэг гарахгүй байсан даа!

- Би түүнийг биеэ ухаалаг авч явсан гэж хэлээгүй. Би зөвхөн түүний юу мэдэрч байсныг тайлбарлахыг оролдож байна гэж Гермиона норж бохирдсон Жинни тэдэнтэй зэрэгцэн суухад хэлэв.

- Ном бич гэж Рон түүнд зөвлөөд төмс авч,

- Охидууд тэнэг зүйл хийх үедээ юу мэдэрдэгийг бич. Тэгвэл хөвгүүд тэднийг ойлгож эхлэх болно! гэв.

- Яг үнэн гэж Харри хэлээд Когтевраны ширээ рүү харав. Чжоу суудлаасаа босож өмнөхийн адил түүн рүү харалгүй Их танхимаас гарч явлаа. Харри Рон, Жинни хоёр луу гунигтайгаар эргэв. Квиддичийн бэлтгэл ямар болов доо?

- Аймшиг гэж Рон дургүйхэн бувтналаа.

- Больж үз дээ. Би тийм биш байсан гэдэгт итгэлтэй байна гээд Гермиона Жинни рүү харав.

- Тиймээ шүү. Айдас төрөм байсан. Анжелина эцэст нь арай л уйлаагүй гээд Жинни санаа алдав.

Хоолны дараа Рон, Жинни хоёр халуун усанд орохоор явж Харри, Гермиона хоёр

Гриффиндорын амралтын өрөө рүү орон ердийнхөөрөө гэрийн даалгаварын ард суулаа. Харри хагас цагийн турш одон орны хичээлийн шинэ ододын газрын зурагтай үзэлцэж байх зуур өрөөний босгоор Фред, Жорж хоёр орж ирлээ.

- Рон, Жинни хоёр байхгүй байгаа юм уу? гээд Фред сандал дөхүүлэн суув.

Харри толгойгоо сэгсэрлээ.

- Тэгвэл сайн байна. Бид тэдний яаж бэлтгэл хийж байхыг харсан. Тэмцээн дээр тэднийг бут ниргэх байх. Бидэнгүй бол тэд юу ч биш.

- Больж үз, Жинни тийм ч муугүй байсан. Үнэнийг хэлэхэд би түүнийг хаана тэгж тоглож сурсаныг ойлгохгүй байна. Бид түүнийг бэлтгэл хийх үедээ авдаггүй байсан шүү дээ гэж Жорж хайхрамжгүй хэлээд дэргэд нь зэрэгцэн суув.

- Тиймээ, тэр та нарыг хараагүй байхад чинь зургаан жил саравч болон цэцэрлэгт шүүр ээлжлэн унаж байсан юм гээд Гермiona сурах бичиг рүүгээ тонгойв.

- Үнэн үү? гэж Жорж хэлээд,

- Тэгвэл бүх зүйл ойлгомжтой гэв.

- Харин Рон яасан бэ? Нэг ч гэсэн бөмбөг барьсан уу? гэж Гермiona сонирхоод ихрүүдийг номон дээгүүрээ харлаа.

- Тэр бидний хэн ч хараагүй гэж бодсон үедээ ийм чадвартай байдаг юм. Ийм учраас бид үзэгчдээс бямба гаригт квоффл түүнийг зүг нисэж эхлэхэд хоорондоо ярилцаж эхлэхийг гуйх хэрэгтэй байх гээд Фред нүдээ эргэлдүүлэв.

Тэр босож цонх руу очин харанхуй руу ширтлээ.

- Квиддич миний хувьд энэ сургуульд торгоох цорын ганц баяр баясгалантай зүйл байсан юмсан.

Гермiona түүнийг ширүүн харцаар ажиглав.

- Та нар удахгүй шалгалт өгнө биз дээ!

- Би чамд хэдийн шалгалт биднийг бага зовоож байна гэж хэлсэн дээ. Харин Ажлаас зайлсхийгч зуушаа худалдаанд гаргах гэж байгаа. Бид хатигнаас яаж салах аргаа олсон. Ердөө хэдэн дусал ургамлын шүүс нэмэхэд болно. Лигийн санаанд баярлалаа ...

Жорж том эвшээгээд үүлэнд хучигдсан шөнийн тэнгэр лүү баргар царайлан харав.

- Би бүр энэ тэмцээнийг үзэхэхээр очих эсэхээ ч мэдэхгүй байна. Хэрвээ Захария Смит биднийг ялах юм бол би өөрийгөө алах байх.

- Түүнийг алсан нь дээр гэж Фред хатуу хэлэв.

- Энэ квиддич чинь тэнхим хоорондын үл ойлголцол болон дайсагналыг үүсгэж байна гэж Гермиона сэтгэлээр унан хэллээ.

Тэр «Шидэтний түүврийн» орчуулгаа эргүүлэхэд Харри, Фред, Жорж гурав түүн зэрэг ярвайн харлаа.

- Яасан? Эцсийн эцэст энэ чинь зөвхөн тоглоом биз дээ!

- Гермиона чи бусдын мэдрэмжийг сайн мэддэг хэрнээ квиддичийг ойлгохгүй байна гээд Харри толгой сэгсэрлээ.

- Магадгүй л юм гэхдээ аз болоход Роныг бөмбөг бариулах нь надаас хамаарахгүй гэж тэр ууртай хэлээд очруулгандаа эргэн оров.

Хэдийгээр Харри Гермионад үнэнээ хүлээснээс одон орны цамхаг дээрээс үсэрсэн дээр байсан ч дараагийн бямба гаригт тэмцээн үзэхдээ хайхрамжгүй байхын тулд бүтэн уул галлеон төлөхөд бэлэн байлаа.

Тэмцээний цорны ганц сайн тал гэвэл богино үргэлжилэн Гриффиндорын хөгжөөн дэмжигчид ердөө хорин хоёр минутын зовж шаналгасан мөчийг тэвчин өнгөрүүлжээ. Харрийн бодлоор хамгийн муу тоглосон гурван хүн гэвэл Рон арван дөрөв дэх бөмбөгөө алдаж, Слоупер блажер руу чиглүүлсэн цохиураа Анжелинагийн нүүрэнд буулгаж, Захария Смит гарт нь байгаа квоффлыг нь булаахаар нэхэн ирэхэд Керк шүүрнээсээ хашгиран унасан явдал байлаа. Ямар нэг гайхамшигаар Пуффендуй тэднийг ердөө арван оноогоор хожсон бөгөөд Жинни Пуффендуйн баригч Саммербийн хамрын урдаас снитчийг шүүрэн авснаар оноо зуун дөч, зуун гучын харьцаатай төгсжээ.

- Сайхан барилт байлаа гэж Харри Жинниг оршуулгын юм шиг уур амьсгалтай амралтын өрөөнд эргэн ирэхэд хэллээ.

- Аз таарлаа гээд Жинни мөрөө хавчив. Снитч хурдан биш нисэж харин Саммерби хамгийн зохимжгүй үедээ нүдээ анивчсан. Юутай ч гэсэн чи багтаа эргэн ирвэл ...

- Жинни намайг тоглохыг үүрд хориглосон.

- Чи сургуульд Амбриж байгаа үед тоглож болохгүй гэж Жинни засаад,
- Үүнд ялгаа байна. Ямар ч тохиолдолд чи эргэж ирвэл би ангууч болмоор байна. Анжелина, Алисия хоёр сүүлчийн жилдээ суралцаж байгаа харин надад снитч барихаас илүү оноо оруулах нь таалагдаж байна гэв.

Харри буланд суугаад өвдгөө ширтэн гартаа цөцгийн шар айрагтай лонх барьсан Рон руу харлаа.

- Анжелина түүнийг тавихыг хүсэхгүй байнаа юм. Тэр түүнд авъяас байгаа гэдэгт итгэлтэй байгаа гэж Жинни Харрийн бодлыг таагаад хэллээ.

Харри Анжелинагийн Ронд итгэсэн явдалд талархсан ч багаас гарахыг зөвшөөрөх нь эелдэг хэрэг байсан гэж бодсоор байлаа. Рон талбайг орхин одох үед удахгүй аваргын төлөө тоглох Слизеринийхэн «Уизли манай хаан» дууг түрэн дуулж байв.

Фред, Жорж хоёр ойртож ирэв.

- Надад түүгээр тоглоом хийх дур алга гэж Фред Роныг харж хэлээд,
- Тэр арван дөрвийг алдсан гээд бодоод үз дээ. За яахав энэ үдэш орхиё гэв.

Рон төдхөн унтлагын өрөө лүүгээ явлаа. Харри түүнийг унтсан дүр үзүүлэхийг хүсэх байх гэж бодоод даруй араас нь явсангүй. Тэгтэл ч үнэхээр Харриг өрөөндөө ортол Рон унтсан гэж бодогдуулахаар чанга хурхирч байлаа.

Харри орондоо хэвтээд тэмцээний тухай бодлогоширов. Түүнийг үзэгчидийн суудлаас үзэх нь аймшигтай байлаа. Түүнд Жиннигийн тоглолт таалагдаж байсан ч снитчийг түргэн барих ёстой байсан гэдгийг мэдэж байв ... жижигхэн бөмбөг Керкийн шагайны ойролцоо хөвөх үед хэрвээ Жинни алгуурлаагүй бол Гриффиндорыг ялалтад хүргэх байсан юм.

Амбриж Харри, Гермiona хоёроос хэдэн эгнээний цаана суужээ. Тэр нэг хоёр удаа түүн рүү эргэж харахад бахын том аманд нь тавлангуй инээмсэглэл тодрох шиг санагджээ. Энэ тухай санангуут уур хилэнд автав. Гэхдээ хэдэн хором өнгөрсөн хойно унтахын өмнө сэтгэл хөдлөлөө чөлөөлөх ёстойгоо саналаа. Снегг энэ үгийг окклюменцийн хичээлийн төгсгөл бүрд давтахаас залхдаггүй юм.

Тэр тайвширахыг хичээсэн ч Амбрижын тухай дурсамжын дараа Снеггийн тухай бодол зурсхийхэд тэднийг хоёуланг нь үзэн ядаж байгаагаа ойлгов. Роны хурхиралт үгүй болж гүнзгий удаан амьсгал болон өөрчлөгджээ. Харри анд шигээ унтаж

чадсангүй. Бие нь ядарсан байсан ч тархи нь нойрсохыг хүсэхгүй байв.

Тэр Невилл профессор Стеблътэй Шаардлагатай өрөөнд вальс эргэн, харин профессор МакГонагалл шотландын үндэсний хөөрөгт цуур тоглож байна гэж зүүдлэв. Тэр баяртайгаар тэднийг ширтэж байснаа дараа нь ДА-гийн бусад гишүүнийг эрж олохоор шийдлээ.

Тэгээд өрөөнөөс гартал өмнөө Варнав Вздрюченногийн хөргийн оронд бамбар ассан хатуу чулуун хана байхыг олж харлаа. Тэр толгойгоо удаанаар баруун тийш эргүүлэв. Тэнд цонхгүй дүлий хонгил үргэлжилж алсын буланд нүцгэн хар хаалга харагдана.

Тэр түүн рүү явахдаа сэтгэл нь хөөрөн догдлохыг мэдрэв. Түүнд эцэст нь аз таарч хаалга нээгдэх юм шиг хачирхалтай мэдрэмж төрөх ажээ ... түүнд хүрэхэд ердөө хэдхэн алхам үлдээд байтал гэнэтхэн баруун талын завсраас сулхан цэнхэр гэрэл гийж байхыг ажиглав ... хаалга ялимгүй нээлттэй байлаа ... тэр гараа сунган нээх гэтэл ...

Рон чанга хурхирахад Харри зуун милийн тэртээ байгаа хаалгыг нээхэд бэлнээр баруун гараа харанхуйд сунгасан чигээр сэрлээ. Тэр гараа буулгаж урам хугарч гэмших мэдрэмж төрөв. Тэр энэ хаалгыг харах ёсгүй байсан ч үүний зэрэгцээ хаалганы ард юу байгааг сонирхоход саад болсон Ронд уурсах сэтгэл төрлөө ... Гэхдээ үүнийгээ нойроо хүрэх хүртэл хагас минут л тэвчжээ.

Даваа гаригийн өглөө тэднийг Их танхимд орохтой зэрэгцэн уулийн шуудан ирлээ. Гермiona «Өдөр тутмын зөнч» сонин тэсч ядан хүлээсэн цорын ганц хүн байсангүй бараг бүгдээрээ Үхэл залгигчдын оргосон талаарх шинэ мэдээг тэсгэлгүй хүлээж байлаа. Гермiona уулиндаа кнат төлөөд яаран сонингоо дэлгэхэд Харри жүржийн шүүс хийж автал бүтэн жилийн туршид анх удаагаа цорын ганц захиа авчирсан уул өмнө нь газардсанд эндүүрэл гэдэгт эргэлзсэнгүй.

- Хэнд вэ? гэж тэр залхуутай хэлээд уулийн хошуунаас жүржийн шүүсээ холдуулж захианы хаягийг уншив.

Харри Поттерд, Их танхим, Хогвартс сургууль

Тэр хөмсөг зангидан гар сунгаад уулийн хошуунаас захиагаа авч амжаагүй байтал ахиад гурав, дөрөв, тав дахь ууль ширээн дээр зэрэгцэн суугаад бие биесээ түлхэн тос, будаан дээгүүр чихцэлдэн зүтгэж тус бүрдээ захиагаа өрсөж өгөхийг хичээв.

- Энэ чинь одоо юу гээч вэ? хэмээн Рон гайхлаа. Бүх Гриффиндорынхон юу болж байгааг эргэж харах агшинд ахин гуугалж далавч алгадах чимээ гарч долоон ууль буулаа.

- Харри! Би үүнийг миний бодож байгаа зүйл гэж бодож байна. Нээ дээ! гээд Гермиона том биетэй хашгираа уулийн дороос илгээмжийг татан гаргав.

Харри хүрэн илгээмжийг урлаа. Түүн дотроос «Шүүмжлэгч» сонингийн гурван сарын шинэхэн дугаар гарав. Харри сэтгүүлийг эргүүлээд хулчгардуухан инээмсэглэх өөрийн царайгаа олж харлаа. Гэрэл зурагны дор том улаан үсгээр дараахь зүйлийг бичжээ.

ХАРРИ ПОТТЕР ЭЦЭСТ НЬ ЯРЬЖ ЭХЭЛЛЭЭ:

ХЭЦҮҮ НЭРТИЙН ТУХАЙ ҮНЭН БОЛОН ТҮҮНИЙГ ЭРГЭН ИРЭЛТИЙГ БИ ӨӨРИЙН НҮДЭЭР ХАРСАН

- Муугүй байгаа биз? гэж Гриффиндорын ширээ рүү ирэн Фред, Рон хоёрын дундах сандал дээр суусан Полумна хэлэв.

- Түүнийг өчигдөр орой явуулахад нь би ааваасаа чамаас үнэгүй нэг хувь илгээхийг гуйсан юм. Энэ бүх захиануудыг уншигчдаас гэж бодож байна гээд Харрийн урд байгаа захианууд руу дохив.

- Би ч тэгж бодож байна гэж Гермиона тэвчээргүйхэн хэлээд, Харри, хэрвээ чи эсэргүүцэхгүй бол бид ... гэв.

- Тэг л дээ гэж Харри үл мэдэгхэн гайхширан хэллээ. Рон, Гермиона хоёр шуудхан захиаг задлав.

- Энэ залуу чамайг галзуу гэж бодож байна. Тийм байж ... хэмээн Рон захиаг харж хэллээ.

- Харин энэ эмэгтэй чамайг гэгээн Мунгогийн эмнэлэгийн шивлэгээс гаралтай цочирдол арилгах эмчилгээнд орохыг зөвлөж байна гэж Гермиона хоёр дахь захиаг уншаад урам хугарсан маягтай хэлэв.

- Муугүй л юм. Хөөх! Тэр надад итгэж байна! хэмээн Харри Пейсли гэгч нэртэй шидтэнгээс ирсэн урт захиаг уншаад хэллээ.

- Харин энэ эргэлзэж байна. Чамайг галзуу хүн гэж хэлээгүй ч Хэцүү нэртийг эргэн төрсөнд жинхэнээсээ итгэхийг хүсэхгүй байгаа юм байна. Чөтгөр гэж, зөвхөн

цаас үрж хэмээн Фред урам зоригтойгоор захиаг уншаад дуу алдав.

- Харин энд чиний итгүүлсэн ахин нэг хүн байна, Харри! «Таны түүхийг сонсоод би «Зөнч» сонин шударга бус үйлдэл хийсэн гэж дүгнэж байна ... Хэдийгээр би Хэцүү нэртийн эргэж ирэлтэнд итгэхийг хүсэхгүй байгаа ч гэсэн таныг үнэн хэлсэн гэдгийг хүлээн зөвшөөрч байна ...» Тиймээ энэ ч гайхамшигтай хэрэг байна даа! гэж Гермiona хэлэв.

- Бас нэг нь чамайг зүгээр л догдолсон хэрэг гэж бодож байна хэмээн Рон мөрөн дээгүүрээ захиаг базаж хаяад хэлэв. Харин энэ чамайг үнэнээ хэлсэн явдалд жинхэнэ баатар гэж бодож байгаа юм байна ... тэр ч байтугай гэрэл зургаа явуулж, Хөөх!

- Энд юу болоод байна? гэсэн жингэнэсэн хоолой тэдний ард гарав.

Харри гараараа дүүрэн дугтуйтай дээшээ харлаа. Фред, Полумна хоёрын ард профессор Амбриж зогсоод бүлцгэр нүд нь Харрийн урд байсан уулийн шуудан дээр тусчээ. Түүний ард сониучирхан ширтэх сурагчид үзэгдэв.

- Хэн таньд ийм их захиа илгээгээ вэ, ноён Поттер? гэж Амбриж асуулаа.

- Захиа авах нь гэмт хэрэг болж байна уу? гэж Фред чангаар хэлэв.

- Хичээлийн дараа үлдэж шийтгэл хүлээх гээгүй юм бол болгоомжтой бай, ноён Уизли хэмээн Амбриж анхааруулаад,

- За тэгэхээр, ноён Поттер гэлээ?

Харри тээнэгэлзсэнээ эрт орой хэдий ч «Шүүмжлэгч» сэтгүүл түүний нүдэнд өртөх нь тодорхой байсан тул,

- Би ярилцлага өгсөн учир хүмүүс надад бичиж байгаа юм. Өнгөрсөн зургаан сард надад тохиолдлын үйл явдлын тухай гэж хэлэв.

Ингэж хэлээд тэрбээр багш нарын ширээ рүү түгшин харлаа. Түүнд агшины өмнө Дамблдор харж байсан юм шиг хачирхалтай мэдрэмж төрсөн ч захирал профессор Флитвиктэй ярилцаж байв.

- Ярилцлага гэнээ? Юуны тухай? хэмээн Амбриж чангаар асуув.

- Би сурвалжлагч надад асуулт тавьж түүнд хариулсан тухайгаа ярьж байна.

Энэ ...

Тэр түүнд «Шүүмжлэгч» сэтгүүлийн дугаарыг сунгав. Тэр аваад хавтасыг нь харлаа. Түүний цайвар царай дээр ой гутам ягаан толбонууд үүсэн гарч ирэв.

- Үүний хэзээ хийгээ вэ?
- Өнгөрсөн амралтын өдөр Хогсмид явахдаа.

Тэр Харри руу уурсан харахад богинохон бүдүүн хуруундаа барьсан сэтгүүл чичирлээ.

- Танд ахиж амралтын өдөр Хогсмид явах аялал гэж байхгүй, ноён Поттер. Та яаж зүрхлэж ... чадав аа. Би ахин дахин таны худал хэлэхийг зогсоох гэж оролдож байхад. Харваас миний хичээл зогсоож дийлээгүй бололтой. Гриффиндороос тавин оноо хасаж ахин нэг долоо хоног шийтгэл оноолоо.

Тэр цааш «Шүүмжлэгч» сэтгүүлийг цээжиндээ наан явахад сурагчид араас нь дагуулан харцгаав.

Нэг ч цаг өнгөрөөгүй байхад бүх сургууль даяар аварга том зарлал гарлаа. Түүнийг зөвхөн тэнхимүүдэд ч биш хонгил түүнчлэн анги танхимуудад өлгөжээ.

ХОГВАРТСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧЫН ТУШААЛ

«Шүүмжлэгч» сэтгүүлийг хадгалсан ямар ч сурагч даруйхан хөөгдөх болно. Боловсролын тухай хуулийн хорин долдугаар зүйл.

Гарын үсэг зурсан: Долорес Жейн Амбриж, Ерөнхий байцаагч

Гермионагийн нүдэнд энэ зарлал өртөх болгонд сэтгэл хөөрөн баярлаж байв.

- Юу чамайг тийм их баярлуулж байгаа юм? хэмээн Харри тэссэнгүй асуув.
- Чи үнэхээр ойлгохгүй байна гэж? хэмээн тэр гайхаад,
- Хэрвээ тэр сургууль даяар чиний ярилцлагыг уншаагүй ганц ч хүн бүү үлдээсэй гэж хүсээгүй л юм бол үүнийг хориглох хэрэггүй байсан юм! гэв.

Гермионагийн зөв байлаа. Хэдийгээр Харри өдрийн төгсгөл хүртэл хориотой сэтгүүлийг хараагүй хэдий ч бүгд бие биедээ дамжуулж байлаа. Харри түүний тухай хичээлийн өмнө хонгилд шивнэлдэх, хоолны үеэр болон хичээлийн цагаар арын ширээн дээр ярилцахыг сонссон бөгөөд Гермiona хичээл орохын өмнө охидын жорлон ороод бүх өрөөнд нь энэ тухай ярилцаж байна гэж мэдэгджээ.

- Дараа нь тэд намайг ажиглаад мэдээж чамайг танихыг мэдэх юм болохоор

асуулгаар бөмбөгдсөн. Минийхээр бол Харри чамд тэд итгэж байгаа үнэн шүү. Би чамайг эцэстээ тэднийг итгүүлсэн гэж бодож байна хэмээн баясан хэллээ.

Тэр үед профессор Амбриж сургууль дээр сурагчдыг зогсоон цүнх болон номыг нь нэгжиж, халаасыг нь эргүүлж байв. Харри түүний «Шүүмжлэгч» сэтгүүлийн хориотой дугаарыг хайж байгааг мэдэж байсан ч сурагчид үргэлж хэдэн алхам урьтаж байлаа. Тэд Харрийн ярилцлагатай хуудсыг илбдэж ямар ч өнцгөөс харсан сурах бичигтэй төстэй болгон хувиргах юмуу шидээр хоосон болгоод хүссэн үедээ ярилцлагыг ахин уншиж болгохоор болгожээ. Удалгүй сургуулийн хүн бүр үүнийг уншсан байлаа.

Багш нарт ч мөн адил боловсролын тухай хуулийн хорин зургадугаар зүйлээр хориглосон байсан ч тэд мэдрэмжээ илэрхийлэх арга олжээ.

Профессор Стебль Харри усны хоолой дөхүүлж өгсний төлөө Гриффиндорыг хорин оноогоор шагнаж, профессор Флитвик шившлэгийн хичээлийн төгсгөлд зальтай инээмсэглэн байж гарт нь хайрцаг чихэртэй атгуулаад «Чшш!» хэмээн цааш явсан бол, профессор Трелони хичээл дээрээ гэнэтхэн хэнгэнэтэл цурхиран уйлж ангийн гайхлыг төрүүлэн Амбрижад сэтгэл хангалуун бус байдгаа мэдэгдээд Харри өөрийн насандаа чадахааргүй зүйлийг хийсэн учир насанд хүрсэн үедээ ид яамны сайд болох юм уу арван хоёр хүүхэдтэй болно гэжээ.

Гэхдээ Харри жинхэнэ аз жаргалыг дараагийн өдөр Чжоу түүнийг хувиргалын хичээлийн өмнө гүйцэхэд мэдэрлээ. Түүнийг юу болсны ухаарч амжаагүй байхад Чжоу гараас нь атган чихэнд нь «Намайг үнэхээр уучлаарай. Ийм ярилцлага өгөх нь их зоригтой хэрэг байлаа ... би шууд уйлсан» гэж хэлжээ.

Түүнийг ахин нэг удаагийн нулимс урсгалт гомдоосон ч гэлээ тэдний ахин ярилцаж эхэлсэн нь баярлуулсан бөгөөд хацар дээр нь түргэхэн үнсээд цаашлан одоход баяр хөөрийг мэдэрчээ. Түүнийг дөнгөж хувиргалын хичээлдээ хүрэв үү үгүй юу итгэмээргүй гайхамшигтай явдал болж Симус угтан ирэв.

- Би зүгээр л чамд итгэж байна гэдгээ хэлэх гэсэн юм. Бас энэ сэтгүүлийг ээждээ илгээсэн хэмээн Харрийн зүүн өвдөг рүү шагайн байж хэлэв.

Хэрвээ Харрид бүрэн аз жаргалд хүрэхэд ямар нэг юм дутуу байсан бол энэ нь Малфой, Крэбб, Гойл нарын хариу үйлдэл байлаа. Тэр өдрийн үдэш Харри тэднийг номын санд толгойгоо унжуулан чимээгүйхэн ярилцаж байхыг харлаа. Тэдний хамт туранхай хүү байсныг Гермiona Тоедор Нотт хэмээн шивнэв. Тэд Харриг номын

тавиур дээгүүр алга болох шившлэгийн ном эрж байхад нь олж харлаа. Гойл сүрдүүлэн нударга зангасан бол Малфой ууртайгаар Крэббэд ямар нэг юм шивнэв.

Харри тэднийг яагаад тэгж байгаа болохыг маш сайн ойлгож байв. Тэр эцгүүдийг нь Үхэл залгигчдын тоонд оруулсан билээ.

- Хамгийн инээдтэй нь гэвэл тэд чамайг эсэргүүцэж чадахгүй. Ингэхэд хүрвэл тэд ч гэсэн хориотой ярилцлагыг уншсан болно! гэж Гермiona номын сангаас гарахдаа хөөрөн хэлэв.

Полумна түүнд оройн хоолон дээр «Шүүмжлэгч» сэтгүүлийн дугаар хэзээ ч тийм түргэн зарагдаж байсангүй гэж хэллээ.

- Аав нэмэлт хувь гаргасан! Тэр хүмүүс чамайг үрчгэр эвэртээс илүү сонирхож байгаад итгэж чадахгүй байгаа юм!

Энэ үдэш Гриффиндорын амралтын өрөөнд Харри баатар шиг хүндэтгэгдэв. Фред, Жорж хоёр «Шүүмжлэгч» сэтгүүлийн хавтасыг Томруулах шидээр илбэдэн хананд өлгөсөн бөгөөд Харрийн аварга том толгой доошоо харж үе үе чангаар «ИД ШИДИЙН ЯАМНЫХАН БОЛ ТЭНЭГҮҮД!» гэх юмуу «АМБРИЖ БОЛ ШИВХ» гэж байлаа. Гермionaд энэ хөгжилтэй гэж санагдсангүй бөгөөд төвлөрч чадахгүй байна гэж уурсан хэлээд эрт унтахаар явлаа. Нэг хоёр цагийн дараа Харрид зурагт хуудасны ярьдаг шид арилж эхлэхэд хөгжилтэй санагдахаа больж «ТЭНЭГҮҮД»,

«АМБРИЖ» гэсэн холбоогүй үг хашгирч байв. Эцсийн эцэст Харрийн толгой өвдөж сорви нь таагүйхэн янгинав. Түүнийг тойрон суугаад зуу дахь удаагаа Хогсмидэд болсон өдрийн тухай асууж байсан хүүхдүүдийн урмыг хугалан эрт унтах хэрэгтэй боллоо гэж хэллээ.

Харри унтлагын өрөөндөө ороход хоосон байлаа. Сорви нь ахин төөнөн өвдөхөд хэвтээд өвдөлт удахгүй намдана хэмээн найдав. Тэр бүхлээрээ хэвтээд толгойны өвчин намдаасай гэж хүслээ. Хажуугаараа эргээд нүдээ аньтал бараг агшин зуур унтчихлаа ...

Тэр лааны гэрэлтэй харанхуй хөшиг бүхий өрөөнд зогсож байв. Урдаа байгаа сандлагын түшлэгийг гараараа тулжээ. Олон жилийн турш нарны гэрэл үзээгүй мэт санагдах урт цагаан хуруунууд нь хилэн бүрээс дээрх том цагаан аалз мэт санагдана.

Сандлын өмнө лааны гэрэлд хар жанчтай хүн өвдөг сөгджээ.

- Тэгэхээр надад муу мэдээлэл өгсөн байх нь гэж Харри хүйтнээр уурсан хэллээ.

- Эзэнтээн, би танаас өршөөл гуйж байна хэмээн сөгдсөн хүн хэлэв. Түүний зулай бүүдгэр гэрэлд гялалзана. Тэр чичирч байлаа.

- Би чамайг буруутгаагүй, Руквуд гэж Харри хэрцгий хүйтэн хоолойгоор хэлэв. Тэр сандлаас барихаа болиод шалан дээр сөгдсөн хүн рүү ойртож урд нь зогсоод харлаа.

- Чи үүнийг үнэн гэдэгт итгэлтэй байна уу, Руквуд?

- Тиймээ, эзэнтээн ... Би өөрөө энэ хэлтэст ажилладаг билээ ...

- Эйвери надад Боуд л түүнийг авах боломжтой гэж хэлсэн.

- Боуд түүнийг хэзээ ч авч чадахгүй, эзэнтээн ... Тэр үүнийг мэдэх ёстой ... тэр Малфойн Имперуус шившлэгийн эсрэг тэмцэж чадсан нь эргэлзээгүй ...

- Бос Руквуд гэж Харри шивнэв.

Өвдөглөсөн хүн яарсандаа арай л унасангүй тушаалыг биелүүлэв. Түүнийг сэвхтэй царайн дахь сорви тодхон харгагдаж байлаа. Тэр бага зэрэг бөхийн зогсоод Харрийн царай руу айдаст автан харав.

- Чи надад үүнийг хэлснээрээ сайн зүйл хийлээ. Юу гэвэл ... Би олон сарын турш хоосон чармайлт гаргасан бололтой ... гэхдээ энэ чухал биш ч ... одоо бид бүгдийг эхнээс нь эхэлнэ. Чи лорд Волдемортын талархалыг хүлээнэ, Руквуд ...

- Эзэнтээн ... баярлалаа, эзэнтээн! хэмээн Руквуд сөөнгөтөн санаа амарсан янзтай хэлэв.

- Надад чиний тусламж хэрэгтэй байна. Надад яаж авч болох бүхий л мэдээлэл хэрэгтэй.

- Тэгэлгүй яахав, эзэнтээн ... бүх зүйл таны тааллаар болно ...

- Маш сайн байна ... чи явж болно. Эйвериг над руу ирүүлээрэй.

Руквуд бөхийсөн чигээр ухраад хаалгаар алга болов.

Харри харанхуй өрөөнд ганцаар үлдээд хана руу эргэж харав. Түүний өмнөх сүүдэрт эртний толь өлгөөтэй байлаа. Харри түүн рүү алхав. Тусгал нь харанхуйд тодоор

үзэгдэв ... гавал шиг цонхигор царай ... улаан нүд бүхий хүүхэн хараа ...

- Үгүй эээ!

- Яасан? гэх хэн нэгний хоолой дэргэд нь гарав.

Харри хөшигнөөс гарахыг галзуурсан мэт оролдоод орооцолдон уналаа. Хэсэг хугацааны турш хаана байгаага ойлгож чадсангүй. Тэр харанхуйгаас одоохон цонхигор гавалтай төстэй царай харагдана гэдэгт итгэлтэй байсан ч дэргэд нь Роны хоолой сонсогдлоо.

- Хэрвээ чи галзуу амьтан шиг орилохоо болихгүй бол наанаас чинь гаргалаа шүү!

Рон хөшгийг угз татахад Харри сарны гэрэлд түүнийг ширтлээ. Тэр нуруугаараа хэвтээд сорви нь тэсвэрлэхийн аргагүй өвдөж байв. Рон харваас унтах гэж байсан бололтой жанчныхаа нэг ханцуйг тайлжээ.

- Ахиад л хэн нэгнийг дайрсан уу? Эцгийг минь үү? Нөгөө могой юу?

- Үгүй ... бүгд бүрэн бүтэн. Үнэндээ ... Эйверид юу болохыг мэдэхгүй байна ... түүнд асуудал үүссэн ... тэр түүнд хуурамч мэдээлэл өгсөн ... Волдеморт уурлаж байна хэмээн Харри бувтнахад дух нь шатаж байгаа юм шиг халуу оргив.

Харри хүчгүй болон ёолоод чичрэн сорвио илэв.

- Гэхдээ Руквуд түүнд тусалсан ... тэр одоо ахин зөв замдаа орсон.

- Чи юуны тухай яриад байна? хэмээн Рон айн асуугаад,

- Чи зөвхөн Хэцүү нэртийг харсан гэж ... хэлэхийг хүсээ юу? гэв.

- Би тэр байсан хэмээн Харри хэлээд харанхуйд гараа нүүрэндээ ойртуулж урт цагаан хуруутай болоогүй байгаа даа хэмээн шалгалаа.

- Тэр Руквудтай ярилцсан. Түүнийг Азкабанаас зугтсан Үхэл залгигч болохыг нь санаж байгаа биз дээ? Руквуд сая түүнд Боуд үүнийг хийж чадахгүй гэж хэллээ.

- Үүнийг гэдэг чинь юу гэж байгаа юм?

- Ямар нэг юм авах ... тэр Боудыг чадахгүй гэдгээ мэдэж байсан гэсэн ... Боудыг Империиус шившлэгээр удирдаж байгаа ... Минийхээр бол тэр Малфойн эцгийн гар үүнд оролцсон гэсэн.

- Боудыг шившиж ямар нэг юм авахуулах гээ юу? Гэхдээ ... Харри энэ лав ...

- Зэвсэг байх хэмээн Харри яриаг нь дуусгаад,

- Би мэднэ гэлээ.

Унтлагын өрөөний үүд нээгдэж Дин, Симус хоёр орж ирлээ. Харри ахин орондоо хэвтээд хөлөө тэвэрлээ. Симус саяхнаас түүнийг галзуу гэж бодохоо больсон болохоор энд ямар нэг ер бусын зүйл болсон гэсэн ойлголт өгч болохгүй байв.

- Чи Хэцүү нэрт байсан гэж хэлсэн үү? хэмээн Рон хажуугийн ширээн дээрх хувинтай уснаас хийж авангаа түүн рүү бөхийн бувтнав.

- Тиймээ гэж Харри аяархан хэллээ.

Рон чимээтэй аягатай ус залгилахад Харри төвөнх нь хэрхэн гүрвэлзэхийг харлаа.

- Харри чи хэлэх ёстой гэж тэр Дин Симус хоёрыг унтахад бэлтгэн жанчаа тайлж ярилцах зуур шивнэлээ.

- Би хэнд ч хэлэхгүй гэж Харри шийдэмгий эсэргүүцэв.

- Хэрвээ би окклюменциг эзэмшсэн бол юу ч харах ёсгүй. Тэд намайг өөрийн ухаанаа хааж сургахыг хүсч байгаа. Тэд үүнийг л хүсч байгаа.

Харри «Тэд» гэсэн үгэндээ Дамблдорыг оролцуулжээ. Тэр орондоо эргэж хэвтээд хажуу тийш эргэж Роны гудас чахрахыг сонслоо. Тэр ч бас хэвтсэн бололтой. Харрийн сорви ахин төөнөж эхлэхэд ёолохгүйн тулд дэрний булан хазлаа. Тэр хаа нэгтээ Эйвериг шийтгэж байгааг мэдэж байв.

Маргааш өглөө нь Харри, Рон хоёр болсон явдлын тухай Гермионад хэлэхийн тулд завсарлага хүлээлээ. Тэднийг сонсохгүй гэдэгт бүрэн итгэлтэй байхын тулд Гермионаг сэрүүхэн салхитай хашаанд аваачин дуртай буландаа суугаад Харри өчигдөрийн зүүдний тухай бүх зүйлийг ярьж өглөө. Түүнийг яриагаа дуусгах үед Гермиона хэсэг зуур эсрэг талын буланд хоёулаа толгойгүй болоод малгай зарж байгаа Фред, Жорж хоёрыг ширтэв. Тэд шидэт бүрхээ жанчин доороо нуужээ.

- Ийм учраас л тэд түүнийг алсан байх нь гэж тэр эцэст нь ихрүүдээс харцаа салган хэлээд,

- Боуд зэвсгийг хулгайлахаар оролдоод ямар нэг зүйл тохиолдож. Би зэвсэг юмуу түүнийг тойроод хүрч болохооргүй хамгаалалтын шившлэг байдаг гэж бодож байна. Ийм учраас л Боуд гэгээн Мунгогийн эмнэлэгт үл ойлгогдох хэлээр яриад байж. Гэхдээ анагаагчын юу хэлснийг санаж байна уу? Тэр түүнийг эдгэж байгаа

гэсэн. Харин тэд түүнийг эдгээхгүй нь мэдээж шүү дээ. Тэр зэвсэгт хүрэх үедээ цочирдолд ороод Малфойн илгээсэн шид тайлагдсан байж таарна. Хэрвээ түүний дуу хоолой хэвийн болвол юу хийсэн тухайгаа ярина биз дээ. Ингээд бүгд зэвсэг хулгайлахаар оролдсоныг мэдэх болно. Мэдээж Люциус Малфой түүнд хараал илгээж чадахгүй. Тэр өдөр шөнөгүй яаманд байдаг юм чинь гэв.

- Тэр яаманд миний сонсголын өдөр байсан. Хүлээгээрэй ... Тэгэхэд тэр нууцын хэлтсийн хонгилд зогсож байсан юм байна шүү дээ! Аав чинь хэлэхдээ сонсголын талаар мэдэхийг оролдсон байх гэсэн ч хэрвээ ...

- Стержис! хэмээн Гермiona дуу алдав.

- Чи юу яриад байна? гээд Рон үл итгэн харлаа.

- Стержис Подморыг хаалгаар орох гэсний төлөө баривчилсан! Магадгүй Люциус Малфой л түүнийг илбэдсэн байх! Чамайг тэнд харсан өдөр үүнийг хийсэн гэдэгт мөрийцсөн ч болох юм. Стержист Грюмын үл үзэгдэх цув байсан биз дээ. Хэрвээ тэр энэ үед хаалган дээр зогсож байсан бол Малфой хөдлөхийг нь сонсоод ... эсвэл хэн нэгэн тэнд байгаа гэдгийг тааварласан ч юмуу ... эсвэл зүгээр л Имперуус шившлэг илгээсэн байх ямар ч байсан гэнэтхэн ажилласан байж болох шүү дээ. Тийм учраас Стержисд ахин боломж бий болж ... тэр магадгүй нууцын хэлтсийн хаалга руу орж Волдемортын зэвсгийг хулгайх гэсэн байх ... тайван бай, Рон ... гэхдээ түүнийг бариад Азкабанд илгээсэн гээд Харри руу том харав. Харин одоо Руквуд Волдемортод зэвсгийг яаж авахыг хэлж өгч байна.

- Би бүх яриаг нь сонсоогүй. Руквуд тэнд ажилладаг болохоор ... магадгүй Волдеморт түүнийг зэвсэг авахаар явуулах байх?

Гермiona толгой дохиод өмнөхийн адилд бодолд автсаар байлаа. Тэгснээ гэнэтхэн,

- Харри чи энэ бүхнийг харах ёсгүй биз дээ гэлээ.

- Юу? гэж тэр мэгдэн асуув.

- Чамайг оюун ухаанаа ийм зүйлээс хамгаалахад суралцахыг зарлигдсан гэж тэр ширүүн дуугарлаа.

- Би мэднэ. Гэхдээ ...

- Бид чиний харсан зүйлийг мартсан нь дээр байх. Харин чи окклюменцигийн хичээлд төвлөрөх хэрэгтэй.

Дараагийн өдрүүдэд ямар ч сайн зүйл болсонгүй. Харри уусмалын хичээлд ахин хоёр тэг авч өмнөхийн адил Хагридын хувь заяанд зовсоор байсны дээр Волдеморт

байсан тухайгаа бодохгүй байж чадсангүй ч Рон, Гермиона хоёрт энэ тухайгаа хэлсэнгүй. Тэр энэ тухай Сириустай ярьж чадахгүйдээ харамссан ч ямар ч боломжгүй болохоор энэ бодлоо үлдэн хөөхийг хичээв.

Азгүй нь гэвэл түүний оюун ухаан нууц хадгалахад найдвартай байхаа болсон байлаа.

- Бос, Поттер.

Долоо хоногийн дараа Харри Руквудын тухай ахин зүүдлээд Снегтийн өрөөнд дөрвөн хөллөж бодлоо цэгцлэхийг оролдож байгаагаа ойлгов. Снегг сая түүний хамгийн таагүй үнэт дурсамжуудыг харсны ихэнхи нь сургуульд орохын өмнө Дадли болон түүний найзуудад басамжлагдаж байсан тухай байлаа.

- Чиний сүүлчийн дурсамж. Тэр юуны тухай вэ?

- Мэдэхгүй гэж Харри ядрангуй босоод дуугарлаа. Та миний үеэл ах намайг жорлонд түгжсэн тухай хэлэх гээ юу?

- Үгүй. Би харанхуй өрөөнд өвдөг сөгдсөн хүний тухай ярьж байна хэмээн Снегг аяархан хэлэв.

- Аан, энэ ... юу ч биш.

Снегтийн хар нүд Харриг өрөмдөн ширтэв. Ой ухаанд нь профессорын легилменцийд харааны холбоос шийдвэрлэх үүрэгтэй гэсэн үг орж ирэхэд Харри нүдээ анивчаад өөр тийшээ харлаа.

- Өрөөнд байсан хүн таны ой ухаанд яаж орж ирсэн хэрэг вэ?

- Энэ ... энэ зүгээр л ... зүүд байсан гээд Харри өөр тийшээ харлаа.

- Зүүд гэнээ? хэмээн тэр давтан асуулаа.

Нам гүм болов. Харри шилэн саванд улаан шингэн дотор хөвж байгаа үхсэн том мэлхийнээс хараа салгасангүй.

- Та бид яагаад энд байгаа болохыг ойлгоогүй бололтой, Поттер? Намайг яагаад үдшээ энэ уйтгартай ажилд зориулж байгаа мэдэх үү? гэж Снегг тун аюултай хоолойгоор хэллээ.

- Тиймээ.
 - Тэгвэл бидний яагаад энд байгаа болохыг сануулаадах, Поттер.
 - Яагаад гэвэл би окклюменций суралцах ёстой гэж Харри үхсэн мэлхий рүү харан хэлэв.
 - Зүйтэй, Поттер. Магадгүй чи бүтэн хоёр сарын хичээлийн дараа ямар нэг юм сурахааргүй мангуу байх (Харри түүн рүү үзэн ядан харлаа). Хар Лордын тухай өөр ямар зүүд зүүдэлсэн бэ?
 - Зөвхөн үүнийг хэмээн Харри худал хэлэв.
 - Боломжтой л юм. Магадгүй чамд ийм зүйл харах нь таалагддаг байж болох юм, Поттер. Магадгүй ийм онцгой болохоо мэдэрдэгтээ түүнд талархдаг байж ч болох юм гэж Снегг хүйтэн хар нүдээрээ өрөмдөн хэлэв.
 - Үгүй, мэдрэхгүй байна гээд Харри шүд зуун шидэт саваагаа чанга атгалаа.
 - Энэ чинь сайн хэрэг шүү, Поттер. Учир нь чамд онцгой зүйл байхгүй бөгөөд Хар лорд Үхэл залгигчдадаа юу ярихыг сонсох нь чиний ажил биш.
 - Үгүй, энэ таны ажил биз дээ? гэж Харри палхийтэл хэлэв.
- Тэр энэ үгийг хэлэхийг хүсээгүй авч ихэд уурссан байлаа. Тэд удтал бие биенээ харахад Харри хэтэрхий цаашилснаа ойлгожээ. Гэвч сонирхолтой нь Снеггийн царайд хачирхалтай бараг сэтгэл хангалуун гэмээр өнгө тодров.
- Тиймээ, Поттер. Энэ миний ажил. Харин одоо хэрвээ бэлэн аваас бид ахин эхэлж болох юм хэмээн нүдээ гялалзуулан хэлээд саваагаа өргөлөө.
 - Нэг ... хоёр ... гурав ... Легилименс!
- Зуугаад Дементорууд Харрийн зүг нуурын дээгүүр хөвж ... тэр зовж шаналан төвлөрөхийг оролдож ... тэд улам ойртсоор ... юүдэн дорх харанхуй нүх нь харагдаж эхэлжээ ... тэгтэл Снеггийн урдаа зогсоод амандаа юм бувтнахыг нь харлаа ... яагаад Снегг Дементорууд алга болсон учрыг харах ёстой гэж ...
- Харри саваагаа өргөлөө.
- Протего!
- Снегг гуйвснаа савааны үзүүр нь дээшээ болж гэнэтхэн Харрийн ой ухаанд дурсамж зурсхийн орж ирлээ. Унжуу хамартай хүн айж дагжсан эмэгтэй рүү хашгирч хар

үстэй хүү буланд уйлж байгаа ... тослог үстэй өсвөр нарсны хүү харанхуй унтлагын өрөөнд ганцаар суугаад саваагаа адрын ялаа руу чиглүүлэн буудаж байгаа ... туранхай хүү шүүр унахыг оролдож байхыг хараад нэг охин хөхөрч байгаа ...

- Хангалттай!

Харри цээж рүүгээ хүчтэй түлхэхийг мэдэрч хэдэн алхам ухраад ханын тавиурыг мөргөхөд жингэнэх чимээ сонсогдов. Снегт үл мэдэг чичирч аймшигтай цонхийжээ.

Харрийн нуруу норжээ. Нэг шилэн сав араас нь унан хагарахад дотроос нь уусмал нь алгуур урсав.

- Репаро гэж Снегт шивнэхэд сав агшин зуур хэвийн болов.

- Тэгэхээр Поттер ... бид сайжиралд хүрэв бололтой. Би таньд Бамбай шидийг хэрэглэхийг зөвлөснөө санахгүй байх чинь ... гэхдээ эргэлзээгүй сэтгэгдэл төрөм байлаа ... гэв.

Харри чимээгүй болж ярихад аюултай болсныг ойлголоо. Тэр Снегийн хүүхэд ахуйн дурсамжинд нэвтэрсэндээ итгэлтэй байв. Эцэг эхийнхээ бие бие рүүгээ хашгирахад уйлж байсан жижигхэн хүү одоо түүний урд зогсоод үзэн ядан харж байна.

- Ахин нэг оролдоод үзье гэж Снегт хэлэв.

Харри айдаст автлаа. Тэр Снегт болсон явдлын хариуг авахыг хүсч байгааг ойлгожээ. Тэд ахин ширээний эсрэг талд байраа эзлэв. Харри энд удаад оюун санаагаа бодлоос чөлөөлөхөд хүнд болсон явдалд эргэлзсэнгүй.

- Тэгэхээр гурав хүртэл тоольё. Нэг ... хоёр ... гээд Снегт саваагаа өргөлөө. Харрийг толгойгоо бодлоос чөлөөлж амжаагүй байтал Снегт хэдийн,

- Легилименс! гэж хашгирлаа.

Тэр нууцын хэлтсийн хонгилоор гүйж нүцгэн чулуун ханан дээрх бамбаруудыг өнгөрөөд ... жирийн хар хаалга нүдний өмнө урган гарч ирэхэд түүнд хүрэхэд ердөө хэдхэн алхам үлдсэн мэт санагдаж ахин завсраар нь туяарах сулхан цэнхэр гэрлийг харлаа ...

Тэгтэл хаалга нээгдлээ! Эцэст нь түүгээр ороход хар хана адартай дугуй өрөөнд цэнхэр лааны дөл асаж эргэн тойрон маш олон тооны хаалга байлаа ... тэр цаашаа явах хэрэгтэй ... Гэхдээ аль хаалгыг сонгох вэ? ...

- Поттер!

Харри нүдээ нээлээ. Тэр газар хэвтэж байсан бөгөөд нууцын хэлтсийн хонгилоор жинхэнээсээ гүйсэн мэт амьсгаадаж байв.

- Тайлбарла! гэж өмнө нь зогсож байсан Снегг ууртай хашгирав.

- Би юу болсныг мэдэхгүй байна. Би өмнө нь хэзээ ч үүнийг харж байгаагүй. Би энэ хаалга надад зүүдлэгдэж байсан гэж хэлсэн биздээ ... гэхдээ тэр хэзээ ч онгойж байгаагүй гэж Харри үнэнээ хэлээд хөл дээрээ бослоо. Дагзан дээр нь том булдруу үүсч нүдний өмнө бүх зүйл бүүдгэртэнэ.

- Чи хангалтгүй ажиллаж байна!

- Ямар нэг ул мэдэгдэх шалтгааны улмаас Снегг дурсамжаа үзүүлсэн хоёр хормын өмнөөс илүүтэй уурсав.

- Мм залхуу, хайхрамжгүй Поттер! Хар лорд гайхах юм алга ...

- Танаас яагаад Волдеморгыг Хар лорд гэж нэрлэдгийг чинь асууж болох уу, ноёнтоон? Би түүнийг зөвхөн Үхэл залгигчид тэгж нэрлэдэг гэж сонссон.

Снегг уурсан ярзайхад гадаа хаа нэгтээ эмэгтэй хүний орь дуу тавих чимээ сонсогдов. Тэр толгойгоо дээшлүүлэн адар руу харав.

- Юу болоод ... гэж тэр бувтнав.

Харри ямар нэг чимээ шуугиан сонссон бөгөөд үүдний танхимаас дуулдаж байна гэсэн сэтгэгдэл төрөв. Снегг хөмсөг зангидан түүн рүү харлаа.

- Чи ямар нэг ер бусын зүйл ирэх замдаа харсан уу, Поттер?

Харри толгой сэгсэрлээ. Хаа нэгтээ ахин эмэгтэй хүний хашгиралт сонсогдлоо. Снегг саваагаа бэлхэн барьсаар хаалгаар гарч одов. Харри алгуурласнаа араас нь даган хөдлөв.

Хашгиралт үүдний танхимын зүгээс сонсогдож байв. Харри чулуун шатаар гүйн газар дорх хонгилоос гарах үедээ бүгдийг сайтар сонслоо. Түүнийг үүдний танхимд хүрэх үед дүүрэн хүн цуглажээ. Их танхимд хооллож байсан сурагчид болсон үйл явдлыг харахаар бөөн бөөнөөрөө гүйн гарч ирэхэд зарим нь гантиг шатан дээрээс өлийлдөнө. Харри өндөр биетэй Слизеринчүүдийн дундуур зүтгэлэн хүүхдүүд голдоо том дугуй зай гарган зогссоныг олж харлаа. Зарим нь цочирдсон, зарим нь айсан төрхтэй харагдана. Үүдний танхимын эсрэг талд профессор МакГонагалл

болсон үйл явдалд дотор нь муухайрсан янзтай зогсож байв.

Үүдний танхимын голд профессор Трелони нэг гартаа шидэт саваа, нөгөө гартаа хоосон лонх бариад галзуурсан хүний байртай зогсож байлаа. Үс нь сэгсийж нүдний шил нь хазайсны улмаас нэг нүд нь нөгөөгөөсөө том харагдаж, тоолохын аргагүй алчуур ороолт мөрөн дээрээ унжуулжээ. Мэргэ төлгийн багшийн хажуугийн шалан дээр хоёр аварга том чемодан байсны нэг нь уруугаа харснаас үзэхэд шатаар араас нь гулгуулсан бололтой. Профессор Трелони шатны хөлд зогсож байсан хэн нэгэн рүү айдаст автан харснаа,

- Үгүй! Үгүй! Энэ боломжгүй ... болохгүй ... би үүнийг зөвшөөрч чадахгүй! гэж хашгирав.

- Та юу болсныг ойлгохгүй байна уу? гэх цангинасан дуу гарахад Харри баруун тийшээ зүтгэлэн Трелониг тэгтэл нь айдаст автуулсан хүнийг олж харлаа. Энэ бол профессор Амбриж байв.

- Та маргаашийн цаг агаарыг ч урьдчилан хэлэх чадваргүй ч байж миний шалгалтын үр дүнд өрөвдөлтэй үр дүн үзүүлсэн гэдгээ ойлгохгүй байна уу?

- Та чадахгүй! Та ... намайг халж чадахгүй! Би энд арван зургаан жилийг өнгөрүүлсэн! Хогвартс миний төрсөн гэр гэж профессор Трелони нулимс урсган хэллээ.

- Тэр цагийн өмнөөс таны гэр байхаа больсон. Сайд таныг халах тушаал гаргасан. Харин одоо эелдэгээр шилтгээнийг орхиж үз. Та бидэнд саад болоод байна хэмээн профессор Амбриж бахын царайдаа ёжтой инээмсэглэн тодруулан хэлээд чемодан дээрээ эхэр татан суух профессор Трелониг харлаа.

Тэр профессор Трелони чичирэн ёолж цөхөрсөндөө чемодан дээрээ урагш хойш савчихыг баяр хөөртэйгээр ширтэнэ. Харри эхэр татан уйлах чимээ сонсоод ийш тийшээ харав. Лаванда, Парвати хоёр мөр мөрөө дэрлэн чимээгүйхэн мэгшиж байлаа. Тэгтэл хөлийн чимээ сонсогдов. Үзэгчдийн дундаас профессор МакГонагалл гарч Трелониг тайвшируулан нуруун дээр нь зөөлөн алгадангаа жанчныхаа халааснаас том ноосон алчуур гаргаж өглөө.

- Сивилла минь ... тайвширч үз ... үүгээр нулимсаа арч ... бүх зүйл бодсоноос тийм ч муу биш байна ... чи Хогвартсыг орхих хэрэггүй ...

- Өө, тийм гэж үү, профессор МакГонагалл? Хэн таныг ийм зүйл хийхийг

зөвшөөрөх юм бэ гэж Амбриж хүйтнээр хэлээд урагш алхав.

- Би гэх хоолой сонсогдлоо.

Үүдний царсан хаалга нээгдэв. Сурагчид босгон дээр зогсож байгаа Дамблдор зам тавьж өглөө. Харри түүний ийм хачирхалтай манантай шөнө гадаа юу хийж байсныг ойлгож чадсангүй. Тэр хаалгаа онгорхой орхиод үзэгчдийн эгнээ дундуур яван чемодан дээрээ суугаад чичирэн уйлж байсан профессор Трелони болон дэргэд нь хөшин зогссон МакГонагалл хоёр луу очлоо.

- Профессор Дамблдор та юу? гэж Амбриж таагүй инээд алдан асуугаад,

- Таныг үйл явдлыг ойлгоогүй байх гэж айж байна. Надад ажлаас халах тухай яамны сайдын гарын үсэг зурсан тушаал байгаа. Боловсролын тухай тухай хуулийн хорин гуравдугаар зүйлд Хогвартсын ерөнхий байцаагч багш нарыг ажилд тэнцэх эсэхийг нь шалгах эрхтэй гэж бичсэн байгаа. Би профессор Трелониг ажил мэргэжилдээ тэнцэхгүй гэж үзсэн учраас халж байна гээд жанчнаасаа хуйлаастай цаас гаргаж ирлээ.

Харрийн гайхлыг төрүүлэн Дамблдор үргэлжлүүлэн инээмсэглэсээр байв. Тэр мэгшин уйлж буй профессор Трелони руу харснаа,

- Таны зөв бололтой, профессор Амбриж. Ерөнхий байцаагч миний багш нарыг халах бүрэн эрхтэй. Гэхдээ таньд тэднийг шилтгээнээс хөөх эрх байхгүй гээд эелдэгээр мэхийн ёсолж,

- Ийм хүч зөвхөн захирлын мэдэлд байдаг гэж айж байна. Би профессор Трелониг Хогвартст үргэлжлүүлэн үлдэхийг хүсч байна гэлээ.

Тэгтэл профессор Трелони хийрхэн инээд алдсанаа далдлах гэж ханиалгалаа.

- Үгүй ээ, үгүй би явах болно, Дамблдор! Би Хогвартсад үлдсэнээс хаа нэгтээ явж зол заяагаа эрсэн нь дээр байх.

- Үгүй. Надад та энд үлдсэн нь дээр байна, Сивилла гээд МакГонагалл руу эргэж,

- Та Сивиллаг шатаар дээш хүргэж өгнө үү, профессор МакГонагалл гэлээ.

- Тэгэлгүй яахав. Босоорой, Сивилла.

Цуглагсад дундаас профессор Стебль яаран гарч ирээд Трелонигийн нөгөө тохойноос дэмнэлээ. Тэд хамтдаа Амбрижийн дэргэдүүр өнгөрч гантиг шатаар

өгсөв. Тэдний араас профессор Флитвик гүйн гарч ирээд саваагаа өргөн «Локомотор, чемодан!» гэтэл профессор Трелонигийн тээш агаарт хөөрөн араас нь өгсөв.

Профессор Амбриж Дамблдороос нүд салгалгүй зогсож хорлонтой инээмсэглэсэн хэвээр байлаа.

- Юу гэвэл та түүнд юу ч хийсэн байлаа гэсэн би мэргэ төлгийн шинэ багшийг томилох үед өрөө шаардагдах болно доо?

- Өө, энэ асуудал биш. Би хэдийн мэргэ төлгийн шинэ багшийг олсон бөгөөд тэр нэг давхарт амьдрахыг эрхэмлэдэг юм гэж Дамблдор эелдэгээр хариулав.

- Та олсон гэнээ? Та юу? Дамблдор, таньд сануулахад боловсролын тухай хуулийн хорин хоёр дугаар зүйлд заасны дагуу ... гэж Амбриж муухай хашгирав.

- Яамнаас хэрвээ захирал шинэ багш олоогүй нөхцөлд үүнийг баримтална гэж заасан байдаг юм. Гэхдээ таньд баяртайгаар мэдэгдэхэд энэ тохиолдолд би амжилттайгаар олсон. Танилцуулахыг зөвшөөрнө үү?

Тэр шөнийн манан суунаглан байгаа үүдний хаалга руу эргэлээ. Харри туурайны чимээ сонслоо. Үүдний ойролцоох сурагчид түгшин шуугилдаж яаран ухрахад зарим нь шинэ багшид зам цэвэрлэж өгөх гээд бүдэрч унав.

Манангаас Харрийн нэг удаа Хориотой ойд өнгөрүүлсэн аймшигтай шөнө харсан цайвар үс, цэнхэр нүд морины бие дээр залгагдсан хүний толгой гарч ирлээ.

- Энэ бол Флоренц. Түүнийг тохируно гэж найдна хэмээн Дамблдор мэгдсэн Амбрижад хандан баясгалантайгаар хэлэв.

БҮЛЭГ 27: ХҮН МОРЬ БА ХОВЧ

- Чамайг одоо мэргэ төлгийн хичээлээс татгалзсандаа харамсаж байна гэж мөрийцсөн ч болох юм, Гермiona? гэж Парвати инээмсэглэн асуулаа.

Профессор Трелониг халснаас хойш хоёр хоног өнгөрч өглөөний цайны үе байлаа. Парвати сормуусаа шидэт саваагаар буржийлгаад халбаганд тусгалаа бахдан харав. Өглөө тэдэнд Флоренцийн анхны хичээл орох байв.

- Тийм ч их биш л дээ. Хэзээ ч моринд дуртай байсангүй гэж гартаа «Өдөр тутмын зөнч» сонинны шинэхэн дугаар барьсан Гермiona хайхрамжгүй хэлэв.

Тэр хуудсыг эргүүлээд харав.

- Тэр чинь морь биш хүн морь! гэж Лаванда уурсан дуу алдав.

- Бас ямар гоёмсог хүн морь гээч хэмээн Парвати санаа алдлаа.

- Тэгсэн ч гэсэн дөрвөн хөлтэй. Ер нь бол Трелонигийн явалт та нарыг гомдоосон юм шиг санагдах юм гэж Гермiona хүйтнээр хэлэв.

- Мэдээж гомдоосон! Бид түүнийг эргэж өрөөнд нь очсон.

- Тэр хэр байна даа? гэж Харри асуув.

- Хөөрхий амьтан тийм ч сайн биш байна лээ. Уйлаад Амбрижтай хамт энд үлдсэнээс шилтгээнийг үүрд явах юмсан гэж ярьж байсан. Би түүнийг буруутгахгүй л дээ. Амбриж түүнтэй аймшигтай харьцсан биз дээ?

- Надад бол зөвхөн Амбриж аймшигтай болж эхлэх шиг санагдаж байна гэж Гермiona баргар хэлэв.

- Итгэхэд ч бэрх юм. Минийхээр бол Амбриж одооныхоос дор байгаагүй хэмээн Рон өндгөн жаврайтай таваг дээгүүр өнгийн дуугарлаа.

- Миний үгийг ойлго. Тэр Дамблдорыг өөртэй нь зөвлөлгүй шинэ багш сонгосон явдалд өшөө авахыг хүсч байгаа юм шиг санагдсан. Ялангуяа ахин нэг хагас хүний хувьд шүү. Та нар Флоренц орж ирэх үед түүний царай ямар болсныг харсан уу? гээд Гермiona сонингоо хаалаа.

Өглөөний цайны дараа Гермiona шидэт тооны ухаандаа явж Харри, Рон хоёр мэргэ төлгийн хичээл рүү явж байгаа Парвати, Лаванда хоёрын араас даган үүдний танхим руу гарлаа.

- Бид умард цамхаг руу явахгүй юм уу? гэж Рон Парвати гантиг шатаар өгссөнгүйд гайхлаа.

Парвати түүн рүү үл тоомсорлон харав.

- Чинийхээр бол Флоренц энэ шатаар өгсөж чадах юм шиг байна уу? Бидэнд одоо арван нэгдүгээр анги хэрэгтэй. Өчигдөр орой самбар дээр зарлал гарсан байсан.

Арван нэгдүгээр анги нэг давхарт байрладаг бөгөөд Их танхимын эсрэг талын үүдний өрөөнөөс эхлэн хүрдэг байлаа. Харри энэ ангийг мэдэх хэдий ч тэнд ховорхон хичээл ордог учир эмх замбараагүй байдаг юм. Тэр Роны араас орохдоо жинхэнэ ойн өвсөн дээр зогсож байгаагаа мэдээд гайхширлаа.

- Үгүй ер өө!

Түүний хөл дор хөвд намилзан эргэн тойрон модод ургаж өтгөн навчис нь цонх адрыг халхлан завсраар нь гэрэл бүүдгэртэн өрөөнд ногоовтор манан үүсгэнэ. Тэд модод руу нуруугаа харуулан гараа энгэртээ зөрүүлэх юмуу өвдгөө тэвдсэн байртай тэврэн суусан сурагчид руу хүрлээ. Зүлгэн дунд Флоренц зогсож байв.

- Харри Поттер! гэж тэр Харрид гар сунгаад хэлэв.

- Ээ ... сайн байна уу. Таныг харахад маш их таатай байна гэж хэлээд хүн морьтой гар барихад цэнхэр нүдээрээ цоо ширтэн харлаа.

- Би ч гэсэн. Бид ахин уулзана гэж хэлсэн байхаа хэмээн хүн морь цайвар үстэй толгойгоо бөхийлгөн хэлэв.

Харри Флоренцын цээжин дээр туурайны оромтой хөхөрсөн толбо байхыг харлаа. Нэг ангийхан нь түүнийг Флоренцтэй танил явдалд түгшингүй ажиглав.

Хаалга хаагдахад сүүлчийн сурагч хогийн савны дэргэдэх хожуул дээр сууж Флоренц гараа өргөн бүгдийг өрөөг харахыг урив.

- Профессор Дамблдор надад ангийг оршин суудаг газартайгаа адил болгон өөрчлөхийг зөвшөөрсөн юм. Би та нарыг даваа гариг хүртэл миний гэр байсан Хориотой ойд сургахыг эрхэмлэж байгаа ч ... одоо энэ боломжгүй болсон.

- Уучлаарай ... эрхэмээ яагаад тэр вэ? Бид тийшээ Хагридтай явахдаа айдаггүй шүү дээ! гэж Парвати гараа өргөн хулчгардуухан асуулаа.

- Асуудлын гол нь зоригтой гэдэгт байгаад биш юм. Би тийшээ очиж болохгүй болсон. Намайг манай сүрэг хөөсөн.

- Сүрэг гэнээ? хэмээн Лаванда гайхширан хэлээд, Тэгэхээр байгаа ... а-аан!
Тэгэхээр та нар олуулаа хэрэг үү! хэмээн ичингүйрэн давтахад
- Харри түүний үнээний тухай бодож байсныг ойлгов.
- Та нарыг Хагрид фестралууд шиг үржүүлсэн үү? гэж Дин сониучирхав.
Флоренц түүн рүү толгойгоо алгуурхан эргүүлэн харахад тэр шуудхан аймшигтай тэнэг зүйл хэлснээ ойлгожээ.
- Би хүсээгүй ... уучлаарай гээд чимээгүй боллоо.
- Хүн морьд бол хүмүүсийн тоглоом юмуу зарц биш гэж Флоренц тайван хэлэв.
Нам гүм болсны дараа Парвати ахин гараа өргөв.
- Уучлаарай эрхэм ээ ... таныг бусад хүн морьд чинь хөөсөн гэж хэлсэн үү?
- Намайг Дамблдорын гуйлтын дагуу та нарт багшилахыг зөвшөөрсөн учраас.
Тэд үүнийг өөрсдийн төрлөөсөө урвасан хэрэг гэж үзэж байгаа юм.
Одоо л Харри бараг дөрвөн жилийн өмнө хүн морь Бейн Флоренц руу Харриг нуруун дээрээ суулгасны төлөө хашгирч байсныг саналаа. Тэр үед түүнийг зөрүүд амьтан гэж нэрлэж байсан. Тэгэхээр Бейн ч Флоренцын цээж рүү өшиглөсөн байж магадгүй гэж Харри бодов.
- Алив эхэлцгээе гэж Флоренц хэллээ. Тэр урт цагаан сүүлээ исгэрүүлэн савчаад гараа толгой дээрх навчистай адар руу өргөн алгуурхан буулгав. Өрөөний гэрэл илүү харанхуй болж үдшийн ойд байгаатай адил адарт одод түгэв.
Ангид гайхсан дуу алдалт сонсогдож Рон сонсогдохуйц «Муугүй л юм!» гэж шивнэлээ.
- Шалан дээр нуруугаараа хэвтээд тэнгэр рүү харцгаа. Тэнд манай ард түмний хувь заяаг бичсэн байдаг юм гэж Флоренц тайван хэлэв.
Харри адар луу харлаа. Түүн лүү жижигхэн улаан од анивчив.
- Би та нарыг гариг болон дагуулуудыг нь одон орны хичээл дээр үзсэнийг мэдэж байна. Та нар газрын зураг дээр ододын тэнгэр дэх хөдөлгөөнийг судалсан. Хүн морьд олон зууны өмнөөс эдгээр нууцыг тайлж ирсэн. Бид тэнгэрийн зургаар ирээдүйг тааварлаж сурах болно ...
- Профессор Трелони бидэнд одон орны зурхай заасан! гэх газар нуруугаараа

хэвтэж байсан Парватигийн хөөрсөн дуу гарч гараа дээш өргөв.

- Ангараг гариг одооных шигээ Санчир гаригийн буланд байгаа үед золгүй явдал болон түүнтэй адилтгах зүйлийг зөгнөж биднийг онцгой болгоомжтой байх ёстойг сануулж байгаа юм гээд баруун дээд талын өнцөг рүү заалаа.

- Хүмүүсийн бодож олсон дэмий зүйл гэж Флоренц бувтнав. Парватигийн гар хүчгүй болон шалан дээр буулаа.

- Жижигхэн гэмтэл, өчүүхэн хүмүүсийн гай зовлон. Тэд аварга том орчлон ертөнцийн хувьд шоргоолж шиг жижигхэн бөгөөд одод эрхэсийн хөдөлгөөн тэдний талаар юу ч үзүүлдэггүй юм гээд Флоренцийн туурайн чимээ хөвдтэй шалан дээгүүр гарав.

- Профессор Трелони ... хэмээн Парвати таагүйхэн ахин хэлэв.

- Ердөө хүн шүү дээ. Ийм учраас танай ард түмэнд саад хийж байгаа зөгнөн хэлж байгаа зүйлээсээ зайлсхийж чадахгүй.

Харри Парватиг харахын тулд толгойгоо хөдөлгөв. Тэр хэдэн сурагчдын цаана ихээхэн доромжлогдсон төрхтэй хэвтэж байлаа.

- Магадгүй Сивилла Трелонид үнэхээр ирээдүйг зөгнөх авъяас байж болох юм хэмээн Флоренц тэдний урдуур холхин яриагаа үргэлжлүүлэхэд Харри сүүл агаарт хөнгөхөн зүсэх чимээ сонслоо.

- Гэвч тэр ихэнхи цагаа тэнэг мэргэ төлөгт зарцуулсандаа хүний хувьд сэтгэл хангалуун байдаг. Би ийшээ та нарыг хүн морьдын үнэнч шударга цэцэн мэргэн ухаанд сургахаар ирсэн билээ. Бид тэнгэрт тусгагдсан хор хөнөөлийн томоохон шинж тэмдэгийг унших болно. Заримдаа харсан зүйлээ ойлгохын тулд арван жилийг өнгөрүүлэх нь ч бий.

Флоренц Харрийн дээр байгаа улаан од руу заалаа.

- Өнгөрсөн арван жилд шидтэний ертөнцөд хоёр багахан дайн дэгдсэн. Ангариг бидний дээгүүр хурцаар гэрэлтэн гялалзаж удахгүй болох тэмцэл тулааныг зөгнөж байна. Хүн морьд ургамал ногоо шатаан утаа болон үнэрээр нь зөгнөн хэлж чаддаг юм ...

Энэ бол Харрийн үзэж өнгөрүүлсэн хамгийн ер бусын хичээл байлаа. Тэд ангийн шалан дээр хамба шарилж цэцэг шатаан Флоренц тэдэнд хөнгөхөн суунаглах

утаанаас хэлбэр дүрс ялган харуулахыг хичээсэн авч тэдний хэн ч шинж тэмдгийг харсангүйд гомдсонгүйн дээр хүмүүс энэ урлагыг ховорхон эзэмшдэг бөгөөд хүн морьд эзэмшсэн хэдий ч ийм зүйл итгэх нь хэтэрхий тэнэг хэрэг гэж үздэг тул тэд ч бас алдаж байгаа хэрэг гэж хэлжээ. Тэр Харрийн мэдэх нэг ч багштай адилгүй байлаа. Түүний хувьд тэднийг сургах нь гол биш бөгөөд ямар ч мэдлэг тэр дундаа хүний мэдлэг ийм энгийн хялбар биш гэж ойлгуулахад чиглэсэн мэт санагдана.

- Түүнийг жинхэнээсээ итгэлтэй байсан гэж хэлэхгүй юм байна. Би удахгүй дайн дэгдэх гэж байгаа хэдэн муугүй шинж тэмдэг мэднэ, харин чи? гэж Рон гал түлж байх зуураа аяархан хэллээ.

Ангийн гадаа хонх дуугарахад бүгд цочлоо. Харри бөглүү ойд биш шилтгээнд байгаа гэдгээ таг мартсан байв. Сурагчид гадагшаа гарахдаа сэхээрч амжаагүй мэт төрхтэй үзэгдлээ.

Харри, Рон хоёр тэдний араас гарахад Флоренц гэнэтхэн,

- Харри Поттер чамтай солих хэдэн үг байна гэв. Харри саатахад хүн морь түүн рүү ирлээ. Рон тээнэгэлзэв.

- Та ч гэсэн үлдэж болно. Зөвхөн хаалгаа хаагаарай гэж Флоренц түүнд хэлэв. Рон яаран гуйлтыг биелүүллээ.

- Та Хагридын найз биз дээ, Харри Поттер? гэж хүн морь хэлэв.

- Тиймээ гэж Харри хариулав.

- Тэгвэл түүнд миний анхааруулгыг дамжуул. Түүний төлөвлөгөө бүтэхгүй. Тэр өөрийн оролдлогоо орхисон нь дээр.

- Оролдлогоо орхих гэнээ? хэмээн Харри гайхширан давтав.

- Тиймээ яагаад гэвэл түүний төлөвлөгөө бүтэхгүй гэж Флоренц толгой дохин батлаад,

- Би өөрөө Хагридыг анхааруулах байсан ч хөөгдсөн учир ойд ойртох нь ухаалаг бус хэрэг болно ... Түүнд хүн морьдтой тулалдахаас илүү хангалттай асуудал байгаа гэв.

- Гэхдээ ... Хагрид юу хийх гэж байгаа юм бэ? гэж Харри түгшив. Флоренц түүн рүү тоомсоргүй харлаа.

- Хагрид саяхан надад томоохон туслалцаа үзүүлсэн. Би удаан хугацааны

өмнөөс түүний амьтдад хайртай байдаг явдлыг хүндэтгэж явдаг. Би түүний нууцыг хэлэхгүй. Гэхдээ Хагрид эрүүл ухаанаар бодох хэрэгтэй. Түүний төлөвлөгөө бүтэхгүй. Түүнд энэ тухай хэл, Харри Поттер. Таньд амжилт хүсье.

Харрийн «Шүүмжлэгч» сэтгүүлд өгсөн ярилцлагын дараах баяр хөөр төдөлгүй арилав. Уйтгартай гурван сар салхитай дөрвөн сараар өөрчлөгдөж түүний амьдрал ахиад санаа зовсон асуудлаар дүүрэн боллоо.

Амбриж өмнөхийн адилаар шидэт амьтны бүх хичээлд ирж байсан учир Флоренцын гуйлтыг биелүүлэхэд хүнд байв. Эцэст нь Харри үүнийг хийх нэг арга олсон нь

«Гайхалтай амьтад ба тэдний оршин байдаг газар» гэдэг номоо мартаад хичээлийн дараа эргэн иржээ. Тэр Хагридад Флоренцын анхааруулгыг давтан хэлэхэд ойн сахиул балмагдан гайхсан хэдий ч даруй биеэ барилаа.

- Сайн залуу шүү, Флоренц. Гэхдээ Флоренц юуны тухай ярьсаныг мэдэхгүй байна. Миний бүх зүйл сайн болж байгаа гэж сөөнгөтөн хэлэв.

- Чи юу бодоо вэ, Хагрид? гэж Харри чухалчлан асуугаад,

- Чи болгоомжтой байх хэрэгтэй. Амбриж хэдийн Трелониг хөөсөн нь минийхээр бол зөвхөн эхлэл. Хэрвээ чи ямар нэгэн хориотой зүйл хийх юм бол тэр чамайг ...

- Ажлаа хадгалж үлдэхээс илүү чухал зүйл бий шүү гээд Хагридын гар үл мэдэг чичирэхэд түмпэнтэй шивхээ асгачихлаа. Чи надад санаа зовох хэрэггүй. Яв даа, тэр бол сайн залуу байгаа юм.

Харри сэтгэл зовсон хэвээр шалаа цэвэрлэж буй Хагридыг орхиод шилтгээн хүрэх замаар явлаа.

Тэр үед багш нар болон Гермionaгийн анхааруулсан ёсоор С.И.Ш-ийн шалгалт нүүр тулан ойртож ирэв. Бүх тавдугаар дамжааныхан сэтгэл хямралд орж Ханна Аббот гэнэтхэн ургамал судалын хичээл дээр нулимс асгаруулан шалгалт өгч чадахгүй усан тэнэг учраас одоохон сургуулийг орхихыг хүсч байна гэж мэдэгдээд хатагтай Помфригийн Тайшвшируулагч уусмалыг түрүүлэн хүртлээ.

Хэрвээ ДА байдаггүйсэн бол Харри ихээхэн золгүй нөхцөлд байх байлаа. Заримдаа түүнд Шаардлагатай өрөөнд өнгөрүүлэх хэдхэн цагийн төлөө амьд явж байгаа юм шиг санагдах нь бий. Тэр хэдэн удаа андуудаа хэр хол явсныг харж бахархах сэтгэл төржээ. Заримдаа Амбриж ДА-гийн бүх гишүүд хар урлагаас хамгаалах хичээлийн

шалгалт дээр «онц» дүн авсныг мэдвэл яах бол гэж боддог байв.

Тэд эцэстээ бүгдийн хүсэн хүлээж байсан Патронусын шид дээр ажиллаж эхэлсэн бөгөөд Харри хүүхдүүдэд Патронусыг гаргах нь эхэндээ ямар байдгийг тайлбарлажээ.

- За чи боль доо. Тэд ямар хөөрхөн юм бэ! гэж Чжоу өөрийн Патронус болох мөнгөлөг хун адар дээгүүр хөөрөхөд хөгжилтэй дуу алдав.

- Тэд хөөрхөн гэдэг нь чухал биш чамайг хамгаалах чадвартай гэдэгт гол учир байгаа юм. Бидэнд Боггарт ч юмуу тиймэрхүү зүйл хэрэгтэй байх. Би анх Патронусыг дуудахдаа Боггартыг Дементор болгон бэлтгэл хийж байсан ...

- Тэгвэл аймшигтай шүү дээ! гээд Лавандаа савааныхаа үзүүрээс мөнгөлөг утаа суунаглуулан, Минийх ... одоо хүртэл ... болохгүй! байна гэж ууртай хэлэв.

Невиллийнх ч гэсэн бас бүтсэнгүй. Тэр нүүрээ үрчийлгэн төвлөрөх хэдий ч савааны үзүүрээс сулхан мөнгөлөг утаа гарч байлаа.

- Чи ямар нэг сайн юмны тухай бод гэж Харри түүнд сануулав.

- Би хичээж л байна хэмээн тэр золгүй хоолойгоор хэлэхэд хэт хичээсэндээ болоод нүүрнээс нь хөлс урсаж байлаа.

- Минийх болж байх шиг байна, Харри! гэж өнөөдөр анх удаагаа Дин ДА-гийн цугларалтанд авчирсан Симус орилоод,

- Хараач ... Өө, явчихлаа! Гэхдээ энэ ямар нэг үстэй зүйл байсан, Харри! гэв.

Гермионагийн Патронус мөнгөлөг халиу агаад түүнийг тойрон хөгжилтэй цовхчин эргэлдэв.

- Тэд үнэхээр хөөрхөн юм хэмээн тэр сэтгэл хангалуунаар ширтэн хэлэв. Шаардлагатай өрөөний хаалга ахин нээгдсэнээ хаагдав. Харри орж ирсэн хүний зүг харсан ч хэн ч үзэгдсэнгүй. Тэгтэл дараагийн агшинд хэн нэгэн өвдөгнийх нь жанчнаас зулгаав. Тэр доошоо хараад гэрийн үйлчлэгч Добби олон давхар ноосон малгайн дороосоо бүлтийн ширтэхийг гайхан олж харлаа.

- Сайн уу, Добби! Чи энд яагаад ... юу болоо вэ?

Үйлчлэгчийн нүд айдаст автан томорч бие нь чичирч байв. Харрийн дэргэдэх хүүхдүүд чимээгүй болон Доббиг дагуулан харлаа. Хэд хэдэн амжилттай болсон

Патронус мөнгөлөг утаа болон суунаглахад өрөөнд урьдынхаас илүү харанхуй болов.

- Харри Поттер, ноёнтоон. Харри Поттер, ноёнтоон ... Добби таныг анхааруулахаар ирлээ ... гэхдээ бүх гэрийн үйлчлэгчийг чимээгүй байхыг зарлигдсан гэж үйлчлэгч хөлөөсөө толгой хүртлээ чичирэн хэлэв.

Тэр хана руу толгойгоороо мөргөхөөр гүйлээ. Харри Доббийн өөрийгөө шийтгэдэг занг мэдэх болохоор барьж авах гэсэн ч чулуун ханыг найман давхар малгайгаараа мөргөөд бөмбөг шиг ойлоо. Гермiona болон хэдэн охид айж өрөвдсөндөө дуу алдав.

- Юу болоо вэ, Добби? гэж Харри өөрийгөө гэмтээхээс нь үйлчлэгчийн жижигхэн гараас зууран асуулаа.

- Харри Поттер ... тэр ... тэр ...

Добби сул гараараа хамар луугаа хүчтэй цохилоо. Харри түүнийг нь бас барив.

- Тэр гэдэг хэн бэ, Добби?

Гэхдээ тэр бүгдийг шууд ойлгожээ. Зөвхөн ганц эмэгтэй л үйлчлэгчийг ийм байдалд оруулж чадна. Добби түүн рүү ялимгүй сөлийсөн нүдээр харснаа чимээгүйхэн юм бувтналаа.

- Амбриж уу? гэж Харри асуухад дотор нь хүйт даав.

Добби толгой дохиод Харрийн өвдөгийг мөргөхийг оролдов. Тэгэхэд нь холдуулан барилаа.

- Тэр яасан гэж? Добби ... тэр үнэхээр энэ тухай ... бидний тухай ... ДА-гийн тухай мэдсэн хэрэг үү?

Тэгээд хариултаа үйлчлэгчийн цочирдсон царайнаас уншлаа. Харри түүний гараас барьсан учир өөрийгөө өшиглөх гээд шалан дээр унав.

- Тэр ийшээ ирж байгаа юу? гэж Харри аяархан асуув. Добби орь дуу тавин шал нүдэж гарав.

- Тиймээ, Харри Поттер! Тэр одоохон энд ирнэ!

Харри босоод хөдөлгөөнгүй айдаст автан зогсох хүүхдүүдийг олж харав.

- Та нар юу хүлээгээ вэ! Зугтацгаа! гэж орилов.

Бүгд үүд рүү ухасхийн хаалган дээр овооролдсоноо дараа нь хэн нэг нь түрүүлж

гарлаа. Харри тэдний гүүлдэх чимээ хонгил цуурайтахыг сонсоод унтлагын өрөө рүүгээ шууд гүйж очихгүй байх ухаан байгаа гэж найдав. Ердөө арван есөн хүн үлджээ. Хэрвээ тэд номын сан руу орж эсвэл уулийн байшингийн ойр хавьд ...

- Зугтъя, Харри! гэж Гермiona хаалган дээр овооролдсон хүмүүс дундаас хашгирлаа.

Тэр өөрийгөө шийтгэх гэж зүтгэх Доббиг бариад гүйж үүдний дарааллын төгсгөлд зогсов.

- Добби! Энэ бол тушаал шүү гал зуухандаа бусад үйлчлэгч рүүгээ буцаж оч, хэрвээ тэр асуувал намайг анхааруулаагүй гэж худал хэл! Бас чамайг өөрийгөө шийтгэхийг хориглож байна! гэж суллахдаа нэмж хэлээд эцэст нь босго даван гарлаа.

- Баярлалаа, Харри Поттер! гэж Добби часхийн дуугараад алга болов. Харри хоёр тийш харахад найзууд нь түргэн зугтсан болохоор хонгилын төгсгөлд зурсхийх дүрс л үзэгдэв. Тэр баруун тийш гүйлээ. Тэнд хөвгүүдийн жорлон байдаг. Хэрвээ тийш хүрч амжвал тэнд байнга байсан гэж ...

- А-аанаан!

Хэн нэгэн түүний хөлөөс барихад шалан дээр түсхийн унаад гэдсээрээ зургаан фут гулгалаа. Ард нь инээд сонсогдов. Тэр нуруугаараа эргээд лууны дүрстэй ваарны ард нуугдсан Малфойг харлаа.

- Бүдрүүлэх шившлэг, Поттер! Хөөе, профессор! Профессор! Бас нэг нь байна! Алсын булангаас Амбриж үсрэн гарч ирээд амьсгаадан нүүрэндээ инээмсэглэл тодруулав.

- Энэ тэр байна! гэж тэр шалан дээр хэвтэж байгаа Харриг хараад баяртайяа уулга алдав. Маш сайн байна, Драко гайхалтай! Зүгээр л гайхалтай. Слизеринд тавин оноо өглөө! Би өөрөө түүнийг аваачих болно ... Бос, Поттер!

Харри хөл дээрээ босоод тэр хоёр луу харлаа. Тэр хэзээ ч Амбрижыг ийм аз жаргалтай байхыг харж байсангүй. Тэр Харрийн тохойноос бахь шиг зуураад дэргэдээ зогсож байгаа Малфой руу нүүр дүүрэн инээмсэглэлээ.

- Цаашаа гүйгээд өөр хэн нэгнийг ол, Драко. Бусаддаа номын санг шалга гэж хэлээрэй ... амьсгаа нь дээрдсэн бүх хүмүүсийг бариарай ... жорлон руу шагайх

хэрэгтэй шүү, хатагтай Паркинсон охидын жорлонг аваарай ... за алив урагшаа ... гээд жигшүүртэй хоолойгоор, Харин Поттер та надтай цуг захирлын өрөө лүү яв гэлээ.

Малфой цааш явахад Харри, Амбриж хоёр хэдэн хормын дараа чулуун лууны дэргэд зогсож байлаа. Харри түүний нөхдөөс хэд нь баригдсан болохыг тааварлав. Тэр Роны тухай хатагтай Уизли түүнийг алах байхдаа гэж бодоод Гермiona хэрвээ түүнийг С.И.Ш-ийн өмнө хөөх юм бол яахыг төсөөлөв. Харин Симус тэдэн дээр анхны удаа ирлээ шүү дээ ... Невиллийн хувьд бүх зүйл сайн болж эхэлсэн болж байдаг ...

- Исгэрдэг зөгий гэж Амбриж хэлэхэд чулуун луу хажуу тийш үсрэн холдоод хана нээгдэж тэд хөдөлдөг эргүүлгэн шат руу гарлаа. Тэднийг грифоны дүрстэй цохиур бүхий хаалганд хүрэх үед Амбриж цохиж төвөг удалгүй шуудхан дотогш орлоо.

Өрөө дүүрэн хүнтэй байв. Дамблдор амирлангуй царайтай ширээндээ суугаад хурууны үзүүрээ имрэнэ. Проефссор МакГонагалл дэргэд нь унтууцсан байртай хөшин зогсчээ. Ид шидийн яамны сайд Корнелиус Фаж галын урд урагш хойш дайвалзан болж буй үйл явдалд сэтгэл хангалуун төрхтэй зогсч байв. Кингсли Бруствер Харрийн танихгүй богинохон ширүүн үстэй шидтэний хамтаар хаалганы хоёр талд зогсчээ. Харин хананы дэргэд үзэг хүнд хуйлаастай цаасаа бэлхэн барьсан сэвхтэй Перси Уизлийн дүрс байлаа.

Өнөөдөр өмнөх захирлуудын хөргүүд унтаж байсангүй. Бүгд болгоомжилж түгшсэн байртай цуглагсдыг анхааралтай ширтэнэ. Харриг орж ирэхэд зарим нь зэргэлдээх хөрш рүүгээ үсрэн орж чихэнд нь юм шивнэлээ.

Хаалга хаагдахад Харри Амбрижийн барилтаас чөлөөлөгдөв. Корнелиус Фаж түүн рүү хэрцгий харлаа.

- Тэгэхээр ... тийм байж ... гэж дуугарав.

Харри түүнд чадахаараа түрэмгий харцаар хариулав. Зүрх нь ухаангүй юм шиг цохилон дотор нь аймшигтай байсан хэдий ч тайван байлаа.

- Тэр Гриффиндорын цамхаг руу зугтахыг оролдсон юм. Бага Малфой түүнийг барьсан гэж Амбриж хөөрөн дуу алдахад Харри порфессор Трелониг үүдний танхимд зовоож байсан цэвдэг өнгийг олж сонслоо.

- Та юу хэлэв ээ? гэж Фаж урамшингүй хэлээд, Люциусыг заавал шагнах

хэрэгтэй. Ингээд, Поттер ... таньд яагаад энд байгаа чинь ойлгомжтой байгаа биз дээ? гэв.

Харри «тийм» гэж хэлэхээр ам нээсэн авч уруулыг нь давж гарахаас урьтаж Дамблдорын царай дээр харц туслаа. Захирал Харри руу харалгүй түүний баруун талын мөрөн дээрх нэг цэгт төвлөрсөн харагдана. Гэхдээ Харри түүний үл мэдэгхэн толгойгоо сэгсрэхийг олж харлаа.

Тэр даруйхан үгээ өөрчилж,

- Т ... үгүй гэв.
- Өршөөгөөрэй? хэмээн Фаж гайхлаа.
- Үгүй гэж Харри хатуу хэлэв.
- Тэгэхээр энэ таньд ойлгомжгүй байгаа юм биз дээ?
- Тиймээ ойлгомжгүй байна.

Фаж итгэлгүйхэн Харри болон профессор Амбриж руу ширтлээ. Харри энэ агшиныг ашиглан Дамблдорын зүг сэмхэн харахад толгой дохисноо ирмэлээ.

- Та профессор Амбриж юуны учир энэ өрөөнд авчирсан тухай ойлгохгүй байна гэнээ? Та сургуулийн дүрмийг зөрчсөнөө мэдэхгүй байна уу? гэх Фажын хоолойд даажигнал сонсогдов.

- Сургуулийн дүрэм гэнээ? Үгүй.
- Эсвэл яамны хуулийг зөрчөөгүй гэж үү? хэмээн Фаж ууртай залруулав.
- Ямар ч тохиолдолд би үүнийг ажиглаагүй гэж Харри эелдэгхэн хэлэв.

Түүний зүрх хүчтэй цохилсон хэвээр байлаа. Фажад худал хэлэхэд нүүрэнд нь цус хуралдахыг хараад таатай байсан хэдий ч үйл явдал хааш эргэхийг мэдсэнгүй. Хэрвээ хэн нэгэн Амбрижад ДА-гийн цугларалтын гол зохион байгуулагч нь гэдгийг хэлсэн бол явж чемоданаа цуглуулах хэрэгтэй болох нь.

- Таны хувьд сургуульд сурагчдын хууль бус цугларалт болж байгаа нь шинэ мэдээ хэрэг үү? гэж Фаж уурандаа сөөнгөтөн асуулаа.
- Тиймээ шинэ гэж Харри хэлээд гэмгүйхэн гайхсан төрх тодруулахыг хичээв.
- Би бодлоо л доо, сайдаа. Ажил хэргийг түргэн явуулахын тулд наашаа мэдээлэгчээ урьж болох юм гэж Амбриж торгомсог хоолойгоор хэлэв.

- Тиймээ, тэгэлгүй яахав хэмээн Фаж толгой дохилоод Амбрижийг гарч одоход Дамблдор руу заналхийлэн харж, Та гэрчийг энд авчирахаас дургүйцээгүй биз дээ, Дамблдор? гэв.

- Өчүүхэн ч үгүй, Корнелиус хэмээн хариу толгой дохилов.

Хэдэн хормын турш бүгд бие бие рүүгээ харалгүй хүлээв. Дараа нь Харрийн нурууны ард хаалга нээгдэв. Түүгээр Амбриж нүүрээ алгаараа дарсан Чжоугийн буржгар найз Мариэтаг дагуулан орж ирлээ.

- Айх хэрэггүй дээ, хонгор минь. Ямар ч айх зүйл байхгүй гээд профессор Амбриж нуруун дээр нь зөөлөн алгадангаа,

- Бүх зүйл сайхан болно. Чи зөв алхам хийсэн. Ямнаас чамд их сэтгэл хангалуун байгаа. Тэр чиний зоригтой охин гэдгийг ээжид чинь хэлэх болно. Мэдэж байна уу сайдаа, Мариэттагийн ээж болох хатагтай Эжком шидэт тээврийн хэлтсийн нисдэг даринь мэргэжилтэн юм. Тэр бидэнд Хогвартсын ханан зуухнуудыг хянахад тусалдаг гэв.

- Гайхалтай, маш гайхалтай! гэж Фаж бахдан хэлээд,

- Охин нь ээж шигээ гэнээ? Алив ороод ир хонгор минь. Над руу хар ичих хэрэггүй дээ, алив чиний юу хэлэхийг сонсоцгооё ... Аа намайг луу идээсэй! гэв.

Мариэтта толгойгоо өргөхөд цочирдсон Фаж хойш үсрэн холдохдоо золтой л зуух руу унасангүй. Түүний жанч уугиж эхлэхэд харааснаа яаран унтраалаа. Мариэтта чанга дуу алдан гонгиноод жанчныхаа захыг нүдээ хүртэл дээшлүүлсэн ч бүгд түүний царайд аймшигтай улаан өнгийн батга гарч хацар хамар дээгүүр нь «ХОВЧ» гэж бичсэнийг харжээ.

- Энэ толбонуудад анхаарал хандуулах хэрэггүй дээ, хонгор минь. Жанчаа доошлуулж сайдад хэл ... гэж Амбриж тэсвэр алдан дуугарав.

Гэвч Мариэтта ахин нэг удаа ёолсон дуу гаргаад цөхөрсөндөө толгой сэгсэрлээ.

- За яахав сайн байна, тэнэг охин минь би өөрөө ярья хэмээн Амбриж түүнийг ээлжит дотор муухайрам инээмсэглэлээр шагнаад яриагаа үргэлжлүүлэн,

- Ингээд сайдаа, хатагтай Эжком миний өрөөнд өнөө үдэш оройн хоолны дараа ирээд надад юм мэдэгдэхийг хүсч байна гэж хэлсэн юм. Тэр хэрвээ намайг долоон давхарт байдаг заримдаа Шаардлагатай өрөө гэж нэрлэгддэг нууц өрөө рүү

шагайх юм бол ихээхэн сонирхол татахаар зүйлийг олж харна гэсэн. Би түүнд хэдэн асуулт тавьсаны үндсэн дээр тэнд цугларалт болж байгааг мэдсэн. Золгүй нь гэвэл тэр агшинд энэ шившлэг үйлчилсэн гээд Амбриж нүүрээ нуусан Мариэтта руу тэвчээргүйхэн зангав.

- Үүний дараа охин тусгалаа толинд хараад сэтгэлээр унаж надад нэмэлт мэдээлэл өгөөгүй.

- Аан, тэгсэн юм бий гэж Фаж Мариэттаг ширтэн хэлээд бараг эцгийн төрхтэй дулаахан сургасан маягаар,

- Профессор Амбриж дээр ирсэн чинь чиний зүгээс маш зоригтой хэрэг байлаа, хонгор минь. Чи туйлын зүйтэй алхам хийж. Харин одоо эелдэг байж надад та нарын цугларалтанд юу болдог тухай хэлээч? Түүний зорилго юу байсан бэ? Хэн тэнд оролцсон бэ? гэв.

Гэвч Мариэтта хэлээ залгисан мэт болжээ. Тэр ердөө ахин толгой сэгсрээд айсан том нүдээр бүлтийн ширтлээ.

- Та үнэхээр үүний эсрэг шившлэг хэрэглэж болохгүй гэж үү? хэмээн сайд Амбрижаас тэвчээр алдан асуулаа.

- Би оролдсон ч болоогүй гэж Амбриж дурамжхан хэлэхэд Харри Гермионад тийм шившлэг илгээсний төлөө бахархах сэтэгдэл төржээ.

- Гэхдээ тэр ярьж чадахгүй гэдэг нь чухал хэрэг биш. Би түүний өмнөөс ярьж чадна. Та санаж байна уу, сайдаа би арван сард таньд Поттер Хогсмидэд «Гахайн толгой» бааранд бүлэг сурагчдыг цугуулсан гэж мэдэгдсэн байхаа?

- Та хаанаас энэ цугларалтын тухай мэдээ вэ? гэж профессор МакГонагалл яриаг нь таслав.

- Надад гэрч байгаа шүү, Минерва. Уилли Уиддеринс санамсаргүй энэ уушийн газар байж таарсан байна. Мэдээж тэр боолтоор ороолттой байсан ч яриаг сонсоход саад болоогүй. Тэр Поттерын хэлсэн үг бүрийг сонсоод шууд сургууль руу надад мэдэгдэхээр гүйж ...

- Тэгвэл, энэ чинь түүнийг яагаад бөөлждөг жорлонгийнх төлөө шүүгээгүйн гол учир байж! Манай шүүхийн систем ч их гярхай байна даа гээд профессор МакГонагалл хөмсгөө өргөв.

- Ичгүүртэй завхрал! Бидний үед яамнаас ийм жижиг сажиг хэрэгт оролцдоггүй байсан. Үгүй шүү, ноёнтоон тэгдэггүй байсан! гэж Дамблдорын ширээний ард байсан улаан хамартай шидтэний хөрөг дэлбэрлээ.

- Баярлалаа, Фортескью одоо хангалттай гэж Дамблдор аяархан хэлэв.

- Поттер сурагчдыг уулзалтанд цуглуулсаны зорилго нь хууль бус бус нийгэмлэгт элсэхийг ятган уриалж ид шидийн яамнаас сургуулийн насны хүүхдэд зохимжгүй гэж үзсэн шившлэгүүдийг суралцахад оршиж байсан байна ...

- Та эндүүрч байх шиг байна, Долорес гэж Дамблдор тайван хэлээд түүн рүү махигар хамартаа зүүсэн шилнийхээ дээгүүр харлаа.

Харри түүн рүү гайхан харлаа. Тэр Дамблдор ямар аргаар түүнийг гай зовлонгоос гаргана гэж найдсаныг ойлгоогүй ч хэрвээ Уилли Уиддершинс «Гахайн толгой» бааранд байгаад хэлсэн үг бүрийг нь сонссон бол мултрах боломжгүй юм.

- Аанхан! гэж Фаж дуу алдангаа, Алив Поттерыг ээлжит таагүй явдлаас аврах түүхийг чинь сонсоё! Дамблдор танаас үргэлжлүүлэхийг гуйж байна. Магадгүй Уилли Уиддершинс худал хэлсэн байх тийм үү? Эсвэл тэр өдөр

«Гахайн толгой»-д Поттер биш ихэр нь байсан гэх нь үү? Эсвэл Дементорууд үл үзэгдэх болж үхсэн хүн амь орсон гэх нь үү? гэв.

Перси Уизли баясан инээв.

- Их инээдтэй байна сайдаа! Маш их шүү!

Харри Персиг өшиглөхгүй байж арайхийн тэслээ. Гэхдээ тэр Дамблдорын уруулд инээмсэглэл тодорхыг хараад ихэд гайхжээ.

- Үгүй дээ, үгүй Корнелиус би Харри тэр өдөр «Гахайн толгой»-д сурагчдыг цуглуулан хар урлагаас хамгаалах дугуйлан байгуулах гэснийг эсэргүүцсэн юм биш. Харри өөрөө ч үүнийг эсэргүүцэж чадахгүй гэдэгт итгэлтэй байна. Би зөвхөн таны анхаарлыг Долоресын тэднийг хууль бус гэсэн буруу үгэнд хандуулахыг хүсч байна. Хэрвээ яамнаас сурагчдын цугларахыг хориглосон тухай хуулийг санах аваас Хогсмидэд зохион байгуулсан цугларалтаас хоёр өдрийн дараа гарсан учир Харри тэгэхэд ямар ч хууль зөрчөөгүй юм.

Перси зулай руугаа хүнд зүйлээр цохиулсан аятай болов. Фаж хөшиж амаа ангайлаа. Амбриж түрүүлж сэхээрэв.

- Энэ бүхэн чинь маш сайн байна, захирлаа гэхдээ одоо боловсролын тухай хуулийн хорин гуравдугаар зүйл гараад хэдийн хагас жил өнгөрсөн. Хэрвээ эхний цугларалт хууль бус биш байсан бол дараагийнх нь тийм байсан нь эргэлзээгүй.

- Тэгэхээр тэд хууль гарсан хойно үргэлжлүүлэн уулзсаар байх нь ээ. Та үүнийгээ баталж чадах юм уу? гэж Дамблдор эелдэгээр хэлээд сониучирхсан байдалтай хуруунуудаа харлаа.

Дамблдорыг ярьж эхлэх үед Харри ардаа Кингслигийн бололтой үл мэдэг шивнэлт сонслоо. Тэр хажуугаар нь далавчны дэвэлт аятай сулхан салхи сэвэлзсэн гэж тангарагласан ч болох байв. Гэхдээ доош харахад ч юу ч харагдсангүй.

- Баталгаа гэнээ? хэмээн Амбриж давтаж хэлэхэд бахын царайд нь жигшүүртэй инээмсэглэл тодров.

- Та сонсоогүй юм уу, Дамблдор? Таныхаар бол бид юуны учир ийшээ хатагтай Эжкомыг урьсан хэрэг болж байна?

- Өө, тэр магадгүй хагас жилийн өмнө болсон уулзалтын талаар хэлсэн байх л даа? Надад төрсөн сэтгэгдэлээр бол таньд өнөө орой л мэдэгдсэн юм шиг санагдаж байна гээд Дамблдор хөмсгөө өргөлөө.

- Хатагтай Эжком, хонгор минь бидэнд энэ уулзалт хэр удаан үргэлжилсэнийг хэлээч. Зөвхөн толгой дохих юмуу сэгсрэхэд болно. Би таны батга үүнд саад болохгүй гэдэгт итгэлтэй байна. Ингэхэд тэд сүүлчийн хагас жилийн турш уулзаж байсан уу?

Харрийн дотор палхийлээ. Эцэст нь тэд Дамблдор ч хүчрэхээргүй хатуу мухарт тулж ирлээ.

- Зөвхөн толгой дохих юмуу сэгсрээрэй. Айх хэрэггүй бүх муу зүйл ард хоцорсон гэж Амбриж Мариэттад аргадангуй хэлэв.

Өрөөнд байсан бүх хүний харц Мариэттагийн царай дээр тусав. Жанчин дээгүүр зөвхөн түүний нүд болон дух руугаа унжсан буржгар үс цухуйж харагдана. Магадгүй энэ тоглоом байж болох ч Харрид түүний нүд хоосорсон юм шиг санагдав. Тэгтэл гайхшийг нь төрүүлэн Мариэтта толгой сэгсэрлээ.

Амбриж Фаж руу түргэхэн харснаа ахин Мариэттад хандав.

- Магадгүй чи асуулт ойлгоогүй байх, тийм үү? Би чамаас үүнтэй төстэй

цугларалт сүүлчийн зургаан сард болсон уу гэж асууж байна. Чи түүнд оролцсон биз дээ?

Мариэтта ахин толгой сэгсэрлээ.

- Толгойгоо сэгсэрдэг чинь юу гэж байгаа юм, хонгор минь? гэж Амбриж гашуунаар асуув.

- Надад бол эргэлзээгүй тодхон байна гэж профессор МакГонагалл огцом хэлээд,

- Охин сүүлчийн хагас жилийн турш ямар ч нууц уулзалт байгаагүй гэж хэлэхийг хүссэн байх. Миний зөв үү, хатагтай Эжком? гэв.

Мариэтта толгой дохилоо.

- Гэхдээ өнөөдөр байсан шүү дээ! Тэд Шаардлагатай өрөөнд байсан бөгөөд хатагтай Эжком та энэ тухай надад өөрийн биеэр мэдэгдсэн биз дээ! Түүнийг Поттер зохион байгуулсан ... Та юуны учир ахиад толгой сэгсрээд байгаа юм бэ, тэнэг охин минь? гэж Амбриж уурсан дуу алдав.

- Хүмүүс ердийнхөөр бол үгүй гэж хэлэхийг хүссэн үедээ толгой сэгсэрдэг юм.

Тийм учраас хатагтай Эжком хүний бус дохио зангаа ашиглаагүй л бол ... гэж

МакГонагалл хүйтнээр хэлэв.

Сэтгэлээр унасан Амбриж Мариэттаг барьж аваад өөр лүүгээ эргүүлж бүх хүчээрээ сэгсэрлээ. Агшин ч өнгөрөөгүй байхад Дамблдор үсрэн босоод саваагаа өргөлөө. Кингли урагш ухасхийсэн ч, Амбриж Мариэттагаас давхийн холдоод түлэгдсэн мэт гараа сэгсэрлээ.

- Би таныг миний сурагчид хүч хэрэглэхийг чинь зөвшөөрч чадахгүй, Долорес гэж Дамблдор хэлэхэд энэ бүх үдшийн турш анх удаа уурссан харагдав.

- Та тайвширах хэрэгтэй, хатагтай Амбриж. Ямар нэг таагүй явдал хэрэгтэй гэж үү? хэмээн Кингли тайван хоолойгоор хэлэв.

- Үгүй л дээ ... таны зөв, Бруствер ... би ... би мартчихаж гэж Амбриж сонсогдох төдий шивнээд Кинглигийн хүчирхэг дүрс рүү өнгийн харлаа.

Мариэтта байрандаа хөшсөн юм шиг зогсчээ. Тэр профессорын гэнэтийн дайралтнаас чөлөөлөгдсөнөө мэдрээгүй юм шиг өмнөхийн адил жанчаараа нүүрээ хаагаад хоосон газар ширтэнэ.

Харрийн тархинд гэнэтхэн энэ нь Кингслигийн сулхан шивнэлттэй холбоотой байх гэсэн таавар төрлөө.

- Долорес өнөөдөр цугларсны учир нь бид болсон явдлын тухай тодорхой тайлбар хүсч байна гэж Фаж бүхнийг шийдэмгий дуусгахыг хүссэн хүний ёсоор хэллээ.

- Тиймээ гэж Амбриж биеэ барин хэлээд,

- Тиймээ ... ингээд хатагтай Эжком намайг мэдээ дуулгасны дагуу би буруутнуудыг газар дээр нь барихаар долоон давхар луу итгэл хүлээлгэсэн хэдэн сурагчдын хамт очсон. Тэдний нэг нь энэ тухай анхааруулсан бололтой биднийг долоон давхар луу очих үед тал бүр тийшээ зугтсан байсан. Ер нь бол энэ чухал биш л дээ. Надад тэдний бүгдийн нэр байгаа. Хатагтай Паркинсон Шаардлагатай өрөөнд орж мөр хайгаад тэндээс үүнийг олсон юм гэв.

Тэрбээр Харрийн айдсыг хүргэн халааснаасаа Шаардлагатай өрөөний хананд өлгөөстэй байсан нэрсийн жагсаалтыг гарган ирж Фажад гардуулав.

- Би энэ жагсаалтанд байгаа Поттерын нэрийг хараад бүх зүйлийг ойлгосон.

- Сайн байна. Маш сайн байна, Долорес хэмээн Фаж мишилзэн хэлэв.

Тэр Мариэттагийн хажууд гартаа саваагаа барин зогссон Дамблдор руу харлаа.

- Та тэдний өөрсдийгөө юу гэж нэрлэснийг харав уу? Дамблдорын арми! гэж Фаж алгуурхан хэлэв.

Дамблдор урагш алхан Фажгаас цаасыг авлаа. Тэр Гермionaгийн хагас жилийн өмнө хийсэн жагсаалтыг хормын зуур гүйлгэн харснаа барьц алдах шиг болов. Дараа нь харцаа өргөн инээмсэглэлээ.

- Юу гэвэл тоглоом дууслаа. Та намайг хэргээ хүлээсэн тухай мэдэгдэлийг бичгээр авч болно, Корнелиус? Эсвэл гэрчүүдийн дэргэд амаар сонсохыг дээрд үзэж байна уу?

Харри МакГонагалл, Кингсли хоёр бие бие лүүгээ харахыг харлаа. Тэдний царайд айдас бичээтэй байв. Тэр юу болсныг ойлгосонгүй. Фаж ч мөн адил бололтой.

- Мэдэгдэл гэнээ? Юу гэнээ ... би ойл ...

- Дамблдорын арми, Корнелиус. Поттерынх биш Дамблдорын арми гэж

Дамблдор инээмсэглэн хэлээд жагсаалтыг Фажын өмнүүр даллав.

- Гэхдээ ...

Гэнэтхэн сайдын царай ойлгосны тэмдэг болон өөрчлөгдөв. Тэр айдаст автан ухарснаа дуу алдан галаас үсрэн холдлоо.

- Та гэнээ? хэмээн ахин уугьж буй жанчаа унтраан шивнэлээ.

- Гарцаагүй гэж Дамблдор эелдэгээр батлав.

- Тэгэхээр та энэ бүхнийг зохион байгуулсан байх нь ээ?

- Би гэж Дамблдор хэлэв.

- Та сурагчдыг хувийн ... армидаа цуглуулсан байх нь ээ?

- Өнөөдөр анхны уулзалт байсан юм. Зөвхөн хэн надтай нэгдэх эсэхийг шалгахыг хүссэн юм. Ингээд би хатагтай Эжкомыг урьсанаараа алдаа гаргаснаа харж байна.

Мариэтта толгой дохив. Фаж тэр хоёр луу харснаа цээжээ түхийлгэв.

- Тэгэхээр та миний эсрэг хуйвалдсан байх нь ээ! гэж ориллоо.

- Яг тийм гэж Дамблдор хөгжилтэйгээр хэлэв.

- Үгүй! гэж Харри хашгирлаа.

Кингсли түүн рүү сэрэмжлүүлэн харж, МакГонагалл сүрдүүлсэн шинжтэй нүдээ томруулахад, Харри гэнэтхэн Дамблдорд юу хийснийг ойлголоо.

- Үгүй ... Профессор Дамблдор!

- Битгий хашгир, Харри. Тэгэхгүй бол өрөөг орхиход хүрэх нь байна шүү гэж Дамблдор тайван хэлэв.

- Тиймээ дуугаа тат, Поттер! гэж Фаж дуу алдаад Дамблдорыг ширтсэн хэвээр ялгуусан баяр хөөртэйгээр инээмсэглэв.

- Тийм байж ... би ийшээ Поттерыг хөөхөөр ирсэн байтал үүний оронд ...

- Үүний оронд намайг баривчлах шалтаг оллоо. Энэ бүхэн кнат хаяад галлеон олохтой адил биш гэж үү? хэмээн Дамблдор инээвхийлэв.

- Уизли! Уизли түүний хэлсэн үг бүрийг бичиж авсан уу? Таньд түүний хэргээ хүлээсэн баримт байгаа биз дээ? гэж Фаж орилов. Тэр хөөрсөндөө чичирч байлаа.

- Тиймээ, ноёнтоон бичсэн! гэж Перси тэсч ядсан байртай дуугарахад хэтэрхий түргэн үсэргэн бичсэнээс болж хамар нь бэх болжээ.

- Тэр яамны эсрэг тэмцэл зохион байгуулахын тулд арми байгуулахыг оролдож байсан болон миний эсрэг боссон тухай?

- Тиймээ, ноёнтоон бүгд байгаа! гэж Перси тэмдэглэлээ харангаа баяртайгаар уулга алдав.

- Гайхамшигтай. Даруйхан бичгийнхээ нэг хувийг «Өдөр тутмын зөнч» сонинд илгээ, Уизли. Хэрвээ ууль түргэн илгээвэл бид өглөөний дугаарт амжина байх! гэхэд Перси өрөөнөөс сум шиг үсрэн гарч хаалга хаагдан Фаж ахин Дамблдор руу эргэлээ.

- Харин одоо таныг хяналтан дор яам руу хүргэж албан ёсоор ял тулгах шүүх хурал хүртэл Азкабан руу илгээх болно!

- Ай даа, тийм байж хэмээн Дамблдор санаа алдаад, Гэвч бидэнд жижигхэн саад тулгарах байх гэж бодож байна гэв.

- Саад гэнээ? Би ямар ч саад харахгүй байна, Дамблдор! гээд Фажын хоолой хөөрсөндөө чичирлээ.

- Харамсалтай нь би түүнийг харж байна гэж айж байна хэмээн Дамблдор гэмшингүй дуугарав.

- Үнэхээр гэж үү?

- Тиймээ. Учир нь та намайг явна гэж гүнзгий төөрөлдөж байна. Би явахгүй, Корнелиус. Надад Азкабанд суух ямар ч хүсэл алга. Мэдээж би тэндээс зугтаж чадах ч цагаа үрэх ямар хэрэг байна? Таньд үнэнийг хэлэхэд түүнийг ашигтайгаар ашиглах сая сая арга байна.

Амбрижийн нүүр халуун усанд булхсан мэт улайлаа. Фаж Дамблдор луу дүйнгэтэн харахад болсон үйл явдалд мэгдсэн шинж илэрхий байв. Дараа нь түүний хоолойд аяархан дуу алдалт сонсогдож Кингсли болон богинохон буурал үстэй энэ үйл явдалд цор ганцаар чимээгүй байсан хүн рүү харлаа. Жижигхэн хүн Фаж руу толгой дохиод урагш алхлаа. Харри түүний гар санамсаргүй мэт халаас руугаа гулгахыг харав.

- Тэнэг юм хийх хэрэггүй Долиш. Би таныг сайн мракоборец гэж мэдэх ч бүх

шалгалтандаа онц үнэлгээ авахаар авъяастай биш гэдгийг мэднэ. Гэхдээ та оролдох л юм бол ... би танд хор учруулах болох нь гэж Дамблдор эелдэгхэн хэлэв.

Долиш нэртэй хүн нүдээ анивчлаа. Тэр ихээхэн тэнэг төрхтэй харагдав. Тэр Фаж рүү юу хийхээ мэдэлгүй заавар өгөхийг найдсан мэт харав.

- Тэгэхээр та Долиш, Бруствер, Долорес болон миний эсрэг ганцаараа тэмцэнэ гэж найдсан хэрэг үү, Дамблдор? хэмээн Фаж инээмсэглэв.

- Үгүй, Мерлиний сахлаар андгайлъя. Зөвхөн та намайг тэгэхэд хүргэвэл гэж Дамблдор хариу инээмсэглэв.

- Түүнд ганцаараа тэмцэх хэрэг гарахгүй! гэж МакГонагалл чанга мэдэгдээд ханцуйгаа шамлав.

- Үгүй үгүй, Минерва! Бүү оролц. Та Хогвартсад хэрэгтэй! гэж Дамблдор огцом эсэргүүцлээ.

- Энэ бүх дэмий явдал чинь хангалттай! гэж Фаж дэлбэрээд саваагаа өргөж, Долиш! Бруствер! Түүнийг барь! гэлээ.

Өрөөнд мөнгөлөг аянга гялсхийхэд их буу буудсан мэт чанга чимээ нүргэлэн шал чичирлээ. Тэгтэл хэн нэгний гар Харрийн шилэн хүзүүнээс барин шалан дээр дарах агшинд дараагийн оч гялсхийж хэд хэдэн хөрөг орилон, Фоукс хашгиран агаарт тоосон үүл босгов. Харри тоосон дунд ханиалгасаар урдаа хар дүрс чимээтэй унаж, түсхийх чимээ гараад, цохилтын чимээ сонсогдож хэн нэгний «Ёо!» гэж хашгирах, шил хагарах чимээг сонсоод, хэн нэгний яарсан алхаа, ёолох дуу ... нам гүм боллоо.

Харри толгойгоо хүчлэн эргүүлээд профессор МакГонагалл ард нь нэг гартаа түүнийг, нөгөө гартаа Мариэттаг дарж байхыг харлаа. Агаарт тоос бужигнана. Харри амьсгаадсаар урдаа өндөр дүрс тодрохыг харав.

- Та нар зүгээр үү? гэж Дамблдор асуув.

- Тиймээ! гэж МакГонагалл хариулаад шалан дээрээс Харри, Мариэтта хоёрыг босголоо.

Тоос шороо намдах үед тэдний өмнө сүйрэл болсон өрөөний дүр зураг үзэгдэв. Дамблдорын ширээ хөмөрч, нарийхан хөлтэй жижиг ширээ хажуугаараа унан мөнгөлөг эдлэлүүд зүг бүр тийш нисчээ. Фаж, Амбриж, Кингсли, Долиш нар шалан дээр хөдөлгөөнгүй хэвтэнэ. Галт шувуу Фоукс тэдний дээгүүр эргэлдэнэ. Харри

түүний аяархан дууг сонслоо.

- Харамсалтай нь Кингслид ч бас шившлэг илгээх шаардлага гарлаа. Тэгэхгүй бол сэжиглэхэд хүрнэ гэж Дамблдор аяархан хэлээд,

- Тэр Мариэттагын ой ухааныг маш түргэн өөрчилж бүгдийг өөр зүг рүү эргүүллээ. Миний өмнөөс түүнд баярлалаа гэж хэлээрэй, Минерва. Үлдсэн хүмүүс нь удахгүй ухаан орно. Хэрвээ тэд биднийг үг сольсныг мэдэхгүй бол бүх зүйл агшин зуур болсон юм шиг дүр гаргаарай. Тэд хөл дээрээ босохоороо юу ч санахгүй гэв.

- Та одоо хаачих вэ, Дамблдор? Гриммогийн байшин руу юу? гэж МакГонагалл шивнэлээ.

- Үгүй дээ. Би нуугдахгүй. Удахгүй Фаж намайг Хогвартсаас хөөсөндөө харамсах болно гэдгийг таньд амлаж байна гэж Дамблдор баргар инээмсэглэн хэлэв.

- Профессор Дамблдор ... гэж Харри эхлэв.

Тэр юу хэлэхээ мэдээхгүй ч ДА-г цуглуулж энэ бүх гай зовлонгийн шалтгаан болсондоо ичгүүртэй байгаа болон эсвэл Дамблдор өөрийнх нь өмнөөс хохирогч болж хөөгдөхөөс аварсанд хичнээн хэцүү байгааг тайлбарлахыг оролдсон ч байж мэднэ. Гэвч Дамблдор түүний яриаг таслан зогсоолоо.

- Намайг сонс, Харри. Чи окклюменцийд суралцах ёстой, намайг ойлгов уу?

Профессор Снеггийн хэлсэн бүх зүйлийг хийгээрэй. Орой болгон унтахын өмнө хар дарсан зүүд зүүдлэхгүйн тулд сургуулилж байгаарай ... чи удахгүй яагаад энэ бүхэн хэрэгтэй байсныг мэдэх болно, надад амла ...

Долиш нэртэй хүн хөдөллөө. Дамблдор Харрийн гарыг атгаж,

- Оюун ухаанаа хаа гэснийг минь санаарай гэлээ.

Дамблдорын хуруу Харрийн бугуйнд дөнгөж хүрэх агшинд духан дээрх сорви нь халуу шатан өвдөж ахин могой адил Дамблдор руу дайран хазаж хэдэн хэсэг болгон хаяхыг хүссэн аймшигтай мэдрэмж төрөв ...

- ... чи ойлгох болно гэж Дамблдор шивнэв.

Фоукс Дамблдорын дээгүүр эргэлдэн нисэв. Тэгэхэд Харриг тавиад гараараа галт шувууны алтлаг урт сүүлээс зуурлаа. Гал дөл гялехийж тэд хоёул алга болов.

- Тэр хаа байна? Хаана? гэж Фаж шалан дээрээс өндийгөөд орилов.

- Мэдэхгүй! гээд Кингсли босож ирлээ.
- Тэр шилжиж чадахгүй! Хогвартсын дотор үйлчлэхгүй гэж Амбриж хашгирав.
- Шат! гэж Долиш хашгираад хаалга руу ухасхийн босгоор алга болов.

Кингсли, Амбриж хоёр араас нь гүйлээ. Фаж тээнэгэлзсэнээ яаралгүйхэн гутлынхаа шороог сойздов. Нам гүм боллоо.

- Тэгэхээр Минерва минь, энэ таны найз Дамблдорын төгсгөл болсон гэж айж байна хэмээн Фаж урагдсан ханцуйгаа засаад ёжтойгоор хэлэв.

- Та тэгж бодож байна уу? хэмээн МакГонагалл зэвүүцэнгүй дуугарлаа.

Фаж түүнийг сонссонгүй. Тэр өрөөг дагуулан ажиглав. Хэд хэдэн хөргүүд түүн рүү уурсан харж, зарим нь нударга зангидаж байлаа.

- Эднийг оронд нь оруулсан нь дээр байх гэж Фаж ахин профессор

МакГонагалл руу харж хэлээд Харри, Мариэтта хоёрын зүг дохив.

МакГонагалл сурагчдыг сурагчдыг чимээгүйхэн хаалганы зүг аваачив. Тэдний ард хаалга хаагдахад Харри Финеас Найжелусын хоолойг сонсов.

- Сайдаа таны Дамблдорын буруутгаж байгааг чинь зөвшөөрч чадахгүй нь ...

БҮЛЭГ 28: СНЕГГИЙН ХАМГИЙН МУУ ДУРСАМЖ

ИД ШИДИЙН ЯАМНЫ ТУШААЛ

Долорес Жейн Амбриж (ерөнхий байцаагч) ид шидтэн илбэчний Хогвартс сургуулийн захирал Альбус Дамблдорын оронд томилогдохоор боллоо.

Боловсролын тухай хуулийн хорин наймдугаар хуулийн дагуу тушаал гаргав.

Гарын үсэг зурсан: Корнелиус Освальд Фаж, Ид шидийн яамны сайд

Өглөө энэ зарлал сургууль дээр гарсны дараа Дамблдор хоёр мракоборец, ерөнхий байцаагч, яамны сайд болон жижигхэн туслагчаас нь хэрхэн зугтаж чадсан тухай хэн ч тайлбарласангүй. Харри энэ зугталтын тухай ярьсан хэдий ч үйл явдлын зарим дүр зураг хэрхэн өөрчлөгдсөнийг сонсчээ (Нэг хоёрдугаар дамжааныхан бие биендээ Фаж одоо гэгээн Мунгогийн эмнэлэгт хулуун толгойтой хэвтэж байгаа гэж итгүүлж байлаа). Бүгд Харри, Мариэтта хоёрыг Дамблдорын өрөөнд тэр үдэш болсон үйл явдалын гэрч гэдгийг мэдэх ч үүний дараа Мариэтта эмнэлэгт хэвтсэн учир, Харри ганцаараа эцэс төгсгөлгүй астуултанд хариулах хэрэг гарчээ.

- Дамблдор удахгүй ирнэ хэмээн Эрни Макмиллан ургамал судлал хүрэх замд Харрийн яриаг сонсоод итгэлтэй мэдэгдэв.

- Тэд түүнийг хоёрдугаар дамжаанд байсан үеийнх шиг удаан хөөж чадахгүй.

Бүдүүн номлогч надад хэлэхдээ гээд хуйвалдсан байртай дуугаа намсгахад

Харри, Рон, Гермiona нар чихээ ойртуулан сонслоо.

- Өчигдөр орой тэд шилтгээний бүс нутгийг нэгжсэн ч Дамблдорыг олоогүй гэсэн. Амбриж түүний өрөөнд ахин орох гэсэн ч луу холдоогүй юм байх. Тэгэхээр захирлын өрөө биш. Тэр уурласандаа арай дэлбэрээгүй! гээд Эрни инээмсэглэв.

- Тиймээ магадгүй тэр зүүдэндээ л захирлын өрөөнд сууж байгаагаа харах байх.

Бусад багш нарыг хэрхэн захирч байгаа тухайгаа мөрөөдөөд л тэнэг додигор атаач авгай ... гэж Гермiona чулуун шатаар шилтгээний хаалга руу өгсөхөд заналтай хэлэв.

- Чи үнэхээр энэ өгүүлбэрийг дуусгахыг хүсч байгаа гэдэгтээ итгэлтэй байна уу, Грэйнджер?

Хаалганы цаанаас Драко Малфой үсрэн гарч ирэхэд Крэбб, Гойл хоёр дагалджээ.

Малфойн цонхигор царайд хорон баясгалантай өнгө тодорно.

- Гриффиндор, Пуффендуй хоёроос хэдэн оноо хасах хэрэгтэй болох нь гэж айж байна хэмээн тэр үгээ зөөн хэлэв.

- Чи ахлагч нараас оноо хасаж чадахгүй, Малфой гэж Эрни эсэргүүцэв.

- Би ахлагч нар бие биенээсээ оноо хасаж чадахгүйг мэднэ. Гэхдээ Шалгалтын бүлгэмийн гишүүдийн хувьд бол ч ...

- Юу? гэж Гермiona огцом асуулаа.

- Шалгалтын бүлгэм, Грэйнджер гээд Малфой жанчин дээрх ахлагчын тэмдгэн дороо зүүсэн жижигхэн мөнгөн «Ш» үсэг бүхий тэмдэг рүү заалаа.

- Ид шидийн яамыг дэмжих сурагчдын тусгай бүлэг бөгөөд профессор Амбрижтэй хамтран ажиллах юм. Ингэхээр Шалгалтын бүлгэмийн гишүүд оноо хасах эрхтэй. Грэйнджер чамайг шинэ захирлын тухай бүдүүлэг зүйл ярьсаны төлөө таван оноо хаслаа. Макмилланыг намайг эсэргүүцсэний төлөө тавыг хаслаа. Поттер чи надад таалагддаггүй учир таван оноо хаслаа. Харин Уизли чиний хувьд цамцаа товчлоогүй учир бас таван оноо хаслаа. Өө, би арай л мартсангүй чи чинь бохир цустан шүү дээ Грэйнджер. Үүний чинь төлөө ахин арван оноо хаслаа.

Рон саваагаа гаргасан ч Гермiona түүнийг хориглон «Хэрэггүй!» гэж шивнэлээ.

- Чиний зүгээс их ухаалаг хэрэг байлаа, Грэйнджер. Шинэ захирал, шинэ цаг үе ... биеэ сайн авч яваарай, Потти ... Уизли хаан хоёр минь ... гээд Малфой инээмсэглэв.

Ингэж хэлээд тэрбээр сэтгэл хангалуун Крэбб, Гойл хоёрын хамт цааш одов.

- Тэр мэхэлж байгаа юм. Тэдэнд оноо хасахыг зөвшөөрсөн байж болохгүй шүү дээ ... энэ чинь инээдтэй хэрэг ... ахлагчын системийг доройтуулж байна гэж Эрни айсан хоолойгоор хэлэв.

Гэвч Харри, Рон, Гермiona нар өөрийн мэдэлгүй ардаа байсан тэнхимийн оноог заадаг том элсэн цаг руу харлаа. Өглөө тэргүүн байр Гриффиндор Когтевран хоёрын дунд байсан юм. Одоо тэдний нүдэн дээр ханан дээрх хэмжээсийн чулуу өөрчлөгдөв. Зөвхөн Слизериний цаг өөрчлөгдсөнгүй.

- Та нар ажигласан уу? гэх Фредийн хоолой сонсогдов.

Тэр Жоржын хамт гантиг шатаар бууж ирээд элсэн цагны өмнө зогсов.

- Малфой биднийг сая тавин оноогоор торгочихлоо гэж Харри хэлээд Гриффиндорын цагны хэдэн чулуу доошилохыг ууртайгаар харлаа.

- Тиймээ Монтегю ч гэсэн бидэнд тийм зүйл хийхийг оролдсон гэж Жорж хэлэв.

- Оролдсон гэдэг чинь юу гэж байгаа юм? хэмээн Рон даруй асуув.

- Тэр хэлж амжаагүй л дээ. Учир нь бид түүний толгойг нэг давхарт байдаг алга болдог шүүгээ рүү шургуулчихсан гэж Фред хэлэв.

Гермиона гайхан мэгдэв.

- Гэхдээ та нарт асуудал үүснэ шүү дээ!

- Монтегю эргэж ирэхээс наашгүй. Энэ ч ойрын долоо хоногт болохгүй байх.

Бид түүнийг хааш нь илгээснээ ч мэдэхгүй байна. Ямар ч гэсэн ... бид асуудалд санаа зовох хэрэггүй гэж шийдсэн.

- Та нарт зовсон удаа байгаа юм уу? гэж Гермиона хэлэв.

- Мэдээж байлгүй яахав. Биднийг одоо хүртэл хөөгөөгүй л биз дээ? гэж Жорж хэлэв.

- Бид үргэлж хаана зогсохоо мэддэг юм гэж Фред хэлэв.

- Заримдаа жаахан хэтрүүлдэг.

- Гэхдээ хэзээ ч жинхэнэ үймээн дэгдээж байгаагүй.

- Харин одоо? гэж Рон болгоомжтой асуулаа.

- Одоо ... гэж Жорж хэлэв.

- Дамблдор байхгүй болсон гэж Фред хэллээ.

- Бид жаахан үймээн дэгдээж болно гэж бодож байна.

- Үүнийг манай хүндэт шинэ захирал хүртэх гавъяатай.

- Хэрэггүй! Гуйя биеэ бариач! Тэр та нарыг хөөх боломж олдвол баяртай байх болно! гэж Гермиона шивнэлээ.

- Чи үнэхээр ойлгохгүй байна гэж үү, Гермиона? Бид энд үлдэхийг хүсэхгүй байна. Бид одоо явсан ч болох ч эхлээд Дамблдорын өшөөг авсан нь дээр гэж бодож байна. Ер нь бол эхний шат нь удахгүй эхэлнэ гээд Фред цагаа харснаа, Би та нарын

оронд байсан бол одоохон Их танхим руу хооллохоор явах байсан даа. Тэгвэл бусад багш нарт та нар үүнд оролцоогүй гэдэг нь тодорхой болно гэв.

- Юу хийх гэж байгаа юм? гэж Гермiona түгшин асуулаа.

- Хараарай. Явцгаа орооцолдох хэрэггүй гэж Жорж дуугарлаа.

Фред, Жорж хоёр гантиг шатаар үдийн хоолондоо яаран явж байгаа сурагчдын дунд уусан алга боллоо. Эрнигийн байдал түгшсэн төрхтэй харагдсан бөгөөд хувиргалын хичээлийн даалгавараа хийх хэрэгтэй гэж бувтнаад яаран одлоо.

- Бид ч гэсэн яарах хэрэгтэй. Ямар ч гэсэн хэмээн Гермiona санаа зовон хэлэв.

- Явцгаая гэж Рон хэлэхэд тэд хамтдаа Их танхим руу явж Харриг дөнгөж босго даван адрын цагаан үүлийг зэрвэс хартал хэн нэгэн мөрөн дээр нь алгадахад эргэж харахдаа Филчтэй золтой мөргөлдсөнгүй хэдэн алхам ухарлаа.

- Захирал чамтай уулзахыг хүсч байна, Поттер гэж тэр жигшүүртэй инээмсэглэн хэллээ.

- Энэ би биш гэж Харри ихрүүдийн төлөвлөгөөг санаад дуугарлаа. Филч эрүүгээ чичигнүүлэн чимээгүйхэн инээд алдав.

- Буруугаа ухамсарлаж байна уу? Миний араас.

Харри Рон, Гермiona хоёр луу харахад түгшсэн байртай үзэгдэв. Тэр мөрөө хавчаад Филчийн араас өлсгөлөн сурагчдын урсгал дундуур үүдний танхим руу гарлаа.

Филч туйлаас баяр хөөртэй байсан бөгөөд гантиг шатаар өгсөхдөө хамар дороо юм гүнгэнэнэ. Тэднийг хоёр давхарт гарах үед,

- Шилтгээнд томоохон өөрчлөлт болсон, Поттер гэв.

- Би ажигласан гэж Харри хүйтнээр хэлэв.

- Тиймээ ... Би хичнээн жилийн турш Дамблдорыг та нарт хэтэрхий зөөлөн хандаж байна гэж баталж байлаа даа. Та нар өөдгүй амьтад эргэн тойрон гүйлдэж өмхий үрэл унагахад чинь миний мэдэл хүрдэгсэн бол ташуурдах байсан. Хэрвээ би өрөөндөө шагайнаас чинь дүүжилсэн бол хонгилд хаздаг нисдэг таваг нисэхгүй байх байсан талаар хэн ч бодож үзээгүй. Гэхдээ боловсролын тухай хуулийн хорин есдүгээр зүйл гарвал тэгэхэд Поттер надад энэ бүхнийг хийх эрх олдох юм ... Бас тэр сайдаас Пивзийг хөөх зөвшөөрөл гуйна ... тэгэхээр одоо шинэ үе эхэлж олон зүйл өөрчлөгдсөн.

Амбриж Филчийг өөрийн талдаа оруулсан нь эргэлзээгүй гэж Харри бодсон хэдий ч хамгийн муу нь гэвэл тэр Хогвартсын нууц хонгил гарцуудыг Уизлийн ихрүүдээс дутуугүй мэддэг болохоор үнэт туслах болох байлаа.

- Бид ирлээ гэж тэр инээвхийлээд гурван удаа Амбрижийн өрөөний хаалгыг цохиж нээгээд,

- Поттерыг авчирлаа, хатагтай гэлээ.

Амбрижийн өрөөнд Харри олон удаа шийтгэгдэж байсан болохоор сайн мэдэх хэдий ч бараг өөрчлөгдсөнгүй. Зөвхөн түүний ширээн дээр том модон хаалтан дээр алтан үсгээр «ЗАХИРАЛ» гэж бичжээ. Харри түүний ширээний ард өөрийнхөө «Аянга» болон, Фред, Жорж хоёрын «Зүлгэгч» шүүр төмөр гадаснаас гинжлэгдэн цоожтой байхыг хараад дотор нь хөрвөх шиг болов.

Амбриж ширээний ард ягаан цаасан дээр бичиж суугаад орж ирэгсдэд нүүр дүүрэн инээмсэглэв.

- Баярлалаа таньд, Аргус.

- Юу гэж дээ, хатагтай хэмээн Филч бөхийн ёслоод босго руу буцав.

- Суу гээд Амбриж сандал руу дохив. Харри суулаа. Хэсэг хугацааны турш тэр бичихээ үргэлжлүүлэв. Харри зэвүүн муухай муурнууд тавган дотроо цовхчин толгойгоо өргөхийг хараад энэ удаад ямар аймшигтай гэнэтийн бэлэг бэлтгэснийг тааж суулаа.

- Тэгэхээр юм уух уу? гэж Амбриж эцэст нь үзгээ тавиад хэлэв. Тэр амттайхан шүүслэг ялаа залгисан бах аятай сэтгэл хангалуун байлаа.

- Юу гэнээ? гэж Харри хэлэхдээ буруу сонслоо гэж боджээ.

- Уух юм, ноён Поттер. Цай? Кофе? Хулууны шүүс?

Тэрбээр уух юм дараалан нэрлэнгээ шидэт саваагаа дохиход ширээн дээр дүүрэн шингэнтэй аяга ээлжлэн бий болж байлаа.

- Баярлалаа, хэрэггүй.

- Харин би таныг надтай хамт уугаасай гэж хүсч байна. Нэгийг нь сонго гэж сүрдүүлсэн өнгөөр хэлэв.

- За яахав ... тэгвэл цай гэж Харри мөрөө хавчлаа.

Тэр босож нуруугаа харуулан эргээд аяганд сүү хийв. Дараа нь түүнийгээ ширээн дээр авчирч тавихдаа хорлонтой инээмсэглэж байв.

- Авна уу гээд аятгатай цай сунгангаа,

- Хөрөхөөс нь өмнө уугаарай. Ингээд ноён Поттер ... би өчигдөр үдшийн гунигтай цугларалтын дараа таньтай бага зэрэг ярилцах гэсэн юм гэв.

Харри юу ч хэлсэнгүй. Тэр суудалдаа буцаж суугаад тэвчээртэй хүлээв. Тэгснээ хэдэн хором өнгөрсний дараа,

- Та чинь юу вэ, уугаагүй юм уу? гэж дуу алдав.

Харри аягаа өргөн уруулдаа хүргэснээ гэнэтхэн буулгалаа. Амбрижын хажуугийн тавган дээр байсан нэг зэвүүн муур мракоборец Грюмын том цэнхэр нүд шиг санагдахад Харри гэнэтхэн Грюмын дайсныхаа аяганаас уудаггүй гэсэн үгийг сонссоноо саналаа.

- Юу болоо вэ? Чихэр нэмэх үү? гэж түүнээс нүд салгалгүй ширтэж байсан

Амбриж асуув.

- Хэрэггүй.

Тэр ахин аягаа өргөж амандаа ойртуулж ууж буй дүр үзүүлсэн ч үнэн хэрэгтээ уруулаа жимийлээ. Амбрижийн инээмсэглэл улам их болов.

- Сайн байна. Маш сайн байна. Харин одоо ... Альбус Дамблдор хаана байна?

гээд урагшаа бөхийлөө.

- Мэдэх юм алга гэж Харри түргэхэн хэлэв.

- Уу уу гэж тэр инээмсэглэсэн хэвээр хэлээд,

- Тэгэхээр ноён Поттер, одоо хүүхдийн тоглоомоо орхиё. Би таныг хаачсаныг нь мэднэ гэж бодож байна. Та Дамблдортой эхнээсээ л хамт байсан. Өөрийнхөө байдлын тухай бодоод үз дээ, ноён Поттер ... гэв.

- Би түүний хаа байгааг мэдэхгүй гэж Харри давтлаа. Тэр ахин ууж буй дүр үзүүлэв.

- Их сайн байна гэж тэр таагүйхэн хэлээд,

- Ингэхэд Сириус Блэкийн одоо хаана байгааг эелдэгээр хэлж өгнө үү гэв.

Харрийн дотор палхийж гар нь чичирэхэд дийз таржигналаа. Тэр аягаа хазайлгахын хамтаар амаа жимийхэд халуун шингэн жанч руу нь оров.

- Мэдэхгүй гэж тэр дэндүү түргэн хэлэв.

- Ноён Поттер таньд сануулахад би гэмт хэрэгтэн Блэкийг Гриффиндорын ханан зууханд арай л барьж аваагүй. Би арван сард тэр өөр хэнтэй ч биш таньтай уулзаж байсан гэдгийг сайн мэдэж байна. Надад үүний баримт нь байгаа шүү. Ингээд давтаж хэлье, ноён Поттер ... Сириус Блэк хаа байна?

- Мэдэхгүй. Өчүүхэн ч мэдэх юм алга гэж Харри чанга хэлэв.

Тэд бие биенээ удтал ширтэхэд Харрийн нүдэнд нулимс цийлэгнэв. Дараа нь Амбриж бослоо.

- За сайн байна, Поттер энэ удаад би таньд итгэлээ. Гэхдээ анхааруулахад миний талд хүчирхэг яам зогсож байгаа. Сургуулийн бүх холбооны сувгууд хараанд байгаа. Нисдэг дарины хяналтын мэргэжилтэн Хогвартсын бүх ханан зуухыг хянаж байгаа. Миний шалгалтын бүлэг уулийн орж гарсан бүх шууданг шалгаж байгаа. Харин ноён Филч шилтгээнээс орж гарах бүхий л нууц орц хонгилыг хянаж байгаа. Хэрвээ би ул мөр олох л юм бол ...

ТҮН!

Тэдний хөл дорхи шал чичирлээ. Амбрижийн сандлаасаа арай ойчсонгүйд ширээнээсээ зууран цочирдон харлаа.

- Юу болоод ...?

Тэр хаалга руу харав. Харри боломжыг ашиглан бараг дүүрэн цайгаа ойролцоох хатсан цэцэгтэй вааранд хийлээ. Гадаа гүйх болон хашгирах чимээ сонсогдоно.

- Хоолондоо, Поттер! гэж Амбриж зандраад саваагаа шүүрэн авч өрөөнөөс ухасхийн гарлаа. Харри агшин зуур хүлээснээ чимээ шуугиан хаанаас дэгдсэнийг харахын тулд бас гарав.

Бүгдийн учир даруй тайлагдав. Хоёр давхарт жинхэнэ үймээн самуун дэгджээ. Хэн нэгэн (Харри бараг л хэн гэдгийг нь таалаа) сургуульд аварга том галын наадам хийсэн бололтой.

Алтлаг ногоон оч бүхий луунууд адрын доогуур хөвөн нисэж гал дөлөөр тургихад, таван футын өндөртэй хурц ягаан өнгийн дугуй нисдэг таваг адил сүрдүүлэн

исгэрсээр өнгөрч, гялалзсан мөнгөн одод бүхий урт сүүлтэй пуужингууд хонгилоор сүнгэнэлдэн хана мөргөөд агаарт даруу бус үг болон бичигдэв. Эргэн тойронд хааяагүй цаасан буу бөмбөг адил тасхийн дэлбэрэх аж.

Шатны дунд Филч, Амбриж хоёр айдаст автан зогсчээ. Харрийн нүдэн дээр хамгийн том галт дугуй тэдний зүг исгэрэн ухасхийлээ. Тэд хоёул хашгиран суухад дугуй цонхоор нисэн гадагш гарлаа. Тэр үед хэд хэдэн луу болон том улаан сарьсан багваахай утаа манаруулан хонгилын нээлттэй хаалгаар гарч гурван давхарт гарлаа.

- Түргэлээрэй, Филч түргэлээрэй! Хэрвээ тэднийг үгүй хийхгүй бол сургуулаар нэг тарах нь байна ... Остолбеней! гэж Амбриж уулга алдав.

Түүний саваанаас гарсан улаан оч нэг пуужинг онолоо. Тэр агаарт хөшихын оронд хүчтэй дэлбэрч ногоон зүлгэн дээрх шулмын хөрөгт нүх гаргахад, тэр цааш харайгаад зэргэлдээх зурганд үсэрч ороход хөзөр тоглож байсан хэдэн шидтэн яаран холдож зай тавьж өглөө.

- Тэднийг бүү шившээрэй, Филч! гэж Амбриж ууртай хашгирав.

- Тэгэхгүй ээ хатагтай! гээд Филч сангасваа болохоор дуугүй боллоо. Тэр ойролцоох пин рүү гүйж очоод шүүр авч нисч байгаа зүйлүүдийг цохихыг оролдов. Хором ч өнгөрөөгүй байхад шүүрний сүрэл шатлаа.

Харри түүний хувьд хангалттай гэж бодоод инээн хонгилоор гүйж нууц хаалгаар ороход Фред, Жорж хоёр ард нь нуугдаад Амбриж, Филч хоёрын орь дуу тавихыг сонсон хөхрөлдөж байв.

- Сэтгэл хөдөлмөөр юм ... маш сэтгэл хөдөлмөөр юм ... Доктор Фейерверкус бизнесээ орхисон нь дээр бололтой гэж Харри чимээгүйхэн инээн хэлэв.

- Тиймээ, муугүй гээд Жорж инээсээр байгаад цийлэгнэсэн нулимсаа арчиж,

- Одоо түүнийг Алга болгох шид ашиглана гэж найдаж байна ... Энэ нь тэднийг арав дахин том болгох юм гэлээ.

Ихрүүдийн бүтээл гал хаялсаар сургууль дээгүүр орой хүртэл нислээ. Хэдийгээр тэд багагүй хохирол учруулсан ч гэлээ бусад багш нар үүнд гомдсонгүй.

- Ай-яа-яа гэж профессор МакГонагалл нэг луу дөл бадруулан ангид нисэн орж ирэхэд даажигнан шогшироод,

- Хатагтай Браун, захирал руу гүйн очиж манай ангид шидэт галын наадмаас

зугтсан биет байна гэж хэлэхгүй юу гэв.

Үр дүнд нь шинэ захирал өдрийн турш сургууль дундуур гүйж багш нарыг дуудсан ч хэн ч энэ галт наадмаас ангижирахад тусалсангүй. Сүүлчийн хонх дуугарах үед Гриффиндорынхон цүнхээ аваад цамхаг руугаа явлаа. Харри сэтгэл хангалуунаар хөлсөндөө норж, хөө тортог болон сэгсийсэн Амбриж профессор Флитвикийн хамт ангиас гарч байхыг харав.

- Баярлалаа таньд, профессор! Мэдээж би энэ пуужингуудаас ангижирч чадах ч зөв гэдэгт нь итгэлтэй биш байна л даа гэх Флитвикийн нарийхан часхийсэн хоолой гарав.

Ингэж хэлээд тэрбээр зальжин инээмсэглэн Амбрижийн ард хаалга хаалаа.

Фред, Жорж хоёр тэр үдэш Гриффиндорын амралтын өрөөнд баатар шиг хүндлэгдлээ. Гермiona хүртэл хөөрсөн олон дундуур тэдэнд баяр хүргэхээр очив.

- Маш гайхалтай галын наадам байлаа гэж тэр бахдан хэлэв.

- Баярлалаа гэж Жорж гайхширан хэлээд,

- Энэ гайхалтай галын наадмыг «Фокус-покус» гэдэг юм. Бидэнд нөөц үлдээгүй нь харамсалтай. Одоо бүхнийг эхнээс нь эхлэх хэрэгтэй боллоо гэв.

- Энэ ч багагүй өртөгтэй шүү гээд Фред Гриффиндорынхны хашгиралтан дунд захиалга авч,

- Хэрвээ чи хүсвэл нэрээ дараалалд оруулж болно, Гермiona. Таван галлеоноор үндсэн цуглуулга болох гайхалтай дэлбэрэгч бодис авч болно шүү ... гэв.

Гермiona ширээ рүүгээ явлаа. Харри, Рон хоёр тэнд суугаад цүнхнээсээ гэрийн даалгавар нь гарч ирээд өөрөө хийгдэж эхлэх юм шиг ховсдуулсан аятай харж байв.

- Бид өнөөдөр яагаад амарч болохгүй гэж? Баасан гаригт улаан өндөгний баярын амралт эхлэнэ биз дээ. Бидэнд цаг хангалттай байгаа хэмээн Гермiona хөгжилтэй хэлээд цонхны гадаа дэлбэрэх Уизлийн мөнгөн сүүлтэй пуужин руу харлаа.

- Чи зүгээр үү? гээд Рон итгэлгүйхэн түүн рүү ширтлээ.

- Би чамд хэлсэн биз дээ. Би өөрийгөө яг л нэг ... үймээн гаргагч шиг мэдэрч байна гэж Гермiona баясгалантай хэлэв.

Харри цагийн дараа Роны хамт унтлагын өрөөндөө орон хувцсаа тайлахад алсад

цаасан буу тас няс хийн дэлбэрч цамхагын дэргэд оч цацруулан «ТРАХ-ТАРАРАХ» гэсэн үг бичигдэв.

Тэр эвшээсээр ор луугаа явав. Шилээ тайлахад цонхны гадаах галын наадам бүүдгэртэн шөнийн тэнгэрт оч цацруулсан гайхамшигтай нууцлаг үүлс шиг санагдана. Тэр хажуугаараа эргээд Амбриж Дамблдорын ажлыг авсан анхны өдөр ямар санагдаж байгаа болон Фаж өнөөдөр сургууль хэдэн хэсэг болон дэлбэрэх шахсаныг мэдсэн бол яах тухай бодлоо. Харри инээмсэглэсээр зовхио анив.

Цаасан буу, пуужингууд сургуулийн талбайгаас исгэрсээр нисэн гарав ... эсвэл магадгүй тэр холдож байгаа юм болов уу ...

Тэр танил нууцын хэлтсийн хонгилд зогсож байв. Тэр жирийн хар хаалга руу нислээ ... Онгойгоорой ... онгойгоорой.

Тэгтэл боллоо. Тэр олон тооны хаалгатай дугуй өрөөнд орж ... эсрэг талын танил хаалганы бариулаас татан дотогш орлоо.

Тэр одоо урт тэгш өнцөгт хэлбэртэй хачирхалтай механик хэрэгслээр дүүрэн өрөөнд зогсож байв. Ханан дээр гэрлийн дүрс анивчих хэдий ч тоосонгүй ... тэр цаашаа явах хэрэгтэй.

Өрөөний буланд хаалга байлаа ... тэнд хүрэх юм бол бас нээгдэнэ ...

Тэгтэл бүдэг гэрэлтэй уужим өндөр сүм шиг танхимд ороход урт тавиур эцэс төгсгөлгүй ханаран үргэлжилж жижигхэн тоостой шилэн бөмбөлөгүүд эгнээгээрээ харагдав ... Харрийн зүрх хөөрсөндөө түргэн цохилон ... тэр цаашаа явахаа мэдэж байв ... тэр урагшаа гүйсэн ч хөлийн чимээ нь аварга том хүнгүй хоосон танхимд сонсогдохгүй байлаа ...

Энэ танхимд л түүнд маш хэрэгтэй зүйл хадгалагдаж байгаа ...

Энэ зүйл түүнд юунаас ч илүү хэрэгтэй ... Сорви нь өвдлөө ...

ТҮН!

Харри агшин зуур сэрээд уурсан сэтгэлээр уналаа. Харанхуй унтлагын өрөөгөөр дүүрэн инээд сонсогдов.

- Янзтай! Минийхээр бол галт дугуй пуужинтай мөргөлдвөл угсрагдах байх.

Үгүй ерөө, хар даа! гээд Симус цонх руу очлоо.

Харри Рон, Дин хоёрыг орноосоо сонирхолтой үзвэр үзэхээр босохыг сонслоо. Тэр хөдөлгөөнгүй чимээгүй хэвтсэн ч сорвины өвдөлт намдсангүйд урам хугарах сэтгэл төрөв. Түүнд хамгийн сүүлчийн агшинд гайхамшигтай амттан алдсан мэт харамсалтай мэдрэмж төрөх ажээ. Тэр энэ удаад байнд ойрхон байлаа шүү дээ!

Одоо Гриффиндорын цонхны хажуугаар гялалзсан мөнгөн далавчтай ягаан гахай нисэн өнгөрөв. Харри хэвтээд Гриффиндорынхон бусад давхарт хэрхэн хөөрөн хашгирахыг сонслоо. Гэнэтхэн маргааш окклюменцийн хичээл орохыг санаад айдаст автав.

Харри өдрийн турш Снегг нууцын хэлтсийн гүнд нэвтэрсэнийг мэдчих вий гэж эмээлээ. Тэр сүүлчийн хичээлээс хойш ийм их хугацаа өнгөрсөн байтал окклюменцийгээр нэг ч удаа сургуулилаагүйдээ гэмших сэтгэл төрж байв. Дамблдорын зугтсан өдрөөс хойш хэтэрхий олон зүйл болсон болохоор бүх хүчээ гарган хичээсэн ч оюун ухаанаа бодлоос чөлөөлөх боломжгүй болжээ. Гэхдээ энэ нь Снеггэд хангалттай цагаатгал болно гэдэгт эргэлзэж байлаа.

Тэр хичээл дээр арын эгнээнд суугаад бэлтгэл хийхийг оролдсон ч юу ч бүтсэнгүй. Түүнийг бүх бодол мэдрэмжээ чөлөөлөхөөр оролдон чимээгүй болох үед Гермiona юм асуух юмуу эсвэл багш сурагчдаас асуулт асууж байлаа.

Оройн хоолны дараа ертөнцийн хамгийн муу зүйлд бэлнээр Снеггийн өрөө рүү явлаа. Замын хагаст үүдний танхимд түүнийг Чжоу гүйцэв.

- Тийшээ явцгаая гээд Харри Снеггтэй уулзах хугацаагаа сунгах болсондоо баярлан танхимын булангийн том цаг руу зангав. Гриффиндорынхоос бараг хэн ч үлдсэнгүй.

- Юу байна даа? Амбриж чамаас ДА-гийн тухай асуусангүй юу?

- Үгүй гэж Чжоу яаран хэлээд,

- Үгүй зөвхөн ... би зүгээр л хэлэхийг хүссэн юм ... Харри, Мариэтта биднийг барьж өгсөн гэж миний зүүдэнд ч ороогүй шүү ... гэв.

- Ойлгомжтой гэж Харри баргар хэлэв. Тэр Чжоуг найзуудаа болгоомжтой сонгоосой гэж үнэнээсээ хүсч байлаа. Мариэтта одоо хүртэл эмнэлэгт хэвтэж хатагтай Помфри батгануудыг арилгаж чадаагүй болохоор энэ нь бага ч гэсэн тайвширам зүйл байв.

- Гэхдээ тэр их сайн охин. Зүгээр л алдаа гаргасан болохоос биш ... Харри түүн

рүү гайхан ширтлээ.

- Сайн охин гэнээ? Алдаа гаргасан гэсэн үү? Тэр биднийг нь бүгдийг барьж өгсөн шүү дээ!

- Гэхдээ ... бид мултарсан биз дээ? Чи түүний ээж яаманд ажилладагыг мэднэ дээ. Түүнд үнэхээр хэцүү байсан байх ...

- Роны эцэг ч гэсэн бас яаманд ажилладаг! Харин түүний царай дээр яагаад ховч гэсэн бичиг байхгүй байгаа юм бол ...

- Энэ ч Гермiona Грэйнджерийн зүгээс аймшигтай муухай зүйл боллоо! Тэр бидэнд жагсаалтыг илбэдсэн гэдгийг хэлэх ёстой байсан юм ... гэж Чжоу дүрсхийв.

- Минийхээр бол гайхамшигтай санаа байсан гэж Харри хүйтнээр хэлэв. Чжоу улайгаад нүд нь хурцаар гялалзав.

- Өө, тийм л дээ би үүнийг чиний үнэт Гермiona бодож олсон гэдгийг мартчихаж ...

- Ахиад л бүү уйлж үзээрэй дээ гэж Харри анхааруулав.

- Би тэгэх гээгүй байна! гэж тэр хашгирав.

- Тэгвэл сайн байна. Надад одоо түүнтэй түүнгүй хангалттай асуудал байгаа.

- Тэгвэл явж асуудлынхаа учрыг ол! гэж Чжоу уурсан дуу алдаад цааш бардмаар явлаа.

Харри уур хилэнд автсаар шатаар бууж Снеггийн газар дорхи хонгилд оров. Хэдийгээр Снег түүний ой ухааныг нэгжинэ гэдгийг мэдэж байсан ч уурсахгүй байж чадсангүй. Өрөө хүрэх замдаа Чжоу Мариэттад юу гэж хэлсэн бол хэмээн бодсоор явлаа.

- Та хоцорлоо, Поттер гэж Снег Харриг хаалга хаахад хүйтнээр хэлэв.

Тэрбээр Харри руу нуруугаа харуулан зогсоод ердийнхөөрөө Дамблдорын гүн ухааны цүнхээлд бодлоо хянамгай хийж байв. Чулуун аяганд сүүлчийн мөнгөн утсыг хийгээд эргэж харлаа.

- Ингэхэд та бие дааж хичээллэсэн үү?

- Тиймээ гэж Харри худал хэлэхдээ бичгийн ширээний хөлнөөс нүд салгасангүй.

- Тэгвэл удахгүй бид үүнийг шалгах болно. Саваагаа хураалга, Поттер гэж Снегг тайван хэлэв.

Харри ширээний нөгөө талд Снеггийн урдаас харан ердийн байрлалаа эзлэв. Түүний зүрх хүчтэй цохилон Чжоуд уурласан хэвээр байсан учир Снегг түүний ой ухаанаас хэтэрхий олон зүйл мэдэх байх гэж түгшлээ.

- Ингээд гурав хүртэл тоольё. Нэг ... хоёр ... гэж Снегг залхуутай хэлэв. Өрөөний хаалга нээгдэж Драко Малфой орж ирлээ.

- Профессор Снегг, ноёнтоон ... өө ... уучлаарай ... Малфой Снегг, Харри хоёр луу гайхан харлаа.

- Зүгээр дээ, Драко. Поттер энд уусмалын хичээлийн нэмэлт даалгавар авахын тулд ирсэн юм гээд Снегг саваагаа буулгав.

Малфойн царайд Амбриж Хагридыг шалгах үед гарч ирсэнтэй адилхан сэтгэл ханамжтай мишээл тодров.

- Би мэдсэнгүй гээд тэр хорсолтой инээмсэглэхэд Харри царай нь улайхаа мэдрэв. Тэр Малфойд үнэнийг хашгиран хэлэх юмуу эсвэл сайн гэгч нь шившлэгээр зочлоод өгөхөд бэлэн байлаа.

- Драко юу болоо вэ? гэж Снегг асуув.

- Профессор Амбрижад таны тусламж хэрэгтэй байна, ноёнтоон. Тэд Монтегюг олсон. Хэн нэгэн түүнийг дөрвөн давхарын жорлон руу чихжээ.

- Монтегю хэн байсныг нь хэлсэн үү?

- Үгүй ээ, ноёнтоон тэр жаахан самуурсан байгаа.

- Их харамсалтай байна, Поттер. Бид хичээлээ маргааш орой үргэлжлүүлэх болох нь дээ.

Снегг эргээд өрөөнөөс гарлаа. Түүний араас явахын урьд Малфой чимээгүйхэн «Нэмэлт хичээл гэнээ?» хэмээн хэлээ гаргав.

Харри ууртайгаар саваагаа халаасандаа хийгээд бас үүд рүү зүглэв. Юутай ч гэсэн окклюменцийн хичээлд орохын тулд ахин хорин дөрвөн цаг хүлээх хэрэгтэй боллоо. Тэр гэнэтийн зайлсхийсэн явдалдаа хувь заяанд баярлах ёстойгоо ойлгож байсан ч хамгийн муу нь гэвэл Малфой одоо сургууль даяар түүнийг уусмалын хичээлийн

нэмэлт даалгавар авсныг зарлах байх.

Харри босгон дээр хүрээд гэнэтхэн хаалганы хүрээнд гэгээ татахыг харав. Тэр зогсоод харахад энэ нь ямар нэг зүйлийг санагдуулав ... дараа нь өнгөрсөн шөнийн зүүдэнд харсан нууцын хэлтсийн хоёр дахь өрөөнд байсан гэрэлтэй адил болохыг мэдлээ.

Тэр эргэж харлаа. Гэрэл Снеггийн ширээн дээрх чулуун аяганаас гарч байв. Түүний дотор мөнгөлөг цагаан зүйл хуйлран эргэлдэнэ. Снеггийн бодол ... Тэр Харриг ямар бодлыг нь харна гэж айсан юм бол ...

Харри гүн ухааны цүнхээлээс нүд салгасангүй сонирхол нь хүчтэй оволзлоо ... Снегг юугаа тэгтлээ нуухыг хүссэн юм бол?

Ханан дээрх мөнгөлөг гэрэл чичигнэв ... Харри хүчлэн бодоод ширээ рүү нэг алхсанаа хоёр дахиа алхав. Магадгүй Снегг нууцын хэлтэстэй холбоотой зүйл түүнээс нуусан юм болов уу?

Харри эргэж харлаа. Одоо түүний зүрх урьдынхаас илүү хүчтэй цохилж байв. Снегг Монтегюг жорлонгоос гаргахад хэр их хугацаа орох бол? Тэр өрөө рүүгээ шууд эргэж ирэх болов уу эсвэл Монтегюг эмнэлэгт хүргэх болов уу? Мэдээж дараагийнх нь байж таарна ... Магадгүй Монтегю Слизериний квиддичийн багийн ахлагч болохоор Снегг түүний бүх зүйл сайн эсэхийг магадлахыг хүсэж болох шүү дээ.

Харри ширээ рүү ойртон гүн ухааны цүнхээлийн өмнө зогсоод ёроол руу нь өнгийн харлаа. Тэгээд хэсэг зуур тээнэгэлзэн чимээ анирдсанаа саваагаа гаргав. Өрөөнд ч тэр, хонгилд ч тэр нам гүм байв. Тэр саваагаа аяархан хүргэлээ.

Мөнгөлөг шингэн хурдтай хуйлран эргэв. Харри тонгойгоод тунгалаг болохыг нь харлаа. Тэр ахин доош шагайгаад хаа нэгтээ байх өрөөний адар дээрх дугуй цонхоор харлаа ... Хэрвээ тэр андуураагүй бол энэ Их танхим байв.

Түүний амьсгалд Снеггийн бодол бүүдгэртэн үзэгдэв ... тэр яахаа мэдэхгүй байлаа ... хэдийгээр энэ ухаангүй хэрэг ч сонирхол нь улам ихсэх аж ... тэр чичирлээ ... Снегг дурын агшинд эргээд ирж болно ... гэхдээ Харри Чжоуд уурссан тухайгаа болон, Малфойн доогтой царайг санамагц ухаангүй шийдвэр зурсхийн орж ирэв.

Тэр гүнзгий амьсгалаад нүүрээ Снеггийн бодолд дүрлээ. Өрөөний шал алга болж

Харри гүн ухааны цүнхээлд толгойгоороо нисэн оров. Тэр хүйтэн харанхуй руу унаснаа гэнэтхэн ...

Харри Их танхимын голд зогсоод дөрвөн тэнхимийн ширээнүүд хаа нэг тийш алга болжээ. Түүний оронд ижилхэн зуугаад ширээ тавьж бүгд дээр нь сурагчид суугаад толгойгоо бөхийлгөн цаасан дээр юм бичиж байв. Нам гүмийг зөвхөн үзэг чахрах юмуу, цаас шаржигнах чимээ эвдэнэ. Харваас энд шалгалт авч байлаа.

Өндөр цонхоор толгой дээгүүр тусах нарны гэрэл хурцаар гийгүүлэн алтлаг, шаргал, хүрэн өнгөөр туяарна ... Харри болгоомжтой эргэн тойрноо харлаа. Энд хаа нэгтгээ Снегт байх ёстой ... энэ түүний ой санамж юм чинь ...

Тэгтэл үнэхээр Харрийн ард талын ширээн дээр сууж байлаа. Харри түүн рүү харлаа. Өсвөр насны Снегт харанхуйд өрөөнд өссөн юм шиг хувхай цагаан ажээ. Тэр тослог шулуун үсээ ширээ рүү унжуулан хамраа цаасанд шүргэх шахам бичиж байв. Харри ар талд нь зогсоод шалгалтын гарчиг болох «СУПЕР ИД ШИДИЙН ШАЛГАЛТ. ХАР УРЛАГААС ХАМГААЛАХ ХИЧЭЭЛ» гэснийг харлаа.

Тэгэхээр Снегт одоо Харрийн адил арван тав юмуу зургаан настай байна. Түүний гар цаасан дээгүүр нисэж хажуу дахь хөршүүдээсээ тохой илүүтэй зайг жижигхэн бичгийн хэвээр дүүргэж байв.

- Таван хором үлдлээ!

Харри санаандгүй байсандаа цочлоо. Холгүйхэн орших эгнээ дундуур холхих профессор Флтивикийн зулай харагдав. Профессор өрөвгөр хар үстэй хүүгийн дэргэдүүр өнгөрөхөд ... тал бүр тийшээ өрвийсөн хар үстэй ...

Харри огцом хөдөлсөн тул хажуугийн ширээнээс хүчтэй зууран авлаа. Хоёр эгнээний цаана гурав дахид нь сууж байгаа хүнийг харахад зүүдэлж байгаа юм шиг санагдав. Хар үстэй хүүгийн толгой нурууг ойртон харахад ... тэр өндийгөөд үзгээ тавьж цаасан дээр бичсэн зүйлээ уншлаа ...

Харри ширээний урд нь зогсоод арван таван настай эцгээ харлаа.

Баяр хөөр түүнийг эзэмдэхэд энэ нь гарцаагүй өөрийгөө харж байгаатай адил зүйл байлаа. Жеймсийн нүд хүрэн өнгөтэй, хамар нь Харрийнхаас арай урт, духан дээр нь сорви байхгүй, хоёулаа адилхан нимгэн царай, ижилхэн уруул, хөмсөгтэй байлаа. Жеймсийн өрвөгөр үс нь ч тэр, гар нь ч тэр Харритай адил байлаа. Хэрвээ эцэг нь босох юм бол тэд өндрөөрөө чацуу гэдэг нь ойлгомжтой байв.

Жеймс том эвшээгээд үсээ сөргүүлэн илж улам арзайлгав. Дараа нь профессор Флитвик руу хяламхийн харснаа дөрвөн суудлын ард сууж буй хүү рүү инээмсэглэн

эргэв.

Жеймс рүү эрхий хуруугаа гозойлгох Сириусыг хараад Харри ахин баяр хөөрт автав. Сириус залхуутайгаар сандлаа түлхэхэд тэр хоёр алхамын зайд зогсож байлаа. Тэр сайхан харагдаж байлаа. Шулуун хар үсээ дух руугаа гоёмсогоор унжуулсан агаад дэргэд нь суусан охин найдангуй харах хэдий ч ажигласангүй. Харин түүнээс хоёр ширээний тэртээ Римус Люпин сууж байхыг хараад Харрийн зүрх ахин ёгхийлээ. Өвдсөн ч юм шиг зүдэнги царайтай (үнэхээр арван тавны сар ойртсон гэж үү) тэрбээр шалгалтандаа бүрэн автаж асуултыг уншингаа эрүүгээ үзгээр маажин хөмсөг зангидлаа.

Тэгэхээр хаа нэгтээ ойрхон Сүүлт байх ёстой ... Тэгтэл ч үнэхээр хэдхэн секунд өнгөрөөгүй байхад Харри жижигхэн бие, шовх хамар, саарал үстэй хүүг олж харлаа. Сүүлт түгшсэн байртай цаас руугаа ширтэн бохир хумсаа хэмлэнгээ газар хөлөөрөө маажив. Тэр үе үе дэргэдэх хөршийнхөө цаас руу найдангуй хяламхийх аж. Хормын турш Харри түүн рүү хараад ахин Жеймс рүү харахад хийсэн зүйлгүй цаасны тасархай дээр зураг сараачиж байв. Тэр снитч зурж байсан бөгөөд дэргэд нь Л.Э. гэсэн үсэг гарч ирлээ. Энэ юу гэсэн үг юм бол?

- Үзгээ доош нь тавиарай! Энэ таньд хамаатай, Стеббинс!
Байрандаа сууцгаагаарай, би цаасыг хурааж авах болно! Акцио!

Ойролцоогоор зуугаад цаас агаарт хөөрөн профессорын сунгасан гарт баригдахад цохиулан арагш уналаа. Инээд хадав. Урд нь сууж байсан хэдэн сурагчид Флитвикийн тохойноос өргөн босоход нь туслав.

- Баярлалаа таньд ... баярлалаа. Маш сайн байна, та нар одоо чөлөөтэй!

Харри доошоо эцэг рүүгээ харахад яаран Л.Э гэсэн үгээ чимэглээд үсрэн босож үзэг болон шалгалтын цаасаа цүнхэндээ хийгээд нуруундаа үүрч Сириусыг хүлээв.

Харин холгүйхэн сууж байсан Снегг билетээ уншсаар ширээний дундуур хаалга чиглэн хөдөллөө. Ясархаг туранхай тэрбээр аалз шиг эв хавгүйхэн хөдлөх агаад тослог үс нь нүүрнийх нь хажуугаар намирна.

Хэдэн охид Снегг болон Жеймс, Сириус, Люпин нарын дундуур өнгөрөхөд Харри Снеггийг хараанаас алдахгүйг хичээхийн зэргэцээ Жеймс болон түүний найзуудын яриаг сонслоо.

- Чамд аравдугаар асуулт таалагдсан уу, Солиот оо? гэж Сириус үүдний

танхимд гарахдаа асуув.

- Тэгэлгүй яахав. Хүн чоныг таних таван шинж тэмдэгийг нэрлэ. Сайхан асуулт шүү гэж Люпин хөгжилтэй хэлэв.

- Чи бүх шинж тэмдэгийг зөв бичсэн гэдэгтээ итгэлтэй байна уу? гэж Жеймс тохуурхсан янзтай санаа тавин асуулаа.

- Тийм гэж бодож байна хэмээн Люпин хэлэхэд тэд үүдэнд бөөгнөрсөн сурагчдын урсгалтай нэгдэн нарны гэрэл гийгүүлсэн нуга руу гарлаа.

- Эхнийх нь гэвэл тэр миний сандал дээр сууж байсан. Хоёрдугаарт гэвэл тэр миний хувцсыг өмссөн байсан. Гуравдугаарт гэвэл түүнийг Римус Люпин гэдэг.

Сүүлтээс бусад бүх хүн инээлдлээ.

- Би хоншоорны хэлбэр болон нүдний хүүхэн хараа бас сүүл гэж бичсэн. Өөр юу ч санаанд ороогүй гэж тэр сэтгэл зовонгүй хэлэв.

- Чи чинь тэнэг юмуу, Сүүлтээ? Сард нэг удаа хүн чонотой шөнийн турш зугаалж байж гэж Жеймс тэвчээргүйхэн хэлэв.

- Аяархан яриач гэж Люпин гуйлаа.

Харри ахин түгшин эргэн тойрноо харав. Снегг тэдний араас шалгалтын асуултаа уншсан чигтээ явж байв. Гэхдээ энэ түүний дурсамж болохоор хэрвээ цэвэр агаарт зугаалах өөр зам сонгон авах юм бол Жеймс болон түүний найзуудыг харж чадахгүй гэдэг нь илэрхий байв. Гэтэл түүний санааг амраан Жеймс болон түүний гурван найз нуурын дэргэдэх зүлэг рүү чиглэхэд Снегг тэднийг дагалдан явах зуураа цаасаа нүүрнээсээ холдуулсангүй. Харри түүний урд явахдаа өмнөхийн адил Жеймс болон бусад руу нь ширтэж байв.

- Харин миний асуулт сайн болсон. Хамгийн багадаа онц гэсэн үнэлгээ авахгүй бол гайхах байна гэх Сириусын хоолой гарав.

- Би ч гэсэн гэж Жеймс хэлэв. Тэр халааснаасаа алтан снитч гаргаж ирэв.

- Чи үүнийг хаанаас аваа вэ?

- Хулгайлсан юм гэж Жеймс хайхрамжгүй хэлээд снитчийг гараасаа тавингаа холдохоос нь өмнө шүүрч аван тоглоход үйл хөдлөл нь гайхамшигтай байлаа. Сүүлт түүнийг бишрэн харав.

Тэд Харри, Рон, Гермиона гурав нэг удаа бүтэн сайны гэрийн даалгавараа хийж

байсан нуурын эргийн дэргэдэх хусны сүүдэрт зүлгэн дээр суув. Харри ахин мөрөн дээгүүрээ эргэж хараад Снеггийг холгүйхэн өтгөн бутны сүүдэрт суухыг хараад баярлалаа. Тэр урьдынх шигээ шалгалтын материалыг улайран харж байсан учир Харри тайвнаар хус болон бутны дунд сууж дөрвөн найз руу ширтлээ. Нуурын мандалд нарны туяа ойн гялалзахад хэсэг охид Их танхимаас инээлдэн гарч ирээд гутал оймсоо тайлан сэрүүн усанд хөлөө дүрлээ.

Люпин ном нээж шимтэн уншлаа. Сириус уйтгарласан янзтай эргэн тойрондоо зугаалж буй сурагчдыг харна. Жеймс өмнөхийн адил тоглосон хэвээр снитч одоохон чөлөөлөгдөх гэж байгаа мэт санагдах ч хамгийн сүүлчийн агшинд шүүрэн авч байв. Сүүлт түүнийг ам ангайн ширтэнэ. Үе үе Жеймсийг гарамгай шүүрэлт хийх болонд Сүүлт дуу алдан бахдаж алга ташиж байв. Таван хормын дараа Харри Жеймс яагаад Сүүлтээс биеэ барихыг гуйхгүй байгааг гайхсан ч тэрбээр бусдын анхаарлыг татах дуртай бололтой. Харри түүний эцэг нь хэтэрхий нямбай гэж хэлэгдэхээс айсан мэт үсээ өрвийлгөх зуршилтай болохыг ажиглав. Тэрбээр нуурын эрэг дээрх охид руу хяламхийн харна.

- Сүүлт хэт хөөрхөөс өмнө больж үз хэмээн Сириус Жеймсийг ахин гайхалтай шүүрэлт хийн снитчийг барьж авах үеэр Сүүлт ээлжит дуу алдахад хэллээ.

Сүүлт үл мэдэгхэн улайхад, Жеймс инээмсэглэв.

- Хэрвээ энэ чиний санааг зовоогоод байгаа бол гээд тэр снитчээ буцааж халаасандаа хийв. Харри яагаад ч юм Сириус цорын ганц Жеймсийг зогсоож чадах хүн гэдэгт итгэлтэй байлаа.

- Уйтгартай байна. Арван тавны сар хэзээ гарах бол? гэж Сириус хэлэв.

- Харин би түүнгүй чинь болоод байна гэж түүний ард ном уншиж байсан

Люпин баргар царайлан хэлээд,

- Юуны түрүүнд бас хувиргалын хичээлийн шалгалт өгөх ёстой. Хэрвээ чи уйдаад байвал намайг шалга гээд номоо сунгав.

Гэвч Сириус ердөө тургилав.

- Өөртөө үлдээ. Наад тэнэг зүйлийг чинь би бүгдийг нь мэднэ.

- Хөгжилдөх үү, Тэнүүлчээ. Тэнд хэн байгааг хараач гэж Жеймс тайван хэлэв.

Сириус ангийн үнэр авсан нохой аятай толгойгоо эргүүлээд,

- Гайхалтай, Ньюниус гэж аяархан хэлэв. Харри мөн тэр зүг рүү харлаа.
- Снегг бутны дэргэд зогсоод жагсаалтаа цүнхэндээ хийж байв. Түүнийг сүүдрээс гарахад Сириус, Жеймс хоёр бослоо.
- Люпин, Сүүлт хоёр суусаар үлдэв. Люпин ном руу ширтсээр хөмсөгний дээгүүр нь хөнгөхөн үрчсийсэн харагдана. Сүүлт тэдний зүг тэсч ядсан байртай харлаа.
- Юу байна даа, Ньюниус? гэж Жеймс чанга хэлэв.
- Снегг яг л ийм дайралт хүлээж байсан мэт түргэн хөдөлж цүнхээ унагаад гараа халаасандаа шургуулж шидэт саваагаа гаргаж иртэл Жеймс,
- Экспеллиармус! гэж хашгирлаа.
- Снеггийн саваа агаарт арван хоёр футын өндөрт хөөрөөд ар талд нь ногоон дээр унав. Сириус хуцах адил инээлээ.
- Импедимента! гээд тэр саваагаа зэвсэг рүүгээ ухасхийсэн Снегг рүү чиглүүлэхэд уналаа.
- Эргэн тойрон байсан хүүхдүүд тэдний зүг харав. Зарим сурагчид ойртон ирлээ. Зарим нь эмээнгүй ширтэж байхад, зарим нь баярласан байртай үзэгдэнэ.
- Снегг хүндээр амьсгаадан ногоон дээр хэвтэнэ. Жеймс, Сириус хоёр түүн рүү саваагаа өргөн ойртоход, Жеймс нуурын эрэг дээр явж байсан охин руу эргэн харлаа. Сүүлт ч мөн хөл дээрээ босоод шунахайран ширтэж сайтар харахын тулд Люпинээс холдов.
- Шалгалт ямар өнгөрөв дөө, Нюнчик? гэж Жеймс асуув.
- Би түүнийг хамраа цаасанд дүрж байхыг нь харсан. Магадгүй түүний бүх ажил учрыг нь олохооргүй толбо болсон байх гэж Сириус ёжлов.
- Үзэгчдийн хэн нэг нь инээлээ. Снегг харваас нэр хүндгүй бололтой. Сүүлт писхийгэл инээд алдав. Снегг босохыг оролдсон ч шившлэг ахин үйлчлэхэд үл үзэгдэх олсоор хүлүүлсэн мэт атиралдав.
- Чи намайг хүлээж байгаарай гэж тэр Жеймс рүү үзэн ядан ширтэж хэллээ.
- Юу хүлээнэ гэж? Чи юу хүссэнээ хийж болно, Нюнчик. Биднээр нусанхай хамраа арчуулах гээ юу? хэмээн Сириус хүйтнээр хэлэв.
- Снегг хараал тавьсаар шившлэг хэлсэн ч эзнээсээ гурван алхамын зайд хэвтэж

байсан саваа хөдөлсөн ч үгүй.

- Чи бохир амаа угаа. Экскуро! гэж Жеймс зэвүүцэнгүй хэлэв. Снеггийн амнаас ягаан савангийн хөөс гарахад хахаж цацан ханиалаа ...

- Түүнийг тайван орхи!

Жеймс, Сириус хоёр эргэж харав. Жеймсийн сул гар даруйхан үс рүүгээ явлаа. Нуурын эрэг дээр байсан охидын нэг хашгирчээ. Тэр мөрөө хүрсэн өтгөн хар үстэй, Харрийн адил тунгалаг ногоон нүдтэй байлаа.

Түүний ээж нь.

- Юу гэнээ, Эванс? гэж Жеймс хэлэхэд хоолойны өнгө гэнэтхэн өөрчлөгдөж яруухан илүү насанд хүрсэн хүнийх шиг боллоо.

- Түүнийг тайван орхи гэж Лили давтаад Жеймс рүү ихэд эгдүүцэн харав. Тэр та нарт юу хийсэн юм?

- Юу гэвэл хэмээн Жеймс хүндхэн бодлогоширох асуулт өгсөн хүний байртай хэлээд,

- Түүний хийсэн зүйлийн баримт нь гэвэл тэр өөрөө оршиж байгаад юм, хэрвээ чи миний юун тухай хэлснийг ойлгож байвал ... гэв.

Сириус, Сүүлт тэргүүтэй олонхи үзэгчид инээлдсэн ч ном уншиж байсан Люпин инээмсэглэсэнгүй. Түүнчлэн Лилид ч бас нөлөөлсөнгүй бололтой.

- Өөрийгөө онцгой ухаантай гэж бодоо юу. Чи бол үнэндээ биеэ тоосон дээрэнгүй амьтан, Поттер. Түүнийг тайван орхи, ойлгомжтой юу? гэж хүйтнээр хэллээ.

- Чамайг надтай зугаалахыг зөвшөөрвөл, Эванс. Хэрвээ ... надтай явж зугаалвал би амьдралдаа хэзээ ч Нюнчик руу шидэт саваагаа чиглүүлэхгүй гэж Жеймс түргэхэн хэлэв.

Тэр үед Снеггэд илгээсэн шид суларлаа. Тэр саваа руугаа удаанаар хөөс сахруулан мөлхөхийг Жеймс харсангүй.

- Хэрвээ надад аварга том наймаалж та хоёрыг сонгох хэрэг гарлаа гэсэн ч би чамтай явахыг зөвшөөрөхгүй.

- Аз таарсангүй дээ! гэж Сириус хөгжилтэй хэлээд Снегг рүү эргэж харснаа,

- Зогс! гэлээ.

Гэхдээ тэр хоцорчээ. Снегг хэдийн саваагаа Жеймс рүү чиглүүлсэн байв. Хурц гэрэл гялсхийхэд Жеймсийн нүүрэн дээр гүнзгий шарх үүсэн цус дуслав. Тэгтэл ахин нэг хурц гэрэл гялсхийн Снегг агаарт олсоор өлгүүлсэн мэт уруугаа харан өргөгдөөд жанч нь толгой нь руугаа хөмрөгдөн туранхай цагаан хөл, бохир богино өмдийг нь гаргав.

Хүүхдүүд хөөрөн хашгиралдахад Сириус, Жеймс, Сүүлт нар хөхрөлдсөндөө арай л унасангүй. Лили уурссан хэдий ч инээмсэглэн,

- Түүнийг буулга! гэлээ.

- Тэгэлгүй яахав гээд Жеймс саваагаа даллав.

Снегг газар нэвсийн уналаа. Тэрбээр жанчныхаа орооцолдоог гарган түргэн хөл дээрээ босоод саваагаа өргөсөн хэдий ч Сириус «Петрифустоалус!» гэж хашгирахад самбар шиг чигээрээ уналаа.

- Түүнийг тайван орхи! гэж Лили хашгирлаа. Тэр ч гэсэн саваагаа өргөжээ.

Жеймс, Сириус хоёр түүн лүү болоомжлон харцгаав.

- Сонсооч Эванс, намайг чамд шид хэрэглэхэд бүү хүргээрэй гэж Жеймс хэлэв.

- Тэгвэл түүнийг орхи!

Жеймс хүндээр санаа алдсанаа Снегг рүү эргэж эсрэг шившлэгийг бувтналаа.

- Эндээс яв. Чиний аз болоход Эванс чиний ойролцоо байж таарлаа, Ньюниус ... гэхэд Снегг хүндхэн хөл дээрээ бослоо.

- Надад бузар бохир цустны тусламж хэрэггүй! Лили нүдээ анивчлаа.

- Сайн байна. Дараагийн удаа би саад болохгүй. Ингэхэд би чиний оронд байсан бол дотуур өмдөө угаах байсан даа, Ньюниус.

- Эвансаас уучлал гуй! гэж Жеймс орилоод Снегг рүү саваагаа сүрдүүлэн зангалаа.

- Би чамайг түүгээр уучлал гуйлгахыг хүсэхгүй байна! Чи түүнээс юугаараа ч дээрдэхгүй! гэж Лили хашгирав.

- Юу гэнээ? Би чамайг амьдралдаа хэзээ ч тэгж нэрлэхгүй гэдгийг ... мэдэж байгаа биз дээ! гэж Жеймс дүрсхийв.

- Хормын өмнө шүүрнээсээ унасан мэт цаг үргэлж сэгсийн явж энэ тэнэг снитчээрээ тоглон, хонгилд өөртөө таалагдаагүй уур хүргэсэн хүн болгон руу шившлэг илгээж явдагыг чинь мэднэ ... Шүүр чинь чамайг яагаад газар толгойгоор чинь унагачихдагүйг ойлгох юм алга! Чамайг харахаас дур гутаж байна!

Тэр огцом эргээд цааш түргэн явлаа.

- Эванс! Хүлээгээч, Эванс! гэж Жеймс араас нь хашгирав. Гэхдээ тэр эргэж харсангүй.

- Ямар ялаа нь түүнийг хазсан юм бол? гэж Жеймс асуултын хариу түүнд хамаагүй мэт царай гаргахыг амжилтгүй оролдон хэлэв.

- Тэр чамайг жаахан их зантай бодож байх шиг байна, найз минь гэж Сириус хэллээ.

- За яахав. Тэгвэл ... гэж Жеймс гомдонгуй дуугарлаа.

Ахиад хурц гэрэл гялсхийж Снегг агаарт уруугаа харан өлгөгдөв.

- Хэн намайг Ньюниусын өмдийг тайлахыг харахыг хүсэж байна?

Гэхдээ Харри Жеймсийн сүрдүүлгээ хэрэгжүүлэхийг харсангүй. Хэн нэг нь тохойноос нь бахь шиг чанга зуурлаа. Тэсэхийн аргагүй өвдөхөд Харри эргэж хараад ардаа насанд хүрсэн Снегг уурсаж хилэгнэсэндээ зэвхий царайлан зогсохыг хараад айдаст автав.

- Хөгжилтэй байна уу?

Харри агаарт өргөгдөхөө мэдэрч зуны өдөр утаа шиг сарнив. Тэр дээшээ нисэж хүйтэн харанхуйг нэвтлэн гарахад Снеггийн гар тавьсангүй. Дараа нь Харри агаарт эргэлдэн хөлөөрөө газар дорхи хонгилын чулуун шал цохин унаад ахин өнөөдрийн өдөр уусмалын багшийн өрөөнд гүн ухааны цүнхээл бүхий ширээний дэргэд зогсож байгаагаа мэдэв.

- Тэгэхээр. Тэгэхээр ... таньд таалагдсан уу, Поттер? гээд Снегг Харрийн гарыг улам чанга базахад чинэрэн өвдлөө.

- Үгүй гээд Харри гараа чөлөөлөхийг хичээв.

Түүнд аймшигтай байлаа. Снеггийн уруул чичирч царай нь цонхийн шүдээ ярзайлгажээ.

- Эцэг чинь таатай хүн байгаа биз? гээд Харрийн шил хамар дээрээс нь гулган унатал дугтарлаа.

- Би ... би тэгэх ...

Снегг бүх хүчээрээ түүнийг холдуулан түлхэв. Харри чулуун шалан дээр хүчтэй уналаа.

- Харсан зүйлээ хэн нэгэнд хэлэх гээд үзээрэй! гэж Снегг архирлаа.

- Үгүй гээд Харри хөл дээрээ өндийн Снеггээс аль болохоор хол байхыг хичээлээ.

- Мэдээж би хэнд ч ...

- Эндээс зайл! Би чамайг энэ өрөөнд хэзээ ч харахыг хүсэхгүй байна!

Харри хаалга руу ухасхийхэд толгой дээгүүр нь хатсан жоомтой ваар сүнгэнэн өнгөрөв. Тэр хаалга нээгээд хонгилоор гүйж зөвхөн гурван давхарт хүрсэн хойноо зогсов. Тэр хүндээр амьсгаадан хана налж хөхөрсөн гараа үрлээ.

Түүнд Гриффиндорын цамхагт руу буцан Рон, Грермиона хоёрт адал явдлынхаа тухай хэлэх ямар ч хүсэл байсангүй. Харри аймшигтай сэтгэлээр унажээ. Тэр Снегг доромжлогдох үедээ юу мэдэрч байсныг мэдэж байсан болохоор хэрвээ гүн ухааны цүнхээлд харсан зүйлийн талаар бодож үзэх аваас түүний эцэг нь Снеггийн үргэлж хэлдэг шиг их зантай хүн байлаа.

БҮЛЭГ 29: МЭРГЭЖЛИЙН СОНГОЛТ

- Чи яагаад окклюменцийн хичээлдээ явахгүй байгаа юм бэ? гэж Гермiona хөмсөг зангидан асуулаа.

- Би чамд хэлсэн биз дээ. Снегг намайг үндсэн зүйлээ сурсан болохоор цаашид бие даан хичээллэх чадвартай гэж бодож байгаа.

- Тэгэхээр чи аймшигтай зүүд зүүдлэхээ больсон хэрэг үү? гэж Гермiona сонирхлоо.

- Бараг л үгүй гэж Харри харцаа буруулан хэлэв.

- Харин минийхээр бол Снегг чамайг зүүдээ бүрэн хянаж сураагүй байхад хичээлээ зогсоох нь зөв гэж бодохгүй байна! Чи түүнээс очиж асуух ёстой ... гэж Гермiona таагүйхэн дуу алдав.

- Үгүй. Алив өөр зүйлийн талаар ярилцвал яасан юм бэ? гэж Харри шийдэмгий хэллээ.

Улаан өндөгний баярын амралтын анхны өдөр Гермiona зуршсан ёсоороо ихэнхи цагаа гурвуулангийнхаа шалгалтанд бэлтгэх хуваарь хийхэд өнгөрүүлэв. Харри, Рон хоёр түүнд саад болсонгүй. Энэ нь түүнтэй маргаж байснаас дээр байсан болохоор ашигтай байлаа.

Рон гэнэтхэн шалгалт болоход ердөө зургаан долоо хоногийн хугацаа үлдсэнийг айдаст автан илрүүлэв.

- Чи яаж энэ тухай маргаж чадав аа? гэж Гермiona саваагаа Роны хуваарьт хүргэн шаардангуй асуулаа. Түүний хүрсэн цаасны дөрвөлжин хэсэг бүр янз бүрийн өнгөтэй болж байв.

- Мэдэхгүй. Их олон зүйл болсон болохоор.

- За яахав, үүнийг ав. Шалгалтанд бэлтгэхэд хэрэг болно гээд түүнд хуваариа сунгав.

Рон цаасыг барайн харснаа царай нь гийлээ.

- Чи надад долоо хоног болгон нэг сул өдөр үлдээсэн байна!

- Квиддчийн бэлтгэлийн өдөр гэж Гермiona хэлэв. Роны инээмсэглэл бөхлөө.

- Энэ чинь юу гэсэн үг юм? Энэ жил бидэнд квиддчийн цомыг хожих боломж

манай аав сайд болохтой адил байгаа.

Гермиона юу ч хэлсэнгүй ч эсрэг талын нүцгэн хана ширтэж буй Харри руу харахад Живоглот чихээ маажуулахаар гарыг нь самардав.

- Чи яагаа вэ, Харри?

- Би юу? Яагаа ч үгүй.

Тэр «Хамгаалах хичээлийн онол» номоо нээгээд ямар нэг зүйл уншиж буй дүр үзүүлэв. Живоглот түүн дээр цагаа үрэх хэрэггүй гэж болдсон бололтой Гермионагийн сандал доогуур оров.

- Би өнөөдөр Чжоуг харсан. Тэр их сэтгэлээр унасан байсан. Та хоёр ахин маргалдаа юу? гэж Гермиона болгоомжтой хэлэв.

- Марг ... аан тийм л дээ гээд Харри ярианы шинэ сэдэв нээгдсэнд талархан хэлэв.

- Юунаас болоод тэр вэ?

- Түүний найз ховч Мариэттагаас болоод.

- Тэгвэл би чамайг буруутгахгүй. Хэрвээ тэр байгаагүй бол ... гэж Рон ууртайгаар мэдэгдэн шалгалтын хуваариа доош тавилаа.

Ингээд Рон Мариэтта Эжкомыг харааж гарахад Харри уурсан төрхөөр «Тиймээ», «Зүйтэй» гэх зэргээр толгой дохин дэмжих зуураа гүн ухааны цүнхээлд харсан зүйлдээ гүнзгий уйтгарт автлаа.

Тэр дурсамж дотроос нь хэмлэхийг мэдэрчээ. Тэр бүхий л амьдралдаа эцэг эх нь сайн сайхан хүмүүс гэдэгт итгэж байсан бөгөөд Снегг эцгийнх нь авирын талаар муу үг хэлэхэд өчүүхэн төдий ч эргэлзэж байгаагүй юм. Жишээ нь Хагрид, Сириус хоёр түүнд эцэг нь гайхамшигтай хүн байсан гэж хэлээгүй билүү? (Тийм л дээ чи өөрөө Сириусыг харсан. Тэр ч гэсэн дээрдэнэ гэж үү? гэсэн даажинтай хоолой толгойд нь сонсогдлоо).

Тэр нэг удаа санамсаргүй профессор МакГонагалл тэдний тухай үймээн таригч гэж Уизлийн ихрүүдийг жишээ татан ярихыг сонсож байсан ч гэлээ Харри Фред, Жорж хоёр хэн нэгнийг хөгжилтэй байхын төлөө агаарт олсоор өлгөнө гэж төсөөлж чадсангүй ... хэрвээ жинхэнээсээ үзэн ядаагүй бол тэгэхгүй байсан ... магадгүй Малфой юмуу эсвэл өөр хэн нэг үүнийг жинхэнээсээ хүртэх гавъяатай хүнийг ...

Харри өөртөө Снегг Жеймсийн гарт зовох тавилантай гэж итгүүлэхийг оролдсон ч Лили «Тэр та нарт юу хийсэн юм?» гэхэд Жеймс «Түүний хийсэн зүйлийн баримт нь гэвэл тэр өөрөө оршиж байгаад юм» гэсэн. Үнэхээр Жеймс энэ бүхнийг зөвхөн Сириус уйдаж байна гэж хэлсний төлөө хийлээ гэж үү? Харри Люпинээс Гриммогийн байшинд сонссон ярианы тухай эргэн санахад Дамблдор түүнийг ахлагч болгосноороо Жеймс, Сириус хоёрыг барина гэж найдсан ч ... гүн ухааны цүнхээлд бол тэр зүгээр суугаад болж байгаа үйл явдлыг харж байсан.

Харри өөртөө Лилийн оролцоог санууллаа. Түүний ээж нь биеэ сайн авч явж байсан. Дурсамжинд тэр Жеймс рүү хашгирах үед царайны хувирал нь жинхэнээсээ дургүйцэж байсан юм шиг санагдахад Харри энэ бүхний дараа тэд яаж гэрлэж чадсаныг ойлгосонгүй. Түүнд нэг хоёр удаа Жеймс хүчээр гэрлэсэн юм шиг бодол зурсхийв ...

Бараг таван жилийн турш эцэг нь сэтгэл санаа тайвшируулагч байлаа. Хэрвээ хэн нэг хүн Жеймстэй адилхан гэвэл Харри бахархдаг байлаа. Харин одоо ... одоо эцгийн тухай нэг бодол орж ирэхэд дотор нь хүйт даалаа.

Улаан өндөгний баярын амралтын төгсгөл ойртоход цаг агаар илүү салхитай дулаахан нарлаг болсон ч Харри болон тавдугаар дамжааныхан долдугаар дамжааныхны адил номын санд дөрвөн хананы дунд хашигдан суугаад сурах бичиг эргүүлж байв. Харри түүний сэтгэл санааны тааруухан байдал шалгалт дөхсөнтэй холбоотой дүр үзүүлэхэд нэг ангийхан нь бас өглөөнөөс үдэш болтол ном эргүүлж байсан болохоор хэн ч үүнд гайхсангүй.

- Би чамтай ярьж байна, Харри! Сонсож байна уу?

- Аан?

Тэр эргэн тойрноо харлаа. Жинни Уизли салхинд арзайсан үстэй номын сангийн ширээний өмнө зогсож байв. Ням гаригийн үдэш байлаа. Гермiona Гриффиндорын цамхаг руу эртний дайрлагын тухай уншихаар явж, Рон квиддичийн бэлтгэлдээ явжээ.

- Өө, сайн уу, Жинни. Чи яагаад бэлтгэл дээрээ биш байгаа юм бэ? гээд Харри номоо түлхлээ.

- Дуусчихсан. Рон Жек Слоуперыг эмнэлэгт хүргэхээр явсан.

- Яагаад?

- Бид ч гэсэн мэдэхгүй байна. Гэхдээ тэр цохиураараа өөрийгөө цохьсон бололтой. Тэр ч яахав ... Би сая илгээмж авлаа. Амбриж дөнгөж саяхан шалгаж дуусчээ.

Жинни ширээн дээр урагдсан цаасыг нямбайлан буцааж ороосон хүрэн хайрцаг тавив. Харри түүн дээр улаан бэхээр «Хогвартсын ерөнхий байцаагч шалгав» гэж бичсэнийг олж харлаа.

- Ээжийн улаан өндөгний баярын өндөг. Чамд ч гэсэн нэг байгаа ... Май аваарай.

Тэр дотроо жижигхэн снитчтэй сайхан чимэглэсэн шоколадан өндөг сунгав. Харри түүн рүү хартал гэнэтхэн айдаст автлаа.

- Чи зүгээр үү, Харри? гэж Жинни аяархан асуув.

- Тиймээ, бүгд гайхалтай гэж Харри сөөнгөтөн бувтнаад шүлсээ залгихад хоолой нь хөндүүрлэв. Тэр яагаад улаан өндөгний баярын өндөг тийм мэдрэмж төрүүлэхэд хүргэснийг ойлгосонгүй.

- Чи сүүлийн үед нэг л биш байгаа. Хэрвээ Чжоутай зүгээр л яриад үзвэл ...

- Надад Чжоутай ярих хэрэг байхгүй гэж Харри ширүүн хэлэв.

- Тэгвэл хэнтэй? гээд Жинни ойртон харлаа.

- Надад ...

Тэр ойр хавьд хүн байгаа эсэхийг шалгахын тулд ийш тийшээ харлаа. Хатагтай Пинс хэдэн тавиурын цаана зогсоод Ханна Абботод овоолсон ном уурсангүй өгч байв.

- Надад Сириустэй ярих хэрэг байна. Гэхдээ би үүнийг боломжгүй гэдгийг мэднэ л дээ хэмээн шивнэв.

Жинни түүнийг бодлогоширон харлаа. Тэр идэхийг хүсээгүй хэдий ч ямар нэг юм хийхийн тулд өндгөө задлан томоохон хэсгийг авч амандаа хийв.

- Хэрвээ чи үнэнээсээ Сириустэй ярилцахыг хүсч байвал бид үүнийг яаж хийх талаар бодож болох юм гэж Жинни яаралгүйхэн хэлээд өндөгнөөс хэсгийг хэлтлэв.

- Боль доо. Амбриж бүх ханан зуухыг хянаж, шуудангуудыг шалгаж байгаа!

гэж Харри баргар царайлан хэллээ.

- Хэрвээ хүн бүх амьдралдаа Фред, Жорж хоёртой амьдарсан бол энэ дэлхий

дээр зоригтой л бол юу ч хийх боломжтойг ойлгож эхэлдэг юм гэж Жинни бодлогоширонгуй хэлэв.

Харри түүн рүү харлаа. Магадгүй шоколад нөлөөлсөн ч байж болох юм. Люпин үргэлж түүнийг Дементортой тэмцсэний дараа зөвлөдөг байсан. Түүний сэтгэл санаа нь дээрдэж бүтэн долоо хоногийн турш дотроос зовоож байсан зүйлээ чанга хэлэх хүсэл төрөхөд найдлага төрөв.

- Чи юуны талаар бодоо вэ?

- Өө, чөтгөр гэж би мартчихаж гээд Жинни хөл дээрээ үсрэн босов.

Тэдэн рүү хатагтай Пинис агшин зуур хүрч ирэхэд үрчгэр царайд нь уур хилэн хуралджээ.

- Номын санд шоколад иднэ гэнээ! Эндээс даруйхан яв! гэж хашгирлаа.

Тэр саваагаа даллан Харрийн ном, бэхийг цүнхэнд нь хийгээд Жиннитэй хамт яаран гарч байгаа эзнийх нь араас нисгэлээ.

Амралт дуусахын өмнө Гриффиндорын цамхагт янз бүрийн мэргэжилтэн болох сурталчилгааны хуудсууд ширээн дээгүүр дүүрч самбар дээр зарлал өлгөгдөв.

МЭРГЭЖИЛ СОНГОХ ЗӨВӨЛГӨӨ

Тавдугаар дамжааны сурагч болгон зуны улирлын эхний долоо хоногт тэнхимийн эрхлэгчтэйгээ ирээдүйн мэргэжлийн тухай хийх богино ярилцлагад оролцох болно. Сурагч бүрд өдөр цагийг тусгайлан мэдэгдэнэ.

Харри өөрийн овогтой цаасыг аваад профессор МакГонагаллын өрөөнд даваа гаригийн хоёр хагаст очих ёстой болсноо тодруулав. Энэ нь мэргэ төлгийн хичээлийг алгасахад хүргэх байлаа. Улаан өндөгний баярын амралтын сүүлчийн долоо хоногт тэр бусад тавдугаар дамжааныхны хамт ихэнхи цагаа мэргэжлийн тухай мэдээллийг үзэж өнгөрүүлсэн билээ.

- Анагаагч болохыг хүсэхгүй байна гэж Рон хичээл эхлэхийн өмнөх үдэш мэдэгдэв. Тэр хавтсан дээрээ зөрөлдсөн шидэт саваа, яс бүхий сүлдтэй гэгээн Мунгогийн эмнэлэгийн танилцуулгыг барьжээ.

- Энд хэлэхдээ хамгийн багадаа уусмалын хичээл, ургамал судлал, хувиргал, шившлэг, хар урлагаас хамгаалах хичээл дээр сайн дүн авсан байх ёстой гэж байна. Миний бодлоор ... чөтгөр гэж ... тэд арай ихийг шаардаж байгаа юм биш үү?

- Гэхдээ энэ чинь хариуцлагатай ажил биз дээ? гэж Гермiona хэлэв.
- Тэр хурц ягаан шаргал өнгийн «МАГЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭСТ АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙНА УУ?» гэсэн хуудсыг уншиж байв.
- Маглуудтай харилцахад нэг их чадвар хэрэггүй бололтой. Ердөө зөвхөн магл судлалын С.И.Ш өгөх хэрэгтэй юм байна. «Бидэнд таны урам зориг, тэвчээр, сайн мэдрэмж чухал» гэнээ.
- Үүнийг сонс доо гээд Харри шидэт банкны товхимолыг авлаа. «Та амьдралаа аялал, осолтой адал явдал болон аюултай эрдэнэсийн дунд өнгөрүүлэх хүсч байна уу? Тэгвэл шидтэнгүүдийн банк Гринготтсд бичиг баримтаа илгээж шившлэг цуцлагчаар гадаадад ажиллах гялалзсан боломж байна». Тэдэнд шидэт тооны ухаан хэрэгтэй юм байна. Энэ чинийх биз дээ, Гермiona!
- Би банкны ажил хэрэг сонирхдоггүй гэж Гермiona хэлээд өөр танилцуулгыг авч «ГАЛ ТЭРГЭНД ХАМГААЛАЛТЫН САВДГУУДТАЙ АЖИЛЛАХ ХҮЧ БАЙНА УУ?» гэж уншив.
- Хөөе гэж хэн нэгэн Харрийн чихэнд хэллээ. Тэр эргэж хараад Фред, Жорж хоёрыг харав.
- Өчигдөр Жинни бидэнд чамайг Сириустэй үг солихыг хүсч байгаа гэж хэллээ гээд Фред хөлөө ширээн дээр тавихад хэд хэдэн ид шидийн яамны танилцуулга шалан дээр унав.
- Юу гэнээ? хэмээн Гермiona гартаа «ИД ШИДИЙН ГЭНЭТИЙН ОСОЛ ЗОЛГУЙ ЯВДЛЫН ХЭЛТЭС РҮҮ УТАСД» гэсэн танилцуулгыг бариад хөшлөө.
- Тиймээ. Саад болохгүй бол гэж Харри аль болох хайхрамжгүй хэлэв.
- Битгий инээдтэй юм яриад бай. Чи Амбриж бүх ханан зууханд хамраа шургуулж уулийн шууданг нэгжиж байгааг мэдэхгүй байна уу? гээд Гермiona нүдэндээ итгэсэнгүй бололтой харлаа.
- Бид үүнийг хийх арга олно гэж найдаж байна. Түүнийг ердөө жаахан сатааруулах хэрэгтэй ... Ингэхэд та нар бидний улаан өндөгний баярын амралтын үеэр биеэ даруухан авч явсныг ажигласан уу? хэмээн Жорж инээмсэглэв.
- Бидэнд чөлөөт цагаасаа үрэх ямар хэрэгтэй байгаа юм бэ гэж бодлоо. Мэдээж бид хүмүүсийг шалгалтанд бэлтгэхэд саад болохыг хүсээгүй л дээ! гэж Фред

дэмжив.

Тэр Гермiona руу гэгээн дүр эсгэсэн байртай багахан бөхийн ёслов. Тэр ийнхүү халамж тавьсан тавьсан явдалд балмагдан харлаа.

- Гэхдээ маргаашнаас ажил хэрэгтээ ахин орох болно. Бид Харриг Сириустай жаахан яриулахын тулд яагаад жаахан үймээн тарьж болохгүй гэж?

- Хэрвээ та нар Амбрижийг сатааруулж чадлаа гэхэд Харри түүнтэй хаана ярилцах юм? гэж Гермiona маш энгийн зүйлийг тэнэгүүдэд тайлбарлаж байгаа аятай хэлэв.

- Түүний өрөөнд гэж Харри аяархан хэлэв.

Тэр энэ тухай хоёр долоо хоногийн турш бодсон ч өөр арга олоогүй билээ. Амбриж өөрийн биеэр хяналтанд ороогүй цорын ганц ханын зуух түүний өрөөнд байгаа гэж хэлсэн билээ.

- Чи чинь галзуурчихаа юу? гэж Гермiona дуугарлаа. Рон танилцуулгыг орхиод тэдний яриаг анхааралтай чагналаа.

- Тэгж бодохгүй л байна гээд Харри мөрөө хавчлаа.

- Эхлээд чи тийшээ яаж орох юм бэ? Энэ асуултын хариу Харрид бэлхэн байлаа.

- Сириусын хутганы тусламжтай.

- Юу гэнээ?

- Өнгөрсөн зул сарын баяраар Сириус надад ямар ч цоожыг онгойлгодог хутга бэлэглэсэн. Хэрвээ тэр хаалгаа Алохомора үйлчлэхээргүй илбэдсэн бол болно гэдэгт би итгэлтэй байна.

- Харин чи энэ тухай юу бодож байна? гэж Гермiona Рonoос шаардангуй асуухад Харри Гриммогийн байшинд өнгөрүүлсэн анхны үдэш хатагтай Уизли ийм захирангуй өнгөөр нөхрөө дуудсаныг саналаа.

- Мэдэхгүй. Хэрвээ Харри оролдож үзэхийг хүсч байгаа бол түүний зөв байх гэж Рон хэлэв.

- Үнэнч найз Уизлийн үг байна гээд Фред Роны нуруун дээр нь алгадав.

- Тэгэхээр бид маргааш хичээлийн дараа бүгд хонгилд гарах үеэр хийсэн нь

дээр гэж бодож байна. Эхлээд ямар нэгэн аргаар Амбрижийг өрөөнөөс нь гарах хэрэгтэй. Харри бид чамд хорин минут өгье. Чи юу гэж бодож байна? гээд Жорж руу харлаа.

- Амархан гэж Жорж батлав.
- Та нар түүнийг юугаар саатуулах гэж байгаа юм? гэж Рон асуув.
- Хараарай дүү минь. Чамд зөвхөн Григорий Льстивогоийн хонгилд үдээс хойш таван цагт байхад болно гээд Фред, Жоржын хамт бослоо.

Маргааш өглөө нь Харри сэрээд ид шидийн яамны сонсголд дуудуулсан аятай зүйлийг мэдрэв. Түүнийг зөвхөн Амбрижийн өрөөнд орж ханан зууханд нь Сириустэй ярих явдал түгшээсэнгүй. Өнөөдөр Харри анх удаагаа Снегг өрөөнөөсөө хөөж гаргасан явдалд ойртох гэж байна.

Орондоо хэвтээд өмнөө хүлээж буй өдрийн тухай бодлогоширонгоо Харри аяархан босож Невиллийн орны дэргэдүүр өнгөрөн цонх руу явлаа. Сайхан өглөө байлаа. Тэнгэрт хөнгөхөн манан суунаглаж, цэнхэртэнэ. Харрийн эсрэг талд эцэг нь Снеггийг зовоож байсан мод байлаа. Тэр Сириусын юу гэж хэлэхийг мэдээгүй ч гэлээ гүн ухааны цүнхээлд харснаар бол загалмайлсан эцгээсээ үйл явдлыг зөөллөсөн үг юмуу эцгийнх нь гаргасан авирыг тайлбарлах үг сонсохыг тэсч ядан хүлээж байлаа ...

Тэгтэл ямар нэг зүйл Харрийн анхаарлыг татан Хориотой ойн цоорхойд хөдлөв. Харри нарны гэрэлд нүдээ анийлгаад Хагрид модны араас гарч ирэхийг харлаа. Тэр доголж байв. Харри түүнийг овоохойны хаалга хүрч дотогш орон алга болох хүртэл харав. Хэдэн хормын турш Харри овоохойг үргэлжлүүлэн харсаар байлаа. Хагрид тэндээс гарч ирээгүй ч яндангаас нь утаа гарснаас үзэхэд ойн сахиул галаа асааж чадахааргүй хүнд шархдаагүй бололтой.

Харри цонхноос эргээд чемодан руугаа очин хувцаслав.

Харри хууль бусаар Амбрижийн өрөөнд нэвтрэх гэж байгаа тухайгаа бодолгүй өдрийг тайван өнгөрүүлсэн ч Гермionaгийн ятгах оролдлогыг няцаахад амаргүй байв. Тэр ч байтугай профессор Бинс хүртэл түүний анхаарлыг татах хүчгүй мэт санагдана. Тэр ид шидийн түүх дээр тасралтгүй Харрийн чихэнд аймшигт анхааруулга шивнэсэн болохоор үүнийг тоохгүй байж чадсангүй.

- Хэрвээ тэр чамайг бариад авах юм бол зүгээр нэг сургуулиас хөөгөөд

зогсохгүй Нюлхалзтай ярьсныг чинь тааварлах болохоор Үнэнийг хэлүүлэгч уусмал өгөх үед миний үгийг санаарай ...

- Гермiona, Харри руу дайрахаа больж үз! Чи профессор Бинсийн яриаг сонсох юмуу эсвэл би өөрөө бичих юм уу? гэж Рон унтууцав.

- Чи өөрөө бичих юм бол үхчихгүй л байх!

Тэднийг газар дорхи хонгилд хүрэх үед Харри, Рон хоёр Гермionатай ярилцахаа болив. Гэхдээ энэ нь түүнд нөлөөлсөнгүй бөгөөд чимээгүй байгааг нь ашиглан өмнөхийн адил аймшигт таавруудаа хэлж чанга шивнэлт нь Симусыг тогоон дээрээ таван хормын турш саатахад хүргэв.

Снегг Харриг байхгүй мэт дүр эсгэхээр шийдсэн бололтой. Энэ нь Вернон ахын дуртай зүйл байсан тул Харри эртнээс үүнд дасал болсон болохоор өчүүхэн ч бухимдалгүй баяртайгаар хүлээж авлаа. Тэр ч байтугай эсрэгээрээ Снегг урьдын адил ёжтой шоолонгуй инээмсэглэхгүй болсон болохоор Харри түүний шинэ арга барилыг таатайгаар хүлээн авч уусмалаа төвлөрөн бэлдлээ. Хичээлийн эцэст тэр шилэн саванд уусмалаа хийгээд Снеггийн ширэн дээр шалгуулахаар орхихдоо сайн дүн авна гэдэгтээ итгэлтэй байлаа.

Түүнийг ширээнээс холдмогц ард нь юм хагарах чимээ гарлаа. Малфой баясан инээд алдав. Харри эргэж хартал түүний бэлтгэсэн уусмалын хагархай шалан дээр хэвтэж, Снегг сэтгэл ханамжтайгаар ширтэж байв.

- Ямар таагүй юм бэ. Ахин нэг тэг авч дээ, Поттер.

Харрийн уур хилэн дүрсхийв. Тэр тогоо руугаа очиж өөр шилэн сав дүүргэж Снеггэд шалгуулахаар өгөх гэсэн ч уусмал алга болжээ.

- Намайг уучлаарай! Намайг үнэхээр, уучлаарай, Харри! Би чамайг дууссан гэж бодоод бүгдийг цэвэрлэчихсэн! гэж Гермiona алгаараа амаа даран хэллээ.

Харри хариу хэлсэнгүй. Хонх дуугарх үед тэр газар дорхи хонгилоос дээшээ яаран гарч үдийн хоолны үеэр Невилл, Симус хоёрын дунд суугаад Гермionад чих рүүгээ үглэх боломж олгосонгүй.

Мэргэ төлгийн хичээл орох үеэр сэтгэл санаа тааруухан байсан тул профессор МакГонагаллын ажил мэргэжлийн уулзалтыг мартсан байснаа Рон түүнээс яагаад энд байгаа болохыг нь асуухад саналаа. Харри дээшээ гүйсэн ч хэдэн минут хожигджээ.

- Уучлаарай, профессор. Би мартчихаж гээд хаалга хаалаа.

- Зүгээр дээ, Поттер гэж тэр түргэн хэлэхэд буланд хэн нэгэн шуухитнах чимээ гарав. Тэр эргэж харлаа.

Профессор Амбриж тэмдэглэлийн дэвтрээ өвдөг дээрээ тавиад сэтгэл хангалуун инээмсэглэл тодруулан сууж байв.

- Суу, Поттер гэж профессор МакГонагалл хэлэв. Тэр ширээн дээрх товхимолуудаа засах үед гар нь үл мэдэг чичрэхийг Харри олж харлаа.

Харри нуруугаа Амбриж руу харуулан суугаад үзэг чахрах чимээг сонсоогүй дүр эсгэлээ.

- Ингэхээр, Поттер бид таны ажил мэргэжлийн сонголтонд чинь туслахаар уулзаж байна. Ямар хичээлийг зургаа, долдугаар дамжаандаа сонгон сурацах гэж байна. Таньд Хогвартсыг төгсөөд юу хийх талаар ямар нэг хувийн бодол байна уу?

- Э-э ... гэж Харри түгдрэв. Ард нь үзэг чахрах чимээ гарч түүнд бодлоо цуглуулахад саад боллоо.

- Тэгээд? гэж МакГонагалл түүнийг яаруулав.

- Юу гэхээр би мракоборец болвол дээр юм гэж бодлоо.

- Чамд үүнд өндөр оноо хэрэгтэй гээд МакГонагалл ширээн дээрх овоолттой цааснаас жижигхэн хар танилцуулга авч,

- Харж байна уу тэд таваас доошгүй «онц» дүн хамгийн багадаа бүгдэд «илүү найдлагатай» авсан байхыг хүлээж байна. Та мракоборецуудын төв байранд заавал зан чанар болон авъяас билгийн шалгалт өгөх ёстой. Энэ их хэцүү,

Поттер. Тэд хамгийн шилдгийг нь авдаг юм. Минийхээр бол сүүлчийн гурван жил тэд хэнийг ч аваагүй байх.

Профессор Амбриж сонсогдом ханиалгасан ч гэлээ үүнийгээ аяархан хийлээ. Профессор МакГонагалл түүнд анхаарал хандуулсангүй.

- Мэдээж та ямар хичээл сонгохыг мэдэхийг хүсч байгаа байх? гэж дуугаа чангаруулан хэлэв.

- Тиймээ. Хар урлагаас хамгаалах хичээл орно биз дээ?

- Тэгэлгүй яахав. Би ч гэсэн тэгж зөвлөх байна гэж МакГонагалл хатуу батлав.

Амбриж ахин ханиалгахдаа энэ удаа тод ханиалгалаа. МакГонагл агшин зуур нүдээ аньснаа нээгээд юу ч болоогүй юм шиг яриагаа үргэлжлүүлэв.

- Би бас хувиргалын хичээлийг авахыг зөвлөх байна. Учир нь олонхи мракоборецууд үргэлж ажилдаа хэрэглэх шаардлага гардаг юм. Дашрамд Поттер би ахлах дамжаанд өөрийн ангидаа С.И.Ш-ийн шалгалтанд «илүү найдлагатай» юмуу эсвэл илүү өндөр оноо хүлээж байгаагаа анхааруулах ёстой. Одоо миний бодлоор та дундаж оноотой байгаа болохоор хэрвээ энэ хичээлийг үргэлжлүүлэхийг хүсч байвал шалгалт хүртэл хөдөлмөрлөх хэрэгтэй. Дараа нь таньд шившлэгийн хичээл хэрэг болно. Түүнчлэн уусмалын хичээл ч ашигтай. Тиймээ, Поттер уусмалын хичээл гэж тэр давтаад инээмсэглэв.

- Мракоборец бүр хорны эсрэг уусмалыг сайн мэддэг байх ёстой. Ингэхэд профессор Снегг сурагчидаа сонгон авахдаа онц дүн авсаныг цуглуулж байгаа учир ...

Профессор Амбриж өмнөхөөсөө илүү чанга ханиалгалаа.

- Таньд ханиалгын дусаалга санал болгож болох уу, Долорес? гэж МакГонагалл Амбриж руу харалгүй хөндий хэлэв.

- Үгүй ээ, үгүй хэрэггүй, баярлалаа таньд гээд Амбриж худал инээмсэглэн,

- Би зөвхөн та нарын ярианаас жижиг зүйл ажигласнаа хэлж болох уу гэдгийг асуухыг хүссэн юм? гэв.

- Харваас би татгалзаагүй байна гэж МакГонагалл шүд зуун хэлэв.

- Надад ердөө ноён Поттерд мракоборец болох чадвар хангалттай байгаа эсэх нь сонирхолтой байна л даа.

- Юу гэнээ? Юу гэвэл Поттер хэрвээ та би таныг хувиргал болон уусмалын хичээлдээ төвлөрөхийг зөвлөх байна. Би сүүлчийн хоёр жил профессор Флитвик таньд «хангалттай», «илүү найдлагатай» дүн тавьж байсныг мэдэх болохоор шившлэгийн хувьд хангалттай гэж бодож байна. Хар урлагаас хамгаалах хичээлийн хувьд таны дундаж оноо хангалттай өндөр. Профессор Люпин бүр таныг ... Таньд үнэхээр ханиалганы дусаал хэрэггүй гэдэгт итгэлтэй байна уу, Долорес?

- Үгүй, үгүй баярлалаа таньд, Минерва гэж саяхан чанга ханиалгасан Амбриж худал инээн хэлээд,

- Намайг түгшээж байгаа нэг зүйл гэвэл Харрийн хар урлагаас хамгаалах хичээл дээр авсан сүүлчийн үнэлгээ байна л даа. Би түүнийг танд илгээсэн гэдэгтэй итгэлтэй байна гэв.

- Та үүгээрээ юу хэлэх гээ вэ? хэмээн МакГонагалл зэвүүцэн хэлээд Харрийн хавтсан дээр байгаа ягаан өнгийн цаасыг түлхэв. Тэр доошоо хөмсгөө өргөн харснаа хавтсыг буцааж тавилаа.

- Ингээд Поттер би дээр хэлсэнчлэн профессор Люпин таныг энэ урлагт авъяастай сурагч гэж боддог болохоор мракоборец болвол ...

- Та миний үгийг ойлгосонгүй юу, Минерва? гэж Амбриж ханиалгахаа мартан хэллээ.

- Мэдээж ойлгосон гэж МакГонагалл шүдээ хүчтэй зуун хэлэхэд зарим нь үг нь ойлгомжгүй боллоо.

- Тэгвэл би будилж ... Би таныг ноён Поттерт юуны учир хуурамч найдлага төрүүлж байгааг ойлгохгүй байгаа ч хэрвээ ...

- Хуурамч найдлага гэнээ? хэмээн МакГонагалл давтахдаа профессор Амбриж руу харсангүй. Тэр хар урлагаас хамгаалах хичээлийн бүх хяналтын ажилд өндөр үнэлгээ авч байсан ...

- Таныг эсэргүүцэхэд хэцүү байгаа ч миний захидлыг харсан бол Харри хичээл дээр маш бага үр дүн үзүүлж байгаа ...

- Тэгвэл би илүү тодорхой хэлэх хэрэгтэй болох нь гэж МакГонагалл хэлээд эцэст нь Амбрижийн нүд рүү эгцлэн харж,

- Тэр хар урлагаас хамгаалах хичээлийн бүх багш нараас өндөр оноо авч байсан болохоор эргэлзэх явдалгүй гэлээ.

Амбрижийн инээд чийдэн унтраах адил агшин зуур алга боллоо. Тэр сандлынхаа түшлэгийг налаад тэмдэглэлийн дэвтрийнхээ хуудсыг маш хурдтай эргүүлэв. Профессор МакГонагалл ахин Харри руу эргэж харахдаа хамар нь сарталзан, нүд нь хурцаар гялалзаж байв.

- Танд асуулт байна уу, Поттер?

- Тиймээ. Ид шидийн яамнаас ямар зан чанараар шалгалт авдаг юм бэ?

- Та дарамт эсэргүүцэх чадвартай гэдгээ цөхрөлтгүй шургуу батлах хэрэгтэй.

Мракоборец болох бэлтгэлээр ахин гурван жил хичээллэдэг болохоор хамгаалах дадлага сайн хийх хэрэгтэй. Энэ нь сургуулиас ч хэцүү ...

- Би таныг ид шидийн яамнаас мракоборецууд болох хүсэлтэй хүний өнгөрсөн амьдралыг сонирхдог гэдгийг харгалзан үзэх байх гэж бодож байна. Гэмт хэрэгт оролцож байсан талаарх гэж Амбриж хүйтнээр хэллээ.

- ... хэрвээ та Хогвартс төгссөний дараах шинэ шалгалт өгөхөд бэлэн биш бол өөр арга олсон нь дээр ...

- Тийм аргаар бол энэ хүүд мракоборец болох боломж Дамблдор сургуульд эргэн ирэхтэй адил байгаа.

- Тэгвэл хангалттай их юм байна гэж МакГонагалл хэлэв.

- Поттер шүүх дээр буртуутгагдаж байсан гэж Амбриж чанга хэлэв.

- Тэгээд бүх зүйлээр цагаатгагдсан гэж МакГонагалл илүү чанга хэлэв.

Профессор Амбриж бослоо.

- Поттерт мракоборец болох өчүүхэн төдий ч боломж байхгүй!

Профессор МакГонагалл ч гэсэн хөл дээрээ босоход энэ нь түүний зүгээс илүү сэтгэгдэл төрүүлэм зүйл боллоо. Тэр Амбрижийн дээр цамхаг шиг сүндэрлэв.

- Поттер би таньд энэ миний хийж чадах хамгийн сүүлчийн зүйл байсан ч гэлээ мракоборец болоход чинь тусална. Би таныг шаардлагатай үр дүнд хүрэх хүртэл шөнө бүр сургах болно!

- Ид шидийн яам Харри Поттерыг хэзээ ч ажилд авахгүй! гэж Амбриж уурсан хэлэв.

- Тэгвэл яаманд шинэ сайд томилогдохоор ажил олдох л болно доо! гэж МакГонагалл хашгирав.

- Аанхан! гэж Амбриж хашгираад бүдүүн хуруугаараа МакГонагалл руу чичиж,

- Энэ! Энэ л байхгүй юу! Тэгэлгүй яахав! Энэ л таны хүссэн зүйл биз дээ, Минерва МакГонагалл! Та Корнелиус Фажыг Альбус Дамблдороор солихыг хүсч байгаа! Тэгэхэд миний байр суурь оногдоно гэж бодож байгаа юм биш биз дээ? Сайдын нэгдүгээр зэргийн орлогч сургуулийн захирал болохыг мөрөөдөж байна уу!

гэв.

- Та дэмий зүйл ярьж байна гэж МакГоаналл хэлээд,

- Поттер манай ажил мэргэжлийн зөвөлгөөн дууссан гэж бодож болно гэлээ.

Харри цүнхээ мөрөн дээрээ тавиад өрөөнөөс яаран гарахдаа профессор Амбриж руу харсангүй. Тэр хонгилоор явахдаа тэдний бие бие рүүгээ хэрхэн хашгирахыг сонслоо.

Үдээс хойш нь профессор Амбриж хар урлагаас хамгаалах дээр ирэхдээ саяхан гүйсэн юм шиг амьсгаадаж байв.

- Чамайг хийх гэж байгаа зүйлээ ухамсарласан гэж найдаж байна, Харри.

Амбриж өнөөдөр ааш муутай байгаа бололтой гэж Гермiona шивнээд номныхоо гучин дөрөвдүгээр хуудсыг нээлээ.

Үе үе Амбриж Харри руу ууртайгаар хялалзахад толгойгоо өндийлгөлгүй

«Хамгаалах хичээлийн онол» номондоо шигдээд бодлогоширлоо ...

Тэр профессор МакГонагалл батлан дааснаас ердөө хэдхэн цагийн дараа Амбриж өрөөндөө барьж авбал юу хэлэхийг төсөөллөө ... гэхдээ эцсийн эцэст түүнийг зүгээр л Гриффиндорын цамхагт эргэн очоод зуны амралтаар Сириусаас гүн ухааны цүнхээлд харсан зүйлийн тухай асуухад юу ч саад болоогүй юм ... энэ хэдийгээр ухаалаг санаа хэдий ч дотор нь тугалга цутгасан мэт хүндэрэхийг мэдэрлээ ... харин Фред, Жорж хоёр Амбрижийг саатуулах аргаа хэдийн төлөвлөж, цүнхэнд нь Сириусын бэлэглсэн хутга болон эцгийнх нь хуучин үл үзэгдэх жанч бэлэн байлаа.

Гэвч баримт бол баримтаараа л үлдэнэ. Хэрвээ түүнийг барих юм бол ...

- Дамблдор чамайг сургуульд үлдээхийн тулд өөрийгөө золиослосон! Хэрвээ чамайг өнөөдөр хөөх юм бол энэ бүхэн ямар ч үр дүнгүй болно! гэж Гермiona номныхоо цаана нуугдан шивнэлээ.

Тэр төлөвлөгөөгөө өөрчилж эцэг нь хорин жилийн өмнө хийсэн зуны нэг сайхан өдрийн дурсамжтайгаар цаашид суралцаж болох ч ...

Тэгтэл Сириусын Гриффиндорын амралтын өрөөний ханан зууханд хэлсэн үгийг саналаа.

Чи эцэгтэйгээ миний бодсоноос ч бага төстэй юм ... Эцэг чинь эрсдэлд дуртай

байсан.

Гэхдээ тэр эцэгтэйгээ адилхан байхыг хүсч байна гэж үү?

- Харри үүнийг бүү хий! Гуйж байна бүү хий! гэж Гермiona хонх дуугарсан хойно цөхрөнгүй хэлэв.

Тэр хариулсангүй юу хийсэн нь дээрийг өөрөө ч мэдэхээ больжээ.

Рон харваас өөрийн зарчмаа баримтлахаар хатуу шийдсэн бололтой Харрид зөвлөгөө өгсөнгүй. Гэсэн хэдий ч Гермionaг ахин ам нээх үед аяархнаар,

- Чимээгүй байж үз! Түүнд өөрийн гэсэн бодол байгаа шүү дээ гэв. Тэднийг ангиас гарах үед Харрийн зүрх ердийнхөөс илүү хүчтэй цохилон.

Хонгилын дунд хүрэх үед алсад ихрүүдийн ажлаа эхэлсэн нь эргэлзээгүй чимээ шуугиан сонсогдлоо. Орилоон хашгираан дээр дуулдаж байв. Хүүхдүүд ангиасаа гараад хөшин сонсоцгоож адар руу болоомжлон харцгаав ...

Амбриж ангиас үсрэн гараад богинохон хөлний чадлаар хурдлан алга болов. Гүйх зуураа саваагаа гаргаж эсрэг зүг тийш чиглэхэд Харри одоо эсвэл хэзээ ч үгүй гэдгийг ойлголоо.

- Харри ... гуйж байна гэж Гермiona сулхан бувтнав.

Гэхдээ тэр хэдийн шийдвэр гаргажээ. Цүнхээ мөрөн дээгүүрээ тохоод сурагчдын эсрэг тал руу гүйлээ.

Амбрижын өрөө рүү ордог хонгилд хүрээд хоосон байхыг нь ажиглав. Тэр рыцарын хуягны цаана нуугдахад урдаас нь дуулга чахран эргэлээ. Харри цүнхээ нээн

Сириусын хутгыг гаргаж ирээд үл үзэгдэх цуваа нөмөрлөө. Дараа нь удаан бөгөөд болоомжтойгоор дуулганы цаанаас гарч чимээгүйхэн Амбрижийн өрөөнд ойртов.

Шидэт хутгаа цоожны нүхэнд шургуулаад зөөлнөөр дээш доош болгоод буцааж татав. Тэгтэл сулхан шархийх чимээ сонсогдоод хаалга нээгдэв. Тэр дотогш ороод түргэн хааж эргэн тойрноо харлаа.

Дотор ханан дээрх зэвүүн муурнуудаас өөр ямар ч хөдөлгөөн байсангүй.

Харри үл үзэгдэх цуваа тайлаад зуух руу очиж жижигхэн хайрцагтай нисдэг дарийг хайж оллоо.

Тэр хоосон зуухны өмнө өвдөглөв. Гар нь чичирч байлаа. Өмнө нь нэг удаа ч хийж

үзэж байгаагүй ч гэлээ ингэх хэрэгтэй гэдэгт итгэлтэй байв. Толгойгоо нүх рүү шургуулаад томоохон чимх дарь авч урдаа байгаа түлээн дээр хаяв. Дарь агшин зуур дүрсхийн маргад ногоон хурц дөл цацрав.

- Гриммогийн арван хоёр дугаар байшин! гэж Харри чанга тод хэлэв.

Энэ бол өмнө түүний туулж байсан хамгийн хачирхалтай мэдрэмж байв. Тэр өмнө нь нисдэг дарьны тусламжтай аялж байсан ч гэлээ тэр үед бүтэн биеэрээ орон даяар тархсан шидэт зуухны суваг дундуур нисэж байсан. Энэ удаад өвдөг нь Амбрижийн өрөөнд хүйтэн шалан дээр хэвээрээ зөвхөн толгой нь маргад ногоон дөлд нисэж байв

...

Гэнэтхэн нислэг эхэлсэн шигээ огцом зогсов. Дотор нь ялимгүй муухайрч толгойдоо хэтэрхий дулаан ороолт углачихсан гэмээр байлаа. Харри нүдээ нээхэд гал зуухны урт модон ширээний ард хүн сууж байв.

- Сириус!

Хүн давхийснээ эргэн тойрноо харав. Энэ бол Сириус байсангүй харин Люпин байлаа.

- Харри! Чи хаанаас ... юу болоо вэ зүгээр үү? гэж гайхан дуу алдав.

- Тиймээ. Би зүгээр л хүссэн юм ... надад Сириустэй ярих хэрэг байна.

- Би түүнийг дуудахъя гээд Люпин хөл дээрээ үсрэн босохдоо тэвдсэн байртай харагдав. Тэр дээр Кикимерийг эрж байгаа. Тэр ахиад л дээврийн хөндийд нуугдсан бололтой.

Люпин гал зуухнаас яаран гарлаа. Одоо Харри сандал ширээнээс ондоо зүйл харахгүй байв. Тэр Сириус яагаад ханан зуухнаас ярилцахад тухгүй байдаг талаар хэлээгүй явдалд гайхлаа. Өвдөг нь хатуу шалан дээр байгаа болохоор янгинана.

Хормын дараа Люпин эргэж ирэв. Түүний араас Сириус ирлээ.

- Юу болоо вэ? Чи зүгээр үү? Тусламж хэрэгтэй болоо юу? гэж тэр сэтгэл зовон асуугаад нүд рүүгээ унжсан урт хар үсээ холдуулж Харритай нэг түвшинд зуухны өмнөх шалан дээр суулаа. Люпин ч мөн өвдөглөн суухад харцанд нь түгшсэн шинж илрэв.

- Үгүй. Надад юу ч тохиолдоогүй ... Би зүгээр л эцгийнхээ тухай ... асуухыг хүссэн юм.

Сириус, Люпин хоёр бие биерүүгээ гайхан харахад Харрид алгуурлах хугацаа байсангүй. Агшин бүр өвдөг нь янгинаж өвдөх нь улам ихсэхийн дээр Жоржын өгсөн хорин минутаас тав нь хэдийн өнгөрөөд байлаа. Харри гүн ухааны цүнхээлд харсан зүйлээ шууд хэллээ.

Түүнийг яриагаа дуусгах үед Сириус, Люпин хоёр хэсэг зуур дуугүй болов. Дараа нь Люпин аяархан,

- Би чиний харсан зүйлийн төлөө эцгийг чинь хатуу шүүхгүй байсан. Тэр ердөө арван таван настай байсан шүү дээ гэлээ.

- Би ч гэсэн арван таван настай! гэж Харри хашгирлаа.

- Сонсооч Харри хэмээн Сириус аргадангуй дуугарав. Жеймс, Снегг хоёр анх уулзсан цагаасаа хойш бие биенээ үзэн яддаг болсоныг чи ойлгох хэрэгтэй. Би Жеймсэд Снеггийн хүссэн бүхэн байсан гэж бодож байна. Найз нөхөд нь хайрладаг, квиддич сайн толодог гээд л. Тиймээ түүнд бараг л бүх зүйл байсан. Харин Снегг бол хачин этгээд зантай Хар урлаг судлахын төлөө бүх сэтгэл зүрх нь явсан хүн байсан. Тэгэхэд Жеймс хар урлагыг үргэлж тэвчиж чаддаггүй байсан. Чи энэ тухай бодож үзээрэй, Харри.

- Тиймээ тэр миний нүдэн дээр Снеггийг ямар ч шалтгаангүй ... зөвхөн та уйтгарласан гэж гомдоллосны төлөө дайрсан.

- Надад бардах зүйл юу ч алга гэж Сириус түргэн хэлэв. Люпин түүн рүү хяламхийгээд,

- Сонсооч Харри чи нэг зүйл ойлгох ёстой. Сургуульд чиний эцэг, Сириус хоёр үргэлж шилдэг нь байсан болохоор бүх хүн тэднийг биширч ... энэ бүхэн толгойг нь эргүүлсэн байх л даа ... гэв.

- Биднийг заримдаа биеэ ихэрхэг авч явдаг байсан гэж хэлэх гээ юу хэмээн Сириус хэлэв. Люпин инээмсэглэв.

- Тэр үргэлж үсээ өрвийлгөөд байсан гэж Харри шаналангуй дуугарав. Сириус, Люпин хоёр инээлдлээ.

- Би түүний энэ зуршлыг мартчихаж гэж Сириус хэлэв.

- Снитчээр тоглож байсаныг нь харсан уу? гэж Люпин сониучирхав.

- Тиймээ гээд Харри тэдний юунд баяссан болохыг ойлголгүй харлаа.
 - Харин надад энэ нь жаахан тэнэг юм шиг харагдсан.
 - Мэдээж энэ тэнэг харагдсан! Бид нар тэр үед бүгд тэнэг байсан юм! гэж Сириус дуу алдснаа,
 - Солиот үүнд бага хамааралтай гэж үнэнээ хэлээд Люпин руу харлаа.
- Гэвч Люпин толгой сэгсэрлээ.
- Би хэзээ нэг үед та нарт Снеггийг тайван орхи гэж хэлж байсан удаа байна уу? Заримдаа л та нарыг хэтэрч байна гэж хэлдэг байсан.
 - Тийм шүү. Заримдаа чи биднийг нүүр улайхад хүргэдэг байсан ...
 - Бас тэр үргэлж нуурын эрэг дээр байгаа охин руу ширтэн түүнийг харна гэж найдаад байсан! гэж Харри хэлэв.
 - Өө, тэгэлгүй яахав тэр үргэлж Лили ойрхон байх үед биеэ илжиг шиг авч явдаг байсан юм! Тэр ойрхон л байх юм бол биеэ барьж чаддаггүй байсан! гээд Сириус мөрөө хавчлаа.
 - Тэр яагаад түүнтэй гэрлэсэн юм бол? Тэр түүнийг үзэн ядаж байсан шүү дээ! хэмээн Харри золгүй хоолойгоор дуугарлаа.
 - Тийм биш гэж Сириус хэллээ.
 - Тэр долдугаар дамжаанаас эхлэн түүнтэй зугаалж эхэлсэн гэж Люпин хэлэв.
 - Жеймсийг биеэ арай дээр авч явдаг болсны дараа гэж Сириус дэмжлээ.
 - Тэр хүмүүс рүү шившлэг илгээн зугаацахаа больсон юм гэж Люпин хэлэв.
 - Снеггийг ч гэсэн үү? гэж Харри асуув.
 - Юу гэвэл хэмээн Люпин булзан хэлээд,
 - Снегг бол онцгой тохиолдол байсан юм ... Тэр хэзээ ч Жеймсд шившлэг илгээх боломж алдаж байгаагүй гэлээ.
 - Ээж үүнтэй тайван эвлэрсэн хэрэг үү?
 - Үнэнийг хэлэхэд тэр энэ тухай хэтэрхий бага мэддэг байсан. Жеймс Снеггийг болзоон дээрээ шившлэг илгээх гэж урихгүй нь ойлгомжтой ...

Харри итгэсэнгүйд Сириус хөмсөг зангидав.

- Сонсооч надад хэзээ ч чиний эцэг шиг сайн найз байгаагүй. Тэр сайн хүн байсан юм. Арван таван насандаа олон тэнэг зүйл хийсэн гэлээ. Тэр өсөж том болсон.

- За яахав. Би зүгээр л Снеггийг өрөвдөхийг хүсэхгүй байна л даа гэж Харри баргар хэлэв.

- Ингэхэд Снегг чамайг энэ бүхнийг гүн ухааны цүнхээлд харсны дараа яасан бэ? гээд Люпины духан дээр хөнгөхөн үрчлээ үүсэв.

- Тэр намайг ахин хэзээ ч окклюменцийд сургахгүй гэж хэлсэн. Яг л миний хүсч ...

- Тэр яасан гэнээ? гэж Сириус чанга хашгирахад Харри цочсондоо ам дүүрэн үнс залгилчихлаа.

- Чи үнэнээсээ хэлж байн уу, Харри? Тэр чамд хичээл заахаа болио юу? гэж Люпин асуулаа.

- Аанхан. Гэхдээ зүгээр дээ надад хамаагүй. Үнэнийг хэлэхэд бүр санаа амарч байна гэж Харри тэдний үйлдэлд гайхширан хэллээ.

- Би явж Снеггтэй ярилцана гэж Сириус хатуу хэлээд босох гэсэн ч Люпин түүнийг даран суулгалаа.

- Хэрвээ хэн нэгэн Снеггтэй ярилцах ёстой гэвэл энэ нь би байх болно! Юуны түүрүүнд Харри чи Снеггэд эргэж очоод хичээлээ зогсоох эрх байхгүй гэж хэл. Хэрвээ Дамблдор энэ тухай мэдэх юм бол ...

- Би түүнд хэлж чадахгүй. Тэр намайг ална! Та нар түүнийг намайг гүн ухааны цүнхээлд нэвтэрсний дараа ямар байсныг харсан ч болоосой! гэж Харри уурсан хашгирлаа.

- Окклюменцийн хичээл үргэлжлэх ёстой, Харри. Үүнээс чухал юу ч байхгүй. Чи намайг ойлгов уу? Юу ч! гэж Люпин ширүүн дуугарлаа.

- За за гэж Харри хэлээд,

- Би оролдъё. .. ямар нэг зүйл хэлэхийг оролдъё ... зөвхөн ... гэв. Тэр чимээгүй болов. Алсад хөлийн чимээ сонсогдлоо.

- Кикимер шатаар ирж байна уу?
- Үгүй. Энэ чиний зүгээс л байх, Харри гэж Сириус хэлэв. Харрийн зүрх хүчтэй цохиллов.
- Тэгвэл би явсан нь дээр байх! гээд толгойгоо яаран Сириусын гал зуухны хана зуухнаас сугалан авлаа. Хэдэн хормын дараа толгой нь мөрөн дээрээ эргэн ирэхэд урьдын адил Амбрижийн ханан зуухын өмнө өвдөглөн зогссон хэвээр байх агаад маргад ногоон дөл сүүлчийн удаа өмнө нь дүрсхийв.
- Түргэлээрэй, түргэлээрэй! Аанхан, тэр түгжихээ мартчхаж гэх хэн нэгний хоолой хаалганы цаана сонсогдлоо.

Харри үл үзэгдэх цуваа дөнгөж нөмөрч амжтал өрөөнд Филч орж ирлээ. Тэр хагартлаа баярласан төрхтэй байв. Баяртайгаар бувтнан өрөөн дундуур явснаа Амбрижийн ширээний шургуулгыг онгойлгож эхлэв.

- Ташуурдах зөвшөөрөл ... ташуурдах зөвшөөрөл ... арайхийж би эцэст нь хүрлээ ... тэд одоо миний гарт байна ...

Тэр шургуулганаас хуудас цаас гарган үнсээд түргэн буцаж гарахдаа цээжиндээ наалаа.

Харри үсэрч босоод цүнхээ мартаагүй байгаа гэж шалгаад хөлөөсөө толгой хүртлээ үл үзэгдэх цуваа найдвартай нөмөрч хаалга онгойлгон Филчийн араас гараад хурдтай гүйлээ.

Дараагийн давхарт буугаад Харри одоо болгоомжлох зүйлгүй харагдаж болно гэж шийдэв. Тэр жанчаа тайлж цүнхэндээ буцааж хийгээд цаашаа яарав. Үүдний танхимын зүгээс чимээ шуугиан сонсогдож байв. Тэр гантиг шатаар гүйгээд арай л бүхэл сургууль цуглаагүйг харлаа.

Трелониг хөөж байсан үдшийн адил үзэгчид цугларчээ. Сурагчид хананы дагууд том дугуй үүсгэн зогссон байв. Цуглагсдын дунд багш нар болон хий үзэгдлүүд харагдана. Тэдний дунд Шалгалтын бүлгийнхэн сэтгэл хангалуун зогсож байлаа. Адрын доогуур Пивз хөвж Фред, Жорж хоёр танхимын голд буланд шахагдсан төрхтэй зогсож байв.

- Тэгэхээр! гэж Амбриж ёслолын байдалтай хэллээ. Харри сая л түүнийг хэдэн гишгүүрийн дор ихрүүдийн зүг харан зогссоныг ажиглав.

- Тэгэхээр! Та нар сургуулийн хонгилыг намаг болгон хувиргажээ. Хөгжилтэй байна уу?

- Маш хөгжилтэй хэмээн Фред өчүүхэн төдий ч айсан шинжгүй хэллээ.

Филч Амбриж руу ойртон очихдоо баярласандаа болоод арай л эхэр татан уйлсангүй.

- Надад бичиг баримт нь байна, захирлаа. Надад баримт нь байна ... ташуур бэлэн болсон ... Танаас гуйя, надад үүнийг шууд хийх зөвшөрөл олгооч гэж сөөнгөтөн хэлээд Харрийн нүдэн дээр ширээнээс авсан цаасаа даллав.

- Маш сайн байна, Аргус. Харин та хоёрын хувьд миний сургуулийн дүрэм зөрчвөл юу тохиолддог гэдгийг мэдэх ёстой хэмээн Амбриж Фред, Жорж хоёрыг харан хэллээ.

- Юу мэдэх ёстой гэнээ? Энэ чинь бүтэхгүй гэж айж байна гээд Фред ах руугаа эргэв.

- Жорж минийхээр бол бид бүрэн дүүрэн боловсрол олж авсан бололтой.

- Тиймээ надад ч гэсэн тийм мэдрэмж төрж байна гэж Жорж хөгжилтэй хэлэв.

- Жинхэнэ ертөнцөд өөрсдийнхөө авъяасыг сорьж үзэх үү? гэж Фред асуув.

- Зөвшөөрч байна.

Ингээд Амбрижийг үг хэлж амжихаас урьтаж тэд саваагаа өргөөд,

- Акцио, шүүр! гэж зэрэг хашгирлаа.

Харри алсад чанга тар нярхийх чимээ сонсов. Зүүн тийшээ эргэн харах агшинд Фред, Жорж хоёрын шүүр ар араасаа төмөр гадастай хүнд гинж чирсээр нисэн өнгөрч эзэд рүүгээ очив. Тэд зүүн тийшээ эргээд шатны өмнө ихрүүдийн урд тооромслон зогсоход гинж чулуун шалан дээр чанга хангинав.

- Дараа дахин уулзахгүй гэж найдъя гэж Фред профессор Амбрижад хэлээд хөлөө шүүрээ давуулав.

- Бидэнд захиа бичих хэрэггүй шүү хэмээн Жорж дэмжээд өөрийнхийгөө уналаа.

Фред чимээгүйхэн зогсож байсан сурагчид руу харлаа.

- Хэрвээ хэн нэгэн зөөврийн намаг худалдаж авахыг хүсвэл Тахир гудамжинд

байрлах ерөн гурав дугаартай «Уизличуудын бүх төрлийн шидэт эдлэл» дэлгүүр лүү очиход болно. Энэ бол бидний шинэ хаяг! гэж чанга хэлэв.

- Хогвартсын сурагчдад энэ хөгшин сарьсан багваахайнаас ангижрах бараа таваарыг авахад онцгой хямдрал үзүүлнэ гэдгээ амлаж байна хэмээн Жорж профессор Амбрижийг заан нэмэрлэв.

- Тэднийг бариарай! гэж Амбриж хашгирсан хэдий ч хожимджээ. Шалгалтын бүлэгийнхэн Фред, Жорж хоёрын зүг ухасхийхэд тэд шалнаас арван таван футын өндөрт төмөр гадсаа савчуулсаар хөөрөв. Фред өмнөө байгаа хий үзэгдэл рүү харлаа.

- Түүнд бидний өмнөөс үзүүлээд өгөөрэй, Пивз.

Харрийн ой ухаанд Пивз хэзээ ч сурагчын тушаал сонсож байгаагүй атал хонхтой малгайгаа аван мэндчилэхэд Фред, Жорж хоёр чанга алга ташилтан дор агаарт хагас тойрог хийгээд үүдний нээлттэй хаалгаар жаргаж буй нарны туяан дор нисэн гарлаа.

БҮЛЭГ 30: ГРОХХ

Дараагийн хэдэн өдрийн турш Фред, Жорж хоёрын чөлөөлөгдсөн түүх Хогвартсын түүхийн алтан фондод орсон нь Харрид ойлгомжтой болов. Хэдийгээр долоо хоног өнгөрсөн ч гэлээ үйл явдлыг өөрийн нүдээр харсан хүмүүс ихрүүдийн адил шүүрэндээ суугаад эхлээд Амбриж руу шивхэн бөмбөг хаяж дараа нь хаалгаар нисэн одох юмсан хэмээн ярилцдаг болж. Ихрүүдийн зугталтын дараа олон яриа хөөрөө үүссэний ихэнхи нь тэднийг дуурайх гэсэн хүмүүсийн томоохон давалгаа байлаа. Харри үргэлж сурагчдын «Үнэнийг хэлэхэд заримдаа шүүрэндээ үсрэн суугаад эндээс явах хүсэл ямар их төрж байна» гэх юмуу «Ахин нэг тийм хичээл орох юм бол би Уизлийн салах ёс хийх үзүүлбэрийг гүйцэтгэх болно доо» гэж хэлэхийг сонсож байлаа.

Фред, Жорж хоёр сургуульдаа удтал мартагдахгүйн тулд санаа тавьжээ. Нэгдүгээрт гэвэл тэд тавдугаар давхарын зүүн жигүүрийн хонгилд тарьсан намгаа яаж цэвэрлэх тухайгаа хэнд ч тайлбарласангүй. Амбриж, Филч хоёр янз бүрийн арга хэрэглэн оролдож үзсэн ч гэлээ үр дүнгүй болов. Эцсийн эцэст намгийг тойруулан олс татаад Филч сурагчдыг анги руу нь салаар зөөх болсондоо уурсан шүд зуув. Харри намгийг МакГонагалл юмуу Флитвик агшин зуур алга болгоно гэдэгт эргэлзсэнгүй ч ихрүүдийн галын наадмын адил тохиолдол болон тэд Амбрижийн зүтгэлийг харж суухыг эрхэмлэжээ.

Амбрижийн өрөөний хаалганд Фред, Жорж хоёрын «Зүлгэгч» шүүрний ормоор хоёр том нүх гарчээ. Филч хуучин хаалганы оронд шинийг тавьж Харрийн «Аянга»-ыг газар дорхи хонгилд зөөн оруулаад Амбриж зэвсэглэсэн савдгаар харгалзуулсан гэсэн цуу яриа таржээ. Гэхдээ үүгээр түүний асуудал дууссангүй.

Фред, Жорж хоёрын жишээгээр олон сурагчдын онгод орж Хогвартсын гол үймээн таригчын суудлыг эзлэхээр өрсөлдөв. Шинэ хаалгыг үл тоомсорлон хэн нэгэн Амбрижийн өрөөнд нюхлер оруулж тавьсан нь гялалзсан зүйл эрэн бүх тавилгыг хөрвүүлж Амбриж орж ирэх үед гар дээр нь үсэрч гараад бүдүүн хуруунаас нь бөгжийг хэмлэн сугалах гэжээ. Шивхэн бөмбөг, өмхий үрэл хоёр одоо хонгилд цаг үргэлж дэлбэрэх болсон бөгөөд сурагчид хичээлд орохын өмнө өөрийгөө хөөсөн толгойтой болгон хувиргаад энэ нь тэдэнд цэвэр агаар залгилахад тустай гэж баталж байлаа.

Филч ташуураа барин хонгилоор хэсүүлэн буруутанг барихыг хичээх авч тэд

хэтэрхий олуулаа учир хэн рүү түрүүлж дайрахаа мэдсэнгүй. Шалгалтын бүлгийнхэн түүнд туслахын хичээсэн ч гишүүдэд нь хачирхалтай зүйлс тохиолдов. Слизериний квиддичийн багийн тоглогч Уоррингтон эмнэлэг рүү эрдэнэ шившийн нэвс шиг үзэшгүй муухай арьстай болон илгээгджээ. Дараагийн өдөр нь Гермионаг баярлуулан Пэнси Паркинсон гэнэтхэн бугын эвэртэй болсны улмаас бүх хичээлийг алгасчээ.

Тэр үед Фред, Жорж хоёр Хогвартсыг орхихоос өмнө Ажлаас зайлсхийгч зууш олноор зарж амжсан нь тодорхой болов. Амбриж ангид орж ирэхтэй зэрэгцэн сурагчид ээлж дараалан дотор нь муухайрч, бөөлжин, аюултай халуурч хамраас нь цус гоожиж эхэлдэг байлаа. Уур хилэндээ хашгирсаар хүчгүй болсон тэрбээр нууцлаг шинж тэмдгийн учрыг олохоор хичээх авч сурагчид түүнд «Амбрижитан» гэдэг өвчин зовоож байна хэмээн шургуу баталж байв. Тэрбээр хичээлийн дараа дөрвөн анги үлдээх шийтгэл оногдуулсан хэдий ч цусаа гоожуулан, ухаан алдаж, хөлсөө гоожуулсан сурагчид түүний хичээлийг бөөн бөөнөөрөө орхиж байсан тул залхаан цээрлүүлэх ажлаасаа татгалзах хэрэг гарчээ.

Гэхдээ Ажлаас зайлсхийгч зууштай Пивзийн гаргаж буй үймээн шуугианыг харьцуулах аргагүй байлаа. Тэрхүү хий үзэгдлийн зүрхэнд Фредийн салах ёсны үг гүн туссан бололтой. Тэрбээр ухаангүй юм шиг хөхрөн сургууль дотуур нисэж ширээ хөмрөн, ангийн самбар эвдэж, баримал, ваар унаган хагалж, хоёр ч удаа хатагтай Норрисыг рыцарын хоосон дуулгаар хонгилд чулуудахад уурссан харуул гарган аварчээ. Пивз дэнлүү хагалж, лаа унтраан, галтай бамбараар айсан сурагчдын дээгүүр жонглёрдож, нямбай хураасан цаасыг гал руу юмуу цонхоор гарган чулуудаж, хоёр давхарын угаалгын өрөөний бүх цоргыг онгойлгон үер тавьж, цүнхэнд дүүргэсэн тэмээн аалз Их танхимд өглөөний цайны үеэр унаган, хэрвээ хүсэх аваас Амбрижын дээгүүр хөвөн явсан газар бүхэнд нь дагаж амаа ангайх тоолонд чанга эвгүй чимээ гаргадаг байв.

Филчийг эс тооцвол бол багш нарын хэн ч захиралд туслах гэж оролдсонгүй. Фред, Жорж хоёрыг сургуулиа орхисноос хойш долоо хоногийн дараа Харри өөрийн нүдээр профессор МакГонагалл болор лааны суурь суллахыг оролдож байгаа Пивзийн дэргэдүүр өнгөрөхдөө «Өөр талаас нь эргүүл!» гэж уруулаа нээлгүй гэж шивнэхийг харжээ.

Монтегю жорлонд зочлосноос хойш одоо хүртэл сэхээ ороогүй байлаа. Тэр

өмнөхийн адил ухаан самуурсан хэвээр байсан тул эцэг эх нь шилтгээний урд талын замаар ууртай алхан ирж харагджээ.

- Тэр ямар нэг юм хэлэх болов уу? Юу болсон тухайгаа? Хатагтай Помфри түүнийг эмчилчихвэл яах вэ? хэмээн ноён ба хатагтай Монтегю дотогш орохыг харахын тулд хацраа шившлэгийн ангийн цонхонд хацраа наан зогссон Гермиона түгшингүй хэлэв.

- Сайжрахгүй байх гэж Рон хайхрамжгүй дуугарав.

- Ямар ч тохиолдолд Амбрижад л асуудал үүснэ биз дээ? гэж Харри баяртай хэлэв.

Рон тэр хоёр саваагаараа аяга зэрэг цохилоо. Харрийн аяга дөрвөн ширхэг богинохон хөл болж утга учиргүй агаарт мушгиралдав. Харин Роны аяга урт нарийхан хөл дээрээ хүндхэн тэнцэж босон ирснээ чичигнэн унахад хоёр хэсэг болон хагарав.

- Репаро гэж Гермиона түргэн хэлээд саваагаа даллахад Роны аяга бүтэн болов. Хэрвээ Монтегюгийн ухаан үүрд ийм байвал гайхамшигтай л юм?

- Хэнд хамаатай юм бэ? гэж Рон уурсан хэлэхэд аяга нь ахин өндийхийг оролдон согтуу юм шиг ганхлаа.

- Монтегю Гриффиндороос оноо хасах гэж оролдоогүй бол тэгэхгүй байсан юм! Хэрвээ чамд санаа зовох өөр юм байхгүй юм бол надад зовсон чинь дээр!

- Чамд уу? Би чамд яагаад санаа зовох ёстой юм бэ? гээд Гермиона дөрвөн хөлөөрөө хөгжилтэй дэвхэрч байсан аягаа авч урдаа тавилаа.

- Ээжээс захиа ирэх үед надад ч таагүй зүйл болно доо. Хэрвээ түүнийг ахин аянгын мэдээ илгээвэл гайхах зүйл алга гэж Рон гашуунаар хэлээд аягаа нарийхан хөл дээрээ тэнцэн зогсоход туслав.

- Гэхдээ ...

- Харж л байгаарай. Фред, Жорж хоёрыг зугтсанд намайг буруутгаж таарна.

Тэр намайг зогсоох ёстой байсан. Тэдний шүүрээс зуурч нисгэхгүй байсан ч юмуу эсвэл өөр юу гэхийг нь мэдэх юм алга ... товчхон хэлэхэд энэ бүхэн миний буруу байх болно.

- Хэрвээ үнэхээр тэгж хэлвэл шударга бус хэрэг байна шүү дээ. Чи юу ч хийгээгүй биз дээ! Гэхдээ түүнийг чамд юу ч хэлэхгүй гэдэгт итгэлтэй байна. Тэд

Тахир гудамжинд байшин түрээслэсэн бол очихоо эртнээс төлөвлөсөн байж таарна.

- Тэгэхэд хүрвэл тэд яаж энэ байшинг авсан бэ гэдэг бас нэг асуудал гарч ирнэ гээд Рон саваагаараа аягыг хүчтэй цохиход унаад сарвалзлаа. Энэ ч тийм жирийн зүйл биш дээ? Тахир гудамжинд байшин түрээслэхэд их мөнгө хэрэгтэй. Ээж тэднийг хаанаас мөнгөтэй болсныг мэдэхийг хүсч л таарна.

- Энэ ч гэсэн миний толгойд орсон. Наземникус тэднийг хулгайлсан зүйл заруулахаар ятгасан юмуу эсвэл өөр аймшигтай зүйл санал болгосон бол яана гээд Гермiona хэлээд Харрийн агаарт сарвалзах богинохон бүдүүн хөлтэй аягыг тойрон гүйж буй өөрийнхийгөө барьж авлаа.

- Огтхон ч тийм биш гэж Харри хэлэв.

- Чи хаанаас мэдэж байгаа юм ? гэж Рон, Гермiona хоёр зэрэг асуулаа.

- Учир нь ... гээд Харри эргэлзсэнээ үнэнээ хэлэх цаг боллоо гэж шийджээ. Тэд Фред, Жорж хоёыг гэмт хэрэгтэн гэж сэжиглэж байхад чимээгүй байж болохгүй байлаа.

- Тэд надаас алт авсан юм. Өнгөрсөн зургаан сард би тэдэнд Гурван шидтэний тэмцээнээс хожсон алтаа өгсөн.

Найзууд нь гайхширан чимээгүй болов. Тэгтэл Гермionaгийн аяга ширээний өнцөг рүү гүйж шалан дээр унаад бут үсрэв.

- Байж боломгүй юм! гэж Гермiona уулга алдав.

- Болно! Би үүндээ харамсахгүй байна! Миний мөнгө хэн нэгэнд байснаас тэдэнд байвал шидэт тоглоомын сайн дэлгүүр болно гэж Харри эсэргүүцлээ.

- Гэхдээ энэ чинь сайн хэрэг байна шүү дээ! гэж Рон бахдан хэлээд,

- Тэгэхээр чи үүнд буруутай бол ээж намайг зэмлэж чадахгүй! Намайг түүнд хэлвэл эсэргүүцэхгүй биз дээ? гэв.

- Хэлсэн нь дээр байх. Ялангуяа тэднийг хулгайн тогоо худалдаж авсан гэж бодож эхэлвэл хэмээн Харри баргар өгүүлэв.

Гермiona хичээлийн төгсгөл хүртэл юу ч хэлсэнгүй ч түүний тэвчээр удаан үргэлжлэхгүй гэдэгт Харри эргэлзсэнгүй. Тэгтэл ч үнэхээр тэднийг шилтгээнээс таван сарын дулаан наранд гармагц Харри руу ширтэн ээлжит амаа нээлээ.

Харри түүнд ярих боломж өгсөнгүй.

- Намайг сургах хэрэггүй. Хийсэн бол хийсэн. Фред, Жорж хоёр мөнгийг авсан болохоор ихэнхийг нь үрсэн байж таарна. Буцааж өгсөн ч би авахыг хүсэхгүй байна. Тиймээс бүү үглэж эхлээрэй дээ, Гермiona.

- Би Фред, Жорж хоёрын талаар юу ч ярих гээгүй байна!

Рон итгэлгүйхэн дуу алдахад Гермiona түүнийг уурссан харцаар шагналаа.

- Тиймээ, би тэгэх гээгүй байна. Би ердөө л Харриг Снеггтэй окклюменцийн хичээлээ үргэлжлүүлэх талаар ярилцах эсэхийг нь асуух гэсэн юм.

Харрийн дотор палхийв. Хэдэн өдрийн өмнө Фред, Жорж хоёрын зугталтын тухай сэдэв хуучрах үед Рон, Гермiona хоёр Сирусын тухай шинэ зүйл мэдэхийг хүсчээ. Харри тэднээс Сирустэй ярилцах болсон гол зорилгоо нууж байсан учир юу хэлэх тухайгаа бодоход хэцүү байв. Эцсийн эцэст Сириус түүнд окклюменцийн хичээлээ үргэлжлүүлэхийг даалгасан гэдэг үнэнийг хэлжээ. Тэгээд үүндээ харамсаж амжаагүй байтал Гермiona Харрийн бүхнээс хүлээгээгүй зүйлд хандлаа.

- Чи хар дарсан зүүд зүүдлэхээ больсон гэж бүү худал хэл. Рон чамайг өнгөрсөн шөнө зүүдэндээ яриад байсан гэсэн!

Харри Рон руу уурсан харав. Түүний найз нь ичин улайжээ.

- Чи жаахан л ярьсан. Би зөвхөн «Алив л дээ, ахиад жаахан!» гэсэн үгийг сонссон гэж уучлал гуйсан байртай хэлэв.

- Би чамайг квиддич тоглож байна гэж зүүдлэсэн юм. Би чамайг жаахан сунаад квоффлд хүрээсэй гэж хашгирсан хэмээн Харри бүдүүлгээр худал хэлэв.

Роны чих улайхад Харри сэтгэл ханамжыг мэдэрлээ. Мэдээж тэр ийм зүйл зүүдлээгүй. Өнгөрсөн шөнө ахин нууцын хэлтсээр зугаалж дугуй өрөөнд ороод тавиур дээрээ тоостой шилэн бөмбөлөг бүхий танхимаар явсан юм.

Тэр ерөн долдугаар эгнээнд хүрч зүүн тийш эргээд тавиурын дагуу явлаа ... Магадгүй энэ үедээ л «ахиад жаахан» чанга хэлсэн байх ... учир нь тэр сэрэхийг хүсэхгүй байгаага мэдэрчээ ... тэгээд эгнээний төгсгөлд хүрч амжаагүй байтал ахин орон дээрээ адар харан хэвтэж байлаа.

- Гэхдээ чи оюун ухаанаа хаахыг хичээж байгаа биз дээ? Чи окклюменцийг ашиглаж байгаа юу? гэж Гермiona шаардангуй асуулаа.

- Тэгэлгүй яахав гээд Харри гомдонгуй дуугарахыг оролдоод өөр тийш харлаа.

Гэвч үнэндээ тоостой шилэн бөмбөлөг бүхий өрөөнд юу нуугдаж байгааг мэдэхийг хүсч байсан учир хориотой зүүдээ үргэлжлээсэй гэж бодож байв.

Хамгийн гол асуудал гэвэл шалгалт хүрэхэд сарын хугацаа үлдсэн явдал саад болж байсан бөгөөд түүний толгой мэдээлээр дүүрэн нойр нь хүрэхгүй удтал хэвтэж эцэст нь арайхийн нойрсох үедээ тархи нь зөвхөн шалгалттай холбоотой дүр зургаар дүүрдэг байв. Заримдаа хар хаалганы өмнө хүрмэгц оюун ухаанд нь Гермionaгийн хоолойтой адил дуу дуулдахад гэмших сэтгэл төрж зорилгодоо хүрч чадалгүй аялалаа дуусгаж байлаа.

- Мэдэж байна уу, хэрвээ Монтегю Слизерин Пуффендуйн эсрэг тэмцээн дээр ирэхгүй бол бидэнд цомыг хожих боломж байна гэж чих нь улайсан Рон хэлэв.

- Тийм шүү гэж Харри сэдэв өөрчлөгдсөнд сайшаан хэллээ.

- Бид нэг удаа хожиж, ганц удаа хожигдсон. Хэрвээ ирэх хагас сайнд Пуффендуйнхан Слизеринчүүдийг хожвол ...

- Тийм шүү зүйтэй гэж Харри юу хэлж байгаагаа мэдэлгүй зөвшөөрлөө.

Дөнгөж сая Чжоу Чанг түүний хажуугаар харалгүй явж өнгөрчээ.

Таван сарын сүүлчийн долоо хоногт болох улирлын сүүлчийн тэмцээн дээр Гриффиндор Когтевраны эсрэг тоглох байлаа. Хэдийгээр Пуффендуйнхан Слизеринийг багахан оноогоор хожсон ч гэлээ Гриффиндорынхон ялалтанд нэг их найдсангүй. Ялангуяа Роны өнгөрсөн тэмцээнд тааруу тоглосон явдал хаалгачын дээд амжилтыг эвджээ. Гэвч тэр өөдрөг үзэлтэй байлаа.

- Би яаж ч бодсон өмнөхөөсөө муудахгүй нь ойлгомжтой. Надад алдах юм алга гэж тэмцээний өдрийн өглөөний цайны үеэр Харри, Гермiona хоёрт хэлэв.

- Минийхээр бол Фред, Жорж хоёр байхгүй болсон нь Ронд арай дээр байх шигээ. Тэд хэзээ ч түүнд жинхэнээсээ итгэж байгаагүй гэж Гермiona Харрид талбай руу хөөрөн шуугьсан хөгжөөн дэмжигчдийн хамт явж байхдаа хэлэв.

Тэднийг малгай дээрээ амьд бүргэд суулгасан Полумна Лавгуд гүйцэв.

- Чөтгөр гэж бүр мартчихаж! Чжоу өнөөдөр бас тоглоно биз дээ? хэмээн Гермiona Полумнаг бүргэдийнхээ далавчыг дэвүүлсээр хуруугаараа заан инээлдэх Слизеринчүүд дундуур өнгөрөхийг харан хэллээ.

Харри үүнийг мартаагүй тул зөвшөөрсөн үг бувтналаа.

Тэд үзэгчдийн суудлын хамгийн дээд талын эгнээнд суулаа. Цэлмэг сайхан өдөр байв. Ронд үүнээс дээрийг хүсч чадахгүй гэлээ ч Харри өнөөдөр анд нь Слизеринийхэнд шоолон дуулуулах боломж өгөхгүй байх гэж найджээ.

Үргэлж байдаг шигээ тайлбарлагчын суудлыг ихрүүдийн явалтын дараа сэтгэлээр унасан Ли Жордан эзлэв. Багийнхан талбай дээгүүр гарч ирэхэд тэр тоглогчдыг нэрлэнгээ хоолойд нь байдаг амьд өнгө сонсогдсонгүй.

- Брэдли ... Дэвис ... Чанг ...

Харри талбай дээр гялалзсан хар үсээ сэвшээ салхинд намируулан явж буй Чжоуг харав. Тэр юу хүсч байгаагаа ойлгоогүй ч дотор нь эвгүй боллоо. Тэр ч байтугай Чжоу шүүрэндээ суухаар бэлтгэх зуураа Рожер Дэвистэй хэрхэн ярилцахыг харахдаа үл ялиг хардах сэтгэл төржээ.

- Ингээд тэмцээн эхэллээ! Дэвис даруйхан квоффлыг эзэмшлээ ... квоффл Когтевраны ахмад Дэвист байна. Тэр Жонсоныг хуураад, Беллээс бултаж, дараа нь Спиннетийг ардаа орхилоо ... тэр хаалга руу зүглэж байна! Оноо авлаа ... гэж Ли чанга мэдэгдэв.

Харри, Гермона хоёр Гриффиндорынхны хамт дуу алдан ёолов. Урьдаас тааварласан ёсоор Слизеринийхэн эсрэг талын суудал дээр дур гутам дуугаа хэлэв.

Квоффлыг Рон барьж чадахгүй

Ялахад тэр бидэнд туслана

- Харри. Гермона ... гэх сөөнгө дуу чихний ард сонсогдлоо.

Тэр эргэж хараад Хагридын сахалтай нүүрийг харав. Тэр нэг хоёр дугаар дамжааныхан суусан эгнээний араар чихцэлдэн зүтгэжээ. Ямар нэг шалтгааны улмаас тэрбээр нугларан бөхийсөн ч гэлээ өмнөхийн адил бүгдээс дөрвөн фут өндөр байлаа.

- Сонсооч та нар надтай явж чадахгүй биз? Яг одоо. Бүгдийг тэмцээн үзэж байхад? гэж шивнэв.

- Э-э ... хүлээж болохгүй юу, Хагрид? Тэмцээний төгсөл хүртэл? гэж Харри асуув.

- Үгүй. Үгүй, Харри үүнийг одоо хийх ёстой ... бүгд өөр тийш харж байхад ... гуйж байна?

Хагридын хамар дээр цусны толбо тогтжээ. Хоёр нүд нь харлан харагдана. Ойн сахиулыг сургуульд ирснээс хойш Харри нэг ч удаа ийм ойроос харж байсангүй. Хагрид ихээхэн золгүй харагдав.

- Тэгэлгүй яахав. Явцгаая.

Тэд Германоангийн хамтаар дургүйцэн үглэх сурагчдын дундуур зүтгэлэн явлаа.

- Би та хоёр их талархаж байна, найзууд минь үнэн шүү гэж Хагрид шатаар буухдаа хэлэв. Тэр зүлгэн дээр буух үед түгшин ийш тийшээ харлаа.

- Түүнийг бидний явсаныг ажиглаагүй байх гэж найдаж байна.

- Амбрижыг хэлж байна уу? Тэр юу ч ажиглаагүй. Чи түүнийг Шалгалтын бүлгэмийнхэнтэйгээ хамт сууж байгааг байсныг хараагүй юм уу? Магадгүй тэмцээн дээр асуудал гарахаас айсан биз.

- Хэрвээ багахан асуудал гарвал гэмгүйсэн гээд Хагрид үзэгчдийн суудал болон овоохойн дунд хоосон байгаа эсэхийг шалган харав. Бидэнд хугацаа хэрэг болно ...

- Юу болоо вэ, Хагрид? гээд Гермона санаа тавин харлаа. Тэд хэдийн Хориотой ойн цоорхой руу явж байв.

- Жаахан хүлээчихвэл удахгүй харна гээд Хагрид хөгжөөн дэмжигчдийн чанга шуугиан сонсогдсон цэнгэлдэх хүрээлэнгийн зүг эргэн харснаа,

- Хэн нэгэн оноо оруулсан юм болов уу? гэв.

- Когтевран л байх гэж Харри урамгүйхэн хэлэв.

- Тэгвэл ч. Сайн хэрэг дээ гэж Хагрид уйман дуугарлаа.

Хагрид түргэн явж алхаагаа түргэсгэхэд тэд гүйцэхийн тулд гүйх хэрэг гарав. Овоохойд хүрэхэд Гермона хаалганы зүг өөрийн мэдэлгүй эргэв. Гэвч Хагрид цаашаа ойн зах руу нум сумаа аван явав. Хүүхдүүдийг саатсаныг хараад эргэж харлаа.

- Бид тийшээ явна гээд сэгсгэр толгойгоо мододын зүг дохив.

- Ой руу юу? гэж Гермона тэвдэнгүй асуув.

- Тиймээ. Алив ээ, түргэлээрэй.

Харри, Гермона хоёр бие бие рүүгээ харснаа нум сум мөрөндөө үүрсэн Хагридын араас явахад ногоон униарт хэдийн далд орж байлаа. Харри, Гермона хоёр түүний

араас гүйцэв.

- Хагрид чамд яагаад зэвсэг хэрэгтэй юм бэ? гэж Харри асуув.
- Урьдчилан сэргийлэх зорилгоор хэмээн Хагрид нүсэр мөрөө хавчлаа.
- Чи бидэнд фестралуудыг үзүүлэхдээ нум сум авч яваагүй гэж Гермiona айсан байртай хэлэв.
- Тэгэхэд бид алс яваагүй. Тэгээд ч Флоренц ойгоос явахаас өмнөх үеийнх шүү дээ.
- Энд Флоренц ямар хамаатай юм бэ? гэж Гермiona сониучирхав.
- Учир нь бусад хүн морьд надад үүнээс болж уурсаж байгаа гэж Хагрид аяархан хэлээд ийш тийшээ харав. Тэд урьд нь ч нэг их нөхөрсөг биш байсан л даа. Би тэдэнтэй хэдэн үг сольж болдог байлаа. Харин одоо бол үгүй.

Тэр хүндээр санаа алдав.

- Флоренц надад тэднийг Дамблдорд ажиллахаар зөвшөөрсөн учир уурласан гэж хэлсэн хэмээн Харри тайлбарлаад Хагридын царайг анхааралтай ширтэв.
- Тэгсэн гэж Хагрид барайн батлаад,
- Уурласан гэж харин ч зөөлхөн хэллээ. Үнэндээ бол галзууртлаа догширсон.

Хэрвээ би оролцоогүй бол түүнийг алах байлаа ... гэв.

- Тэд түүн рүү дайрсан юм уу? хэмээн Гермiona гайхширлаа.
- Тиймээ. Сүргээс багагүй гэж Хагрид сөөнгөтөөд замаасаа хэдэн мөчир зайлуулав.
- Чи тэднийг зогсоосон хэрэг үү? Ганцаараа юу? гэж Харри гайхаж бахдах зэрэгцэн хэлэв.

- Тэгэлгүй яахав. Би түүнийг алуулахыг зогсоод харах байсан гэж үү!
- Дэргэдүүр нь өнгөрч байсан нь сайн хэрэг ... Флоренц энэ тухай санасан бол надад элдэв тэнэг анхааруулга илгээхгүй байсан даа! гэж гэнэтхэн уурсан нэмэрлэв.

Хагридын энэ сэдвийг сөхсөн явдалд Харри, Гермiona хоёр бие бие рүүгээ гайхан харлаа.

- Юутай ч атугай одоо бусад хүн морьд надад шүд зууж байгаа. Гай нь гэвэл

ойд тэд их нөлөөтэй юм ... хамгийн ухаантай амьтан нь.

- Ийм учраас чи биднийг энд авчирсан хэрэг үү, Хагрид? Хүн морьд руу юу? гэж Гермиона асуулаа.

- Үгүй ээ, тэд энд ямар ч хамаагүй. Гэхдээ тэд асуудал үүсгэж чадна ... удахгүй юу болохыг нь харна аа гээд Хагрид толгой сэгсэрлээ.

Энэ нууцлаг үгийнхээ дараа тэр чимээгүй болж дуугүй алхав. Хагрид алхам бүрдээ тэднийг гурав алхахад хүргэж байсан бөгөөд энэ нь багагүй хүндхэн байлаа.

Тэдний явж байсан замыг модод шахан хүрээлж цаашлах тусам өдрийн гэрэл навчсын завсар арай ядан нэвтэрч харанхуйлав. Удалгүй тэдэнд фестралуудыг үзүүлж байсан ойн цоорхой хол хоцорсон ч Харри ширэнгэ рүү эргээгүй явдалд түгшсэнгүй. Тэд ойн хамгийн гүнд хүрэх замаар явж байгаа бололтой.

- Хагрид! Бид хаашаа явж байгаа юм бэ? гээд Харри арай ядан ширэлдсэн бөөрөлзгөний бутны дундуур гарах зуураа өнгөрсөн удаа Хориотой ойн зам дээр үлдэх үед юу болсныг санаад хэллээ.

- Жаахан цаашилна. Алив ээ, Харри ... бие хамтдаа байх ёстой шүү.

Шивээлсэн мододын дундуур гарахад Хагридын дэргэд байх ихэд амаргүй байлаа. Ойн сахиул тэдэнд аалзны шүлснээс илүү анхаарал хандуулсангүй тул Харри, Гермиона хоёр цаг үргэлж мөчирт орооцолдон жанчаа салгаж авахын тулд зулгаан татаж байв. Төдхөн Харрийн хөл, гар хөнгөхөн зүсэгдэж маажигдав. Тэд ойн гүнд орсон учир Харри зөвхөн өмнөө байх Хагридын том хар дүрсийг ялган харж байв. Жижигхэн мөчир хугарах, бут сэрчигнэх тэр ч байтугай шувуу дэрхийн нисэхэд Харри бүрэнхий руу болгоомжлон харж байлаа. Тэр гэнэтхэн ойн гүнд амьд амьтантай тааралдалгүй ийм хол явж байгаагүйгээ санаад муу совин татав.

- Бид саваагаараа гэрэлтүүлж болох уу, Хагрид? гэж Гермиона аяархан асуув.

- Э-э ... тэгсэн нь дээр байх.

Тэр гэнэтхэн зогсоод эргэлээ. Гермона түүнийг мөргөөд арай л унасангүй. Харри цагаа олж барьж авлаа.

- Жаахан зогссон нь дээр байх шиг байна. Бид очих газартаа хүрээгүй л байна.

- Сайн байна! гээд Гермиона Харрийн хамт Люмос! гэж бувтнахад савааны үзүүрээс гэрэл гялсхийв. Харанхуйд Хагридын царай дээр чичирсэн цацраг тусахад

Харри түгшсэн гунигтай болохыг нь ажиглав.

- Юу гэвэл ... Бүх зүйл юу болохыг ... ойлгож байна уу ... Тэр чимээтэй амьсгалав.

- Ерөнхийдөө өнөөдөр биш ч би маргааш ажлаасаа халагдана. Харри, Гермiona хоёр бие бие рүүгээ харснаа түүн рүү харлаа.

- Гэхдээ чамайг одоо хүртэл хөөгөөгүй байгаа. Чи яагаад тэгж бодсон юм ... гэж Гермiona болгоомжлон дуугарлаа.

- Амбриж намайг өрөөндөө нюхлер оруулсан гэж бодож байгаа юм.

- Чи биш биз дээ? гэж Харри дуу алдав.

- Мэдээж биш! Зүгээр л шидэт амьтан л бол тэр шууд миний хийсэн хэрэг гэж бодож байгаа. Та нар намайг эргэж ирснээс хойш түүнийг хөөх боломж хүлээж байгаа гэдгийг мэднэ. Би явахыг хүсэхгүй байгаа ч ... сургуулийнхны нүдэн дээр Трелони шиг хөөгдсөнөөс өөрөө явсан нь дээр гэж бодож байна.

Харри, Гермiona хоёр эсэргүүцэх гэсэн ч Хагрид том гараа даллан болиулав.

- Энэ ямар ертөнцийн төгсгөл биш дээ. Би сургуульд Дамблдорт туслахгүй болсноос хойш бүлэгт ямар ч ашиггүй болсон ... Харин та нарыг Граббл-Дерг авах болно ... шалгалтыг чинь өгүүлнэ гээд хоолой нь чичирснээ,

- Санаа зовох хэрэггүй дээ гэж Гермiona гарыг нь илэхээр ухасхийхэд хэлээд хантаазнаасаа том ноосон алчуур гаргаж нүдээ арчлаа.

- Сонсож бай би та нарт бүгдийг хэлээгүй байна. Би зүгээр л явна ... гэхдээ хэнд ч хэлэхгүйгээр явж чадахгүй нь ... яагаад гэвэл ... надад та нарын тусламж хэрэгтэй байна. Ронь ч гэсэн хэрвээ тэр эсэргүүцэхгүй бол.

- Мэдээж бид чамд туслана. Юу хийх хэрэгтэй вэ? гэж Харри даруйхан хэлэв.

Хагрид чанга шуухитнаснаа Харрийн мөрөн дээр чимээгүй алгадахад дэргэдэх модоо мөргөчихлөө.

- Би чамайг зөвшөөрнө гэдгийг мэдэж байсан юм. Би үүнийг хэзээ ч ... мартахгүй ... явцгаая жаахан явах л үлдлээ ... болгоомжтой халгай байна ...

Тэд арван таван хормын турш чимээгүй явцгаалаа. Харриг хэр удаан явах тухай асуулт тавихаар амаа нээтэл Хагрид зогсох дохио болгон баруун гараа өргөв.

- Тэгвэл арай дээр ... Одоо маш чимээгүй ...

Тэд урагш гэтэн ойртоход Харри Хагридын өндөртэй зэрэгцэм аварга том толигор довцог харлаа. Тэр энэ лав ямар нэг аварга амьтаны ичээ байх гэж бодов. Довцгийн ойролцоох модод үндсээрээ булгарч хашаа мэт хүрээлэн хэвтэнэ. Тэд бүгд зогслоо.

- Унтаж байна гэж Хагрид шивнэв.

Харри алсад аварга том хос уушиг амьсгалж буй адил хэмнэлээр хүржигнэх чимээ сонслоо. Тэр Гермiona руу хяламхийхэд овгороос нүд салгалгүй амаа ангайн ширтэж байв.

- Хагрид. Энэ хэн бэ? гэж тэр сонсогдох төдий шивнэлээ.

Түүний асуулт Харрид хачирхалтай санагдав. Энэ юу вэ? гэж асуух гэсэн байлгүй дээ.

- Хагрид, чи бидэнд хэлсэн биз дээ. Чи тэднийг ирэхээс татгалзсан гэж хэлсэн биз дээ! гээд Гермionaгийн саваа барьсан гар чичирлээ.

Харри тэдэн рүү ээлжлэн харснаа гэнэтхэн бүгдийг ойлгоод айсандаа аяархан дуу алдаж овгорыг харлаа.

Аварга том овгор гүн хурхирах адил алгуур хөдлөнө. Энэ бол овгор биш гарцаагүй хэн нэгний нуруу байлаа ...

- Тиймээ... тэр ирэхийг хүсээгүй. Гэхдээ би түүнийг авчрах ёстой байсан, Гермiona! гэж Хагрид цөхрөнгүй хэлэв.

- Гэхдээ яагаад? Яагаад ... яах гэж ... өө бурхан минь Хагрид! гэж Гермiona дуу алдав.

- Би түүнийг авчрах ёстой байсан. Биеэ авч явахад нь жаахан сургах гэсэн юм ... тэгвэл хүмүүст түүнийг гэмгүй гэдгийг батлах болно! гэж Хагрид уйлах шахам дуугарлаа.

- Гэмгүй гэнээ! хэмээн Гермiona чанга дуу алдахад Хагрид чимээгүй бай гараа зангав. Зүлгэн дээр хэвтээд чанга хурхирч байгаа аварга биет зүүдэндээ яраглан эргэв.

- Тийм учраас л чи үргэлж гэмтээд байсан хэрэг үү? Ийм учраас энэ шархнууд үүссэн хэрэг үү?

- Тэр хүчээ мэддэггүй юм! Түүнийг сургах аваас хамаагүй дээрдэх болно гэж Хагринд яаран дуугарлаа.

- Одоо л чамайг яагаад гэр лүүгээ бүтэн хоёр сар явсныг ойлгож байна. Хагринд чи түүнийг хүсээгүй юм бол яах гэж ийш нь авчирсан юм бэ? Тэр өөрийнхэнтэйгээ амьдарсан нь дээр биш үү? хэмээн Гермiona бодлогоширон хэлэв.

- Тэд бүгд түүнийг гомдоодог, Гермiona. Яагаад гэвэл тэр жижигхэн!

- Жижигхэн гэнээ? Энэ жижигхэн болж байна уу?

- Би түүнийг орхиж чадаагүй, Гермiona. Тэр ... тэр миний дүү! гээд Хагриндын хөхөрсөн нүүрэн дээгүүр нулимс урсан сахалд нь шингэв.

Гермiona түүн рүү амаа ангайн харлаа.

- Хагринд! Чи сая дүү гэж хэллээ. Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Харри удаанаар хэлэв.

- Бараг л төрсөн дүү гэж Хагринд засаад, Миний ээж өөр аварга биеттэй холбогдоод Грохх төрсөн юм ... гэв.

- Грохх гэнээ? хэмээн Харри хэлэв.

- Тийм л дээ ... ямар ч гэсэн нэрээ тэгж хэлэх шиг санагдсан. Тэр англиар сайн ярьж чаддаггүй юм ... би түүнийг сургахыг хичээж байгаа ... ер нь гэвэл тэр түүнийг надаас илүүгүй хайрласан. Аварга биетүүд дотроо давжаа биеттэй том хүүхэд л гэсэн үг ... ердөө арван зургаан фут.

- Хөөх, ямар жижигхэн юм бэ! Үнэхээр өчүүхэн юм! гэж Гермiona даажигнан хэллээ.

- Тэд нар түүнийг дээрэлхэж ... би түүнийг орхиж болохгүй байлаа ...

- Хатагтай Максим бас түүнийг ийш нь авчрахыг хүссэн үү? гэж Харри асуув.

- Тэр ... надад энэ чухал болохыг ойлгосон. Гэхдээ ... гэхдээ дараа нь бага зэрэг ядраад ... бид гэр хүрэх замдаа хуваагдсан юм ... үнэндээ тэр хэнд ч хэлэхгүй гэж амласан ...

- Чи яаж түүнийг хэнд ч харагдалгүй авчирч чадав аа?

- Ийм учраас л тийм их хугацаа өнгөрсөн юм. Зөвхөн шөнө явж болох байлаа.

Мэдээж түүнийг явахыг хүссэн үед явж байсан ч тэр буцаж явах гээд.

- Хагрид, чи түүнийг яагаад чөлөөлөөгүй юм бэ. Чи хэрцгий ууртай аварга биет энд үлдэхийг хүснэ гэж бодоо юу? гээд Гермiona газар унасан модон дээр сууж нүүрээ дарлаа.

- Хэрцгий гэнээ чи арай дэндүүлж байна. Тэр одоо биеэ хамаагүй сайн авч явдаг болсон ... илүү тайван байгаа ...

- Тэгвэл энэ уяа чинь ямар хэрэгтэй юм бэ? гэж Харри асуув.

Ердөө секунтын өмнө тэр бүдүүн модны их биед уясан зузаан олсыг олж харжээ.

- Чи түүнийг уяатай байлгаж байгаа юм уу? гэж Гермiona сулхан дуугарав.

- Ер нь бол тийм л дээ. Харж байна уу ... би хэдийн хэлсэн дээ ... тэр өөрийнхөө хүчийг мэддэггүй гэж.

Одоо л Харри ойн энэ хэсэгт өөр амьтан амьдрах нь ямар сэжигтэй болохыг ойлгож эхлэв.

- За яахав, чи Харри, Рон бид гурваас юу хүсээ вэ? гэж Гермiona болгоомжтой асуув.

- Намайг байхгүй байхад түүнийг харж байхыг гэж Хагрид сөөнгөтөн хэлэв.

Харри, Гермiona хоёр таагүй харц солилцоход тэр хэдийн Хагридад юу гуйсныг нь хийнэ гэж амалснаа ухаарч байлаа.

- Чи яаж ингэж бодож чадав аа? гэж Гермiona гайхширан дуугарлаа.

- Тэжээх хэрэггүй, юу ч хэрэггүй! гэж Хагрид яаран хэлээд,

- Тэр өөрөө хоол олоод идчих болохоор асуудалгүй. Шувуу, буга гээд л бас бус юм ... Үгүй ээ, түүнд хоол хэрэггүй найзууд хэрэгтэй тэгээд л тэр. Би зөвхөн хэн түүнд цаашид туслахыг мэдмээр байна ... жаахан сургах болно ойлгож байна уу ... гэв.

Харри юу ч хэлсэнгүй өмнөө унтаж байгаа аварга биетийн аймшигтай дүрс рүү ахин эргэж харлаа. Хагридаас ялгаатай нь гэвэл Грохх маш том биетэй болохоор дотор зарсхийм харагдана. Харри эхлээд аварга биетийн зүүн талд байгаа хөвдтэй том бул чулууг овгор шороо гэж бодсон ч Гроххын толгой болохыг нь ойлгов. Тэр биетэйгээ харьцуулахад хүмүүсийнхийг бодвол маш том бөгөөд бараг л дүгэриг, өтгөн буржгар үс нь оймын өнгөтэй ажээ. Вернон ахын адил бараг хүзүүгүй шахам биетэй агаад толгойн хөвөөнд нь ганц том аварга чих байлаа. Нуруундаа маш том хэмжээтэй

амьтны бохир ширээр оёсон нэвсгэр хувцас углажээ. Хөл нь биеийнхээ дор атийжээ. Харри зөвхөн түүний аварга том чарга шиг нүцгэн улыг харж байв. Тэд бохир заваан бөгөөд ногоон дээр дээр дээрээсээ давхралджээ.

- Чи биднийг түүнд заахыг хүссэн гэнээ хэмээн Харри өнгөгүй хоолойгоор дуугарлаа. Тэр одоо л Флоренцийн анхааруулгыг ойлгож байв. «Түүний төлөвлөгөө бүтэхгүй. Оролдлогоо орхисон нь дээр». Мэдээж Хориотой ойд өөр амьтад амьдарч байгаа болохоор Хагридын Грохход англи хэл сургах гэсэн бүтэлгүй оролдлогыг мэдсэн байж таарна.

- Тийм л дээ! Та нар зөвхөн хааяа ярьж байхад болно гэж Хагрид найдангуй хэлээд,

- Учир нь би түүнийг хүмүүстэй ярьж сурвал бидний хайрлаж байгааг ойлгоод үлдэх байх гэж бодсон юм гэв.

Харри хурууныхаа ард нүүрээ нуусан Гермiona руу харлаа.

- Энэ ч харагдаж байгаа шигээ биш байх. Норберт ч бас муугүй байсан гэж хэлэхэд тэр хоолойгоо чичрүүлэн инээд алдав.

- Та нар зөвшөөрч байгаа юм уу? гэж Хагрид Харрийн сүүлчийн үгийг сонсолгүй хэллээ.

- Э-э... Бид оролдож үзье Хагрид гэж Харри хэдийн амласан болохоор дуугарав.

- Би чамайг ингэнэ гэдгийг чинь мэдэж байсан юм, Харри гэж хэлээд Хагридын нойтон царай баясан гийхэд ахин алчуураар арчив.

- Би та нарыг хэтэрхий их цаг үрээсэй гэж хүсээгүй ... та нарт шалгалт шүүлэг гээд л бас бус юм байгааг ойлгож байна ... та нар ийшээ үл үзэгдэх цуваа өмсөж долоо хоногт нэг удаа ирээд түүнтэй жаахан ярьж болох юм ... Тэгэхээр би түүнийг сэрээгээдхэе. Та нарыг танилцуулах хэрэгтэй.

- Танилцуул ... үгүй ээ! гээд Гермiona үсрэн бослоо. Гуйж байна, Хагрид. Түүнийг битгий сэрээ. Үнэндээ бидэнд ...

Гэвч Хагрид хэдийн аварга том модны дэргэд хэвтэж буй Гроххын зүг очив. Түүн рүү арван фут ойртоод газраас урт олс авч мөрөн дээгүүрээ эргэн инээмсэглээд аварга биетийн нуруунаас бэхэлсэн уяаны үзүүрээс хүчтэй татлаа.

Аварга биет хүржигнэхэд нам гүм ойд чанга цуурайтлаа. Мододын оройгоос шувууд дэрхийн нисэв. Тэгтэл Харри, Гермiona хоёрын нүдэн дээр аварга биет газраас өндийн босч ирээд чичирснээ гараараа өвдгөө тулан босов. Дараа нь тайван байдал үймүүлэгчийг харахын тулд эргэлээ.

- За яасан, Грошик. Муугүй зүүрмэглэв үү? гэж олсны үзүүрээс угзрахад бэлхэн барьсан Хагрид наргиантай хэллээ.

Харри, Гермiona хоёр аврага биетийн нүдэнд өртөхгүйг хичээв. Грохх хоёр модны хооронд сөхрөн суулаа. Тэд түүний итгэмээргүй аварга царай луу харахад бүрэнхийд саарал сартай адил үзэгдэв. Гроххын хамар богинохон хэлбэр дүрсгүй, тал тоосгоны хэмжээтэй зэрэмдэг шар шүдтэй, тийм том аварга биетэд гэхэд багадааар жижигхэн ногоовтор хүрэн нүдээ сүүмийн анивчихад нойрноосоо сайн сэрээгүй байлаа. Грохх нударга зангидан ууртайгаар нүдээ арчаад хөл дээрээ үсрэн бослоо.

- Ай! гэж хашгирах Гермionaгийн айсан дууг Харри ардаа сонслоо.

Гроххын шагай уяатай байсан мод сүртэй шаржигнав. Хагридын хэлсэн ёсоор арван зургаан футын өндөр ажээ. Тэрбээр сүүмгэр нүдээр эргэн тойрноо харснаа гараа сунгаад зэргэлдээх модны дээд талын мөчрийг сөхөж сэгсчин дотроос нь шувуу гарсангүйд унтууцан хүрхэрлээ. Модноос өндөг гар бөмбөг шиг шуугин унахад Хагрид толгойгоо хамгаалан гэврэв.

- Сонсооч, Грошик хэмээн Хагрид өндөг унахаас сэргийлэн дээшээ хялайн харж хашгираад,

- Би ийшээ найзуудаа танилцуулахаар авчирлаа. Миний хэлснийг санаж байна уу? Би тэдэнд чамайг харуулахын тулд багахан аялал хийнэ гэж хэлсэн биз дээ? Чи үүнийг санаж байна уу, Грошик? гэв.

Гэвч Грохх ахин нам дуугаар хүрхэрснээс үзэхэд Хагридын хэлснийг сонсоогүй бололтой. Тэр өөр нэг модны оройгоос барьж аваад алсад юу байгааг харахын тулд сонирхон татав.

- Хөөе, Грошик, хэрэггүй! Чи түүнийг булгалах нь байна гэж Хагрид хашгирав. Тэгтэл Харри үнэхээр модны үндэс шажигнаж эхлэхийг харлаа.

- Би хүмүүс авчирсан! Найзууд ойлгож байна уу? Чи доошоо харвал царсны ёроолд би найзууд авчирсныг харах болно!

- Хэрэггүй, Хагрид! гэж Гермiona гонгиносон хэдий ч Хагрид Гроххын

хөлнөөс уяатай олсны үзүүрээс татлаа.

Аварга биет модны үзүүрийг тавихад сэгсрэгдэн Хагрид руу шилмүүс бороо шиг оров.

- Хараач гээд Хагрид яаран хүүхдүүд рүү гүйж,

- Энэ бол Харри, Грошик! Харри Поттер! Тэр чамайг намайг байхгүй үед харах болно ойлгож байна уу? гэв.

Аварга биет сая л Харри, Гермиона хоёрын байхыг ажиглажээ. Тэрбээр бул чулуу шиг толгойгоо бөхийлгөн тэднийг дагуулан харлаа.

- Харин энэ бол Гермиона харж байна уу? Гер ... гээд Хагрид Гермиона руу эргэж,

- Хэрвээ чамайг Герми гэж дуудвал эсэргүүцэхгүй биз дээ? Чиний нэр хэтрхий хэцүү болохоор тэр санаж чадахгүй гэв.

- Тиймээ тэгэлгүй яахав гэж Гермиона хэлэв.

- Энэ бол Герми, Грохх! Тэр ч гэсэн ирж байх болно! Таатай байгаа биз дээ, аан? Одоо чамд хоёр найз ... Хэрэггүй, Грошик!

Гроххын гар гэнэтхэн Гермионагийн зүг ухасхийхэд Харри гараас нь амжин татаж модны цаагуур нуугдахад сарвуу нь хоосон газар буулаа.

- Чи муу хүү, Грошик! Маш муу хүү! Барьж болохгүй ... ёо! гээд Хагридын орилохыг сонсоод Гермиона айсандаа дагжтал чичирэн модонд наалдлаа.

Харри модны араас толгойгоо цухуйлган Хагрид газар хамраа барин хэвтэхийг олж харлаа. Грохх харваас түүнийг сонирхохоо больсон бололтой ахин модны орой сэгсчиж байв.

- За яахав гэж Хагрид бувтнаад хөл дээрээ босож нэг гараараа цус болсон хамраа чимхэнгээ нөгөө гараараа нум сумаа авлаа.

- Сайн байна ... одоо боллоо ... бид түүнтэй танилцлаа ... тэр одоо та нарыг мэдсэн болохоор ирж болно. Тиймээ ... сайн хэрэг л дээ ...

Тэр Грохх руу харахад үхэр чулуу шиг царайдаа сэтгэл хангалуун инээмсэглэл тодруулан нарс сэгсчиж байв.

- Минийхээр бол өнөөдрийн хувьд хангалттай. Бид буцсан нь дээр байх гэж

Хагрид хэлэв

Харри, Гермiona хоёр толгой дохив. Хагрид нум сумаа ахин мөрөндөө үүрээд хамраа чимхсэн хэвээр ширэнгэ рүү түрүүлж хөдлөв.

Хэсэг хугацааны турш бүгд чимээгүй явахад хэн ч дуугарсангүй бөгөөд алсад Гроххын мод шажигнуулан сэгсрэх сонсогдож байлаа. Гермionaгийн нүүр цонхийн цайж бодлогоширчээ. Харрийн сэтгэл үймэрлээ. Хэрвээ хэн нэгэн Хагрид Гроххыг

Хориотой ойд нууж байгааг мэдвэл яах бол? Харин тэр Рон, Гермiona хоёртой Хагридын аварга биетийн соёлжуулна гэж ухаангүй ам өгсөн байдаг! Хагрид яаж аварга том биетэй соёотой мангасыг гэмгүй жижигхэн хүүхэд болон хүмүүсийн дунд амьдарч чадна гэж бодсон юм бол?

- Зогсоорой гэж Хагрид гэнэтхэн хэлэхэд Харри, Гермiona хоёр өтгөн бутны дунд зогслоо. Тэр мөрөн дээрх саадагнаас сум аван нумандаа онилов. Харри, Гермiona хоёр саваагаа өргөөд ойролцоо навчис шажигнахыг сонсов. Өө, чөтгөр гэж.

- Хагрид! Бид чамд ийшээ ирэх хэрэггүй гэж сануулсан шиг санагдах юм гэх эрэгтэй хүний хоолой харав.

Тэд хэсэг хугацаанд харсны эцэст ногоон манан дундаас эрэгтэй хүний нүцгэн бие тодорсноо морины толигор бие болон хувирахыг харлаа. Хүн морь омог бардам өргөн шанаатай урт хар үстэй байлаа. Тэр Хагридын адил зэвсэгтэй байсан бөгөөд нуруундаа хурц сумтай саадаг, мөрөндөө урт нум зүүжээ.

- Юу байна даа, Магориан? гэж Хагрид болгоомжтой асуув.

Хүн морины ард шажигнах чимээ сонсогдсоноо дөрөв таван хүн морь гарч ирэв. Харри тэдний дунд бараг дөрвөн жилийн өмнө Флоренцтэй танилцах үед уулзсан сахалтай Бейн байхыг танилаа. Гэвч Бейн Харриг таньсан шинж үзүүлсэнгүй.

- Тэгэхээр бид энэ хүний царай манай ойд ахин үзэгдэхгүй гэж тохиролцсон юм шиг санагдах юм хэмээн Магориан сайнгүй өнгөөр дуугарав.

- Энэ хүн гэдэг чинь би юм уу? Зүгээр л та нарт алах боломж өгөөгүйн учраас уу?

- Чи оролцох хэрэггүй байсан юм, Хагрид. Бидэнд өөрийн амьдрал, хууль бий.

Флоренц биднээс гутамшигтайгаар урвасан.

- Юу яриад байгааг чинь ойлгох юм алга. Тэр Альбус Дамблдор тусалж байгаа шүү дээ гэж Хагрид дуу алдав.

- Флоренц хүмүүст боолын хөдөлмөр хийж байгаа гэж саарал биетэй хүн морь бүдүүлгээр хэлэв.

- Боолын хөдөлмөр гэнээ! хэмээн Хагрид зэвүүцэн хэлээд,
Тэр ердөө

Дамблдорт хүндэтгэл үзүүлсэн хэрэг гэв.

- Тэр бидний мэдлэг нууцыг хүмүүст худалдаж байна. Ийм зүйлийг тэвчиж болохгүй гэж Магориан тайван хэлэв.

- Энэ бол та нарын л хэрэг. Миний хувьд гэвэл та нар том алдаа хийж байна гээд Хагрид мөрөө хавчлаа.

- Хүн чи биднийг анхааруулсаар байтал ойд яаж ирж зүрхлэв? гэж Бейн дүрсхийв.

- Тэгвэл одоо намайг сонс гэж Хагрид уурсан хэлээд,

- Хэрвээ эсэргүүцэхгүй бол би манай ой гэсэн үгийг чинь багахан сонсмоор байна. Ийшээ хэн ирж буцахыг та нар шийддэг юм биш гэв.

- Чи ч гэсэн биш, Хагрид. Өнөөдөр би чамд явахыг зөвшөөрсний учир нь дагуулсан залуу хүмүүс чинь ...

- Тэд түүнийх биш! Энэ чинь сургуулийн сурагчид байна, Магориан! Тэд хэдийн урвагч Флоренцийн хичээлд сууж амжсан биз гэж Бейн зэвүүцэнгүй хэлэв.

- Тийм байлаа ч гэсэн унагыг алах бол аймшигтай гэмт хэрэг. Гэмгүй хүмүүст бид хүрэхгүй. Хагрид өнөөдөр найрамдалтай явж үз. Гэхдээ цаашид эндээс хол байгаарай. Чи бусад хүн морьдоос урвасан Флоренцэд тусалснаараа бидэнтэй нөхөрлөлөө эвдсэн.

- Би та нар шиг зөрүүд амьтдаас болж ойгоос хол байж чадахгүй! гэж Хагрид дүрсхийв.

- Хагрид хэмээн Гермiona саарал биетэй Бейн газар туурайгаараа цавчилахыг харж айн дуу алдаад, Хагрид, явцгаая! Гуйж байна! гэв.

Ойн сахиул нум сумаа өргөсөн хэвээр урагш хөдлөхдөө өмнөхийн адил Магорианыг сүрдүүлэн харсаар байлаа.

- Бид чиний ойд юу нууж байгааг мэднэ, Хагрид! Бидний тэвчээр хязгааргүй биш шүү! гэж Магорина араас нь хашгирахад бусад хүн морьд үзэгдэхгүй болов.

Хагрид Магорианыг хайн эргэж харлаа.

- Та нар түүний энд байгааг тэвчих хэргтэй болж дээ. Тэр та нараас дутуугүй энд байх эрхтэй! гэж хариу орилоход Харри, Гермиона хоёр хантаазнаас бүх хүчээ гарган зуурлаа. Тэр барайсан хэвээр доош харж уурссан хэдий ч тэднийг хараад дороо тайвширлаа.

- Тайвшир хүүхдүүдээ. Зөрүүд амьтад байгаа биз? гэж цааш хүндээр амьсгаадан явахдаа хэлэв.

- Хагрид хэрвээ хүн морьд ойд хүмүүс байхыг хүсэхгүй байгаа бод бид яаж ирж чадах юм бэ гэж Гермиона өтгөн халгай дундуур гарахдаа хэлэв.

- Чи тэднийг хэлснийг сонссон. Тэд унаганд хүрдэггүй ... бас хүүхдүүдэд. Бид тэднийг сонссон.

- Сайхан оролдлого байлаа гэж Харри сэтгэлээр унасан Гермионад шивнэлээ.

Тэд зам дээр гарч ахин арван хором явсны эцэст мододын завсар гэгээ татан цэнхэр тэнгэр харагдаж алсад хөгжөөн дэмжигчдийн хөөрсөн дуу сонсогдов.

- Ахин нэг оноо юу? Эсвэл тэмцээн дуусаж байгаа юм болов уу? гээд Хагрид модны ард нуугдан цэнгэлдэх хүрээлэнг харав.

- Мэдэхгүй гэж Гермиона золгүй хоолойгоор дуугарлаа. Харри түүний үсээр дүүрэн навч мөчир орооцолдож, жанч нь хэдэн газраа урагдан, царай болон гартаа маажигдсан олон тооны шархтай болсон хөөрхийлөлтэй байдлыг харлаа. Тэр өөрийгөө ч нэг их дээрдэхгүй байгааг ойлгож байв.

- Дууссан юм шиг байна! Харж байна уу хүмүүс явцгааж байна ... Хэрвээ та нар хүмүүсийн дунд хурдан орж хутгалдвал хэн ч тэнд байхгүй байсныг чинь мэдэхгүй!

- Сайхан санаа байна. Тэгэхээр ... дараа уулзая, Хагрид гэж Харри хэлэв.

- Би түүнд итгэхгүй байна гэж Гермиона Хагридын сонсож чадахааргүй газар холдонгуут сулхан хоолойгоор дуугарав. Би түүнд итгэхгүй байна. Үнэхээр итгэхгүй байна!

- Тайвширч үз.

- Тайвширч үз гэнээ! хэмээн тэр дуу алдаад,
 - Аварга биет! Аварга биет ойд байна! Бас түүнд англи хэлний хичээл заах юм гэнэ! Энэ чинь бид ирж очихдоо сүрэг дайсагнасан хүн морьдын дундуур гарна гэсэн үг! Би түүнд итгэхгүй байна!
 - Бидэнд юу ч хийх хэрэг гарахгүй! гэж Харри тайвшируулахыг хичээгээд шилтгээн рүү шуугилдан буцаж байгаа Пуффендуйнхан дунд орсон учир дуугаа намсгав. Тэр биднийг хөөх хүртэл туслахыг гуйгаагүй. Магадгүй энэ хэзээ ч болохгүй байж магадгүй!
 - Больж үз, Харри хэмээн Гермиона уурсан хэлээд хөшсөн юм шиг зогсоход хүмүүс тойрон гарцгаав.
 - Түүнийг заавал хөөх болно. Бид өнөөдөр Амбрижын яахыг харсан биз дээ? Нам гүм болов. Харри Гермионаг зэрвэс харахад нүдэнд нулимс дүүрчээ.
 - Чи тэгж бодоогүй байлгүй.
 - Үгүй ээ ... магадгүй ... үгүй байж болох юм. Гэхдээ түүнд яагаад амьдралаа ингэж хүндрүүлэх хэрэг байдаг юм бол? гэж тэр нулимсаа арчин хэлэв.
 - Мэдэхгүй.
- Рональд Уизли манай хаан Рональд Уизли манай баатар Цагаригны өмнө хана болж
Тэнд үргэлж зогсож байдаг
- Тэд яаж энэ тэнэг дуугаа дуулж чадаж байна аа? Өмнө элэглэсэн нь багадаад байгаа юм байх даа? гэж Гермиона унтууцав.
- Ногоон нуга дээгүүр шилтгээн орох замаар тэмцээнээс буцаж байгаа бөөн сурагчид гарч ирэв.
- Слизеринийхнийг гүйцэхээс өмнө түргэн явцгаая гэж Гермиона хэлэв.
- Квоффлыг Рон алдахгүй
Ялалтыг тэр хэнд ч алдахгүй
Хаалгачаар Рон төрсөн болохоор
Гриффиндорынхон бахархдаг юм
- Гермиона ... гэж Харри итгэлгүйхэн дуугарав.
- Дуу улам чангарах хэдий ч ногоон хувцастай Слизеринийхний зүгээс биш харин

алтлаг улаан хувцастай шилтгээний зүг мөрөн дээрээ нэг дүрс суулган удаан явж буй хэсгээс гарч байлаа.

Рональд Уизли манай хаан Рональд Уизли манай баатар Цагаригны өмнө хана болж Тэнд үргэлж зогсож байдаг

- Байж боломжгүй юм гэж Гермиона аяархан дуу алдав.
- Болно! гэж Харри чанга хэллээ.
- Харри! Гермиона! Бид чадсан! Бид ялсан! гэж Рон мөнгөлөг цомоор даллан орилов. Тэр аз жаргалд автсан байлаа.

Тэд түүнийг инээмсэглэн харлаа. Шилтгээний хаалгаар орохдоо Рон хаалганы орой мөргөсөн хэдий ч хэн ч хөл дээр нь буулгасангүй. Тэд дуулсан хэвээр үүдний танхимаар орж хараанаас алга болов. Баясан гийсэн Харри, Гермиона хоёр тэдний араас дуу бөхтөл дагуулан харлаа. Дараа нь бие рүүгээ эргэхэд царайнаас нь инээмсэглэл алга болов.

- Шинэ мэдээгээ маргааш дуулгах уу? гэж Харри хэлэв.
- Сайн байна. Би ерөөсөө яараагүй гэж Гермиона ядрангуй зөвшөөрөв.

Тэд хамтдаа шатаар өгслөө. Үүдний хаалган дээр очоод хоёул Хориотой ойн зүг зовнингуй эргэн харав. Харри итгэлтэй биш байсан ч алсад жижигхэн шувуу бужигналдан хэн нэг хүн модны оройг уурандаа үндсээр нь газраас суга татах гэж байгаа мэт сэгсчүүлэхийг харжээ.

БҮЛЭГ 31: С.И.Ш

Рон Гриффиндорыг квиддичийн цом авахад тусалсан явдалд хязгааргүй баяр хөөртэй байсан болохоор маргааш нь ямар ч зүйлд төвлөрч чадсангүй. Тэр ахин дахин баяртайгаар тэмцээний тухай ярин Харри, Гермiona хоёрт Гроххын тухай ярих ямар ч боломж өгсөнгүй. Үнэнийг хэлэхэд тэд Роныг ийм хэрцгий аргаар газар дэлхий дээр эргэж буулгахыг хүсээгүй тул ярихыг тийм ч их хичээгээгүй байж болох юм. Маргааш нь цаг агаар цэлмэг дулаахан байж тэд Роныг нуурын эрэг дээр байх хусны дор шалгалтанд бэлтгэе гэж ятгав. Тэнд Гриффиндорын амралтын өрөөнөөс илүү гадны чих бага байлаа. Эхлээд Ронд энэ санаа нэг их таалагдсангүй. Түүнд цамхагт суун дэргэдүүр нь өнгөрсөн хүмүүс мөрөн дээр нь нөхөрсгөөр алгадангаа «Уизли манай хаан» гэж дуулах нь таалагдаж байсан ч хэсэг хугацааны дараа цэвэр агаар амьсгалах нь ашигтай гэж бодоод зөвшөөрчээ.

Тэд сурах бичгээ дэлгээд модны сүүдэрт сууж хорь дах удаагаа Роныг анхны бөмбөгөө хэрхэн барьсныг сонслоо.

- Би хэдийн Дэвисийн илгээсэн бөмбөгийг алдсан байсан болохоор өөртөө итгэлгүй байсан ч яагаадыг бүү мэд Брэдди миний зүг нисэх үед гэнэтхэн «Би чадна» гэж бодсон. Ингээд тэр баруун талын цагариг руу нисэж байсан болохоор хаашаа ухасхийхээ сонгоход надад секунтээс илүү хугацаа үлдээгүй. Ойлгож байна уу ер нь бол миний баруун талын, түүний зүүн талын цагариг руу нисэхэд дотоод дуу хоолой минь хуурч байна гэж хэлсэн учир би зүүн тийш харин түүний баруун тал руу ухасхийсэн юм. Та нар үүнийг яаж дууссаныг харсан биз дээ гэж тэр даруухан хэлээд үсээ сөргүүлэн илэнгээ ойр хавийн хөршүүд болох Пуффендуйн гуравдугаар дамжааныхан үгийг нь сонсож буй эсэхийг харлаа.

- Тэгтэл таван хормын дараа Чемберс миний зүг нислээ. Яасан? Чи яагаад инээмсэглээд байгаа юм? гээд үгээ дуусгалгүй Харрийн царайг хараад хэллээ.

- Юу ч биш. Зөвхөн бид ялсанд баярлаж байна тэгээд л тэр гэж Харри түргэхэн хэлээд инээмсэглэлээ нуухын тулд хувиргалын хичээлийн ном руугаа тонгойв. Үнэндээ агшины өмнө Рон Харрид энэ модны дор үсээ сөргүүлэн илж байсан квиддичийн өөр нэгэн тоглогчыг санагдуулжээ.

- Тийм шүү. Бид ялсан гэж Рон энэ үгийн дуулдах чимээнд цэнгэн хэлээд,

- Чи Жинни хамрынх нь урд снитчийг барьж авахад Чангийн царай ямар

болсныг харсан уу? гэв.

- Тэр уйлсан байх гэж Харри гашуунаар хэлэв.
- Аан ... тийм л дээ гээд Рон үл мэдэг хөмсөг зангидсанаа,
- Гэхдээ чи түүний газардахдаа шүүрнээсээ унасныг харсан байлгүй дээ? гэв.
- Э-э гэж Харри түгдэрлээ.
- Үнэнийг хэлэхэд ... үгүй ээ, Рон гээд Гермиона гүнзгий амьсгал авч номоо хаан уучлал эрэн хараад,
- Биднийг уучлаарай. Харри бид хоёр өчигдөр цэнгэлдэх хүрээлэнд Дэвисийн эхний бөмбөг оруулахыг л харсан гэв.
- Та нар тэмцээн үзээгүй юм уу? Миний нэг ч барилтыг хараагүй юм уу? гэж тэр урам хугаран дуугарав.
- Үгүй гэж Гермиона хэлээд гарыг нь эвлэрэнгүй барьж,
- Гэхдээ бид тэндээс явахыг хүсээгүй, Рон. Бидэнд үүнийг хийх хэрэг гарсан юм! гэв.
- Юу? Яах гэж? хэмээн Роны царай заналхийлсэн улаан өнгөтэй болов.
- Хагридаас болоод. Одоо бид түүнийг аварга биетүүдээс эргэж ирснээсээ хойш яагаад үргэлж хөхөрсөн явдгийг мэдэх болсон. Тэр бидэнтэй ой руу хамт явахыг хүсэхэд нь татгалзаж чадсангүй. Ер нь бол сонсооч ...

Бүх түүх ердөө таван хором үргэлжилэхэд Роны эгдүүцсэн царай итгэлгүй өнгөөр солигдов.

- Тэр аварга биетүүдийн нэгийг авчраад ойд нууж байгаа хэрэг үү?
- Аанхан гэж Харри баргар хэлэв.
- Үгүй дээ. Байж боломгүй юм!
- Ямар ч л гэсэн тэгсэн. Грохх ойролцоогоор арван зургаан фут өндөр биетэй, хорин фут өндөр нарс булга татах дуртай, бас намайг Герми гэдгийг мэднэ гэж Гермиона таагүйхэн хэлэв.

Рон хийрхэн инээд алдлаа.

- Тэгээд Хагрид биднээс юу хүсээ вэ?

- Биднийг түүнд англи хэл заахыг хүсч байгаа юм гэж Харри яриаг нь дуусгав.
- Тэр ухаан солиорчээ гэж Рон айсан янзтай хэллээ.
- Тийм шүү гэж Гермиона уурсан батлаад сурах бичгийнхээ хуудсыг эргүүлж уулийг театрын дуран болж хувиргах жишиг зургийг харангаа,
- Би ч гэсэн эхэндээ тэгж бодож байсан. Азгүй нь гэвэл Харри бид хоёр түүнд туслахаар амалчихсан гэлээ.
- Та нар амлалтаа зөрчих хэрэгтэй тэгээд л тэр гэж Рон хатуу хэлээд,
- Би юу хэлэхийг хүсч байна гэвэл ... шалгалт хаяанд ирсэн байхад бидэнд сургуулиас гарах ямар ч боломж байхгүй ... тэгээд ч Норберт болон Арогагийн тухай санаж байгаа биз дээ? Бидэнд Хагридын нөхөр болох мангасуудтай орооцолдох нь ямар хэрэгтэй юм бэ? гэв.
- Чиний зөв, гэвч гай нь гэвэл ... бид түүнд амлачихсан гэж Гермиона өрөвдөлтэй дуугарлаа.

Рон сэгсийсэн үсээ толийлгон илбэв. Тэр харваас чухалчлан бодож байгаа бололтой.

- За яахав. Хагридыг бас ч гэж хөөчихөөгүй байна. Харин тэр улирлын сүүлч хүртэл тэсэх юм бол бидэнд Грохход ойртох шаардлага гарахгүй байх гэлээ.

Шилтгээний эргэн тойрон нарны гэрэлд хурцаар туяаран, үүлгүй тэнгэр нуурын мандалд тусгалаа тольдон инээмсэглэж, хилэн ногоон зүлэг сэвшээ салхины аясаар долгиолно. Зургаан сар гарахад тавдугаар дамжааныхан удахгүй шалгалт өгнө гэсэн ганц л зүйлд сэтгэл зовж байв.

Багш нар тэдэнд гэрийн даалгавар өгөхөө больж шалгалттай холбоотой сэдвийг давтан үзэж байлаа. Бүгдийн шалгалтанд бэлтгэх эрч хүчтэй уур амьсгалд Харри автсандаа болоод энэ дэлхий дээр С.И.Ш-ээс өөр зүйл байдгийг мартсан ч уусмалын хичээл ороход Люпин Снеггтэй оккленцийн хичээл үргэлжүүлэх талаар ярилцсан эсэхийг гайхлаа. Хэрвээ тэгсэн бол Снегг харваас Люпиныг Харриг тоомсорлож байгаатай адилхан үл тоомсорложээ. Гэхдээ Харри Снеггийн нэмэлт хичээлгүй хангалттай завгүй байсан болохоор үүнд сэтгэл зовсонгүй. Түүний санааг амраан Гермиона оккленцийн хичээлийн тухай шаардахаа болив. Тэрбээр одоо цаг үргэлж бувтнан хичээлээ давтангаа орой болгон буланд үйлчлэгчийн хувцас үлдээхээ больсон байна.

Гермиона С.И.Ш дөхсөнтэй холбогдуулан биеэ хачирхалтай авч явж байгаа цорын ганц хүн биш байлаа. Эрни Макмиллан шалгалтанд хэрхэн бэлтгэж байгаа тухай асуух таагүй дадалтай болжээ.

- Та нар өдрийн хэдэн цагийг шалгалтанд бэлтгэхэд өнгөрүүлж байна? гэж Харри, Рон хоёроос ургамал судлалын хичээл рүү хамт явахдаа нүдээ гялалзуулан асуулаа.

- Мэдэхгүй. Их байх гэж Рон хэлэв.

- Наймаас их үү?

- Арай бага гэж Рон түгшин дуугарлаа.

- Минийх бол найм гэж Эрни цээжээ түхийлгэн хэлээд,

- Найм юмуу есөн цаг. Би өдөр болгон өглөөний цайны өмнө нэг цаг гаргасан.

Найм бол миний дундаж тоо. Амралтын өдөр гэхэд амжилттайгаар арав хүргэж болох байх. Даваа гаригт ес хагас давтсан. Харин мягмар гаригт тийм ч сайнгүй ердөө долоо хагас. Лхагва гаригт ...

Харри профессор Стебль энэ агшинд тэднийг хүлэмж рүү оруулан Эрнигийн яриаг тасалсанд ихэд талархжээ.

Тэр үед Драко Малфой ч гэсэн сэтгэл үймэрлээ давах шинэ арга олсон байна.

- Бидний юу мэдэх нь чухал биш хэнийг таних нь чухал гэж тэр шалгалт эхлэхээс хэдэн өдрийн өмнө Крэбб, Гойл хоёрт уусмалын хичээл дээр чанга хэлээд,

- Манай аав олон жилийн өмнөөс шидэт шалгалтын комиссийн гол хүн болох хөгшин Гризельда Марчбэнкстэй нөхөрсөг холбоо тогтоосон ... тэр манай оройн хоолонд байнга зочилдог ... гэв.

- Энэ үнэн болов уу? хэмээн Гермиона Харри, Рон хоёрт шивнэв.

- Хэрвээ тийм байсан ч бид юу ч хийх боломжгүй гэж Рон хэлэв.

- Би лав үнэн гэж бодохгүй байна гэж тэдний ард байсан Невилл Долгопус хэлээд, Учир нь Гризельда Марчбэнкс манай эмээтэй найзалдаг юм. Тэр хэзээ ч Малфойн тухай дурдаж байгаагүй гэв.

- Тэр ямар вэ, Невилл? Ширүүн үү? гэж Гермиона асуулаа.

- Үнэнийг хэлэхэд яг л манай эмээ гэсэн үг.

- Тэр чамайг таньдаг болохоор яах ч үгүй гэж Рон урамшуулав.

- Би тэгнэ гэж бодохгүй байна. Эмээ үргэлж намайг профессор Марчбэнкет эцгээсээ өөр гэж хэлдэг юм ... та нар түүнийг гэгээн Мунгогийн эмнэлэгт харсан биз дээ.

Невилл баргар царайлан газар ширтлээ. Харри, Рон, Гермиона нар бие бие лүүгээ харсан хэдий ч юу хэлэхээ мэдсэнгүй. Невилл анх удаагаа тэдэнтэй шидтэний эмнэлэг дээр уулзсан тухайгаа ярилаа.

Тэр үед сэтгэн бодох чадвар нэмэгдүүлэхэд туслах хар захын наймаа таваас долдугаар дамжааныханы хооронд өрнөж байлаа. Харри, Рон хоёр даруйхан Когтевраны зургадугаар дамжааны Эдди Кармайклын санал болгосон тархи сэргээгч хандыг хорхой хүрэн сонирхов. Тэр өнгөрсөн жил энэ хандын тусламжтай есөн ширхэг С.И.Ш-ийн шилдэг гэсэн үнэлгээ авсан хэмээн баталж пинтийг нь арван хоёр галлеоноор зарахад бэлэн байлаа. Рон Харрид Хогвартс төгсөн ажилд орсон хойно мөнгийг нь төлнө гэж амалсан ч Гермиона Кармайклын уусмалыг булааж аваад жорлон руу асгачихлаа.

- Гермиона! Бид үүнийг чинь худалдаж авах гэж байгаа шүү дээ! гэж Рон гонгинов.

- Битгий тэнэг юм яриад бай. Та нар Харольд Динглээс лууны нунтагласан хумс авсан! Энэ чинь л хангалттай!

- Динглд лууны нунтагласан хумс үлдсэн болов уу? гэж Рон хомхойрон сониучирхав.

- Байхгүй. Би түүнийг нь ч гэсэн хураан авсан. Энэ бүхэн цэвэр ашиггүй зүйл гэдгийг мэдэж байгаа биз дээ.

- Лууны хумс үйлчилж л таараа! гэж Рон дуу алдаад.

- Тэр сайхан зүйл тархийг итгэмээргүй сэргээж хэдэн цагийн турш ухаантай болгодог юм ... Гермиона жаахан чимхийг өгчих л дөө гуйж байна, тэр ямар ч хоргүй ээ гэв.

- Хор учруулж болно. Би түүнийг үзсэн юм чинь. Үнэн хэрэгтээ доксины хатсан баас юм билээ.

Энэ мэдэгдлийн дараа Харри, Рон хоёр тархи сэргээгчийн араас хөөцөлдөхөө

больжээ.

Маргааш өглөө нь хувиргалын хичээл дээр тэд шалгалтын хуваарь болон нарийвчилсан дүрэмтэй нь танилцлаа.

- Харж байна уу та нар С.И.Ш-ийн шалгалтыг хоёр долоо хоногийн турш дараалан өгөх нь байна. Өглөө онолын шалгалтаа өгөөд үдээс хойш нь дадлагын ажил өгөх нь байна. Одон орны дадлагын ажлыг мэдээж хэрэг шөнө өгөх болно хэмээн профессор МакГонагалл сурагчдыг самбараас шалгалтын өдөр сараа хуулан авахад хэллээ.

- Цааш нь анхааруулахад шалгалтын цаасыг хууран мэхлэхийн эсрэг шившлэгээр шившсэн байгаа. Сануулагч юмуу өөрөө хариулдаг үзэг ашиглах болон алдаа засдаг бэх хориотой. Харамсалтай нь жил болгон хамгийн багадаа нэг сурагч шидэт шалгалтын комиссын дүрмийг зөрчдөг юм. Би зөвхөн Гриффиндорынхон тийм зүйлд оролцохгүй байх гэдэгт найдаж байна. Манай шинэ захирал ... гээд МакГонагалл царайгаа Петунья эгч байраа цэвэрлэх үедээ ялангуяа хивсний толбо арилгах үеийнх шиг болгосноо,

- Тэнхимийн эрхлэгчидийг сурагчиддаа хууран мэхэлсэн тохиолдолд хатуу шийтгэх болно гэж анхааруулахыг гуйсан гэв.

Профессор МакГонагалл мэдэгдэм санаа алдлаа. Харри түүний хамрын самсаа сарталзахыг ажиглажээ.

- Тэглээ гээд та нарт чаддаг бүхнээ үзүүлэхгүй байх шалтгаан байхгүй. Та нар ирээдүйнхээ тухай зайлшгүй бодох ёстой.

- Юм асууж болох уу, профессор? Бидний шалгалтын дүн хэзээ гарах юм бэ? гээд Гермiona гараа өргөв.

- Долоон сард хүн бүрт дүнгийн үнэлгээтэй ууль илгээх болно.

- Сайхан хэрэг. Амралтаараа санаа зовохгүй байж болох нь гэж Дин Томас шивнэв.

Харри зургаан долоо хоногийн дараа Улаан модон гудамжинд суугаад дүнгээ хүлээж байгаа тухай төсөөлөв. Тэр юутай ч гэсэн энэ зун нэг захиа авах нь байна.

Тэдний эхний шалгалт болох шившлэгийн онол даваа гаригийн өглөө байлаа. Харри ням гаригт хоолны дараа Гермionaг шалгахыг зөвшөөрөөд бараг шуудхан үүндээ

харамслаа. Тэр аймшигтай санаа зовж хариулт болгондоо алдаа гаргасан эсэхээ шалган номоо шүүрч авч байсан бөгөөд эцэст нь Харрийн хамар луу номныхоо хурц ирмэгээр цохьчихлоо.

- Чи үүнийгээ өөрөө хий гэж тэр хатуу хэлээд номыг нь буцааж өгөхөд нүдэнд нь нулимс цийлэгнэлээ.

Рон энэ үед чихээ алгаараа таглан уусмалын хичээлийн тэмдэглэлээ уруулаа чимээгүй хөдөлгөн уншиж байсан бөгөөд харин Симус Финниган газар хэвтээд шившлэгийн тодорхойлолт давтахад Дин «Шившлэгийн хичээлийн онол» номноос шалгаж байв. Парвати, Лаванда хоёр нүүлгэх шившлэгийг давтан харандааны савыг ширээний ирмэг дагуу хөдөлгөн сургуулилж байлаа.

Оройн хоолон дээр шалгалтын өмнөх дарамттай уур амьсгал ноёрхлоо. Харри, Рон хоёр өдөржингөө хичээл хийсэн болохоор бараг юу ч ярилгүй амтархан идлээ. Зөвхөн Гермiona цүнхнээсээ номоо гаргаж ирэхийн тулд хутга сэрээгээ ширээн дээр тавихыг завдав. Рон түүнд хэвийн хоолох ёстойг сануултал гэнэтхэн хутга, сэрээ хуруунаас нь гулган тавган дээр чимээтэй уналаа.

- Өө, бурхан минь. Тэд хэн бэ? Шалгалтынхан уу? гэж тэр үүдний танхим руу харан бувтнав.

Харри, Рон хоёр агшин зуур эргэн харлаа. Үүдний танхимд Амбриж хэсэг эртний төрхтэй шидтэнгүүдтэй зогсож байв. Харри сэтгэл ханамжтайгаар Амбриж бухимдаж эхлэхийг харлаа.

- Ойртож харах уу? гэж Рон санал болгов.

Харри, Гермiona хоёр толгой дохиод гурван найз хамтдаа үүдний танхим руу яаран гарч шалгалтынхны дэргэдүүр өнгөрөхдөө удааширав. Харри жижигхэн биетэй үрчлээтэй нүүр бүхий бөгтөр эмэгтэйг профессор Марчбэнкс байх гэж бодов. Амбриж түүнд гүн хүндэтгэлтэй хандаж байлаа. Профессор Марчбэнкс харваас чих хатуу бололтой дэргэд нь хоёр алхамаас илүүгүй зайд зогсож байсан ч чанга ярих аж.

- Энд ирсэн маань ямар сайхан хэрэг вэ. Бид ийшээ нэг бус удаа ирж байна!

Ингэхэд би удтал Дамблдортой уулзсангүй! Тэр одоо хаана байгааг мэдэхгүй биз? гээд түүнийг одоохон шүүрний пингээс гарч ирэх гэж байгаа аятай эргэн тойрноо найдангуй харлаа.

- Мэдэх юм алга. Гэхдээ яамныхан түүнийг ул мөрийг удахгүй олно гэж

зүрхлэн хэлэх байна гээд Амбриж шатны дэргэд хөдөлж ядан зогсож байсан Харри, Рон, Гермиона гурав руу уурсан хялалзав. Рон гутлын үдээсээ үдэж буй дүр эсгэлээ.

- Магадгүй л юм! Гэхдээ би Дамблдорыг хүсээгүй үедээ олдоно гэдэгт эргэлзэж байна! Би түүний хувиргалын хичээлийн шалгалтыг авч байсан юм ... Саваагаа тэгж хөдөлгөдөг хүнийг би амьдралдаа харж байгаагүй!

- М-м ... тийм л дээ гэж Амбриж бувтнав. Харри, Рон, Гермиона гурав гантиг шатаар хөлөө зөөн өгслөө.

- Таныг багш нарын өрөөнд аваачихыг зөвшөөрнө үү. Ийм аялалынхаа дараа аяга цайнаас татгалзахгүй биз дээ?

Үдшийн үлдсэн хэсэг уйтгартай өнгөрөв. Бүгд сүүлчийн хоромд юм давтахыг оролдсон ч төдийлөн амжилт гаргасангүй. Харри орондоо эрт орсон ч нойр нь хүрэлгүй удаан хэвтлээ. Тэр мэргэжил сонголтын зөвөлгөөн дээр МакГонагалл түүнийг мракоборец болоход туслана гэж уурсан мэдэгдсэнийг саналаа. Одоо шалгалтын өмнө арай даруухан санаа олоогүйдээ харамсаж байв.

Өглөөний цайн дээр тавдугаар дамжааныхан хоорондоо бараг ярилцсангүй. Парвати хамар дороо шившлэг бувтнаж, Гермиона «Шившлэгийн шинжлэх ухааны ололт амжилт» гэдэг номыг хурдтай гүйлгэн уншиж, Невилл хагас хором тутамд хутга сэрээгээ жимсний чанамал руу дүрж байв.

Өглөөний цай дуусахад тав болон долдугаар дамжааныхан үүдний танхимд үлдэж бусад сурагчид хичээлдээ явлаа. Дараа нь есөн цаг гучин минутад анги ангиараа Их танхимд ороход Харрийн гүн ухааны цүнхээлд харсны адил дөрвөн тэнхимийн ширээг хурааж танхимын төгсгөл хүртэл ширээ эгнүүлэн тавилжээ. Профессор МакГонагалл багш нарын ширээний урд зогсож байв. Бүгд байрандаа суусан хойно «За, эхлэе» гээд том элсэн цаг эргүүлэн тавилаа. Түүний хажууд нөөц үзэг, бэхийн сав, хуйлаастай цаас байлаа.

Харри зүрх нь булгилсаар цаасаа эргүүлэв. Гермиона баруун талд нь дөрвөн эгнээний цаана суусан бөгөөд хэдийн хурдтай бичиж эхэлжээ. Тэр эхний асуулт руу нүдээ гүйлгэв. А). Шившлэг ашиглан Б). Савааны тусламжтай биетийг хэрхэн нисгэх тухай зураглан бичнэ үү гэжээ.

Харрийн толгойд царсан бороохой агаарт хөөрч савдагын толгой дэлсэж буй бүүдгэр дүр зураг зурсхийв ... Тэр үл мэдэг инээмсэглээд цаас руугаа бөхийн бичиж эхлэв.

- За яасан муугүй биз дээ? Би Хөгжилтэй шидийн талаар зөв бичсэн гэдэгтээ итгэлтэй биш байна. Надад цаг хүрэлцээгүй ... Ингэхэд та нар зогьсуулахын эсрэг шившлэгийг бичсэн үү? Минийх хэтэрхий их болсон байх гэж айж байна ... харин хорин гуравдугаар асуултын хувьд бол ... гэж Гермiona хоёр цагийн дараа үүдний танхимд шалгалтын цаасаа барин асуулаа.

- Гермiona энэ чинь өнгөрсөн явдал шүү дээ. Бид нар ямар давтаж өгөх гэж байгаа биш. Миний хувьд нэг л хангалттай гэж Рон хэлэв.

Тавдугаар дамжааныхан хамтдаа хооллоод (дөрвөн тэнхимийн ширээ ахин гарч иржээ) дараа нь Их танхимын хажуугийн жижиг өрөөнд орж дадлагын ажлаа өгөхөөр хүлээв. Төдхөн тэднийг цагаан толгойн үсгээр жижигхэн бүлэг болгон хувааж хэсэг хэсгээр нь дуудахад дарааллаа хүлээж байх зуур нам дуугаар шившлэг давтан, савааны хөдөлгөөнөөр сургуулилж, үе үе санамсаргүй хөршийнхөө нүд юмуу нуруу руу хатгаж байлаа.

Герминагийн нэр гарлаа. Тэр чичирсээр Энтони Голдстейн, Грегори Гойл, Дафной Грингласс нарын хамт гарав. Шалгалтанд орсон хүмүүс эргэж ирээгүй болохоор Харри, Рон хоёр Гермiona юу болж өнгөрснийг мэдсэнгүй.

- Түүнд санаа зовох хэрэггүй дээ. Шившлэгийн шалгалтаа зуун арван хоёр хувь өгснийг санаж байна уу? гэж Рон хэлэв.

Арван хормын дараа профессор Флитвик ирлээ.

- Пэнси Паркинсон! Падма Патил! Парвати Патил! Харри Поттер!

- Амжилт хүсье гэж Рон нам дуугаар хэлэв. Харри саваагаа чанга атгаад Их танхимд орлоо.

- Профессор Тофти чөлөөтэй байна, Поттер гэж хаалганы хажууд зогсож байсан Флитвик хэллээ. Тэр Харрид алсын буланд жижигхэн ширээний ард сууж байгаа халзан толгойтой хамгийн хөгшин эрэгтэй хүнийг заав. Түүнээс холгүй профессор Марчбэнкс суугаад Драко Малфойгоос шалгалт авч байв.

- Тэгэхээр та Поттер юм биз дээ? Нөгөө алдарт Поттер уу? гэж профессор Тофти бариултай нүдний шилнийхээ цаанаас асуулаа.

Харри нүднийхээ булангаар Малфой ууртай хяламхийхийг хартал Левитацийн шившлэгээр хөөргөж байсан шилэн аяга нь газар унаад хагарлаа. Харри биеэ барьж

чадалгүй инээвхийлэв. Профессор Тофти дэмжингүй инээмсэглэлээ.

- За сайн байна бухимдах хэрэггүй. Харин одоо энэ өндөгтэй тавиурыг хэдэн удаа эргэлдүүл дээ.

Харрийн хувьд муугүй болох шиг санагдав. Түүний Левитацийн шившлэг Малфойнхоос хамаагүй дээр боллоо. Гэсэн хэдий ч өнгө солих шидийг өсгөх шившлэгтэй андуураад шаргал өнгөтэй болгох ёстой хархаа доргоны хэмжээтэй болгон томруулчихлаа. Харри алдаагаа засмагц дэргэд нь Гермiona байсангүй явдалд баярлаж шалгалтын дараа энэ тухай хэлэхгүй байхаар шийдэв. Зөвхөн Ронд энэ тухай ярилаа. Тэр тавгийг том мөөг болгон хувиргасан бөгөөд яаж ингэсэн болохоо ч мэдэхгүй байв.

Үдэш амрах цаг байсангүй. Тэд хоолны дараа шууд амралтын өрөөнд очиж маргаашийн хувиргалын шалгалтанд бэлтгэв. Эцэст нь Харриг орондоо орох үед толгойд нь шившлэгийн ярвигтай хэцүү онолууд эргэлдэж байв.

Өглөө нь бичгийн шалгалтан дээр Байр солих шидийн тодорхойлолтыг мартаж дадлагын ажлаа муу өглөө. Юутай ч гүрвэлээ алга болгох үед, золгүй Ханна Аббот зэргэлдээх ширээнд будилж гүйцээд өмхий хүрэнг сүрэг шувуу болгон хувиргаж үр дүнд бүх шувууг Их танхимаас хөөх гэж арван хором боллоо.

Лхагва гаригт тэд ургамал судлалын шалгалт өгөв (Хэрвээ соёотой шимтгэлэй цэцгэнд хазуулсаныг эс тооцвол Харри бүгдийг сайн өгжээ). Харин пүрэв гаригт хар урлагаас хамгаалах хичээлийн шалгалт өглөө. Энд л Харри анх удаагаа итгэлтэй байхаа мэдэрчээ. Тэр бичгийн асуултанд төвөггүй хариулж, дадлагын ажил дээр Бамбай шидийг үүдний дэргэд зогсож байсан Амбрижийн нүдэн дээр сэтгэл хангалуун хийв.

- Зүйтэй, зүйтэй! гэж Харриг ахин шалгаж байсан профессор Тофти (Энэ удаад тэр ахин Харриг шалгаж байв) Богартыг алга болгоход дуу алдаад,

- Гайхалтай! Энэ бүхэн чинь сайн байна, Поттер ... гэхдээ ... гэв. Тэр урагш бага зэрэг бөхийлөө.

- Би ойрын найз Тиберия Огденоос чамайг Патронусын шидийг дуудаж чаддаг гэж сонслоо ... Үзүүлж болохгүйсэн болов уу. Мэдээж нэмэлт оноо тавих болно ...

Харри саваагаа өргөөд Амбриж руу харлаа.

- Экспекто патронум!

Түүний саваанаас мөнгөлөг буга гарч танхимын төгсгөл хүртэл давхилаа. Бүх шалгалтынхан түүнийг мөнгөлөг утаа болтол дагуулан харахад профессор Тофти хөөрөн алга ташлаа.

- Маш сайн байна! Их сайн байна, Поттер явж болно!

Тэр Амбрижын дэргэдүүр өнгөрөхдөө харц тулгарлаа. Түүний царайд хорон инээмсэглэл тодорсон хэдий ч үүнийг тоосонгүй. Хэрвээ тэр эндүүрээгүй бол зөвхөн онц дүн авах болно.

Баасан гаригт Харри, Рон хоёр амарч, Гермиона эртний дүрс бичгийн шалгалтыг өглөө. Урд нь бүтэн долоо хоног байсан тул найзууд амарч бэлтгэхээр шийдэв. Тэд эвшээлгэн суниасаар шидэт шатар тоглоход онгорхой цонхоор зуны сэвшээ салхи орж ирлээ. Алсад ойн цоорхойд Хагрид бага ангийхнийг хичээлд нь дагуулан явж байв. Харри тэдний ямар амьтан судалж байгааг таахыг оролдоод ганц эвэрт байх гэж бодлоо. Тэгтэл хөргөн нүх нээгдэж Гермиона ааш муутай орж ирэв.

- За ямар болж өнгөрөв дөө? гэж Рон эвшээн асуув.

- Би эхвазыг буруу орчуулчихсан. Энэ чинь «нөхөрлөл» гэсэн үг болохоос «хамгаалалт» биш. Би түүн дээр будилчихлаа гэж Гермиона уурсан хэлэв.

- За боль доо. Энэ чинь ердөө ганцхан алдаа байна шүү дээ. Чи ямар ч гэсэн дүнгээ авч л таараа ... гэж Рон залхуутай дуугарлаа.

- Амаа тат! гэж Гермиона дүрсхийгээд,

- Заримдаа ганцхан алдаа шалгалтын хувь заяаг бүхэлд нь өөрчилдөг юм.

Ингэхэд хэн нэгэн Амбрижиын өрөөнд ахиад нюхлер оруулчихсан байна. Түүнийг шинэ хаалгаар яаж нэвтрүүлснийг ойлгох юм алга. Би сая түүгээр өнгөрөхдөө Амбрижын орилж байхыг сонслоо. Магадгүй хөлөөс нь хазсан байх ... гэв.

- Сайхан хэрэг гэж Харри, Рон хоёр зэрэг хэлэв.

- Тийм бишээ! Та нар мартаа юу? Тэр үүнийг Хагридын хийсэн хэрэг гэж бодож байгаа! Хэрвээ түүнийг хөөчихвөл яах болж байна!

- Тэр одоо хичээлтэй байгаа. Түүнийг буруутгаж чадахгүй гээд Харри цонхны зүг зангав.

- Заримдаа чи хэтэрхий гэнэн байх юм, Харри. Чи түүнд үнэхээр баталгаа хэрэгтэй гэж бодож байна уу? гээд Гермиона тайвширч чадсангүй. Тэр охидын

унтлагын өрөө рүү ороод хаалгаа чанга саван хаалаа.

- Эелдэгхэн охины аймшигтай араншин гэж Рон бувтнаад бэрсээ түлхэн Харрийн морийг идлээ.

Гермиона бараг бүтэн долоо хоногийн турш ааш муутай байсан учир Харри, Рон хоёр үүнийг тоосонгүй амралтын өдрүүдийг даваа гаригийн уусмалын хичээлийн шалгалтанд бэлтгэн өнгөрүүлээ. Шалгалтан дээр Харри таагүй явдал хүлээж байгаа гэдэгт итгэлтэй байв. Түүний мракоборец болох найдлага бөхжээ. Тэгтэл ч үнэхээр бичгийн шалгалт хүнд байсан бөгөөд зөвхөн Хувиргагч уусмал дээр Харри хамгийн дээд оноо авлаа. Тэр хоёрдугаар дамжаандаа энэ хориотой уусмалыг хэрэглэж байсан болохоор үйлчлэлийг нь тодорхой бичжээ.

Ингээд үдийн хоолны дараа болох дадлагын ажлаас эмээж байсан ч дэргэд нь Снегт байгаагүй болохоор тогооны өмнө өөрийгөө илүү чөлөөтэй мэдэрлээ. Харрийн дэргэд зогсож байсан Невилл ч гэсэн уусмалын хичээлд байдгаас илүү хөгжилтэй харагдав. Профессор Марчбэнкс «Тогооноосоо алхам холдоно уу. Таны цаг дууслаа» гэж хэлэх үед Харри шилэн саваа бөглөхдөө сайн дүн авахгүй байх гэж бодсон ч золоор унасангүй.

- Ердөө дөрвөн шалгалт үлдлээ гэж Парвати Патил Гриффиндорын амралтын өрөө рүү буцах үед ядрангуй хэлэв.

- Зөвхөн гэнээ! хэмээн Гермиона тасхийгээд,

- Би одоо шидэт тооны ухаан өгөх ёстой. Миний бодлоор хамгийн хэцүү нь байх гэв.

Бүгдэд түүнтэй маргалдахгүй байх ухаан хангалттай байсан тул тэр уур хилэнгээ амралтын өрөөнд хэтэрхий чанга инээлдлээ хэмээн нэгдүгээр дамжааныханд гаргав.

Мягмар гаригт шидэт амьтны хичээлийн шалгалт эхлэв. Харри Хагридад цохилт өгөхгүйн тулд бүгдийг яг таг гүйцэтгэхийг хичээв. Дадлагын хичээл Хориотой ойн захын нугад боллоо. Сурагчид арваад үхэр зараан дунд нуугдсан нарлаг тогтоон таньж, лукотрустэй хэрхэн харьцахыг үзүүлж, галт наймаалжыг галд нь өртөлгүй тэжээн цэвэрлэж, олон төрлийн хоолноос ганц эвэртэд хор учруулахгүйг нь сонгох ёстой байлаа.

Харри Хагридыг овоохойн цаанаас сэтгэл зовон шагайхыг харав. Шалгагч болох

булцгар эмэгтэй инээмсэглээд явж болно гэж хэлэхэд Харри түүнд сэмхэн эрхий хуруугаа гозойлгоод шилтгээн рүүгээ буцлаа.

Одон орны бичгийн шалгалт лхагва гаригийн өглөө элдвийн зүйлгүй өнгөрөв. Харри Бархасвадь гаригийн дагуулуудыг бүгдийг нь зөв нэрлэсэн гэдэгтээ итгэлгүй байсан ч тэдний дунд арслан оршин суудаггүй гэдэгт эргэлзсэнгүй. Одон орны дадлагын сорилтыг оройн хоолны дараа өгөх болохоор оронд нь мэргэ төлгийн хичээлийнхийг өгөв.

Харри эртнээс энэ шинжлэх ухааны сонирхохоо больсон болохоор шалгалт тааруухан боллоо. Тэр ширээн дээрх болор бөмбөлөгнөөс ямар нэг дүр зураг олж харахыг оролдсон ч тунгалаг хэвээр байсан болохоор цайны навчаар мэргэлж байсан үеийнхтэй адил сэтгэлээр унаж профессор Марчбэнксийг өнгөрсөн мягмар гаригт үхэх ёстой байсан гэж хэлжээ.

- Бид нар энэ хичээл дээр үргэлж бүтэлгүйтэж байх юм хэмээн Рон баргар царайлан бувтнаад гантиг шатаар хамтдаа буулаа. Тэр болор бөмбөлөгт сахалтай эрэгтэй хүний дүрс байхыг хараад дараа нь шалгагчын дүрс байсныг илрүүлсэн тухайгаа Харрид ярин тайвшируулжээ.

- Анхнаасаа бид яах гэж энэ тэнэг хичээлийг сонгосон юм бол гэж Харри хэлэв.

- Одоо л татгалзах цаг болж.

- Тийм шүү. Бархасвадь, Тэнгэрийн ван хоёр ойртоход юу болох талаар санаа зовохыг хүсэхгүй байна.

- Харин би аяган дахь цайны навч «Рон үхнэ!» гэж батлаад байвал тэсэж чадахгүй шууд л хогийн саванд хаяна. Тэнд л түүний байх газар.

Харри инээд алдах агшинд Гермiona тэднийг гүйцэв. Тэр түүнийг уурлуулахаас айн инээдээ болилоо.

- Ашгүй шидэт тооны ухааныг хэвийн өглөө. Хоолны өмнөхөн түргэхэн ододын газрын зураг харахаас гэж хэлэхэд хоёул сэтгэл амран санаа алдлаа.

Арван нэгэн цагт тэд одон орны хичээлийн цамхаг руу очиход шөнө цэлмэг байсан болохоор одод гайхалтай сайхан харагдаж байлаа. Шилтгээний эргэн тойрон мөнгөлөг сарны гэрэлд умбан, агаар чийглэг сэрүүн болжээ. Тэд профессор Марчбэнксийн тушаалаар газрын зургаа дүүргэх ажилдаа оров.

Профессор Марчбэнкс, Тофти хоёр тэдний дундуур холхин одод, гаригийн баршилын тэнхлэгүүдийг хэрхэн дуран авайгаар тодорхойлж байхыг харав. Нам гүмийг зөвхөн цаас шарчигнах, дуран авай тохируулах болон цаасан дээр олон тооны үзэг сараачих чимээ эвдэнэ. Хагас цаг өнгөрснөө дараа нь цаг болоход шилтгээний цонхноос газар анивчин тусаж байсан алтлаг дөрвөлжин гэрлүүд ар араасаа алга боллоо.

Харри газрын зураг дээр Орионы ордыг байрлуулж дуусах үед шилтгээний үүдний хаалга нээгдэн чулуун шатны урдах нуга дээгүүр гэрэл гялсхийв. Харри хаалга ахин хаагдаж харанхуй болохоос өмнө дурангаараа доош хараад ногоон дээр тав зургаан урт нарийхан дүрс харлаа.

Харри ахин шагайвраа тохируулж Сугар гариг руу харав. Тэгээд газрын зураг руугаа бөхийсөн ч ямар нэг зүйл анхаарлыг нь татахад үзэг нь цаасан дээрээ хөшиж доошоо хяламхийн хартал зүлгэн дээгүүр зургаан дүрс явж байхыг харлаа. Хэрвээ сарны гэрэл тэдний зулайг гэрэлтүүлээгүй бол харанхуйд ялгахын аргагүй байв. Тэднийг толгойлж байсан намхан дүрс Харрийн танил дүрс байв.

Тэр Амбрижийг үл таних таван хүний хамтаар шөнө дунд болсны дараа хаашаа явж буйг ойлгосонгүй. Тэгтэл ард нь хэн нэгэн ханиалгахад шалгалтан дээр байгаа гэдгээ ухаарлаа. Яаран дурангаа өргөж Сугар гаригийг ахин олж хараад газрын зураг дээр тэмдэглэх гэтэл гэнэтхэн алсад ер бусын чимээ чанга цуурайтахын хамтаар түүнийг дагалдан нохой хуцлаа.

Тэр доошоо харахад зүрх нь хүчтэй дэлсэв. Хагридын цонхноос тусаж буй гэрэлд нуга дээгүүр явж буй хүмүүсийн дүрс тодров. Тэгтэл хаалга нээгдэж босгон дээгүүр зургаан дүрс алхан орохыг тодорхой харлаа. Хаалга хаагдаж нам гүм болов.

Харри дотор тайван бус болов. Тэр Рон, Гермиона хоёрыг харсан эсэхийг мэдэхээр эргэх гэсэн ч энэ агшинд профессор Марчбэнкс ард нь ирсэн тул яаран зураг руугаа бөхийгөөд овоохойн зүг сэмхэн шагайлаа. Овоохойд орсон хүмүүс үе үе цонхны цаана зурсхийн үзэгдэнэ.

Профессор Марчбэнкс шилэн хүзүү рүү нь харж байгаа нь мэдрэгдэхэд Харри хэдийн тогтоосон ч гэлээ ахин дуран руугаа шагайн сар луу харлаа. Түүнийг цааш холдмогц алсад нүргэлэх чимээ гаран одон орны цамхагын орой хүртэл цуурайтайв. Харрийн зэргэлдээх хүмүүс дуран авайгаа овоохойн зүг чиглүүлэв.

Профессор Тофти хоолой засан ханиалгалаа.

- Найзууд минь төвлөрцгөө гэж аяархан хэллээ.

Ихэнхи сурагчид дуран руугаа буцав. Харри зүүн тийш хараад Гермiona бас овоохойн зүг харж байхыг ажиглав.

- Кхм ... хорин хором үлдлээ гэж профессор Тофти сануулав.

Гермиона цочоод газрын зураг руугаа эргэлээ. Харри өөрийнх рүүгээ хараад Сугар гаригийг Ангараг гэж нэрлэсэн алдаагаа олж харав. Тэр бөхийгөөд засан бичлээ.

Дор ямар нэг зүйл чанга түсхийлээ. Хэдэн хүүхдүүд цочин дуу алдаад юу болсныг харахаар дурангаа яаран чиглүүлэв.

Хагридын хаалга нээгдэж овоохойноос гэрэл цэлсхийн тусахад үүдэн дээр эзнийх нь нүсэр дүрс гарч ирлээ. Тэр уурсан хилэгнэж нударга зангидан хашгирах агаад тойрон хүрээлсэн зургаан хүн түүний зүг нарийхан улаан оч илгээж буйгаас үзэхэд Хөшөөх шид хэрэглэж байгаа бололтой.

- Үгүй! гэж Гермiona хашгирлаа.

- Хонгор минь! Бид шалгалтан дээр байна! гэж профессор Тофти уурсангуй хэлэв.

Гэхдээ хэн ч ододын газрын зураг руугаа анхаарал хандуулсангүй. Хагридын овоохойн ойролцоо улаан оч цацрах хэдий ч тэр босоо хэвээр үзэлцэж байв. Орилж хашгирах чимээ сургуулийн бүх нутаг дэвсгэрээр хадахад хэн нэгэн «Хагрид ухаалаг байж үз!» гэж хашгирлаа.

- Долиш! Ухаалаг гэдгийг чинь чөтгөр аваг. Та нар намайг тийм амархан барихгүй шүү! гэж Хагрид хариу хашгирав.

Харри Соёотын жижигхэн дүрс эзнээ хамгаалахыг хичээн тойрон хүрээлсэн шидтэнгүүдийн хүрээ рүү цовхчиход Хөшөөх шившлэг илгээн унагахыг нь харлаа. Хагрид уурсан орилоод гэмтэнг агаарт өргөн чулуудахад арван алхамын зайд унаад ахиж босож ирсэнгүй. Гермiona дуу алдан амаа дарав. Харри Роныг бас айсан төрхтэй байхыг нь ажиглав. Тэдний хэн ч Хагридыг жинхэнээсээ уурласан байхыг харж байсангүй.

- Хараач! гэж Парвати дуу алдаад шилтгээний үүд рүү заахад хаалга ахин нээгдэж харанхуй нуга дээр гэрэл туслаа. Овоохойн зүг ахин нэг өндөр дүрс

ухасхийлээ.

- Энэ чинь утгагүй хэрэг! Ердөө арван зургаан минут үлдээд байна! гэж профессор Тофти дуу алдав.

Гэвч хүүхдүүд түүний үгийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлээд сүүлчийн оролцогч гүйсээр тэмцэл болж буй газар хүрэхийг харлаа.

- Та нар яаж зүрхэлж байна! Та нар яаж зүрхлэв ээ! гэж гүйж байсан хүн хашгирлаа.

- МакГонагалл байна! гэж Гермiona шивнэв.

- Түүнийг тайван орхи! Даруйхан! гэх МакГонагаллын хоолой харанхуйд гарч, Та нар ямар шалтгааны улмаас дайрч байгаа юм бэ? Тэр буруутгагдахаар зүйл юу ч хийгээгүй ... гэв.

Гермiona, Парвати, Лаванда гурав зэрэг часхийн орилов. Овоохойн гадаа байсан хүмүүс тэнхимийн эрхлэгчийг угтан дөрвөөс доошгүй Хөшөөх шившлэг илгээлээ. Овоохой хүрэх замын хагаст улаан оч түүнийг оноход МакГонагаллын дүрс агшин зуур газар унаад хөдөлсөнгүй.

- Намайг луу идээсэй! Ямар ч анхааруулгагүй шүү! Энэ чинь дэндүү явдал! гэж профессор Тофти шалгалтан дээр байгаагаа мартаад уулга алдав.

- Хулчгарууд! гэж Хагрид дэлбэрэв. Түүний үг цамхагын орой хүртэл цуурайтан шилтгээний хэдэн цонхноос гэрэл аслаа.

- Өрөвдөлтэй хулчгарууд! Авцгаа! Үүнийг та нарт!

- Өө, бурхан минь! гэж Гермiona уулга алдлаа.

Хагрид ойртож ирсэн хоёр хүнийг хүчирхэг цохилтоор угтахад дороо унасныг үзвэл цэвэр нам цохьсон бололтой. Харри Хагридыг хоёр ч шившлэгт өртөн гуйвахыг нь харлаа. Гэхдээ үгүй бололтой дараагийн агшинд Хагрид шуудайтай юм үүрэн босч ирэхэд Харри Соёотын бие болохыг ойлгов.

- Түүнийг барь, барь! гэж Амбриж орилсон хэдий ч сүүлчийн туслагч нь Хагридын нударганд өртөхийг яарсангүй эсрэгээрээ ухрахдаа газар ухаангүй хэвтэж байсан хүний биед бүдрээд уналаа. Хагрид эргээд Соёотыг хүзүүгээрээ давуулан зугтлаа. Амбриж түүний араас ахин нэг Хөшөөх шившлэг илгээсэн ч нэмэр болсонгүй хаалгаар гарч харанхуйд алга болов.

Нам гүм болоход мэгдсэн сурагчид доош нүд салгалгүй ширтэв. Тэгтэл профессор Тофтигийн сулхан дуу гарч,

- Э-э ... та нарт таван хором үлдлээ гэв.

Хэдийгээр Харри газрын зургаа барагтайхан дүүргэсэн ч гэлээ шалгалтын төгсгөлийг цөхрөн хүлээлээ. Таван хором өнгөрөхөд тэр Рон, Гермiona хоёрын хамтаар дуран авайгаа аваад эргүүлгэн шатаар буулаа. Сурагчдын хэн ч ор луугаа явсангүй бүгд шатны хөлд ярилцан зогслоо.

- Өөдгүй хулчгар! Хагридыг шөнө дунд дайрна гэнээ! хэмээн Гермiona дуу алдав. Тэр уурласандаа болоод арай ядан дуугарч байлаа.

- Амбриж гарцаагүй түүнийг Трелонигийн адил зайлуулахыг хүссэн байна гэх Эрни Макмилланы дуу гарав.

- Хагрид, сайн байна! гэж Рон түгшихээсээ илүү хөөрөн хэлээд,

- Түүнийг яагаад шившлэг унагаж чадсангүй вэ? гэлээ.

- Магадгүй аварга биетийн цуснаас болсон байх. Авагра биетүүдийг шившлэгээр хөшөөхөд туйлын бэрх. Тэд яг л савдаг гэсэн үг ... хөөрхий МакГонагалл ... дөрвөн Хөшөөх шившлэг шууд цээж рүү нь оносон гэтэл тэр чинь настай хүн шүү дээ! гэж Гермiona чичирсэн хоолойгоор хэлэв.

- Аймшигтай юм гээд Эрни толгойгоо сүржин сэгсэрснээ,

- За би явж унтлаа. Бүгдээрээ баяртай! гэв. Хүүхдүүд харсан зүйлийнхээ талаар ярилцсаар тарлаа.

- Ямар ч гэсэн Хагридыг Азкабанд суулгаж чадсангүй. Тэр Дамблдор луу явсан болов уу? Юу гэж бодож байна? гэж Рон хэлэв.

- Магадгүй л юм. Ямар аймшигтай юм бэ! Би Дамблдор удахгүй эргэж ирнэ гэж найдаж байтал оронд нь Хагридыг алдлаа! гэж Гермiona уйлах шахан дуугарав.

Тэднийг Гриффиндорын амралтын өрөө рүү буцахад дүүрэн хүнтэй байв. Овоохойн гадна дэгдсэн чимээ шуугиан нилээн олон хүнийг сэрээжээ. Симус, Дин хоёр Харри, Хон, Гермiona нартай одон орны цамхагт харсан зүйлийнх нь талаар ярилцлаа.

- Хагридыг яагаад халж байгаа юм бол? Тэр ямар Трелони биш. Энэ жил хамаагүй дээр байсан биз дээ! гээд Анжелина Жонсон толгой сэгсэрлээ.

- Амбриж хагас цусны хүмүүсийг үзэн яддаг юм. Тэр эртнээс Хагридыг хөөхөөр оролдсон гэж Гермiona гашуунаар хэлээд сандал дээр суулаа.
- Бас тэр Хагридыг өрөөнд нь нюхлер оруулсан гэж бодож байгаа гэх Кэти Беллийн дуу гарав.
- Өө, чөтгөр гэж хэмээн Ли Жордан амаа дарлаа. Би түүнийг оруулсан шүү дээ. Фред, Жорж хоёр надад хэдэн зүйл үлдээсэн болохоор цонхоор нь хөөргөөд оруулсан юм.
- Түүнийг ямар ч гэсэн халах л байсан. Тэр Дамблдортой хэтэрхий ойрын холбоотой гэж Дин хэллээ.
- Яг үнэн гээд Харри Гермionaгийн хажуу талд суулаа.
- Профессор МакГонагаллыг зүгээр гэдэгт найдаж байна хэмээн Лаванда уйлагнан хэлэв.
- Түүний шилтгээнд буцааж авчирахад бид унтлагын өрөөний цонхоор харсан. Тийм ч сайн харагдахгүй байсан гэж Колин Криви хэлэв.
- Хатагтай Помфри түүнийг даруйхан хөл дээр нь босгочихно. Тэр гайхамшигтай сувилагч шүү дээ гэж Алисия Спиннет хатуу хэллээ.

Ойролцоогоор өглөөний дөрвөн цагт амралтын өрөө хоосорлоо. Харри сэрүүн хэвтэн Хагридын зугтах үеийг ахин дахин санаж Амбрижад уурссандаа болоод хамгийн муугаар шийтгэх тухай бодоход Рон өлсгөлөн соплохвост оруулахыг санал болгов. Тэр өс хонзон авах талаар бодсоор унтаад гурван цагийн дараа босохдоо амарч чадаагүй байлаа.

Сүүлчийн шалгалт болох ид шидийн түүхийн шалгалтыг үдийн хоолны дараа өгөх байв. Харри өглөөний цайны дараа орондоо эргэж ирээд толгойгоо гараараа барин зүүрмэглэхгүйг хичээн цонхны хажууд суугаад Гермionaгийн түр зээлдүүлсэн тэмдэглэлийг уншихыг оролдов.

Хоёр цагаас тавдугаар дамжааныхан Их танхимд ороод өөрсдийн байраа эзлэн шалгалтын цаасаа эргүүлэхийг хүлээв. Харри ихэд ядарчээ. Тэр зөвхөн энэ бүхнийг түргэн дуусгаад унтаж амрахыг хүсч байв. Маргааш Ронтой цэнгэлдэх хүрээлэн явж

шинэ шүүрийг нь туршиж үзээд эрх чөлөөний амтыг мэдрэх болно ...

- Цаасаа эргүүлнэ үү. Эхэлцгээ гэж профессор Марчбэнкс элсэн цагийг эргүүлж тавиад хэлэв.

Харри эхний асуултыг дүйнгэтэн харлаа. Хэдэн хормын турш ширтээд нэг ч үг ойлгосонгүй. Хаа нэгтээ цонхон дээр ялаа дүнгэнэж төвлөрөхөд саад болов. Удаан зовсны эцэст анхаарлаа төвлөрүүлээд уншиж эхлэв.

Түүнд нэр усыг санахад их хэцүү байсан болохоор дараа нь хариулахаар дөрвөн асуулт алгасав. (Арван наймдугаар зууны үеийн албингийн бослогын дараа шидэт саваа эзэмшихийг үгүйсгэсэн хууль гарсан талаар юу гэж бодож байна?) Тэр тавдугаар асуулт руу зоригтой дайрлаа (1749 оны нууцын тухай хуулийг хэн зөрчсөн бэ). Тэр энэ талаар мартсан хэдий ч энэ нь ямар нэгэн цус сорогчтой холбоотой түүх шиг санагдав.

Цааш нь хариулж болох асуулт эрэн цааш аравдугаар асуултыг харлаа. (Олон улсын шидтэнгүүдийн холбоо яагаад Лихтенштейний шидтэнгүүдийг элсүүлэхээс татгалзсан нөхцөлийн талаар тодорхой бичнэ үү)

Би үүнийг Гермionaгийн «Олон улсын шидтэнгүүдийн холбооны бүрэлдэхүүн» гэдэг тэмдэглэлээс өнөөдөр уншсан юм байна шүү дээ гэж Харри бодлоо.

Тэр бичиж эхлэхдээ үе үе профессор Марчбэнксийн хажуугийн ширээн дээр байх том элсэн цаг руу харж байлаа. Түүний урд урт хар гэзгээ нуруу руугаа унжуулсан Парвати Патил суужээ. Хоёр гурван ч удаа түүнийг толгойгоо сэргээхээр сэгсрэхэд нь жижигхэн алтан гэрэл гялсхийхийг харлаа.

«Олон улсын шидтэнгүүдийн холбооны нийгэмлэгийн анхны ерөнхийлөгч болох Пьер Бонаккор Лихтенштейний шидтэнгүүдтэй маргалдсаны учир нь ...»

Харрийн эргэн тойронд сүрэг харх гүйлдэх мэт үзэгний чимээ чахарч байв. Нар шилэн хүзүү рүү нь халуу оргитол төөнөв. Яагаад Бонаккорд шидтэн Лихтенштейнийг доромжилсон юм бол? Харрид энэ нь ямар нэг савдагтай холбоотой гэсэн сэтгэгдэл төржээ ... Тэр ахин Парватигийн үс рүү харав. Хэрвээ легилменцийг эзмэшсэн бол түүний шилэн хүзүүний хонхорхойноос Пьер Бонаккорд Лихтенштейний шидтэнгүүдтэй зөрчилдөхөд савдаг ямар хамаатайг унших юмсан ...

Харри нүдээ аниад халуу оргисон нүүрээ алгаараа дарахад зовхиных нь доторх

алтлаг гэрэл бөхөж харанхуй сэрүүн боллоо. Бонаккорд савдаг агнахыг хориглохыг хүссэн ... гэхдээ Лихтенштейний овогт харгис догшин савдгууд байдаг ... Аанхан, саналаа!

Тэр нүдээ нээтэл цаасанд гялбан нулимс цийлэгнэв. Тэр удаанаар савдгын тухай хоёр мөр бичээд дараа нь бичсэнээ уншлаа. Тиймээ түүний ажил Гермionaгийн тэмдэглэлд бичсэнтэй адил тодорхой болсонгүй бололтой.

Тэр ахин нүдээ аниад үүнийг төсөөлөн санахыг хичээлээ ... эхлээд холбооноос Францад тэдэнтэй уулзсан ... тиймээ энэ тухай хэдийн бичсэн ... албинуудыг бослогын дараа хөөн гаргасан ... энэ тухай ч бас бичсэн ... харин Лихтенштейнээс хэн ч ирээгүй ...

«Бод» гэж тэр өөртөө тушаагаад нүүрээ алгаараа даргал эргэн тойронд ахин үзэг чухарч төгсгөлгүй асуулт хариулан, цагны нарийхан нүхээр элс гоожин ...

Тэр ахин нууцын хэлтсийн хүйтэн харанхуй хонгилоор итгэлтэй алхаж байлаа ... ердийнхөөрөө хар хаалга урд нь нээгдэхэд олон тооны хаалгатай дугуй өрөөнд орлоо

...

Урд нь чулуун шалтай хоёр дахь хаалга нээгдэхэд ... ханан дээр гэрэл анивчин бүжиглэж хачирхалтай эдлэл чагхийн дуугарч гэхдээ түүний учрыг нь олж байх цаг алга тэр яарах хэрэгтэй ...

Тэр ахин хэдэн алхам хийн гурав дахь хаалгаар орлоо ...

Ингээд ахин сүм шиг уужим танхимд орж шилэн бөмбөлөгтэй тавиурууд эгнээ эгнээгээр үргэлжилнэ ... зүрх нь түргэн цохиллоо ... тэр одоо л хэрэгтэй газраа хүрэх нь байна ... ерөн долдугаар эгнээнд хүрээд зүүн тийш эргэн эгнээ хоорондын жигүүрээр явлаа ...

Эгнээний төгсгөлд хүрэхэд шалан дээр ямар нэг хар дүрс шархадсан амьтан шиг атиралдан хэвтэж байлаа. Харри айсандаа зүрх нь ёгхийлээ ...

Тэгтэл түүний дотроос хүйтэн хоолой сонсогдож,

- Түүнийг надад өг ... би түүнд хүрч чадахгүй ... харин чи чадна гэв.

Шалан дээр байсан хар дүрс хөдлөв. Харри саваа барьсан урт цагаан хуруу урд нь өргөгдөхийг харлаа ... энэ чинь түүний гар байна шүү дээ ... тэгтэл ахин өөрийнх нь хүйтэн хоолой сонсогдож,

- Круцио! гэлээ.

Шалан дээр байсан хүн өвдсөндөө хашгиран босохыг хичээсэн ч зовж тарчилсандаа атиралдав. Харри инээлээ. Тэр саваагаа өргөж шившлэгийг зогсооход хүн ёолсноо хөдөлгөөнгүй болов.

- Лорд Волдеморт хүлээж байна шүү!

Тэр удаанаар толгойгоо өргөлөө. Түүний туранхай царай цус болж зовж шаналсандаа үрчийсэн хэдий ч нугаршгүй шийдмэг байв ...

- Чи намайг алах хэрэг гарч дээ гэж Сириус шивнэв.

- Эрт орой хэдий ч тэгэх л болно. Гэхдээ эхлээд чи надад түүнийг өг, Блэк ... Чи ийм маягаар өвдөлт мэдэрсээр л байх уу? Ахин бодоод үз ... бидэнд хангалттай цаг байгаа хэн ч чиний хашгиралтыг сонсохгүй ...

Волдеморт ахин саваагаа өргөмөгц хэн нэг нь цөхрөн хашгираад хүйтэн шалан дээр уналаа. Харри газар унаад хашгиран сэрлээ. Сорви нь тэсэхийн аргагүй өвдөж нууцын хэлтэс гэнэтхэн Их танхимын хана болон хувирав.

БҮЛЭГ 32: ГАЛААС ГАРСАН НЬ

- Би хүсэхгүй байна ... намайг эмнэлэгт хүргэх хэрэггүй ... би явахгүй гэж Харри хэлхээ холбоогүй үг бувтнасаар үүдний танхимд аваачсан профессор Тофтигоос чөлөөлөгдөхийг оролдоход эргэн тойрны хүүхдүүд сониучирхан харлаа.

- Миний ... миний бүх зүйл хэвийн, эрхэмээ. Үнэн шүү ... би зүгээр л унтаад ... хар дарсан зүүд зүүдэлсэн юм гэж Харри духныхаа хөлсийг арчин хэллээ.

- Мэдрэлийн хүчдэл! гэж хөгшин шидтэн өрөвдөнгүй хэлээд Харрийн мөрөн дээр чичирсэн гараараа алгадлаа.

- Залуу хүмүүсийн хувьд байдаг л зүйл! Одоо аяга хүйтэн ус уугаад Их танхимд эргэж очсон нь дээр байх. Шалгалт дуусахаас өмнө сүүлчийн асуултыг хариулж амжина биз дээ?

- Тиймээ гэж Харри сэтгэлээр унан хэлснээ,

- Үгүй ээ ... Би дуусчихсан ... бичиж чадах зүйлээ биччихсэн гэлээ.

- За яахав тэгвэл. Би явж чиний шалгалтын цаасыг хураая. Харин чи ор луугаа явж хэвт гэж тэр аяархан хэллээ.

- Ойлголоо эрхэм ээ. Маш их баярлалаа гэж Харри толгой дохилоо.

Хөгшин шидтэн Их танхимын босго дөнгөж давмагц Харри гантиг шатаар дээш гүйгээд хонгилоор ухасхийхэд ханан дээрх хөргүүд араас нь зэмлэнгүй үглэн үлдлээ. Тэр шат алгасан харайгаад эцэст нь эмнэлгийн жигүүрт хүрмэгц Монтегюгийн аманд цэнхэр өнгийн шингэн хийж байсан хатагтай Помфри цочсондоо хашгирлаа.

- Та галзуураа юу, Поттер!

- Би даруйхан профессор МакГонагаллтай уулзах хэрэгтэй байна! Одоо ... маш яаралтай! гэж Харри амьсгаадан хэлэв.

- Тэр энд байхгүй, Поттер гэж хатагтай Помфри гунигтай хэлээд,

- Өнөө өглөө гэгээн Мунгогийн эмнэлэгт хүргэсэн. Дөрвөн Хөшөөх шившлэг шууд цээж рүү шүү ... энэ ч түүний насан дээр! Тэр амьд үлдсэн нь хачирхалтай юм ...

- Тэр ... байхгүй гэнээ? хэмээн Харри цочирдон хэллээ.

Хаалганы цаана хонх дуугарахад Харри алсад чимээ шуугиан гарч сурагчдын

хонгилд дээш доош гүйлдэхийг сонсов. Тэр хатагтай Помфри руу айдаст автан харлаа.

Тэгэхээр хэнтэй ч зөвлөлдөж чадахгүй нь. Дамблдор сургуулиа орхиж, Хагрид ч гэсэн мөн адил хэрвээ профессор МакГонаглл дэргэд нь байсан бол ... Ширүүн ууртай хэдий ч итгэлтэй ямар найдвартай ...

- Би таныг цочирдсон явдалд гайхахгүй байна гэж хатагтай Помфри ширүүнээр дэмжээд,

- Тэдний нэг нь ч Минерва МакГонагаллтай өдөр дунд нүүр тулахыг оролдсон болоосой! Хулчгар амьтад ... үзлийн муухай хулчгар! Хэрвээ би сурагчид надгүй яах бол гэж санаа зовоогүй бол даруйхан ажлаасаа гарах өргөдлөө өгөх байлаа гэв.

- Тиймээ гэж Харри өнгөгүй хоолойгоор дуугарав.

Тэр хонгилоор эргэн яваад зогсоход сурагчид дэргэдүүр нь түлхэн өнгөрөх хэдий ч хөдөлж чадсангүй. Сандрал хорт хий мэт бүчин авахад толгой нь эргэж юу хийх тухай бодох чадваргүй болов ...

Рон, Гермиона гэж дотоод хоолой нь хэллээ.

Тэр ахин сурагчдын дундуур түлхэн гүйхдээ уурсан хараахыг нь тоосонгүй. Тэр хоёр давхар руу уруудан гантиг шатны орой дээрээс тэдний яаран ирэхийг харав.

- Харри! Юу болсон бэ! Чи зүгээр үү үү? Өвдөөгүй биз дээ! гэж Гермиона айн дуу алдав.

- Чи хаана байсан бэ? гэж Рон шаардангүй асуув.

- Миний араас гэж Харри түргэн хэлээд,

- Явцгаая надад та нарт хэлэх зүйл байна гэлээ.

Тэр тэднийг нэг давхарт дагуулан авчрав. Хоосон анги эрж олоод Рон, Гермиона хоёрыг араас нь босго давмагц хаалга хааж нуруугаараа налаад эргэж харлаа.

- Волдеморт Сириусыг барьжээ.

- Юу?

- Чи хаанаас ...

- Харсан юм. Дөнгөж сая. Шалгалтан дээр унтах үедээ.

- Гэхдээ ... гэхдээ хаана? Яаж? гээд Гермионагийн царай зэвхийрлээ.

- Яаж гэдгийг нь мэдэхгүй байна. Гэхдээ хаана гэдгийг нь мэднэ. Нууцын хэлтсийн тавиуртай шилэн бөмбөлөгтэй ерөөнд байсан. Волдеморт одоо Сириустэй ерөн долдугаар эгнээний төгсгөлд байгаа ... Тэр Сириусыг тэндээс хэрэгтэй зүйлийг нь авахыг хүссэн ... Тэр түүнийг тамлаж байна ... Эрт орой хэдий ч гэсэн ална гэсэн!

Харри зөвхөн өвдөг нь ч төдийгүй хоолой нь чичирч байгааг мэдрэв. Тэр ширээн дээр очиж суугаад тайвширахыг хичээв.

- Бид тийшээ яаж очих вэ? Нам гүм болов.

- Х-хаашаа? гэж Рон дуугарлаа.

- Нууцын хэлтэс рүү очиж Сириусыг аврахын тулд! гэж Харри чанга хэлэв.

- Гэхдээ ... Харри ... гэж Рон сулхан бувтналаа.

- Юу? Яасан гэж?

Харри тэднийг яагаад ухаангүй зүйл хэлсэн мэт ширтээд байгааг нь ойлгосонгүй.

- Харри ... гэхдээ яаж ... Волдеморт яаж нууцын хэлтэст шидтэнгүүдэд ажиглагдахгүй орсон юм бол? гэж Гермиона айн хэлэв.

- Би хаанаас мэдэх юм. Асуудал гэвэл бид тийшээ яаж орох вэ гэдэгт л байна!

- Гэхдээ ... чи өөрөө бодоод үз л дээ, Харри гээд Гермиона алхам ойртлоо.

- Одоо үдээс хойшийн таван цаг ... ид шидийн яаманд дүүрэн албан хаагчид байгаа ... Волдеморт яаж Сириусыг хэнд ч харагдалгүй тийшээ оруулж чадах юм бэ? Харри тэднийг барих чинь том шагнал биз дээ ... чинийхээр бол тэд мракоборецээр дүүрэн барилгад ажиглагдахгүй үлдэнэ гэж үү?

- Би мэдэхгүй байгаа ч Волдемортод үл үзэгдэх цув ч юмуу өөр ямар нэг зүйл байж болно биз дээ! Би нууцын хэлтэст олон удаа байхдаа нэг ч амьд амьтан хараагүй! гэж Харри хашгирлаа.

- Чи тэнд хэзээ ч байгаагүй, Харри. Бүгдийг ердөө зүүдэлсэн хэрэг гэж Гермиона аяархан хэлэв.

- Энэ бол ер бусын зүүд! гэж Харри түүний нүүр лүү хашгираад босч алхам ойртлоо. Тэр мөрнөөс нь бариад дугтрахыг хүслээ.

- Чи тэгвэл Роны эцэгт тохиолдсон явдлыг юу гэж тайлбарлах гэж байна? Би түүнд юу тохиолдсоныг яаж мэдсэн хэрэг болж байна?

- Түүний зөв гэж Рон тайван хэлээд Гермиона руу харав.
- Гэхдээ энэ чинь ... байж боломгүй хэрэг! гэж Гермиона цөхрөн хашгирлаа.
Волдемогт Сириусыг яаж барьж авсан хэрэг болж байна? Тэр Гриммогийн байшинд үргэлж байсан биз дээ?
- Магадгүй Сириус тэсгэлгүй цэвэр агаар амьсгалах гэж гарсан байж болох юм.
Тэр байшинд түүнд гашуун дурсамж төрүүлдэг болохоор ... гэж Рон хэлэв.
- Гэхдээ яагаад ... яагаад Волдемогтод заавал Сириус шаардагдсан гэдгийг нь надад тайлбарлаадах? Тэр яагаад түүнийг ашиглан зэвсэг юмуу хэрэгтэй зүйлээ авах гэсэн юм бол? хэмээн Гермиона зөрүүдлэв.
- Мэдэхгүй үүнд чинь мянган янзын шалтгаан байж болно! Магадгүй Волдемогтод Сириусыг зовохыг харах нь таатай байж болно ... гэж Харри орилов.
- Миний юу бодсоныг сонсооч. Сириусын ах Үхэл залгигч байсан биз дээ?
Магадгүй тэр Сириуст зэвсэгт хүрэх нууцыг хэлсэн юм болов уу? гэж Рон аяархан дуугарлаа.
- Тийм шүү ... ийм л учраас Дамблдор Сириусыг үргэлж цоожтой байлгасан хэрэг! гэж Харри хэлэв.
- Хүлээгээрэй! гэж Гермиона дуу алдав. Намайг, өршөөгөөрэй. Гэхдээ та хоёрт Волдемогт Сириусыг тэнд байлгаж байгаа гэх ямар ч баталгаа байхгүй биз дээ ...
- Гермиона! Харри тэднийг харсан! гэж Рон зандрав.
- За яахав сайн байна. Тэгвэл би үүнийг хэлэх хэрэгтэй болох нь ... гэж тэр айсан хэдий ч шийдэмгий дуугарлаа.
- Юуг?
- Чамайг ... энэ шүүмжлэл биш шүү, Харри! Гэхдээ чи жаахан ... юу гэж ч тайлбарламаар юм дээ ... хүмүүсийг аврах дуртай юм шиг санагдахгүй байна уу!
Харри түүн рүү муухай харлаа.
- Чи юуны тухай яриад байна? Хүмүүсийг аврах дуртай гэдэг чинь юу гэсэн үг юм?
- Юу гэвэл ... чи ... жишээлбэл... өнгөрсөн жил ... нууранд болсон тэмцээнд ... заавал тэгэх ёсгүй байсан ... чи Делакурын дүүг аврах хэрэггүй байсан ... харин чи

жаахан ... аваад ирсэн ...

Харри уурсан толгой сэгсэрлээ. Түүнд үүнийг санахад ичгүүртэй байв.

- Би үүнийг чиний зүгээс талархам зүйл гэдгийг зөвшөөрч байна гэж Гермiona түргэн хэллээ. Түүний царай Харригаас үхтлээ айсан төрхтэй байв.

- Бүгд чамайг жинхэнэ гайхамшигтай зүйл хийсэн гэж бодсон ...

- Ямар инээдтэй юм бэ гэж Харри шүдээ зуун хэлээд,

- Учир нь би Роныг цагаа үрсэн гэж хэлэхэд өөрийгөө баатар гэж төсөөлснөө сайтар ойлгосон ... Чинийхээр бол үүнийг юу гэж хэлэх вэ? Чи намайг ахин баатар болохыг хүссэн гэж хэлэх гээ юу?

- Үгүй ээ үгүй! Би ингэж хэлээгүй! гэж Гермiona яаран хэлэв.

- Тэгвэл чи биднийг цагаа үрж байна гэж хэлэх гэсэн байх нь! гэж Харри орилов.

- Би ингэж л хэлэх гэсэн юм ... Волдеморт чамайг мэднэ, Харри! Тэр Жинниг нууц өрөөнд чамайг занганд оруулахын тулд аваачсан. Тэр чамайг Сириуст заавал туслахаар ирнэ гэдгийг мэдэж байгаа! Тэгээд ч тэр чамайг нууцын хэлтэст хуурч аваачих гэсэн бол яах вэ?

- Гермiona түүний тэгсэн эсэх нь чухал биш! МакГонагаллыг гэгээн Мунгогийн эмнэлэгт аваачсан болохоор Хогвартсад хэлж болохоор бүлгийн гишүүн үлдээгүй. Хэрвээ бид ид шидийн яам руу очихгүй бол Сириус үхнэ!

- Гэхдээ, Харри ... хэрвээ энэ зүүд байсан бол ... ердөө зүүд байсан бол ... Харри уурсах хүчгүй болжээ. Гермiona айсан байртай түүнээс алхам холдов.

- Чи яагаад ойлгохгүй байгаа юм! гэж Харри түүн рүү ориллоо.

- Энэ чинь хар дарсан зүүд биш, ер бусын зүүд ч биш! Чинийхээр бол би яах гэж оккленцийн хичээлд явж, юуны учир Дамблдор намайг энэ зүйлийг харахаа болихыг хүссэн байх вэ? Яагаад гэвэл тэд жинхэнэ, Гермiona. Сириусыг барьсан, би түүнийг харсан! Түүнийг Волдеморттой хамт байгааг хэн ч мэдэхгүй. Ийм учраас бид л түүнийг аврах боломжтой. Хэрвээ үүнд оролцохыг хүсэхгүй бол чиний л хэрэг харин би тийшээ явлаа ойлгомжтой юу. Хэрвээ би зөв санасан бол чи намайг үргэлж хэн нэгнийг аварч байдаг гэж гомдоллохгүй байсан даа. Би чамайг Дементороос

аварсан биз дээ бас гээд Рон руу эргэснээ,

- Бас чиний дүүг василискаас аварсан гэж харамсаагүй биз дээ ... гэв.
- Би хэзээ ч харамсаж байна гэж хэлээгүй! хэмээн Рон дуу алдав.
- Гэхдээ Харри, чи сая хэллээ шүү дээ гэж Гермиона цөхрөнгүй эсэргүүцэв.

Дамблдор чамайг энэ зүйлээс ухаанаа хааж сурахыг хүссэн гэж! Хэрвээ чи окклюменций сурсан бол хэзээ ч ийм зүйл харахгүй байсан ...

- Хэрвээ чи тэгж бодож байгаа юм бол би юу ч хараагүй юм шиг байя л даа ...
- Сириус чамд оюун ухаанаа хамгаалж сурахаас илүү чухал зүйл байхгүй гэж хэлсэн биз дээ!
- Мэдэж байна уу! Тэр одоо гарцаагүй өөр зүйл хэлэх байсан ...

Ангийн хаалга нээгдэхэд бүгд эргэж харлаа. Жинни сониучирхсан байртай орж ирэхэд араас нь Полумна дагалджээ. Полумна ердийнхөөрөө цэвэр санамсаргүй тохиолдоор ирсэн мэт байлаа.

- Сайн уу. Бид Харрийн хоолойг сонслоо. Чи яагаад хашгираа вэ? гэж Жинни итгэлгүйхэн хэлэв.
- Чамд хамаагүй гэж Харри бүдүүлгээр хэлэв. Жинни хөмсгөө өргөлөө.
- Би чамд надтай ийм өнгөөр ярих боломж өгөөгүй шиг санагдах юм. Би зөвхөн тусламж хэрэгтэй юу гэж асуухыг хүссэн юм гэж хүйтнээр хэлэв.
- Үгүй ээ, хэрэггүй гэж Харри товч хэлэв.
- Чи өнөөдөр их бүдүүлэг байх чинь гэж Полумна хэлэв.

Харри хараан цааш эргэлээ. Тэр одоо юунаас ч илүү Полумна Лавгудтай ярихыг хүсэхгүй байв.

- Хүлээгээрэй. Хүлээгээрэй ... Харри тэд тусалж чадах байх гэж Гермиона гэнэтхэн дуугарлаа.

Харри, Рон хоёр түүн рүү харлаа.

- Сонсож бай. Харри бид Сириусыг штабынхаа байранд үнэхээр байхгүй гэдгийг тодруулах хэрэгтэй!
- Би чамд харсан гэж хэлээд байгаа биз дээ ...

- Харри, гуйя чамаас! Гуйж байна. Лондон руу явахаасаа өмнө Сириусыг гэртээ байхгүй эсэхийг шалгаж үзье л дээ. Хэрвээ тэр үнэхээр байхгүй бол тангараглая би чамд саад хийхгүй. Би чамтай хамт явж ... түүнийг аврахын төлөө бүхнийг хийнэ! гэж Гермiona цөхрөн хэллээ.

- Сириусыг одоо тамлаж байгаа! Бидэнд цаг байхгүй! гэж Харри хашгирав.

- Гэхдээ Волдеморт биднийг мэхэлж байвал яах болж байна? Үгүй ээ, Харри бид үүнийг заавал шалгах ёстой!

- Яаж? Бид яаж үүнийг шалгах болж байна? гэж Харри шаардав.

- Амбрижын ханан зуухыг ахин нэг удаа ашиглаад Гриммогийн байшинтай холбогдоё. Амбрижийг ахин сатааруулахын тулд Жинни, Полумна хоёр үзэгчийн дүрд тоглож чадах байх гэж Гермiona өөрийн бодолдоо итгэхгүй мэт айсан шинжтэй хэллээ.

Юу болсныг төдийлөн ойлгоогүй хэдий ч Жинни зөвшөөрсний тэмдэг болгон толгой дохиж харин Полумна,

- Сириус гэж хэн юм бэ жижигхэн сахалтай хүн үү? гэв. Түүнд хэн ч хариу хэлсэнгүй.

- За яахав гэж Харри ууртай бувтнаад Гермionад хандан,

- Хэрвээ чи үүнийг түргэн хийх арга олох юм бол би эсэргүүцэхгүй. Хэрвээ чадахгүй бол нууцын хэлтэс рүү шууд явлаа гэв.

- Нууцын хэлтэс гэнээ? Чи яаж тийшээ хүрэх юм бэ? гэж Полумна гайхширан асуулаа.

Харин ахин энэ асуултыг чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв.

- Тэгэхээр гээд Гермiona хоёр гараа зөрүүлэн урагш хойш алхав. Тэгэхээр ... сайн байна ... бидний нэг Амбрижийг хайж олоод ... мэхэлж өрөөнөөс нь холдуулна. Түүнд жишээлбэл Пивз аймшигтай зүйл бодож олсон гэж хэлж болох юм.

- Би явъя. Түүнд Пивз хувиргалын хичээлийн ангийг сүйтгэсэн гэж хэлнэ. Энэ түүний ангиас хол юм чинь. Ер нь Пивз миний замд тааралдвал би жинхэнээсээ түүнийг хийлгэхээр ятгана гэж Рон даруйхан хэлэв.

Гермiona хувиргалын хичээлийн ангийг сүйтгэх санааг эсэргүүцээгүй ч үйл явдалд ихэд нухацтай хандаж байлаа.

- Сайн байна гэж тэр духаа үрчийлгэн үргэлжлүүлэн холхиж,
- Одоо бид сурагчдыг түүний ангиас холдуулах хэрэгтэй.
Ялангуяа

Слизеринийхэн түүнд заавал хэлнэ гэв.

- Полумна бид хоёр хонгилын үзүүрт зогсоод тийшээ явах гэсэн хүмүүст хоолой боодог хийтэй цаасан буу дэлбэрсэн гэж хэлнэ гээд Жинни Гермионагийн гайхсан царайг олж харснаа,

- Фред, Жорж хоёр үүнийг зохион бүтээсэн ч туршиж амжаагүй юм гэлээ.
- За яахав. Тэгвэл Харри бид хоёр үл үзэгдэх цуван дор нуугдаж Сирустэй ярилцахын тулд өрөөнд ороод ...

- Тэр тэнд байхгүй, Гермиона!

- Би зөвхөн шалгах тухай ярьж байна ... Сириус тэнд байгаа эсэхийг шалгаад болно. Чи тийшээ ганцаараа орж болохгүй. Ли цонхоор нюхлер оруулж сул газар гэдгийг нь баталсан биз дээ.

Хэдийгээр уурсаж тэвчээр алдаж байсан ч гэлээ Харри Гермионад Амбрижийн өрөөнд хамт ороход бэлэн явдалд талархаж байлаа. Тэр үүнийг үнэнч нөхөрлөлийн тэмдэг гэдгийг ойлгож байв.

- Би ... за яахав, баярлалаа гэж бувтнав.

- Сайн байна. Хэрвээ энэ бүтвэл бидэнд таваас илүүгүй хором хэрэгтэй гэж

Гермиона төлөвлөгөөг нь зөвшөөрсөн явдалд сэтгэл амран хэлээд,

- Тэгэхгүй бол дурын агшинд Филч юмуу зэвүүн Шалгалтын бүлгийнхний хэн нэг нь ороод ирж болох юм гэв.

- Таван хором байхад хангалттай. За явцгаая гэж Харри хэллээ.

- Одоо юу? гэж Гермиона цочирдон асуулаа.

- Мэдээж одоо! гэж Харри уурсан хэлээд,

- Чи арай эхлээд оройн хоолонд орох гэсэн юм биш биз дээ? Гермиона, Сириусыг одоо тамлаж байгаа! гэв.

- Би ... за яахав гэж тэр цөхрөн дуугарлаа.

- Чи явж үл үзэгдэх цуваа аваад Амбрижийн хажуугийн хонгилд уулзацгаая.

Тохиролцов уу?

Харри хариулахын оронд ангиас үсрэн гарч сурагчдын дундуур зүсэн гүйлээ. Хоёр давхар өгсөөд Симус, Дин хоёртой уулзахад баяртайгаар амралтын өрөөнд шалгалт дууссаны баяр тэмдэглэх гэж байгаа гэж мэдэгдэв. Харри тэдний яриаг бараг сонссонгүй. Тэр хөргөн нүхээр ороход тэд хичнээн шил цөцгийний шар айраг худалдаж авах тухайгаа маргалдсаар үл үзэгдэх цув, Сириусын хутгыг цүнхэндээ хийгээд явахыг нь анзаарсангүй.

- Чамд хэдэн галлеон байхгүй биз, Харри? Харольд Дингл бидэнд жаахан галт виски зарж болох байх ...

Гэвч Харри хэдийн хонгилоор буцан гүйгээд хэдэн хормын дараа шатны сүүлчийн гишгүүрийг алгасч харайн Рон, Гермиона, Жинни, Полумна нар хэлсэн газартаа зогсохыг харлаа.

- Авчихлаа. За яасан бэлэн үү? гэж тэр амьсгаадан хэлэв.

- Бэлэн гэж Гермиона зургадугаар дамжааныхан дэргэдүүр нь чанга ярилцан өнгөрөхөд шивнээд,

- Тэгэхээр Рон чи Амбрижийг саатуулахаар яв... Жинни, Полумна хоёр хонгил дахь хүмүүсийг чөлөөлж эхлээрэй ... Харин Харри бид хоёр зам чөлөөтэй болтол үл үзэгдэх цув өмсөөд зогсч байя ... гэв.

Рон урагш алхахад шаргал өнгийн үс нь хүүхдүүдийн дундуур үзэгдэн явсаар хонгилын төгсгөлд хүрэв. Тэр үед Жинни сурагчдын дундуур чихцэлдэн хонгилын нөгөө талд очиж зогсоод түүний дэргэд Полумнагын цагаан толгой нийлэв.

- Ийшээ гэж Гермиона шивнээд Харрийн гараас зууран дундад зууны үеийн шидтэнгийн хөшөөнөөс холдуулав.

- Чи зүгээр гэдэгтээ итгэлтэй байна уу, Харри? Чи бүр цонхийчихож.

- Бүх юм зүгээр гэж тэр бувтнаад цүнхнээсээ үл үзэгдэх цуваа гаргаж ирлээ.

Үнэн хэрэгтээ сорви нь янгинаж байсан ч Волдеморт Сириуст үхлийн цохилт өгч байсан үеийнх шиг хүчтэй биш байлаа. Хар лорд Эйвериг шийтгэх үед сорви нь хамгийн хүчтэй өвдөж билээ.

- Алив гэж тэр шивнээд цуваа давуулан нөмөрлөө. Тэд зогсоод чимээ чагналаа.

- Тийшээ явж болохгүй! Үгүй ээ, уучлаарай та нар өөр гарц олохын тулд шат руу буцах хэрэгтэй болж дээ. Сая энд хэн нэгэн хоолой боодог хий тавьчихсан гэж Жинни чанга хэлээд сурагчдын өмнө зогслоо.

Хүүхдүүдийн дургүйцэн үглэх сонсогдов. Тэдний нэг нь,

- Би ямар ч хий харахгүй байна гэв.

- Тэр чинь өнгөгүй хий гэж Жинни итгэлтэй унтууцан хэлээд,

- Хэрвээ чи хүсээд байгаа юм бол яв л даа. Дараагийн тэнэг чиний ухаангүй биеийг шалгах гэж явахгүй л байх гэв.

Хүүхдүүд алгуур тарж эхлэв. Хоолой боодог хийний тухай мэдээ тархсан бололтой тийшээ хэн ч явсангүй. Эцэст нь бараг хэн ч үлдсэнгүйд Гермiona,

- Одоо явах хэрэгтэй байх, Харри. Үүнээс илүү боломж олдохгүй шүү гэв.

Тэд цуваа нөмрөн урагшлав. Хонгилын төгсгөлд хүрээд Полумна тэдний ард хоцорлоо. Тэд Жиннигийн дэргэдүүр өнгөрөх үед Гермiona,

- Сайн байна ... дохиогоо битгий мартаарай гэлээ.

- Бас юун дохио вэ? гэж Харри хаалганд ойртох үедээ асуулаа.

- Амбриж ойртовол чангаар «Уизли манай хаан» дууг дуулж эхлэх ёстой юм. Харри Сириусын хутгыг цоожны нүхэнд шургуулан шархийн нээгээд өрөөнд орлоо.

Тавган дээрх эрээн муурнууд үд дундын дулаан нарны илчинд ээхийг эс тооцвол өрөөнд нам гүм хоосон байлаа. Гермiona сэтгэл амран санаа алдав.

- Би түүнийг хоёр дахь нюхлерын дараа нэмэлт хамгаалалт тавьсан байх гэж бодсон юмсан.

Тэд цуваа тайллаа. Гермiona яаран цонх руу очиж саваагаа буулгаад сургуулийн талбай руу түгшин харлаа. Харри ханан зуух руу ухасхийн чимх нисдэг дарь авч хийхэд маргад ногоон дөл бадамлан асав. Дараа нь түргэн өвдөглөөд толгойгоо гал руу шургуулж,

- Гриммогийн арван хоёрдугаар байшин! гэж хашгирлаа.

Толгой нь хүүхдийн тоглоомын тойруулган дээр байгаа мэт эргэж байсан ч өвдөг нь хатуу хүйтэн шалан дээр тавиастай байв. Тэр нүдээ аниад эргэлт намдах үед нээн хартал урд нь Гриммогийн байшингийн гал зуухны өрөө байлаа.

Энд хэн ч байсангүй. Тэр үүнийг хүлээж байсан ч гэлээ хүнгүй тасалгааг хараад айдаст автахгүй байж чадсангүй.

- Сириус! Сириус чи хаана байна? гэж хашгирлаа.

Түүний хоолой гал зууханд цуурайтсан ч хэн ч хариулсангүй. Зөвхөн зуухны баруун талд шурхийх чимээ гарлаа.

- Энд хэн байна? гэж тэр асуухдаа хулгана байсан байсан юм болов уу гэж бодлоо.

Урд нь гэрийн үйлчлэгч Кикимер гарч ирэв. Түүний хоёр гар боолттой байгаагаас үзвэл саяхан хүнд гэмтсэн бололтой. Тэр сэтгэл хангалуун байлаа.

- Ханан зууханд Поттерын толгой байна гэж Кикимер хэлээд Харри руу хачирхалтай хөөрөн харлаа.

- Тэр яагаад ийшээ ирсэн юм бол Кикимер үүнийг гайхаж байна!

- Сириус хаана байна, Кикимер? гэж Харри шаардангуй асуув. Үйлчлэгч инээд алдлаа.

- Эзэн гэртээ байхгүй, Харри Поттер.

- Тэр хаашаа явсан юм? Тэр хаачсан бэ, Кикимер? Кикимер хариуд нь инээд алдлаа.

- Би чамд анхааруулж байна шүү! гэж Харри заналхийлэхдээ түүнд огтхон ч гэм учруулж чадахгүй гэдгээ ойлгож байлаа. Люпин хаа байна? Хурц нүдэт? Тэдний нэгээс хүн байна уу?

- Кикимерээс өөр хэн ч байхгүй! гэж үйлчлэгч хөөрөн хэлээд цааш эргэн хаалга руу удаанаар явлаа.

- Кикимер одоо эзэгтэйтэй ярихаар явлаа. Тиймээ тийм, түүнд эртнээс ийм боломж олдсонгүй. Эзэн түүнийг ойртуулдаггүй байсан ...

- Сириус хаачсан бэ? Кикимер, тэр нууцын хэлтэс рүү явсан уу? гэж Харри араас нь орилов.

Кикимер хөшсөн юм шиг зогслоо. Гал зууханд байх олон сандлын хөл доогуур

Харри үйлчлэгчийн халзан толгойг харж байв.

- Эзэн Кикимерт хаашаа явахаа хэлдэггүй гэж тэр тайван хэлэв.

- Гэхдээ чи мэдэж байгаа! Тийм биз дээ! Чи түүний хаана байгааг мэдэж байгаа! гэж Харри хашгирав.

Удтал чимээгүй болсны эцэст гэрийн үйлчлэгч чанга инээгээд,

- Эзэн нууцын хэлтсээс эргэж ирээгүй! Кикимер эзэгтэйтэйгээ ахин хоёулхнаа үлдсэн! гэж баясгалантай хэлэв.

Тэгээд яаран хаалгаар гарч хонгил руу явлаа.

- Өө, чи муу ...

Гэхдээ Харри харааж амжсангүй зулай нь аймшигтай өвдлөө. Тэр үнс залгин хахаж цацан ханиалгаад дөл дундуур чирэгдэхээ мэдрэн гэнэтхэн урдаа профессор Амбрижын хувхай царай тодрохыг харж гайхлаа. Тэр түүнийг ханан зуухнаас үснээс нь чирэн гаргаад бүх хүчээ гарган хойш нь гэдийлгэв.

- Чи намайг хоёр нюхлерын дараа өрөөндөө жижигхэн харх ч шургалахыг зөвшөөрнө гэж бодоо юу? Тэнэг хүү! Тиймээ би хаалгандаа хулгайчийн эсрэг дохиоллын шид суулгасан юм! гээд, Түүний савааг ав гэж хэн нэгэнд хэлэхэд халаасан дахь саваа нь бусдын гар оров.

- Түүнийхийг ч гэсэн.

Харри хаалганы ойролцоо шар шурхийх чимээ сонсоод Гермiona ч гэсэн саваагаа хураалгасныг ойлголоо.

- Та нар миний өрөөнд юу хийж байсныг мэдмээр байна гээд Амбриж үснээс нь чанга зулгаасан учир арай унасангүй.

- Би ... би «Аянга»-аа авах гэсэн юм! хэмээн Харри сөөнгөтөв.

- Худалч! гээд тэр ахин зулгаалаа.

- Шүүр чинь газар доорхи хонгилд савдгийн хамгаалалтанд байгаа гэдгийг чи сайн мэдэж байгаа, Поттер. Чи миний ханан зуухны урд толгойгоо шургуулаад зогсож байсан. Хэнтэй ярьж байсан юм?

- Хэнтэй ч биш гээд Харри ахин гараас нь мултрахыг хичээтэл хэдэн туг үс хуйхнаас нь ширхийн зулгаагдахыг мэдрэв.

- Худалч! гэж Амбриж хашгирав. Тэр түүнийг ширээ рүү хүчтэй түлхлээ.

Харри одоо л Гермiona хананд шахагдан Миллисента Булстроудын урд зогсож,

Малфой цонхны тавцан дээр бөхийн суугаад Харрийн савааг барин инээмсэглэж байхыг харлаа.

Гадаа түргэн алхаа сонсогдож өрөөнд хэдэн том биетэй Слизеринчүүд орж ирэв. Тэд тус бүрдээ Рон, Жинни, Полумна түүнчлэн Харрийн гайхлыг төрүүлэн Невиллийг хүртэл оруулж ирэв. Крэбб түүний хоолойноос дурын агшинд боож алахад бэлэн чанга зуурчээ. Олзлогдогчын аманд алчуур чихсэн байлаа.

- Бүгдийг нь барилаа гээд Уоррингтон Роныг өрөөний гол руу бүдүүлгээр түлхэн гаргав.

- Харин энэ гээд тэр Невиллийг хуруугаараа чичин, Надад түүнийг барихад саад болсон гээд бүдүүн охины шилбэ рүү өшиглөн мултрахыг хичээж буй Жинни руу заав.

- Гайхамшигтай, маш гайхамшигтай. Хогвартс удахгүй Уизлийн бүх гэр бүлээс чөлөөлөгдөх нь гэж Амбриж мултрахыг оролдож байгаа Жинниг харан хэлэв.

Малфой чанга баясан инээлээ. Амбриж түүнд нүүр дүүрэн инээмсэглэл шагнаад яаралгүйхэн түшлэгтэй сандалдаа сууж олзлогдогчид руу цэцгийн мандалд байгаа бах адил цавчилгүй ширтэв.

- Тэгэхээр Поттер миний өрөөний гадна харуулуудаа байрлуулж энэ алиа салбадайг (Малфой бүр чанга инээлээ) илгээн хий үзэгдэл хувиргалын хичээлийн танхимыг сүйтгэсэн гэж хэлэхэд чинь би түүнийг сургуулийн дуран авайн шагайварт бэх түрхээд завгүй байгаа гэдгийг нь мэдэж байсан. Ноён Филч дөнгөж сая тэгж хэлсэн юм.

- Ийм аргаар та нарын хувьд маш чухал хэн нэгэнтэй ярих гэсэн байх нь.

Магадгүй Альбус Дамблдортой юу? Эсвэл хагас цусны Хагридтай юу? Минерва МакГонагалл байсан гэдэгт эргэлзэж байна. Би түүнийг хүнтэй ярьж чадахааргүй ухаантай байгаа гэдгийг мэдэж байна л даа.

Малфой тэргүүтэй Шалгалтын бүлгэмийнхэн ахин инээлдлээ. Харри уур хилэнд автсандаа чичирлээ.

- Би хэнтэй ярьж байсан нь таны хэрэг биш. Амбрижийн царай чангарлаа.

- Маш сайн байна. Их сайн байна, ноён Поттер ... би таньд үнэн хүлээх боломж олгосон. Та татгалзлаа. Надад зөвхөн нэг арга үлдлээ ... Драко! Профессор Снеггийг

дуудаад ир.

Малфой Харрийн савааг халаасандаа нуугаад өрөөнөөс инээвхийлэн гарч одлоо. Тэр сая л хичнээн тэнэг байснаа мэдэрлээ. Тэр яаж мартаж чадав аа? Сириусыг аврахад тусалж чадахаар бүлгийн гишүүд сургуулийг орхисон гэж бодож байсан. Гэхдээ тэр ташаарчээ. Флениксийн бүлгийн нэг гишүүн урьдын адил Хогвартсад байсан хэвээр байж. Энэ бол Снегт байлаа.

Өрөөнд нам гүм болж үе үе Слизерийнхэний тэврэлтээс мултрах гэж оролдох тэмцлийн чимээ гарч байв. Рон Уоррингтоноос чөлөөлөгдөхийг хичээхэд уруулаас нь цус гоожин өрөөний хивсэн дээр дуслав. Жинни хоёр гараараа чанга тэвэрсэн зургадугаар дамжааны охины хөл дээр гишгэхийг оролдсон хэвээр. Невилл Крэббийн гараас мултрахыг оролдон хөх ягаан царайтай болжээ. Гермiona Милисентийг түлхэн тавиулахыг зүтгэнэ. Полумна ганцаараа тайван зогсоод уйдсан янзтай цонхоор харж байв.

Харри Амбриж руу харахад түүнийг цоо ширтэж байв. Хонгилд ахин хөлийн чимээ сонсогдоход тэр царайгаа аль болох тайван хайхрамжгүй болгохыг хичээлээ. Тэгтэл өрөөнд Драко Малфой Снегтийн хамт орж ирэв.

- Та надтай уулзахыг хүсээ юу, захирал аа? гээд Снегт эргэн тойрондоо зууралдсан сурагчдыг хайхрамжгүй харлаа.

- Аан, профессор Снегт! Тиймээ, надад ахин нэг шил Үнэнийг хэлүүлэгч уусмал хэрэгтэй байна. Түргэхэн тусмаа сайн шүү гээд Амбриж инээмсэглэн босож ирлээ.

- Та миний сүүлчийн лонхыг Поттерыг байцаахаар авсан гэж Снегт хүйтнээр тослог үсэн дороосоо харж хэлээд.

- Арай бүгдийг нь ашиглачихаагүй биз дээ? Би гурван дусал хангалттай гэж хэлсэн санагдах юм гэв.

Амбриж улайлаа.

- Гэхдээ та ахиад нэгийг өгч болно биз дээ? гэж эелдэгхэн хоолойгоор хэлэв.

- Мэдээж чадна гээд Снегт мушийлаа.

- Энэ хандыг бэлтгэхэд бүтэн сарны мөчлөг шаардагддаг юм. Иймээс сарын дараа та түүнийг авах боломжтой.

- Сарын дараа гэнээ? хэмээн Амбриж бах шиг хөөн хэлээд,
- Сарын дараа юу? Гэхдээ тэр өнөөдөр надад хэрэгтэй, Снегг! Би сая Поттерыг ханан зуухандаа үл таних хүнтэй ярьж байхад нь барьж авлаа! гэв.
- Тийм гэж үү? хэмээн Снегг сонирхсон янзтай хэлээд Харри руу эргэж харлаа.
- Би үүнд нэг их гайхахгүй байна л даа. Поттер хэзээ ч сургуулийн дүрэм журмыг дагаж байгаагүй юм.

Түүний хүйтэн харанхуй нүд Харриг цоо ширтэхэд Снеггэд ухаанаа уншуулахаар урдаас нь цавчилгүй ширтэж бүх хүчээ гарган зүүдэндээ харсан зүйлийнхээ талаар бодлоо ...

- Би түүнийг байцаахыг хүсч байна! Би таныг надад үнэнийг хэлүүлэгч уусмал өгөхийг хүсч байна! гэж Амбриж хашгирахад Снегг Харригаас харц буруулан түүний уурандаа чичирсэн царай луу харлаа.

- Би нөөц байхгүй гэж хэлсэн биз дээ. Гэхдээ та Поттерыг хордуулахыг хүсч байвал би сайхан сэтгэлээр тийм зүйл авчирч чадна гэдэгтээ итгэлтэй байна. Гэхдээ ганц асуудал гэвэл ихэнхи хор хэтэрхий түргэн үйлчилдэг болохоор хохирогч үнэнийг хэлэхээсээ өмнө үхчихдэг юм.

Ингэж хэлээд Снегг ахин өөрийн бодлоо үггүй дамжуулахыг зовж шаналан хичээж байгаа Харри руу харлаа.

«Волдеморт Сириусыг нууцын хэлтэст барьж байна. Волдеморт Сириусыг нууцын хэлтэст барьж байна» гэж тэр цөхрөн давтлаа.

- Би таньд туршилтын хугацаа өглөө! гэж Амбриж орилоход Снегг ахин харц буруулахдаа хөмсгөө өргөв. Та ашиггүй зүйл хийж байна! Би танаас өөр зүйл хүлээж байсан юм. Люциус Малфой үргэлж таньд хүндэлтгэлтэй ханддаг! гэж ярьдаг. Харин одоо миний өрөөнөөс гар!

Снегг түүнд шоолонгуй бөхийгөөд хаалгаар эргэн гарлаа. Харри бүлэгтэй холбоо барих сүүлчийн боломж уусмалын хичээлийн профессорын хамт өрөөг орхихыг мэдрэв.

- Тэнүүлч олзлогджээ! Тэр түүнийг нуусан газраа байлгаж байгаа! гэж хашгирав.

Снегг хаалганы бариулаас барин хөшлөө.

- Тэнүүлч гэнээ? Бас ямар Тэнүүлч вэ? Тэнд юу нуусан юм бэ? Тэр юуны тухай яриад байна, Снегг? гэж Амбриж дуу алдаад тэднийг тэсч ядан харав.

Снегг эргэлээ. Түүний царай ойлгогдохын аргагүй байв. Харри түүний тааварласан эсэхийг ойлгож чадаагүй ч Амбрижыг байхад тодорхой зүйл ярьж болохгүй байлаа.

- Ойлгох юм алга. Хэрвээ би таны утгагүй үг хашгирахыг сонсохыг хүссэн бол шулганадаг ханд өгөх байлаа, Поттер. Ингэхэд Крэб гараа жаахан сулруул. Хэрвээ Долгопупсыг боож алвал төгсгөлгүй бичиг цаасны асуудал эхлэнэ шүү. Бас таныг ажилд ороход хүрвэл надад таны энэ араншингийн тухай дурьдах хэрэг гарна.

Тэр хаалга тасхийтэл хаахад Харри үл ялиг тайвширлаа. Снегг түүний сүүлчийн найдлага байлаа. Тэр Амбриж руу хараад цээжнийх нь гүнээс уур хилэн буцлахыг мэдрэв.

- Юу гэвэл сайн байна гээд тэр саваагаа авлаа.

- Сайн байна ... надад өөр сонголт үлдсэнгүй ... энэ сургуулийн сахилгаас илүү чухал асуудал ... энэ яамны аюулгүйн түвшинд хүрсэн асуудал ... тиймээ ... тийм ...

Тэр харваас ямар нэг шийдвэр гаргахын тулд өөртэйгээ ярьж буй бололтой. Хөлөө сэлгэн гишгэснээ Харри руу харж саваагаараа алгаа тасхийтэл цохилоо. Харри гэнэтхэн савааны өмнө хамгаалалтгүй байгаагаа мэдээд айдаст автлаа.

- Та намайг хүчээр хийлгэлээ, Поттер ... би үүнийг хүсээгүй гэж Амбриж хэлээд түгшин холхисноо,

- Гэхдээ заримдаа нөхцөл байдлыг цагаатгаж болдог юм ... Сайд надад өөр зам байгаагүй гэдгийг ойлгоно гэдэгт итгэлтэй байна

Малфой түүний араас тэсч ядан харлаа.

- Круциатусын шившлэг чиний хэлийг нээх байх гэж Амбриж аяархан хэлэв.

- Үгүй! Профессор Амбриж ... энэ чинь хууль бус хэрэг шүү дээ! гэж Гермiona дуу алдав.

Гэвч Амбриж түүнийг тоосонгүй. Түүний царайд Харрийн урьд өмнө харж байгаагүй жигшүүртэй өнгө тодорлоо. Тэр саваагаа өргөв.

- Сайд таныг хууль зөрчихийг зөвшөөрөхгүй, профессор Амбриж! гэж

Гермиона хашгирав.

- Корнелиус түүнд хор учруулахгүй гэдгийг мэдэхгүй гэж Амбриж үл ялиг амьсгаадан хэлээд саваагаа Харрийн бие рүү чиглүүлэн хамгийн их өвтгөх газрыг нь оллоо.

- Тэр намайг өнгөрсөн зун Поттер луу Дементор илгээхэд мэдээгүй ч хөөх боломж олдсонд нь баяртай байсан. Энэ удаа ч гэсэн адил.

- Тэгэхээр энэ та байсан байх нь ээ! Та над руу Дементор явуулсан юм уу? гэж Харри дуу алдав.

- Хэн нэгэн хийх л ёстой байсан гэж Амбриж хэлэхэд саваа нь Харрийн дух руу чиглэн хөшлөө.

- Тэд бүгдээрээ чамайг чимээгүй болгох хэрэгтэй гэж гонгинож байсан ч ... нэр төрийг чинь гутаан ... зөвхөн би ганцаараа л шийдэмгий алхаа хийсэн ... үнэндээ чи тэр удаад мултраад гарсан, Поттер! Гэхдээ чи өнөөдөр мултрахгүй

... Үгүй, өнөөдөр л биш шүү гээд гүнзгий амьсгал авлаа.

- Круци ...

- Үгүй ээ! гэж Гермиона Милисента Булстроудын араас хашгирлаа.

- Үгүй ... Харри ... бид түүнд хэлэх хэрэгтэй!

- Яагаад ч үгүй! гэж Харри орилов.

- Тэр чамайг хүчээр хийлгэхээс өмнө бид үүнийг хийх хэрэгтэй.

Гермиона нүүрээ дараад мэгшин уйллаа. Милисента түүнийг шахахаа болиод дургүйцсэн янзтай зайлсхийн холдов.

- Тийм байж! гэж Амбриж баяр ёслолын байдалтай хэлээд,

- Бид эцэст нь манай жижигхэн бүхнийг мэдэгч хатагтайгаас хариулт авах нь!

За алив хонгор минь, хэлээрэй! гэв.

- Гей ... мо ... на ... үгүй! гэж Рон алчуурынхаа цаанаас хашгирав.

Жинни Гермиона руу аймшигтайгаар харлаа. Невилл амьсгаадсаар нүд салгалгүй харав. Зөвхөн Харри л Гермиона гарныхаа цаана цөхрөн уйлахдаа дусал нулимс гаргасангүй болохыг ажиглажээ.

- Би ... намайг үүний төлөө уучлаарай ... гэхдээ ... би үүнийг тэсэж чадахгүй гэж

Гермиона бувтналаа.

- Зүйтэй, зүйтэй охин минь! гээд Амбриж Гермионагийн мөрнөөс барин сандал руу түлхэн суулгаад тонгойв.

- За? Поттер сая хэнтэй ярилцаж байсан бэ?

- Тэр ... гээд Гермиона шүлсээ залгихдаа гараа нүүрнээсээ холдуулсангүй.

- Тэр профессор Дамблдортой ярилцахыг оролдож байсан юм.

Рон нүдээ том нээн хөшлөө. Жинни хөлөө дэвслэхээ больж тэр ч байтугай Полумна хүртэл үл мэдэг гайхширлаа. Аз болоход Амбрижийн анхаарал сонирхсон зүйлдээ бүрэн төвлөрсөн болохоор тэдний ийм сэжигтэй үйлдэл гаргахыг анзаарсангүй.

- Дамблдор гэнээ? Тэгэхээр та нар түүний хаана байгааг мэдэж байгаа юм хэрэг үү? гэж Амбриж тэсч ядан хэлэв.

- Үгүй ... үгүй! Бид Цоорхой тогоо, Тахир гудамж, Гурван шүүр бас Гахайн толгойд хайсан юм гэж Гермиона цурхирав.

- Ухаангүй тэнэг охин! Дамблдор ид шидийн яамныхан араас нь хөөж байхад бааранд сууж байх юм гэнэ! гэж Амбриж урам хугаран хашгирлаа.

- Гэхдээ ... гэхдээ бид түүнд чухал зүйл мэдэгдэх ёстой байсан! гэж Гермиона алгаараа нүүрээ чанга даран хэлэхэд Харри нулимс байхгүйгээ нуух гэснийг нь мэдэж байлаа.

- Тийм үү? Та нар түүнд юу мэдэгдэхийг хүссэн юм? гэж Амбриж гэнэтийн баяр хөөрт автан асуулаа.

- Бид ... бид түүнд хэлэх гэсэн юм ... бэлэн болсон гэдгийг!

- Юу бэлэн гэж? Юу юм? Хариул! гэж Амбриж шаардаад Гермионагийн мөрнөөс барин сэгсэрлээ.

- Зэв ... зэвсэг гэж Гермиона хэлэв.

- Зэвсэг гэнээ? хэмээн Амбриж нүдээ бүлтийлгэн дуу алдав.

- Тэгэхээр та нар тэмцэхээр оролдож байсан байх нь? Яамны эсрэг зэвсэг ашиглах гээ юу? Профессор Дамблдорын тушаалаар биз дээ?

- Т-т-тийм. Гэхдээ тэр дуусахаас нь өмнө сургуулийг орхисон болохоор бид одоо дуусгасан ч түүнийг олж энэ тухай хэлж ч-ч-чадахгүй байгаа!

- Ямар төрлийн зэвсэг юм? гэж Амбриж огцом асуугаад бүдүүн хуруугаараа Гермionaгийн мөрнөөс чанга барилаа.
- Үнэнийг хэлэхэд бид өөрөө ч мэдэхгүй байна. Бид зөвхөн профессор Дамблдорын тушаасныг хийсэн гээд Гермiona хамраа чанга шуухитнуулав. Амбриж сэтгэлийн цэнгэлд автан бослоо.
- Намайг энэ зэвсэг рүү аваач.
- Би үзүүлэхийг хүсэхгүй байна ... тэдэнд! гэж Гермiona чанга дуу алдаад шалгалтын бүлгийнхний зүг хурууны завсраараа харлаа.
- Энэ чиний шийдэх асуудал биш гэж Амбриж ширүүн хэлэв.
- За яахав. Сайн байна ... тэд түүнийг харвал таны эсрэг хэрэглэнэ гэж айж байна! Үнэндээ олон хүн очиж харах тусмаа сайн! Тэгвэл та гавъяагаа алдаж сургууль даяар ... яаж ашиглахыг нь мэдэх болохоор та тэдэнд уурлаж ... хөөх болно! Энэ үг Амбрижад хүчирхэг сэтгэгдэл төрүүлсэн бололтой Шалгалтын бүлгийнхний зүг сэжигтэй хараад бүлцгэр нүд нь Малфой дээр тогтов.
- Амбриж Гермionaгийн үгийн талаар түр бодлогоширч үзээд дараа нь бараг л эхийн маягтай,
- Сайн байна, хонгор минь зөвхөн чи бид хоёр ... бас Поттерыг авцгаая тэгэх үү? Алив босоорой гэлээ.
- Профессор. Профессор Амбриж та Шалгалтын бүлгийнхний хэн нэгийг авч явбал дээр биш үү гэж Малфой тэсч ядан дуугарлаа.
- Би яамны албан ёсны ажилтан, Малфой! Таныхаар бол би саваагүй хоёр өсвөр насны хүүхдийн эсрэг тэмцэж чадахааргүй юм шиг байна уу? Ямар ч тохиолдолд зэвсгийг сургуулийн насны хүүхдэд үзүүлж болохгүй. Та энд эргэж ирэхийг минь хүлээгээд тэдэнд санаа тавьж бай гээд Рон, Жинни, Невилл, Полумна нар руу зангалаа.
- За яахав гэж Малфой урам хугарсан янзтай хэлэв.
- Харин та хоёр урд гараад надад зам заа. Алив явцгаа гээд Амбриж саваагаа Харри, Гермiona хоёр луу чиглүүлэв.

БҮЛЭГ 33: ТЭМЦЭЛ БА НИСЛЭГ

Харри Гермионагийн санаанд юу орсныг ойлгосонгүй. Тэднийг өрөөнөөс хонгилд гармагц хоцрохыг хичээн алхаагаа удаашруулах зуураа хаашаа явж байгаа тухай мэдэхийг оролдлоо. Гэхдээ түүнтэй ярилцаж зүрхэлсэнгүй. Амбриж ард нь ойрхон явж амьсгаадах нь сонсогдож байв.

Гермионагийн араас шатаар бууж үүдний танхимд гарлаа. Их танхимын хоёр далавчтай хаалганаас хутга сэрээ хангинаж, хөгжилтэй дуу цуурайтана. Харрид арван алхамын зайд хүмүүс шалгалт дууссаныг тэмдэглэн баяртайгаар хооллож байгаа нь итгэмээргүй хачирхалтай санагджээ.

Гермиона царсан хаалгаар гарч үүдний чулуун шатаар буугаад үдшийн сэрүүн салхинд гарлаа. Нар Хориотой ойн мододын оройг өнгөрчээ. Гермиона болон Харри түүнчлэн Амбрижын урт хар сүүдэр ногоон дээр харагдаж байлаа.

- Тэр Хагридын овоохойд нуугаастай байгаа хэрэг үү? Тийм үү? гэж Амбриж Харрийн шилэн хүзүү рүү тэвчээргүйхэн амьсгаадаж асуув.

- Мэдээж үгүй. Хагрид санамсаргүй түүнийг ажиллуулж мэднэ гэж Гермиона даажигнан хэлэв.

- Тийм шүү. Хагас цусны болхи хүн тэгж л таарна! гэж Амбриж хөөрөн хэлэв.

Түүнийг инээд алдахад Харри хоолой руу нь асах хүслээ арайхийн барилаа. Үдшийн дулаахан агаарт сорви нь лугшин өвдөх хэдий ч Волдеморт тоглоомд жинхэнээсээ оролцсон үеийнх шиг хатгуулан өвдсөнгүй.

- Тэгвэл ... хаана юм? гэж Амбриж итгэлгүйхэн хэлээд Хориотой ой руу зүглэж байсан Гермионагийн араас яаран явлаа.

- Мэдээж тэнд. Тийм л газар нуухгүй бол сурагчид санамсаргүй илрүүлж магадгүй гээд Гермиона харанхуй мододын зүг заав.

- Тиймээ, эргэлзээгүй. Сайн байна, сайн байна ... хоёулаа урд яваарай гэж Амбриж түгшин дуугарлаа.

- Бид түрүүлж явах юм чинь савааг минь өгч болох уу? гэж Харри асуулаа.

- Үгүй гэж бодож байна, ноён Поттер. Ид шидийн яам миний амьдралыг та нарынхаас илүү үнэлэнэ гэж айж байна хэмээн Амбриж баясгалантай хэлээд

савааныхаа үзүүрээр нуруу руу нь хатгалаа.

Тэднийг сэрүүхэн ойн сүүдэрт орох үед Харри Гермionaгийн нүд харахыг оролдов. Ойд ийм үдшийн цагаар алсад шидэт саваагүй явах нь түүний бодлоор муйхар тэнэг хэрэг байлаа. Гэвч тэр Амбриж руу жигшин харснаа ойн гүн рүү шийдэмгий явахад цаадах нь богино хөлөөрөө арай ядан гүйцэв.

- Цаашаа хол явах уу? гэж Амбриж бөөрөлзгөний бутанд зууралдсан жанчаа татан асуулаа.

- Өө, тэгэлгүй яахав. Түүнийг маш сайн нуусан гэж Гермiona хэлэв.

Харрийн түгшүүр улам нэмэгдэв. Гермiona Грохх руу явж байсан зөрөг замыг биш харин гурван жилийн өмнө аймшигт аалз Арагогын ичээ рүү явж байсан замыг сонгон авлаа. Тэгэхэд тэр тэдэнтэй байгаагүй болохоор замын төгсгөлд ямар аюул хүлээж байгаа талаар огтхон ч сэжиглэсэнгүй.

- М-м ... чи энэ зам гэдэгт итгэлтэй байна уу? гээд Харри түүнийг учиртай харлаа.

- Тиймээ итгэлтэй байна гэж тэр чанга хэлээд өтгөн бутан дундуур гарахдаа хэтэрхий их чимээ гаргалаа. Амбриж ард нь унасан модонд бүдэрч унав. Тэдний хэн ч туслахаар зогссонгүй. Гермiona алхаагаа саалгүй эргэж хараад чангаар,

- Ахиад жаахан явах хэрэгтэй байна! гэж хашгирлаа.

- Гермiona, чимээгүй. Хэн нэгэн сонсож магадгүй гэж Харри бувтнаад хоцрохгүйг хичээлээ.

- Харин би сонсоосой гэж хүсэж байна хэмээн Гермiona Амбрижийг мөчир тас нясхийлгэн араас нь гүйцэхэд аяархан хэлэв ...

Тэд цаашаа удаан яваад ойн гүнд ороход шигүү ургасан мододын оройгоос гэгээ нэвтрэхгүй байлаа. Харрид урьд нь төрж байсан хэн нэгэн хараад ч байгаа юм шиг мэдрэмж төрөв.

- Цаашаа хэр их явах вэ? гэх Амбриж ууртай хоолой сонсогдлоо.

- Жаахан л үлдлээ! Ердөө хоёр алхам ... гэж Гермiona хашгирангаа чийглэг харанхуй ойн цоорхойд гарлаа.

Агаарт сум исгэрэн нисэх чимээ сонсогдоод бөглүү чимээ гарган модонд зоогдлоо. Эргэн тойронд гэнэтхэн туурайн чимээ дүүрэв. Харри ойн хөрс чичрэхийг мэдэрчээ.

Амбриж часхийн орилоод түүнийг урдаа бамбай болгон барилаа.

Тэр гараас нь мултраад ийш тийшээ харав. Эргэн тойрон бүхий л зүгээс тавиад хүн морь гарч ирээд нум сумаа хөвчлөн Харри, Гермiona, Амбриж нар луу чиглүүлэв. Тэд удаанаар ухран ойн цоорхойн төвд гарлаа. Амбриж айсандаа хачирхалтай гонгинов. Харри Гермiona руу хяламхийн хараад инээмсэглэж байхыг нь ажиглав.

- Хүн чи хэн бэ? гэх хоолой гарав.

Харри толгойгоо зүүн тийш эргүүлэв. Хүн морьдын бүслэлтээс Магориан нумаа бэлхэн барьсаар гарлаа. Харрийн баруун талд байсан Амбриж шидэт саваагаа чичигнүүлэн ойртож буй хүн морь луу чиглүүлэв.

- Би чамаас хэн гэдгийг чинь асууж байна шүү, хүн минь гэж Магориан бүдүүлэг давтав.

- Би Долорес Амбриж! Сайдын нэгдүгээр зэргийн орлогч, Хогвартсын ерөнхий байцаагч! гэж Амбриж үхтлээ айсан дуугаар хэлэв.

- Тэгэхээр чи ид шидийн яамных юм биз дээ? гэж Магориан асуулаа. Тойрон бүсэлсэн хүн морьдийн ихэнхи нь түгшин шивнэлдэв.

- Яг тийм! гэж Амбриж чангаар хэлээд,

- Ийм учраас юу хийж байгаагаа бодож үзээрэй! Шидэт амьтдыг хянан зохицуулах хэлтсийн хуулинд та нар шиг хагас цусны амьтны халдлагыг албан ёсоор хориглосон байдаг юм шүү ... гэв.

- Чи биднийг хэн гэж нэрлэсэн бэ? гэж хар үстэй зэрлэг төрх бүхий Бейн орилов.

Эргэн тойронд уурссан шивнэлт түгэн нумаа хөвчиртөл татлаа.

- Тэднийг битгий тэгж нэрлэ! гэж Гермiona цөхрөн хашгирсан хэдий ч Амбриж сонссонгүй. Тэр өмнөхийн адил Магориан руу чичирсэн шидэт саваагаа чиглүүлээд,

- Арван тавдугаар хуулийн «В» хэсэгт хүнтэй ойролцоо ухаан бүхий шидэт амьтдын халдлагын үйлдэл бүрийг хариуцлагад тооцно гэж тодорхой заасан байдаг юм. Иймээс өөрийнхөө алхамын талаар сайн бодоорой ... гэв.

- Хүнтэй ойролцоо ухаантай гэнээ? хэмээн Магориан давтахад Бейн болон бусад хүн морьд уурсан хашгирч туурайгаараа цавчлав.

- Энэ чинь бидний хувьд аймшигтай доромжлол, хүн минь! Бидний ухаан аз болоход та нарынхаас хамаагүй илүү!

- Та нар манай ойд юугаа хийж байгаа юм? Яах гэж ирсэн юм? гэж Харри, Гермiona хоёрын ойд хийсэн сүүлчийн зугаалгаараа харсан саарал хүн морь хашгирлаа.

- Танай ойд гэнээ? хэмээн Амбриж давтан асуугаад айсандаа биш унтууцсандаа чичирлээ.

- Та нар энд ид шидийн яамнаас зөвшөөрөл олгосон учир амьдарч байгаа гэдгээ битгий мартаарай.

Сум зулайг нь шүргэн исгэрэн өнгөрөхөд үс нь хийсэв. Амбриж чанга хашгираад гараараа толгойгоо барихад хүн морьд дуу алдан хөхрөлдөж зэрлэг инээд нь бүүдгэр ойн цоорхойд цуурайтав.

- Тэгэхээр энэ хэний ой байна даа, хүн минь? гэж Бейн асуув.

- Бузар бохир цустангууд! Адгууснууд! Хяналтгүй амьтад! гэж Амбриж гараараа толгойгоо барьсан хэвээр орилов.

- Чимээгүй! гэж Гермiona хашгирсан хэдий ч хожимджээ. Амбриж шидэт саваагаа Магориан руу чиглүүлэн,

- Инкарцеро! гэж хашгирлаа.

Хаа нэгтээгээс могой шиг бүдүүн олс гарч ирээд хүн морины цээжин биеийг гартай нь чанга баглав. Магориан уурсан хашгирч хойд хөлөө тангараад чөлөөлөгдөхийг оролдоход бусад хүн морьд дайралтанд орлоо.

Харри Гермionaг газарт дарав. Тэр нүүрээ доош харуулан хэвтээд дэргэд нь туурайн чимээ нижигнэхэд айсан хэдий ч нэг хүн морь уурсан хашгирч дээгүүр нь харайн бусад нь дэргэд нь зогслоо.

- Үгүй ээ! Яаж зүрхэлж байна! Би сайдын нэгдүгээр зэргийн орлогч ... та нар чадахгүй ... намайг сулла, зэрлэг амьтад минь сонсож байна уу? Үгүй ээ! гэж Амбриж хашгирах сонсогдов.

Харри улаан оч хараад тэр хүн морьдын хэн нэг рүү Хөшөөх шившлэг илгээсэнийг мэдэв. Дараа нь цөхрөн ориллоо. Харри толгойгоо өндийлгөөд Бейн түүнийг агаарт сарвалзуулан өргөснийг харлаа. Тэр айсандаа уулгалан орилж шидэт саваагаа газарт

унагахад Харрийн зүрх цохилон. Хэрвээ түүнд хүрвэл ...

Гэвч түүнийг гараа хөдөлмөгц саваа хүн морины туурайнд хоёр хэсэг болон хуваагдав.

- Алив! гэх ширүүн хоолой дээр нь сонсогдмогц бүдүүн үсэрхэг гар дээш өргөн хөл дээр нь хүчтэй босгов. Гермionaг ч мөн адил босголоо. Харри хүн морьдын янз бүрийн өнгийн толгой дээгүүр Бейн Амбрижийг ширэнгэ рүү авч одохыг харлаа. Түүний хашгиралт сулран суларсаар эцэст нь туурайн чимээнд дарагдан үгүй болов.

- Харин эднийг! гэж Гермionaг гартаа барьж байсан ширүүн төрхтэй саарал хүн морь асуулаа.

- Тэд жаахан. Бид унаганд гар хүрдэггүй гэж гунигтай хэлэх дуу Харрийн ард сонсогдов.

- Тэд түүнийг ийш нь авчирсан, Ронан. Тэгээд ч тийм жаахан биш ... энэ удахгүй эрийн цээнд хүрэх гэж байна гэж Харриг чанга барьсан хүн морь эсэргүүцэв. Тэр Харрийн шилэн хүзүүнээс хүчтэй дугтарав.

- Та нараас гуйя биднийг тавиач. Бид та нарын бодож байгаа шиг биш. Түүн шиг яаманд зүтгэдэггүй! Бид түүнийг ийшээ авчирсны учир нь та нарын тусламжтайгаар салах гэсэн юм гэж Гермiona царайчлан гуйлаа.

Гермionaг барьж байсан саарал хүн морины царайг хараад Харри агшин зуур түүнийг аймшигтай алдаа гаргасаныг ойлголоо. Хүн морь уурсан газар цавчилаад толгойгоо өргөн,

- Чи харав уу, Ронан? Тэд овгийнхоо биеэ тоосон занг хэдийн сурч! Бид та нарын бохир ажлыг хийх ёстой юм гэнэ! Тийм үү, хүний охин минь? Бид та нарын дайсныг хөөх дуулгавартай нохой чинь болж байна уу? гэв.

- Үгүй! Танаас гуйя ... Би тэгж хэлэх гээгүй юм! Би зүгээр л та нарыг бидэнд тусалж чадна гэж найдсан юм хэмээн Гермiona айдаст автан хэлэв.

Гэвч тэр ингэж хэлснээрээ байдлыг улам дордууллаа.

- Бид хүмүүст тусалдаггүй! гэж Харриг барьж байсан хүн морь ууртай хашгираад гараа чангалахад зүүн хөл нь газраас өргөгдөв.

- Бид гарал угсаа болон өөрсдийн амьдралаараа бахархдаг. Бид та нарын бардам занг дарахаас нааш эндээс явахыг зөвшөөрөхгүй!

- Бид ямар ч тийм зүйл хийгээгүй! Бид та нарын хүсэхгүй байгааг ойлгож байгаа ч ... гэж Харри хашгирлаа.

Гэхдээ хэн ч түүнийг сонссонгүй.

- Тэд ийшээ урилгагүй ирсэн учир үүнийгээ төлөх ёстой гэж сахалтай хүн морь орилов.

Хүн морьд дэмжин шуугилдлаа. Тэдний нэг болох бор өнгийн хүн морь,

- Эмэгтэйг явуулсан газар луу эднийг илгээе! гэв.

- Та нар гэмгүй хүнд хүрдэггүй гэж хэлсэн биз дээ! гэж Гермiona нулимс урсган хашгирлаа. Бид та нарт муу зүйл юу ч хийгээгүй, шидэт саваа ашиглан заналхийлээгүй, бид зөвхөн сургуульдаа эргэж очихыг хүсч байна, гуйя тавиач дээ ...

- Бид танай урвагч Флоренц шиг биш, хүний охин минь! гэж саарал хүн морь нөхдийнхөө дэмжлэг дундаас улам чанга хашгирлаа. Чи биднийг ердөө хөгжилтэй ярьдаг морьд гэж бодоо юу? Бид эртний ард түмэн байтал шидтэний зүгээс халдлага доромжлолыг тэвчихгүй! Бид танай хуульд захирагдахгүй ...

Гэхдээ Харри, Гермiona хоёр хүн морины үгийг цааш сонссонгүйн учир нь ойн захад чанга тас нясхийх чимээ гарав. Бүгд эргэн тойрноо харлаа. Харриг гартаа барьж байсан хүн морь доош унагаад нум сумаа авлаа. Гермiona бас суллагдахад Харри түүн рүү тэмүүлэв. Тэгтэл хоёр бүдүүн мод ярагдан дундаас нь аварга биет Гроххын аймшигтай дүрс урган гарч ирэв.

Ойролцоох хүн морьд арагш ухарлаа. Тэд навчис дундаас цухуйх аварга том саарал нүүр лүү нумаа чиглүүлэн татаж хүлээв. Грохх амаа ангайлгахад тоосго шиг шар шүд нь гялсхийн, сүүмгэр нүд нь дороо байгаа жижигхэн амьтдыг харахын тулд онийлоо. Хоёр шагайндаа зузаан олс чиржээ.

Тэр амаа улам том ангайлаа.

- Хаггер.

Харри түүний ямар хэлээр яриад байгаагүй ойлгосонгүй. Тэр Гроххын биетэй нь зэрэгцэх нүсэр том тавхай руу харлаа. Гермiona түүний гараас чанга зулгаахад хүн морьд нүсэр том дугуй толгойгоо хэн нэгнийг хайж олохыг найдсан мэт эргүүлэх аварга биет рүү чимээгүйхэн харав.

- Хаггер! гэж тэр улам шаардангуй хэллээ.

- Эндээс холд, аварга биетээ! Чамд энд хийх зүйл байхгүй! гэж Магориан хашгирав.

Харваас энэ үг Грохход ямар ч сэтгэгдэл төрүүлсэнгүй бололтой. Тэр доошоо бөхийгөөд (Хүн морьд нумаа улам хөвчлөн татлаа),

- Хаггер! гэж нүргэлүүлэв.

Хүн морьд сэтгэл зовсон байртай харагдсан ч Гермionaд эсрэгээрээ найдлага төрсөн бололтой.

- Харри! Тэр Хагрид гэж хэлээд байх шиг байна! гэж шивнэлээ.

Грохх энэ агшинд хүн морьдын дунд байгаа хоёр хүнийг олж харлаа. Тэрбээр сайн ажиглахын тулд толгойгоо улам бөхийлгөв. Гермiona дагжтал чичирлээ. Грохх ахин амаа том нээж,

- Гермi гэв.

- Чи сонсов уу? Тэр ... тэр санаж байна! гэж Гермiona дуу алдаад Харрийн мэдээ алдтал чанга атгалаа.

- Гермi! Хаггер хаана байна? гэж Грохх хүнгэнүүлэв.

- Би мэдэхгүй! Надад их харамсалтай байна, Грохх. Гэхдээ би мэдэхгүй! гэж үхтэлээ айсан Гермiona дуу алдав.

- Грохход Хаггер хэрэгтэй!

Аварга биетийн хүчирхэг гар доош явлаа. Гермiona бүх хүчээрээ хашгиран хэдэн алхам гүйгээд унав. Харрид шидэт саваа байсангүй болохоор хазаж, маажиж, самардахад бэлтгэв ... Тэгтэл тэдний зүг тэмүүлсэн гарт цагаан үстэй хүн морины хөл оногдов.

Хүн морьд үүнийг тэвчсэнгүй. Гроххын хуруу Харрид хүрэхийн даваан дээр тавиад сум хөөрөн аварга биетийн нүсэр том нүүрэнд зоогдлоо. Тэр өвдсөндөө орилоод босч царайгаа гараараа үрчин сумны модыг хугалж зэвийг нь улам гүн шигтгэлээ.

Тэр хашгиран хөлөө дэвсэхэд хүн морьд тал бүр тийш тарж зугтав. Гроххын нүүрнээс хайрганы хэмжээтэй цус дуслахад Харри Гермionaг хөл дээр нь босгон модны дор нуугдав. Тэднийг эргэж харах үед Грохх нүүрнээсээ цусан бороо асгаруулан хүн морьдийг таамгаар барихыг хичээсэн авч замбараагүй таран зугтаад

мододын цаагуур оров. Грохх уурсан хашгираад замдаа тааралдсан мододыг хуга татан араас нь хөөж одлоо.

- Үгүй ээ. Аймшигтай юм! Тэр тэднийг алах байх гэж Гермиона ёолоод чичирсээр хүчгүй болон газар суулаа.

- Үнэнийг хэлэхэд энэ намайг бага зовоож байна гэж Харри гашуунаар хэлэв.

Хүн морьдын туурайн чимээ нам гүм болов. Харри чимээ чагнаснаа гэнэтхэн сорви нь хүчтэй төөнөхийг мэдрээд айдаст автлаа.

Тэр хичнээн их хугацаа алдаа вэ! Тэр Сириусыг шалгалтан дээр зүүдэлснийхээ дараа л аврах ёстой байсан юм. Гэтэл тэр саваагаа алдаад зогсохгүй Гермионатай Хориотой ойн дунд яахаа мэдэхгүй зогсож байна.

- Ухаалаг төлөвлөгөө хэлэх юм алга! Үүнээс илүүг ч бодож олох юм биш. Бид одоо хаачих болж байна? гэж Харри Гермиона уураа гаргалаа.

- Шилтгээн рүү буцах хэрэгтэй гэж Гермиона сулхан хэлэв.

- Одоо Сириус үхсэн ч байж магадгүй! гэж Харри хашгираад ойролцоох модыг өшиглөлөө. Чанга шажигнах чимээ гарахад толгойгоо өргөөд уурсан лукотрус мөчир шиг урт хуруугаа түүн рүү чиглүүлсэн байхыг олж харлаа.

- Бид шидэт саваагүй юу ч хийж чадахгүй гэж Гермиона найдлагагүй бувтаад хөл дээрээ босов.

- Ингэхэд Харри чи Лондон руу яаж хүрэх гээ вэ?

- Тийм шүү бид энэ тухай чинь л бодож байна гэх танил хоолой гарав. Харри, Гермиона хоёр харанхуй мододын зүг зэрэг ширтлээ.

Рон гарч ирэхэд түүний араас Жинни, Невилл, Полумна нар дагалджээ. Бүгдийн царай тааруухан харагдана. Жиннигийн хацар урт хумсанд хэдэнтээ маажуулж, Невиллийн баруун нүдний дор том хөхөрч, Роны уруул язран цус болжээ. Гэхдээ үүнийг эс тооцвол тэд сэтгэл өөдрөг байв.

- За тэгээд ямар санаа байна даа? гээд Рон дороо байсан мөчрийг Харрийн саваагаар холдуулав.

- Та нар яаж мултраа вэ? гэж Харри саваагаа аваад гайхан асуулаа.

- Хоёр гурван хөшөөх бас нэг зэвсэггүй болгох шившлэг, харин Невилл саад арилгах шившлэгийг сайхан хийсэн гэж Рон хайхрамжгүй хэлээд Гермионагийн

шидэт савааг сунгав.

- Гэхдээ Жиннигийнх хамгийн сайн болсон. Тэр Малфой руу сарьсан багваахайн хараал илгээсэн нь гайхалтай болж нүүрээр нь дүүрэн далавчтай амьтад шавсан. Бид та нарыг ой руу явж байхыг чинь цонхоор харсан юм. Ингэхэд та нар Амбрижыг яагаа вэ?

- Түүнийг хүн морьд аваад явчихсан. Бүтэн сүрэг гэж Харри хэлэв.

- Та нарыг орхисон хэрэг үү? хэмээн Жинни гайхлаа.

- Орхисны учир гэвэл араас нь Грохх хөөсөн болохоор тэр гэж харри тайлбарлав.

- Грохх гэж хэн юм бэ? хэмээн Полумна сониучирхав.

- Хагридын дүү байгаа юм. Гэхдээ энэ тухай дараа ярья. Харри чи ханан зуухнаас ямар нэг юм мэдэв үү? Хэцүү нэрт үнэхээр Сириусыг барьж уу? гэж Рон асуулаа.

- Тиймээ. Би Сириусыг амьд гэдэгт итгэлтэй байгаа ч тийшээ яаж очиж туслахаа мэдэхгүй байна гэж хэлэхэд Харрийн сорви ахин өвдлөө.

Бүгд айсан байртай чимээгүй боллоо. Асуудал даван туулахын аргагүй санагдав.

- Бид нисэх хэрэгтэй гэж Полумна хэлэв.

- Тийм байж гэж Харри уурсан хэлээд,

- Нэгдүгээрт бид гэдэгт чи өөрийгөө багтаасан бол юу ч бүтэхгүй. Хоёрдугаарт гэвэл Раноос бусад нь шүүргүй, минийх савдгаар харгалзуулсан байгаа болохоор ... гэв.

- Надад шүүр байгаа! гэж Жинни эсэргүүцэв.

- Тэгсэн ч гэсэн чи хаашаа ч нисэхгүй гэж Рон ууртай дуугарлаа.

- Өршөөгөөрэй гэхдээ Сириусын хувьд заяа намайг чамаас дутуугүй зовоож байна! гэж Жинни шүд зуун хэлэхэд Фред, Жорж хоёртой гайхам адил харагдав.

- Чи ч гэсэн ... гэж Харри эхэлсэн ч Жинни ууртайгаар таслаад,

- Би чамайг Хэцүү нэрттэй гүн ухааны чулууны төлөө зодолдож байсан үеэс хойш гурван насаар өссөн! Би л Малфойг Амбрижын өрөөнд зэвсэггүй болгож, түүн рүү нисдэг биет илгээсэн биз дээ ... гэв.

- Тиймээ, гэхдээ ...
- Бид Дамблдорын армид хамтдаа байсан. Бид Хэцүү нэртийн эсрэг тэмцэхээр зохион байгуулагдсан биз дээ? Тэгээд ч бидэнд үүнийг анх удаагаа жинхэнээсээ хийх боломж олдож байна. Эсвэл ДА чинийхээр тоглоом байсан юм уу? гэж Невилл хэлэв.
- Үгүй ... тоглоом биш гэж Харри дургүйхэн дуугарлаа.
- Тэгвэл бид бүгдээрээ хамт явна. Бид туслахыг хүсч байна.
- Яг үнэн гэж Полумна баяртайгаар дэмжив.

Харри Рон руу харлаа. Тэр түүнийг адил зүйл бодож байгааг мэдэж байв. Хэрвээ тэр ДА-гийн ямар гишүүдийг Сириусыг аврахад авч явах вэ гэвэл Жинни, Невилл, Полумна нарыг сонгохооргүй байлаа.

- Тэгсэн ч гэсэн энэ ямар ч хамаагүй. Бид нар тийшээ яаж хүрэхээ мэдэхгүй байна гэж Харри гунигтай хэлэв.
- Харин би үүнийг шийдэгдсэн гэж бодсон юмсан. Бид ниснэ! гэж Полумна ярианд оролцов.
- Алив намайг сонс гэж Рон уурсан хэлээд,
- Чи магадгүй шүүргүй нисэж чаддаг байж болох ч харин бид далавч хаанаас авах вэ? гэлээ.
- Зөвхөн шүүрээр нисэж болдог юм биш гэж Полумна шаргуу эсэргүүцэв.
- Тэгээд юугаар гэж? Чиний үрчгэр эвэртээр үү? гэж Рон сонирхов.
- Үрчгэр эвэрт нисдэггүй юм. Харин энэ нисэж чадна. Бас Хагрид тэднийг дуртай газар руу чинь хүргэж өгнө гэж хэлсэн дээ.

Харри огцом эргэж харав. Модны хооронд аймаар цагаан нүдээ гялалзуулсан хоёр фестрал зогсож байв. Тэд үг бүрийг нь ойлгосон мэт харна.

- Тиймээ! гэж тэр шивнээд ойртов. Тэд толгойгоо сэжин урт хар зогдроо сэгсрэв. Харри гараа сунган нэгнийх нь гялалзсан хүзүүг илэв. Тэр яаж эднийг өмнө нь аймаар гэж бодож байсан юм бол?
- Юу? Энэ тэнэг морьдоор уу? Хэн нэгэн үхэхийг хараагүй бол харж чаддаггүй юу? гэж Рон итгэлгүйхэн хэлээд Харрийн илж буй фестралын хажуугаар харав.
- Тиймээ гэж Харри хариулав.

- Хэд байна?
- Ердөө хоёр.
- Харин бидэнд гурав хэрэгтэй гэж Гермiona шийдэмгий дуугарлаа.
- Гурав биш дөрөв гэж Жинни ууртай залруулав.
- Надад бол зургаа хэрэгтэй шиг санагдаж байна гэж Полумна тайван хэллээ.
- Тэнэг юм битгий яриад бай! Бид нар бүгдээрээ нисэж чадахгүй! гэж Харри ахин уурсаад,
- Тэгэхээр та гурав үүнд оролцохгүй гээд Невилл, Жинни, Полумна нар руу зангав.

Эсэргүүцлийн шинэ шуурга дэгдэв. Сорви нь ахин хүчтэй өвдлөө. Агшин бүр үнэт мөч хорогдож байлаа. Түүнд маргалдаж байх цаг байхгүй.

- За яахав сайн байна нисэхийг хүсч байвал та нарын хэрэг. Гэхдээ бид бусад фестралуудыг олж чадахгүй болохоор та нар ...
- Бусад нь ирнэ эргэлзэх хэрэггүй гэж Жинни Рон шиг буруу зүг рүү ширтэн хэллээ.

- Чи яагаад тэгж бодож байгаа юм?
- Яагаад гэвэл Гермiona та хоёр цусанд будагдчихаж. Харин бид Хагрид фестралуудыг түүхий махыг тэжээдгийг мэднэ. Одоохон энэ хоёр дээр нэмэгдэнэ.

Харри жанчнаас нь зөөлхөн зулгаахыг мэдээд харвал ойролцоох фестрал ханцуйд наалдсан Гроххын цусыг долоож байв.

- Сайн байна гэж хэлэхэд нэг санаа төрөв.
- Рон бид хоёр үүн дээр суугаад түрүүлж ниснэ. Харин Гермiona та нартай үлдээд фестралуудын анхаарлыг татан ...
- Би ард үлдэхгүй! гэж Гермiona ууртай эсэргүүцэв.
- Хэн ч үлдэх хэрэг гарахгүй. Харж байна уу бусад нь ирж байна ... харваас та хоёр харваас бүх ойгоор үнэртэж байгаа бололтой гээд Полумна инээмсэглэв.

Харри эргэж харлаа. Мододын дундуур зургаа долоон фестрал ирж байв. Том ясархаг далавчаа биедээ наагаад нүд нь харанхуйд гялалзана. Бүгд өөр шалтаг хайсангүй.

- Сайн байна. Нэгийг нь сонгоцгоо явцгаая гэж Харри ууртай дуугарлаа.

БҮЛЭГ 34: НУУЦЫН ХЭЛТЭС

Харри ойролцоох фестралын дэлнээс чанга зуураад гөлгөр нуруун дээр нь эв хавгүйхэн морьдлоо. Морь эсэргүүцсэнгүй зөвхөн ханцуйг нь ахин долоохоор толгойгоо эргүүлэв.

Тэр нисдэг морины далавчны уулзвараас өвдгөөрөө чанга хавчаад нөхдөө харав. Невилл зэргэлдээх фестралын нуруун дээр гэдсээрээ тохогдоод богинохон хөлөө давуулах гэж оролдоно. Полумна морин дээрээ тайван суугаад жанчаа засангаа тийм аялал хамгийн ердийн хэрэг мэт байлаа. Зөвхөн Рон, Гермiona Жинни гурав байрнаасаа хөдлөлгүй хоосон газар руу амаа ангайлган ширтэнэ.

- Яасан? гэж тэр асуулаа.

- Чинийхээр бол бид яаж суумаар юм шиг байна? Ядаж харагдаж байвал яахав гэж Рон хэлэв.

- Өө, энэ чинь маш амархан. Нааш ир гээд Полумна фестралаасаа гулгаж буун тэднийг чиглэв.

Тэр хүүхдүүдийг бусад фестралуудад суухад туслан нуруун дээр нь гаргаад дэлнээс бариулахад тэд их айсан байлаа. Тэдэнд чанга барихыг зөвлөөд Полумна гэдрэгээ буцав.

- Энэ чинь ухаангүй хэрэг. Ухаангүй ... Хэрвээ би түүнийг харж байсан бол ... гэж Рон сул гараараа морины хүзүүнээс болгоомжтой бариад хэллээ.

- Эсрэгээрээ чамд аз тохиосон гэж бод. За бүгд бэлэн үү? гэж Харри хэлэв.

Бүгд хариу дохиход тэр таван хос өвдөг жанчных нь доогуур чанга хавчсаныг харлаа.

- Тэгвэл сайн байна ... гээд фестралын гилгэр хар толгой руу хараад шүлсээ залгингаа,

- Лондон дахь ид шидийн яамны зорчигчын гарц руу ... Э-э ... хэрвээ та нар замаа мэддэг бол гэж итгэлгүйхэн хэлэв.

Хэдэн хормын турш фестрал хөдөлсөнгүй. Дараа нь хүчирхэг далавчаа дэлгэхдээ Харриг арай газар унагасангүй. Морь дээшээ огцом хөөрсөн тул Харри ясархаг нуруунаас нь унахгүйн тулд бүх биеэрээ наалдах хэрэг гарав. Тэр нүдээ аниад нүүрээ намирсан дэлэнд наан мододын орой дээгүүр жаргаж буй нарны зүг хөөрлөө.

Харри хэзээ ч ийм хурдан нисэж байгаагүй юм шиг санагдав. Фестрал шилтгээний дэргэдүүр өнгөрч далавчаа ажиглагдамгүй дэвэхэд хүйтэн салхи нүүр лүү алгадлаа. Тэр хүчтэй салхинд нүдээ онилгон нөхдөө эргэж харав. Тэд гулгаж унахгүйн тулд фестрал руу аль болох тонгойжээ.

Сургуулийн нутаг дэвсгэрээс гараад Хогсмидийг өнгөрөхөд дор уул толгод жирэлзэн өнгөрнө. Бүрэнхий болж эхлэхэд жижигхэн тосгоны гэрэл жирэлзэн өнгөрч, толгодын дундах замаар ганц машин гэр лүүгээ буцаж байлаа ...

- Гайхамшигтай! гэж Роны сулхан хашгирах дуу дуулдахад тэр үзэгдэхгүй зүйлээр нисэх ямар хачирхалтай болохыг төсөөлөв.

Бүрий ягуухан нэмэгдэж хөх ягаан өнгийн тэнгэр харанхуйлан жижигхэн мөнгөлөг одод түгэв. Одоо зөвхөн тэд хурд болон хэр хол нисэж байгаагаа маглуудын хотын гэрлээр багцаалах болж. Харри мориныхоо хүзүүнээс чанга тэврээд аль болох түргэн аваачихыг бодолдоо гуйлаа. Сириусыг нууцын хэлтсийн шалан дээр хэвтэж байхыг хартал хэр их хугацаа өнгөрөх бол? Сириус тусламж хүлээх чадах болов уу? Гэхдээ Харри загалмайсан эцэг нь үхээгүй гэдэгт итгэлтэй байлаа. Хэрвээ тэгсэн бол Волдемортын уур хилэнг мэдэрч сорви нь ноён Уизлиг дайрсан шөнийх шиг өвдөх байх.

Бүгд алсад цаашлан ниссээр харанхуй болоход Харрийн царай хүйт дааж, фестралын ташаанаас чанга хавчсан хөл нь мэдээ алдаж байсан ч гулгаж унахаас айгаад хөдөлсөнгүй. Чихийг нь салхины урсгал балбан, уруул нь шөнийн салхинд бээрч гүйцжээ. Тэр хэдийн бусад мэдрэмжээ алдаад зөвхөн амьтан далавчаа үл мэдэг дэвэн шөнийн харанхуйг зүсэн урагшилсаар байлаа.

Хэрвээ тэд хоцорсон бол яана ...

Тэр амьд тэмцсэн хэвээр гэдгийг би мэдэрч байна ...

Хэрвээ Волдеморт Сириусын бууж өгөхгүй гэдгийг ойлговол ...

Би үүнийг мэдрэх байсан ...

Фестрал гэнэтхэн доошилоход Харри хүзүү рүү нь гулган чанга зуурлаа. Тэд эцэст нь уруудаж эхэллээ ... Тэгтэл ард нь хүн хашгирах чимээ гарах шиг болоход түргэн эргэж харсан ч унаж буй бие харсангүй ... магадгүй тэр гэнэтийн зүг өөрчлөлтөөс айсан байх л даа.

Хурц шаргал өнгийн гэрэл бүх зүгт ойртож дүгэрэглэн томроход байшингийн

дээвэр, авто машины анивчсан гэрэл, дөрвөлжин цонхноос тусаж буй цайвар туяаг ялган таньж болохоор болжээ. Фестрал гэнэтхэн явган замын зүг хурдлахад Харри унахгүйн тулд бүх хүчээ гарган дэлнээс зуурсан ч газарт сүүдэр шиг хөнгөхөн хүрэхэд нуруунаас нь гулган буулаа. Тэр эргэн тойроноо харахад өмнөхийн адил дүүрэн хогтой савны хажуудах эвдэрхий телефон утасны бүхээг гудамжны бүүдгэр гэрэлд үзэгдэв.

Рон холгүйхэн газардаад фестралаас буунгаа,

- Ахин хэзээ ч гэж бувтнаад хөл дээрээ хүндхэн бослоо. Дараа нь үл үзэгдэх мориноосоо холдохыг хичээсэн ч бөгсийг нь мөргөөд арай л унасангүй. Үгүй ээ, баярлалаа ... үүнээс муу зүйл үзсэнгүй

Гермиона, Жинни нар түүний нөгөө талд газардав. Хоёулаа гулган буугаад хатуу газар зогсож байгаадаа санаа амарсан төрхтэй байв. Невилл мориноосоо чичирсээр үсэрч буухад, Полумна төвөггүйхэн гулгаж буув.

- Бид одоо хаачих вэ? гэж тэр Харригаас сонирхолтой аялал хийж буй мэт эелдэгээр сониучирхав.

- Ийшээ хэмээн Харри фестралыг талархан алгадаад телефон утасны бүхээг рүү түргэн очиж хаалгыг нь онгойлгоод,

- Алив! гэж найзуудаа удааширахыг нь хараад яарууллаа.

Рон, Жинни хоёр дотогш хүлцэнгүй ороход араас нь Гермиона, Невилл, Полумна нар чихцэлдэн оров. Харри фестрал руу эцсийн удаа харахад хогийн савнаас идэх юм хайн ухаж байлаа. Харри Полумнагийн араас оров.

- Харилцуурт хэн ойрхон байна? Зургаа, хоёр, дөрөв, дөрөв, хоёрыг эргүүл!

Рон гараа арайхийн сунгалаа. Түүнийг сүүлчийн дугаарыг хиймэгц бүхээгт эмэгтэй хүний тунгалаг хоолой сонсогдлоо.

- Ид шидийн яаманд тавтай морилоорой. Нэр болон аялалын зорилгоо хэлнэ үү.

- Харри Поттер, Рон Уизли, Гермиона Грэйнджер, Жинни Уизли, Невилл Долгопупс, Полумна Лавгуд ... Бид энд хэрвээ яамныхан биднээс түрүүлчихээгүй бол хүн аврахаар ирлээ!

- Баярлалаа, таньд. Зочдоо тэмдгээ жанчныхаа урд зүүнэ үү.

Булангийн зоос гарч ирдэг нүхнээс хэдэн тэмдэг гарлаа. Гермиона тэднийг аваад

чимээгүйхэн Харрид Жиннигийн толгой дээгүүр сунгав. Тэр аваад «Харри Поттер, аврах даалгавартай» гэж бичсэнийг уншлаа.

- Хүндэт зочдоо та бүхэн орохын өмнө саваагаа үүдний танхимын төгсгөлд байрлах жижүүрийн шидтэнд бүртгүүлнэ үү.

- Сайн байна! Одоо бид орж болох уу? гэж Харри чанга хэллээ. Сорви нь ахин лугшин өвдөв.

Утасны бүхээгийн шал чичирснээ явган зам өгсөн шилэн хананы цаагуур далд орж хог ухаж буй фестралууд үзэгдэхээ болив. Тэднийг харанхуйд ороход нэгэн хэвийн хүнгэнэх дуу гарлаа.

Төдхөн хөл дорх завсраар нарийхан алтлаг оч татсанаа өргөсөн нэмэгдлээ. Дотор давчуу байсан тул Харри доош суугаад саваагаа бэлхэн барьж үүдний танхимд хэн нэгэн хүлээж байгаа эсэхийг харлаа. Гэвч танхим хоосон байв. Одоо ханан зуухны гал асахгүй, цахилгаан шат зогсож байсан болохоор өдрийнхөөс бүүдгэр гэрэлтэй байсан ч солонгорсон адар дээрх алтлаг дүрс тэмдэг мурилзан хөдлөх нь харагдана.

- Ид шидийн яам таньд сайхан үдшийг хүсч байна гэж эмэгтэй хүний хоолой хэлэв.

Бүхээгийн хаалга нээгдэхэд Харри, Невилл, Полумна нар гадагш гарлаа. Нам гүмийг зөвхөн алтан усан оргилуур дахь шидтэнгийн савааны үзүүр, хүн морины сум, албингийн шовгор оройтой малгай, үйлчлэгчийн чихнээс ус олгойдох чимээ эвдэнэ.

- Явцгаая гэж Харри аяархан хэлэхэд зургуул танхимын төгсгөл рүү хөдлөв.

Харри урд нь явлаа. Тэд усан оргилуурыг өнгөрөөд Харрийн савааг шалгасан жижүүрийн шидтэн сууж байсан ширээ рүү очиход хоосон байлаа.

Харри болгоомжлон түгшлээ. Тэр энд жижүүр сууж байх ёстой гэдэгт итгэлтэй байсан учир түүний эзгүй явдал нь муугийн тэмдэг байлаа. Энэ таагүй мэдрэмж алтан хаалгаар гаран цахилгаан шат руу очиход улам хүчтэй болов. Тэр ойролцоох доошоо гэсэн товчлуурыг дарахад цахилгаан шат түчигнэн агшин зуур бүхээг нь нээгдэхэд хүүхдүүд дотогш орлоо. Харри есөн давхарын товчлуурыг дарахад сараалж хяхтнан хаагдаж түжигнэсээр доошоо явлаа. Харри анх ноён Уизлитай ирэх үедээ цахилгаан шат ийм их чимээ шуугиантай болохыг ажиглаагүй байжээ. Тэр чимээ шуугианыг байшингийн бүх хамгаалалт сонссон байх даа гэж бодтол цахилгаан шат зогсож эмэгтэй хүний хоолой «Нууцын хэлтэс» гэж хэлэхэд сараалж

нээгдэв. Тэд хонгилд гарахад эргэн тойрон нам гүм байх агаад зөвхөн цахилгаан шатны салхинд үлээгдсэн бамбарын дөл анивчина.

Харри энгийн хар хаалга руу эргэв. Тэр удаан хугацааны турш зүүдэндээ харсны эцэст ирлээ.

- Явцгаая гээд тэднийг хонгилоор дагуулан явлаа. Түүний араас Полумна зүг бүр тийш амаа ангайн харсаар хөдлөв.

- Хүлээгээрэй гээд Харри хаалганаас хэдэн алхамын өмнө зогсов. Магадгүй ... хэн нэгэн гэнэтийн түгшүүр дуудахаар үлдсэн нь дээр байх ...

- Чи эндээс хол байх юм чинь яаж бидний дохиог сонсох болж байна? гээд Жинни хөмсгөө өргөв.

- Бид чамтай хамт явна, Харри гэж Невилл хэлэв.

- Цагаа үрэх хэрэггүй гэж Рон хатуу нэмэрлэв.

Харри урьдын адил бүгдийг авч явах хүсэлгүй байсан ч түүнд сонголт үлдсэнгүй. Тэр ахин хаалга руу эргэн урагш явахад ... зүүдэнд байдгийн адил цэлсхийн нээгдлээ.

Тэд уужим дугуй өрөөнд оржээ. Эндхийн бүх зүйл тэр ч байтугай шал адар нь хүртэл хар байлаа. Өрөөний эргэн тойронд ялгахын аргагүй адилхан бариулгүй хаалгууд хүрээлж завсар хооронд нь цэнхэр лааны дөл асаж байв. Түүний хүйтэн гэрэл толигор гантиг шалан дээр тусах нь харанхуй усан дунд байгаа мэт санагдуулна.

- Хэн нэгэн хаалга хаагаарай гэж Харри аяархан гуйлаа.

Тэр үүнийг зөвхөн Невилл биелүүлсэнд шуудхан харамсчээ. Тэд бамбарын гэрэлтэй хонгилоос тусгаарлагдахад харанхуй болж шалны дээр чичигнэх цэнхэр дөлний тусгалаас ондоо юу ч харагдахаа болилоо.

Харри зүүдэндээ өрөөний эсрэг талд хаалга байгаа гэдэгт үргэлж итгэлтэй байсан. Гэтэл энд арван хоёроос доошгүй хаалга байлаа. Тэднийг харан аль нь хэрэгтэй эсэхийг шийдэхийг оролдох зуур хүржигнэх чимээ гарч ханан дахь лааны гэрэл хөдлөв. Дугуй өрөө эргэлээ.

Гермиона хөл дорх шал нь хөдөлж эхлэхээс айн Харрийн гараас зуурсан ч тэгсэнгүй. Зөвхөн хана хурдан эргэлдсэн болохоор хэдэн агшины турш жирэлзсэн цэнхэр дөл болон хувирч гэнэт зогсоод хөдөлгөөнгүй болов.

Харрийн нүдэнд цэнхэр судлаас өөр юу ч харагдахгүй байлаа.

- Энэ юу вэ? гэж Рон эмээнгүй асуув.
- Магадгүй бид ямар хаалгаар орж ирснээ мартсан байх гэж Жинни аяархан хэлэв.

Харри түүний зөв гэдгийг шууд ойлгожээ. Одоо гарах хаалгыг танихад амаргүй байлаа.

- Бид эндээс яаж гарах вэ? гэж Невилл түгшин асуулаа.
- Энэ чухал биш гэж Харри шийдэмгий хэлээд нүдний өмнө сүүмэлзэх цэнхэр судлаас салахын тулд анивчин саваагаа чанга атгалаа.

- Бид Сириусыг олоогүй цагтаа эндээс явахгүй ...
- Зөвхөн түүний нэрийг битгий дуудаарай! гэж Гермiona сэтгэл зовон хэлэхэд хэтэрхий хувийн зөвөлгөө байсан ч зөн совин нь Харрид аль болох чимээгүй байхыг сануулж байлаа.

- Одоо хаачих вэ, Харри? гэж Рон асуув.
- Би мэдэхгүй ... гээд Харри шүлсээ залгив.
- Би зүүдэндээ цахилгаан шатыг өнгөрөөд хонгилын эцсийн хаалгаар нэвтрэн харанхуй өрөөнд орж тэндээс өөр хаалгаар ороход ... анивчсан гэрэл байдаг. Хаалгануудыг шалгаж үзэх хэрэгтэй байна. Би хэрэгтэй өрөөгөө харах юм бол танина. Явцгаая.

Тэр найзуудынхаа хамт нүүрэн талын хаалгаар оров. Зүүн гар талд нь гэрэл гялалзахад саваагаа дайралтанд бэлтгэн өргөөд үүдийг түлхэв.

Тэр амархан нээгдлээ.

Энд эхний өрөөнөөс харанхуй агаад адраас урт алтан гинжээр дүүжилсэн бүрхүүл өлгөж дөрвөлжин өрөөний адил гэрэл гялалзахгүй байлаа. Өрөө хэдэн ширээ, голд нь байх том шилэн хоргыг эс тооцвол хоосон байлаа. Түүн дотор ногоон шингэн дүүрэн байсан бүгд чөлөөтэй сэлж болохоор том ажээ. Дотор нь сувдан цагаан зүйл залхуутай хөвж байхыг ажиглав.

- Энэ чинь одоо юу вэ? гэж Рон шивнэлээ.
- Мэдэхгүй гэж Харри хэлэв.
- Загас юм болов уу? гэж Жинни санал болгов.

- Усны чөтгөрийн авгалдай. Аав тэднийг яаманд үржүүлдэг гэсэн хэмээн Полумна хөөрөн хэлэв.

- Үгүй гэж Гермiona хачирхалтай хоолойгоор дуугарлаа. Тэр шилэн хорго руу очиж дотогш харлаа. Энэ чинь тархи байна.

- Тархи гэнээ?

- Тиймээ ... тэд түүгээр юу хийдэг юм бол?

Харри түүний дэргэд очлоо. Одоо түүнийг ойроос харахад эндүүрэхийн аргагүй байв. Гялалзсан таагүй зүйл ногоон өнгийн шингэнд хөвж ахин хараанаас холдохдоо өнгөт байцаа шиг болж байлаа.

- Эндээс явцгаая. Энэ өрөө биш байна. Өөр хаалгыг шалгах хэрэгтэй гэж Харри хэлэв.

- Энд ч гэсэн хаалга байна гээд Рон хана руу заалаа. Харрийн дотор палхийв.

Нууцын хэлтэс ямар том юм бэ!

- Би зүүдэндээ харанхуй өрөөнд ороод хоёр дахь руу нь шууд ордог байсан.

Эргэж очоод хаашаа явахаа шийдэх хэрэгтэй байх.

Тэд ахин харанхуй дугуй өрөөнд очиход Харрийн нүдэнд цэнхэр дөлний оронд тархи сүүмэлзэв.

- Хүлээгээрэй гэж Гермiona огцом хэлэхэд Полумна хэдийн шилэн хорготой өрөөний үүдийг хааж байлаа. Флагрейт!

Тэр саваагаа даллан хаалган дээр галт хэрээс зурав. Хаалга хаагдахад ахин хүржигнэх чимээ гарч хана түргэн эргэлдэхэд одоо зөвхөн цэнхэр судал төдийгүй алтлаг улаан гэрэл жирэлзэв. Бүгд ахин чимээгүй болох үед галт хэрээс арилаагүй тэдний ямар хаалгаар орсныг нь үзүүлж байлаа.

- Сайн байна. Алив, үүнийг шалгая гэж Харри хэлэв.

Тэр ахин эсрэг талын хаалга руу очоод саваагаа бэлхэн барьсаар түлхэн нээхэд найзууд нь дагалдав.

Шинэ өрөө сүүлчийнхийг бодвол арай том тэгш өнцөгт хэлбэртэй сулхан гэрэлтэй агаад шал нь доошоогоо арван хоёр футын гүнзгий нүх рүү гишгүүр болон сунажээ. Тэд чулуун шатны хамгийн дээр зогсоод өрөөний эргэн тойрныг харлаа. Харрид энэ

танхим Визенгамотын шүүхийн өрөөг санагдуулав. Гинжтэй сандлын оронд нүхний ёроолд чулуун индэр байрлуулж дээр нь ан цав бүхий маш эртний нуман хаалга тавьсан нь яагаад тоос болж үйрээгүй нь ойлгомжгүй байлаа. Тавцан тойрон хүрээлсэн ханагүй бөгөөд хаалган дээр нооронхой хар хөшиг өлгөсөн нь хүйтэн агаарт саяхан хүрсэн мэт дэрвэлзэн хөдөлж байв.

- Энд хэн байна? гэж Харри асуугаад доошоо сандал руу харайлаа. Түүнд хэн ч хариулсангүй бөгөөд хөшиг салхинд сэвэлзсэн хэвээр байв.

- Болгоомжтой! гэж Гермиона шивнэв.

Харри чулуун сандал дагуу уруудсаар хөнхөр нүхний ёроолд хүрэв. Түүний алхаа болгоныг даган чанга чимээ цуурайтаж байлаа. Дор нь зогсоод харахад чулуун хаалга хамаагүй өндөр санагдав. Хөшиг саяхан түүгээр хэн нэгэн орсон мэт аяархан сэвэлзэх аж.

- Сириус? гэж Харри аяархан дуудлаа.

Түүнд хөшигний цаана хүн зогсож байгаа юм шиг хачирхалтай мэдрэмж төржээ. Саваагаа аль болох чанга атгаад тавцангийн ирмэгийг тойрон явсан ч тэнд хэн ч байсангүй. Зөвхөн хуучирч ноорсон хар хөшиг нөгөө өнцгөөсөө харагдлаа.

- Явъя. Тэнд юу ч байхгүй, Харри. Эндээс явсан нь дээр гэж чулууны шатны хагаст зогсож байсан Гермиона хэлэв.

Тэр тархитай өрөөнд байснаас илүү айсан байлаа. Гэхдээ нуман хаалга Харрид сүрлэг санагджээ. Аяархан долгилох хөшиг сонирхлыг нь татаж байлаа. Түүнд тавцан руу гаран хөшгийг нээх хүсэл төрөв.

- Явъя, Харри гуйж байна! гэж Гермиона шаардангуй давтлаа.

- Одоохон гэж хэлсэн ч байрнаасаа хөдөлсөнгүй. Чихэнд нь сулхан шивнэлт мэт хачирхалтай чимээ сонсогдлоо. Энэ нь хөшигний цаана хүмүүс зогсоод аяархан ярилцаж буй мэт ажээ.

- Та нар юу хэлсэн бэ? гэж чанга асуухад үг нь цуурайтав.

- Хэн ч юу ч хэлээгүй, Харри! гээд Гермиона түүн рүү дөхөв.

- Хэн нэгэн түүний ард зогсоод шивнэж байна. Чи юу, Рон? гэж тэр хөмсөг зангидан асуулаа.

- Би энд л байна шүү дээ, найз минь гээд Рон тавцан руу хүрч ирлээ.
- Хэн ч юу ч сонсохгүй байна гэж үү? хэмээн Харри гайхан асуухад аяархан шивнэлт чангарлаа. Тэр гэнэтхэн тавцан дээр нэг хөлөө тавин зогсож байгаагаа мэдрэв.
- Би ч гэсэн сонсож байна. Тэнд дотор нь хүмүүс байх шиг байна гэж Полумна хэлээд нөгөө талаас ирлээ. Тэр хөшиг рүү нүд салгалгүй ширтэж байв.
- Дотор нь гэдэг чинь юу гэж байгаа юм? гээд Гермiona уурсангүй хэлээд ёроолын гишгүүр дээрээс харайлаа.
- Тэнд ямар ч дотор гэж байхгүй. Энэ чинь зөвхөн нуман хаалга тэнд хүмүүстэй өрөө байхгүй. Хангалттай Харри, эндээс явцгаая.

Тэр түүний тохойноос татахад хөдөлсөнгүй.

- Харри бид ийшээ Сириусын төлөө ирсэн шүү дээ! гэж тэр хүчилсэн нарийхан хоолойгоор хэлэв.
- Сириусын төлөө гэж Харри давтаад сэвэлзсэн хөшиг рүү ховсдуулсан мэт харав. Тиймээ, тийм ...

Ямар нэг зүйл тархинд нь зурсхийв. Сириус олзлогдоод тамлагдаж байхад тэр энд нуман хаалга ширтээд зогсож байна ...

Тэр хөшигнөөс нүд буруулан тавцангаас хэдэн алхам ухарлаа.

- Явцгаая.
- Би үүнийг л чамд хэлээд байна шүү дээ ... за алив, явцгаая тэгвэл! гээд Гермiona тэргүүлэн чулуун тавцанг тойрон явлаа. Нөгөө талд Жинни, Невилл хоёр зогсоод ховсдуулсан мэт хөшиг рүү ширтэж байв. Гермiona үг хэлэлгүй Жиннигийн гараас атган авахад, Рон Невиллийнхийг барьж аваад шийдэмгийгээр сандал руу өгсөн хаалга руу буцав.
- Энэ юун хаалга юм бол? гэж Харри Гермionaгаас харанхуй дугуй өрөөнд эргэж ирэхдээ асуув.
- Мэдэхгүй, гэхдээ аюултай гэдэгт илэрхий гэж Гермiona хатуу хэлээд хаалган дээр галан хэрээс зурлаа.

Хана ахин эргэлдээд зогсов. Харри гурав дахь хаалгыг түлхлээ. Тэр нээгдсэнгүй.

- Яасан бэ? гэж Гермиона асуув.
 - Энэ ... түгжээтэй байна гээд Харри хаалгыг бүх хүчээрээ түлхсэн ч үр дүнгүй боллоо.
 - Энэ юм болов уу? гээд Рон сэтгэл хөдлөн хэлээд Харрийн хамт хаалгыг онгойлгохыг оролдов. Гарцаагүй энэ л байж таарна!
 - Замаас холд! гэж Гермиона ширүүн хэлээд саваагаа ердийн хаалганы цоож байх газар луу чиглүүлж,
 - Алохомора! гэв. Юу ч болсонгүй.
 - Надад хутга байгаа шүү дээ! гэж Харри дуу алдав. Тэр жанчнаасаа Сириусын хутгыг гаргаж ирээд хана хаалга хоёрын завсар шургуулав. Бусад нь түүнийг дээш доош хөдөлгөн хаалгыг мөрөөрөө түлхэхийг тэвчээргүйхэн харж байлаа. Гэхдээ хаалга бөх хаалттай хэвээр байлаа. Харри хутгаа аваад харахад ир нь мохсон байв.
 - За яахав, бид энэ өрөөг алгасахаас гэж Гермиона шийдэмгий хэлэв.
 - Гэхдээ энэ бидэнд хэрэгтэй хаалга байвал яах вэ? гээд Рон хаалга руу болгоомжлохоосоо илүү сониучирхан харлаа.
 - Тийм байх боломжгүй. Харри зүүдэндээ үргэлж чөлөөтэй ордог байсан гэж Гермиона тайлбарлаад ээлжит галт хэрээсээ зурав. Харри ашиггүй ажлаа орхиод хутгаа буцан халаасандаа хийлээ.
 - Тэнд юу нуусан юм бол? гэж Полумна хана ахин эргэлдэхэд хэлэв.
 - Ямар нэгэн гайхамшигтай зүйл биз гэж Гермиона бувтнахад Невилл түгшин инээд алдав.
- Хана зогсоход Харри дараагийн хаалгыг цөхрөн нээлээ.
- Энэ байна!
- Тэр очир алмазны гэрэл бүжиглэсэн энэ үзэсгэлэнтэй газрыг шууд танилаа. Харрийн нүд гялалзсан гэрэлд дасахад гялтагнасан нүүртэй том жижиг цагууд, ханын болон дүүжин цаг тавиур шүүгээний завсар өлгөж өрөөний дагуух ширээн дээр тавьсаныг харлаа. Хатуу чанга чаг хийх чимээ жижигхэн армийн алхаа шиг дуулдаж байв. Гялалзсан гэрлийн эх сурвалж болох өндөр болор шилэн сав өрөөний төгсгөлд байв.
- Ийшээ!

Тэд эцэст нь зөв замдаа орсон болохоор Харрийн зүрх хурдтай цохилгов. Тэр ширээн дундуурх нарийхан зайгаар гараад зүүдэндээ байдаг шиг чигээрээ явж ширээн дээрх болор сав руу очиход салхинд үлээгдэх мэт давалгаалан гялалзаж байлаа.

- Хөөх, хараач! гэж Жинни дуу алдаад болор сав руу заав.

Гялалзсан урсгалын дотор үнэт чулуу адил жижигхэн өндөг байв. Тэр хагарч нээгдсэнээ соно бялзуухай гарч савны амсар руу ниссэнээ доошоо унаж өд нь зулгараад ахин өндөг боллоо.

- Зогсох хэрэггүй! гэж Харри Жинни өндөг ахин шувуу болохыг харахаар зогсоход ширүүн хэлэв.

- Өөрөө тэнэг хаалганы өмнө удаан зогсчихоод! гэж тэр эсэргүүцсэн ч хэдий араас нь даган болор суулга хоцорлоо.

- Энэ байна гэж Харри ахин хэлэхэд зүрх нь хүчтэй цохилж ярихад амаргүй болов.

- Бид ийшээ орох хэрэгтэй ...

Тэр андуудаа харахад сэтгэл түгшсэн байртай саваагаа гаргаж ирлээ. Тэр ахин хаалгыг түлхэв. Хаалга нээгдлээ.

Тэд эцэст нь эрсэн зүйлээ олжээ. Сүм шиг уужим танхимд жижигхэн тоостой бөмбөлөг бүхий тавиурууд эцэс төгсгөлгүй сүндэрлэн үргэлжилнэ. Тавиур хоорондын завсаруудад хаалтанд хийсэн лааны гэрэл бүүдгэр гийгүүлэх аж. Энд дугуй өрөөний адил цэнхэр дөл бадамлан асаж байлаа. Танхимд их хүйтэн байв.

Харри болгоомжтой урагш алхаад тавиур хоорондын эгнээгээр шагайлаа. Энд юу ч сонсогдож ямар нэг хөдөлгөөн мэдрэгдсэнгүй.

- Чи ерөн долдугаар эгнээ гэж хэлсэн шүү дээ хэмээн Гермiona шивнэв.

- Тиймээ гэж Харри хариу шивнээд ойролцоох эгнээний төгсгөл рүү ойртлоо.

Тэнд цэнхэр лааны дөлд тавин гурав гэсэн мөнгөлөг тоо гялалзаж үзэгдэв.

- Бид баруун тийшээ яваах хэрэгтэй байх. Тиймээ ... тэнд тавин дөрөв байна ... гэж Гермiona дараагийн эгнээ рүү харж хэллээ.

- Саваагаа бэлхэн бариарай гэж Харри аяархан сануулав.

Тэр урагш гэтэн явж урт тавиурын төгсгөлд хүрлээ. Тавиур дээрх бөмбөлөг бүрт

жижигхэн шаргал хаяг наажээ. Зарим бөмбөлөг ер бусын тунгалаг өнгөтэй байхад зарим нь шатсан чийдэн шиг бүдэг байлаа.

Тэд наян дөрөвдүгээр эгнээг өнгөрөөд ... ная тавдугаар эгнээнд хүрч ... Харри бүх хүчээ гарган сонсохыг хичээсэн ч Сириус амандаа алчуур чихүүлсэн юмуу юмуу ухаан алдсан бололтой ...

Магадгүй тэр үхсэн юм болов уу гэж дотоод хоолой нь хэлэв.

«Би үүнийг мэдрэх ёстой байсан. Би үүнийг мэдэх байсан» гэж тэр өөртөө хэлэхэд зүрх нь хэнхдэгээс нь үсрэн гарах шахам цохилов.

- Эрэн долоо! гэж Гермiona шивнэв.

Тэд эгнээний төгсгөлд зогсоод ийш тийшээ харлаа. Тэнд хэн ч байсангүй.

- Тэр хамгийн төгсгөлд нь байгаа. Эндээс харагдахгүй байх ... гээд Харрийн ам хатлаа.

Харри тэднийг шилэн бөмбөлөг сүндэрлэсэн тавиур дундуур дагуулан явахад зарим нь бүдэг туяарч байв.

- Тэр ойр хавьд байх ёстой. Хаа нэгтээ ... маш ойрхон гэж Харри хэлээд алхам бүрдээ шалан дээр атиралдан хэвтэж буй Сириусын дүрсийг харахыг хичээлээ.

- Харри гэж Гермiona тодорхойгүй хэлэхэд хариулахыг хүссэнгүй. Түүний ам хатжээ.

- Энд хэн нэгэн байх шиг байна гэж Гермiona хэлэв.

Тэд лааны бүдэг гэрэл дэх эгнээний төгсгөлд гарч ирлээ. Тэнд хэн ч байсангүй. Тоостой нам гүм байв.

- Тэр магадгүй ... гэж Харри сөөнгөтөн хэлээд дараагийн эгнээ рүү харснаа, Эсвэл гээд цааш явлаа.

- Харри гэж Гермiona ахин хэлэв.

- Яасан? гэж тэр унтууцлаа.

- Би ... Сириусыг энд байгаа гэж бодохгүй байна.

Бүгд чимээгүй болов. Харри тэдэн рүү харахыг хүссэнгүй. Дотор нь эвгүй оргижээ. Тэр Сириус яагаад энд байхгүй байгааг ойлгосонгүй. Тэр энд байх ёстой! Энд

байхыг нь Харри зүүдэндээ харсан шүү дээ ...

Тэр захын эгнээ хүртэл гүйгээд тавиуруудыг ээлжлэн шагайлаа. Хоосон ... ахиад л хоосон эгнээнүүд сүүмэлзэн өнгөрөв. Тэр буцаж эргээд чимээгүй зогсох нөхдөө өнгөрөв. Энд Сириусын ул мөр байтугай тэмцэл болсоны шинж үгүй ажээ.

- Харри! гэж Рон дуудав.

- Яасан?

Тэр Роны үгийг сонсохыг хүссэнгүй. Рон түүнийг тэнэг гэж хэлээд Хогвартс руу буцахыг санал болгоно байх. Тэр нүүр нь халуу оргихыг мэдрээд тод гэрэлтэй үүдний танхимд найзуудынхаа зэмлэнгүй харцыг харахаасаа өмнө харанхуйд байгаадаа сэтгэл хангалуун байлаа ...

- Чи үүнийг харсан уу? гэж Рон асуув.

- Яасан? гэж Харри давтаад энэ удаад магадгүй Сириусын ул мөр байх гэж тэсч ядан бодлоо. Тэр ерөн долдугаар эгнээ рүү очоод Рон тавиур дээрх тоостой шилэн бөмбөлөг рүү харж зогсохыг ажиглалаа.

- Яасан? гэж Харри баргар асуув.

- Энд ... энд чиний нэр байна.

Харри ойртлоо. Рон бүдэг гэрэл туяарсан тоостой шилэн бөмбөлөг рүү заалаа. Харваас түүнд олон жилийн турш хэн ч гар хүрээгүй бололтой.

- Миний нэр гэнээ? хэмээн Харри бодлогоширон асуув.

Тэр алхам урагшиллаа. Рон түүнээс өндөр болохоор Харри шаргал хаягийг уншихын тулд хүзүүгээ өлийлгөв. Түүн дээр өдөр сарыг сараачин бичсэнээс үзвэл ойролцоогоор арван зургаан жилийн өмнөх агаад дор нь ингэж бичжээ.

С.П.Т А.П.В.Б.Д Хар лорд уу

эсвэл (?)Харри Поттер уу?

Харри хаяг руу харлаа.

- Энэ юу юм бол? Энд яагаад чиний нэр байгаа юм бол? гэж Рон түгшин асуулаа.

Тэр бусад хаяг руу харлаа.

- Минийх энд алга. Өөр хэнийх ч алга гэж тэвдэнгүй хэлэв.

- Харри, чи гар хүрэхгүй байсан нь дээр байх гэж Гермиона түүнийг гар сунгахад ширүүн хэлэв.

- Яагаад? Энд надад хамаатай зүйл байх шиг байна!

- Хэрэггүй, Харри гэж Невилл гэнэтхэн хэлэхэд Харри түүн рүү харлаа.

Невиллийн дугуй царайд хөлс гялтагнана.

- Гэхдээ энд миний нэр байна шүү дээ.

Ингээд тэр болчимгүй зүйл хийж байгаагаа мэдэрсээр хуруугаа тоостой бөмбөлөгөнд ойртуулав. Тэр хүйтэн байх гэж бодсон ч тийм байсангүй. Харин ч эсрэгээрээ олон цагийн турш наранд хэвтсэн мэт дулаахан байлаа. Тэр аюултай аялалаа цагаатгах ямар нэгэн ер бусын зүйл болохыг найдан хүлээж байсан тул шилэн бөмбөлөгийг аваад харлаа.

Гэхдээ юу ч болсонгүй. Бусад нь тойрон харлаа.

Тэгтэл тэдний ард хоолой сонсогдов. Хэн нэгэн тайвнаар үгээ сунган,

- Сайн байна, Поттер. Хари одоо тэнэг зүйл хийлгүй удаанаар эргээд надад түүнийг өгдөө гэв.

БҮЛЭГ 35: ХӨШИГНИЙ ЦААД ТАЛД

Эргэн тойрон бүхий л зүгээс хар дүрс гарч ирээд баруун зүүн талд зугтах замыг хаахад юүдэнгийн дорх нүд нь гялалзаж арваад савааны үзүүр тэдний зүрх рүү чиглэжээ. Жинни айн дуу алдав.

- Түүнийг надад өг, Поттер гэж Люциус Малфой үгээ сунган давтаад алгаа дээш харуулан сунгав.

Харрийн дотор палхийлээ. Тэд занганд оржээ. Хүн бүрт хоёроос доошгүй өрсөлдөгч байлаа.

- Надад өг гэж Малфой ахин хэлэв.

- Сириус хаана байна? гэж Харри асуулаа.

Хэдэн Үхэл залгигчид инээлдэв. Дараа нь Харрийн зүүн талд байсан дүрснээс эмэгтэй хүний хахир хоолой гарч баясгалантайгаар,

- Хар лорд бүгдийг мэддэг юм! гэлээ.

- Бүгдийг гэж Малфой аяархан хэлээд,

- Харин одоо надад зөгнөлийг өгдөө, Поттер! гэв.

- Би Сириусын хаана байгааг мэдэхийг хүсч байна!

- Сириусын хаана байгааг мэдэхийг хүсч байна гэнэ ээ! хэмээн эмэгтэй даажигнан хэллээ.

Үхэл залгигчид Харри болон найзуудыг нь ердөө хоёр алхамын зайд тойрон хүрээлэхэд савааны гэрэл нь Харрийн нүдийг гялбуулав.

- Та нар түүнийг барьсан. Тэр энд байгаа гэдгийг би мэдэж байна гэж Харри сандрал автахаа үл тоомсорлон хэллээ.

- Бяцхан хүүхэд сэрээд айсан зүүднийхээ тухай ярьж байна гэж эмэгтэй даажигнан хүүхдийн яриагаар хэллээ. Харри дэргэдээ Рон хөдлөхийг мэдрэв.

- Хэрэггүй. Одоо биш гэж Харри бувтналаа.

Түүнийг даажигнаж байсан эмэгтэй хахир дуугаар инээлээ.

- Түүнийг сонсов уу? Үгүй ээ, та нар сонсов уу? Тэр бусад хүүхдүүддээ бидэнтэй тулалдах заавар өгч байх шиг байна!

- Чи Поттерыг над шиг мэдэхгүй, Беллатриса. Түүнд баатар болох томоохон сул тал байдаг юм. Хар лорд үүнийг сайн мэднэ. Харин одоо надад зөгнөлийг өгдөө, Поттер.

- Би Сириус энд байгааг гэдгийг мэднэ. Би та нарыг барьсан гэдгийг мэднэ! гэж Харри айдас нь арай хөнгөрөхөд хэллээ.

Ахиад л Үхэл залгигчид инээлдэхэд эмэгтэй бусдаас илүү чангаар хөхрөв.

- Чамд бодит амьдрал болон зүүднийхээ ялгааг олж сурах хугацаа байна, Поттер. Харин одоо зөгнөлийг өгөхгүй бол саваагаа ашиглаж эхлэнэ шүү гэж Малфой хэлэв.

- Тэг л дээ гээд Харри саваагаа урдаа өргөлөө. Тэгтэл хоёр талаас нь агаарт Рон, Гермиона, Невилл, Жинни, Поламна нарын таван саваа өргөгдөв. Харрийн зүрх ёгхийлээ. Хэрвээ Сириус үнэн хэрэгтээ энд байхгүй бол тэр найзуудаа ямар ч шалтгаангүй үхлийн аюулд авчирсан байна ...

Гэвч Үхэл залгигчид дайрсангүй.

- Хэрвээ чи надад зөгнөлийг өгвөл хэн ч зовохгүй гэж Малфой хүйтнээр хэлэв. Одоо Харрийн инээх ээлж ирлээ.

- Тэгэлгүй дээ! Би таньд энэ ... зөгнөлийг өгөх үү? Тэгвэл та биднийг гэр лүү тайван буцаах юм биз дээ?

Түүнийг яриагаа дуусгаж амжаагүй байтал Үхэл залгигч эмэгтэй,

- Акцио, зөгн ... гэж хашгирлаа.

Харри цагаа олж «Протего!» шившлэгийг хашгирч амжсан учир бөмбөлөг хурууны үзүүрээс мултралгүй тэслээ.

- Өө, тэр яаж тоглохоо мэддэг юм байна, бяцхан Поттер гээд түүний ухаангүй нүд юүдэн дороосоо гялалзав. За яахав ... тэгвэл ...

- Одоохон боль! Хэрвээ чи түүнийг хагалчихвал гэж Люциус Малфой зандрав.

Харрийн ухаан цэлмэлээ. Үхэл залгигчид энэ тоостой шилэн бөмбөлөгийг хүсч байна. Харин тэр сонирхохгүй байна. Тэр зөвхөн найзуудаа эндээс амьд гаргаж түүний тэнэг явдлыг аймшигтай үнээр төлөхийг хүссэнгүй ...

Эмэгтэй урагш алхаад юүдэнгээ сөхөв. Азкабан Беллатриса Лестрейнжийн царайг

туранхай гавалтай төстэй болгон өөрчилсөн ч нүдэнд нь хачирхалтай оч гялсхийж байлаа.

- Тэгэхээр тэмцэх гэсэн юм биз дээ? гээд тэр цээжээ түхийлгэснээ түргэн болив.

- Сайн байна. Хамгийн багыг нь аваад ир. Бид охиныг яаж зовоохыг хараарай.

Би өөрөө үүнийг хийнэ гэж дэргэдээ зогсож байсан Үхэл залгигчид тушаав.

Харри найзууд нь Жиннийг ойртон хүрээлэхийг мэдрэв. Тэр хажуу тийш алхаад зөгнөлийг цээжиндээ наалаа.

- Бидний хэн нэгийг дайрахыг оролдох юм бол зөгнөлийг хагалах болно шүү.

Танай эзэн хоосон гартай буцвал сэтгэл хангалуун байна гэж бодохгүй байна. Эсвэл миний буруу юм уу?

Беллатриса байрнаасаа хөдөлсөнгүй түүн рүү нүд салгалгүй ширтээд хэлнийхээ үзүүрээр уруулаа долоов.

- Тэгэхээр зөгнөл гэж юу болохыг тайлбарлаадах гэж Харри хэллээ.

Тэр яриаг үргэлжлүүлэх өөр арга олж чадсангүй. Невиллийн гар чичирэхэд бусад нь шилэн хүзүү рүү нь түргэн амьсгаадав. Тэр тэднийг цаг үрэлгүй энэ мухардалаас гарах арга олоосой гэж хүслээ. Түүний толгой хоосорчээ.

- Зөгнөл гэж юу юм бэ гэнэ үү? хэмээн Беллатриса инээвхийлэн давтаад,

- Чи тоглож байна уу, Харри Поттер гэлээ.

- Ердөөсөө ч үгүй. Тэр яагаад Волдемортод хэрэг болсон юм? гээд зугтах гарцан дээр эвшээлгэн байсан Үхэл залгигч дээр харц тусгав.

Үхэл залгигчид аяархан шивнэлдлээ.

- Чи түүнийг нэрлэж зүрхэлнэ гэнээ? хэмээн Беллатриса шивнэлээ.

- Тэгээд юу гэж? хэмээн Харри үг сөргөн шилэн бөмбөлөгийг чанга атгаад анхаарлыг нь татах ахин нэг оролдлого хийлээ. Тиймээ надад түүнийг нэрлэхэд хэцүү биш байдаг ...

- Амаа тат! гэж Беллатриса хашгирав.

- Чи яаж өчүүхэн амаараа түүнийг хэлж зүрхэлж байна. Чи яаж хагас цусны заваан хэлээрээ хэлж зүрхэлж байна ...

- Тэгэхээр та түүнийг бас хагас цусны гэдгийг мэддэггүй байх нь ээ? гэж Харри огцом асуув. Гермiona аяархан дуу алдлаа.

- Танай Волдемортыг? Түүний ээж нь шидтэн эцэг нь магл байсан юм! Эсвэл тэр та нарт өөрийгөө цэвэр цусны шидтэн гэж хэлээ юу?

- Дөжир ...

- Үгүй!

Беллатриса Лейстренжийн савааны үзүүрээс улаан оч гарсан ч Малфой түлхсэн учир шившлэг Харрийн зүүн талын тавиурыг онож хэдэн шилэн бөмбөлөг хагарав.

Хагарсан шилнээс хий үзэгдэл адил хоёр сувдан цагаан дүрс утаа шиг суунаглан гарч ирээд шилний хэлтэрхийтэй шалан дээр зогсон ярьж эхлэв. Тэдний хоолойг Малфой, Беллатриса хоёрын хашгиралтан дундаас ялгаж сонсоход бэрх байлаа.

- Шинэ нарны үе ирж байна гэж сахалтай хөгшин хүний дүрс хэлэв.

- Битгий довтол! Бид зөгнөлийг авах ёстой.

- Тэр яаж зүрхэлж ... тэр яаж ... бузар ... бохир хагас цустан гэж Беллатриса уялдаа холбоогүй үг хашгирлаа.

- Зөгнөлийг бид автал хүлээ! гэж Малфой орилов.

- Хэн ч дараа нь ирэхгүй гэж залуу эмэгтэй хүний дүрс хэлэв.

Бөмбөлөгөөс гарсан хоёр дүрс агаарт ууршин алга болов. Шалан дээр хэвтэх шилний хэлтэрхийнээс ондоо тэднийг сануулах юу ч үлдсэнгүй. Гэхдээ энэ нь Харрид санаа төрүүлжээ. Тэгэхээр одоо бусаддаа дамжуулах хэрэгтэй боллоо.

- Хэрвээ надад зөгнөл гэж юу болохыг тайлбарлахгүй бол өгөхгүй гэж тэр цаг хожихыг хичээн хэлээд хажуу тийш удаанаар хөдлөхдөө ардаа байгаа хүнийг мэдрэхийг хичээв.

- Бидэнтэй тоглох хэрэггүй шүү, Поттер гэж Малфой хэлэв.

- Би тоглоогүй гэж Харри хэлээд анхаарлаа төвлөрүүлэн хөлөө хойш нь явууллаа. Тэр хэн нэгний хөл дээр гишгэчихлээ. Чихэнд нь Гермionaгийн үг сонсогдов.

- Яасан? гэж тэр шивнэлээ.

- Дамблдор хэзээ ч чамайг нууцын хэлтэст хадгалагдаж байгаа зүйлээс болж

сорвитой болсныг хэлээгүй юм уу? хэмээн Малфой инээд алдав.

- Би ... юу? гээд тэр агшин зуур төлөвлөгөөгөө мартчихлаа.
- Энд миний сорви ямар хамаатай юм?
- Яасан? гэж Гермiona араас нь шаардангуй шивнэлээ.
- Тэгэхээр чи юу ч мэддэггүй юм байна гэж Малфой хорсолтой баясан хэлэв. Үхэл залгигчид ахин инээлдэхэд, Харри Гермionад аль болох уруулаа хөдөлгөлгүй,
- Тавиурыг нураа ... гэлээ.
- Тэгэхээр Дамблдор чамд хэзээ ч хэлж байгаагүй юм биз дээ? Энэ чинь чамайг яагаад эрт ирээгүйн учрыг тайлбарлаж өглөө, Харри Поттер. Хар лорд гайхаж байсан ...
- ... намайг «одоо» гэж хэлэхээр ...
- Тэр чиний зүүдэнд хадгалагдаж байгаа газрыг нь үзүүлэхэд гүйж ирээгүй.

Чамайг бүгдийг тодорхой мэдэхээр сонирхож ирэх байх гэж тэр бодож байсан юм ...

- Яасан гэнээ? хэмээн Харри асуув. Тэр Гермiona үгийг нь бусдадаа дамжуулахыг сонсоод Үхэл залгигчдыг сатааруулахын тулд яриаг үргэлжлүүлэв.
- Тэр намайг ийшээ ирж авахыг хүсээ юу? Яах гэж?
- Яах гэж гэнээ? хэмээн Малфой гайхширан асуугаад,
- Яагаад гэвэл нууцын хэлтсээс зөгнөлийг зөвхөн тэнд дурьдагдсан хүн л авч чадна, Поттер. Хар лорд бусдыг түүнийг хулгайлахаар илгээсэн ч юу ч бүтээгүй гэв.
- Гэхдээ тэр яагаад миний тухай зөгнөлийг авахуулахыг хүссэн юм бол?
- Та хоёрынх, Поттер хоёулангийн чинь ... чи хэзээ ч өөрөөсөө Хар лорд яагаад чамайг хүүхэд байхад алах гэж оролдсоныг асууж байгаагүй юу?

Харри юүдэн дороос гялалзах Малфойн саарал нүд рүү харлаа. Тэгэхээр энэ зөгнөл эцэг эхийнх нь үхлийн шалтгаан болж духан дээр нь цахилгаан хэлбэртэй сорви үлдээсэн байх нь? Тэр үнэхээр бүх асуултын хариуг гартаа барьж байна гэж үү?

- Тэгэхээр хэн нэгэн бид хоёрын тухай зөгнөл хэлсэн байх нь ээ? гэж тэр тайван асуугаад Люциус Малфой руу ширтэн дулаахан бөмбөлөгийг чанга атгалаа. Энэ нь снитчээс хоёр дахин том бас шороотой байв.

- Волдеморт намайг ирж түүнийг авахуулахын тулд занганд оруулсан хэрэг үү?
Тэр өөрөө яагаад ирж болоогүй юм?
- Өөрөө гэнэ үү? гээд Беллатриса галзуу юм шиг хөхөрлөө.
- Чи Хар лордыг ид шидийн яаманд ирэхийг тоохгүй өнгөрнө гэж бодоо юу?
Түүнийг мракоборецуудын гарт өгч миний үнэт үеэл дүү шиг цагаа үр гээ юу?
- Аанхан тэр та нарыг бохир ажлаа хийлгэхээр явуулж! Эхлээд ийшээ
Стержисыг хулгайлуулахаар илгээсэн ... дараа нь Боудыг ...
- Их сайн байна, Поттер маш сайн байна гэж Малфой удаанаар хэлээд.
- Гэхдээ Хар лорд чамайг тэнэг биш гэдгийг мэднэ ...
- Одоо! гэж Харри орилов.

Ард нь таван янзын хоолой «Редукто!» гэж хашгирлаа. Таван шившлэг зүг бүр нисэн гарахад зэргэлдээх тавиурууд цохилтонд өртөн дэлбэрч нүсэр бие нь ганхаад зуугаад шилэн бөмбөлөг зэрэг хагарч хэлтэрхий болон бутраад сувдан цагаан дүрсүүд агаарт задран гарлаа. Тэдний хоолойноос гарсан дуу шалан дээр бороо шиг асгарах шилний хагархайд дарагдав.

- Зугтаарай! гэж Харри тавиур сүртэй ганхан шилэн бөмбөлөгнүүд ар араасаа унаж эхлэхийг хараад хашгирав. Тэр Гермионагийн жанчнаас шүүрээд дээрээс асгаран бууж буй шилний хагархайнаас хамгаалан толгойгоо нөгөө гараараа тэвэрлээ. Ямар нэг Үхэл залгигч түүний хажуугийн тоосон үүлэн дундаас гарч ирэхэд тохойгоороо багтай нүүр руу нь хүчтэй цохиход өвдсөндөө хашгирах чимээ гарч, тавиурууд бие биеэ давхарлан унаад зөгнөгчид суллагдан гарлаа.

Харри өмнөх зам чөлөөлөгдсөнийг анзаарчээ. Рон, Жинни, Полумна гурав дэргэдүүр нь толгойгоо гараараа хаан гүйлээ. Ямар нэг хүнд зүйл хацар луу нь цохиж мөрнөөс нь барьж авахад Гермионагийн «Дөжир!» гэж хашгирах дуу сонсогдов. Түүнтэй зэрэгцэн мөр нь суларлаа ...

Тэд ерэн долдугаар эгнээний төгсгөлд хүрчээ. Харри баруун тийш эргээд бүх хүчээ гарган гүйв. Ардаа Гермиона, Невилл нарын гүйх хөлийн чимээг сонстол чанх өмнө нь тэдний орж ирсэн хаалганы дутуу нээлттэй завсраар болор суулганы гэрэл тусахыг харав. Тэр босгон дээгүүр үсрээд зөгнөлийг гартаа чанга барьж бусдыгаа орж ирэхэд чанга хаалаа ...

- Коллопортус! гэж Гермiona амьсгаадан хэлэхэд хаалга хачирхалтай чахран дуугарлаа.

- Бусад ... бусад маань хаачаа вэ? гэж Харри асуув.

Тэр Рон, Полумна, Жинни нарыг энэ өрөөнд хүлээж байгаа байх гэж бодсон ч хэн ч байсангүй.

- Тэд ийшээ гүйгээгүй байх! гэж Гермiona айн шивнэлээ.

- Сонсооч! гэж Невилл дуу алдав.

Тэдний саяхан орж ирсэн хаалганы цаана хөлийн чимээ болон хашгиралт сонсогдов. Харри хаалганд чихээ наагаад Люциус Малфойн хашгирахыг сонслоо.

- Түүнийг орхи Нотт, тавь сонсож байна уу? Түүний шарх Хар лордыг зөгнөлийг алдахтай харьцуулахад юу ч биш. Жагсон нааш ир, бид үүнийг заавал хийх ёстой! Хос болон хуваагдаад хайцгаая. Поттертой болгоомжтой харьцах ёстойгоо бүү мартаарай зөгнөл түүнд байгаа болохоор шаардлага гарвал бусдыг нь алж болно ... Беллатриса, Родольфус та хоёр зүүн тийш, Крэбб, Рабастаном хоёр баруун тийш, Жагсон Долохов урагшаа хаалга руу харин Макнейр Эйвери хоёр ийшээ. Руквуд тийшээ, Малсибер надтай хамт!

- Одоо бид юу хийх вэ? гэж Гермiona хөлөөсөө толгой хүртлээ чичирэн асуулаа.

- Энд зогсоод биднийг олохыг хүлээж болохгүй! Эндээс даруйхан холдох хэрэгтэй.

Тэд чимээ гаргахгүйг хичээн гялалзсан шилэн шилэн савны хажуугаар дугуй танхим руу гарах хаалга руу гүйхэд бяцхан өндөгнөөс шувуу ахин төрж байлаа. Тэднийг бараг байндаа хүрэх үед Харри хүчирхэг хүнд цохилт Гермionaгийн шившсэн хаалганд ирэхийг сонслоо.

- Холдоорой! Алохомора! гэх бүдүүн хоолой сонсогдов.

Хаалга нээгдэхэд Харри, Гермiona, Невилл гурав цагтай ширээн доогуур шургалж амжив. Хэдэн секунтын турш тэд шалан дээгүүр явах жанчны хормой харлаа. Тэдэн рүү хоёр Үхэл залгигч түргэн ойртож ирэв.

- Үүдний танхим руу зугтсан байх гэж бүдүүн хоолой хэлэв.

- Ширээн дор шалгая гэж нөгөө нь хэллээ.

Харри нэгнийх нь өвдөг нугларахыг хараад ширээн дороос саваагаа цухуйлган,

- Дөжир! гэж чанга хашгирлаа.

Улаан оч ойролцоох Үхэл залгигчийг цохиход дүүжин цаг цохин хойшоо уналаа. Нөгөө нэг нь Харрийн шившлэгээс үсрэн холдоод саваагаа ширээн дор мөлхөж байсан Гермiona руу чиглүүлж,

- Авада ... гэв.

Харри түүн рүү ухасхийн өвдгөөр нь тэвэрлээ. Үхэл залгигч шалан дээр унаад хараагаа алдав. Невилл ширээ хөмрүүлэн яаран туслахаар гарч ирээд тэдэн рүү саваагаа чиглүүлэн,

- Экспеллиармус! гэж хашгирав.

Харри, Үхэл залгигч хоёрын саваа гараас нь мулт үсэрч зөгнөлийн танхим руу явах чигт уналаа. Тэд хоёулаа босон түүний зүг ухасхийв. Үхэл Залгигч түрүүлэн гүйхэд Харри түүнээс хоцорсонгүй. Гэтэл Невилл араас нь,

- Замаас холд, Харри! гэж алдаагаа засахаар тэсч ядан хашгирлаа. Харри хажуу тийш болмогц Невилл ахин чиглүүлээд,

- Дөжир! гэж хашгирав.

Үхэл залгигчийн мөрөн дээгүүр улаан оч нисээд янз бүрийн хэлбэр хэмжээ бүхий цагаар дүүрэн шилэн нүүртэй шүүгээг онолоо. Шүүгээ ганхаснаа газар унан хагарахад хэлтэрхий зүг бүр цацагдсанаа дараа нь ахин хана руу үсрэн босч бүтэн болсноо унаж хагарлаа ...

Үхэл залгигч гялалзсан хоргын дэргэдэх шалан дээр хэвтэж байсан саваагаа авлаа. Харри ширээн дээгүүр харайх үед Үхэл залгигч эргэж хараад саад болж байсан багаа хуу татан авч сул гартаа бариад,

- Дөжи ...

- Дөжир! гэж саяхан гүйцэж ирсэн Гермiona хашгирав. Улаан оч Үхэл залгигчийн цээж рүү онолоо. Тэр гараа өргөсөн хэвээр хөшиж шилэн хорго руу арагшаа саван уналаа. Харри түүний унахад толгой хатуу шил цохих чимээ сонсохыг хүлээсэн ч үүний оронд толгой гялалзсан шингэнтэй суулга руу нэвт ороод савангийн хөөс бургилав.

- Акцио, саваа! гэж Гермiona хашгирав. Харрийн саваа харанхуй булангаас

үсрэн гарч ирэхэд эзэнд нь өглөө.

- Баярлалаа. Харин одоо ...

- Хараач! гэх Невиллийн хоолойд айдас сонсогдов. Тэр Үхэл залгигчийн толгойноос нүд салгалгүй хөшжээ.

Гурвуулаа дайралтанд бэлтгэн саваагаа өргөөд хоргонд орсон хүний толгой юу болсныг амаа ангайн харлаа.

Тэр нүдэн дээр хар үс нь гавал руугаа буцаж орон маш түргэн халзарснаа хацар нь толигор болж, халзан толгойг тойроод шар үс ургалаа ...

Үхэл залгигчийн булчинлаг бүдүүн хүзүү байсан газар хүүхдийн толгой бий болоход тийчэгнэн босохыг хичээв. Тэгснээ толгой нь хөөн ахин хэвийн хэмжээндээ орж хуйх болон эрүүнээс нь хар үс цухуйлаа ...

- Энэ чинь цаг хугацаа байна. Цаг хугацаа гэж Гермiona эмээнгүй хэлэв.

Үхэл залгигч гайхан толгойгоо чөлөөлөхийг хичээсэн ч амжсангүй ахин багасаад жижигхэн хүүхдийн толгой болон хувирав ...

Зэргэлдээх өрөөнд тар нярхийх чимээ сонсогдоод цөхрөн орилох дуу гарав.

- Рон! Жинни! Полумна! гэж Харри аймшигтай хувиралтаас нүд буруулан хашгирлаа.

- Харри! гэж Гермiona дуу алдав.

Үхэл залгигч эцэст нь хоргоноос толгойгоо гарган авчээ. Түүний байдал аймшигтай төрхтэй байлаа. Жижигхэн хүүхдийн толгой чанга орилсоор бүдүүн гараа зүг бүр тийш сарвалзуулав. Харри арай л оногдолгүй өнгөрлөө. Түүнийг саваагаа өргөтөл гайхалтай нь Гермiona зогсоолоо.

- Хүүхдэд гар хүрч болохгүй!

Маргах цаг байсангүй. Зөгнөлийн танхимаас яаран алхах хөлийн чимээ дуулдахад Харри түүний хашгиралт бусад Үхэл залгигч нарыг дуудсан болохыг хожуу ухаарчээ.

- Зугтая! гээд тэр хүүхдийн толгойтой Үхэл залгигчийг орхиод өрөөний булангийн онгорхой хаалга хүртэл гүйлээ.

Тэднийг замын хагастаа хүрсэн хойно Харри харанхуй өрөөнөөс хоёр Үхэл залгигч

гарч ирээд угтан гүйхийг харлаа. Зүүн тийш огцом эргээд жижигхэн, тоостой, давчуухан пин шиг өрөөнд ороод хаалгаа чанга хаалаа.

- Колло ... гэж Гермiona хэлж дуусаагүй байтал хаалга нээгдэж хоёр Үхэл залгигч түргэн орж ирэв. Тэд хоёулаа баясан хашгирлаа.

- Импедимента!

Хоёр шившлэг Харри, Невилл, Гермiona гурвын хөл рүү онолоо. Невилл ширээн дээгүүр нисээд үзэгдэхээ болив. Гермiona номын шүүгээ мөргөн унахад хүнд ботиуд асгарлаа. Харри дагзаараа чулуун хана мөргөж нүдэнд нь оч манаран хэдэн хормын турш юу болж байгааг ойлгохоо болив.

- Бид түүнийг барьсан! Тэр өрөөнд ... гэж Харрийн хажуугийн Үхэл залгигч орилов.

- Силенцио! гэж Гермiona хашгирахад хар шидтэн дуугүй болов. Түүний багний цоорхойд уруул хөдлөх боловч чимээ гарсангүй. Хоёр дахь Үхэл залгигч түүнийг түлхэн холдуулав.

- Петрификус тоталус! гэж Харри Үхэл залгигч саваагаа өргөхийг хараад хашгирлаа. Үхэл залгигч агшин зуур хөл гар нь биедээ наалдаад хатуу самбар адил нүүрээрээ газар унаад хөдөлсөнгүй.

- Сайн байна, Ха ...

Гэтэл Гермionaгийн хэлгүй болгосон Үхэл залгигч гэнэтхэн саваагаа даллахад улаан өнгийн дөл Гермionaгийн цээж рүү харван онолоо. Тэр гайхсандаа аяархан дуу алдаад шалан дээр унаж хөдөлгөөнгүй болов.

- Гермiona!

Харри Гермionaгийн дэргэд өвдөглөн унахад Невилл саваагаа барьсаар ширээн дороос яаран мөлхөн гарч ирэв. Шинэ дайснаа дөнгөж ажиглав уу үгүй юу Үхэл залгигч толгой руу нь хүчтэй өшиглөхөд Невиллийн саваа хоёр хуваагдаж нүүрэндээ гутлаар цохиуллаа. Тэр өвдсөндөө дуу алдаад хойш ухран хамраа дарлаа. Харри саваагаа өргөн огцом эргэж Үхэл залгигч багаа тайлахыг хараад энэ туранхай царай үрчлээтэй царай «Өдөр тутмын Зөнч» сонинд Пруэттыг алсан Антонин Долохов гэсэн нэртэй байсныг саналаа.

Долохов инээмсэглэв. Тэр сул гараараа Харрийн барьсан зөгнөл рүү заагаад өөр

лүүгээ заан цааш нь Гермiona руу дохив. Хэдийгээр ярьж чадахгүй ч гэлээ түүний дохио тодорхой байлаа. Надад зөгнөлийг өгөхгүй бол чамд юмуу түүнд муу зүйл тохиолдох болно ...

- Чи түүнийг аваад биднийг алахгүй гэж бодож болох уу! гэж Харри хэлэв. Дотор нь үймрэн зөв шийдвэр гаргахад саад болов. Тэр Гермionaгийн мөрөн дээр гараа тавихад бүлээн байлаа. «Зөвхөн битгий үхээрэй, гуйж байна, битгий үхээрэй, хэрвээ чи үхвэл миний буруу байх болно ...»

- Чи ду хийгээд байгаа юм бэ, Харри? гэж ширээн дороос гарч ирсэн Невилл ууртай хэлэхэд хамар нь хугарч эрүүг нь даган цус урсчээ.

- Дүүний хүссэн дүйлийг бүү өг!

Гэнэтхэн ард нь түжигнэх чимээ гарахад Долохов эргэж харлаа. Хаалгаар хүүхдийн толгойтой Үхэл залгигч чарлан уйлж том нударгаа зүг бүрт сарвалзуулан орж ирлээ. Харри боломжыг алдалгүй,

- Петрификус тоталус! гэж хашгирлаа.

Шившлэг Долоховыг онохоос урьд хааж амжсан ч нөгөөдхөө дайран унаад хоёул хөдөлгөөнгүй болов.

- Гермiona сэргэ л дээ ... гэж Харри гуйн мөрнөөс нь сэгсэрэхэд Хүүхдийн толгойтой Үхэл залгигч бүдэчсээр өрөөнөөс гарч одлоо.

- Түүнийг одоо яах вэ? гэж Невилл асуугаад ширээн доогуур бөхийн харахад хамар нь хөөн хавджээ.

- Мэдэхгүй.

Невилл Гермionaгийн бугуйнаас барилаа.

- Судас нь дохилж байна, Харри. Би үүнд идгэлтэй байна.

Харри сэтгэл нь хөнгөрөн санаа амрахыг мэдрээд агшин зуур толгой нь эргэх шиг болов.

- Тэр амьд уу?

- Дийм гэж бодож байна.

Нам гүм болоход зөвхөн хүүхдийн толгойтой Үхэл залгигч хөрш өрөөнд уйлсаар бүдчин явах сонсогдоно.

- Невилл гарц холгүй байгаа. Дугуй өрөө бидний хажууд байгаа ... хэрвээ чи тийшээ хүрч амжвал Үхэл залгигчид ирэхээс өмнө зөв хаалгыг олж чадах байх. Чи Гермionaг цахилгаан шатны хонгилд хүргээд ... тэндээс хэн нэгнийг олж ... түгшүүр зарла ...

- Харин ди юу хийх гэж дайгаа юм? гэж Невилл ханцуйгаараа цусаа арчин асуугаад Харри руу харлаа.

- Бусдыгаа хайж олъё.

- Дэгвэл би ч гэсэн дэднийг хайх болно гэж Невилл хатуу хэлэв.

- Гэхдээ Гермiona ...

- Дүүнийг хамт аваад явна. Би дүүнийг авч явж ... чи дэдэнтэй үдэлцсэн нь дээр байх гэж Невилл шийдэмгий дуугарлаа.

Тэр Гермionaгийн гарыг барин босоод Харри руу баргар царайлан харахад тээнэгэлзсэнээ тохойг нь мөрөн дээгүүр нь давуулахад туслав.

- Хүлээгээрэй. Үүнийг ав гээд Харри шалан дээрээс Гермionaгийн савааг авлаа.

Невилл хөлөөрөө савааныхаа хугархайг өшиглөөд хамтдаа удаанаар үүд рүү хөдлөв.

- Эмээ надайг алах байх даа. Эдгийн минь хуучин даваа байсан юм гэж Невилл сөөнгөтөн хэлэхэд хамраас нь цус дусаллаа.

Харри хаалгаар толгойгоо цухуйлган ийш тийшээ болгоомжтой харав. Хүүхдийн толгойтой Үхэл залгигч бахирсаар цагтай ширээнд тээглэн унаж хөмрүүлээд эхэр татан Харрийн цаг хугацааны эрчлүүр хадгалагдаж байгаа байх гэж тааварласан шилэн шүүгээ рүү ойчиход эвдэрсэн зүйл эргэн засагдав.

- Тэр биднийг анзаарахгүй. Явъя ... Битгий хоцроорой гэж Харри шивнэлээ.

Тэд пингээс гарч харанхуй хоосон өрөөнд орлоо. Ахин хэд алхах үед Невилл Гермionaгийн хүндийн жинд найгаж байлаа. Цаг хугацааны өрөөний хаалга хаагдахад хананууд ахин эргэлдэв. Дагзандаа цохилт аваад удаагүй болохоор Харри гуйвалсаар нүдээ аниад хана зогстол нээсэнгүй. Тэгтэл зүрх шимшрээд явчихлаа. Гермionaгийн галт хэрээс хаалганаас алга болжээ.

- Чинийхээр бол бид хаашаа ...?

Гэхдээ тэднийг шийдвэр гаргахаас урьтаж баруун талын хаалга нээгдэн гурван хүн

гадагш уналаа.

- Рон! Жинни! Та нар зүгээр үү? ... гэж Харри сөөнгөтөн хэлээд тэдэн рүү ухасхийлээ.

- Харри гэж Рон хөхрөн хэлээд найгаснаа Харрийн жанчнаас зуураад төвлөрсөн юмгүй нүдээр харахыг хичээв.

- Чи хаана байсан бэ ... ха-ха-ха ... инээдтэй байна, Харри ... чи өөртэйгээ төсгүй болчихож ...

Роны нүүр цонхийн цайж амнаас нь хар юм дусалж байлаа. Дараагийн агшинд тэр өвдөг сөхрөхдөө гараа тавьсангүй болохоор Харри даалгүй тонгойлоо.

- Жинни! Юу болоо вэ? гэж Харри айн хэлэв.

Гэвч Жинни ердөө толгой сэгсрээд хана даган сууж хүндээр амьсгаадан шагайгаа барилаа.

- Тэр хөлөө хугалчихсан байх. Би хяхтнах чимээ сонссон гэж Полумна хэлэв.

Тэр л ганцаараа цохилтонд өртөлгүй бүтэн үлдсэн бололтой.

- Тэд дөрвүүлээ байсан биднийг харанхуй гаригуудтай өрөөнд хөөж оруулсан юм. Маш хачирхалтай газар бид заримдаа харанхуйд хөвж байлаа ...

- Харри, бид Тэнгэрийн ванг ойроос харсан! Ойлгож байна уу, Харри? Бид

Тэнгэрийн ванг харсан ... ха-ха-ха гэж Рон сулхан хөхрөн хэлэв. Түүний амнаас цустай хөөс гарч байлаа.

- ... ерөнхийдөө тэдний нэг Жиннигийн хөлнөөс барьж авахад би Агшаах шившлэг илгээн Тэнгэрийн вангаар нүүр лүү нь цохиж ... гээд Полумна нүдээ аниад амьсгаадан суух Жиннигийн зүг гараа найдлагагүй зангалаа.

- Харин Рон яасан юм? гэж Харри түгшин хэллээ. Рон үргэлжлүүлэн хөхөрч жанчнаас нь чанга зуурлаа.

- Тэд түүнийг яасныг мэдэхгүй юм. Гэхдээ тэр хачин болчихсон. Би ийшээ арайхийж авчирлаа гэж гунигтай хэлэв.

- Харри гэж Рон чихэнд ойртон хөхрөн хэлээд,

- Энэ охин хэн болохыг мэдэж байна уу, Харри? Энэ Хагас ... Хагас ухаантай

Лавгуд ... ха-ха-ха ... гэв.

- Бид эндээс гарах хэрэгтэй. Чи Жиннид тусалж чадах уу, Полумна?
 - Тиймээ гээд Полумна саваагаа чихнийхээ ард аюулгүй хавчуулав. Тэр Жиннигийн бүсэлхийгээр тэврэн хөл дээр нь босгов.
 - Шагай бол дэмий хэрэг, би өөрөө босно! гэж Жинни тэвчээргүйхэн хэлээд дараагийн агшинд арай л унасангүй Полумнагаас барьж авлаа.
- Харри Роны гарыг мөрөн дээгүүр давуулаад хэдэн сарын өмнө гэр лүүгээ Дадлиг бас тэгж авч явсныг саналаа. Дараа нь арван хоёр хаалга руу харав. Тэдний ердөө нэг нь л ид шидийн яамны үүд рүү хүргэх болно ...
- Тэр Ронтой хаалганы зүг явав. Түүнд хүрэхэд ердөө хэдэн алхам үлдээд байтал эсрэг талын өөр хаалга нээгдэж Беллатриса Лейстрейнж тэргүүтэй гурван Үхэл залгигч орж ирлээ.
- Баригдав уу! гэж тэр хашгирав.
- Хөшөөх шид өрөөн дундуур гялсхийхэд Харри өмнөх хаалга руугаа Роныг бүдүүлгээр түлхэж бөхийн Невилл, Гермiona хоёрт туслав. Тэднийг дөнгөж босго давмагц Беллатрисагийн хамрын урд хаалга хаагдав.
- Коллопортус! гэж Харри хашгираад хаалганы нөгөө талаас гурван хүн мөрлөхийг сонслоо.
 - Зүгээр ээ! Тийшээ өөр аргаар орж болно ... Бид тэднийг барилаа, тэд энд байна! гэж эрэгтэй хүний хоолой хашгирлаа.
- Харри эргэлээ. Тэд ахин тархитай өрөөнд байв. Энд үнэхээр олон хаалга байлаа. Тэр хананы цаана хүн гүйх чимээ сонсоод эхний хаалга руу Үхэл залгигчаас өрсөн гүйлээ.
- Полумна ... Невилл ... туслаарай!
- Гурвуулаа өрөөн дотуур гүйж хаалгануудыг лацдахад Харри яарсандаа ширээ мөргөөд уначихлаа.
- Коллопортус!
- Хананы цаана алхаа сонсогдон үе үе хэн нэгэн бүх биеэрээ хаалга түлхэхэд хяхтнах чимээ гарч байв. Полумна, Невилл хоёр өрөөний нөгөө талд байгаа хаалгануудыг лацдахад Харри Полумнагийн хашгирахыг сонслоо.

- Колло ... а-а-а-а-а!

Тэр агшин зуур эргээд таван Үхэл залгигч хаалгаар орж ирэхэд Полумна зайлж амжилгүй мөргүүлэхийг харлаа. Тэр ширээ цохин унаад шал руу өнхөрч Гермionaгийн адил хөдөлгөөнгүй болов.

- Поттерыг барь! гэж Беллатриса орилоод Харри руу ухасхийв. Тэр цаашаа гүйхдээ тэд зөгнөлийг хагалахаас айж байгаа учир юу ч тохиолдохгүй гэдэгт итгэлтэй байлаа ...

- Хөөе! гээд Рон хөл дээрээ хүндхэн босоод согтуу юм шиг найгаж хөхөрсөөр, Хөөе, Харри! Тэнд тархи байна. Гайхамшигтай юм тийм үү? гэв.

- Замаас холд, Рон. Шалан дээр хэвт ...

Гэхдээ Рон хэдийн саваагаа шилэн хорго руу чиглүүлжээ.

- Үнэн шүү, Харри тэнд тархи байна ... хараач ... Акцио, тархи!

Өрөөнд байсан бүх хүн агшин зуур хөшлөө. Харри, Жинни, Невилл болон таван Үхэл залгигч шилэн хорго руу эргэж харахад ногоон шингэнээс тархи загас адил үсрэн гарч ирээд агаарт дүүжлэгдэн Роны зүг хөөрөхдөө хөдөлдөг тууз гарган задарлаа.

- Ха-ха-ха, Харри чи хараач ... гээд Рон тархийг харж,

- Нааш ирээд хүрч үз дээ. Гайхамшигтай юм ... гэв.

- Хэрэггүй, Рон!

Харри Роныг хүрмэгц юу болохыг мэдээгүй ч тархинаас урт тэмтрүүл сунгагдахад сайн зүйл болохгүй гэдэгт итгэлтэй байлаа. Тэр урагш гүйсэн ч Рон хэдийн тархийг хоёр гараараа барьж авчээ.

Түүний арьсанд дөнгөж хүрмэгц тэмтрүүл Роны гарыг олс шиг ороолоо.

- Харри, энийг хараач ... үгүй ... үгүй! Надад энэ таалагдахгүй байна! Хөөе, чи больж үз ... зогс ...

Нарийхан тууз түүний цээжийг баглав. Тэр мултрахыг оролдоход тархи наймаалжны бие шиг улам чангарлаа.

- Диффиндо! гэж Харри орилоод тэмтрүүлийг таслан суллахаар найдсан ч шившлэг тус болсонгүй. Рон унаад чөлөөлөгдөхөөр сарвалзав.

- Тэр түүнийг боомилж байна, Харри! гэж шалан дээр хөдөлж чадахгүй суусан Жинни хашгирахад гэнэтхэн улаан оч Үхэл залгигчийн савааны үзүүрээс гарч нүүр лүү нь онолоо. Тэр хажуу тийшээгэ ухаангүй унав.

- Дөдир! гэж Невилл Гермionaгийн савааг урдаас нь ирж буй Үхэл залгигч руу чиглүүлэн орилов. Дөдир, дөдир!

Гэвч юу ч болсонгүй.

Нэг Үхэл залгигч Невилл руу Хөшөөх шившлэг илгээхэд хажуугаар нь инчийн зайтай зөрөв. Одоо зөвхөн Харри, Невилл хоёр таван дайсны эсрэг тэмцсэн хэвээр үлдэхэд саваанаас мөнгөлөг гэрэл гарч тэдний арын ханыг нь онолоо. Харри зугтахад Беллатриса Лестрейнж түүний араас ухасхийв. Тэр зөгнөлийг толгой дээрээ өргөөд Үхэл залгигчдийг найзуудаасаа холдуулахыг боджээ.

Түүний төлөвлөөгөө бүтэх шиг болов. Тэд түүний араас хөөцөлдөх замдаа сандал ширээ дайрч унагасан ч зөгнөлд хор учруулахгүйн тулд шившлэг илгээж зүрхэлсэнгүй. Харри Үхэл залгигчдийн орж ирсэн цорын ганц онгорхой үүд болох хаалгаар үсрэн гарахдаа Невилл Роныг чөлөөлөх арга олоосой гэж найдлаа. Шинэ өрөөнд хэдэн алхам гүйтэл гэнэтхэн шал хөл дороос нь алга болохыг мэдэрчээ ...

Тэр чулуун шатаар унаж гишгүүр даган өнхрөөд эцэст нь хөнхөр нүхний голд нуман хаалгатай тавцангийн хажууд нуруугаараа хүчтэй уналаа. Өрөөгөөр дүүрэн Үхэл залгигчдын инээд хадав. Тэр босоод тархитай өрөөнд байсан таван Үхэл залгигч доошоо уруудахад бусад нь ондоо хаалгаар орж ирээд сандал дамжин харайсаар ойртож байхыг харлаа. Харри бостол хөл нь чичирч муу захирагдан унах шахлаа. Зөгнөл ямар нэг шидээр бүтэн үлджээ. Түүнийг зүүн гартаа бариад саваагаа баруун гартаа чанга атгалаа. Харри ухарч эхлэхдээ дайснуудаа хараандаа байлгахыг хичээлээ. Удалгүй хөл нь ямар нэгэн хатуу зүйлд тулахад нуман хаалгатай тавцан байлаа. Тэр арагшаагаа авирав.

Үхэл залгигчид түүн харан зогслоо. Зарим нь түүний адил хүндээр амьсгаадаж байв. Нэг нь битүү цус болжээ. Бие хүлсэн шившлэгээс мултарсан Долохов саваагаа Харрийн нүүр лүү чиглүүлэн инээмсэглэв.

- Чи хожигдсон, Поттер. Харин одоо сайн хүү байж надад зөгнөлийг өгдөө гэж Малфой аяархан хэлээд нүүрнээсээ багаа авлаа.

- Хо ... бусдыгаа холдуулвал өгнө! гэж Харри цөхрөн хэлэв. Хэдэн Үхэл

залгигчид инээлдэв.

- Чи наймаалцах нөхцөлд биш байна, Поттер. Бид арав харин чи ганцаараа гэдгээ харж байгаа биз дээ ... Эсвэл Дамблдор чамайг тоолж сургаагүй юм уу? гэж Малфой хэлэхэд цонхигор царайд нь сэтгэл ханамжтай өнгө тодорлоо.

- Тэр гандаараа биш! Дүүнд бас би байна! гэх хоолой дээрээс сонсогдлоо.

Харрийн зүрх ёгхийв. Невилл Гермионагийн савааг гартаа чанга атгаад чулуун шатаар бууж ирлээ.

- Невилл ... хэрэггүй ... Рон руу буц ...

- Дөдир! гэж Невилл ахин орилоод саваагаа Үхэл залгигчид руу ээлжлэн чиглүүлэв. Дөдир! Дөд ...

Тэдний хамгийн хүчирхэг биетэй нь Невиллийн араас тэврээд гарыг нь агдлан барилаа. Невилл өшиглөн мултрахыг хичээв. Үхэл залгигчид инээлдлээ.

- Энэ чинь Долгопус уу? Чиний эмээ бидэнд саад учруулсан гэр бүлийнхээ гишүүдийг алдахад хэдийн дасал болсон учир ... чиний үхэл түүний хувьд гэнэтийн явдал биш болно гээд Люциус Малфой инээмсэглэв.

- Долгопус гэнээ? хэмээн Беллатриса давтаад царайд нь хорон инээмсэглэл тодорлоо.

- Би чиний эцэг эхтэй уулзаж байсан болохоор баяртай байна, хүү минь!

- Би мэднэ! гэж Невилл дэлбэрээд хүчтэй эсэргүүцэхэд ард нь барьж байсан

Үхэл залгигч,

- Хэн нэг нь түүнийг хөшөөгөөч! гэж орилов.

- Үгүй ээ, үгүй гэж Беллатриса татгалзав. Түүнд ямар нэг санаа төрсөн бололтой Харри руу хөөрөн харснаа дараа нь Невилл руу эргэв.

- Үгүй, алив Долгопусыг ухаан алдатлаа хичнээн тэсвэрлэхийг харъя, яг л эцэг эх шигээ ... хэрвээ Поттер бидэнд зөгнөлийг өгөхийг хүсэхгүй байгаа бол шүү дээ.

- Дүүнд бидий өг! гэж Невилл орилоод Беллатрисийг саваагаа өргөн ойртоход өшиглөхийг оролдов. Дүүнд бидий өг, Харри!

Беллатриса түүн рүү саваагаа чиглүүллээ.

- Круцио!

Невилл чих дөжрөм хашгираад өвдөг нь нугларан уналаа. Үхэл залгигч түүнийг тавихад шалан дээр унаад өвдсөндөө эвхрэлдэв.

- Энэ бол зөвхөн эхлэл! гэж Беллатриса саваагаа холдуулаад хэлэв. Невиллийн хашгиралт намдахад шалан дээр хэвтээд уйлж байлаа. Тэр Харри руу эргэв.

- За, Поттер нэг бол бидэнд зөгнөлийг өг эсвэл найзыгаа үхтлээ зовохыг хар!
Харрид сонголт үлдсэнгүй. Тэр халуун бөмбөлөгтэй гараа урагш сунгалаа. Малфой авахаар урагш ухасхийв.

Гэнэтхэн дээд талын хоёр хаалга нээгдэж өрөөнд таван хүн гүйн орж ирлээ. Энэ бол Сириус, Люпин, Хурц нүдэт, Тонкс, Кингсли нар байлаа.

Малфой саваагаа барин эргэхэд Тонкс хэдийн Хөшөөх шившлэг илгээжээ. Харри түүний байгаа онохыг харахыг хүлээлгүй саад болохгүйн тулд тавцан доогуур шургалав. Үхэл залгигчид бүлгэмийн гишүүд гэнэт ирсэн явдалд балмагдсандаа шатнаас шат дамжин үсэрч шившлэгээс бултлаа. Хурц оч түүний дэргэд буух үед Харри Невиллийн зүг харлаа. Тэр ээлжит улаан очоос бултаад шалан дээр түүний дэргэд мөлхөж хүрэв.

- Чи зүгээр үү? гэж толгой дээгүүр нь ахин нэг шившлэг гэрэлтүүлэн өнгөрөхөд хашгирлаа.

- Дүгээр гэж Невилл хэлээд дөрвөн хөллөн босохыг хичээв.

- Харин Рон?

- Дүгээр байх. Дэр намайг гадахад тархитай тэмцэдсээр үлдсэн ...

Тэдний өмнөх чулуун шал цохилтонд өртөн дэлбэрч цуурахад Невилл гараа холдуулж амжлаа. Найзууд осолтой газраас түргэн холдоход хаа нэгтээгээс бүдүүн гар Харрийн шилэн хүзүүнээс дээш өргөж хөл нь газар арай ядан хүрлээ.

- Надад түүнийг өг. Надад зөгнөлийг өг ... гэж түүний чихэнд хоолой хэлэв. Эрэгтэй Харрийн хоолойг багалзуурдахад амьсгалж чадахаа болив. Тэр ус

гүйлгэнэсэн нүдээр Сириус нэг Үхэл залгигчтай хэдэн алхамын зайд үзэлцэж байхыг харлаа. Кингсли шууд хоёртой тулалдаж байв. Тонкс чулуун нүхний хагаст зогсоод доошоо Беллатриса руу шившлэг илгээж байсан учир хэн ч Харрийн үхэж буйг анзаарсангүй. Тэр саваагаа үл үзэгдэх дайсныхаа ташаа руу чиглүүлсэн авч шившлэг

хэлэх хүчгүй байсан тул зөгнөлтэй гараа чанга атгалаа ...

- А-А-А!

Невилл хаанаас ч юм гарч ирээд бас шившлэгийн үг хэлж чадахгүй тул Гермионагийн саваагаар Үхэл залгигчийн багны нүд рүү хатгалаа. Тэр өвдсөндөө хашгирч Харриг тавилаа. Харри чөлөөлөгдөөд даруй эргэж харан,

- Дөжир! гэлээ.

Үхэл залгигч шалан дээр хажуулдан унахад баг нь ховхров. Энэ бол Клювокрылыг арай л алаагүй Макнейр байлаа. Түүний нэг нүд хавдаж цус хуржээ.

- Баярлалаа! гэж Харри хашгираад Невиллийг түлхэн Сириус болон түүний өрсөлдөгчид зам тавьж өглөө. Тэд маш хурдтай үзэлцэж байсан болохоор савааны гэрэл нь гялалзсан толбо болон хувирчээ.

Харри хөл дор нь хатуу дугуй юм дайралдахад арай л унасангүй эхлээд зөгнөлөө унагачихаж гэж айсан боловч дараа нь Грюмын шидэт нүд шалан дээгүүр өнхөрч байхыг харлаа.

Түүний эзэн хажуулдан хэвтээд толгой нь цус болж ард нь байсан Долохов Харри, Невилл нарын зүг ухасхийлээ.

- Таранталлегра! гэж тэр орилоод саваагаа Невилл руу чиглүүлэхэд хөл нь галзуурсан юм шиг бүжиглэж эхлэв. Невилл тэнцвэр алдаад ахин газар унав.

- За, Поттер ...

Тэр Гермионад хэрэглэсэн шившлэгийн адил саваагаа ташуулдан цавчихад Харри,

- Протега! гэж хашгирлаа.

Харри царай луугаа мохоо хутгаар цохиулахтай адил зүйлийг мэдэрчээ. Цохилт хүчтэй байсан болохоор Невиллийн татганаж байгаа хөлний дэргэд унаж Бамбай шид түүнийг хамгийн муу зүйлээс аварлаа.

Долохов саваагаа ахин өргөв.

- Акцио, зөгн ...

Гэнэтхэн түүний зүг Сириус нисэн орж ирээд мөр лүү нь хүчтэй мөргөн унагав. Зөгнөл ахин Харрийн хурууны үзүүрээс мултрах шахаад тэсэж үлдлээ. Сириус, Долохов хоёрын тэмцэл эхэлж саваа илд шиг гялалзан үзүүрээс нь очис асгарч байв.

Долохов Харри, Гермiona нарт хийсэн шидийг хэрэглэн саваагаараа цавчихтай зэрэгцэн Харри шалан дээрээс үсрэн босоод,

- Петрификус тоталус! гэж хашгирав.

Долохов ахин гар хөл нь баглагдан нуруугаараа шалан дээр унав.

- Сайн байна! гэж Сириус бахдахад Харрийн толгой дээгүүр хоёр Хөшөөх шившлэг нисэн өнгөрлөө.

- Харин одоо эндээс зугтаа ...

Тэд нэгэн зэрэг бөхийхөд ногоон оч Сириусыг шүргэх шахам өнгөрлөө. Харри Тонкс ерөөний нөгөө хэсэгт унаад бие нь чулуун гишгүүр даган гулгаж баярлаж хөөрсөн Беллатриса тэмцлийн гүн рүү эргэхийг харлаа.

- Харри! Зөгнөлийг аваад Невиллийн хамт зугтаа! гэж Сириус бүх хүчээрээ хашгираад Беллатрисаг угтан ухасхийв.

Харри дараа нь юу болсоныг харсангүй урд нь Руквудтай тэмцэлдэж байсан Кингсли урган гарч ирлээ. Ахин нэг ногоон оч Харрийн толгой дээгүүр гялсхийхэд Невилл рүү гүйлээ ...

- Босож чадах нь уу? Миний хүзүүгээр тэвэр ... гэж хөл нь хяналтгүй сарвалзаж буй Невиллийн чихэнд хашгирлаа.

Харри хамаг булчингаа чангалан Невиллийг өргөх гэсэн ч хөл нь өмнөхийн адил захирагдахгүй байсан тул дэмжиж болсонгүй. Гэнэтхэн хаа нэгтээгээс тэдэн рүү хүн ухасхийн ирлээ. Хоёулаа арагш унахад Невилл дээшээ харан эргэлдэж буй цох шиг хөлөө нүдэж, Харри шилэн бөмбөлөгийг хагалахгүйн тулд зүүн гараа өргөв.

- Зөгнөлийг надад өг, Поттер! Түүнийг надад өг! гэх Люциус Малфойн дуу чихэнд сонсогдоод савааны үзүүр хавирга руу нь өвдтөл хатгалаа.

- Үгүй ... тавиач ... Невилл, аваарай!

Харри бөмбөлөгийг шалан дээгүүр Невиллийн зүг өнхөрүүлэхэд барьж аваад цээжиндээ наалаа. Малфой саваагаа Невилл рүү чиглүүлэхэд Харри саваагаа мөрөн дээгүүрээ хатган,

- Импедимента! гэж хашгирав.

Шившлэг Малфойг хойш шидэв. Харри түргэн босоод түүнийг Сириус Беллатриса хоёрын тэмцлийн дунд тавцан дээр нуруугаараа унасныг харлаа. Малфой ахин

саваагаа Харри, Невилл хоёр луу чиглүүлэхэд тэдний дунд Люпин үсрэн гарч ирэв.

- Харри, бусдыгаа цуглуулаад зугт!

Харри Невиллийн мөрнөөс барьж жанчнаас нь өргөөд чулуун суудлын эхний эгнээнд хүргэв. Невиллийн хөл чичирч биеэ даах хүчгүй болжээ. Харрин ахин хүч гарган нэг эгнээ өгслөө ...

Шившлэг хөл дорх чулууг цохиход сандал хэдэн хэсэг болон бутраад Харри ахиад л доош уналаа. Невилл газар палхийн суухад Харри зөгнөлийг түүний халаас руу шургуулав.

- Алив л дээ! Хөл дээрээ жаахан өндий ... гэж тэр цөхрөн орилоод Невиллийн жанчнаас өргөлөө.

Ахин нэг томоохон хүч гаргасан ч Невиллийн жанч урагдан жижигхэн шилэн бөмбөлөг халааснаас нь унаад барьж авахаас урьд тийчигнэсэн хөлд цохиулан арван футын өндрөөс нисэж доод талын гишгүүрт цохигдон хагарлаа. Тэд хоёул хагарсан газрыг айдаст автан харахад агаарт ер бусын том нүдтэй сувдан цагаан дүрс хөөрөхийг хэн ч анзаарсангүй. Харри түүний уруул хөдлөхийг харсан хэдий ч тэмцлийн чимээ шуугиан дунд үг сонсогдсонгүй. Дүрс ярьж дуусаад агаарт алгуур алга болов.

- Намайг уудлаарай, Харри! Би будуутай, Харри би хүдээгүй гэж амь тэмцэн тийчэгнэж буй хөлдөө зовж шаналсан Невилл хашгирлаа.

- Энэ чухал биш! Босохыг оролд доо, эндээс явах хэрэгтэй байна гэж Харри хашгирав.

- Дабблдор! гээд Невилийн хөлстэй нүүр гэнэтхэн гийлээ. Тэр Харрийн ар тал руу харж байв.

- Юу?

- Дабблдор!

Харри эргэж хараад түүний харцыг дагуулан харав. Тэдний дээр байсан тархитай ерөөний босгон дээр Альбус Дамблдор саваагаа өргөн зогсоод царай нь уур хилэнд автжээ. Харрийн бүх биеэр аврагдсан гэсэн цахилгаан гүйдэл гүйлээ.

Дамблдор Харри, Невилл хоёрын хажуугаар доош уруудахад тэд зугтах тухай бодохоо болилоо. Тэдний сургуулийн захирал доод талын суудалд хүрэх үед

ойролцоо байсан Үхэл залгигч ажиглаад бусаддаа хашгиран мэдэгдэв. Тэднийг нэг зугтахыг оролдон эсрэг талын шатны гишгүүр лүү сармагчин шиг авирлаа. Дамблдор түүний араас хялбархан шившлэг илгээж үл үзэгдэх олстой дэгээгээр гогдон авлаа ...

Зөвхөн хоёр өрсөлдөгч үргэлжлүүлэн тэмцсээр орчиндоо болж буй зүйлд анхаарал хандуулсангүй. Харрийн нүдэн дээр Сириус Беллатрисагийн илгээсэн улаан очоос бултаад инээлээ ...

- Алив л дээ! Чиний дээрдсэн гэдгийг харж байна! гэж хашгирахад хоолой нь том танхимд цуурайтайв.

Хоёр дахь улаан оч түүний цээж рүү онолоо.

Сириусын царайнаас инээмсэглэл алга болсонгүй зөвхөн нүд нь гайхсандаа томорлоо.

Харри Невиллийг тавьсанаа өөрөө ч мэдсэнгүй. Тэр ахин доод талын гишгүүр лүү уруудаж саваагаа гарган гүйхэд, Дамблдор ч гэсэн тавцангийн зүг ухасхийв.

Сириус мөнх унах шиг санагдаж бие нь алгуур ганхлаа.

Харри загалмайлан эцгийнхээ царайд айдас гайхширал төрөхийг хараад дараагийн агшинд нуман хаалганы гүн рүү алга болоход хөшиг гэнэтийн салхинд хүчтэй дэрвэлзсэнээ нам гүм боллоо.

Беллатриса Лестрейнжийн ялалтын дуу хадсан ч Харри айх зүйл юу ч болоогүй гэж мэдэж байв. Сириус ердөө унаад хөшигний цаагуур орсон одоохон хаалганы нөгөө талаас гараад ирнэ ...

Гэвч Сириус гарч ирсэнгүй.

- Сириус! Сириус! гэж Харри хашгирав.

Тэр нүхний ёроолд хүрэхдээ багтартал амьсгаадаж байв. Сириус ойрхон л байх ёстой тэр одоохон хөшигний цаанаас гаргана ...

Гэхдээ түүнийг тавцан дээр үсрэн гарахаас урьтаж Люпин араас нь тэврэн авлаа.

- Чи юу ч хийж чадахгүй, Харри.

- Түүнд туслая, түүнийг аврая, тэр саяхан энд байсан! ...

- ... хэтэрхий оройтсон, Харри.

- Би одоохон түүнийг гаргана гээд Харри уурсан мултрахыг оролдсон ч Люпин тийм ч амархан тавихааргүй байлаа.
- Чи юу ч хийх боломжгүй, Харри ... юу ч ... тэр эргэж ирэхгүй болсон.

БҮЛЭГ 36: ТҮҮНИЙ ЦОРЫН ГАНЦ АЙДАГ ХҮН

- Худал! гэж Харри хашгирлаа.

Тэр үүнд итгэж чадсангүй. Тэр үүнд итгэхийг хүсээгүй учир Люпинтэй сүүлчийн бүх хүчээ гарган тэмцлээ. Люпин ердөө хөшигний цаана хүмүүс нуугдаж байгааг ойлгохгүй байна. Харри тэдний шивнэлтийг энэ өрөөнд анх орж ирэхдээ сонссон. Сириус нуугдсан тэр ердөө л харагдахгүй нуугдсан ...

- Сириус! Сириус! гэж тэр ахин хашгирав.

- Тэр эргэж ирж чадахгүй, Харри. тэр эргэж ирэхгүй, тэр үх ...

- Тэр үхээгүй! Сириус! гэж Харри дэлбэрлээ.

Тэдний эргэн тойронд учир нь олдохгүй үймээн болж байв. Хажуугаар нь шивлэг ахин дахин зурсхийн өнгөрөх хэдий ч Харри үүнд анхаарал хандуулсангүй. Тэр зөвхөн Люпин Сириусыг хоёр алхамын зайд энэ хуучин хөшигний цаана зогсоод тэндээс гарч ирэхгүй мэт дүр үзүүлж байна гэсэн ганц бодолд автжээ. Үгүй тэр одоо гарч ирнэ, духнаасаа хар үсээ холдуулан сэгсрээд ахин тэмцэлд эргэн ирнэ!

Люпин Харриг тавцангаас холдуулав. Харри нуман хаалга руу харсаар түүнийг хүлээлгэж байгаад нь Сириуст уурлаж эхлэв.

Гэхдээ Люпины гараас мултрахыг ородож байх зуур ухааны нэгээхэн хэсэг нь Сириус хэзээ ч өмнөх шигээ түүнийг хүлээхгүй болсныг ойлгов. Сириус үргэлж эрсдэлд ордог байсан зөвхөн Харриг харах гэж, түүнд туслах гэж ... хэрвээ Сириус Харриг цөхрөн дуудаж байхад энэ хаалганы араас гарч ирэхгүй бол үүнийг ганц л зүйлээр тайлбарлаж болох байлаа. Тэр эргэж ирэхгүй ... тэр үнэхээр ирэхгүй ...

Дамблдор үлдсэн Үхэл залгигчдыг өрөөний голд цуглуулахад тэд үл үзэгдэх олсоор хүлээтэй байлаа. Хурц нүдэт Грюм шалан дээр хэвтэж байгаа Тонксын хажууд мөлхөн хүрээд сэргээхийг оролдов. Тавцанд оч гялсхийсэн хэвээр хаа нэгтээгээс чанга хашгиралт гарлаа. Кингсли Сириусын тулааныг Беллатристай үргэлжлүүлж байв.

- Харри!

Невилл чулуун шатаар гулгасаар зогсож буй газар нь ирлээ. Харри Люпиныг эсэргүүцэхээ больсон ч ямар ч атугай сэрэмжлэн тохойноос нь барьжээ.

- Харри ... надад их хадамсалтай байна. Энэ хүд ... Сириус ... чиний найд

байсан уу? гэж Невилл хэлэв. Түүний хөл одоо хүртэл хэвийн болоогүй байлаа. Харри толгой дохив.

- Одоохон гэж Люпин тайван хэлээд саваагаа Невиллийн хөл рүү чиглүүлэн, «Финита!» гэв. Шившлэг тайлагдахад Невиллийн хөл шалан дээр хөдөлгөөнгүй унав.

- Харин одоо ... одоо бусдыг чинь хайж больё. Тэд хаа байна, Невилл? Люпин нуман хаалга руу эргэв. Тэр цонхийн цайгаад үг бүрээ шаналан ярьж байлаа.

- Дэд дээр байгаа. Роныг дархи дайрсан ч дүүний бүх зүйл хэдийн гэж бодож байна. Харин Гермiona удаангүй болоод хэвтэж байгаа ...

Тавцангийн цаана чанга тасхийх чимээ гараад орилох дуу хадав. Харри Кингслиг өвдсөндөө хашгиран унахыг харлаа. Беллатриса Лестрейнж чөлөөлөгдөн зугтав. Дамблдор түүний араас шившлэг илгээсэн ч бултаад гишгүүрийн хагаст хүрлээ.

- Харри, зогсооч! гэж Люпин хашгирсан ч Харри түүний тэврэлт суларсныг ашиглан мултарч амжлаа.

- Тэр Сириусыг алсан! Тэр түүнийг алсан. Харин би түүнийг ална! гэж Харри хашгирав.

Тэр дээшээ чулуун шатаар түргэн ухасхийлээ. Ард нь ямар нэг юм хашгирсан ч анхаарал хандуулсангүй. Беллатрисагийн жанч хаалганы цаагуур ороход араас нь даган тархитай өрөөнд оров ...

Тэр түүн рүү мөрөн дээгүүрээ шившлэг илгээлээ. Тархитай хорго агаарт үсрэн асгарав. Харри өмхий ногоон шингэнд будагдаж тархи биеийг нь урт тэмтрүүлээрээ ороон авахад «Вингардиум левиоса!» гэж хашгирахад зүг бүр тийш нисэв. Тэр гулсаж хальтирсаар хаалга руу гүйгээд шалан дээр ёолон хэвтэж байгаа Полумнагийн дээгүүр харайн, сулхан нэрийг нь дуудаж байгаа Жиннигийн хажуугаар гүйж, аяархан инээж байгаа Рон болон ухаангүй хэвтэж байгаа Гермiona нарыг өнгөрлөө. Дугуй танхимд орох хаалгыг нээхэд Беллатриса эсрэг талын хаалгаар орсноос үзвэл тэнд цахилгаан шат руу буцах зам байгаа бололтой.

Тэр тийш гүйсэн ч хаалга хаагдахад хана эргэлээ. Ахиад л эргэн тойрны бүх зүйл алга болон цэнхэр судал болон жирэлзэж лааны дөл анивалзав.

- Гарц хаана байна? Эндээс яаж гарах вэ? гэж тэр өрөө хөдөлгөөнгүй болоход

цөхрөн хашгирлаа.

Өрөө энэ л асуултыг хүлээж байжээ. Чанх урд нь хаалга нээгдэхэд бамбарын хурц гэрэлтэй хонгил хоосон байлаа. Харри ахин гүйлээ ...

Тэр цахилгаан шат дээр хяхтнах чимээ сонсоод хурдаа хасан булан эргээд хоёр дахь цахилгаан шатны товчлуурыг нударгаараа цохилоо. Тэгтэл харжигнах чимээ гаран сараалж хоёр тийш нээгдэв. Харри дотогш ороод «Үүдний танхим» гэж бичсэн товчлуурыг дарлаа. Хаалга хаагдаж цахилгаан шат хөдлөв.

Тэр сараалж бүрэн нээгдэхийг хүлээлгүй хүчээр чихэн гараад эргэн тойрноо харав. Беллатриса хэдийн танхимын төгсгөл дэх телефон утасны бүхээгт хүрч байснаа эргэж хараад ахин нэг шившлэг илгээв. Тэр бултаад шидтэн ах дүүсийн усан сангийн араар ороход дэргэдүүр нь нисэн өнгөрч танхимын төгсгөлийн алтан хаалгыг оноход хонх адил хүнгэнэлээ. Беллатрисын алхаа чимээгүй болов. Тэр хөшөөний цаана нуугдаад сонслоо.

- Гараад ир, гараад ир бяцхан Харри минь! гэж тэр элэглэсэн хоолойгоор аялгуулан хэлэхэд толигор шалан дээгүүр чанга цуурайтлаа.

- Чи яах гэж миний араас гүйгээ вэ? Би чамайг үнэт үеэл дүүгийн минь өшөөг авах гэж байна гэж бодлоо.

- Тиймээ хүсч байна гэж Харри арав дахин чанга хашгирахад эргэн тойронд цуурайтан «Тиймээ, Хүсч байна!», «Тиймээ, хүсч байна!», «Тиймээ хүсч байна!» гэж давтлаа.

- Тийм байж ... магадгүй чи түүнд хайртай байсан уу, жижигхэн Поттер минь?

Харрийн дотор хэзээ ч мэдэрч байгаагүй үзэн ядалт дүрсхийхэд усан оргилуурын араас сум шиг үсрэн гараад,

- Круцио! гэж хашгирлаа.

Беллатриса хашгирлаа. Шившлэг түүний хөлийг оносон ч Невилл шиг атриалдан өнхөрсөнгүй. Агшин зуур хүнд амьсгаадан босож ирээд инээхээ болив. Харри ахин алтан усан сангийн араар нуугдав. Беллатрисийн хариу шившлэг сүр жавхлантай шидтэнгийн толгойг оноход үсрээд хорин алхамын зайд модон шал уртаар зуран уналаа.

- Чи урьд нь хэзээ ч Уучлашгүй шивлэгийг ашиглаж байгаагүй байх, тийм үү

хүү минь? Чи түүнийг үйлчлэхийг жинхэнээсээ хүсэх ёстой, Поттер! Өвтгөхийг хүсэн сэтгэл ханамж авах ёстойгоос биш шударга уур хилэн өвтгөж чадахгүй! Би чамд яаж хийдгийг нь үзүүлэх үү? Би чамд хичээл заая ...

Харри усан оргилуурын араар тойрон явахад тэр «Круцио!» гэж хашгирсанд түргэн бөхийлөө. Шившлэг хүн морины нум барьсан гарыг оноход алтан шидтэний толгойноос холгүй шалан дээр түсхийн уналаа.

- Чи намайг ялж чадахгүй, Поттер! гэж Беллатриса хашгирав.

Тэр түүний баруун тийш явахыг сонсоод арагш ухарч хүн морины хөлийн цаагуур нуугдахад толгой нь гэрийн үйлчлэгчтэй чацуу байлаа.

- Би Хар лордын хамгийн үнэнч зарцаар үлдсэн. Тэр намайг хар урлагт сурган хүчирхэг шид эзэмшсэн болохоор өрөвдөлтэй хүү чи хэзээ ч надтай тэмцэж чадахгүй ...

- Дөжир! гэж Харри хашгираад албингийн араар ороход толгойгүй шидтэн инээмсэглэсэн хэвээр хэвтэж байв. Тэр түргэн хариулсан учир арай ядан нуугдаж амжлаа.

- Протега!

Түүний илгээсэн Хөшөөх шившлэг буцаж ойлоо. Харри усан оргилуурын ард нуугдахад албингийн нэг чих танхим дундуур нисэж одов.

- Би чамд боломж өгч байна, Поттер! Надад зөгнөлийг өг! Түүнийг шалан дээгүүр над руу өнхрүүл тэгвэл чиний амь аврагдана! гэж Беллатриса хашгирав.

- Тэгвэл чамд намайг алах хэрэг гарч дээ. Учир нь надад тэр байхгүй! гэж Харри хашгирахад дух нь хүчтэй өвдөн хуучин сорви нь халуу шатаж өөртэйгээ холбоогүй уур хилэнг мэдэрлээ.

- Тэр үүнийг мэдэж байна! Чиний хөгшин найз Волдеморт түүний хагарсныг мэдэж байна! Тэр үүнийг төлөө чамайг магтах болов уу? Юу гэж бодож байна? гээд Харри түүний адил ухаангүй инээд алдлаа.

- Юу? Чи юуны тухай яриад байна? гэж тэр дуу алдахад анх удаагаа хоолойд нь айдас сонсогдлоо.

- Зөгнөл Невиллийг шатны гишгүүр өгсүүлэх гэж оролдох үед хагарсан! Чи Волдемортыг үүний тухайд юу гэж хэлнэ гэж бодож байна? Түүний сорви төөнөхөд

... өвдсөндөө нүдэнд нь нулимс цийлэгнэлээ ...

- Худалч! гэж тэр айдаст автан орилоод,

- Тэр чамд байгаа, Поттер. Чи түүнийг надад өг! Акцио зөгнөл! Акцио зөгнөл!
гэв.

Харри ахин инээхэд сорви нь тэсвэрлэхийн аргагүй өвдөж гавал нь одоохон хэсэг болон хуваагдах гэж байгаа юм шиг санагдав. Тэр хоосон гараараа албингийн нэг чихний араар даллаад түргэн нуугдахад ахин нэг ногоон оч илгээгдлээ.

- Харж байна уу, хоосон байхыг! Юу ч авсангүй! Хагарсныг нь хэн ч мэдээгүй гэж өөрийн эзэндээ хэл!

- Үгүй! Чи худал хэлж байна, энэ чинь худал! Би буруугүй, Эзэнтээн, Би оролдсон ... Намайг битгий шийтгээч гэж тэр орилов.

- Хичээх хэрэггүй дээ! Тэр чамайг сонсохгүй! гэж Харри хашгираад өвчнөө тэсвэрлэхийн тулд нүдээ анилаа.

- Тийм гэж үү, Поттер? гэх өндөр хүйтэн хоолой гарав. Харри нүдээ нээлээ.

Өндөр туранхай хар юүдэн бүхий могой адил аймшигтай царай, час улаан хүүхэн хараатай нүд ... лорд Волдеморт танхимын голд зогсоод түүн саваагаа чиглүүлэхэд Харри хөдлөх хүчгүй болон байрандаа хөшлөө.

- Тэгэхээр чи миний зөгнөлийг хагалсан юм биз дээ? гэж Волдеморт асуугаад өрөвдөх сэтгэлгүй улаан нүдээр цоо ширтэв.

- Үгүй, Белла тэр худал хэлээгүй байна ... би үнэн гэдгийг үнэ цэнгүй тархинаас нь харж байна ... бүтэн сар бэлтгэж, хичнээн их чармайлт гаргасан гээч ... харин Үхэл залгигч чи Харри Поттерт миний төлөвлөгөөг ахин эвдэх боломж олгосон байна ...

- Эзэнтээн, намайг өршөөгөөрэй, би мэдээгүй! Би анимаг Блэктэй тэмцэж байсан! гэж Беллатриса цурхиран уйлаад Волдемортын хөлд уналаа.

- Та мэдэж байгаа, эзэнтээн ...

- Амаа тат, Белла гэж Волдеморт заналхийлсэн хоолойгоор хэлэв.

- Би хормын дараа чиний учрыг олно. Чи намайг ид шидийн яаманд тэнэг гонгинолт сонсохоор ирсэн гэж бодоогүй биз дээ?

- Гэхдээ, эзэнтээн ... тэр энд ... дор байгаа ... Волдеморт түүнд анхаарал хандуулсангүй.

- Надад чамд хэлэх зүйл алга, Поттер гэж тайван хэлээд,

- Чи надад хэтэрхий үргэлж, хэтэрхий удаан саад хийлээ. Авада Кадевра! гэв.

Харрид эсэргүүцэхээр ам нээх хүч байсангүй. Толгой нь хоосорч саваа нь газар луу унжлаа.

Гэтэл усан оргилуурын толгойгүй алтан шидтэний хөшөө амь орон байрнаасаа үсэрч бугаад тэдний дунд газардав. Шившлэг түүний цээжийг оноход хөшөө гараа дэлгэн Харриг шинэ дайралтнаас хамгааллаа.

- Юу? ... гэж Волдеморт хашгирснаа эргэн тойрноо хараад,

- Дамблдор! гэв.

Харри эргэж харахад зүрх нь хүчтэй дэлслээ. Алтан хаалганы урд Дамблдор зогсож байв.

Волдеморт саваагаа өргөн ахин нэг ногоон оч Дамблдорын зүг илгээсэн ч буурал үстэй хөгшин огцом эргээд жанчнаасаа хуй үүсгэн алга боллоо. Дараагийн агшинд тэр Волдемортын ард гарч ирээд эвдэрсэн усан оргилуурын зүг саваагаа даллахад үлдсэн хөшөөнүүд амь оров. Шидтэн эмэгтэйн хөшөө Беллатриса руу ухасхийн гүйхэд хашгиран шившлэг илгээсэн хэдий ч шалан дээр даран унагалаа. Тэгтэл албин, гэрийн үйлчлэгч хоёр ханан зуух руу гүйж, ганц гартай хүн морь Волдеморт руу давхилаа. Толгойгүй шидтэн Харриг холдуулан түлхэж тулааны талбараас холдуулав. Дамблдор Волдеморт руу хөдлөхөд хүн морь хамтдаа шогшуулав.

- Өнөө шөнө энд ирсэн чинь тэнэг хэрэг болж дээ, Том. Одоохон энд мракоборецууд ирнэ гэж Дамблдор тайван хэлэв.

- Тэр үед би энд байхгүй, харин чи үхсэн байх болно гэж Волдеморт зандарлаа.

Тэр Дамблдор руу ахин үхлийн шившлэг илгээхэд бултсанд жижүүрийн шидтэнгийн ширээ өртөж зомгол боллоо.

Дамблдор саваагаа ажиглагдамгүй хөдөлгөхөд шившлэгийн хүч нь аугаа байсан тул алтан шидтэнгээр хамгаалуулсан Харрийн үс хийсэж, Волдеморт шившлэгийг няцаахын тулд агаарт мөнгөлөг бамбай бий болгов. Шившлэг бамбайд үзэгдэм хохирол учруулаагүй ч харанга шиг чанга цуурайтахад Харрийн хамаг бие

агзасхийлээ.

- Чи намайг алах гээ юу, Дамблдор? Өөрийгөө тийм хэрцгий гэж бодоо юу? гэж Волдеморт хашгираад улаан нүдээ бамбайн дээгүүр шоолонгуй нарийсгав.

- Бид хоёулаа хүнийг алах өөр арга мэднэ, Том гэж Дамблдор тайван хэлээд Волдемортын урдаас өчүүхэн ч айсан шинжгүй явахад энэ тайван алхааг нь саатуулах зүйл үгүй мэт санагдав.

- Гэхдээ би чиний амьдралыг авахад хүрвэл сэтгэл ханамжтай байхгүй гэдгээ хүлээн зөвшөөрөх байна.

- Үгүй ээ, үхлээс дор юу ч байхгүй, Дамблдор! гэж Волдеморт хашгирав.

- Чи алдаж байна гэж Дамблдор эсэргүүцээд Волдемортод ойртоход дууны өнгө нь хамтдаа шар айраг ууж буй хүмүүсийн адил хайхрамжгүй байлаа. Харри түүний дайсныхаа урдаас ямар ч хамгаалалтгүй аймшиггүй явахыг айдаст автан хараад хашгиран анхааруулахыг хүссэн ч толгойгүй хамгаалагч нь түүнийг хананд шахаад мултрах гэсэн оролдлого нь үр дүнгүй болов.

- Чи энэ дэлхий дээр үхлээс дор юу ч байхгүй гэж бодож байдагт гол сул тал чинь оршиж байгаа юм ...

Ахин нэг ногоон оч мөнгөлөг бамбайг мөргөв. Энэ агшинд Дамблдорын араас давхиж байсан ганц гартай хүн морь урдуур нь орон цохиулаад зуун хэсэг болон хагарч хэлтэрхий нь шалан дээр унаж амжаагүй байхад тэр ахин саваагаа даллав. Түүний савааны үзүүрээс урт нарийхан дөл гарч Волдемортыг бамбайн хамт хүрээлэв. Агшин зуур Харрид Дамблдор ялах шиг санагдсан ч галт олс могой болон хувирч Волдемортыг орхиод ууртай исгэрэн Дамблдор руу эргэлээ.

Волдеморт агаарт алга болоход могой шалан дээрээс өндийгөөд дайралтанд бэлтгэв

...

Тэгтэл танхимын голд дөл дүрсхийгээд Волдеморт саяхан таван хөшөө зогсож байсан усан сангийн тавцан дээр бий болов.

- Болгоомжтой! гэж Харри хашгирлаа.

Түүний хашгиралттай зэрэгцэн ахин нэг ногоон оч Волдемортын саваанаас харван нисэхэд могой ухасхийн дайрлаа.

Дамблдорын урдуур Фоукс орж хошуугаа том ангайн ногоон очыг бүтнээр залгиад

дүрсхийн шалан дээр унаж жижигхэн, үрчийсэн нисэх чадваргүй боллоо. Тэр агшинд Дамблдор саваагаа даллан урт хөдөлгөөн хийхэд могой агаарт шингэн хар утаа болж, усан оргилуурын ус дээш хөөрөн Волдемортыг хайлмал шилэн эрүүл шиг хучин авлаа.

Хэдэн секунтын турш Волдемортын тодорхойгүй дүрс долгионд чичигнэн балархай болж харагдав.

Дараа нь тэр алга болоод ус хашлагандаа чимээтэй унаж гадагш цацагдлаа.

- Эзэнтээн! гэж Беллатриса хашгирав.

Бүх зүйл дуусаад Волдеморт зугтсан гэдэгт итгэлтэй болсон Харри хамгаалагчынхаа араас үсрэн гарахыг хүссэн ч Дамблдор түүнийг,

- Бүү хөдөл, Харри! гэв.

Дамблдорын хоолойд анх удаагаа айдас сонсогдсонд Харри яагаад гэдгийг нь ойлгосонгүй. Танхимд зөвхөн тэднээс гадна хөшөөний дор цурхиран уйлах Беллатрисагаас ондоо хэн ч үлдсэнгүй, галт шувуу феникс аяархан дуугарав ...

Тэгтэл Харрийн сорви аймшигтайгаар өвдөхөд үхэж буйгаа ойлгов. Энэ бол хэлж боломгүй тэсвэрлэхийн аргагүй өвдөлт байлаа ...

Тэр танхимд биш улаан нүдтэй амьтаны цагариглан ороолтонд хөл гараа чанга баглуулан зогсоод хэзээ түүний бие энэ амьтаных болж дуусахыг нь мэдсэнгүй. Тэд хамтдаа нэгдэн нийлэхэд өвдөлтөөс зугтах аргагүй байлаа ...

Дараа нь амьтан Харрийн амаар ярихад зовж шаналан эрүүгээ хөдөлгөлөө ...

- Намайг ал, Дамблдор ...

Биеийн хэсэг бүр нь чөлөөлөгдөхийг хичээж, Харри ахин бусдын гарт зэвсэг болжээ ...

- Хэрвээ үхэл юу ч биш юм бол хүүг ал, Дамблдор ...

Зөвхөн үүгээр өвдөлт намдах байсан тул Харри ... түүнийг алаасай ... Дамблдор шийдээсэй ... үхэл бол үүнтэй харьцуулахын аргагүй гэж бодлоо.

Тэгвэл би ахин Сириусыг харна ...

Тэгтэл Харрийн зүрхэнд дулаахан мэдрэмж дүүрч цагариг сулран өвдөлт намдлаа. Харри шалан дээр доош харан нүдний шилгүй хэвтээд мөсөн дээр хэвтэж байгаа юм

шиг чичирч байлаа ...

Танхимд олон хүний хоолой сонсогдов ... Харри нүдээ нээгээд нүдний шил нь толгойгүй шидтэний хөшөөний хөлд байхыг харж авч зүүгээд толгойгоо өргөтөл Дамблдорын урт махигар хамар хэдэн дюймийн зайд байхыг харав.

- Чи зүгээр үү, Харри?

- Зүгээр гэж Харри толгойгоо шууд өргөж чадсангүй.

- Тиймээ, би ... Волдеморт хаана байна ... хэн энд байгаа юм ... тэд ...

Үүдний танхимд дүүрэн хүн цуглав. Шалан дээр маргад ногоон дөлний тусгал дүрсхийн ханан зуухнаас шилтэнгүүд төгсгөлгүй гарч ирж байлаа. Дамблдор түүнийг хөл дээр нь босгоход Харри жижигхэн үйлчлэгч, албингийн хөшөө мэгдсэн ид шидийн яамны сайдыг дагуулан ирж байхыг харав.

- Тэр энд байсан! гэж гал улаан жанчтай урт үстэй шидтэн хашгирлаа. Тэр танхимын нөгөө зүгт хормын өмнө Беллатриса хөшөөнд даруулан хэвтэж байсан газар луу заалаа.

- Би түүнийг харсан, ноён Фаж. Хэцүү нэрт байсан гэж тангараглая. Тэр эмэгтэйг аваад шилжсэн!

- Мэднэ, Уильямсон мэднэ би бас түүнийг харсан! гэж судалтай жанч өмссөн Фаж хэлэв. Тэр саяхан хэдэн миль гүйсэн мэт амьсгаадаж байв.

- Мерлиний сахал минь ... энд ... энд! Ид шидийн яаманд! Яаж тэр вэ ... энэ чинь итгэж боломгүй хэрэг ... үнэнийг хэлэхэд ... байж боломгүй юм!

- Хэрвээ та нууцын хэлтэс рүү очвол, Корнелиус гээд Дамблдор алхам урагшилахад шинэ ирэгсэд анх удаагаа түүнд анхаарал хандуулав. (зарим нь саваагаа өргөж, зарим нь гайхширан харж, үйлчлэгч албингийн хөшөө хоёр алга ташихад Фаж цочсондоо унах шахлаа) Үхлийн өрөөнд хэдэн Үхэл залгигч Шилжихийн эсрэг шидээр хүлээтэй цаашдын хувь заяагаа танаар шийдүүлэхээр хүлээж байгааг мэдэх болно.

- Дамблдор! Та ... энд ... би ... би гэж Фаж гайхан дуу алдав.

Тэр мракоборецууд руу одоохон «Түүнийг барь!» гэж хашгирах гэж буй мэт харлаа.

- Би танай хүмүүстэй тэмцэхэд бэлэн байна, Корнелиус. Тэгээд ахин тэднийг ялах болно! Гэхдээ хэдэн хормын өмнө та өөрийн нүдээр бүтэн жилийн турш би

үнэнийг хэлсэн гэдгийн баталгааг харлаа шүү дээ. Лорд Вола-де-Морт эргэж төрөөд байхад та олон сарын турш буруу хүнээ хөөж явснаа эцэст нь ойлголоо!

- Би ... үгүй ... гэж Фаж ээрээд дэргэдэх хүмүүс рүүгээ цаашид яахыг хэлнэ гэж найдсан мэт харав. Гэвч бүгд чимээгүй байсан тул үргэлжлүүлэн,

- За сайн байна ... Долиш! Уильямсон! Нууцын хэлтэс рүү очоод шалга ... харин Дамблдор та надад бүх зүйлийг тодорхой тайлбарлах ёстой ... шидтэн ах дүүсийн усан сан ... тиймээ энд юу болоо вэ? гэж өнгөгүй хоолойгоор хэлээд хөшөөнөөс үлдсэн алтлаг хэсгүүдийг харлаа.

- Бид энэ тухай Харриг Хогвартс руу буцаж явуулсаны дараа ярилцъя гэж Дамблдор хэлэв.

- Харри ... Харри Поттер гэнээ?

Фаж агшин зуур эргээд Дамблдор, Волдеморт хоёрын тэмцлийн үеэр түүнийг хамгаалж байсан хөшөөний дэргэд зогсож байгаа Харри руу харлаа.

- Тэр ... энд байгаа юм уу? Гэхдээ яагаад ... энэ чинь юу гэсэн үг юм? гээд Фаж нүд бүлтийн ширтэв.

- Би Харриг сургууль руу нь хүргэсний дараа бүгдийг тайлбарлая гэж Дамблдор тэвчээртэй давтав.

Тэр шалан дээр хэвтэж байсан алтан шидтэний толгой руу очоод саваагаа чиглүүлэн аяархан «Портус!» гэж шивнэлээ. Толгойд цэнхэр дөл сүүмэлзэн шал чимээтэй цохин чичирснээ хэдэн агшины дараа чимээгүй болж хөдөлгөөнгүй боллоо.

- Хөөе хөөе, Дамблдор! гэж Фаж Дамблдорыг толгойг аван Харри явахад хашираад,

- Таньд зөөвөрлөгч ашиглах албан ёсны зөвшөөрөл байхгүй шүү! Та ийм зүйлээ яамны сайдын нүдэн дээр хийж болохгүй ... та ... та ... гэв.

Дамблдор түүн рүү бараан шилнийхээ дээгүүр захирангуй харахад хоолой нь сулран чимээгүй боллоо.

- Та Долорес Амбрижыг Хогвартсаас холдуулах тушаал өг. Бас мракоборецууддаа миний шидэт амьтны хичээлийн багшийг ажилдаа эргэж ороход нь мөрдөхөө боль гэж хэл. Өнөө орой би таньд ... гээд халааснаасаа арван хоёр зүүтэй цаг авч анхааралтай харснаа,

- Хагас цаг л өгье. Энэ нь болсон үйл явдлын тухай тайлбарлахад хангалттай байх. Би үүний дараа сургууль руу буцах ёстой. Хэрвээ таньд цаашид миний тусламж шаардагдвал Хогвартс руу холбоо бариарай. Надад тийшээ захирлын нэрээр илгээхэд болно гэлээ.

Фаж нүдээ улам хүчтэй бүлтийлгэхэд ам нь ангайж, өрвийсөн буурал үсэн доорх дугуй нүүр нь ягаарлаа.

- Би ... та ...

Дамблдор түүн рүү нуруугаа харуулан эргэлээ.

- Харри зөөвөрлөгчөөс барь.

Тэр алтан хөшөөний толгой сунгахад Харри гараа хүргэлээ. Түүнд юу болох цаашид хаачих нь хамаагүй байлаа.

- Хагас цагийн дараа уулзацгаая гэж Дамблдор аяархан хэлээд,

- Нэг ... хоёр ... гурав! гэлээ.

Харри ахин хүйснээсээ дэгээгээр татуулах танил мэдрэмжийг мэдрэв. Толигор шал хөлийн дороос хөндийрөхөд үүдний танхим, Фаж, Дамблдор нар алга болоод хуй түүнийг хаа нэг тийш эргэлдүүлэн нисгэлээ.

БҮЛЭГ 37: АЛДАГДСАН ЗӨГНӨЛ

Харрийн хөл хатуу юм цохиход өвдөг нь нугарч, алтан шидтэнгийн толгой шалан дээр чимээ гарган уналаа. Тэр эргэн тойрноо хараад зөөвөрлөгч Дамблдорын өрөөнд авчирсныг мэдрэв.

Захирлыг эзгүйд өрөөний бүх зүйл хэвийн байдалд орсон харагдана. Урт хөлтэй ширээн дээрх гоёмсог мөнгөн эдлэлүүд жингэнэн уугьж, өмнөх захирлын хөргүүд жаазандаа зүүрмэглэн толгойгоо сандлын түшлэг дээр тавин унтах агаад нэг нь зурагны хүрээ дэрлэн унтаж байлаа. Харри цонх руу харав. Тэнгэрийн хаяанд бүдэг ногоон судал татсанаас үзэхэд үүр цайх ойртож байгаа бололтой.

Нам гүмийг хаа нэг унтаж буй хөрөгний хурхирч шуухитнах чимээ эвдэх нь түүний хувьд тэсч боломгүй байлаа. Хэрвээ эргэн тойрны зүйлс түүний дотоод сэтгэлийг тусгадагсан бол бүх зургууд өвдсөндөө хашгирах байсан биз. Тэр хүндээр амьсгаадангаа юу ч бодохгүйг хичээн өрөөнд чимээгүй холхилоо. Гэвч бодол толгойд нь урсан орж ирэхэд ... түүнээс аврагдах замгүй байлаа ...

Энэ бол Сириусын үхэлд буруутай явдал байсан бөгөөд түүний үхэлд зөвхөн Харри л буруутай байлаа. Хэрвээ тийм тэнэг байж Волдемортын мэхэнд автаагүй бол, хэрвээ зүүд нь үнэн гэдэгт итгэлтэй байгаагүй бол, хэрвээ Гермионагийн Волдепорт түүний баатар болох дуртай талыг ашиглан тоглож байна гэсэн үгийг сонссон бол ...

Энэ нь тэвчиж боломгүй байлаа. Тэр энэ тухай бодож, энэ зовлон шаналалыг тэвчиж чадахгүй нь ... дотоод сэтгэлд нь аймшигтай ангал үүсэхэд урьд нь Сириусын байсан хар нүх рүү харахыг хүссэнгүй. Харри энэ аймшигтай чимээгүй хоосонд ганцаар үлдэхийг хүсэхгүй байна, тэр үүнийг тэвчиж чадахгүй ...

Гэнэтхэн ард талын хөргөөс чанга хүйтэн хоолой,

- Аан ... Харри Поттер ... гэлээ.

Финеас Найжелус амттай эвшээлгээд Харри руу сониучирхсан харцаар харав.

- Чамайг юу ийм эрт ийш нь авчраа вэ? Дүрмийн дагуу бол энэ өрөө хууль ёсны захирлаас өөр бүх хүмүүст хориотой. Эсвэл Дамблдор чамайг ийш нь авчраа юу? Хүлээгээрэй битгий хэл гээд ахин эвшээлээ.

- Эсвэл миний зохимжгүй зээгийн ээлжит илгээмж үү?

Харри чимээгүй байлаа. Финеас Найжелус Сириусыг үхсэн гэж мэдээгүй болохоор

Харри юу ч хэлж чадсангүй. Энэ тухай чанга хэлэх нь туйлын засаж залруулашгүй зүйл байв.

Өөр хэдэн хөрөг хөдлөв. Байцаагдах айдас төрөхөд Харри хаалга руу явж бариулаас татлаа.

Тэр хөдөлсөнгүй. Хаалга түгжээтэй байв.

- Үүнийг Дамблдор бидний дунд удахгүй ирнэ гэж найдаж болох уу? гэж захирлын ширээний ард өлгөөтэй байсан махлаг бие, улаан хамартай шидтэний хөрөг хэлэв.

Харри эргэж харлаа. Шидтэн түүнийг сонирхон харна. Харри толгой дохиод ахин бариулыг татсан ч хөдөлсөнгүй.

- Сайхан хэрэг. Түүнийг үгүйд их уйтгартай байлаа ... маш уйтгартай. Тэр сандалдаа хаан адил тухлан суугаад Харри руу инээмсэглэв.

- Дамблдор таныг өндрөөр үнэлдэгийг мэдэх үү. Тиймээ тийм. Таныг залуу хүний чинь хувьд маш их хүндэлдэг юм.

Харрийн цээжинд гэмшил төрөн ямар нэг төрлийн шимэгч мангас мэт зангирав. Харри үүнийг тэвчиж чадахгүй болохоор өөртэйгээ үлдэж чадахгүй ... тэр хэзээ ч дотоод сэтгэлээ ийм хаалттай байснаа мэдэрч байсангүй ...

Хоосон ханан зууханд маргад ногоон дөл дүрсхийхэд Харри хаалганаас холдоод галаас гарч ирж буй хүний дүрс рүү ширтлээ. Дамблдор ханан зуухнаас гарч ирэхэд зүүрмэглэж байсан шидтэнгүүд сэрж мэндчилэн дуу алдав.

- Баярлалаа гэж Дамблдор аяархан хэлэв.

Тэр Харри руу харалгүй хаалга руу яваад жанчныхаа халааснаас жижигхэн өдгүй Фоуксын биеийг гаргаж галт шувуу ердийнхөөрөө сууж байдаг тавиур дээр хянамгай тавилаа.

- За, Харри чи шөнийн үйл явдалд хүнд гэмтэл авсан нөхөд чинь удахгүй эдгэрнэ гэдгийг сонсоод баярлах байх гэж тэр эцэст нь шувууны биенээс эргээд хэллээ.

Харри «сайн байна» гэж хэлэх гэсэн ч ямар ч чимээ гарсангүй. Түүнд хэдийгээр Дамблдор удаан хугацааны эцэст анх удаагаа урдаас нь ширтэх шиг санагдсан ч гэлээ царай нь зэмлэнгүй байсанд нүд рүү нь харж чадсангүй.

- Хатагтай Помфри шархдагсдыг хөл дээр нь түргэн босгоно. Магадгүй Нимфадора Тонкс гэгээн Мунгогийн эмнэлэгт хэсэг хугацааг өнгөрүүлэх байх. Гэхдээ тэр энэ бүхний дараа эрүүл саруул болно.

Харри дэмжин хивс рүү толгой дохиход цонхны гадаа тэнгэр улам гийлээ. Тэр хөргүүд Дамблдорын үг бүрийг анхааралтай сонсож Харрийн хаана шарх авсныг тааж байгаа байх гэж бодлоо.

- Би чиний юу мэдэрч байгааг ойлгож байна гэж Дамблдор аядуухан хэлэв.
- Үгүй, ойлгохгүй гэж Харри гэнэтхэн чангаар хэлэв. Түүнийг уур хилэн нөмрөн авлаа. Дамблдор хэзээ ч түүний мэдрэмжийн талаар ойлгохгүй!
- Харж байна уу, Дамблдор? гэж Финеас Найжелус шоолонгуй хэлэв.
- Сурагчийг хэзээ ч битгий ойлгохыг хичээж бай. Тэд үүнийг тэвчиж чаддаггүй юм. Тэд өөрсдийгөө золгүй ойлгомжгүй болгохыг эрхэмлэж өрөвдөлтэй байдалд ...
- Хангалттай, Финеас гэж Дамблдор яриаг нь таслав.

Харри Дамблдор руу нуруугаа харуулан эргээд цонхоор ширтлээ. Алсад сургуулийн цэнгэлдэх хүрээлэн цайвалзана. Сириус нэг удаа тэнд сэгсгэр хар нохойны дүртэй Харрийн тоглохыг харахаар ирж билээ ... магадгүй тэр Харриг Жеймсээс сайн эсэхийг харахыг хүссэн байх ... Харри энэ тухай түүнээс асууж байсангүй ...

- Өөрийнхөө мэдрэмжээс ичих хэрэггүй. Эсрэгээрээ ... чи ийм зовлонг мэдэрч байна гэдэг чинь аугаа хүчтэй гэсэн үг хэмээх Дамблдорын хоолой сонсогдов.

Харри уур хилэн дотроос нь дүрсхийж аймшигт хоосныг төөнөхийг мэдрээд Дамблдор энэ хэрэггүй хоосон үгийнх нь төлөө үзүүлээд өгөх хүсэл төрөв.

- Миний аугаа хүч гэнээ? хэмээн Харрийн хоолой чичирсэн ч цэнгэлдэх хүрээлэнгээс нүд салгасангүй. Тиймээ та ... та хаанаас мэдэх юм ...
- Би юу мэдэхгүй гэж? хэмээн Дамблдор асуулаа.

Энэ арай дэндлээ. Харри эргэж харахдаа уур хилэндээ чичирч байв.

- Алив миний юу мэдэрч байгаа тухай ярилцахаа больё, тохиролцов уу?
 - Харри, чиний зовлон шаналал хүн хэвээр үлдсэн гэдгийг чинь баталж байна!
- Өвдөлт бол хүний нэг хэсэг юм ...

- Тэгвэл ... би ... хүн ... байхыг ... хүсэхгүй ... байна! гэж Харри дэлбэрээд

ойролцоох урт хөлтэй ширээн дээр байсан мөнгөн эдлэлийг шүүрэн авч өрөөн дундуур шидэхэд хана мөргөөд үйрмэг болон бутрав. Хэд хэдэн хөргүүд айж уурласандаа хаширсан хэдий ч Армандо Диппет дэмжингүй «Ийм байж!» гэлээ.

- Надад хамаагүй! гэж Харри хашгираад сарны дуранг авч зуух руу чулуулав.

Дараагийн удаа түүний гарт мөнгөн эдлэлтэй ширээ хөмөрлөө. Тэр шалан дээр тар нярхийн унаад урт хөлөө зүг бүр сарвайлгав.

- Хамаагүй биш гэж Дамблдор хэлэв. Тэр Харриг өрөөг нь сүйтгэхийг болиулах өчүүхэн төдий ч оролдлого хийсэнгүй. Түүний царай туйлын тайван байлаа.

- Тиймээ одоо чамд бүх зүйл хамаагүй ... огтхон ч хамаагүй болохоор чи зовж шаналахаа болихын тулд үхэхэд ч бэлэн байгаа ...

- Худал! гэж Харри чанга орилсон учир хоолой нь цахиртлаа. Дараагийн агшинд тэр Дамблдор руу ухасхийх гэсэн хүсэлтэйгээ тэмцэлдлээ. Энэ тайван царайг харахгүйн тулд хэмх цохиж, өвдтөл сэгсрэн дотроо байгаа айдсын өчүүхэн хэсгийг мэдрүүлэх юмсан ...

- Үгүй, худал гэж Дамблдор улам тайван хэлэв.

- Чи эцэг эхийгээ алдсан харин одоо бараг төрсөн хүү нь байсан хүнээ алдлаа.

Мэдээж чамд бүх зүйл хамаагүй.

- Та хаанаас миний юу мэдэрч байгааг мэдэх юм! Та ... тэнд зогсоод ... та ... гэж Харри хашгирав.

Гэвч үг хэлэх хүч хүрсэнгүй тул бүх өрөөг орвонгоор нь эргүүлсэн ч санаа нь амрахааргүй байлаа. Тэр эндээс зугтахыг хүслээ. Зугтаж зугтаж эргэж харалгүй хаа нэгтээ нуугдаад энэ тод цэнхэр нүд, энэхүү үзэн ядмаар буурал үстэй тайван царайг л харахгүй байвал болно. Тэр хаалга руу эргэж бариулаас нь хүчтэй угзарлаа.

Гэвч хаалга онгойхыг хүссэнгүй. Харри ахин Дамблдор руу эргээд,

- Намайг гарга гэж хэлэхэд бүх бие нь чичирч байлаа.

- Үгүй гэж Дамблдор хэлэв.

Хэдэн хормын турш тэд бие биеэ чимээгүй харлаа.

- Намайг гарга гэж Харри ахин хэлэв.

- Үгүй.

- Хэрвээ та намайг энд барих юм бол ... хэрвээ гаргахгүй юм бол ...
- Би чамайг цаашид миний зүйлүүдийг эвдлэхийг эсэргүүцээгүй. Надад тэд хэтэрхий олон байгаа.

Тэр ширээндээ очиж суугаад Харригаас нүд салгалгүй ширтэв.

- Намайг гарга гэж Харри хүйтнээр хэлэхэд хоолой нь бараг Дамблдорын адил тайван боллоо.

- Намайг сонсохоос нааш гаргахгүй.

- Таныхаар бол ... би хүсэж ... таныхаар бол надад энд ... Тиймээ, надад таны юу хэлэх хамаагүй! Би юу ч сонсохыг хүсэхгүй байна! гэж Харри орилов.

- Хэрэгтэй гэж Дамблдор хатуу хэлэв.

- Яагаад гэвэл чи надад уурлах ёстойгоороо уурлахгүй байгаа. Чамайг над руу дайрах гэснийг ойртож ирэхэд чинь мэдсэн. Би үүнийг хүртэх гавъяатай.

- Та юуны тухай яриад байна? ...

- Сириусын үхэлд би буруутай. Үнэнийг хэлэхэд би ихэмсэг зан гаргаж бүх хариуцлагыг өөрийн биедээ хүлээсэн. Сириус зоригтой ухаалаг эрч хүчтэй хүн байсан. Тийм хүмүүс бусад нь аюулд учирч байхад гэртээ дулаан газарт суухыг ховорхон зөвшөөрдөг юм. Хэрвээ би хариуцлагаасаа хуваалцахыг хүссэн бол чамд өчигдөр нууцын хэлтэс рүү явах ямар ч хэрэггүй байсан. Хэрвээ би чамтай нээлттэй байсан бол, Харри. Харамсалтай нь надад зориг дутсан. Чи эртнээс Волдеморт нууцын хэлтэст занганд оруулахыг оролдож байгаа гэдгийг мэдсэн бол өчигдөр урхинд нь орохгүй байлаа. Тэгвэл Сириус чиний араас явахгүй байсан. Энэ бол миний буруу зөвхөн минийх.

Харрийн гар бариулаас барьсан хэвээр зогсоод үүнийгээ мартсан байв. Тэр Дамблдор руу нүд салгалгүй ширтэн амьсгаа даран сонсохдоо муухан ойлгож байлаа.

- Суу, гуйж байна гэж Дамблдор хэлэв. Энэ бол тушаал биш гуйлт байлаа.

Харри тээнгэлзсэнээ өрөөн дундуур удаанаар явж хэмхэрсэн мөнгөн эдлэлийн хэлтэрхий дундуур өнгөрөөд Дамблдорын ширээний урдаас харан суулаа.

- Үүнийг юу гэж ойлгох вэ. Миний зээ сүүлчийн Блэк үхсэн хэрэг үү? гэж Финеас Найжелус асуулаа.

- Тиймээ, Финеас гэж Дамблдор хэлэв.
- Би үүнд итгэхгүй байна гэж тэр ширүүн хэллээ.

Харри толгойгоо эргүүлээд Финеас хөргөөсөө алга болохыг харж Гриммогийн байшин руу явсан байх гэж төсөөлөв. Магадгүй тэр хөргөөс хөрөг дамжин Сириусыг бүх байшингаар эрэх байх ...

- Би чамд тайлбарлах ёстой байсан, Харри. Миний алдаа ... хөгшин хүний алдаа. Би одоо чамд хамааралтай ямар ч зүйл хийгээгүй харж байна. Залуу хүмүүс хөгшин хүн юу мэдэрч байгааг ойлгодоггүй юм. Гэхдээ хөгшин хүн залуу байсан гэдгээ мартвал буруутай байдаг юм ... харин би сүүлийн үед үүнийг мартсан бололтой ...

Нар мандахад гялалзсан алтан цацраг уулын оройг гийгүүлж тэнгэр өнгөгүй цайвалзана. Нарны туяа Дамблдорын мөнгөн хөмсөг, сахал, гүнзгий үрчлээ бүхий царайг гийгүүлэв.

- Арван таван жилийн өмнө би анх чиний духан дээрх сорвийг хараад юу болохыг тааварласан юм. Би энэ сорвийг Волдеморт та хоёрын дунд гүнзгий холбоо тогтсоны тэмдэг гэж хүлээн авсан билээ.

- Та надад энэ тухай ярьсан, профессор гэж Харри яриаг нь таслав. Тэр бүдүүлэг байгаагаа ойлгож байсан ч бүх зүйл хамаагүй байлаа. Энэ нь одоо түүнийг бага зовоож байв.

- Тиймээ гэж Дамблдор гэмшингүй зөвшөөрөөд,

- Гэхдээ ... би эхлээд сорвины чинь тухай ярих шаардлагатай юм. Ингээд чи шидэт ертөнцөд богино хугацааны дараа эргэн ирсний дараа сорви Волдемортыг ойртох юмуу хүчтэй сэтгэл хөдлөл эзэмдэн авахыг анхааруулдаг гэсэн миний зөв байсан гэдэг нь тодорхой болсон гэв.

- Мэднэ гэж Харри ядрангуй хэлэв.

- Энэ бол чиний Волдемортын ойртох юмуу зүсээ хувиргахыг илрүүлэх болон түүнийг биедээ эргэн орохын тулд яаж хүчээ цуглуулж байгааг мэдрэх авьяас байсан.

Харри тэр ч байтугай толгой дохисонгүй. Тэр энэ бүхнийг мэдэх билээ ...

- Тэр үеэс би Волдеморт та хоёрын дундын холбоог мэдэхээс айж эхэлсэн

билээ. Тэгтэл ч үнэхээр цаг нь ирж түүний ухаанд гүн нэвтрэх үед чинь чиний байгааг мэдэрсэн. Би чиний ноён Уизлиг дайрсны гэрч болсон шөнийн тухай ярьж байна.

- Тиймээ, Снегг надад хэлсэн гэж Харри бувтнав.
- Профессор Снегг гээч, Харри гэж Дамблдор тайвнаар залруулаад,
- Гэхдээ чи яагаад үүнийг би тайлбарлаж өгөөгүйн учрыг асуугаагүй. Яагаад би чамайг окклюменцийд сургаагүй юм бэ? Яагаад би олон сарын турш чиний харцнаас зугтсан бэ? гэв.

Харри харцаа өргөв. Дамблдор түүн рүү гашуудалтай ядрангуй харж байлаа.

- Тиймээ. Тийм энэ намайг гайхшируулсан гэж Харри аяархан хэлэв.
- Харж байна уу ... би Волдеморт чиний ухаанд хүчээр нэвтэрч бодлыг чинь залахаас айсан юм. Би түүнд ийм боломж өгөхийг хүсээгүй. Хэвээ тэр бидний холбоог ойлговол, багш сурагч хоёрын ердийн харьцааг ойлговол чамайг заавал ашиглан тагнуулахыг хүснэ гэдэгт итгэлтэй байсан юм. Би түүний чамайг эзэмдэн захирахаас айж байсан. Волдеморт тийм аргаар чамайг ашиглахыг оролдоно гэдэг нь зөв байсан гэж бодож байна. Тэгэхэд ховорхон тохиолдлоор бидний хооронд харааны холбоос үүсэх үед би чиний нүдний гүнд сүүдэр байхыг харсан билээ ...

Харри тэдний харц тулгарах үед дотор нь нуугдаж байсан могой толгойгоо өндийлгөн дайрахад бэлэн болсон мэдрэмжийг саналаа.

- Өчигдөр шөнө Волдеморт намайг алахын тулд биш чамайг алахын тулд эзэмдсэн гэдгээ баталж үзүүллээ. Тэр чиний ухаанд богино хугацаагаар нэвтрэн чамайг алах байх гэж найдаж байсан. Харж байна уу бидний хоорондын зайгаар би чамайг хамгаалахыг оролдож байсныг, Харри. Хөгшин хүний алдаа ...

Тэр гүнзгий санаа алдлаа. Харри түүний үгийг хэдэн сарын өмнө сонссон бол ихэд сонирхох байсан ч одоо Сириусыг алдсан хоосонтой харьцуулвал энэ нь ямар ч бодол төрүүлсэнгүй.

- Сириус чиний Артур Уизли гэмтсэн шөнө юу мэдэрснийг хэлсэн. Би тэгэхэд хамгийн муу айдас минь батлагджээ гэдгийг ойлгосон юм. Волдеморт чамайг ашиглаж болно гэдгийг ойлгосон байна. Би чиний оюун ухааныг Волдемортоос хамгаалахын тулд профессор Снеггээр окклюменцийн хичээл заалгасан билээ.

Тэр чимээгүй боллоо. Харри толигор ширээний гадаргуун дээр нарны гэрэл удаанаар тусахад мөнгөлөг бэхийн сав, улаан үзэг туяарахыг нүд салгалгүй харлаа ... Тэр хөргүүд унталгүй Дамблдорыг анхааралтай сонсож байгаа гэдгийг мэдэж байв. Учир нь жанч шар шурхийх юмуу аяархан хоолой засан ханиалгах дуу сонсогдох аж. Финеас Найжелус байрандаа байсангүй ...

- Профессор Снегт чамайг нэг бус сарын турш нууцын хэлтсийн хаалгыг зүүдэлж байгааг илрүүлсэн. Мэдээж тэр өөртэй хамааралтай зөгнөлийн талаар сонсохыг биедээ орсон цагаас хойш өдөр шөнөгүй бодож байсан. Тэр энэ

хаалгыг төсөөлөнгүүт хэдийгээр чи юу болж байгааг ойлгоогүй ч гэлээ зүүдэнд чинь орсон юм.

- Харин дараа нь чи баригдахаасаа өмнө нууцын хэлтэст ажиллаж байсан Руквудыг Волдемортод зөгнөл ид шидийн яаманд найдвартай хамгаалалтанд байгаа гэж хэлэхийг харсан. Түүнийг тавиураас зөвхөн нэр дурьдагдсан хүн л зовж шаналахгүй авч чадах байсан. Тийм аргаар Волдеморт өөрийн биеэр ид шидийн яаманд очих ёстой байсан ч эрсдэлд орохгүйн тулд чамаар зөгнөлийг авахуулахаар хүссэн юм. Ийм учраас чамайг окклюменцийн тусламжтай хамгаалах чухал шаардлагатай байлаа.

- Гэхдээ би юу ч сураагүй гэж Харри бувтналаа. Тэр чанга хэлэхийг оролдсон ч дотор нь байгаа гэмшилд дарагдан амаргүй байв.

- Би сургуулилаагүй надад хамаагүй байсан. Гермiona цаг үргэлж энэ ямар чухал болохыг баталж байсан ч би зүүдлэхээ зогсоогүй. Хэрвээ би түүнийг сонссон бол хэзээ ч хаашаа явах ёстойгоо харахгүй байсан тэгвэл Сириус ... тэгвэл Сириус ... Харрийн ухаанд ямар нэг зүйл зурсхийхэд цагаатгах тайлбар олохыг хүслээ ...

- Би Сириусын жинхэнээсээ баригдсан эсэхийг шалгахын тулд Амбрижын өрөөнд орж ханан зууханд Кикимертэй ярихад Сириусыг гэртээ байхгүй гэж хэлсэн!

- Кикимер худал хэлсэн юм. Чи түүний эзэн биш болохоор худал хэлснийхээ төлөө өөрийгөө шийтгэх хэрэг байхгүй. Кикимер чамайг ид шидийн яам руу явуулахыг хүссэн юм гэж Дамблдор тайван хэлэв.

- Тэгэхээр тэр... тэр намайг тийш нь илгээсэн юм уу?

- Тиймээ. Кикимерийг олон сарын өмнөөс зөвхөн өөрийнхөө хууль ёсны эзэнд зүтгэж байгаагүй гэж айж байна.

- Яаж тэр вэ? Тэр нэг ч удаа Гриммогийн байшингаас гарч байгаагүй! гэж Харри бодлогоширон асуулаа.
- Кикимер зул сарын баярын өмнөх боломжоо ашигласан юм. Сириус түүнийг зайл гэж хашгирсаныг санаж байна уу? Тэр Сириусын үгийг хүлээж аваад гэрээ орхих тушаал гэж ойлгосон байна. Тэгээд Блэкийн гэр бүлийн цорын ганц гишүүн болох түүний хүндэтгэлтэй ханддаг ... Блэкийн үеэл, Беллатрисагийн дүү, Люциусын Малфойн эхнэр Нарцисса руу очжээ ...
- Та хаанаас энэ бүхнийг мэдээ вэ? гэж Харри асуухад зүрх нь хурдтай цохилж толгой нь эргэв. Тэр Кикимер зул сарын баяраар хачирхалтай эзгүй байснаа дээврийн хөндийгөөс олдсоныг санав ...
- Кикимер энэ тухай надад өнгөрсөн шөнө ярьсан. Чиний нууцлаг анхааруулгыг сонсоод профессор Снегг Сириусыг нууцын хэлтэст олзлогдсон байхыг харсан гэж тааварлажээ. Мэдээж чи даруйхан Сириустай холбоо тогтоохын тулд Фениксийн бүлгийн гишүүдийн найдвартай мэдээллийн арга болох Долорес Амбрижын өрөөний ханан зуухыг ашиглах нь ойлгомжтой. Үүний дараа профессор Снегг Сириусыг бүрэн бүтэн Гриммогийн байшинд байгааг мэджээ.
- Гэвч энэ үед чи Амбрижтай Хориотой ой руу яваад эргэж ирээгүй байлаа. Профессор Снегг түгшиж эхэлсэн байна. Түүнд чи урьдын адил Сириусыг Волдемортод олзлогдсон хэвээр гэж бодож байгаа нь тодорхой байсан учир энэ тухай бүлгийн гишүүдэд түгшүүр зарлан мэдэгдсэн юм гээд Дамблдор хүндээр санаа алдав.
- Тэр холбоо тогтоосны дүнд штабын байранд Аластор Грюм, Нимфадора Тонкс, Кингсли Бруствер болон Римус Люпин нар ирсэн. Бүгд тэр даруй чамд туслахыг зөвшөөрсөн. Профессор Снегг Сириусыг штабын байранд миний ирэхийг хүлээн үлдээхийг хүссэн байна. Хэн нэгэн надад болсон явдлын тухай мэдэгдэх ёстой байлаа. Ингээд профессор Снегг чамайг Хориотой ойд хайхаар явжээ.
- Гэсэн ч Сириус ард үлдэн бусдыгаа чамайг хайлгахаар явуулж чадсангүй. Тэр Кикимерт болсон явдлын тухай хэлэхийг тушаагаад өөрөө бүлгийн бусад гишүүдийн араас байшинг орхисон байна. Энэ бүхний дараа намайг Гриммогийн байшинд ирэхэд үйлчлэгч инээн байж Сириусын хаашаа явсныг хэлсэн.

- Тэр инээсэн хэрэг үү? гэж Харри гайхан асуулаа.
- Тиймээ, инээсэн. Чи Кикимер бидний бүх нууцыг задалж чадахгүй гэдгийг мэднэ. Тэр бүлгийн нууц хадгалагчын тоонд ордоггүй болохоор Малфойд манай штабын байрны тодорхой хаяг болон төлөвлөгөөний талаар мэдээлэл өгч чадахгүй. Түүнд энэ бүхнийг илчлэх хориотой. Бусад үйлчлэгчийн адил тэр эзнийхээ шууд тушаалыг зөрчиж болохгүй шидийн холбоотой. Гэсэн ч тэр Нарциссад Волдемортод маш үнэтэй мэдээллийг өгчээ. Сириус энэ бүхнийг илэрхий гэж бодсон учир хориглоогүй байна.

- Та юуны тухай ярайд байна? гэж Харри асуулаа.

- Жишээлбэл Сириуст энэ дэлхий дээр чамаас үнэтэй зүйл байгаагүй. Бас Сириус чамайг эцгийн болон ахын ёсоор зэрэг хайрладаг байсан. Мэдээж Волдемортод Сириус бүлгийн тоонд ордог болон чи түүний хаана байгааг мэддэг гэдэг нь тодорхой байсан учир Кикимерийн мэдээллийг аваад чамайг Сириус Блэкийг аврахын төлөө ямар ч эрсдэл хүнд нөхцөлийг туулахад бэлэн гэдгийг чинь ойлгожээ.

Харрийн уруул хүйтэрч мэдээ алдлаа.

- Тэгэхээр ... би өчигдөр Кикимерээс Сириус гэртээ байгаа юу гэдгийг асуух үед ...

- Малфой эргэлзээгүй түүнд Волдемортын зааврыг дамжуулан Сириусын гэртээ байгааг нуу гэж хэлсэн байна. Хэрвээ чи гэрт Сириус байгаа эсэхийг шалгахад шийдвэл Кикимер эзэн байхгүй гэж хэлэх ёстой байсан. Өчигдөр чамайг ханан зууханд ирэх үед Кикимер Ключокрылг гэмтээсэн учир Сириус гиппогрифээ дээр эмчилж байжээ.

Харрид агаар хүрэлцэхгүй болсон тул түргэн амьсгаадав.

- Кикимер таньд энэ тухай ... инээж байгаад ярьсан хэрэг үү?

- Тэр надад хэлэхийг хүсээгүй. Гэхдээ би легилменцийг муугүй эзэмшсэн болохоор худал хэлэхийг мэддэг юм ... тиймээс би түүнийг ятган ... бүх түүхийг хэлүүлээд дараа нь нууцын хэлтэс рүү яаран явсан.

- Харин ... харин Гермиона биднийг түүнтэй эелдэг харьцах ёстой гэж хэлсэн гээд Харри нударга зангидсан гар нь хүйт даахыг мэдэрлээ.

- Түүний бүрэн зөв байсан, Харри. Бид Гриммогийн арван хоёрдугаар байшинд штабын байраа байгуулах үед би Сириуст Кикимертэй зөөлөн хүндэтгэлтэй харьцах ёстой гэдгийг анхааруулсан. Би түүнд Кикимер бидэнд аюултай байж магадгүй гэж хэлсэн. Гэвч Сириус үүнийг ноцтой тусгаж аваагүй гэж бодож байна эсвэл тэр хэзээ ч Кикимерыг амьд амьтан гэж тооцож байгаагүй болохоор хүний ...

- Түүнийг битгий буруутга ... Сириусын тухай ... тэгж битгий ярь гээд Харри амьсгал нь давчдахад ярьж чадахгүй болж уур хилэн нь ахин дүрэлзлээ. Дамблдор Сириусыг шүүмжлэх эрх байхгүй!

- Кикимер худалч ... өөдгүй хууран мэхлэгч ... тэр хүртэх гавьяатай.

- Кикимер шидтэний хийх зүйлийг хийсэн, Харри. Тэр бол өрөвдөлтэй амьтан.

Түүний байдал чиний найз Доббигоос ч золгүй. Кикимер Блэкийн сүүлчийн удамд үйлчилж байхдаа Сириуст үнэнээсээ зүтгэж байгаагүй. Кикимерын хичнээн их буруу байлаа ч гэсэн Сириус түүний байдлыг хөнгөлөхийн тулд хуруугаа ч хөдөлгөөгүй ...

- Сириусын тухай ингэж битгий ярь! гэж Харри ууртай хашгирав.

Тэр ахин хөл дээрээ үсрэн босоод уур хилэнд автсандаа Сириусыг ойлгохгүй, хичнээн зоригтой, хичнээн их зовсныг мэдэхгүй байгаа Дамблдор руу дайрахад бэлэн байлаа.

- Снеггийг яах болж байна? Яагаад түүний тухай ярихгүй байгаа юм? Би түүнд Волдеморт Сириусыг барьсан гэж хэлэхэд зөвхөн ердийнх шигээ шоолон инээмсэглээд ...

- Чи мэднэ Харри. Профессор Снегг Долорес Амбрижын өмнө чиний үгийг ноцтой хүлээн авч болохгүй байсан. Тэгээд ч би чамд түүний бүх боломжоо ашиглан бүлгийн гишүүдийг яаралтай цуглуулсан болохыг тайлбарласан. Тэр л чамайг Хориотой ойгоос эргэж ирээгүй үед дүгнэлт хийж хаана хайх ёстойг тааварласан юм. Зөвхөн тэр л профессор Амбриж чамайг Сириусын байгаа газрын тухай байцаахад хуурамч Үнэнийг хэлүүлэгч шингэн өгсөн.

Харри энэ баримтыг чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв. Тэр Снеггийг хичнээн хэрцгий буруутгаж байснаа мэдэртэл дотор нь гэмших сэтгэл төрж Дамблдор түүний үгийг зөвшөөрөхийг хүслээ.

- Снегг ... Снегг ... Сириусыг гэртээ үлдсэний төлөө ... аймхай гэж хэлсэн.

- Сириус түүнийг үгийг тоохгүй байх хангалттай ухаантай насанд хүрсэн хүн.
- Снегг надад окклюменцийн хичээл заахаа больсон! Тэр намайг өрөөнөөсөө хөөж гаргасан!
- Би үүнийг мэднэ. Ахин нэг удаа хэлье. Би чамайг өөрөө сургахаар аваагүйдээ харамсаж байна. Тэгэхэд чиний оюун ухаан миний дэргэд Волдемортод нээлтэй байх нь ямар ч аюулгүй гэдэгт итгэлтэй байсан бол ...
- Снеггийн хичээлийн дараа миний сорви үргэлж хүчтэй өвддөг байсан гээд Харри Роны үгийг санаж,
- Тэр Волдемортыг миний дотор нэвтрүүлэхэд туслаагүй гэдгийг та яаж мэдэх юм ... гэлээ.
- Би Северус Снеггэд итгэдэг. Гэхдээ би мартжээ. Бас л нэг хөгшин хүний алдаа, цаг хугацаа ч эдгээж болдоггүй гүн шарх байдаг юм. Би профессор Снегг чиний эцгийг үзэн яддагаа давсан гэж бодсон ч ... алдсан байсан ...
- Энэ чинь тэгээд хэвийн хэрэг үү? гэж Харри хашгирахад ханан дээрх хөргүүд унтууцан гүнгэнэлдэв. Тэгэхээр Снегг миний эцгийг үзэн ядаж болдог харин Сириус Кикимерийг үзэн ядаж болдоггүй хэрэг үү?
- Сириус Кикимерийг үзэн яддаггүй. Тэр түүнийг зарц гэж бодоод ямар ч анхаарал халамж тавьдаггүй байсан. Хайхрамжгүй үл ойшоосон явдал үргэлж дургүйцлийг төрүүлдэг юм ... өнөөдөр бидний устгасан усан оргилуур худал хэлсэн. Шидтэнгүүд бид нөхөдтэйгээ хэтэрхий удаан хугацааны турш хүний ёсноос гадуур харьцаж байсныхаа үр дүнг хүртэж байна ...
- Таныхаар бол Сириус хариугаа хүртсэн хэрэг болж байна уу? гэж Харри орилов.
- Би ингэж хэлэхийг чи хэзээ ч сонсохгүй. Сириус харгис хүн биш хэдий ч үйлчлэгчтэйгээ нөхөрсөг бус харьцдаг. Түүний Кикимерт дургүйн учир нь гэрийг нь амьд санагдуулдаг юм. Харин тэр гэрээ үзэн яддаг.
- Тиймээ, үзэн яддаг! гээд Харрийн хоолой сөөлөө. Тэр цаашаа эргэсэн ч хаашаа явахаа мэдсэнгүй. Өрөөнд нарны хурц гэрэл гийгүүлж хөргүүд түүний хөдөлгөөнийг дагуулан харж байлаа.
- Та түүнийг хориотой байлгаж байгааг үзэн яддаг байсан. Ийм л учраас тэр

өнгөрсөн шөнө үлдээгүй ...

- Би Сириусын амийг аврахыг оролдсон гэж Дамблдор аяархан хэлэв.
- Хүмүүст түгжээтэй байх нь таалагддаггүй юм! гэж Харри уурсан хашгираад эргэж харлаа.
- Та өнгөрсөн зун надад ийм зүйл хийснээ санаж байна уу?

Дамблдор нүдээ аниад урт хуруугаараа нүүрээ дарлаа. Энэ нь эцэж ядарч гашуудсаны тэмдэг байсан ч Харри тайвширсангүй. Эсрэгээрээ улам уурсан дэлбэрч Дамблдор сул дорой шинж үзүүлж байна гэж бодлоо. Тэр ийм сул дорой биш болохоор урж тасдан чулуудан хаяхыг хүслээ.

Хэдэн хормын дараа Дамблдор нүүрнээсээ гараа холдуулж Харри руу нүдний шилнийхээ дээгүүр харав.

- Гуйя суу, Харри. Би чамд таван жилийн өмнө хэлэх ёстой байсан цаг нь боллоо. Чи одоо бүх зүйлийг мэдэх болно. Би чамаас багахан тэвчээртэй байх гэдэг ганц л зүйлийг гуйя. Намайг дуусгах үед ... уур хилэнгээ гаргах боломж олгох болохоор хүссэн бүх зүйлээ хийгээрэй. Би зогсоохгүй.

Харри түүн рүү хэсэг хугацааны турш уурсан хараад ахин эсрэг талын сандал дээр суулаа.

Дамблдор нарны гэрэл гийгүүлсэн цонх руу харснаа ахин Харри руу харж,

- Таван жилийн өмнө чи Хогвартст эрүүл чийрэг аюулгүй яг л миний найдсан шиг ирж билээ, Харри. Ер нь бол ... тийм ч эрүүл биш л дээ. Чи олон зовлон амссан байсан. Би чамайг нагац ах, эгчийн чинь босгон дээр тавихдаа юу болохыг мэдэж байсан. Би чамайг хүнд хэцүү арван жилийг туулах ёстой гэдгийг мэдэж байсан гэв.

Тэр завсарлахад Харри чимээгүй байв.

- Чи намайг яагаад ийм алхам хийснийг асууж болох байсан. Яагаад чамайг ямар нэг шидтэний гэр бүлд өгөөгүй юм бол гэж? Олонхи хүн үүнийг баяртайгаар хүлээн авч томоохон хүндэтгэлтэйгээр хүү шигээ өсгөх байсан.

- Миний хариулт ийм байна. Юуны түрүүнд би чамайг амьд үлдээхийг хүссэн юм. Би ганцаараа л чамд ямар том аюул заналхийлж байгааг мэдэж байсан. Волдеморт хэдхэн цагийн өмнө зугтсан ч олон тооны догшин хэрцгий өрөвдөх сэтгэлгүй дагалдагч нар нь эрх чөлөөтэй үлдсэн байсан. Үүнээс гадна би шийдвэр

гаргахдаа ирээдүйг чинь бодож үзсэн юм. Би Волдемортыг үүрд алга болсон гэж итгэж байсан уу? Үгүй ээ. Би арав, хорь, тавин жилийн дараа хэзээ эргэж ирэхийг нь мэдээгүй ч эрт орой нэгэн цагт ирнэ гэдэгт итгэж байсан. Бас хэнээс ч илүү чамайг алахаас нааш тайвширахгүй гэдгийг мэдэж байсан.

- Би Волдемортыг ямар ч шидтэнгээс илүү хар шидийг эзэмшсэн гэдгийг мэдэж байсан. Миний хамгийн хүнд хэцүү хүчирхэг хамгаалалтын шившлэг ч түүнийг бүх хүчээ аван эргэж ирэхэд дийлэхгүй гэдгийг мэдэж байсан.

- Гэхдээ надад Волдемортын сул тал тодорхой байлаа. Ингээд би шийдвэр гаргаж чамайг хамгаалахын тулд түүний мэдэх хэдий ч хэзээ ч ойшоож байгаагүй эртний шидийг ашигласан юм. Би ээж чинь чамайг аврахын төлөө өөрийнхөө амийг золиослосон тухай ярьж байна. Тэр чамд ямар найдвартай хамгаалалт өгснөө өөрөө ч төсөөлөхгүй биз. Тэр өдөр хамгаалалт чиний цусанд гүйж байсан юм. Ийм учраас би эхийн чинь цусыг ашиглахаар шийдсэн билээ. Би түүнд өөр хамаатан үлдээгүй болохоор чамайг эгч рүү нь аваачсан.

- Тэр надад дургүй. Түүнд хамаагүй ... гэж Харри даруй хэлэв.

- Гэхдээ тэр чамайг авсан гэж Дамблдор яриаг нь таслаад,

- Тиймээ уурлаж дургүйцэж байсан хэдий ч авсан. Би шидээр түүнийг чамтай гагнасан юм. Эхийн чинь амиа өргөсөн цусан төрлийн холбоосыг хамгийн хүчирхэг хамгаалалт болгон өгсөн гэв.

- Би ойлгосонгүй ...

- Хэдийгээр чи хамаатнуудынхаа оршин суудаг газрыг гэр гэж нэрлэхгүй ч Волдеморт чамайг тэнд байхад хор учруулж чадахгүй байсан. Тэр хурууныхаа ч үзүүрийг хүргэж чадахгүй байлаа. Түүний цус чиний найдвартай хоргодох газар болсон юм. Чи тийшээ зөвхөн жилд нэг удаа буцахад чамд юу ч хийж чадахааргүй байлаа. Нагац эгч чинь үүнийг мэднэ. Би бүгдийг босгон дээр чиний хажууд орхисон захианд тайлбарласан. Тэр чамайг гэртээ авснаараа амьдралыг чинь арван таван жилийн турш аварч байсан гэдгээ мэднэ.

- Хүлээгээрэй. Түр хүлээгээрэй.

Тэр сандлаасаа босоод Дамблдор руу харлаа.

- Тэгэхээр та түүнд Аянгын мэдээ илгээсэн байх нь. Та түүнд битгий маргаарай гэж хэлсэн ... энэ таны хоолой байсан ...

- Би бодохдоо гээд тэр толгойгоо үл ялиг бөхийлгөв.
- Түүнд чамайг гэр бүлдээ авсан үеийн тохиролцоог сануулах хэрэгтэй гэж бодсон юм. Би Дементорын дайралт өргөмөл хүүг гэртээ байлгах нь ямар аюултай гэдгийг сануулсан байх сэжиглэсэн.
- Тэгсэн. Үнэндээ ... нагац ах минь бүгдээс илүү уурласан. Тэр намайг гудамжинд гаргахыг хүссэн ч Аянгын мэдээ ирээд тэр ... тэр намайг үлдэх ёстой гэсэн. Гэхдээ энэ ямар ч хамаагүй ... гээд шал руу ширтлээ.

Тэр Сириусын нэрийг хэлж чадсангүй.

- Таван жилийн өмнө гээд Дамблдор ахин ярьж эхэллээ.
- Чи Хогвартсад ирэхдээ жаргалтай ч биш махлаг ч биш хэдий ч яг л миний харахыг хүссэн шиг амьд эрүүл байсан. Чи эрх бяцхан хүүхэд биш жирийн хүү байлаа. Одоо болтол миний төлөвлөгөө ёсоор явж байв.
- Харин дараа нь ... чи Хогвартсад байсан анхны жил юу тохиолдсоныг надаас дутуугүй санаж байгаа. Чи дуудлагыг гайхамшигтай хүлээн авч намайг харж амжихаас өмнө түргэн хариулсан. Миний зөгнөсөн ёсоор Волдеморттой нүүр тулгарсан. Ингээд ахиад л амьд үлдсэн. Чи их зүйл хийсэн. Чи түүний хүч чадалтай болж эргэн ирэхэд саад болсон. Энэ бол гавъяа ... насанд хүрсэн хүний гавъяа байсан. Би чамаар ямар их бахархаж байснаа төсөөлж ч чадахгүй нь.
- Миний гайхамшигтай төлөвлөгөө өө сэвгүй биелж байлаа. Өө сэв илэрхий байсан би тэгэхэд бүх зүйл сүйрч болохыг ойлгосон юм. Тэгсэн ч миний төлөвлөгөө амжилттай биелж байсан болохоор өө сэв гарч сүйрэхийг зөвшөөрөөгүй. Би ганцаараа үүнээс сэрэмжилж, би ганцаараа хүч гаргах ёстой байлаа. Миний эхний сорилт чамайг Волдеморттой тэмцсэний дараа эмнэлэгт хэвтэж байхад чинь болсон юм.
- Би таны юу ярьж байгааг ойлгохгүй байна.
- Чи надаас Волдеморт яагаад хүүхэд байхад чинь алахыг оролдсон юм бэ гэж асууснаа санаж байна уу?

Харри толгой дохилоо.

- Чинийхээр бол би тэр үед юу гэж хариулах байсан хэрэг вэ?

Харри түүний гүн цэнхэр нүд рүү харан чимээгүй болоход зүрх нь ахин хүчтэй

цохиллоо.

- Чи миний төлөвлөгөөнөөс өө сэв олж харав уу? Үгүй ... харваас үгүй бололтой. Юу гэвэл ... тэгэхэд би хариулах эсэхээ шийдэж чадаагүй юм. Арван нэгэн жил үүнийг хэлэхэд хэтэрхий залуу байна гэж би өөртөө хэлсэн. Би хэзээ ч чамд арван нэгэн настай байхад чинь хэлэхээр төлөвлөж байгаагүй. Би чамайг үүнийг тэсвэрлэхгүй байх гэж айсан юм.

- Тэгэхэд надад аюулын шинж тэмдэг мэдэгдсэн. Би өөрөөсөө яагаад чиний асуулт бага түгшээснийг асуух ёстой байлаа. Би нэг л өдөр аймшигт хариулт өгөх цаг ирнэ гэдгийг мэдэж байсан. Би тийм онцгой өдрийн тухай бодолгүй дэндүү баярласнаа хүлээн зөвшөөрөх ёстой ... чи хэтэрхий залуу байсан, хэтэрхий залуу.

- Ингээд чиний Хогвартст суралцсан хоёр дахь жил эхэлсэн. Чи ахин хүнд сорилттой нүүр тулгарч мөрөн дээрээ насанд хүрсэн шидтэн бүрийн үүрээд байдаггүй ачааг үүрэн миний мөрөөдөж ч байгаагүй амжилтыг гаргасан. Үнэндээ чи асуултаа давтаж Волдеморт яагаад энэ тэмдгийг духан дээр чинь үлдээснийг асуугаагүй. Тиймээ мэдээж бид чиний соривины тухай ярьсан ... бид хаалттай сэдэвт их дөхөж очсон. Би тэгэхэд яагаад чамд бүгдийг хэлээгүй вэ?

- Юу гэвэл ... арван хоёр насанд тийм зүйл ярих нь эцсийн эцэст арван нэгэн наснаас арай л дээр гэж санагдсан. Би чамайг цусанд будагдаж, эцэж зүдэрсэн хэдий ч баяртай явахыг зөвшөөрөөд таагүй хатгуулахыг мэдэрч өөрийгөө түргэн тайвшируулснаа хэлэх ёстой. Чи бас л залуу байсан болохоор тэр үдшийн чинь баяр хөөрийг гутаах хүч байгаагүй ...

- Одоо ойлгож байна уу, Харри? Чи одоо л миний гялалзсан төлөвлөгөөг харж байна уу? Би эртнээс урхинд унахаа мэдэж байсан ч өөртөө зайлуулж чадна, зайлуулж чадна гэж хэлсэн юм!

- Би ойл ...

- Чи надад хэтэрхий үнэтэй байсан. Чиний аз жаргал миний хувьд чухал байсан. Чи үнэнийг мэдэх нь сэтгэл санааны чинь тайван байдлыг алдагдуулах байсан. Миний төлөвлөгөөнөөс чиний амьдрал үнэтэй байсан учир нурж болох байсан. Өөрөөр хэлвэл миний байдал Волдеморт хайрладаг хүмүүсээс үргэлж тэнэг явдал хүлээж байдагтай адил байсан.

- Үүнийг хамгаалалт гэж бодож байна уу? Би чамайг хэнээс ч илүү хамгаалж

байсан. Гиймээ би чамайг хичнээн анхааралтай ажиглаж байсныг чи төсөөлж

чадахгүй. Чиний зовлон дээр нэмж өвтгөж болно гэж үү? Би нэргүй нүүргүй хүмүүсийг бусдын зохион бүтээсэн тодорхойгүй ирээдүй хөнөөж болохыг мэдэж байна. Гэхдээ чи одоо энд амьд эрүүл хөгжилтэй байна. Би хэзээ ч миний гарт ийм гайхамшиг байна гэж төсөөлөөгүй.

- Чи гуравдугаар дамжаанд орсон. Би чамайг алсаас ажиглаж хэрхэн Дементорыг хөөн сурч, хэрхэн Сириустэй уулзаж гэмгүй гэдэгт нь итгээд үхлээс аврахыг алсаас харсан. Тэгэхэд чи загалмайлсан эцгээ ид шидийн яамны сарвуун дороос ялгуусан амжилттайгаар аварсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Одоо чи арван гурван нас хүрсэн болохоор миний баримт илүү итгэлтэй болж байлаа. Чи залуу байсан ч онцгой гэдгээ хэдийн баталсан. Гэвч сэтгэл минь намайг тайван байх боломж өгөөгүй, Харри. Би удахгүй цаг нь ирнэ гэдгийг мэдэж байсан.

- Гэтэл чи өнгөрсөн жил төөрдөг байшинд Седрик Диггорийн үхлийг хараад зогсохгүй өөрөө арай л үхээгүй ... би Волдеморт эргэж ирснийг мэдэж байсан хэдий ч ахин чамд юу ч хэлээгүй. Ингээд өнөө шөнө миний эртнээс нууцалж байсан зүйлийг чамд хэлэх цаг болсон гэдгийг ойлголоо. Өнөөдөр чи надад урьд нь хэлэх ёстой байсан гэдгийг баталж үзүүлэв. Гэхдээ надад үүнийг цагаатгах цорын ганц зүйл байна. Би чамайг Хогвартсын нэг ч сурагч түүхэндээ туулж байгаагүй хүнд сорилт туулахыг хараад хамгийн хүнд зүйлийг нэмж хэлэхийг хүсээгүй юм.

Харри хүлээсэн ч Дамблдор үргэлжлүүлсэнгүй.

- Би тэгсэн ч гэсэн ойлгохгүй байна.

- Волдеморт чамайг хүүхэд байхад чинь алах гэж оролдсоны учир нь төрөхөөс чинь өмнөхөн гарсан зөгнөлөөс болсон юм. Тэр чамайг хүүхэд байхад алахаар очихдоо зөгнөлийн хугацаанд итгэж байсан юм. Тэр алдаа гаргасанаа чамд шилгээсэн шившлэг буцаж ойн өөрийг нь цохиход мэдсэн. Ийм учраас биедээ эргэж ирсний дараа ялангуяа чиний өнгөрсөн жилийн ер бусын зугталтын дараа зөгнөлийг тодорхой мэдэх гэсэн ганц л бодолд автсан. Энэ бол түүний эргэж ирснээсээ хойш уйгагүй хөөцөлдөж байсан зэвсэг байсан юм. Түүнийг мэдэж байж л чамайг хэрхэн устгахаа мэдэх байлаа.

Нар өндөрт хөөрөн мандахад Дамблдорын өрөө илчинд нь дулаацав. Годрик Гриффиндорын илдийг хадгалж байгаа шилэн шүүгээ сүүн цагаан гэрлээр туяарч, газар унасан мөнгөн эдлэлийн хэлтэрхий бороон дусал шиг гялалзан, Харрийн ард

байсан Фоукс аяархан жиргэв.

- Зөгнөл хагарсан. Би Невиллийг нуман хаалгатай өрөөнд сандал өгсүүлэн дээш гаргах үед ... жанч нь урагдаад уначихсан ...

- Чи зөвхөн нууцын хэлтсийн архивт байсан хувийг хагалсан. Гэхдээ зөгнөлийг тухайн үед сонссон хүнээс нь эргэн дуудаж болно.

- Энэ хэн байсан юм? гэж Харри хэлэхдээ хариултыг нь мэдлээ.

- Би гэж Дамблдор хатуу баталлаа.

- Энэ арван зургаан жилийн өмнөх хүйтэн шөнө «Гахайн толгой» бааранд болсон явдал. Би тийшээ мэргэ төлгийн багшаар орохоор өргөдөл гаргасан хүнтэй уулзахаар очсон юм. Өргөдөл гаргагчийн өвөг эцэг алдартай маш авъяаслаг зөнч байсан болохоор би түүнтэй эелдэгээр уулзах ёстой гэж бодсон. Гэвч миний урам хугарсан. Түүнд өвөг эцгийнх нь авъяасын ул мөр өчүүхэн ч үгүй юм шиг санагдсан. Би түүнд эелдэгээр найдаж байна гэж хэлэхдээ энэ ажилд тохирно гэж бодоогүй. Ингээд явахаар хаалга руу эргэсэн.

Дамблдор босож Харрийн дэргэдүүр өнгөрөөд Фоуксын хонуурын ойролцоох хар шүүгээ рүү очлоо. Тэр доош бөхийн дотроос нь янз бүрийн дүрс тэмдэг сийлсэн чулуун суулга гаргаж ирлээ. Дараа нь ширээ рүү эргэн ирж түүнийг тавиад саваагаа шанаандаа хүргэлээ. Түүнээс аалзны шүлс мэт мөнгөлөг утас гарахад хэдэн удаа суулганд хийж гүнзгий санаа алдаад саваагаа мөнгөлөг шингэнд хүргэлээ.

Суулган дотор мөрөндөө алчуур зүүж, нүдэндээ том шил зүүсэн дүрс гарч ирээд удаанаар эргэлдэв. Тэгтэл Сивилла Трелони ам нээгдэн ердийн нууцлаг хоолойгоороо биш Харрийн нэг удаа сонссон сөөнгө хахир хоолойгоор ярьж эхлэв.

- Ирээдүйд Хар лордыг ялах хүчтэй хүн ... гурван удаа түүнээс мултарсан, долоон сарын сүүлд төрсөн ... Хар лорд түүнийг өөртэйгээ эн тэнцүү болох тэмдэглэх хэдий ч бүх хүчийг нь мэдэхгүй ... тэдний нэг нь нөгөөгийнхөө гарт үхэх ёстой, нэг нь тайван амьдарч чадахгүй нөгөөгөө ... Хар лордыг дийлэх хүчирхэг хүн долоон сард төрнө ...

Профессор Трелонигийн дүрс мөнгөлөг шингэнд удаанаар эргэлдэн алга боллоо. Өрөөнд нам гүм болов. Дамблдор, Харри ханан дээрх хөргүүд хүртэл дуугарсангүй. Тэр ч байтугай Фоукс хүртэл чимээгүй байлаа.

- Профессор Дамблдор гэж Харри түүнийг гүн ухааны цүнхээлээс хараа

салгалгүй гүн бодлогошироход аяархан хэлээд,

- Энэ чинь ... юу гэж ... энэ юу гэж байгаа юм? гэв.

- Энэ бол Хар лордыг ялах цорын ганц боломжтой хүн долоон сарын сүүлчээр арван зургаан жилийн өмнө төрсөн гэж байгаа юм. Эцэг эх нь Волдемортоос гурван удаа мултарсан.

Харрид занганд орсон юм шиг мэдрэмж төрөв. Түүнд амьсгалахад хүнд боллоо.

- Энэ ... би юу? Дамблдор санаа алдав.

- Хамгийн хачирхалтай нь гэвэл Харри чамд бүрэн хамааралтай биш.

Севиллагийн зөгнөл шидтэний гэр бүлд төрсөн хоёр хүүд хамаатай. Хоёулаа долоон сарын эцсээр төрсөн, хоёулангийнх нь эцэг эх Фениксийн бүлгийн гишүүн, гурван удаа гайхамшигаар Волдемортын гарт үхэхээс аврагдсан. Эдний нэг бол чи. Нөгөө нь бол Невилл Долгопупс.

- Гэхдээ тэр үед ... тэгвэл яагаад зөгнөл дээр Невиллийнхийг биш миний нэрийг тавьсан юм?

- Волдеморт чамайг бага байхад чинь довтолсны дараа хаяг өөрчлөгдсөн юм.

Танхимын хадгалагч Волдеморт алахаар оролдсоныг мэдэж байсан учир чамайг ганцаараа хамааралтай гэж бодсон хэрэг.

- Тэгвэл магадгүй ... энэ би биш байж болох уу?

- Эргэлзээгүй чамайг байх гэж айж байна гэж Дамблдор үг бүрээ удаанаар хүч гарган хэллээ.

- Гэхдээ та хэлсэн шүү дээ.. Невилл ч гэсэн долоон сарын сүүлээр төрсөн ... түүний эцэг эх ...

- Чи зөгнөлийн сүүлийн хэсгийг мартаад байна. Волдемортыг устгах хүүд тэмдэг тавих болно гэсэн ... Волдеморт түүнийг өөртэйгээ эн чацуу гэж болгоно гэсэн. Ингээд тэр үүнийг хийсэн, Харри. Тэр Невилийг биш чамайг сонгосон. Тэр чамд сорви өгснөөрөө аз жаргал, хараалыг нэгэн зэрэг өгсөн.

- Гэхдээ тэр буруу сонгосон бол яана! Тэр буруу хүнээ тэмдэглэсэн бол яана!

- Тэр өөртөө аюултай гэж бодсон хүүг л сонгосон. Бас өөр шигээ цэвэр цусны

шидтэн биш хүнийг сонгосон гэдгийг анхаарч үз. Тэр урьд нь чамайг хэзээ ч харж байгаагүй ч гэсэн амжилтгүй халдлагаараа хүч өгсөн юм. Тэгээд ч чи түүнээс нэг бус бүр дөрвөн удаа зугтсан.

- Тэр яагаад үүнийг хийсэн юм бол? гээд Харри хүйт даахаа мэдэрлээ.

- Яагаад намайг хүүхэд байхад алахыг оролдсон юм бол? Тэр яагаад бидний насанд хүрэхийг хүлээгээгүй юм? Тэгвэл бидний хэн нь аюултай блохыг мэдэж болох байсан шүү дээ ...

- Энэ магадгүй логик байж болох ч чи Волдеморт зөгнөлийн тухай барагцаалсан зүйл мэдсэн гэдгийг мартаж байна. Сивиллагийн сонгосон хямдхан «Гахай толгой» дэн буудалд «Гурван шүүр»-т байснаас илүү сониуч үйлчлүүлэгч нар байдаг юм. Чи болон найзуудад чинь гай тохиолдсоны адил би тэр шөнө буудалд гадны чих байгаагүй гэдэгт итгэлтэй байгаагүй. Мэдээж би Сивилла Трелонитой уулзсаныхаа дараа үнэт зүйл сонссон гэж зүүдлээ ч үгүй. Гэхдээ аз болоход сэм чагнасан хүн зөгнөлийг сонссон даруйдаа байшингаас гарсан байсан.

- Тэгэхээр тэр зөвхөн ...?

- Тэр зөвхөн эхлэлийг нь сонссон. Долоон сард төрсөн эцэг эх нь гурван удаа Волдемортын гараас мултарсан хүү. Үр дүнд нь тэр эзэндээ чам руу дайрах нь хүчээ дамжуулах эрсдэлтэй болон тэмдэг тавих нь эн тэнцүү болгох аюултай гэж анхааруулаагүй. Волдемортын толгойд чам руу дайрах нь аюултай цаашид ухаалагаар хүлээсэн нь дээр гэж ороогүй байна. Зөгнөлийн хэлснээр тэр үнэхээр чиний бүх хүчийг мэдэхгүй.

- Гэхдээ энэ чинь худал! Надад ямар ч хүч байхгүй. Би түүн шиг тэмцэж чадахгүй ... би бусдын биед орж чадахгүй ... хүмүүсийг алж чадахгүй.

- Нууцын хэлтсийн өрөөний хаалга үргэлж түгжээтэй байдаг. Түүнд нэгэн зэрэг гайхамшигтай болон аймшигтай үхлийн хүч агуулагдан хүний оюун ухааныг хүчээр эзэмддэг юм. Тэнд хамгийн нууцлаг зүйл хадгалагдаж байдаг. Чамд

ийм хүч хангалттай байхад Волдеморт эсрэгээрээ жаахан байгаа. Энэ хүч чамайг Сириусыг аврахаар явахад хэрэг болсон. Энэ хүч чамайг Волдемортын эзэмдэлтээс аварсан учир нь тэр үзэн ядалтаар дүүрэн хүний бие дотор оршиж чадна. Эцсийн эцэст чи оюун ухаанаа хааж сураагүй нь чухал биш. Энэ аврагч хүчний нэрийг хайр гэдэг юм.

Харри нүдээ анилаа. Хэрвээ тэр Сириусыг аврахаар очоогүй бол, Сириус үхэхгүй байсан ... Зөвхөн Сириусын тухай гашуудлаас түр ангижруулсанд баярлаад хайхрамжгүйхэн,

- Харин зөгнөлийн төгсгөл ... «нэг нь тайван амьдарч чадахгүй» ... тэгээд цааш нь? гэлээ.

- Нөгөөгөө амьд байхад гэж Дамблдор дуусгав.

- Тэгэхээр энэ чинь гээд Харрийн дотор гүн цөхөрлөө. Энэ чинь бид эцэстээ нэг нэгнийгээ алах ёстой гэсэн үг үү?

- Тийм.

Удтал чимээгүй болоход нам гүмийг хэн ч эвдсэнгүй. Алсад хананы цаана аяархан хоолой сонсогдох нь сурагчид Их танхим руу өглөөний цайндаа бууж буй бололтой. Энэ дэлхий дээр хүмүүс хоол идэхийг хүсэн, инээлдэж Сириус Блэк үүрд явсан гэдийг мэдэхгүй байх нь итгэмээргүй санагдана. Харрид Сириус хаа нэгтээ мянган милийн алсад байгаа юм шиг санагдав. Түүний оюун ухааны нэгээхэн хэсэг хөшгийг сөхөхөд Сириус түүн рүү эргэн харж ердийн нохой хуцахтай төстэй инээдээрээ угтах байх гэсэн зүйлд итгэсэн хэвээр байлаа.

- Би чамд ахин нэг зүйл тайлбарлах ёстой байх, Харри. Би чамайг яагаад ахлагчаар сонгоогүйн учрыг гайхаж байсан уу? Үнэнийг хэлэхэд ... би чиний үүрч ирсэн хариуцлага хангалттай гэж бодсон юм.

Харри түүн рүү харахад Дамблдорын хацар дээгүүр нулимс бөмбөрч урт мөнгөн сахал руу нь орлоо.

БҮЛЭГ 38: ХОЁРДУГААР ДАЙН ЭХЛЭВ

ХЭЦҮҮ НЭРТ ЭРГЭН ИРЖЭЭ

Баасан гаригийн үдэш ид шидийн яамны сайд Корнелиус Фаж Хэцүү нэрт манай оронд эргэн ирсэн гэсэн товч мэдэгдэл хийлээ.

«Шидтэнгүүдийн ертөнцөд гүнээ харамсалтайгаар мэдэгдэхэд өөрийгөө Лорд хэмээгч нь бидний дунд эргэн ирсэн. Та миний хэний тухай ярьж байгааг ойлгож байгаа биз дээ. Түүнчлэн Азкабаны Дементорууд бослого гарган цаашид ид шидийн яаманд үйлчилэхээс татгалзсан. Бид Дементоруудыг Лордын талд орсон гэж үзэж байгаа юм» хэмээн ядарч зүдрэн сэтгэлээр унасан сайд сурвалжлагчдаар хүрээлүүлэн мэдэгдлээ.

«Бид шидтэнгүүдэд сэрэмжтэй байхыг анхааруулж байна. Одоо ид шидийн яамнаас яаж өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах вэ гэдэг анхан шатны лавлах гаргаж байгаа бөгөөд ойрын хугацаанд гэрийн хаягаар үнэ төлбөргүй хүргэж өгөх болно».

Сайдын шидэт ертөнцөд хийсэн мэдэгдэл айж эмээсэн түгшүүртай байсан бөгөөд өнгөрсөн лхагва гаригийг хүртэл ид шидийн яамнаас «Хэцүү нэрт бидний дунд байгаа гэдэг утгагүй ярианд битгий итгэ» гэж уриалж байсан билээ.

Ид шидийн яамны түшмэдүүдийн бодлоо огцом өрчилсөний учир тодорхойгүй байгаа ч пүрэв гаригийн орой Хэцүү нэрт дагалдагч нарынхаа хамтаар (Үхэл залгигчид) ид шидийн яаманд нэвтэрсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Альбус Дамблдор ид шидтэн илбэчний Хогвартс сургуулийг эргэн толгойлох болсны дээр олон улсын шидтэнгүүдийн холбооны ерөнхийлөгч, Визенгамотын дээд шүүхийн гишүүн байх эрхийг нь сэргээж өнгөрсөн явдлын тухайд ямар ч тайлбар хийгээгүй байна. Тэр өнгөрсөн жилийн турш Хэцүү нэртийг үхээгүй бөгөөд ахин дэмжигчдээ цуглуулах замаар ээлжит ноёрхолоо тогтоох гэж байгаа гэж баталж байсан. Тэр үед амьд үлдсэн хүү ...

- Энэ чинь чи байхгүй юу, Харри. Тэд чамайг заавал дурьдана гэдгийг би мэдэж байсан гээд Гермиона сонин дээгүүрээ харлаа.

Тэд эмнэлэгийн жигүүрт байлаа. Харри Роны орны ирмэг дээр суугаад хоёул Гермионагийн чанга уншиж байгаа «Ням гаригийн зөнч»-ийг сонсож байв. Жиннигийн шагайг хатагтай Помфри түргэн эдгээсэн учир Гермионагийн одоо орны

хөлд суугаад, Невиллийн хамар хэвийн хэмжээндээ эргэж орон хоёр орны дундах сандлыг эзэлж, харин Полумна найзууд руугаа үе үе харангаа «Шүүмжлэгч» сэтгүүлийн сүүлчийн дугаарыг уруугаа харуулан уншиж Гермionaгийн үгийг сонсохгүй байлаа.

- Мэдээж тэр ахин «амьд үлдсэн хүү» болно. Тэд хичнээн гүнзгий төөрөлдөж байснаа түргэн мартаж байна шүү! гэж Рон баргар хэлэв.

Түүний орны хажуугийн шүүгээн дээр шоколадан мэлхийн том овоолго байсан бөгөөд түүнээсээ хэдийг Харри, Жинни, Невилл нарт өгөөд өөрийнхийгөө идлээ. Түүний бугуйн дээр тархины тэмтрүүлийн ороосон гүнзгий ором үлдсэн байв. Хатагтай Помфри хүүхдүүдэд Роны сорвинд доктор Летогийн хандыг хэрэглэж байгаа учир түргэн эдгэх болно гэж тайлбарлажээ.

- Тиймээ тэд чамд ч бахархалтай хандаж байна гэж Гермiona сонин дээгүүр нүдээ гүйлгэн хэлээд,

- «Нэг хоолой үнэнийг хэлж байсан ... энэ хүү доог тохуун дор гүжирдүүлж байсан ч өөрийн түүхэндээ эргэлзээгүй ...» Хмм гээд хөмсөг зангидасанаа, Би яагаад «Зөнч» сонин дээр энэ гүтгэлэг гарсан тухай нэг ч үг олж харахгүй байгаа юм бол гэв ...

Тэр ярвайснаа хавиргаа дарлаа. Долоховын шившлэг чанга хэлээгүй болохоор бүрэн үйлчилээгүй хэдий ч хатагтай Помфри Гермionaг хараад «хангалттай хөнөөл учирсан гэдэг нь тодорхой байна» гэсэн юм. Гермionaд өдөр бүр арван янзын ханд өгч байсан ч тэр эмнэлэгт уйдсандаа түргэн сайжирч байлаа.

- «Хэцүү нэртийн ноёрхолд хүрэх сүүлчийн оролдлого» гэж хоёр болон дөрөвдүгээр хуудсанд байна. «Сайд бидэнд хэлэх ёстой» гэж тавдугаар хуудсанд, «Яагаад хэн ч Альбус Дамблдорыг сонсоогүй вэ» гэж зургаа болон наймдугаар хуудсанд, «Харри Поттерын тухай тусгай сурвалжлага» ес дүгээр хуудсанд ... Тиймээ гээд Гермiona сонингоо хөнжил дээр тавьсанаа,

- Тэд гарцаагүй удаан хугацааны турш бичих зүйлтэй боллоо. Харригийн тухай тусгай биш сурвалжлага «Шүүмжлэгч» сэтгүүлд сарын өмнө нийтлэгдсэн биз дээ ... гэв.

- Аав тэднийг худалдсан гэж Полумна хэлээд сэтгүүлийнхээ хуудсыг эргүүлж,

- Тэр маш сайн ашиг олсон болохоор бид энэ зун Скандинавийн арлууд руу

Үрчгэр эвэрт олж барих аялал хийх гэж байгаа гэв. Гермiona өөртэйгээ хормын турш тэмцэлдсэнээ,

- Амжилт хүсье гэлээ.

Жинни инээмсэглэлээ нуун цааш эргэж харлаа.

- Тэгэхээр гээд Гермiona ахиад ярвайснаа,

- Сургууль дээгүүр юу байна даа? гэв.

- Нэгдүгээрт Флитвик Фред, Жорж хоёрын гаргасан намгийг алга болгосон.

Түүнд ердөө гурван секунд л шаардсан. Цонхны доор жаахныг устгалгүй үлдээсэн ...

- Яагаад? хэмээн Гермiona гайхлаа.

- Тэр үүнийг маш сайн шид гэсэн гээд Жинни мөрөө хавчлаа.

- Минийхээр бол тэр сургуульд Фред, Жорж хоёрын дурсгалыг үлдээхээр шийдсэн байх гэж амандаа дүүрэн шоколад чихсэн Рон дуугараад, Тэд л надад үүнийг илгээсэн байх. Тэдний дэлгүүр нь муугүй байгаа бололтой гээд хажуудаа овоолсон мэлхий рүү заалаа.

Гермiona түүн рүү таагүй хараад,

- Тэгэхээр Дамблдор эргэж ирснээс хойш бүх асуудал дууссан уу? гэв.

- Тиймээ ... бүх зүйл ахин байрандаа эргэж орсон гэж Невилл хэлэв.

- Филч баярласандаа тэнгэрт гарах нь холгүй байгаа байх даа? гэж Рон сониучирхаад Дамблдорын шоколадан мэлхийн зургийг ваар түшүүлэн тавилаа.

- Тэгж хэлэхээргүй л байна. Минийхээр бол түүнд үнэхээр аймшигтай байгаа гээд Жинни дуугаа намсган,

- Хогвартсад хэзээ ч Амбриж шиг гайхамшигтай захирал байгаагүй гэж хэлсэн гэлээ.

Бүгд эргэж харлаа. Профессор Амбриж талын орон дээр хэвтээд адар ширтэж байв. Түүнийг авчрахын тулд Дамблдор ганцаараа ой луу хүн морьдтой ярилцахаар яваад нэг ч шарх шалбархайгүй Амрбижийн хамт эргэж ирсэн бөгөөд яасан гэдгийг нь хэн ч мэдсэнгүй, тэр өөрөө ч энэ тухай яриагүй юм. Тэр шилтгээнд эргэж ирснийхээ дараа хүүхдүүдийн мэдэж байгаагаар нэг ч үг хэлээгүй болно. Түүний нямбайлан

самнасан байдаг саарал үс нь арзайж, навч мөчрийн хог орооцолдсоныг эс тооцвол эсэн мэнд байлаа.

- Хатагтай Помфри түүнийг мэдрэлийн цочирдолд орсон гэсэн хэмээн

Гермиона шивнэлээ.

- Минийхээр бол зүгээр л ааш муутай байх шиг байна гэж Жинни хэлэв.

- Ямар ч байсан түүнд үүнийг сонсох амьдралын шинж тэмдэг байна гээд Рон аяархан тагнайгаа ташлаа.

Амбриж ухасхийн босоод эргэн тойрноо цочирдон харлаа.

- Ямар нэг юм болоо юу, профессор? гэж өрөөнд орж ирсэн хатагтай Помфри асуув.

- Үгүй ... үгүй. Би зүүдэлсэн бололтой гэж Амбриж бувтнаад дэрэн дээрээ хэвтлээ.

Гермиона, Жинни хоёр амаа даран инээлдлээ.

- Хүн морьдуудын тухай гэснээс. Одоо хэн мэргэ төлгийн багш вэ? Флоренц бидний дунд үлдэж байгаа юу? гэж Гермиона жаахан тайвшираад хэлэв.

- Минийхээр бол түүнд сонголт байхгүй болсон. Бусад хүн морьд түүнийг буцаж очихыг зөвшөөрөхгүй гэж Харри хэллээ.

- Магадгүй Трелони тэр хоёр хамтдаа багшилж болох биш үү? гэж Жинни санал болгов.

- Гэхдээ Дамблдор Трелонигоос үүрд салахыг хүсэж байгаа гэж Рон мэдэгдээд арван дөрөв дэх мэлхийгээ идлээ. Хэрвээ надаас ийм тэнэг хичээлийн тухай асуувал Флоренц ч түүнийг аврахгүй гэж хэлнэ.

- Чи яаж тэгж хэлж чадаж байна! Бидэнд сая жинхэнэ зөгнөл байсан гэдэг нь тодорхой болсон биз дээ? гэж Гермиона шаардав.

Харрийн зүрх түргэн цохилон. Тэр зөгнөлийн дотор байсан зүйлийг Рон, Гермиона хоёр болон өөр хэнд ч хэлээгүй билээ. Невилл бүгдэд Үхлийн өрөөнд шатаар өгсөхдөө санамсаргүй хагалсан гэж хэлсэн бөгөөд Харри үүн дээр нэмэрлэсэнгүй. Тэр алуурчны золиос болсон тухайгаа яриад тэдний нүүрний хувирал ямар болохыг харахад бэлэн биш байлаа ...

- Тэр хагарсан нь харамсалтай юм гээд Гермiona толгойгоо сэгсэрлээ.
- Тийм шүү ... Гэхдээ Хэцүү нэрт тэнд байсан зүйлийг хэзээ ч мэдэж чадахгүй болсон юм чинь ... гэж Рон хэлээд,
- Чи хаачих нь вэ? хэмээн Харриг босохыг хараад гайхан асуулаа.
- Э-э ... Хагрид руу очлоо. Тэр саяхан буцаж ирсэн болохоор та нарын бие ямар байгааг хэлнэ гээд амалчихсан юм.
- Тэгвэл ч яахав гэж Рон бувтнаад цонхоор цэлмэг тэнгэр рүү атаархангуй харж,
- Ай даа, бид чамтай хамт явдаг болоосой гэлээ.
- Түүнд бидний өмнөөс мэнд хүргээрэй. Бас жижигхэн найз нь ... хэр байгааг нь асуугаарай! гэж Гермiona араас нь хашгирав.

Харри сонссоны тэмдэг болгон гараа даллаад хаалгаар гарлаа.

Шилтгээнд ням гариг гэхэд ер бусын нам гүм байлаа. Бүх сурагчид нарны гэрэлд нуга дээр гарч шалгалт дууссан баяр болон сүүлчийн өдрүүдэд гэрийн даалгавар давтаж хичээл хийхгүй болсноо тэмдэглэн өнгөрүүлж байгаа бололтой. Харри хоосон хонгилоор удаан явангаа цонхоор харахад зарим хүүхдүүд квиддичийн талбай дээгүүр нисч, зарим нь нууранд аварга наймаалжтай хамт сэлж байв.

Тэр хүмүүстэй нийлэх эсэхээ шийдэж чадсангүй. Хэдийгээр найзуудаасаа холдохыг хүссэн ч гэлээ ганцаараа үлдээд нөхдөө ахин санаж эхлэв. Магадгүй Хагридын зочилсон нь дээр байх гэж бодлоо. Тэр түүнийг эргэж ирснээс хойш ерөөсөө ярилцаагүй юм байна шүү дээ.

Харри дөнгөж үүдний танхимын гантиг шатны ёроолд хүртэл Слизериний амралтын өрөө рүү явдаг баруун талын хаалганаас Малфой, Крэбб, Гойл нар гарч ирлээ. Харри хөшсөн юм шиг зогсоод тэднийг харав. Нам гүмийг нээлттэй хаалгаар орж байгаа хүмүүсийн хашгиралт, инээд эвдэнэ.

Малфой эргэж харахад Харри түүний ойр хавьд багш байгаа эсэхийг шалгасан болохыг ойлголоо. Дараа нь эргэж хараад аяархнаар,

- Чи үхдэл болсон, Поттер гэв.

Харри хөмсгөө өргөлөө.

- Хачирхалтай юм. Үхсэн хүн явдаггүй гэж би бодсон юмсан.

Малфойн тийм ууртай байхыг Харри хэзээ ч харж байсангүй. Түүний туранхай цонхигор царайд уур хилэн дүрэлзэхэд сэтгэл ханамжтай болохоо мэдэрлээ.

- Чи надад бүгдийг төлөх болно. Би чамаар эцэгт минь хийсэн зүйлийн хариуг төлүүлэх болно гэж шивнэх шахам хэлэв.

- Би бүр айчихлаа. Волдеморттой уулзсантай харьцуулахад та гурвын бэлтгэсэн ... Яасан бэ? гэж энэ нэрийг сонсоод Малфой, Крэбб, Гойл нар цочирдон хөшихөд хэллээ.

- Тэр эцгийн чинь найз биз дээ? Чи арай түүнээс айдаг юм биш биз дээ?

- Чи өөрийгөө их эд гэж бодоо юу гээд Малфой түүн рүү ухасхийхэд Крэбб, Гойл хоёр дагалдав. За яахав, надад зөвхөн чиний учрыг олох хугацаа өг. Чи миний эцгийг шоронд хийж чадахгүй ...

- Харин би түүнийг тэнд байгаа гэж бодсон юмсан.

- Дементорууд Азкабанаас явсан. Чамайг нүд цавчиж ч амжаагүй байхад эцэг минь нөхөдтэйгээ суллагдах болно гэж Малфой тайван хэллээ.

- Тиймээ, магадгүй л юм. Гэхдээ эцсийн эцэст тэдний ямар новшнууд болохыг бүгд мэдсэн юм чинь.

Малфой саваа руугаа гараа явуулсан ч Харри түүнээс хурдан байлаа. Түүнийг халаасандаа гараа шургуулж амжихаас урьтаж саваагаа гаргаж ирлээ.

- Поттер!

Үүдний танхимд чанга дуу цуурайтав. Газар дорхи хонгилын шатаар Снегг өгсөн гарч ирэхэд Харриг Малфойтой харьцуулахын аргагүй үзэн ядалт нөмрөн авлаа ... Дамблдор юу ч хэлсэн байлаа тэр хэзээ ч Снеггийг уучлахгүй ... хэзээ ч ...

- Та юу хийж байна, Поттер? гэж Снегг хүйтнээр асуугаад ойртож ирлээ.

- Ямар шившлэг Малфойд илгээвэл дээрийг бодож байна гэж Харри ууртай хэлэв.

Снегг түүнийг цоо ширтэв.

- Даруйхан саваагаа хураа. Гриффиндороос арван оноо ... гээд ханан дээрх том элсэн цаг руу харснаа уруул нь ёжтой мушийв.

- Аан. Гриффиндорын цаганд хасаж болохоор оноо үлдээгүй бололтой. Юу гэвэл Поттер ийм тохиолдолд бидэнд ердөө ...

- Өөр нэмж хэлэх зүйл байна уу?

Профессор МакГонагалл шилтгээний үүдний шатан дээр нэг гартаа дөрвөлжин хээтэй цүнх, нөгөө гартаа хүнд таяг бариад гарч ирлээ. Түүний царайны өнгөөс үзвэл бие нь сайжирсан бололтой.

- Профессор МакГонагалл! Би таныг эмнэлэгээс гарсныг харж байна! гээд Снегг урагш алхав.

- Тиймээ, профессор Снегг гэж МакГонагалл батлаад аян замынхаа жанчыг тайлан,

- Миний бүх зүйл хэвийн болсон. Хөөе, та хоёр ... Крэбб! Гойл! гэв. Тэрбээр тэднийг захирангуй зангахад эв хавгүйхэн том хөлөө чирсээр очлоо.

- Үүнийг аваад миний өрөөнд аваачиж тавь гээд профессор МакГонагалл Крэббийн цээж рүү цүнхээрээ чичсэнээ, жанчаа Гойлд өглөө. Тэд эргээд дээшээ гантиг шатаар өгсөв.

- Тэгэхээр ... гээд МакГонагалл ханан дахь элсэн цаг руу харж,

- Би Поттер болон түүний нөхдийн ачаар ертөнц Волдеморт эргэн ирснийг мэдсэн тул тус бүрдээ тавин оноо хүртэх эрхтэй гэж бодож байна. Та энэ тухай юу гэж бодож байна, профессор? гэв.

- Юу? гэж Снегг Харрийн бодлоор маш сайн сонссон хэдий ч дуу алдаад,

- Аан ... тэгвэл ... гэв.

- Тэгэхээр Поттер болон хоёр Уизли, Долгопупс, хатагтай Грэйнджер нарт тус бүр тавин оноо өглөө гэж МакГонагалл хэлэхэд Гриффиндорын цагны доод талын ёроолыг дүүргэн бадмаараг бороо асгарав.

- Аан бас хатагтай Лавгудад тавин оноо өгөх хэрэгтэй байх гээд Когтевраны цаг руу харахад тодорхой тооны индраанил уналаа.

- Харин одоо та Поттероос арван оноо хасахыг хүсэж байна уу? Хүлээгээрэй ... Хэд хэдэн бадмаараг дээшээ үсрэн орсон ч доор бүтэн овоолго үлдэв.

- Поттер, Малфой би та нарыг ийм сайхан өдөр гадаа зугаалсан нь ашигтай гэж

бодож байна гэж МакГонагалл хөгжилтэй үргэлжлүүлэв.

Харрид хоёр давтуулах хэрэг байсангүй. Тэр саваагаа халаасандаа буцааж хийгээд үүдний хаалга руу явахдаа Снегг, Малфой хоёр луу харсангүй.

Гадаа халуун наранд төөнүүлсээр Хагридын овоохой руу явдаг зүлгэн дээгүүр явлаа. Эргэн тойрон дүүрэн сурагчид зүлгэн дээр тэрийн хэвтээд биеэ наранд шарж, ярилцангаа «Ням гаригийн зөнч» уншиж амттан идэж байлаа. Зарим хүүхдүүд дуудах юмуу гараа даллах нь «Өдөр тутмын зөнч»-ийн адил түүнийг баатар гэж бодож буйгаас бололтой. Харри тэдэнтэй ярилцахаар очсонгүй. Тэд гурван өдрийн өмнө юу болсныг мэдэхгүй байсан тул асуултаас зугтан замаа хөөлөө.

Хагридын овоохойн хаалгыг цохиод явахаар эргэтэл булангаас Соёт үсрэн гарч ирээд баярласандаа арай л газар унагачихсангүй. Хагрид ногооны талбайдаа буурцаг тарьж байв.

- Сайн уу, Харри! гэж тэр Харриг хашаанд ойртоход баясан хэлээд,
- Гэр лүү орж аяга багваахай цэцгийн шүүс уух уу ... гэв.
- За сонин юу байна? Тиймээ ... э-э ... чи зүгээр үү? гэж модон ширээний ард суунгаа шилэн аягатай хүйтэн шүүс гарт нь бариулан асуулаа.

Хагридын царай дээр бичигдсэн түгшүүрийг хараад Харри ойн сахиул биеийнх нь эрүүл мэндийн талаар яриагүйг ойлголоо.

- Зүгээр гэж Харри түргэн хэллээ. Тэр Хагридын ухаанд байгаа сэдвийн талаар ярилцахыг хүсэхгүй байв. Ингэхэд чи хаана байсан бэ?
- Ууланд нуугдаж байсан юм. Сириусын урьд нь байсан агуйд ...

Тэр хоолой засан ханиалгаснаа Харри руу хараад аягатайгаасаа том балгалаа.

- Ер нь гэвэл буцаад л ирлээ гэж сулхан хэлэв.
- Чи ... чи сайхан харагдаж байна гэж Харри Сириусээс ярианы сэдвийг холдуулахын тулд хэлэв.
- Юу? гээд Хагрид том алгаараа нүүрээ дарж үзэв.
- Аан, тийм л дээ ... Грошик биеэ хамаагүй дээр авч явдаг болсон. Үнэнийг хэлэхэд тэр намайг хараад их баярласан шүү. Би бүр түүнд найз охин олж өгдөг юмуу гэж бодож байгаа ...

Харри жирийн үед бол Хагридыг даруйхан энэ санаагаа орхи гэж ятгах байлаа. Ойд магадгүй Грохоос илүү хэрцгий зэрлэг ахин аврага биет суурьших нь хэний ч санааг зовоох зүйл байсан ч Харрид маргах хүч байсангүй. Тэр ахин ганцаар үлдэхийг хүсээд түргэн явахын тулд аягатай шүүснийхээ талыг хоослов.

- Одоо бүгд чамайг үнэнийг хэлснийг мэдэж байгаа. Тэгсэн нь дээр биз дээ?
гэж Хагрид гэнэт аяархан хэлэв. Харри мөрөө хавчлаа.

- Сонсооч ... гээд Хагрид түүний зүг бөхийв. Би Сириусыг чамаас илүү мэднэ ...
Тэр тэмцэлд үхсэн ... явахыг хүссэн замаараа явсан ...

- Тэр явахыг хүсээгүй! гэж Харри уурсан хэллээ
Хагрид сэгсгэр үстэй толгойгоо унжуулав.

- Магадгүй чиний зөв байх. Гэхдээ тэгсэн ч гэсэн, Харри ... Тэр бусад нь тэмцэж байхад гэртээ суугаад байх хүн биш. Чамд туслахаар гүйгээгүй бол дараа нь сэтгэл нь шаналах байсан ...

Харри үсрэн босоод,

- Би эмнэлэг рүү явж Рон, Гермиона хоёрыг эргэх хэрэгтэй байна гэж өөрийн мэдэлгүй хэлэв.

- Аан гэж сэтгэлээр унасан Хагрид дуугараад,

- Юу ... тэгвэл яахав, Харри ... явж өөртөө санаа тавь гэв.

- Тийм шүү ... баярлалаа ...

Харри үүд рүү яаран очоод Хагридыг салах ёс гүйцэтгэж амжихаас урьтаж нарны гэрэлд алхан гарлаа. Түүнийг ахиад л хүмүүс дуудав. Тэр агшин зуур нүдээ аниад эргэн тойрны бүх зүйл алга болж сургуулийн нутаг дэвсгэрт ганцаараа үлдээсэй гэж хүслээ ...

Шалгалт дуусахаас хэдэн өдрийн өмнө Волдемортын ухаанд нь суулгасан үзэгдлийг харах үедээ бүх шидтэний ертөнц түүнийг үгэнд итгэн, Волдемортын эргэж ирсэнд эргэлзэхээ больж түүнийг худалч галзуу гэж дуудахаа болиосой гэж хүсч байсан. Харин одоо ...

Тэр нуурын эрэг рүү очоод хажуугаар өнгөрөх хүмүүсээс зайлсхийн өтгөн бутны ард суугаад гялалзсан ус руу харлаа ...

Магадгүй Дамблдортой уулзсанаас хойш тусгаарлагдсанаа хурцаар мэдэрдэг болсон байж мэднэ. Үл үзэгдэх саад түүнийг шидтэний ертөнцөөс тусгаарлажээ. Хувь заяа түүнд эртнээс тэмдэгээ тавьсан ч урьд нь ямар аюул заналхийлж байгааг ойлгож байсангүй ...

Нарны гэрэл эргэн тойронд нь инээлдэж буй нэг ангийхан дээр нь тусахад тэр өөрийгөө хичнээн хол өөр зааглагдсан болон хэн нэгнийг алах ёстой юмуу алагдах ёстой болсон гэдэгтээ итгэхэд хэцүү байлаа.

Тэр нуурын эрэг дээр ус руу ширтэн удтал суухдаа эсрэг талын эрэг дээр Сириус нэг удаа зуугаад Дементоруудтай тэмцэж байсан тухай дурсахгүй байхыг хичээв.

Нар жаргаж хүйтэн боллоо. Харри босож шилтгээн рүү алхахдаа ханцуйгаараа нүүрээ арчлаа.

Улирал дуусахаас гурван өдрийн өмнө Рон, Гермиона хоёр эмнэлгээс бүрэн эдгэрээд гарчээ. Гермиона заримдаа Сириусын тухай ярихыг оролдон нэрийг нь дурсмагц Рон яриаг шууд хазайлгаж эхэлдэг байлаа. Харри урьдын адил загалмайлсан эцгийнхээ тухай яриаг дэмжих эсэхийг мэдэхгүй байв. Ер нь бол ганц л зүйлд итгэлтэй байлаа. Хэдийгээр одоо түүнд амаргүй байгаа ч хэдэн өдрийн дараа Улаан модон гудамжны дөрвөн тоот байшинд очих үед Хогвартсыг санах болно гэдгээ мэдэж байв. Тэр одоо яагаад зун бүр буцах ёстойгоо мэддэг болсон ч хачирхалтай нь энэ тусалсангүй. Эсрэгээрээ гэр лүүгээ хэзээ ч байгаагүй айдастай буцах нь байна.

Профессор Амбриж Хогвартсыг улирлын сүүлчээр орхив. Тэр эмнэлгээс оройн хоолны үеэр гарч ажиглагдахгүй явах гэж найдсан нь илэрхий ч гай болоход Фредийн салах ёсны үгийг гүйцэтгэх сүүлчийн боломжыг алдаагүй Пивзтэй таарчээ. Тэр түүнийг баяртайгаар хөөж, дүүрэн шохойтой оймс болон таягаар ээлжлэн цохилоо. Хүүхдүүд түүний хэрхэн шилтгээнээс зугтан одохыг харахаар үүдний танхимд гүйн гарахад тэнхимийн эрхлэгч нар чимээ шуугианыг намдаахаар тийм ч их хичээсэнгүй. Үнэндээ профессор МакГонагалл багшийн ширээний ардах дуртай сандалдаа суугаад харамсалтай нь Амбрижийн араас үдэн хашгирч чадахгүй болохоор Пивзэд таягаа зээлдүүлсэн гэж чанга хэлжээ.

Хичээлийн жилийн сүүлчийн өдөр бараг бүх сурагчид Их танхимын найр эхлэхээс өмнө чемоданаа багласан хэдий ч Харри эхлээгүй байв.

- За боль доо, маргааш хийчих! Явъя миний гэдэс нуруундаа наалдах нь байна!

гэж Рон унтлагын өрөөний үүднээс хашгирав.

- Одоохон ... чи явж бай би араас чинь гүйцье ...

Рон хаалга хаамагц Харри юмаа цуглуулах өчүүхэн ч оролдлого хийсэнгүй. Тэр энэ дэлхий дээр юунаас илүү үдэлтийн цайллаганд оролцохыг хүсэхгүй байлаа. Дамблдор түүний нэрийг дурьдахаас айж байв. Тэдний захирал нь Волдемортын эргэн ирсэн тухай чимээгүй байхгүй нь мэдээж ... эцсийн эцэст энэ тухай өнгөрсөн жил ярьсан билээ ...

Харри зарим зүйлээ хийх зай гаргахаар чемоданыхаа ёроолоос үнгэгдсэн жанч гаргаж ирэхдээ гэнэтхэн буланд цаасанд ороолттой зүйл байхыг харлаа. Тэр түүнийг хаанаас гараад ирснийг ойлгосонгүй. Доошоо бөхийгөөд авч гартаа эргэлдүүлэв.

Хормын дараа гэнэт саналаа. Энэ зүйлийг Сириус түүнд Гриммогийн арван хоёр дугаар байшингаас явахад өгсөн шүү дээ. «Хэрвээ би шаардагдвал заавал ашиглаарай. Тохиролцов уу?»

Харри орон дээрээ суугаад цаасыг урлаа. Түүнээс жижигхэн дөрвөлжин толь унаж ирэв. Тэр бохир их дээр үеийн эд ажээ. Харри түүнийг авч өөрийнхөө тусгалыг харав.

Тэр толийг эргүүллээ. Эсрэг талд нь Сириусын сараачин бичсэн хэдэн үг байв.

Энэ бол хоёр нүүртэй толь нөгөө хагас нь надад байгаа. Хэрвээ надтай ярихыг хүсвэл зөвхөн нэр хэлэхэд болно. Тэгвэл чи миний толинд, харин би чинийхэд гарч ирэн ярилцах боломжтой болох юм. Жеймс бид хоёр үүнийг хичээлийн дараа өөр газар үлдэн шийтгүүлэхдээ ашигладаг байлаа.

Харрийн зүрх хүндээр цохилов. Тэр дөрвөн жилийн өмнө Еиналежийн толинд нас барсан эцэг эхээ харсныг саналаа. Харин одоо Сириустэй ярих юм биш байгаа даа ... тиймээ тийм, тэр үүнийг мэдэж байна.

Тэр өрөөнд хүн байгаа эсэхийг шалган харахад хоосон байлаа. Тэгээд ахин толь руу харж чичирсэн гараар өргөөд Сириусын нэрийг чанга хэлэв.

Толины гадарга манантан бүрхэв. Тэр үнэт бэлгийг ойртуулан бариад баяртайгаар нүд салгалгүй манантах утаа руу хартал эргэлзээгүй өөрийн тусгал байлаа.

Тэр толийг ханцуйгаараа арчаад үг бүрээ тод чанга хэлэв.

- Сириус Блэк!

Юу ч болсонгүй. Толинд өмнөхийн адил урам хугарсан царай харагдсаар байв ... гарцаагүй түүний өөрийнх ...

«Сириус нуманд хаалганд алга болох үед толь нь байгаагүй байх. Ийм учраас ажиллахгүй байгаа хэрэг» гэсэн бодол Харрийн тархинд зурсхийв.

Ахин хэдэн хормын турш хөдөлгөөнгүй суугаад дараа нь толийг чемодан руугаа хүчтэй чулуудахад хагарлаа. Бараг бүтэн хормын турш ямар гайхамшигтай агшин байв аа! Тэр одоохон Сириусыг харж ахин түүнтэй ярилцана гэдэгт итгэж байсан ...

Урам хугарал нөмрөн авахад босож хагарсан толь дээгүүр юмаа замбараагүй хийлээ

...

Тэгтэл гэнэтхэн нэг санаа төрөв ... энэ тольноос дээр байж таарна ... хамаагүй дээр илүү чухал санаа ... тэр яагаад өмнө энэ тухай бодоогүй юм бол? Яагаад асуугаагүй юм бол?

Тэр унтлагын өрөөнөөс үсрэн гарч эргүүлгэн шат уруудан гүйгээд хүнгүй амралтын өрөөний хөргөн нүхээр гарч хонгилоор хар хурдаараа гүйхдээ тарган хатагтай араас нь «Цайллага одоо эхэлж байгаа болохоор чи амжина!» гэж хашгирахыг тоосонгүй.

Гэвч Харрид цайллага руу явах ямар ч санаа байсангүй.

Энэ шилтгээнд үргэлж хэрэггүй үедээ хий үзэгдэл дүүрэн байдаг атал харин одоо ... Тэр шатаар уруудан холгүй орших хонгилоор явахдаа нэг ч амьд болон үхсэн амьтантай тааралдсангүй. Бүгд Их танхимд байгаа бололтой. Шившлэгийн танхимын өмнө зогсоод амьсгаадан цайллага дуусахыг хүлээх хэрэгтэй болох нь гэж гунигтай бодлоо ...

Гэхдээ Харрийн сүүлчийн найдлага бөхөж амжаагүй байтал сувдан тунгалаг дүрс хонгилын үзүүрт гялсхийв.

- Хөөе ... хөөе, Ник! Ник!

Хананаас чамин өдтэй бүрх малгай духдуулан тавьж толгой нь мөрөн дээрээ осолтой ганхах ноён Николас де Мимси-Дельфингтон гарч ирэв.

- Оройн мэнд гэж тэр Харриг хараад бүх биеэрээ гарч ирэн хэлээд,

- Тэгэхээр би ганцаараа хоцроогүй хэрэг байх нь ээ? Гэхдээ энэ нь надад ямар ч бодол төрүүлдэггүй юм гээд санаа алдав.

- Ник, би чамаас юм асууж болох уу?

Бараг толгойгүй Никийн царайд хачирхалтай өнгө зурсхийн хуруугаа сунган захаа захсанаас үзэхэд өөртөө бодлогоширох хугацаа өгөх гэсэн бололтой.

- Э-э ... одоо юу, Харри? Цайллагын дараа болохгүй юм уу? гэж тэвдсэн байртай хэлэв.

- Үгүй ээ ... гуйж байна, Ник. Би үнэхээр чамтай ярих хэрэгтэй байна. Алив ийшээ орох уу?

Харри ойролцоох ангийн хаалгыг онгойлгоход бараг толгойгүй Ник санаа алдав.

- За яахав тэгвэл. Үүнийг гэнэтийн явдал гэж хэлж чадахгүй нь дээ ... Харри түүнд хаалга нээж өгсөн ч Ник хана нэвтлэн орохыг эрхэмлэв.

- Чи юуны тухай хэлсэн бэ? хэмээн Харри асуугаад хаалга хаалаа.

- Би чамайг намайг хайхыг чинь хүлээж байсан юм. Энэ заримдаа тохиолддог юм ... хүмүүс хэн нэгийгээ алдах үед гэж Ник хэлээд цонх руу очлоо. Шилтгээний нуга мананд хучигдсан байв.

- Ойлгомжтой. Чиний зөв, би үнэхээр чамайг эрж байсан. Ник чимээгүй байв.

- Би юу хэлэх гэсэн юм бэ гэвэл ... гэж Харри эхлэхдээ энэ яриаг эхлэхэд ийм амаргүй гэж бодсонгүй.

- Чи ... үхсэн биз дээ? Гэхдээ чи энд байсан хэвээр байна. Ник санаа алдаад цонхноос харц салгасангүй.

- Миний зөв үү үгүй юу? Чи үхсэн ч би чамтай ярилцаж байна ... чи Хогвартсын эргэн тойронд болон үүгээр түүгээр явдаг гэж Харри шаардангуй үргэлжлүүлэв.

- Тиймээ би явж ярьдаг. Чиний зөв гэж Ник аяархан хэлэв.

- Тэгэхээр чи эргэж ирсэн үү? Хүмүүс заримдаа буцаж ирдэг биз дээ? Тэд хий үзэгдэл болоод алга болдоггүй. Миний зөв үү? гэж хөөрөн хэлэхэд Ник урьдын адил юу ч хэлсэнгүй.

Нам гүм болоход бараг толгойгүй Ник тээнэгэлзсэнээ аниргүйг эвдэв.

- Хүн бүр хий үзэгдэл болдоггүй юм.

- Энэ чинь юу гэж байгаа юм? Харри түргэн асуулаа.

- Зөвхөн ... зөвхөн шидтэн.
- Аан! гээд Харри санаа амарсандаа золтой инээчихсэнгүй.
- Тэгвэл бүх зүйл хэвийн шив. Миний чамд ярьж байгаа хүн бол шидтэн юм.

Тэгэхээр тэр эргэж ирнэ тийм үү? гэв.

Ник цонхноос эргээд Харри руу гашуудалтай харлаа.

- Тэр эргэж ирэхгүй.
- Хэн?
- Сириус Блэк.
- Гэхдээ чи эргэж ирсэн биз дээ! Чи үхсэн ч гэсэн ахин энд байна ... чи алга болоогүй! гэж Харри уурсан дуу алдлаа.
- Шидтэнгүүд газар дэлхийгээ орхисон хэдий ч эндээс явахыг хүсэлгүй амьдарч байсан газраа холхидог юм. Гэхдээ цөөхөн тооны шидтэн энэ замыг сонгон авдаг гэж Ник шаналангүй хэллээ.
- Гэхдээ яагаад? Гэхдээ энэ чухал биш ... Сириус ер бусын зүйлээс хэзээ ч айж байгаагүй ... тэр эргэж ирнэ, би мэдэж байна!

Харри ингэж хүчтэй батлаад толгойгоо хаалга руу эргүүлж одоохон түүгээр сувдан цагаан тунгалаг Сириус инээмсэглэсээр орж ирэх юм шиг харав.

- Тэр эргэж ирэхгүй гэж Ник давтлаа.
- Тэр ... цаашаа явсан.
- Цаашаа гэдэг чинь юу гэж байгаа юм? Хаашаа? Үхсэний дараа юу болдог юм бэ? Үхсэний дараа хүн хаачдаг юм? Яагаад бүгдээрээ эргэж ирдэггүй юм? Яагаад энэ шилтгээнээр хий үзэгдлээр дүүрэн биш байдаг юм? Яагаад? ...
- Би хариулж чадахгүй гэж Ник үнэнээ хэлэв.
- Гэхдээ чи үхсэн биз дээ! Чамаас өөр хэн хариулах юм! гэж Харри унтууцан хэллээ.
- Би үхлээс айсан. Тэгээд ард үлдэхийг эрхэмлэсэн юм. Заримдаа би боддог юм ... ойлгож байна уу ... би одоо энд ч биш тэнд ч биш ... Үнэнийг хэлэхэд би ...
- Би хэзээ ч үхлийн нууцыг мэдэхгүй, Харри. Яагаад гэвэл дуураймал амьдрал

сонгон авсан. Магадгүй нууцын хэлтсийн хэн нэг ухаантан энэ асуудлыг судлана биз ...

- Надад энэ газрыг бүү сануул! гэж Харри уурсан хашгирлаа.

- Чамд тусалж чадаагүйд уучлаарай. Харин одоо ... намайг өршөөгөөрэй ... цайллага руу явлаа.

Ингээд Харри ахин ганцаар хоцроод бараг толгойг Никийн уусан алга болсон хана руу харлаа.

Одоо зөвхөн Сириустэй үхсэн хойноо ярих найдлага үлдлээ. Харрид загалмайлан эцгээ хоёр дахь удаагаа алдсан мэт мэдрэмж төрөв. Тэр удаанаар хоосон шилтгээн рүү буцахад амьдралдаа ахин хэзээ ч баярлаж чадахгүй болсон мэт санагдлаа.

Тэр булан эргээд тарган хатагтайн хөрөг рүү явж байхдаа хэн нэгний дүрсийг харав. Харри Полумнаг танилаа. Тэр самбарт цаас нааж байв. Ойролцоо нуугдах газар байсангүйн дээр хөлийн алхаа нь сонсогдсон нь лавтай тул зугтаж чадсангүй.

- Сайн уу гэж Полумна хэлээд самбараас алхам ухарч түүн рүү харлаа.

- Чи яагаад цайллага дээр биш байгаа юм? гэж Харри асуув.

- Миний бараг бүх зүйл алга болчихсон. Ойлгож байна уу хүүхдүүд тэднийг нуучихдаг юм. Гэхдээ өнөөдөр сүүлчийн орой болохоор цуглуулах хэрэгтэй байна. Би самбарт зарлал тавьж байгаа юм ... гээд алдагдсан эд зүйлээ эргүүлж өгөхийг гуйсан зарлал руу зангалаа.

Харрийн дотор Сириусын үхлээс хойш уур хилэн ч биш уй гашуу ч биш хачирхалтай мэдрэмж төрлөө. Хэдэн хормын дараа Полумнаг өрөвдөж буйгаа ойлгов.

- Тэд яагаад чиний юмыг нуудаг юм? гэж хөмсөг зангидан асуув.

- Юу гэвэл ... тэд намайг жаахан хачин гэж боддог юм. Зарим нь намайг хагас ухаантай Лавгуд гэж дууддаг гээд Полумна мөрөө хавчив.

Харри түүн рүү харахад цээж нь янгинан өвдлөө.

- Энэ чиний юмыг авах шалтгаан биш. Би чамд тусалж хайлцахыг хүсч байна уу?

- Үгүй дээ. Тэд олдоно эцсийн эцэст үргэлж олддог. Би зүгээр л өнөөдөр олохыг хүссэн юм. Дашрамд ... чи яагаад өөрөө цайллага дээр биш байгаа юм?

Харри мөрөө хавчлаа.

- Хүсээгүй тэгээд л тэр.

- Мэдэж байна уу минийхээр бол энэ худал. Үхэл залгигчийн алсан хүн чиний загалмайлсан эцэг байсан биз дээ? Жинни надад хэлсэн гээд Полумна түүн рүү хачирхалтай бүүдгэр нүдээрээ харлаа.

Харри Полумнатай Сириусын тухай ярихыг хүсэхгүй байсан болохоор товчхон толгой дохив. Тэр гэнэтхэн фестралуудыг харсныг нь саналаа.

- Харин чи ... Чиний хэн нэг бас үхсэн үү?

- Тиймээ. Миний ээж. Тэр их ер бусын шидтэн байсан болохоор туршилт хийх нь таалагддаг байсан ч нэг шившлэг нь гай авчирсан юм. Би тэгэхэд естэй байсан.

- Уучлаарай гэж Харри бувтналаа.

- Тиймээ, энэ бол аймшигтай гэж Полумна цаг агаарын тухай ярьж байгаа юм шиг тайван хэлээд,

- Надад заримдаа маш их гунигтай байдаг. Гэхдээ надад аав үлдсэн. Тэгээд ч би ээжийгээ ахиж хэзээ ч харахгүй биз дээ?

- Э-э ... юу гэнээ? гэж Харри асуулаа. Тэр толгойгоо итгэлгүйхэн сэгсрэв.

- Боль доо. Чи хөшигний ард юу байгааг сонссон.

- Чи юуны тухай ...

- Нуман хаалгатай өрөөнд. Тэд харагдахгүй ч бүгд байдаг. Чи тэднийг сонссон.

Тэд бие бие лүүгээ харлаа. Полумна инээмсэглэв. Харри юу бодохоо мэдсэнгүй. Полумна олон янзын хачирхалтай зүйлд итгэдэг хэдий ч ... тэр үнэхээр хөшигний ард байсан хоолойг сонссон.

- Чи үнэхээр намайг юмыг чинь хайж олоход туслахыг хүсэхгүй байна уу?

- Үгүй дээ. Хэрэггүй. Би доошоо бууж зүсэм бялуу идэнгээ хүлээдэг юмуу гэж бодлоо. Төгсгөлдөө үргэлж олддог юм ... амралтаа сайхан өнгөрүүлээрэй, Харри.

- Баярлалаа. Чамд ч гэсэн.

Тэр хонгилоор явлаа. Харри түүний араас дагуулан хараад дотроос нь бул чулуу авах адил хөнгөрөхийг мэдэрчээ.

Маргааш өдөр нь «Хогвартс экспресс» буухиа галт тэргээр гэр лүүгээ буцах аялал олон янзын үйл явдлаар дүүрэн боллоо. Нэгдүгээрт Малфой, Крэбб, Гойл нар долоо хоногийн турш багш нарын эзгүйд Харри руу дайрах боломж хүлээсэн болохоор жорлонгоос ирэх замд нь отоож байжээ. Тэдний довтолгоо амжилтай болсонгүй учир нь дайралт хийх газраа ДА-гийн гишүүдээр дүүрэн өрөөнөөс холгүй сонгож авсан бөгөөд болсон явдлыг шил нэвт харсан хүмүүс Харрид туслахаар яарав. Тэр үед Эрни Макмиллан, Ханна Аббот, Сьюзен Боунс, Жастин Финч-Флетчли, Энтони Голдстейн, Терри Бут нар бүгд Харрийн заасан шившлэгүүдийг эзэмшсэн байсан болохоор Малфой, Крэбб, Гойл нар сургуулийн дүрэмт хувцастай гурван аварга нялцгай биет болон хувирав. Харри, Эрни, Жастин нар тэднийг тээшийн тавиур дээр өргөн тавихад хүрэн өнгийн шингэн гоожуулж байлаа.

- Үнэнийг хэлэхэд түүнийг галт тэрэгнээс буухад Малфойн ээжийн царай ямар болохыг харахыг тэсч ядан хүлээж байна гэж Эрни сэтгэл хангалуун хэлээд дээрээ атиралдаж буй Малфой руу харлаа. Эрни Малфойг шалгалтын бүлгийнхний хаанчлалын үед Пуффендуйгаас оноо хассаны төлөө уучлаагүй байв.

- Гойлын ээж лав баярлах байх гэж өрөөнд гарсан чимээ шуугианы дагуу орж ирсэн Рон хэлээд,

- Тэр хамаагүй дээр харагдаж байна ... Ингэхэд Харри дөнгөж сая тэргэнцэртэй хоол өнгөрлөө. Ямар нэг юм авах уу? гэв.

Харри бусаддаа талархаад Роны араас гарч хулуун жигнэмэг, тогоон хэлбэртэй амтат боов авлаа. Гермiona ахин «Өдөр тутмын зөнч» шагайж, Жинни «Шүүмжлэгч» сэтгүүлийн үгийн сүлжээг бөглөхөөр шийдэж, Невилл жилийн дотор ажиглагдам өссөн Мимбулус мимблетониягаа илэхэд хүрэх тоолонд нь аяархан дуугарч байв.

Харри, Рон хоёрын замын ихэнхи хэсгийг шидэт шатар тоглож өнгөрүүлэв. Үе үе Гремиона тэдэнд «Зөнч» сонингоос чанга уншиж өгч байлаа. Сонин одоо Дементоруудаас хэрхэн хамгаалах тухай болон, Волдеморт өглөө дэргэдүүр нь явж өнгөрсөн гэж зүтгэх захиаг шалгаж буй зэрэг зүйлсээр дүүрэн байлаа.

- Хэрэгтэй юм юу ч алга. Гэхдээ удаан хүлээхгүй байх ... гэж Гермiona баргар хэлээд сонингоо эвхэн санаа алдав.

- Хөөе, Харри гээд Рон хаалганы цонх руу толгой дохилоо.

Харри эргэж харав. Хонгилд Чжоу, нүүрний халхавч өмссөн Мариэтта Эжкомын

хамт явж өнгөрлөө. Харри, Чжоу хоёрын харц тулгарахад тэр улайсан ч зогссонгүй. Харри ахин хөлөг руу хараад Роны морь хүүг нь идэхийг харлаа.

- Та хоёрын хооронд юу болоо вэ? гэж Рон аяархан асуув.

- Юу ч биш гэж Харри үнэнээ хэлэв.

- Би ... түүнийг өөр хүнтэй уулзаж байгаа гэж сонссон хэмээн Гермiona болгоомжтой дуугарлаа.

Харри энэ мэдээлэл нөлөөлсөнгүй явдалд гайхширлаа. Сириусын үхлээс хойш Чжоуд таалагдахыг хүсч байсан нь өнгөрсөн үеийн юм шиг санагдах ажээ. Тэр сүүлчийн удаа загалмайлсан эцгээ амьд харснаас хойш долоо хоногийн хугацаа өнгөрсөн ч энэ нь бүтэн жил болон сунаж хоёр янзын ертөнцийг зааглахад тэднийг нэг Сириусынх байсан бол нөгөө нь байсангүй ...

- Тэгвэл сайн байна, найз минь. Тэр хөөрхөн ч гэсэн чамд арай хөгжилтэй хүн хэрэгтэй гэж Рон хэлэв.

- Тэр магадгүй өөр хүнтэй хөгжилтэй байх болов уу гээд Харри мөрөө хавчлаа.

- Одоогийн найз нь хэн юм? гэж Рон Гермionaгаас асуусан хэдий ч Жинни,

- Майкл Корнер гэлээ.

- Майкл ... гэхдээ ... энэ чинь чиний найз биз дээ! гээд Рон эргэж харахдаа золтой хүзүүгээ хугалчихсангүй.

- Байсан гэж Жинни шийдэмгий хэллээ.

- Гриффиндор Когтевраныг квиддич дээр хожсоны дараа тэр их баргар байсан болохоор би салах боломж өгсөн юм. Харин тэр Чжоуг тайвшируулахаар гүйж очсон гээд бодлогоширонгүй үзгээрээ хамраа маажингаа «Шүүмжлэгч»- ээ эргүүлэн хариултаа шалгаж эхлэв. Рон ихэд сэтгэл хангалуун харагдав.

- Надад тэр үргэлж тэнэг юм шиг санагддаг. Зүйтэй хийж, дүү минь. Дараагийн удаа арай дээр хүнийг сонгоорой гээд бэрсээрээ Харрийн тэргийг идлээ.

Тэр ингэж хэлснийхээ дараа яагаад ч юм Харри руу сэмхэн харлаа.

- Би хэдийн Дин Томасыг сонгосон. Баярлаж байна уу?

- Юу гэнээ? гэж Рон орилоод өвдгөөрөө хөлөг цохиж унагав. Живоглот дүрсүүдийн араас ухасхийхэд дээд талын тавиур дээр сууж байсан Хэдвиг, Гахай

хоёр ууртай гуугчин далавчаа нүдлээ.

Галт тэрэг Кингс Кросс тавцан дээр ойртон ирж удааширахад Харрид галт тэрэгнээс гарахад итгэмээргүй хэцүү байлаа. Түүнд нэгэнт татгалзаж болохгүйгээс хойш есөн сарын нэгэн хүртэл өрөөндөө уйтгартай суугаад Хогвартс руу буцах өдрөө хүлээсэн нь дээр гэсэн бодол зурсхийв. Эцэст нь галт тэрэг уур баагиулан зогсмогц Харри Хэдвигийн торыг аваад тавцан руу хүнд чемоданаа гаргахад бэлтгэв.

Тасалбар шалгагчыг дохио өгөхөд Харри, Рон, Гермиона гурав есөн бүхэл дөрөвдүгээр тавцангийн дундах шидэт хаалтыг явж өнгөрөхөд нөгөө талд нь гэнэтийн явдал болох Харрийн хэзээ ч төсөөлөөгүй хүмүүс хүлээж байлаа.

Тэнд аян замын хэлхгэр жанчтай Хурц нүдэт Грюм бүрх малгай шидэт нүд рүүгээ хэлтийлгэн өмсөөд, мойног хуруугаараа урт таяг барин зогсож байв. Дэргэд нь элэгдсэн нөхөөстэй жинсэн өмд, «Эмгэн шулмас» хамтлагийн бэлэг тэмдэг бүхий хөх ягаан футболкатай Тонкс тод ягаан өнгийн үсээ дээврийн шилээр тусах нарны гэрэлд гялалзуулан зогсож байв. Ард нь цонхигор царай, бууралдуу үстэй Люпин хуучин ноосон цамц, өмдөн дээрээ урт ноорхой жанч хэдэрчээ. Тэднийг ноён ба хатагтай Уизли маглуудын хамгийн сайн хувцастайгаа толгойлон зогсох агаад тод ногоон өнгийн арьсан хүрэмтэй Фред, Жорж хоёр хамт байлаа.

- Рон, Жинни! гээд хатагтай Уизли яаран хүүхдүүдээ чанга тэвэрч,
- Өө, Харри хонгор минь! Чи зүгээр үү? гэлээ.
- Зүгээр гэж Харри худал хэлэхэд хатагтай Уизли түүнийг чанга тэврэлтээр шагнав. Харри түүний мөрөн дээгүүр Рон ихрүүдийн шинэ хүрэм рүү гөлөрч байхыг харлаа.
- Энэ чинь одоо юу вэ? гээд тэр толгой дохив.
- Дээд зэргийн лууны шир, дүү минь. Ажил хэрэг цэцэглээд бид өөрсдийгөө баярлуулахаар шийдсэн юм гээд Фред цахилгаанаа татлаа.
- Сайн уу, Харри гэж Люпин хатагтай Уизли түүнийг орхин Гермиона руу эргэхэд хэлэв.
- Сайн уу. Би мэдсэнгүй ... та нар энд юу хийж байгаа юм бэ?
- Юу гэвэл бид нагац ах эгч хоёр чинь чамайг гэр лүүгээ аваачихаас өмнө жаахан ярилцахаар шийдсэн юм гээд Люпин инээвхийлэв.

- Хэрэггүй байх гэж Харри даруйхан хэлэв.
- Хэрэгтэй гэж Грюм сөөнгөтөөд доголлон ойртож,
- Энэ тэд үү, Поттер? гэв.

Тэр мойног хуруугаараа мөрөн дээгүүрээ заахад шидэт нүд нь шилэн хзүүгээ нэвт харсан нь илт байлаа. Харри түүний нуруу луу хараад үнэхээр гурван Дурслы тойрон хүрээлэгсдийг нь хирдхийсэн байдалтай харан зогсохыг ажиглав.

- За, Харри! гээд ноён Уизли саяхан урам зоригтой мэндчилсэн Гермionaгийн эцэг эхэд охиноо тэврэх боломж олгон,
- Эхлэх үү? гэв.
- Тэгье, Артур гэж Грюм зөвшөөрөв.

Тэд Дурслийнхны зүг хөдлөв. Гермiona эхийнхээ тэврэлтээс мултраад араас нь дагалаа.

- Өдрийн мэнд гэж ноён Уизли эелдэгээр хэлээд Вернон ахын урд зогсов.
- Та намайг санаж байна уу? Миний нэрийг Артур Уизли гэдэг.

Хоёр жилийн өмнө ноён Уизли Дурслийнхны зочны өрөөг сүйтгэсэн болохоор Харри Вернон ах түүнийг мартсан бол их гайхах байлаа. Тэгтэл ч үнэхээр Вернон ахын царай тоосго шиг хүрэгтэн ууртай харсан хэдий ч дуугүй байхыг эрхэмлэж буйгаас нь үзэхэд Дурслийнхан шидтэнгүүдээс хоёр дахин бага байсанд оршиж буй бололтой.

Петунья эгчийн царайд айж сандрах холилдон үзэгдээд хэн нэгэн тэдний хамт байгааг харчих вий гэсэн байртай эргэн тойрноо харав. Дадли жижигхэн ажиглагдахгүй байхыг хичээсэн ч тийм байхад хүч нь хүрсэнгүй.

- Бид таньтай Харригийн тухай хэдэн үг солихыг хүсч байна гэж ноён Уизли өмнөхийн адил инээмсэглэн хэлэв.
- Тиймээ. Түүнийг гэр лүүгээ аваачихаас чинь өмнө гэж Грюм дуугарав.

Вернон ахын сахал уурандаа өрвийлөө. Түүнд бүрх малгай духдуулсан хүний талаар алдаатай сэтгэгдэл төрсөн бололтой Грюм руу шууд хандлаа.

- Манай гэрийн хэрэг таньд ямар хамаатайг мэдэхгүй байна!
- Хэрвээ энэ бүхнийг дурьдвал бүтэн номын сан дүүрэн юм болно гэж Грюм

сөөнгөтөв.

- Энэ чухал биш гэж Тонкс оролцоход ягаан үс нь Петунья эгчийг бүхнээс илүү уурлуулсан хэдий ч ажиглаагүй дүр эсгэн нүдээ анилаа. Өөрөөр хэлвэл бид Харритай муу харьцаж байна гэдгийг мэдэх юм бол ...

- Бид нар мэднэ гэдэгт эргэлзэх явдалгүй гэж Люпин нөхөрсгөөр хэлэв.

- Тиймээ, хэрвээ та Харрид фелетоноор ярих боломж өгөхгүй бол гэж ноён Уизли нэмэрлэв.

- Телефон гэж Гермiona шивнэлээ.

- Тийм шүү хэрвээ бидний чихэнд Поттерт таагүй хандаж байна гэж сонсогдох л юм бол та үүнийхээ хариуг төлөх болно гэж Грюм мэдэгдэв.

Вернон ах уурсан хөөлөө. Тэр харваас уур хилэнгээ хачирхалтай хэвийн бус малгайтай хүнд гаргахаар шийдсэн бололтой.

- Та намайг сүрдүүлж байгаа юм уу, ноёнтоон? гэж чанга хэлэхэд хэдэн хүн гайхан эргэж харлаа.

- Яг тийм гэж Хурц нүдэт Вернон ахыг түргэн ойлгосон явдалд сэтгэл хангалуун хэлэв.

- Таныхаар бол би айлгаж болмоор хүн шиг байна уу? гэж Вернон ах хилэгнэв.

- Юу гэвэл ... гээд Грюм бүрх малгайгаа ялимгүй хойшлуулан зэрлэгээр эргэлдэх шидэт нүдээ гаргалаа. Вернон ах айдаст автан хойш үсрэхдээ тээшний тэргийг өвдтөл цохьчихлоо.

- Би чамд хэлсэн шүү, Дурсль гээд Харри руу эргэн,

- Тэгэхээр, Поттер ... биднийг хэрэгтэй болвол дуудаарай. Хэрвээ чамаас сураг сонсогдолгүй гурван өдөр болвол хэн нэг маань очих болно ... гэв.

Петнунья эгч өрөвдөлтэй гонгинов. Тэр харваас эргэлзээгүй ийм хүмүүс цэцэрлэгийнх нь зам дээр явахыг харвал хөршүүд нь юу гэж хэлэх бол гэж бодсон байх.

- Баяртай шив, Поттер гээд Грюм Харрийн мөрөн дээр гараа тавилаа.

- Өөртөө санаа тавьж байгаарай, Харри гэж Люпин аяархан хэлэв.

- Бид чамайг тэндээс аль боломжтой болсон даруй авна гэж хатагтай Уизли ахин тэврээд шивнэв.

- Удахгүй уулзая, найз минь гэж Роны хоолойд түгшүүр сонсогдлоо. Тэд гар барилцав.
- Үнэхээр удахгүй шүү, Харри гэж Гермiona хэлээд,
- Амалж байна гэлээ.

Харри толгой дохилоо. Тэр бүгд түүнийг харж байхад яагаад ч юм үг хэлж чадсангүй. Тэр инээмсэглээд салах ёс гүйцэтгэн гараа даллаж эргээд буудлын барилгаас нарны гэрэлтэй гудамжинд түрүүлэн гарахад Вернон ах, Петунья эгч, Дадли нар араас нь яаравчилан дагалаа.

ТӨГСӨВ